

# БИ ТӨГС ХҮЧИТ БУРХАН РУУ ХЭРХЭН БУЦАЖ ОЧСОН ТУХАЙ

I БОТЬ



Бид бол ердөө л сатаны завхарсан зан чанартай энгийн бүлэг хүмүүс, бид хэдэн эриний өмнөөс Бурханаар урьдчилан тогтоогдсон хүмүүс бөгөөд бид бол бохир заваан газраас Бурханы өргөн гаргасан ядарч зүдэрсэн хүмүүс юм. Бид нэгэнтээ Бурханыг үгүйсгэж, буруушаан зэмлэж байсан хэдий ч одоо Тэр биднийг байлдан дагуулсан. Бид амийг хүлээн авсан ба Бурханаас мөнх амийн замыг хүлээн авсан. Бид газар дээр хаана байх нь хамаагүй, хавчлага шахалт, зовлон гамшгийг үл харгалзан бид Төгс Хүчит Бурханы авралаас салангид байж чадахгүй. Тэр бидний Бүтээгч учраас бидний цорын ганц аврал юм!

“Үг нь махбодоор илэрсэн” номоос эш татав

---

# Гарчиг

1. Шүүлт бол тэнгэрийн хаанчлалд хүрэх түлхүүр юм
2. Ариусгалтад хүрэх зам
3. Шүүлтийн нууцыг илчлэх нь
4. Хууртагдсан сүнс сэрсэн нь
5. Хэрэн хэсүүчилсэн зүрх сэтгэл гэртээ харилаа
6. Сонсооч! Хэн үг хэлж байна вэ?
7. Мунхаг охин болох шахсан минь
8. Төгс Хүчит Бурхан намайг цэвэр болох замд хөтөлсөн
9. Өөр төрлийн хайр
10. Тэнгэрийн хаанчлал үнэхээр газар дээр байна
11. Би Эзэнтэй эргэн уулзлаа
12. Гурвалын оньсого тайлагдлаа
13. Энэ дуу хоолой хаанаас гардаг вэ?
14. Эзэн Зүүн зүгт гарч ирсэн
15. Одоо би Бурханы шинэ нэрийг мэдсэн
16. Бурханы үг бол миний хүч чадал
17. Сатаны чанд бүслэлтээс гарсан нь
18. Бурханы үг намайг замчлан урхинаас гаргадаг
19. “Шууданч тагтаа” чухал мэдээ авчирлаа
20. Би ХКН-ын засгийн газрын худал хуурмагийг нэвт харж, Бурханы хайр намайг Түүн рүү буцаан татдаг
21. Цуу ярианы занганаас мултрах нь
22. “Барын үүр”-ээс дайжсан нь
23. Аюулын ирмэгт
24. Тэнгэрийн хаанчлалд хүрэх замд хэн саад болдог вэ
25. Би жинхэнэ Христ, хуурамч Христийг ялган таньж чаддаг боллоо
26. Зүрх сэтгэлийнхээ үүдийг нээж, Эзэнийг эргэн ирэхэд угтан авах нь
27. Эзэнтэй дахин уулзсан нь
28. Гэрлийг харахын тулд мананг нэвтрэх нь
29. Харанхуй хонгилын дараах халуун дулаан гэрэл
30. Тэр өдөр тэнгэр тун цэлмэг, нартай байлаа
31. Бөөрөлзгөнийн моддын дунд ургасан бяцхан өвс
32. Өнгөрснөөс бүрмөсөн салсан нь

- 
33. Золгүй явдлаар ерөөл хүртсэн нь
  34. Христэд итгэгчийн сүнслэг сэрэлт
  35. Би жинхэнэ аз жаргалыг оллоо
  36. Эцсийн өдрүүдэд Бурханы авралыг хүлээн зөвшөөрсний дараа бид шинэ амьдралыг олж авдаг
  37. Ачлалгүй хүү эргэн ирсэн нь
  38. Бурхан миний дэргэд байдаг
  39. Би жинхэнэ гэрээ оллоо
  40. Өөр аргаар аврагдсан нь
  41. Эзэнийг эргэн ирэхэд нь би угтан авлаа
  42. Гэртээ харьсан нь
  43. 5дугаар сарын 28-ны Жаоюанийн хэрэг гэр бүлийн хямрал учруулав
  44. Салах маргаан намжсан нь
  45. Төөрөөд замаа дахин оллоо
  46. Би гэртээ ирлээ
  47. Үхлийн ирмэгээс буцсан минь
  48. Үхлийн ирмэгээс амьд үлдсэн нь

## 1. Шүүлт бол тэнгэрийн хаанчлалд хүрэх түлхүүр юм

Жэн Лу, Хятад

Би Христэд итгэгч гэр бүлд төрсөн. Аав минь дандаа л “Эзэнд итгэснээр нүгэл маань уучлагдаж, бид нүгэлгүй болдог, Эзэн ирээд биднийг тэнгэрийн хаанчлалд аваачна, яагаад гэвэл Библид, ‘Учир нь хүн зүрх сэтгэлдээ итгэн зөв шударга байдалд хүрдэг; мөн амаараа хүлээн зөвшөөрч авралд хүрдэг’ (Ром 10:10) гэсэн байдаг” гэж хэлдэг байлаа. Тийм болохоор би өөрийгөө итгэлээр зөвтгөгдөж, аврагдсан, тэнгэрт очно гэж олон жил итгэсэн юм. Дараа нь Эзэн Есүсийн үгийг унштал, **“Үнэнээр Би та нарт хэлье, та нар өөрчлөгдөж, жаахан хүүхдүүдтэй адил болохгүй бол тэнгэрийн хаанчлалд орохгүй”** (Матай 18:3). **“Намайг, ‘Эзэн минь, Эзэн минь’ гэсэн бүхэн тэнгэрийн хаанчлалд орохгүй; харин тэнгэрт байгаа Миний Эцэгийн хүслийг биелүүлдэг хүн орно”** (Матай 7:21) гэсэн байсан. Үүнд би маш их будилсан. Эцэгийн хүслийг биелүүлдэг хүн л тэнгэрт гарч болно гэж Эзэн хэлээд, бидэнд бусдыг бүү үзэн яд, бүү атаарх, бие биеэ хайрла гэж хэлсэн. Гэхдээ би энэ стандартад хүрэхгүй байгаагаа мэдэж байлаа. Би өөрийн ашиг сонирхлын төлөө цаг үргэлж худал хэлж, хуурч мэхэлдэг, бас ах эгч нарт нэг их

---

тэвчээртэй ханддаггүй байсан. Би бусдыг өөр шигээ хайрлаж чадаагүй юм. Юм буруугаар эргэн үед Бурханыг буруутгадаг байлаа. Бурханыг үнэхээр хайрладаг байгаагүй. Тэгээд Эзэний тушаалыг сахиж чадахгүй, Бурханы хүслийг биелүүлэхгүй байсан. Би яаж тэнгэрт гарч чадах юм бэ? Тэгтэл Бурханы ийм үг санаанд орлоо: **“Тиймээс та нар ариун бай, учир нь Би ариун билээ”** (Леви 11:45). Би үргэлж нүгэл үйлдэж, нүглээ улайн, нүгэлд хүлээтэй хэвээр байсан. Эзэн ирээд намайг тэнгэр лүү аваачна гэж үү? Энэ бүгдийг ухаж ойлгохоор Библийг сайтар судаллаа. Ахин дахин уншсан ч нүглээс ангижрах зам олж чадаагүй юм. Тэгээд Паулын хэлсэн үг санаанд орсон: **“Өө, би хөөрхийлөлтэй хүн юм! Энэ үхлийн биеэс хэн намайг ангижруулах билээ?”** (Ром 7:24). Үүнийг Паул ч олж чадаагүй байхад би яаж чадах вэ дээ? Нас явж, амьдралынхаа дийлэнх хугацаанд итгэгч байсан мөртөө тэнгэрт орох эсэхээ би бас л баттай мэдэхгүй, маш хөөрхийлөлтэй, төөрч будилсан мэт санагдсан. Тэнгэр лүү гарч, эцэст нь амар тайвнаар Эзэнтэй уулзах арга олохыг маш их хүссэн юм. Тийм болохоор олны танил, ахмад Христэд итгэгчдийг хаа байгаа газар нь очиж уулзаж эхэлсэн ч тэд ч бас надад тусалж чадаагүй. Бусад урсгалын цуглаанд оролцтол тэд итгэлээр зөвтгөгдөж, аврагдах тухай өнөөх л улиг болсон юмаа ярьсан. Үүнд би маш их урам хугарсан юм.

Гэнэтийн боломж олдож, би гадныхны ажиллуулдаг шашны сургуульд суралцаж эхэллээ. Гадныхны номлол сайхан байх болно гэж бодоод, тэндээс хариултаа олно гэж бат итгэж, итгэл дүүрнээр, хоёр сар гаруй тэнд суралцсан. Харамсалтай нь пастор хичээл дээрээ чуулганы түүх, Есүсийн амьдрал, Шинэ, Хуучин Гэрээний тойм гэх зэргийн тухай номоос л уншдаг, амийн замын талаар огт ярьдаггүй байсан юм. Нэг үдэш, оройн хоолны дараа би пастороос **“Бидэнд амийн замын талаар ярьж өгч болох уу?”** гэж асуулаа. Пастор: **“Энд бид яг наадхыг чинь заадаг юм шүү дээ. Бид бол олон улсад танигдсан, дэлхийн хамгийн том шашны байгууллага. Гурван жилийн дараа та олон улсын пасторын гэрчилгээ авна. Тэгээд дэлхийн хаана ч сайн мэдээ номлож, чуулган байгуулж болно”** гэлээ. Үүнд би үнэхээр их урам хугарсан. Би пастор болохыг хүсээгүй. Зүгээр л яаж тэнгэрт гарахыг мэдмээр байсан. Тийм болохоор, **“Тэр гэрчилгээ тийм сайхан юм бол тэрийг ашиглаад тэнгэрт гарч болох уу?”** гэж асуухад пастор үүнд огт хариулаагүй. Би цааш нь ингэж асуусан юм. **“Таныг олон жил итгэсэн гэж сонссон. Тэгээд та аврагдав уу? Тэнгэрт гарч чадах юм уу?”** гэж. Пастор ч бүрэн итгэлтэйгээр, **“Мэдээж! Би тэнгэрт гарна гэдэгтээ итгэлтэй байна”** гэхэд би: **“Та наад үгээ юунд үндэслэж байгаа юм бэ? Та бусдыг өөр шигээ хайрладаг уу? Нүглээс ангижраад, одоо ариун болсон уу? Жаахан хүүхэд шиг болсон юм уу? Бид өөрийн эрхгүй нүгэл үйлдэж, цаг үргэлж Эзэний сургаалаас зөрдөг. Өдрөөр нүгэл үйлдээд, шөнө нь нүглээ улайдаг. Бурхан бол ариун. Бидэн шиг нүгэлтэй хүмүүс тэнгэрийн хаанчлалд орж чадна гэх гээд байна уу?”** гэж асуулаа. Ингэж асуусны

---

минь дараа пасторын нүүр час улайгаад, таг дуугүй болсон. Миний урам хугарч, шашны сургуулиас гараад, гэртээ харьсан.

Харих замдаа сэтгэлээр унаж, эцсийн найдлага тасарсан мэт санагдаж, тэнгэрт гарах замыг хаанаас олохоо ер мэдэхгүй байсан. Дараа нь хөгшин эцгийн минь нулимстай царай санаанд орлоо. Аав маань итгэлээр зөвтгөгдөнө, бид үхээд тэнгэрт гарна гэж насан туршдаа номлосон ч харуусалтайгаар өөд болсон юм. Би амьдралынхаа дийлэнх хугацаанд Эзэнд итгэж, хүмүүсийг үхээд тэнгэрт гарна гэж өдөр болгон хэлдэг байсан ч одоо тэнгэрийн хаанчлалд яаж орохоо сайн мэдэхгүй байсан юм. Би аав шигээ болж, харуусалтайгаар үхэх юм гэж үү? Гэтэл Эзэн Есүсийн хэлсэн үг гэнэт бодогдлоо: **“Гуй, тэгвэл та нарт өгнө; хай, тэгвэл олно; тогш, тэгвэл та нарт нээгдэнэ”** (Матай 7:7) гэсэн байдаг. “Эзэн итгэмжтэй байдаг, бууж өгч болохгүй! Амьд мэнд байгаа цагт тэнгэр лүү гарах замыг хайсаар л байя” гэж би бодлоо. Тэгээд Эзэний өмнө очиж, ийнхүү залбирлаа: “Хүндэт Эзэн минь, би нүглээс ангижирч, тэнгэрт гарах замыг хаа сайгүй хайлаа, хэн ч надад тусалж чадахгүй байна. Өө Эзэн минь, би яах ёстой юм бэ? Би бол, тэнгэрт гарахын тулд итгэлдээ тууштай бай, эцсээ хүртэл тэвч гэж хүмүүст өдөр болгон хэлдэг номлогч. Гэхдээ яаж нүглээс ангижирч, тэнгэрт гарахыг одоо би өөрөө ч мэдэхгүй байна. Би сохор нь сохрыгоо удирдах гэгч болж, тэднийг бүгдийг нь нүхэнд унагаж байгаа биш үү? Өө Эзэн минь! Тэнгэрт гарах замыг хаанаас олж болох вэ? Таны удирдамжийг гуйж байна” гэсэн.

Гэртээ хариад, олон чуулганы сайн гишүүд, удирдагчид Зүүний Аянга руу явсан гэж сонслоо. Хүмүүс тэдний номлолыг маш сайхан гэгцгээн, шинэ гэрэлтэй, тэр ч бүү хэл зарим пасторын бишрэлийг төрүүлсэн гэж байлаа. “Яахаараа би Зүүний Аянгын хүмүүстэй огт уулзаж байгаагүй байдаг билээ? Нэг өдөр тэдэнтэй уулзвал сайхан аа! Би явж очоод, тэдэнтэй хамт эрж хайж, номлол нь яагаад тийм сайхан байдгийг харж, миний асуудлыг шийдвэрлэж чадах эсэхийг нь үзэх ёстой юм байна” гэж бодогдсон.

Нэг өдөр манай чуулганы Ван ах ирээд, Төгс Хүчит Бурханд итгэдэг хоёр хамаатан нь айлчилж яваа болохоор намайг очооч гэж гуйлаа. Ахын ингэж хэлэхийг сонсоод маш их баярлаж, ахын гэрт яаран очсон юм. Би тэдэнтэй танилцаад, асуудлаа хэлж, “Баптисм хүртвэл аврагдлаа гэсэн үг, зүрх сэтгэлдээ Бурханд итгэж, амаараа нүглээ улайвал итгэлээр зөвтгөгдлөө гэсэн үг, бас Эзэн ирээд биднийг тэнгэр лүү өргөнө гэж би үргэлж итгэж ирсэн. Гэхдээ би тэнгэрт гарч чадах эсэх талаар өнгөрсөн хэдэн жилийн турш будилж, энэ нь тийм энгийн байж болохгүй гэж бодож байна. Библид, ‘Ариун байдалгүйгээр хэн ч Эзэнийг харахгүй’ (Еврей 12:14) гэдэг. Би ч, чуулганы ах эгч нар ч байнга л нүгэл үйлддэг, бидэн шиг нүгэл дунд амьдардаг хүмүүс тэнгэрт гарч чадахгүй

---

гэж бодогдох юм. Бид яг яаж тэнгэрийн хаанчлалд орж болохыг мэдмээр байна. Энэ талаар нөхөрлөж өгч болох уу?” гэсэн.

Жоу эгч инээмсэглээд, “Тэнгэрийн хаанчлалд орох нь Христэд итгэгч болгоны хувьд чухал асуудал. Энэ асуудлын тухайд Эзэн Есүс: **‘Намайг, Эзэн минь, Эзэн минь гэсэн бүхэн тэнгэрийн хаанчлалд орохгүй; харин тэнгэрт байгаа Миний Эцэгийн хүслийг биелүүлдэг хүн орно’** (Матай 7:21) гэж тодорхой хэлсэн. Эзэн маш тодорхой хэлсэн. Үгийг нь хэрэгжүүлж, Бурханы хүслийг биелүүлдэг хүмүүс л тэнгэрийн хаанчлалд орж чадна. Бид нэг аврагдвал үүрд аврагддаг гэж Эзэн хэзээ ч хэлээгүй, биднийг итгэлээр зөвтгөгдсөн болохоор хаанчлалд нь орж болно гэж ч хэлээгүй. Итгэлээр зөвтгөгдөх гэдгийг Паул зохиосон юм. Паул зүгээр л элч, завхарсан хүн байсан. Паул Христ биш байсан болохоор үг нь Христийн үг байгаагүй. Бид тэнгэрт гарахын тулд Паулын үгэнд найдаж болохгүй. Есүс л Эзэн, бас тэнгэрийн хаанчлалын Хаан юм. Түүний үг л эрх мэдэлтэй, үнэн мөн. Хүний үзэл үнэн биш, Эзэний хаанчлалд орох стандартыг тогтоож чадахгүй. Бид үүн дээр Эзэний үгийг л баримталж болно. Паулын үгээр явж болохгүй, тэгээд л гүйцээ” гэсэн. Дараа нь Жоу эгч, итгэлээр зөвтгөгдөж, аврагдах гэж юу гэсэн үг болох тухай, мөн аврагдаж, тэнгэрт гарах тухай Төгс Хүчит Бурханы үгийн хэдэн хэсгийг бидэнд уншиж өгсөн юм. Төгс Хүчит Бурхан ингэж хэлсэн байдаг: **“Тухайн үед Есүсийн ажил бүх хүн төрөлхтнийг золин аврахын төлөө байв. Түүнд итгэсэн бүх хүний нүгэл уучлагдсан; чи Түүнд итгэдэг л бол Тэр чамайг золин аврах байсан; хэрвээ Түүнд итгэсэн бол чи нүгэлтэн байхаа больж, нүглээсээ чөлөөлөгдөх байв. Аврагдах, итгэлээр зөвтгөгдөх гэдэг нь энэ юм. Гэхдээ итгэсэн хүмүүст ч Бурханыг эсэргүүцдэг, тэрслүү зүйл үлдсэн бөгөөд үүнийг мөн л аажмаар арилгах хэрэгтэй байлаа. Аврал гэдэг нь Есүс хүнийг бүрэн олж авсан гэсэн үг биш, харин хүн нүгэлтэн байхаа больж, нүглээ уучлуулсан гэсэн үг юм. Чи итгэх л юм бол дахиад хэзээ ч нүглийнх байхаа болих юм”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурханы ажлын үзэгдэл (2)”). **“Есүс эцсийн өдрүүдэд бууж ирнэ гэдгийг л чи мэддэг, гэхдээ Тэр яг яаж бууж ирэх вэ? Дөнгөж золин аврагдсан, өөрчлөгдөөгүй, эсвэл Бурханаар төгс болгуулаагүй чам мэтийн нүгэлтэн Бурханы зүрх сэтгэлийн дагуу байж чадах уу? Одоо ч гэсэн хуучин хэвээрээ байгаа чиний хувьд, Есүсээр авруулж, Бурханы авралын улмаас нүгэлтэн гэж тооцогдохгүй байгаа чинь үнэн боловч нүгэлтэй биш, бохир заваан биш гэдгийг чинь энэ нь нотлохгүй. Хэрвээ өөрчлөгдөөгүй юм бол чи яаж ариун байж чадах юм бэ? Дотроо чи бохир заваанаар дүүрч, хувиа хичээсэн, өөдгүй байдаг мөртөө Есүстэй хамт буухыг хүссээр байдаг—тийм азтай явдал байна гэж үү дээ! Бурханд итгэх итгэлдээ чи нэг алхмыг орхисон: Чи зүгээр л золин аврагдсан, гэхдээ өөрчлөгдөөгүй. Чи Бурханы зүрх сэтгэлийн дагуу байхын тулд чамайг өөрчилж, цэвэрлэх ажлыг**

---

Бурхан биечлэн хийх ёстой; чи зөвхөн золин авруулсан бол ариун байдалд хүрч чадахгүй. Ийм маягаар чи Бурханы сайн ерөөлийг хуваалцах эрхгүй байх болно, учир нь чи хүнийг удирдах Бурханы ажилд нэг алхмыг орхигдуулсан, энэ нь өөрчлөгдөж, төгс болох гол алхам юм. Тиймээс дөнгөж золин аврагдсан нүгэлтэн чи Бурханы өв залгамжлалыг шууд өвлөн авч чадахгүй” (Үг нь махбодоор илэрсэн номын “Нэршил болон ялгамж чанарын талаар”). “Хэдийгээр Есүс хүмүүсийн дунд их ажил хийсэн ч бүх хүн төрөлхтний золин авралыг л гүйцэлдүүлж, хүний нүглийн тахил болсон юм; Тэрээр хүнийг бүх завхарсан зан чанараас нь салгаагүй. Хүнийг Сатаны нөлөөнөөс бүрэн аврах нь, Есүсээс нүглийн тахил болж хүний нүглийг үүрэхийг шаардаад зогсохгүй, бас хүнийг сатанлаг завхарсан зан чанараас нь бүрэн салгахын тулд улам их ажил хийхийг Бурханаас шаардсан. Ингээд хүний нүгэл уучлагдсаны дараа Бурхан хүн төрөлхтнийг шинэ эрин үе рүү хөтлөхийн тулд махбодод эргэн ирж, гэсгээлт, шүүлтийн ажлыг эхлүүлсэн юм. Энэ ажил нь хүнийг илүү өндөр хүрээнд аваачсан. Түүний ноёрхол дор захирагддаг бүх хүн илүү өндөр үнэнийг эдэлж, илүү агуу ерөөлийг хүлээн авна. Тэд үнэхээр гэрэлд амьдарч, үнэн, зам, амийг олж авна” (Үг нь махбодоор илэрсэн номын Өмнөх үг).

Дараа нь Ван эгч ингэж нөхөрлөлөө: “Хуулийн эрин үеийн сүүлчээр Сатан хүн төрөлхтнийг улам гүн гүнзгий завхруулж, хүмүүс улам их нүгэл үйлдэж, хүн болгон хуулийн дор үхэх аюулд байсан. Тиймээс Нигүүлслийн эрин үед Эзэн Есүс золин авралын ажил хийж, цовдлуулснаар хүний нүглийн тахил болж, хүний нүглийг уучилсан юм. Тухайн үед бид Эзэнд итгэж, нүглээ улайж, Эзэнд гэмшихэд л болох байсан, тэгээд нүгэл маань уучлагдаж, бид Эзэний хайрласан нигүүлслийг эдэлж чадах байлаа. Энэ нь хуулийн дор амьдарч байсан хүмүүсийн хувьд аврал байсан юм. Энэ ‘аврал’ нь хуулийн дор яллагдаж, хараагдахаа больж, дахин хэзээ ч хуулиар яллагдахгүй гэсэн утгатай байсан. Энэ нь ‘итгэлээр аврагдах’ явдал байсан юм. Итгэлээр зөвтгөгдлөө гээд бид зөв шударга болчихдог юм биш. Итгэлээр зөвтгөгдөж, аврагдана гэдэг нь бид нүгэлгүй болж, бүрмөсөн ариусаж, бүрэн аврал хүртсэн, бас тэнгэрт гарч чадна гэсэн үг биш. Хэдийгээр нүгэл маань уучлагдсан ч нүгэлт уг чанар, сатанлаг зан чанар маань бидний дотор гүн үндэслээтэй хэвээр байна. Бид одоо ч худал хэлж, хуурч мэхэлж, бусдад атаархаж, бусдыг үзэн ядаж чаддаг, бас үргэлж нүгэл үйлдэж, Бурханыг эсэргүүцдэг. Сатанлаг зан чанараар ингэж их дүүрсэн, Бурханд дуулгаваргүй байж, эсэргүүцдэг бидэн шиг хүмүүс ер нь тэнгэрийн хаанчлалд орж яаж чадах юм бэ? Тийм учраас Эзэн Есүс эргэж ирнэ гэж амласан. Тэгээд эцсийн өдрүүдэд Төгс Хүчит Бурхан ирсэн. Тэр биднийг цэвэрлэж, аврах бүх үнэнийг илэрхийлсэн, бас сатанлаг уг чанар болон зан чанарыг маань шийдвэрлэж, биднийг нүглээс бүрэн аварч, ариусгаж, улмаар тэнгэрийн хаанчлалд оруулахын тулд шүүлтийн



---

ажил хийж байгаа. Төгс Хүчит Бурханы шүүлтийн ажил Эзэн Есүсийн ийм зөгнөлийг биелүүлдэг: **‘Та нарт хэлэх зүйл Надад олон байгаа боловч та нар одоо тэдгээрийг дааж чадахгүй. Гэхдээ үнэний Сүнс болох Тэр ирэх үедээ та нарыг бүх үнэн рүү удирдана’** (Иохан 16:12–13). **‘Учир нь Би дэлхий ертөнцийг шүүхийн тулд биш, харин аврахын тулд ирсэн билээ. Намайг голж, Миний үгийг хүлээж авдаггүй хүнийг шүүх шүүгч байдаг: Миний хэлсэн үгс түүнийг эцсийн өдөр шүүх болно’** (Иохан 12:47–48). **‘Бас 1 Петрт: Учир нь шүүлт Бурханы гэрээс эхлэх цаг болжээ’** (1 Петр 4:17) гэдэг. Нигүүлслийн эрин үеийн золин авралын ажлыг туулснаар бид Эзэний нигүүлслийг л эдэлж, нүглээ уучлуулж чадна. Харин нүглээс ангижирч, цэвэрлэгдэж чадахгүй. Тийм болохоор бид эцсийн өдрүүд дэх Бурханы шүүлтийн ажлыг хүлээн авч, дуулгавартай дагаж, үнэхээр гэмшиж, завхралаа цэвэрлэж, нүглээс ангижирч, нэгмөсөн бүрэн аврагдах ёстой. Тэгээд бид гамшгаас амьд үлдэж чадна, Бурхан биднийг хаанчлалдаа оруулна” гэлээ.

Эгчийн нөхөрлөл үнэхээр нүдийг минь нээсэн юм. Итгэлээрээ аврагдаж, тэнгэрт гарна гэх санаа ердөө л бидний төсөөлөл, бас Эзэний үгтэй нийцдэггүй байж шүү дээ. Эзэн Есүс золин авралын ажил хийсэн болохоос нүглээс ангижруулах ажил хийгээгүй, тиймээс бидний дотор нүгэлт уг чанар маань хэвээр үлдэж, бид одоо ч өөрийн эрхгүй нүгэл үйлдэн, Эзэнийг эсэргүүцдэг. Би махан биеэ яаж ч хаяж, биеэ яаж ч захирлаа гэсэн тэр олон жилийн турш нүглээс хэзээ ч ангижирч чадаагүйд гайхах юм алга. Энэ нь нүгэлт уг чанараас минь болсон, бас Бурханы шинэ ажлыг туулаагүйгээс минь болсон байж таарлаа. Төгс Хүчит Бурхан бидний нүгэлт уг чанарыг үндсээр нь арилгаж, биднийг нэгмөсөн цэвэрлэж, бүрэн аврахын тулд шүүлтийн ажил хийдэг. Энэ бидэнд яг хэрэгтэй зүйл, энэ маш сайхан хэрэг юм! Эцсийн өдрүүдэд Бурхан биднийг яаж шүүж, цэвэрлэдгийг би мэдэхгүй байсан болохоор эгч нараас энэ талаар асуулаа.

Ван эгч Төгс Хүчит Бурханы үгээс өөр нэг хэсгийг уншиж өгсөн юм: **“Эцсийн өдрүүдэд Христ хүнийг сургах, хүний мөн чанарыг ил болгох, хүний үг болон үйлдэлд нь дүн шинжилгээ хийхийн тулд төрөл бүрийн үнэнийг хэрэглэдэг. Хүний үүрэг, хүн яаж Бурханд дуулгавартай байх ёстой, хүн яаж Бурханд үнэнч байх ёстой, хүн яаж хэвийн хүн чанарыг амьдран харуулах учиртай болон Бурханы мэргэн ухаан, зан чанар гэх зэрэг төрөл бүрийн үнэн эдгээр үгэнд агуулагддаг. Эдгээр үг нь бүгд хүний мөн чанар болон ялзарсан зан чанар луу чиглэдэг. Ялангуяа, хүн Бурханыг хэрхэн голдгийг илчилсэн үгсийг хүн бол Сатаны биелэл, Бурханы эсрэг дайсны хүч болдог тухайд хэлсэн байдаг. Шүүлтийн ажлаа хийхдээ Бурхан хүний уг чанарыг ердөө хэдхэн үгээр тодорхой болгодог юм биш; Тэрээр удаан хугацааны туршид илчилж, харьцаж, засдаг. Илчлэл, харьцалт болон засалтын эдгээр аргыг энгийн үгээр бус,**



---

харин хүнд огт байдаггүй үнэнээр л орлуулж болно. Зөвхөн ийм төрлийн арга барилыг л шүүлт гэж нэрлэж болно; ийм төрлийн шүүлтээр л дамжуулан хүн номхорч, Бурханд захирагдахаар бүрэн үнэмшээд зогсохгүй, Бурханы тухай жинхэнэ мэдлэгийг олж авч чаддаг. Шүүлтийн ажлын авчирдаг зүйл гэвэл Бурханы жинхэнэ дүр төрх болон өөрийнх нь тэрслүү байдлын үнэний талаарх хүний ойлголт юм. Шүүлтийн ажил нь хүнд Бурханы хүслийн тухай, Бурханы ажлын зорилгын тухай, хүний ойлгошгүй нууцуудын тухай ихээхэн ойлголт олж авах боломж олгодог. Түүнчлэн, өөрийн ялзарсан мөн чанар болон ялзралынхаа үндсийг таньж мэдэх, хүний муу муухайг нээн илрүүлэх боломжийг олгодог. Энэ бүх үр дүнг шүүлтийн ажил авчирдаг, учир нь энэ ажлын мөн чанар нь үнэндээ Бурханы үнэн, зам, амийг Түүнд итгэдэг бүх хүнд нээх ажил юм. Энэ ажил нь Бурханы хийдэг шүүлтийн ажил билээ” (Үг нь махбодоор илэрсэн номын “Христ шүүлтийн ажлыг үнэнээр хийдэг”).

Дараа нь эгч ингэж нөхөрлөсөн: “Эцсийн өдрүүдэд Төгс Хүчит Бурхан биднийг шүүж, цэвэрлэхийн тулд үнэнийг илэрхийлж, Бурханыг эсэргүүцдэг хүний сатанлаг уг чанар, зан чанарыг илчилдэг. Бурханы үгийн шүүлт, илчлэл, баримтаар дамжуулан бид Сатаны завхралд яг хэр их өртсөнөө олж хардаг. Бид уг чанартаа биеэ тоосон, зальхай, үнэнийг үзэн яддаг, хатуу чанд, ёрын муу байдаг. Сатанлаг зан чанар бидний яс маханд шингэж, бид бараг хүн шиг харагддаггүй. Эдгээр завхарсан зан чанарт хянуулаад бид өөрийн эрхгүй Бурханыг эсэргүүцэж, тэрсэлдэг. Жишээ нь, бид бусдаас хүндлэл хүлээхийн тулд ажиллаж, номлож байхдаа ихэвчлэн онгирч, гайхуулдаг. Бид өөрсдийнхөө ашиг сонирхлын төлөө яахаас ч буцахгүй, бас нэр төрийн төлөө тэмцэлдэж, бие биеийнхээ эсрэг хуйвалдаж, өөрсдөөсөө сайн хэнд ч атаархаж, үзэн яддаг, ерөөл хүртэж, Бурханы хаанчлалд орохын төлөө л өөрсдийгөө зарлагадаж, гэр оронд асуудал гармагц Бурханыг буруутгаж, буруугаар ойлгодог. Бурханы шүүлт, гэсгээлт бидэнд завхралыг маань харуулдаг. Дараа нь бид сатанлаг уг чанараа үнэхээр үзэн ядаад, харуусаж, өөрсдийгөө үзэн ядаж эхэлдэг, тэгээд Бурханд гэмшдэг. Бас Бурханы зөвт зан чанарын талаар бага зэрэг мэдэж авч, Бурханаас эмээж, Бурханд захирагдаж эхлэн, ухамсартайгаар махан биеэ хаяж, Бурханы үгийг хэрэгжүүлж чаддаг, бас зүй зохистой бүтээгдсэн зүйлийн хувиар үүргээ биелүүлж чаддаг болж, хүний төрхийг амьдран харуулж эхэлдэг. Энэ бүхнийг туулснаар бид, Сатаны завхралд хэчнээн гүн гүнзгий автсанаа мэдэрч, Бурханы үгийн шүүлтийг хүлээн авах ёстой гэдгээ, сатанлаг зан чанараа цэвэрлэх ёстой, Бурханыг цаашид эсэргүүцэж болохгүй, энэ нь л Бурханы хаанчлалд орох цорын ганц зам гэдгийг мэдэрдэг” гэлээ.

Эдгээр нөхөрлөлийг сонсоод сэтгэл цэлмэлээ. Хэрвээ бид Төгс Хүчит Бурханы шүүлтийн ажил биш, Нигүүлслийн эрин үеийн золин авралын ажлыг л хүлээн авах юм бол

---

насан туршдаа Эзэнд итгээд ч нүгэлд үргэлж хүлээтэй байна, тэгээд хэзээ ч Бурханы хүслийг биелүүлж, Бурханы хаанчлалд орохгүй. Төгс Хүчит Бурхан үнэнийг илэрхийлж, шүүлтийн ажлаа хийж байгаа нь тэнгэрийн хаанчлалд орох цорын ганц арга зам юм! Би тэнгэрийн хаанчлалд орох замыг олон жилийн турш газар сайгүй хайгаад, одоо эцэст нь олоод, баярын нулимс цийлгэнэж, урт удаан хугацаанд тээж явсан хүсэл минь биелсэн. Энэ бол Бурханы дуу хоолой, Төгс Хүчит Бурхан бол эргэж ирсэн Эзэн Есүс мөн! Эзэн Есүсийг мэндлэх үед, төрснөөс нь хойш наймхан хоногийн дараа уулзаад, Симеон магнай хагартлаа баярласан. Би энэ насандаа Бурханы дуу хоолойг сонсож, Эзэнийг угтан авч чадсандаа Симеоноос ч их баярлаж, илүү их ерөөгдсөнөө мэдэрдэг! Би Төгс Хүчит Бурханд маш их талархаж байна!

## 2. Ариусгалтад хүрэх зам

Кристофер, Филиппин

Намайг Кристофер гэдэг, би Филиппин дэх гэр чуулганы пастор. 1987 онд баптисм хүртэж, Эзэн Есүс рүү эргэж, дараа нь Эзэний нигүүлслээр 1996 онд орон нутгийн чуулганы пастор болсон юм. Тухайн үед би Филиппиний олон газарт ажиллаж, номлож байсан төдийгүй Хонг Конг, Малайз зэрэг газруудад ч номлож байв. Ариун Сүнсний ажил болон удирдамжаар дамжуулан Эзэний төлөөх ажилдаа би шавхагдашгүй эрч хүчтэй, номлолдоо дуусашгүй урам зоригтой байдаг байлаа. Би сөрөг, сул дорой болсон ах, эгч нартаа үргэлж дэмжлэг үзүүлдэг байсан юм. Заримдаа тэдний үл итгэгч гэр бүлийнхэн надтай нөхөрсөг бус харьцах үед би хүлээцтэй, тэвчээртэй байж мөн л чаддаг байв; би Эзэнд итгэх итгэлээ алдаагүй бөгөөд Эзэн тэднийг өөрчилж чадна гэдэгт итгэдэг байлаа. Иймээс, итгэгч болсноосоо хойш би асар их өөрчлөгдсөн юм шиг санагддаг. Гэвч 2011 оноос эхлээд би Ариун Сүнсний ажлыг урьдын адил хүчтэй мэдрэхээ болив. Аажмаар би номлолынхоо шинэ гэгээрлийг алдаж, нүгэлтэй амьдралаас ангижрах хүч чадал дутаж байлаа. Эхнэр, охин хоёр маань миний дургүй зүйлийг хийж байхыг харах үедээ би өөрийн эрхгүй тэдэнд уурлаж, уурласандаа тэднийг загнадаг байв. Энэ нь Эзэний хүсэлтэй нийцэхгүй байгааг мэдэж байсан ч биеэ барьж чадахгүй байлаа. Энэ нь миний хувьд маш их шаналгаатай байсан юм. Би нүгэл үйлдээд, дараа нь нүглээ улайх амьдралаас өөрийгөө салгахын тулд Библи уншиж, мацаг барьж, залбирахад шамдан, хамт эрж хайж, судлах сүнслэг пасторуудыг хаа сайгүй хайлаа. Гэвч миний бүх хүч чармайлт талаар болсон бөгөөд нүгэлт амьдрал, сэтгэл дэх харанхуй байдалд минь ямар ч өөрчлөлт гарсангүй.

2016 оны хаврын нэгэн орой эхнэр минь надаас “Кристофер, ойрд үнэхээр их

---

зовуурьтай байгааг чинь би анзаарлаа. Сэтгэлд чинь юу бодогдоо вэ?” гэж асуув. Намайг юу зовоогоод байгааг би эхнэртээ хэлэв: “Би пастор болж, Эзэнд олон жилийн турш итгэсэн мөртөө сүүлийн хэдэн жил яагаад өөрийгөө нүгэлт амьдралаас чөлөөлж чадахгүй байна вэ гэж гайхширч байлаа. Би Эзэнийг мэдэрч чадахаа болиод, Эзэн намайг хаячихсан юм шиг л байна. Би хаа сайгүй явж номлодог хэдий ч чөлөөт цагаараа, ялангуяа шөнө дүлээр үргэлж хоосон, түгшүүртэй санагдаж, энэ мэдрэмж ерөөсөө улам нэмэгдсээр байна. Би энэ олон жилд Эзэнд итгэж, Библийг ихээхэн уншиж, Эзэний маш олон номлолыг сонсон, загалмай үүрч, өөрийгөө ялан дийлнэ гэж байнга шийдэж байсан боловч үргэлж нүгэлд хүлэгддэг тухайгаа боддог. Би ашиг сонирхол, нэр нүүрээ хамгаалахын тулд худал хэлж чаддаг бөгөөд **‘Тэдний амнаас ямар ч худал олдсонгүй’** (Илчлэл 14:5) гэдгийг хэрэгжүүлж чаддаггүй. Бэрхшээл, цэвэршүүлэлттэй тулгарах үедээ эдгээр нь Эзэний зөвшөөрлөөр тохиолдож байгааг мэддэг хэдий ч Эзэний талаар гомдоллож, Түүнийг буруугаар ойлгохоо больж мөн л чаддаггүй. Би өөрийгөө дуртайяа үгүйсгэж огт чаддаггүй. Ийм маягаар нүгэлд амьдарч байгаад би Эзэнийг ирэхэд тэнгэрийн хаанчлалд орж чадахгүй гэж айж байна!”

Үүнийг сонсоод эхнэр маань: “Кристофер, чи яаж ингэж бодож чадаж байна аа? Чи итгэлтэй байх ёстой; чи чинь пастор шүү дээ! Хэдийгээр бид нүгэл дотор амьдарч, нүглийн хүлээсээс ангижраагүй боловч Библид ‘Хэрвээ та Эзэн Есүсийг амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан Түүнийг үхлээс амилуулсан гэж зүрх сэтгэлдээ итгэвэл аврагдах болно’ (Ром 10:9). ‘Учир нь Эзэний нэрийг дуудах хэн боловч аврагдах болно’ (Ром 10:13). Бид Библи уншиж, цуглаанд оролцож, Эзэнд залбирч, загалмайгаа үүрэн, Эзэнийг хоёр дахиа ирэх хүртэл алдалгүй дагасаар байгаа цагт бид тэнгэрийн хаанчлалд орж, Эзэний ерөөлийг хүлээн авч чадна” гэж хэллээ.

Би дараа нь эхнэртээ ингэж хэлэв: “Би өмнө нь тэгж боддог байсан ч Петр 1:16-д ‘Учир нь, **“Би ариун учраас та нар ариун байгтун”** гэж бичигдсэн юм.’ Би Эзэнд гучин жил итгэсэн атлаа Эзэний замыг сахиж чадалгүй, нүгэл дунд амьдарч, Эзэнийг үргэлж эсэргүүцэх чадвартай хэвээр байна. Би Эзэний шаардлагад өчүүхэн ч нийцдэггүй. Өө! Эзэний сургаалыг дуулгавартай дагахаар би хэчнээн удаа шийдсэн ч Түүний үгийг хэрэгжүүлж чадаагүй билээ дээ. Ийм байхад би яаж тэнгэрийн хаанчлалд ороход тохирох юм бэ? Эзэн Есүс: **‘Намайг, “Эзэн минь, Эзэн минь” гэсэн бүхэн тэнгэрийн хаанчлалд орохгүй; харин тэнгэрт байгаа Миний Эцэгийн хүслийг биелүүлдэг хүн орно’** (Матай 7:21). Эзэний үгийн дагуу бол тэнгэрийн хаанчлалд орох нь бидний боддог шиг энгийн биш. Эзэн ариун учраас Түүний үгийг хэрэгжүүлж чаддаггүй, Түүнийг байнга эсэргүүцдэг хүмүүс яаж тэнгэрийн хаанчлал руу өргөгдөж чадах билээ? Өөрчлөгдсөн, Бурханы хүслийг хэрэгжүүлдэг хүмүүс л тэнгэрийн хаанчлалд орж чадна!”

---

Эхнэр минь түр зуур бодоод, “Чиний хэлсэн зүйл ортой байна. Эзэн ариун бөгөөд бид нүгэлтэй хэвээр байгаа. Бид Бурханы хаанчлалд ороход тохирохгүй. Зүгээр л ... би гэнэт саналаа л даа ... Лиу пастор Солонгос пастор Кимийг чуулганд урьсан биш үү? Хоёулаа энэ асуудлаар бага зэрэг эрэлхийлбэл ямар вэ?” гэв. Би: “Тэгье, сайхан санаа байна. Эзэн Есүс: **‘Гуй, тэгвэл та нарт өгнө; хай, тэгвэл олно; тогш, тэгвэл та нарт нээгдэнэ’** (Матай 7:7). Бид эрж хайж байгаа цагт Эзэн биднийг хөтөлнө гэдэгт би итгэж байна. Пасторын хувьд би ах эгч нарын амийг бодолцох ёстой. Би итгэлдээ ёс журамгүй байвал тэдэнд ч, өөртөө ч хор хөнөөл учруулна. Тэгэхээр Ким пасторыг иртэл хүлээгээд энэ асуудлын талаар түүнээс асууя” гэж хэллээ.

Би Ким пасторыг хайж олохыг хүсэж байсан тул түүний нөхцөл байдлын талаар бага ч болов мэдэхийг хүссэн юм. Ингээд би түүний байдаг Солонгос чуулганыг интернэтээс хайв. Гарч ирсэн хуудсууд дотор <https://mn.kingdomsalvation.org/> вэб сайт харагдлаа. Нээгээд үзэхэд эдгээр үг миний анхаарлыг татав: **“Хүн махан биеийн амар амгалан, аз жаргал, нэг гишүүнийх нь итгэл бүхий л гэр бүлийнхэнд ерөөл авчрах, өвчнийг эдгээх гэх мэт ихээхэн нигүүлслийг хүлээн авчээ. Үлдсэн нь хүний сайн үйл хэрэг, мөн түүний сүсэг бишрэлтэй төрх байдал байв; хэрвээ хүн эдгээрт үндэслэн амьдарч чаддаг бол түүнийг боломжийн итгэгч гэж үздэг байлаа. Ийм итгэгчид л үхсэнийхээ дараа диваажинд орж чадах байсан ба энэ нь тэд аврагдсан гэсэн үг байлаа. Гэвч энэ хүмүүс амьдрах хугацаандаа амийн замыг огт ойлгоогүй юм. Тэд зан чанараа өөрчлөх ямар ч замгүйгээр тогтмол давтамжтайгаар нүгэл үйлдэж, дараа нь нүглээ улайдаг байсан: Нигүүлслийн эрин үе дэх хүний нөхцөл байдал ийм байлаа. Хүн бүрэн аврал хүртсэн үү? Үгүй!”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Бие махбодтой болохын нууц (4)”). Эдгээрийг үнэхээр сайн хэлсэн байсан тул би яах ч аргагүй үргэлжлүүлэн уншлаа: **“Тиймээс ажлын тэрхүү үе шат дууссаны дараа шүүлт, гэсгээлтийн ажил хэвээр үлдсэн юм. Энэ үе шат нь үгийн тусламжтайгаар хүнийг ариусгаж, улмаар түүнд дагах зам өгөхийн төлөө байдаг. Хэрвээ чөтгөрийг хөөн зайлуулахаа үргэлжлүүлсээр байсан бол энэ үе шат үр дүнгүй, утга учиргүй байх байлаа, учир нь энэ нь хүний нүгэлт уг чанарыг арилгаж чадахгүй бөгөөд хүн нүглээ уучлуулаад л зогсонги байдалд орох байв. Цовдлолын ажил аль хэдийн дуусаж, Бурхан Сатаныг ялан дийлсэн учраас нүглийн тахилаар дамжуулан хүн нүглээ уучлуулсан. Гэвч хүний доторх завхарсан зан чанар хэвээр үлдэж, хүн нүгэл үйлдэж, Бурханыг эсэргүүцэж мөн л чаддаг бөгөөд Бурхан хүн төрөлхтнийг олж аваагүй. Тийм учраас ажлын энэ үе шатанд Бурхан хүний завхарсан зан чанарыг илчлэхийн тулд үг ашиглаж, зөв замын дагуу хэрэгжүүлэхэд түүнийг хүргэдэг. Энэ үе шат нь өмнөхийг бодвол илүү утга учиртай, мөн түүнчлэн илүү үр дүнтэй байдаг, учир нь**

---

одоо цагт хүний амийг шууд хангаж, хүний зан чанарыг бүрэн шинэчлэхэд хүргэдэг зүйл нь үг билээ; энэ нь ажлын илүү бүрэн гүйцэд үе шат юм” (Үг нь махбодоор илэрсэн номын “Бие махбодтой болохын нууц (4)”). Үүнийг унших нь миний хувьд тун сэтгэл хөдлөм байлаа. Хэдийгээр би үүнийг бүрэн ойлгож чадахгүй, зарим үг нь бүр будилмаар санагдаж байсан ч эдгээр үг надад жаахан итгэл найдвар харах боломж олгосон юм. Үүн дотроос өөрийгөө ариусгаж, өөрчлөх замыг олж болох юм гэж надад санагдлаа. Миний залбирлыг сонссоных нь төлөө би зүрхнийхээ угаас Бурханд талархаж байв. Үргэлжлүүлэн уншихын хэрээр би эдгээр нь үнэхээр ангасан сүнснийг минь усалж, хариулах гайхалтай үг юм гэдгийг мэдэрсэн билээ. Вэб сайт дээр “Хэрэв та улс орон эсвэл бүс нутгийнхаа Сайн мэдээний шууд холбогдох дугаарыг олж чадахгүй бол бидэнд зурвас үлдээнэ үү, бид тантай аль болох хурдан холбогдох болно” гэж байхыг харав. Би хурдхан хараад Филиппинд зориулсан шууд холбогдох дугаарыг олоогүй тул тэр даруй зурвас үлдээж, холбоо барих дугаар болон э-мэйл хаягаа эргэлзэлгүйгээр бичиж үлдээлээ.

Тэр үдэш гэртээ хариад би эхнэртээ энэ тухай хэлсэн бөгөөд миний хэлснийг сонссоныхоо дараа эхнэр минь ч бас эрж хайхыг хүсэж байв. Маргааш нь тэд миний зурваст хариу өгч, тэр өдрийнхөө үдээс хойш бидэнтэй онлайнгаар холбогдохоор зохицуулсанд би Эзэнд үнэхээр талархаж байна. Үдээс хойш нь бид Лиу эгч, Су эгч хоёртой ярилцлаа. Ярианаас нь үзэхэд тэд энгийн, ухаалаг, гүн ойлголттой ярьж байгаа нь мэдрэгдэв. Эхнэр маань надаас ч их санаа зовж, “Би нэг асуулт асуувал болох уу?” гэж асуув. Тэд урам зоригтойгоор: “Мэдээж болно” гэсэн юм. Эхнэр маань: “Танай чуулганы вэб сайт дээр ‘Эцсийн өдрүүдийн Бурхан шүүлт, гэсгээлтийн ажлын үе шатыг хийсэн’ гэж бичсэн байна. Эзэн ариун учраас ариун бус ямар ч хүн Эзэнийг харахгүй гэдгийг нөхөр бид хоёр мэднэ, гэхдээ Ром номд ингэж хэлсэн, ‘Хэрвээ та Эзэн Есүсийг амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан Түүнийг үхлээс амилуулсан гэж зүрх сэтгэлдээ итгэвэл аврагдах болно’ (Ром 10:9). ‘Учир нь Эзэний нэрийг дуудах хэн боловч аврагдах болно’ (Ром 10:13). Хэрэв бид Эзэн Есүст итгэдэг бол аль хэдийн аврагдсан бөгөөд тэнгэрийн хаанчлалд орж болно, гэтэл эцсийн өдрүүдийн Бурхан яагаад шүүлт, гэсгээлтийн ажлын үе шатыг хийж байгаа юм бэ? Би үүнийг сайн ойлгохгүй байна, тэгээд та нарын бодлыг сонсох гэсэн юм” хэмээн хариулав.

Лиу эгч хариуд нь: “Бурханд талархъя! Хамт нөхөрлөж, Бурханаар бүгдээрээ удирдуулъя. Эхлээд ‘аврагдах’ гэдэг нь юу гэсэн үг болохыг харцгаая. Хуулийн эрин үеийн сүүлчээр хүмүүс бүгд Бурханаас холдож, Бурханаас эмээх зүрх сэтгэлтэй байхаа больсон. Тэд улам бүр нүгэлтэй болж, бүр сохор, доголлон, өвчтэй мал болон шувууг тахил болгон өргөхөд хүрчээ. Тэр үеийн хүмүүс хуулийг баримтлахаа больсон бөгөөд хууль зөрчсөнийхөө төлөө үхэх ялаар яллагдах аюулд ороод байв. Ийм нөхцөл байдалд, хуулийн

---

дор амьдарч буй хүмүүсийг тодорхой үхлээс аврахын тулд Бурхан Өөрөө махбод болж, золин аврах ажлыг хийж, бүх хүн төрөлхтнийг нүглээс золин аврахын тулд эцэст нь цовдлогдсон. Хүмүүс Эзэн Есүст итгэж, улмаар залбирлаараа Бурханы өмнө ирж, Бурханы нигүүлсэл, ерөөлийг эдлэх эрхтэй болсноор нүглээ уучлуулж чадсан юм. Энэ бол Нигүүлслийн эрин үед ‘аврагдах’ гэдгийн жинхэнэ утга учир юм. Өөрөөр хэлбэл, ‘аврагдах’ гэдэг нь хүний нүгэл уучлагдаж байгаагаас цаашгүй билээ. Өөрөөр хэлбэл, Бурхан хүмүүсийг нүгэлтэй гэж үзэхээ болино, гэхдээ хүмүүс төрөлхөөсөө нүгэлгүй гэсэн үг биш. Тиймээс аврагдах гэдэг нь бид бүрмөсөн ариусаж, бүрэн аврал хүртсэн гэсэн үг биш. Хэрэв бид ариусагдахыг хүсэж байвал Бурханы эцсийн өдрүүдийн шүүлтийн ажлыг хүлээн авах ёстой” гэж хэллээ.

Тэдний нөхөрлөлийг сонссоны дараа л, Ромын захидалд дурдсан “аврагдах” гэдэг нь Эзэн Есүсийн авралыг хүлээн зөвшөөрч, хууль зөрчсөнийхөө төлөө үхэх ялаар яллагдахаа болино гэдгийг хэлж байгааг эхнэр бид хоёр ойлгосон юм. Энэ нь бүрэн дүүрэн ариусагдах явдал гэж бидний төсөөлж байсан “аврагдах”-аас өөр байсан юм. Тэдний хэлсэн зүйл утга учиртай байлаа. “Аврагдах” гэдгийг тэгж тайлбарласан нь нүгэл үйлдээд, дараа нь нүглээ улайдаг байдалд амьдарч байгаа бидний нөхцөлтэй таарч байв. Тиймээс Эзэн Есүсийн хийсэн зүйл бол хүнийг бүрэн дүүрэн ариусгаж, аврах ажил биш, ердөө золин аврах ажил байжээ. Хүмүүс Эзэнд итгэмэгцээ аврагддаг хэдий ч энэ нь тэд бүрэн дүүрэн ариуссан гэсэн үг биш. Тэдний нөхөрлөлийг сонсоод би эрж хайж болох үнэн үүн дотор байгааг мэдэрсэн тул нөхөрлөлийг үргэлжлүүлэн сонсох хүсэлтэйгээ илэрхийлэв. “Эзэнд талархъя! Та нарын хэлж байгаа зүйл гайхалтай юм. Та нартай ингэж нөхөрлөснөөр бид одоо ‘аврагдах’ гэдгийн жинхэнэ утгыг ойлгож байна. Нөхөрлөлөө үргэлжлүүлнэ үү. Эзэн биднийг залж чиглүүлэх болтугай” гэж би хэлэв. Су эгч ийн үргэлжлүүлээ: “За тэгье, Төгс Хүчит Бурханы үгээс хэдэн хэсгийг уншицгаая, тэгвэл энэ бүгд улам тодорхой болно. Төгс Хүчит Бурхан ингэж хэлсэн: **‘Тухайн үед Есүсийн ажил бүх хүн төрөлхтнийг золин аврахын төлөө байв. Түүнд итгэсэн бүх хүний нүгэл уучлагдсан; чи Түүнд итгэдэг л бол Тэр чамайг золин аврах байсан; хэрвээ Түүнд итгэсэн бол чи нүгэлтэн байхаа больж, нүглээсээ чөлөөлөгдөх байв. Аврагдах, итгэлээр зөвтгөгдөх гэдэг нь энэ юм. Гэхдээ итгэсэн хүмүүст ч Бурханыг эсэргүүцдэг, тэрслүү зүйл үлдсэн бөгөөд үүнийг мөн л аажмаар арилгах хэрэгтэй байлаа. Аврал гэдэг нь Есүс хүнийг бүрэн олж авсан гэсэн үг биш, харин хүн нүгэлтэн байхаа больж, нүглээ уучлуулсан гэсэн үг юм. Чи итгэх л юм бол дахиад хэзээ ч нүглийнх байхаа болих юм’** (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурханы ажлын үзэгдэл (2)”). **‘Эцсийн өдрүүдийн ажил бол үг хэлэх явдал юм. Үгийн тусламжтайгаар хүнд асар их өөрчлөлт гарч болно. Эдгээр үгийг хүлээн зөвшөөрснөөр өнөөгийн хүмүүст гарч**

---

байгаа өөрчлөлтүүд нь Нигүүлслийн эрин үеийн тэмдэг, гайхамшгийг хүлээн зөвшөөрсөн хүмүүсийнхээс хамаагүй их. Учир нь Нигүүлслийн эрин үед гараа дээр нь тавьж, залбирснаар хүнээс чөтгөрүүдийг хөөн зайлуулж байсан боловч хүний доторх завхарсан зан чанар хэвээр үлдсэн юм. Хүний өвчнийг эдгээж, нүглийг нь өршөөсөн боловч хүний доторх завхарсан сатанлаг зан чанарыг яг яаж арилгах тухайд бол энэ ажил хараахан хийгдээгүй. Хүн итгэлээсээ үүдэн аврагдаж, нүглээ уучлуулсан боловч хүний нүгэлт уг чанар арилаагүй бөгөөд дотор нь үлдсэн юм. Бие махбодтой болсон Бурханы тусламжтайгаар хүний нүглийг уучилсан боловч хүний дотор нүгэл байхаа больсон гэсэн үг биш. Нүглийн тахилаар дамжуулан хүний нүглийг өршөөж болох боловч хүний нүгэл үйлдэхийг яг яаж болиулах, нүгэлт уг чанарыг нь яаж бүрэн арилгаж, өөрчлөх тухайд бол хүн энэ асуудлыг шийдвэрлэх ямар ч аргагүй байдаг. Хүний нүглийг өршөөсөн нь Бурханы цовдлолын ажлаас үүдсэн боловч хүн хуучны, завхарсан сатанлаг зан чанар дотроо үргэлжлүүлэн амьдарсан юм. Ийм болохоор хүнийг сатанлаг завхарсан зан чанараас нь бүрэн аврах ёстой, ингэснээр түүний нүгэлт уг чанар дахин хэзээ ч хөгжихгүйгээр бүрэн арилж, улмаар хүний зан чанар өөрчлөгдөх боломжтой болох юм. Энэ нь амийн өсөлтийн замыг, амийн замыг болон зан чанараа өөрчлөх замыг ухаарахыг хүнээс шаарддаг. Түүнчлэн, энэ замын дагуу хэрэгжүүлж, зан чанараа аажмаар өөрчилж, гэрлийн гялбаан дор амьдарч, хийдэг бүхнээ Бурханы хүслийн дагуу байлгаж, завхарсан сатанлаг зан чанараа хаяж, Сатаны харанхуйн нөлөөнөөс ангижирч, улмаар нүглээс бүрэн ангижрахыг хүнээс шаарддаг. Тэгсэн цагт л хүн бүрэн аврал хүртэнэ’ (Үг нь махбодоор илэрсэн номын “Бие махбодтой болохын нууц (4)”). ‘Хэдийгээр Есүс хүмүүсийн дунд их ажил хийсэн ч бүх хүн төрөлхтний золин авралыг л гүйцэлдүүлж, хүний нүглийн тахил болсон юм; Тэрээр хүнийг бүх завхарсан зан чанараас нь салгаагүй. Хүнийг Сатаны нөлөөнөөс бүрэн аврах нь, Есүсээс нүглийн тахил болж хүний нүглийг үүрэхийг шаардаад зогсохгүй, бас хүнийг сатанлаг завхарсан зан чанараас нь бүрэн салгахын тулд улам их ажил хийхийг Бурханаас шаардсан. Ингээд хүний нүгэл уучлагдсаны дараа Бурхан хүн төрөлхтнийг шинэ эрин үе рүү хөтлөхийн тулд махбодод эргэн ирж, гэсгээлт, шүүлтийн ажлыг эхлүүлсэн юм. Энэ ажил нь хүнийг илүү өндөр хүрээнд аваачсан. Түүний ноёрхол дор захирагддаг бүх хүн илүү өндөр үнэнийг эдэлж, илүү агуу ерөөлийг хүлээн авна. Тэд үнэхээр гэрэлд амьдарч, үнэн, зам, амийг олж авна’ (Үг нь махбодоор илэрсэн номын Өмнөх үг). Хэрэв бид Нигүүлслийн эрин үеийн Бурханы золин авралын ажлыг баримтлаад, эцсийн өдрүүдийн шүүлтийн ажлыг нь хүлээн авахгүй бол нүгэлт байдлын маань уг үндэс шийдвэрлэгдэх боломжгүйг Төгс Хүчит Бурханы үгээс харж болно. Эцсийн өдрүүдийн Төгс Хүчит Бурхан ирсэн бөгөөд золин авралын ажлын



---

суурин дээр хүнийг шүүх, ариусгах ажлын үе шатыг явуулж байгаа. Тэрээр хүний завхралын үнэнийг илчилж, хүний сатанлаг уг чанарыг шүүхийн тулд үнэнийг айлдаж байна. Тэрээр хүмүүсийн сатанлаг зан чанарыг өөрчилж, тэднийг Сатаны нөлөөнөөс бүрмөсөн чөлөөлөхөөр ирсэн бөгөөд ингэснээр хүмүүс бүрэн аврал хүртэж болох юм. Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн шүүлтийн ажил нь хүмүүсийг ариусгаж, аварч, төгс болгоход хамгийн чухал, үндсэн ажил гэдэг нь илэрхий. Тиймээс, Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн шүүлтийн ажлыг хүлээн авснаар л бид өөрсдийн завхарсан мөн чанарыг болон Бурханы зөвт зан чанарыг үнэхээр ойлгож, Сатаны нөлөөнөөс бүрэн ангижирч, Бурханаар бүрэн авруулаад, Бурханд дуулгавартай байж, шүтэн мөргөдөг, Бурхантай нийцэлтэй хүмүүс болж чадна.”

Энэ бүх нөхөрлөлийг сонсоод зүрх сэтгэл минь үнэхээр цэлмэж, урт удаан хугацааны төөрөгдөл минь эцэстээ шийдвэрлэгдсэн мэт санагдаж байлаа. Нигүүлслийн эрин үед Бурхан хүмүүсийн сатанлаг зан чанарыг арилгах ажил бус, золин аврах ажил л хийсэн болж таарав. Эцсийн өдрүүдэд бие махбодтой болсон Бурханы үнэнийг илчлэх шүүлтийн ажил нь хүн төрөлхтнийг бүрэн ариусгаж, аврах ажил юм. Тэгвэл Бурхан үнэндээ хүмүүсийг яаж ариусгаж, өөрчилж, бүрмөсөн авардаг юм бэ? Би энэ асуултын хариултыг мэдэхийг ихэд хүсэж байсан тул “Таны сая ярьсныг би ойлголоо, бас эргэн ирсэн Эзэн шүүлтийн ажлын үе шатыг явуулснаар л бид ариусгалтад хүрч чадна гэдгийг ойлголоо. Энэ бол миний нэлээд удаан хүсэн хүлээж байсан зүйл юм. Төгс Хүчит Бурхан хүмүүсийг ариусгаж, аврах шүүлтийн ажлаа яаж хийдэг вэ гэдгийг л би үнэхээр мэдмээр байна. Энэ талаар нөхөрлөөч” хэмээн тэсгэлгүй асуув.

Су эгч: “Төгс Хүчит Бурхан хүмүүсийг цэвэрлэж, аврах шүүлтийн ажлаа хэрхэн хийдэг тухай асуулт нь өөрчлөгдөж, ариусахыг хүсдэг хэн бүхэнд нэн чухал юм. Үнэний энэ талын тухайд Төгс Хүчит Бурханы үг тун тодорхой хэлдэг. Би Төгс Хүчит Бурханы үгийг та нарт илгээе. Ах минь тэдгээрийг уншаарай!” гэлээ.

Би Төгс Хүчит Бурханы үгийг сэтгэл хөдлөн уншив: “Эцсийн өдрүүдэд Христ хүнийг сургах, хүний мөн чанарыг ил болгох, хүний үг болон үйлдэлд нь дүн шинжилгээ хийхийн тулд төрөл бүрийн үнэнийг хэрэглэдэг. Хүний үүрэг, хүн яаж Бурханд дуулгавартай байх ёстой, хүн яаж Бурханд үнэнч байх ёстой, хүн яаж хэвийн хүн чанарыг амьдран харуулах учиртай болон Бурханы мэргэн ухаан, зан чанар гэх зэрэг төрөл бүрийн үнэн эдгээр үгэнд агуулагддаг. Эдгээр үг нь бүгд хүний мөн чанар болон ялзарсан зан чанар луу чиглэдэг. Ялангуяа, хүн Бурханыг хэрхэн голдгийг илчилсэн үгсийг хүн бол Сатаны биелэл, Бурханы эсрэг дайсны хүч болдог тухайд хэлсэн байдаг. Шүүлтийн ажлаа хийхдээ Бурхан хүний уг чанарыг ердөө хэдхэн үгээр

---

тодорхой болгодог юм биш; Тэрээр удаан хугацааны туршид илчилж, харьцаж, засдаг. Илчлэл, харьцалт болон засалтын эдгээр аргыг энгийн үгээр бус, харин хүнд огт байдаггүй үнэнээр л орлуулж болно. Зөвхөн ийм төрлийн арга барилыг л шүүлт гэж нэрлэж болно; ийм төрлийн шүүлтээр л дамжуулан хүн номхорч, Бурханд захирагдахаар бүрэн үнэмшээд зогсохгүй, Бурханы тухай жинхэнэ мэдлэгийг олж авч чаддаг. Шүүлтийн ажлын авчирдаг зүйл гэвэл Бурханы жинхэнэ дүр төрх болон өөрийнх нь тэрслүү байдлын үнэний талаарх хүний ойлголт юм. Шүүлтийн ажил нь хүнд Бурханы хүслийн тухай, Бурханы ажлын зорилгын тухай, хүний ойлгошгүй нууцуудын тухай ихээхэн ойлголт олж авах боломж олгодог. Түүнчлэн, өөрийн ялзарсан мөн чанар болон ялзралынхаа үндсийг таньж мэдэх, хүний муу муухайг нээн илрүүлэх боломжийг олгодог. Энэ бүх үр дүнг шүүлтийн ажил авчирдаг, учир нь энэ ажлын мөн чанар нь үнэндээ Бурханы үнэн, зам, амийг Түүнд итгэдэг бүх хүнд нээх ажил юм. Энэ ажил нь Бурханы хийдэг шүүлтийн ажил билээ” (Үг нь махбодоор илэрсэн номын “Христ шүүлтийн ажлыг үнэнээр хийдэг”).

Бурханы үгийг уншиж дууссаны минь дараа Су эгч нөхөрлөлөө үргэлжлүүлэв: “Төгс Хүчит Бурханы үг Бурхан хүмүүсийг хэрхэн шүүж, ариусгадгийг маш тодорхой тайлбарладаг. Эцсийн өдрүүдэд Бурхан хүн төрөлхтнийг шүүж, ариусгаж, аврахын тулд юуны өмнө хүний Бурханыг эсэргүүцдэг завхарсан зан чанар, сатанлаг уг чанарт чиглэсэн үнэнийг айлдаж байгаа. Төгс Хүчит Бурхан, Сатан хүмүүсийг хэрхэн завхруулдаг, Бурхан хүмүүсийг хэрхэн авардаг, хүнийг л дагах гэж юу болох, Бурханд дуулгавартай байх гэж юу болох, өөрсдийн итгэлд бид ямар үзэл бодолтой байх ёстой, зан чанарын өөрчлөлт гэж юу болох, Бурханаас эмээж, муугаас зайлах гэж юу болох, Бурханы зан чанарт халдах гэж юу болох, яаж үнэнч шударга хүн байх гэх мэт маш олон талын үнэнийг айлдсан. Эдгээр үнэн нь бүгд эрх мэдэл, хүч чадалтай бөгөөд хүмүүсийн амийг хангаж чадна. Энэ бол хүн төрөлхтөнд Бурханы хайрласан мөнх амийн зам мөн. Хүмүүс Бурханы үгийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж байгаа цагт ариусгалт болон авралыг хүртэж чадна. Төгс Хүчит Бурханы шүүлтийн ажлыг хэдэн жил туулсныхаа дараа бид энэ бүхнийг биечлэн мэдэрсэн. Төгс Хүчит Бурханы хүнийг шүүж, гэсгээж, илчлэх үгийг унших үед тэдгээр нь хоёр иртэй илд мэт санагддаг бөгөөд бидний тэрслүү байдал, завхрал, эсэргүүцэл, буруу санаа зорилго, үзэл, төсөөлөл, тэр ч байтугай зүрх сэтгэлийн маань гүнд нуугдсан Сатаны хорыг илчилдэг. Биднийг Сатан үнэхээр дэндүү гүн гүнзгий завхруулсан ба бид биеэ тоосон, өөрийгөө зөвтгөдөг, зальтай, овжин, аминч, бүдүүлэг, өөрийнхөө хувийн ашиг сонирхлоос өөрийг хардаггүй, Бурханаас огт эмээдэггүй гэдгийг энэ нь харуулдаг. Бидний үйлдэл, зүрх сэтгэл, оюун санаа бохир, завхралаар дүүрсэн бөгөөд ямар ч хүний төрхгүй гэдгээ бид хардаг. Бид нүүр царайгаа харуулахаас дэндүү их ичдэг бөгөөд хэрвээ

---

завхарсан сатанлаг зан чанараараа үргэлжлүүлэн амьдарвал үргэлж Бурханд жигшигдсэн хүмүүс байж, Бурханы магтаалыг хэзээ ч хүртэж чадахгүй ба таягдуулж, шийтгүүлэх тавилантай байна гэдгээ ухаардаг. Төгс Хүчит Бурханы үгийн шүүлт, илчлэл нь Бурханы сүр жавхлант, уур хилэнт, зөвт зан чанарыг бидэнд таниулдаг бөгөөд аажмаар Бурханаас эмээх зүрх сэтгэлтэй болж, үнэхээр гэмшиж, өөрчлөгдөхөд биднийг хүргэдэг. Одоо бид бага ч болов хүний төрхийг амьдран харуулж байгаа гэж бидэнд санагддаг бөгөөд Бурханы агуу авралыг үнэхээр хүртсэнээ бид харж байна. Хэрэв Бурханы шүүлт бидэн дээр ирээгүй бол бид хүний халдлагыг тэвчдэггүй Бурханы зөвт зан чанар, Түүний ариун агаад сайн сайхан мөн чанарыг мэдэх боломжгүй байх байлаа. Бас өөрсдийн тэрслүү байдал, завхралыг үзэн яддаг болж чадахгүй, завхралаа хөсөр хаяж, ариусгагдаж ч чадахгүй байх байв. Иймээс Бурханы шүүлт, гэсгээлтийг туулах тусмаа бид Бурханы шүүлт, гэсгээлт бол бидний хувьд хамгийн сайн халамж, хамгийн агуу ерөөл, хамгийн жинхэнэ аврал мөн гэдгийг улам их хардаг!”

Лиу эгч ч бас нөхөрлөж, “Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн шүүлт, гэсгээлтийн ажил нь хүмүүсийг бүрэн дүүрэн ариусгаж, аварч, төгс болгох ажил юм. Хэрэв бид эцсийн өдрүүдийн Христийн сэнтийн өмнөх шүүлтийг хүлээж авахгүй бол ариусгалт, амь зан чанарын өөрчлөлтөд хүрч чадахгүй. Бурханд гологдож, Түүгээр таягдуулах нь бидний үр дүн байх нь гарцаагүй; бид сүйрэл амсаж, мөхөх болно. Аврагдаж, тэнгэрийн хаанчлалд орох боломж бидэнд хэзээ ч олдохгүй. Энэ бол гарцаагүй” гэж хэлэв.

Би: “Бурханд талархъя! Та нарын нөхөрлөлийг сонссоны дараа зүрх сэтгэл минь ихэд цэлмэлээ. Би маш олон жил Эзэнд итгэсэн боловч үнэн хэрэгтээ нүгэлд амьдарч, үүнээс салах чадалгүй байсаар ирсэн. Хэрэв би эцсийн өдрүүд дэх Бурханы шүүлт, гэсгээлтийг туулахгүй бол нүглийн хүлээс, хязгаарлалтаас ангижирч чадахгүй гэдгээ одоо ойлгож байна. Одоо би ариусгалт, авралд хүрэх замыг оллоо” гэж баяртайгаар хэлэв. Хэдэн өдрийн нөхөрлөлийн дараа эхнэр бид хоёр зарим үнэнийг ойлгох болж, Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн авсан юм.

Намайг гэх хайр, авралынх нь төлөө Төгс Хүчит Бурханд талархаж байна! Пасторын хувиар би таньдаг бүх пастор болон ах, эгч нараа Бурханы өмнө авчрах үүрэг, хариуцлагатай. Хэсэг хугацаанд энэ ах, эгч нартай хамт ажилласны дараа чуулганы цуглаанд байнга ирдэг хэдэн арван ах эгч Төгс Хүчит Бурханыг хүлээн авсан төдийгүй бас өөр нэг гэр чуулганы пасторыг би Бурханы гэр бүлд авчирсан бөгөөд тэдний чуулганы ах, эгч нарын дийлэнх нь ч бас Бурхан руу эргэлээ. Энэ ах, эгч нар Бурханы эцсийн өдрүүдийн авралыг хүлээн авч, Бурханы сэнтийн өмнө өргөгдөхийг хараад би маш их баярласан юм. Энэ нь бүгд Төгс Хүчит Бурханы ажлын үр дүн билээ: Бүх алдар Төгс

---

Хүчит Бурханд байх болтугай!

### 3. Шүүлтийн нууцыг илчлэх нь

Эньхуй, Малайз улс

Намайг Эньхуй гэдэг, 46 настай. Би Малайзад амьдардаг ба Эзэнд итгээд 27 жил болж байна. 2015 оны 10 дугаар сард би ажилд орохоор өөр хот руу нүүсэн юм. Шинэ хамт олон маань бүгд чаатлах, шинэ найз олох, юм нийтлэхдээ Фэйсбүүк ашиглах үнэхээр дуртай байлаа. Намайг Фэйсбүүк дээр бүртгэлгүй гэдгийг мэдээд тэд надад бүртгэл нээн тохируулж өгсөн бөгөөд хэрхэн онлайнд нэвтэрч, ашиглахыг би аажмаар сурсан юм. Цаг завтай байх үедээ би Эзэн доторх зарим нэг ах, эгчийнхээ нийтэлсэн зүйлийг харж, тэдгээрийг бусадтай хуваалцаж, “таалагдлаа” гэж дардаг байв. Заримдаа би Эзэнийг магтсан зүйл нийтэлж, эсвэл найзуудын бүлгэм дэх хүмүүстэй Эзэний нигүүлслийг хуваалцдаг байлаа. Би өдөр бүр үнэхээр сэтгэл хангалуун байсан юм.

2016 оны 2 дугаар сарын нэгэн өдөр, Фэйсбүүкийн нэг найзынхаа профайлыг үзэж байгаад би энэ нийтлэлийг харав: “Бид өнөөдөр бүлгэмдээ шүүлтийн асуудлыг хэлэлцлээ. Бид бүгд өөр өөр зүйл хэлсэн боловч ерөнхийдөө гол зүйлс дээр санал нийлсэн. Нэг хүн: ‘Би ямар нэг зүйлийг ойлгохгүй бол хуучны утгагүй үг хэлж зүрхэлдэггүй—энэ бол ирээдүйд Бурханы хийх зүйл бөгөөд бид элдвээр таамаглахаар оролдож болохгүй’ гэж хэлсэн. Өөр нэг хүн: ‘Дуулал 75:2-т **“Товлосон цаг ирэхэд Би шулуун шударгаар шүүх болно”** гэдэг. Хүн нэг бүрийн хийдэг бүх зүйлийг Бурхан тэмдэглэж байгаа тул Эзэн Есүс бүх хүнийг шүүхээр эргэж ирэх үедээ яг л кино тоглуулж байгаа мэт бидний үйл хэргийг бүгдэд илчилнэ. Тиймээс бид Бурханаар шүүгдэж, тамд хаягдахгүйн тулд үйлдэлдээ шулуун шударга байх ёстой ба мууг үйлдэж яавч болохгүй’ гэж хэлсэн. Бас нэг хүн: ‘Библид ийн өгүүлсэн байдаг: **“Агуу цагаан сэнтий болон дээр нь заларсан Нэгнийг би харлаа, Түүний дүр төрхөөс тэнгэр, газар зугтсан ба тэдний хувьд байх газар олдсонгүй. Их, бага үхсэн хүмүүс Бурханы өмнө зогсож байгааг би харлаа; номнууд дэлгээстэй байв: өөр нэг ном дэлгээстэй байсан нь амийн ном байлаа: үхэгсэд өөрсдийнхөө үйлсийн дагуу уг номонд бичигдсэн зүйлсээр шүүгдэв”** (Илчлэл 20:11–12). Эцсийн өдрүүдэд Эзэн Есүс эргэж ирэх үедээ аварга том ширээг тэнгэрт байрлуулаад ард нь сууж, номыг нээнэ гэдгийг судраас харж болно. Тэгээд бүх хүн төрөлхтөн газарт өвдөг сөгдөн, Тэрээр хүн болгоны нэрийг дуудаж, үйл хэргийнх нь дагуу нэг бүрчлэн шүүнэ. Эзэн сайн хүмүүсийг тэнгэрийн хаанчлалд аваачна, харин муу хүмүүс там руу хаягдана’ гэж хэлсэн.”

---

Тэр нийтлэлийг уншиж дууссанахаа дараа би сандал дээрээ суусаар, Эзэн Есүс хүн төрөлхтнийг шүүж буй дүр зургийг санаандаа зурлаа: Эзэн, сэнтийд сууж, хүмүүс бүгд Түүний ширээний өмнө өвдөг сөгдөх бөгөөд Бурханаар шүүгдэхийн тулд бүх нүглээ улайж, Эзэн хүн нэг бүрийг үйл хэргийнх нь дагуу тэнгэр лүү юм уу там руу илгээнэ. 20 гаруй жилийн турш Эзэний үнэнч дагагч байснаа, мөн Түүний сургаалыг биелүүлэхээр хичээнгүйлэн зүтгэснээ би бодов. Эзэн миний сүсэг бишрэлийг хараад тэнгэрт аваачна гэж би итгэж байлаа. Гэхдээ энэ бүхнийг улам цааш бодтол гэнэт нэг санаа төрөв: Одоо би Интернет ашиглаж мэддэг болсон юм чинь “шүүлт” гэж хайгаад юу гарч ирэхийг нь харж яагаад болохгүй гэж? Би хөтчөө нээгээд үг бичлээ; аль холбоос дээр дарснаа санахгүй байгаа ч гайхалтай нь “Бурханы шүүлт, гэсгээлт бол хүний авралын гэрэл юм” гэх өгүүлбэр гарч ирсэн юм. Энэ нь тэр даруй миний анхаарлыг татсан тул цааш уншихаар вэб сайт руу нь оров. Вэб хуудас ачаалах зуур тааламжтайн зэрэгцээ бодолд автуулам “Бурханы шүүлт, гэсгээлт бол хүний авралын гэрэл юм” гэх энэхүү магтан дууг би сонслоо: Дууны үг нь: **“...Хүн Сатаны зохион байгуулалт, нөлөөнөөс ангижирч, Бурханы гэрэлд амьдрахын тулд амьдралдаа цэвэрлэгдэж, зан чанартаа өөрчлөлт гаргахыг хүсвэл, мөн утга учиртай амьдралыг амьдран харуулж, бүтээлийн үүргээ биелүүлэхийг хүсвэл Бурханы гэсгээлт, шүүлтийг хүлээн авах ёстой ба Бурханы сахилгажуулалт, цохилтыг өөрөөсөө холдуулах ёсгүй. Бурханы гэсгээлт, шүүлт бол гэрэл, хүний авралын гэрэл бөгөөд хүний хувьд хамгийн сайн ерөөл, хамгийн агуу нигүүлсэл, хамгийн сайн хамгаалалт гэдгийг мэдэж ав”** (“Хургыг дагаж шинэ дуу дуулья” ном).

Магтан дуу дуусахад би үгийг нь тунгаан бодсон ба нэлээд сэтгэл хөдлөм санагдсан билээ. “Бурханы гэсгээлт, шүүлт бидний авралын гэрэл мөн гэж үү? Энэ нь хүн төрөлхтний хамгийн агуу хамгаалалт, нигүүлсэл мөн үү? Бид үүнийг хэрхэн ойлгох вэ? Хүмүүс ариусгагдаж, утга учиртай амьдралаар амьдрахыг хүсвэл Бурханы гэсгээлт, шүүлтийг хүлээн зөвшөөрөх ёстой гэсэн үг үү?” гэж би бодож эхэллээ. Энэ дууны үгийг тунгаан бодоход олон асуулт толгойд эргэлдэж байсан юм. “Хэрвээ Бурхан хүнийг шүүвэл хүн яллагдахгүй гэж үү? Шүүлт яахаараа авралын гэрэл болдог билээ?” гэж бас бодогдов. Иймэрхүү зүйл урьд нь хэзээ ч сонсож байгаагүй учраас би сониучирхаж, бас догдолж байлаа. Магтан дуунд өгүүлж байсан шүүлт нь шүүлтийн тухай миний ойлголтоос өөр байсан ч шүүлт үнэхээр гүнзгий ач холбогдолтой бөгөөд хүний ирээдүй, хувь заяатай холбоотой гэх бүдэг бадаг мэдрэмж надад байсаар байв. Магтан дууны эх сурвалжийг шалгаад Төгс Хүчит Бурханы Чуулганаас гаргаж гэдгийг олж мэдсэн тул би вэб сайт руу нь орлоо. Нүүр хуудас нь шинэлэг, аятайхан байгаад зогсохгүй агуулга нь ч баялаг, олон янз байхыг харав. Тэнд сонсох, унших материал, дуу, хэлэлцүүлэг болон өөр олон зүйл

---

байсан юм. “Энэ вэб сайтын тухай надад яагаад хэн ч хэлээгүй байдаг билээ? Ийм сайхан зүйл байхад хэн ч мэдээгүй болохоор надтай хуваалцаж чадаагүй юм уу?” гэж би бодлоо. Би “Ном” гэсэн нэртэй холбоос дээр дарж, гарч ирсэн жагсаалтыг доош гүйлгэж байгаад “Амийн оролтын туршлагын тухай гэрчлэлүүд” гэсэн ном байхыг олж харав. Түүн дээр дартал ихэвчлэн Бурханы шүүлтийн тухай гэрчлэлүүд харагдлаа. Жишээ нь: “Бурханы шүүлт, гэсгээлт намайг аварсан”, “Бурханы шүүлт, гэсгээлт миний хувьд агуу аврал байсан”, “Бурханы шүүлт, гэсгээлтээс би хайрыг нь харсан”, “Бурханы шүүлт, гэсгээлт нүгэлт сүнсийг минь сэрээсэн”, “Бурханы шүүлт, гэсгээлт намайг зөв замд оруулсан.” Ажилдаа явах цаг бараг болсон тул би тэдгээр гэрчлэлийн цөөн хэдийг нь товчхон харж л амжсан юм. Итгэгчид, завхарсан зан чанар нь хэрхэн өөрчлөгдсөн тухай дүрслэн бичсэн байснаас гадна өөрсдийн итгэл дэх дутагдал, завхрал, эндүү ташаа үзэл санаа гэх мэтийнхээ талаар, мөн Төгс Хүчит Бурханы шүүлтийн үгээр дамжуулан эдгээр нь хэрхэн өөрчлөгдсөн талаар өгүүлсэн байлаа. Энэ нь “Бурханы шүүлт, гэсгээлт бол хүний авралын гэрэл юм”-н талаар улам их сонирхоход намайг хүргэв. Шүүлт нь яллагдах тухай байгаагүй юм гэж үү? Хүн бүрийн төгсгөлийг тодорхойлох тухай байгаагүй юм гэж үү? Би үнэхээр догдолж эхэлсэн ба “Бурханы шүүлт, гэсгээлт бол хүний авралын гэрэл юм.” “Амийн оролтын туршлагын тухай гэрчлэлүүд” нь хүмүүсийн итгэлд туйлын их тустай ном байж магадгүй бөгөөд үүнийг сайн судлах хэрэгтэй гэсэн дүгнэлтэд би хүрсэн юм. Гэвч цаг үлдээгүй тул компьютерээ унтраагаад ажилдаа явлаа.

Тэр шөнөдөө би унтаж чадалгүй орон дотроо эргэн хөрвөөж байлаа; Төгс Хүчит Бурханы Чуулганы вэб сайтын зургууд толгойд орж ирсээр байв. Ялангуяа “Бурханы шүүлт, гэсгээлт бол хүний авралын гэрэл юм” гэх өгүүлбэр толгойноос огт салахгүй байсан бөгөөд “шүүлт” гэдэг нь чухам юуг хэлснийг мэдэхийг үнэхээр их хүсэж байлаа.

Маргааш нь би өглөө эрт босоод Төгс Хүчит Бурханы Чуулганы вэб сайтыг нээж, “шүүлт” гэх үгийг хайж эхлэв. Би “Христ шүүлтийн ажлыг үнэнээр хийдэг” гэсэн гарчигтай нийтлэлийг олж хараад, нээсэн бөгөөд эдгээр үгийг уншсан юм: **“Өнгөрсөн цаг үед яригдаж байсан Бурханы гэрээс эхлэх шүүлтийн тухайд, эдгээр үгэн дэх ‘шүүлт’ гэдгээр эцсийн өдрүүдэд сэнтийнх нь өмнө ирсэн хүмүүс дээр Бурханы өнөөдөр хийдэг шүүлтийг хэлдэг. Эцсийн өдөр ирсэн үед Бурхан тэнгэрт том ширээ засаж, дээр нь цагаан бүтээлэг дэвсээд, дараа нь бүх хүнийг газарт өвдөг сөгдүүлж, Өөрөө агуу сэнтийд суунгаа хүн бүрийн нүглийг илчилж, үүгээрээ тэднийг тэнгэрт гаргах уу, гал болон хүхэрт нуурт унагах уу гэдгийг тогтоодог гэсэн ер бусын төсөөлөлд итгэдэг хүмүүс байж магад. Хүний төсөөлөл ямар ч байлаа гэсэн, Бурханы ажлын мөн чанарыг өөрчилж чадахгүй. Хүний төсөөлөл гэдэг хүний харсан, сонссон зүйлийг нийлүүлж, нэгтгэсэн, хүний тархинаас гардаг, санаа бодлынх нь бүтээл төдий юм.**

---

Иймд Би, хүний төсөөлөл хэчнээн гайхамшигтай байлаа ч зураглал төдийхнөөс хэтрэхгүй ба Бурханы ажлын төлөвлөгөөг орлож чадахгүй гэж хэлдэг. Эцсийн эцэст, хүнийг Сатан завхруулсан тул хүн яаж Бурханы бодлыг ойлгож чадах юм бэ? Хүн Бурханы шүүлтийн ажлыг маш гайхамшигтай байна гэж боддог. Бурхан Өөрөө шүүлтийн ажил хийж байгаа учраас хамгаас өргөн цар хүрээтэй, эгэл хүмүүст ойлгомжгүй байх ёстой, энэ нь тэнгэр даяар цуурайтаж, газрыг доргиох ёстой гэдэгт итгэдэг; эс бөгөөс энэ яаж Бурханы хийсэн шүүлтийн ажил байж чадах юм бэ? Энэ нь шүүлтийн ажил болохоор Бурхан ажиллахдаа маш сүрлэг, сүр жавхлантай байх ёстой ба шүүгдэж байгаа хүмүүс цурхиран уйлж, өвдөг дээрээ сөхрөн өршөөл хүсэж байх ёстой гэдэгт тэр итгэдэг. Ийм дүр зураг гайхамшигтай, үнэхээр сэтгэл хөдлөм байх нь гарцаагүй... Хүн бүр Бурханы шүүлтийн ажлыг ер бусын гайхалтай гэж төсөөлдөг. Гэвч Бурхан хүмүүсийн дунд шүүлтийн ажлаа аль хэдийн эхэлчхээд байх үед ч чи үхсэн юм шиг унтсаар үлдсэн гэдгээ мэдэх үү? Чамайг Бурханы шүүлтийн ажил албан ёсоор эхэлж байна гэж бодох үед Бурхан аль хэдийн газар тэнгэрийг шинээр бүтээчихсэн байх болно гэдгийг мэдэх үү? Магадгүй тэр үед чи амьдралын утга учрыг дөнгөж ойлгосон байх боловч бөх унтсаар л буй чамайг Бурханы өршөөлгүй шийтгэлийн ажил там руу аваачих болно. Тэр үед л чи Бурханы шүүлтийн ажил аль хэдийн дууссаныг гэнэт ухаарна.” Би энэ үгсийг уншаад үнэхээр гайхлаа. Эдгээр нь Бурханы эцсийн өдрүүдийн шүүлтийн ажлын тухай хүмүүсийн сэтгэлийн гүн дэх бодлууд, тэдний үзэл бодлыг маш нарийн нягт илчилжээ—эдгээр нь бас үнэхээр жинхэнэ, бодитой байв. “Миний баримталсаар ирсэн, тэнгэр дэх шүүлтийн тухай санаа зөвхөн миний төсөөлөл байсан юм гэж үү? Хүмүүс бүгд Бурханы шүүлтийг нууцлаг, ер бусын гэж төсөөлдөг болохыг энэ хэсэг харуулж байна. Түүнчлэн, шүүлтийн ажил аль эрт эхэлсэн бөгөөд удахгүй дуусна гэдгийг энэ нь илтгэдэг. Мөн Бурханы илрэлийг эрж хайхад цаг бүү үр гэж хүмүүсийг уриалдаг. Эдгээр нь Бурханы дуу хоолой мөн юм гэж үү?” гэж би гайхширлаа. Тэр бодол сэтгэлийг минь тайван бус болгож, Бурханы шүүлтийн утга учир үнэндээ юу болохыг тэр даруй ойлгохоор үнэхээр хүссэн юм. Гэхдээ Төгс Хүчит Бурханы Чуулганы вэб сайт дээр хэтэрхий олон контент байсан болохоор тухайн үед хаанаас судалж эхлэхээ мэдэхгүй байсан тул Төгс Хүчит Бурханы Чуулганы гишүүдийг өөрсдийг нь хайж олоод, аливааг ойлгоход минь тусалж чадах эсэхийг үзэхээр шийдэв.

Би Төгс Хүчит Бурханы Чуулганы вэб сайт дээрх чатын функцийг ашиглан шүүлтийн талаар илүү ихийг мэдэж авах сонирхолтой байгаагаа хэлж зурвас үлдээсэн юм. Нэг хүн надад тэр дор нь хариулан, Төгс Хүчит Бурханы Чуулганы хоёр эгчийг танилцуулсан нь, надтай харилцсан Лиу Хуй, Ли Мэй хоёр байв. Тэдэнтэй ярилцах явцдаа тэр хоёр эгч нээлтэй, шударга, шулуухан хүмүүс болохыг олж мэдсэн бөгөөд сэтгэлээ уудлан



---

ярилцахыг хүссэн юм. “Төгс Хүчит Бурханы Чуулганы вэб сайт надад үнэхээр таалагдлаа. Энд төрөл бүрийн сүнслэг ном, магтан дуу, клип, сайн мэдээний кино, Бурханы үгийн уран уншлага гэх мэт зүйл байна. Үнэхээр их агуулга байгаа ч Бурханы шүүлт гэдэг нь ямар утгатай болохыг би ердөө ойлгохгүй юм. Би ‘Христ шүүлтийн ажлыг үнэнээр хийдэг’ гэдгийг л уншсан, энэ нь Бурханы шүүлтийн ажил аль хэдийнээ эхэлсэн бөгөөд тэнгэр дэх шүүлтийн талаарх санаа бол хүний үзэл, төсөөллийн үр дүн төдий гэсэн утгатай мэт санагдсан. Энэ нь шүүлтийн тухай миний ердийн ойлголтоос нэлээд өөр юм. Та нар энэ тухай ойлголтоо надтай хуваалцаж болох уу?” гэж би тэдэнд хэлсэн юм.

Ли Хуй эгч: “Бурханыг магтъя! Хамтдаа эрж хайн, нөхөрлөө! Би ч бас чамтай адилхан бодож, Бурханы эцсийн өдрүүдийн шүүлтийн ажил тэнгэрт хийгдэнэ гэж итгэдэг байсан. Гэвч, Төгс Хүчит Бурханы үгийг уншиж, ах, эгч нартай нөхөрлөсний дараа энэ нь ердөө миний үзэл, төсөөлөл байсныг би ухаарах болсон. Бурханы шүүлтийн ажил тэнгэрт, эсвэл газарт хийгдэх эсэхийг Библи дэх зарим зөгнөлд тодорхой өгүүлсэн. Жишээ нь, Илчлэл 14:6–7-д ингэж хэлдэг: **‘Тэнгэрийн дундуур өөр нэг тэнгэрэлч нисэж байгааг би харлаа. Газар дээр оршин суугчид, бүх үндэстэн, овог, хэлтэн, ард түмэнд тунхаглах мөнхийн сайн мэдээ түүнд байгаа ба тэр чанга дуугаар, “Бурханаас эмээж, Түүнд алдрыг өргө; учир нь Түүний шүүлтийн цаг ирлээ: тэнгэр, газар, тэнгис ба усны ундаргыг бүтээсэн Түүнийг шүтэн мөргө” гэв’** Дуулал 96:13-д: **‘Учир нь Тэр ирж байна, учир нь Тэр газар дэлхийг шүүхээр ирдэг: Тэрээр дэлхий ертөнцийг зөвт байдлаар, хүмүүсийг Өөрийнхөө үнэнээр шүүнэ.’** Иохан 9:39-д: **‘Шүүлтийн төлөө Би энэ дэлхийд ирсэн тул хардаггүй хүмүүс харж болох юм’** гэж хэлдэг. Эдгээр библийн эшлэлд **‘Газар дээр оршин суугчид тунхаглах мөнхийн сайн мэдээ, ‘учир нь Тэр газар дэлхийг шүүхээр ирдэг’, ‘Шүүлтийн төлөө Би энэ дэлхийд ирсэн’** гэж дурддаг. Эцсийн өдрүүдэд Бурхан хүний ертөнцөд биеэр ирэх ёстой ба шүүлтийн ажил хийж, бүх хүнийг, бүх үндэстнийг шүүхээр ирэх болно гэдгийг эндээс бид харж болно. Түүнчлэн, Бурхан хүн төрөлхтнийг бүтээхээсээ өмнө бидэнд зориулсан тохиромжтой амьдрах орчныг бэлдэхийн тулд тэнгэр, газар, бүх зүйлийг бүтээсэн гэдгийг Библийг уншсаны хувьд бид мэднэ. Бурхан дараа нь хүн төрөлхтнийг бүтээж, биднийг тэнгэрт биш, газар дээр амьдруулахаар зохицуулсан. Тэгвэл бид яаж тэнгэрт очиж чадах юм бэ? Завхарсан хүн төрөлхтөн энэ газар дээрх Бурханы шүүлтийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй. Түүнчлэн, Патм арал дээр байхдаа Иохан агуу цагаан сэнтий тэнгэрт байхыг харсан гэж Илчлэлийн номд тэмдэглэсэн байдаг. Үнэндээ энэ нь ердөө л Иоханы үзэгдлүүдийн нэг байсан ч зарим хүн үүнийг, эцсийн өдрүүдийн үеэр Бурхан эргэж ирэхдээ хүмүүсийг тэнгэрт шүүнэ гэсэн үг гэж шууд утгаар нь тайлбарласан. Энэ бидний өөрсдийн үзэл, төсөөлөл төдийхөн бөгөөд зөгнөлүүдийг буруугаар тайлбарласан хэрэг юм—энэ нь Бурханы ажлын бодит байдал огт

---

биш.”

Би үүнийг сонсоод мэл гайхлаа: Эгч нарын надтай хуваалцсан библийн бүх эшлэлийг би уншсан мөртөө эдгээр үгийн жинхэнэ утгыг яагаад хэзээ ч анзаараагүй байдаг билээ? Тийм ээ! Бурхан хүн төрөлхтнийг газар дээр амьдруулахаар бүтээсэн тул бид яаж ер нь тэнгэрт очиж чадах билээ? Миний итгэл үнэхээр тодорхой бус, мэдлэггүй байдлаар дүүрэн байв!

Ли Мэй эгч дараа нь надтай ингэж нөхөрлөлөө: “Эцсийн өдрүүдэд Бурхан газар дээр шүүлтийн ажлыг хийхийн тулд бие махбодтой болоод зогсохгүй, Түүний ажил аль эрт эхэлсэн бөгөөд удахгүй дуусна. Бурханы шүүлтийн ажил хүмүүсийн төсөөлдөг шиг тэнгэрт хийгддэггүй, мөн тэдний итгэдэг шиг хүмүүсийг яллах явдал ч биш юм. Үнэн хэрэгтээ, Бурханы шүүлтийн ажил гүйцэлдэхээс өмнө, Бурханы сэнтийн өмнө очдог бүх хүн бол Бурханы үгээр шүүгдэж, шалгуулж, цэвэрлэгддэг хүмүүс билээ. Бурханы шүүлтийг хүлээн зөвшөөрч, ариусгагддаг бүх хүнийг Бурхан хаанчлал руугаа аваачна. Харин Бурханы үгийн шүүлтийг хүлээн зөвшөөрөхөөс татгалздаг хүмүүсийн хувьд нүгэлт уг чанарыг нь Бурхан шүүж, цэвэрлэхгүй тул тэд нүгэл дунд амьдарч, байнга нүгэл үйлдсээр байх болно. Мөн худал ярьж, хуурч, Бурханы эсрэг тэрсэлж, Бурханыг эсэргүүцнэ. Тэд нүглийнхээ улмаас тамд устах ба энэ нь Бурханы зөвт зан чанарын жинхэнэ илрэл юм. Олон жил Эзэнийг дагасан бид, итгэлээсээ үүдэн нүглээсээ золин авруулсан боловч нүгэлт уг чанарын маань асуудал шийдвэрлэгдээгүй гэдгийг гүнээ ухаарсан юм. Бид Эзэнийг дагадаг атлаа нөгөөтээгүүр Эзэний сургаалыг байнга сөрж, харин ч бүр махан биеийн хүслээ дур зоргоор нь тавьж, худал хэлэх, хууран мэхлэх, далдуур явуулга хийж, алдар нэр, эд хөрөнгийн төлөө тэмцэлдэх гэх мэт нүгэл үйлддэг. Бид хоосон хийрхэлд шунан дурлаж, материаллаг ертөнцийн ёрын муу чиг хандлагын араас хөөцөлддөг. Гэх мэтчилэн бий. Ялангуяа шалгалт, осол, гай гамшигтай тулгарах үедээ бид Бурханыг буруугаар ойлгож, Түүнийг буруутгаж, бүр Түүнээс урвадаг. Бид нүгэл үйлдээд түүнийгээ улайх байнгын нөхцөл байдал дунд амьдарч байгаа ч нүгэлт уг чанарынхаа дөнгөнөөс хэзээ ч ангижирч байгаагүй гэж хэлж болно. Библид: ‘Ариун байдалгүйгээр хэн ч Эзэнийг харахгүй’ (Еврей 12:14) гэж хэлдэг. Бидэн шиг завхарсан хүмүүс Бурханы хаанчлалд орж яаж чадах билээ? Төгс Хүчит Бурхан ийн хэлсэн: **‘Дөнгөж золин аврагдсан, өөрчлөгдөөгүй, эсвэл Бурханаар төгс болгуулаагүй чам мэтийн нүгэлтэн Бурханы зүрх сэтгэлийн дагуу байж чадах уу? Одоо ч гэсэн хуучин хэвээрээ байгаа чиний хувьд, Есүсээр авруулж, Бурханы авралын улмаас нүгэлтэн гэж тооцогдохгүй байгаа чинь үнэн боловч нүгэлтэй биш, бохир заваан биш гэдгийг чинь энэ нь нотлохгүй. Хэрвээ өөрчлөгдөөгүй юм бол чи яаж ариун байж чадах юм бэ? Дотроо чи бохир заваанаар дүүрч, хувиа хичээсэн, өөдгүй байдаг мөртөө Есүстэй**

---

хамт буухыг хүссээр байдаг—тийм азтай явдал байна гэж үү дээ! Бурханд итгэх итгэлдээ чи нэг алхмыг орхисон: **Чи зүгээр л золин аврагдсан, гэхдээ өөрчлөгдөөгүй. Чи Бурханы зүрх сэтгэлийн дагуу байхын тулд чамайг өөрчилж, цэвэрлэх ажлыг Бурхан биечлэн хийх ёстой; чи зөвхөн золин авруулсан бол ариун байдалд хүрч чадахгүй. Ийм маягаар чи Бурханы сайн ерөөлийг хуваалцах эрхгүй байх болно, учир нь чи хүнийг удирдах Бурханы ажилд нэг алхмыг орхигдуулсан, энэ нь өөрчлөгдөж, төгс болох гол алхам юм. Тиймээс дөнгөж золин аврагдсан нүгэлтэн чи Бурханы өв залгамжлалыг шууд өвлөн авч чадахгүй**’ (Үг нь махбодоор илэрсэн номын “Нэршил болон ялгамж чанарын талаар”). Иймээс эцсийн өдрүүдийн үеэр Бурхан Өөрийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, завхарсан хүн төрөлхтний хэрэгцээний дагуу хүмүүсийг шүүх, гэсгээх, цэвэрлэх үе шатыг явуулж байгаа билээ. Зорилго нь, биднийг Сатаны эзэмшлээс бүрмөсөн аварч, нүгэлт уг чанарын маань дөнгийг үгүй хийх явдал бөгөөд ингэснээр бид ариусгагдаж, аврагдаж чадна. Эндээс, Бурханы эцсийн өдрүүдийн шүүлтийн ажил нь бүхэлдээ цэвэрлэх болон аврах явдал гэдгийг харж болно. Энэ нь хүмүүсийн төсөөлдөг шиг биднийг яллах явдал биш юм.”

Лиу Хуй эгч үргэлжлүүлэн ийн нөхөрлөв: “Тэр тийм шүү, Энххуй эгч ээ. Бодоод үзэцгээе, хэрвээ Бурханы шүүлтийн ажил биднийг яллах, шийтгэхийн төлөө байсан бол Сатаны нөлөөгөөр ихэд завхарсан бидний хэн ч, хэзээ ч аврагдахгүй, эсвэл Бурханы хаанчлалд орж чадахгүй байх байсан. Хэрвээ тийм байсан бол Бурханы шүүлтийн ажил байхын хэрэг юу сан билээ? Эцсийн өдрүүдэд Бурхан яагаад шүүлтийн ажил хийдгийг болон үүний ач холбогдол юу болохыг Төгс Хүчит Бурханы үг тодорхой өгүүлдэг. Төгс Хүчит Бурханы үгээс хоёр хэсгийг уншицгаая: **‘Хүн бүхий л амьдралдаа Сатаны эзэмшил дор амьдардаг, өөрөө Сатаны нөлөөнөөс ангижирч чадах хүн нэг ч үгүй. Бүгд өчүүхэн ч утга учиргүй, эсвэл үнэ цэнгүйгээр бохир заваан дэлхийд, завхрал, хоосрол дунд амьдардаг; тэд махан биеийн төлөө, шунал тачаалын төлөө, Сатаны төлөө тийм хэнэггүй амьдралаар амьдардаг. Тэдний оршин тогтнолд өчүүхэн төдий ч үнэ цэн үгүй. Өөрийг нь Сатаны нөлөөнөөс чөлөөлөх үнэнийг хүн олж авах чадваргүй. Хэдийгээр хүн Бурханд итгэж, Библи уншдаг ч өөрийгөө Сатаны нөлөөллийн хяналтаас хэрхэн чөлөөлөхийг ойлгодоггүй. Эрин үеүдийн туршид маш цөөхөн хүн энэ нууцыг олж илрүүлсэн, тун цөөн хүн үүнийг ухаарсан... Хэрвээ хүн цэвэрлэгдэхгүй бол бохир заваан байдаг; хэрвээ тэр Бурханаар хамгаалуулж, халамжлуулахгүй бол Сатаны хоригдол хэвээр үлддэг; хэрвээ шүүгдэж, гэсгээгдэхгүй бол Сатаны харанхуй нөлөөний дарлалаас зугтах ямар ч аргагүй байх болно. Чиний харуулдаг завхарсан зан чанар болон амьдран харуулдаг дуулгаваргүй зан авир Сатаны эзэмшил дор амьдарсаар байгааг чинь батлахад хангалттай. Хэрвээ чиний**

---

оюун санаа болон бодол цэвэрлэгдээгүй бол, мөн чиний зан чанар шүүгдэж, гэсгээгдээгүй бол бүхий л оршихуй чинь Сатаны эзэмшлийн хяналтад байж, оюун санаа чинь Сатанд захирагдах ба бодлыг чинь Сатан зохион байгуулж, бүх оршихуйг чинь Сатаны гар хянаж байдаг’ (Үг нь махбодоор илэрсэн номын “Петрийн туршлага: гэсгээлт, шүүлтийн талаарх түүний мэдлэг”). ‘Шүүлт, гэсгээлтийн энэ ажлаар дамжуулан өөрийнхөө доторх бохир, завхарсан мөн чанарын талаар хүн бүрэн мэдэж авах бөгөөд бүрэн өөрчлөгдөж, цэвэр болж чадна. Ийм маягаар л хүн Бурханы сэнтийн өмнө буцан очих үнэ цэнтэй болж чадна. Өнөөдөр хийгдэж байгаа бүх ажил нь хүнийг цэвэрлэж, өөрчлөхийн төлөө байдаг; үгийн шүүлт, гэсгээлт, мөн цэвэршүүлэлтээр дамжуулан хүн завхралаа хаяж, ариусгагдаж чадна’ (Үг нь махбодоор илэрсэн номын “Бие махбодтой болохын нууц (4)”). Тэгвэл бид Бурханы үгээс юу туулж чадах вэ? Нэг талаар, Бурханы үг туйлын бодитой бөгөөд амьдралын маань бодит нөхцөл байдлыг маш сайн тусгадаг гэдгийг бид харж болно. Нөгөө талаар, өөрсдийгөө бузар муухай, завхралаас ангижруулж, Сатаны харанхуйн нөлөөнөөс ангижруулахын тулд бид эхлээд Бурханы шүүлт, цэвэрлэлтийг туулах ёстой гэдгийг харж болно. Тэр үед л бид Бурханаар хаанчлал руу нь хүргүүлэх эрхтэй болно. Бурханы эцсийн өдрүүдийн шүүлтийн ажилгүйгээр бид Бурханы зүрх сэтгэлийн дагуух хүмүүс болохуйцаар цэвэрлэгдэхгүй, мөн Бурханы хаанчлалд орж чадахгүй нь лавтай. Бид нүгэл үйлдэж, Бурханыг эсэргүүцэхээ хэзээ ч болихгүй бөгөөд эцэстээ тамд Бурханаар устгуулах болно. Үнэн хэрэгтээ, Төгс Хүчит Бурханы Чуулганы ах, эгч нарын бодит гэрчлэлүүдээс Бурханы шүүлт, гэсгээлт бол хүмүүсийн авралын гэрэл болохыг харж болно. Сатан биднийг бүгдийг нь завхруулсан боловч бид Төгс Хүчит Бурханы өмнө очиж, Бурханы үгэн дэх шүүлт, гэсгээлтийг хүлээн авч чаддаг учраас амь зан чанар маань аажмаар өөрчлөгддөг. Бид тэрслүү, эсэргүү байдлаас хүлээн зөвшөөрч, захирагддаг байдал руу; биеэ тоосон, өөрийгөө зөвтгөдөг, хэнд ч бууж өгдөггүй байдлаас аминч үзлээ хойш тавихыг хүсдэг, зөв зүйлд болон үнэнд захирагддаг байдал руу шилждэг. Түүнчлэн, Бурханы шүүлт, гэсгээлтэд илэрхийлсэн бүхэн бол үнэн, бас Бурханы зөвт, ариун зан чанарын илэрхийлэл тул Бурханы шүүлт, гэсгээлтийг туулах тусмаа бид Бурханыг төдий чинээ их мэддэг. Бид Бурханыг мэдэх тусмаа дэлхий дээрх хүмүүс, юмс, үйл явдлыг төдий чинээ тодорхой харж чаддаг. Улмаар бидний үзэл бодол, үнэт зүйл янз бүрийн түвшинд өөрчлөгддөг. Бид улам Бурханыг хүндэтгэж, Бурханд захирагддаг. Энэ бол Төгс Хүчит Бурханы шүүлт, гэсгээлтийн бидэнд үзүүлдэг үр нөлөө юм. Бурханы үгэн дэх үнэний гэрлийн шүүлтгүйгээр бид бүгд харанхуйд амьдарч, өдөр бүр нүгэл үйлдээд түүнийгээ улайн, дараа нь дахин нүгэл үйлдсээр, нүглийн дөнгөнөөс хэзээ ч салахгүй байх байсан. Тэгвэл Бурхан биднийг яаж ер нь Өөрийнхөө хаанчлалд аваачиж чадах билээ?”

---

Ли эгч, Лиу эгч хоёртой нөхөрлөсний дараа миний зүрх сэтгэлд тод гэрэл ассан мэт санагдлаа. Тэдний хэлсэн зүйл үнэн байв: Манай чуулганы пастор, ахлагч, ах, эгч нар бүгд нүглийн хүлээсээс өөрсдийгөө салгаж чадаагүй. Би ч бас өөрийн эрхгүй байнга нүгэл үйлдэж, Эзэний үгийг хэрэгжүүлж чаддаггүй байв. Бид бүгд нүгэл үйлдээд, дараа нь түүнийгээ улайдаг байдалд амьдарч байгаа—Бурхан эргэн ирж, шүүлт болон цэвэрлэлтийн ажлын үе шатыг хийх нь бидэнд үнэхээр хэрэгтэй юм. Хэрвээ би Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг судлаагүй бол эдгээр үнэнийг хэзээ ч ойлгож авахгүй байжээ. Тэгээд би Бурханы удирдамжид үнэхээр талархаж байв. Төгс Хүчит Бурханы үгийг уншиж, эгч нарын нөхөрлөхийг сонсохын зэрэгцээ Бурханы үгийн шүүлтээр дамжуулан завхарсан зан чанар нь хэрхэн өөрчлөгдсөн тухай өгүүлсэн Төгс Хүчит Бурханы Чуулганы ах, эгч нарын бичгээр үйлдсэн гэрчлэлийг уншаад би Бурханы эцсийн өдрүүдийн шүүлтийн ажлын талаар бага зэрэг ойлгох болсон билээ. Миний үзэл арилсан ба Бурханы шүүлт, гэсгээлт нь нүглээс зайлж, ариусгалтыг олж авахад бидэнд чухал болохыг одоо би мэдэж авсан.

Дараа нь Лиу Хуй эгч ингэж хэллээ: “Төгс Хүчит Бурханы үгээс дахиад хоёр хэсгийг уншицгаая. Төгс Хүчит Бурхан ийн хэлжээ: **‘Шүүлтийн ажлаа хийхдээ Бурхан хүний уг чанарыг ердөө хэдхэн үгээр тодорхой болгодог юм биш; Тэрээр удаан хугацааны туршид илчилж, харьцаж, засдаг. Илчлэл, харьцалт болон засалтын эдгээр аргыг энгийн үгээр бус, харин хүнд огт байдаггүй үнэнээр л орлуулж болно. Зөвхөн ийм төрлийн арга барилыг л шүүлт гэж нэрлэж болно; ийм төрлийн шүүлтээр л дамжуулан хүн номхорч, Бурханд захирагдахаар бүрэн үнэмшээд зогсохгүй, Бурханы тухай жинхэнэ мэдлэгийг олж авч чаддаг. Шүүлтийн ажлын авчирдаг зүйл гэвэл Бурханы жинхэнэ дүр төрх болон өөрийнх нь тэрслүү байдлын үнэний талаарх хүний ойлголт юм. Шүүлтийн ажил нь хүнд Бурханы хүслийн тухай, Бурханы ажлын зорилгын тухай, хүний ойлгошгүй нууцуудын тухай ихээхэн ойлголт олж авах боломж олгодог. Түүнчлэн, өөрийн ялзарсан мөн чанар болон ялзралынхаа үндсийг таньж мэдэх, хүний муу муухайг нээн илрүүлэх боломжийг олгодог. Энэ бүх үр дүнг шүүлтийн ажил авчирдаг, учир нь энэ ажлын мөн чанар нь үнэндээ Бурханы үнэн, зам, амийг Түүнд итгэдэг бүх хүнд нээх ажил юм. Энэ ажил нь Бурханы хийдэг шүүлтийн ажил билээ’** (Үг нь махбодоор илэрсэн номын “Христ шүүлтийн ажлыг үнэнээр хийдэг”). **‘Христийн хэлсэн үнэнд найдалгүйгээр амь олж авахыг хүсдэг хүмүүс бол газар дэлхий дээрх хамгийн инээдэмтэй хүмүүс, Христийн авчирсан амийн замыг зөвшөөрдөггүй хүмүүс бол бүтэшгүй мөрөөдөлд автсан хүмүүс юм. Иймд Би эцсийн өдрүүдийн Христийг зөвшөөрдөггүй хүмүүсийг Бурхан үүрд үзэн ядна гэж хэлдэг. Христ бол хүний эцсийн өдрүүдэд хаанчлалд орох үүд хаалга бөгөөд**

---

үүнийг хэн ч тойрч эс гарна. Христээр дамжилгүйгээр хэн ч Бурханаар төгс болгуулахгүй. Чи Бурханд итгэдэг, иймээс чи Түүний үгийг хүлээн зөвшөөрч, Түүний замыг дуулгавартай дагах ёстой. Чи үнэнийг ойлгохгүйгээр, амийн хангалтыг хүлээн зөвшөөрөхгүйгээр ерөөл хүртэнэ гэж санахын ч хэрэггүй. Христэд үнэхээр итгэдэг бүх хүнийг амиар хангахын тулд Тэр эцсийн өдрүүдэд ирсэн. Энэ ажил нь хуучин эринийг төгсгөж, шинэ эринд орохын төлөө байдаг бөгөөд Түүний ажил бол шинэ эринд орох бүх хүний явах ёстой зам юм. Хэрвээ чи хүлээн зөвшөөрч чадахгүй, оронд нь яллаж, доромжилж, бүр хяхаж хавчдаг бол мөнхийн галд шатах тавилантай бөгөөд Бурханы хаанчлалд хэзээ ч орж чадахгүй’ (Үг нь махбодоор илэрсэн номын “Эцсийн өдрүүдийн Христ л хүнд мөнх амийн замыг өгч чадна”). Хүн төрөлхтний хэрэгцээнд нийцүүлэн, хүмүүсийг цэвэрлэж, аврах бүх үнэнийг илэрхийлэхийн тулд эцсийн өдрүүдэд Бурхан бие махбодтой болсныг Төгс Хүчит Бурханы үгээс харж болно. Тэрээр хүн төрөлхтний халдахыг тэвчихгүй Бурханы зөвт зан чанарыг илчилдэг. Бурхан үгээрээ дамжуулан хүмүүсийн уг чанар, мөн чанар, завхралынх нь жинхэнэ байдлыг илчилдэг. Төгс Хүчит Бурханы илэрхийлсэн шүүлтийн үгийг хүлээж авснаар л бид биеэ тоосон, зальхай, аминч зан, муу муухай байдал зэргээ мэдэж авч чаддаг ба энэ нь бүгд сатанлаг уг чанар болон завхарсан зан чанарын маань нэг хэсэг юм. Бурханы шүүлт, гэсгээлтийг хүлээн авснаар л бид Бурханы зөвт зан чанарыг мэдэж, Бурханыг хүндэлж, жинхэнээсээ гэмшдэг зүрх сэтгэлтэй болж чадна. Улмаар бид завхарсан зан чанараа өөрчилж, цэвэрлэж чадна. Энэ нь Бурханы шүүлтийн ач холбогдол, мөн авралд хүрэх цорын ганц зам билээ. Энэхуй эгч ээ, бид Төгс Хүчит Бурханы үгээс аль болох ихийг чин сэтгэлээсээ уншиж байгаа цагт Бурханы эцсийн өдрүүдийн шүүлтийн ажлын ач холбогдол бидэнд тодорхой болно, үүнээс ч илүүтэйгээр, зөвхөн эцсийн өдрүүдийн Христ л хүмүүст мөнх амийн замыг өгч чадна гэдгийг бид харна.”

Эзэнийг магтъя! Эгч нартай ярилцсанаар би асар ихийг олж авлаа. Хэдийгээр би Бурханы шүүлт, гэсгээлтийг хараахан туулаагүй байгаа ч, эгч нартай нөхөрлөж, “Амийн оролтын туршлагын тухай гэрчлэлүүд”-ийг уншсанаар Бурханы шүүлт, гэсгээлт хүмүүсийг үнэхээр өөрчилж чадна гэж надад санагдсан юм. Бас, намайг өөрчилж, ариусгахын тулд Бурхан шүүлт, гэсгээлтийн үе шатаа явуулах үнэхээр хэрэгтэй гэж надад санагдсан бөгөөд ингэснээр би тэнгэрийн хаанчлалд хүргэгдэх эрхтэй болно. Дараа нь, дахиад хэдэн өдөр нөхөрлөсний дараа Бурханы шүүлтийн ажлын ач холбогдол болон Бурханы нэртэй холбоотой үнэний талаар би илүү ихийг ойлгож авав. Би бас жинхэнэ Христийг хуурамчаас, жинхэнэ чуулганыг хуурамч чуулганаас хэрхэн ялгаж танихыг бас олж мэдлээ. Бурхан бие махбодтой болох, Бурханы ажил, хүний ажлын хоорондох ялгаа, хүн төрөлхтнийг Сатан хэрхэн завхруулдаг, Бурхан бидний хэрхэн авардаг гэх мэт

---

үнэнийг би олж мэдсэн. Төгс Хүчит Бурхан бол үнэхээр эргэж ирсэн Эзэн Есүс мөн гэдэг баттай дүгнэлтэд би хүрээд, Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг баяртайгаар хүлээн авсан юм. Бурханыг магтъя! Тэр үеэс хойш би Бурханы үгийг унших ханашгүй их хүсэлтэй болов. Чуулганы амьдралаар амьдарч, ах эгч нартай үнэнийг нөхөрлөж, Бурханы үгийн усалгаа, хооллолтыг хүлээн авснаар миний сүнс асар их хангалт хүртэж байгаа мэт санагдсан юм. Энэ нь надад, Библи дэх Илчлэлийн номын: **“Харагтун, Би үүдэнд зогсоод тогшиж байна: Хэрвээ хэн нэгэн Миний дуу хоолойг сонсоод хаалгаа нээвэл, Би түүн дотор орж, түүнтэй хамт, тэр Надтай хамт хооллох болно”** (Илчлэл 3:20) гэх зөгнөл бүрэн биелснийг харах боломж олгосон билээ. Энэ зөгнөл над дээр биечлэн хэрэгжиж байгааг би бас мэдэрсэн юм. Төгс Хүчит Бурханы үг зүрх сэтгэлийн минь үүдийг тогшин, Бурханы дуу хоолойг сонсож, Бурханы шүүлтийн ажлыг мэдэж, Түүний өмнө буцаж очих боломж олгосон юм. Бурханыг магтъя!

## 4. Хууртагдсан сүнс сэрсэн нь

Юанжи, Бразил

Би хойд Хятад дахь жижигхэн хотод төрсөн бөгөөд 2010 онд би хамаатнуудаа даган Бразил руу явсан билээ. Бразилд байх хугацаандаа би нэгэн Христэд итгэгч найзтай болж, тэрээр надад номлол сонсгохоор сүм рүү дагуулан явдаг байлаа. Би гурван удаа явсныхаа дараа ч юу ч олж мэдээгүй байв. Дараа нь би ажлынхаа улмаас үнэхээр завгүй болсон тул 2015 оны 6-р сарын нэгэн өдрийг хүртэл сүмд дахиж очоогүй бөгөөд тэр өдөр найз маань намайг сүмд дахин нэг удаа аваачив. Тэр үед, ах эгч нарын хуваалцаж байсан зүйлээр дамжуулан Эзэн Есүс бол Золин аврагч гэдгийг би бага зэрэг ойлгож авсан юм. Ялангуяа Эхлэл номыг анх унших үед хүнийг үнэндээ бол Бурхан бүтээсэн, бас Бурхан бүх зүйлийг бүтээсэн гэдгийг ухаарч, Бүтээгч үнэхээр гайхалтай юм гэдгийг би мэдэрч билээ. Сургуульд байхад сурах бичгүүдэд хүн сармагчнаас бий болсон бөгөөд дэлхий дээрх бүх зүйл байгалийн жамаар үүссэн гэж заадаг байв—би хорь гаруй жилийн турш хууртагдаж байсан болж таарлаа. Гагцхүү Библийг уншсаны дараа би бүрэн сэрсэн бөгөөд тэр үеэс хойш Эзэн Есүс итгэсэн билээ.

2015 оны сүүлээр би Хятадад таван сар байсныхаа дараа Бразил руу буцсан юм. Энэ удаад би тогтвортой ажил олж, зохих ёсоор суурьшихаар шийдэв. Гэвч юмс үргэлж төлөвлөснөөр болдоггүй шүү дээ. Ажил төрөл, хувийн амьдрал маань нэг л жигдэрч өгөхгүй байсан нь намайг маш их хямрааж, түгшээх болов. Нэгэн орой би гомдоллохоор Христэд итгэгч найз руугаа ярилаа. Тэрээр: “Өөрийгөө тайван байлгаад, Эзэнд залбирч,



---

Эзэн чамд зориулж бүх зүйлийг хэрхэн зохицуулдгийг хар” гэж надад хэлэв. Тиймээс би зүрх сэтгэлээ тайван болгоод, “Эзэн Есүс минь! Одоогоор ажил төрөлд минь хүндрэл бэрхшээл тулгараад, би яаж зохицуулахаа мэдэхгүй байна. Эзэн минь, би Танаас тусламж авах байх гэж найдаж байна” хэмээн Эзэнд залбирав. Гайхмаар нь, дөрөв хоногийн дараа дарга маань намайг дуудаж, ажилдаа буцан орохыг хүссэн юм. Би туйлын их баярлаж, Эзэн Есүс залбирлыг минь сонссонд талархаж байлаа. Үүний дараа би Эзэний ерөөлийг илүү их хүлээн авсан тул ажлаасаа чөлөө авах болсон ч гэсэн, Түүний хайрыг хариулахын тулд долоо хоног бүр цуглаанд оролцож эхлэв.

2016 оны 6-р сараас эхлэн би чуулганы цугларалтуудад оролцохоос гадна Библийн эшлэлүүдийг Фэйсбүүк дээр найзуудтайгаа хуваалцдаг болсон төдийгүй Эзэний талаар илүү их ойлголттой болохын тулд Фэйсбүүкийн агуулгыг гүйлгэн хардаг байлаа. Олон ч найзтай болсон бөгөөд тэд завтай үедээ Библийн эшлэлүүдийг надтай хуваалцдаг байлаа. Энэ нь надад маш их урам өгдөг байв. Нэгэн өдөр би Фэйсбүүк үзэж байтал “Бурхан шүүлтээр бууж ирнэ” гэсэн тайлбартай видео анхаарлыг минь тэр даруй татав. Тэгээд сониучирхан дээр нь дарлаа. Тэр видеог үнэхээр сайн хийсэн байх юм гэж төсөөлж ч байсангүй. Ердөө л гайхамшигтай байсан юм! Би уянгалаг, хүчирхэг дуулалт, сэтгэлийн утсыг хөндсөн үг, жүжигчдийн урам зоригт татагдав. Анхаарлаа төвлөрүүлээд хартал тэр видео Төгс Хүчит Бурханы Чуулганых байв. Тэгээд би: “Жүжигчид бүгд өөрсдийгөө үнэхээр зориулж байна—яг л Бурханд сонсгохоор дуулж байгаа юм шиг байна шүү дээ. Төгс Хүчит Бурханы Чуулган огтхон ч муу биш юм шиг байна! Би анх удаа л тэдний талаар сонсож байна. Хэрэв надад боломж олдвол би энэ чуулгантай холбогдох хэрэгтэй юм байна” гэж бодлоо.

Нэгэн өдөр би тэрхүү видеог Фэйсбүүкийн найз Ян эгч рүү илгээв. Би тэр эгчтэй Библийн талаар байнга хэлэлцдэг байсан юм. Эгчид ч видео үнэхээр таалагдсан бөгөөд Төгс Хүчит Бурханы Чуулганы талаар илүү их мэдэж авахыг хүсэж байгаагаа хэлэв. Энэ чуулган үнэхээр маш онцгой бөгөөд Ариун Сүнсний ажлаар дүүрэн гэдгийг эгч мэдэрчээ. Тэгээд би тэрхүү видеог өөрийн Фэйсбүүк хуудаснаа хуваалцав. Гэвч хачирхалтай нь, нэг найз маань уг видеог үзээд, Төгс Хүчит Бурханы Чуулган бол сайн биш гэж хэлсэн төдийгүй энэ чуулганы талаарх төрөл бүрийн сөрөг зүйлийг над руу илгээсэн юм. Төгс Хүчит Бурханыг доромжилж, Төгс Хүчит Бурханы Чуулганыг ялласан энэ бүх материалыг хараад би айж, “Энэ чуулган сайн л юм шиг байх юм, гэтэл яагаад ийм шүүмжлэл байдаг билээ?” гэж бодов. Видеог дахин үзэх үедээ би, эцсийн өдрүүдэд хуурамч Христүүд гарч ирнэ хэмээн пастор маань нэгэн удаа номлолоороо хэлж байсныг гэнэтхэн санах. Хэрэв би Эзэн Есүсийн замаас хазайвал тэгээд л дуусаа биш гэж үү? Үүнийг ердөө үл тоомсорлож болохгүй гэдгийг би мэдэж байсан тул үзэхгүй байхаар шийдэв. Тэр даруйдаа би Ян

---

эгчтэй холбогдож, нөхцөл байдлыг тайлбарлалаа. Хариуд нь Ян эгч: “Бид үнэн худлыг нь олж тогтоохын тулд тухайн түүхийн ердөө нэг талд нь найдаж болохгүй. Энэ нь Эзэний сургаалуудад үл нийцнэ. Эзэнд итгэгчид бид бүгдээрээ Түүний эргэн ирэхийг хүлээж байгаа ба яг одоо зарим хүн Эзэнийг хэдийн эргэн ирсэн гэж хэлж байгаа. Бид үүнийг судлах ёстой. Бид зүгээр л бусдыг дагаж, сохроор шүүж, яллаж болохгүй. Төгс Хүчит Бурханы Чуулганы хүмүүсийг олж уулзаад, судалж үзэцгээе. Тэдний жинхэнэ төрхийг харъя—ямар ч жинхэнэ зүйлийг хуурамч болгож болохгүй, ямар ч хуурамч зүйлийг жинхэнэ болгож болохгүй” гэлээ. Тэгээд би: “Ян эгчийн зөв шүү. Эзэн эргэн ирсэн тухай сайн мэдээг хэн нэгэн номлохыг би үнэхээр анх удаа сонслоо. Бас Төгс Хүчит Бурханы Чуулганыг яллан интернэтэд бичсэн зүйлийн үнэн худлыг би огт мэдэхгүй. Төгс Хүчит Бурханы Чуулганы хийсэн видео, кинонууд нэлээд сайн гэдгийг л харж байна. Би очиж, тэдний тухай мэдэж авах хэрэгтэй. Энэ бол Эзэний эргэн ирэлтэд хандах цорын ганц ухаалаг арга зам мөн” гэж би бодсон юм. Иймээс би Ян эгчийн хамт Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг судалж үзэхийг зөвшөөрөв.

Янг эгч видеоны доод хэсэгт үлдээсэн холбоо барих мэдээллээр дамжуулан Хойд Америкт байрладаг Төгс Хүчит Бурханы Чуулганы Жан ахтай холбогдсон юм. Онлайнаар үүнтэй холбогдох үедээ Ян эгч бид хоёр ижил асуулт тавив: “Эзэн эцсийн өдрүүдэд эргэж ирнэ гэдгийг бид хоёр мэдэж байгаа. Гэхдээ Эзэн Есүс: **‘Тэр үед хэн нэгэн хүн та нарт “Хараач, Христ энд байна”, эсвэл “Христ тэнд байна” гэвэл түүнд бүү итгэ. Учир нь хуурамч Христүүд болон хуурамч эш үзүүлэгчид гарч ирэн агуу тэмдэг, гайхамшгуудыг үзүүлэх ба боломжтой бол сонгогдсон хүмүүсийг ч хууран мэхэлнэ’** (Матай 24:23–24) гэж хэлсэн. Жан ах аа, эцсийн өдрүүдэд хүмүүсийг мэхлэхээр хуурамч Христүүд гарч ирэх энэ асуудлын талаар та ямар бодолтой байдаг вэ?”

Жан ах ингэж хэлэв: “Эзэн Есүс бидэнд анхааруулах үүднээс ийм зүйл хэлсэн. Түүнийг эцсийн өдрүүдэд эргэн ирэх үед хуурамч Христүүд бас гарч ирнэ. Хуурамч Христүүдэд мэхлүүлэхгүйн тулд биднийг ялган таних чадвартай болгох нь Эзэний хүсэл юм. Гэхдээ, Эзэн эргэн ирсэн гэж хэлж буй хэн бүхнийг хавтгайруулан үл тоож, тэр ч байтугай тэднийг шүүж, ялла гэсэндээ Тэр ингэж хэлээгүй. Ингэвэл Эзэн Есүсийн үгийг буруугаар ойлгосон явдал болно. Хуурамч Христүүд ямар болохыг Эзэн Есүс ингэж тодорхой хэлсэн байдаг: **‘Учир нь хуурамч Христүүд болон хуурамч эш үзүүлэгчид гарч ирэн агуу тэмдэг, гайхамшгуудыг үзүүлэх ба боломжтой бол сонгогдсон хүмүүсийг ч хууран мэхэлнэ’** (Матай 24:24). Хуурамч Христүүдийн илэрхий шинж бол тэд Эзэн Есүсийн ажлыг дуурайж, тэмдэг харуулж, гайхамшиг үзүүлж, өвчнийг эдгээж, чөтгөрүүдийг хөөн зайлуулдаг. Энэ бол хуурамч Христүүдийн хамгийн их зальжин, ёрын муу байдаг талбарууд бөгөөд бас тэдний өвөрмөц үндсэн шинж тэмдэг юм. Хуурамч

---

Христүүдийн илэрхийлэл болон шинжүүдийн талаар Төгс Хүчит Бурханы үг бүр ч илүү тодорхой, хурц гярхай байдаг. Төгс Хүчит Бурхан ийн хэлсэн: **‘Өнөө үед тэмдэг, гайхамшиг үзүүлж, чөтгөрүүдийг хөөн зайлуулж, өвчтэйг эдгээж, олон ид шид үзүүлж чадах хүн гарч ирээд, Есүс ирлээ хэмээн өөрийгөө зарлавал энэ нь Есүсийг дуурайсан муу ёрын сүнснүүдийн дүр эсгэлт байх болно. Үүнийг санаж яв! Бурхан нэг ажлаа давтдаггүй. Есүсийн ажлын үе шат аль хэдийн биелсэн ба ажлын тэрхүү үе шатыг Бурхан дахин хэзээ ч хийхгүй... Хэрвээ эцсийн өдрүүдэд Бурхан тэмдэг, гайхамшиг үзүүлсээр, чөтгөрүүдийг хөөн зайлуулж, өвчтэйг эдгээсээр—яг Есүс шиг үйлдсэн бол нэг ажлаа давтаж байгаа хэрэг болж, Есүсийн ажил ямар ч ач холбогдол, үнэ цэнгүй байх байсан юм. Тиймээс Бурхан эрин үе бүрд ажлын нэг үе шатыг хэрэгжүүлдэг. Түүний ажлын үе шат бүрийг гүйцэлдмэгц муу ёрын сүнснүүд удалгүй дуурайдаг ба Сатан Бурханыг өсгий даран дагаж эхэлсний дараа Бурхан өөр арга барилд шилждэг. Бурхан ажлынхаа нэг үе шатыг биелүүлмэгц муу ёрын сүнснүүд үүнийг нь дуурайдаг. Та нар энэ талаар тодорхой ойлгох ёстой’** (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурханы өнөөдрийн ажлыг мэдэх нь”). Бүх хуурамч зүйл үнэн зүйлийн амжилтын хойноос дагаж, даган дуурайж л чадна гэдгийг бид бүгдээрээ мэднэ. Хуурамч Христүүд ч мөн ялгаагүй. Тэд бол муу ёрын сүнснүүд бөгөөд тэдэнд Христийн мөн чанар байхгүй. Тэд Христийн ажлыг хийж чадахгүй, үнэнийг илэрхийлэх чадваргүй, мөн Бурханы зан чанар, Бурханд юу байгаа, Тэр юу болох бүхнийг илэрхийлж чадахгүй. Хүнд үнэн, зам, амийг авчирч чадахгүй. Тиймээс хуурамч Христүүд Эзэн Есүсийн аль хэдийн хийсэн ажлыг дуурайж л чадна; тэнэг, мэдлэггүй хүмүүсийг хуурахын тулд зарим тэмдэг, гайхамшигийг л үзүүлж чадна. Муу ёрын сүнсэнд эзэмдүүлсэн, өөрсдийгөө эргэн ирсэн Эзэн Есүс хэмээн даулиун тунхагладаг зарим хүн байдаг бөгөөд өвчнийг эдгээх, чөтгөрүүдийг хөөн зайлуулах, гайхамшиг үзүүлэх, гэмшил, уучлалын замыг номлох зэрэг зүйлсийг хийхдээ Эзэн Есүсийг дуурайдаг. Тэд хүмүүсийг хуурдаг хуурамч Христүүд гэдэг нь эргэлзээгүй. Бурханы ажил үргэлж шинэ байдаг, хэзээ ч хуучин байдаггүй, үргэлж урагшлан өрнөж байдаг. Тэрээр урьд өмнө хийсэн хуучин ажлаа хэзээ ч давтахгүй. Энэ нь Эзэн Есүс ажиллахаар ирж, Хуулийн эрин үеийг төгсгөн, Нигүүлслийн эрин үеийг эхлүүлсэн үетэй яг адилхан. Тэрээр хууль гаргаж, хүмүүсийн амьдралыг залж чиглүүлсэн Ехова Бурханы ажлыг давтаагүй, харин оронд нь Хуулийн эрин үеийн ажлын суурин дээр золин аврах ажлаа хийсэн. Эзэн Есүс хүн төрөлхтөнд гэмшил, уучлалын замыг авчирсан; бид Түүний өмнө очиж, нүглээ улайж, гэмшиж байгаа цагт Эзэн бидний нүглийг уучилж, гэм бурууг маань мартан, хүн төрөлхтөнд Эзэний хайрладаг арвин их нигүүлсэл, ерөөлийг эдлэх эрхтэй болгох байв. Энэ бүх ажил шинэ байсан бөгөөд ямар ч муу ёрын сүнс, эсвэл Сатан үүнийг хийж чадахгүй байх байлаа. Эцсийн өдрүүдэд эргэн ирсэн Эзэн Есүсийн хувьд энэ нь адилхан—Төгс Хүчит Бурхан Нигүүлслийн эрин үеийг дуусгаж, Хаанчлалын

---

эрин үеийг эхлүүлсэн. Төгс Хүчит Бурхан Эзэн Есүсийн золин авралын ажлыг давтаагүй. Тэрээр чөтгөрүүдийг хөөн зайлуулж, өвчтэйг эдгээж, эсвэл хүмүүст зориулж гайхамшиг үзүүлдэггүй. Харин үүний оронд золин авралын ажлын суурин дээр үнэнийг илэрхийлж, хүнийг шүүж, цэвэрлэх ажлын үе шатыг хэрэгжүүлдэг. Тэрээр хүн төрөлхтнийг Сатаны эзэмшлээс бүрмөсөн аварч, биднийг Бурханы хаанчлал руу буцаан авчирдаг. Энэ бол Бурханы урьд нь хэзээ ч хийж байгаагүй цоо шинэ ажил бөгөөд үүнийг ямар ч хуурамч Христ хийж чадахгүй. Бид Бурханы ажил үргэлж шинэ, хэзээ ч хуучин байдаггүй гэдгийг мэдэж, жинхэнэ Христийг хуурамч Христүүдээс ялган таних зарчмуудыг ойлгож байгаа цагт Бурханы илрэлт, ажил болон хуурамч Христүүдийн мэхлэлтийг аяндаа ялгаж салгах болно.”

Жан ахтай ярилцсаны үр дүнд би асар ихийг олж авсан юм; түүний нөхөрлөл маш тодорхой байв. Хуурамч Христүүд урьд өмнө нь Бурханы хийсэн зарим нэг ажлыг давтан дуурайж л чадна, гэхдээ тэд ямар ч шинэ ажил хийж чадахгүй, хүн төрөлхтнийг шинэ замаар хангаж ч чадахгүй. Энэ мөчид би Эзэн Есүсийн хэлсэн энэ үгийн ар дахь жинхэнэ утгыг ойлгосон юм: **“Учир нь хуурамч Христүүд болон хуурамч эш үзүүлэгчид гарч ирэн агуу тэмдэг, гайхамшгуудыг үзүүлэх ба боломжтой бол сонгогдсон хүмүүсийг ч хууран мэхэлнэ”** (Матай 24:24). Ян эгч ч бас үүнээс ихээхэн зүйл олж авснаа хэлсэн тул бид Жан ахтай маргааш орой нь уулзахаар цаг товлож, нөхөрлөлийг нь үргэлжлүүлэн сонсохоор болов.

Төгс Хүчит Бурханы Чуулганы Жан ахын хуваалцсан зүйл гайхалтай байсан бөгөөд миний хувьд үнэхээр үр өгөөжтэй болохыг би мэдрэв. Гэхдээ би интернэтэд байсан тэр бүр цуу яриаг бодох үедээ бага зэрэг болгоомжилсон хэвээр байлаа. Чуулган руугаа буцаж очсоныхоо дараа би нэгэн ахаас Төгс Хүчит Бурханы Чуулганы талаар ямар нэг зүйл мэддэг эсэхийг нь асуув. Тэрээр пастор энэ чуулгантай холбоо барьж огт болохгүй гэж хэлсэн гэв; мөн хэд хэдэн пасторын хэлсэн зарим зүйлийн талаар надад хэлж, Төгс Хүчит Бурханыг шүүмжилж, дайрч давшилж, ялласан юм. Үүнийг сонссоны дараа би бага зэрэг эргэлзэж тээнэгэлзэв. Би энэ сөрөг мэдээллийн талаар Ян эгчид цаг алдалгүй мэдэгдэж, Төгс Хүчит Бурханы Чуулганаас холбоогоо таслахыг зөвлөлөө. Гэвч Ян эгч Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг судлахаар шийдсэн харагдаж байв. Тэрээр надад хандан: “Хурганы мөр намайг хаашаа ч хөтөлсөн бай, би дагах болно. Саяхан, Төгс Хүчит Бурханы үгийг онлайнар уншиж, Төгс Хүчит Бурханы Чуулганы янз бүрийн видео, сайн мэдээний кинонуудыг үзээд би нэлээд их үнэнийг ойлгож авсан. Урьд нь намайг мухардалд оруулж байсан хүндрэл бэрхшээл, эргэлзээний олонх нь шийдвэрлэгдсэн. Төгс Хүчит Бурханы үг үнэн гэдгийг би мэдэрдэг. Бусад хүмүүс Төгс Хүчит Бурханы Чуулганыг яаж ч ялласан бай хамаагүй, тодорхой ойлгох хүртлээ би үүнийг заавал судалж

---

үзэх болно...” гэв. Би Ян эгчийг ятгаж чадаагүй тул түүнийг болон Жан ахыг Фэйсбүүк дээр блоклож, тэдэнтэй дахин холбогдож зүрхлээгүй юм.

Гэхдээ хоёр хоног ч өнгөрөөгүй байтал надад хийх ажил байхгүй болж эхлэв. Гэртээ өдөр бүр хоол хийхээс өөр хийх зүйл байхгүй байлаа. Ямар ч хийх зүйл байхгүй байсан тул би YouTube нээж, кино үзэв. Хачирхалтай нь нээх болгонд Төгс Хүчит Бурханы Чуулганы кино, дууны клип, найрал дууны видео гарч ирээд байв. Тэгээд би: “Төгс Хүчит Бурханы Чуулганы видео болон кинонууд үнэхээр хурдан тавигддаг юм байна. Үнэхээр гайхалтай юм аа! Бурханаас ирдэг зүйлс гарцаагүй хөгжин цэцэглэх ёстой тул Төгс Хүчит Бурханы Чуулган үнэхээр Бурханаас ирсэн байж болох уу? Өнгөрсөн удаад Жан ахын ярьсан зүйлс үнэнд нийцэж байсан шүү дээ. Төгс Хүчит Бурханы Чуулганыг ойлгож авахаар дахин нэг удаа оролдож үзэх хэрэгтэй байх. Би ердөө бусдын хэлсэн зүйлээс болж Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг судлахаас яаран татгалзаж болохгүй” хэмээн бодож эхэллээ. Гэвч интернэтээс харсан, Төгс Хүчит Бурханыг ялласан зүйл болон Төгс Хүчит Бурханы Чуулгантай холбоо барьж болохгүй гэсэн пасторынхаа анхааруулгыг санангуутаа би цааш лавшруулах хэрэггүй байх гэж бодов. Иймд би YouTube-ээс үзэх өөр видео хайхаар шийдэв. Гэвч хаашаа л харна, Төгс Хүчит Бурханы Чуулганы видеонууд байсан ба яах ч аргагүй байдалд орсон мэт надад санагдаж эхлэв. Эцэст нь миний сониуч зан дийлж, “Төгс Хүчит Бурханы Чуулган сайн, муу байх нь хамаагүй. Тэдний видеонуудыг халт үзээдхэе, тэгээд үнэхээр сайн биш байх юм бол ялган таних чадвартай болох сургамж болог” гэж бодов. Ингээд би “Сайн мэдээний найрал дууны 9 дэх цуврал” гэсэн нэртэй видеоог нээв. Энэ видео миний үнэхээр сайн мэдэх орчин үеийн нийгмийг бодитоор дүрслэн харуулсан учраас миний сонирхлыг татсан юм. Энэ нь хүний амьдралыг маш тод томруун, бодитоор, жинхэнээр дүрслэн харуулжээ. Үзэх явцдаа би уйлж, инээж, зүрх сэтгэл минь хөдөлж, маш их эрч хүчээр бялхаж байлаа. Төгс Хүчит Бурханы Чуулганаас гаргасан видео нэг бүрийг тэр даруй үзмээр санагдав. Дараа нь би Төгс Хүчит Бурханы Чуулганы видеонуудыг өдөр бүр үздэг болсон ба нэг долоо хоногийн дотор Хятад найрал дууны видеоны 17 хэсгийг бүгдийг нь үзсэн байв. Үзэх тусам л улам сонирхолтой санагдаж байлаа. Зүрх сэтгэлд минь тэдгээрийг даруй үзэж, судлахыг шаардаж буй хүч байгаа мэт байв. Тэгээд би: “Төгс Хүчит Бурханы Чуулганы зөндөө олон видеоог үзлээ. Видео болгон нь надад маш үр өгөөжтэй байсны зэрэгцээ алин дээр нь ч сөрөг үг байсангүй. Бүгд эерэг юм. Зарим нь дэлхийн харанхуй байдлыг ил гаргаж, зарим нь Бурханыг гэрчилж, зарим нь хүнийг Бурханы өмнө эргэж очиход залан чиглүүлж байна. Махан биеийн, эсвэл дэлхий ертөнцийн хэрэг явдлын хольц алга. Төгс Хүчит Бурханы Чуулган Ариун Сүнсний ажлаар дүүрэн байна. Цуу ярианд хэлээд байсан шиг огт биш юм. Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг үнэхээр судалж үзэх хэрэгтэй юм

---

байна!” гэж бодлоо.

Нэгэн өдөр Фэйсбүүк ухаж байхдаа би “Би эцсийн өдрүүдийн авралыг Фэйсбүүкээс олсон юм” гэсэн гарчигтай, хэн нэгний туршлага, гэрчлэлийг олж уншив. Түүнийг нээгээд унштал тэр эгч надтай адил туршлагатай болохыг харав. Эгчийг анх Төгс Хүчит Бурханы Чуулгантай холбоо барьж эхлэх үед онлайн найзууд нь түүнд энэ чуулгантай холбоотой баахан цуу яриа явуулжээ. Тэрээр маш их түгшиж байв. Эцэстээ юу тохиолдсоныг нь ойлгохыг тэсгэлгүй их хүсэж байсан тул би цааш нь яаравчлан уншив. Тэр эгч Эзэнд залбирч, өөрийг нь залж чиглүүлж өгөхийг Эзэнээс гуйсныг би харлаа. Эгч өөрийн сонголтоор сонсож, итгэж болохгүй гэдгээ мэдэрсэн боловч үнэн худал эсэхийг нь ялган танихын тулд Төгс Хүчит Бурханы Чуулганыг бодитой байдлаар судлах хэрэгтэй байв. Цуу яриаг сохроор сонсож, Эзэний хоёр дахь ирэлтийг судлахаас татгалзах нь тийм ч ухаалаг хандлага биш байх байсан тул Эзэний эргэн ирэлтийн тухай үнэнийг олж мэдэх ёстой гэж түүнд санагджээ. Эдгээр үг үнэхээр үнэн зөв байлаа. Эзэний эргэн ирэлт бол чухал зүйл бөгөөд хүн үүнд хянамгай хандах ёстой. Бид зүгээр л олон нийтийг дагаж, сохроор үгүйсгэж, татгалзаж болохгүй. Би нийтлэлийг үргэлжлүүлэн уншаад, Төгс Хүчит Бурханы Чуулганы талаар эгчийн ойлгож авсан зүйл онлайн найзуудынх нь хэлж байснаас тэс өөр байсныг харав. Мөн түүнчлэн тэрээр Төгс Хүчит Бурханы Чуулганы эгч нарыг биечлэн гэртээ хүлээж авч, тэд Төгс Хүчит Бурханы үгийн талаар түүнтэй нөхөрлөж, түүнд тусалж, санаа тавьдаг байжээ. Энэ эгчийн бодит туршлага надад цаашид эдгээр цуу ярианд хууртаж болохгүй, бас хов живд итгэн эцсийн өдрүүд дэх Төгс Хүчит Бурханы ажлыг судлахаас татгалзаж болохгүй гэдгийг хэлж өгсөн юм. Эс тэгвэл би Бурханы эцсийн өдрүүдийн авралыг алдаж магадгүй байв. Тэгээд би Төгс Хүчит Бурханы Чуулгантай дахин холбогдож, үргэлжлүүлэн судлах ёстой гэдгээ мэдсэн билээ!

Шөнө нь орон дотроо эргэж хөрвөж байхдаа: “Би блоклосон байгаа хэдий ч Ян эгчийг хайж олох ёстой. Хэрэв түүнийг олж чадвал би Төгс Хүчит Бурханы Чуулганы Жан ахыг гарцаагүй олж чадна. Ян эгч бол жинхэнэ итгэгч бөгөөд энэ бүх хугацаанд тэрээр Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг судалсаар ирсэн. Яг одоо тэрээр маш олон зүйлийг хэдийнээ ойлгосон байх. Түүний судалгаа хэрхэн явж байгааг би эгчээс үнэхээр асуух хэрэгтэй” гэж бодов. Амаргүй байсан боловч зарим найзынхаа тусламжтайгаар хоёр хоногийн дараа би Ян эгчийн Фэйсбүүк бүртгэлийг олов. Түүнийг блоклосонд уурлаагүйд нь би үнэхээр их баярлаж байлаа. Түүнтэй холбогдох үед тэрээр хэдийнээ олон зүйлийг судалж, тодорхой ойлгож авснаа, мөн Төгс Хүчит Бурхан бол Эзэн Есүсийн эргэн ирэлт мөн гэдгийг надад хэлэв. Бас тэрээр намайг Жан ахтай баяртайгаар холбож өгсөн юм. Бид гурав интернэтээр холбогдох үед би тэдэнд: “Саяхны туршлагаараа дамжуулан, Эзэн намайг залж чиглүүлж байгааг би харж байна. Мөн би эцсийн өдрүүд дэх Төгс Хүчит

---

Бурханы ажлыг эрж хайж, судлахыг хүсэж байна. Гэвч надад та хоёроос асуух маш олон асуулт байгаа ба та хоёрыг нөхөрлөл хийгээсэй гэж хүсэж байна. Миний үнэхээр ойлгохгүй байгаа нэг зүйл бол Есүс Өөрийн ажлыг хийхийн тулд эрэгтэй хүний бие махбодтой болсон, гэтэл одоо Тэр ажлаа хийхийн тулд яагаад эмэгтэй хүний бие махбодтой болно гэж? Энэ нууцлаг байна. Жан ах аа, та үүнийг надад тайлбарлаад өгөөч?” гэж би хэлэв.

Жан ах асуултын минь хариуд ийн хэлэв: “Тийм ээ. Бурхан бид махбодтой болох явдалд нууц агуулагддаг. Үүний ач холбогдол асар их, гүн гүнзгий бөгөөд бидний ухан ойлгож чадахааргүй зүйл билээ. Тиймээс бид Эзэний эргэн ирэлтийн тухайд хүндэлсэн зүрх сэтгэлээ хадгалах ёстой. Бурханы ажил бидний үзэл санаатай огт нийцэхгүй байсан ч гэсэн бид хэл яриагаа цэгнэх ёстой. Бид асуудалд ул суурьтай хандалгүйгээр шүүж болохгүй. Нухацтай хэлэхэд, Бурханы ажлыг дур зоргоороо шүүх нь Бурханы эсрэг доромжлол бөгөөд доромжлох гэм нүглийг энэ болон дараа дараачийн амьдралд уучилж өршөөх аргагүй юм. Эцсийн өдрүүдийн Төгс Хүчит Бурхан ирчихсэн бөгөөд бүх нууцыг тайлсан. Энэ нь Есүсийн дараах зөгнөлийг бүрэн биелүүлдэг: **‘Та нарт хэлэх зүйл Надад олон байгаа боловч та нар одоо тэдгээрийг дааж чадахгүй. Гэхдээ үнэний Сүнс болох Тэр ирэх үедээ та нарыг бүх үнэн рүү удирдана: Учир нь Тэр Өөрийн санаагаар ярихгүй; харин сонссон зүйлээ Тэр ярих болно: Мөн Тэр ирэх зүйлсийг та нарт харуулна’** (Иохан 16:12–13). Үнэний энэ талыг ойлгохын тулд Төгс Хүчит Бурханы үгийг хамтдаа уншицгаая. Төгс Хүчит Бурхан ингэж хэлсэн: **‘Тухайн үед Есүс ирэхдээ эрэгтэй байсан бол Бурхан энэ удаад ирэхдээ эмэгтэй байгаа. Үүнээс чи, Бурхан эрэгтэй болон эмэгтэй хүнийг хоёуланг нь Өөрийн ажлын төлөө бүтээснийг харж болох ба Түүнд хүйсийн ялгаа байдаггүй. Түүний Сүнс ирэхдээ Өөрийн хүссэн ямар ч махбодыг сонгон авч болох бөгөөд тэрхүү махбод Түүнийг төлөөлж чадна; эрэгтэй ч бай, эмэгтэй ч бай, Түүний махбод болсон бие мөн л бол Бурханыг төлөөлж чадна. Хэрвээ Есүс ирэхдээ эмэгтэй хүн болж гарч ирсэн бол, өөрөөр хэлбэл, Ариун Сүнснээс хүү биш, харин охин олдсон бол ажлын тэрхүү үе шат мөн л адилхан гүйцэлдэх байв. Хэрвээ тийм байсан бол ажлын одоогийн үе шатыг эрэгтэй хүн гүйцэлдүүлэх байсан, тэгсэн ч ажил мөн л адилхан хийгдэж дуусах байв. Аль ч үе шатанд хийгдсэн ажил адилхан ач холбогдолтой; ажлын аль ч үе шат давтагддаггүй, нөгөөтэйгөө ч зөрчилддөггүй. Тухайн үед, Есүс Өөрийн ажлыг хийж байхдаа цорын ганц Хүү гэж нэрлэгдэж байсан бөгөөд “Хүү” гэдэг нь эрэгтэй хүйс гэсэн утгыг агуулдаг. Тэгвэл одоогийн энэ үе шатанд яагаад цорын ганц Хүү гэж дурддаггүй вэ? Яагаад гэвэл, ажил нь Есүсийнхээс өөр хүйстэй байхыг шаардсан юм. Бурханы хувьд хүйсийн ялгаа ер байхгүй. Тэр Өөрийнхөө ажлыг хүссэнээрээ хийдэг ба ажлаа хийхдээ ямар ч**

---

хязгаарлалтад баригддаггүй, харин маш чөлөөтэй байдаг. Гэхдээ ажлын үе шат болгон өөрийн гэсэн бодит ач холбогдолтой. Бурхан хоёр удаа махбод болсон бөгөөд эцсийн өдрүүдийн үеэр бие махбодтой болдог нь сүүлчийнх гэдэг нь илэрхий юм. Тэрээр Өөрийн бүх үйл хэргийг мэдэгдэхийн тулд ирсэн. Хэрвээ энэ үе шатанд хүнд харуулах ажлаа биечлэн хийхийн тулд Тэр махбод болоогүй бол, Бурхан эмэгтэй биш, зөвхөн эрэгтэй гэсэн үзэлтэй хүн үүрд зууралдах байлаа... Анх Ехова хүн төрөлхтнийг бүтээхдээ хоёр төрлийн хүнийг буюу эрэгтэй, эмэгтэй хүнийг хоёуланг нь бүтээсэн; иймээс Түүний махбод болсон бие ч бас эрэгтэй, эмэгтэй болж хуваагддаг. Тэр Адам, Ева хоёрт хэлсэн үгэндээ үндэслэн Өөрийн ажлыг шийдээгүй. Тэр хоёр удаа махбод болсон нь бүхэлдээ, хүн төрөлхтнийг анх бүтээх үеийн Түүний бодлын дагуу тодорхойлогдсон, өөрөөр хэлбэл, ялзруулагдахаас өмнөх эрэгтэй, эмэгтэй хүнд үндэслэн Тэрээр хоёр удаа бие махбодтой болох ажлаа гүйцэтгэсэн юм’ (Үг нь махбодоор илэрсэн номын “Хоёр удаа бие махбодтой болох нь бие махбодтой болохын ач холбогдлыг гүйцээдэг”). ‘Хүйсийн хувьд нэг нь эрэгтэй, нөгөө нь эмэгтэй бөгөөд үүгээр Бурхан бие махбодтой болохын утга учрыг биелүүлж, Бурханы талаарх хүний үзлийг арилгадаг: Бурхан эрэгтэй, эмэгтэй аль нь ч болж чадах ба мөн чанартаа бол бие махбодтой болсон Бурхан хүйсгүй юм. Тэрээр эрэгтэй, эмэгтэй хүнийг хоёуланг нь бүтээсэн бөгөөд Түүний хувьд хүйсийн ялгаа байхгүй’ (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурханы оршдог махбодын мөн чанар”).”

Бурханы үгийг уншиж дууссаны дараа Жан ах ингэж нөхөрлөв: “Бурханы хийдэг бүхэн утга учиртай. Бурхан утга учиргүй, эсвэл үнэ цэнгүй юу ч хийдэггүй. Библид: ‘Ингээд Бурхан хүнийг Өөрийн дүр төрхөөр бүтээж, Бурханы дүр төрхөөр түүнийг бүтээжээ; эрэгтэй, эмэгтэй хүнийг Тэр бүтээв’ (Эхлэл 1:27) гэсэн байдаг. Анх Бурхан эрэгтэй, эмэгтэй хүнийг Өөрийн дүр төрхөөр бүтээсэн гэдгийг бид үүнээс харж болно. Бурхан эрэгтэй хүний бие махбодтой болж чадна, мөн эмэгтэй хүний бие махбодтой болж ч чадна. Бурханд хүйсийн ялгаа гэж байдаггүй; эрэгтэй, эмэгтэй хүний аль нь ч болсон бай, Тэрээр Бурханы мөн чанарыг эзэмшдэг бөгөөд Бурханы ажлыг хийж чаддаг. Бурхан хоёр удаа бие махбодтой болохдоо хоёр өөр хүйстэй болсон нь бие махбодтой болохын ач холбогдлыг гүйцэлдүүлж, Бурхан зөвхөн эрэгтэй хүний бие махбодтой болж чадна, харин эмэгтэй хүний бие махбодтой болж чадахгүй гэсэн хүний эндүү ташаа итгэл үнэмшлийг арилгахын төлөө байдаг. Энэ нь, Бурхан бие махбодтой болохдоо эрэгтэй хүний ялгамж чанарыг агуулаад зогсохгүй эмэгтэй хүний ялгамж чанарыг ч агуулж чадна гэдгийг ухаарах боломжийг хүнд олгодог. Мөн Бурхан бол үнэхээр төгс хүчит бөгөөд бид Түүнийг ойлгож чадахгүйн зэрэгцээ Бурханыг дур зоргоороо шүүж, хязгаарлах ёсгүй гэдгийг харах боломжийг хүмүүст олгодог. Түүнчлэн, Бурханы мөн чанар сүнс бөгөөд сүнснүүдэд



---

хүйсийн ялгаа байдаггүй. Хүйс зөвхөн бүтээгдсэн хүн төрөлхтөнд л хамаатай байдаг. Хүн төрөлхтнийг аварч, золин аврахын тулд Бурхан хоёр удаа бие махбодтой болсон. Тиймээс бие махбодтой болсон Бурханы хүйс нь Өөрийн ажлыг махбодоор хийж буй цаг үеэс хамаарч байдаг. Бие махбодтой болсон Бурханы газар дээрх ажил дуусмагц Бурхан сүнсний ертөнц рүүгээ буцдаг бөгөөд тэр үед ямар ч хүйсийн ялгаа байхаа болино. Тиймээс хэрэв бид Бурханыг тодорхой нэг хүйсээр хязгаарлавал энэ нь асар их доромжлол юм!”

Төгс Хүчит Бурханы үг болон Жан ахын нөхөрлөлийг сонсоод надад гэнэт гүн ойлголт төрөв. Бурхан бие махбодтой болох болгондоо яагаад өөр өөр хүйстэй болсныг би эцэст нь ойлгосон юм. Мөн хүн төрөлхтнийг анх бүтээх үеийн Бурханы хүсэл болон сайхан санаа зорилго үүнд агуулагдаж байгааг би ухаарлаа. Хэрэв Бурхан хоёр удаа бие махбодтой болох үедээ эрэгтэй хүн болж ажиллахаар ирсэн бол бид Бурханыг эрэгтэй хүн гэдэгт үүрд итгэж, эр хүйс эм хүйсээс илүү агуу бөгөөд өндөр байр суурьтай хэмээн эндүүрэн итгэх байсан юм. Эцсийн өдрүүдэд бие махбодтой болсон Бурхан эмэгтэй хүн болж ажиллаж байгаа нь Бурханы шударга, зөвт байдлын биелэл бөгөөд Бурхан энэ удаа эмэгтэй хүний бие махбодтой болж ажиллаж байгаа нь асар их ач холбогдолтой болохыг надад харуулсан юм! Эс бөгөөс, бид хэзээ ч Бурханыг ойлгохгүй байх байсан бөгөөд Бурханы талаарх бидний үзэл, хязгаарлалт хэзээ ч арилахгүй байж, улмаар энэ нь Бурханы зан чанарт халдах байжээ. Бурхан анх бие махбодтой болох үедээ эрэгтэй хүн болж гарч ирсэн бөгөөд эцсийн өдрүүдэд эмэгтэй хүн болж гарч ирсэн юм. Бурхан хоёр удаа бие махбодтой болсон нь Бурхан бие махбодтой болохын бүрэн гүйцэд утга учрыг бидэнд үнэхээр харуулдаг; энэ нь надад Бурханы талаар илүү үнэн зөв, илүү бодитой ойлголтыг өгсөн юм. Бурханд талархъя! Бурханы ажил үнэхээр ухаалаг юм!

Ян эгч, Жан ах хоёр Бурханы үгийн талаарх ойлголт, мэдлэгийг минь сонссоныхоо дараа Бурханы хүслийг ойлгож, Бурханы талаарх үзэл, буруу ойлголтоо арилгаж чадсанд минь баярлаж байв. Бурхан над дээр авралын ажил хийсэнд тэдний сэтгэл хөдлөн уйлцгаав. Дараа нь бид дахиад гурван удаа нөхөрлөсөн юм. Удирдамжийнх нь төлөө Бурханд талархъя. Би илүү их үнэнийг ойлгож, Бурхан бие махбодтой болохын нууцыг олж мэдэж, Бурханы ажлын гурван үе шатны нууцыг мэдэж авсан юм. Мөн Бурханы ажил ба хүний ажлын хоорондох ялгаа, Ариун Сүнсний ажил ба Сатаны ажлын хоорондох ялгаа болон үнэний бусад талыг мэддэг болов. Төгс Хүчит Бурхан бол Эзэн Есүсийн эргэн ирэлт бөгөөд Тэр бол үнэн, зам, амь гэдгийг үнэхээр мэдэрч чадсан юм. Тэрхүү Бямба гарагийн орой Ян эгч надад “Бурханы хайр зүрх сэтгэлийг минь хүрээлдэг” нэртэй шинэ дууны клип явуулав: “Бурханыг үнэхээр хайрлагсдыг төгөлдөршүүлэхийн тулд Бурханы хүсэл илчлэгдсээр байна. Амьд цоглог, гэм буруугүй хүмүүс ээ, Бурханд магтаал өргөцгөөе,

---

Үнэн Бурханы эргэн тойронд хамтдаа, сайхан бүжгүүд бүжицгээе. Хүмүүс бүгд Бурханы дуу хоолойгоор, өөр өөр газраас эргэн дуудагдсан. Амийн үгс бидний дээр өгөгдсөн. Бид Бурханы шүүлтийн үгсээр ариусгагддаг.” Энэ дуу намайг маш их зоригжуулсан болохоор сэтгэл хөдлөн уйллаа. Би Ян эгчийн дугаар луу залгасан ч сэтгэл хөдлөлдөө автан юу ч ярьж чадсангүй. “Бурханд талархъя! Баярлалаа...” гэх үгийг л ахин дахин хэлэхээс өөрийг хийж чадахгүй байлаа.

Тэр шөнөдөө миний сэтгэл хөдлөл жаахан дарагдах үед би ах, эгч хоёртой чин сэтгэлийн яриа өрнүүлэв. Төгс Хүчит Бурхан энэ хугацаанд намайг аврах тал дээр бууж өгөөгүйд, бас эсэргүүцэл, тэрслүү байдал дээр минь үндэслэн надад хандаагүйг би баярлаж байсан юм. Харин ч Тэрээр үргэлж надтай хамт байжээ. Тэрээр намайг чиглүүлж, бага багаар сэтгэлийг минь хөдөлгөхийн тулд сайн мэдээний кино, видео, ах эгч нарын туршлагын тухай нийтлэлүүдийг ашиглан, намайг Өөрийн гэр болон Өөрийн өмнө буцааж авчирсан байв. Би ах эгч хоёрт хандан, зүрх сэтгэлийнхээ гүнээс: “Би Бурханы хайрыг хэдийн мэдэрсэн, бас Бурхан бие махбодтой болох тухай үнэнийг ойлгодог. Би хов жив, цуу ярианд дахин хэзээ ч итгэхгүй. Би Төгс Хүчит Бурханыг өөрийн Аврагч, өөрийн Бурхан гэж бүрэн хүлээн зөвшөөрч байна. Учир нь Төгс Хүчит Бурхан бол Эзэн Есүсийн эргэн ирэлт, намайг маш их нигүүлслээр хангасан Бурхан, хүн төрөлхтний Золин Аврагч гэж би аль хэдийн тогтоосон” гэж хэллээ.

Урьд нь цуу яриа сонсож, Бурханы эцсийн өдрүүдийн ажлын талаар дотроо зөрчилдөж, бүр Бурханыг шүүмжилсэн үг хэлж, тун тэрслүү байснаа эргээд бодох үед Бурханд асар их өртэй мэт санагдан, санаа зовж, харамсаж байлаа. Гэвч Ян эгч надад хандан: “Бурханыг мэдэхгүй байх үедээ хүмүүс бид худал хуурмагт амархан хууртдаг. Бид үнэхээр гэмшиж байгаа цагт Бурхан үүнийг санахгүй. Бурханы үгэнд ингэж хэлдэг: **‘Бурхан энэ удаа хүмүүсийг ниргэхээр ирээгүй, харин ч аль болох олон хүнийг аврах гэж ирсэн. Ямар ч алдаа дутагдалгүй хүн гэж хэн байна вэ? Хэрэв хүн бүрийг ниргэх юм бол үүнийг яаж аврал гэж нэрлэх юм бэ? Зарим гэм бурууг санаатайгаар хийсэн байдаг бол зарим гэм бурууг санамсаргүй хийсэн байдаг. Санамсаргүй хийгдсэн зүйлсийн хувьд чи тэдгээрийг ухамсарлаж ойлгосны дараа өөрчилж болно. Тиймээс Бурхан чамайг өөрчлөгдөхөөс өмнө ниргэнэ гэж үү? Ийм байдлаар Бурхан хүмүүсийг авардаг гэж үү? Ийм зүйл байдаггүй! Чи санамсаргүй эсвэл тэрслүү уг чанараараа гэм буруу үйлдсэн эсэхээс үл хамааран үүнийг санаж ав: Бушуу түргэн бодит байдлыг ухамсарла! Урагшаа зүтгэ. Ямар ч нөхцөл байдал гарч ирэх нь хамаагүй чи урагшаа зүтгэх ёстой. Бурхан хүмүүсийг аврах гэж ажиллаж байна. Тэр Өөрийн аврахыг хүсэж байгаа хүмүүсийг сохроор ниргэхгүй’”** (Христийн ярианы тэмдэглэл номын “Бурханы хүсэл бол хамгийн дээд боломжит хэрээр хүмүүсийг аврах”). Бурханы үг надад

---

асар их тайвшрал өгч, Бурхан өршөөл, уучлалаар дүүрэн гэдгийг олж харах боломж олгосон юм. Бурханы хайр маш агуу! Зүрх сэтгэл дотроо мэдэрдэг Бурханд талархах сэтгэлээ би барьж чадахгүй нь. Хожим нь би Төгс Хүчит Бурханы Чуулганы ах эгч нартай холбогдсоноор дамжуулан тус чуулган цуу ярианд хэлж байсантай огт адилгүй гэдгийг харж чадсан юм. Үнэндээ энэ нь шал эсрэгээрээ байв. Энэ бол бидний хувьд үнэнийг эрэлхийлж, Бурханыг мэдэх газар байлаа. Төгс Хүчит Бурханы Чуулганд цуглаан хийх үед хэн ч идэж, уух, баясаж цэнгэх талаар ярьдаггүй; хэн ч машин, мөнгө, орон байрны талаар ярьдаггүй; мөн хэн ч дэлхий дээрх бохир, заваан, ёрын муу зүйлсийн талаар ярьдаггүй байв. Харин бид бүгд Төгс Хүчит Бурханы үгийг хамтдаа уншиж, Бурханы үгийн талаарх өөрсдийн туршлага, мэдлэгээ нөхөрлөдөг байсан юм. Бид Төгс Хүчит Бурханы үгийг хэрэгжүүлж, дагаж мөрддөг. Төгс Хүчит Бурханы Чуулган дотор Бурханы үг, үнэн болон Христ эрх мэдэл эзэмшдэгийг би харж байна. Энэ бол эрх тэгш, зөвт байдлаар дүүрэн газар юм. Шинэ тэнгэр, газар дахь үзэсгэлэнтэй сайхан амьдралыг амсаж байгаа мэт надад санагдаж байна! Одоо тэдгээр цуу яриаг эргээд бодоход тэдгээр нь хүмүүсийг урхидаж, хор хөнөөл учруулахаас цаашгүй болохыг ухаардаг. Тэдгээр цуу ярианы улмаас би Бурханы эцсийн өдрүүдийн авралыг бараг л алдах дөхсөн. Азаар Төгс Хүчит Бурхан намайг аварч, Бурханы ажлын талаар ойлголттой болох боломж олгосон. Миний сүнс сэрж, би Сатаны цуу ярианы орооцолдсон торыг сэт цохиж, Бурханы сэнтийн өмнө ирсэн. Намайг аварсных нь төлөө би Бурханд талархаж байна!

## **5. Хэрэн хэсүүчилсэн зүрх сэтгэл гэртээ харилаа**

Ново, Филиппин

Миний нэрийг Ново гэдэг, би Филиппин хүн. Би бага байхаасаа л ээжийгээ даган Бурханд итгэж, ах эгч, дүүстэйгээ хамт номлол сонсохоор чуулганд явдаг байлаа. Эзэнд олон жил итгэсэн хэдий ч надад ямар ч өөрчлөлт гараагүй, үл итгэгчтэй адил мэт санагддаг байв. Зүрх сэтгэлдээ би, илүү их мөнгө олж, өдөр хоногуудаа тав тухтай өнгөрөөж, сайхан амьдрах тухай байнга боддог байв. Цаашлаад цаг үргэлж найзуудтайгаа гарч уудаг байсан бөгөөд мөнгө байх л юм бол мөрийтэй тоглодог байлаа. Эдгээр зүйлийг хийх нь Эзэний хүсэлтэй нийцдэггүй гэдгийг би мэддэг байсан бөгөөд Эзэнд байнга залбирч, нүглээ улайн, энэ муу зуршлуудаа орхиж, тэрхүү өдрөөс эхлээд дахин хэзээ ч нүгэл үйлдэхгүй хэмээн бат шийддэг байсан юм. Гэвч найзууд зулгуйдан ятгаж, уруу татахад өөрийгөө хянаж чаддаггүй байлаа. Ийнхүү би улам бүр доройтож, зүрх сэтгэл минь Бурханаас улам холдон, чин сэтгэлээсээ залбирахаа болив. Долоо хоног бүр би хэдхэн энгийн залбирал хэлээд л болчихдог боллоо. Эзэн эргэж ирэх үедээ хүн нэг бүрийг

---

үйлдэл, зан авирынх нь дагуу шүүгээд, дараа нь тэнгэр өөд явах уу, там руу явах уу гэдгийг нь шийднэ гэж мэдэж байсан болохоор би заримдаа үнэхээр цөхөрдөг байв. Би ихэд доройтсон учраас Бурхан намайг дахин уучлахгүй гэж надад санагдсан юм. Хожим нь би гэрлэж, хүүхдүүдтэй болоод, эхнэр, хүүхдүүддээ л боддог болов. Би итгэлээ аль хэдийн сэтгэлийнхээ мухарт мартсан байлаа. Хүүхдүүдээ илүү дээр ирээдүйтэй болгож, баян болох хүслээ биелүүлэхийн тулд би гадаад явж ажиллахаар шийдээд Тайваньд ирэв. Ажилтай болсныхоо дараа ч гэсэн би амьдралын хэв маягаа өөрчилсөнгүй. Завтай цагаараа хамт ажиллагсадтайгаа цуг гадагшаа гарч, ууж, каракед дуулан, зугаа цэнгэлийн амьдралаар амьдарч байв. Тэгээд Бурханд итгэх итгэлээ аль эрт мартсан байлаа.

2011 онд би Тайванийн нэг үйлдвэрт гагнуурчнаар ажиллаж байсан юм. 2012 оны нэг өдөр Тайваньд хамт ажилладаг хүн маань намайг Католик шашинтай гэдгийг мэдээд сүмийнхээ мөргөлд урилаа. Тэгээд нэг ням гарагийн өглөө тэрээр үйлдвэр дээр ирж намайг аваад, найзынхаа гэрт аваачив. Тэнд би Иосеф ахтай уулзсан юм. Тэрээр надаас: “Ах аа, та Эзэн Есүсийн хоёр дахь ирэлтэд итгэдэг үү?” гэж асуулаа. Би тийм ээ гэхэд ах надаас: “Эргэн ирэх үедээ Эзэн Есүс ямар ажил хийхийг та мэдэх үү?” гэж асуув. “Эзэн Есүс эргэж ирэх үедээ агуу цагаан сэнтийд заларч, хүн төрөлхтнийг шүүнэ. Хүн бүр шүүх суудлын өмнө өвдөг сөгдөн нүглээ улайна, дараа нь Эзэн тэдний үйлдэл, үйл хэрэгт үндэслэн тэнгэр лүү явах уу, там руу явах уу гэдгийг нь шийднэ” гэж би хариулсан юм. Иосеф ах үргэлжлүүлэн “Хэрвээ бид танд Эзэн Есүс аль хэдийн ирчихээд одоо эцсийн өдрүүдийн шүүлтийн ажлаа хийж, улмаар **‘шүүлт Бурханы гэрээс эхэлдэг’** гэх зөгнөлийг биелүүлж байгаа гэвэл та итгэх үү?” гэж надаас асуув. Ингэж хэлэхийг нь сонсоод би нэлээд гайхлаа. “Эзэн Есүс аль хэдийн эргээд ирсэн гэж үү? Яаж ингэж болох билээ? Агуу цагаан сэнтий тэнгэрт харагдахыг би хараагүй, Эзэн үүлэн дээр бууж ирэхийг бас хараагүй. Гэтэл ах надад, Эзэн шүүлтийн ажлаа хийхээр аль хэдийн эргэн ирээд, улмаар **‘шүүлт Бурханы гэрээс эхэлдэг’** гэх зөгнөлийг биелүүлж байгаа гэж хэлж байна. Энэ нь ортой юм. Бурханы мэргэн ухааныг хүн ойлгошгүй тул эрж хайсан минь дээр юм байна” гэж би бодлоо. Тэгээд би: “Ах аа, Эзэн Есүс эргэн ирсэн үү, үгүй юу гэдгийг би хэлж зүрхлэхгүй, тиймээс үүнийг надтай нөхөрлөөч” гэж хариулсан юм. Тэгэхэд тэд Эзэний эргэн ирэлт болон Эзэн шүүлтийн ажил хийхтэй холбоотой хэд хэдэн хэсгийг Библиэс олоод, надад уншиж өглөө. Тухайлбал, Петрийн 1 дэх захидлын 4-р бүлэг, 17-р эшлэлд: **‘шүүлт Бурханы гэрээс эхлэх цаг болжээ’** гэж байв. Бас Иоханы сайн мэдээний 16-р бүлгийн 12–13-р эшлэлд: **“Та нарт хэлэх зүйл Надад олон байгаа боловч та нар одоо тэдгээрийг дааж чадахгүй. Гэхдээ үнэний Сүнс болох Тэр ирэх үедээ та нарыг бүх үнэн рүү удирдана: Учир нь Тэр Өөрийн санаагаар ярихгүй; харин сонссон зүйлээ Тэр ярих болно: Мөн Тэр ирэх зүйлсийг та нарт харуулна”** гэдэг. Иосеф ах, энэ

---

“Үнэний Сүнс” гэдэг нь Эзэн эргэн ирээд, үнэнийг илэрхийлж, шүүлтийн ажлаа хийж байгааг хэлдэг гэсэн юм. Эцсийн өдрүүдийн Бурхан хүний Хүү болоод махбодод эргэн иржээ. Хуулийн эрин үе дэх золин авралынхаа ажлын суурин дээр Тэр үнэнийг илэрхийлж, Бурханы гэрээс эхлэн шүүлтийн ажлаа хийдэг. Үнэн хэрэгтээ, шүүлтийн энэ ажил нь хүнийг бүрмөсөн ариусгаж, аврах ажил юм. Энэ нь Эзэн Есүсийн: **“Хэрвээ Миний үгийг сонсоод баримталдаггүй хүн байвал Би түүнийг шүүхгүй: учир нь Би дэлхий ертөнцийг шүүхийн тулд биш харин аврахын тулд ирсэн билээ. Намайг голж, Миний үгийг хүлээж авдаггүй хүнийг шүүх шүүгч байдаг: Миний хэлсэн үгс түүнийг эцсийн өдөр шүүх болно”** (Иохан 12:47–48). **“Учир нь Эцэг ямар ч хүнийг шүүдэггүй, харин бүх шүүлтийг Хүүдээ даатгасан билээ... Тэр хүний Хүү болохоор шүүлтийг гүйцэтгэх эрх мэдлийг ч Түүнд өгсөн”** (Иохан 5:22–27) гэх зөгнөлийг яг таг биелүүлдэг. Би ахын нөхөрлөлийг анхааралтай сонссон бөгөөд надтай хуваалцаж буй эдгээр зүйл нь үнэн гэдэгт итгэсэн юм, учир нь Эзэний бүх зөгнөл биелж, гүйцэлдэх ёстой гэдэгт би итгэдэг байв.

Дараа нь Иосеф ах “Христ шүүлтийн ажлыг үнэнээр хийдэг” хэмээх Төгс Хүчит Бурханы үгээс хоёр хэсгийг уншиж өглөө: **“Шүүлтийн ажил бол Бурханы Өөрийн ажил тул мэдээж үүнийг Бурхан Өөрөө хийх ёстой; хүн Түүний оронд хийж чадахгүй. Шүүлт бол үнэнийг ашиглан хүн төрөлхтнийг байлдан дагуулах явдал учраас, энэ ажлыг хүмүүсийн дунд хийхээр Бурхан дахиад л бие махбод болсон дүрээрээ гарч ирэх нь дамжиггүй юм. Өөрөөр хэлбэл, эцсийн өдрүүдэд Христ газар дэлхий даяарх хүмүүсийг сургахын тулд үнэнийг ашиглаж, бүх үнэнийг тэдэнд мэдэгдэнэ. Энэ бол Бурханы шүүлтийн ажил юм.”** “Эцсийн өдрүүдэд Христ хүнийг сургах, хүний мөн чанарыг ил болгох, хүний үг болон үйлдэлд нь дүн шинжилгээ хийхийн тулд төрөл бүрийн үнэнийг хэрэглэдэг. Хүний үүрэг, хүн яаж Бурханд дуулгавартай байх ёстой, хүн яаж Бурханд үнэнч байх ёстой, хүн яаж хэвийн хүн чанарыг амьдран харуулах учиртай болон Бурханы мэргэн ухаан, зан чанар гэх зэрэг төрөл бүрийн үнэн эдгээр үгэнд агуулагддаг. Эдгээр үг нь бүгд хүний мөн чанар болон ялзарсан зан чанар луу чиглэдэг. Ялангуяа, хүн Бурханыг хэрхэн голдгийг илчилсэн үгсийг хүн бол Сатаны биелэл, Бурханы эсрэг дайсны хүч болдог тухайд хэлсэн байдаг. Шүүлтийн ажлаа хийхдээ Бурхан хүний уг чанарыг ердөө хэдхэн үгээр тодорхой болгодог юм биш; Тэрээр удаан хугацааны туршид илчилж, харьцаж, засдаг. Илчлэл, харьцалт болон засалтын эдгээр аргыг энгийн үгээр бус, харин хүнд огт байдаггүй үнэнээр л орлуулж болно. Зөвхөн ийм төрлийн арга барицыг л шүүлт гэж нэрлэж болно; ийм төрлийн шүүлтээр л дамжуулан хүн номхорч, Бурханд захирагдахаар бүрэн үнэмшээд зогсохгүй, Бурханы тухай жинхэнэ мэдлэгийг олж авч чаддаг. Шүүлтийн ажлын

---

**авчирдаг зүйл гэвэл Бурханы жинхэнэ дүр төрх болон өөрийнх нь тэрслүү байдлын үнэний талаарх хүний ойлголт юм. Шүүлтийн ажил нь хүнд Бурханы хүслийн тухай, Бурханы ажлын зорилгын тухай, хүний ойлгошгүй нууцуудын тухай ихээхэн ойлголт олж авах боломж олгодог. Түүнчлэн, өөрийн ялзарсан мөн чанар болон ялзралынхаа үндсийг таньж мэдэх, хүний муу муухайг нээн илрүүлэх боломжийг олгодог. Энэ бүх үр дүнг шүүлтийн ажил авчирдаг, учир нь энэ ажлын мөн чанар нь үнэндээ Бурханы үнэн, зам, амийг Түүнд итгэдэг бүх хүнд нээх ажил юм. Энэ ажил нь Бурханы хийдэг шүүлтийн ажил билээ” (“Үг нь махбодоор илэрсэн” ном).**

Эдгээр үгийг уншсанахаа дараа Иосеф ах Бурханы эцсийн өдрүүдийн шүүлтийн ажлын талаарх олон үнэнийг надтай нөхөрлөв. Бурханы ажил маш бодитой, огтхон ч ер бусын биш бөгөөд Бурханы эцсийн өдрүүдийн шүүлтийн ажил миний төсөөлсөнтэй огт адилгүй гэдгийг би ойлгож авсан юм. Бурхан агаарт аварга том ширээ тавиад, агуу цагаан сэнтийд заларч, бүх хүн төрөлхтөн Түүний өмнө өвдөг сөгдөнө. Тэгээд Бурхан сайн муу байсан эсэхийг маань тогтоож, тэнгэр лүү явах уу, там руу явах уу гэдгийг маань шийдэхийн тулд бидний нүглийг нэг нэгээр нь жагсаана гэж би төсөөлдөг байв. Гэтэл харин, үнэнийг бодитой байдлаар илэрхийлж, хүний нүглийг шүүн, хүний завхралын үнэн болон хүний уг чанар, мөн чанарыг ил болгохын тулд Бурхан махбод болж, дэлхий ертөнцөд иржээ. Иосеф ах цааш нь үргэлжлүүлэн нөхөрлөж, ариусгагдахын тулд биеэ тоосон, өөрийгөө чухалчилдаг зан, шударга бус, зальхай, аминч, өөдгүй зан гэх мэт сатанлаг зан чанар маань бүгд Бурханы шүүлтийг туулах ёстой гэж бидэнд хэллээ. Бид бузар булай байдал, завхрал, балиар муухай, хорон муу байдлаа харж, Бурханыг эсэргүүцэн, Бурханаас урвадаг мөн чанараа харж, Сатан биднийг маш гүн гүнзгий завхруулж, бид сатанлаг зан чанараар дүүрч, Сатаны биелэл болсон бөгөөд мөхөх ёстой гэдгээ харах нь Бурханы шүүлтийн ажлын эцсийн үр дүн юм. Ийм маягаар л бид өөрсдийгөө үзэн ядаж, хараах болж, Сатаныг нэгмөсөн хаяж чадна. Түүнчлэн, Бурханы үгийн шүүлт, гэсгээлт дотроос бид Бурханы зөвт, ариун, халдашгүй зан чанарыг мэдэж авч болох юм. Тэгээд бид өөрийн мэдэлгүй Бурханаас эмээх зүрх сэтгэлтэй болох ба дахин хэзээ ч Бурханыг болчимгүйгээр эсэргүүцэж, Түүнд дуулгаваргүй хандаж зүрхлэлгүй, махан биеэ хаяж, үнэнийг хэрэгжүүлж чадна. Амь зан чанар маань өөрчлөгдмөгц бид үнэхээр Бурханыг дуулгавартай дагаж, шүтэн мөргөж чадна. Тэгээд эцсийн өдрүүдэд Бурханы илэрхийлсэн үнэний янз бүрийн талыг олж авмагц Бурхан биднийг бүрмөсөн ариусгаж, аварч, Өөрийнхөө хаанчлал руу аваачна. Бурханы эцсийн өдрүүдийн шүүлтийн ажлыг хүлээн зөвшөөрөхөөс татгалздаг хүмүүс Бурханы ариусгалтыг олж авч чадахгүй—эцэст нь тэд Бурханы ажлаар таягдан хаягдахаас аргагүй бөгөөд аврагдаж, тэнгэрийн хаанчлалд орох боломжоо алдсан байх болно. Иосеф ахын нөхөрлөлийг сонсоод би,

---

хүнийг аврах Бурханы ажил үнэхээр үнэн, бодитой болохыг мэдэрсэн юм!

Би Эзэнд маш олон жил итгэснээ, мөн Эзэнд байнга нүглээ улайж, гэмшиж байсан хэдий ч үргэлжлүүлэн нүгэл үйлдэж, худал хэлж, хууран мэхэлж, шударга бус, зальхай байж, өөрийгөө ихэд чухалчилдаг, биеэ тоосон, өөрийгөө зөвтгөдөг сатанлаг зан чанараа бүр ч олон удаа илчилж байснаа бодлоо. Би нүгэл үйлдээд, түүнийгээ улайдаг, нүглээ улайгаад, нүгэл үйлддэг мөчлөгт байнга амьдарч—тийм зовлон шаналал дунд амьдарч байсан юм. Бурхан эцсийн өдрүүдийн шүүлт, ариусгалтын ажлаа хийхээр одоо ирсэн бөгөөд энэ нь завхарсан хүн төрөлхтөнд үнэхээр их хэрэгтэй. Эзэнд итгэдэг, нүглээ уучлуулсан хүмүүст эцсийн өдрүүд дэх Бурханы шүүлтийн ажлын ариусгалт мөн л хэрэгтэй байдаг. Библид: “Ариун байдалгүйгээр хэн ч Эзэнийг харахгүй” (Еврей 12:14) гэж хэлдэг. Эзэн бол ариун. Бид нүглээ л уучлуулсан боловч нүгэлт уг чанар, сатанлаг зан чанар маань ариусгагдаагүй бол хэдийд ч нүгэл үйлдэж, Бурханыг эсэргүүцэж, байнга гомдоллож, бүр Бурханаас ч урвах чадвартай хэвээр байгаа. Тийм бузар булай, завхралаар дүүрсэн бид яаж Эзэний царайг харах эрхтэй байх юм бэ? Тэр үед л би, эцсийн өдрүүд дэх Бурханы шүүлтийн ажил хэр их чухал болохыг зүрх сэтгэлдээ мэдэрсэн билээ! Хүмүүсийн үзэл, төсөөллийн дагуу Эзэн ирээд, Өөртэйгээ уулзуулахаар хүн бүрийг агаарт гаргасан бол тун бодит бус байх байжээ! Иосеф ах дараа нь, Бурханы шүүлт, гэсгээлтийг хэрхэн хүлээн авсан тухай өөрийнхөө туршлага, гэрчлэлийг надтай нөхөрлөсөн юм. Түүний нөхөрлөл Ариун Сүнсний гэгээрэл, гэрэлтүүлэлтийг агуулж байгааг би үнэхээр мэдэрлээ. Үүнийг сонсоход үнэхээр сургамжтай байсан бөгөөд Эзэн Есүс үнэхээр ирчихсэн байж таарна гэж би итгэсэн юм. Тиймээс, Эзэнийг ирэхэд угтан авах боломжоо алдахгүйн тулд би Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг эрж хайж, судлахаар шийдлээ.

Дараа нь Иосеф ах надад “Үг нь махбодоор илэрсэн” номыг өгч, би үнэхээр их баярлав. Тэгээд орой нь байрандаа очсоныхоо дараа Бурханы үгийг уншиж эхэлсэн ба бүхэл шөнөжингөө уншлаа. Би Төгс Хүчит Бурханы энэ үгийг уншсан юм: **“Ам чинь хууран мэхлэлт, бузар булай, урван тэрслэлт, биеэ тоосон үгээр дүүрсэн байдаг. Та нар Надад чин сэтгэлийн үг, ариун үг, Миний үгийг туулснаар Надад захирагдсан үгийг хэзээ ч хэлж байгаагүй. Эцэст нь, та нарын итгэл ямар вэ? Та нарын зүрх сэтгэлд ердөө хүсэл, мөнгө л байдаг, оюун ухаанд чинь материаллаг зүйл л байдаг. Өдөр бүр Надаас ямар нэгэн зүйлийг яаж авахаа тооцоолдог. Өдөр бүр Надаас хэчнээн их эд баялаг, хэчнээн их материаллаг зүйл олж авснаа тоолдог. Өдөр бүр, илүү ихийг, илүү өндөр стандартыг эдлэхийн тулд та нар бүр ч их ерөөл өөрсөд дээр чинь бууж ирэхийг хүлээдэг. Хором бүрд та нарын бодол санаанд Би биш, Надаас ирдэг үнэн ч биш, харин та нарын нөхөр, эхнэр, хөвгүүд, охид болон идэж, өмсдөг эд зүйлс чинь байдаг. Та нар яаж бүр их, дээд зэргийн таашаал авч болох талаар л**

---

**боддог. Гэвч гэдсээ хагартал чихсэн ч та нар цогцос хэвээр бус уу? Гаднаа үнэхээр сайхан хувцсаар өөрсдийгөө гоёсон ч гэсэн, алхаж яваа амьгүй цогцос хэвээр бус уу? Та нар ходоодныхоо төлөө үсээ бууралтгал шаргуу ажилладаг ч, Миний ажлын төлөө ширхэг үс ч золиосолдоггүй. Та нар байнга завгүй байж, махан биеийнхээ төлөө, охид хөвгүүдийнхээ төлөө биеэ зүдрээж, тархиа гашилгадаг ч—нэг нь ч Миний хүслийн төлөө санаа зовниж, сэтгэл түгшдэггүй. Та нар Надаас юу олж авна гэж найдсаар байгаа юм бэ?”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Дуудагддаг нь олон ч сонгогддог нь цөөхөн”).

Эдгээр үг яг л миний амьдралын нөхцөл байдлыг илчилж, зүрх сэтгэлд минь яг ямар санагддагийг илчилсэн байлаа. Мөн хөшүүн зүрх сэтгэлийг минь зүсэх давхар иртэй илд мэт байв. Бурхан л хүний зүрх сэтгэлийн гүнийг шинжилж чадна, Бурхан л хүн төрөлхтний завхралын үнэнийг болон хүний дотор гүн нуугдсан зүйлсийг илчилж чадна гэдгийг би мэдэж байлаа. Эдгээр үг бол Ариун Сүнсний айлдвар, Бурханы дуу хоолой мөн гэж санагдсан юм. Би Эзэнд олон жил итгэж, байнга нүглээ улайж, гэмшиж байсан хэдий ч нүгэлт уг чанар, сатанлаг зан чанар маань ариусгагдаагүй, огтхон ч өөрчлөгдөөгүй гэдгийг Бурханы үгээс мэдэж авлаа. Би Эзэний нэрийг л хүлээн зөвшөөрч байсан боловч зүрх сэтгэлд минь Эзэнд зориулсан зай байсангүй, би Эзэний төлөө өөрийгөө зарлагадаж, ажилласан ч үгүй. Би байнга л яаж илүү их мөнгө олох, махан биеийн зугаа цэнгэлээ хэрхэн ихэсгэх, гэр бүлийнхнээ хэрхэн чинээлэг амьдруулах талаар л анхаарч байсан болохоос Бурханы хүслийг ч нэг ч удаа хайхарч байсангүй. Худал хэлж, байнга нүгэл үйлдэж байгаагаа ч мэддэг байсан боловч энэ талаар ер бодож байсангүй. Бурхан үүрд элэгсэг, үүрд өршөөнгүй байдаг ба намайг нүгэл үйлдсэн ч гэсэн нүглийг минь уучилж, өршөөнгүй хандаж, намайг ерөөнө гэж үргэлж итгэдэг байлаа. Эцсийн өдрүүдэд Бурханы илэрхийлсэн эдгээр айлдварыг уншсанахаа дараа л би Бурханы зөвт, ариун зан чанарыг харсан бөгөөд Бурханы зан чанарт хэн ч халдаж болохгүй гэдгийг мэдсэн билээ. Бурханы үгийн шүүлт, гэсгээлт миний дотор Түүнийг хүндлэх хүндлэл төрүүлж, би урьдын байдалдаа маш их харамссан юм. Тэгээд Бурханы өмнө унаж, гашуунаар ийн уйллаа: “Өө Бурхан минь, би Таны эсрэг тэрсэлж, олон зүйл дээр Таныг хуурч, эсэргүүцсэн бөгөөд Таны өмнө очиход зохисгүй. Хийсэн бүхэнд минь шийтгэл л тохирно. Өө Бурхан минь, надад гэмшиж, аврагдах боломж өгсөнд баярлалаа. Одооноос эхлээд би үнэнийг эрэлхийлж, үүргээ сайн гүйцэтгэж, Таны хайрыг хариулахын тулд чадах бүхнээ хийнэ.” Залбирсныхаа дараа би өөрийн энэ шийдвэрийг бататгалаа: Би Бурханы шүүлтийг хүлээн авч, нүгэл үйлдээд, нүглээ улайдаг амьдралаа өөрчлөх ёстой; илүү их үнэнийг ойлгож, махан биеэ хаях хүчтэй болж, үнэнийг хэрэгжүүлж, Бурханы хүслийг хангахын тулд Бурханы үгийг улам их уншиж, тунгаан бодох ёстой.



---

Тэр үеэс хойш би, ажлынхаа завсарлагаар Бурханы үгийг уншиж, тунгаан бодохын тулд “Үг нь махбодоор илэрсэн” номыг ажилдаа авч явах болов. Төгс Хүчит Бурханы үгээс би ааш авир, бодол санаа минь хэчнээн завхарсан, тэрслүү болохыг харсан юм. Дараа нь би Бурханы эдгээр үгийг уншлаа: **“Чиний залбирал алхам алхмаар, зүрх сэтгэлийн чинь жинхэнэ байр байдал, Ариун Сүнсний ажлын дагуу байх ёстой; мөн Бурханы хүсэл болон хүнээс шаарддаг шаардлагад нийцүүлэн Бурхантай ярилцах ёстой. Чи залбирлаа хэрэгжүүлж эхлэх үедээ эхлээд зүрх сэтгэлээ Бурханд өг. Бурханы хүслийг ухаарахаар бүү оролд, харин зүрх сэтгэл доторх үгээ Бурханд хэлэх гэж л хичээ. Бурханы өмнө очих үедээ ингэж хэл: ‘Өө Бурхан минь! Танд би дуулгаваргүй байдаг байснаа өнөөдөр л ухаарлаа. Би үнэхээр завхарсан бөгөөд жигшүүртэй. Би амьдралаа хий дэмий өнгөрөөсөөр иржээ. Өнөөдрөөс эхлээд би Таны төлөө амьдарна. Би утга учиртай амьдралыг амьдран харуулж, Таны хүслийг хангалуун байлгана. Таны Сүнс үргэлж миний дотор ажиллаж, намайг үргэлж гэрэлтүүлж, гэгээрүүлэх болтугай. Би Таны өмнө хүчтэй, цангинасан гэрчлэл хийе. Биднээс харагддаг Таны алдар, Таны гэрчлэл, Таны ялалтын баталгааг Сатанд хараг.’ Ийм маягаар залбирах үед зүрх сэтгэл чинь бүрмөсөн чөлөөлөгдөнө. Ийм маягаар залбирснаар зүрх сэтгэл чинь Бурханд илүү ойртоно, ийм маягаар байнга залбирч чадвал Ариун Сүнс чиний дотор гарцаагүй ажиллана”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Залбирлыг хэрэгжүүлэх тухай”). Бурханы үгээс би завхарсан зан чанарыг минь шийдвэрлэх хэрэгжүүлэлтийн замыг олсон бөгөөд Бурханд чин үнэнч сэтгэлээр залбирч, завхарсан зан чанарынхаа талаар сэтгэлээ нээж, зүрх сэтгэлдээ юунд хүрэхээр найдаж байгаа тухайгаа Бурханд хэлдэг болж эхэллээ. Би Бурханы үгийн дагуу амьдрахын тулд намайг залж чиглүүлэхийг Бурханаас гуйсан юм. Иймэрхүү залбирлаар дамжуулан Бурхан намайг удирдаж, гэгээрүүлж байгаа нь үргэлж мэдрэгддэг байсан ба зүрх сэтгэл минь итгэл, хүч чадлаар дүүрлээ. Би урьдынх шигээ амьдрахаа больж, зүрх сэтгэлдээ тээж байсан завхарсан бодол, санаандаа нийцүүлэн үйлдэхээ ч болив. Миний амьдрал өөрчлөгдсөн; энэ нь нүгэл үйлдээд, нүглээ улайдаг урьдын доройтсон амьдрал байхаа больсон, харин ч би үнэхээр Бурханы өмнө амьдарч, Бурханы халамж, хамгаалалтыг олж авсан билээ.

2014 оны 7-р сард би Филиппин рүү буцсан бөгөөд тэр үед л би Бурхан Филиппин дэх маш олон ах эгчийг ч бас сонгосон гэдгийг мэдсэн юм. Би үнэхээр их баярлаж байлаа. Одоо би Бурханы үгийг чуулганы ах эгч нартайгаа нөхөрлөдөг, бид чуулганы амьдралаар амьдарч, бие биедээ тусалж, дэмждэг. Бид бүгд үнэнийг эрэлхийлдэг; бас зан чанараа өөрчилж, Бурханаар авруулахаар чармайдаг. Бид бас Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг өөрийн орны хүмүүс болон бусад орны хүмүүст гэрчилдэг, ингэснээр

---

тэд Эзэн Есүс аль хэдийн эргэн ирсэн гэдгийг мэдэж, бидэнтэй адилаар Бурханы эцсийн өдрүүдийн авралыг хүртэж болох юм. Төгс Хүчит Бурханд талархъя! Одоо би тун баялаг, аз жаргалтай амьдралаар амьдардаг. Урьдын доройтож, гажуудсан амьдралаасаа бүрэн ангижирсан. Амьдралын зорилго, зүг чигээ олж авахад минь Төгс Хүчит Бурхан л намайг хөтөлсөн юм. Энэ бол утга учиртай амьдралаар амьдрах цорын ганц зам гэдгийг би мэдэрч байна!

## 6. Сонсооч! Хэн үг хэлж байна вэ?

Жоу Ли, Хятад

Чуулганы номлогчийн хувьд сүнсээрээ хоосорч, номлох зүйлгүй болохоос илүү зовлонтой зүйл гэж үгүй. Цуглаанд ирэх ах эгч нар улам цөөрч байгааг хараад би арга мухардаж, Эзэний өмнө олон ч удаа очиж чин сэтгэлээсээ залбиран, ах эгч нарын итгэлийг бэхжүүлж өгөөч гэж гуйсан юм. Гэвч чуулганы эзгүйрэл огт дээрдээгүйн зэрэгцээ би хүртэл сул дорой, сөрөг байдал дунд амьдрах боллоо...

Нэг өдөр гэртээ ажиллаж байхад минь Ван ах, Линь ах хоёр гэнэт ирсэн бөгөөд тэднийг би баяртайгаар оруулав. Мэнд мэдэлцсэний дараа Ван ах: “Жоу эгч ээ, одоо таны сүнс ямаршуу байна даа?” гэж асуув. Би санаа алдан: “Ярих юм алга. Одоо сүнс минь сул дорой болсон, бас номлолдоо номлох зүйл ч алга! Ах эгч нар ч бас бүгд сөрөг, сул дорой байна. Чуулганд бараг хүн алга” гэж хариуллаа. “Жоу эгч ээ, та яагаад номлох зүйлгүй болж, чуулган яагаад бараг хүнгүй болсныг мэдэж байна уу?” гэж Линь ах асуусан юм. Түүнийг асуумагц би: “Би яг тэрийг чинь л мэдмээр байна. Яагаад гэдгийг нь энэ хоёр үнэхээр мэдэж чадсан юм болов уу?” гэж бодлоо. Тэгээд, “Яагаад тэр вэ?” гэж яаран асуув. “Яагаад гэвэл Эзэн аль хэдийн эргэн ирсэн. Тэр хоёр дахь удаагаа бие махбодтой болоод, үгээ айлдан, шинэ ажил хийж байгаа. Хаанчлалын эрин үе дэх Бурханы ажлыг олон ах эгч аль хэдийн хүлээн зөвшөөрөөд, Ариун Сүнсний өнөөгийн ажлын урсгал дотор амьдарч байгаа юм. Тэдний нөхцөл байдал сайжирсаар байна. Бурханы шинэ ажилтай хөл нийлүүлээгүй хүмүүс Ариун Сүнсний ажлыг алдсан тул номлох үггүй болж, сөрөг, сул дорой байна. Бид Бурханы мөртэй хөл нийлүүлэхээр яаравчлах ёстой!” гэж Ван ах хэллээ. Үүнийг сонсоод би, “Хэрвээ хэн нэгэн, Бурхан шинэ ажил хийхээр эргэн ирж, шинэ үг айлдсан гэж хэлбэл Библиэс гажиж байгаа хэрэг, Библиэс гажна гэдэг Эзэнд итгэхгүй байгаа явдал; энэ бол урвалт” хэмээх ахлах хамтран зүтгэгчийнхээ үгийг гэнэт санасан юм. Үүнийг бодоод би маш нухацтайгаар: “Библиэс гажна гэдэг Эзэнд итгэхгүй байгаа хэрэг гэж ахлах хамтран зүтгэгчид бидэнд байнга хэлдэггүй бил үү? Библиэс гажна гэдэг

---

Эзэний замаас гажиж байгаа хэрэг гэдгийг та хоёр хоёулаа мэдэж байгаа шүү дээ. Надад ийм маягаар номлож яаж зүрхэлж байна аа!” гэж хэллээ. Ингэж хэлэнгээ би ууртайгаар босож зогсов. “Жоу эгч ээ, та битгий уурла. Бурханд чин сэтгэлээсээ итгэдэг, хичээнгүй хүн гэдгийг чинь бид мэднэ. Тийм болохоор л бид хоёр танд Бурханы шинэ ажлын талаар хэлж байгаа юм. Эзэнд бид маш олон жил итгэсэн. Тэгээд Эзэний эргэн ирэхийг үргэлж хүсэн хүлээдэг байсан биш үү? Одоо Эзэн эргэж ирээд, эцсийн өдрүүдийн шүүлтийн ажил хийж байна. Энэ бол гайхалтай мэдээ. Бид Эзэнийг угтан авах боломжоо алдалгүй, хичээнгүйлэн эрж хайж, судлах ёстой!” гэж Линь ах хэлсэн юм. Линь ахыг үгээ дуусгахаас өмнө би гараа өргөн, “Боль, боль, боль! Цааш нь бүү ярь. Библиэс гаждаг зүйлд би итгэхгүй. Та нар Эзэний замыг дагадаггүй юм бол, харин би дагах ёстой” гэж чангаар үгийг нь таслав. Үгийг нь үнэхээр сонсохгүй байгааг минь тэд харсан тул яаж ч чадалгүй явцгаасан юм. Дараа нь тэднийг хэдэн удаа эргэн ирэхэд нь би зүгээр л үл тоомсорлолоо.

Дараа нь Ван ах, Линь ах хоёр надад сайн мэдээ номлохоор хоёр эгчтэй хамт манайд ирсэн юм. Тэр өдөр нөхрийгөө гадаа ажиллах зуур би гэртээ вандуй арилгаж байлаа. Манай нөхөр тэдний ирэхийг хараад, гэртээ оруулчихжээ. Тэднийг хармагцаа миний зүрх дэлсэж эхлэв: Тэд хоёр хүн нэмэлт хүч болгож авчраад, бас яах гээд хүрээд ирэв ээ? Тэр дөрөв гэрт орж ирж, надтай мэнд мэдээд, дараа нь нөхөртэй минь нөхөрлөж эхлэв. Миний санаа бүр ч зовж, “Тэдний номлож байгаа зүйл Библиэс гажиж байгаа тул би нөхрөө харж хамгаалж, юу ч сонсгохгүй байх ёстой!” гэж дотроо бодлоо. Тэднийг хөөгөөд явуулчихмаар байсан ч нөхрийн минь сэтгэл гонсойх вий гэж санаа зовсон юм. Тэгээд чимээгүй байхаас өөр яаж ч чадаагүй боловч тэдний хэлсэн ганц ч үгийг би хүлээн зөвшөөрсөнгүй. Гэвч нөхөр минь тэднийг сонсоод толгой дохин, “Аанхан! Тийм шүү! Тийм! Тийм байдаг байжээ. Та нар маш сайн тайлбарлаж байна шүү!” гэж өөрийн эрхгүй хэлж байлаа. Нөхөр минь ингэтлээ ятгалгад автсаныг хараад би гэнэт багтартлаа уурлаж, нөхөр лүүгээ чичлэн, “Юу нь зөв байна? Чи Библийг хэр их уншсан юм бэ? Бурханд хэр удаан итгэсэн юм бэ? Эзэнд залбирсан юм уу? ‘Тийм, тийм, тийм’ л гээд байх юм, гэхдээ чи яг хэр их ойлгож байгаа юм бэ?” гэж дайрав. Намайг ингэтлээ дуугаа өндөрсгөхийг сонсоод өрөө гэнэт нам гүм болж, тэд бүгд бие бие рүүгээ харцгаасан юм. Нөхөр минь надад: “Битгий хашхич аа. Эхлээд сонс. Ингэвэл бидэнд сайн шүү дээ. Хэрвээ чи сонсохгүй юм бол зөв үү, буруу юу гэдгийг нь яаж мэдэж чадах юм бэ?” гэж яаран хэлэв. Нөхрөө тэднийг сонсохыг нь болиулж чадахгүй гэдгээ ойлгоод би вандуйгаа ууртайгаар нааш цааш түлхэж, албаар чанга чимээ гарган, “Чамд сонсгох оо? Юу ч сонсгохгүй дээ. Үүнийг чинь дуусгаад өгье өө!” гэж бодлоо. Гэвч вандуйгаар чанга дуу чимээ гаргалаа гээд нөхөр минь тэдний нөхөрлөлийг сонсохоо больсонгүй. Харин ч тэр дөрөвтэй ярилцаж, инээлдэн, нөхөрлөл нь туйлын эв найртай байлаа. Хэсэг хугацааны дараа нөхөр

---

минь надад баяртайгаар ийн хэлэв: “Өө, Ли! Эзэн үнэхээр эргээд иржээ. Энэ номын үг нь Бурханы биечлэн хэлсэн айлдвар юм байна! Ёстой сайхан юм! Ли, явж хоол унд бэлдээч.” Дараа нь Линь ах хэдэн хуурцаг, магтан дууны ном болон “Үг нь махбодоор илэрсэн” номын нэг хувийг нөхөрт минь өгчхөөд явлаа. Би дахин ер тэвчиж чадалгүй, “Ахлах хамтран зүтгэгчид бидэнд Бурханд итгэхдээ Библиэс гажиж болохгүй, Библиэс гажна гэдэг Бурханд итгэхгүй байгаа явдал гэж хэчнээн хэлсэн билээ? Чи мартчихаа юу? Яагаад энэ асуудал дээр тууштай байр суурь баримталж чадахгүй байгаа юм бэ?” гэж нөхөртөө хэлэв. “Тэдний хэлсэн үг Библиэс гажиж байгаа юм биш, харин Библиэс дээгүүр, илүү гүн гүнзгий юм байна. Тэгээд ч тэдний түгээж байгаа Бурханы шинэ ажил нь Эзэний үг болон Илчлэлийн номон дахь зөгнөлийг биелүүлж байна. Тэдний нөхөрлөлийг сонссоны дараа би Библиэс урьд нь ойлгодоггүй байсан олон зүйлээ ойлгож, тодорхой мэддэг боллоо. Тэдний гэрчилж байгаа Төгс Хүчит Бурханы сайн мэдээ бол үнэн зам мөн. Чи нүдээ нээгээд хар л даа. Манай чуулганд цөөхөн л хүн үлдсэн байна. Чуулган эзгүйрсэн. Гэтэл чи ахлах хамтран зүтгэгчдийн үгээс гарахгүй л байх юм. Энэ чинь дэндүү мунхаг хэрэг биш үү? Үүнийг даруйхан судалсан нь дээр дээ” хэмээн нөхөр маань тээнэгэлзэлгүйгээр хэлэв. Нөхрийнхөө ингэж хэлэхийг сонсоод би: “Чи юугаа мэддэг юм бэ? Библиэс гажна гэдэг Эзэнээс урваж байгаа хэрэг. Чи Библийг баримталдаггүй юм гэхэд би баримтална шүү!” гэж ууртайгаар хэллээ.

Үүний дараа нөхөр минь өдөр бүр зав л гармагц Линь ахын үлдээсэн “Үг нь махбодоор илэрсэн” хэмээх номыг уншдаг боллоо. Нэг өдөр тэрээр номоо унших гэж үүрээр босов. **“Чи ... мартчихсан юм гэж үү? Чи үнэхээр ... мартчихсан юм уу?”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Петр Есүсийг хэрхэн мэдэж авсан тухай”) гэж нөхрийнхөө уншиж байгааг би нойрмоглоон сонссон юм. Нөхрийнхөө чангаар уншиж байхыг сонсоод жаахан уур хүрч, “Ийм хар өглөөгүүр, хүн унтуулах ч үгүй юм!” гэж бодлоо. Хэсэг хугацааны дараа **“Учир нь цовдлогдохоосоо өмнө Есүс түүнд: ‘Би энэ дэлхийнх биш, чи ч бас энэ дэлхийнх биш’ гэсэн”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Петр Есүсийг хэрхэн мэдэж авсан тухай”). гэхийг нь сонслоо. Хачин юм аа! Энэ номд яагаад Эзэн Есүсийг дурдсан байдаг билээ? Би буруу дуулсан юм болов уу? Дараа нь, **“Чи ... мартчихсан юм гэж үү? Чи үнэхээр ... мартчихсан юм уу?”** гэх нь тодхон сонсогдсон юм. Үүнийг сонсоод сэтгэл минь бага зэрэг хөдлөн, цааш унтаж чадсангүй. “Энэ үгийг хэн хэлсэн юм бол оо? Өө Бурхан минь! Та надаас ийм асуулт асууж байгаа юм гэж үү? Энэ үгийг Та надад хэлж байгаа юм шиг байна. Энэ үг маш зөөлөн юм! Хурдхан босож, өглөөний цайгаа бэлдье. Өглөөний цайны дараа тэр номд юу гэж бичсэн байгааг харъя, тэгээд Библиэс үнэхээр гажиж байна уу, Бурханы үг мөн байна уу, үгүй юу гэдгийг үзье” гэж дотроо бодов.

---

Өглөөний цайны дараа нөхөр минь дахиад л явж өнөөх номоо уншлаа. “Яагаад цуг уншъя гэж гуйсангүй вэ?” гэж би дотроо бодов. Тэгээд үүдэнд нь нэлээд зогссон ч нөхөр минь толгой өндийх сэхэлгүй номоо уншаад намайг анзаарсангүй. Иймээс би гал тогоонд нааш цааш холхин, маш их санаа зовлоо. Тэр номд бичсэн зүйлийг үнэхээр уншмаар байсан юм. Иймээс өрөө рүү шагайхад, нөхөр минь мөн л толгой өндийх сөхөөгүй номоо уншиж байгаа харагдав. Би ч гэсэн очиж уншмаар байсан боловч ах эгч нарыг надад номлохоор олон удаа ирж байхад нь байнга татгалзаж байснаа бодохоор, санаачилгаараа очиж уншъя гэвэл нөхөр минь шүүмжлэх болов уу гэж гайхширч байлаа. Шүүмжлэх юм бол би маш их ичнэ шүү дээ! Ингэж бодоод, буцаад явлаа. Гадаа нь нааш цааш холхиж байхдаа би өглөө нөхрийнхөө уншиж байсан үгийг санаад, улам ч их зовнив. “Ингэж болохгүй юм байна. Би ороод, тэр ном яг юун тухай болохыг нь харах хэрэгтэй” гэж бодлоо. Гэвч хаалган дээр оччихоод дахиад л буцав. Би байж сууж чадахгүй, яахаа мэдэхгүй байлаа. Тэгээд эцэст нь сэтгэл шулуудсан юм: Өө! Бурхан намайг сэтгэл дэх үгээ хэл гэж хүсэж байна! Би яах гэж тийм юм ярьж, нөхрийнхөө зөвлөгөөг авахгүй байв аа? Ийнхүү би сэтгэлээ бэлдэн, өрөөнд явж орсон бөгөөд “Наад номыг чинь хамт уншиж болох уу?” гэж зориг гарган эв дүйгүйхэн хэллээ. Нөхөр минь над руу зэрвэс хараад маш их гайхан, “Тэг тэг! Хоёулаа цуг уншъя” гэж баяртайгаар хэлэв. Тэр мөчид миний сэтгэл асар их хөдөлсөн юм. Нөхөр минь миний бодож байсан шиг намайг шүүмжилсэнгүй! Зовнисон зүрх сэтгэл минь эцэстээ тайвширч, тэр номыг би нөхөртэйгөө хамт баяртайгаар уншив. Гэвч тэр номоос уншсан зүйл минь үүрээр миний сонссон зүйл биш байлаа! Яг тэр үед нөхөр маань гарч явсан бөгөөд номын хуудсыг би яаран эргүүлэв. Тэгээд хайж байсан зүйлээ тэр дороо олж, баяртайгаар ийн уншлаа: **“Петр Есүсийн үгээр асар их зоригжсон, учир нь цовдлогдохоосоо өмнө Есүс түүнд: ‘Би энэ дэлхийнх биш, чи ч бас энэ дэлхийнх биш’ гэсэн. Дараа нь Петрийг асар их өвдөх үед Есүс түүнд: ‘Петр ээ, чи мартчихав уу? Би дэлхийнх биш, Өөрийнхөө ажлын төлөө л Би арай эрт явж одсон. Чи ч бас дэлхийнх биш, чи үнэхээр мартчихаа юу? Би чамд хоёр удаа хэлсэн, санахгүй байна уу?’ хэмээн сануулсан юм. Үүнийг сонсоод Петр: ‘Би мартаагүй!’ гэв. Тэгэхэд Есүс ингэж хэлсэн: ‘Чи нэгэнтээ тэнгэрт Надтай хамт аз жаргалтай байж, хэсэг хугацааг Миний хажууд өнгөрүүлсэн. Чи Намайг санаж, Би чамайг санадаг. Хэдийгээр Миний нүдээр бол бүтээлүүдийг дурдахын ч хэрэггүй боловч гэм зэмгүй агаад хайр татам нэгнийг Би яаж хайрлахгүй байж чадах юм бэ? Чи Миний амлалтыг мартчихаа юу? Чи газар дээрх Миний даалгаврыг хүлээн зөвшөөрөх ёстой; Миний даалгасан үүргийг биелүүлэх ёстой. Нэг л өдөр Би чамайг заавал хажуудаа аваачна”**” (Үг нь махбодоор илэрсэн номын “Петр Есүсийг хэрхэн мэдэж авсан тухай”). Үүнийг би хэдэнтээ уншсан ба унших тусам эдгээр үг Библиэс гажаагүй болохыг мэдэрсэн юм. Тэдгээр нь Библиэс харин ч илүү тодорхой, ойлгомжтой байлаа. Гэвч манай

---

ахлах хамтран зүтгэгчид: “Бурхан шинэ ажил хийхээр ирж, шинэ үг айлдаж байна гэх мэдээ түгээдэг хэн бүхэн Библиэс гажиж байгаа бөгөөд Библиэс гажна гэдэг Эзэний замаас гажиж байгаа хэрэг” гэж хэлсэн шүү дээ. Гэтэл тэдний хэлсэн зүйл баримттай нийцэхгүй байгаа юм биш үү? Тэгээд би зүрх сэтгэлдээ ийн залбирав: “Өө Бурхан минь! Энэ бүхэн юу гэсэн үг юм бэ? Та намайг гэгээрүүлж, замчилж, хүслээ ойлгуулах болтугай...”

Дараа нь би Төгс Хүчит Бурханы хэлсэн ийм үгийг харсан юм: “**Олон жилийн турш хүмүүсийн итгэлийн (дэлхийн гурван гол шашны нэг болох Христийн шашны) уламжлалт арга барил нь Библийг унших явдал байсан; Библиэс холдох нь Эзэнд итгэх итгэл биш, Библиэс холдох нь буруу ном, тэрс үзэл бөгөөд хүмүүс өөр ном уншиж байхад ч гэсэн, эдгээр номын үндэс суурь нь Библийн тайлбар байх ёстой. Өөрөөр хэлбэл, хэрвээ чи Эзэнд итгэдэг бол Библийг унших ёстой бөгөөд Библиэс гадна Библитэй холбоогүй ямар ч номыг шүтэх ёсгүй. Хэрвээ шүтвэл чи Бурханаас урваж байна. Библи байсан үеэс эхлээд Эзэнд итгэх хүмүүсийн итгэл нь Библид итгэх итгэл байсаар ирсэн. Хүмүүс Эзэнд итгэдэг гэж хэлэхийн оронд тэд Библид итгэдэг гэж хэлсэн нь дээр; тэд Библийг уншиж эхэлсэн гэж хэлэхийн оронд тэд Библид итгэж эхэлсэн гэж хэлсэн нь дээр; тэд Эзэний өмнө эргэн очсон гэж хэлэхийн оронд Библийн өмнө эргэн очсон гэж хэлсэн нь дээр. Ийм маягаар хүмүүс Библийг Бурхан мэт, мөн өөрсдийнх нь амийн эх булаг шиг шүтсэн ба үүнийг алдах нь амиа алдахтай адил байв. Хүмүүс Библийг Бурхантай адил өндөр дээд гэж үздэг ба Бурханаас дээгүүрт үздэг хүмүүс ч бий. Хүмүүс Ариун Сүнсний ажилгүй бол, Бурханыг мэдэрч чаддаггүй бол амьдарсаар байж чадах боловч Библийг алдах юм уу Библийн алдартай бүлэг болон үгийг алдмагцаа амиа алдсантай адил болдог” (Үг нь махбодоор илэрсэн номын “Библийн талаар (1)”). Бурханы үг үнэхээр сэтгэлийг минь хөдөлгөлөө. Үнэндээ энэ миний тухай ярьж байсан бус уу? Эзэнд итгэж эхэлсэн үеэ санахад итгэлээ би ийнхүү баримталж байсан юм. Библийг би амийн эх булаг мэт үздэг байжээ. Тэгээд уншиж дуусах болгондоо, хүүхдүүд хүрчих вий гэж эмээн өндөрт залдаг байв. Библийг би бусад бүх зүйлээс дээгүүрт үзэж, тэр ч бүү хэл Библиэс гажих нь Эзэнээс урваж байгаа хэрэг гэж боддог байлаа. Тэгсэн минь буруу байв уу? Эрж хайх сэтгэлээр би “Библийн талаар (1)”-ээс “Библийн талаар (4)” хүртэл үргэлжлүүлэн уншив. Унших тусмаа улам гэгээрсэн мэт санагдлаа. Төгс Хүчит Бурханы үг надад бүрэн ойлгуулсан юм. Библи бол ердөө л Бурханы ажлын түүхэн тэмдэглэл, Бурханы ажлын эхний хоёр үе шатны гэрчлэл болж таарлаа. Дэлхийг бүтээснээс эхлээд Хуулийн эрин үеийн төгсгөл хүртэл Ехова Бурханы хийсэн ажлыг Хуучин Гэрээнд тэмдэглэсэн байдаг бол Нигүүлслийн эрин үед Эзэн Есүсийн хийсэн ажлыг Шинэ гэрээнд тэмдэглэсэн байдаг. Бурханы ажил ямагт шинээрээ,**

---

хэзээ ч хуучин байдаггүй бөгөөд үргэлж урагшилдаг. Одоо Бурхан Библийн гадна Хаанчлалын эрин үеийн ажил гэх шинэ ажил хийжээ. Ажлын энэ үе шат бол хүн төрөлхтнийг аврах Бурханы авралын ажлын эцсийн үе шат юм. Хуулийн эрин үеэс Нигүүлслийн эрин үе, тэгээд эцсийн өдрүүд дэх Хаанчлалын эрин үе хүртэлх гурван үе шатыг бүгдийг нь нэгэн Бурхан хийдэг. Төгс Хүчит Бурханы үгийг уншсанаар нүд минь үнэхээр нээгдэж, би тэдгээр үгээр нүдээ хужирлалаа! Тийм ээ, Бурхан маш төгс хүчтэй, мэргэн ухаантай байдаг хойно зүгээр л Библид бичигдсэн хязгаарлагдмал ажил хийж яахан болох билээ? Мөн Бурханы эцсийн өдрүүдийн үг, ажил Библийг няцаадаггүй гэдгийг би Төгс Хүчит Бурханы үгээс үнэхээр олж харсан юм. Харин ч тэдгээр нь Библид тэмдэглэсэн байдаг Хуулийн эрин үе болон Нигүүлслийн эрин үеийн ажлыг өргөж, гүнзгийрүүлсэн бөгөөд одоо Бурханы хийдэг бүхэн хүмүүсийн өнөөгийн хэрэгцээнд улам нийцдэг. Бурханы үгийн нэгэн хэсэгт ийнхүү хэлсэн байв: **“Өнөөдөр яагаад чамаас Библи уншихгүй байхыг шаардаж байгааг, яагаад Библиэс тусдаа өөр ажил байгааг, яагаад Бурхан Библиэс илүү шинэ, илүү дэлгэрэнгүй хэрэгжүүлэлтийг хайдаггүйг, яагаад Библийн гаднах илүү хүчирхэг ажил байдгийг чи ойлгох ёстой. Та нарын ойлгох ёстой бүхэн энэ юм. Чи хуучин, шинэ ажлын хоорондох ялгааг мэдэх ёстой бөгөөд Библийг уншдаггүй байсан ч үүнийг задлан шинжилж чаддаг байх ёстой; тэгэхгүй бол чи Библийг шүтсээр л байх болно, улмаар шинэ ажилд орж, шинэ өөрчлөлтүүдийг туулахад хэцүү байх болно. Илүү өндөр зам байхад яагаад тэр хуучирсан, дорд замыг судална гэж? Илүү шинэлэг айлдвар, илүү шинэлэг ажил байхад яагаад хуучны түүхэн тэмдэглэл дунд амьдарна гэж? Шинэ айлдарууд чамайг хангадаг ба шинэ ажил мөн гэдгийг энэ нь баталдаг; хуучин тэмдэглэлүүд сэтгэлийг чинь хангаж чадахгүй, эсвэл одоогийн хэрэгцээг чинь хангаж чадахгүй бөгөөд тэдгээр нь одоо энд хийгдэж байгаа ажил биш, харин түүх гэдгийг энэ нь баталдаг. Хамгийн өндөр зам бол хамгийн шинэлэг ажил юм, мөн шинэ ажил байгаа болохоор өнгөрсөн үеийн зам хэчнээн өндөр байлаа ч, хүмүүсийн эргэцүүллийн түүх хэвээр бөгөөд лавлах үнэ цэн нь ямар ч байлаа гэсэн, энэ нь мөн л хуучин зам юм. Хэдийгээр энэ нь ‘ариун номд’ бичигдсэн ч хуучин зам бол түүх; харин үүний талаарх тэмдэглэл ‘ариун номд’ байхгүй ч шинэ зам бол одоо үеийнх. Энэ зам чамайг аварч чадна, энэ зам чамайг өөрчилж чадна, учир нь энэ бол Ариун Сүнсний ажил билээ”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Библийн талаар (1)”). Би Библийг байнга баримталдаг байсан атлаа сүнсээрээ улам сөрөг болж, бүр номлох зүйлгүй болсныхоо учрыг тэр мөчид гэнэт ойлгож, ухаарсан юм. Ах эгч нар ч бас улам бүр сул дорой болж, цуглаанд оролцохоо ч больцгоосон атал Төгс Хүчит Бурханы хаанчлалын сайн мэдээг хүлээн зөвшөөрсөн ах эгч нар итгэлээр дүүрэн байлаа. Намайг яаж ч хандлаа гэсэн тэд хэзээ ч сөрөг болж, шантраагүй бөгөөд надад сайн мэдээ номлохоор удаа дараа ирсээр байсан юм. Учир нь

---

миний зууралдаж байсан зүйл бол Бурханы өнгөрсөн ажил байжээ. Энэ нь, аль хэдийн Ариун Сүнсний ажлыг алдсан хуучин зам байж. Харин Төгс Хүчит Бурханы Чуулганы ах эгч нар Бурханы шинэ ажлын удирдлагыг зөвшөөрч, Бурханы өнөөгийн үгийн хангалтыг хүлээн авсан бөгөөд Ариун Сүнсний ажлыг хүртсэн байлаа. Шинэ, зам, хуучин зам хоёрын ялгаа энэ байв! Шашны ертөнц уруудан доройтож, Төгс Хүчит Бурханы Чуулган улам бүр өсөн дэвшиж байсны уг шалтгаан энэ байж! “Эзэн минь, Та үнэхээр эргэн ирээд, бидэнд шинэ зам, амийн шинэ хангалт өгсөн гэдгийг би одоо л эцэст нь ойлголоо. Танд талархъя!” гэж би залбирав.

Энэ удаад би баярлах, гуниглах зэрэгцэн байлаа. Бурхан намайг ийм тэрслүү, дуулгаваргүй байсан ч хаялгүй, Өөрийн дуу хоолойг сонсгохын тулд нөхрөөр минь Бурханы үгийг уншуулах ийм онцгой арга замыг ашигласанд нь би баярлаж байсан юм. Энэ үнэхээр намайг гэх Бурханы хайр, аврал байлаа! Би Эзэний эргэн ирэхийг олон жил хүсэн хүлээсэн атлаа Эзэн эргэн ирээд, хаалгыг минь тогших үед голж магадгүй гэдгээ хэзээ ч бодож үзээгүйдээ гунигласан юм. Тэр ах эгч нар надад сайн мэдээ түгээхээр хэд хэдэн удаа ийм хол явж ирсэн байтал би тэднийг ердөө л үл тоомсорлосон билээ. Тэд нөхөртэй минь нөхөрлөл хийсэн ч би тэднээр доог тохуу хийж, тэднийг албаар үймүүлсэн юм... Үүнийг бодоод зүрх сэтгэл минь шаналж, өөрийн эрхгүй нулимс унагалаа. Бурханы өмнө өвдөг сөгдөөд би Түүнд ийнхүү залбирав: “Төгс Хүчит Бурхан минь! Миний буруу байжээ. Би маш олон жилийн турш ямагт Библийг баримталж явсан бөгөөд Библиэс гажна гэдэг Бурханд итгэхгүй байгаа явдал гэж боддог байлаа. Тэгээд Библид Бурхан мэт хандаж, Таны шинэ ажлыг ахин дахин голж, Таны ирэлтийг голжээ. Би үнэхээр харалган явж! Одоо би Библийг хойш тавьж, Таны шинэ ажлыг дагаж, шинэ эрин үеийн үгийг тань сонсоход бэлэн байна. Би Танд дахин хэзээ ч дайсагнахгүй, мөн үзэл төсөөллөөрөө бүхий л амьдралаа сүйрүүлэхийг хүсэхгүй. Өө Бурхан минь! Би шийдвэртэй байж, Тантай хамтран ажиллаж, Танд үнэхээр итгэдэг чуулганы хүмүүсийг гэр бүлд тань эргүүлэн авчирч, Танд өрөө төлөхийг хүсэж байна!”

## **7. Мунхаг охин болох шахсан минь**

Ли Фан, Хятад

2002 оны намар Үнэний Сүм гэх манай урсгалын Жао эгч Эзэн ирсэн тухай гайхалтай мэдээ дуулгахаар зээ охин нь болох Ван эгчийг манай гэрт авчирсан юм. Дэлхий ертөнцийг бүтээснээс хойш өнөөг хүртэл Бурхан хүн төрөлхтнийг аврахын тулд ажлын гурван үе шатыг явуулсан гэдгийг би хэд хоногийн турш Төгс Хүчит Бурханы үгийг



---

уншиж, Ван эгчийн дэлгэрэнгүй нөхөрлөлийг сонссоноор ойлголоо. Түүнчлэн Бурхан ажлынхаа үе шат бүрд шинэ нэр авдгийг, эрин үе бүр дэх Бурханы нэрийн ач холбогдол, Бурхан бие махбодтой болохын нууц гэх зэрэг бусад үнэнийг мэдэж авсан билээ. Эдгээр үнэн үнэхээр нүдийг минь нээж, би нүдээ хужирлаж байлаа. “Энэ зам тов тодорхой сонсогдож байна, бас Төгс Хүчит Бурхан эргэн ирсэн Эзэн Есүс байж тун магадгүй. Тийм болохоор би энэ боломжийг ашиглаж, Төгс Хүчит Бурханы үгийг илүү их уншсан нь дээр юм байна” гэж би дотроо бодсон юм. Ван эгч явахаасаа өмнө надад Бурханы үгийн хэдэн ном үлдээлээ. Би өдрийн цагаар зав гарах болгонд Бурханы үгийг уншдаг байв. Унших тусмаа тэдгээрт улам дуртай болж, Бурханы үг гэдгийг нь бүр их мэдэрдэг байлаа. Гурав хоногийн дараа би сэтгэл түгших болов. “Эзэн эргэн ирсэн тухай энэ гайхалтай мэдээг итгэгч хүү маань болон чуулганы маань олон ах эгч мэдээгүй хэвээр байгаа. Би тэдэнд даруйхан хэлэх хэрэгтэй юм байна” гэж би бодлоо.

Маргааш өглөө нь би хүүгийнхээ гэрт эртлэн очсон юм. Тэгээд “Энэ тун гайхалтай ном байна. Чи үүнийг даруйхан унших хэрэгтэй” гэж хүүдээ баяртайгаар хэлэв. Хүү минь над руу зэрвэс хараад “Ямар ном юм бэ? Та нэлээд баяртай байх шиг байна. Зүгээр л тэнд тавьчих, би завтай болохоороо үзье” гэлээ. Бүх итгэгч Эзэний эргэн ирэхийг хүсэн хүлээдэг тул Эзэн аль хэдийн эргэн ирсэн тухай мэдээд хүү минь баярлана гэж би бодсон юм.

Гэвч гурав хоногийн дараа хүү минь зургаан хүн дагуулан гэрт ирнэ гэж би зүүдлээ ч үгүй явсан билээ. Тэдний нэг нь манай урсгалын Шиа пастор байсан бөгөөд бусад нь хүүгийн маань урсгалын пастор, номлогчид байлаа. Юу болоод байгаа, яагаад ийм олон хүн надтай уулзахаар ирснийг би ойлгож чадахгүй байсан тул тэднийг хараад жаахан гайхшрав. Ли овогт пастор над руу нэг хором сүрхий хараад, санаа зовсон төрхтэйгээр ийн хэллээ: “Эгч ээ, бид бүгд Эзэнд итгэгчид, нэгэн том гэр бүл. Нэг хүн танд ном өгсөн гэж танай хүү хэлсэн, гэхдээ та тэр номыг уншиж ёстой болохгүй. Одоо эцсийн өдрүүд болж байна, бас Эзэн Есүс ингэж хэлсэн байдаг: **‘Тэр үед хэн нэгэн хүн та нарт “Хараач, Христ энд байна”, эсвэл “Христ тэнд байна” гэвэл түүнд бүү итгэ. Учир нь хуурамч Христүүд болон хуурамч эш үзүүлэгчид гарч ирэн агуу тэмдэг, гайхамшгуудыг үзүүлэх ба боломжтой бол сонгогдсон хүмүүсийг ч хууран мэхэлнэ’** (Матай 24:23–24). Эзэн Есүсийн энэ үг нь, Эзэн эргэн ирсэн гэж хэлдэг хэн бүхэн бол бидний сэрэмжилж, үгийг нь сонсохоос татгалзах ёстой луйварчин гэсэн утгатай гэж бид итгэдэг. Яг одоо дэлхий дахинд гагцхүү Зүүний Аянга л Эзэний эргэн ирэлтийг ил тод гэрчилж байна. Тийм болохоор та юу ч хийлээ гэсэн тэдэнтэй холбогдохоо боль. Зүүний Аянгын ямар ч номыг бас битгий унш. Тэдний зам бидний итгэлээс өөр, тийм болохоор тэднийг бүү сонс. Та Библийг төдийлөн сайн ойлгодоггүй, мөн биеийн хэмжээ багатай болохоор амархан

---

хууртаж байгаа юм. Бид олон жил номлож ирсэн, бас Библийг сайн ойлгодог. Тэгээд Хятадын хаа сайгүй явж, олон зүйл үзсэн, амийн хувьд илүү боловсорсон хүмүүс. Өнөөдөр бид таныг аврахаар зорьж ирлээ. Тиймээс та өөрийнхөөрөө зүтгэлгүй, бидэнд итгэх ёстой.” Үүнийг сонсоод би: “Энэ пастор миний талаар санаа зовж байх шиг байна, бас түүний хэлсэн үг ч буруу биш шүү дээ. Би өндөр настай, тааруухан боловсролтой, бас Библийг төдийлөн сайн ойлгодоггүй. Би тэдэн шиг сайн ялган таньж чадахгүй нь лавтай” гэж дотроо бодлоо. Тэр үед Шиа пастор: “Би бол пастор, бас Эзэн сүргээ удирдуулахаар надад өгсөн. Тийм болохоор таныг үнэн замаас төөрүүлэхгүй байх нь миний хариуцлага мөн. Хэрэв би Эзэний сүргийг харж хандахгүй бол Эзэнд тайлан тавьж чадахгүй. Эгч минь, бусад бүлгүүд рүү битгий ингэж гүй. Зүүний Аянга таныг биднээс хулгайлах юм бол Эзэнд итгэсэн энэ олон жил чинь талаар болно шүү!” гэлээ. Тэдний түгшсэн царайг харж, надтай ярьж байгаа ноцтой өнгийг нь сонсоод би жаахан айв. Тэгээд: “Тийм шүү. Хэрэв би буруу итгэж эхлэх юм бол итгэж ирсэн энэ олон жил талаар өнгөрөх биш үү?” гэж бодлоо. Гэвч дараа нь “Тэр номд байсан үг маш сайн, зөв зүйтэй санагдсан. Энэ пастор, номлогчид Төгс Хүчит Бурханы үгийг уншиж үзээгүй юм байж үнэн зам биш гэж яаж хэлж чадаж байна аа?” гэж бодогдов. Иймээс би: “Та нарын ингэж хэлж байгаа чинь зөв байж магадгүй, гэхдээ тэднээс сонссон зүйл Библи дэх Эзэний үгтэй бүрэн нийцдэг!” гэж тэдэнд хэллээ. Миний ингэж хэлэхийг сонсоод тэд бүгд нэгэн зэрэг ярьж эхэлсэн бөгөөд намайг айлгахын тулд маш олон зүйл хэлснээс миний толгой эргэж, будилж, сэтгэл санаагаар маш их хямарсан юм. Би тэнд хэлэх ганц ч үггүй болчхоод сууж байлаа. Дараа нь тэд надтай цуг залбирч, Зүүний Аянгыг хараалгах гэж хүссэн ч намайг үгэнд нь орохгүй болохоор дахин айлган сүрдүүлж эхлэв. Эцэст нь манай хүү: “Одоо би ээжийгээ зохицуулъя даа” гэж хэлсэн юм. Тэгээд шүүгээн дотроос миний магтан дууны хоёр ном, ‘Хургыг дагаж шинэ дуу дуулъя’ дууны кассетууд, мөн ‘Шүүлт Бурханы гэрээс эхэлдэг’ гэх нэртэй Бурханы үгийн номыг аваад пасторт өгч явуулсан билээ.

Тэднийг явсны дараа би маш их сэтгэлээр унаж, оройн хоолоо ч идэж чадахгүй байсан тул Эзэний өмнө очиж, ийнхүү залбирав: “Эзэн Есүс минь, тэр пасторуудын хэлж байгаа зүйл үнэн үү, худал уу? Тэд миний аминд үнэхээр санаа зовсон бололтой байна. Хэрэв би тэдний үгэнд орохгүй бол буруу зүйлд итгэх болов уу? Өө Эзэн минь, Та үнэхээр Төгс Хүчит Бурхан болж эргэн ирсэн байхад Таныг хүлээн зөвшөөрөхгүй бол би Танд хаалгаа хаасан хэрэг болох бус уу? Тэгвэл би мунхаг охидоос ямар ч ялгаагүй байх бус уу? Өө Эзэн минь, өнгөрсөн хэд хоногт Төгс Хүчит Бурханы үгийг уншаад сүнс минь маш их хангалт олж авсан юм шиг санагдаж байна. Би үүнийг үнэхээр, чин үнэнчээр мэдэрсэн, гэхдээ миний буруу байж болох уу? Тэд миний номууд, магтан дуутай кассетуудыг аваад явчихсан болохоор би үнэхээр гуниглаж, яахаа мэдэхгүй байна. Намайг замчлаач дээ...”

---

Ван эгч надад Төгс Хүчит Бурханы өөр нэг ном өгөөд, шүүгээнийхээ бүр ёроолд нь хадгалаарай гэж гуйсныг би залбирсныхаа дараа гэнэт саналаа. Тэр ном одоо ч байгаа гэдгийг ухаараад сэтгэл минь жаахан дээрдэв. Гэвч дараа нь тэр пасторуудын хэлсэн зүйлийг бодоод, мөн л яахаа мэдэхгүй хэвээр байлаа. Тэр номыг унших уу, болих уу? Тэр шөнө сэтгэл үймрэн, би бараг нойр авсангүй. Тэгээд нулимс унаган, Бурханд ахин дахин залбирлаа...

Маргааш өглөө нь манай хүү эртлэн ирээд, хуучин чуулганы маань цуглаанд намайг аваачив. Би үнэхээр сэтгэл хоёрдож байсан ч хүү минь намайг цуглааны газар луу чирч аваачин, тэр ч бүү хэл намайг Зүүний Аянгад хулгайлагдсан гэж номлогчид хэлээд, үлд гэж ятгахын тулд чадах бүхнээ хийгээч гэж түүнээс гуйлаа. Номлогч болон бүх ах эгч тэр дороо намайг бүчин авсан юм. Номлогч гарыг минь атгаад, зөөлхөн дуугаар ийн хэлэв: “Эгч ээ, та юу ч хийлээ гэсэн бусад хүний номлохыг бүү сонс. Та буруу итгээд эхэлбэл Эзэн шүтлэгтнүүдийг өргөхөөр эргэн ирэхэд үлдэж хоцорно шүү дээ, тийм биз дээ? Та биеийн хэмжээ багатай болохоор хэн нэгэн танд унш гэж ямар нэг төрлийн ном өгөх юм бол эхлээд биднээс асуусан нь дээр. Бид танд шалгаад өгье...” Ах эгч нар ч бас намайг үлдээч гэж ятгахаар хичээсээр байсан бөгөөд тэдний “хайранд” сэтгэл минь хөдөлсөндөө би нулимс унагав. Сэтгэл минь хэчнээн их хөдөлсөн байгааг хараад, тэд санаагаа дахин нэг удаа хэлсэн юм: “Зүүний Аянгаас хэн нэгэн танайд дахиад зочилж ирвэл та битгий оруулаарай. Тэдэнтэй дахиад битгий холбогдоорой!” Би санал нийлэн толгой дохилоо.

Хэдхэн хоногийн дараа Ван эгч дахин надтай уулзахаар ирэв. Би эгчид: “Пастор надад Библиэс ийм хэсгийг уншиж өгсөн: **‘Тэр үед хэн нэгэн хүн та нарт “Хараач, Христ энд байна”, эсвэл “Христ тэнд байна” гэвэл түүнд бүү итгэ. Учир нь хуурамч Христүүд болон хуурамч эш үзүүлэгчид гарч ирэн агуу тэмдэг, гайхамшгуудыг үзүүлэх ба боломжтой бол сонгогдсон хүмүүсийг ч хууран мэхэлнэ’** (Матай 24:23–24). Эцсийн өдрүүдэд хуурамч Христүүд гарч ирнэ, бас Эзэн эргэн ирлээ гэж хэлсэн хэн боловч луйварчин. Би Библийг ойлгодоггүй, биеийн хэмжээ минь жаахан болохоор амархан төөрөлддөг юм. Би өөр ямар ч замыг сонсож зүрхлэхгүй, тийм болохоор таныг оруулахгүй. Та дахиж битгий ирээрэй” гэж хэллээ. Ван эгч үнэхээр чин сэтгэлээсээ ийн хэлэв: “Эзэн Есүс эцсийн өдрүүдэд биднийг хуурамч Христүүдээс сэрэмжлүүлэхийн тулд ингэж хэлсэн боловч Христээс бас нүүр буруулаг гэж зориогүй юм шүү дээ. Хуурамч Христүүд байгаа бол жинхэнэ Христ аль хэдийн илэрсэн учраас л тэр юм. Яагаад гэвэл жинхэнэ Христ байхгүй бол дүр эсгэгчдэд дуурайх зүйл юу ч байхгүй. Эзэн Есүсийн тэр үг бидэнд ялган таньж сурах ёстой гэдгийг хэлж байна; харин ердөө л эцсийн өдрүүдэд хуурамч Христүүд гарч ирнэ гэдгээс болж Эзэн эргэн ирсэн тухай сайн мэдээг сонсохоос татгалзах ёстой гэж хэлээгүй. Эс бөгөөс бид Эзэнийг эргэн ирэхэд нь яаж угтан авч чадах

---

юм бэ? Үнэндээ Эзэн Есүс хуурамч Христүүдийн шинж чанарыг аль хэдийн тодорхой дүрсэлсэн шүү дээ. Голлох зүйлсэд тэмдэг, гайхамшиг үзүүлэх, өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг хөөх, мөн хүмүүсийг хуурахын тулд Эзэн Есүсийн аль хэдийн хийчихсэн ажлыг дуурайх зэрэг багтдаг. Иймээс эцсийн өдрүүдэд Эзэн Есүсийг дуурайж гэмшлийн замыг тунхагладаг, цөөн хэдэн энгийн тэмдэг үзүүлж, өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг хөөж чаддаг хэн бүхэн бол хуурамч Христ юм. Эцсийн өдрүүдэд махбодод эргэн ирсэн Эзэн Есүс болох Төгс Хүчит Бурхан нь Эзэн Есүсийн аль хэдийн хийчихсэн ажлыг давтдаггүй, харин Эзэн Есүсийн золин авралын ажлын суурин дээр шинэ ажил хийдэг. Төгс Хүчит Бурхан Нигүүлслийн эрин үеийг төгсгөж, Хаанчлалын эрин үеийг нээсэн бөгөөд үнэнийг илэрхийлж, хүн төрөлхтнийг шүүж, цэвэрлэх ажлын үе шатыг хийдэг. Золин аврагдсан боловч нүгэл дунд амьдарсаар байгаа бүх хүнийг Төгс Хүчит Бурхан нүгэлт уг чанарынх нь дөнгөнөөс нь салгаж, Сатаны харанхуйн нөлөөнөөс ангижруулах замаар бүрмөсөн аварна. Дараа нь Тэр хүн төрөлхтнийг гайхалтай сайхан эцсийн хүрэх газарт нь аваачна. Энэ ажлыг Бурхан Өөрөө л хийж чаддаг: өөр ямар ч хуурамч Христ хийж чаддаггүй.” Хэдийгээр эгчийн хэлж байгаа зүйл үндэслэлтэй санагдсан ч пасторын хэлсэн үг толгойд эргэлдсээр байлаа. Сэтгэл санаа минь хямарч, анхаарлаа төвлөрүүлж чадахгүй байсан бөгөөд эгчийн нөхөрлөлийг цааш сонсохыг хүссэнгүй. Иймээс би эгчээс салахын тулд хөршийндөө хийх ажилтай гэж худал хэллээ. Дараа нь Ван эгч манай гэрт олон удаа ирсэн ч би үргэлж түүнээс зайлсхийдэг байв. “Тэр муу хүн шиг харагдахгүй л байх юм. Чи юундаа айсан юм бэ?” гэж хөрш минь надаас асуусан юм. Ван эгчийн сайн хүн гэдгийг би сэтгэлдээ мэдэж байсан боловч биеийн хэмжээ минь бага байсан болохоор буруу зүйлд итгэхээс айж байлаа.

Хуучин чуулганыхаа цуглаанд оролцохоор эргэн очсоныхоо дараа номлогч нар урьд нь хэлсэн зүйлээ мөн л номлосоор байгааг сонсов. Тэд Зүүний Аянгаас хэрхэн сэрэмжлэх, чуулганд хандив өргөх талаар үргэлж ярьж, эсвэл өөрсдийнхөө хэчнээн их ажиллаж, Эзэний төлөө хэр их зовсон, Эзэний хэчнээн их нигүүлслийг эдэлсэн тухай маш их уйтгартай улиг болсон зүйлээ л давтацгааж байв... Тэд шинэ гэрэлтэй өчүүхэн зүйл ч хэлэх чадваргүй байлаа. Би тэдний ярьж байгаа зүйлээс дорхноо залхаж гүйцээд зүүрмэглэж эхэлсэн юм. Нэг удаа өөр чуулганы ах ирж номлосон боловч Эзэний ажлыг хийхээр газар сайгүй яаж явсан, хэчнээн их зовлон туулсан, сайн мэдээ түгээх замаар хэр олон хүнийг элсүүлсэн, хэчнээн олон чуулган байгуулсан тухайгаа мөн л нэгэн хэвийн зүйл ярих. Тэр өөрийгөө л магтсаар байлаа. Түүнийг сонсоод би тун их эвгүйцэж, Эзэнд гэрчлэл хийлгүй өөртөө л гэрчлэл хийж байна гэх дүгнэлтэд хүрэв. Өөр нэг удаа, цуглааны газарт дөнгөж очих үед маань нэг эгч: “Өнөөдөр хорин хэдтэй, теологийн оюутан бидэнд номлол хийнэ” гэж хэллээ. Би үүнийг сонсоод тун их баярлаж, энэ удаагийн номлолд

---

онцгойлон анхаарал хандуулъя гэж дотроо бодсон юм. Учир нь тэр манай номлогчдоос илүү сайн номлол хийж чадах нь лавтай байлаа. Гэвч тэр оюутан Зүүний Аянгаас хэрхэн сэрэмжлэх талаар номлолоо эхэлж, дараа нь өөрөө 16 настайдаа ердийн хичээл номоо хэрхэн орхиж, теологи судлахаар шашны сургуульд орсон, бороонд ч хамаагүй гадуур хэрхэн ажиллаж зовсон, хэчнээн олон газраар явсан тухайгаа ярив... Сонсох тусмаа би улам их залхсан юм. “Энэ чинь шинэ саванд савласан хуучин дарс л байна даг! Юундаа нэгэн хэвийн уйтгартай зүйлээ чалчаад байдаг юм бэ? Энэ нь Эзэний үгийн талаарх тэдний мэдлэг, туршлагатай ямар ч холбоогүй, бас Эзэний замыг дагаж, үгийг нь хэрэгжүүлж, ороход биднийг залж чиглүүлэхгүй байна шүү дээ” гэж дотроо бодлоо. Би цуглаандаа эргэж очоод аль хэдийн нэг сар гаруй болж байсан ч тэднээс юу ч олж аваагүй байв. Тэдгээр номлолыг сонсох тусам сүнс минь улам хатаж, энэ маягаараа итгэвэл сүнсээрээ өлсөж цангаад үхэх юм байна гэж бодогдсон юм. Өчүүхэн ч гэлээ амь хаанаас олох вэ? Ингэж бодох тусам би улам их сэтгэлээр уналаа.

Цуглааны дараа би уй гунигт автсаар гэртээ харив. Тэгээд Ван эгчийн өгсөн ‘Шүүлт Бурханы гэрээс эхэлдэг’ хэмээх номын тухай бодлоо. Хүмүүс биеэ тоож, өөрсдийгөө өргөмжлөх ёсгүй, харин Бурханыг агуу хэмээн хүндэлж, өргөмжлөх ёстой хэмээн тэр номд өгүүлсэн байдаг. Гэтэл энэ номлогчид бүгд өөрсдөдөө гэрчлэл хийж, өөрсдийгөө бусад бүхнээс дээгүүрт хүндэлж, бусдад хүндлэгдэн, шүтэгдэж байна. Тэр номын хэлсэн зүйл надад үнэн санагдав! Иймээс тэр орой би гэртээ ганцаараа байхдаа ‘Шүүлт Бурханы гэрээс эхэлдэг’ хэмээх номыг гаргаж ирээд, зарим хэсгийг нь уншлаа. Унших тусмаа зүрх сэтгэл минь хөөрч, эдгээр үг миний амийг тэжээж болохыг үнэхээр мэдэрсэн билээ. Яагаад манай пастор ийм сайн номыг уншуулахгүй байсныг гайхлаа. Пастор маань бидний амийг хариуцдаг гэж байнга хэлдэг атлаа номлолдоо өөрийгөө л гэрчилж мэддэг мэт байсан юм. Амь хэрхэн олж авах тухай бидэнд хэзээ ч хэлж байсангүй. Тэгээд би нэг үе маш сул дорой болж, чуулганы цуглаанд явахыг хүсэхгүй байснаа санах. Пастор над дээр хэзээ ч зочлон ирээгүй, мөн ямар нэг дэмжлэг үзүүлээгүй. Гэтэл тэр яахаараа Төгс Хүчит Бурханы үгийг уншиж, жаахан сүнслэг тэжээл авч эхэлмэгц маань гарч ирж, хуучин чуулган руу маань эргүүлэн чирч аваачаад, улиг болсон зүйл давтаж байгаагаа сонсгодог билээ? Энэ чинь миний аминд хариуцлага хүлээж байгаа хэрэг биш шүү дээ! Би хэчнээн буруутсанаа гэнэт ойлгон, өөрийгөө асар их буруутгалаа: Төгс Хүчит Бурханы үг миний амийг хангаж чадсан тул Бурханаас ирсэн байж тун магадгүй байв. Би яагаад тийм тэнэг, харалган байж, пасторын хэлсэн үгэнд итгэн, үнэн замыг судлахаа больж чадав аа? Тэгээд бас Ван эгч намайг үргэлж хайрлах сэтгэлээр дэмжин, Бурханы эцсийн өдрүүдийн авралыг хүртээхийн тулд Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг надад гэрчилдэг байсан талаар бодлоо. Гэтэл би Ван эгчид төдий л сайхан хандалгүй, бүр хэд хэдэн удаа түүнтэй

---

уулзахаас зайлсхийж байсан юм. Би эгчид дайсан мэт хандах ёсгүй байж. Ингэж бодоод би туйлын их гуниглалаа. Иймээс би Эзэний өмнө очиж, нулимстайгаар гэмшлийн залбирал хийв: “Эзэн минь, Бурханы үгийн номыг надад авчирсан тэр эгчид би дайсан мэт хандаж, эгчээс нүүр буруулсан. Энэ нь хүнээс нүүр буруулж байгаа биш, харин үнэндээ Таны авралаас татгалзаж байгаа хэрэг байж! Эзэн минь, би тэр пасторуудын үгэнд орж, Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг судлахаа болих ёсгүй байснаа одоо мэдлээ. Би Танд гэмшмээр байгаа ч Ван эгчийг яаж олохоо мэдэхгүй байна. Надад туслаач дээ...” Залбирсныхаа дараа би тэр номыг дахин барьж аваад, шөнө дүл болтол уншсан юм. Унших тусам агуулга нь сайн санагдаж, Төгс Хүчит Бурханы үгийг уншихыг минь болиулсан пасторуудыг улам их жигших болсон билээ.

Залбирлыг минь сонссон Эзэнд би маш их талархсан юм! Маргааш нь үд дунд намайг хооллож байх үеэр Ван эгч манай гэрт ирэв. Би хамгийн сүүлд уулзсанаас хойш болсон бүх зүйлийн талаар эгчид ярьж өглөө. Эгч шашин дотроос тэжээл олж авч чадахгүй байсныг минь дуулаад, Төгс Хүчит Бурханы үгийн ийм хэсгийг уншиж өгөв: **“Бурхан энэ баримтыг гүйцэлдүүлнэ: Тэр орчлон ертөнц даяар бүх хүнийг Өөрийнхөө өмнө ирүүлж, газар дээрх Бурханыг шүтүүлэх ба өөр газрууд дахь Түүний ажил зогсож, хүмүүс албан хүчээр үнэн замыг эрж хайна. Энэ нь Иосеф шиг байх болно: Түүнд идэх юм байсан учраас хүн бүр хоол хүнс авахаар түүн рүү очиж, түүнд бөхийдөг байсан. Өлсгөлөнгөөс зайлсхийхийн тулд хүмүүс албан хүчээр үнэн замыг эрж хайна. Шашны нийгэмлэг тэр чигтээ асар их өлсгөлөн амсах ба зөвхөн өнөөдрийн Бурхан л хүний таашаалыг хангах мөнх урсах булагтай амийн усны ширгэшгүй булаг бөгөөд хүмүүс Түүн рүү очиж, Түүнд найдна”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Мянган жилийн хаанчлал ирчихсэн”). Дараа нь эгч надтай ийнхүү нөхөрлөлөө: “Бурхан бол амийн усны эх булаг, Бурхан л хүмүүсийн амийг хангаж чадна. Хүмүүс Бурханыг орхих үед модноосоо тасарсан мөчир мэт бүх зүйл харанхуйлж, хатаж ганддаг. Бид Бурханд итгэхдээ Хурганы мөрийг ойр дагаж, Бурханы өнөөгийн ажлыг хүлээн зөвшөөрч, Бурханы өмнө очих ёстой, учир нь ингэснээр л бид Ариун Сүнсний ажил, Бурханы амийн амьд усны тэжээл, хангалтыг олж авч чаддаг. Шашны тэр пастор, ахлагчдыг сонсохоор яагаад тэжээл авч чаддаггүй вэ? Үүнд хоёр шалтгаан бий. Нэгдүгээрт, тэр пастор, ахлагчид Эзэний тушаалыг баримталдаггүй, мөн Эзэний үгийг хэрэгжүүлдэггүй. Тэдэнд Бурханаас эмээх зүрх сэтгэл байх нь бүү хэл, амийн бодит туршлага байдаггүй, Бурханы талаарх бодит мэдлэг бүр ч байдаггүй. Тэгээд ажил, номлолдоо Бурханыг огт өргөмжилдөггүй, мөн Түүнд гэрчлэл хийдэггүй. Тэд үргэлж өөрсдийгөө магтаж, өөрсдөдөө гэрчлэл хийдэг. Эзэний замаас бүрэн гажсанаараа тэд, хүмүүсийг хуурдаг, байдаг л нэг хуурамч хоньчид болсон юм. Ийм учраас тэд Ариун Сүнсэнд жигшигдэн гологддог бөгөөд Түүний гэгээрэл,

---

удирдамжийг хэзээ ч олж авч чаддаггүй. Шашны нийгэмлэг ийм их эзгүйрсэн байдгийн гол шалтгаан нь энэ. Нөгөө шалтгаан нь гэвэл, Эзэн Есүс шинэ эрин үеийн ажлыг хийхээр аль хэдийн эргэн ирээд байна. Ариун Сүнс Нигүүлслийн эрин үеийн хүмүүсээс ажлаа аль хэдийн татан аваад, Бурханы шинэ ажилтай хөл нийлүүлж буй бүлэг хүмүүс дээр одоо ажиллаж байгаа. Гэвч пастор, ахлагчид Бурханы шинэ ажлыг огт судалдаггүй бөгөөд Бурханы мөрийг дагаж, Түүний удирдлагыг хүлээн зөвшөөрдөггүй. Харин ч тэд Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг улайран эсэргүүцэж, яллан, эцсийн өдрүүдийн Христ болох Төгс Хүчит Бурханыг гүтгэж, доромжлохоос өөрийг хийдэггүй. Тэд үнэн замыг судлах, Бурханд эргэн очиход нь итгэгчдэд саад болохын тулд чадах бүхнээ хийснээр Эзэнийг загалмайд цовдолсон фарисайчуудтай яг адилхан болсон. Бурхан тэднийг аль хэдийн яллаж, хөөн зайлуулсан тул Ариун Сүнс тэдэн дээр ажиллах аргагүй юм. Иймээс бид амийн тэжээл хүлээн авахыг хүсвэл Ариун Сүнсний өнөөгийн ажилтай хөл нийлүүлж, Бурханы одоо илэрхийлж буй үгийг хүлээн зөвшөөрч, эцсийн өдрүүдийн Христ болох Төгс Хүчит Бурханы удирдлага, хангалт, хариулгыг хүлээн зөвшөөрөх ёстой. Үнэн ба амийг олж авах цорын ганц арга зам бол энэ. **‘Би бол зам, үнэн, амь юм’** (Иохан 14:6). **‘Гэхдээ өөрт нь Миний өгөх уснаас уудаг хэн ч, хэзээ ч цангахгүй; харин Миний өгөх ус түүний дотор мөнх амь руу оргилох булаг болно’** (Иохан 4:13–14) хэмээн Эзэн Есүсийн хэлсэн үгийг энэ нь биелүүлдэг.”

Пастор, ахлагчид болон теологийн оюутнуудад номлохуйц зүйл байхгүй байсны учрыг би Бурханы үгийн талаарх Ван эгчийн нөхөрлөлийг сонссоныхоо дараа гэнэт ухаарсан юм: Тэдэнд үнэн байхгүй юм байна! Бурханыг эсэргүүцдэг тэднийг Ариун Сүнс аль эрт орхижээ. Тэд номлох үедээ гагцхүү оюуны мэдлэгтээ л найддаг болохоос Ариун Сүнсний гэгээрэлгүй байдаг тул номлол нь хэнд ч ашиг тус өгдөггүй юм байна. Гэвч миний ойлгохгүй бас нэг зүйл байсан тул Ван эгчээс: “Бүх пастор, ахлагч Библийг тун сайн мэддэг, мөн шашны сургуульд явсан, ихээхэн амьтай гэгцгээдэг. Би Библийг тийм ч сайн ойлгодоггүй, бас тэднийг амийн хувьд үнэхээр надаас илүү боловсорсон гэж бодсон учраас тэдний үгэнд орсон юм. Тийм болохоор би одоо тэдэнд үнэхээр тийм их амь байдаг эсэхийг хэлж мэдэхгүй байна. Эгч ээ, тэдэнд үнэхээр тийм их амь байдаг гэж та бодож байна уу?” хэмээн асуув. Ван эгч ингэж хариуллаа: “Хэн ч өөрсдөд нь амь бий гэж гэрчилж болохгүй. Энэ нь бүгд Бурханы үгийн дагуу шийдэгддэг. Амьтай байна гэж юу гэсэн үг вэ? Ялангуяа ямар зүйл харагдах ёстой вэ? Эзэн Есүс ингэж хэлсэн байдаг: **‘Би бол зам, үнэн, амь юм’** (Иохан 14:6). Мөн Төгс Хүчит Бурханы хэлснээр: **‘Бодит байдалтай эсэх чинь чиний хэлдэг зүйлд биш, харин амьдран харуулдаг зүйлд үндэслэдэг. Бурханы үг чиний амь, жам ёсны илэрхийлэл болсон цагт л чамайг бодит байдалтай болсон гэж хэлж болох ба тэр үед л чамайг жинхэнэ ойлголт, бодит биений**

---

хэмжээтэй болсонд тооцож болно. Чи шинжилгээг удаан хугацааны туршид тэсвэрлэж чаддаг, мөн Бурханы шаарддаг төрхийг амьдран харуулж чаддаг байх ёстой. Үүнийг зүгээр нэг хэлбэрдэж болохгүй, харин чамаас аяндаа урсан гарч байх ёстой. Тэгсэн цагт л чи үнэхээр бодит байдалтай болж, тэр цагт л амийг олж авсан байх болно’ (Үг нь махбодоор илэрсэн номын “Үнэнийг хэрэгжүүлэх нь л бодит байдалтай болж байгаа хэрэг”). ‘Олон хүнд амь байдаггүй гэж яагаад хэлдэг вэ? Учир нь тэд Бурханыг мэддэггүй болохоор зүрх сэтгэлд нь Бурхан байхгүй, тэдэнд амь байхгүй гэж хэлдэг’ (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурханыг мэддэг хүмүүс л түүнд гэрчлэл хийж чадна”). Христ бол үнэн, зам, амь гэдгийг Бурханы үгээс бид харж болно. Үнэн хүмүүсийн амь болж чаддаг тул үнэнийг олж авна гэдэг амь олж авахтай адилхан бөгөөд амьтай байх нь хүн үнэнийг олж авсан, Бурханыг мэддэг гэдгийг илтгэдэг. Үнэнийг ойлгодоггүй, Бурханы хүслийг ойлгодоггүй хүн Бурханаас эмээх сэтгэлгүй байх бөгөөд Бурханы үгийн бодит байдлыг амьдран харуулж чадахгүй. Өөрөөр хэлбэл, тэд ямар ч амьгүй байдаг. Хэрэв хүн Бурханы үгийг амиа болгоогүй бол өөрсдийнх нь дотор төрөлхөөс байдаг Сатаны хорын дагуу амьдарсаар байх болно. Тэд биеэ тоосон, ихэрхүү, аминчхан, жигшүүртэй, зальхай, ов мэхтэй байдал гэх зэрэг завхарсан зан чанараа байнга илчилдэг. Тэгээд Бурханд итгэдэг байлаа ч гэсэн Бурханаас эмээж, муугаас зайлж чаддаггүй. Тэд байнга худал хэлж, хууран мэхэлж, нүгэл үйлдэж, Бурханыг эсэргүүцсээр байдаг. Тэднийг ер нь яаж амьтай хүмүүс гэж нэрлэж болох юм бэ? Хэрэв тэд өөрсдийгөө амьтай гэж хэлбэл энэ нь Бурханы үгийг туулж, үнэнийг олж авснаар үүсдэг шинэ амь биш, харин ердөө л Бурханыг эсэргүүцдэг завхарсан зан чанараар дүүрэн өнөөх махан биеийн, сатанлаг амь байдаг. Иймээс пастор, ахлагчид Библийг мэддэг, Библи болон теологийн онолын талаар мэдлэгтэй байж болох ч, энэ нь Бурханыг мэддэг, Бурханаас эмээдэг, үнэнийг ойлгож, Ариун Сүнсний ажилтай байдаг гэсэн үг биш юм. Мөн тэд Эзэний үгийг хэрэгжүүлж, Түүнийг дуулгавартай дагадаг гэсэн үг яавч биш. Харин ч тэд ихэвчлэн өөрсдийгөө өргөмжилж, гэрчилж, гол төлөв итгэгчдээр өөрсдийгөө шүтүүлэхээр оролддог нь харагддаг. Тэд биеэ тоосон, ихэрхүү, Бурханаас айх айдасгүй байж, хүмүүсийг хуурахын тулд хоёр нүүр гаргаснаар Сатаны төрхийг л илчилж, амьдран харуулдаг. Тэд Эзэний үгийн талаарх ямар ч бодитой мэдлэг, бусад хүнд ашиг тустай аливаа бодит туршлагын талаар ажлаараа ч, номлолоороо ч ярьж чаддаггүй. Тэднийг хэчнээн олон жил сонслоо ч гэсэн ямар нэг үнэнийг хэзээ ч ойлгохгүй бөгөөд амь чинь хэзээ ч өсөхгүй. Тэд Бурханы талаар, мөн Түүний ажлын талаар ямар ч мэдлэггүй байдаг ба Бурхан үнэнийг илэрхийлж, шүүлтийн ажлаа хийхээр эцсийн өдрүүдэд махбодод эргэн ирэх үед зүрх сэтгэлдээ Бурханаас айх өчүүхэн төдий ч айдасгүйгээр улайран эсэргүүцэж, яллаж, доромжилдог. Тэдэнд ямаршуухан амь байдаг вэ? Сатаны амь л байдаг. Тэд Библийг сайн мэддэг, өөрсдийгөө Бурханд чин сэтгэлээсээ итгэдэг, амьтай гэж боддог



---

байсан ч Бурханыг мэдэлгүй, бүр Эзэнийг эсэргүүцэж, яллаж, загалмайд цовдолсон фарисайчуудтай яг адил. Хүн Библийг сайн мэддэг байлаа гээд үнэн болон амьтай байдаг гэсэн үг биш гэдгийг энэ нь бидэнд хэлж байна. Үнэнийг ойлгож, хэрэгжүүлдэг, Бурханыг мэддэг, Бурханаас эмээх зүрх сэтгэлтэй, Бурханы үгийн дагуу амьдарч чаддаг хүмүүс л амьтай байдаг. Өөрсдийгөө нэлээд их амьтай гэж тэр пастор, ахлагчид хэлдэг нь итгэгчдийг мэхэлж, өөрсдийгөө хуурч байгаа хэрэг юм.”

Төгс Хүчит Бурханы үг, Ван эгчийн нөхөрлөлийг сонссоны дараа оюун санаанд минь бүх зүйл тов тодорхой болсон юм. Библийг сайн мэддэг, тайлбарлаж чаддаг байлаа гээд үнэнийг ойлгодог, Бурханыг мэддэг, амьтай байдаг гэсэн үг биш юм байна. Өмнө нь би өндөр дээд байр суурьтай, теологи судалсан, Библийн мэдлэгтэй хүмүүс бүгд маш их амьтай байдаг гэж боддог байлаа. Гэвч миний үзэл бодол ямар ч утгагүй байсныг одоо ойлгов. Үнэнгүй хүмүүс ялган салгаж чаддаггүй бөгөөд амархан хууртдаг юм шиг байна. Тэгээд би Ван эгчээс нэг асуулт асуулаа: “Төгс Хүчит Бурхан үгээ маш сайн хэлэх юм. Бид Түүний үгийг няхуур уншихад л Бурханы үг, Бурханы дуу хоолой мөн гэдгийг нь ухаарна шүү дээ. Гэтэл пастор, ахлагчид яагаад үүнийг хүлээн зөвшөөрөхгүй, бүр Түүнийг эсэргүүцэж, яллахын тулд чадах бүхнээ хийдэг юм бэ?” Ван эгч ийн хариулав: “Одоо эцсийн өдрүүдэд Төгс Хүчит Бурхан ирээд, завхарсан хүн төрөлхтнийг цэвэрлэж, аврахад шаардлагатай бүх үнэнийг илэрхийллээ. Эдгээр үнэн бол Бурханы бидэнд хайрласан мөнх амийн зам юм. Хүмүүс Бурханы үгийг нухацтайгаар уншиж байгаа цагт эдгээр үг бол үнэн, зам, амь мөн бөгөөд хүн төрөлхтний амьд үлдэх үндэс суурь, хөтөч юм гэдгийг хүлээн зөвшөөрөх болно. Энэ бол баримт. Хэдийгээр ихэнх пастор, ахлагч Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг эсэргүүцэж, яллан, Төгс Хүчит Бурханы үгийг уншихад нь хүмүүст саад хийхээр оролддог ч тэдгээр үгэн дэх эрх мэдэл, хүч чадлыг сонсож чадахгүй гэсэн үг биш. Зарим пастор, ахлагчид ямар ч хэрэгтэй зүйл номлож чадахгүй болохоороо Төгс Хүчит Бурханы үгийг хулгайлж, итгэгчдэдээ номлодог бөгөөд үүнийгээ Ариун Сүнсний өөрсдөд нь хайрласан гэгээрэл гэгцээдэг. Гэвч тэд яагаад Төгс Хүчит Бурханыг улайран эсэргүүцэж, яллсаар байдаг юм бэ? Энэ нь үнэнийг үзэн яддаг уг чанар, мөн чанартай нь холбоотой. Эзэн Есүс анх ажлаа хийж эхэлсэн үеийг эргэн санавал, Тэрээр олон гайхамшиг үзүүлснээс ялангуяа Лазарыг дахин амилуулж, таван мянган хүнийг таван талх, хоёр загасаар хооллосон нь Иудейн газар нутаг даяарх ард түмний хувьд илүү гайхамшигтай байлаа. Иймээс тухайн үед эгэл жирийн олон хүн Эзэн бол Мессиагийн ирэлт мөн гэдгийг үг, ажлаас нь таньсан юм. Гэвч иудейчүүдийн удирдагчид Эзэн Есүсийг хүлээн зөвшөөрөхийн оронд Түүнийг эсэргүүцэж, яллаж, эцэстээ Ромын засгийн газартай хуйвалдан Эзэнийг цовдолсон. Яагаад ийм зүйл болсон юм бэ? Тэд Эзэн Есүсийн үгэн дэх эрх мэдэл, хүч чадлыг сонсож чадаагүй учраас тэр үү? Үгүй ээ! Эзэн Есүсийн замыг улам

---

олон хүн хүлээн зөвшөөрч байхыг харснаас тэр юм. Бүхий л эгэл ард Эзэн Есүст итгэх юм бол өөрсдийг нь хэн ч дагахгүй, шүтэхгүй бөгөөд тэд байр суурь, амин зуулгаа алдана гэж бодсон учраас тэгсэн юм. Эзэн Есүс бол Бурхан гэдгийг тэд тодорхой мэдэж байсан атлаа Түүнийг албаар эсэргүүцсэн байдаг. Энэ нь Бурханыг эсэргүүцэж, үнэнийг үзэн яддаг антихрист мөн чанарыг нь илчилсэн билээ. Эзэн Есүс тэднийг ихэд зэмлэж, ийнхүү хэлсэн: **‘Гэхдээ одоо та нар Бурханаас үнэнийг сонсоод та нарт хэлсэн хүнийг буюу Намайг алахаар хичээж байна’** (Иохан 8:40). **‘Яагаад та нар Миний хэлсэн үгийг ойлгодоггүй юм бэ? Та нар Миний үгийг сонсож чаддаггүйгээс болж байгаа юм. Та нар эцэг диаволаасаа гаралтай бөгөөд эцгийнхээ хүслийг хийх болно. Тэр анхнаасаа алуурчин байсан ба түүнд ямар ч үнэн байхгүй тул Үнэнийг баримталдаггүй’** (Иохан 8: 43–44). Одоо үед, шашны нийгэмлэгийн өнөөгийн удирдагчдын уг чанар болон мөн чанарыг Төгс Хүчит Бурханы үг тов тодорхой илчлээд байна. Төгс Хүчит Бурхан ингэж хэлсэн байдаг: **‘Том сүмд Библи уншиж, үүнийг бүхэл өдөржингөө цээжээр уншдаг хүмүүс байдаг атал тэдний дундаас нэг нь ч Бурханы ажлын зорилгыг ойлгодоггүй. Тэдний дундаас нэг нь ч Бурханыг мэдэж чаддаггүй; тэдний дундаас бүр нэг ч хүн Бурханы хүсэлд нийцэж чаддаггүй. Тэд бүгдээрээ үнэ цэнгүй, өөдгүй хүмүүс бөгөөд Бурханд зааж сургахын тулд дор бүрнээ өндөрт зогсдог. Тэд Бурханы нэрээр далайлгадаг атлаа Түүнийг дур зоргоороо эсэргүүцдэг. Бурханд итгэдэг гэх атлаа тэд хүний махыг идэж, цусыг уусаар байдаг. Ийм хүмүүс бүгд хүний сүнсийг залгидаг диаволууд, зөв замд орохоор хичээж буй хүмүүст зориуд саад учруулдаг толгойлогч чөтгөрүүд, мөн Бурханыг эрж хайдаг хүмүүст садаа болдог бул хар чулуу билээ. Тэд “эрүүл чийрэг бие махбодтой” харагдаж болох ч Бурханыг эсэргүүцэхэд хүмүүсийг хөтөлдөг антихристүүдээс цаашгүй гэдгийг дагагчид нь яаж мэдэх юм бэ? Хүний сүнсийг залгидаг амьд диаволууд гэдгийг дагагчид нь яаж мэдэх юм бэ?’** (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурханыг мэддэггүй бүх хүн бол Бурханыг эсэргүүцдэг хүмүүс юм”). Өнөөдөр шашны нийгэмлэгийн энэ удирдагчид яг л хуучин цагийн фарисайчууд шиг байгаа юм. Тэд Библийг сайн мэддэг хэрнээ Бурханы ажлын талаар юу ч мэддэггүй. Тэгээд Бурханы илрэлтийг хүсэн хүлээж, эрж хайдаг улам олон хүн Төгс Хүчит Бурханы үгийг хүлээн зөвшөөрч байгааг хараад, итгэгчид бүгд Төгс Хүчит Бурханд итгэх юм бол хэн ч өөрсдийг нь дагаж, мөнгө хандивлахаа болино гэхээс айж байна. Иймээс тэд байр суурь, амин зуулгаа хамгаалахын тулд Эзэнд үнэнч байж, Түүний сүргийг хамгаалж байна хэмээх нэрийдлээр Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг улайран эсэргүүцэж, яллаж байгаа бөгөөд үнэн замыг эрж хайж, судлахад нь итгэгчдэд саад болохын тулд чадах бүхнээ хийдэг. Иймээс шашны удирдагчид бол үнэндээ үнэнээс залхсан, үнэнийг үзэн яддаг фарисайчууд гэдгийг бид эдгээр баримтаас харж болно. Тэд бол хүмүүсийн сүнсийг залгидаг амилсан чөтгөр, Бурханы эцсийн өдрүүдийн ажлаар

---

илчлэгдэж буй антихристүүд юм.”

Бурханы үг болон эгчийн нөхөрлөлийг сонссоныхоо дараа би гэнэт ухаарлаа. Тэгээд хэдэнтээ толгой дохин, ийн хэлэв: “Тэр пастор, ахлагчид Бурханыг эргэн ирсэн гэдэгт хүмүүс гэрчлэл хийж байгааг сонсоод, эрж хайж, судлахын оронд Түүнийг тууштайгаар ялладгийн учрыг би одоо л эцэст нь ойлголоо. Тэрхүү пастор, ахлагчид намайг хамгаалж байна, аминд минь санаа тавьж байна гэж чангаар зарладаг ч үнэндээ намайг хойш чангааж, Бурханы үгийг унших, Бурханаас амийн тэжээл олж авахад минь саад хийхээр чадах бүхнээ хийж байдгийн учрыг би одоо ойлгож байна. Учир нь тэдний хийдэг бүхэн өөрсдийнхөө ашиг сонирхлыг хамгаалахын тулд байдаг юм байна. Хүмүүс Төгс Хүчит Бурханыг дагаад эхэлбэл өөрсдийнх нь номлолыг сонсохгүй, мөнгөө хандивлахгүй гэж айдаг болохоороо тэд үнэн замыг судлахад нь хүмүүст саад хийдэг юм байна. Тэд үнэхээр жигшүүртэй юм, бас тэд жинхэнэ аврал хүртэх боломжийг минь сүйтгэх шахлаа. Би илүү сайн ялган таньж мэддэг болсон болохоор тэдэнтэй холбоотой байхаас татгалзана. Тэд саад болохоор юу ч хийлээ гэсэн би бат зогсож, Төгс Хүчит Бурханыг дагах болно.” Үүний дараа би хуучин чуулганыхаа цуглаанд дахин хэзээ ч очоогүй билээ.

Удалгүй хуучин чуулганы маань хоёр номлогч манай гэрт ирлээ. Тэдний нэг нь болох Жан номлогч надад: “Эгч ээ, та яагаад цуглаанд ирэхгүй байна аа? Зүүний Аянтын хүмүүстэй дахиад холбогдоо юу? Та юу ч хийлээ гэсэн тэдний итгэлд битгий ороорой. Хэрэв та тэдний итгэлийг дагах юм бол өнгөрлөө л гэсэн үг!” гэв. Би итгэлтэй дуугаар ийнхүү хариуллаа: “Ойрд танай цуглаанд оролцоод би юу ч олж авсангүй. Сүнс минь улам их харанхуйлж, Эзэний байгааг мэдэрч чадахгүй байлаа. Гэвч Төгс Хүчит Бурханы үгийг уншиж эхэлснээс хойш сүнс минь өөдрөг болж, одоо үнэнийг ойлгож эхлэн, амь минь тэжээгдэж байна. Бурхан надтай хамт байгаа, Ариун Сүнс над дээр ажиллаж байгаа нь мэдрэгдэж байна. Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс, Төгс Хүчит Бурханы илэрхийлсэн үнэн нь амийн амьд ус гэдэгт би одоо итгэлтэй болсон. Төгс Хүчит Бурханы үг л надад тэжээл өгч чаддаг, би хаанаас амь олж авч чадна, тийшээ л явах болно.” Нөгөө номлогч нь болох Сон пастор тэгэхэд: “Бид таны талаар санаа зовж байна. Зөв замаас гажих вий гэж санаа зовж байна шүү дээ. Таны амь боловсроогүй...” гэв. Би түүнд: “Амь минь боловсроогүй байсан ч гэлээ Бурхан намайг залж чиглүүлэх л болно. Санаа зовсонд тань баярлалаа, гэхдээ та нар өөрсдийнхөө амийг бодох хэрэгтэй. Миний амь Бурханы гарт байгаа...” Миний хэлсэн үгийг сонсоод тэд унтууцан явж одоцгоосон юм. Тэдний алслан одохыг хараад би урьд өмнө нь хэзээ ч мэдэрч байгаагүй асар их тайвшралыг мэдрлээ. Дараа нь тэд дахиад хоёр удаа ирсэн ч ятгалгад нь миний сэтгэл огт хөдлөхгүй байгааг хараад дахин хэзээ ч ирээгүй юм. Бурхан намайг замчилсны ачаар би тэрхүү шашны удирдагчдын үнэн нүүр царай, хорон муу сэдлийг нэвт харж, Сатаны заль мэхийг

---

ч мөн нэвт харан, төөрөгдлөөс гарч, Бурхан руу эргэн ирсэн юм. Одоо би амийн амьд усаар хангагдаж байгаа бөгөөд Төгс Хүчит Бурханыг үргэлж дагаж, шүтэн мөргөх болно!

## 8. Төгс Хүчит Бурхан намайг цэвэр болох замд хөтөлсөн

Ганчиан, АНУ

Би амьжиргаагаа залгуулахын тулд 2007 онд ганцаараа Сингапурт ажиллахаар ирсэн юм. Жилийн турш Сингапурын цаг агаар маш халуун байдаг учраас би өдөр бүр ажиллаж байхдаа асар их хөлөрдөг байлаа. Үнэхээр хүнд бэрх байсан учраас би үгээр илэрхийлэхийн аргагүй зовж зүдэрч, дээрээс нь ямар ч хамаатан садан, найз нөхөдгүй, дасал болоогүй амьдрал байсан тул энэ нь надад уйтгартай, залхмаар санагддаг байв. Наймдугаар сарын нэгэн өдөр би ажлаас харьж явах замдаа сайн мэдээний зурагт хуудас хүлээн авсан бөгөөд тэнд: “Христ Есүс дотор та нарыг мөнхийн алдар луугаа дуудсан бүх нигүүлслийн Бурхан Өөрөө, хэсэг зуур зовсны чинь дараа та нарыг төгс болгож, бататгаж, бэхжүүлж, байгуулах болно” (1 Петр 5:10) гэж бичсэн байлаа. Эдгээр үгийг уншаад би зүрх сэтгэлдээ халуун дулааныг мэдрэв. Дараа нь би чуулган руу ахыг даган явлаа. Мэндийг минь асуун ах эгч нар урамтай угтсан нь надад урт удаан хугацаанд байгаагүй гэр бүлийн минь халуун дулааныг мэдрүүллээ. Нүд минь гэнэтхэн халуун нулимсаар дүүрч, гэртээ ирсэн мэт мэдрэмж надад төрөв. Тэр цагаас хойш ням гараг бүрд чуулган миний байх ёстой газар боллоо.

Би 12-р сард баптизм хийлгэж, Эзэнд итгэх замд албан ёсоор орсон билээ. Чууланд орсон хойноо би номлогчийг Матайн 18-р бүлгийн 21-22-р хэсгийг уншихыг сонсов: “Дараа нь Петр Түүн дээр ирж, ‘Эзэн минь, ах дүү маань миний эсрэг бурууг үйлдвэл би түүнийг хэдэн удаа уучлах вэ? Долоон удаа юу?’ гэв. Есүс түүнд: **‘Би чамд долоон удаа биш, харин дал дахин долоон удаа гэж хэлье’** гэжээ.” Үүнийг сонсоод би дотроо ингэж бодлоо: “Эзэн Есүсийн уучлал, тэвчээр яаж ийм агуу байж чаддаг юм бэ? Тэр хүмүүст дал дахин долоон удаа уучлал өгнө. Хүмүүс үнэхээр ингэж чаддаг байсан бол хүмүүсийн дунд тэмцэл гэж үгүй, хайр, халуун дулаан л байх байсан!” Эзэний үг сэтгэлийг минь маш их хөдөлгөж, би Эзэний сургаалын дагуу явна хэмээн шийдлээ.

Хоёр гурван жилийн дараа дарга маань надад барилгын талбайн удирдлагыг хариуцуулан өгсөн учраас би бүх эрч хүчээ ажилдаа зориулж, яваандаа цуглаанд оролцохоо болив. Дараа нь найзынхаа танилцуулснаар би Ли даргатай уулзаж, түүнтэй хамт барилгын компани байгууллаа. Би маш аз жаргалтай байсан бөгөөд их хүчин зүтгэл гаргана хэмээн сэтгэл шулуудсан юм. Тухайн үед би мөнгөний эргүүлэгт бүрмөсөн автаж,

---

цуглаанд оролцохоор чуулган руу явахаа болив. Төсөл амжилттай болж, өрсөлдөх чадвараараа бусдаас магтаал хүртэхийн тулд ажилчдаасаа шаарддаг шаардлага минь улам нэмэгдэж, илүү хатуу боллоо. Тэднийг ямар нэг зүйл зүй зохисгүйгээр юм уу, миний шаардлагаас өөрөөр хийх юм бол би загнадаг байсан бөгөөд багийн ахлагч нь миний зүхлээс болж ихэвчлэн нулимс унагахад хүрдэг байв. Ажилчид намайг харах бүрдээ айж, бүр надаас нуугддаг байлаа. Хуучны сайн найзууд маань ч намайг тоохоо байж, надад сэтгэлээ уудлахаа болив. Энэ байдлыг хараад би ихэд шаналсан! Эзэн Есүс бидэнд бусдыг дал дахин долоон удаа уучил, хөршөө өөр шигээ хайрла гэж сургадаг. Гэвч би үүнийг өчүүхэн төдий ч хэрэгжүүлээгүй, ганц ч удаа хийгээгүй. Үүнийг яаж Христэд итгэгч байна гэх вэ? Би нүгэл үйлдсэнээ мэдэж байсан бөгөөд нүглээ улайн, гэмшиж, Эзэнд ойр ойрхон залбирдаг байв. Би өөрийгөө өөрчлөхөөр шийдлээ. Гэхдээ ямар нэг зүйл болох бүрд би өөрийн эрхгүй нүгэл үйлддэг байв. Сэтгэл минь ихэд шаналж байлаа.

2015 оны наймдугаар сард компани маань тааруу байсан учраас бид ажил хэргээ түр зогсоож, би гэртээ эргэж очив. Сэтгэл санаа минь дарамттай, гутруу байсан учир би өдөржин архи ууж, хөзөр тоглодог байв. Намайг уухаа боль гэж хэлэхээр нь эхнэрээ би аймшигтайгаар зүхэж: “Энэ чинь миний мөнгө, би олсон юм, мөнгөө би хүссэнээрээ зарцуулна...” гэж хэлдэг байлаа. Эхнэр минь яаж ч чадалгүй цааш суун уйлдаг байв. Би уураа гаргах бүрийдээ гэмшдэг байсан ч, биеэ барьж дийлдэггүй байсан юм. Тэр үед би Христэд итгэгчийн бүх зүй зохистой байдлыг бүрэн алдсан байв. Зан авир болон биеэ авч явах байдал минь үл итгэгчийнхтэй адил байлаа.

Би арга ядаж, зовж шаналж байх үедээ цуглаанд оролцохоор чуулган руу дахин явав. Тэр үед би Эзэн Есүст тогтмол залбирдаг байв: “Өө, Эзэн минь! Би хийхийг хүсээгүй олон зүйлээ хийж, хүмүүсийг шархлуулах олон үг хэлсэн. Би үргэлж нүгэлд амьдран, Таны эсрэг тэрсэлж ирсэн. Нүгэл үйлдэх болгондоо би гэмшиж, өөрийгөө тэр дундаа үзэн яддаг боловч биеэ барьж огт чадахгүй юм! Орой нь би нүглээ улайдаг ч, өдрөөр би хуучин зангаа тавилгүй дахиад л нүгэл үйлддэг. Өө, Эзэн минь! Намайг авраач гэж Танаас гуйя, нүглээс салахын тулд би яах ёстой вэ?”

2016 оны шинэ он гарахын өмнөх өдөр би Нью-Йоркт амьдрахаар очиж, Америкийн нутаг дэвсгэр дээр хөл тавилаа. Чөлөөт цагаараа би цуглаанд оролцохоор чуулганд явдаг байв. Түүнчлэн би гэрчлэлийн бүлэгт оролцож, ах эгч нартай цуг Библи уншин, хамтдаа залбирдаг байлаа. Тэнд би Чинлиань гэдэг эгчтэй танил болов. Нэг өдөр Чин Лиань эгч залгаад, надад хэлэх сайхан мэдээ байна гэв. Би “Ямар сайхан мэдээ вэ?” гэлээ. Эгч, “Энд номлогч иржээ. Чи явж, номлогчийн яриаг сонсмоор байна уу?” гэв. Би, “Гайхалтай! Хаана юм бэ?” гэлээ. Эгч тэгээд намайг гэртээ ирүүлэх цаг товлосон юм.

---

Товлосон өдрөө би Чин Лиань эгчийн гэрт очив. Тэнд хэд хэдэн ах эгч байсан бөгөөд бие биетэйгээ мэнд мэдсэний дараа хүн бүр өөрсдийгөө танилцуулаад, Библийг хэлэлцэж эхлэв. Би Жао эгчийг маш гэгээрмээр нөхөрлөл хийхийг сонсоод, эндээс асар их үр ашиг хүртсэн мэт санагдав. Тэгээд би Жао эгчид тогтмол нүгэл үйлдэж, нүглээ улайдаг тухайгаа болон нүглээсээ ангижирч чадахгүй байгаа зовлонгоо ярьж, тусламж хүслээ. Дараа нь эгч надад нөхөрлөл хийж, Эзэнд итгэж эхэлсний дараа ч гэсэн үргэлж нүгэл үйлдсээр л байдаг бөгөөд өдөр нь нүгэл үйлдэж, орой нь нүглээ улайдаг мөчлөгөөр эргэлдэж, үүнээсээ хэзээ ч ангижирч чаддаггүй амьдралаар амьдардаг нь ганц надад тулгарсан асуудал бус, харин Эзэнд итгэдэг бүх хүнд нүүрлэдэг асуудал болохыг хэлэв. Жао эгч дараа нь бидэнд Бурханы үгийн зарим нэг уран уншлагын дүрс бичлэг үзүүлэв. Дүрс бичлэгт эдгээр үгийг хэллээ: **“Иймээс хүний эрүүл ухааны анхдагч чиг үүрэг нь алдагдаж, мөс чанарынх нь анхдагч чиг үүрэг ч алдагдсан гэж Би хэлнэ... Өөрийн мөн чанарыг мэдэхээс эхлээд үзэл санаа, уг чанар, оюун санааны төлөв гэх үндсэн өөрчлөлтөөр дамжин хүний зан чанар өөрчлөгддөг. Ийм маягаар л хүний зан чанарт жинхэнэ өөрчлөлт гарна. Сатанд хорлогдож, дэвслүүлэн, үзэл санаа, ёс суртахуун, мэдлэг ухаан, эрүүл ухаанд нь Сатан ноцтой хор хүргэсний улмаас хүнд ялзарсан зан чанар үүсдэг. Суурь зүйлийг нь Сатан завхруулж, Бурханы анх бүтээсэнтэй огт адилгүй болгосон учраас л хүн Бурханыг эсэргүүцэж, үнэнийг ойлгодоггүй. Тиймээс Бурханы талаарх мэдлэг, үнэний талаарх мэдлэгийг нь өөрчлөх үзэл санаа, мэдлэг ухаан, эрүүл ухааны өөрчлөлтөөс нь хүний зан чанарын өөрчлөлт эхлэх ёстой”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Зан чанар чинь өөрчлөгдөхгүй байх нь Бурханд дайсагнаж буй хэрэг”).

Эдгээр үгийг сонсоод сэтгэл минь их хөдөлсөн бөгөөд “Тэд миний тухай яриад байгаа юм биш үү? Би ямар ч ёс зүй, учир шалтгаангүйгээр үргэлж бусдыг дорд үзэж, тэдэнд энэ тэрийг зааж, иймээ тиймээ юманд хараан, ариун хүний цадигийг алдсан.” Эдгээр үг бүгдээрээ оршихуйн минь голыг сүлбэсэн юм. Би өмнө нь ийм үг хэзээ ч уншиж байгаагүй, ингэж ярьдаг номлогчийг ч сонсоогүй. Энэ бүх хугацаанд би ойр ойрхон нүгэл үйлддэгээсээ болж шаналдаг байсан боловч нүгэлд толгойгоо мэдүүлэхээ больж хэзээ ч чадаагүй. Эдгээр үг надад нүглийг орхих замыг харуулж, би гайхан шагшив: Эдгээр үгийг маш сайн бичсэн байна, гэхдээ эднийг хэн бичсэн байж болох вэ?

Энэ нь Бурханы үг гэдгийг, мөн Эзэн Есүс аль хэдийн махбодод эргэн ирээд, эцсийн өдрүүдэд үгээрээ дамжуулан хүмүүсийг шүүж, цэвэрлэх ажил хийж байгаа гэдгийг Жао эгч надад хэлсэн юм. Энэ мэдээг би сонсоод чихэндээ ч итгэж чадсангүй. Эзэнд итгэгчид дундаас Түүний эргэн ирэхийг хүлээдэггүй хэн байх билээ? Одоо би Эзэний эргэн ирсэн тухай мэдээг санамсаргүйгээр сонсож байлаа. Би үнэхээр догдолж, бүр яахаа мэдэхгүй болов: Эзэн үнэхээр эргэн ирсэн гэж үү? Энэ тухай би эгчээр даруйхан нөхөрлөл хийлгэх

---

ёстой байв. Жао эгч ингэж хэллээ, “Эзэн Есүс үнэхээр эргэн ирсэн бөгөөд Тэр бол эцсийн өдрүүдэд бие махбодтой болсон Христ буюу Төгс Хүчит Бурхан билээ. Тэрээр хүмүүсийг ариусгах, аврах талаар үнэнийг илэрхийлж, Бурханы гэрээс эхлэн шүүлтийн ажлыг эхэлсэн. Сатанлаг уг чанартаа хүлэгдэн, нүгэл дотор амьдарч, үүнээсээ ангижирч чадахгүй байж ирсэн биднийг Тэрээр Сатаны эзэмшлээс бүрмөсөн аварч, эцэстээ Бурхан биднийг аварч, олж авах болно. Нигүүлслийн эрин үед Эзэн Есүс зөвхөн золин авралын ажлыг хийн, биднийг нүглээс золин аварч, хуулийн дор биднийг яллуулахгүйн тулд нүглийг маань цагаатгасан билээ. Эзэн бидний нүглийг цагаатгасан боловч сатанлаг уг чанарыг маань болон сатанлаг зан чанарыг маань өршөөгөөгүй. Хүний дотор биеэ тоосон, зальхай зан, хувиа хичээх үзэл, шунал, хорлонт байдал болон бусад завхарсан зан чанар оршсон хэвээр байна. Эдгээр нь нүглээс илүү гүн гүнзгий нэвчсэн, номхруулахад илүү хэцүү зүйлс юм. Яг эдгээр сатанлаг зан чанар, сатанлаг уг чанарыг шийдвэрлээгүйгээс л болж бид өөрийн эрхгүй нүгэл үйлдэж, бүр хуулийг зөрчихөөс илүү ноцтой нүгэл ч үйлдсэн хэвээр байна. Хуучны Фарисайчуудын хувьд Эзэнийг загалмайд цовдолтлоо эсэргүүцэн ялласан шалтгаан нь хүний нүгэлт уг чанар шийдэгдээгүйгээс болсон биш үү? Үнэндээ бид өөрсдөө эдгээр завхарсан зан чанарын хяналтад байдаг учраас үүнийг бүгдээрээ ихэд үнэлдэг. Иймээс бид ойр ойрхон худал хэлж, зальхай үйл хийж, биеэ тоосон, ихэрхүү зантай байж, бусдыг дээрэнгүй хандлагаар зэмлэдэг юм. Бусдыг өршөөж, хөршөө өөр шигээ хайрлахыг Эзэн биднээс шаарддагийг бид тодорхой мэддэг атлаа үүнийг хэрэгжүүлдэггүй. Хүмүүс өөр хоорондоо нэгнийхээ эсрэг явуулга хийж, алдар хүнд, ашиг хонжооны төлөө тэмцэлдэж, хамтдаа эв эетэй амьдрах чадваргүй байдаг. Бид өвдөх юм уу, байгалийн гамшиг, хүнээс үүдэлтэй золгүйтлийн үеэр Бурханыг бас л буруутгаж зүрхлэн, тэр бүү хэл Бурханыг үгүйсгэж, Бурханаас урвадаг. Бид сатанлаг уг чанар, сатанлаг зан чанараа шийдвэрлэхгүй бол нүгэл үйлдэж, нүглээ улайж, дахин нүгэл үйлдэж, нүглээ улайдаг энэхүү мөчлөгт амьдралаас хэзээ ч өөрсдийгөө ангижруулж чадахгүй. Иймээс хүнийг нүглээс бүрмөсөн аврахын тулд Бурхан бидний нүгэлт уг чанарыг шийдвэрлэхийн төлөөх шүүлт, цэвэрлэлтийн ажлын үе шатаа явуулах шаардлагатай юм. Энэ замаар л бид цэвэрлэгдэж, Бурханд аврагдан, Бурханд олдож чадна. Төгс Хүчит Бурханы үгийн зарим хэсгийг уншсаны дараа бид аяндаа ойлгоно.”

Жао эгч Бурханы үгийн номыг нээж, ийнхүү уншиж эхлэв: **“Хүнийг золин аварч, нүглийг нь уучилсан тухайд бол, Бурхан хүний гэм бурууг санадаггүй, гэм буруугийнх нь дагуу хүнд ханддаггүй гэж л авч үзэж болох юм. Гэвч махан биед амьдардаг хүн нүглээс ангижраагүй бол үргэлжлүүлэн нүгэл үйлдэж, завхарсан сатанлаг зан чанараа эцэс төгсгөлгүй илчилж л чадна. Энэ бол хүний амьдардаг, нүгэл үйлдэж, нүглээ уучлуулдаг эцэс төгсгөлгүй орчлын амьдрал юм. Хүн**

---

төрөлхтний ихэнх нь өдөр нь нүгэл үйлдээд орой нь нүглээ улайдаг. Ийм маягаар нүглийн тахил хүний хувьд үүрд хүчинтэй байдаг ч энэ нь хүнийг нүглээс аварч чадахгүй. Хүн завхарсан зан чанартай байсаар байгаа тул авралын ажлын хагас нь л гүйцэлдсэн” (Үг нь махбодоор илэрсэн номын “Бие махбодтой болохын нууц (4)”). “Хэдийгээр Есүс хүмүүсийн дунд их ажил хийсэн ч бүх хүн төрөлхтний золин авралыг л гүйцэлдүүлж, хүний нүглийн тахил болсон юм; Тэрээр хүнийг бүх завхарсан зан чанараас нь салгаагүй. Хүнийг Сатаны нөлөөнөөс бүрэн аврах нь, Есүсээс нүглийн тахил болж хүний нүглийг үүрэхийг шаардаад зогсохгүй, бас хүнийг сатанлаг завхарсан зан чанараас нь бүрэн салгахын тулд улам их ажил хийхийг Бурханаас шаардсан” (Үг нь махбодоор илэрсэн номын Өмнөх үг). “Хүний нүглийг өршөөсөн нь Бурханы цовдлолын ажлаас үүдсэн боловч хүн хуучны, завхарсан сатанлаг зан чанар дотроо үргэлжлүүлэн амьдарсан юм. Ийм болохоор хүнийг сатанлаг завхарсан зан чанараас нь бүрэн аврах ёстой, ингэснээр түүний нүгэлт уг чанар дахин хэзээ ч хөгжихгүйгээр бүрэн арилж, улмаар хүний зан чанар өөрчлөгдөх боломжтой болох юм. Энэ нь амийн өсөлтийн замыг, амийн замыг болон зан чанараа өөрчлөх замыг ухаарахыг хүнээс шаарддаг. Түүнчлэн, энэ замын дагуу хэрэгжүүлж, зан чанараа аажмаар өөрчилж, гэрлийн гялбаан дор амьдарч, хийдэг бүхнээ Бурханы хүслийн дагуу байлгаж, завхарсан сатанлаг зан чанараа хаяж, Сатаны харанхуйн нөлөөнөөс ангижирч, улмаар нүглээс бүрэн ангижрахыг хүнээс шаарддаг. Тэгсэн цагт л хүн бүрэн аврал хүртэнэ” (Үг нь махбодоор илэрсэн номын “Бие махбодтой болохын нууц (4)”). Жао эгч нөхөрлөлдөө ингэж хэлэв: “Бид яагаад үргэлж сатанлаг уг чанартаа хүлэгдэж, нүглээс ангижирч чадахгүй байдаг тухайд Бурханы эдгээр үгийг уншсаны дараа бид тодорхой ойлгодог, тийм биз дээ? Нигүүлслийн эрин үед Бурхан зөвхөн золин авралын ажил хийсэн бөгөөд энэ нь хүмүүсийг шүүж, цэвэрлэж, бүрмөсөн аврах эцсийн өдрүүдийн ажил байгаагүй. Иймээс бид нүглээ хэчнээн их улайж, гэмшиж, өөрсдийгөө ялан дийлж, мацаг барин залбирлаа ч гэсэн нүгэл хийхгүй байх нөхцөлд хүрч чадахгүй. Өөрөөр хэлбэл бид нүгэлт уг чанарынхаа хүлээс, хяналтаас чөлөөлөгдөхийг хүсвэл Эзэн Есүсийн золин авралын ажлыг л туулах нь мөн л хангалтгүй байна гэсэн үг юм. Бид эргэн ирсэн Эзэн Есүсийн хийсэн шүүлтийн ажлыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Учир нь Бурхан эцсийн өдрүүдийн шүүлтийн ажлаа хийхдээ Бурханыг эсэргүүцэж, урвадаг хүний сатанлаг уг чанарыг шүүж, илчлэхийн тулд үнэний олон талыг илэрхийлдэг. Энэ нь Бурханы зөвт, ариун агаад зөрчлийг хүлцдэггүй зан чанарыг хүнд тодорхой болгож, хүнд Сатаны өөрийг нь гүн гүнзгий завхруулсан үнэнийг Бурханы үгийн шүүлт, гэсгээлтээс тодорхой харуулж, хүний зөрчлийг хүлцдэггүй Бурханы зөвт зан чанарыг үнэхээр мэддэг болгож, Бурханыг хүндэлдэг зүрх сэтгэлийг бий болгон, үүний үр дүнд хүний сатанлаг зан чанарыг өөрчилж, ариусган, хүнийг Сатаны нөлөөнөөс



---

аврагдахад хүргэдэг. Бурханы сүр жавхлан, уур хилэнт шүүлт, гэсгээлтээс бид Бурханыг нүүр тулан уулзсан мэт харж, тэнгэрээс ирж буй агуу их гэрлийг хардаг. Бурханы үг хос ирт сэлэм мэт зүрхийг минь зүсэж, Бурханыг эсэргүүцэн, Бурханаас урвадаг сатанлаг уг чанарыг маань төдийгүй бидний илрүүлэх аргагүй зүрх сэтгэлийн маань хамгийн цаад чанад дахь завхарсан зан чанарыг маань хүртэл илчлэн, бидний уг чанарын мөн чанар нь биеэ тоосон, ихэрхүү, хувиа хичээсэн, дорд, булзамтгай, зальхай зан зэрэг сатанлаг зан чанараар дүүрэн гэдгийг болон хүний төрхийн өчүүхэн ч хэлтэрхий бидэнд байхгүй, Сатаны бүрэн биелэл болохыг маань бидэнд харуулдаг. Тэр үед л бид Бурханы өмнө газар сөгдөн мөргөж, өөрсдийгөө үзэн ядан, харааж эхэлдэг. Үүний зэрэгцээ бид Бурханы үг бол үнэн бөгөөд Бурханы зан чанар болон Бурханы амь юу болохын бүх илчлэл мөн гэдгийг мэдэрдэг. Бурханы зөвт зан чанар нь зөрчлийг хүлцдэггүй бөгөөд Бурханы ариун байдлын мөн чанар нь өө сэвийг хүлцдэггүй гэдгийг бид хардаг. Үүний дүнд Бурханыг хүндэлдэг зүрх сэтгэл төрж, бид хамаг чадлаараа үнэнийг эрж хайн, Бурханы үгийн дагуу үйлдэж эхэлдэг. Үнэнийг аажмаар ойлгохоо даган бид өөрсдийнхөө сатанлаг уг чанар болон сатанлаг зан чанарыг улам бүр мэдэж, эдгээрийн тухайд улам бүр ялган таних чадвартай болдог. Бид түүнчлэн Бурханыг улам илүү мэдэж авдаг. Бидний доторх завхарсан зан чанар аажмаар цэвэрлэгдэн, бид нүглийн хүлээснээс ангижирч, жинхэнэ чөлөөлөлт, эрх чөлөөн дунд бид Бурханы өмнө амьдардаг. Хүнийг шүүх Бурханы эцсийн өдрүүдийн ажлаар хүрдэг үр дүн нь энэ яг мөн билээ. Иймээс Нигүүлслийн эрин үе дэх ‘золин аврал’-ын ажил болон эцсийн өдрүүд дэх ‘нүглээс ангижруулах’ ажил нь ажлын хоёр өөр үе шат гэдгийг харж болно. ‘Золин аврал’ нь ердөө л Эзэн Есүс хүний нүглийг оронд нь үүрч, хүмүүсийг нүглийнхээ төлөө хүртэх ёстой байсан шийтгэлээс нь мултрах боломж олгосон явдал байсан. Гэвч энэ нь хүний нүгэлгүй гэдгийг харуулаагүй, мөн хүн дахин хэзээ ч нүгэл үйлдэхгүй, бүрэн ариусгагдсан гэдгийг бүр ч харуулаагүй. Харин ‘нүглээс ангижруулах’ гэдэг нь хүний нүгэлт уг чанарыг тултал нь илчилж, хүнд цаашид завхарсан уг чанартаа түшиглэлгүйгээр амьдрах, амийн зан чанартаа өөрчлөлт хийж, бүрэн ариусах боломжийг олгох явдал. Иймээс Бурханы эцсийн өдрүүд дэх шүүлтийн ажлыг хүлээн зөвшөөрснөөр л бидний завхарсан зан чанар бүрмөсөн шийдэгдэж, бид өөрсдийгөө Сатаны нөлөөнөөс ангижруулан, аврагдаж, Бурханы хаанчлал руу хүргүүлэн, Бурханы амлалт, ерөөлийг хүртэж чадна.”

Бурханы үгийг болон эгчийн нөхөрлөсөн зүйлийг сонсоод би энэ нь үнэнтэй тун сайн нийцдэг, бодитой гэдгийг нь мэдэрлээ. Би энэ олон жил Эзэнд итгэсэн итгэлээ эргэн харав: Би ойр ойрхон худал хэлж, хууран мэхлээд зогсохгүй биеэ тоосон, цадиггүй, бүдүүлэг, бодлогогүй, гөжүүд байжээ. Манай ажлын нэгжийн ажилчид надаас айж, зайгаа барьж, гэр оронд маань манай эхнэр охин хоёр ч гэсэн надаас жаахан айдаг байв. Хэн ч надад зүрх

---

сэтгэлээ илчлэхийг хүсдэггүйгээс гадна надад ч сэтгэлээ уудлах дотно найз нөхөр олддоггүй байв. Энэ зовлонтой байсан. Би үргэлж Библи уншин залбирч, Эзэнд нүглээ улайн, бүр өөрийгөө жигшсэн ч дараа нь дахин нүгэл үйлдэж эхлэн, өөрийгөө огт өөрчилж чадаагүй. Үе үе нүгэл үйлдэж, Эзэнийг эсэргүүцдэг над шиг хүнд Бурханы аврал их хэрэгтэй! Одоо Эзэн Есүс аль хэдийн бие махбодтой болсон Төгс Хүчит Бурхан болж эргэн ирээд байна. Өнөөдөр би Бурханы дуу хоолойг сонсож, Эзэн Есүс үнэнийг авчран, хүнийг шүүх, цэвэрлэх, аврах ажлыг гүйцэтгэхээр дахин ирснийг мэдэж авах зол завшаантай учирч чадна, би үнэхээр асар их азтай юм! Намайг хүсэл тэмүүллээр дүүрэн байгааг эгч хараад, надад “Бурханы хонин сүрэг Бурханы дуу хоолойг сонсдог” хэмээх Бурханы үгийн номын нэг хувийг өглөө. Би номыг баяртайгаар авч, Төгс Хүчит Бурханд сайтар итгэнэ хэмээн шийдлээ.

Би Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүд дэх ажлыг хүлээн зөвшөөрснийхөө дараа Бурханы олон үгийг уншсан юм. Бурханы ажлын гурван үе шат, бие махбодтой болохын нууц, Бурханы нэрийн утга учир болон Ариун Библийн дотоод түүхийн талаар болоод ялагчдыг хэрхэн бий болгодог, Христийн хаанчлал хэрхэн биеллээ олдог, төрөл бүрийн хүний эцсийн үр дүн, хүрэх газар хэрхэн ялгаатай байх, үнэний эдгээр болон бусад талын тухай би аажмаар жаахныг ойлгов. Мөн би Бурханд илүү итгэдэг боллоо.

Эхэндээ би хүнийг хатуугаар шүүж, илчилдэг Бурханы үгийг уншаад бачимдаж, эвгүй байдаг байв. Миний дотор зарим нэг үзэл байсан бөгөөд надад Бурханы үг хэтэрхий хатуу санагддаг байсан юм. Тэр жаахан зөөлөн байж болоогүй юм уу? Бурхан хүнийг энэ маягаар шүүвэл хүн яллагдах бус уу? Тэгвэл хүн яаж аврагдаж чадах юм бэ? Дараа нь би Бурханы үгнээс ингэж уншсан юм: **“Эцсийн өдрүүдэд Христ хүнийг сургах, хүний мөн чанарыг ил болгох, хүний үг болон үйлдэлд нь дүн шинжилгээ хийхийн тулд төрөл бүрийн үнэнийг хэрэглэдэг. Хүний үүрэг, хүн яаж Бурханд дуулгавартай байх ёстой, хүн яаж Бурханд үнэнч байх ёстой, хүн яаж хэвийн хүн чанарыг амьдран харуулах учиртай болон Бурханы мэргэн ухаан, зан чанар гэх зэрэг төрөл бүрийн үнэн эдгээр үгэнд агуулагддаг. Эдгээр үг нь бүгд хүний мөн чанар болон ялзарсан зан чанар луу чиглэдэг. Ялангуяа, хүн Бурханыг хэрхэн голдгийг илчилсэн үгсийг хүн бол Сатаны биелэл, Бурханы эсрэг дайсны хүч болдог тухайд хэлсэн байдаг. Шүүлтийн ажлаа хийхдээ Бурхан хүний уг чанарыг ердөө хэдхэн үгээр тодорхой болгодог юм биш; Тэрээр удаан хугацааны туршид илчилж, харьцаж, засдаг. Илчлэл, харьцалт болон засалтын эдгээр аргыг энгийн үгээр бус, харин хүнд огт байдаггүй үнэнээр л орлуулж болно. Зөвхөн ийм төрлийн арга барилыг л шүүлт гэж нэрлэж болно; ийм төрлийн шүүлтээр л дамжуулан хүн номхорч, Бурханд захирагдахаар бүрэн үнэмшээд зогсохгүй, Бурханы тухай жинхэнэ мэдлэгийг олж авч чаддаг”** (Үг нь махбодоор

---

илэрсэн номын “Христ шүүлтийн ажлыг үнэнээр хийдэг”). “Бурхан юугаар дамжуулан хүнийг төгс болгодог вэ? Өөрийнхөө зөвт зан чанараар дамжуулан үүнийг гүйцэтгэдэг. Бурханы зан чанар нь үндсэндээ зөвт байдал, уур хилэн, сүр жавхлан, шүүлт, хараалаас бүрддэг бөгөөд хүнийг үндсэндээ шүүлтээр дамжуулан төгс болгодог. Зарим хүн ойлгодоггүй бөгөөд Бурхан яагаад хүнийг шүүлт, хараалаар л төгс болгож чаддаг юм бэ гэж асуудаг. Тэд: ‘Бурхан хүнийг хараавал хүн үхэхгүй гэж үү? Хэрэв Бурхан хүнийг шүүвэл хүн яллагдахгүй гэж үү? Тэгвэл түүнийг яаж бас төгс болгож чадах юм бэ?’ гэгцгээдэг. Энэ бол Бурханы ажлыг мэддэггүй хүмүүсийн үг юм. Бурхан хүний дуулгаваргүй занг харааж, хүний нүглийг шүүдэг. Тэрээр хатуу ширүүнээр, өчүүхэн ч мэдрэмжгүйгээр ярьдаг хэдий ч хүний дотор буй бүхнийг илчилж, эдгээр хатуу үгээр хүний доторх гол зүйлийг ил болгож, ийм шүүлтээр дамжуулан махан биеийн мөн чанарын талаар хүнд гүн гүнзгий мэдлэг өгч, улмаар хүн Бурханы өмнө дуулгавартай захирагддаг. Хүний махан бие нүгэл болон Сатанд харьяалагддаг, энэ нь дуулгаваргүй бөгөөд Бурханы гэсгээлтийн бай юм. Тиймээс хүнд өөрийгөө мэдэх боломжийг олгохын тулд Бурханы шүүлтийн үг түүн дээр буух ёстой ба төрөл бүрийн цэвэршүүлэлт хэрэглэх ёстой; зөвхөн тэр үед л Бурханы ажил үр нөлөөтэй болж чадна” (Үг нь махбодоор илэрсэн номын “Зовлонг шалгалтыг туулснаар л Бурханы хайр татам байдлыг мэдэж болно”). Бурхан үнэнийг илэрхийлэх замаар эцсийн өдрүүд дэх шүүлтийн ажлаа хийдэг гэдгийг, мөн Тэрээр хүний завхарсан зан чанар, сатанлаг уг чанар болон Бурханыг эсэргүүцэх хорон муу үйл хэргийг хатуу шүүж, илчилж, ялладаг гэдгийг би Бурханы үгнээс ойлгосон юм. Тэрээр бидэнд өөрсдийн маань завхралын үнэнийг тодорхой харуулах, завхарсан зан чанарын маань мөн чанарыг бүрэн ойлгуулах, сатанлаг уг чанар болон завхралын маань эх сурвалжийг бүрэн ойлгуулахын тулд үүнийг хийдэг, учир нь энэ замаар л бид өөрсдийгөө үзэн ядаж, махан биеэ хаяж чадах билээ. Үүний зэрэгцээ Бурхан зөвт, сүр жавхлант, уур хилэнт зан чанараа шүүлт, гэсгээлтдээ үзүүлдэг учраас л бид Түүний зөвт, ариун байдлыг харж, өөрсдийн бузар булай, муу муухай, хорон муу байдлыг тодорхой харж чаддаг. Түүнчлэн биднийг өөрсдийнхөө сатанлаг уг чанарыг болон завхралынхаа үнэнийг мэдэг хэмээн Бурхан үүнийг хийдэг. Бурхан хүнийг ингэж хатуу шүүгээгүй, асуудлын голыг яг онож цохиогүй бол, мөн зөвт, сүр жавхлант зан чанараа илчлээгүй бол Сатанаар маш гүн гүнзгий завхрагдсан хүмүүн бид өөрсдөдөө дүгнэлт хийж, өөрсдийгөө мэдэж авч чадахгүй, мөн өөрсдийн завхрал болон сатанлаг уг чанарынхаа үнэнийг мэдэж чадахгүй байх байсан юм. Хэрэв тэгсэн бол бид нүгэлт уг чанараасаа хэрхэн ангижирч, ариусгагдах билээ? Бурханы хатуу үгээр хүрдэг үр дүнгээс бид, хүнийг гэх Бурханы жинхэнэ хайр болон хүнийг аврах гэж Түүний гаргадаг нүсэр их хүчин зүтгэл үүн дотор нуугдаж байдгийг харж болно! Би Бурханы үгийг унших тусмаа Бурханы шүүлтийн ажил үнэхээр агуу болохыг улам их

---

мэдэрдэг! Бурханы ажил үнэхээр бодитой! Бурханы хатуу шүүлт л хүнийг ариусгаж, өөрчилж, аварч чадна. Бурханы эцсийн өдрүүд дэх шүүлтийн ажил бол үнэхээр бидэнд хэрэгтэй зүйл юм!

Уг чанар минь биеэ тоосон, ихэрхүүгээс гадна би аймшигтай биеэ зөвтгөдөг учраас ярих болгондоо үргэлж бусдад дээрэнгүй байдлаар сургаал айлдаж, аливааг хийх бүрийдээ хуулийг гууль болгон, үргэлж бусдад өөрийгөө сонсгож, бусад хүний өмнө онгирох дуртай байлаа. Цуглаан дээр би хэд хэдэн удаа ажлынхаа нэгж дээр асуудлыг хэрхэн зохицуулсан, дуулгаваргүй ажилчдыг хэрхэн зэмлэж, үгэндээ оруулсан, гэрт эхнэр охин хоёр маань хэрхэн үргэлж намайг бүх зүйл дээр дуулгавартай дагадаг талаар нөхөрлөл хийсэн юм. Тэр дундаа би Бурханы үгийн талаар нөхөрлөх үедээ “Бурханы үгийн энэ эшлэл ийм утга учиртай гэж би бодож байна,” болон “би ингэж бодож байна” гэх мэт зүйл үргэлж хэлдэг байлаа. Намайг өөрөө ч мэдэлгүй үргэлж биеэ тоож, өөрийгөө зөвтгөсөн зан чанар илэрхийлж байгааг нэг ах хараад, цуглаан дээр үүнийг надад тайлбарлаж, ийм маягаар ярьж, үйлдэх нь биеэ тоож, өөрийгөө зөвтгөн, эрүүл ухаангүй байгаагийн илэрхийлэл гэж хэлсэн билээ. Урьд өмнө нь хэн нэг хүн намайг маш олон хүний өмнө ийм маягаар илчилсэн бол би өөрийгөө өмөөрч марган, удалгүй няцаах байсан нь лавтай. Гэхдээ тухайн үед би “Тулгарсан ямар ч сэдвийн тухайд чи ‘би боддог’ гэж үргэлж хэлдэг бол, ай, чи үзэл бодлоо орхисон нь дээр. Би чамайг үзэл бодлоо орхиж, үнэнийг эрж хай гэж би шавдуулъя. Бурханы үг юу гэж хэлэхийг хар. Чиний ‘үзэл бодол’ бол үнэн биш! ... Чи маш их биеэ тоож, өөрийгөө зөвтгөдөг! Үнэнтэй тулахад чи өөрийнхөө үзэл, төөрөгдлийг ч орхиж чаддаггүй. Чи Бурханыг өчүүхэн ч дуулгавартай дагахыг хүсдэггүй. Үнэнийг үнэхээр эрж хайдаг, үнэхээр Бурханыг хүндэлдэг зүрх сэтгэлтэй хүмүүсээс ‘би боддог’ гэж хэлсээр байдаг хэн байна вэ? Энэ хэллэгийг аль хэдийн таягдан хаясан байдаг. Энэ бол сатанлаг зан чанарын илчлэл юм” хэмээсэн “Амийн оролтын тухай номлол ба нөхөрлөл”-ын үгийг санасан тул маргаж, өөрийгөө зөвтгөлгүй, дуугүй байхаар шийдсэн юм. Жирийн үед намайг ямар нэг асуудалтай тулгарах бүрд үргэлж “би” гэдэг үгээр эхэлдэг “би боддог,” “би үздэг,” “би итгэдэг” гэх үг аман дээр минь гарч ирж, би үргэлж бүх зүйл дээр эцсийн шийдийг гаргадаг байсныг нөхөрлөл дэх эдгээр үг надад сануулсан юм. Би өөрийгөө аливааг нэвт шувт харж, асуудлыг зохицуулж чаддаг гэж итгэдэг байсан. Би үргэлж бусдыг үгээрээ байлгаж, өөрийгөө дуулгавартай дагуулдаг байлаа. Өөрийгөө үргэлж ихэд үзсэнээрээ би яг биеэ тоосон зан чанарыг илчилж байсан хэрэг биш үү? Ах миний зан чанарыг тайлбарлах үедээ хэлсэн зүйл нь бүгд үнэн байсан, үүнийг би хүлээн зөвшөөрөх ёстой. Миний итгэдэг зүйл бол үзэл, төсөөллөөс минь урган гарч, Сатанаас ирсэн бөгөөд үнэн биш гэдэг нь гарцаагүй байсан юм. Би гэртээ ч бай, ажлын нэгж дээрээ хамтран зүтгэгчдийнхээ дунд ч бай үргэлж гол хүн нь мэт аашилж байсан. Хэн нэг нь

---

надад дуулгаваргүй байж, эсвэл миний үзэл санаатай нийцэхгүй зүйл хийвэл би уурлаж, зэмлэдэг байлаа. Би эдгээр зүйлийг илчлэх чадвартай байсан гэдэг нь миний зүрх сэтгэлд Бурханыг гэх орон зай байгаагүй, Бурханыг агуу гэж хүндлэлгүй, өөрийгөө агуу гэж хүндэлдэг байсныг минь тайлбарлана. Би үргэлж ийм зүйл хэлж, ийм маягаар аашилж чаддаг байсан бөгөөд зан чанар минь хэчнээн их биеэ тоосон байсныг энэ нь нотолж байна!

Дараа нь би Бурханы эдгээр үгийг уншив: **“Хэрэв чиний дотор үнэхээр үнэн байдаг бол алхдаг зам чинь аяндаа зөв байх болно. Үнэн байхгүй бол ёрын мууг үйлдэхэд амархан бөгөөд чи өөрийн эрхгүй үүнийг хийнэ. Жишээлбэл, хэрвээ биеэ тоосон, ихэрхүү зан дотор чинь оршиж байгаа бол Бурханыг эсэргүүцэхгүй байх боломжгүй мэт чамд санагдана; Түүнийг эсэргүүцэх ёстой мэт санагдана. Чи үүнийг зориуд хийхгүй; өөрийн биеэ тоосон, ихэрхүү уг чанарт захирагдан хийх болно. Биеэ тоосон, ихэрхүү зангаасаа болж чи Бурханыг дорд үзэж, Түүнийг шалихгүй гэж үзэхэд хүрдэг; тэдгээр нь чамайг өөрийгөө өргөмжилж, байнга өөрийгөө гайхуулж, сүүлдээ Бурханы орыг эзлэн суугаад, өөртөө гэрчлэл хийхэд хүргэдэг. Эцэст нь чи өөрийн санаа, бодол, үзлийг шүтэх ёстой үнэн болгож хувиргана. Биеэ тоосон, ихэрхүү уг чанарынхаа эрхшээлд байдаг хүмүүс хэчнээн их ёрын муу үйл хийдгийг хараач! Ёрын муу үйлээ шийдвэрлэхийн тулд уг чанарынхаа асуудлыг эхлээд тэд шийдвэрлэх ёстой. Зан чанарын өөрчлөлтгүйгээр энэ асуудлыг сууриар нь шийдвэрлэх боломжгүй болно”** (Христийн ярианы тэмдэглэл номын “Үнэнийг эрэлхийлснээр л хүн амь зан чанарын өөрчлөлтөд хүрч чадна”). Бурханы хэлсэн үг бүр үнэн бөгөөд эдгээр нь намайг бүрэн үнэмшүүлсэн юм. Би ажил дээрээ, хамтран зүтгэгчдийнхээ хажууд байхдаа болон гэр орондоо бусдад хэрхэн дээрэнгүйгээр сургаал айлддаг байснаа бодов. Энэ бүхэн нь миний сатанлаг, биеэ тоосон уг чанартаа ноёрхуулж байгаа явдал байснаас биш миний уур уцаараас үүдээгүй, муухай ааштайгаас минь ч юм уу, биеэ барьж чаддаггүйгээс минь болоогүй. Би өөрийгөө хэв чанартай, авьяастай, мөнгө олж чаддаг гэж итгэдэг байсан учраас өөрийгөө бусад хүнээс дээр гэж үзэж, бусад бүх хүнийг дорд үзэж, өөрийгөө бусад бүх хүнээс илүүд санаж, давуу гэж үргэлж боддог байв. Эдгээр бодол нь миний биеэ тоосон занг өрдөж, амьдралын минь утга учир болсон билээ. Би нүглийнхээ эх сурвалжийг олж, сатанлаг, завхарсан зан чанараа шийдэлгүй орхивол юу болох аюултайг харсан. Тэгээд би ухамсартайгаар сайжирч, хүний биеэ тоосон уг чанарыг Бурхан шүүж, илчилдэг тухай Түүний олон үгийг уншин, эдгээр үгтэй жишиж өөртөө дүгнэлт хийсэн билээ. Бурханы шүүж, илчлэх үг болон цуглаан дээрх ах эгч нарын хэлэлцэхээр дамжуулан би өөрийнхөө биеэ тоосон уг чанарыг жаахан ойлгож эхлэв. Би үнэн хэрэгтээ өөр хэнээс ч дээр байгаагүй гэдгийг, миний чадвар, хөрөнгийг бүгдийг нь

---

Бурхан хайрласан гэдгийг харсан учраас надад онгирох зүйл огт байсангүй. Бурхан надад мэргэн ухаан, оюуны чадамж хайрлаж, намайг ерөөгөөгүй байсан бол би ердөө өөртөө түшиглэн юу хийж чадах байсан гэж? Дэлхий дээр авьяастай хүн маш олон бий; тэд яагаад бүхий л амьдралынхаа туршид хөдөлмөрлөж, борви бохисхийлгүй явж, эцэстээ гар хоосон хоцордог юм бэ? Бас би Бурханы үгэн дотроос биеэ тоосон уг чанараа шийдэх замыг олсон нь ах эгч нарын засалт, харьцалтыг илүү их зөвшөөрч, Бурханы шүүлт, гэсгээлт, шалгалт, цэвэршүүлэлтийг улам их хүлээн авч, Бурханы үгтэй холбогдуулан өөртөө дүгнэлт хийж, өөрийгөө үнэхээр мэдэж, үзэн яддаг болж, сатанлаг зан чанарынхаа дагуу үйлдэхээ больж, Бурханы үгийн дагуу үйлддэг болох явдал байв. Дараа нь би шүүлт, гэсгээлт, засалт, харьцалтын олон тохиолдлыг туулж, олон бэрхшээл, бүтэлгүйтлийг үзсэн бөгөөд сатанлаг уг чанар болон завхарсан мөн чанарын минь талаарх мэдлэг аажмаар гүнзгийрч, мөн би Бурханы агуу, зөвт, ариун байдлын талаар жаахан мэдлэгтэй болсон билээ. Би Бурханы зөвт, ариун байдлыг мэдэх тусмаа өөрийнхөө бузар булай, дорд, өчүүхэн, өрөвдөлтэй байдлыг улам их олж харсан юм. Урьд нь чухал гэж бодон, гайхуулдаг байсан зүйлс маань одоо дурдахад үнэ цэнгүй санагдаж, өөрийн мэдэлгүй миний биеэ тоосон зан чанар өөрчлөгдөж эхэллээ. Ах эгч нар зөв зүйл хэлсэн эсэх, хамтран зүтгэгчид маань зөв зүйл хэлсэн эсэх, гэр бүл маань зөв зүйл хэлсэн эсэхээс үл хамааран би хүлээн зөвшөөрч, дээрэнгүй байдлаар ярьдгаа болин, даруугаар үйлдэж, хуулийг гууль болгохоо болив. Асуудал гармагц би бусадтай хэлэлцэж, хэний зөв байна, түүний саналыг дагадаг байв. Аажмаар эргэн тойрон дахь хүмүүстэйгээ харилцах харилаа минь хэвийн болж эхлэв. Би зүрх сэтгэлдээ амар амгалан, баяр баясалтай болж, жинхэнэ хүний дүрээр арай илүү амьдарч байгаа гэдэгтээ итгэв.

Бурханы үгийг тогтмол уншиж, чуулганы амьдралаар амьдрахыг даган би Бурханы эцсийн өдрүүд дэх шүүлтийн ажлыг хүлээн зөвшөөрч чадсан минь үнэхээр сайн хэрэг байсныг улам бүр мэдэрсэн билээ. Завхарсан зан чанараа өөрөө шийдвэрлэх арга ердөө байхгүй гэдгийг би тодорхой ойлгосон. Бурханы үгийн шүүлт, гэсгээлтээр л дамжуулан би аажмаар өөрчлөгдөж, цэвэрлэгдсэн билээ. Төгс Хүчит Бурханы Чуулганд би үнэнийг эрж хайхаар шаргуу ажиллан, Төгс Хүчит Бурханы үгийн шүүлт, гэсгээлтийг хүлээн зөвшөөрч байгаа олон ах эгчийг харсан. Хэн нэг хүн жаахан завхрал ил гаргамагц хүн бүр үүнийг нэг нэгэндээ тайлбарлаж, бие биедээ тусалдаг. Бид бүгд өөрсдөдөө дүн шинжилгээ хийж, Бурханы үгтэй жишин өөрсдийгөө мэдэж авч, завхралаа шийдэхийн тулд үнэнийг эрж хайж, хүн бүр үнэнч хүн байж, ариун, нээлттэй байх явдлыг хэрэгжүүлэн, бид үнэнтэй нийцэх ямар ч нөхөрлөлийг хүлээн зөвшөөрч, үүнд захирагддаг бөгөөд завхарсан зан чанар маань улам бүр өөрчлөгддөг; Төгс Хүчит Бурханы үг үнэхээр л хүмүүсийг ариусгаж, өөрчилж чаддаг. Бие махбодтой болсон Бурхан бидний дунд ирж, биднийг

---

шүүж, ариусгах үгээ биечлэн илэрхийлж, биднийг нүглээ хөсөр хаяж, аврагдахад хөтөлдөг – бид үнэхээр зол завшаантай юм! Эзэнд чин сэтгэлээсээ итгэж, Түүний эргэн ирэхийг тэсэж ядан хүлээж, нүглийн хүлээсийг хөсөр хаян, цэвэрлэгдэх гэж хүсэж тэмүүлдэг атлаа дагах замгүй зовлонд амьдардаг бүх хүнийг бодоод би Бурханд залбирч, ийм шийдвэрт хүрсэн юм: “Би Таны хаанчлалын сайн мэдээг бүр ч олон хүнд номломоор байна, ингэснээр тэд над шиг байж, Таны хөлийн мөрийг даган, ариусгагдаж, авралд хүрэх замд орж чадна!”

## **9. Өөр төрлийн хайр**

Чэншинь, Бразил

2011 онд тохиолдлоор олдсон боломжоор, би Хятадаас Бразилд ирсэн юм. Намайг яг ирэх үед, нүд минь шинэлэг, шинэхэн туршлага, сониуч зангаар дүүрэн байсан ба ирээдүйн талаар сайхан мэдрэмжтэй байлаа. Гэхдээ богино хугацааны дараа, энэ шинэлэг, шинэ мэдрэмжийг алс холын харь нутагт байхын ганцаардал болон шаналал даруй орлосон юм. Өдөр бүр би гэртээ орь ганцаараа харьж, ганцаараа хооллож, ярих ч хүнгүй өдөр бүр эргэн тойрныхоо ханыг ширтэн, зүрх сэтгэлдээ нэн их ганцаардаж, байнга гав ганцаараа уйлдаг байв. Ихээхэн шаналлыг, арга мөхөс байдлыг мэдрэх үед минь Эзэн Есүс найзаар дамжуулан намайг цуглаанд авчрав. Эзэний үгийг уншиж, магтан дуу дуулж, цуглаан дээр залбирснаар дамжуулан ганцаардмал зүрх сэтгэл минь Эзэний тайтгарлыг хүлээн авсан юм. Би Библиэс, тэнгэр, газар болон бүх зүйлийг Бурхан бүтээсэн бөгөөд хүн ч бас Бурханы бүтээл гэдгийг сурч авав. Эзэн Есүс хүн төрөлхтнийг золин аврахаар цовдлогдсон, мөн биднийг нүглээс золин аварсан хүн бол Эзэн Есүс бөгөөд Тэр бол хүн төрөлхтний цор ганц Золин аврагч билээ. Бүхнээс илүү Эзэний авралтай нүүр тулаад миний сэтгэл ихэд хөдөлсөн ба үлдсэн амьдралынхаа туршид Эзэнийг дагахаар сэтгэл шулуудсан билээ. Үүнээс болж, Талархлын баярын өдөр зүгээр нэр төдий биш, бодит амьдрал дээр Христэд итгэгч болохоор баптисм хүртсэн юм. Би магтан дуу, ялангуяа Бурханыг магтсан дуунуудыг дуулах дуртай байсан учраас баптисм хүртсэнийхээ дараа найрал дуунд орох санаачилга гаргаж, үүний нэг хэсэг болж ажиллах боллоо. Бурханы удирдамж болон ерөөлөөр дамжуулан би амар тайван, аз жаргалтай амьдарч байв. Цуглаанд явах болгондоо, эсвэл шүтлэг бишрэлдээ Бурханыг магтах бүрдээ би эрч хүчээр бялхаж байлаа.

Гэвч, сайн нөхцөл байдал үүрд үргэлжлээгүй ба чуулганы үйлчлэлийн эгнээнд орохын хэрээр би чуулган дахь ах, эгч нарын нэг нэгэндээ үзүүлдэг анхаарал, халамж

---

гаднаа бүгд найрсаг харагдаж байсан боловч яриа болон үйлдлээрээ яг үнэндээ тэд бүгд хувийн ашиг сонирхлынхоо дагуу үйлдэж байсныг бага багаар харлаа. Чуулганы үйлчлэлд ажиллаж байхдаа тэд ямар нэгэн хувийн алдагдал хүлээхийг хүсээгүй бөгөөд хэн илүү ихийг хийж, хэн багыг хийж байгаа талаар бусдын ар хударгаар үргэлж хов ярьдаг байлаа. Пастор хүртэл туйлын их зантай байв. Тэрээр өргөлийнх нь хэмжээнд үндэслэн хүмүүст хандаж, мөн номлохдоо үргэлж өргөлийн талаар ярьдаг байв. Цуглаанд ирэх бүрдээ пасторын хамгийн их онцолдог зүйл нь хүмүүс өргөлөө өгч байгаа эсэх, тэд хэр ихийг өгсөн гэдэг бөгөөд ах, эгч нарын амийн талаар юу ч сонсохыг хүсдэггүй байлаа. Тэр хайрын талаар ярьдаг байсан боловч ганц ч үнэнч үйлдэл үзүүлээгүй юм. Ах, эгч нарт бэрхшээлтэй байх үед пастор тэдэнд тусалдаггүй байв, гэхдээ хүмүүсийг илүү ихээр эгдүүцүүлдэг зүйл нь тэр тэднийг шүүмжилдэг байсан ба хүч чадалгүй, мөнгөгүй ах, эгч нарыг дорд үздэг байлаа... Би чуулганы энэ орчин нөхцөлийг хараад, сэтгэлээр унан, будилж орхив: Чуулган яаж нийгмээс ялгаагүй болтлоо өөрчлөгдчихөв? Аажмаар би өмнө нь байсан хайр, итгэлээ алдаж, Ням гарагт чуулган руу явах болоход миний бие тэнхээгүй мэт санагдав. Дуулахыг ч хүсэхгүй байлаа. Долоо хоног бүр, чуулганд явахдаа би нэг бол гадаа кофе ууж зогсоно, эсвэл вандангууд дээр түр дуг хийдэг байлаа. Номлол дуусахад би өргөлөө шидчихээд, гарч оддог байв. Миний зүрх сэтгэлд үргэлжид уй гашуу, хүчин мөхөс байдал байх боллоо.

2016 оны 8 дугаар сарын нэгэн Ням гарагт би, Гао Шиаоинг болон Лиу Фанг эгч нарын ангийн хүүхэд болох, Америкаас ирсэн Ли Мин эгчтэй уулзав. Тэд бүгд Эзэнд итгэдэг байлаа. Бид зүлгэн дээр суунгаа ярилцаж эхлэв. Бид ярьсаар, ярьсаар чуулганы орчин нөхцөлийн талаарх сэдэв дээр ирж, би чуулган дээр харсан болгоноо хэллээ. Ли Мин эгч үүнийг сонссоны дараа бодлогошронгуй толгой дохиж, ингэж хэллээ: “Өнөө үед, танай чуулган гэлтгүй, бүхий л шашны ертөнц Ариун Сүнсний ажлыг алдчихсан. Тэд харанхуй болон эзгүйрэл рүү унасан. Эзэн Есүс нэгэнтээ: **‘Ёс бус байдал элбэгшсэнээс болж олон хүний хайр хөрөх болно’** (Матай 24:12) гэж зөгнөсөн. Аль хэдийн эцсийн өдрүүдийн цаг үе болчихоод байхад, шашин дахь хууль ёсгүй байдал илүү их тархан нэмэгдсээр байна. Пасторууд болон ахлагчид Эзэн Есүсийн тушаалыг сахьдаггүй, Эзэний замыг хэрэгжүүлдэггүй ба энэ мэтээр нүгэлд амьдрах нь том асуудал биш гэж боддог. Чуулганы хөгжил цэцэглэлт бол Ариун Сүнсний ажлаар олж авсан үр жимс гэдгийг бид бүгд мэднэ. Өнөөдөр, Бурхан хэдийнээ шинэ ажил хийж, Ариун Сүнсний ажил Бурханы шинэ ажлыг хүлээн зөвшөөрдөг, дуулгавартай дагадаг бүлэг хүмүүст шилжчихсэн. Шашны пасторууд болон ахлагчид, эцсийн өдрүүд дэх Бурханы ажлыг эрж хайж, судлан шинжлэхэд итгэгчдийг хөтөлдөггүй, харин ч Бурхан руу эргэн очиход нь хүмүүст саад хийхийн тулд бүх төрлийн цуу яриа, буруу ойлголт тарааснаар Бурханы шинэ ажлыг



---

эсэргүүцэж, ялладаг. Тэд Бурханы үзэн ядалт болон гололттой учирна, иймээс шашны ертөнц бүхэлдээ Бурханы ерөөлгүй болж, Ариун Сүнсний ажлыг бүхэлд нь алдаж, Эзэнээр орхигдож, таягдан хаягддаг. Иймээс, шашин улам бүр эзгүй, харанхуй болдог. Энэ нь, Эзэн Есүс ажлаа хийхээр бие махбодтой болсон үетэй яг адил юм. Эзэн Есүсийн ажил Нигүүлслийн эрин үеийг нээж, Хуулийн эрин үеийг төгсгөсөн. Эзэн Есүсийг дагасан хүмүүс Бурханы шинэ ажлыг хүлээн зөвшөөрч, дуулгавартай дагасан учраас Ариун Сүнсний ажлыг олж авсан байхад эсрэгээрээ Эзэн Есүсийг хүлээн зөвшөөрөлгүй, сүмдээ байсаар байсан хүмүүсийн дунд Ариун Сүнс ажиллаагүй. Тиймээс, нэгэнтээ Бурханы алдраар дүүрэн байж, итгэгчид Бурханыг шүтдэг байсан газар нь наймаа хийх газар, хулгайч нарын үүр болсон юм. Өөрөөр хэлбэл, чуулганы эзгүйрлийн шалтгаан нь нэг талаараа пасторууд болон ахлагч нар Бурханы тушаалуудыг дагаж мөрддөггүй, Бурханы үгийг ч хэрэгжүүлдэггүйгээс, мөн тэдний муу үйлдлийн даалгавруудаас болдог. Нөгөө талаараа, Бурхан шинэ ажил гүйцэтгэж, Ариун Сүнсний ажил хувирснаас, мөн хүмүүс Бурханы хөлийн мөртэй хөл нийцүүлэн алхаж чадаагүйгээс болдог. Гэхдээ, чуулганы эзгүйрэлд Бурханы хүсэл байдаг бөгөөд үүнээс үнэнийг олж болно. Чуулганы эзгүйрлээр дамжуулан Бурханд чин зүрх сэтгэлээр итгэдэг болон үнэнээр цангадаг хүмүүсээс Бурхан шашныг орхихыг шаардсан, тэгснээр тэд Ариун Сүнсний шинэ ажлыг хайж, Бурханы мөртэй хөл нийлүүлж, Бурханы одоогийн ажил болон авралыг олж авахаар Бурханы дэргэд ирэхийн тулд үүнийг орхиж чадна.”

Ли эгчийн нөхөрлөсөн зүйлийг сонсоод би толгой дохин, ингэж хэллээ: “Таны хэлсэн зүйл зөв. Яг таны хэлсэн шиг л байна. Чуулган анхнаасаа Бурханыг шүтэн мөргөх газар байсан тул би энэ асуудлыг хэзээ ч ойлгож чадахгүй байсан гэтэл одоо шашин болон нийгмийн хооронд бүхэлдээ ямар ч ялгаа алга. Мөн түүнчлэн, пасторуудын номлодог зүйлд ямар ч шинэ гэрэл байхгүй, тэднийг сонсоход ямар ч таашаал байхгүй бөгөөд хүмүүс одоо харанхуйд амьдардаг. Бид Бурханы шинэ ажлыг хараахан гүйцээгүй болж таарч байна, иймээс Бурханы шинэ ажлыг гүйцэхийн тулд одоо юу хийх ёстой вэ?” Ли эгч ингэж хэлсэн юм: “Эзэн Есүс аль хэдийн эргэж ирсэн. Эцсийн өдрүүдэд, Бурхан Төгс Хүчит Бурханы нэрийн дор үнэнийг илэрхийлэхээр хүний бие махбодтой болсон. Тэрээр хүн төрөлхтнийг шүүх болон ариусгах ажлын үе шатыг хийсэн. Бид эцсийн өдрүүд дэх Бурханы ажлыг гүйцэж, Бурханы үгийн шүүлтийг хүлээн зөвшөөрөх ёстой, тэгвэл Ариун Сүнсний ажлыг олж авч чадна...” Эзэн Есүс шүүлтийн ажлын үе шатыг хийхээр аль хэдийн эргэн ирчихсэн гэдгийг сонсоод би гайхшралд оров. Би: “Шүүлт нь хүнийг хэрэгт татагдсаны дараа шийтгэх гэж байдаг бус уу? Бурхан эцсийн өдрүүдэд Бурханд итгэдэггүй хүмүүсийг шүүхээр ирдэг ба Эзэн Есүст итгэдэг бид хэдийнээ нүглээ өршөөлгөж, аврал хүртсэн. Бид Бурханы шүүлтийг хүлээн авах хэрэггүй, учир нь Эзэн ирэх үедээ биднийг

---

шууд тэнгэрийн хаанчлал руу өргөнө. Тэр яаж биднийг шүүхээр ирдэг билээ?” гэж бодлоо. Тэгж бодоод би өөрийн үзэл бодлыг илэрхийллээ. Тэр мөчид, Лиу Фанг эгч ингэж хэлэв, “Ах аа, би Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг долоо хоногийн турш Гао эгчтэй хамт судалж байна. Төгс Хүчит Бурханы үгээс бид Бурханы дуу хоолойг таньсан. Төгс Хүчит Бурхан бол үнэхээр эргэн ирсэн Эзэн Есүс. Төгс Хүчит Бурханы үгийг унш, та ч мөн ойлгох болно. Эзэн Есүс шүүлтийн ажлыг хийхээр эргэн ирсний шалтгаан нь, Эзэнд итгэдэг бид хэдийгээр нүглээ уучлуулсан ч нүгэл дунд амьдарсаар байгаа ба үүнээс өөрсдийгөө чөлөөлж чадахгүй. Нүглийн хүлээс, хяналтаас өөрсдийгөө чөлөөлөх ямар ч аргагүй бөгөөд үнэндээ биднийг шүүж, ариусгаж, нүгэлт уг чанар болон ялзарсан сатанлаг зан чанарыг маань үндсээр арилгахын тулд Бурхан үнэнийг илэрхийлэх нь бидэнд үнэхээр хэрэгтэй. Эцсийн өдрүүд дэх Төгс Хүчит Бурханы шүүлтийн ажил бол Эзэн Есүсийн золин аврах ажлын суурин дээр баригдсан шинэ агаад гоц гойд ажил юм. Энэ нь үгийн шүүлтээр дамжуулан хүмүүсийг бүрэн ариусгаж, авардаг бөгөөд тэднийг гайхалтай хүрэх газарт аваачдаг.” Үүний дараа тэд тэвчээртэйгээр зарим нэг үнэний талаар надтай нөхөрлөв. Гэвч тэд юу ч хэлсэн бай, Өөрт нь итгэдэг хүмүүсийг шүүхээр Эзэн эргэн ирж байгаа гэдгийг би хүлээн зөвшөөрч чадахгүй байлаа. Үүнтэй зэрэгцэн би зөрчилдөж, оюун санаандаа бас будилж байлаа: Гао эгч, Лиу эгч хоёр маш сүсэг бишрэлтэй итгэгчид, тэдний Эзэнийг гэсэн итгэл, хайрыг нь хүн бүр хүлээн зөвшөөрдөг, тийм байтал тэд яаж Өөрт нь итгэдэг биднийг шүүхээр Эзэн Есүс эргэн ирж байгаа гэдэгт, мөн Тэр биднийг шууд тэнгэрийн хаанчлал руу өргөхгүй гэдэгт итгэж чадав? Үүнд миний мэдээгүй үнэний зарим нууц байгаа юм гэж үү?

Намайг бодож байхад Ли Мин эгч ном гаргаж ирээд, надад үнэн сэтгэлээсээ ингэж хэлэв: “Ах аа, Эзэн Есүс: **‘Сүнсээрээ ядуу хүмүүс ерөөлтэй еэ: учир нь тэнгэрийн хаанчлал бол тэднийх юм’** (Матай 5:3). Дүгнэлт гаргах гэж бүү яар, за юу? Эхлээд Төгс Хүчит Бурханы үг Бурханы дуу хоолой мөн үү гэдгийг, энэ нь биднийг амиар хангаж чадах эсэхийг, биднийг ариусгаж, аварч чадах эсэхийг харцгаая, тэгж байж бид Төгс Хүчит Бурхан нь эргэн ирсэн Эзэн Есүс мөн эсэхийг мэдэх болно. Бурханы хонин сүрэг Бурханы дуу хоолойг сонсох болно, тиймээс Бурханы үгийг хамт уншицгаая!” Би сэтгэл зүрхэндээ бага зэрэг дургүй байсан бөгөөд асуултад нь хариулсангүй. Гурван эгч миний хандлагыг хараад бага зэрэг гонсойлоо. Лиу эгч гэнэтхэн: “Эхлээд залбирцгаая, дараа нь Бурханы үгнээс дахиад жаахан уншицгаая!” гэж санал болгов. Түүнийг тэгж хэлсний дараа, гурван эгч залбирч эхэлсэн бөгөөд би тэднийг дагах ёстой боллоо. Гэсэн ч, залбирч байхдаа би зүрх сэтгэлдээ тайван байлгаж бараг чадсангүй. Хэдийгээр эгч нар юуны талаар залбирч байсныг нь би сонсоогүй ч, тэдний амьдран харуулж байгаа зүйлийг хараад сэтгэл хөдлөлөө. Тэд үнэхээр чин сэтгэлийн хандлагаар Бурханд хандаж байсан ба

---

бүх зүйлсээс Бурханы хүслийг хайж байв. Намайг эцсийн өдрүүд дэх Бурханы ажлыг судална гэж тэд найдсан бөгөөд энэ нь бас намайг гэсэн Бурханы хайр байлаа. Залбирлын дараа Ли эгч надад ном өгөнгөө: “Үнэн замыг судлах тухай зуун асуулт хариулт гэх энэ номон дахь ихэнх асуулт нь бүх бүлэглэлийн хүмүүс дунд оршдог. Асуулт болгоныг тайлбарлахдаа харгалзах хэсгүүдийг Бурханы үгээс сонгосон. Алив хар даа” гэж чин сэтгэлээсээ хэлэв. Би номыг авахыг хүсээгүй ч, хэчнээн чин сэтгэлээсээ хандаж байгааг нь үзээд, Гао эгч, Лиу эгч хоёр луу дахин харж, намайг судалж, эрж хайна гэж ямар их найдаж байгааг нь харлаа. Эзэний ирэлтийг угтан авах нь үнэндээ ямар чухал хэрэг болохыг, мөн үүнд хайхрамжгүй хандаж болохгүй гэдгийг би бодлоо. Тэгээд би номыг хүлээн авч: “За, би энэ номыг хүлээж авахад бэлэн байна. Өнөөдөртөө энд зогсьё. Би эхлээд номыг уншъя, дараа нь ярилцъя” гэлээ.

Гэртээ хариад, номоо нэг тийш тавихад миний бодлууд бүгд холилдсон байлаа. Ли Мин эгчийн нөхөрлөсөн зүйлийг эргээд бодоход энэ нь бүгд тодорхой, ойлгомжтой санагдав. Түүний хэлсэн өгүүлбэр бүр баримт байв, харин миний ойлгож чадаагүй зүйл бол: яагаад Эзэн эргэж ирэхдээ шүүлтийн ажлын үе шатыг хийх болов? Үүнийг нухацтай нарийвчлан авч үзсэний дараа ч би үүнийг ойлгохгүй байсаар байв. Харин Эзэний хоёр дахь ирэлтийн тухайд, би энэ талаар сонсож байсан учраас сохроор дүрэм журам зохион хувь заяатайгаа эвлэрэн сууж чадахгүй байлаа. Мөн номыг уншиж, өөрийн ялгах чадварыг жаахан дээшлүүлэх нь зүйтэй гэж би бодов. Тэгээд, би зургаан өдөр энэ номыг үг үсэггүй уншиж өнгөрөөлөө. Миний өмнө нь хэзээ ч сонсож байгаагүй олон олон үнэн болоод нууцыг Төгс Хүчит Бурхан мэдэгдсэнийг би харав. Энэ нь асар их хангалт олж авах боломжийг надад олгосон ба Төгс Хүчит Бурханы үгсийг уншихад Эзэн Есүсийнхтэй ижил өнгөөр хэлэгдсэн олон зүйл байхыг мэдрэв. Бурханы дуу хоолой ярьж буй мэт эрх мэдэл болон хүч чадал байлаа. Иймд, номоо уншиж дууссаны дараа би Төгс Хүчит Бурханы хийсэн шүүлтийн ажлын цаана юу байгааг бүр ч их ойлгохыг хүсэв. Би тодруулга авахаар Гао эгчтэй уулзахаар шийдлээ.

Маргааш өдөр нь би Гао эгчийн гэр лүү явсан ба түүний зарим нэг найзуудтай уулзаж таарав. Тэд бүгд эцсийн өдрүүд дэх Төгс Хүчит Бурханы ажлыг хүлээн зөвшөөрсөн ба бие биетэйгээ нөхөрлөхөөр цугларсан байв. Бид хоорондоо мэндэлж, Ли Мин эгч надаас: “Ах аа, та ямар үзэл тээсээр байна вэ? Эцсийн өдрүүд дэх Бурханы ажлын ямар талыг ойлгомоор байна? Бид хамтдаа нөхөрлөж болно шүү” хэмээн асууж, шууд гол яриандаа орлоо. Би ингэж хэлэв: “Эцсийн өдрүүдэд Ариун Сүнсний ажил урагшилсаар байсан учир чуулган эзгүйрсэн гэдгийг та дурьдсан. Би үүнийг хүлээн зөвшөөрч болно, гэхдээ Эзэнд итгэдэг бид өөрсдийн нүглийг хэдийнээ уучлуулсан, бас Эзэн биднийг нүгэлтэй гэж хардаггүй шүү дээ. Яагаад Бурхан шүүлтийн ажлын дараагийн алхмыг хийхийг хүсдэг

---

билээ? Бид энэ алхмыг дамжилгүйгээр тэнгэрийн хаанчлал руу өргөгдөж чадахгүй гэж үү? Бурхан хүнийг шүүх үед тэр хүнийг нүгэлтэй гэж тодорхойлдоггүй гэж үү? Тэд бүгд шийтгэгдэх ёстой биш гэж үү? Тэгвэл тэд яаж тэнгэрийн хаанчлал руу өргөгдөж чадах юм бэ?” Ли Мин эгч ийнхүү хэлэв: “Ихэнх хүмүүсийн үзлээс харвал Эзэний шүүхээр эргэн ирсэн хүмүүс нь Бурханд итгэдэггүй үл итгэгчид байсан. Бурхан хүмүүсийг шүүх үед тэднийг нүгэлтэй болоод шийтгэгдсэн гэж тодорхойлдог бөгөөд Бурханд итгэдэг хүмүүс өөрсдийн нүглийг өршөөлгөсөн. Эзэнийг ирэх үед тэд шийтгэгдэхгүй, тэнгэрийн хаанчлал руу шууд өргөгдөнө. Тиймээс тэд эцсийн өдрүүд дэх Бурханы шүүлтийн ажлыг хүлээн зөвшөөрөхөөс татгалздаг. Энэ бол Бурханы хүслийг бүхэлд нь буруу ойлгож буй явдал бөгөөд тухайн хүн Бурханы ажлыг мэдэхгүй байгааг харуулдаг. Үнэн хэрэгтээ, үнэнийг илэрхийлж, хүнийг шүүж, ариусгаж буй эцсийн өдрүүд дэх Төгс Хүчит Бурханы ажил бол итгэгчдийг тэнгэрийн хаанчлал руу өргөхийн тулд юм шүү дээ. Библид: **‘Шүүлт Бурханы гэрээс эхэлнэ’** (1 Петр 4:17) гэж хэлдгийг бид бүгд мэднэ. Энэ зөгнөл, эцсийн өдрүүд дэх Бурханы шүүлтийн ажил Бурханы гэрээс эхэлдгийг бидэнд тодорхой хэлдэг. Өөрөөр хэлбэл, энэ нь Бурханд үнэн зүрх сэтгэлээсээ итгэдэг, эцсийн өдрүүд дэх Бурханы ажлыг хүлээн зөвшөөрдөг хүмүүсээс эхэлдэг. Иймд, Эзэн Есүст итгэнэ гэдэг нь Бурханы шүүлтийн ажлыг хүлээж авах ёсгүй гэсэн үг гэх үзлийг алдаатай хэмээн бид үздэг. Эцсийн өдрүүдэд Өөрийнх нь сэнтийн өмнө ирдэг бүх хүнийг шүүхийн тулд Бурхан үгээ ашигладаг бөгөөд энэ хүмүүсийг ариусгаж, авардаг. Гай гамшгаас өмнө Тэр ялагчдын бүлгийг бий болгодог ба дэлхий дээр гай гамшиг тохиосны дараа сайныг шагнаж, мууг нь шийтгэнэ. Эцсийн өдрүүд дэх Бурханы шүүлтийн ажил ийнхүү явагддаг. Эцсийн өдрүүд дэх Бурханы шүүлтийн ажлаас хэн ч зугтах боломжгүй, харин Бурханы шүүлтийг хүлээн зөвшөөрч, дуулгавартай дагадаг хүмүүсийн хувьд тэд ариусгагдаж, аврагдаж, төгс болгуулдаг. Эцсийн өдрүүд дэх Бурханы шүүлтийн ажлаас татгалзаж, эсэргүүцдэг хүмүүсийн хувьд, хэдий тэд Бурханы үгийн шүүлтээс нуугдаж болох ч, эцэст нь сүйрлээс зугтаж чадахгүй. Энэ бол бодит баримт! Бурхан эцсийн өдрүүдэд биднийг шүүхийг хүсдэгийн шалтгааныг Төгс Хүчит Бурханы үгэнд маш тодорхой хэлсэн байдаг. Төгс Хүчит Бурхан хэлэхдээ: **‘Есүс эцсийн өдрүүдэд бууж ирнэ гэдгийг л чи мэддэг, гэхдээ Тэр яг яаж бууж ирэх вэ? Дөнгөж золин аврагдсан, өөрчлөгдөөгүй, эсвэл Бурханаар төгс болгуулаагүй чам мэтийн нүгэлтэн Бурханы зүрх сэтгэлийн дагуу байж чадах уу? Одоо ч гэсэн хуучин хэвээрээ байгаа чиний хувьд, Есүсээр авруулж, Бурханы авралын улмаас нүгэлтэн гэж тооцогдохгүй байгаа чинь үнэн боловч нүгэлтэй биш, бохир заваан биш гэдгийг чинь энэ нь нотлохгүй. Хэрвээ өөрчлөгдөөгүй юм бол чи яаж ариун байж чадах юм бэ? Дотроо чи бохир заваанаар дүүрч, хувиа хичээсэн, өөдгүй байдаг мөртөө Есүстэй хамт буухыг хүссээр байдаг—тийм азтай явдал байна гэж үү дээ! Бурханд итгэх итгэлдээ чи нэг алхмыг орхисон: Чи зүгээр л золин**

---

аврагдсан, гэхдээ өөрчлөгдөөгүй. Чи Бурханы зүрх сэтгэлийн дагуу байхын тулд чамайг өөрчилж, цэвэрлэх ажлыг Бурхан биечлэн хийх ёстой; чи зөвхөн золин авруулсан бол ариун байдалд хүрч чадахгүй. Ийм маягаар чи Бурханы сайн ерөөлийг хуваалцах эрхгүй байх болно, учир нь чи хүнийг удирдах Бурханы ажилд нэг алхмыг орхигдуулсан, энэ нь өөрчлөгдөж, төгс болох гол алхам юм. Тиймээс дөнгөж золин аврагдсан нүгэлтэн чи Бурханы өв залгамжлалыг шууд өвлөн авч чадахгүй’ (Үг нь махбодоор илэрсэн номын “Нэршил болон ялгамж чанарын талаар”). Эзэн Есүст итгэснээр бидний нүгэл ердөө өршөөгддөг гэдгийг бид Бурханы үгээс ойлгодог. Энэ нь бид нүгэл үйлддэггүй, эсвэл нүгэлгүй гэсэн үг биш. Бодит байдал дээр, бид бүгд нүгэл үйлдэж, дараа нь нүглээ улайх хор хөнөөлт тойрогт амьдардаг бөгөөд биднийг шүүж, цэвэрлэхээр Бурхан Өөрийн үгийг илэрхийлэх нь бидэнд хэрэгтэй байсаар байна. Бид цэвэрлэгдэх л юм бол, тэнгэрийн хаанчлал руу өргөгдөхөд тохирох болно. Үүнийг Библид ингэж тэмдэглэсэн байдаг: **‘Та нар өөрсдийгөө ариусгаж, ариун байх ёстой; учир нь Би ариун билээ’** (Леви 11:44). **‘Ариун байдалгүйгээр хэн ч Эзэнийг харахгүй’** (Еврей 12:14). Бурхан бол цэвэр бөгөөд ариун. Бузартаж, ялзарсан хүмүүс Бурханы царайг харж чадахгүй ба Бурханы хаанчлалд ороход тохирохгүй. Эзэн Есүсийн хийсэн золин аврах ажил зөвхөн бидний нүглийг өршөөсөн боловч ялзарсан зан чанар болон нүгэлт уг чанараас биднийг чөлөөлөөгүй. Иймд бидний биеэ тоосон, ихэрхүү зан, хууран мэхлэлт, заль мэх, хувиа хичээсэн зан, жигшүүрт байдал, хорон муу ба шунал, үнэнд дургүйцэх, шударга бус байдалд нааштай хандах болон бусад ялзарсан сатанлаг уг чанар байсаар байдаг. Эдгээр ялзарсан уг чанар нь яг нарийндаа биднийг нүгэлд хөтөлж, Бурханыг эсэргүүцэхэд хүргэдэг эх сурвалж юм. Хэрвээ тэднийг үгүй хийхгүй бол бид байнга нүгэл үлдэж, нэр хүнд, эд хөрөнгийн төлөө тэмцэж, атаа жөтөө болон хэрүүл тэмцэлтэй байж, худал хэлж, хууран мэхэлж, өөрсдийгөө өргөмжилж, өөрсдийгөө гэрчлэх гэх мэтийг хийнэ. Ялангуяа, Бурханы ажил бидний үзэлтэй нийцэхгүй байх үед бид Бурханыг шүүж, үгүйсгэж, буруутгаж, Бурханы ажлыг эсэргүүцэхдээ өөрсдийн үзэл болон төсөөлөлд найдах боломжтой байсаар байдаг. Бурханыг эсэргүүцдэг ийм хүмүүс яаж тэнгэрийн хаанчлал руу өргөгдөж чадах юм бэ? Бурхан үнэнийг илэрхийлж, эцсийн өдрүүд дэх шүүлтийн ажлыг хийдэг ба ингэж хийж байгаа Түүний зорилго нь бидний дотроо агуулдаг ялзарсан сатанлаг уг чанарыг цэвэрлэх, мөн тэнгэрийн хаанчлалд өргөгдөх мөрөөдлийг маань биелүүлэх юм. Бид Бурханы шүүлтийг хүлээн зөвшөөрч, ялзарсан зан чанараасаа чөлөөлөгдөхөд ариусгалтад хүрч, өөрчлөгддөг. Бид Бурханы амлалтыг өвлөж, тэнгэрийн хаанчлал руу Бурханаар хүргүүлэх шаардлагыг хангасан байх болно.”

Эгчийн нөхөрлөсөн зүйлийг болон Төгс Хүчит Бурханы үгийг сонссоны дараа би

---

бодлоо: Хүн Эзэнд итгэсний дараа түүний нүгэл өршөөгдсөн гэх баримт нь тэр нүгэл үйлддэггүй гэсэн үг биш. Энэ бол үнэхээр үнэн! Чуулганд байгаа хүмүүсийг, пастор болон ахлагчдаас эхлээд энгийн гишүүн өөрийгөө хүртэл харвал хүн болгон өдөр нь нүгэл үйлдэж, шөнө нь нүглээ улайдаг байдалд амьдарч байгаа бөгөөд нүглийн хүлээс болон хяналтаас зугтаж чаддаггүй. Хүмүүс Бурханы үгийн шүүлт болон ариусгалтыг туулалгүйгээр Эзэний царайг мэдээж харах боломжгүй юм шиг байна! Үүнийг ингэж хэлбэл, Бурхан ирж, хүнийг шүүж, ариусгах ажлын үе шатыг хийх нь туйлын чухал юм байна! Хүн Эзэн Есүст итгэлтэй байвал шүүгдэх шаардлагагүй гэж би нэгэнтээ итгэдэг байсан. Эзэн ирэхдээ, Тэр Өөрт нь итгэдэггүй хүмүүсийг шүүнэ хэмээн би боддог байлаа. Одоо би энэ үзэл нь Бурханы хүсэлтэй огтхон ч нийцэхгүй, алдаатай хүлээн зөвшөөрөл гэдгийг ойлгов. Дараа нь Гао эгч надад Төгс Хүчит Бурханы Чуулганы “Сайхан Канаан нутаг дахь аз жаргал” гэх дуулж, бүжиглэж байгаа видеог тоглуулж үзүүллээ: “Би догдолж баярласаар Бурханы гэр бүлд эргэн ирлээ. Би бодитой Бурхан Таныг мэдэхдээ баярлаж, зүрх сэтгэлээ Түүнд өгсөн. Би Нулимсны Хөндийг туулсан ч Бурханы энэрэл хайрыг харсан. Бурханыг гэсэн миний хайр өдөр тутам өсдөг, Бурхан бол баяр хөөрийн минь ундарга. Бурханы гоо үзэсгэлэнд автаж, зүрх минь Түүнтэй холбогдоно. Би Бурханыг хэзээ ч бүрэн хайрлаж чадахгүй, магтаалын дуу зүрхэнд минь бялхана. ...” Дуу бүхэлдээ баяр хөөртэй, сэтгэл хөдөлгөм байсан ба ялангуяа урам зориг авахуйц байлаа. Дүрс бичлэг дээрх ах, эгч нарын царай аз жаргалаар бялхаж байхыг харсан бөгөөд даган дуулахгүй байж чадсангүй. Бид дуунд хамтдаа бүжиглэж эхэлсэн бөгөөд зүрх сэтгэл маань үнэхээр хөдөлсөн байв. Бурханы үгийн хангалттай байсан ах эгч нар ерөөгдөж, баяр хөөртэй байхыг би харлаа. Хэдий тэд Бурханы шүүлт болон гэсгээлтийг туулсан ч, ямар ч санаа зовох зүйлгүй, харин ч сул, чөлөөтэй, баяр хөөртэй агаад аз жаргалтай байв. Шашин дахь итгэл болон урам зориг минь яаж бүгд алга болсныг би бодлоо. Миний харсан бүхэн чуулганы эзгүйрэл, харанхуй байдал л байсан боловч Төгс Хүчит Бурханы Чуулганы ах, эгч нар Ариун Сүнсний ажлаар дүүрэн байлаа. Тэд үнэний талаар гэрэлтэй нөхөрлөж, Бурханыг эрч хүчтэйгээр магтаж, агуу сэтгэл хөдлөл, энергиэр Бурханд гэрчлэл хийж байв... Энэ хоёрыг харьцуулбал, хоёр өөр ертөнц шиг харагдаж байлаа. Тэр үед, урсгал дагаж явсан өнчин хүүхэд гэртээ эргэн ирж, ээжийн тэврэлтийн халуун дулааныг эдэлж байгаа мэт надад санагдав. Би ингэж бодсон юм: Тэнд үнэхээр эрж хайх үнэн байна. Эцсийн өдрүүд дэх Бурханы шүүлтийн ажлын үнэний талаар ах эгч нар юу гэж нөхөрлөхийг би сайн сонсох ёстой, тэгж байж Би Эзэнийг эргэн ирэхэд тэнгэрийн хаанчлал руу өргөгдөх боломжоо алдахгүй.

Үүний дараа, Ли эгч бидэнд Бурханы үгнээс дахиад хоёр хэсгийг уншиж өгөв: **“Бурхан юугаар дамжуулан хүнийг төгс болгодог вэ? Өөрийнхөө зөвт зан чанараар**

---

дамжуулан үүнийг гүйцэтгэдэг. Бурханы зан чанар нь үндсэндээ зөвт байдал, уур хилэн, сүр жавхлан, шүүлт, хараалаас бүрддэг бөгөөд хүнийг үндсэндээ шүүлтээр дамжуулан төгс болгодог. Зарим хүн ойлгодоггүй бөгөөд Бурхан яагаад хүнийг шүүлт, хараалаар л төгс болгож чаддаг юм бэ гэж асуудаг. Тэд: ‘Бурхан хүнийг хараавал хүн үхэхгүй гэж үү? Хэрэв Бурхан хүнийг шүүвэл хүн яллагдахгүй гэж үү? Тэгвэл түүнийг яаж бас төгс болгож чадах юм бэ?’ гэцгээдэг. Энэ бол Бурханы ажлыг мэддэггүй хүмүүсийн үг юм. Бурхан хүний дуулгаваргүй занг харааж, хүний нүглийг шүүдэг. Тэрээр хатуу ширүүнээр, өчүүхэн ч мэдрэмжгүйгээр ярьдаг хэдий ч хүний дотор буй бүхнийг илчилж, эдгээр хатуу үгээр хүний доторх гол зүйлийг ил болгож, ийм шүүлтээр дамжуулан махан биеийн мөн чанарын талаар хүнд гүн гүнзгий мэдлэг өгч, улмаар хүн Бурханы өмнө дуулгавартай захирагддаг. Хүний махан бие нүгэл болон Сатанд харьяалагддаг, энэ нь дуулгаваргүй бөгөөд Бурханы гэсгээлтийн бай юм. Тиймээс хүнд өөрийгөө мэдэх боломжийг олгохын тулд Бурханы шүүлтийн үг түүн дээр буух ёстой ба төрөл бүрийн цэвэршүүлэлт хэрэглэх ёстой; зөвхөн тэр үед л Бурханы ажил үр нөлөөтэй болж чадна” (Үг нь махбодоор илэрсэн номын “Зовлонт шалгалтыг туулснаар л Бурханы хайр татам байдлыг мэдэж болно”). “Шүүлтийн ажлын авчирдаг зүйл гэвэл Бурханы жинхэнэ дүр төрх болон өөрийнх нь тэрслүү байдлын үнэний талаарх хүний ойлголт юм. Шүүлтийн ажил нь хүнд Бурханы хүслийн тухай, Бурханы ажлын зорилгын тухай, хүний ойлгошгүй нууцуудын тухай ихээхэн ойлголт олж авах боломж олгодог. Түүнчлэн, өөрийн ялзарсан мөн чанар болон ялзралынхаа үндсийг таньж мэдэх, хүний муу муухайг нээн илрүүлэх боломжийг олгодог. Энэ бүх үр дүнг шүүлтийн ажил авчирдаг, учир нь энэ ажлын мөн чанар нь үнэндээ Бурханы үнэн, зам, амийг Түүнд итгэдэг бүх хүнд нээх ажил юм” (Үг нь махбодоор илэрсэн номын “Христ шүүлтийн ажлыг үнэнээр хийдэг”).

Ли эгч бидэнд нөхөрлөж, ингэж хэллээ: “Биднийг Сатан завхруулсны дараа, бид бүгдээрээ Сатаны эзэмшил дор амьдарч, Бурханыг эсэргүүцсэн өөдгүй хүмүүс болсон. Бурханы зөвт байдал болон ариун мөн чанарт үндэслэвэл бид бүгд Бурханы хараал болон сүйрлийн бай, гэхдээ Бурханы хүсэл бол хүн төрөлхтнийг сөнөөх биш, харин ч хүн төрөлхтнийг аврах явдал юм. Иймээс хүмүүсийг Сатаны эзэмшил доороос бүрэн аврахын тулд Бурхан эцсийн өдрүүдэд үг илэрхийлж, хүнийг шүүж, ариусгах ажил хийдэг. Шүүлтийн ажил нь үнэндээ, Бурханы эсрэг байдаг, Бурханыг эсэргүүцдэг хүмүүсийн үг, үйлдэл, уг чанар болон мөн чанарыг илрүүлэхийн тулд Бурхан үгээ ашиглаж байгаа хэрэг юм. Өөрийгөө үзэн ядах түвшинд хүрч, үнэхээр гэмшиж, өөрчлөгдөхийн тулд ялзралынхаа мөн чанар, жинхэнэ нөхцөл байдлыг мэдэж, Бурханы зөвт, ариун байдлын зан чанарыг танин мэдэхэд энэ нь хүмүүсийг хүргэдэг. Энэ нь ялзарсан сатанлаг зан

---

чанараас ангижирч, Бурханаар авхуулахын төлөө байдаг. Ийм маягаар хүмүүс аврал хүртэх болно. Зөвхөн Бурханы үгийн шүүлт, гэсгээлтээр л дамжуулан бид ялзралаар дүүрсэн гэдгээ харах боломжтой. Цаг ямагт, газар сайгүй аминч, биеэ тоосон зан, зальхай, шунахай байдлын ялзарсан зан чанарыг бид үзүүлдэг. Бид Бурхантай хамааралтай үзэл, төсөөлөл, хэмжээ хязгааргүй хүсэл болон үндэслэлгүй шаардлагуудаар дүүрсэн. Бидэнд ямар ч мөс чанар, эрүүл ухаан байхгүй, мөн сүсэг бишрэл, үнэнч байдлын аль нь ч байхгүй. Бид Бурханы шүүлтийг хүлээн зөвшөөрөх тусмаа, хэр гүнзгий ялзарснаа болон үнэхээр хүн чанаргүй гэдгээ улам их танин мэддэг. Бид өөрсдөдөө зэвүүцэж, зүрх сэтгэлдээ өөрсдийгөө үзэн ядаж эхэлдэг. Бурханы шүүлтийг хүлээн зөвшөөрөх тусмаа бид Бурханы ариун, зөвт байдлыг төдий чинээ харж, бидний зүрх сэтгэл Бурханыг улам их хүндлэх болно. Бид өөрсдийн махан биеийн хүслийн эсрэг байхыг, Бурханы үгийн дагуу амьдрахыг хүсэх болно. Дараа нь, аливаа зүйлсийн талаарх үзэл бодол болон ялзарсан уг чанарт маань өөрчлөлт гарах бөгөөд бид жинхэнэ хүний зарим дүр төрхийг амьдран харуулж эхэлнэ. Бурханы шүүлт болон гэсгээлтийг үнэхээр амталсан нь бидний хувьд асар их хайр болоод аврал юм. Бурханы шүүлт, гэсгээлтгүйгээр бид нар бүгд сүйрлийн бай болох байсан.”

Эгчийг энэ хүртэл нөхөрлөхөд миний сэтгэл үнэхээр хөдөлж, Бурханы хайр хэчнээн агуу бөгөөд жинхэнэ болохыг харав. Тэр бол хүн төрөлхтнийг хайрладаг Бурхан! Хүмүүсийг аврах Бурханы сайн санаа зорилгыг буруу ойлгосон хүн нь би л байлаа. Бурхан хүмүүсийн гэм буруутайг шийдэж, тэднийг шийтгэхийн тулд шүүдэг гэж би бодсон боловч эцсийн өдрүүдэд Бурхан Өөрийнхөө үгийг илэрхийлж, хүмүүсийг шүүж байгаа нь илүү жинхэнэ хайр буюу бидний төлөө бүр ч илүү агуу аврал юм гэж хэзээ ч бодсонгүй! Төгс Хүчит Бурханд талархъя! Төгс Хүчит Бурханы үгийг уншсанаар дамжуулан, мөн эгч нарын нөхөрлөсөн зүйлээс би Бурханы шүүлтийн ажлын тухай зарим ойлголтыг олж авч, Бурханы талаарх алдаатай үзлээ хаясан юм. Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүсээс өөр хэн ч биш гэх бат итгэлтэй болж, Бурханы шүүлтийн ажлыг хүлээн зөвшөөрөхөд бэлэн болов. Би манангаас бүрэн гарч ирж, нүүрэнд минь баясгалантай инээмсэглэл туяарч байлаа. Ли эгч аз жаргалтайгаар ингэж хэллээ: “Чамайг залж чиглүүлсний төлөө Бурханд талархъя. Энэ бүхэн бол Бурханы үгээр хүрсэн үр дүн юм. Үнэнийг ойлгохоосоо өмнө хэдий бид Бурхан болон Бурханы ажлын талаар үзэлтэй байдаг ч, бидэнд хэрэгтэй бүхэн нь үнэнийг хайж, хүлээн зөвшөөрч, Бурханы үгийг сонсох явдал юм, тэгж байж бид үнэнийг ойлгож, Бурханы ажлын талаар мэдлэгтэй болж, үзэл болон төсөөлөл маань үүл, утаа мэт хийсэх болно гэдгийг энэ нь бидэнд харуулдаг. Бид дараа нь Бурханы хүслийг ойлгох боломжтой болж, Бурханыг буруугаар ойлгохоо болино.” Би аз жаргалтайгаар толгойгоо дохиж, авралынх нь төлөө Бурханд талархлаа.



---

Эцсийн өдрүүд дэх Бурханы ажлыг хүлээн авсны дараа, Гао эгч болон бусад хүмүүс Төгс Хүчит Бурханы Чуулганы сайн мэдээний кино, клип болон магтан дууг надтай хуваалцаж болох учир би утсан дээрээ мессеж илгээдэг апп суулгав. Би “Амийн ус сэнтийнээс урсдаг” гэх Төгс Хүчит Бурханы Чуулганы сайн мэдээний киног үзэх үед энэ нь надад асар их нөлөө үзүүлсэн юм. Кинон дээрх чуулганы эзгүйрлийн нөхцөл байдал манай нөхцөл байдалтай яг ижил байсан ба энэ эзгүйрлийн эх үүсвэрийг уг кино надад тов тодорхой харуулсан билээ. Бурханы ажил шилжиж, Бурхан чуулган дотор ажиллахаа больсон учраас эцсийн өдрүүд дэх Төгс Хүчит Бурханы ажлыг хүлээн зөвшөөрөхөөс татгалздаг хүмүүс бүгд өлсгөлөнд зовж байсан юм. Төгс Хүчит Бурханы үгийг хүлээн зөвшөөрдөг хүмүүс амийн усны Бурханы хангалтыг олж авсан ба дахиж цангахаа больдог. Тэд Бурхантай нүүр нүүрээ харах ерөөгдсөн амьдралд хүрсэн. Би “Хүлээлт” гэх киног үзээд, санаа алдахаас ч өөр аргагүй байв. Кинон дахь хөгшин пастор бүхий л амьдралынхаа туршид Эзэнд итгэж, өөрийнхөө шаргуу ажлыг магтахуйц хэмээн боджээ. Эзэн ирж, өөрийг нь өргөхийг л тэр хүлээж байв. Гэхдээ тэр Эзэн ирэхдээ үүлэн дээр буун ирж, хамгийн түрүүнд өөрт нь илчлэл өгнө гэсэн итгэлтэйгээ зөрүүдлэн зууралджээ. Энэ зөрүүд байдлаасаа болж тэр эцсийн өдрүүд дэх Бурханы ажлыг эсэргүүцэж, үүнээс татгалзаж, эцэст нь үүл хүлээн тэнгэр өөд ширтэж, харамсалтайгаар үхэхээ хүлээж байлаа. Энэ гашуун сургамж хүмүүсийг үнэхээр гүн гүнзгий бодолд автуулсан юм! Үүний зэрэгцээ, Түүнээс зөвхөн ерөөл олж авахыг эрж хайж, харин Түүний шүүлт болон ариусгалтыг хүлээн зөвшөөрөх дургүй байсан тэрслүү хүү намайг аварсанд нь би зүрх сэтгэлдээ баярлаж, Төгс Хүчит Бурханд талархлаа илэрхийлсэн. Тэр намайг эцсийн өдрүүд дэх Бурханы авралыг олж авхуулахаар Бурханы сэнтийн өмнө хөтөлсөн билээ.

Одоо би Төгс Хүчит Бурханы Чуулганы амьдралд орсон бөгөөд Бурханы үгийн шүүлт, гэсгээлтийг үнэхээр туулснаар дамжуулан Бурхан шүүлтийн ажил хийж байгаа нь ямар бодит болоод практик болохыг аажуухнаар ойлгож эхэлсэн юм. Бурхан хүмүүсийн зальхай уг чанарыг задлан шинжлэхэд миний ярианд аливаа худал үг байхгүй гэж надад санагдсан ба Бурханы үгэнд илчлэгдсэн бодит нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрөөгүй. Гэвч, аливааг илчлэхээр Бурхан надад бодит орчин нөхцөлийг өгч байгаатай тулгарах үедээ би хувийн ашиг сонирхол, бардам зангаа хамгаалахаар өөрийн эрхгүй худал ярих болдог. Түүнчлэн, миний зүрх сэтгэлд заль мэх, худал хуурмаг байдаг ба бусдад дэлгэхийг хүсдэггүй олон нууц ч бас надад бий. Энэ нь надад, Бурханы үгээр илчлэгдсэн бүхэн үнэн бөгөөд бодит нөхцөл байдал гэдгийг, мөн энэ бол хүний уг чанар болон мөн чанар гэдгийг харуулсан юм. Зөвхөн тэр үед л би Бурханы үгэнд бүрэн үнэмшсэн бөгөөд надад үнэнийг эрж хайх, өөрийн зальхай уг чанарыг өөрчлөх хойшлуулшгүй хүсэл бий болов. Энэ туршлагын дараа, хэрвээ энэ мэтийн Бурханы практик шүүлт болон гэсгээлт байгаагүй бол

---

би зальхай уг чанараа хэзээ ч мэдэхгүй байх байлаа. Би бас зальхай зан чанараа өөрчлөхийн тулд үнэнийг хэрэгжүүлж чадахгүй байх байсан юм. Бурханы шүүлт, гэсгээлт нь миний хувьд яахын аргагүй цэвэрлэлт болон аврал байсан ба өөр төрлийн хайр байв. Би энэ онцгой хайрыг сайтар нандигнаж, Бурханы шүүлт, гэсгээлтийг хүлээн зөвшөөрөхийг хүсэж байна. Бурханыг сэтгэл хангалуун байлгадаг шинэ хүн болохын тулд би даруй өөрчлөгдөхийг хүсэж байна. Бүх нэр хүнд, алдар суу Бурханд байг!

## **10. Тэнгэрийн хаанчлал үнэхээр газар дээр байна**

Чэн Бо, Хятад

Итгэгч бидний хамгийн их хүсэн хүлээдэг зүйл бол тэнгэрийн хаанчлалд орж, хүнд Эзэний хайрласан мөнхийн аз жаргалыг эдлэх явдал билээ. Ирээдүйд бидэнд зориулж Эзэний бэлдэх газар тэнгэрт байдаг бөгөөд тэнд алтан талбай, хаш чулуун ханатай, эрдэнэсийн чулуу хаа сайгүй гялтганаж, бид амийн модны жимсийг идэж, амийн голын усыг ууж чадна, мөн ямар ч өвчин шаналал, нулимс, уй гашуу байхгүй, бүгд эрх чөлөөтэй, чөлөөлөгдсөн байна гэж пастор номлолдоо хэлэхийг сонсох бүрдээ би асар их сэтгэл хөдлөл, баяр хөөрт автдаг байв. Энэ нь миний маш их хүсэн хүлээж байсан газар бөгөөд газар дээрх зүдэргээт, уй гашуут амьдрал зүрх сэтгэлийг минь үнэхээр ихэд туйлдуулж орхисон байсан юм. Иймээс би сайн мэдээ түгээн гадуур явж, Эзэний төлөө өөрийгөө урам зоригтойгоор зарлагдаж байлаа; би сайн мэдээ түгээж, чуулганууд байгуулсан бөгөөд энэ нь хэчнээн шаналгаатай, хэцүү болсон ч гэсэн хэзээ ч амсхийж байгаагүй юм. Ялангуяа бид эцсийн өдрүүдэд байгаа ба Эзэн биднийг бүгдийг нь тэнгэрлэг гэр лүү маань аваачихаар удахгүй эргэн ирнэ гэдгийг мэдэж байсан тул би хавьгүй илүү идэвх санаачилгатай ажиллаж, өөрийгөө зарлагдаж байлаа.

Нэг өдөр би ээжтэйгээ уулзахаар охин дүүгийнхээ гэрт очсон бөгөөд намайг явах гэж байтал дүү маань нэг ном өгч, анхааралтай уншаарай гэж шавдуулав. “Дүүгийн өгсөн энэ ном сүнслэг ном байх учиртай, сүнс минь яг одоо нэлээн ангаж хатсан санагдаад байгаа. Би Эзэний байгааг мэдрэхгүй, Библи унших үедээ ямар ч гэрэлтүүлэлт олж авахгүй байгаа. Би харихаараа энэ номыг сайтар унших хэрэгтэй. Магадгүй үүнээс бага зэрэг хангалт авах байх” гэж би бодов. Гэртээ харьсныхаа дараа би тэр номыг нээн уншиж эхэлсэн бөгөөд нэг л мэдэхэд сэтгэл татагдсан байлаа. Тэр номыг унших тусам улам уншмаар санагдаж, эдгээр үгэнд гэрэл байгааг, Ариун Сүнсний гэгээрлийг агуулж байгааг, бас эдгээр үгийг энгийн хүн хэлэх аргагүй болохыг төдий чинээ их мэдрэв. Тэр номыг уншсаны дараа Библийг урьд нь уншаад ойлгоогүй зарим үнэнийг ойлгож авсан ба дотроо

---

ойлгомжтой байдал, таашаалыг мэдэрсэн юм. Би Эзэнд залбирч, ойртон очихыг хүссэн ба итгэл маань нэмэгдэж, сүнслэг байр байдал минь улам бүр сайжирлаа. “Ариун Сүнсний ажил л хүнийг итгэл, хүч чадлаар хангаж, хүний сүнсэнд хангалт, тэжээл өгч чадна. Энэхүү номон дахь үг Ариун Сүнснээс ирсэн нь гарцаагүй” гэж бодогдов. Үр дүнд нь би өглөө бүр сэрээд юун түрүүнд энэ номыг уншдаг болсон юм.

Нэг өдөр би номоо нээгээд дараах хэсгийг уншив: **“Бурхан амралтад орно гэдэг нь хүн төрөлхтнийг аврах ажлаа хийхээ болино гэсэн үг юм. Хүн төрөлхтөн амралтад орно гэдэг нь бүх хүн Бурханы гэрэл дотор, Түүний ерөөл дор амьдарна, Сатаны завхрал байхгүй, ямар ч зөв шударга бус зүйл тохиолдохгүй гэсэн үг. Хүмүүс Бурханы халамж дор газар дээр хэвийн амьдарна”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурхан хүн хоёр амралтад хамт орох болно”). Үүнийг уншаад зүрх дэлсэж, би ийн бодлоо: “Ирээдүйд хүн газар дээр амьдрах юм уу? Эзэн Есүс ирээдүйд биднийг тэнгэрт амьдарна гэж амласан бус уу? Энд яагаад биднийг газар дээр амьдарна гэж байна вэ? Яаж боломжтой байж болох юм бэ? Би үүнийг буруу уншаад байна уу?” Тиймээс би дахин анхааралтай уншлаа; хүн ирээдүйд газар дээр амьдарна гэж яах аргагүй хэлж байв. Тэгвэл энэ нь яг үнэндээ юу гэсэн үг вэ? Ийм байж таарахгүй хэмээн би гайхширлаа. Энэ нь яг юу гэсэн утгатай болохыг ойлгох ёстойгоо би мэдэж байв. Тэгээд би үргэлжлүүлэн уншлаа: **“Бурханд Бурханы хүрэх газар, хүнд хүний хүрэх газар гэж бий. Амрах зуураа Бурхан бүх хүний газар дээрх амьдралыг залж чиглүүлсээр байх болно, Бурханы гэрэлд хүмүүс тэнгэр дэх цор ганц жинхэнэ Бурханд шүтэн мөргөнө... Хүмүүс амралтад орох гэдэг нь жинхэнэ бүтээл болсон гэсэн утгатай; тэд газар дээрээс Бурханд шүтэн мөргөж, хэвийн хүний амьдралаар амьдарна гэсэн үг. Хүмүүс Бурханд дуулгаваргүй байж, Бурханыг эсэргүүцэхээ болиод, Адам, Евагийн анхдагч амьдралдаа буцна”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурхан хүн хоёр амралтад хамт орох болно”). Би унших тусмаа төдий чинээ их будиллаа: Хүн газар дээрээс Бурханд шүтэн мөргөх юм уу? Энэ нь яаж хийгдэх юм бэ? Энэ нь тэнгэрт болно гэж Библид хэлдэг биш үү? Яаж газар дэлхий дээр байх юм бэ? Би Библи рүүгээ яаран очиж, Иохан 14:2-3-ыг нээн Эзэн Есүсийн хэлснийг уншив: **“Миний Эцэгийн гэрт олон орон байр бий: тийм байгаагүй бол Би та нарт хэлэх байлаа. Би та нарт зориулан орон байр бэлдэхээр явна. Хэрвээ Би яваад та нарт зориулан орон байр бэлдчихвэл дахин ирээд та нарыг Өөртөө авах болно; Би хаана байна та нар ч бас тэнд байх болно.”** Өөрийнх нь амилал болон тэнгэр өөд гарсан нь бидэнд зориулсан орон байр бэлдэхийн төлөө юм гэж Эзэн Есүс тодорхой хэлсэн байдаг, иймээс бидний хүрэх газар тэнгэрт байх ёстой. Энэ бол Эзэний амлалт! “Энэ номонд хэлж буй зүйл Эзэний хэлдгээс өөр байгаа тул би үүнийг уншаад байж болохгүй” гэж би бодов. Номыг хаасны дараа ухаан санаа маань маш их будилсан байдалтай байсан

---

бөгөөд юу зөв болохыг мэдэхгүй байв. Тэгээд би Эзэнд хандан ахин дахин залбирсан юм: “Өө Эзэн минь, намайг замчилж, удирдаач. Би энэ номыг унших хэрэгтэй юу, үгүй юу? Өө Эзэн минь, намайг гэгээрүүлж, залж чиглүүлээч...” Залбирсныхаа дараа би, энэ номыг уншаад Эзэнтэй улам ойр харилцаатай болж, итгэлдээ илүү их урам зоригтой болж, сүнс маань хангалт хүртсэн тухай бодов. Хэрвээ би энэ номыг хойш тавьж, уншихаа боливол сүнсээрээ ангаж хатсан урьдын байдалдаа буцаж очно гэж ч санагдлаа. Энэ ном намайг маш их босгон байгуулсан, бас энэ нь Ариун Сүнснээс ирсэн, Ариун Сүнснээс ирсэн юм чинь алдаа мадагтай байх боломжгүй гэдгийг баталж чадах тул хэдийгээр зарим агуулга нь миний үзэлтэй нийцэхгүй байсан ч гэсэн үүнээс татгалзаж, уншихаа болих ёсгүй гэдгийг би мэдэж байв. Энэ бүхнийг бодоод би сэтгэл шулуудахаасаа өмнө үргэлжлүүлэн уншихаар шийдсэн юм.

Тэгээд би номоо дахин авч, үргэлжлүүлэн уншлаа: **“Хүний амрах газар дэлхий дээр, Бурханы амрах газар тэнгэрт байдаг. Хүмүүс амралтад Бурханд шүтэн мөргөж, газар дэлхий дээр амьдарна, харин Бурхан үлдсэн хүмүүсийг амралтад залж чиглүүлдэг ба тэднийг газар дэлхийгээс бус, тэнгэрээс залж чиглүүлнэ”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурхан хүн хоёр амралтад хамт орох болно”). Би үүнийг ахин дахин эргэцүүлж, “Бурханы амрах газар тэнгэрт буй бөгөөд хүн газар дээрх амралтдаа Бурханд шүтэн мөргөнө гэж энэ хэсэг хэлж байна. Үүнд хэлж байгаачлан хүний амрах газар үнэхээр газар дэлхий дээр байх юм гэж үү? Боломжгүй юм! Эзэний байгаа газарт бид байх болно, Эзэн Есүс дахин амилж, тэнгэр өөд очсон тул бид ч бас гарцаагүй тэнгэр өөд очно гэдгийг Эзэн Есүс аль хэдийн хэлсэн!” гэж бодов. Би өнгөрсөн хэдэн жилийн талаар, Эзэний төлөө хэрхэн явж байснаа, тийм их зовлонг хэрхэн даван туулснаа бодлоо. Энэ бүх зовлон тэнгэр өөд гарч, дэлхий ертөнцийн зовлонг туулахаа болихын төлөө байгаагүй гэж үү? Үнэхээр энэ номонд бичигдсэн шиг ирээдүйд хүн газар дээр амьдарсаар байх юм бол миний итгэл найдвар хий дэмий болох бус уу? Би хөдөлж чадалгүй, орон дээрээ суугаад толгойноосоо хөлийн өлмий хүртлээ сульдан тамирдаж байлаа. Энэ тухай бодох тусам улам тайван бус санагдаж байсан юм. Тэгээд энэ талаар тодорхой ойлгохын тулд би дүүгийнхээ гэр лүү яаравчлав.

Дүүгийнхээ очоод би нэг дунд эргэм насны эмэгтэйтэй уулзсан ба эгч түүнийг Ли эгч гэж танилцууллаа. Удалгүй би энэ номыг уншсаны дараа юу бодогдсоноо тэдэнд хэлэв. Миний хэлэхийг сонсоод Ли эгч надтай ингэж нөхөрлөлөө: “Эгч ээ, Эзэн Есүс бидэнд зориулж орон байр бэлдэхээр амласан, Тэр хаана ч байсан, бид бас тэнд байна гэж Эзэнд итгэдэг бид бүгд боддог. Эзэн тэнгэр өөд буцсан тул ирээдүйд эргэн ирэхдээ Тэрээр биднийг гарцаагүй тэнгэрт угтан авч, бид Түүнтэй хамт тэнд амьдарна гэж боддог. Гэхдээ ийм төрлийн төсөөлөл, үндэслэл үнэн зөв эсэхийг бид ер нь бодож үзсэн үү? Хэрвээ

---

бидний төсөөлдөг шиг, Эзэн ирээд биднийг тэнгэрт амьдруулахаар авч явах юм бол Эзэний залбирал дахь **‘Таны хаанчлал ирэх болтугай, Таны хүсэл тэнгэрт байдаг шигээ газар дээр биелэх болтугай’** (Матай 6:10) хэмээх үг, бас Илчлэлийн номон дахь **‘Харагтун, Бурханы асар хүмүүсийн дунд байж, Тэр тэдэнтэй хамт суурьших ба тэд Түүний ард болж, Бурхан Өөрөө тэдэнтэй хамт байж, тэдний Бурхан болно’** (Илчлэл 21:3) хэмээх зөгнөл хий дэмий болох биш үү? Тэдгээр нь яаж биелэх юм бэ? Хэрвээ Бурханы бидэнд өгөх эцсийн хүрэх газар тэнгэрт байсан бол Бурхан хүнийг анх бүтээхдээ биднийг газар дээр амьдруулахын утга учир юу байсан байх вэ?” Би өчүүхэн төдий ч үнэмшээгүй бөгөөд эрс татгалзан ийн хариуллаа: “Хэдийгээр Сударт тэгж бичсэн боловч Эзэн Өөрөө: **‘Би та нарт зориулан орон байр бэлдэхээр явна. Хэрвээ Би яваад та нарт зориулан орон байр бэлдчихвэл дахин ирээд та нарыг Өөртөө авах болно; Би хаана байна та нар ч бас тэнд байх болно’** (Иохан 14:2–3) гэж хэлсэн. Эзэн Есүс дахин амилсныхаа дараа тэнгэр өөд очсон бөгөөд Эзэн яваад бидэнд зориулсан орон байр бэлдэнэ гэж энд хэлж байна. Тэр хаана байна, бид ч бас тэнд байна гэж Тэр хэлсэн. Тэгэхээр бид газар дээр мөнх амийг олж авах биш, харин тэнгэр өөд гарч, мөнх амь олж авна гэж Бурхан амласныг энэ нь нотолж байна. Энэ бол хэний ч үгүйсгэж чадахгүй зүйл!”

Ли эгч тэвчээртэйгээр ийнхүү үргэлжлүүллээ: “Эгч ээ, Өөрт нь итгэдэг хүмүүст Эзэн орон байр бэлдэж байгаа гэдэг нь үнэн, гэхдээ тэр газар үнэхээр газар дээр байдаг уу, эсвэл тэнгэрт байдаг уу? Эзэний эдгээр үгэнд тэрийг хэлээгүй, тэгвэл Эзэний бидэнд зориулан бэлдэж байгаа орон байр тэнгэрт байдаг гэж хэлэхдээ бид юунд үндэслэдэг юм бэ? Энэ үнэхээр Эзэний амлалт уу, эсвэл бидний өөрсдийн үзэл, төсөөлөл үү? Эзэнд итгэдэг бидний хувьд бүх зүйл Эзэний үгэнд үндэслэх ёстой—бид Эзэний үгийг өөрсдийн үзэл, төсөөлөлтэй хольчихоод, Эзэн ийм утгаар хэлсэн гэгцгээх ёсгүй. Энэ нь Эзэний үгийг өөрсдийн санаа, сэдлийн дагуу тайлбарлаж байгаа хэрэг биш үү? Энэ нь Эзэний үгийг гуйвуулж байгаа бус уу? Бид Эзэний үгийг тайлбарлахдаа өөрсдийн толгой дахь төсөөлөлд юм уу өөрсдийн бодол, шилэлт сонголтод найдаж болохгүй. Хэрвээ тэгвэл алдаа гаргана. Эхлэл 2:7–8-д: **‘Ехова Бурхан газрын шорооноос хүнийг бүтээж, амин амьсгалыг хамар луу нь үлээн оруулжээ; тэгээд хүн амьд биет болов. Ехова Бурхан дорно зүгт Еденд цэцэрлэг тарьлаа; тэнд Өөрийн бүтээсэн хүнийг тавьжээ’** гэж байдаг. Эхэнд Бурхан хүнийг газар дээр бүтээсэн, хүнийг бүтээхээсээ өмнө Тэрээр бидний амьдралд тохиромжтой орчныг бэлдэхийн тулд бүх зүйлийг эхлээд бүтээсэн гэдэг нь тодорхой байна. Биднийг газар дээр амьдруулах нь Бурханы хүсэл юм гэдгийг бид харж болно. Түүнээс гадна, Эзэний Залбиралд Бурханы хаанчлал газар дээр ирэхийн төлөө Эзэн биднийг залбируулдаг. Бас Илчлэлийн номонд ингэж зөгнөсөн байдаг: **‘Энэ дэлхийн хаанчлал нь бидний Эзэний болон Түүний Христийн хаанчлал болсон’** (Илчлэл 11:15). **‘Харагтун, Бурханы асар хүмүүсийн дунд байж, Тэр тэдэнтэй хамт суурьших болно’**

---

(Илчлэл 21:3). Бурханы бидэнд бэлдэж буй орон байр газар дээр байдаг ба бидний хожмын хүрэх газар тэнгэрт бус, газарт байдгийг бид эдгээр эшлэл болон зөгнөлөөс харж болно.” Ли эгчийн нөхөрлөл миний үзлээс тэс өөр байв. Түүний хэлснийг би ердөө сонсоогүй тул босож зогсоод ууртайгаар: “Одоо хангалттай! Би тэнгэр лүү явж чадна гэсэндээ энэ бүх жилүүдэд Эзэний төлөө гүйж, өөрийгөө зарлагадаж, зовж шаналсан! Эзэн намайг тэнгэр дэх гэртээ аваачих болохоор газар дэлхий дээр зовж шаналахаа болино гэж би цаг ямагт хүсэн хүлээсэн, гэтэл бидний эцсийн хүрэх газар дэлхий дээр байна гэж та хэлж байна. Би үүнийг хүлээн зөвшөөрч чадахгүй” гэв. Ингэж хэлээд би явахаар эргэлээ. Охин дүү маань яаран ирээд намайг ухааруулахаар оролдон: “Хүүе, та яаж ийм зөрүүд байж чаддаг байна аа? Таны баримталж байгаа үзэл зөв гэж үү? Эзэн **‘Би яваад та нарт зориулан орон байр бэлдчихвэл’** гэж хэлсний жинхэнэ утга учрыг та мэдэхгүй ч өөрийн бодолтой зууралдсаар байна. Энэ чинь тэнэг хэрэг биш үү? Энэ бол үнэнийг эрэлхийлдэг хүмүүст байвал зохих хандлага биш! Бидний хүсэн хүлээж байсан Эзэн Есүс аль хэдийн эргээд ирчихсэн, Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс! Танд уншуулахаар өгсөн тэр ном бол Бурханы Өөрийн айлдвар, үгс юм! Биднийг авахаар ирнэ гэж өдөр бүр хүлээж байсан Эзэн одоо ирчихсэн байгаа. Бид анхааралтай сонсох ёстой. Энэ алтан боломжийг алдаж хэрхэвч болохгүй!” гэлээ.

Дүүгийнхээ хэлснийг сонсоод би мэл гайхав. Дөнгөж сая сонссон зүйлдээ ердөө итгэж зүрхэлсэнгүй: Эзэн ирчихсэн гэнэ ээ? Энэ үнэн үү? Тэгтэл дүү маань ийн хэллээ: “Энэ номон дахь үгс Ариун Сүнснээс ирсэн гэж та өмнө нь хэлсэн биш бил үү? Үүнийг уншаад та маш их хангалт хүртэж, Ариун Сүнсний ажлыг олж авсан, бас Эзэнтэй харилцах харилцаа чинь илүү ойр болсон. Одоо бодоод үз: Эзэний үгээс өөр хэн ийм үр нөлөө үзүүлэхүйц байдлаар ярьж чадах юм бэ? Одоо Эзэн ажиллаж, шинэ үг айлдахаар эргээд ирчихсэн бөгөөд бид Бурханы үгийн амтыг таашааж чадна. Хэрвээ бид үүнийг эрэлхийлэхгүй, судлан шинжлэхгүй бол, өөрсдийнхөө ойлголт, төсөөлөл болон Библийн үгчилсэн утгатай сохроор зууралдаад л байвал эцэст нь өөрсдийгөө сүйрүүлнэ. Тухайн үедээ Библийг сайтар мэддэг байсан фарисайчууд Библийн үг үсэгтэй сохроор зууралдсан боловч Библийн талаарх ойлголт нь зөв эсэхийг, мөн Бурханы хүсэлтэй нийцэж байгаа эсэхийг нягтлан шалгах гэж огт оролдоогүй. Харин ч тэд Мессиа гэж нэрлэгдээгүй хэн боловч ирэх учиртай Аврагч биш гэж бодсон. Эзэн Есүсийн зам хүний амийг хангаж чадах эсэхийг, эсвэл хэрэгжүүлэлтийн замыг хүнд өгч чадах эсэхийг тэд ердөө шалгаагүй. Зүгээр л өөрсдийн үзэл, төсөөлөлтэй зөрүүдлэн зууралдаж, Эзэн Есүсийн авралаас сохроор татгалзан, эцэст нь Эзэнийг загалмайд цовдлох жигшүүрт нүгэл үйлдсэн. Бид фарисайчуудын хөлийн мөрийг дагаж, Бурханыг эсэргүүцдэг замаар нь явж болохгүй!” Дүүгийнхээ үгийг сонсоод би хэлж байгаа зүйл нь үндэслэлтэй юм гэж бодлоо. Эзэний үг

---

л ангаж хатсан сүнсний шийдэл мөн. Энэ номыг уншиж эхэлснээс хойш сүнсний байр байдал маань үнэхээр сайжирсаар байсан тухай, мөн энэ нь надад Бурханд итгэх итгэлийг өгч, Эзэний байгааг мэдэрч чадсан тухайгаа би бодлоо. Тэр ч байтугай би зарим үнэнийг ойлгож авсан. Энэ номон дахь үгс үнэхээр эргэн ирсэн Эзэний айлдвар юм гэж үү? Эзэн эргэн ирэх нь үнэхээр том хэрэг. Би сохроор татгалзаж, шүүмжилж болохгүй, харин үүнийг судалж, эрж хайхаар хичээх ёстой гэдгээ би мэдэж байв. Үнэнийг эрж хайлгүй, зүгээр л үзэлтэйгээ зууралдан, Бурханыг эсэргүүцсэн тэр фарисайчууд шиг байж болохгүй! Тэрхүү мөчид би тааламжтайгаар гайхширч, бас айж байв. Би Эзэнд итгэж, санаа зоволгүйгээр амьдарч болох, газар дээрх хүнд хэцүү амьдралаар амьдрах шаардлагагүй тэнгэрийн хаанчлалд намайг хүлээн авахаар Түүний ирэхийг хүлээж байсан бөгөөд тэр өдөр Эзэн эргэн ирсэн тухай мэдээг сонссон учраас тааламжтайгаар гайхсан. Энэ бол үнэхээр гайхамшигтай, баярт тохиолдол байлаа. Хэрвээ Төгс Хүчит Бурхан эргэн ирсэн Эзэн юм бол Эзэн намайг тэнгэрийн хаанчлалд аваачна гэсэн мөрөөдөл минь нуран унана гэхээс айж байв... Зүрх сэтгэл минь туйлын их үймэрч, өөр өөр сэтгэл хөдлөлөөр бялхаж байлаа. Арга мухардан байхдаа би Эзэнд залбирахаас өөр яаж ч чадсангүй: “Өө Эзэн минь! Намайг тэнгэрлэг гэртээ аваачихаар ирэхийг тань би өдөр бүр хүлээдэг байсан боловч миний эцсийн хүрэх газарт зориулж Таны бэлдсэн орон байр энд газар дээр байдаг гэж тэд хэлж байна. Энэ баримттай би үнэхээр нүүр тулж чадахгүй нь. Би газар дээр ийм хүнд хэцүү амьдралаар амьдрахыг үнэхээр хүсэхгүй байна. Өө Эзэн минь! Би одоо зүрх сэтгэлдээ үнэхээр их зовж байна. Надад тусалж, урдах замд минь залж чиглүүлээч.” Залбирсны дараа, **“Сүнсээрээ ядуу хүмүүс ерөөлтэй ээ: учир нь тэнгэрийн хаанчлал бол тэднийх юм”** (Матай 5:3) гэх Эзэн Есүсийн үг санаанд оров. Энэ үнэн! Сүнсэндээ ядуу, тэнгэрийн хаанчлалд орохын тулд үнэнийг эрэлхийлдэг хүмүүс Эзэнд таалагддаг. Би сүнсэндээ ядуу байх ёстой—тэдний нөхөрлөлийг анхааралтай сонсох нь л Эзэний хүсэлд нийцнэ.

Энэ мөчид Ли эгч: **“Зүрх сэтгэлдээ цэвэр ариун хүмүүс ерөөлтэй ээ: учир нь тэд Бурханыг харах болно”** (Матай 5:8) гэж Эзэн хэлсэн. Бид Эзэний үгийг сонсох хэрэгтэй, Эзэнийг эргэн ирэхэд халуун дотноор угтан авахын тулд ариун зүрх сэтгэлтэй байх ёстой. Бурханы өнөөдөр хийж байгаа ажил бидний үзэл, төсөөлөлтэй нийцэхгүй байгаа хэдий ч Бурханы хийдэг бүхэн сайн бөгөөд бүгд хүн төрөлхтний төлөө байдаг, мөн Бурханы хүслийг агуулдаг—энд эрж хайх үнэн байгаа. Хэрвээ бидэнд бүрэн гүйцэд ойлголт байхгүй бол бид эхлээд өөрсдийгөө хойш тавьж, үнэнийг эрж хайхад хичээл чармайлт гаргах ёстой, ингэснээр бид Бурханы гэгээрлийг хүлээн авч, Түүний хүслийг ойлгож чадна. Эгч ээ, зүрх сэтгэлээ нээж, одоо ч гэсэн ойлгохгүй байгаа зүйлсийнхээ талаар ярь, тэгээд бид нөхөрлөлөөр хамтдаа эрж хайж болно” гэлээ. Ли эгчийн хэлж байгаа зүйл утга

---

учиртай бөгөөд би тайвширч, эрж хайх хэрэгтэй санагдсан тул “Эгч ээ, миний ойлгохгүй нэг зүйл байна. Бидний эцсийн хүрэх газар яагаад тэнгэрт биш, харин энд газар дээр байгаа юм бэ?” гэж би хэлэв. Ли эгч Иохан 3:13: **“Тэнгэрээс доош бууж ирсэн хүний Хүүгээс өөр тэнгэр лүү дээш гарсан хүн нэг ч байхгүй”**, Исаиа 66:1 **“Тэнгэр бол Миний сэнтий, газар бол Миний хөлийн гишгүүр”** гэсэн эшлэлүүдийг гаргаад надад уншуулахаар өглөө. Дараа нь эгч энэ хоёр хэсгийн утгын талаар нөхөрлөв. Эгчийн нөхөрлөлөөр зүрх сэтгэл минь гэнэт цэлмэлээ—би Библийн энэ хоёр эшлэлийг аль хэдийн мэддэг байсан, харин яагаад эдгээрийг урьд нь хэзээ ч бодож байгаагүй юм бол? Тэнгэрээс бууж ирсэн хүний Хүүгээс өөр хэн ч тэнгэр өөд гарч чадахгүй, учир нь тэнгэр бол Бурханы сэнтий, газар бол Бурханы хөлийн гишгүүр гэдгийг Эзэн тун тодорхой хэлсэн тул хүн яаж тэнгэр өөд явах үнэ цэнтэй байж чадах юм бэ? Бурхан хүнийг газар дээр бүтээж, биднийг газар дээр амьдруулсан. Бурхан хүнийг бүтээсэн яг тэр өдрөөс эхлэн хүн үеийн үед газар дээр амьдарч, өсөн үржсэн билээ. Хүн төрөлхтнийг аврахын тулд Бурханы хийсэн бүх ажил газар дээр явагдсан. Энэ бол Бурханы аль эрт урьдчилан тогтоосон зүйл бөгөөд хэний ч өөрчилж чадахгүй зүйл юм. Дараа нь эгч Библийг нөхөрлөлдөө холбож, Эзэн бидэнд зориулж орон байр бэлдэнэ гэж хэлсэн тухай ярилаа. Тэгээд, энэ нь эцсийн өдрүүд дэх бие махбодтой болсон Бурханы газар дээрх илрэлт болон ажлыг хэлж байгаа ба биднийг эцсийн өдрүүдэд төрж, Бурханы дуу хоолойг сонсож, Бурханы сэнтийн өмнө өргөгдөж, Бурханы эцсийн өдрүүдийн шүүлт, ариусгалтыг хүлээн авч, эцэст нь Бурханы хаанчлал руу хүргэгдэнэ гэж Тэрээр урьдчилан тогтоосон гэж эгч тайлбарласан билээ. Энэ нь **“Би хаана байна та нар ч бас тэнд байх болно”** (Иохан 14:3) гэх үгийн жинхэнэ утга учир юм. Бурханы хаанчлал үнэндээ газар дээр байгаа ба хүний эцсийн хүрэх газар тэнгэрт биш, газар дээр байгааг би харлаа! Энэ бүх цаг хугацаанд би өөрийн үзэл, төсөөлөл дунд амьдарч, Бурхан эргэн ирээд намайг тэнгэрт амьдруулахаар аваачна хэмээн хязгаарласан боловч энэ нь Эзэний хүсэлтэй, эсвэл баримтуудтай огт нийцэхгүй байлаа! Гэсэн хэдий ч би Сатанаас болж зовж шаналан газар дээр ийм амьдралаар амьдрахыг хүсэхгүй хэвээр байлаа. Тэгээд би өөрийн бодлыг Ли эгчид тайлбарлав.

Намайг сонссоныхоо дараа Ли эгч “Үг нь махбодоор илэрсэн” номыг нээж, Төгс Хүчит Бурханы үгээс нэг хэсгийг уншиж өглөө: **“Амралтад амьдарна гэдэг нь дайн дажингүй, бузар буртаггүй, ямарваа шударга бус байдал үлдээгүй амьдрал гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, Сатаны үймээн (энд ‘Сатан’ гэдгээр дайсны хүчийг хэлж байна), Сатаны завхралаас ангид, Бурханы эсрэг ямар нэгэн хүчний халдлагад өртдөггүй амьдрал; бүх зүйл өөрсдийн төрлийг дагаж, бүтээлийн Эзэнд шүтэн мөргөдөг, тэнгэр газар тэр аяараа амар амгалан байдаг амьдрал юм—‘хүмүүсийн амар тайван амьдрал’ гэдгийн утга учир энэ... Бурхан, хүн хоёр амралтад орсны дараа Сатан**



---

оршин байхаа болино; үүний адилаар хорон муу хүмүүс ч бас оршин байхаа болино. Бурхан, хүн хоёр амралтад орохоос өмнө газар дээр нэгэнтээ Бурханыг хавчиж байсан хорон муу хүмүүс болон газар дээр Түүнд дуулгаваргүй байсан дайснууд аль хэдийн устгагдсан байх болно; тэднийг эцсийн өдрүүдийн агуу гамшиг устгасан байх болно. Тэр хорон муу хүмүүс үндсээрээ устгагдмагц газар дэлхий Сатаны дарлалыг дахин хэзээ ч амсахгүй. Тэр үед л хүн төрөлхтөн бүрэн аврал хүртэж, Бурханы ажил бүрэн дуусна. Эдгээр нь Бурхан, хүн хоёр амралтад орох урьдчилсан нөхцөл юм” (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурхан хүн хоёр амралтад хамт орох болно”).

Төгс Хүчит Бурханы үгийг уншсанаар дамжуулан, хэдийгээр бид газар дээр үргэлжлүүлэн амьдрах боловч хүн төрөлхтнийг аврах ажлынхаа эцсийн үе шатыг Бурхан дуусгамагц Сатан устаж, газар дээрх бидний амьдралыг Сатан дахин хэзээ ч үймүүлэхгүй, бид дахин хэзээ ч шаргуу хөдөлмөрлөж, гуниглахгүй, мөн цаашид нулимс, шүүрс алдалт гэж байхаа болино гэдгийг би ойлгож авсан юм. Энэ нь яг л Адам, Ева хоёр Еден цэцэрлэгт амьдарч байсан үеийнх шиг байх болно. Бид Бурханд чөлөөтэй шүтэн мөргөж, Бурхан хүнтэй хамт байх сайхан, ерөөгдсөн амьдралаар амьдарна. Энэ бол хүн төрөлхтний эцсийн хүрэх газар бөгөөд эцсийн өдрүүдийн ажлаараа Бурханы бүрмөсөн гүйцэлдүүлэх зүйл юм. Энэ үнэхээр гайхамшигтай! Яг тэр мөчид би: “Хүн төрөлхтний эцсийн хүрэх газрыг хэн ийм тодорхой тайлбарлаж чадах юм бэ? Хүн төрөлхтний төгсгөлийг хэн зохицуулж чадах юм бэ? Бурхан л үүнийг хийж чадна!” хэмээн уулга алдсан юм. Би Төгс Хүчит Бурханы үгэн дотроос Бурханы дуу хоолойг таньсан бөгөөд Төгс Хүчит Бурханы ажил бол Бурханы илрэлт болон ажил юм гэдгийг би харсан! Надад байсан үзэл эцэст нь үгүй болж, би Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг баяртайяа хүлээн авч, Бурханы сэнтийн өмнө буцан очсон билээ.

## 11. Би Эзэнтэй эргэн уулзлаа

Ли Лань, Өмнөд Солонгос

Төгс Хүчит Бурхан ингэж хэлсэн байдаг: “Эцсийн өдрүүдийн Христ амийг, мөн өнө удаан мөнхөд үргэлжлэх үнэний замыг авчирдаг. Энэ үнэн бол хүн амийг олж авах зам, нөгөөтээгүүр хүн Бурханыг мэдэж, Бурханаар сайшаагдах цорын ганц зам юм. Хэрвээ чи эцсийн өдрүүдийн Христийн өгсөн амийн замыг эрж хайхгүй бол хэзээ ч Есүсийн сайшаалыг олж, тэнгэрийн хаанчлалын үүдээр орох шаардлагыг хангаж чадахгүй. Учир нь чи бол түүхийн хоригдол агаад утсан хүүхэлдэй юм. Дүрэм журам, бичиг үсэгт захирагдаж, түүхэнд дөнгөлүүлсэн хүмүүс хэзээ ч амийг олж авч

---

чадахгүй, мөнх амийн замыг ч бас хэзээ ч олж авч чадахгүй. Яагаад гэвэл, тэдэнд байгаа бүхэн бол сэнтийгээс урсах амийн ус биш, харин ердөө л хэдэн мянган жилийн турш тогтонги байсан булингартай ус юм... Бурханы ажлын алхмууд нь долгилох давлагаа, нүргэлэх аянга мэт далайцтай, хүчирхэг—гэтэл чи мунхаглалдаа хөтлөгдөж, юу ч хийлгүй зүгээр суугаад сүйрлээ хүлээж байна. Ийм байж чи яаж Хурганы мөрийг дагадаг нэгэн гэж тооцогдох юм бэ? Чи өөрийнхөө зууралддаг тэр Бурханыг үргэлж шинэ, хэзээ ч хуучирдаггүй Бурхан гэж яаж батлах вэ? Мөн шарласан номуудын чинь бичиг үсэг яаж чамайг шинэ эринд аваачих вэ? Тэдгээр нь яаж чамайг Бурханы ажлын алхмуудыг хайхад хөтлөх вэ? Мөн яаж чамайг тэнгэр лүү аваачих вэ? Чиний гарт буй зүйл бол түр зуурын тайтгарал өгөх бичиг үсэг болохоос амь өгөх чадалтай үнэн биш юм. Чиний уншдаг бичвэрүүд зүгээр л хэл яриаг чинь баяжуулдаг зүйл болохоос төгс байдалд хүргэх зам байх нь байтугай, хүний амьдралыг мэдэхэд туслах мэргэн ухааны үг ч биш юм. Энэ зөрөө чамд ямар нэг юм бодогдуулахгүй байна уу? Энэ чамд доторх нууцуудыг нь ойлгуулахгүй байна гэж үү? Чи өөрөө тэнгэрт хүрч очиж, Бурхантай уулзаж чадах уу? Бурхан ирэхгүй бол чи өөрөө тэнгэрт хүрч очиж, Бурхантай хамт гэр бүлийн аз жаргал эдэлж чадах уу? Чи одоо ч мөрөөдсөөр л байна уу? Тэгвэл Би чамайг мөрөөдөхөө больж, одоо хэн ажиллаж байгааг, эцсийн өдрүүдэд хүмүүсийг аврах ажлыг хэн явуулж байгааг хар гэж зөвлөж байна. Эс бөгөөс чи хэзээ ч үнэнийг олж авч чадахгүй, мөн хэзээ ч амийг олж авч чадахгүй” (“Үг нь махбодоор илэрсэн” ном). Төгс Хүчит Бурханы үгийн энэ хэсэг урьдын итгэлийг минь санагдууллаа. Би шашны үзэл, Библийн үгтэй зууралддаг байсан болохоор Бурханы эцсийн өдрүүдийн авралыг алдах шахсан. Бурхан гайхамшигт арга зам ашигласан болохоор надад Бурханы дуу хоолойг сонсож, Эзэнийг эргэн ирэхэд нь угтах аз завшаан тохиосон юм.

Хоёр жилийн өмнө, нэг өглөө би маш эртлэн босоод, дэрнийхээ хажууд Библийг нээлээ. Тэгээд Эзэн Есүс фарисайчуудыг зэмлэж байгаа талаар уншсан: “Есүс Бурханы сүмд орж, худалдаачид болон худалдан авагчдыг бүгдийг нь хөөн гаргаж, мөнгө солигчдын ширээ болон тагтаа худалдагсдын сандлыг хөмрөөд тэдэнд: **“Миний гэр залбирлын гэр гэж нэрлэгдэх болно гэж бичигдсэн байдаг; гэхдээ та нар үүнийг дээрэмчдийн үүр болгочхож’ гэлээ”** (Матай 21:12–13). Тухайн үед би жаахан гуниглаж, чуулганы өнөөгийн байдал Хуулийн эрин үеийн төгсгөл дэх сүмийнхээс ямар ч ялгаагүй санагдаж байсан. Чуулган дахь пастор, ахлагчид итгэгчдийг бие биеэ хайрлах ёстой гэж үргэлж хэлдэг мөртөө өөрсдөө байнга атаач хэрүүл хийж, тахлаас болж маргадаг байлаа. Тэр ч бүү хэл итгэгчдийн төлөө залбирахдаа хахууль авч, заримдаа авсан мөнгөнийхөө хэмжээнд үндэслэн хэр удаан залбирахаа шийддэг байсан. Чуулганы ихэнх гишүүн сөрөг,

---

сул дорой болж, цуглаанд ирэх хүмүүс өдөр ирэх тусам цөөрч байсан юм. Пастор, ахлагчид номлолдоо сэтгэл гаргахгүй, бас Эзэний хонин сүргийг яаж сайн хариулах вэ гэж эрж хайдаггүй атлаа итгэгчдийн гэрлэлтийг баталгаажуулахаас хэзээ ч залхдаггүй байсан. Чуулган шүтэн мөргөлийн газар байх ёстой ч хуримын ордон болсон байсан. “Пастор, ахлагчид Эзэний замаас гажжээ. Сүм тэр чигтээ шашных бус мэт санагдаж байна. Хуулийн эрин үеийн төгсгөлд сүм эзгүйрч, хулгайчдын үүр болсонтой яг адил байна. Эзэн эргэн ирэхдээ иймэрхүү чуулганд илрэх үү?” гэж надад өөрийн эрхгүй бодогдсон.

Яг ингэж бодож байтал утасны дохио гэнэт дуугарлаа, үүнийг унтрааж байхдаа, Төгс Хүчит Бурханы Чуулганы видеог Юүтүб дээр санал болгож байгааг анзаарсан юм. Тэгээд үнэхээр гайхсан. Тэр чуулганы сувагт огт бүртгүүлээгүй байтал яахаараа надад ийм мэдэгдэл ирдэг билээ? Тэгээд, нэг сарын өмнө найз маань намайг номлол сонсохоор тэнд аваачсан, бас сонссон зүйл минь үнэхээр шинэ соргог, гэгээрэлтэй байсныг санасан юм. Үүнээс би үнэхээр юм олж авсан шүү. Тэгээд цааш нь судалмаар байсан ч тэд Эзэн Есүсийг аль эрт эргэж ирсэн, эцсийн өдрүүд дэх шүүлтийн ажлыг хийж, маш олон үнэнийг илэрхийлж байгаа, бас “Үг нь махбодоор илэрсэн” гэх ном Төгс Хүчит Бурханы илэрхийлсэн үгээр дүүрэн байдаг гэж гэрчилсэн юм. Цуглаан дээр тэд бүгд Төгс Хүчит Бурханы үгийг уншиж, нөхөрлөдөг гэсэн. Би үүний учрыг олохгүй байлаа. Бурханы бүх үг, ажил Библид байдаг, Библийн гадна Бурханы үг, ажил байдаггүй гэж пастор, ахлагчид бидэнд байнга хэлдэг шүү дээ. Эзэн шинэ үг айлдсан гэж тэд яаж гэрчилж чадаж байна аа? Ямартай ч, үе үеийн итгэгчид Библид үндэслэн итгэж ирсэн болохоор Эзэнд итгэнэ гэдэг Библид итгэх явдал. Өөрөөр Эзэнд итгэж яаж болох юм бэ? Найз маань, тэр чуулган руу очоод, илүү их номлол сонсьё гэж надаас гуйх болгонд би татгалздаг байсан. Тийм болохоор утсан дээрээ Төгс Хүчит Бурханы Чуулганы тэр холбоосыг харчхаад дээр нь дараагүй юм.

Гэхдээ гайхмаар нь, үүнээс хойш хэд хоногийн турш тэр чуулганы сувгийн кино, магтан дууг Юүтүб санал болгосоор байлаа. “Эдний сувагт бүртгүүлээгүй ч гэсэн ийм мэдэгдэл ирээд л байх юм. Эзэн намайг замчилж байгаа юм болов уу? Төгс Хүчит Бурханы Чуулганы сувгийг үз гэж Эзэн хүсэж байгаа юм гэж үү?” гэж бодогдлоо. Ингэж бодоод, “Өө, Эзэн минь! Яагаад утсан дээр эдгээр видео гарч ирээд байгаа юм бэ? Тэд Таныг аль эрт эргэн ирсэн гэж гэрчилдэг. Энэ үнэхээр үнэн гэж үү? Би эдгээр видеог үзэх ёстой юу? Эзэн минь, намайг замчлаач дээ” гэж Эзэнд залбирсан юм. Залбирсны дараа Эзэний ийм үг санаанд орсон: **“Сүнсээрээ ядуу хүмүүс ерөөлтэй ез: учир нь тэнгэрийн хаанчлал бол тэднийх юм”** (Матай 5:3). Эзэн ирнэ гэдэг чухал асуудал болохоор энэ талаар сонсох үедээ даруухнаар эрж хайж, судалж, нухацтай бодож, Төгс Хүчит Бурхан үнэхээр эргэн ирсэн Эзэн Есүс мөн эсэхийг харах хэрэгтэй гэж бодсон. Хэрвээ эрж хайж,

---

судлахгүй байж байтал Эзэн үнэхээр эргээд ирсэн байвал би Эзэнийг ирэхэд нь угтан авах боломжоо алдах биш үү? Ингэж бодоод, чуулганы зарим видеог үзэх хэрэгтэй гэж шийдлээ. Тэдний вэбсайт руу ороод, кино, магтан дууны видео, тусгай найрал дуу, туршлага, гэрчлэлийн нийтлэл гэх зэрэг маш олон янзын агуулга байгааг харсан. “Хайрт минь, намайг хүлээгээч” гэх нэг магтан дууны видеон дахь дууны үгэнд сэтгэл минь маш их хөдөлсөн юм. Эзгүй чуулганд байж, Ариун Сүнсний ажилтай чуулганыг хаа сайгүй хайж байсан тэр бүх хугацааг минь бодогдуулсан. Тэр вэбсайтыг унших тусам би улам их тэжээл олж авлаа. Тэгээд тэр чуулганыг ойлгож, судалмаар байсан болохоор вэбсайт дээрээс нь илүү олон кино олж үзсэн.

Нэг өдөр, Бурхан, Библи хоёрын харилцааны талаар голлон өгүүлсэн сайн мэдээний нэг кино үзсэн юм. Тэнд гарсан Бурханы үгийн нэг хэсгийг би хэзээ ч мартахгүй: **“Библи байсан үеэс эхлээд Эзэнд итгэх хүмүүсийн итгэл нь Библид итгэх итгэл байсаар ирсэн. Хүмүүс Эзэнд итгэдэг гэж хэлэхийн оронд тэд Библид итгэдэг гэж хэлсэн нь дээр; тэд Библийг уншиж эхэлсэн гэж хэлэхийн оронд тэд Библид итгэж эхэлсэн гэж хэлсэн нь дээр; тэд Эзэний өмнө эргэн очсон гэж хэлэхийн оронд Библийн өмнө эргэн очсон гэж хэлсэн нь дээр. Ийм маягаар хүмүүс Библийг Бурхан мэт, мөн өөрсдийнх нь амийн эх булаг шиг шүтсэн ба үүнийг алдах нь амиа алдахтай адил байв. Хүмүүс Библийг Бурхантай адил өндөр дээд гэж үздэг ба Бурханаас дээгүүрт үздэг хүмүүс ч бий. Хүмүүс Ариун Сүнсний ажилгүй бол, Бурханыг мэдэрч чаддаггүй бол амьдарсаар байж чадах боловч Библийг алдах юм уу Библийн алдартай бүлэг болон үгийг алдмагцаа амиа алдсантай адил болдог... Ихэнх хүмүүс Бурханд яагаад итгэх ёстойгоо, эсвэл Бурханд хэрхэн итгэх ёстойгоо ч ер ойлгодоггүй бөгөөд Библийн бүлгүүдийг тайлж унших сэтгүүрийг сохроор хайхаас өөрийг хийдэггүй. Хүмүүс Ариун Сүнсний ажлын чиглэлийг хэзээ ч эрэлхийлж байгаагүй; бүр анхнаасаа л тэд Библийг цөхрөнгөө баран судалж, шинжилсэн ба Библийн гаднах Ариун Сүнсний илүү шинэлэг ажлыг хэн ч, хэзээ ч олоогүй. Хэн ч, хэзээ ч Библиэс холдоогүй, хэзээ ч тэгж зүрхлээгүй”** (“Үг нь махбодоор илэрсэн” ном). Энэ хэсгийг үзсэний дараа, “Би Библид яг ингэж ханддаг шүү дээ. Библи Эзэнийг төлөөлдөг юм шиг санаж, Эзэнд итгэнэ гэдэг Библид итгэх явдал, тэр хоёр салшгүй гэж боддог. Гэхдээ би нэг юм ойлгосонгүй: Библи бол Эзэний гэрчлэл, бас итгэлийн маань үндэс суурь. Христэд итгэгчийн хувиар бид, хоёр мянган жилийн турш Библид үндэслэн итгэсэн, тэгэхээр энэ үнэхээр Эзэний хүсэлтэй нийцдэггүй юм гэж үү? Үнэндээ яг юу болоод байна аа?” гэж бодогдлоо.

Эдгээр асуултын хариуг олох гэж тэр киног цааш үзсэн юм. Сайн мэдээ түгээж байсан дүр Бурханы үгийн өөр нэг хэсгийг уншсан: **“Тэд ердөө Библийн хүрээнд л Миний оршин тогтнолд итгэдэг, тэд Намайг Библитэй адилтгадаг; Библи байхгүй**

---

бол Би гэж үгүй, Би байхгүй бол Библи гэж үгүй. Тэд Миний оршин тогтнол болон үйлдэлд ямар ч анхаарал хандуулдаггүй, харин оронд нь Бичвэрийн үг нэг бүрд туйлын онцгой анхаарал хандуулдаг бөгөөд Бичвэрт зөгнөөгүй л бол Намайг хийхийг хүссэн зүйлээ огт хийх ёсгүй гэж олонх нь итгэдэг. Тэд Бичвэрт хэтэрхий их ач холбогдол өгдөг. Тэд үг үсгийг хэтэрхий чухалчилж, эцэстээ бүр хэлсэн үг бүрийг минь дэнсэлж, Намайг яллахад Библийн эшлэлүүдийг ашигладаг гэж хэлж болно. Тэдний эрж хайдаг зүйл нь Надтай нийцэлтэй байх зам юм уу үнэнтэй нийцэлтэй байх зам бус, харин Библийн үгтэй нийцэлтэй байх зам бөгөөд Библитэй нийцэхгүй л бол бүгдийг нь, огт ялгалгүйгээр Миний ажил биш гэж тэд итгэдэг. Ийм хүмүүс фарисайчуудын ачлалт үр удам биш гэж үү? Иудейн фарисайчууд Есүсийг яллахын тулд Мосегийн хуулийг ашигласан. Тэр үед тэд Есүстэй нийцэлтэй байхыг эрж хайгаагүй, харин хуулийг үг үсэггүй хичээнгүйлэн дагаж, бүр Есүст Хуучин Гэрээний хуулийг дагаагүй, мөн Мессиа биш хэмээн ял оноогоод, эцэст нь гэм зэмгүй Есүсийг загалмайд цовдолсон. Тэд ямар мөн чанартай байсан бэ? Тэд үнэнтэй нийцэлтэй байх замыг хайгаагүй юм биш үү? Тэд Миний хүсэл болон Миний ажлын үе шат, арга барилын аль алиныг нь хайхардаггүй байсан мөртөө Бичвэрийн үг нэг бүрээр хэнээрхдэг байсан. Тэд үнэнийг эрж хайдаг биш, харин үгтэй салахгүй зууралддаг хүмүүс байсан; тэд Бурханд итгэдэг биш, харин Библид итгэдэг хүмүүс байсан юм. Үнэн хэрэгтээ тэд Библийн хоточ нохой байсан” (“Үг нь махбодоор илэрсэн” ном). Төгс Хүчит Бурханы эдгээр үгийг уншчихаад, тэд үргэлжлүүлэн нөхөрлөсөн. Тэгээд Эзэнд итгэх нь Библид итгэх явдал, тэгэхгүй бол Эзэнд итгэх итгэл биш гэж итгэгчид бүгд боддог, гэхдээ ингэж бодох буруу гэлээ. Бас, “Эзэн Есүсийг номлож, ажиллаж байхад дагалдагчид нь Судраас гажиж, Эзэний ажил, үгийг хүлээн зөвшөөрсөн, тэгвэл тэд үнэндээ Эзэнд итгэгчид байгаагүй гэж хэлж болох уу? Иудейн шашны фарисайчууд бүгд Судартай зууралдсан боловч үнэнийг илэрхийлж, золин авралын ажил хийсэн Эзэн Есүсийг цовдолсон. Энд ямар асуудал байсан бэ? Судартай зууралдаж байгаа хүн Эзэнийг мэддэг гэсэн үг үү? Эзэний замыг дагаж, Эзэнийг хүндэтгэж, Эзэнд захирагддаг гэсэн үг үү? Бурхан бол бүтээлийн Эзэн, бүх зүйлийн амийн эх сурвалж, гэтэл Библи зүгээр л Бурханы өнгөрсөн ажил, үгийн тэмдэглэл шүү дээ. Үүнийг яаж Бурхантай эн зэрэгцүүлж болох юм бэ? Эзэнд итгэгчид Библид сохроор итгэж, үүнийг шүтэж, Бурхантай эн тэнцүү мэтээр хандаж, тэр ч бүү хэл, Эзэн болон Эзэний ажлыг Библиэр орлуулдаг. Ингэх нь Эзэнийг дорд үзэж, доромжилж байгаа хэрэг биш үү? Эзэний илрэлт, ажлыг эрж хайлгүй Библитэй зууралддаг хүн итгэгч, Эзэний дагалдагч үнэхээр мөн үү? Эзэн Есүс фарисайчуудад ингэж хэлсэн: ‘Бичвэрүүдийг хай. Та нар тэдгээрт мөнхийн амь чинь бий гэж боддог: Мөн тэдгээр нь Намайг гэрчилдэг юм. Түүнчлэн амьтай болгож чадах Над дээр та нар ирдэггүй’ (Иохан 5:39–40). Тэр бас ингэж хэлсэн: ‘Би бол зам,

---

**үнэн, амь юм. Надаар дамжилгүйгээр хэн ч Эцэгт хүрэхгүй’** (Иохан 14:6). Бурхан, Судар хоёрын харилцааны тухайд Эзэн Есүс тов тодорхой хэлсэн. Судар зүгээр л Бурханыг гэрчилдэг болохоос Эзэнийг төлөөлдөггүй, бас авралын ажлыг нь орлож чаддаггүй. Бид Библийг л баримталлаа гээд мөнх амь хүртэж чадахгүй. Христ л зам, үнэн, амь юм. Бид амь олж авахын тулд Эзэнийг эрж хайх ёстой!” гэсэн.

Тэр киног дуусгаад, сэтгэл маш их хөдөлсөн шүү. Тэнд хэлсэн бүх зүйл зөв зүйтэй, Эзэн Есүсийн үгэнд нийцтэй санагдсан. Библи үнэхээр Эзэнийг төлөөлдөггүй гэдгийг би ухаарсан юм. Библи биш, Эзэн л биднийг амиар хангадаг Нэгэн шүү дээ. Библид итгэнэ гэдэг Эзэнд итгэж, Эзэнийг дагаж байгаатай адилгүй! Гэтэл би Библи Эзэнийг үнэхээр төлөөлдөг гэж үргэлж боддог байж. Тэгээд Библийг Эзэнээс дээгүүрт тавьж байсан биш үү? Энэ талаар бодох тусам, Төгс Хүчит Бурханы үгэнд үнэн байна, бас төөрөгдлийг минь шийдэж чадна гэж санагдсан. Эзэнийг угтан авах боломжоо алдахгүйн тулд би нухацтай эрж хайж, судлах ёстойгоо мэдэж байсан юм. Тэгээд Төгс Хүчит Бурханы Чуулган руу найзтайгаа цуг явахаар шийдлээ. Чуулганд очиход ах эгч нар бүгд халуун дулаанаар хүлээж авч, бидэнд үнэхээр тэвчээртэйгээр нөхөрлөсөн. Тэдэнд би төөрөгдлөө ингэж тайлбарласан юм: “Бурханы бүх ажил, үг Библид байгаа, тийм болохоор Библийн гаднах юу ч Бурханы үг, ажлыг агуулах аргагүй гэж цуглаан дээр пастор, ахлагчид бидэнд үргэлж хэлдэг. Гэтэл та нар, Эзэн Есүс Төгс Хүчит Бурхан болж эргэн ирээд, эцсийн өдрүүдэд шинэ ажил хийж, шинэ үг илэрхийлж байгаа гэж гэрчилж байна. Үнэндээ яг юу болоод байна аа?” гэсэн.

Жоу эгч хариуд нь Төгс Хүчит Бурханы үгийн хэдэн хэсгийг уншиж өгсөн юм. “Библийг ойлгож, тайлж чадна гэдэг үнэн замыг олохтой адил гэж олон хүн итгэдэг ч үнэн хэрэгтээ юмс үнэхээр ийм энгийн гэж үү? Библийн бодит байдлыг хэн ч мэдэхгүй: энэ нь Бурханы ажлын түүхэн тэмдэглэл, Бурханы ажлын өмнөх хоёр үе шатны гэрчлэлээс цаашгүй бөгөөд Бурханы ажлын зорилгын талаарх ямар ч ойлголтыг чамд өгдөггүй. Энэ нь, Хуулийн эрин үе болон Нигүүлслийн эрин үе дэх Бурханы ажлын хоёр үе шатыг тэмдэглэсэн гэдгийг Библи уншсан хүн бүр мэднэ. Хуучин Гэрээ нь Израилийн түүх болон бүтээлийн цаг үеэс эхлээд Хуулийн эрин үеийн төгсгөл хүртэлх Еховагийн ажлыг тэмдэглэсэн байдаг. Шинэ Гэрээ нь Дөрвөн Сайн Мэдээнд байдаг газар дээрх Есүсийн ажил, түүнчлэн Паулын ажлыг бичсэн байдаг—эдгээр нь түүхэн тэмдэглэл бус уу?” “Библид тэмдэглэгдсэн зүйлс хязгаарлагдмал; тэдгээр нь Бурханы ажлыг бүхэлд нь төлөөлж чадахгүй. Дөрвөн сайн мэдээ нийлээд зуугаас цөөхөн бүлэгтэй ба тэнд Есүс инжрийн модыг хараасан, Петр Эзэнийг гурван удаа үгүйсгэсэн, Есүс цовдлол болон амиллынхаа дараа шавь нартаа харагдсан, мацаг барих тухай сургаал, залбирлын тухай сургаал, салалтын

---

тухай сургаал, Есүсийн төрөлт ба угийн бичиг, Есүс шавь нараа томилсон тухай гэх мэт хязгаарлагдмал тооны үйл явдлыг бичсэн байдаг. Гэсэн хэдий ч хүн тэдгээрийг эрдэнэс мэт үнэлж, бүр өнөөдрийн ажлыг тэдгээртэй харьцуулан шалгадаг. Тэр ч бүү хэл тэд Есүсийн амьдралдаа хийсэн бүх ажил нь ердөө тийм хэмжээтэй, Бурхан ердөө тийм зүйлийг л хийх чадвартай ба илүү ихийг хийж чадахгүй гэж итгэдэг. Энэ нь утгагүй хэрэг биш гэж үү?” “Тухайн үед Есүс хэрхэн хэрэгжүүлэх, хэрхэн цугларах, залбирлаараа хэрхэн гүйх, бусдад хэрхэн хандах гэх мэт сэдэвтэй хэдэн цуврал сургаалыг л Нигүүлслийн эрин үед шавь нартаа айлдсан. Түүний гүйцэтгэсэн ажил нь Нигүүлслийн эрин үеийн ажил байсан бөгөөд шавь нар нь болон Өөрийг нь дагадаг хүмүүс хэрхэн хэрэгжүүлэх учиртай талаар л Тэр нарийвчлан тайлбарласан. Тэрээр Нигүүлслийн эрин үеийн ажлыг л хийсэн ба эцсийн өдрүүдийн нэг ч ажлыг хийгээгүй юм... Эрин үе бүр дэх Бурханы ажил тодорхой хил хязгаартай байдаг; Тэр тухайн эрин үеийнхээ ажлыг л хийдэг бөгөөд ажлын дараагийн үе шатыг хэзээ ч урьдчилан гүйцэтгэдэггүй. Энэ маягаар л эрин үе болгон дахь Түүний бэлгэдлийн ажил илүү товойн гарч чаддаг. Есүс зөвхөн эцсийн өдрүүдийн тэмдгүүдийн талаар, хэрхэн тэвчээртэй байж, хэрхэн аврагдах тухай, хэрхэн гэмшиж, нүглээ улайх, мөн хэрхэн загалмай үүрч, зовлонг тэвчих талаар л ярьсан; Тэрээр, эцсийн өдрүүдийн хүн хэрхэн орох ёстой, Бурханы хүслийг хангахын тулд хэрхэн эрж хайх ёстой талаар хэзээ ч яриагүй. Ийм байхад Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг Библиэс хайх нь утгагүй биш үү? Зүгээр л Библи тэй зууралдсанаар чи юу харж чадах юм бэ? Библи тайлбарлагч ч бай, номлогч ч бай, өнөөдрийн ажлыг хэн урьдчилан харж чадах юм бэ?” “Хэрвээ чи Хуулийн эрин үеийн ажлыг харж, израильчууд Еховагийн замыг хэрхэн дагасныг харахыг хүсвэл Хуучин Гэрээг унших ёстой; хэрвээ чи Нигүүлслийн эрин үеийн ажлыг ойлгохыг хүсвэл Шинэ Гэрээг унших ёстой. Гэхдээ чи эцсийн өдрүүдийн ажлыг хэрхэн харж байна вэ? Чи өнөөдрийн Бурханы удирдамжийг хүлээн зөвшөөрч, өнөөдрийн ажилд орох ёстой, учир нь энэ бол шинэ ажил бөгөөд хэн ч үүнийг өмнө нь Библид бичээгүй... Өнөөдрийн ажил бол хүний хэзээ ч алхаж байгаагүй зам, хэн ч өмнө нь хараагүй зам билээ. Энэ нь урьд нь хэзээ ч хийгдэж байгаагүй ажил—газар дээрх Бурханы хамгийн сүүлийн үеийн ажил юм... Хэн өнөөгийн ажлыг нэг бүрчлэн, юу ч үлдээлгүйгээр урьдчилан тэмдэглэж чадах билээ? Тогтсон ёсыг зөрчдөг, энэхүү илүү хүчирхэг, илүү ухаалаг ажлыг хэн салбайсан хуучин номд тэмдэглэж чадах вэ? Өнөөдрийн ажил бол түүх биш, иймээс хэрвээ чи өнөөдрийн шинэ замаар алхахыг хүсвэл Библийг орхих ёстой, мөн зөгнөлийн ном, эсвэл Библи дэх түүхийг даван гарах ёстой. Зөвхөн тэр үед л чи шинэ замаар зүй зохистой алхаж чадна, тэр үед л чи шинэ ертөнцөд, шинэ ажилд орж чадна” (“Үг нь махбодоор илэрсэн” ном).

---

Төгс Хүчит Бурханы үгийг уншсанахаа дараа Жоу эгч цааш нь ингэж нөхөрлөсөн. “Хуучин Гэрээ, Шинэ Гэрээ нь ердөө л Хуулийн эрин үе болон Нигүүлслийн эрин үе дэх Бурханы ажлын хоёр үе шатны тэмдэглэл гэдгийг Библи мэддэг хүн болгон мэднэ. Эд бол Бурханы ажлын гэрчлэл шүү дээ. Бурхан ажлын нэг үе шатыг дуусгах болгонд үүнийг нь туулсан хүмүүс Бурханы ажил, үгийг тэмдэглээд, дараа нь эдгээр тэмдэглэлийг Библи болгон эмхэтгэсэн юм. Гэхдээ тэр хоёр эрин үе дэх Бурханы ажил, үг Библид бүрэн тэмдэглэгдээгүй. Библи дэх Эзэн Есүсийн үг зүгээр л өчүүхэн хэсэг нь. Яг л Иоханы сайн мэдээнд хэлдэгчлэн, **‘Түүнчлэн Есүсийн хийсэн өөр олон зүйл байгаа ба хэрэв тэд тэр бүгдийг бичсэн бол тэдний бичсэн номуудыг ертөнц хүртэл өөрөө багтааж чадахгүй байх байсан гэж би боддог’** (Иохан 21: 25). Хуулийн эрин үе дэх зарим эш үзүүлэгчийн зөгнөл Сударт бүрэн тэмдэглэгдээгүй. Үүнийг бүгд л мэднэ. Тэгэхээр Бурханы бүх үг Библид байдаг, Библийн гадна Бурханы ямар ч ажил, үг байхгүй гэж пастор, ахлагчид хэлдэг нь баримтаас зөрж байгаа биш үү? Тэд худал хэлж, хууран мэхэлж байгаа биш үү? Бурхан бол Бүтээлийн Эзэн. Тэр маш агуу, бас элбэг дэлбэг, Библи гэх ганцхан ном Бурханы ажил, үгийг яаж бүрэн хамарч чадах юм бэ?” гэсэн. Дараа нь эгч Илчлэлийн номоос уншиж өгсөн юм: **“Сэнтийн дээр сууж байгаа Түүний баруун гарт, дотор нь болоод ар талд нь бичиж, долоон тамгаар лацадсан ном байгааг би харлаа”** (Илчлэл 5:1). **“Ахлагчдын нэг нь надад ‘Битгий уйл’ гэв: харцгаа, номыг нээж, долоон лацыг задлахын тулд Иудагийн овгийн Арслан буюу Давидын Үндэс ялсан билээ”** (Илчлэл 5:5). “Энэ номын гадна, дотор бичээс байгаа, үүнийг долоон лацаар лацадсан байдаг, эцсийн өдрүүдийн эргэн ирсэн Эзэн л энэ номыг нээж, долоон лацыг тайлж чадна гэж энд хэлсэн байна. Ингэснээр л тэр номд юу бичигдсэнийг бид харж болно. Бас Илчлэлд олон удаа ингэж зөгнөсөн байдаг: **‘Чуулгануудад Сүнс юу айлдаж буйг чихтэй бүхэн сонсогтун’** (Илчлэл 2–3). Эзэн эргэн ирэхдээ илүү их үг айлдана гэдгийг Библийн эдгээр зөгнөл нотолдог. Тэгвэл эргэн ирсэн Эзэний ажил, үг үнэхээр Библид урьдчилан бичигдсэн байж болох уу? Библи дэх Бурханы үг эцсийн өдрүүдэд чуулгануудад хэлдэг Ариун Сүнсний үгийг орлож чадах уу? Хурганы нээсэн номыг орлож чадах уу? Эцсийн өдрүүд дэх Бурханы шүүлтийн ажлыг орлож чадах уу?” гэж эгч нөхөрлөсөн. Үүнийг сонсоод би дотроо, “Эдгээр эшлэлийг нэлээд их уншсан юм байна. Яагаад ер нь энэ асуултууд санаанд ороогүй юм бол оо?” гэж бодсон. Тэгээд эгч цааш нь ингэж нөхөрлөсөн юм: “Библи бол Бурханы өнгөрсөн ажлын тэмдэглэл. Хуучин Гэрээ бий болсноос олон жилийн дараа Эзэн Есүс ирж, Нигүүлслийн эрин үеийн золин авралын ажлыг хийсэн. Тэгвэл Түүний ажил, үг Сударт зүгээр л шууд орчихсон уу? Бурханы ажил, үгийг эмхэтгээд, Библи болгох ёстой болсон шүү дээ. Эцсийн өдрүүдэд Төгс Хүчит Бурхан ирээд хүн төрөлхтнийг ариусгаж, аврах бүх үнэнийг илэрхийллээ. Эдгээр үнэн Библид зүгээр л шууд орчхож чадах уу? Тэгэхээр Бурханы бүх ажил, үг Библид тэмдэглэгдсэн



---

байдаг, Библиэс гадна огт байдаггүй гэж хэлэх нь алдаатай, утгагүй үзэл бодол, бас тэр чигтээ хүний үзэл, төсөөллийн үр дүн” гэлээ.

Жоу эгчийн нөхөрлөлийг сонсоход надад үнэхээр гэгээрэлтэй байсан. Эгчийн нөхөрлөсөн бүх зүйл баримттай нийцэж байх шиг санагдсан юм. Библи бол зүгээр л Хуулийн эрин үе, Нигүүлслийн эрин үе гэх Бурханы ажлын хоёр үе шатны тэмдэглэл. Библи Бурханы ажлын гэрчлэл мөн ч Эзэнийг болон эцсийн өдрүүд дэх Эзэний ажил, үгийг төлөөлж чадахгүй. Эзэн Есүсийн ажил, үг ч Библид бүрэн тэмдэглэгдээгүй байтал эцсийн өдрүүд дэх Бурханы ажил, үгийг Библид урьдчилан тэмдэглэж яаж чадах юм бэ? Би пастор, ахлагчдын үгийг дагаж, Бурханы ажил, үгийг Библид байгаа зүйлээр хязгаарлаж, үүний гаднах юу ч Бурханаас ирээгүй гэдэгт итгэдэг байлаа. Би зүгээр л улайм цайм утгагүй юм ярьж байсан биш үү? Эзэнийг хязгаарлаж, доромжилж байсан биш үү? Ингэж бодоод би их харууссан. Төгс Хүчит Бурханы үгийг эртхэн уншихгүй яав даа? Үнэхээр пастор, ахлагчдыг сохроор дагаж, үзэл төсөөлөлд үндэслэн Бурханы үгийг хязгаарлах ёсгүй байж. Эдгээр үзэл бодол үнэхээр хор хөнөөлтэй юм!

Дараа нь Жоу эгч хэлэлцэх өөр нэг асуудал дэвшүүлсэн: Бурханы эцсийн өдрүүдийн ажил, үгийг хүлээн зөвшөөрөлгүй Библийг л баримталснаар хүмүүс яагаад Бурханы хаанчлалд орж, мөнх амьтай болж чаддаггүй юм бэ? Тэгээд эгч, “Библи зүгээр л Бурханы ажлын хоёр үе шатны тэмдэглэл. Энэ нь эцсийн өдрүүдэд хүн төрөлхтнийг шүүж, ариусгах Бурханы ажлыг орлож чадахгүй. Хуулийн эрин үед газар дээрх хүмүүсийн амьдралыг залж чиглүүлэхээр хууль, тушаал тунхаглах нь Бурханы гол ажил байсан. Нигүүлслийн эрин үед Эзэн Есүс ердөө л золин аврах ажил хийсэн. Хүн төрөлхтнийг Сатаны эзэмшлээс золин аварч, биднийг нүглээс маань золин аварч, Бурханд залбирах эрхтэй болгож, улмаар Бурханы бүх нигүүлслийг эдлэх боломж олгохын тулд Эзэн цовдлогдсон юм. Гэхдээ бидний нүгэлт уг чанар, нүглийн маань уг үндэс шийдвэрлэгдээгүй. Тийм болохоор бид цаг ямагт худал хэлж, нүгэл үйлдэж, Бурханы эсрэг тэрсэлж, Бурханыг эсэргүүцээр байгаа, бас бид Бурханы хаанчлалд орох үнэ цэнгүй. Тийм болохоор Эзэн Есүс хүнийг шүүж, бүрэн аврахын тулд эцсийн өдрүүдэд эргэн ирж, үнэнийг илэрхийлнэ гэж зөгнөсөн шүү дээ. Иоханы сайн мэдээнд ингэж хэлсэн байдаг: **‘Та нарт хэлэх зүйл Надад олон байгаа боловч та нар одоо тэдгээрийг дааж чадахгүй. Гэхдээ үнэний Сүнс болох Тэр ирэх үедээ та нарыг бүх үнэн рүү удирдана’** (Иохан 16:12–13). Бас, **‘Намайг голж, Миний үгийг хүлээж авдаггүй хүнийг шүүх шүүгч байдаг: Миний хэлсэн үгс түүнийг эцсийн өдөр шүүх болно’** (Иохан 12:48) гэж хэлсэн байдаг. Төгс Хүчит Бурхан үнэнийг илэрхийлж, шүүлтийн ажил хийхээр эцсийн өдрүүдэд ирэх нь Эзэн Есүсийн зөгнөлийг бүрэн биелүүлдэг. Төгс Хүчит Бурхан олон сая үг илэрхийлсэн нь бүх юмыг хамардаг. Библийн нууцыг ил болгож, хаанчлалын ирээдүйг

---

зөгнөж, зарим нь хүн төрөлхтний хүрэх газрыг ярьж, бусад нь хүн төрөлхтөн Бурханыг эсэргүүцдэгийн уг үндсийг задлан шинжилдэг. Бүрэн аврагдахын тулд хүмүүст хэрэгтэй үнэнийг ч бас Бурхан маш тодорхой илчилдэг. Үүнд, хүнийг аврах Бурханы ажлын гурван үе шатны дотоод түүх, эцсийн өдрүүд дэх Бурханы шүүлтийн ажлын нууц, Бурхан бие махбодтой болохын нууц багтдаг. Сатан хүн төрөлхтнийг яаж завхруулдаг, Бурхан хүнийг аврахаар яаж ажилладаг, бас хүн төрөлхтнийг Сатан завхруулсны мөн чанар болон үнэн, Бурханыг гэх жинхэнэ итгэл, дуулгавартай байдал, хайр гэж юу болох, утга учиртай амьдралыг яаж амьдран харуулах гэх мэтийг Бурхан илчилдэг. Төгс Хүчит Бурханы илэрхийлсэн үнэн нь эцсийн өдрүүдэд бидэнд өгч байгаа мөнх амийн зам юм. Эцсийн өдрүүд дэх Бурханы шүүлт, ариусгалтыг хүлээн зөвшөөрөлгүй зүгээр л Библийг зууралдвал бид хэзээ ч үнэнийг олж авч, нүглээс ангижирч, бүрэн аврагдаж, тэнгэрийн хаанчлалд орохгүй” гэсэн.

Төгс Хүчит Бурханы Чуулганы ах эгч нарын нөхөрлөлийн тусламжтайгаар би эцсийн өдрүүд дэх Төгс Хүчит Бурханы шүүлтийн ажил Библийн зөгнөлийг бүрэн биелүүлдэг гэдгийг ойлгосон юм. Төгс Хүчит Бурханы үг бол үнэн, Бурханы дуу хоолой, бас эцсийн өдрүүдэд Бурханы бидэнд өгдөг мөн амийн зам юм! Би пастор, ахлагчдын үгэнд орж, шашны үзэл баримталдаг байсан болохоор Бурханы ажил, үг Библиэр хязгаарлагддаг гэж боддог байлаа. Би Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн зөвшөөрч, эрж хайхаас татгалзсан. Тэгээд Бурханы өнөөгийн үгийн хангалтыг олж авч чадалгүй, харанхуйд унажээ. Төгс Хүчит Бурханы Чуулганы видеог Юүтүбээр санал болгож, Бурханы дуу хоолойг сонсох аз завшаан олгосон Бурханы өршөөл, аврал байгаагүй бол би одоо ч пастор, ахлагчдыг дагаж, эцсийн өдрүүд дэх Бурханы ажлыг эрж хайж, судлахгүй байх байлаа. Тэгсэн бол зуун жилийн турш Библийг уншаад ч Эзэнийг эргэж ирэхэд нь хэзээ ч угтан авахгүй байх байсан. Эцсийн өдрүүд дэх Бурханы авралыг олж авч чадсан маань тэр чигтээ Бурханы удирдамжаас үүдэлтэйг би ойлгосон. Энэ бол Бурханы гайхалтай аврал юм!

## **12. Гурвалын оньсого тайлагдлаа**

Жинмо, Малайз

1997 онд надад Эзэн Есүсийн сайн мэдээг хүлээн зөвшөөрөх завшаан тохиосон бөгөөд намайг баптисм хүртэх үед пастор Эцэг, Хүү, Ариун Сүнс хэмээх Гурвалын нэрээр залбирч, надад баптисм хүртээсэн юм. Тэр үеэс хойш би залбирах бүрдээ хайр энэрэлт тэнгэрлэг Эцэг, Аврагч Эзэн Есүс, Ариун Сүнс хэмээх Гурвалын нэрээр залбирдаг боллоо.

---

Гэвч гурав яаж нэг болж болдог юм бол? хэмээх эргэлзээ сэтгэлд минь үргэлж байдаг байв. Гурвал гэж яг юу болохыг би хэзээ ч бүрэн томьёолж, ойлгож чадаагүй юм.

Хоёр жилийн дараа би чуулганыхаа санваартан болсон ба итгэгч болох гэсэн хүмүүсийг шашин судлахад нь дагалдаж байх үед Гурвал гэж юу гэсэн утгатайг хэн нэг нь үргэлж асуудаг байлаа. Нүглээ улайх үеэр ч бас хүмүүс Эцэг, Хүү, Ариун Сүнсний гурвалын талаар байнга асуудаг байв. Энэ нууцыг би ч бас ойлгодоггүй байсан тул тэдэнд огт хариулж чадаагүй бөгөөд үүндээ нэлээд их зовнисон юм. Би энэ асуудлыг тодорхой мэдэж авахыг тун их хүссэн тул баттай хариулт сонсоно гэж найдсандаа пастор, номлогчдоос үүнийг тайлбарлаж өгөөч гэж гуйлаа. Гэвч тэдний хариулт үндсэндээ нэг иймэрхүү байв: “Бурхан бол Эцэг, Хүү, Ариун Сүнснээс бүрддэг Гурвал юм. Эцэг биднийг аврах төлөвлөгөө гаргаж, Хүү нь үүнийг дуусгаж, харин Ариун Сүнс энэ төлөвлөгөөг хэрэгжүүлдэг. Эцэг бол Бурхан, Хүү нь Бурхан, Ариун Сүнс ч бас Бурхан юм—энэ гурван үнэн бие нь хамтдаа нэгэн жинхэнэ Бурханыг бүрдүүлдэг.” Энэ тайлбарт би харин ч улам будилсан бөгөөд “Гурван үнэн биетэй юм бол яаж нэгэн Бурхан байж чаддаг юм бэ?” гэж асуулаа. Тэгэхэд тэд ийн хариулав: “Гурвал бол нууц. Үүнийг хэтэрхий гүн бодоод хэрэггүй. Зүгээр л итгэлдээ найдаж, үүнд итгэхэд л болно.” Хэдийгээр би маш их будилсаар байсан ч үүнийг хүчээр хүлээн зөвшөөрөөд “Энэ талаар дахиад битгий бод. Зүгээр л үүнд итгэ!” гэж бодсон юм. Тэгээд залбирах үедээ хайр энэрэлт тэнгэрлэг Эцэг, Аврагч Эзэн Есүс, Ариун Сүнс гэх Гурвалд залбирсаар л байв. Ингэж залбирснаар л Бурхан залбирлыг минь сонсох мэт санагдан, Бурханы нэг үнэн биед л залбирах юм бол намайг сонсохгүй байх вий гэж айдаг байлаа. Ийнхүү би олон жилийн турш өөрийн төсөөлөл дэх Гурвалд итгэн, ийм төөрөгдөл дунд явсаар байсан юм. Үүний дараа, Гурвал гэж юу гэсэн үг болох тухай чуулганы ах эгч нарыг асуух болгонд би мөн л юу гэж хариулахаа мэддэггүй байв. Тэгээд яах ч аргагүй пасторын хэлсний дагуу хариулдаг байсан ч тэд үнэхээр ойлгохгүй байгааг царайнаас нь харж болохоор байсан юм. Үүнээс болж би арга мухардсан бөгөөд Эзэний өмнө очин залбирахаас өөр яаж ч чадсангүй: “Хүндэт тэнгэрлэг Эцэг минь, Танд талархъя! Гурвалын талаар ах эгч нар болон итгэгч болох гэсэн хүмүүсийг асуухаар би юу гэж хариулахаа мэдэхгүй юм. Надад туслахыг Танаас гуйя. Гурвал гэдгийг ойлгуулж, энэ асуудлын талаар будилдгийг минь болиулахаар Ариун Сүнс намайг замчлах болтугай, тэгээд улам олон хүн Таныг мэдэж авах болтугай.”

2017 оны 5-р сард би Фэйсбүүкээр нэг эгчтэй танилцсан юм. Тэр эгч маш их элэгсэг, тэвчээртэй хүн байсан бөгөөд судрын цөөн хэдэн хэсгийг хуваалцаж, хэлэлцсэний дараа би тэр эгчийн нөхөрлөлд гэрэл байгааг олж мэдлээ. Эгчийн нөхөрлөлөөс би нэлээд их ач тус хүртсэн ба эгчтэй ярилцахыг хүсэж байв. Дараа нь тэр эгч намайг өөр хэдэн ах эгчтэй хамт зарим цуглаан руу аваачсан юм. Эдгээр цуглаан дээр хуваалцсан нөхөрлөлөөс би бие

---

махбодтой болох гэж юу болох, Эзэн ямар арга замаар ирэх гэх мэт урьд нь хэзээ ч ойлгодоггүй байсан зарим үнэнийг ойлгож авлаа. Тэдгээрээс би асар их үр ашиг хүртэж, судрын зарим хэсгийн талаар илүү тодорхой ойлголттой болов. Библийг уншаад миний ойлгож чадаагүй ийм их зүйлийг яаж ойлгож чадсан юм бэ гэж эгчээс асуухад “Миний ойлгодог бүх зүйл Бурханы үгийг уншсанаас үүдэлтэй юм. Бидний Эзэн Есүс аль хэдийн эргэн ирсэн. Эцсийн өдрүүдэд үгээ илэрхийлж, шинэ ажил явуулахаар хүний Хүүгийн дүрээр бие махбодтой болсон...” гэж эгч хариулав. Би энэ мэдээг сонсоод мэл гайхаж, магнай хагартлаа баярлан, “Үнэн гэж үү? Эзэн үнэхээр эргээд ирсэн юм уу?” хэмээн эгчийг асуултаар буллаа. “Тийм ээ, энэ үнэн!” гэж эгч итгэлтэй хариулсан юм. Тэгээд Эзэн эцсийн өдрүүдэд бие махбодтой болох хэлбэрээр эргэн ирсэн боловч Бурханы нэр өөрчлөгдсөн гэдгийг цааш ярих. Бурхан одоо Илчлэлийн номд зөгнөсөн “Төгс Хүчит” болж, Төгс Хүчит Бурхан гэж нэрлэгдэх болсон байлаа. “Төгс Хүчит Бурхан” гэх нэрийг сонсмогцоо сэтгэл минь сэрдхийж, “Төгс Хүчит Бурхан гэнэ ээ? Энэ чинь Зүүний Аянга юм биш үү? Пастор маань Зүүний Аянгаас болгоомжлоорой гэж биднээс гуйн, тэдэнтэй огт холбогдохгүй бай гэж хэлсэн шүү дээ. Тэгээд ч бид Эзэн Есүст итгэдэг байтал Эзэн Есүс эргэн ирээд, Төгс Хүчит Бурхан гэдэг нэртэй болсон гэж энэ эгч хэлж байна, тэгвэл Түүний нэр яахаараа өөр байдаг билээ? Би эцэст нь төөрч орхих гэж үү?” хэмээн дотроо бодсон юм. Гэвч дараа нь ингэж бодогдлоо: “Энэ эгчийг мэддэг болсноос хойш түүний олон нөхөрлөл Библийн дагуу байдгаар зогсохгүй маш их гэрэлтүүлэлттэй, Ариун Сүнсний гэгээрлийг илт агуулдаг гэдгийг би олж мэдсэн. Хэрэв энэ зам буруу юм бол юу гэж Ариун Сүнсний ажилтай байх билээ? Эгчийн үгийг цааш нь сонсох уу, болих уу?”

Зөрчилдөөнтэй мэдрэмжид автан яахаа мэдэхгүй байх яг тэр үед маань эгчийн урьд нь хуваалцсан ийм үг гэнэт санаанд орсон юм: **“Махбод болсон Бурханыг Христ гэдэг, иймээс хүмүүст үнэнийг өгч чаддаг Христийг Бурхан гэдэг. Энэ тухайд ямар ч хэтрүүлсэн зүйл байхгүй”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Эцсийн өдрүүдийн Христ л хүнд мөнх амийн замыг өгч чадна”). Энэхүү хэсэгт Христийг дурдан, Христ хүмүүст үнэнийг өгч чадна гэж хэлсэн байна. Иоханы сайн мэдээний 14-р бүлгийн 6-р эшлэлд Эзэн Есүс: **“Би бол зам, үнэн, амь юм. Надаар дамжилгүйгээр хэн ч Эцэгт хүрэхгүй”** хэмээсэн байдаг. Эзэн Есүс бол махбод болсон Бурхан, Христ бөгөөд **“Би бол зам, үнэн, амь юм”** гэсэн юм. Төгс Хүчит Бурхан, Есүс хоёрын үг хоёулаа Христ болон үнэний талаар дурдсан байна. “Хэрэв Төгс Хүчит Бурхан Христ юм бол үнэнийг илэрхийлж, хүмүүсийн амийг тэжээлээр хангаж чаддаг нь лавтай” гэж би бодов. Тэгээд эгчийн саяхан уншиж өгсөн Төгс Хүчит Бурханы олон үгийн талаар бодлоо. Тэдгээрийг сонсож байхад эрх мэдэл, хүч чадал агуулж байгаа нь мэдрэгдэж, Төгс Хүчит Бурханы үг үнэхээр үнэн бөгөөд Ариун Сүнснээс гарсан гэдэг нь мэдрэгдсэн шүү дээ! Иймээс энэ зам нь үнэн зам

---

байж таарна, харин буруу байх аргагүй гэдгийг би ухаарсан юм. “Иймээс итгэл нь сонсохоос, сонсох нь Христийн үгээр ирдэг” (Ром 10:17) гэж Библид өгүүлсэн байдаг. Хэрэв Төгс Хүчит Бурхан эргэн ирсэн Эзэн Есүс байгаад, би энэ замыг эрж хайж, судалж чадалгүй, зүгээр л пастор, ахлагчдын хэлсэн үгэнд сохроор итгэвэл Эзэний авралыг алдаж, Түүнийг эргэн ирэхэд нь угтан авч чадахгүй байх бус уу? Ингэж бодоод би Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг илүү сайн ойлгохын тулд дахиад хэдэн цуглаанд оролцохоор шийдлээ.

Өөр нэг цуглаан дээр тэр эгч Бурханы үгийн энэ хэсгийг бидэнтэй хуваалцсан юм: **“Өнөөдрийн ажил Нигүүлслийн эрин үеийн ажлыг урагшлуулсан; өөрөөр хэлбэл, бүхий л зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөн дэх ажил урагшилсан. Хэдийгээр Нигүүлслийн эрин үе дууссан ч Бурханы ажилд ахиц гарлаа. Ажлын энэ үе шат нь Нигүүлслийн эрин үе болон Хуулийн эрин үед үндэслэн хийгддэг гэж Би яагаад ахин дахин хэлдэг вэ? Яагаад гэвэл, өнөөдрийн ажил бол Нигүүлслийн эрин үед хийгдсэн ажлын үргэлжлэл бөгөөд Хуулийн эрин үед хийгдсэн зүйлийн ахиц дэвшил юм. Гурван үе шат нь өөр хоорондоо нягт харилцан холбогдсон ба гинжин холбоос нэг бүр нь дараагийнхтайгаа нягт холбогдсон байдаг. Ажлын энэхүү үе шат нь Есүсийн хийсэн дээр тулгуурлан хийгддэг гэж Би бас яагаад хэлдэг вэ? Энэ үе шат Есүсийн хийсэн ажилд тулгуурлан хийгдээгүй гэж үзвэл энэ үе шатанд өөр цовдлол явагдах хэрэгтэй болох байсан бөгөөд өмнөх үе шатны золин аврах ажлыг дахиад эхнээс нь хийх хэрэгтэй болох байв. Энэ нь утгагүй байх байлаа. Иймээс ажил бүрэн дууссан юм биш, харин эрин үе урагшилсан бөгөөд ажлын түвшин өмнөхөөсөө бүр ч илүү өндөрт өргөгдсөн юм. Ажлын энэхүү үе шат Хуулийн эрин үеийн суурин дээр, Есүсийн ажлын суурин дээр хийгдсэн гэж хэлж болно. Бурханы ажил шат шатаар хийгдсэн бөгөөд энэ үе шат нь шинэ эхлэл биш юм. Ажлын гурван үе шатны хослолыг л зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө гэж үзэж болно”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Хоёр удаа бие махбодтой болох нь бие махбодтой болохын ач холбогдлыг гүйцээдэг”). Дараа нь эгч ийнхүү нөхөрлөлөө: “Бурханы ажил хэзээд урагшилдаг, Бурхан хүний хэрэгцээний дагуу өөр өөр эрин үед өөр өөр нэр авч, ялгаатай ажил хийдэг. Гэхдээ Бурхан ямар нэртэйгээр ажлын аль ч үе шатыг гүйцэтгэж байлаа гэсэн мөн чанартаа үргэлж Бурхан Өөрөө л хүн төрөлхтнийг аврах ажлыг явуулж байгаа хэрэг юм. Хуулийн эрин үед Бурхан ажлаа хийхийн тулд Ехова гэх нэрийг авсан бөгөөд газар дээрх хүний амьдралыг залж чиглүүлэхийн тулд хууль, тушаалыг тунхаглаж, хүмүүст нүгэл гэж юу болох, хүмүүс ямар дүрэм журам дагах ёстой, Бурханыг хэрхэн шүтэн мөргөх ёстой гэх зэргийг мэдэх боломж олгосон байдаг. Нигүүлслийн эрин үед Бурхан махбод болж, Есүс гэх нэрийг авсан бөгөөд Хуулийн эрин үеийн ажлын суурин

---

дээр хүн төрөлхтнийг золин аврахын тулд цовдлогдох ажил явуулсны дүнд хүний нүгэл уучлагдсан юм. Одоо Хаанчлалын гэх сүүлийн эрин үед Бурхан хоёр дахь удаагаа махбод болж, Төгс Хүчит Бурхан хэмээх нэрийг авч, золин аврах ажлын суурин дээр хүнийг шүүж, ариусгах ажлаа хийдэг. Үүний дүнд хүний өвөрлөдөг нүгэлт уг чанар, завхарсан зан чанар арилж, хүний нүгэл үйлдэж, Бурханыг эсэргүүцдэг үндсэн шалтгаан бүрмөсөн үгүй болдог. Ажлын үе шат бүр нь өмнөхөөсөө дээгүүр, илүү гүн гүнзгий байснаар ажлын гурван үе шат бие биеэ бүрэн төгс гүйцээдэг. Бурханы ажлын аль ч үе шат дан ганцаараа байж болдоггүй бөгөөд харилцан сүлжилдсэн ажлын гурван үе шат хамтдаа л Бурханы хийдэг хүн төрөлхтнийг аврах бүрэн гүйцэд ажлыг бүрдүүлж, хүн төрөлхтөнд зориулсан Бурханы зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөг бүрдүүлдэг юм. Бурхан гагцхүү эрин үеийг зааглаж, эрин үеийг өөрчлөхийн тулд л Өөрийн нэрийг ашигладаг тул эрин үеийг даган Бурханы нэр ямагт өөрчлөгдөж байгаа нь бидэнд харагддаг. Гэвч Бурханы нэр яаж ч өөрчлөгдлөө гэсэн Бурхан бол нэгэн Бурхан хэвээрээ.” Бурханы үг болон эгчийн нөхөрлөлийг сонсоод би гайхширав. Эзэнд би цаг ямагт итгэдэг байсан ч Бурханы зургаан мянган жилийн удирдлагын ажлыг тайлбарлаж чаддаг хүнтэй хэзээ ч уулзаж үзээгүй юм. Гэтэл Төгс Хүчит Бурханы үг энэ нууцыг тайлжээ—эдгээр үг үнэхээр Бурханы дуу хоолой байлаа! Би итгэлдээ төөрөлдөөгүй байж: Төгс Хүчит Бурхан үнэхээр эргэн ирсэн Эзэн Есүс юм байна. Бурхан зүгээр л нэг эрин үеэс нөгөөд нэрээ сольдог юм байна, тэгээд л тэр. Гэвч Тэр нэгэн Бурхан хэвээрээ.

Үүнийг би дахиад хэд хоногийн турш судалсан юм. Эцсийн өдрүүдэд Бурханы явуулдаг шүүлтийн ажил, Бурханы нэрсийн ач холбогдол гэх зэрэг үнэний талуудын тухай эгч бидэнд нөхөрлөсөн бөгөөд үүнийг сонсох тусмаа би улам тодорхой ойлголттой боллоо. Нэг өдөр эгч: “Бурханы үг Библи дэх бүх нууцыг илчилсэн” гэж хэлсэн бөгөөд үүнийг сонсоод сэтгэл минь тэр дороо цэлмэв; маш олон жилийн турш намайг асар их шаналгасан Гурвалын асуудлын талаар би эгчид хэлсэн юм. Дараа нь эгч надад Бурханы үгийн нэг хэсгийг уншиж өглөө. Төгс Хүчит Бурхан ингэж хэлсэн байдаг: **“Хэрвээ та нарын дундаас хэн нэг нь Гурвал үнэхээр оршдог гэж хэлбэл гурван бодгаль дахь энэ нэг Бурхан яг юу вэ гэдгийг тайлбарла. Ариун Эцэг гэж юу вэ? Хүү нь юу вэ? Ариун Сүнс гэж юу вэ? Ехова Ариун Эцэг үү? Есүс Хүү юу? Тэгвэл Ариун Сүнс юу вэ? Эцэг нь Сүнс биш гэж үү? Хүүгийн мөн чанар ч бас Сүнс биш гэж үү? Есүсийн ажил нь Ариун Сүнсний ажил байгаагүй гэж үү? Тухайн үеийн Еховагийн ажлыг ч гэсэн Есүсийнхтэй адил Сүнс хийгээгүй гэж үү? Бурхан хэдэн Сүнстэй вэ? Чиний тайлбараар бол Эцэг, Хүү, Ариун Сүнс гэсэн гурван бодгаль нь нэг; хэрвээ тийм бол гурван Сүнс байна, гэхдээ гурван Сүнс байна гэдэг нь гурван Бурхан байна гэсэн үг. Тэгвэл цор ганц жинхэнэ Бурхан байхгүй гэсэн үг; ийм төрлийн Бурхан яаж Бурханы**

---

төрөлх мөн чанартай байж чадах юм бэ? Хэрвээ чи цорын ганц Бурхан байдаг гэдгийг хүлээн зөвшөөрвөл Тэр яаж хүүтэй байж, мөн эцэг байж чадах юм бэ? Эдгээр нь бүгдээрээ зүгээр л чиний үзэл биш гэж үү? Цорын ганц Бурхан байдаг, энэ Бурханд цорын ганц үнэн бие байдаг, цорын ганц Бурханы Сүнс байдаг, яг л Библид бичсэнчлэн ‘Цорын ганц Ариун Сүнс, цорын ганц Бурхан байдаг.’ Чиний ярьдаг Эцэг, Хүү оршдог эсэхээс үл хамааран, эцсийн эцэст цорын ганц Бурхан байдаг бөгөөд та нарын итгэдэг Эцэг, Хүү, Ариун Сүнсний мөн чанар бол Ариун Сүнсний мөн чанар юм. Өөрөөр хэлбэл, Бурхан бол Сүнс, гэхдээ Тэр махбод болж, хүмүүсийн дунд амьдарч, түүнчлэн бүх зүйлээс дээгүүр байж чаддаг. Түүний Сүнс бүхнийг-хамардаг бөгөөд хаа сайгүй оршдог. Тэрээр махбодод, орчлон ертөнцөд, орчлон ертөнцийн дээр нэгэн зэрэг оршиж чадна. Бурхан бол цорын ганц жинхэнэ Бурхан гэж бүх хүн хэлдэг тул хэний ч хүслээр хуваагдашгүй ганцхан Бурхан байдаг! Бурхан бол цорын ганц Сүнс, цорын ганц бодгаль; тэр нь Бурханы Сүнс юм” (Үг нь махбодоор илэрсэн номын “Гурвал оршин байдаг уу?”).

Эгч надад ийнхүү нөхөрлөв: “Бурханы үг маш тодорхой байна. Бурхан цор ганц бөгөөд ганцхан л Бурхан бий. Ариун Сүнс ч цорын ганц байдаг. Эцэг, Хүү, Ариун Сүнс нь Сүнсний нэг мөн чанартай. Бурхан Ехова шиг Сүнсэнд ажиллаж чаддагаас гадна Есүс, Төгс Хүчит Бурхан шиг хүний Хүүгийн дүрээр бие махбодтой болон ажиллаж бас чаддаг. Гэхдээ Бурхан Сүнсэнд ажилласан ч бай, махбодод ажилласан ч бай, мөн чанартаа Өөрийн ажлыг явуулж буй Бурханы Сүнс хэвээрээ. Иймээс Гурвал гэх ойлголт нь хүний үзэл, төсөөлөлд хамаардаг бөгөөд ямар ч үндэслэлгүй. Үнэндээ Гурвал гэх ойлголт Эзэнийг мэндэлснээс хойш 300 гаруй жилийн дараа Никаягийн дэлхий дахины зөвлөл дээр үүссэн байдаг. Тэр зөвлөл дээр Христийн шашны ертөнцийн газар бүрээс ирсэн шашны шинжээчид Бурханы нэгдмэл болон олон талт чанарын талаар ширүүн мэтгэлцээн өрнүүлж, эцэст нь өөрсдийн үзэл, төсөөлөл, логик дүгнэлтэд үндэслэн Гурвалын ухагдахууныг бий болгосон юм. Тэр цагаас хойш хүмүүс Ариун Хүү болох Эзэн Есүсээс гадна тэнгэрт Ариун Эцэг байдаг ба Эцэг, Хүү хоёрын аль алиных нь ашигладаг Ариун Сүнс хэмээх хэрэгсэл бас байдаг хэмээн итгэсэндээ тэнгэр газар, бүх зүйлийг бүтээсэн нэгэн жинхэнэ Бурханыг Гурвал гэж тодорхойлох болжээ. Энэ нь ердөө дэндүү утгагүй. Хэрэв бид шашны ертөнцийн тайлбарыг баримталж, Эцэг, Хүү, Ариун Сүнсний Гурвалд итгэх юм бол гурван Сүнс, гурван Бурхан байгаа гэсэн үг болно. Энэ нь цор ганц, нэгэн Бурхан байдаг гэх баримттай зөрчилдөх бус уу? Үнэндээ Гурвал гэж байдаггүй. Энэ бол бүхэлдээ хүний оюун санаанаас урган гарсан тайлбар бөгөөд үзэл, төсөөлөлдөө үндэслэн завхарсан хүн төрөлхтний гаргасан дүгнэлт юм. Бурхан хэзээ ч ийм зүйл хэлээгүй, Бурханы онгод оруулсан ямар ч эш үзүүлэгч, элч хэзээ ч ийм зүйл хэлээгүй бөгөөд

---

Библийн хаана ч ийм зүйл бичигдээгүй байдаг.”

Бурханы үг болон эгчийн нөхөрлөлийг сонсоод сэтгэлд минь зарим эргэлзээ байсаар байсан тул би ийн асуулаа: “Есүс баптисм хүртсэний дараа тэнгэр нээгдэж, Ариун Сүнс тагтаа мэт ирээд Есүс дээр бууж, тэнгэрээс нэгэн дуу хоолой: **‘Энэ бол Миний хайртай Хүү. Би Түүнийг ихэд таалдаг’** (Матай 3:17) гэсэн гэж Библид өгүүлдэг. Бас Эзэн Есүс цовдлогдохынхоо өмнө: **‘Өө Эцэг минь, хэрвээ боломжтой бол энэ аягыг Надаас өнгөрүүлээч: гэхдээ Миний хүслээр биш, харин Таны хүслээр болог’** (Матай 26:39) хэмээн залбирсан. Тэнгэр дэх Бурхан Есүсийг хайрт Хүүгээ гэж дуудсан бөгөөд Есүс залбирахдаа тэнгэр дэх Бурханыг Эцэгээ хэмээн дуудсан гэж сударт өгүүлдэг. Тэгэхээр энд бидэнд Эцэг, Хүү, Ариун Сүнс байна—Бурхан Гурвал гэдэг нь эндээс харагдаж байгаа бус уу? Төгс Хүчит Бурханы үгэнд, Гурвал оршин байдаггүй, энэ бол хүний үзэл, төсөөллөөс цаашгүй гэж яагаад хэлсэн байдаг юм бэ? Энэ бүгд ямар учиртай юм бэ?”

Миний асуултад хариу болгон эгч ийнхүү нөхөрлөв: “Хуучин Гэрээнд Гурвал гэх ойлголт ердөө байдаггүй. Харин Эзэн Есүс ажлаа явуулахын тулд махбод болж, газар дээр ирсний дараа л **‘Эцэг, Хүү’** гэх тайлбар гарсан юм. Филипп Бурханыг мэддэггүй байсан бөгөөд газар дээрх Эзэн Есүсээс гадна тэнгэрт Ариун Эцэг бас бий гэж итгэдэг байсан тул Есүст: **‘Эзэн минь, бидэнд Эцэгээ харуулаач’** гэж хэлсэн хэмээн Иоханы сайн мэдээнд тэмдэглэсэн байдаг. Эзэн Есүс түүний эндүү ташаа үзэл бодлыг залруулж, энэ нууцыг ил болгон, **‘Би та нартай хамт ийм удаан байсан атал чи Намайг танихгүй гэж үү, Филипп ээ? Намайг харсан хүн Эцэгийг харсан; гэтэл ‘Бидэнд Эцэгийг харуулаач’ гэж чи яаж хэлнэ вэ?’** (Иохан 14:9) гэж Филипп хэлсэн юм. Түүнчлэн Тэр бас **‘Би Эцэгийн дотор, Эцэг Миний дотор байгаа’** (Иохан 14:10). **‘Би болон Миний Эцэг нэг юм’** (Иохан 10:30) хэмээсэн байдаг. Эцэг нь Хүү, Хүү нь Эцэг юм; Эцэг Хүү хоёр нэг бөгөөд нэгэн Сүнснийх билээ. Эзэн Есүс ингэж хэлэхдээ Эцэг, Хүү гэдэг нь хоёр биш, нэгэн Бурхан гэдгийг бидэнд хэлж байсан юм.”

Тэгээд эгч надад: “Эцэг, Хүү”-гийн нууцыг илчлэх нь гэх гайхалтай киноны хэсгийг үзүүллээ. Дараа нь бид үргэлжлүүлэн Төгс Хүчит Бурханы үгийн нэг хэсгийг уншив: **“‘Есүс бол Түүний хайртай Хүү гэж Бурхан тов тодорхой хэлээгүй гэж үү?’ хэмээн хэлдэг хүмүүс одоо ч байдаг. Есүс бол Бурханы хайртай Хүү, Түүнийг Тэр ихэд таалдаг гэж Бурхан Өөрөө гарцаагүй хэлсэн. Тэр нь, Бурхан Өөрийгөө гэрчилж байсан хэрэг боловч ердөө өөр өнцгөөс буюу тэнгэр дэх Сүнсний өнцгөөс бие махбодтой болсон Өөртөө гэрчлэл хийж байсан хэрэг юм. Есүс бол Түүний тэнгэр дэх Хүү биш, бие махбодтой болсон Бурхан юм. Чи ойлгов уу? ‘Би Эцэгийн дотор, Эцэг Миний дотор байдаг’ хэмээх Есүсийн үг нь Тэд бол нэг Сүнс гэдгийг илтгэдэггүй гэж**



---

үү? Бие махбодтой болсноос болж Тэд тэнгэр, газрын хооронд тусгаарлагдаагүй гэж үү? Үнэндээ Тэд нэг хэвээр байгаа; ямар ч байсан энэ нь Бурхан зүгээр л Өөрийгөө гэрчилж байгаа хэрэг... Тэр бие махбодтой болсон байсан учраас Түүнийг Бурханы хайртай Хүү гэж дуудсан бөгөөд эндээс Эцэг, Хүүгийн хоорондын харилцаа гарч ирсэн. Энэ нь зүгээр л тэнгэр, газрын хоорондох тусгаарлалтаас болсон юм. Есүс махбодын өнцгөөс залбирсан. Тэр тийм хэвийн хүн чанартай махбод өмссөн байсан учраас махбодын өнцгөөс Тэрээр: ‘Миний гадаад бүрхүүл бүтээгдсэн зүйлийнх. Би энэ дэлхийд ирэхийн тулд махбод өмссөн тул тэнгэрээс холын хол байна’ гэж хэлсэн юм. Энэ шалтгааны улмаас Тэр зөвхөн махбодын өнцгөөс л Эцэг Бурханд залбирч байв. Энэ нь Түүний үүрэг байсан бөгөөд бие махбодтой болсон Бурханы Сүнсний эзэмших ёстой зүйл байлаа. Махбодын өнцгөөс Эцэгт залбирч байснаас нь болоод Түүнийг Бурхан биш гэж хэлж болохгүй. Хэдий Бурханы хайртай Хүү гэж дуудагдаж байсан ч Тэр бол Бурхан Өөрөө хэвээр юм, учир нь Тэр бол бие махбодтой болсон Сүнс бөгөөд Түүний мөн чанар бас л Сүнс юм” (Үг нь махбодоор илэрсэн номын “Турвал оршин байдаг уу?”).

Эгч ингэж хэлсэн юм: “Бурхан эхний удаад Эзэн Есүсийн дүрээр махбод болж, ажлаа явуулахаар ирэх үед хэн ч Бурханыг мэдээгүй, бие махбодтой болох тухай үнэнийг ойлгоогүй, бие махбодтой болох гэж юу болохыг мэдээгүй. Хэрэв Эзэн Есүс Өөрийгөө тэдний шүтэн мөргөдөг Ехова Бурхан мөн гэж шууд хэлсэн бол тухайн үед тэд биеийн хэмжээнээсээ үүдэн үүнийг хүлээн зөвшөөрч чадахгүй байх байсан бөгөөд Эзэн Есүс ажлаа явуулж эхлээ ч үгүй байхдаа хүн төрөлхтөнд яллагдаж, гологдох байсан юм. Тэгвэл хүн төрөлхтнийг золин аврах Бурханы ажил боломжгүй болж, хүн төрөлхтөн хэзээ ч Есүсийг нүглийн тахил болгон олж авахгүй байх байлаа. Хүн төрөлхтнөөр Эзэн Есүсийг хүлээн зөвшөөрүүлж, тэднийг Түүнд итгүүлж, Бурханы авралыг хүртээхийн тулд Есүсийг ажлаа албан ёсоор эхлэхээс өмнө Бурхан, Сүнснийхээ өнцгөөс Өөртөө гэрчлэл хийж, Есүс үнэхээр Бурханаас ирсэн гэдгийг хүмүүст харуулахын тулд махбод дахь Өөрийгөө Хүүгээ гэж дуудсан юм; энэ нь Эзэн Есүсийн авралыг хүлээн зөвшөөрөхөд маань тус болсон. Харин Эзэн Есүс залбирч, тэнгэр дэх Бурханыг Эцэгээ гэж дуудсан нь бие махбодтой болсон хүний Хүү махан биеийн өнцгөөс Өөрийнхөө доторх Сүнсийг Эцэг гэж дуудаж байгаа явдал байв. Энэ нь Сүнс болон махбодын ялгаан дээр үндэслэн хийгдсэн болохоос тус тусдаа Эцэг, Хүү байдаг гэсэн үг биш байсан юм. Үнэн хэрэгтээ Бурхан бие махбодтой болох хугацаанд л Эцэг, Хүү гэх тайлбар зохимжтой байсан. Газар дээрх Бурханы ажил дуусгавар болж, өөрөөр хэлбэл, Эзэн Есүс золин авралын ажлыг дуусгаж, дахин амилаад тэнгэр өөд гарах үед Эцэг, Хүү гэх тайлбар ямар ч хэрэггүй болсон байв. Иймээс бид хүн төрөлхтний үзлээс бий болсон Эцэг, Хүү гэх тайлбарыг ашиглан, үүнийг бүхэлд нь

---

Бурханд хамруулж, Бурханд Эцэг, Хүү гэж байдаг, бас Эцэг Хүү хоёулаа ашигладаг Ариун Сүнс гэх хэрэгсэл байдаг—Бурхан бол Гурвал мөн гэж хэлж болохгүй. Ийм зүйл хэлэх нь Бурханы үгтэй нийцдэггүй, мөн баримттай нийцдэггүй. Бид урьд нь үнэнийг ойлгодоггүй байсан тул ийм зүйл хэлэх үед маань Бурхан биднийг яллаагүй. Харин одоо Бурхан энэ үнэн болон нууцыг бүрэн илчилсэн бөгөөд бид үнэнийг хүлээн зөвшөөрч, Бурханы үгийн дагуу Бурханыг мэдэх ёстой. Энэ л зөв зүйтэй ба ингэх нь л Бурханы хүсэлд нийцдэг.”

Эзэн Есүс тэнгэр дэх Бурханыг яагаад Өөрийн Эцэг гэж дуудсаны учрыг би энэ эгчийн нөхөрлөлөөс л ойлгож авсан юм. Яагаад гэвэл, Тэрээр хүний Хүүгийн дүрээр бие махбодтой болоод, хүний өнцгөөс тэнгэрлэг Эцэгт залбирч байжээ. Бурхан Өөрийн хайртай Хүү хэмээн Есүст гэрчлэл хийсэн нь Сүнсний өнцгөөс махбод болсон биедээ гэрчлэл хийж байгаа явдал байв. Нэг нь тэнгэрт, Нөгөө нь газарт байсан ч Тэд мөн чанартаа нэгэн Сүнстэй байсан юм байна. Гагцхүү Бурхан эдгээр зүйлийг өөр өөр өнцгөөс хэлж байсан учраас л “Эцэг, Хүү” гэх тайлбар урган гарчээ. Бурхан бол нэгэн жинхэнэ Бурхан бөгөөд бүхнийг хамардаг, хаа сайгүй байдаг нэгэн Сүнс юм. Тэр тэнгэрт, бас газар дээр байж, махбод болж чаддаг. Энэ бүхнийг ойлгоод бүх зүйл гэнэт тодорхой болж, олон жилийн турш тасралтгүй тээж явсан будилаан тэр дороо үгүй болж, би гэрэлтүүлэлт, чөлөөлөлтийн гайхалтай мэдрэмж авлаа.

Дараа нь тэр эгч надад “Гурвал”-ын судалгаа хэмээх сайн мэдээний гэрчлэлийн кино үзүүлсэн бөгөөд тэндээс би Бурханы энэ үгийг харсан юм: **“Энэ олон жилийн турш Бурханыг та нар ийм маягаар хуваасан, энэ нь үеэс үед илүү нарийн болж хуваагдсаар нэг Бурхан нь гурван Бурхан болж илт хуваагдах хэмжээнд очсон. Одоо хүний хувьд Бурханыг нэг болгон буцаан нийлүүлэх ердөө боломжгүй, учир нь та нар Түүнийг хэтэрхий нарийн хуваасан! Хэтэрхий оройтохоос нь өмнө Миний шуурхай ажил хийгдээгүй бол хэр удаан ийм байдлаар ичгүүр сонжуургүйгээр үргэлжлүүлэх байсныг чинь хэлэхэд хэцүү юм! Бурханыг ийм байдлаар хуваасаар байвал Тэр яаж та нарын Бурхан хэвээр байж чадах юм бэ? Та нар Бурханыг таньж чадна гэж үү? Та нар Түүнийг өвөг дээдсээ гэж таниад, Түүн рүү буцан очиж мөн л чадна гэж үү? Хэрвээ Би арай оройтож ирсэн бол ‘Эцэг, Хүү’ Ехова Есүс хоёрыг Израиль руу буцаан илгээчихээд та нар өөрсдийгөө Бурханы нэг хэсэг гэгцгээх байлаа. Азаар одоо бол эцсийн өдрүүд. Эцэстээ Миний удаан хүлээсэн энэ өдөр ирсэн ба ажлын энэ үе шатыг Өөрийн гараар хэрэгжүүлсний дараа л Би Бурханыг Өөрийг нь хуваадгийг чинь болиулсан. Хэрвээ тэгээгүй бол та нар нөхцөл байдлыг хурцатгаж, тэр ч бүү хэл өөрсдийн дунд байгаа бүх Сатаныг шүтэхээр ширээн дээрээ тавих байлаа. Энэ бол та нарын арга чарга! Бурханыг хуваах та нарын арга барил! Та нар одоо ч ингэсээр л**

---

**байх уу? Би та нараас асууя: Хэдэн Бурхан байдаг вэ? Аль Бурхан нь та нарт аврал авчрах вэ? Та нарын үргэлж залбирдаг Бурхан чинь эхнийх нь үү, хоёр дахь нь уу, эсвэл гурав дахь нь уу? Тэдний алинд нь та нар үргэлж итгэдэг вэ? Эцэгт үү? Хүүд үү? Аль эсвэл Сүнсэнд үү? Чи хэнд нь итгэдгээ Надад хэл. Чи үг хэлэх бүрдээ Бурханд итгэдэг гэж хэлдэг хэдий ч үнэндээ уураг тархиндаа л итгэдэг! Та нарын зүрх сэтгэлд Бурхан ердөө байхгүй! Гэсэн ч та нарын оюун санаанд өдий төдий тийм ‘Гурвалууд’ байдаг! Та нар санал нийлэхгүй байна гэж үү?” (Үг нь махбодоор илэрсэн номын “Гурвал оршин байдаг уу?”).**

Тэр киног дуусгасны дараа би баярласан боловч бас сэтгэл гонсойж, өөрийгөө жаахан зэмлэлээ. Олон жил тээж явсан эргэлзээ минь эцэст нь тайлагдсан тул би баярлаж байсан юм. Бурхан нэг бөгөөд Гурвалын тайлбар гэж ердөө байдаггүй. Нэгэн жинхэнэ Бурханд итгэх нь л Бурханы хүсэлд нийцдэг бөгөөд би урьдынх шигээ Эцэгт нэг хором залбираад, дараагийн хоромд Ариун Сүнс юм уу Хүүд залбирах шаардлагагүй болж, нэлээд их тайвширсан юм. Гэхдээ би Бурханд ийм олон жил итгэсэн атлаа Бурханыг мэдээгүй явсандаа сэтгэл гонсойж, өөрийгөө зэмлэсэн билээ. Би өөрийн үзэл, төсөөллөөр зохиосон, үлгэр домгийн тодорхойгүй Бурханаас өөрцгүй зүйлд итгэж явсан юм. Бодитой Бурханд итгээгүйн зэрэгцээ Бурханыг эсэргүүцэж, хувааж, үнэндээ Бурханыг доромжилж байжээ! Төгс Хүчит Бурхан ирснээр завхарсан хүн төрөлхтний итгэлийн бүхий л утгагүй байдлыг илчилсэн бөгөөд шашны ертөнцийг үргэлж будилуулж ирсэн энэ нууцыг Төгс Хүчит Бурхан л ил болгосон тул Бурханд талархъя. Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс, тэнгэр газар, бүх зүйлийг бүтээсэн Эзэн гэдэг нь эргэлзээгүй. Тэрээр нэгэн жинхэнэ Бурхан мөн юм!

Дараа нь би Төгс Хүчит Бурханы үгийг уншсанаар, Бурханы бүх үг үнэн бөгөөд Бурханы дуу хоолой мөн гэдгийг олж харсан юм. Тэгээд Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг эргэлзэх зүйлгүйгээр хүлээн зөвшөөрөөд, Хурганы мөртэй хөл нийлүүлж эхэлсэн билээ. Одоо би залбирах үедээ гурван Бурханд залбирах шаардлагагүй болсон юм. Харин Төгс Хүчит Бурханы нэрээр л залбирч, ингэснээр маш тайван, амгалан, баяр хөөртэй болдог. Би залбирахдаа Бурханы аль нэг үнэн биед хангалттай залбирахгүй байна, тэгэхээр Бурхан залбирлыг минь сонсохгүй байх вий гэж санаа зовох шаардлагагүй боллоо. Үнэнийг ойлгож, Бурханыг мэдсэнээр бий болдог чөлөөлөлт, эрх чөлөө, баяр хөөр, аз жаргалыг би үнэхээр мэдэрсэн юм. Бурханд талархъя!

### **13. Энэ дуу хоолой хаанаас гардаг вэ?**

---

## Шийнь, Хятад

Би Христэд итгэдэг гэр бүлд төрсөн ба олон хамаатан маань номлогч. Би багаасаа л эцэг эхтэйгээ хамт Эзэнд итгэсэн. Өсөж том болсныхоо дараа би: Хэрвээ итгэгч нөхөртэй болох юм бол нөхөртэйгөө хамт Эзэнд үйлчилнэ гэж Эзэнд залбирсан юм. Намайг гэрлэсний дараа, миний нөхөр үнэхээр Эзэнд итгэх болсон ба үнэн хэрэгтээ бүтэн цагаар өөрийгөө зориулдаг номлогч болов. Нөхрийгөө Эзэний төлөө санаа амар ажиллуулах гэсэндээ, мөн Эзэний өмнө өгсөн амлалтаа биелүүлэг гэсэндээ би санаачилга гарган, гэр бүлээ авч явах хүнд ачааг үүрсэн юм. Хэдийгээр энэ нь бага зэрэг хэцүү, ядармаар байсан боловч Эзэний дэмжлэг надад байсан учир хэдий их зовлон туулсан ч зүрх сэтгэл минь баяр хөөр, амар амгалангаар дүүрэн байв.

1997 оноос хойш, нөхрийн маань номлол урьдынх шигээ гэрэлтэй биш байхыг би олж мэдлээ. Би гэр орны ямар нэгэн ажил хийлгэхээр нөхрөөсөө гуйх үед номлолынхоо ажлаар завгүй байна гэсэн шалтаг байнга хэлэх болов. Гэрийн ажил хийсэн ч гэсэн зүрх сэтгэлээ зориулдаггүй байсан бөгөөд шалихгүй зүйлээс болж үргэлж уурлах боллоо. Хэдийгээр гаднаа би тэвчиж, түүнтэй маргаагүй ч сэтгэл зүрхэндээ нөхрийнхөө энэ зан авирт үнэхээр сэтгэл хангалуун бус байв. Гэр орны хүнд хэцүү ачаа болон сүнсний минь доторх харанхуй байдал намайг зовлон шаналалтай болгож орхилоо. Би бүх хүн унтсаны дараа шөнө дүлээр Эзэний өмнө очиж, залбиран, зүрх сэтгэлээ уудалж, надад илүү их итгэл болон хүч өгөөч гэж гуйхаас өөр яаж ч чадаагүй юм. Үүний зэрэгцээ, Эзэн хурдан эргэн ирж, намайг өрөвдөлтэй амьдралаас минь авраасай гэж би хүсэн эрмэлзэж байв.

2000 оны 4 дүгээр сарын нэгэн өдөр, хувцаснуудаа янзалж байхдаа би нөхрийнхөө цүнхийг олоод, дүүртэл нь юм чихсэн байхыг харлаа. Би сониуч зандаа хөтлөгдөн цахилгааныг нь онгойлгоод дотор нь Библи болон магтан дууны ном, бас гаднаа хавтастай шинэ ном байхыг харав. “Би яахаараа энэ номыг ер харж байгаагүй байдаг билээ? Энэ нь номлолд зориулсан лавлах ном, эсвэл зарим нэг сүнслэг хүний туршлагыг агуулсан ном байж таараа. Би үүнийг унших ёстой, магадгүй би үүнээс хангалт олж авч болох юм” хэмээн дотроо бодов. Сониуч зандаа хөтлөгдөн номыг нээж, “Төгс болгуулах хүмүүс цэвэршүүлэлт туулах ёстой” гэсэн гарчгийг хараад “Яасан шинэлэг гарчиг вэ! Гарчгаас нь үзвэл, цэвэршүүлэлт туулах нь муу зүйл биш! Би одоо дийлж чадахааргүй цэвэршүүлэлт туулж байгаа, иймээс цэвэршүүлэлтийн тухай туршлагыг нь анхааралтай унших хэрэгтэй. Тэгвэл үүн дотроос хэрэгжүүлэлтийн замыг олж чадна” гэж би бодсон юм. Тэгээд уншиж эхлэв: **“Урьд нь хүмүүс амлалтаа өгөхөөр Бурханы өмнө бүгд ирж ‘Өөр хэн ч Бурханыг хайрладаггүй байсан ч гэсэн би Түүнийг хайрлах ёстой’ гэж хэлдэг байсан. Гэвч одоо цэвэршүүлэлт чам дээр ирж, энэ нь чиний үзэлтэй нийцэхгүй болохоор чи**

---

Бурханд итгэх итгэлээ алддаг. Энэ жинхэнэ хайр мөн гэж үү? Иовын үйл хэргийн тухай чи олон удаа уншиж байсан байж тэр талаар мартлаа гэж үү? Жинхэнэ хайр итгэл дотроос л хэлбэрээ олдог... Зовлон зүдүүртэй тулгарах үедээ чи махан биеийн төлөөх зовнилоо хойш тавьж, Бурханы эсрэг гомдол гаргахгүй байж чаддаг байх ёстой. Бурхан Өөрийгөө чамаас нуух үед Түүнийг дагах итгэлтэй байж, урьдын хайраа бөхөөж, сарниулалгүйгээр хадгалж чаддаг байх ёстой. Бурхан юу ч хийсэн чи Түүний хэв загварт захирагдаж, Түүний эсрэг гомдол гаргахаасаа илүү махан биеэ хараахад бэлэн байх ёстой. Чи шалгалттай тулгарах үедээ хэдийгээр гашуун нулимс унагаж, хайртай эд зүйлээсээ хагацах дургүй байсан ч гэсэн Бурханыг сэтгэл хангалуун болгох ёстой. Энэ л жинхэнэ хайр, итгэл билээ. Чиний жинхэнэ биеийн хэмжээ ямар ч байсан гэсэн бэрхшээл зовлонг эдлэх хүсэл болон жинхэнэ итгэлийн аль алиныг нь чи эхлээд эзэмших ёстой бөгөөд махан биеийг хаях хүсэл мөн чамд байх ёстой. Чи Бурханы хүслийг хангахын тулд хувийн бэрхшээл зовлонг тэсэж даван, хувийн ашиг сонирхолдоо хохирол амсахад бэлэн байх хэрэгтэй. Мөн чи зүрх сэтгэлдээ харамслыг мэдэрч чаддаг байх ёстой: Урьд нь чи Бурханыг сэтгэл хангалуун байлгаж чаддаггүй байсан, одоо чи харамсаж чадна. Эдгээрийн аль нь ч чамд дутагдах ёсгүй—ийм зүйлсээр дамжуулан Бурхан чамайг төгс болгоно. Хэрэв чи эдгээр шалгуурыг хангаж чадахгүй бол төгс болгуулж чадахгүй” (“Үг нь махбодоор илэрсэн” ном). Эдгээр үг үнэхээр зүрх сэтгэлийг минь хөдөлгөв. Үүнийг уншингаа би уйлж байлаа—энэ яг миний туулж байгаа зүйл бус уу? Урьд нь би өөрийгөө болон нөхрийгөө Эзэнд зориулахаар шийдсэн байсан. Нөхрийнхөө Эзэний төлөө хийж буй, гэрийн гаднах ажлыг дэмжихийн тулд би хэчнээн шаналгаатай, зүдэргээтэй байсан ч гэр орныхоо ажлыг эрхлэх бүх ачааг үүрэхдээ тун сэтгэл хангалуун байсан юм. Гэвч, одоо гэрт үүссэн хүндрэлүүд болон нөхрийн халамж дутмагаас болоод би нэн хэлмэгдсэн мэт байнгын мэдрэмжтэйгээр амьдарч байв; би цэвэршүүлэлт дунд амьдарч, нэгэн цагт надад байсан хайр, итгэлийг алдсан байлаа. Би Бурханы өмнө гаргасан шийдвэрээ хадгалж чадалгүй, ганцаараа үргэлж нууцхан уйлдаг байв. Тийм асар их, хүнд бэрх шалгалт дунд Иов хэрхэн Бурханд гэрчлэл хийж, Түүнд итгэл алдахгүй байж чадсан тухай би бодлоо. Иов “Ехова өгсөн, Ехова буцаан авчихлаа; Еховагийн нэр алдаршиг” (Иов 1:21) гэж хэлсэн. Би үүнийг яаж мартаж чадав аа? Тэгээд би Эзэний өмнө хийсэн бүхнийхээ талаар гүнээ харамсав. Иов Бурханыг хангалуун байлгаж чадахгүй байхын оронд өөрийн биеэр зовж, ашиг сонирхлоо золиослохыг илүүд үзэх байсан. Би Эзэнд маш олон жил итгэсэн мөртөө Эзэнд итгэх итгэлээ алдсан. Тэгээд цэвэршүүлэлт туулж байхдаа Эзэнд гомдоллосон бөгөөд Эзэнийг гэсэн хайраа жаахан ч болов илэрхийлээгүй! Үүнийг ухаараад би, цаашид урьдных шигээ байхаа болино, мөн Эзэний төлөө хийж байгаа нөхрийнхөө ажлыг дэмжих ёстой бөгөөд миний хувьд багахан бэрхшээл туулах нь зөв гэж

---

нууцхан шийдсэн юм.

Ингэж бодмогц гэнэтхэн сэтгэл санаа минь дээрдлээ. Эдгээр үгийг үнэхээр сайн хэлсэн, үнэхээр миний бодит нөхцөл байдлын голыг нь олсон мэт надад санагдав. Тэдгээр нь надад хэрэгжүүлэлтийн замыг зааж өгсөн ба нэг л мэдэхэд миний дотор итгэл, хүч чадал төрлөө. “Эдгээр үгийг хэн хэлэв? Тэр яаж ийм арвин ойлголттой байж чаддаг билээ? Би олонд танигдсан сүнслэг хүмүүсийн бичсэн номыг уншсан бөгөөд тэр номууд зарим талаар сургамжтай ч энэ ном шиг тодорхой, ойлгомжтой бичигдээгүй, мөн үнэнийг ч агуулдаггүй. Үнэндээ эдгээр үг хэнээс гарсан юм бол?” хэмээн би гайхширлаа. Би энэ номын үгэнд сэтгэл татагдаж, үргэлжлүүлэн уншихыг хүсэв; илүү их унших тусам, эдгээр үг үнэхээр гайхалтай болохыг төдий чинээ их мэдэрч байлаа. Мөр нэг бүр шууд зүрх сэтгэлд хүрч байв. Хүний зовлон хэдий үлэмж байлаа ч, бид эцсээ хүртэл Бурханыг дагаж, зовлонгийн өмнө Бурханд баяртайгаар захирагдах ёстой. Хүн шалгалтын дунд сул дорой болсон ч гэсэн, бат зогсохын тулд Эзэнд итгэж, Бурханд найдах хэрэгтэй гэдгийг эдгээр нь надад ойлгуулсан юм. Унших тусам зүрх сэтгэлдээ гэрэлтүүлэгдсэн мэт, хэрэгжүүлэх замтай болсон мэт улам их санагдав. Нөхрийгөө гэртээ ирэх яг тэр үед би түүнээс “Энэ номыг хаанаас аваа вэ?” хэмээн шууд асуулаа. Нөхөр минь инээмсэглэн, “Би энэ номыг нэг хүнээс зээлсэн юм, удахгүй буцааж өгөх ёстой” гэлээ. Би өөр юу ч хэлсэнгүй.

Нэг өдөр, хоол хийж байхад нөхрийн минь тоглуулж байсан магтан дуу энд тэндээсээ сонсогдож байлаа: **“Дээдлэн хүндлэхгүй хэн байна? Бурхантай уулзах гэж хүсэн хүлээхгүй хэн байна?... Бурхан нэгэн цагт хүнтэй баяр гунигаа хуваалцсан бол өнөөдөр хүн төрөлхтөнтэй дахин уулзаад өнгөрч одсон цаг хугацааны шастирыг хуваалцдаг. Иудагаас явсных нь дараа хүмүүс Түүний ямар ч ул мөрийг олж чадаагүй. Бурхантай дахин нэг уулзах сан гэж хүсэн мөрөөсдөг тэд өнөөдөр Түүнтэй ахин нүүр учирч, дахин уулзсан гэдгээ огт мэддэггүй. Энэ нь өчигдрийг санагдуулахаас өөр яалтай? Хоёр мянган жилийн өмнөх энэ өдөр иудейчүүдийн үр удам болох Ионагийн хүү Симон Аврагч Есүсийг харж, Түүнтэй нэг ширээнд хооллож, Түүнийг олон жил дагасныхаа дараа улам их хайрлах болсон: Тэр Эзэн Есүсийг чин сэтгэлээсээ хайрлан, асар их хайртай байсан билээ. Бурхан өнөөдөр хүн төрөлхтөнтэй дахин уулзаад өнгөрч одсон цаг хугацааны шастирыг хуваалцдаг”** (Хургыг дагаж, шинэ дуу дуулъя номын “Хоёр мянган жилийн хүсэл”). Энэ магтан дууны үгс нь зүрх сэтгэлийн минь гүн дэх бодлыг илэрхийлж, Эзэний эргэн ирэхийг хүсэн хүлээж буй мэдрэмжийг минь өдөөлөө. Би сонсонгоо уйлж, “Анх итгэгч болсноос эхлээд өнөөг хүртэл би Эзэн Есүсийг өдөр бүр бодон, Түүнийг илүү хурдан эргэн ирж, бид хамтдаа урьдын цаг хугацаагаа дурсан санагалзаж чадна гэж найддаг байлаа” гэж бодсон юм. Энэ дууны үг үнэхээр жинхэнэ, сэтгэл хөдөлгөм байсан ба Эзэнийг гэх хүмүүсийн

---

хүсэл эрмэлзлийг бүр ч илүү илэрхийлж чадаж байв. Би тэгээд хоолоо хойш тавин, бүх анхаарлаа төвлөрүүлэн сонслоо. Дараа нь “Бурханы төлөөх үнэнч зүрх сэтгэл” гэх өөр нэгэн магтан дуу явав: **“Бурханыг хайрлах бодол болон чин сэтгэлийн хүслийг минь Бурхан хүлээн зөвшөөрөөсэй гэдгээс өөр юуг ч би амьдралдаа гуйхгүй”** (“Хургыг дагаж шинэ дуу дуулъя”). “Хэн энэ магтан дууг бичив? Түүний шийдвэр яаж ийм агуу байж чадна вэ?” гэж би бодсон юм. Ялангуяа **“Бурханыг хайрлах бодол болон чин сэтгэлийн хүслийг минь Бурхан хүлээн зөвшөөрөөсэй гэдгээс өөр юуг ч би амьдралдаа гуйхгүй”** гэх мөр миний хувьд тун зоригжуулам байв. Бурханыг гэх тийм хайр үнэхээр цэвэр ариун! Урьд нь би итгэхдээ Эзэнийг хайрлахаа мэддэггүй байсан боловч Эзэний нигүүлслийг эдэлж, амар тайван, баяр хөөрийг эрэлхийлэхийг л хүсдэг байжээ. Тэр өдөр уг магтан дуу миний ертөнцийг үзэх үзлийг үнэхээр нээж өгсөн бөгөөд Бурханд итгэдэг хүмүүс Бурханыг хайрлах ёстой, мөн өөрсдийнхөө төлөө ямар нэг зүйлийг эрж хайх ёсгүй—зөвхөн энэ төрлийн хайр л цэвэр ариун байж чадна гэдгийг би харсан билээ. Энэ магтан дууг тун сайн бичсэн байв. Тэгээд, би ч бас энэ зорилгыг эрэлхийлэхийг хүсэж байна, бусад хүмүүс хайрласан ч бай, үгүй ч бай, би Эзэнийг хайрлана гэж нууцхан шийдсэн юм.

Тэр номон дахь үгийг уншиж, тэр магтан дуунуудыг сонссоны дараа би эдгээр үгийн дагуу үйлдэж эхэллээ. Нөхөр минь дахиад ажиллахаар явж, гэр орны ажилд туслах ямар ч цаг завгүй байх үед би өмнөхтэйгээ адил гуниглаагүй билээ. Би Бурханыг сэтгэл хангалуун байлгахыг хүссэн учраас бусад ах, эгч нар хэлсэн зүйлд ямар нэг алдаа байвал тэвчээртэй байж чаддаг байв. Магтан дуунд дүрсэлсэн шиг Бурханыг бүх зүрх сэтгэлээсээ хайрлахыг л би хүссэн юм.

Нүд ирмэх зуур ургацаа тариалах цаг ирлээ. Нэг орой, нөхөр минь цэвэрлэгээ хийж байгаад надад: “Маргааш би өөр хотод байдаг чуулган руу явах хэрэгтэй” гэлээ. Би шуудхан, “Цөөн хэдэн хоногийн дараа ирж чадах уу?” гэв. Нөхөр минь, “Мэдэхгүй байна. Би эртхэн эргэж ирэхийг хичээх учир гэр орны ажилд санаа зоволтгүй” гэлээ. Хэлснийг нь сонсоод царай минь барайж, “Битгий санаа зов л гэх юм, би яаж санаа зовохгүй байж чадах юм бэ? Бусад айл аль хэдийн тариалж дуусчихаад байхад чи хэзээ эргэж ирэхээ ч мэдэхгүй явж байна. Манайх талбайгаа хагалаа ч үгүй байгаа, хэрвээ үрээ оройтож суулгавал намар ургац сайн хураахгүй. Тэгвэл бид яах болж байна аа? Нөхөр минь талбайдаа үр суулгаж дуусгачихаад, ах эгч нарт туслахаар явсан ч болоосой!” гэж бодов. Тэр орой би орондоо хэвтээд, унтаж огт чадахгүй байлаа. Сэтгэл минь ихэд үймрэн: “Түрүүчийн удаа нөхөр минь хагас сар гаруй явж байгаад эргэн ирсэн, гэхдээ тэр үед газар тариалангийн ажил байгаагүй. Харин одоо тариалангийн чухал үе ирчихээд байхад нөхөр минь дахиад хагас сар явчихвал би яах билээ? Магадгүй би ажлыг нь хийх хамтран

---

зүтгэгчийг нөхрөөрөө олуулаад, нөхрөө болиулах ёстой л болох нь” гэж бодов. Гэхдээ би: “Үгүй, тэгж болохгүй, ах эгч нар нөхрийн минь тусламжийг хүлээж байгаа. Хэрвээ нөхөр минь явахгүй бол Эзэний эсрэг зөрчил болох биш үү?” хэмээн дахин нэг бодлоо. Энэхүү цэвэршүүлэлтийн дунд би Эзэний өмнө очин: “Эзэн минь! Би нөхрийгөө явуулж, ах эгч нарт туслуулахыг хүсэхгүй байгаа юм биш, зүгээр л бид одоо талбайдаа тариалах хэрэгтэй байна. Би энэ цэвэршүүлэлтийн үр нөлөөг үнэхээр мэдэрч, яахаа мэдэхгүй байна. Эзэн минь! Би Танаас тусламж гуйж байна, зүрх сэтгэлийг минь хамгаалж, эдгээр зүйлээс болж үймрэхгүй байлгаач” хэмээн залбирлаа. Залбирсны дараа, эдгээр үг санаанд минь маш тод буусан юм: **“Чиний жинхэнэ биеийн хэмжээ ямар ч байсан гэсэн бэрхшээл зовлонг эдлэх хүсэл болон жинхэнэ итгэлийн аль алиныг нь чи эхлээд эзэмших ёстой бөгөөд махан биеийг хаях хүсэл мөн чамд байх ёстой. Чи Бурханы хүслийг хангахын тулд хувийн бэрхшээл зовлонг тэсэж даван, хувийн ашиг сонирхолдоо хохирол амсахад бэлэн байх хэрэгтэй”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Төгс болгуулах хүмүүс цэвэршүүлэлт туулах ёстой”). Эдгээр үг тэр дороо зүрх сэтгэлд минь хүрч, сэтгэл нэлээд цэлмэлээ: “Тийм шүү! Хэрвээ хүн Эзэнийг сэтгэл хангалуун байлгахыг хүсвэл бэрхшээл туулах шийдвэртэй байх хэрэгтэй бөгөөд Бурханы хүсэлд нийцэж байгаа цагт баяртайяа махан биеэрээ зовж, хувийн ашиг сонирхолдоо буулт хэрэгтэй!” гэж би бодлоо. Эдгээр үг надад итгэл өгч, би: “Хэрвээ тариалан жаахан оройтвол оройтно л биз! Ургац хэр их хураахыг Бурхан л мэднэ, харин нөхөр минь Эзэний төлөө ажиллах л хамгийн чухал” гэж бодлоо. Ингэж бодоод, зүрх сэтгэл минь хөнгөрч, чөлөөлөгдөн, нэг мэдэхэд л унтсан байв. Маргааш өглөө нь би нөхөртөө: “Яваад Эзэний төлөө ажилла, юунд ч санаа бүү зов! Хэзээ эргэж ирэх чинь хамаагүй ээ. Би Эзэний зохицуулалтад захирагдана” гэж хэлэв. Миний үйлдэл Эзэнийг сэтгэл хангалуун болгож байна гэж бодоход л би зүрх сэтгэлдээ баяр хөөр, амар тайвныг мэдэрч байлаа.

Нөхөр минь хэд хоногийн дараа буцан ирсэн ба шал өөр хүн шиг санагдав. Гэр орны ажилд надад тусалж, бүр “Чи хэт их ажиллаж байна! Гэрийн доторх, гаднах бүхнийг хийсээр сүүлийн энэ хэдэн жил чамд хэцүү байлаа. Би үүнийг мэдэж байгаа. Өмнө нь би үргэлж ажиллахаар явж, гэр орны ажлын ачааг чамтай хуваалцаж тусалдаггүй байсан. Одоогоос эхлээд завтай байх үедээ би илүү их тусална” гэж хэлсэн юм. Нөхөр минь өмнө нь ингэж ярьж байсан удаагүй учир ингэж хэлэхийг нь сонсоод миний сэтгэл ихэд хөдлөв. Би дотроо: “Нөхөр минь тэр номыг уншсанаас хойш их өөрчлөгдсөнийг би харсан. Номлол нь гэрлээр дүүрээд зогсохгүй, надад хандах хандлага нь ч өмнөхөөсөө өөр байна. Энэ бүх хугацаанд Библийг уншаад нөхөр минь өөрчлөгдөөгүй, харин тэр номыг уншсаны дараа богино хугацаанд маш их өөрчлөгдлөө. Тэр ном үнэхээр хүмүүсийг өөрчлөх хүчтэй юм шиг байна!” гэж бодлоо. Үүний зэрэгцээ, тэр номонд байсан зүйл надад ч бас асар их



---

ач тустай байсныг би мэдэрсэн юм. Үүнийг уншсаны дараа би итгэлтэй, хүчтэй болж, мөн тэр номонд бичсэний дагуу үйлдэх үед нөхөртөө сэтгэл дундуур байсан минь үгүй болсон. Энэ номыг уншсаны дараа нөхрийн минь надад хандах хандлага ч бас өөрчлөгдөж, намайг хэрхэн анхаарч, халамжлахаа ойлгосон юм. Энэ бүх өөрчлөлт, тэр номын агуулга үнэхээр хүчтэй, эрх мэдэлтэй гэх мэдрэмжийг минь гүнзгийрүүллээ. Гэхдээ, энэ номон дахь үгсийг хэн бичсэн юм бэ? гэж би гайхширч байв. Би үүний хариултыг ер олсонгүй.

Хоёр сарын дараа нэгэн өдөр, нөхөр минь цуглаанд оролцохдоо намайг авч явмаар байгаагаа хэлэв. Энэ цуглаан үнэхээр онцгой гэдгийг би мэдэрсэн бөгөөд тийм биш бол нөхөр маань намайг авч явахгүй байсан юм. Би хүлээлтээр дүүрч, нөгөө номыг дахин харахаар хүлээж байлаа. Дараагийн өдөр нь нөхөр бид хоёр, хоёр эгчтэй хамтаар нэг эгчийн гэр лүү явахаар машинд аз жаргалтайгаар сууж байлаа. Цуглаанд олон ах, эгч оролцож байв, тэдний дунд Библийг нөхөрлөлдөө нэгтгэж, эцсийн өдрүүд дэх Бурханы ажлын талаар олон үнэнийг бидэнд нөхөрлөсөн гуч орчим насны эгч байв. Тэр эгчийг сонсох үед зүрх сэтгэл минь үнэхээр цэлмэж, өмнө нь огт ойлгодоггүй байсан Библийн олон эшлэлийн талаар, мөн шүүлтийн ажил хийхээр Бурхан эргэн ирэх талаар тодорхой ойлгож авав. “Эгчийн нөхөрлөл яаж ийм гайхалтай байж, Библийг ийм тодорхой тайлбарлаж чаддаг билээ? Яаж ийм ихийг ойлгодог байна аа?” гэж би дотроо бодлоо. Яг тэр үед эгч нүүр дүүрэн инээмсэглэн, чангаар ингэж хэлэв: “Би ах, эгч та нарт үнэхээр сэтгэл хөдлөм сайхан мэдээ хэлье. Бидний удаан хүсэн эрмэлзсэн Эзэн Есүс шинэ ажлаа хийж, үг айлдаж, бүх үнэн болон нууцыг дэлгэж, Бурханы ажлын гурван үе шат, Өөрийн зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө, түүнчлэн Бурхан бие махбодтой болох тухай болон Библийн нууцуудыг ил болгохоор бидний дунд бие махбодтой болж эргэн ирсэн. Өнөөдөр, миний нөхөрлөсөн бүхэн Бурханы айлдсан үгээс гарсан юм.” Тэнд байсан ах, эгч бид нар энэ агуу мэдээг сонсоод, энэ бүгдийг эргэн ирсэн Эзэн хүн төрөлхтөнтэй хуваалцсан болохоор энэ эгч ийм ихийг ойлгосон болохыг эцэст нь ухаарсан юм. Одоо бид нар ч бас Эзэний дуу хоолойг сонсож байлаа. Бид бүгд аз жаргалтайгаар өөр хоорондоо тэврэлдэн, баярын нулимс унагаж, тэр газар бүхэлдээ баяр хөөрөөр бялхаж эхэлсэн билээ. Би үнэхээр аз жаргалтай байсан болохоор баярласандаа үсэрмээр санагдаж, “Би Эзэн Есүсийг удахгүй эргэн ирнэ гэж үргэлж найддаг байсан. Одоо Эзэн үнэхээр эргэн иржээ! Амьдрах хугацаандаа Эзэн Есүсийн эргэн ирэлтийг угтаж чадсан болохоор би үнэхээр ерөөгджээ!” хэмээн бодлоо.

Удалгүй цуглаан тарах болоход эгч хүн нэг бүрд “Шүүлт Бурханы гэрээс эхэлдэг” гэх номыг өгөв. Бурханы үгийн номыг хоёр гартаа болгоомжтой барьж байхад өмнө нь уншсан ном гэнэт санаанд орлоо. Нөгөө ном чинь энэ юм биш биз дээ? Гэртээ харьсныхаа дараа би: “Тэр өдөр миний харсан ном, өнөөдөр эгчийн өгсөн Бурханы үгийн ном мөн

---

үү?” хэмээн тэвчээр алдан нөхрөөсөө асуулаа. Нөхөр минь инээмсэглэн, “Мөн” гэв. Тэр үед надад дөнгөж зүүднээсээ сэрж буй мэт санагдаж байв. Эцсийн эцэст тэр дуу хоолой Бурханаас гарчээ—тэр нь эргэн ирсэн Эзэн Есүсийн дуу хоолой, Бурханы дуу хоолой юм! Тэдгээр үг миний сэтгэлийг хөдөлгөж, надад итгэл, хүч чадал өгч, намайг өөрчилж, зовлонгоос минь салгаж чадсанд гайхах зүйл алга. Тэгээд би: “Чи Бурханы шинэ ажлыг хүлээн авчихаад яагаад надаас нуусан юм бэ?” хэмээн нөхрийгөө зэмлэлээ. Нөхөр минь: “Тухайн үед би чамд хэлэхийг үнэхээр хүссэн ч танай гэр бүлийн ихэнх хүмүүс шашны хүрээний номлогчид бөгөөд эцсийн өдрүүд дэх Бурханы ажлыг эсэргүүцэж, ялладаг. Энэ бүх хугацаанд тэд үнэн замыг судлах замд маань хөндөлссөөр ирсэн. Хэрвээ би хангалттай тодорхой тайлбарлаж чадалгүй, хамаатнууд чинь энэ талаар олж мэдээд чамайг үймүүлж, чамд саад болохоор гэнэт гарч ирвэл аврал хүртэх боломжийг чинь сүйтгээд зогсохгүй, намайг ч бас муу хүн болгоно гэж би айсан! Иймээс би энэ талаар судалж, тодорхой мэдсэнийхээ дараа чамд хэлэхээр шийдсэн юм” гэлээ. Энэ тайлбарыг сонсоод нөхрийнхөө талаарх миний буруу ойлголт алга болсон ба намайг аварсанд нь Бурханд бүр ч их талархсан юм. Би Бурханы үгийн энэ номыг анхааралтай уншихаар сэтгэл шулуудлаа.

Төгс Хүчит Бурханы үгийг унших нь хатсан сүнсэнд минь хоол тэжээл, хангалт авчирлаа. Эргэж ирсэн Эзэний үгийг хоёр чихээрээ сонсож, Бурханы өмнө өргөгдөж, Бурхантай нүүр нүүрээ харан уулзаж чадна гэж би хэзээ ч бодоогүй юм. Тэгээд хайр болон авралынх нь төлөө Бурханд тун их талархаж байлаа. Арав гаруй хоногийн дараа нөхөр, бид хоёр сайн мэдээ түгээдэг эгч нартай хамт, Эзэнд үнэхээр итгэдэг чуулганыхаа ах, эгч нарыг Төгс Хүчит Бурханы өмнө аваачихаар ажилласан билээ.

## **14. Эзэн Зүүн зүгт гарч ирсэн**

Чиу Жэн, Хятад улс

Нэг өдөр, эгч маань над руу залгаж, хойд зүгээс буцаж ирснээ болон надад хэлэх чухал зүйл байгаагаа хэлсэн юм. Тэр надаас даруй хүрч ирэхийг хүслээ. Юу тохиолдсон байж болох тухай мэдрэмж надад төрсөн бөгөөд утсаар ярьсныхаа дараа эгчийнхээ гэрт очив. Ороод, эгч маань ном уншиж байгааг хармагцаа би тайвширлаа. Намайг ирснийг хараад эгч гэнэт босож ирэн: “Дүү минь! Би хойд зүгээс энэ удаа сайн мэдээ олж авлаа: Эзэн Есүс эргэн иржээ!” гэж хэлэв.

Үүнийг сонссоны дараа би сэтгэл түгшин бодлоо: Энэ бүх жилүүдэд Зүүний Аянга Эзэн Есүс эргэж ирснийг үргэлж гэрчилж байсан; эгч маань Зүүний Аянгыг хүлээн зөвшөөрсөн юм гэж үү? Намайг ярихаас өмнө эгч маань нухацтайгаар: “Дүү минь! Эзэн

---

бие махбодтой болж, манай Хятад улсад иржээ” гэв. Би түргэхэн шиг: “Хүмүүс юу гэж ч хэлсэн бүү итгэ. Бурхан Хятадад ирж чадах уу? Библид маш тодорхой ингэж бичсэн байдаг: ‘Тэр өдөр Түүний хөл Иерусалимын урд, зүүн зүгт Чидун уулан дээр гишгэх болно. Чидун уул тэгээд зүүнээс баруун тийш дундуураа хуваагдаж, маш өргөн хөндий үүснэ; уулын нэг тал нь умард зүг рүү, нөгөө тал нь өмнө зүг рүү нүүнэ’ (Зехариа 14:4). Бурхан Израильд ирсэн. Тэр Хятадад ирж чадахгүй. Эзэний төлөө ажилладаг хүний хувьд та үүнийг ч мэддэггүй нь ямар ичгэвтэр хэрэг вэ!” гэж хэлэв.

Эгч чин сэтгэлээсээ, “Дүү минь, би чам шиг л боддог байсан, гэхдээ Төгс Хүчит Бурханы үг болон ах эгч нарын нөхөрлөлөөр дамжуулан Эзэн үнэхээр Хятадад бие махбодтой болсныг би ухаарсан. Чиний ярьсан бичвэр бол зөгнөл, гэхдээ зөгнөлийг бид хүссэнээрээ тайлбарлаж болохгүй. Тэдгээр нь Бурханы ажлын баримтуудаар дамжин биелдэг, тэгснээр хүмүүс харж чаддаг. Эзэнийг ажил гүйцэтгэхээр ирэх үед Петр ч, Самари эмэгтэй ч, Етиопийн тайган ч Библийн зөгнөлүүдийн үгчилсэн утгатай зууралдаагүй, гэтэл Эзэн Есүсийн хэлсэн зүйл болон гүйцэтгэсэн ажлын баримтууд нь Мессиа Эзэн Есүс болж ирсэн гэдгийг баталсан юм. Тэд бүгд Бурханы мөрийг дагаж, Эзэний авралыг хүлээн авсан. Библийн зөгнөлийн үгтэй зууралдсан фарисайчууд бүгд хэдийнэ ирчихсэн байгаа Мессиа буюу Эзэн Есүст энгийн хүн мэт хандаж, Эзэн Есүсийг үгүйсгэж, эсэргүүцэн, ялласан бөгөөд эцэст нь Эзэн Есүсийг цовдолсон. Тиймээс тэд Бурханаар шийтгүүлсэн юм. Дүү минь, бид Эзэний ирэлтийг анхааралтай авч үзэх ёстой. Бид Бурханыг хүндэтгэсэн зүрх сэтгэлтэй байх ёстой. Чи юу ч хийсэн бай, амархан бүү шийд!” гэж хэлэв.

Би эгч рүүгээ зэрвэс хараад Библийг барьж, “Ехова Бурхан Израильд хууль тогтоож, Эзэн Есүс мөн Израильд цовдлогдсон. Хятад бурхангүй намаар удирдуулдаг улс орон байхад яагаад Эзэн ийм оронд ирэх билээ? Бид маш олон жилийн турш Эзэнд итгэсэн, гэхдээ бид хүмүүсийн хэлсэн болгонд итгэж болохгүй!” гэлээ.

Эгч “Дүү минь, Эзэн Есүс тэр үед ажиллаж байхад фарисайчууд Эзэнийг эсэргүүцэж, ингэж хэлсэн: ‘Хай, шалгаад үз: учир нь Галилаас ямар ч эш үзүүлэгч гарахгүй’ (Иохан 7:52). ‘Христ Галилаас гарна гэж үү?’ (Иохан 7:41). Харин үнэн хэрэгтээ Эзэн Есүс Галилын Назарт өссөн юм. Библид: ‘Өө, Бурханы мэргэн ухаан болон мэдлэгийн аль алины баялаг юутай гүн билээ! Түүний шүүлтүүд яасан ойлгохын аргагүй, Түүний замууд нь яасан олж илрүүлэхийн аргагүй билээ! Учир нь, хэн Эзэний хүслийг мэдсэн юм бэ? Эсвэл хэн Түүний зөвлөх байсан бэ?’ (Ром 10:33–34) гэж хэлдэг. Бид Бурханы мэргэн ухааныг хэрхэн ойлгож чадах билээ? Бид өөрсдийн оюун ухаанд суурилан Бурханы ажлыг шинжилж болохгүй! Бид өдөр бүр Эзэний ирэлтийг тэсэж ядан хүлээж байна. Одоо Эзэн

---

үнэхээр эргэж ирсэн болохоор хэрвээ бид өөрсдийн үзэлд баригдаж, эрж хайж, судлахгүй бол Эзэнтэй уулзах завшааныг алдаж, гэмшлээр дүүрэн байх болно!” хэмээн санаа зовнин хэллээ.

Эгчийнхээ маш нухацтай харагдаж байгааг хараад би: “Эгч маань Эзэнд чин сэтгэлээсээ итгэдэг бөгөөд бодолтой, өөртөө итгэлтэй хүн. Тэрээр ерөнхийдөө хийж байгаа зүйлдээ болгоомжтой ханддаг бөгөөд Эзэний ирэлт шиг ийм том хэмжээний асуудалд хэн нэгний хэлсэнд сохроор итгэх магадлал бүр ч багатай. Одоо тэр Зүүний Аяныг хүлээн зөвшөөрч байгаа болохоор Эзэн Өөрийн ажлыг хийхээр үнэхээр Хятадад эргэж ирсэн юм гэж үү?” гэж бодов. Гэтэл өөр нэгэн бодол орж ирлээ: “Эзэн яаж Хятад ажиллаж таарах вэ? Хэтэрхий төсөөлөхийн аргагүй юм!” Тэгээд би баттайгаар: “Библи бол мянган давхаргатай бялуу бөгөөд хүн бүрийн тайлбарлах арга өөр өөр байдаг. Бурхан эцсийн өдрүүдэд үнэхээр Израильд бууж ирэх болно гэдгийг Библид зөгнөсөн байдаг. Үүнээс гадна ихэнх Хятад хүмүүс Буддаг шүтдэг бөгөөд улсын засгийн газар шашны итгэл үнэмшлийг үргэлж хавчдаг. Бурхан Хятадад ажиллахаар ирэхгүй!” гэв.

Эгч: “Дүү минь, Эзэн эргэж ирээд, Хятадад ажиллахаар гарч ирсэн. Энэ нь тун ач холбогдолтой. Би Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг дөнгөж хүлээн зөвшөөрсөн. Би үнэний энэ талыг тийм ч сайн ойлгохгүй хэвээр байгаа боловч Төгс Хүчит Бурханы Чуулганы ах, эгч нар тун гэрэлтүүлэм байдлаар гэрчилдгийг сонссон. Би тэднээр чамд нөхөрлөл хийлгэе!” гэлээ. Би гараа сэгсрэн “Битгий тэгээрэй. Би явлаа” гэв. Гэртээ харьсныхаа дараа би буйдан дээр хөдөлгөөнгүй суугаад эгчийн хэлсэн зүйлийг эргэн саналаа. Би дотроо тавгүйтэж, тайвширч чадсангүй. Эзэн Есүс Чидун ууланд хөл тавихыг би ямагт хүлээдэг байсан, гэтэл Эзэн Хятадад ирсэн гэж эгч яаж гэнэт хэлж чадаж байна аа? Яаж ийм байж болох билээ? Би Библийн хуудсыг тасралтгүй эргүүлсэн боловч Эзэн Хятадад ажиллахаар ирнэ гэж зөгнөсөн бүлгийг олсонгүй. “Эзэн Есүс Өөрийн ажлыг хийх үед Фарисайчууд Эзэнийг эсэргүүцэж, ингэж хэлсэн: ‘Хай, шалгаад үз: учир нь Галилаас ямар ч эш үзүүлэгч гарахгүй’ (Иохан 7:52). ‘Христ Галилаас гарна гэж үү?’ (Иохан 7:41). Гэвч үнэн хэрэгтээ Эзэн Есүс Галилын Назарт өссөн...” Эгчийн үг үе үе санаанд минь орж ирсэн бөгөөд түүний хэлсэн үг үнэн гэж би бодлоо. Би Библийг хэсэг хугацаанд хараад эгчийнхээ үгийг түр зуур бодов. Үүнийг дахин дахин бодож үзээд юу зөв болохыг би мэдээгүй боловч зүрх сэтгэлдээ Эзэнийг дуудан “Эзэн минь, би яах ёстой вэ? Эзэн минь, Та хаана ирэх юм бэ?” гэлээ.

Хэдэн өдрийн дараа эгч маань намайг хайн дахиад ирлээ. Гэрт орж ирэнгүүтээ тэрээр инээмсэглэн ингэж хэлэв: “Дүү минь, Төгс Хүчит Бурханы Чуулганы Шиэ болон Хао эгч, намайг дэмжихээр гэрт минь хүрч ирсэн. Тэд Төгс Хүчит Бурханд удаан хугацаанд

---

итгэсэн, надаас хамаагүй ихийг ойлгодог. Хэрэв чамд Эзэний эргэн ирэлтийн талаар ойлгохгүй зүйл байгаа бол очоод, тэдэнтэй нөхөрлө.” Эзэнд олон жилийн турш хэрхэн итгэснээ, Эзэнийг ирэхийг хэрхэн хүлээж байснаа, Эзэн ирсэн эсэхийг мэдэхийг бүр ч их хүсэж байсан тухайгаа би бодлоо. Би энэ боломжийг ашиглан тэдэнтэй нөхөрлөсөн нь дээр байв. Тэгээд би эгчтэйгээ хамт гэрт нь очсон юм. Намайг өрөөнд оронгуут хоёр эгч надтай маш халуун дотноор мэндчилж, маш ойр дотно ярилаа. Нөхөрлөл хийх ямар нэг асуулт надад байгаа эсэхийг тэд надаас асуув. Тиймээс би “Эзэн Есүс аль хэдийн эргэж ирээд, Хятадад ажил хийж байгаа гэж та нар хэлдэг үү? Библид ямар нэг үндэслэл байдаг уу?” гэж асуулаа. Хао эгч инээмсэглээд, “Дүү минь, эцсийн өдрүүдэд Эзэн Хятадад ажиллахаар ирэх тухай зөгнөлүүд Библид үнэндээ байгаа” гэлээ. Би “Яаж ийм байж болох юм бэ? Би Библийг олон удаа уншсан боловч библийн ганц ч тэмдэглэл олоогүй. Библи дэх үндэслэл нь хаана байна вэ?” гэж яаран хэллээ. Хао эгч тэвчээртэйгээр ингэж хэлэв: “Дүү минь, Судрын хоёр эшлэлийг уншицгаая, тэгээд чи мэдэх болно. Малахи 1:11-т: **‘Учир нь нар мандахаас жаргах хүртэл Миний нэр Харь үндэстнүүдийн дунд агуу байх болно.’** Матай 24:27 дээр ингэж хэлдэг: **‘Аянга зүүнээс цахилж, баруун зүгт ч гэсэн гялбадаг шиг; хүний Хүүгийн ирэлт нь ч мөн тийм байх болно.’** Судрын энэ хоёр эшлэлээс харахад Бурханы дахин нэг удаа бууж ирэх газар бол дэлхийн Зүүн зүг бөгөөд энэ нь Харь үндэстний газар нутагт байдаг гэдгийг бид тодорхой харж болно. Хятад бол дэлхийн Зүүн зүг гэдгийг бид бүгд мэднэ. Бурханы ажлын эхний хоёр үе шат хоёулаа Израильд байв. Израилийн хувьд Хятад бол Харь үндэстэн юм. Тиймээс Бурхан ажлаа хийхийн тулд эцсийн өдөр Хятадад ирэх нь эдгээр зөгнөлийг биелүүлдэг!” Эгч нарын нөхөрлөлийг сонсож, Судрын энэ хоёр эшлэлийн утгыг эргэцүүлсний дараа тэдний нөхөрлөл маш их гэрэлтүүлэм юм гэж би бодлоо. Хэдийгээр би энэ хоёр эшлэлийг өмнө нь уншсан ч, Эзэний эргэн ирэлт Хятадад, Зүүн зүгт байна гэдгийн утга учрыг олж хараагүй байж. Одоо тэдний тайлбарлахыг сонсоод, энэ нь Ариун Сүнсний гэгээрлээс гарч ирсэн мэт надад санагдсан билээ.

Хао эгч үргэлжлүүлэн ингэж хэлэв: “Төгс Хүчит Бурхан юу гэж хэлснийг харцгаая: **‘Орчлон даяар Би Өөрийн ажлыг хийж байна, зүүн зүгт аянга цахилгаан зогсолтгүй цахилж, бүхий л үндэстэн, урсгалыг доргиодог. Миний дуу хоолой бүх хүнийг өнөөдөр лүү хөтөлсөн. Би бүх хүнийг дуу хоолойгоороо байлдан дагуулж, энэ урсгалд оруулж, Өөрийнхөө өмнө дуулгавартай байлгана, учир нь Би аль эрт Өөрийн алдар сууг бүх дэлхийгээс эгүүлэн татаж, зүүн зүгт шинээр гаргасан. Миний алдар сууг харахыг хүсэн хүлээдэггүй хэн байна вэ? Намайг эргэн ирэхийг сэтгэл түгшин хүлээдэггүй хэн байна вэ? Миний дахин илрэлтээр цангахгүй хэн байна вэ? Миний хайр татам байдлыг санагалзахгүй хэн байна вэ? Гэрэл рүү гарч ирэхгүй байх хэн**

---

байна вэ? Канааны баян тансаг руу хараа бэлчээхгүй хэн байх вэ? Золин аврагч эргэн ирэхийг хүсэн хүлээхгүй хэн байх вэ? Агуу Төгс Хүчитийг эрхэмлэн хайрладаггүй хэн байна вэ? Миний дуу хоолой дэлхий даяар тархах болно; Би сонгосон хүмүүстэйгээ нүүр тулаад тэдэнд илүү олон үг хэлэхийг хүсэж байна. Уул, усыг доргиох хүчит аянга шиг бүх орчлон ертөнц, хүн төрөлхтөнд хандан Би үгээ хэлдэг. Тиймээс, Миний аман дахь үгс хүний эрдэнэ болж, хүмүүс бүгд Миний үгийг нандигнадаг. Аянга цахилгаан зүүнээс баруун зүг хүртэл цахилдаг. Миний үгс хүн татгалзхааргүй байхын зэрэгцээ ойлгохын аргагүй боловч тэгэх тусмаа баярлан хөөрмөөр байдаг. Бүх хүн дөнгөж төрсөн нярай мэт Миний ирснийг тэмдэглэж, баяр хөөртэй байна. Дуу хоолойгоороо дамжуулан Би бүх хүнийг Өөрийнхөө өмнө авчрах болно. Түүнээс хойш Би албан ёсоор хүмүүсийн эгнээнд орох бөгөөд ингэснээр тэд Намайг шүтэн биширнэ. Цацруулж буй алдар суу, аман дахь үгээрээ Би бүх хүнийг өмнөө ирүүлэн, зүүн зүгээс аянга цахилж, зүүн зүгийн “Чидун жимсний уулан” дээр Өөрийгөө бууж ирснийг харуулна. Намайг иудейчүүдийн Хүүгийн хувьд биш, харин Зүүн зүгийн аянга болж газар дээр аль эртнээс байсныг тэд харах болно. Учир нь Би дахин амилж, хүн төрөлхтний дундаас холдон яваад удаж байгаа бөгөөд хүмүүсийн дунд алдар суутайгаар дахин гарч ирсэн. Би бол одоогоос тоолж баршгүй олон эрин үеийн өмнө шүтэгдэж байсан Тэр нэгэн, мөн Би одоогоос тоолж баршгүй олон эрин үеийн өмнө израильчуудын хаясан нярай билээ. Түүнээс гадна, Би энэ эрин үеийн хамгийн алдан суут Төгс Хүчит Бурхан билээ! Бүгд Миний сэнтийн өмнө ирж, Миний алдар суут төрхийг харж, дуу хоолойг минь сонсож, Миний үйлсийг харцгаа. Энэ бол Миний бүхий л хүсэл; Миний төлөвлөгөөний төгсгөл, оргил үе, мөн Миний удирдлагын зорилго юм. Үндэстэн болгон Намайг шүтэн биширч, хэл болгон Намайг хүлээн зөвшөөрч, хүн болгон итгэлээ Надад өгч, бүх хүн Надад захирагдах болтугай!’ (Үг нь махбодоор илэрсэн номын “Хаанчлалын сайн мэдээ ертөнц даяар тархахыг зөгнөсөн Долоон Аянгын Нүргээн”). Бурхан анх удаа бие махбодтой болохдоо хаанчлалын сайн мэдээг авчирсан гэдгийг бид бүгдээрээ мэддэг. Энэхүү сайн мэдээ нь Баруунаас Зүүн зүг рүү шилжсэн. Гэхдээ, Бурхан дэлхийн Зүүн зүг болох Хятадад махбодод эргэн ирж, мөнхийн сайн мэдээг авчирч, хүмүүсийг шүүх, ариусгах, аврах ажлыг хийнэ гэж хүмүүс бодож байсангүй. Энэ удаад Бурханы ажил Зүүнээс Баруун руу...”

Үүнийг сонсоод би эгчийн үгийг тасалж, “Эгч ээ, Ехова Бурхан Израильд ажилласан гэж Хуучин гэрээнд тэмдэглэсэн, Эзэн Есүсийн ажил Иудейд байсан, Бурханы ажлын хоёр үе шат хоёулаа Израильд байсан, иймээс Эзэний эргэн ирэлт ч бас Израильд байх ёстой. Энэ нь Хятадад байна гэж та яаж хэлж чадаж байна вэ?” хэмээн будилсан байдалтай асуухад Хао эгч инээмсэглээд, “Бурханы ажлын эхний хоёр үе шат хоёулаа Израильд

---

байсан, иймээс Эзэн эргэж ирэхдээ Израильд Өөрийн ажлыг хийх нь гарцаагүй гэж бид боддог. Ийм бодол баримтуудтай нийцэх үү? Бурхан зөвхөн израильчуудын Бурхан байж таарах уу? Бурхан зөвхөн израильчуудыг удирдаж, хамгаалдаг юм гэж үү? Төгс Хүчит Бурхан юу гэж хэлснийг харцгаая” гэж хэллээ.

Шинэ эгч Бурханы үгийн номыг нээж, дараах үгийг уншлаа: “Аврагч эцсийн өдрүүдэд ирэхдээ мөн л Есүс гэгдэн, дахин Иудейд төрж, Иудейд ажлаа хийсэн бол, Би зөвхөн Израилийн ард түмнийг л бүтээж, Израилийн ард түмнийг л золин аварсан ба Харь үндэстнүүдтэй ямар ч хамаагүй гэдгийг энэ нь нотлох байсан. ‘Би бол тэнгэр, газар, бүх зүйлийг бүтээсэн Эзэн’ хэмээх Миний үгтэй энэ нь зөрчилдөх байсан бус уу? Би Иудейг орхисон бөгөөд Харь үндэстнүүдийн дунд ажлаа хийдэг, учир нь Би бол зөвхөн Израилийн ард түмний Бурхан биш, харин бүх бүтээлийн Бурхан билээ. Би Израилийн ард түмний Бурхан Ехова төдийгүй Харь үндэстнүүдийн дундах Өөрийн сонгосон бүх хүний Бүтээгч тул эцсийн өдрүүдэд Харь үндэстнүүдийн дунд гарч ирдэг. Би Израил, Египет, Ливаныг төдийгүй Израилын чанад дахь бүх Харь үндэстнийг бүтээсэн” (Үг нь махбодоор илэрсэн номын “Аврагч аль хэдийн ‘цагаан үүлэн’ дээр эргэн ирсэн”). “Би бол израилчуудын цор ганц Бурхан төдийгүй, бүх Харь үндэстний, тэр ч байтугай хараасан үндэстнүүдийнхээ ч Бурхан гэдгээ Би бүх хүнд мэдүүлнэ. Би бол бүх бүтээлийн Бурхан гэдгээ бүх хүнд харуулна. Энэ бол Миний хамгийн агуу ажил, эцсийн өдрүүдийн ажлын төлөвлөгөөний минь зорилго ба эцсийн өдрүүдэд биелүүлэх цорын ганц ажил юм” (Үг нь махбодоор илэрсэн номын “Сайн мэдээ түгээх ажил нь бас хүнийг аврах ажил мөн”). “Тэр израильчуудыг удирдаж, Иудейд төрсөн бөгөөд бас Харь үндэстний нутагт төрсөн. Түүний бүх ажил Өөрийн бүтээсэн бүх хүн төрөлхтний төлөө хийгддэг бус уу? Тэр израильчуудыг зуу дахин их хайрлаж, Харь үндэстнүүдийг мянга дахин их жигшдэг үү? Энэ та нарын үзэл биш гэж үү?... Хэрвээ та нар, Бурхан бол зөвхөн израильчуудын Бурхан гэж үзсэн хэвээр, мөн Израиль дахь Давидын гэр бол Бурханы төрөлтийн уг сурвалж бөгөөд Израилиас өөр ямар ч үндэстэн Бурханыг ‘бий болгох’ эрхгүй, тэр ч бүү хэл ямар ч Харь үндэстний гэр бүл Еховагийн ажлыг биечлэн хүлээн авч чадахгүй гэж бодсоор байвал энэ нь чамайг зөрүүд эсэргүүцэгч болгохгүй гэж үү?... Бас Бурхан Харь үндэстний нутагт хэрхэн биечлэн бууж ирэх талаар хэзээ ч бодож байгаагүй. Тэр Синаи Уул, эсвэл Чидун Уулан дээр буун ирж, израильчуудад харагдах учиртай. Харь үндэстнүүд (өөрөөр хэлбэл, Израилийн гаднах хүмүүс) нь бүгд Түүний жигшил зэвүүцлийн бай биш гэж үү? Тэр яаж тэдний дунд биечлэн ажиллаж чадах юм бэ? Энэ бүхэн нь олон жилийн туршид та нарын бий болгосон, гүн үндэслэсэн үзэл юм. Та нарыг өнөөдөр байлдан дагуулахын зорилго нь эдгээр үзлийг чинь эвдэх явдал.

---

Тиймээс Бурхан Синаи Уулан дээр, эсвэл Чидун Уулан дээр биш, харин урьд нь хэзээ ч удирдаж байгаагүй хүмүүсийнхээ дунд—та нарын дунд биечлэн илрэхийг та нар хардаг” (Үг нь махбодоор илэрсэн номын “Байлдан дагуулалтын ажлын дотоод үнэн (3)”). “Хэрвээ Түүний одоогийн ажил израильчуудын дунд явагдсан бол, Түүний зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө эцэс болох үед Бурхан бол зөвхөн израильчуудын Бурхан, израильчууд л Бурханы сонгосон хүмүүс, израильчууд л Бурханы ерөөл, амлалтыг өвлөх эрхтэй гэж хүн бүхэн бодох байв. Эцсийн өдрүүдэд агуу улаан лууны улсын Харь үндэстэнд бие махбодтой болсон Бурхан, Бурхан бол бүх бүтээлийн Бурхан хэмээх ажлыг гүйцэлдүүлдэг; Тэрээр Өөрийн удирдлагын ажлыг бүхэлд нь гүйцээдэг... Тиймээс ажлын үе шат бүр асар их утга учиртай; Бурхан утга учиргүй, үнэ цэнгүй юу ч хийхгүй” (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурхан бол бүх бүтээлийн эзэн”).

Дараа нь Хао эгч нөхөрлөлд ингэж хэлэв: “Өмнө нь бид Бурханы ажлын эхний хоёр үе шат Израильд хийгдсэн учраас Бурхан бол израильчуудын Бурхан гэж зүрх сэтгэлдээ тодорхойлсон. Израиль бол Бурханы ажлын өлгий нутаг, мөн Бурханы ажилд зориулсан суурь бүс нутаг байсан, тиймээс бид Бурханы ажил зөвхөн Израильд байх болно, сайн мэдээ зөвхөн Израилиас гарч ирж болно, израильчууд л үнэхээр Бурханы сонгосон хүмүүс гэж бодсон юм. Хэрэв Бурхан эцсийн өдрүүдэд Израильд ажилласаар байгаа бол Бурхан зөвхөн Израильд ажил хийж болно, Бурхан зөвхөн израильчуудыг ерөөж болох бөгөөд Түүний ерөөл Харь үндэстнүүдтэй ямар ч холбоогүй гэж бид бүр ч их бодох болно. Эцсийн өдрүүдэд Бурхан Харь үндэстний нутагт хүмүүсийг шүүж, ариусгах ажлаа хийхээр сонгосон юм. Энэ нь мөн агуу улаан луугийн оршин байгаа нутаг—Хятад юм. Энэ нь бүх хүн төрөлхтний үзлийг эргүүлж, үнэндээ Бурхан бол зөвхөн израильчуудын Бурхан биш, харин бүх Харь үндэстний Бурхан, бүх бүтээлийн Бурхан гэдгийг хүмүүс харуулдаг. Бурхан зөвхөн израильчуудыг ерөөдөг бус, Харь үндэстнүүдийг ч бас ерөөдөг. Энэ нь **‘Бурхан бол бүх бүтээлийн Эзэн’** гэх ажлыг гүйцэлдүүлдэг. Бурхан эцсийн өдрүүдэд Хятадад ажил хийхээр шийдсэн нь маш чухал ач холбогдолтой гэдэг нь тодорхой. Бурхан бол үнэхээр бүхнийг чадагч, маш ухаалаг юм.”

Эгчийн нөхөрлөлийг сонсоод би эргэцүүлэлд умбав: Тийм ээ, Бурхан бол бүх бүтээлийн Эзэн мөн. Хүн төрөлхтөн бүгд Бурханаар бүтээгдээгүй гэж үү? Бурхан израильчуудыг авардаг төдийгүй Хятадын ард түмнийг авардаг. Бурхан өнөөдөр Хятадад ажиллахаар ирж байгаа нь Харь үндэстнүүдийг гэх Түүний хайр биш гэж үү? Бурханы хүслийг би үнэхээр ойлгодоггүй юм шиг байна! Энэ талаар бодоод би жаахан ичиж, хоолойны өнгөө зөөлрүүлэн ингэж хэлэв: “Эгч ээ, би таны хэлснийг ойлгож байна. Хэрэв Бурхан Израильд дахин ажил хийхээр ирвэл бид Бурханы тухай дүрэм журам тогтоож,



---

Бурхан бол ердөө израильчуудын Бурхан гэж бодно. Өнөөдрийн Бурханы ажил нь хүмүүсийн үзлийг эвдэж, Бурхан бол бүх бүтээгдсэн зүйлийн Эзэн гэдгийг хүмүүст ойлгуулахын төлөө юм. Бурхан Израильд, бас Хятадад ажлаа хийж чадна, тэгснээр бид Бурханы ажлын талаар дүрэм журам тогтоохгүй. Үзэл, төсөөлөл дээр суурилан Бурханы ажлын талаар дүрэм журам тогтоох нь үнэхээр дэндүү мунхаг, мэдлэггүй хэрэг юм шиг байна! Гэхдээ одоо ч ойлгохгүй байгаа нэг зүйл байна. Христийн шашин болон Католик шашин улсынх нь шашин болсон Европ, Америк гэх мэтийн маш олон улс орон дэлхий дээр байдаг. Бурхан эдгээр оронд ирж, хүмүүсийг шүүж, ариусгах ажлаа хийвэл илүү хялбар байхгүй гэж үү? Хятад бол шүтээн шүтэгчдээр дүүрсэн бурхангүй орон юм. Улсын засгийн газар Бурханд итгэдэг хүмүүсийг улайран хавчдаг, гэтэл Бурхан яагаад Хятадад ажиллана гэж?”

Шизэ эгч инээмсэглэн, “Дүү минь, чиний асуулт маш чухал! Бурханыг дайсан гэж үздэг улс оронд Бурхан яагаад шүүлт болон ариусгалтын ажлыг хийхээр сонгодог билээ? Хэрэв бид Израиль болон Хятадад ажил хийж байгаа Бурханы зорилго, ач холбогдлыг ойлговол үнэний энэ талыг ойлгоно. Бурханы үг юу гэж хэлсэн болохыг харцгаая. Төгс Хүчит Бурхан хэлэхдээ: **‘Хуучин гэрээ нь израильчуудад хэлсэн Еховагийн үгийг болон Израиль дахь Түүний ажлыг тэмдэглэсэн байдаг; Шинэ гэрээ нь Иудей дахь Есүсийн ажлыг тэмдэглэсэн байдаг. Гэхдээ Библид яагаад ямар ч хятад нэр байдаггүй вэ? Бурханы ажлын эхний хоёр хэсэг Израильд хийгдсэн учраас, Израилийн хүмүүс сонгогдсон хүмүүс байсан учраас—өөрөөр хэлбэл, тэд Еховагийн ажлыг хүлээн авах эхний хүмүүс байлаа. Тэд хүн төрөлхтнөөс хамгийн бага завхарсан нь байсан бөгөөд эхэндээ Бурханыг дээдэлж, хүндлэх сэтгэлтэй байсан юм. Тэд Еховагийн үгийг дуулгавартай дагаж, үргэлж сүмд үйлчилж, тахилчийн өмсгөл юм уу титэм зүүдэг байв. Тэд Бурханыг шүтэн мөргөсөн хамгийн эртний хүмүүс, Түүний ажлын хамгийн эртний бай байлаа. Энэ хүмүүс бүх хүн төрөлхтний үлгэр дуурайл, загвар байв. Тэд бол ариун, шулуун шударга байдлын үлгэр дуурайл, загвар байсан юм. Иов, Абрахам, Лот, Петр, Тимот гэх мэтийн хүмүүс бүгд израильчууд байсан ба хамгийн ариун үлгэр дуурайл, загвар байлаа. Израиль нь хүн төрөлхтний дундаас Бурханыг шүтэн мөргөсөн хамгийн анхны улс орон байсан бөгөөд зөв шударга хүмүүс өөр хаанаас ч илүүтэйгээр эндээс төрөн гарчээ. Ирээдүйд бүх газар нутаг даяарх хүн төрөлхтнийг илүү сайн удирдахын тулд Бурхан тэдэн дээр ажилласан. Тэдний ололт амжилт, Еховаг шүтэн мөргөж байсан шударга байдал тэмдэглэгдсэн, ингэснээр тэд Нигүүлслийн эрин үед Израилиас цааших газар нутгийн хүмүүст үлгэр дуурайл, загвар болж чадах байв; тэдний үйлдэл өнөөдрийг хүртэл хэдэн мянган жилийн ажлыг хадгалсан юм.’** ‘Еховагийн ажил нь дэлхийг

---

бүтээх явдал байсан бөгөөд энэ нь эхлэл байсан юм; ажлын энэ үе шат бол ажлын сүүлч бөгөөд төгсгөл юм. Эхэндээ Бурханы ажил Израилийн сонгогдсон хүмүүсийн дунд хийгдсэн бөгөөд энэ нь бүх газраас хамгийн ариун газар дахь шинэ эриний эхлэл байв. Ажлын сүүлчийн үе шат нь, дэлхийг шүүж, эрин үеийг төгсгөхийн тулд бүх улс орноос хамгийн бузар заваан оронд хийгддэг. Эхний үе шатанд Бурханы ажил хамгийн гэрэл гэгээтэй газар хийгдсэн бол сүүлчийн үе шат нь хамгийн харанхуй газарт хийгддэг бөгөөд энэхүү харанхуйг хөөн зайлуулж, гэрлийг авчирч, бүх хүнийг байлдан дагуулна. Бүх газраас хамгийн бузар заваан, харанхуй газрын ард түмэн байлдан дагуулагдаж, жинхэнэ Бурхан байдгийг бүх хүн ам хүлээн зөвшөөрч, хүн болгон бүрэн үнэмших үед бүхий л орчлон ертөнц даяар байлдан дагуулалтын ажлыг гүйцэтгэхэд энэхүү баримтыг ашиглана. Ажлын энэ үе шат бэлгэдлийн чанартай: Энэ эрин үеийн ажил дуусмагц зургаан мянган жилийн удирдлагын ажил бүрмөсөн төгсөнө. Хамгийн харанхуй газарт байгаа хүмүүс байлдан дагуулагдмагц хаа сайгүй ийм зүйл болно гэдэг нь илэрхий юм. Ийм болохоор зөвхөн Хятад дахь байлдан дагуулалтын ажил л утга учиртай бэлгэдлийг агуулдаг. Хятад улс харанхуйн бүх хүчийг илтгэдэг бөгөөд Хятадын ард түмэн нь Сатан, махан бие, мах цуснаас бүтсэн бүх хүнийг төлөөлдөг. Хятадын ард түмнийг агуу улаан луу хамгийн их завхруулсан, тэд Бурханыг хамгийн хүчтэй эсэргүүцдэг бөгөөд хүн чанар нь хамгийн олиггүй, ариун бус тул бүх завхарсан хүн төрөлхтний төлөөлөгч билээ. Бусад улс оронд ямар ч асуудал байхгүй гэж хэлж байгаа юм биш; хүний үзэл бүгд адилхан бөгөөд эдгээр улс орны хүмүүс сайн хэв чанартай байж болох хэдий ч хэрвээ Бурханыг мэддэггүй бол Түүнийг эсэргүүцдэг байж таарна. Яагаад иудейчүүд ч бас Бурханыг эсэргүүцэж, сөрсөн бэ? Яагаад фарисайчууд ч бас Түүнийг эсэргүүцсэн бэ? Яагаад Иудас Есүсээс урвасан бэ? Тэр үед шавь нарынх нь олонх нь Есүсийг мэдээгүй. Есүсийг цовдлогдож, дахин амилсны дараа ч яагаад хүмүүс Түүнд итгээгүй вэ? Хүний дуулгаваргүй байдал бүгд адилхан бус уу? Зүгээр л Хятадын ард түмнийг жишээ болгож байгаа ба байлдан дагуулагдах үедээ тэд үлгэр дуурайл, загвар болж, бусдад лавлагаа болох болно. Та нар бол Миний удирдлагын төлөвлөгөөний хавсралт гэж Би яагаад үргэлж хэлдэг вэ? Учир нь Хятадын ард түмэнд завхрал, бузар, шударга бус байдал, эсэргүүцэл, тэрслүү байдал хамгийн бүрэн дүүрэн илэрхийлэгдэж, янз бүрийн хэлбэрээрээ илчлэгддэг. Нэг талаас, тэд дорд хэв чанартай, нөгөө талаас, амьдрал, сэтгэлгээ нь хоцрогдмол, мөн зуршил, нийгмийн орчин, төрсөн гэр бүл нь бүгд ядуу дорд, хамгийн их хоцрогдсон байдаг. Тэдний байр суурь ч бас дорд. Энэ газарт хийж байгаа ажил бэлгэдлийн чанартай бөгөөд туршилтын энэ ажлыг бүхэлд нь хийж дуусгасны дараа Бурханы дараагийн ажил хавьгүй илүү дээр явагдана. Хэрвээ ажлын энэ үе шатыг дуусгаж чадвал дараагийн ажлыг хэлэхийн ч хэрэггүй.

---

**Ажлын энэ үе шат гүйцэлдвэл агуу амжилтад бүрэн хүрч, бүхий л орчлон ертөнц даяарх байлдан дагуулалтын ажил бүрмөсөн төгсөнө. Үнэндээ, та нарын дундах ажил амжилттай болмогц энэ нь бүх орчлон ертөнц даяарх амжилттай тэнцүү байх болно. Би та нарыг үлгэр жишээ, загвар болгосны ач холбогдол энэ юм. Тэрслүү байдал, эсэргүүцэл, бузар бохир байдал, шударга бус байдал—энэ бүхэн нь энэхүү хүмүүст байдаг бөгөөд тэдэнд байдаг зүйл хүн төрөлхтний бүх тэрслүү байдлыг төлөөлдөг. Тэд үнэхээр амаргүй. Тиймээс тэднийг байлдан дагуулалтын загвар болгодог ба байлдан дагуулагдмагцаа тэд аяндаа бусдын үлгэр жишээ, загвар болно’ (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурханы ажлын үзэгдэл (2)”).**

Бурханы үгийг уншсаны дараа Шиэ эгч нөхөрлөлөө цааш нь үргэлжлүүлэв: “Ажлынхаа үе шат бүрд Өөрийн ажилд зориулан ямар төрлийн газар болон байг сонгох нь бүгд Түүний ажлын хэрэгцээнд суурилдаг бөгөөд тэдгээр нь бүгд үлэмж их утга учиртай гэдгийг Төгс Хүчит Бурханы үг бидэнд тодорхой хэлж байна. Жишээ нь, израильчууд Бурханы сонгосон хүмүүс байсан учраас Бурханы ажлын эхний хоёр үе шат Израильд болсон. Тэд бүх хүн төрөлхтнөөс хамгийн бага ялзарсан нь бөгөөд Бурханаас эмээх зүрх сэтгэлтэй байсан. Тэдний дунд ажил хийх нь, Бурханыг шүтэн бишрэх үлгэр дуурайл, загвар болох бүлгийг бий болгоход Бурханы хувьд хамгийн хялбар байв. Тийнхүү Бурханы ажил илүү хурдан, илүү хялбархан тархаж, тэгснээр бүх хүн Бурханы оршин тогтнол ба Бурханы ажлыг мэдэж, илүү олон хүн Бурханы өмнө ирж, Бурханы авралыг хүлээн авах боломжтой болох байсан юм. Тиймээс ажлын эхний хоёр үе шатыг Бурхан Израильд хийх нь хамгийн утга учиртай юм. Эцсийн өдрүүдэд Бурхан хүмүүсийг байлдан дагуулж, ариусгах ажил хийдэг. Бурханы байлдан дагуулалт болон ариусгалтыг эхлээд хүлээн зөвшөөрөх төлөөлөгч хүмүүс бас Түүнд хэрэгтэй. Бүх хүн төрөлхтний дундаас Хятадын ард түмэн хамгийн их ялзарч, хоцрогдсон бөгөөд Хятад улс нь Бурханд хамгийн бага итгэдэг үндэстэн, мөн Бурханыг хамгийн хүчтэй эсэргүүцдэг орон юм. Тиймээс эцсийн өдрүүдэд Бурхан эхлээд Өөрийн шүүлт болон байлдан дагуулалтын ажлыг Хятадад хийж, хамгийн их ялзарсан хүмүүсийг гэсгээх, шүүх ажлаа хийж, хамгийн ихээр ялзарсан биднийг байлдан дагуулж, ариусгах нь Бурханы бүхнийг чадагч, ариун, зөвт байдлыг хамгийн ихээр онцлон харуулж, Сатаныг шившиглэнэ. Хамгийн их ялзарсан хүмүүсийг Бурхан байлдан дагуулах үед бүх орчлон ертөнцийн үлдсэн хүн төрөлхтний хувьд энэ нь бүр ч тодорхой бөгөөд Сатан ч бас бүрэн ялагдана. Ажлынхаа үе шат бүрд Бурханы сонгосон газар, бай болон эцсийн хүрсэн үр дүнгээс бид Бурханы ажил бол маш ухаалаг, гайхамшигтай гэдгийг бүр ч сайн харж чадна!”

Төгс Хүчит Бурханы үг болон эгч нарын нөхөрлөлийг сонссоны дараа би ийнхүү ойлгосон юм: Бурхан хамгийн бага ялзарсан хүмүүсийн дундаас үлгэр дуурайл, загвар

---

болох бүлгийг бий болгохыг хүссэн учраас өмнө нь Израильд ажил хийсэн бөгөөд тэдний гэрчлэл, Бурханы сайн мэдээний тунхаглалаар дамжуулан бүр ч олон хүн Бурханы авралыг хүлээн авах байсан. Эцсийн өдрүүдэд Бурханы хийдэг ажил нь байлдан дагуулалт, ариусгалын ажил бөгөөд Тэр хамгийн их ялзарсан, хамгийн их бохирдсон Хятад хүмүүсийг Бурханы ажлын бай болгож, энэ хүмүүсийг байлдан дагуулагдаж, аврагдах хүмүүсийн үлгэр дуурайл, загвар болгохоор сонгосон. Энэ нь Бурханы мэргэн ухаан, төгс хүчит байдлыг бүр ч их илчилж байна. Би Бурханы санаа зорилгыг ойлгоогүй бөгөөд Бурхан Израилийн Чидун уулан дээр дахин бууж ирнэ гэж Библиэс уншаад шууд утгаар нь хүлээн авч, Бурхан гарцаагүй Израильд ажил хийнэ гэж бодсон. Бурхан олон жилийн өмнө Хятадад ирсэн гэж хэн бодох билээ дээ! Бурханы ажил хүмүүсийн төсөөлдөг шиг энгийн зүйл биш бололтой!

Энэ үед Шиэ эгч үргэлжлүүлэн ингэж хэллээ: “Ямар улс оронд Бурхан ажил хийх нь хамаагүй, энэ нь бүгд Түүний ажлын төлөө, хүн төрөлхтнийг илүү их аврахын төлөө байдаг бөгөөд бүгд маш утга учиртай. Хэрэв бид өнөөдөр Бурханы илрэлтийг эрж хайхыг хүсэж байвал эхлээд өөрсдийн төсөөлөл болон үзлийг орхих ёстой. Бид Бурханы мөрийг хязгаарлагдмал гэж тодорхойлж, Бурхан энэ, эсвэл тэр улсад ирэх ёстой гэж бодож болохгүй. Бурхан бол бүх хүн төрөлхтний Бурхан. Тэр Өөрийн ажлын хэрэгцээний дагуу ажиллах газрыг чөлөөтэй сонгож болно. Төгс Хүчит Бурхан ингэж хэлдэг: **‘Бурхан бол бүхий л хүн төрөлхтний Бурхан юм. Тэрээр Өөрийгөө ямар ч улс үндэстэн, ард түмний хувийн өмч гэж үздэггүй, харин ямар ч хэлбэр, улс үндэстэн, ард түмэнд хязгаарлагдмалгүй, Өөрийн төлөвлөснөөр ажлаа явуулдаг. Чи магад энэ хэлбэрийг хэзээ ч төсөөлөөгүй байх, эсвэл энэ хэлбэрт үгүйсгэх хандлагаар ханддаг байх, эсвэл Бурханы Өөрийгөө илчилдэг улс үндэстэн, ард түмэн нь хүн болгонд ялгаварлан гадуурхагддаг, газар дэлхий дээр хамгийн хоцрогдмол байж таардаг байх. Гэвч Бурханд Өөрийн мэргэн ухаан гэж бий. Тэрээр Өөрийн агуу их хүч чадал болон үнэн, зан чанараараа дамжуулан Өөртэй нь нэг санаатай, Өөрийнхөө бүрэн төгс болгохыг хүссэн бүлэг хүмүүсийг үнэнхүү олж авсан—бүх төрлийн шалгалт, гай гамшиг болон бүх төрлийн хавчлагыг туулж, Түүгээр байлдан дагуулагдсан бүлэг Түүнийг эцсээ хүртэл дагаж чаддаг’** (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурханы илрэлт шинэ эрин үеийг авчирсан”).

Төгс Хүчит Бурханы үгийг сонссоны дараа би баярлан уйлж, эгч нарт ингэж хэлэв: “Эдгээр үг Бурханы хүч чадал, эрх мэдлийг агуулдаг бөгөөд Бурханаас ирдэг. Одоо би эцэст нь ойлголоо: Бурхан бол зөвхөн Израильчуудын Бурхан биш, бас Хятадын ард түмний Бурхан, үүнээс ч илүүтэйгээр бүх хүн төрөлхтний Бурхан юм. Бурхан үнэхээр эргэн иржээ! Энэ өдрүүдэд би буруу зам руу орохоос айсандаа сайн идэж, унтаж чадахгүй

---

байлаа! Өнөөдөр та нартай нөхөрлөсний ачаар сэтгэлд байсан чулуу газарт унав. Намайг орхиогүйд Бурханд үнэхээр талархаж байна!” Дараа нь хоёр эгч надад ‘Үг нь махбодоор илэрсэн’ номыг өгөв. Би номоо хоёр гартаа барин аз жаргалтайгаар гэртээ харилаа. Төгс Хүчит Бурханы үгийг уншсанаар би Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс мөн гэдэгт итгэсэн юм. Бидний Эзэн Есүс үнэхээр эргэж ирсэн!

## **15. Одоо би Бурханы шинэ нэрийг мэдсэн**

Жао Шин, Тайвань

Би багаасаа л эцэг эхийнхээ хамт Эзэнд итгэж, цуглаанд оролцдог байсан болохоор ахлах сургуулиа дүүргээд, Христийн шашны коллежид элссэн юм. Нэг хичээлийн үеэр пастор бидэнд, “Еврей 13-р бүлэг, 8-р эшлэлд ‘Эзэн Есүс өчигдөр, өнөөдөр ч хэвээрээ бөгөөд мөнхөд хэвээрээ’ гэсэн байдаг. Эзэн Есүс бол цорын ганц Аврагч. Эрин үе ямар ч бай, Түүний нэр хэзээ ч өөрчлөгдөхгүй. Эзэн Есүсийн нэрд итгэснээр л бид аврагдаж болно...” гэлээ. Үүнийг сонссоныхоо дараа би, Эзэн Есүсийн нэрийг баримталснаар л аврагдаж болох юм байна, Түүний нэрийг хэзээ ч үгүйсгэж болохгүй гэж бат итгэсэн. Хичээлээс гадуур нөхөрлөл, Библи судлал, сайн мэдээний бүлгүүдэд идэвхийлэн оролцдог байлаа. Номлол, цуглаан нэг ч алгасаж үзээгүй шүү. Гэхдээ пастор, алхагчид нэг л улиг болсон юмаа ярих хандлагатай байдгийг яваандаа олж мэдсэн. Тэнд ямар ч шинэ гэрэл байгаагүй, тэгээд миний сүнс ямар ч тэжээлгүй болсон юм. Зарим ах эгч сул дорой болж, цуглаанд явахаа больсон, тэд маш бага тусламж, дэмжлэг хүлээн авдаг байлаа. Зарим нь бүр цуглааны үеэр зүүрмэглэж, үйл ажиллагааны дараа бусдад даатгал, бараа таваар зардаг байсан. Чуулганы ийм нөхцөл байдлыг хараад миний уур хүрч, урам хугарсан даа. “Сүнслэг амьдралдаа ахиц дэвшил эрэлхийлдэггүй, үргэлж ертөнцийн юмс, хөрөнгө мөнгө хүсэмжилдэг бол Христэд итгэгч гэгдсээр байж болох уу? Бас ийм юм болоод байгааг пастор, ахлагчид харсаар байж хайхрахгүй юм. Эзэний хүсэлд энэ нийцдэг гэж үү? Үүнийг яаж Бурханыг шүтэн мөргөж байна гэх юм бэ?” гэж бодогдсон. Тийм урт хугацаанд цуглаанаас ямар ч хангалт аваагүй болохоор сүнс минь хатаж гундсан юм. Бас ажил дээр завгүй байсан болохоор зүгээр л цуглаанд явахаа болилоо. Үүндээ харамссан учраас үргэлж л бүх зорилго, найдвараа алдсан мэт санагдаж, төөрөлдөн, арга мухардаад, гэртээ Библи уншиж, Эзэнд залбирдаг байсан.

Дараа нь 2017 оны 10-р сард Төгс Хүчит Бурханы Чуулганы Ли, Ван гэх хоёр эгчтэй интернэтээр танилцсан юм. Эзэний үгийн талаарх тэдний нөхөрлөл бодитой, гэгээрэлтэй санагдсан. Би Эзэнд олон жил итгэхдээ Эзний үгийн талаар хүн ийм тодорхой нөхөрлөж

---

байхыг хэзээ ч сонсож байгаагүй. Тэдэнд Ариун Сүнсний удирдамж байгаа нь мэдрэгдсэн. Тийм болохоор интернэтээр ойр ойрхон уулздаг боллоо.

Нэг цуглаан дээр бага зэрэг хоцорч интернэтэд ороод, яг тэгэхэд Ли эгч ингэж хэлж байгааг сонслоо, “Хүн төрөлхтнийг аврах Бурханы удирдлагын төлөвлөгөө гурван эрин үед хуваагдсан байдаг, эрин үе бүрд Бурхан шинэ ажил хийж, шинэ нэр авдаг юм. Эрин үеийг өөрчилж, ажлаа төлөөлүүлэхийн тулд Бурхан нэрээ ашигладаг. Бурханы ажил урагшилж, Түүний хийдэг өөр өөр ажлыг даган нэр нь өөрчлөгддөг. Хуулийн эрин үед Бурхан Ехова гэх нэрээр хууль, тушаал тунхагласан. Хуулийн эрин үеийг дуусгаж, Нигүүлслийн эрин үед золин авралын ажил хийх үед Бурханы нэр Ехова биш, Есүс болсон. Одоо эцсийн өдрүүдэд Бурханы ажил дахин урагшилж, Бурхан Есүсийн золин авралын ажилд үндэслэн Бурханы гэрээс эхлэн шүүлтийн ажил хийж байна. Тэр Нигүүлслийн эрин үеийг дуусгаж, Хаанчлалын эрин үеийг эхлүүлсэн, үүнийг даган Бурханы нэр өөрчлөгдөж, Есүс байхаа больж, Төгс Хүчит Бурхан болсон” гэлээ. Бурханы нэр өөрчлөгдсөн гэж хэлэхийг нь сонсоод би, “Үгүй байлгүй дээ. Библид, ‘Эзэн Есүс өчигдөр, өнөөдөр ч хэвээрээ бөгөөд мөнхөд хэвээрээ’ (Еврей 13:8) гэж тодорхой хэлдэг. Эзэн Есүсийн нэр хэзээ ч өөрчлөгдөж болохгүй, гэтэл та Бурханы нэрийг одоо өөрчлөгдсөн гэж байгаа юм уу? Хэрвээ бид залбирахдаа Есүсийг дуудахын оронд Төгс Хүчит Бурханыг дуудвал Библид нийцнэ гэж үү?” гэж бодлоо. Дараа нь Ли эгч надад нэг зүйрлэлээр тайлбарлаж өгсөн: “Жао эгч ээ, танай компани таныг нэг жил төлөвлөлтийн дарга болгоод, нэг жил менежер болгож, дараа нь захирал болгох юм бол ажлын тань хэрэгцээний дагуу таны цол хэргэм өөрчлөгдөнө шүү дээ. Ажил тань өөрчлөгдөхөд таны цол хэргэм өөрчлөгддөг. Урьд нь хүмүүс таныг төлөвлөлтийн дарга, менежер гэх байсан бол харин одоо захирал аа гэж дуудна. Тэд таныг өөр өөрөөр дуудна, гэхдээ та өөрчлөгдсөн байх уу? Эсвэл хэвээрээ байх уу?” гэлээ. Ли эгч цааш нь ярихдаа: “Бурхан эрин үе болгонд ингэж нэр авдаг. Бурханы ажил өөр болж, нэр нь өөрчлөгддөг ч Тэр нэг Бурхан хэвээрээ байдаг” гэсэн юм. Би энэ бүгдийг ойлгож эхэллээ. Гэхдээ Есүсийн нэр өөрчлөгдөх тухай бодохоор хүлээн зөвшөөрч ер чадахгүй байсан. “Таны юу гэх хамаагүй, би Эзэн Есүсийн нэрийг баримтална. Би тэгж амархан үнэмшихгүй шүү” гэж бодлоо.

Тэр цуглааны дараа интернэтээр Ли эгчийг блоклосон ч маргааш орой нь манай үүдэнд хоёр эгч ирээд Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн сайн мэдээг номлосон юм. Би Есүсийн нэр өөрчлөгдөж болохгүй гэж бодсон болохоор тэдэнд бага зэрэг эгдүүцэж, юу ч гэж хэлсэн бай, сонсохыг хүсээгүй. Тэд явж байхдаа, “Эгч ээ, **‘Гуй, тэгвэл та нарт өгнө; хай, тэгвэл олно; тогш, тэгвэл та нарт нээгдэнэ’** (Матай 7:7) гэж Эзэн хэлсэн байдаг. Яагаад үүнийг хүлээн зөвшөөрөхгүй байгааг чинь мэдэхгүй юм, гэхдээ та ер нь энэ тухай үнэхээр судалж үзсэн юм уу?” гэлээ. Явсных нь дараа тэдний хэлсэн үг өөрийн

---

эрхгүй бодогдсон. Тэгээд сэтгэл түгшлээ. Төгс Хүчит Бурханы Чуулганы хүмүүсээс сонссон бүх нөхөрлөлөө санаж, сүнс минь хэр их тэжээгдсэнийг бодсон. Тэдний уншсан Төгс Хүчит Бурханы үг үнэн, бас Ариун Сүнсний айлдвар гэдгийг, би сэтгэлдээ мэдэж байсан. Тэднийг тэгж голчлоод би ямар юмных нь үнэний эрэлч байх вэ дээ? Нэг цуглаан дээр Ли эгч нөхөрлөхдөө ингэж хэлсэн нь санагдлаа, “Бурханы хоньд Бурханы дуу хоолойг сонсдог. Эзэнийг эргэн ирэхэд угтан авъя гэвэл дуу хоолойг нь сонсож сурах ёстой. Ухаалаг охид Эзэний дуу хоолойг сонсдог учраас Эзэнийг дагадаг. Яг л Нигүүлслийн эрин үеийн Петртэй адил. Петр Эзэний үгийг сонсоод Бурханы дуу хоолойг таньсан болохоор Эзэнийг дагасан биш үү?” гэсэн. Үүнийг ухаараад би Библиэ яаран гаргаж ирээд, Илчлэлийн номын 3-р бүлгийг нээхэд 20-22-р эшлэлд ингэж хэлсэн байлаа, **“Харагтун, Би үүдэнд зогсоод тогшиж байна: Хэрвээ хэн нэгэн Миний дуу хоолойг сонсоод хаалгаа нээвэл, Би түүн дотор орж, түүнтэй хамт, тэр Надтай хамт хооллох болно... Чуулгануудад Сүнс юу айлдаж буйг чихтэй бүхэн сонсогтун.”** Би энэ хоёр эшлэлийг нухацтай тунгаан бодсон. Эцсийн өдрүүдэд Ариун Сүнс үг хэлнэ, Түүний үгийг бид сонсох ёстой гэж Эзэн хэлсэн байдаг. Эзэн эргэн ирсэн гэдгийг сонсох аз завшаан надад тохиосон, гэтэл би яагаад өөрийнхөө үзэлд баригдаж, ойлгохгүй байгаа бүхнээ сонсоогүй царайлахыг тэгж их хүсээ вэ? “Бурханы нэр өөрчлөгдөж байгааг одоо ойлгож чадахгүй бол эхлээд судалж, ойлгогчлоод, дараа нь яахаа шийдэх ёстой шүү дээ” гэж бодогдсон. Тэгээд Матай 7-р бүлгийн 7-р эшлэлээс ингэж уншлаа: **“Гуй, тэгвэл та нарт өгнө; хай, тэгвэл олно; тогш, тэгвэл та нарт нээгдэнэ.”** “Эзэн үнэхээр эргэж ирчхээд хаалгыг минь тогшиж байхад би үзлээсээ үүдэн нүдэн балай, чихэн дүлий болоод юу ч харж, сонсож чадахгүй, бас хаалгаа тайлахгүй бол Эзэнд хаягдах биш үү?” гэж бодсон. Тэр шөнө би цурам ч хийж чадаагүй. Сайн мэдээг голсондоо сэтгэл зовж, “Миний буруу юм болов уу? Төгс Хүчит Бурхан үнэхээр эргэн ирсэн Эзэн Есүс мөн гэж үү?” гэж гайхсан. Ингэж бодоод Эзэнд залбирч, Эзэний удирдамж, гэгээрэл гуйлаа.

Дараа нь “Хаанчлал бууж ирсэн тухай сайн мэдээ” гэх нэртэй, Төгс Хүчит Бурханы Чуулганы албан ёсны вэб сайт руу ороод, Бурханы нэрсийн талаар ийм хэсгийг уншлаа: **“Бурханы нэр өөрчлөгддөггүй гэж зарим нь хэлдэг. Тэгвэл Еховагийн нэр яагаад Есүс болсон юм бэ? Мессиа ирнэ гэж зөгнөсөн атал яагаад Есүс гэдэг нэртэй хүн ирсэн юм бэ? Бурханы нэр яагаад өөрчлөгдсөн бэ? Ийм ажил аль эрт хийгдээгүй гэж үү? Бурхан өнөөдөр илүү шинэлэг ажил хийж чадахгүй гэж үү? Өчигдрийн ажил ч өөрчлөгдөж болох бөгөөд Еховагийн ажлыг Есүсийн ажил үргэлжлүүлж болно. Тэгвэл Есүсийн ажлыг өөр нэг ажил залгамжилж болохгүй гэж үү? Хэрвээ Еховагийн нэр Есүс болж өөрчлөгдөж болдог юм бол Есүсийн нэр ч бас өөрчлөгдөж болохгүй гэж үү? Энэ нь хачин жигтэй зүйл биш; ердөө хүмүүс л дэндүү бодлогогүй. Бурхан үргэлж**

---

**Бурхан байх болно. Түүний ажил болон Түүний нэр яаж ч өөрчлөгдсөн бай, зан чанар, мэргэн ухаан нь хэзээ ч өөрчлөгдөхгүй. Хэрвээ чи, Бурханыг зөвхөн Есүсийн нэрээр л нэрлэж болно гэж боддог бол мэдлэг чинь хэтэрхий хязгаарлагдмал юм байна**” (“Үг нь махбодоор илэрсэн” ном). Үүнийг уншчихаад сэтгэл нэлээд хөдөлсөн шүү. Хуулийн эрин үед Бурхан Ехова гэх нэртэй байсан, тэр нэрээр израильчуудыг удирдан чиглүүлсэн талаар бодсон. Гэхдээ Эзэн Есүсийг ажлаа хийхээр ирэх үед Бурханы нэр Еховагаас Есүс болж өөрчлөгдсөн биш үү? “Энэ юу болоод байна аа? Эцсийн өдрүүдэд Эзэн үнэхээр шинэ нэртэй болж болох юм уу? Төгс Хүчит Бурхан үнэхээр Эзэн Есүсийн илрэлт байтал үүнийг нь би эрж хайж, судлахгүй, Эзэнийг угтан авах боломжоо алдах юм бол хэчнээн мунхаг хэрэг болох бол!” гэж бодлоо. Эцсийн өдрүүд дэх Төгс Хүчит Бурханы ажлыг судалъя гэж яг тэгэхэд шийдсэн юм.

Би интернэтээр Төгс Хүчит Бурханы Чуулганы Чэнь ахтай холбогдсон. Тэгээд цуглаан дээр ахад будилааныхаа талаар хэллээ. “Библид, ‘Эзэн Есүс өчигдөр, өнөөдөр ч хэвээрээ бөгөөд мөнхөд хэвээрээ’ (Еврей 13:8) гэсэн байдаг. Эзэн Есүсийн нэр өөрчлөгдөж болохгүй. Хэрвээ Эзэн одоо ирвэл бас л Есүс гэгдэх ёстой. Төгс Хүчит Бурхан гэж яаж болдог юм бэ? Би үргэлж Эзэн Есүсийн нэрээр залбирч, тэр нэрийг дуудаж ирсэн байж, өөр нэрээр залбирч яаж болох юм бэ?” гэлээ. Дараа нь Чэнь ах надад Бурханы үгийн хоёр хэсгийг явуулсан юм: **“Бурхан хувиршгүй гэж хэлдэг хүмүүс бий. Тэр зөв, гэхдээ энэ нь Бурханы зан чанар болон мөн чанарын хувиршгүй байдлыг хэлдэг. Түүний нэр болон ажилд гарсан өөрчлөлт нь Түүний мөн чанар өөрчлөгдсөн гэдгийг нотолдоггүй; өөрөөр хэлбэл, Бурхан үргэлж Бурхан байх бөгөөд энэ нь хэзээ ч өөрчлөгдөхгүй. Хэрвээ чи, Бурханы ажил өөрчлөгдөшгүй гэж хэлбэл зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөгөө Тэр дуусгаж чадах байсан уу? Бурхан үүрд өөрчлөгдөшгүй гэдгийг л чи мэднэ, гэхдээ Бурхан үргэлж шинэ, хэзээ ч хуучин биш гэдгийг чи мэдэх үү? Хэрвээ Бурханы ажил өөрчлөгдөшгүй юм бол Тэр хүн төрөлхтнийг өнөөг хүртэл удирдаж чадах байсан гэж үү? Хэрвээ Бурхан хувиршгүй юм бол Тэр яагаад хоёр эрин үеийн ажлыг аль хэдийн хийчихсэн юм бэ?... ‘Бурхан үргэлж шинэ агаад хэзээ ч хуучин биш’ хэмээх үг нь Түүний ажлыг хэлдэг бөгөөд ‘Бурхан хувиршгүй’ хэмээх үг нь Бурханд төрөлхөөсөө юу байгаа, Тэр юу болохыг хэлдэг. Ямартай ч чи зургаан мянган жилийн ажлыг ганц зүйлд хамааруулж болохгүй, эсвэл үхмэл үгээр хязгаарлаж болохгүй. Энэ нь хүний тэнэглэл юм. Бурхан хүний төсөөлдөг шиг энгийн биш бөгөөд Түүний ажил аль нэг эрин үед саатаж болохгүй. Жишээ нь, Ехова гэдэг нэр үүрд Бурханы нэр байж болохгүй; Бурхан Өөрийн ажлыг Есүсийн нэрээр ч бас хийж чадна. Энэ бол Бурханы ажил үргэлж урагш ахиж байдгийн тэмдэг билээ”** (“Үг нь махбодоор илэрсэн” ном).



---

Үүнийг уншсаны дараа Чэнь ах ингэж нөхөрлөлөө: “‘Бурхан хувиршгүй’ гэх үг нь Бурханы зан чанар, мөн чанарыг хэлдэг. Харин Бурханы нэр хэзээ ч өөрчлөгдөж болохгүй гэсэн үг биш. Бурхан үргэлж шинэ байдаг, хэзээ ч хуучин байдаггүй. Бурханы ажил ямагт гагцхүү урагшилж, ажлыг нь даган Түүний нэр өөрчлөгддөг. Гэхдээ Бурханы нэр яаж ч өөрчлөгдлөө гэсэн зан чанар, мөн чанар нь хэзээ ч өөрчлөгддөггүй. Бурхан үүрд Бурханаараа байдаг, энэ л хувиршгүй юм.” “Бид ‘Бурхан хувиршгүй’ гэж юуг хэлдгийг ойлгохгүй, бас Бурханы ажил үргэлж шинэ байж, хэзээ ч хуучин байдаггүйг ойлгохгүй бол Бурханы ажлыг өөрсдийнхөө үзэлд үндэслэн хязгаарлаж, бүр Бурханыг эсэргүүцэж, шүүх гээд байдаг.” “Фарисайчууд судартай зууралдаж, Мессиаг хүлээсэн. Гэхдээ Эзэн ирэхдээ Мессиа биш Есүс гэх нэртэй байсан болохоор Эзэнийг үгүйсгэж, ялласан. Түүний үг, ажил эрх мэдэл, хүч чадалтайг мэддэг байсан хэрнээ тэд судлаагүйгээр зогсохгүй, эсэргүүцэж, ялласан. Эцэстээ тэд ромчуудтай хуйвалдан Есүсийг загалмайд цовдолж, аймшигт харгислал үйлдсэн юм.” “Хэрвээ бид одоо Библийг зууралдаж, Есүсийн нэр хэзээ ч өөрчлөгдөж болохгүй, Тэр л аврагч гэж итгээд эцсийн өдрүүд дэх Төгс Хүчит Бурханы ажлыг үгүйсгэж, яллах юм бол яг л фарисайчууд шиг болох биш үү? Тэгвэл бид Бурханыг эсэргүүцэж, Бурханы зан чанарт халдах эрсдэлтэй” гэлээ.

“Эзэн Есүс өчигдөр, өнөөдөр ч хэвээрээ бөгөөд мөнхөд хэвээрээ” гэж Библид хэлсэн байдаг нь Бурханы зан чанар, мөн чанарыг л хэлж байгаагаас биш, Бурханы нэр хэзээ ч өөрчлөгдөж болохгүй гэсэн үг биш гэдгийг би эцэст нь ойлгосон юм. Пасторууд үзэл, төсөөлөлдөө үндэслэн номлож, Библийг ч төдийлөн ойлгодоггүй гэдгийг олж харлаа.

Дараа нь Чэнь ах надад Бурханы үгийн хоёр хэсгийг уншиж өгсөн: “**Эрин үе бүрд Бурхан шинэ ажил хийж, шинэ нэрээр нэрлэгддэг; Тэр яаж өөр өөр эрин үед адилхан ажил хийж чадах юм бэ? Тэр яаж хуучинтай зууралдаж чадах юм бэ? Есүсийн нэрийг золин авралын төлөө авсан, иймээс эцсийн өдрүүдэд эргэж ирэх үедээ Тэр адилхан нэрээр нэрлэгдсээр байх уу? Тэр золин авралын ажлыг хийсээр байх уу? Ехова, Есүс хоёр нэг атлаа яагаад өөр өөр эрин үед өөр нэрээр нэрлэгддэг юм бэ? Тэдний ажлын эрин үе ялгаатайгаас болдоггүй гэж үү? Ганц нэр Бурханыг бүхэлд нь төлөөлж чадах уу? Тийм болохоор Бурхан өөр өөр эрин үед өөр нэрээр нэрлэгдэх ёстой бөгөөд эрин үеийг өөрчилж, эрин үеийг төлөөлөхийн тулд нэр ашиглах ёстой. Учир нь нэг ч нэр Бурханыг Өөрийг нь бүрэн төлөөлж чадахгүй бөгөөд нэр болгон тухайн эрин үе дэх цаг хугацааны талын Бурханы зан чанарыг л төлөөлж чаддаг; энэ нь Түүний ажлыг төлөөлдөг байхад л хангалттай. Тиймээс бүхий л эрин үеийг төлөөлөхийн тулд Бурхан Өөрийн зан чанарт тохирох ямар ч нэрийг сонгож болно.**” “‘Ехова’ бол Израил дахь ажлынхаа үед Миний авсан нэр бөгөөд хүнийг өрөвдөж, хүнийг харааж, хүний амьдралыг замчилж чаддаг израилчуудын (Бурханы сонгосон хүмүүс) Бурхан

---

гэсэн утгатай юм. Энэ нь агуу хүч чадлыг эзэмшсэн, мэргэн ухаанаар дүүрэн Бурхан гэсэн утгатай. ‘Есүс’ бол Иммануел бөгөөд хайраар дүүрэн, энэрлээр дүүрэн, хүнийг золин авардаг нүглийн тахил гэсэн утгатай юм. Тэр Нигүүлслийн эрин үеийн ажлыг хийсэн, Нигүүлслийн эрин үеийг төлөөлдөг ба удирдлагын төлөвлөгөөний нэг хэсгийг л төлөөлж чадна... Нигүүлслийн эрин үеийн хүмүүст дахин төрж, аврагдах боломж олгохын тулд Есүс гэх нэр бий болсон бөгөөд энэ нь бүхий л хүн төрөлхтний золин авралын төлөөх онцгой нэр юм. Иймээс Есүс хэмээх нэр золин авралын ажлыг төлөөлж, Нигүүлслийн эрин үеийг илэрхийлдэг. Ехова хэмээх нэр нь хуулийн дагуу амьдарч байсан Израилийн ард түмний төлөөх онцгой нэр юм. Эрин үе, ажлын үе шат болгон дахь Миний нэр ул үндэсгүй биш, харин бэлгэдлийн ач холбогдлыг агуулдаг: Нэр болгон нэг эрин үеийг төлөөлдөг. ‘Ехова’ нь Хуулийн эрин үеийг төлөөлдөг бөгөөд Израилын ард түмний шүтэн мөргөдөг Бурханыг хүндэтгэсэн нэр юм. ‘Есүс’ нь Нигүүлслийн эрин үеийг төлөөлдөг ба Нигүүлслийн эрин үед золин аврагдсан бүх хүний Бурханы нэр билээ. Хэрэв хүн эцсийн өдрүүдэд бас л Аврагч Есүсийг ирээсэй гэж хүсэн хүлээж, Түүнийг мөн л Иудейд байсан төрхөөрөө ирнэ гэж бодвол бүхэл бүтэн зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө Золин авралын эрин үед зогсож, цаашид ахин дэвших боломжгүй болох байлаа. Түүнчлэн эцсийн өдрүүд хэзээ ч ирэхгүй, эрин үе хэзээ ч төгсөхгүй байх байв. Аврагч Есүс зөвхөн хүн төрөлхтний золин аврал болон авралын төлөө байдаг учраас тэр юм. Нигүүлслийн эрин үе дэх бүх нүгэлтний төлөө Би Есүс хэмээх нэрийг авсан бөгөөд бүхий л хүн төрөлхтнийг төгсгөлд аваачих нэр минь энэ биш” (“Үг нь махбодоор илэрсэн” ном).

Тэгээд Чэнь ах ингэж нөхөрлөлөө: “Бурханы удирдлагын төлөвлөгөө гурван эрин үед хуваагддаг. Бурхан эрин үе болгонд ажлын нэг үе шатыг хийж, зан чанарынхаа нэг хэсгийг илэрхийлдэг. Эрин үе болгонд авдаг нэр нь тухайн эрин үе дэх Бурханы ажил, зан чанарыг төлөөлдөг ч Бурханыг бүхэлд нь төлөөлж чадахгүй. Хуулийн эрин үед Бурхан Ехова гэх нэртэй байсан. Энэ нэр Хуулийн эрин үе дэх Бурханы ажлыг, мөн Бурханы зан чанарын сүр жавхлан, уур хилэнт, өршөөнгүй, хараалт талыг төлөөлсөн. Бурхан хууль, тушаал тунхаглаж, газар дээрх хүмүүсийн амьдралыг удирдахад Ехова гэх нэрийг ашигласан. Хүмүүсийн зан авир журамлагдаж, хүн бүр Бурханыг яаж шүтэн мөргөхөө мэдсэн. Гэхдээ тэр эрин үеийн төгсгөлд хүмүүс Сатаны завхралд улам бүр өртсөөр хууль, тушаалыг дагаж мөрдөж чадахаа больсон. Хүн болгон яллагдаж, үхэх аюулд байсан юм. Хүнийг хуулиас аврахын тулд Бурхан Есүс гэх нэрээр махбод болж, золин авралын ажил хийж, Нигүүлслийн эрин үеийг эхлүүлэн, Хуулийн эрин үеийг төгсгөсөн. Эзэн Есүс гэмшлийн замыг өгч, өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг үлдэн хөөж, хүмүүсийн нүглийг уучилсан. Бас Бурханы өршөөнгүй, хайр энэрэлт зан чанарыг илэрхийлж, эцэст нь

---

цовдлогдоод бүх хүн төрөлхтнийг золин аврах ажил гүйцэлдсэн. Есүсийг Аврагчаа гэж хүлээн зөвшөөрч, Түүний нэрээр залбирч, нүглээ улайж, гэмшдэг хүн бүхэн нүглээ уучлуулж, Эзэний хайрласан амар амгалан, баяр баяслыг олж авч чаддаг. Эзэн Есүс золин авралын ажил хийсэн болохоос эцсийн өдрүүдэд хүн төрөлхтнийг шүүж, цэвэрлэх ажил хийгээгүй учраас итгэлээр бидний нүгэл уучлагддаг ч нүгэлт уг чанар маань хэвээр үлддэг. Бид одоо ч нүгэл үйлдэж, нүглээ улайдаг ёрын тойрогт амьдардаг. Цаг үргэлж худал хэлж, хууран мэхэлсээр, ертөнцийн хандлага хөөцөлдөж, атаархаж, үзэн яддаг гэх мэт. Бид нүгэлд амьдран, үүнээсээ ангижрах хүчин мөхөстдөг. Тийм болохоор биднийг нүглийн хүлээсээс бүрмөсөн аварч, цэвэрлэж, Бурханы хаанчлалд ороход тохиромжтой болгохын тулд Бурхан шүүж, цэвэрлэх ажил хийхээр эцсийн өдрүүдэд дахин нэг удаа махбод болоод Хаанчлалын эрин үеийг эхлүүлж, Нигүүлслийн эрин үеийг төгсгөж, нэр нь бас Төгс Хүчит Бурхан болж өөрчлөгдсөн. Үүгээр Илчлэл дэх дараах зөгнөлүүд яг биелдэг: **“Би бол байгаа, байсан мөн хожим ирэх Төгс хүчит Альфа ба Омега, Эхлэл ба Төгсгөл”** гэж Эзэн айлдав’ (Илчлэл 1:8). **‘Ялагчийг Би Өөрийн Бурханы сүмдээ багана болгоно, тэр цаашид тэндээс гарахгүй: Би түүн дээр Өөрийн Бурханы нэрийг, тэнгэрээс Миний Бурханаас ирсэн Миний Бурханы хотын нэр болох шинэ Иерусалимыг бичнэ: Би түүн дээр Өөрийн шинэ нэрийг бичнэ’** (Илчлэл 3:10–12).”

Миний нүд нээгдэж, эцсийн өдрүүдэд Эзэн нэрээ өөрчилдөг гэдгийг олж харсан! Эдгээр эшлэлийг би урьд нь уншиж байсан мөртөө яагаад ойлгоогүй юм бол? Эзэн эцсийн өдрүүдэд дахин ирэхдээ Төгс Хүчит Бурхан гэх шинэ нэртэй болохыг эдгээрт тодорхой зөгнөсөн байна. Гэтэл би, “Эзэн Есүс өчигдөр, өнөөдөр ч хэвээрээ бөгөөд мөнхөд хэвээрээ” (Еврей 13:8) гэдэгт үргэлж итгээд, Есүсийн нэр хэзээ ч өөрчлөгдөж болохгүй гэж шийдсэн байж. Тэгээд эцсийн өдрүүд дэх Бурханы ажлыг анхнаас нь голж, эсэргүүцсэн. Би маш мунхаг байж шүү! Бурхан шинэ ажил эхлэх бүрдээ шинэ нэр авдаг, бас эрин үеийг өөрчилж, тухайн эрин үе дэх ажил, зан чанараа төлөөлүүлэхэд тэр нэрээ ашигладгийг би тэгэхэд мэдэж авч, эрин үе болгонд Бурханы авдаг нэр гүн гүнзгий ач холбогдолтойг ухаарсан юм. Хэрвээ би, Бурханы нэр өөрчлөгдөж болохгүй, Бурхан эцсийн өдрүүдэд Есүс болж ирнэ гэх үзлээ дагасан бол Бурханы ажил яаж урагшлах болж байна? Үргэлж л Нигүүлслийн эрин үе байх биш үү? Үүнийг ухаараад, Төгс Хүчит Бурхан гэх эцсийн өдрүүд дэх Бурханы шинэ нэрд огт эргэлздэггүй болсон.

Дараа нь Чэнь ах надад Бурханы үгийн нэг хэсгийг уншиж өгсөн. Төгс Хүчит Бурхан ингэж хэлсэн байдаг: **“Намайг нэг үе Ехова гэдэг байсан. Түүнчлэн Мессиа гэж дууддаг байсан ба хүмүүс хайрлаж хүндэлсэндээ Аврагч Есүс гэж нэг үе нэрлэсэн. Гэвч өнөөдөр Би өнгөрсөн үед хүмүүсийн мэддэг байсан Ехова юм уу Есүс биш, харин эцсийн өдрүүдэд эргэж ирсэн Бурхан, энэ эрин үеийн төгсгөлийг авчрах Бурхан**

---

билээ. Би бол газрын мухраас өндийн босож, Өөрийн бүх зан чанараар бялхдаг, эрх мэдэл, нэр төр, алдар суугаар дүүрэн Бурхан Өөрөө билээ. Хүмүүс Надтай хэзээ ч харьцаж байгаагүй, Намайг хэзээ ч мэдэж байгаагүй бөгөөд Миний зан чанарыг хэзээд мэдэхгүй байсаар ирсэн. Дэлхийг бүтээснээс эхлээд өнөөдрийг хүртэл нэг ч хүн Намайг хараагүй. Энэ бол эцсийн өдрүүдэд хүнд харагддаг атлаа хүмүүсийн дунд нуугдаж байдаг Бурхан билээ. Тэрээр хүмүүсийн дунд үнэн, бодитоор амьдран суудаг ба төөнөх нар, дүрэлзэх гал адил хүч чадлаар дүүрч, эрх мэдлээр бялхан байдаг. Миний үгээр шүүгдэхгүй ганц ч хүн, нэг ч зүйл байхгүй, дүрэлзэх галаар ариусгагдахгүй ганц ч хүн, нэг ч зүйл байхгүй. Яваандаа бүх үндэстэн Миний үгээс болоод ерөөгдөнө, мөн Миний үгээс болж бут ниргүүлнэ. Энэ маягаар, эцсийн өдрүүдэд бүх хүн Намайг эргэж ирсэн Аврагч гэдгийг, бүх хүн төрөлхтнийг байлдан дагуулдаг Төгс Хүчит Бурхан гэдгийг, бас нэгэнтээ хүний төлөөх нүглийн тахил байсан боловч эцсийн өдрүүдэд мөн бүх зүйлийг шатаах нарны дөл, бүх зүйлийг илчлэх зөвт байдлын Нар болдгийг минь харна. Эцсийн өдрүүдийн Миний ажил энэ юм. Би бол зөвт Бурхан агаад төөнөх нар, дүрэлзэх гал гэдгийг бүх хүнд харуулахын тулд энэ нэрийг авч, энэ зан чанарыг эзэмшсэн юм. Ингэснээр цорын ганц жинхэнэ Бурхан болох Намайг бүх хүн шүтэн мөргөж, тэгснээрээ тэд Миний жинхэнэ царайг харах юм: Би бол зөвхөн израилчуудын Бурхан биш, мөн зөвхөн Золин аврагч биш, харин тэнгэр, газар, тэнгис далай даяарх бүх бүтээлийн Бурхан билээ” (“Үг нь махбодоор илэрсэн” ном).

Дараа нь Чэнь ах ингэж нөхөрлөлөө: “Эцсийн өдрүүдэд Төгс Хүчит Бурхан Хаанчлалын эрин үеийн шүүлтийн ажлыг эхлүүлж, хүн төрөлхтнийг цэвэрлэж, аврахад хэрэгтэй бүх үнэнийг илэрхийлж, хүнийг аврах Бурханы удирдлагын ажлын нууцыг илчилж, Сатан хүн төрөлхтнийг завхруулсан гэх үнэнийг болон хүн нүгэл үйлдэж, Бурханыг эсэргүүцдэгийн уг үндсийг ил болгодог. Төгс Хүчит Бурхан завхарсан хүн төрөлхтний тэрслүү, зөв шударга бус байдлыг шүүж, зан чанараа өөрчлөх замыг үгээрээ хүмүүст харуулдаг. Төгс Хүчит Бурханы нэрийг хүлээн зөвшөөрч, Бурханы үгийн шүүлт, гэсгээлт, шалгалт, цэвэршүүлэлтийг туулдаг, нүглээс ангижирч, цэвэрлэгддэг бүх хүн агуу гамшгаас амьд үлдэнэ. Бурхан ерөөл, амлалтаа эдлүүлэхийн тулд тэднийг хаанчлалдаа оруулна.” “Эцсийн өдрүүд дэх Төгс Хүчит Бурханы ажлыг хүлээн зөвшөөрдөггүй, Түүнийг эсэргүүцэж, яллаж, доромжилж, гүжирддэг ёрын муу хүмүүс, антихристүүд, үл итгэгчид агуу гамшигт уйлж, шүдээ хавирч, Бурхан тэднийг устгана. Бурхан ямар ч зөрчлийг хүлцдэггүй зөвт, сүр жавхлант зан чанартайгаар хүнд үзэгдэж, хүмүүсийг бүрмөсөн цэвэрлэж, аварч, биднийг сатанлаг завхарсан зан чанараас маань ангижруулж, хаанчлалдаа оруулахын тулд эцсийн өдрүүдэд Төгс Хүчит Бурхан гэх нэр авсан. Бас

---

Бурхан хүн бүрийг төрлөөр нь ангилж, энэ ёрын муу эрин үеийг эцэслэж, улмаар хүнийг удирдаж, аврах бүхий л 6,000 жилийн ажлаа дуусгадаг.” “Энэ нь бас, Бурхан бүгдийг бүтээж, захираад зогсохгүй хүн төрөлхтнийг замчлахын тулд үг хэлж ,ажиллаж чаддаг гэдгийг хүн болгонд харуулахын төлөө байдаг. Тэр хүний төлөө нүглийн тахил болж, хүнийг цэвэрлэж, төгс болгож чаддаг. Бурхан бол Эхэн ба Эцэс. Бурханы гайхалтай үйл хэрэг, төгс хүчин, мэргэн ухааныг хэн ч ухан ойлгож чадахгүй. Хаанчлалын эрин үед Тэр Төгс Хүчит Бурхан гэх нэр авдгийн ач холбогдол энэ юм.” “Эцсийн өдрүүд дэх Бурханы ажлыг хүлээн зөвшөөрч, Төгс Хүчит Бурханы нэрээр залбирч, үгийг нь уншдаг бүхэн Ариун Сүнсний ажил болон амийн усны хангалт авч чаддаг. Гэхдээ Нигүүлслийн эрин үеийн чуулганууд дахь өнөөгийн эзгүйрэл урьд хожид үзэгдээгүй. Итгэгчдийн итгэл хөрж, номлогчид ярих юмгүй болж, залбирах үед хэний ч сэтгэл хөдлөхгүй байна. Улам олон хүн ертөнцийн чиг хандлагад уруу татагдаж байна. Тэд Хурганы мөртэй хөл нийлүүлээгүй, бас Төгс Хүчит Бурханы шүүлтийн ажлыг хүлээн зөвшөөрөөгүй болохоор амийн усны хангалтыг олж авч чаддаггүйгээс энэ үүдэлтэй. Тэд тусламж гуйх газаргүй болж харанхуйд унадаг” гэсэн.

Төгс Хүчит Бурхан, Ехова, Есүс бүгд нэг Бурхан гэдгийг Чэнь ахын нөхөрлөл надад харуулсан юм. Энэ нь, Бурхан өөр өөр эрин үед өөр өөр ажил хийхээр янз бүрийн нэр авч байгаа л төдий. Гэхдээ Бурханы нэр яаж ч өөрчлөгдлөө гэсэн ялгамж чанар, мөн чанар нь хэзээ ч өөрчлөгддөггүй. Бурхан Бурханаараа л байдаг. Гүйцээ. Эрин үе болгон дахь Бурханы нэр ач холбогдолтой. Ялангуяа Бурхан Хаанчлалын эрин үед Төгс Хүчит Бурхан гэх нэр авч, Бурханы гэрээс эхлэн шүүлтийн ажил хийж байгаа нь бид нүглээс ангижирч, Бурханаар аврагдахад амин чухал! Би олон жил цуглаан, номлол дээр огт хангалт авалгүй явснаа бодлоо. Ах эгч нарын итгэл суларч, номлогчид ярих юмгүй болсон байсан. Энэ бүгд Ариун Сүнсний ажил урагшилснаас болсон байж. Хурганы мөртэй хөл нийлүүлээгүй, Бурханы өнөөгийн үгийн хангалтыг хүртээгүй болохоор бид харанхуйд унасан байсан юм. Тэр мөчид би, Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс мөн гэдэгт бат итгэж, Төгс Хүчит Бурханыг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн юм даа. Тэр үеэс хойш би өдөр болгон Төгс Хүчит Бурханы нэрээр залбирч, Түүний үгийг уншдаг болсон. Тэгээд амийн усаар услуулж, Хурганы найрт оролцсон юм. Төгс Хүчит Бурханд талархъя!

## **16. Бурханы үг бол миний хүч чадал**

Жинниань, Канад

Би хүүхэд ахуй цагаасаа гэр бүлийнхнээ даган Эзэнд итгэж, үргэлж Библи уншин,

---

цуглаанд оролцдог байлаа. Гэрлэснийхээ дараа би Эзэн Есүсийн сайн мэдээг хадам ээждээ дамжуулсан бөгөөд тэр цагаас эхлээд хадам ээж аливаа зүйл тохиолдоход уур уцаарт автах юм уу урьдынх шигээ дур зоргоороо аашлахаа больж, гэр бүлийн маань харилцаа тэр чигтээ сайжирч эхэлсэн билээ. Ээжид нь гарсан өөрчлөлтийг хараад нөхөр минь ч бас 2015 онд Эзэнд итгэж эхэлсэн бөгөөд надтай хамт долоо хоног бүр чуулган руу явдаг байв. Эзэний сайн мэдээг хүлээн авсны дараа гэр бүлийнхэн маань амар амгалан байхыг хараад энэ нь Эзэний нигүүлсэл мөн болохыг би мэдэж, Эзэнд зүрх сэтгэлийнхээ гүнээс талархсан юм.

2017 оны 2-р сарын нэгэн өдөр ажил дээрээ байхад үйлчлүүлэгч эмэгтэй намайг хараад сэтгэл нь ихэд хөдлөв. Тэр намайг татан, “Та манай найзтай их адилхан харагдлаа. Би таныг найзтайгаа танилцуулж болох уу? Тэр маань Канадад дөнгөж ирээд, найз нөхөдгүй байгаа юм, тэгэхээр танд цаг зав байгаа бол түүнтэй уулзаж ярилцвал сайн байх сан” гэлээ. Би үүнийг сонсоод үнэхээр гайхширч, “Ийм зүйл байж болно гэж үү? Найз нь надтай үнэхээр тийм их адилхан юм байх даа?” гэж бодов. Гэхдээ бүх зүйлд Эзэний сайн санаа зорилго байдаг бөгөөд хайрын сэтгэлээр бусдад туслах нь Эзэний бас нэг сургаал юм гэдгийг ухаарсан учраас би түүний хүсэлтийг хүлээж авав. Хэд хоногийн дараа би түүний найз Шиао Ханьтай уулзлаа. Хань надтай үнэхээр адилхан харагдаж байв; бид хоёрыг харсан хүмүүс ихэр юм уу гэж асууж байлаа. Бид их адилхан харагддагаас болсон уу, эсвэл аливаа зүйлийн цаана Эзэний зохицуулалт байснаас болсон уу мэдэхгүй юм, гэхдээ түүнийг хараад надад тэр даруй маш дотно санагдав. Түүнтэй хэд хэдэн удаа уулзсаны дараа бид юугаа ч ярьж болох эгч дүүс шиг болсон байлаа. Намайг хамгийн их гайхшируулсан зүйл гэвэл Шиао Ханиар дамжуулан би эцсийн өдрүүдэд эргэн ирсэн Эзэн Есүсийн сайн мэдээг сонссон явдал байв.

Нэгэн өдөр Шиао Хан намайг авга эгчийнхээ гэрт аваачсан ба эгч нь Төгс Хүчит Бурханы хаанчлалын сайн мэдээг бид хоёртой хуваалцсан юм. Тэрээр эцсийн өдрүүдэд Бурханы айлдсан үгийг биднээр уншуулж, Адам, Еваг бүтээсэн Бурханы хүсэл, хөвөгч авдар бариулахаар Ноаг дуудах үеийн Бурханы бодол, санаа зорилго, Ноагийн цаг үеийн хүмүүсийг устгахдаа Бурханы зүрх сэтгэл хэрхэн өвдсөн тухай болон өөр бусад зүйлийн талаар бидэнд нөхөрлөсөн юм. Бурханы эцсийн өдрүүдийн үгэнд эдгээр нууц бүгд илчлэгдсэн байдаг бөгөөд тэгээгүй бол хэн ч эдгээр нууцыг ойлгож чадахгүй гэж тэр хэлэв. Бурхан Өөрөө л хийдэг бүхнийхээ ар дахь бодол санааг тайлбарлаж чадах учраас би эгчид итгэсэн юм. Бурхан биечлэн үг хэлж, ажиллахаар ирээгүй бол өөр хэн Бурханы бодол, санаа зорилгыг бүрэн дүүрэн тайлбарлаж чадах билээ? Би Бурханы үгэнд ихэд татагдаж, Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүд дэх ажлыг нухацтай судлахаар шийдлээ. Судлах явцдаа би, Библийг уншаад ер ойлгохгүй байсан олон асуултыг хөндсөн бөгөөд

---

Шиао Ханий эгч надад Төгс Хүчит Бурханы үгэнд тулгуурлан хариулт өгч байв. Хариултууд маш бүрэн гүйцэд байсан бөгөөд тодорхой, ойлгомжтой байлаа. Бурханы үгийг унших тусам зүрх сэтгэл дэх төөрөгдөл аажмаар шийдвэрлэгдэж, эцсийн өдрүүдэд Төгс Хүчит Бурхан үгээрээ дамжуулан шүүлтийн ажил хийдэг бөгөөд энэ нь **“Шүүлт Бурханы гэрээс эхэлнэ”** (1 Петр 4:17) хэмээх Библийн зөгнөлийг биелүүлдэг гэдгийг ойлгож авсан юм. Бурханы ажлын энэ үе шат нь Эзэн Есүсийн ажил өргөжиж, гүнзгийрч байгаа хэрэг бөгөөд хүн төрөлхтнийг ариусгаж, аврах Бурханы эцсийн өдрүүд дэх ажлын сүүлчийн үе шат билээ. Хэсэг хугацаанд судалсныхаа дараа би Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс мөн гэдэгт итгэлтэй болж, Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг баяртайяа хүлээн зөвшөөрсөн бөгөөд ах эгч нартайгаа хамт цуглаанд оролцож эхэллээ.

Гурван сар гаруйхны дараа нэгэн өглөө би зуршил болсноороо эгч нартайгаа хамт цуглаан хийж байтал гэнэт гар утас минь дуугарч эхлэв. Утсаа нээгээд, хэн хэгэн хүн миний Айфоноор дамжуулан байршлыг минь тогтоохоор оролдож байна гэх мэдэгдэл харлаа. Би үнэхээр гайхаж, юу болоод байгааг мэдээгүй боловч тэр даруй нөхөр маань надад Ви Чатаар зурвас илгээн “Чи хаана байна?” гэж асуув. Би зурвасыг хараад бага зэрэг тээнэгэлзлээ, учир нь манай нөхөр сар гаруйн өмнө чуулганы цуглаанд яваад ирэхдээ пастор нь Төгс Хүчит Бурханы Чуулганы талаар олон сөрөг зүйл хэлж, итгэгчдийг сонор сэрэмжтэй байж, Зүүний Аянгын хүмүүстэй ямар ч холбоо тогтоохгүй байхыг анхааруулсан талаар надад ярьсан юм. Тухайн үед нөхрийг маань пастор болон ахлагч нь төөрөгдүүлж, тэдний цуу яриа нөхрийг маань Төгс Хүчит Бурханы Чуулганы эсрэг хандуулна гэж би айсан юм. Би үнэнийг илүү ойлгож, Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг тодорхой гэрчилж чаддаг болтлоо нөхөртөө сайн мэдээ түгээхээ хүлээнэхийг хүссэн учраас Төгс Хүчит Бурханы Чуулганы эгч нартай цуглаан хийдэг талаараа нөхөртөө хэлж огт зүрхлээгүй билээ. Үүнийг санаад би нөхөртөө: “Би ажил руугаа явж байна” гэж хариулав. Гэвч энэ талаар дахин бодоод нэг л биш байгааг мэдрэв: “Нөхөр маань энэ цагаар хэзээ ч над руу зурвас явуулдаггүй. Яагаад гэнэт өнөөдөр хаа байгааг минь асууж зурвас явуулж байгаа юм бол? Юу болоод байна аа?”

Тэр орой ажлаасаа гэртээ хариад нөхөр минь ууртай царайлан орон дээр сууж байгааг би олж харав. Нөхөр маань гэртээ нуусан Бурханы үгийн номуудыг минь олчхоод ширээн дээр өрж тавьсан байлаа. Би энэ бүхнийг хараад үнэхээр гайхсан боловч бодох ч завдал өгөлгүй манай нөхөр ингэж асуув: “Чи хэзээнээс Төгс Хүчит Бурханд итгэж эхэлсэн юм бэ? Төгс Хүчит Бурханы Чуулганы талаар интернэтэд маш олон сөрөг мэдээ байна, мэдэхгүй байна уу? Чи өнөөдөр надад худлаа хэлсэн. Өглөө ажил руугаа яваагүй байсан. Хаана байсан юм бэ?” Би бага зэрэг дургүйцэн: “Тэгэхээр өнөө өглөө утасны минь дохио

---

дуугарч эхэлсэн нь чи миний байршлыг тогтоохоор оролдсоноос болсон байх нь ээ!” гэж хариулав. Нөхөр маань: “Өнөө өглөө ажлын завсарлагааны үеэр хаана байгааг чинь мэдмээр байсан болохоор байршлыг чинь хайгаад, хэлсэн газартаа байхгүй байгааг чинь илрүүлсэн юм” гэлээ. Тэгээд дууныхаа өнгийг зөөлрүүлэн, “Төгс Хүчит Бурханд итгэгчид эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондох зааг хязгаарыг тодорхой мөрддөггүй гэж интернэтэд Хятадын засгийн газар хэлсэн байсан, өөр сөрөг мэдээлэл ч бас их байна. Чи тэдэнтэй дахиж холбоо барихгүй байж болох уу? Зүгээр л сүмийн цуглаанд явсан чинь хамаагүй дээр, бас би долоо хоног болгон чамтай хамт явж болно. Чи яагаад тэдэнтэй холбоотой байгаа юм бэ?” хэмээн үргэлжлүүлэв. Нөхөр маань үгээ дуусгаад интернэтэд орж, надад уншуулах гэж Төгс Хүчит Бурханы Чуулганы талаар маш олон сөрөг мэдээлэл олов. Эдгээр ор үндэслэлгүй цуу яриаг уншсанаах дараа би ууртайгаар ингэж хэллээ: “Энэ хүмүүс Төгс Хүчит Бурханы Чуулгантай хэзээ ч, ямар ч холбоотой байгаагүй. Яагаад тэд энэ талаар дэмий чалчиж байгаа юм бэ? Энэ чинь огт ор үндэслэлгүй, цуурхал байна. Ямар ч үнэмшилгүй худал үг, цуу яриа! Өнгөрсөн хэдэн сард би Төгс Хүчит Бурханы Чуулганы ах эгч нартай холбоотой байж, энгийн, сайхан хувцаслан, төв шударга байдлаар ярьж, биеэ авч явдгийг нь харсан. Ах эгч нарын хооронд тодорхой зааг хязгаар байдаг, бас харилцах зарчим ч байдаг. ХКН-ын засгийн газар болон пастор, ахлагчдын тараадаг цуу яриатай тэд огтхон ч адилгүй. Төгс Хүчит Бурханы гаргасан, Хаанчлалын эрин үеийн захиргааны зарлигт ингэж тодорхой хэлсэн байдаг: **‘Хүн ялзарсан зан чанартайгаас гадна сэтгэл хөдлөлтэй байдаг. Ийм болохоор Бурханд үйлчлэх үед эсрэг хүйсийн хоёр гишүүн хоёулхнаа хамт ажиллах туйлаас хориотой. Ийм үйлдэл хийж байгаад баригдсан хэн боловч гарцаагүй хөөгдөнө, хэнийг ч ялгахгүй’** (Үг нь махбодоор илэрсэн номын “Хаанчлалын эрин үед Бурханы сонгосон хүмүүсийн дуулгавартай дагах ёстой захиргааны арван зарлиг”). Бурхан бол ариун, зөвт бөгөөд хүмүүсийн садар самуун авирыг юунаас ч илүүтэй жигшдэг. Иймээс Бурхан Өөрийн сонгосон хүмүүст зориулж хатуу чанд захиргааны зарлиг гаргасан бөгөөд эдгээрийг зөрчсөн хэн боловч чуулганаас хөөгдөнө. Төгс Хүчит Бурханы Чуулганы ах эгч нар Бурханы захиргааны зарлигийг чанд мөрддөг, хэн ч зөрчиж зүрхэлдэггүй. Миний биечлэн харж, туулсан зүйл гэвэл энэ. Төгс Хүчит Бурханы Чуулганы эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондох зааг хязгаар тодорхойгүй байдаг гэдэг нь ХКН-ын засгийн газар болон пастор, ахлагчдын тараасан цуу яриа, гүжирдлэгээс цаашгүй!” Гэхдээ намайг юу ч гэж хэлсэн, нөхөр минь ердөө сонсолгүй, ах эгч нартайгаа цуглаан хийхээ боль гэж шаардсаар байв. Харийн энэ оронд нөхрөөсөө өөр ойр дотно хүнгүй, нөхөртэйгөө маргахыг хүсээгүй учраас нөхрийнхөө хэчнээн тууштай байгааг хараад би сөрөг болж эхэллээ. Нөгөөтээгүүр Хятадад байдаг гэр бүлд маань болон пасторт хэлчих вий гэж би айж байлаа. Тэгвэл улам л их төвөг удах байв. Иймээс цуглаанд битгий яв гэж нөхөр маань шаардах үед би зөвшөөрч, харин гэртээ



---

Бурханы үгийг үргэлжлүүлэн уншмаар байна гэснийг маань нөхөр зөвшөөрөв. Ийнхүү шуурга нэг хэсэгтээ намжлаа.

Бурханы үгийг гэртээ ганцаараа уншихад ойлгохгүй зүйл олон байлаа. Иймээс нөхрөө ажил дээрээ байх үед нь би гар утсаараа эгчтэй холбоо барьсан ба энэ нь эгч нартай хамт цуглаанаа үргэлжлүүлэх боломжийг надад олгосон юм. Мөн нөхөр минь намайг цуглаанд явахыг болиулсан талаар би эгч нарт хэлж, дараа нь нэг эгч надад Бурханы үгийн хэсгийг уншиж өгөв: **“Хүмүүс дээр Бурханы хийдэг ажлын алхам бүрд, гаднаа энэ нь хүмүүсийн хоорондын харилцаа мэт, хүний зохицуулалт, хүний хөндлөнгийн оролцооноос үүдэлтэй мэт харагддаг. Гэвч нүднээс далдуур, ажлын алхам бүр, тохиолдож буй юм бүхэн нь Бурханы өмнө Сатаны тавьсан бооцоо бөгөөд Бурханд гэрчлэл хийхдээ бат зогсохыг хүмүүсээс шаарддаг. Жишээ нь, Иовыг шалгасан үеийг авч үзье: Нүднээс далдуур Сатан Бурхантай мөрий тавьж байсан бөгөөд Иовд тохиолдсон зүйл нь хүмүүсийн үйл хэрэг, хүмүүсийн хөндлөнгийн оролцоо байсан. Та нарт хийдэг Бурханы ажлын алхам бүрийн ард Сатаны Бурхантай тавьсан мөрий байдаг—энэ бүгдийн ард тэмцэл байдаг... Бурхан, Сатан хоёр сүнсний ертөнцөд тулаан хийх үед чи Бурханыг хэрхэн сэтгэл хангалуун болгож, Түүнд хийх гэрчлэлдээ хэрхэн бат зогсох ёстой вэ? Чамд тохиолддог бүхэн асар их шалгалт гэдгийг, мөн Бурхан чамаар гэрчлэл хийлгэх хэрэгтэй болох тэр цаг үеийг чи мэдэх ёстой”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурханыг хайрлах нь л үнэхээр Бурханд итгэж буй хэрэг”). Эгч маань ингэж нөхөрлөлөө: “Төгс Хүчит Бурханыг хүлээн зөвшөөрсний дараахан иймэрхүү зүйлтэй тулгарах үед гаднаа гэр бүл маань бидний замд хөндөлсөж, цуглаанд явуулахгүй байгаа мэт харагддаг ч Бурханы үгээр дамжуулан харах юм бол үүний ард Сатаны үймээн байдаг, энэ бол сүнслэг тулаан юм. Бурхан биднийг аврахыг хүсдэг ч Сатан тийм ч амархан бууж өгөхийг хүсдэггүй тул биднийг үймүүлэхээр Бурханы араас дагаж, Бурханы өмнө очихыг маань болиулахын тулд эргэн тойрны хүмүүсийг ашигладаг. Сатан Бурхантай харилцах хэвийн харилцааг маань сүйрүүлж, биднийг сөрөг, сул дорой болгон, улмаар Бурханыг орхиулж, Бурханаас урвуулж, эцэст нь биднийг Сатаны эзэмшилд эргэн очиж, Бурханаар авруулах боломжоо алдахад хүргэхийг зорьдог. Иймээс бид ялган таних чадвартай болж, аливааг Бурханы үгийн дагуу харж, Сатаны заль мэхийг нэвт харан, Бурханд илүү их залбирч, найдан, Бурханд жинхэнээсээ итгэх ёстой. Тэгвэл бид Бурханы үйлдлийг итгэлээрээ дамжуулан харж чадна.” Бурханы үг болон эгчийнхээ нөхөрлөлийг сонсоод би гэнэт ингэж ухаарлаа: “Сатан намайг үймүүлж, Бурханаас урвуулахын тулд нөхрийг минь ашиглаж байгаа учраас Бурханд итгэж, Бурханыг дагах замд минь манай нөхөр хөндөлсөж байгаа юм байна. Энэ нь Иовын туулсан шалгалттай адил юм. Сатан Иовыг сорихын тулд мэддэг бүх аргаараа оролдсон. Иовыг арвин их эд

---

хөрөнгө, хонь малаа алдахад хүргэж, биеийг нь аймшгийн яр хатгинд бариулсан төдийгүй Иовд саад хийж, дайрч давшлахын тулд найз нөхдийг нь ашигласан. Тэр ч бүү хэл эхнэрийг нь ашиглан Иовыг уруу татаж, Бурханыг хаяулах гэсэн. Сатан Бурханд итгэх Иовын итгэлийг сүйрүүлж, түүгээр Бурханыг үгүйсгүүлж, голуулах гэж хий дэмий горьдон. Сатан үнэхээр ёрын муу, жигшүүртэй юм!” Ингэж бодоод Сатаныг үзэн ядах сэтгэлээр дүүрсэн боловч дараа нь би: “Сатан хэдийгээр Иовыг сүйрүүлэхээр улайран зүтгэсэн боловч Бурханы зөвшөөрөлгүйгээр Иовын аминд хор хөнөөл учруулж хэзээ ч зүрхлэхгүй байх байсан, тэгвэл миний туулж байгаа зүйл ч бас Бурханы гарт байгаа гэсэн үг биш үү? Би Бурханыг үнэхээр хүндэлж, Бурханд найдаж байгаа цагт Сатаны сорилтыг ялахад Бурхан намайг залж чиглүүлэх нь лавтай” гэж бодлоо. Энэ бодол намайг Бурханд улам их итгүүлэн, би гар утсаараа дамжуулан эгч нартайгаа холбоотой үлдэж, цуглаанд үргэлжлүүлэн оролцож, нөхөрлөл хийхээр шийдсэн юм.

Нэг шөнө би утсаа ширээн дээр тавьсан бөгөөд манай нөхөр утсыг минь авч, эгчтэй ярьсан яриаг минь гүйлгээд уншчихна гэж би санасангүй. Нөхөр минь маш ууртайгаар: “Чи тэдэнтэй одоо ч холбоотой байна, тэгээд яриа чинь тухай бүрдээ хоёр цаг үргэлжилсэн байна” гэлээ. Дараа нь нөхөр минь интернэтэд байсан бүр их сөрөг мэдээллээр намайг бөмбөгдөн, янз бүрийн аргаар намайг хянаж эхлэв. Би утсаараа эгчтэй холбогдож чадахаа болилоо. Ингээд би чуулганы амьдралаа дахин алдаж, эгчээс ямар ч тусламж авч чадсангүй. Үүний дараа нөхөр минь интернэтээс олсон цуу яриагаа өдөр бүр над руу илгээж эхэлсэн бөгөөд ах эгч нартайгаа ямар нэг холбоо тогтооход минь саад хийж, үймүүлж байв. Нөхрийнхөө хавчлага, саад тотгортой тулгараад би туйлын хөөрхийлөлтэй болж, өөрийн эрхгүй дахин сул дорой болж эхэллээ. “Төгс Хүчит Бурханд итгэхийг минь манай нөхөр яагаад тэтгэлээ эсэргүүцдэг юм бэ? Би Бурханд л итгэхийг хүсдэг, яагаад энэ ийм хэцүү юм бэ? Би хэзээ ийм их саад тотгоргүйгээр Бурханд итгэж чадах юм бэ? Одоогоос амьдрал минь ийм байх юм гэж үү?” хэмээн би бодов. Ингэж бодоод би нулимс унагахгүйг хичээсэн ч чадаагүй бөгөөд нэн ганцаардаж, арга мухардаж байв. Би цааш яаж үргэлжлүүлэхээ мэдэлгүй, үүнээсээ болоод хэчнээн удаа уйлсныг ч бүү мэд. Зовж байхдаа би Бурханд залбирахаас өөр яаж ч чадсангүй: “Бурхан минь! Нөхрийнхөө хавчлагын өмнө би юу хийхээ мэдэхгүй, үүнийг яаж туулахаа мэдэхгүй байгаа боловч нөхцөл байдал ямар ч байлаа гэсэн, Таны сайн санаа зорилгыг агуулдаг гэдэгт итгэж байна. Намайг залж чиглүүлж, үүнийг туулах итгэл өгөөч гэж Танаас гуйя.”

Гайхалтай нь, залбирч дууссан даруйдаа би Бурханы үгийн хоёр хэсгийг эгчээс хүлээн авав: **“Бурхантай дайсагнаж, Түүний араас мөшгөхдөө Сатаны зорилго бол Бурханы хийхийг хүсдэг бүх ажлыг нурааж, Бурханы олж авахыг хүсдэг хүмүүсийг эзэмдэж, хянах, Бурханы олж авахыг хүсдэг хүмүүсийг бүрмөсөн устгах явдал юм.**

---

Хэрвээ тэднийг устгахгүй бол тэд Сатаны эзэмшилд орж, түүгээр ашиглуулдаг—энэ бол түүний зорилго” (Үг нь махбодоор илэрсэн номын “Цор ганц Бурхан Өөрөө IV”).

**“Чи дотроо Миний зоригийг тээж, итгэдэггүй төрөл төрөгсөдтэйгөө нүүр тулахдаа зарчимтай байх ёстой. Харин чи бас Миний төлөө ямар ч харанхуй хүчинд бууж өгөх ёсгүй. Төгс замаар алхахын тулд Миний мэргэн ухааныг түш; Сатаны хуйвалдаан биелэх боломж бүү олго. Миний дэргэд зүрх сэтгэлээ байлгахад бүх хүчин чармайлтаа гарга, Би чамайг тайтгаруулж, амар амгалан, баяр хөөр авчирна”** (Үг нь махбодоор илэрсэн” номын Христийн эхэн үеийн айлдваруудын “10-р бүлэг”). Бурханы үгийг тунгаан бодоод би Сатаны муу санаа зорилгыг бага зэрэг ялган таних чадвартай болов. Бурхан хүн төрөлхтнийг аврахаар ажилладаг бол Сатан Бурханы ажлыг нурааж, хүмүүсийн төлөө Бурхантай тэмцэлдэхээр тархиа гашилгадаг тул хүмүүсийг төөрөлдүүлж, мэхлэхийн тулд интернэтээр янз бүрийн цуу яриа дэгдээдэг. Мөн аврал хүлээн авахаар Бурханы өмнө очуулахгүй гэсэндээ гэр бүлийг маань ашиглан бидэнд саад хийж, биднийг үймүүлдэг. Манай нөхөр үнэнийг мэдэхгүй байсан учраас Сатаны тараасан цуу ярианд сохорч, мэхлэгдсэн болохоор л итгэлийн минь замд зөрүүдлэн хөндөлсөжээ. Сатан ч бас намайг хүлж, хорлохын тулд сул дорой байдал дээр минь дөрөөлсөн юм. Миний эмзэг цэг бол сэтгэл хөдлөл гэдгийг Сатан мэдэж байсан тул нөхрөө гэх сэтгэлээр минь дамжуулан над руу дайрч давшлан, махан биеийн мэдрэмжид анхаарч, гэр бүлийнхээ эв эеийг хадгалах хүслээсээ болоод Бурханыг дагахаа болиход намайг хүргэж, улмаар үнэн замыг орхиж, Бурханаар авруулах боломжоо алдахад хүргэжээ. Сатан үнэхээр жигшүүртэй юм! Үүний зэрэгцээ, Бурхан намайг үгээрээ тайтгаруулж, Сатаны харанхуйн хүчинд бүү бууж өг хэмээн зоригжуулж, надад хэрэгжүүлэлтийн зам өгч байгааг би мэдэрсэн юм. Бурхан: **“Төгс замаар алхахын тулд Миний мэргэн ухааныг түш”** гэж хэлсэн. Ийм орчинд би Бурхантай хэрхэн хамтран ажиллаж, мэргэн ухаан ашиглан цуглаанд очиж болох вэ? Өнгөрсөн удаад нөхөр минь намайг мөшгөхдөө утсыг минь ашигласан учраас би эгчийн гэрт цуглаанд оролцохоор очиж чадахаа больсон төдийгүй эгчтэй уулзахын тулд утсаа хэрэглэж ч болохгүй гэдгийг санасан боловч худалдааны төвийн суудалтай хэсэгт эгчтэй уулзаж болох байв. Нөхөр маань дахиад асуувал би дэлгүүр хэсэж явсан гэж хэлж болно. Иймээс Бурханы удирдамжтайгаар би эгчтэй дахин уулзаж чадсан юм. Миний бэрхшээлийг ойлгомогцоо эгч Бурханы үгийн талаар надтай нөхөрлөж, намайг тайтгаруулж, зоригжуулсан билээ. Үнэнийг ойлгосны дараа сөрөг байдал минь даруй арилав.

Нэг өдөр би ажлаасаа хариад Бурханы үгийг уншъя гэтэл Бурханы үгийн номуудаа гол төлөв хадгалдаг шургуулга, шүүгээнүүдэд хайгаад хайгаад номоо олсонгүй. Би ихэд сандарч, “Өө яана аа. Нөхөр маань миний номуудыг хаячихсан байж таарлаа. Их хянуур

---

хүн учраас миний олж чадах хогон дунд хаяагүй нь лавтай. Ажил дээрээ аваачиж хаясан бол би номоо яагаад ч олохгүй дээ” гэж бодов. Энэ бодол намайг ихэд тавгүйтүүлж, би яахаа мэдэхгүй байлаа.

Хэд хоногийн дараа нөхөртэйгөө хамт жолооны шалгалт өгөхөөр явах үедээ би эгч нарынхаа нэгтэй тааралдав. Би эгчид Бурханы үгийн номууд минь алга болсныг нууцхан хэллээ. Эгч намайг илүү их залбирч, Бурханд найдаж, дахиад нэгд нэггүй хайж үз гэв. Бурхан бүх зүйлийг хянаж, захирдаг учраас нөхөр минь номуудыг хаясан эсэх нь Бурханы гарт байгаа гэдгийг, мөн төсөөллөөрөө яаран дүгнэлт хийх хэрэггүй гэдгийг эгч хэлэв. Би гэртээ хариад энэ талаар өөр нэг эгчид зурвас бичихэд адилхан зүйл хэлсэн юм. Тэр хоёр хоёулаа ингэж нөхөрлөсөн учраас үүний цаана Бурханы сайн санаа зорилго байх ёстой гэдэгт би итгэлээ. Бурхан надад сануулахаар эгч нарыг минь ашиглаж байв уу? Тэгээд би Бурханы үгийн дараах хэсгийг санав: **“Төгс Хүчит Бурхан бүх зүйл, бүх хэрэг явдлыг захирдаг! Бид зүрх сэтгэлдээ Түүнийг цаг ямагт хүндэлж, сүнсэнд орж, Түүнтэй нөхөрлөж байгаа цагт Тэр эрж хайдаг бүх зүйлийг маань бидэнд үзүүлэх ба Түүний хүсэл бидэнд илчлэгдэх нь гарцаагүй. Тэр үед зүрх сэтгэл маань баяр баясалтай, амар амгалан, бүрэн тодорхой байдалд тайван байх болно”** (“Үг нь махбодоор илэрсэн” номын Христийн эхэн үеийн айлдваруудын “7-р бүлэг”). Хүмүүсийг найдаж, тусламж олж аваг гэж Бурхан үргэлж дэргэд байдгийг би Бурханы үгээс ойлгов. Бид асуудалд орж, гарах гарцгүй болох үедээ Бурханыг чин сэтгэлээсээ дуудаж л байвал Бурхан биднийг гэгээрүүлж, замчлан, бэрхшээлээ даван гарахад маань тусална. Бурханы үгийн гэгээрэл, удирдамжийн ачаар Бурханд итгэх итгэл минь дахин хүчирхэгжиж, би хэрэгжүүлэлтийн замыг буцаан олж авлаа. Мөн Бурханы үгийн номуудаа алга болгосон тухайд бол гагцхүү өөрийнхөө хүчин чармайлтад найдвал номуудаа хэзээ ч олохгүй гэдгийг ойлгов. Бурхан бол бүхнээс хүчирхэг бөгөөд Бурханд найдаж, Бурханыг хүндэлж, дараа нь номуудаа бодитой байдлаар хайхаар Бурхантай хамтран ажиллаж байгаа цагт Бурхан намайг замчилж, надад тусална гэдэгт би итгэлээ. Иймээс би Бурханы өмнө очиж, чин сэтгэлээсээ ийнхүү залбирав: “Бурхан минь! Би Таны үгийн номуудаа олж чадахгүй байна. Эхэндээ би юу болсныг таах гэж өөрийн үзэл, төсөөлөлд найдан, түргэн зангаараа үйлдсэн. Би Таныг бүхнээс дээр тавиагүй бөгөөд бүх зүйл Таны хяналтад байдгийг ухаарсангүй. Одоо би Таныг хүндэлж, энэ асуудлыг Танд даатгаж, дараагийн удаа хайхдаа Тантай хамтран ажиллахыг хүсэж байна. Би номоо олох эсэх нь Таны зөвшөөрлөөр болно. Таны удирдамжийг гуйя.”

Залбирсны дараа гэнэтхэн агуулах орж гутлаа авмаар санагдлаа. Гайхмаар нь, гутлаа авахаар өвдөглөж байгаад би цагаан уут харсан бөгөөд Бурханы үгийн номууд энэ уутанд байгаа гэх тов тодорхой бодол гэнэт санаанд оров. Би уутыг аваад харахад энэ үнэн

---

байлаа! Гайхах, баярлах зэрэгцсэн би: “Бурханд талархъя! Бурханд талархъя!” хэмээн хашхирахгүй байж чадсангүй. Бурхан надаар ном олуулахаар замчилсныг би тэгэхэд ухаарав. Бүх зүйл Бурханы захиралтад байдгийг, тэр ч бүү хэл хүмүүсийн зүрх сэтгэл дэх бодол, санааг хүртэл Бурхан зохицуулдгийг, мөн Бурханд найдаж, Бурханыг хүндэлбэл боломжгүй зүйл гэж үнэндээ байдаггүйг би үнэхээр харсан юм. Үүний дараа би номоо хурдхан унтлагын өрөөнд аваачиж, шургуулгадаа болгоомжтой хийв. Тэр орой нөхөр маань эргэж ирээд агуулахын өрөөнд нуусан Бурханы үгийн номыг олсон гэдгийг маань олж мэдсэн ба тэдгээрийг өөрт нь өгөхийг надаас шаардав. Энэ удаад би Бурханд үнэхээр найдан, надад итгэл, хүч чадал өгөөч гэж Бурханаас гуйн, нөхөртөө цаашид буулт хийхээс татгалзав. Миний шийдэмгий байдлыг хараад нөхөр дахиж шалсангүй.

Дараа нь эгч надад номлол сонсоход зориулсан утас өгсөн ба үүн дээр Бурханы үгийн янз бүрийн номыг татсан байлаа; энэ нь цуглаанд оролцох, сүнслэг үйл ажиллагаа хийхийг минь амарчлах зорилготой байв. Нэг удаа би цүнхээ солих үедээ хайхрамжгүй байдлаасаа болоод тэр утсаа гэрт үлдээсэн бөгөөд цуглаанд дахин явж байгааг нөхөр минь олж мэджээ. Нөхөр маань: “Чи яагаад тэдэнтэй холбоо барьсаар байгаа юм бэ? Яагаад нууцаар цуглаанд яваад байгаа юм бэ?” гэж асуусан зурвас илгээсэн байлаа. Би тэр зурвасыг хараад уурлах, санаа зовох зэрэгцсэн боловч өнгөрсөн хугацаан дахь туршлагаа санаад, нөхөр минь надад саад хийж, хяхаж хавчихаар оролдох болгонд үргэлж буулт хийж, ухарч, сөрөг, сул дорой болдог байснаа болон надад хамгийн их дутагдаж байсан зүйл нь Бурханд найдан, Бурханыг гэрчлэх явдал гэдгийг санах. Энэ удаа Сатанд бууж өгч болохгүй гэдгээ би мэдэж байлаа. Би Бурханд найдаж, Бурханыг хүндэлж, итгэлээр дамжуулан Сатаныг ялан дийлж, Бурханы төлөө гэрчлэлд зогсох байв. Би: **“Хаана, хэзээ байх нь, эсвэл ямар тааламжгүй орчин байх нь хамаагүй, Би чамайг тод хардаг болгох бөгөөд хэрвээ чи зүрх сэтгэлээсээ Надад найдвал Миний зүрх сэтгэл чамд илчлэгдэнэ; энэ маягаар чи урдах замаараа явах бөгөөд хэзээ ч замаа алдахгүй”** (“Үг нь махбодоор илэрсэн” номын Христийн эхэн үеийн айлдваруудын “13-р бүлэг”). гэх Бурханы үгийг бодов. Иймээс би Бурханд ийнхүү залбирлаа: “Бурхан минь! Өнөөдөр Та намайг сонгож, Таны мөрийг дагах боломж олгосон. Хэрвээ би бүх хүчээрээ эрэлхийлэлгүй, Сатаны хүчинд бууж өгвөл аврагдах боломжоо алдана. Өө Бурхан минь! Би одоогийн бэрхшээлээ Танд даатгамаар байна. Төгс Хүчит Бурханд итгэж байгаа талаар нөхөр маань гэр бүлд минь юм уу, пасторт хэлсэн ч бай, эсвэл надад юу ч хийсэн бай, би Танд захирагдана. Энэ удаад би Таны төлөө гэрчлэлд зогсож, Сатаныг шившиглэхийн тулд Танд найдах болно.”

Залбирсны дараа би аажмаар хавьгүй тайвшрав. Тэгээд утсаа аваад, “Тийм ээ, би цуглаанд дахиад явж байгаа. Маргааш орой суугаад энэ талаар нухацтай ярилцацгаая”

---

гэсэн хариуг нөхөртөө илгээв. Энэ зурвасыг явуулмагц зүрх сэтгэлд минь цэвэршүүлэгдэж байгаа мэт санагдсаар байлаа: Үнэнийг нухацтайгаар эрэлхийлэхийг хүсэх бүрд минь яагаад саад тулгардаг юм бэ? Тэгтэл эгчийн олон удаа нөхөрлөж байсан Иовын туршлага санаанд оров. Бас Бурхан ингэж хэлсэн нь бодогдлоо: **“Тэгвэл, Иовыг ийм зовлон шаналалд унасан үед Бурхан юу хийсэн бэ? Бурхан ажиглаж, харан үр дүнг нь хүлээсэн. Бурхан ажиглаж, харж байхдаа юу мэдэрсэн бол? Мэдээжээр, шаналж байсан”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурханы ажил, Бурханы зан чанар ба Бурхан Өөрөө II”). Би Бурханы үгийг тунгааж, Иовын туршлагын талаар бодов. Тэр бүхий л амьдралаа Бурханаас эмээж, муугаас зайлж өнгөрөөсөн боловч Бурхан Иовыг олж авна гэдэгт Сатан баяртай байгаагүй тул Иовыг олон удаа сорьсон билээ. Гэхдээ, Сатан Иовыг сорих үед Бурхан бүхнийг хянаж, ажиглаж байсан бөгөөд Иовын амийг авч болохгүй хэмээх хатуу хязгаарлалтыг Сатанд тавьж, улмаар Иовын аюулгүй байдлыг баталгаажуулсан. Би Бурхан хүмүүсийг нандигнадаг агаад зовоохыг хүсдэггүй, мөн Сатаны нөлөөнд орж, Сатанд хорлуулж байгааг маань харахыг хүсдэггүй гэдгийг харсан юм. Түүнчлэн, Иовыг сорихыг Сатанд зөвшөөрсөн нь Бурханы сайн санаа зорилгыг агуулж байв. Бурхан Иовын гэрчлэлийг олж авч, Бурханд итгэлтэй, дуулгавартай байдлыг нь төгс болгоно гэж найдаж байжээ. Энэ чинь миний одоогийн нөхцөлтэй яг адилхан биш үү? Хэдийгээр Сатан намайг ахин дахин сорьсон боловч Бурхан намайг хэзээ ч орхилгүй, өдий хүртэл замчилсан. Намайг амиа өсгөж, Өөрийнх нь төлөө гэрчлэлд зогсон, Сатаныг шившиглэнэ гэж найдсандаа Бурхан эдгээр орчин нөхцөлийг зохицуулсан тул энэ удаад би Бурханы төлөө гэрчлэлд зогсож, Сатаныг шившиглэхийн тулд тэмцэх ёстой гэдгээ мэдэж байлаа. Би дахин нэг удаа Бурханд илүү их итгэсэн бөгөөд Бурханы зохицуулсан зүйлд захирагдаж, Бурханы талд зогсож, Сатанд дахин хэзээ ч буулт хийхгүй байхаар шийдэв.

Дараагийн өдрийн орой нь ажлаасаа харихад нөхөр минь ирчихсэн, намайг хүлээж байв. Намайг суухад нөхөр минь: “Чи Төгс Хүчит Бурханд итгэхээ больж чадах уу?” гэлээ. Дараа нь нөхөр маань Төгс Хүчит Бурханы Чуулганы тухай, интернэтээс харсан бүх сөрөг мэдээллийнхээ талаар ярьж эхэллээ. Би ингэж хариулсан юм: “Үгүй ээ, би чадахгүй. Төгс Хүчит Бурханы Чуулганы талаар чи үнэндээ юу мэдэх вэ? Интернэтээс харсан бүхэн чинь ХКН-ын засгийн газраас Төгс Хүчит Бурханы Чуулганыг гутааж, нэр төрд нь халдаж, яллахын тулд зохиосон цуу яриа төдий юм. Эдний аль нь ч үнэн биш. ХКН бол бурхангүй үзэлтэй улс төрийн нам бөгөөд ялангуяа үнэн болон Бурханыг үзэн яддаг учраас хүмүүсийг төөрөгдүүлэхийн тулд төрөл бүрийн цуу яриа зохиож, тараахын тулд чадах бүхнээ хийдэг. Тэд хүмүүсийг хуурч Бурханыг эсэргүүцэхэд хүргэн, эцэстээ өөрсөдтэй нь цуг устгагдаасай хэмээн хий дэмий найддаг. Энэ бол ХКН-ын засгийн газрын ёрын муу

---

санаа зорилго юм. Гэхдээ Бурханд итгэснээрээ би ямар ч буруу зүйл хийгээгүй, бас чиний урмыг хугалах зүйл ч хийгээгүй. Миний итгэлийн зам бол амьдралын зөв зам мөн, бас би энэ замаар үргэлжлүүлэн алхана гэж шийдсэн. Би энэ талаар хангалттай бодож үзсэн, тэгээд чамайг пастор, номлогч нар луу утасдаж, номлолоор нь намайг буруутгуулж, чуулганаас хөөлгөж болно гэж шийдсэн. Чи бас манай эцэг эх рүү залгаж, тэднээр намайг доромжлуулж, дарамтлуулж болно. Гэхдээ чамайг юу ч хийлээ гэсэн, миний шийдвэр өөрчлөгдөхгүй. Би одоо Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн зөвшөөрсөн бөгөөд Бурханы үгийг уншиж, Бурханы зохицуулсан нөхцөл байдлыг туулснаар Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс мөн гэдэгт итгэх болсон. Юу ч болсон бай, би сонголтдоо үнэнч байна.” Нөхөр маань: “Чи Эзэнээс урваж байгаагаа мэдэж байгаа, тийм биз? Эзэн чамд ийм их нигүүлсэл хайрласан. Чи яаж Түүнээс урваж чадаж байна аа?” гэж хэлэв. Би: “Төгс Хүчит Бурхан, Эзэн Есүс хоёр бол нэг Бурхан учраас Төгс Хүчит Бурханд итгэнэ гэдэг Эзэнээс урваж байгаа хэрэг бус; энэ нь Хурганы мөрийг дагаж байгаа хэрэг. Би Эзэн Есүсийн нигүүлслийг маш их эдэлсэн учраас л Эзэн Есүс одоо эргээд ирчихсэн гэх мэдээг сонсоод судлах ёстойгоо мэдсэн ба дараа нь хүлээн зөвшөөрсөн. Эзэн Есүс одоо шинэ үг айлдаж, Бурханы ажил болон хүслийг тайлбарлахаар махбодоор эргэн ирээд байна. Би Бурханы дуу хоолойг сонссон тул үүнийг эрэлхийлэхийн төлөө илүү шаргуу ажиллаж, илүү олон цуглаанд явж, намайг гэх Бурханы хайрыг хариулах ёстой” гэж хэлсэн юм. Эцэст нь нөхөр минь: “За за, больж үз! Хүссэнээ л хий! Би пасторт чинь хэлж, чамайг чуулган руу буцаан авчруулах, мөн эцэг эх рүү чинь ч залгах талаар бодсон боловч тэднийг ихэд уурлаад, өвдөх вий гэж айсан юм. Одоогоос эхлээд чи хүссэндээ л итгэ, би оролцохгүй” гэлээ.

Манай нөхөр Төгс Хүчит Бурханд итгэх замд минь дахин хөндөлсөхгүй гэдгийг сонсоод би ихэд баярлав. Энэ нь Бурханы удирдамж бөгөөд нөхрийн минь зүрх сэтгэл, оюун ухаан ч бас Бурханы гарт байгааг би мэдэж байлаа. Нөхөр минь ийм зүйл хэлсэн нь бүхэлдээ Бурханы захиралтаас болжээ; Бурхан л надад гарах гарц нээсэн билээ. Бурхан зүрх сэтгэлийг минь хүсдэг гэдгийг би энэ туршлагаараа дамжуулан харсан бөгөөд Бурханд үнэхээр найдаж, Бурханыг хүндэлж, Бурханыг сэтгэл хангалуун байлгахын тулд бүхнээ эрсдэлд оруулах үедээ би Бурханы үйл хэргийг болон Бурхан намайг чимээгүйхэн чиглүүлж, надад тусалсаар ирснийг хардаг билээ. Би Бурханы дараах үгийг саналаа: “Сатан хүнийг завхруулж, эсвэл хүнд харгис хор хөнөөл учруулах болгонд Бурхан гар хумхин суудаггүй, мөн Өөрийн сонгосон хүмүүсийг үл тоомсорлож, хараагүй дүр үзүүлдэг ч үгүй. Сатаны хийдэг бүхнийг Бурхан тов тодорхой ойлгодог. Сатан юу хийх нь хамаагүй, ямар чиг хандлага бий болгох нь хамаагүй, Сатаны хийхээр оролдож байгаа бүхнийг Бурхан мэддэг ба сонгосон хүмүүсээ хаядаггүй. Харин ч

---

**Бурхан огт анхаарал таталгүйгээр, нууцаар, чимээгүйхнээр, шаардлагатай бүхнийг хийдэг”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Цор ганц Бурхан Өөрөө VI”). Эдгээр үгийг тунгаан бодоод миний сэтгэл үнэхээр хөдлөв. Тэр хугацаанд өөрийнхөө туулсан зүйлийг—Сатан цуглаанд оролцоход минь саад хийж, хяхаж хавчихаар нөхрийг минь ашиглах үед Бурханы үгийн талаарх ах, эгч нарын нөхөрлөлөөр дамжуулан Бурхан надад Сатаны заль мэхийг нэвт харуулж, намайг сөрөг байдлаас гаргасныг би эргээд бодов. Нөхөр минь Бурханы үгийн номуудыг нууж, Бурханд итгэхийг минь болиулахаар оролдох үед би үнэхээр Бурханд найдаж, Бурханыг хүндлэн, дараа нь Бурханы гайхалтай үйл хэргийг харсан юм; би Бурхантай хамт зогсохоор сэтгэл шулуудан, Бурханыг дагахын тулд бүхнээ зориулахыг хүсэх үед Сатан шившиг болж, ухарсан билээ. Бурхан үнэхээр миний хажууд байдаг бөгөөд биеийн хэмжээний минь дагуу надад зориулсан орчин нөхцөлийг зохицуулдаг гэдгийг би туршлагаараа дамжуулан харсан юм. Бурхан надад дааж чадахгүй ачаа өгөөгүй. Урьд нь би зүрх сэтгэлээ Бурханд үнэхээр өгөөгүй байх үедээ гэр бүлийнхнээ гэх хайранд үргэлж анхаарч, асуудлыг зохицуулахдаа хүний арга барилд түшиглэж, Сатаныг хаяж зүрхэлдэггүй байсан бөгөөд үүний үр дүнд Сатан хамгийн сул талыг минь далимдуулж, ашиглаж, над руу удаа дараа дайрч давшилж, эцэс төгсгөлгүйгээр намайг зовоосон тухай би бодлоо. Гэвч Бурханд үнэхээр найдаж, бүхнээ зориулах үед Бурхан надад замыг нээж, Сатан ялагдан шившиглэгдэж, яаж ч чадалгүй үлдсэн. Энэ бүхнийг туулсныхаа дараа би Бурханы төгс хүчин, дээд эрх болон өөрийнхөө тэрслүү зан чанарыг үнэхээр ойлгосон юм. Мөн Бурханд итгэх итгэл, дуулгавартай байдал маань нэмэгдэж, Сатаны заль мэхийг ялган таньдаг болж, Сатаны ёрын муу, жигшүүрт уг чанарыг харав. Тэгээд дотор минь Сатаны эсрэг жинхэнэ үзэн ядалт төрсөн билээ. Бурханы удирдамж, гэгээрлийн ачаар л би энэ бүхнийг ойлгож чадсан юм. Би Бурханд үнэхээр талархаж байна!

Тэрхүү хугацаанд туулсан зүйлээсээ би асар ихийг олж авсан юм. Энэ явцад би сул дорой, сөрөг байсан боловч Бурханы үгийн удирдамж, эгч нарын дэмжлэг туслалцаа надад Сатаны сорилт, дайралтыг ялан гарч, өнөөг хүртэл үргэлжлүүлэх итгэл өгсөн юм. Бодит туршлагаараа дамжуулан би Бурханы хайрыг болон Бурхан намайг чиглүүлж, бүх зүйлийн туршид хажуугаас минь холдоогүй гэдгийг харсан. Бид Бурханд зүрх сэтгэлээ үнэхээр өгч, Бурханыг хүндэлж, Бурханд найдах үедээ гайхалтай үйл хэргийг нь харж, зовлон шаналлаасаа салж чадна. Энэ өдрөөс эхлээд би Бурханы ажлыг илүү их туулж, Бурханы талаар жинхэнэ мэдлэгтэй болохыг хүсэж байна.

## **17. Сатаны чанд бүслэлтээс гарсан нь**



---

Жао Ган, Хятад

Өнгөрсөн 11 дүгээр сард Хятадын зүүн хойд хэсэгт тэсгим хүйтэн болж, газар дээр буусан цас үл хайлж, гадуур явж буй хүмүүс маш их даарснаас гараа сугандаа хавчуулж, нуруугаараа бөгтийн болгоомжтой нь аргагүй алхацгааж байсан билээ. Тэр нэгэн өдөр өглөө эрт хүргэн ах, эгч, арваад ах эгч нарынхаа хамт гэртээ дулаахан орон дээр сууцгааж байхад маань салхи баруун хойноос салхилж байсан юм. Хүн бүхэн хажуудаа Библиэ тавиад, гартаа “Шүүлт Бурханы гэрээс эхэлдэг” гэх ном барьцгаажээ. Төгс Хүчит Бурханы Чуулганы хоёр эгч Бурханы ажлын гурван үе шаттай холбоотой үнэний талаар нөхөрлөж байлаа. Ийнхүү нөхөрлөх явцдаа хоёр эгч ажлын гурван үе шатыг зургаар дүрсэлцгээв: “Хүн төрөлхтнийг аврах Бурханы ажлыг Хуулийн эрин үеэс Нигүүлслийн эрин үе, дараа нь Хаанчлалын эрин үе гэсэн гурван үе шатанд хувааж болно. Ажлын үе шат бүр нь өмнөх үе шатаасаа илүү өндөр, илүү гүн гүнзгий байдаг. Эцсийн өдрүүдэд хийгдсэн ажил бол ажлын эцсийн үе шат бөгөөд энэ үе шатанд Бурхан хүнийг шүүж, цэвэрлэхийн тулд үг илэрхийлдэг...” Бид толгой дохин сонсоцгоож, зүрх сэтгэл маань цэлмэв: Хүн төрөлхтнийг аврах Бурханы удирдлагын төлөвлөгөөнд ийм олон нууц байна гэж хэн бодох вэ дээ! Бурханаас Өөрөөс нь өөр хэн Бурханы ажлын энэ гурван үе шатыг ийм тодорхой ярьж чадах вэ дээ? Энэ үнэхээр Бурханы ажил мөн! Бид дараа өдрийн орой хүртэл үргэлжлүүлэн нөхөрлөсөн бөгөөд бүлгийнхэн маань бүгд Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг эрэлхийлж, судлахыг хүсэж байгаагаа илэрхийлэв.

Үүний дараа хоёр эгч Бурхан бие махбодтой болохын ач холбогдлын талаарх үнэнийг нөхөрлөж, бусад нь анхааралтай сонсож байх үед гэнэтхэн манай чуулганы удирдагч Ван Пин хүрээд ирэв. Тэрээр гэрт оронгуутаа Төгс Хүчит Бурханы Чуулганы хоёр эгчийг хуруугаараа чичлэн: “Энэ хоёр юу хийж байгаа юм бэ?” гэж надаас асуув. “Тэд бол Жан эгч, Му эгч хоёр” гэж би шулуухан хэлэв. Ярьж ч дуусаагүй байтал тэрээр унтууцсан өнгөөр: “Жан эгч, Му эгч гэж хэн юм? Зүүний Аянгын номлогчид гэдгийг нь би харж байна. Тэд бол хонь хулгайлагчид...” гэж хэлэв. Ван Пинийг ярьж дуусахад бид бүгд цочирдон сууж байлаа. “Ван Пин эгч хөршөө өөр шигээ хайрлах талаар, бас дайснаа хайрлах талаар бараг үргэлж ярьдаг мөртлөө яагаад өнөөдөр энд ирж ийм үндэслэлгүй зүйл хэлдэг билээ? Яагаад энэ хоёр эгчийг шүүж, яллаж байгаа юм бол?” гэж би дотроо бодов. Намайг ийнхүү бодож байтал Жан эгч Ван Пинд хандан: “Эгч ээ, өнөөдөр бид энд ирсэнд ямар нэг далд санаа зорилго байхгүй. Эзэн Есүс хэдийнээ эргэн ирсэн. Бид ердөө Бурханы эцсийн өдрүүдийн сайн мэдээг түгээхийг л хүсэж байна” гэж хэлтэл Ван Пин Жан эгчийн яриаг таслан: “Эзэний эргэн ирсэн гэнэ ээ? Удирдагчаар ажиллаж буй бид хүртэл Эзэний эргэн ирэлтийн талаар юу ч мэдээгүй байхад та нар энэ тухай яаж мэдэх юм бэ? Энэ боломжгүй! Эзэн Есүс: **‘Надаас өмнө ирсэн бүхэн хулгайч, дээрэмчид юм:**

---

**харин хонин сүрэг тэднийг сонсоогүй’** (Иохан 10:8) гэсэн байдаг. Та хоёр хоёулаа яг одоо яв, дахиад энд хэзээ ч бүү ир” гэж хашхирав. Ван Пинг ингэж хэлэхэд би дотроо зэвүүцэж: Эгчийн номлол үргэлж ухаалаг, үндэслэлтэй байдаг мөртөө яагаад гэв гэнэт ийм энэрэлгүй болж чадав аа? гэж бодов. Тэгээд би Ван Пинд хандан: “Ван эгч ээ, орой болчихлоо шүү дээ. Та тэднийг хаашаа яв гээд байгаа юм бэ? Эзэн бидэнд дайснаа хайрлах ёстой гэж заадаг, Бурханд итгэдэг энэ хоёр эгчийн тухайд бол хэлэх ч хэрэггүй. Хэрэв бид энэ хоёр эгчид ийм маягаар хандвал Эзэнд итгэгчидтэй огт адилгүй байх болно” гээд хэлэх зүйлээ хэлж ч дуусаагүй байхад Ван Пин хүргэн ахын маань эхнэрийн гарыг санаа зовсон байдалтай атган, түүнд болон нөхөрт нь хандан: “Хэрэв Жао Ган энэ хоёр эмэгтэйд явуулахыг хүсэхгүй байгаа юм бол бүгдээрээ явцгаая. Тэднийг битгий сонс!” гэв. Тэгээд тэр хоёрыг хөтлөн явж одлоо.

Тэднийг явсны дараа Му эгч бидэн рүү эргэж хараад: “Ах, эгч нар аа, дөнгөж сая харсан зүйл чинь ямар санагдаж байна вэ? Бүгдээрээ энэ тухай хэлэлцье!” гэв. Ах, эгч нар бүгд над руу харж, хэн нь ч юу ч хэлсэнгүй. “Эгч ээ, сүүлийн хоёр өдөр Төгс Хүчит Бурханы үгийг уншиж, таны нөхөрлөлийг сонсоод би Төгс Хүчит Бурханы үг бол үнэн гэдэгт, Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс гэдэгт бат итгэж байна. Гэхдээ Ван Пингийн хэлсэн зүйл учир шалтгаангүй зүйл бас биш ээ. Эцсийн эцэст тэр бол бидний удирдагч, бас Эзэнд удаан хугацаанд итгэсэн. Тэр Библийг сайн мэддэг бөгөөд Эзэний төлөө үргэлж завгүй ажиллаж, өөрийгөө зарлагадсан. Хэрэв Эзэн эргээд ирсэн бол тэрээр хамгийн түрүүнд мэдэх ёстой хүн юм” гэж би шулуухан хэлэв. Жан эгч эелдгээр ийнхүү хариулав: “Бурханыг эргэн ирэхэд хамгийн түрүүнд удирдагчид олж мэдэх ёстой бөгөөд дараа нь тэд итгэгчдэд хэлэх ёстой гэж хүмүүс итгэдэг ч ингэж бодох үндэслэл Эзэний үгэнд үнэхээр байдаг гэж үү? Энэ нь үнэн болон Бурханы ажлын баримтуудтай нийцдэг гэж үү? Эзэн Есүс: **‘Миний хонин сүрэг Миний дуу хоолойг сонсдог, Би тэднийг мэддэг бөгөөд тэд Намайг дагадаг’** (Иохан 10:27). **‘Чуулгануудад Сүнс юу айлдаж буйг чихтэй бүхэн сонсогтун’** (Илчлэл 2:7) гэсэн. Ирэх үедээ Тэрээр гарцаагүй үг айлдаж, үнэнийг илэрхийлэх бөгөөд Бурханы дуу хоолойг сонсож, улмаар үүнийг эрэлхийлж, хүлээн зөвшөөрсөн бүх хүн Эзэнийг эргэн ирэхэд угтан авч, Бурханы өмнө өргөгдөнө гэдгийг Эзэн Есүс бидэнд тодорхой хэлсэн байдаг. Эргэн ирэх үедээ энэ тухайгаа аль нэг удирдагчийг гэгээрүүлнэ гэж Эзэн хэлсэн үү? Үгүй, тэгж хэлээгүй. Тиймээс хүмүүсийн ийм үзэл бодол хүмүүсийг зүгээр л төөрөгдүүлж, будилуулдаг бөгөөд хэрэв тэд энэхүү мэдэгдлийн дагуу Эзэн өөрсдийг нь гэгээрүүлэхийг хүлээх юм бол огт идэвхгүйгээр төгсгөл ирэхийг хүлээж байгаа хэрэг юм. Төгс Хүчит Бурханы үгэнд юу гэж хэлснийг харцгаая. Төгс Хүчит Бурхан ингэж хэлсэн: **‘Бурханы шинэ ажил ямар ч байлаа гэсэн, зөгнөлөөр баталгаажих ёстой, мөн ийм ажлын үе шат болгонд Түүнийг “чин”**

---

сэтгэлээсээ дагадаг бүх хүнд бас илчлэл үзэгдэх ёстой; эс бөгөөс тэр ажил Бурханых байж таарахгүй гэж бүр ч олон хүн боддог. Хүний хувьд Бурханыг мэдэж авах нь угаасаа хялбар ажил биш. Үүнээс гадна, хөгийн зүрх сэтгэл, өөрийгөө чухалчилдаг, ихэрхүү тэрслүү уг чанарыг нь харгалзан үзвэл Бурханы шинэ ажлыг хүлээн зөвшөөрөх нь хүний хувьд бүр ч хэцүү билээ. Хүн Бурханы шинэ ажлыг анхааралтай судалдаггүй, төлөв даруухнаар хүлээн зөвшөөрдөг ч үгүй; харин ч Бурханы илчлэл болон удирдамжийг хүлээнгээ басамжилсан хандлага баримталж байдаг. Энэ нь Бурханы эсрэг тэрсэлж, эсэргүүцдэг хүмүүсийн зан авир биш гэж үү? Ийм хүмүүс яаж Бурханы сайшаалыг хүртэж чадах юм бэ? (Үг нь махбодоор илэрсэн номын “Өөрийн үзлээр Бурханыг хязгаарласан хүн Бурханы илчлэлийг хүлээн авч яахан чадах билээ?”). Эзэн ирэх асуудлын тухайд хэрэв хүмүүс өөрсдийн үзэл, төсөөллийг сохроор баримтлан, үнэнийг үл эрэлхийлж, Бурханы дуу хоолойг сонсоход анхаарлаа үл төвлөрүүлж, үүний оронд Бурхан өөрсдийг нь гэгээрүүлэхийг л хүлээвэл Эзэний эргэн ирэлтийг хэзээ ч угтан авч чадахгүй гэдгийг Бурханы үгээс бид ухаардаг. Бурханы дуу хоолойг сонсохыг хичээдэг хүмүүс л Эзэний илрэлтийг угтаж чадна. Үнэн хэрэгтээ, Нигүүлслийн эрин үед Эзэн Есүсийг дагасан хүмүүсийн нэгийг нь ч Бурхан Есүсийг дагахаас нь өмнө гэгээрүүлээгүй юм. Тэд хэн нэгэн Эзэн Есүсийг гэрчилж байхыг сонсоод юм уу Эзэн ярьж, номлол айлдаж байгааг сонсоод Эзэний дуу хоолойг таньсныхаа дараа Түүнийг дагасан байдаг. Хэдийгээр Петр Бурханы гэгээрлийг хүртэж, Эзэн Есүс бол Христ, бас Бурханы Хүү гэдгийг танин мэдсэн ч энэ нь Эзэн Есүсийг хэсэг хугацаанд дагасны дараа л тохиолдсон юм. Эзэний үг болон ажлаас Түүний талаар тодорхой мэдлэгтэй болсны дараа л тэрээр Ариун Сүнснээс гэгээрэл, гэрэлтүүлэлт олж авчээ. Энэ бол баримт. Одоо эцсийн өдрүүдэд, бие махбодтой болсон Төгс Хүчит Бурхан үнэнийг илэрхийлж, хүн төрөлхтнийг шүүж, ариусгаж, аврах ажлыг хийдэг. Олон хүн Төгс Хүчит Бурханыг хүлээн зөвшөөрч, дагаж байгаа ч тэдний дунд Бурханыг дагахаасаа өмнө Түүний гэгээрлийг олж авсан нэг ч хүн байхгүй. Бурхан зөвт бөгөөд хэнийг ч илүүд үздэггүй нь лавтай. Бурхан үнэнийг эрэлхийлэхээр цангадаг сайхан сэтгэлтэй хүмүүсийг таашаан үздэг. Яг л Эзэн Есүсийн хэлсэнчлэн: **‘Зөвт байдлын төлөө өлсөж, цангадаг хүмүүс ерөөлтэй ээ: учир нь тэд цатгагдах болно’** (Матай 5:6). **‘Зүрх сэтгэлдээ цэвэр ариун хүмүүс ерөөлтэй ээ: учир нь тэд Бурханыг харах болно’** (Матай 5:8). Мөн Төгс Хүчит Бурхан ингэж хэлсэн: **‘Өөрийг нь гарч ирэхийг хүсэн хүлээдэг хүмүүсийг Бурхан эрж хайдаг. Өөрийнх нь үгийг сонсож чаддаг, Түүний даалгаврыг мартаагүй, зүрх сэтгэл, бие махбодоо Түүнд өргөн барьдаг хүмүүсийг Тэр эрж хайдаг. Өөрийнх нь өмнө хүүхэд шиг дуулгавартай байдаг, Өөрийг нь эсэргүүцдэггүй хүмүүсийг Тэр эрж хайдаг’** (Үг нь махбодоор илэрсэн номын “Бүх хүн төрөлхтний хувь заяаг Бурхан захирдаг”). Хүн үнэнийг хайрлаж, үнэнээр цангаж байгаа цагт түүний байр суурь ямар

---

байх, Библийн талаар хэр их ойлгодог байхаас үл хамааран Бурхан түүнийг гэгээрүүлж, чиглүүлэх бөгөөд Бурханы дуу хоолойг сонсож, илрэлтийг нь харах боломж олгоно гэдгийг энэ нь бидэнд харуулж байна. Бурхан эргэж ирэх үедээ эхлээд өөрсдийг нь гэгээрүүлнэ гэж удирдагчаар ажилладаг хүмүүс боддог бол тэд Бурханы ажлын талаар ямар ч ойлголтгүй, Бурханы зөвт зан чанарыг мэддэггүй болох нь харагдаж байна. Мөн түүнчлэн тэд маш их биеэ тоосон гэдгийг энэ нь илчилдэг. Төгс Хүчит Бурханы үгэнд хэлсэнчлэн: **‘Иймээс Бурханыг болон Түүний ажлыг “бүрэн ойлгодог” гэж хэлдэг хүмүүс бол чадваргүй хүмүүс гэж Би хэлдэг; тэд бүгд биеэ тоосон, мунхаг байдаг. Хүн Бурханы ажлыг тодорхойлох ёсгүй; түүнчлэн, хүн Бурханы ажлыг тодорхойлж чадахгүй. Бурханы нүдээр бол хүн шоргоолж шиг өчүүхэн юм; тэгэхээр хүн яаж Бурханы ажлыг ойлгож чадах юм бэ? “Бурхан ингэж, тэгж ажилладаггүй”, эсвэл “Бурхан ийм, тийм” хэмээн чалчих дуртай хүмүүс биеэ тоосон байдалтай ярьж байгаа бус уу?’** (Үг нь махбодоор илэрсэн номын Өмнөх үг). Бурханы төгс хүчин болон мэргэн ухаан ойлгохын аргагүй гүн гүнзгий билээ. Хүмүүс бол ердөө өчүүхэн бүтээлүүд юм. Тэдний оюун ухаан болон бодол хязгаарлагдмал, тэгэхээр бид яаж Бүтээгчийн ажлыг ухаан ойлгож чадах билээ дээ? Тиймээс Эзэний эргэн ирэхийг хүлээнгээ бид Бурханыг зүрх сэтгэлдээ хүндэлж, анхааралтай хайж, судалсаар байх ёстой. Бурханыг дур зоргоороо хязгаарлаж, шүүхийн тулд бид өөрсдийн үзэл, төсөөллийг ашиглах ёсгүй, учир нь энэ нь Бурханы зан чанарт халдаж, бас жинхэнэ аврал хүртэх боломжийг маань үгүй хийх болно.”

Бурханы үгийг сонссоныхоо дараа би, бид Бурханы өмнө үнэхээр шалихгүй, бүр шоргоолжноос ч өчүүхэн гэдгийг ойлгов. Түүнчлэн бид биеэ тоосон, ихэрхүү завхарсан зан чанараар дүүрэх хүртлээ Сатанаар завхруулагдсан билээ. Бид Бурханы хязгаарлахын тулд өөрсдийн төсөөлөл болон үзэлд үргэлж найдах дуртай бөгөөд Бурханы ажил бидний үзэлтэй нийцэхгүй байх үед бүр Бурханыг үгүйсгэж, яллаж, эсэргүүцдэг. Мэдээж, хэрэв хүн үнэнийг ойлгодоггүй, зүрх сэтгэлдээ Бурханыг өчүүхэн төдий ч хүндэлдэггүй бол хүссэн бүхнээ хийж зүрхэлнэ. Энэ нь маш аюултай! Энэ нь надад Эзэн Есүсийн нэгэнтээ хэлсэн үгийг сануулав: **“Танд талархъя, өө, тэнгэр, газрын Эзэн, Эцэг минь, учир нь Та эдгээр зүйлийг ухаалаг, цэцэн хүмүүсээс нууж, балчир хүүхдүүдэд илчилжээ. Тийм ээ, Эцэг минь: учир нь энэ нь Таны нүдээр сайн гэж харагдсан билээ”** (Матай 11:25–26). Үнэхээр тийм юм байна гэдгийг би өнөөдөр л харсан юм! Бурханы үгийн илчлэл болон Жан эгчийн нөхөрлөл надад **“Эзэнийг эргэн ирэх үед энэ талаар удирдагчид хамгийн түрүүнд гэгээрэх учиртай”** гэсэн санаа нь худал хуурмаг, утгагүй болохыг, үнэнтэй ердөө нийцдэггүй болохыг, мөн хүний үзэл, төсөөллөөс л гарсан болохыг ухааруулсан юм. Бодит амьдралд бол үнэнээр цангаж, Бурханы дуу хоолойг эрэлхийлдэг

---

хүмүүс л Бурханы ажил ба удирдамжийг хүлээн авч, Бурханы өмнө хүргэгдэх боломжтой байх болно. Энэ нь надад Бурханы шударга, зөвт байдлын талаар шинэ ойлголтыг өгсөн юм. Бурханд талархъя!

Гурав дахь өдрийнх нь өглөө эрт Жан эгч, Му эгч хоёрыг явсны дараа чуулганы маань дээгүүр зиндааны хамтран зүтгэгч Гуань ах ирж, “Жао ах аа, таныг Зүүний Аянгад итгэдэг гэж би сонслоо?” гэж надад хэлэв. Би чин сэтгэлээсээ: “Тийм ээ, би эцсийн өдрүүд дэх Төгс Хүчит Бурханы ажлыг хүлээн авсан, яагаад гэвэл Төгс Хүчит Бурханы үгээр дамжуулан би, Түүний ажлын гурван үе шатны нууц, Бурхан бие махбодтой болохын ач холбогдол гэх зэрэг урьд нь ойлгодоггүй байсан олон үнэнийг ойлгодог болсон. Төгс Хүчит Бурханы үг бол Илчлэл номонд зөгнөсөн **‘Чуулгануудад Сүнс юу айлдаж буйг’** болохыг би харж байна” гэж хэлэв. Гуань ах над руу зэрвэс хараад: “Жао ах аа, та үнэхээр энэ хүмүүсийн итгэдэг зүйлийг дагах гэж байгаа юм уу? Тэд ямар төрлийн хүмүүс болохыг мэдэх үү?” гэв. “Тэд хүн чанар сайтай бөгөөд үнэний талаар маш тодорхой нөхөрлөдгийг би харж байна. Тэдний хэлэлцсэн бүх зүйл Бурханы ажлын үнэнтэй холбоотой байсан. Сүүлийн энэ хоёр хоногт би үнэхээр ихийг олж мэдлээ” гэж би хариулсан юм. Гуань ах надад уурлан: “Чи яаж ийм зөрүүд байж чадаж байна аа? Еврей 6:6–8-д: ‘Хэрвээ тэд унавал, тэднийг гэмшлээр дахин шинэчлэх боломжгүй; учир нь тэд өөрсдөө Бурханы Хүүг дахиад цовдолж, илэрхий гутамшиг болгодог. Учир нь өөр дээрээ үргэлж асгарах бороог ууж, өөрийг нь эдлэгсдэд ашигтай ургамал ургуулдаг газар Бурханаас ерөөл хүртдэг: Харин өргөст ургамал, халгай ургуулдаг газар нь гологдож, хараалд ойртон; шатаагдаж дуусдаг’ гэсэн байдаг. Чи чинь номлогч шүү дээ, бас Эзэний нигүүлслийг маш их эдэлсэн мөртөө ах, эгч нарыг Эзэнд итгэхэд нь залж чиглүүлэхгүй байгаад зогсохгүй, харин ч манай чуулганаас явахад хүргэж байна. Чи шийтгүүлэхээс айхгүй байна гэж үү? Хэрэв чи одоо буцаж эргэхгүй бол Эзэний хамгаалалтыг алдаж, аз жаргалтай амьдарч чадахаа болино. Урьдын өвчин чинь сэдэрч, хоёр хүүхэд чинь сайн ажилтай болохгүй...” гэв.

Гуань ахыг авсны дараа би бага зэрэг хямран: “Түүний хэлсэн зүйлс ортой юм шиг байна. Тэгэхээр Төгс Хүчит Бурханд итгэх итгэл минь Эзэний нигүүлслийг алдахад хүргэвэл би яах вэ?” гэж бодов. Энэ тухай бодонгуут зүрх алдаж, би яаравчлан өвдөглөн сууж, Бурханд залбирлаа: “Төгс Хүчит Бурхан минь! Гуань ахын үг намайг бага зэрэг сул дорой болголоо. Түүний хэлсэн зүйл үнэхээр үнэн үү, үгүй юу? Би одоо яахаа үнэхээр мэдэхгүй байна...” Бурханд ийнхүү залбирч байтал эхнэр минь эргэж ирээд, би түүнд дөнгөж сая юу болсон талаар хэллээ. Миний хэлснийг сонсоод эхнэр бухимдаж: “Тэр үнэхээр тэгж хэлсэн гэж үү?” гэв. Намайг толгойгоо дохиход эхнэр маань санаа зовсон байдалтайгаар: “Тэрээр олон жилийн турш Эзэнд итгэсээр ирсэн голлох удирдагч бөгөөд

---

Библийг маш сайн мэддэг. Бидэнд худал хэлнэ гэж би бодохгүй байна. Хэрэв энэ нь үнэхээр түүний хэлсэн шиг байвал бид яах ёстой юм бол оо?” гэв. Яг тэр мөчид би Жан эгч, Му эгч хоёрын нөхөрлөсөн Бурханы ажлын гурван үе шатны үнэний талаар гэнэт бодов: Хүн төрөлхтнийг аврах Бурханы ажлыг гурван үе шатанд хуваадаг ч ажлын гурван үе шатыг бүгдийг нь нэг Бурхан явуулдаг. Энэ тухай бодонгуут гэнэтхэн бүх зүйл тодорхой болж, би эхнэртээ хандан: “Гуань ахын хэлсэн зүйл буруу юм шиг байна. Эцсийн өдрүүд дэх Бурханы ажлыг хүлээн авснаар бид Эзэний замыг орхиж, Эзэн Есүсээс урваж байгаа хэрэг гэж тэр хэлсэн боловч сүүлийн хэдэн өдөр бидний уншсан Төгс Хүчит Бурханы үг бол үнэхээр Бурханы дуу хоолой, Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс мөн. Төгс Хүчит Бурханыг дагаснаар бид үнэн хэрэгтээ Хурганы мөрийг дагаж байгаа юм. Бид бол ухаалаг охид. Эзэн яагаад биднийг шийтгэнэ гэж?...” хэмээн пал хийтэл хэллээ. Энэ талаар ид нөхөрлөж байхад Жан эгч, Му эгч хоёр орж ирэв...

Эхнэр маань Гуань ахын манайд ирэхдээ хэлсэн зүйлийг хоёр эгчид ярихад Жан эгч энэ бүх зүйлийн талаар надад ямар санагдсаныг асуув. Тиймээс би өөрийн мэдэрсэн сул дорой байдал, дөнгөж сая ойлгож авсан зүйлээ хэлэв. Жан эгч инээмсэглэн: “Бурханд талархъя! Энэ бол үнэхээр цэвэр ойлголт, Бурханы гэгээрэл ба удирдамж!” гэв. Эхнэр маань гайхширан: “Биднийг замаа алдаагүй байхад Гуань ах яагаад ийм зүйл хэлж байгаа юм бэ? Тэр бол Эзэнд олон жилийн турш итгэсэн гол удирдагч шүү дээ!” гэж асуулаа. Би эхнэр лүүгээ харан: “Тэр зүгээр л биднийг хуучин чуулган руугаа буцаж оч гэж хүсэж байгаа юм!” гэв. Жан эгч инээмсэглэн ингэж хэллээ: “Яг одоо бид тэдний гаднах дүр төрхийг л харж чадах боловч уг чанарынх нь мөн чанарыг хараагүй! Эзэн Есүс нэгэн удаа ингэж хэлсэн: **‘Хоёр нүүрт хуулийн багш нар, фарисайчууд та нар золгүй еэ! Яагаад гэвэл та нар хүмүүсээс тэнгэрийн хаанчлалыг хааж, өөрсдөө орохгүй бөгөөд орж буй хүмүүсийг ч оруулахгүй’** (Матай 23:13). **‘Хоёр нүүрт хуулийн багш нар, фарисайчууд та нар золгүй еэ! Учир нь та нар цагаанаар будсан булшны хөшөө шиг үнэндээ гаднаа сайхан харагддаг боловч дотроо үхэгсдийн яс болон бузар бүхнээр дүүрэн байдаг’** (Матай 23:27). Гаднаас нь харахад фарисайчууд Бурханд үйлчлэхдээ үнэхээр үнэнч байсан. Хүмүүсийн оюун ухаанд бол фарисайчууд Бурханы үнэн сүсэгт зарц нар байсан бөгөөд хамгийн итгэж болохуйц шашны удирдагчид байв. Гэхдээ Эзэн Есүс Өөрийн ажлыг явуулахаар ирэх үед фарисайчуудын Бурханыг эсэргүүцдэг уг чанар илчлэгдсэн юм. Эзэн Есүсийн ажлыг улайран эсэргүүцэж, яллаж байсан хүмүүс нь фарисайчууд байлаа. Тэд янз бүрийн цуу яриа зохиож, жирийн хүмүүсийг мэхлэхийн тулд хуурамч гэрчлэл хийж байжээ. Эзэн Есүс бол чөтгөрүүдийн захирагч Беелзевүлээр чөтгөрүүдийг хөөн зайлуулсан гэж тэд хэлсэн юм. Эзэн Есүс загалмай дээр цовдлогдсоноос хойш гурван өдрийн дараа дахин амилангуут тэд цэргүүдийг хахуульдаж,

---

Эзэн Есүсийн биеийг шавь нар нь хулгайлсан гэх зэрэг гэсэн худал цуурхал тараалгажээ. Фарисайчууд төрөл бүрийн худал хуурмаг зүйл зохиосон бөгөөд үнэн замыг эрэлхийлж, судлахад нь хүмүүс саад хийхийн тулд бүхий л арга чаргаа хэрэглэсэн. Тэдний зорилго бол Бурханы ажлыг хориглосноор Бурханы сонгосон хүмүүсийг үүрд мөнх ноёрхох явдал байв. Хэдийгээр тэд гаднаа сүсэг бишрэлтэй харагдаж байсан ч мөн чанартаа үнэнийг үзэн ядаж, Бурханд дайсагнадаг антихристүүд байсан юм. Эзэн Есүс тэднийг илчилж, яллах үедээ: **‘Могойнууд аа, хорт могойн удам аа, та нар яаж тамын шийтгэлээс зугтааж чадах вэ?’** (Матай 23:33) гэж хэлсэн. Тэгэхээр одоо энэ тухай бодоод үзье: Өнөөгийн шашны удирдагчид фарисайчуудаас ялгаатай гэж үү?” Тэгээд эгч нар Төгс Хүчит Бурханы үгийн дараах хэсгийг уншихыг надаас хүсэв: **“Том сүмд Библи уншиж, үүнийг бүхэл өдөржингөө цээжээр уншдаг хүмүүс байдаг атал тэдний дундаас нэг нь ч Бурханы ажлын зорилгыг ойлгодоггүй. Тэдний дундаас нэг нь ч Бурханыг мэдэж чаддаггүй; тэдний дундаас бүр нэг ч хүн Бурханы хүсэлд нийцэж чаддаггүй. Тэд бүгдээрээ үнэ цэнгүй, өөдгүй хүмүүс бөгөөд Бурханд зааж сургахын тулд дор бүрнээ өндөрт зогсдог. Тэд Бурханы нэрээр далайлгадаг атлаа Түүнийг дур зоргоороо эсэргүүцдэг. Бурханд итгэдэг гэх атлаа тэд хүний махыг идэж, цусыг уусаар байдаг. Ийм хүмүүс бүгд хүний сүнсийг залгидаг диаволууд, зөв замд орохоор хичээж буй хүмүүст зориуд саад учруулдаг толгойлогч чөтгөрүүд, мөн Бурханыг эрж хайдаг хүмүүст садаа болдог бул хар чулуу билээ. Тэд ‘эрүүл чийрэг бие махбодтой’ харагдаж болох ч Бурханыг эсэргүүцэхэд хүмүүсийг хөтөлдөг антихристүүдээс цаашгүй гэдгийг дагагчид нь яаж мэдэх юм бэ? Хүний сүнсийг залгидаг амьд диаволууд гэдгийг дагагчид нь яаж мэдэх юм бэ?”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурханыг мэддэггүй бүх хүн бол Бурханыг эсэргүүцдэг хүмүүс юм”). Эгч нар Бурханы эдгээр үгийн дагуу бидэнтэй дэлгэрэнгүй нөхөрлөж, шашны удирдагчдын бүх үйлдлийг, уг чанарынх нь мөн чанарын хамтаар задлан шинжилсэн бөгөөд тэд Төгс Хүчит Бурханд итгэхэд маань зогсолтгүй саад хийж, үймүүлдэг, тэр ч бүү хэл биднийг хамгаалах гэсэндээ биш, харин ч Бурханы сонгосон хүмүүсийг ноёрхож, биднээр өөрсдийгөө Бурхан мэт шүтүүлж, тахиулах гэсэндээ биднийг заналхийлж, сүрдүүлдэг гэдгийг эцэст нь би ухаарсан юм. Тэгэхээр үнэн хэрэгтээ бол тэд яг л фарисайчуудтай адил. Тэд бүгд үнэнийг үзэн ядаж, Бурханыг эсэргүүцдэг антихристүүд юм. Бурхан биднийг аврахаар ирсэн боловч тэд Бурханы ажлыг хүлээн авч, Бурханы үгийг уншихыг маань болиулахын тулд боломжит бүх аргыг бодож олдог. Ингэснээрээ тэд биднийг там руу доош татаж байгаа бус уу? Тэд үнэхээр хорлонтой! Энэ хүмүүс Бурханыг хэрхэн эсэргүүцэж, хүний төлөө Бурхантай хэрхэн тэмцэлддэгийн мөн чанарыг Төгс Хүчит Бурханы үг илчлээгүй бол би бараг тэдний урхинд орж, жинхэнэ аврал хүртэх боломжоо сүйтгэх байлаа. Яг тэр үед эхнэр маань үнэхээр гайхширан: “Тэгэхээр тэд бидэнд хор хөнөөл учруулахаар энд ирсэн байж таарлаа! Энэ хүмүүс

---

биднийг тамд унагах хүртлээ үнэхээр зогсохгүй юм байна! Би тэдний хэлсэн зүйлд одоо итгэхгүй ээ” гэж хэлэв.

Дараа нь Му эгч Бурханы үгийн өөр нэг хэсгийг бидэнд уншиж өгөв: “Хүмүүс дээр Бурханы хийдэг ажлын алхам бүрд, гаднаа энэ нь хүмүүсийн хоорондын харилцаа мэт, хүний зохицуулалт, хүний хөндлөнгийн оролцооноос үүдэлтэй мэт харагддаг. Гэвч нүднээс далдуур, ажлын алхам бүр, тохиолдож буй юм бүхэн нь Бурханы өмнө Сатаны тавьсан бооцоо бөгөөд Бурханд гэрчлэл хийхдээ бат зогсохыг хүмүүсээс шаарддаг. Жишээ нь, Иовыг шалгасан үеийг авч үзье: Нүднээс далдуур Сатан Бурхантай мөрий тавьж байсан бөгөөд Иовд тохиолдсон зүйл нь хүмүүсийн үйл хэрэг, хүмүүсийн хөндлөнгийн оролцоо байсан. Та нарт хийдэг Бурханы ажлын алхам бүрийн ард Сатаны Бурхантай тавьсан мөрий байдаг—энэ бүгдийн ард тэмцэл байдаг” (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурханыг хайрлах нь л үнэхээр Бурханд итгэж буй хэрэг”). Тэгээд Жан эгч ийн нөхөрлөж эхлэв: “Бидэнд тохиолдож буй аливаа зүйл гаднаасаа хүн хийсэн мэт харагддаг хэдий ч бодит байдал дээр үүний цаана Сатан Бурхантай мөрийцөж байдаг гэдгийг Бурханы үгээр дамжуулан бид харж болно. Энэ нь Иовыг Сатан сорьдогтой яг адилхан. Еховаг орхихыг эхнэр нь түүнээс хүссэн боловч Иов Сатаны заль мэхийг нэвт харж чадсан юм. Иов Бурханд итгэх итгэлдээ найдаж, Бурханы төлөө гэрчлэлд зогссон бөгөөд мэдлэггүй, зөрүүд эм хэмээн эхнэрээ загнасан байдаг. Бурханы аврахыг хүссэн хүн бүрийг Сатан үргэлж улайран сорьж, үймүүлэн, тэдэн рүү дайрч довтлохын тулд өөрт байгаа бүх заль мэхийг дайчилна, ингэснээр тэд Бурханы орхиж, Бурханаас урваж, эцэст нь жинхэнэ аврал хүртэх боломжоо алддаг гэдгийг Иовын туршлага бидэнд хэлдэг. Сатан хүнийг үүрд хянаж, залгихыг хүсдэг тул хүн Бурханы авралыг хүртээсэй гэж хүсдэггүй!” Му эгч ч бас: “Тэр үнэн. Сатан биднийг Бурханаас урвуулж, биднээр Бурханыг үгүйсгүүлж, үнэн замыг хаяулах зорилгоор удирдагчдыг удаа дараа ашиглан бидэн рүү дайрч довтолж, биднийг айлган сүрдүүлдэг. Энэ бол Сатаны заль мэх юм. Сүнсний ертөнцөд явагдаж буй энэ тулааныг бид тодорхой харж чаддаг байх ёстой!” гэж нөхөрлөлөө. Энэ хоёр эгчийн нөхөрлөлийг сонссоны дараа би хэсэг зуур тунгаан бодоод, “Тэгэхээр Сатан Бурхантай мөрийцөж байгаа. Удирдагчдын хэлдэг зүйлээр дамжуулан Сатан бидний сул тал руу дайрдаг бөгөөд хулчгар зангаасаа болоод бид үнэн замыг хаяж, Бурханыг орхиосой гэж хүсэж байгаа юм байна! Сатан үнэхээр хорон санаатай юм!” гэж хэлэв. Тэгтэл эхнэр маань ч бас: “Энэ Сатан үнэхээр зэвүүн юм аа! Хэрэв бид Бурханы үг болон та нарын нөхөрлөлийг сонсоогүй бол энэ нь Сатаны заль мэх мөн гэдгийг яахан мэдэж чадах билээ?” гэж хэллээ. “Одоо бид эдгээр зүйлийг ойлгодог болсон болохоор Сатаны хатуу чанд бүслэлтийг нэвтэлж, Бурханы төлөө гэрчлэлд зогсож, бодитой үйлдлээрээ Сатаныг шившиглэхийн тулд Бурханд найдах



---

хэрэгтэй!” гэж би баяртайгаар хэлэв. Жан эгч ч бас: “Ах аа, эгч ээ, одоогоос эхлээд бүгдээрээ Бурханы үгийн талаар илүү их нөхөрлөж байя. Ийм маягаар л бид өөрсдийгөө илүү их үнэнээр зэвсэглэж, удалгүй нэг өдөр эцсийн өдрүүд дэх Бурханы ажлын талаар итгэлтэй болж, үнэн зам дээр сууриа тавьж чадах бөгөөд тэр үед Сатаны төрөл бүрийн цуу яриа, худал үгэнд мэхлэгдэхээ болино” гэж баярлан хэллээ. “Тэгье! Хэрэв та нар ойр ойрхон ирж, бидэнтэй нөхөрлөж чадвал бүр ч сайн байна” гэж би хэлэв. Му эгч инээмсэглэн: “Тэгвэл бид ойр ойрхон ирж байя” гэв.

Хэдэн өдрийн дараа би өглөө эрт орноосоо босоод, цонхоороо хартал маш их цас орсон байсан бөгөөд би өөрийн мэдэлгүй гараа үрж эхлэв. Тэгээд би ноосон малгай, даавуун бээлий өмсөөд, цас цэвэрлэхээр гадаа гарав. Цэвэрлэж дуусаад гэртээ орсон бөгөөд эхнэрийг гэрээ цэгцэлж байх хооронд би зуухны тагийг нээж, гал өрдөж асаалаа. Энэ үед эхнэрийн маань ах, эхнэртэйгээ хамт ирэв. Бэр эгч маань орж ирэнгүүтээ түгшсэн дуугаар: “Ван удирдагч, Гуань хамтран зүтгэгч хоёр энд ирж, та хоёртой маш их ярьсан, та хоёр яагаад тэднийг сонсохгүй байгаа юм бэ? Тэд биднээс өнөөдөр энд ирж, та нарыг дахин нэг удаа ятгахыг биднээс тусгайлан хүссэн юм. Зүүний Аянгад цаашид бүү итгэ. Бидний амийг манай удирдагчид л хариуцдаг шүү дээ!” гэв. Ингэж хэлэхийг нь сонсоод би: “Хэрэв тэд үнэхээр бидний амийг хариуцдаг юм бол эцсийн өдрүүд дэх Төгс Хүчит Бурханы ажлыг судалж, Эзэний эргэн ирэлтийг угтан авахад биднийг хөглөх учиртай!” гэж хатуу хэлэв. Тэгтэл эхнэр маань: “Тэд үүнийг бидний төлөө хийж байгаа юм биш. Хэрэв бид бүгдээрээ Төгс Хүчит Бурханд итгэвэл өөрсдийг нь сонсох нэг ч хүн үлдэхгүй гэдгээс тэд айж байгаа” гэж пал хийтэл хэлэв. Бэр эгч үүнийг сонсоод уцаарлаж: “Яаж та хоёр хоёулаа ийм зүйл хэлж чадаж байна аа? Тэд та нараас юу ч хийхийг хүсээгүй. Зүгээр л та нарыг чуулган руугаа буцаж ирээсэй гэж хүссэн биш гэж үү? Намайг сонс. Гэр бүлийнхээ хоорондох харилцаагаа бодсон ч тэр би яалаа гэж та нарыг хорлоё гэж бодох билээ дээ?” гэв. Эхнэрийн маань ах үргэлжлүүлэн: “Өнгөрсөн жилүүдэд би та нарт яаж ханддаг байсныг бодоод үз. Бид та нарын төлөө хэчнээн ихийг хийснийг мэдэх үү? Өөрсдийгөө биднээс салгах зүрх сэтгэл та нарт үнэхээр бий гэж үү? Та нар гэмшихгүй байна гэж үү?” гэв. Тэр хоёрыг ийм зүйл хэлэхэд сэтгэл ихэд гонсойж, дотроо ингэж бодов: “Тэд үнэхээр бидэнд маш их тусалж байсан. Одоо Төгс Хүчит Бурханыг дагахаар зүтгэж байгааг маань тэд харж байна. Мэдээж маш их гомдож байгаа байх, гэхдээ яах ч билээ дээ? Үнэн замыг орхиж, Бурханаас урвахыг надаас хүсэж магадгүй боловч би яавч тэгж чадахгүй. Учир нь Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс гэдгийг би мэднэ. Харин хэрэв намайг Төгс Хүчит Бурханд итгэхээр зүтгэвэл тэд миний талаар юу гэж бодох бол? Намайг талархалгүй хүн гэж хэлэх болов уу?” Яг тэр үед сэтгэл гонсойж, зүрх сэтгэл минь хоёрдож байв. Би Бурханд чимээгүйхэн залбирч, надад гарах гарц өгөхийг Түүнээс

---

гуйлаа. Гэнэтхэн би Бурханы дараах үгийг бодов: **“Хүмүүст тохиолддог бүхэн нь Бурханд гэрчлэл хийхдээ бат зогсох хэрэгтэй үед нь тохиолддог”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурханыг хайрлах нь л үнэхээр Бурханд итгэж буй хэрэг”). Дараа нь, чамд тохиолдож буй бүхэн сүнсний ертөнцөд явагдаж буй тулаантай холбоотой бөгөөд энэ нь Сатан Бурхантай мөрий тавьж байгаа хэрэг юм хэмээн Жан эгч, Му эгч хоёрын хэд хоногийн өмнө надтай нөхөрлөсөн үгийг санав. “Өнөөдөр эхнэрийн маань ах, бас бэр эгч маань ураг төрлийн байдлаа ашиглан Бурханаас урваж, шашин руу эргэн очихыг биднээс шаардсан боловч энэ бол Сатаны арга заль юм. Хэрэв би өөрийн мэдрэмжийг хамгаалахын тулд Бурханаас урвасан бол үнэхээр талархалгүй байгаа хэрэг бөгөөд мөс чанаргүй гэдгийг маань харуулах байлаа. Хэрэв би хүргэн ахынхаа урмыг хугалахыг хүсэхгүй байгаа бол Бурханы эцсийн өдрүүдийн сайн мэдээг түүнтэй хуваалцах ёстой, ингэснээр тэд ч бас Бурханы авралыг хүртэх боломжтой болно. Энэ бол өөрт байх ёстой энэрэх сэтгэлээ харуулах цорын ганц арга зам юм” гэж би бодож байлаа. Энэ тухай бодоход зүрх сэтгэл минь цэлмэж: “Ах аа, бэр эгч ээ, та хоёр надад сайн хандаж ирснийг би мэднэ. Ийм ч учраас би та нарт Төгс Хүчит Бурхан бол үнэхээр эргэн ирсэн Эзэн Есүс мөн гэдгийг хэлэх хэрэгтэй байна. Эцсийн өдрүүд дэх Төгс Хүчит Бурханы ажлыг дагаснаар л бид Бурханы авралыг хүртэж чадна! Эс тэгвэл Эзэнд олон жилийн турш итгэж ирсэн итгэл маань хий дэмий болж, бид юу ч олж авахгүй! Алив, би та хоёрт Бурханы үгийн нэг хэсгийг уншиж өгье. Үүнийг сонссоны дараа та нар эдгээр үг нь үнэн бөгөөд Бурханы айлдвар мөн эсэхийг мэдэх болно” гэж хэлэв. Тэгээд Бурханы үгийн номоо авч, уншиж эхлэх гэтэл бэр эгч маань агшин зуур босож зогсоод, огт баярлалгүйгээр ингэж хэлэв: “Бид өнөөдөр чамайг ятгахаар энд ирсэн. Гэвч санаагаа өөрчлөхийн оронд чи бүр бидэнд сайн мэдээ түгээх гэж оролдлоо. Гэхдээ бид чамайг сонсохгүй” гэв. Ингэж хэлээд эгч нөхрийгөө хөтлөн, ууртайгаар явж одлоо.

Би тэднийг араас гарч, хашааны хаалга хүртэл явсан боловч тэд хэдийн явсан болохыг харав. Яах ч аргагүй болсон би тэнд толгойгоо сэгсрэн зогслоо. Энэ үед би цаг агаар сайжирч, хашааны гаднах нарс модон дээр дулаан гэрэл тусаж байгааг харав. Нарс модыг хучиж байсан цас хайлж эхлэн, яг тэрхүү мөчид мод дөнгөж баптисм хүртсэн мэт байсан юм. Цасаар хучигдсан газартай харьцуулахад шулуун, өндөр мод онцгой ногоорон харагдаж байлаа. Би маш их баярласан бөгөөд тэрхүү нарс модны адилаар би ч бас салхи болон цасны баптисм хүртэж, нарны илчинд өссөн мэт санагдав. Хатуу чанд бүслэлтээс гарч, Бурханы төлөө гэрчлэлд зогсоход минь Бурханы үг л намайг хөтөлсөн гэдгийг би мэдэж байлаа. Төгс Хүчит Бурханд талархъя!

## **18. Бурханы үг намайг замчлан урхинаас гаргадаг**

---

## Тиан'на, Хонг Конг

“Бурхан хүмүүсийн дунд агуу зүйл хийснийг чи мэдсэн үү?” хэмээх Бурханы үгийн нийтлэлийг эргүүлж суутал цуу ярианы хүлээсээс ангижирч, Бурханы өмнө эргэн ирсэн, хоёр жилийн өмнөх туршлага минь өөрийн эрхгүй санаанд орлоо.

Гэр бүлийнхээ хамтаар би Хонг Конгд амьдардаг юм. Хадам аав, хадам дүү (нөхрийн маань бага дүү) хоёр хоёулаа Эзэн Есүст итгэдэг. Хадам дүү сүмийн пастор тул чуулганы ах, эгч нар манайд байнга зочлон ирж, хамтдаа залбирцгаан, Эзэнийг магтсан магтан дуу дуулцгаадаг байсан юм. Дараа нь 2014 оны 12 дугаар сард нэг сайн найз маань бас Эзэнд итгэдэг гэдгээ надад хэлэв. Гэр бүл, найзуудынхаа нөлөөнд автан Эзэнд итгэх итгэлийг бага зэрэг сонирхох болсон юм. Нэг их удалгүй би өөр сүмийн гишүүн болох Пэйпэй эгчтэй танилцлаа. Эгч харилцахад амархан, нөхөрсөг хүн байв. Гэр бүлийн зарим гишүүн, бас найзууд маань Эзэнд итгэдэг гэдгийг олж мэдээд тэр ихэд баярлаж, намайг гэртээ зочлохыг уриад, гэрт нь очиход Чэн Хуй эгчтэй намайг танилцуулсан юм. Хэд хэдэн цуглааны явцад Чэн Хуй эгч, Бурхан бүх зүйлийг бүтээсэн талаар, бүх зүйлийг захирах Бурханы дээд эрх, мөн түүнчлэн Сатаны уг гарлын тухай гэх мэт үнэнийг надтай хуваалцлаа. Түүний хэлсэн зүйлс анхаарлыг минь үнэхээр татаж, намайг туйлын их баярлуулсан билээ. Тэдний туршлага, итгэлийн тухай ойлголтоо хуваалцахыг нь сонсох би үнэхээр дуртай байсан ба энэ аз жаргалаа бусадтай хуваалцахыг маш их хүсэж байв. Нэг өдөр би өөрийгөө барьж дийлэлгүй, итгэгч болохыг хүсэж буйгаа гэр бүлийнхэндээ хэллээ. Хадам дүүд минь мэдээ маш хурдан хүрчээ. Тэрээр залгаж, надаас гэнэт яагаад Бурханд итгэх болсныг минь асуугаад “Зүүний Аянга нэртэй чуулган байдаг бөгөөд Эзэн Есүс аль хэдийн эргэн ирсэн хэмээн хаа сайгүй гэрчилдэг. Тэд урсгал бүрийн маш олон үнэнч эрэлчдийг хулгайлсан. Үүнд хэт хөнгөмсөг бүү хандаарай; тэдэнтэй бүү орооцолдоорой” гэж хэлэв. Тэгээд, сайн мэдээ хуваалцаж байгаа хүмүүс надад ном өгсөн эсэх талаар надаас ахин дахин асууж, бас итгэлтэй холбоотой аливаа зүйлд онцгой анхаарал болгоомжтой хандахыг удаа дараа захилаа. Хадам дүүгийн маань үг толгойд минь байнга эргэлдэн, ухаан самууруулах болов. Нэг талаас, өөр чуулган олсныг минь хадам дүү эсэргүүцэж байсан ч нөгөө талаас, Бурханд итгэх талаар Чэн эгчийн хэлсэн зүйл надад үнэхээр таалагдаж байв. Надад хадан завсар хавчуулагдсан мэт санагдаж, Чэн эгчтэй цаашид холбоо барих хэрэгтэй эсэхээ би огт мэдэхгүй байлаа.

Иймээс би пасторуудын номлолыг сонсохоор интернэтээс хайж эхэлсэн юм. Зүүний Аяндын талаар маш их мэдээлэл интернэтэд байгааг би олж харсан ч нэг их анхаарал хандуулсангүй; сайн номлол олоход л бүрэн төвлөрсөн байлаа. Би маш олон номлол сонсож, харьцуулсан бөгөөд эцэст нь Чэн эгч тэд нарын номлол л хамгийн шилдэг гэж

---

бодогдсон хэвээр байв. Учир нь Бурханыг гэрчлэх талаар тэд илүү их хуваалцдаг бөгөөд тэднийг сонсоод би Бурханы талаар илүү дээр ойлголттой болсон. Хэсэг бодож үзсэний дараа би Чэн эгчийн нөхөрлөлийг үргэлжлүүлэн сонсохоор шийдлээ. Дараагийн өдрүүдэд нь эгч надад Мосе израильчуудыг хөтлөн Египетээс гаргасан, Абрахам Исаакийг золиосолсон, Эзэн Есүс хүн төрөлхтний төлөө цовдлогдсон, Петрийн туршлага, Лазар дахин амилж, Бурханыг алдаршуулсан тухай гээд олон түүхийг ярьж өглөө. Библийн эдгээр гайхалтай түүх үнэхээр сэтгэл татаж, Бурханы хийсэн ажлын талаар илүү гүнзгий ойлголт өгөв. Цуглаан бүрийн дараа би дараагийн цуглааныг тэсэж ядан хүлээдэг байлаа.

Сарын дараа цуглааны үеэр Чэн эгч Библийн зарим эшлэл болон Төгс Хүчит Бурханы үгийн хэсгийг надад уншиж өгөв. Библид: **“Гэхдээ хүний Хүүгийн ирэлт нь ч бас Ноагийн өдрүүд шиг байх болно. Учир нь үерийн өмнөх өдрүүдэд, Ноаг бүхээгт орох өдрийг хүртэл тэд идэж ууж, гэрлэж, нөхөрт гарч байсан бөгөөд үер бууж, бүгдийг нь авч явах хүртэл мэдээгүй; иймээс хүний Хүүгийн ирэлт ч бас тийм байх болно”** (Матай 24:37–39) гэсэн байдаг. Төгс Хүчит Бурхан ийн хэлсэн байдаг: **“Ноагийн бүхээг барьсан цаг үеийг эргэн хар: Хүн төрөлхтөн гүн ялзарсан, Бурханы ерөөлийн замаас гажиж, Бурханаар халамжлуулахаа больсон, Бурханы амлалтыг алдчихсан байсан. Тэд Бурханы гэрэлгүйгээр харанхуйд амьдарч байв. Тиймээс тэд садар самуун уг чанартай болж, жигшүүрт доройтолд өөрсдийгөө хаясан байв. Тийм хүмүүс Бурханы амлалтыг хүлээж авч чадахааргүй болсон; тэд Бурханы нүүрийг харахад ч, Бурханы дуу хоолойг сонсоход ч тохирохгүй байлаа. Учир нь тэд Бурханыг хаяж, Түүний хайрласан бүх зүйлийг орхиж, Бурханы сургаалыг мартчихсан байсан юм. Тэдний зүрх сэтгэл Бурханаас улам бүр холдсоноор тэд хамаг эрүүл ухаан, хүн чанараа алдан доройтож, улам ёрын муу болсон юм. Тиймээс тэд үхэл рүүгээ бүр ч ойртож, Бурханы уур хилэн, шийтгэлийг хүртсэн. Ноа л Бурханд шүтэн мөргөж, муугаас зайлсан учир Бурханы дуу хоолойг сонсож, Бурханы зааврыг сонсож чаджээ. Ноа Бурханы үгийн зааврын дагуу бүхээг барьж, бүх төрлийн амьтдыг цуглуулсан. Ингээд бүх зүйл бэлэн болсны дараа Бурхан дэлхий дээр сүйрлээ эхлүүлсэн. Ноа болон түүний гэр бүлийн долоон гишүүн л сүйрлээс амь гарсан, учир нь Ноа Еховаг шүтэн мөргөж, муугаас зайлсан билээ.**

**Өнөө үеийг одоо хар л даа: Бурханд шүтэн мөргөж муугаас зайлж чадах Ноа шиг зөв шударга хүмүүс байхаа больжээ. Гэсэн ч Бурхан хүн төрөлхтөнд нигүүлсэнгүй хэвээр, энэхүү төгсгөлийн эрин үед тэднийг уучилсаар байдаг. Өөрийг нь гарч ирэхийг хүсэн хүлээдэг хүмүүсийг Бурхан эрж хайдаг. Өөрийнх нь үгийг сонсож чаддаг, Түүний даалгаврыг мартаагүй, зүрх сэтгэл, бие махбодоо Түүнд өргөн барьдаг хүмүүсийг Тэр эрж хайдаг. Өөрийнх нь өмнө хүүхэд шиг дуулгавартай**

---

**байдаг, Өөрийг нь эсэргүүцдэггүй хүмүүсийг Тэр эрж хайдаг”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Бүх хүн төрөлхтний хувь заяаг Бурхан захирдаг”). Чэн эгч ийнхүү нөхөрлөв: “Ноагийн өдрүүдэд хүмүүс идэж уун, гэрлэж, нөхөрт гарцгааж байсан; садар самуун, завхарсан байсан тул тэд Бурханы үгийг сонсож, Бурханд шүтэн мөргөөгүй. Оронд нь шүтээн шүтэж, нүгэл нь туйлдаа хүрсэн байв. Тухайн үеийн хүмүүсийг аврахын тулд Бурхан Ноаг дуудан, хөвөгч авдар бариулж, үер дэлхийг сүйрүүлнэ гэдгийг хүмүүст хэлүүлжээ. Ноа үүнийг зуу гаруй жилийн турш тунхагласны дараа ч гэсэн Бурханы үгэнд хэн ч итгэсэнгүй, хэн ч гэмшсэнгүй. Тиймээс Бурхан их үерээр тэр эрин үеийн хүмүүсийг устгажээ. Эцсийн өдрүүдийн хүмүүс Ноагийн цаг үеийн хүмүүсээс ч илүү завхарсан. Нийгэм бүхэлдээ ёс суртахууны хувьд дампуурч, өдөр өдрөөр доройтож байна. Гэр бүл салалтийн түвшин өндөр хэвээр үлдэж, гэмт хэрэг ердийн үзэгдэл болж, бас дээр нь порнограф, мөрийтэй тоглоом, мансууруулах бодис хүмүүсийн сэтгэлийг доройтуулжээ. Хүмүүс улам бүр зальхай, шуналтай, ёрын муу, жигшүүртэй, аминч болсоор байна. Мөс чанартай, эсвэл сайн, үнэнч хүн байх талаар хэн ч анхаардаггүй мөртөө идэж, уун, зугаацан цэнгэж, эрх мэдлээр бэлгийн харьцааг, эсвэл бэлгийн харьцаагаар эрх мэдэл худалдан авахад л ач холбогдол өгдөг. Хүмүүс үнэнээс залхаж, ёрын мууг өргөмжилдөг. Тэд нүгэл үйлдэхэд баясан шунадаг бөгөөд Бурханы сүйрлийг хүртвэл зохих түвшинд аль эрт хүрчээ. Энэ бүх шинж тэмдэг эцсийн өдрүүд ирснийг харуулж байна. Одоо Эзэн Есүс эргэн ирсэн бөгөөд хоёр дахь удаагаа бие махбодтой болж дэлхий дээр амьдардаг. Тэр хүн төрөлхтний аврал, ариусгалтын төлөө бүх үнэнийг айлдсан. Ийм гүн завхарсан хүмүүс биднийг бүрэн аврахаар Тэр ирсэн. Хүн төрөлхтнийг гэх Бурханы хайр, энэрэл үнэхээр агуу!” Эгчийн хэлсэн эдгээр үгийг сонсоод сэтгэл минь хөдөлж, би дотроо: “Бид үнэхээр муу хүмүүс тул аль эрт Бурханаар устгагдах ёстой байжээ. Бурханы өршөөлийн ачаар л бидэнд Бурханы гэрт ирж, айлдсан үгийг нь унших хувь тохиож, Бурханыг мэдэх боломж олджээ. Ямар агуу ерөөл вэ!” хэмээн бодлоо. Намайг замчилж, Бурханы эцсийн өдрүүдийн ажилтай мөр зэрэгцэн очиж, аврагдах завшааныг олж авах боломж олгосонд нь би Бурханд ахин дахин талархав. Намайг яг явах гэж байтал эгч надад Бурханы үгийн ном өглөө. Хоёр гартаа номоо бариад сэтгэл минь маш их хөдөлсөндөө би уйлж эхэлсэн юм. Тэгээд чадлынхаа хэрээр Бурханыг дагахаар шийдсэн билээ.

Нэг өдөр компьютерээ асаагаад би Зүүний Аяндын талаар ямар нэг юм бичсэн вэб сайт олж харлаа. Сониуч зандаа хөтлөгдөн холбоос дээр дараад, Зүүний Аяндын талаар ХКН-ын засгийн газар болон шашны нийгэмлэгийн зүгээс бичсэн сөрөг суртал ухуулгыг олж харав. Вэб сайт дээр дурдсан “Зүүний Аянга” бол Чэн эгчийн надад номлосон Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажил болохыг ухаарах үедээ би мэл гайхаж, сэтгэл ихэд үймлээ: Би итгэлийн замаасаа төөрчихсөн юм гэж үү? Юу хийх ёстой вэ? Гэвч, уулзах

---

болгонд Чэн эгч болон бусад нь надад маш элэгсэг ханддаг, интернэтэд бичсэнтэй огт адилгүй байдгийг би саналаа. Бурханы үгийг анх уншиж эхлээд Бурханы хайранд сэтгэл хөдөлж байсан үеэ би бодов—тэдгээр үг эрх мэдэл, хүч чадлыг агуулж байсан тул Бурханы илэрхийлэл, дуу хоолой биш байж яаж болох юм бэ? Тэгээд би Бурханы үгийг уншихаар гаргаж ирсэн ч анх байсан сэтгэл хөдлөлийн мэдрэмжээ дахин мэдэрч чадсангүй—Бурхан надаас нүүрээ нуужээ. Цагаан цаас, хараар бичсэн үгээс өөр зүйл надад харагдсангүй. Интернэтээс уншсан сөрөг суртал ухуулгын хэсэг бүр нэг нэгээрээ оюун санаанд минь харван орж ирж байлаа. Би яахаа мэдэхээ болив. “Үүнд итгэх хэрэгтэй юу, үгүй юу? Зүүний Аянга Бурханы ажил мөн үү? Зүүний Аянга үнэхээр Бурханы ажил байвал яах билээ? Энэ итгэлийг хэрэгжүүлэхгүй бол Бурханыг мэдэж, аврагдах боломжоо алдчих биш үү? Гэхдээ энэ худал байхад нь сохроор дагачихвал би мэхлэгдсэн гэсэн үг болох биш үү? Үүнийг лавшруулан судлах хэрэгтэй юу, үгүй юу?” хэмээн гайхширсаар байв. Эдгээр асуулт намайг шаналгасаар, бүр ажил хийх ч сонирхолгүй болголоо. Би үнэхээр энэ тухай гэр бүлийнхэнтэйгээ ярилцаж, зөвлөгөө авахыг хүссэн ч хадам дүүгийн хэрхэн анхаарал болгоомжтой байж, өөр чуулган хайж энэ тэрүүгээр явахгүй байхыг удаа дараа захисныг бодлоо. Хэрэв би итгэлдээ үнэхээр алдсан байвал тэд намайг бүр ч хатуу зэмлэх биш үү? Хэдийгээр би туйлдаа хүртэл сэтгэлээр унаж, сэтгэл минь маш их өвдөж, яах учраа олохгүй байсан ч гэр бүлийнхэнтэйгээ зөвлөлдөх санаагаа орхив. Хэдэн өдрийн өмнө эгч нартай нөхөрлөж байхдаа мэдэрч байсан баяр баясгалан, амар тайван байдлаас тэс өөр санагдаж байлаа.

Хэнд хандахаа мэдэхээ больсон болохоор би Бурханд залбирч, Бурханыг эрж хайхыг хичээн, зүрх сэтгэл дэх бэрхшээл, айдас нэг бүрээ Түүнд даатган, Түүнээс гэгээрэл гуйлаа. Залбирсны дараа Чэн эгчийн надад нэгэнтээ хэлж байсан үг гэнэт санаанд оров: Эзэн Есүсийг төрөх үед Херод хаан сэнтийгээ алдахаас айсандаа хот даяарх хоёр нас хүрээгүй бүх эрэгтэй хүүхдийг алах тушаал гаргасан. Эзэн Есүсийг сургаалаа хэлэх үед, итгэгчид нь Эзэн Есүсийг дагаж, өөрсдөө байр сууриа алдах вий гэж айсандаа Иудейн шашны удирдагчид Түүнийг эсэргүүцэж, яллахын тулд галзууран догширсон. Тэд Эзэн Есүсийн үйлдсэн гайхамшгийг жирийн нэг хүн хийж чадахгүй гэдгийг мэдэж байсан ч Түүнийг санаатайгаар гүтгэн, Беелзебүлийн тусламжтайгаар чөтгөрүүдийг хөөж байна гэгцээсэн юм. Тэд мөн Бурханыг доромжилсон хэмээн Эзэн Есүсийг буруутгасан. Эцэст нь тэд Ромын засгийн газартай хамтран Эзэн Есүсийг цовдолсон. Харин өнөөдөр ХКН-ын засгийн газар болон шашны нийгэмлэгийнхний Төгс Хүчит Бурханыг яллах гэсэн галзуурсан үйлдлүүд нь Нигүүлслийн эрин үед Ромын засгийн газар болон Иудейн шашны удирдагчдын Эзэн Есүсийн эсрэг үйлдсэн гэмт хэрэгтэй яг адилхан байна. Эрт цагаас хойш л үнэн зам дарангуйлалд өртөж ирсэн. Ажиллахаар ирэх бүрдээ Бурхан шашны

---

ертөнц болон эрх баригч хүчний хавчлагыг амсдаг. Гэсэн хэдий ч хэн ч Бурханы ажлын замд хөндөлсөж чадахгүй. Эцсийн эцэст Эзэн Есүс загалмайд цовдлогдож, хүн төрөлхтнийг аврах ажлаа мөн л гүйцэлдүүлсэн ба Түүний сайн мэдээ бүх дэлхий даяар түгсэн. Харин өнөөдөр Хятадын засгийн газар, шашны нийгэмлэгийнхэн Төгс Хүчит Бурхан болон Түүний ажлыг яллах маш олон цуу яриа зохиож онлайнаар тараасан хэдий ч Түүний хаанчлалын сайн мэдээ мөн л хурдацтай тархсан. Хэрэв энэ Бурханы ажил биш байсан бол Хятадын засгийн газар аль эрт арчин хаячих байсан бус уу? Тэгтэл, уулзах бүрийд Чэн эгч болон бусад нь надад үнэхээр чин сэтгэлээсээ хандаж, бас тэдний бүх нөхөрлөл Бурханыг өргөмжилж, Бурханыг гэрчилж байсан нь санаанд оров. Тэд дэлхий ертөнцийн зүйлсийн тухай, эсвэл хүмүүсийн аминд ашиг тусгүй зүйлсийн талаар хэзээ ч ярьдаггүй байлаа. Энэ бүхэн нь намайг эерэг удирдамж, тусламжаар хангасан. Зүрх сэтгэлд минь байсан эргэлзээ нэг мэдэхэд хаашаа ч юм сарниж алга болсон байсан тул би эрж хайсан сэтгэлээр Бурханд дахин залбирсан юм: “Бурхан минь! Та үнэхээр эргэн ирсэн юм бол Таны ажлыг мэдэж, Таны өмнө эргэн очиход намайг замчлаач.” Мэдээж Бурхан залбирлыг минь сонсжээ.

Ариун Сүнсний удирдамж дор би “Үг нь махбодоор илэрсэн” гэх Бурханы үгийн номоос “Бурхан хүмүүсийн дунд агуу зүйл хийснийг чи мэдсэн үү?” гэсэн өгүүллийг харав. Тэнд Төгс Хүчит Бурхан ийнхүү хэлжээ: **“Хэрэв энэ махбод байгаагүй бол бүх хүн төрөлхтөнд зайлахын аргагүй гамшиг нүүрлэж, эцсийн өдрүүдэд хүн төрөлхтөнд Бурханы оноох илүү хүнд шийтгэлээс зайлж зугтах боломжгүй болох байсныг та нар мэдэх ёстой. Хэрэв энэхүү эгэл жирийн махбод төрөөгүй бол та нар бүгд амьдарч чадахгүй атлаа амьдрал гуйж, үхэж чадахгүй мөртөө үхлийн төлөө залбирах байдалд орох байлаа. Хэрэв энэ махбод байгаагүй бол та нар үнэнийг олж авч, өнөөдрийн Бурханы сэнтийн өмнө ирж чадахгүй, харин жигшүүрт нүглийнхээ улмаас Бурханд шийтгүүлэх байсан юм. Хэрвээ Бурхан махбодоор эргэж ирээгүй бол хэнд ч аврагдах боломж олдохгүй байх байсан; энэ махбод ирээгүй бол Бурхан аль эрт хуучин эрин үеийг төгсгөх байсан гэдгийг та нар мэдсэн үү? Ийм байтал, хоёр дахь удаагаа бие махбодтой болсон Бурханыг та нар голсоор байж чадна гэж үү? Та нар энэхүү эгэл жирийн хүнээс маш их ашиг тус хүртэж чадах байтал яагаад Түүнийг баяртайгаар хүлээн авахгүй байна вэ?”** “Бурханы ажил бол чиний ойлгож ухаарч чадахгүй зүйл юм. Хэрвээ чи сонголт чинь зөв эсэхийг ч бүрэн ухаарч чадахгүй, Бурханы ажил амжилт олох эсэхийг ч мэдэж чадахгүй бол азаа үзээд, энэхүү эгэл жирийн хүн чамд асар их тус хүргэх эсэхийг, мөн Бурхан үнэхээр агуу ажлыг хийсэн эсэхийг харж яагаад болохгүй гэж?” Бурханд талархъя! Бурханы үгийг уншсаны дараа би хамаагүй их тайвширлаа. Энэ үнэхээр зөв ажээ! Бурханы ажлыг сайн мэдэхгүй, бас интернетэд байгаа

---

тэр бүх зүйлийг бүрэн дүүрэн ойлгодоггүйгээс хойш азаа туршихад болохгүй гэх газаргүй гэдгийг би ухаарав. Цааш улам гүнзгийрүүлэн судалж, дүгнэлтэд хүрч яагаад болохгүй гэж? Хэрэв энэ үнэхээр Бурханы илрэлт, ажил байхад нь би голбол Бурханыг голсон хэрэг болохгүй гэж үү? Энэ тэгээд насан туршийн харуусал болох биш үү? Би маргааш нь явж Чэн эгчтэй уулзан, үргэлжлүүлэн эрж хайж, судлахаар шийдэв.

Чэн эгчтэй уулзаад би түүнтэй өнгөрсөн хэдэн өдрийн туршлагыг хуваалцаж, Зүүний Аянгад үнэхээр юу тохиолдоод байгааг асуулаа. Эгч надад Бурханы үгээс хоёр хэсгийг уншиж өгөв: “Бүх хүн анхааралтай байж, бүх зүйл шинэчлэгдэн сэргэж, хүн бүр эргэлзэлгүйгээр Бурханд захирагдаж, Бурханы ачааны хүнд хариуцлагыг үүрэхэд бэлэн байх үе нь зүүний аянга цахиж, зүүнээс баруун зүгт байгаа бүхнийг гэрэлтүүлж, энэхүү гэрлийн ирэлтээр газар дэлхийн бүх хүнийг айлгах үе юм; энэ мөчид Бурхан дахин нэгэнтээ шинэ амьдралыг эхэлдэг... Өөрөөр хэлбэл, Бурханы Өөрийн гэрчлэл эхлэх үед, Түүнийг ажиллаж эхлэх үед, бурханлаг чанар газар дэлхий даяар бүрэн эрх мэдлийг эзэмшиж эхлэх үед дэлхий ертөнцийн зүүн зүгт—бүхий л орчлон ертөнцөд мөнхөд гэрэлтсэн, зүүний аяндын гялалзсан цацраг байдаг. Газар дэлхийн улс орнууд Христийн хаанчлал болох үе нь бүхий л орчлон ертөнц гэрэлтүүлэгдэх үе билээ. Одоо үе бол зүүний аянга цахих үе. Бие махбодтой болсон Бурхан ажиллаж эхэлдэг, түүнчлэн бурханлаг чанараар шууд ярьдаг. Бурхан газар дээр ажиллаж эхлэх үе нь зүүний аянга цахих үе юм гэж хэлж болно. Илүү тодорхой хэлбэл, амийн ус сэнтийнээс урсах үе—сэнтийнээс гарах айлдваруудын эхлэх үе нь—яг нарийндаа долоон Сүнсний айлдварууд албан ёсоор эхлэх үе юм” (“Үг нь махбодоор илэрсэн” номын Бүх орчлон ертөнцөд хандсан Бурханы айлдваруудын нууцын тухай тайлбарын “12-р бүлэг”). “Зүүн зүгийн гэрэл аажмаар цайрах үед л дэлхий даяарх харанхуй аажмаар гэгээрч эхлэх ба тэр үед л Намайг Израилиас олон жилийн өмнө яваад зүүн зүгт шинээр мандаж буйг хүн төрөлхтөн олж мэднэ. Нэгэн цагт Би Израильд бууж, дараа нь тэндээс явсан учир Израильд дахин төрж чадахгүй. Учир нь Миний ажил бүх орчлон ертөнцийг удирдан чиглүүлдэг бөгөөд үүнээс гадна аянга шууд зүүнээс Баруун зүгт цахидаг. Энэ шалтгааны улмаас Би зүүн зүгт бууж, Канааныг зүүн зүгийн хүмүүст авчирсан. Би хүмүүсийг дэлхийн өнцөг булан бүрээс Канааны нутагт авчрахыг хүсдэг, тиймээс бүх ертөнцийг удирдахын тулд Канааны нутагт айлдвараа айлдсаар байх болно. Одоо Канаанаас бусад бүх газарт гэрэл байхгүй бөгөөд бүх хүн өлсгөлөн, хүйтний аюулд нэрвэгдээд байна. Би алдар суугаа Израильд өгснөө буцаагаад авсан бөгөөд дараа нь Израильчуудыг мөн бүх хүн төрөлхтнийг зүүн зүгт авчирсан. Би бүгдийг нь гэрэлд авчирсан, ингэснээр тэд дахин гэрэлтэй золгож, холбоотой болж, цаашид гэрлийг хайх шаардлагагүй болно. Гэрлийг хайж буй бүх



---

хүнд дахин гэрлийг харж, Израильд байсан алдар сууг минь харахыг Би зөвшөөрнө; Би эрт дээр үед хүн төрөлхтний дунд цагаан үүл хөлөглөн бууж ирснийг, тоолж баршгүй цагаан үүл, элбэг дэлбэг жимсийг багц багцаар нь тэдэнд харуулж, цаашлаад Израилийн Ехова Бурханыг харуулна. Би тэдэнд Еврейчүүдийн Эзэн, удаан хүлээсэн Мессияг болон үеийн үед хаадад хавчигдан шахагдаж ирсэн Өөрийнхөө илрэлтийг бүтнээр нь харуулна. Би орчлон ертөнц даяар ажиллаж, агуу ажил гүйцэтгэн, эцсийн өдрүүдэд хүн төрөлхтөнд бүхий л алдар суу, үйлээ илчилнэ. Би олон жил Намайг хүлээж байсан хүмүүст, Намайг цагаан үүл хөлөглөн ирэхийг хүсэн хүлээсэн хүмүүст, дахин нэг удаа гарч ирэхийг минь хүсэн хүлээж байсан Израильд болон Намайг хавчин шахдаг бүхий л хүн төрөлхтөнд өөрийн алдар суут төрхөө бүрэн дүүрэн харуулна. Ингэснээр Би олон жилийн өмнө алдар суугаа зүүн зүгт авчирсан бөгөөд Миний алдар суу Иудейн нутагт байхаа больсон гэдгийг бүгд мэдэх болно. Учир нь эцсийн өдрүүд аль хэдийн иржээ!” (Үг нь махбодоор илэрсэн номын “Хаанчлалын сайн мэдээ ертөнц даяар тархахыг зөгнөсөн Долоон Аяндын Нүргээн”).

Дараа нь эгч ингэж нөхөрлөлөө: “Эцсийн өдрүүд дэх Бурханы ажил болон үг нь Зүүнээс ирдэг аянга болохыг Бурханы үгээс бид харж болно. ‘Аянга’ гэдэг нь гэрлийг, ‘гэрэл’ гэдэг нь Бурханы үгийг хэлж байгаа юм; өөрөөр хэлбэл, эцсийн өдрүүдэд Бурхан эргэн ирэх гэдэг нь Бурхан хүний Хүүгийн дүрээр бие махбодтой болж, эхлээд Дорно зүгт буюу Хятадад гарч ирж, ажиллан, үг айлдаж, бүлэг ялагчдыг бий болгох явдал. Харин дараа нь Түүний эцсийн өдрүүдийн сайн мэдээ Өрнө зүгт хурдацтай түгж, ингэснээр дэлхий дахины бүх хүн Бурханы эцсийн өдрүүдийн авралыг хүлээн авч чадна. Энэ нь Матай 24:27-д: **‘Аянга зүүнээс цахилж, баруун зүгт ч гэсэн гялбадаг шиг; хүний Хүүгийн ирэлт нь ч мөн тийм байх болно’** гэж бичсэнийг биелүүлдэг. Мөн түүнчлэн, эцсийн өдрүүдэд Бурханы ажиллах цаг яг л аянга мэт ахар бөгөөд түргэн дуусдаг. Хоёрхон арван жилийн хугацаанд Бурханы хаанчлалын сайн мэдээ эх газрын Хятад даяар аль хэдийн түгээд, дэлхий дахины улс орнуудад тархаж байна. Зүүний Аянга бол Бурханы эцсийн өдрүүдийн үг болон ажил, Бурханы илэрхийлсэн үнэн юм. Төгс Хүчит Бурхан бол Библид зөгнөсөнчлөн эцсийн өдрүүдэд хүний өмнө гарч ирдэг хүний Хүү; Тэрээр эцсийн өдрүүдэд шинэ ажлыг хэрэгжүүлдэг. Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн зөвшөөрдөггүй бүх хүн Ариун Сүнсний ажлаар таягдан хаягдах болно.” Үүнийг сонсох үедээ л би Зүүний Аянга гэдэг нь Бурханы ажил, Бурханы илэрхийлсэн үнэнийг хэлж байгаа бөгөөд энэ бол эцсийн өдрүүд дэх Бурханы илрэлт юм гэдгийг ухаарав! Бурхан анх бурхангүй үзэлтэй улс төрийн хүчин болох Хятадад илэрч, ажиллаж эхэлсэн. Тэр эхлээд Хятадад бүлэг хүмүүсийг ялагч болгон байлдан дагуулж, төгс болгон, дараа нь үүнийгээ

---

Өрнө зүг рүү, бүр цаашлаад бүх дэлхий даяар тэлсэн бөгөөд тэгснээр бүх улс үндэстэн, бүх газар нутгаас Бурханы сонгосон хүмүүс Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн зөвшөөрч, Бурханы ариусгалт, авралыг хүртэн, Бурханы зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөг бүрэн биелүүлж чадах байв. Энэ Түүний мэргэн ухааны илрэл биш гэж үү? Бурхан Өөрөө эдгээр нууцыг илчлэхийн тулд үг айлдаагүй бол би хэзээ ч ойлгож чадахгүй байлаа!

Чэн эгч нөхөрлөлөө ийнхүү үргэлжлүүлэв: “Тэвч Бурханы илрэлт, ажилтай нүүр тулаад бүх урсгалын удирдагчид эрж хайж, судалж чадаагүйгээр үл барам бүр Бурханыг улайран яллаж, эсэргүүцэж, доромжилсон. Тэд Төгс Хүчит Бурханы Чуулганы нэрийг сэвтээхийн тулд олон нийтэд цуу яриа түгээн, Төгс Хүчит Бурханы хаанчлалын сайн мэдээ түгэхийг зогсоож, Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг устгаж, итгэгчдийг Төгс Хүчит Бурхан руу эргэн очихыг нь болиулах гэсэндээ Төгс Хүчит Бурханыг дагадаг хүмүүсийг балмадаар хүчилж, баривчилж, хавчихын тулд бурхангүй үзэлт ХКН-ын засгийн газартай гар нийлсэн. Яг л Эзэн Есүсийг эсэргүүцэж, яллаж, цовдолсон Ромын засгийн газар, Иудейн шашны удирдагчдын адилаар тэд бүгд бол үнэнийг, Бурханыг үзэн яддаг, Бурханд дайсагнадаг сатанлаг диаволууд билээ. Төгс Хүчит Бурханы айлдсан үг бүгд үнэн бөгөөд эрх мэдэл, хүч чадал эзэмшдэг. Эдгээр үг дэлхий даяар тархмагц үнэнийг хайрлаж, Бурханы илрэлтээр цангадаг бүх хүн Төгс Хүчит Бурхан руу эргэж, Түүнд шүтэн мөргөнө. Тэр үед хэн ч тэднийг үргэлжлүүлэн дагахгүй гэдгийг тэд мэддэг. Тиймээс, Бурхан хүн төрөлхтнийг аврахаар ажиллахын тулд дахин нэг удаа бие махбодтой болсон болохоор бурхангүй үзэлтэй ХКН-ын засгийн газар болон шашны нийгэмлэгийн антихрист хүчин Бурханы ажилд саад болж, устгахаар цөхрөнгөө баран оролдож байгаа юм. Тэд, үнэн замыг эрж хайж, судалж шинжлэхээс нь сэргийлэхийн тулд төрөл бүрийн жигшүүрт арга барил ашиглан хүмүүсийг хүлж, мэхэлдэг. Интернэтэд байгаа тэдгээр цуу яриаг уншсаны дараа чи Бурханы ажилд эргэлзэж эхэлж байгаатай яг адил—Сатаны зорилго бол бид бүгдийг Бурханд эргэлзүүлэх явдал юм. Хүмүүсийг үргэлж хянаж, хор хөнөөл учруулж байх ёрын муу зорилгодоо хүрэхийн тулд Сатан биднээс Бурханыг үгүйсгэж, Бурханаас урваж, Бурханы авралыг алдаж, өөрийнх нь эзэмшил дор эргэн очоосой гэж хүсдэг. Бурханы үгэнд илчилсэнчлэн: **‘Бурхан Өөрийн ажлыг хийж, Бурхан нэг хүнийг халамжилж, энэ хүнээ харж ханддаг ба тэр зуур Сатан Түүний алхам бүрийг тувт салахгүй мөрддөг. Бурхан хэнийг л ивээнэ Сатан араас нь мөшгөж, мөн л ажигладаг. Хэрвээ Бурхан энэ хүнийг хүсвэл, Сатан Бурханд саад болохын тулд Бурханы хийдэг ажлыг уруу татаж, үймүүлж, сүйрүүлэхээр янз бүрийн хорон муу заль мэх ашиглан далд зорилгодоо хүрэхийн төлөө чадах бүхнээ хийнэ. Энэ зорилго нь юу вэ? Бурхан хэнийг ч олж авахыг тэр хүсдэггүй; Бурханы хүсдэг бүх**

---

хүнийг тэр өөртөө авахыг хүсдэг, тэднийг эзэмдэж, хянаж, удирдахыг хүсдэг ба ингэснээр тэд түүнийг шүтэж, муу үйл үйлдэхэд нь түүнтэй нэгдэх юм. Энэ нь Сатаны хорлонтой сэдэл биш гэж үү?’ (Үг нь махбодоор илэрсэн номын “Цор ганц Бурхан Өөрөө IV”). Бид Бурханы үгийн дагуу Сатаны заль мэхийг нэвт харах ёстой; Бурханы дайсан байж, хүмүүсийг Бурхан руу эргэн очиход саад хийдэг Сатаны ёрын муу мөн чанарыг бид тодорхой харах ёстой. Хүмүүсийг эзэмдэж, бүхлээр нь залгих гэсэн өөдгүй муу санаа зорилгыг нь бид харах ёстой бөгөөд тэгснээр Бурханаар авруулах боломжоо алдахгүй.” Бурханы үгийг уншиж, эгчийн нөхөрлөлийг сонсоод би онлайнд байсан тэр бүх цуу яриаг Сатан гаргасныг үнэхээр ойлголоо. Тэдгээр нь, үнэн замыг судалж, Бурхан руу эргэн очиход нь хүмүүст саад учруулахаар Сатаны тавьсан урхи, занга гэдгийг би ойлгосон. Хэрэв тэдгээрийг ялгаж салгах чадвар надад дутагдсан бол би Сатанд олзлогдох байжээ. Эгчийн нөхөрлөл надад Зүүний Аянгын тухай, мөн энэ нь Бурханы илрэлт, ажил гэдэг тухай жинхэнэ ойлголтыг өгсөн билээ. Би одоо ХКН-ын засгийн газар болон шашны нийгэмлэгийн сатанлаг ёрын муу хүчний Бурхан руу дайрахдаа ашигладаг жигшүүрт арга барилыг танин мэдэх чадвартай болсон; бас үнэн зам эрт цаг үеэс л дарангуйлалд өртөж ирснийг харсан. Гайхалтай нь Сатаны учруулсан саад Бурханы ажлыг илүү сайн ойлгох боломжийг надад бүрдүүлж, Сатаныг үнэхээр танин мэдэж, түүнийг голох боломжтой болгожээ. Бурханы мэргэн ухаан үнэхээр Сатаны арга заль дээр суурилан хэрэгждэг. Бурханд талархъя!

Гэртээ харьсныхаа дараа би Төгс Хүчит Бурханы Чуулганы видеонуудыг онлайнаар үзэж эхлэв. Нэг дор би найрал дууны арван цуврал видео, бас Бурханы үгийн хэдэн уншлага, хэдэн сайн мэдээний кино үзлээ. Эдгээр видео, киноны илэрхийлж байгаа бүхэн үнэн байсан бөгөөд Бурханы илрэлт, эцсийн өдрүүдийн ажлыг гэрчилж байв. Эдгээр нь надад Бурханы жинхэнэ, хайр татам байдлыг олж харан, Бурханы зөвт зан чанарын талаар тодорхой хэмжээний мэдлэгтэй болоход тусалсан юм. Төгс Хүчит Бурханы айлдсан үг бүгд үнэн бөгөөд хүмүүсийг өөрчилж, цэвэрлэж, аварч үнэхээр чадаж байгааг харсан нь надад тэнгэрийн хаанчлалд хүрэх замыг олох боломж олгон, аврагдах итгэл найдвар өгсөн билээ. Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн зөвшөөрснийг минь сонсоод хадам дүү минь хэд хэдэн удаа ирж төвөг удсан ба ийм юм хийлгэхээр чуулганыхаа хэдэн хүнийг ч бас цуглуулсан юм. Бас намайг будилуулж, Төгс Хүчит Бурханд итгэх итгэлийг минь орхиулах гэсэндээ интернэтэд байсан ихээхэн сөрөг мэдээг тоть шиг давтаж байлаа. Гэсэн хэдий ч би Төгс Хүчит Бурханы ажлын талаар аль хэдийн бүрэн дүүрэн итгэлтэй болсон байсан болохоор тэдгээр цуу яриа надад ямар ч нөлөө үзүүлсэнгүй. Эргээд харахад Бурханы удирдамж л надад зарим үнэнийг ойлгох боломж олгожээ. Би алхам алхмаар цуу ярианы дөнгө, хүлээсээс ангижирч, үнэн зам дээр сууриа тавьсан юм. Намайг аварч,

---

хамгаалж, Бурханы гэр рүү замчилсных нь төлөө Бурханд талархъя!

## 19. “Шууданч тагтаа” чухал мэдээ авчирлаа

Су Жие, Хятад

1999 оны нэг өдөр, цуглаан дууссаны дараа пастор надад дөхөж ирээд, “Су Жие, чамд захиа ирсэн” гэлээ. Би үүнийг хармагцаа Шаньдунд байгуулсан чуулганаас маань ирсэн гэдгийг мэдэв. Захиаг аваад, харихаар алхах замдаа: “Энэ захиа их зузаан юм, тэдэнд зарим нэг бэрхшээл тулгараа юм болов уу?” гэж бодлоо.

Би гэртээ ирээд, хүлээж тэвчилгүй захиаг нээж, ингэж бичсэн байхыг харав: “Су эгч, та Эзэн дотор амар амгалан байх болтугай! Би танд зарим нэг гайхалтай мэдээ дуулгахаар бичиж байна: Бидний өдөр шөнөгүй хүсэн эрмэлздэг Аврагч, Эзэн Есүс маань эргэн ирсэн. Тэр аль хэдийн махбодод эргэн ирсэн ба Өөрийн үгээр хүмүүсийг шүүж, цэвэрлэх ажлын үе шатыг Хятадад хийж байгаа; Тэрээр Нигүүлслийн эрин үеийг төгсгөж, Хаанчлалын эрин үеийг эхлүүлсэн... Та Бурханы шинэ ажлыг хүлээн зөвшөөрч, Бурханы мөртэй хөл нийлүүлнэ гэж би найдаж байна. Та юу ч хийсэн бай, Бурханы эцсийн өдрүүдийн авралын энэ боломжийг битгий алдаарай.” Энэ хүртэл уншмагцаа би: Тэд үнэн хэрэгтээ ямар ч бэрхшээлтэй тулгараагүй, харин Зүүний Аянгад итгэсэн байх нь! хэмээн цочирдлоо. Би энэ захиаг хэн бичсэнийг мэдэхийг ихэд хүссэн тул хурдхан шиг сүүлчийн хуудсыг эргүүлэв. Энэ захиаг Мэн ах бичсэн болж таарсан бөгөөд төгсгөлд нь чуулганы бүх ах, эгч нарын гарын үсэг байлаа. Би захиаг уншиж дуусаад мэгдэн цочирдов. Хэвийн байдалдаа орохын өмнө би хэсэг гөлөрч, дотроо ингэж бодов: “Зүүний Аянга Эзэнийг эргэн ирсэн гэж гэрчилдэг бөгөөд нэлээд хэдэн урсгалын олон сайн, тэргүүний хонийг хулгайлсан. Шаньдуны чуулганы Мэн ах ч бас Зүүний Аянгад итгэх юм гэж би хэзээ ч бодсонгүй. Энэ чуулганы ах, эгч нарыг бүгдийг нь Зүүний Аянга хулгайлжээ. Яах вэ?” Энэ талаар бодоод бүр ч их яарсан боловч Шаньдун руу явахад хэтэрхий хол байсан ба би эндхийн ажилдаа маш завгүй байлаа. Яг тэр үед би явж чадахгүй байв. Арга мөхөстсөн би уйлж, Эзэнд ингэж залбирахаас өөр яаж ч чадсангүй: “Эзэн минь! Энэ ах, эгч нар Танд тийм ч удаан итгээгүй бөгөөд тэдний суурь хараахан тогтвортой биш. Тэднийг хамгаалаач...”

Дараа нь би Библиэс хайж, үзэг цаас нийлүүлэн эхний захиагаа тэдэнд бичлээ. Захиандаа би ингэж бичив: “Есүс Христ дэх ах, эгч нар минь, би та нарт сэрэмжтэй байхыг зөвлөө. Паул: ‘Христийн нигүүлсэл рүү та нарыг дуудсан Түүнээс та нар ийм түргэн салж, өөр сайн мэдээ рүү эргэсэнд би гайхаж байна: Тэр бол өөр сайн мэдээ биш; харин та нарыг үймүүлж, Христийн сайн мэдээг гуйвуулах зарим хүн байгаа. Харин бид эсвэл тэнгэрэлч ч

---

гэсэн бидний та нарт тунхагласнаас өөр сайн мэдээг тунхаглавал тэр хараагдаг. Өмнө нь бидний хэлсэнчлэн, би одоо дахин хэлье, та нарын хүлээж авснаас өөр сайн мэдээг хэн нэгэн та нарт номловол тэр хараагдаг’ (Галат1:6–9) гэж хэлсэн. Ах эгч нар минь, та нарыг Эзэний өмнө авчрах амаргүй байсан; та нар Эзэнээс ийм хурдан урваж яаж чадаж байна аа? Та нарын биеийн хэмжээ хэтэрхий жаахан, бусад замуудыг дураараа бүү сонс! Та нар намайг сонсох ёстой, учир нь та нартай миний хуваалцсан зүйл бол үнэн зам юм. Зөвхөн Эзэн Есүс Христ л бидний Аврагч. Та нар үүнийг үүрд баримтлах ёстой...” Бичиж дуусаад найман хуудас захиа руугаа харсны дараа л би тайвширсан юм: Тэгээд дотроо ийнхүү бодлоо: Би бичих хэрэгтэй бүхнээ бичиж, шалгах хэрэгтэй бүх бичвэрээ шалгаж, өгөх ёстой зөвлөгөө болон зоригжуулалтын үгээ ч бичлээ. Үүнийг уншсанаах дараа тэд гарцаагүй надад хариу бичиж, өөрсдийн алдааг хүлээн зөвшөөрөх болно гэж би итгэж байна.

Хоёр долоо хоногийн дараа би ийм хариу авав: “Су эгч ээ, бид харсан, сонссон болгоноо ярихгүй байж чадахгүй нь, учир нь бидний итгэдэг Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс мөн. Бид үнэн замыг баримталж, урагшилж байна; бид Эзэнээс өчүүхэн ч урваагүй, харин Эзэний мөрийг дагаж байгаа. ‘Христийн нигүүлсэл рүү та нарыг дуудсан Түүнээс та нар ийм түргэн салж, өөр сайн мэдээ рүү эргэсэнд би гайхаж байна: Тэр бол өөр сайн мэдээ биш; харин та нарыг үймүүлж, Христийн сайн мэдээг гуйвуулах зарим хүн байгаа’ (Галат1:6–7) гэх Паулын үгийг та дурджээ. Паулын хэлсэн эдгээр үгэнд цаад шалтгаан бий. Паулын тэр үед ярьсан ‘өөр сайн мэдээ’ нь фарисайчууд хүмүүсээс Еховагийн хуулийг сахихыг шаардаж байсныг хэлсэн болохоос эцсийн өдрүүдийн хүмүүс хаанчлалын сайн мэдээг түгээж, Эзэн махбодоор эргэн ирсэн ба Бурханы гэрээс эхлэн шүүлтийн ажлаа хийж байгаа гэж гэрчилж байгааг хэлээгүй гэдгийг мэдэхийн тулд бид Библийг л судлах хэрэгтэй. Паул Галатын чуулгануудад энэ захидлыг бичих үед Бурханы хаанчлалын сайн мэдээг номлосон нэг ч хүн байгаагүй. Тиймээс, Паулын хэлсэн ‘өөр сайн мэдээ’ нь Эзэн эргэн ирж, эцсийн өдрүүдийн шүүлтийн ажлаа Бурханы гэрээс эхлэн хийж байгааг хэлдэггүй. Эзэний хийхээр эргэн ирсэн шүүлтийн ажлын энэхүү алхам нь Илчлэлийн номын энэ зөгнөлийг биелүүлдэг: **‘Тэнгэрийн дундуур өөр нэг тэнгэрэлч нисэж байгааг би харлаа. Газар дээр оршин суугчид, бүх үндэстэн, овог, хэлтэн, ард түмэнд тунхаглах мөнхийн сайн мэдээ түүнд байгаа ба тэр чанга дуугаар, “Бурханаас эмээж, Түүнд алдрыг өргө; учир нь Түүний шүүлтийн цаг ирлээ” гэв’** (Илчлэл 14:6–7). Энд байгаа ‘мөнхийн сайн мэдээ’ гэдэг нь хаанчлалын сайн мэдээг хэлдэг. Мөн түүнчлэн, энэ сүүлчийн авралыг Ариун Сүнс аль эрт Эзэн Есүсийн шавь нарт илчилсэн билээ. Петрийн хэлсэнчлэн: **‘Учир нь шүүлт Бурханы гэрээс эхлэх цаг болжээ’** (1 Петр 4:17). ‘Эцсийн үед илчлэгдэхэд бэлэн авралын төлөө та нар итгэлээрээ дамжуулан Бурханы

---

хүчээр хамгаалагджээ’ (1 Петр 1:5). Су эгч ээ, Эзэний эргэн ирэлт нь итгэгч бидний хүсэн хүлээдэг зүйл биш гэж үү? Одоо Эзэн үнэхээр эргэн ирсэн; бид даруухан эрэлчид байх ёстой. Бид, эхний удаа бие махбодтой болсон Бурхан болох Эзэн Есүст фарисайчуудын хандсан шиг байж, Бурханы шинэ ажлыг тодорхойлохдоо Библийн мэдлэг, үзэл, төсөөллөө сохроор ашиглаж, Эзэн Есүс хуулийг дагаагүй учраас Эзэнийг яллаж, эсэргүүцэж, дараа нь Эзэнийг цовдолсон шиг байх ёсгүй. Фарисайчууд Ехова Бурханд л итгэсэн боловч бие махбодтой болсон Ехова Бурхан—Эзэн Есүсийн ажлыг хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд эцэст нь Эзэн тэднийг яллаж, хараасан. Бидний эргэцүүлбэл зохих цуст сургамж энэ биш гэж үү? Эзэн Есүс бол бидний Аврагч гэдгийг хэн ч үгүйсгэж чадахгүй. Гэхдээ бид Эзэн Есүсийг л хүлээн зөвшөөрдөг атлаа Эзэний эргэн ирэлтийг хүлээн зөвшөөрдөггүй бол фарисайчуудтай адилхан бус уу? Тэгвэл бид Бурханд итгэдэг мөртөө Бурханыг эсэргүүцдэг хүмүүс болохгүй гэж үү? Түүнчлэн, Су эгч ээ, та бидэнд Эзэний сайн мэдээг номлосноос болж бид таны хэлснээр хийж чадахгүй. Бид Бурханд итгэдэг. Петр болон бусад элч нар нэгэнтээ, ‘Бид хүнээс илүү Бурханд дуулгавартай байх ёстой’ (Үйлс 5:29) гэж хэлсэн. Эзэний ирэхтэй холбоотой асуудал дээр бид хүнийг сонсож бүр ч болохгүй. Төгс Хүчит Бурханы үг бол Бурханы дуу хоолой гэдгийг бид хэдийнээ тогтоосон. Та ч гэсэн үүнийг судална гэдэгт бид найдаж байна.”

Захидлыг уншиж байхдаа би маш их уурлаж, өчүүхэн төдий ч үнэмшээгүй юм. Тэгээд Библийн лавлах номыг яаран гаргаж, Галатын номын танилцуулгыг гаргалаа. Би анхааралтай уншаад, ихэд гайхав: Үнэхээр үнэн байж! Паулын хэлсэн ‘өөр сайн мэдээ’ нь үнэхээр фарисайчууд хүмүүсээс Еховагийн хуулийг сахихыг шаардаж байсныг хэлсэн болохоос Эзэн эргэн ирэхдээ Бурханы гэрээс эхлэн шүүлтийн ажлаа хийхийг хэлээгүй нь лавтай байлаа. Энэ эшлэлийн агуулга ийм байсныг би яагаад ийм олон жилийн турш огт анзаараагүй байдаг билээ? Тэдний үнэмшээгүйд гайхах зүйл алга. Гэхдээ тэр үед надад, миний хэлсэн зүйл буруу байлаа ч гэсэн, тэдний номлосон шиг Эзэн эргэн ирсэн гэдгийг энэ нь баталж чадахгүй гэх өөр нэг бодол орж ирлээ. Би захиаг эхнээс нь дуустал дахин уншсан боловч унших тусам, улам их уур хүрэв. “Ийм богинохон хугацаагаар явсны дараа тэд надтай ийм өнгөөр ярьж, бүр намайг ... намайг фарисай гэж хэлж зүрхэлнэ хэмээн хэзээ ч санасангүй. Би фарисайчуудыг хэнээс ч илүүгээр үзэн яддаг. Би яаж Эзэнийг фарисайчууд шиг эсэргүүцэж чадах билээ? Би маш олон жилийн турш ихэд шаргуу ажиллаж, итгэгчдийн төлөө өдөр шөнөгүй хөдөлмөрлөсөн. Тэд яаж үүнийг мэдэхгүй байх юм бэ?” гэж бодогдов. Энэ талаар бодох тусам, надад улам таагүй санагдаж: “Үгүй ээ, энэ хэдхэн шинэ итгэгч намайг яаж няцааж чадах юм бэ? Би Библийг маш олон удаа уншсан—энэ мэтгэлцээнд ялахгүй байна гэж яавч байхгүй” гэж би бодлоо.

Ингээд би дахин нэгэнтээ үзэг цаас нийлүүлэн, хоёр дахь захиагаа ингэж бичив: “Ах,

---

эгч нар аа, Эзэн дотор амар амгалан та нартай хамт байх болтугай! Бичсэн захиаг чинь уншаад би туйлын их бухимдлаа. Миний хэлснээр хий гэж би та нараас гуйж байгаа юм биш ээ—та нар санаа зорилгыг минь үнэхээр буруу ойлгожээ. Та нар Эзэн Есүсийн замыг орхих вий гэхээс би айж байна. Учир нь Эзэн Есүс ингэж хэлсэн: **‘Тэр үед хэн нэгэн хүн та нарт “Хараач, Христ энд байна”, эсвэл “Христ тэнд байна” гэвэл түүнд бүү итгэ. Учир нь хуурамч Христүүд болон хуурамч эш үзүүлэгчид гарч ирэн агуу тэмдэг, гайхамшгуудыг үзүүлэх ба боломжтой бол сонгогдсон хүмүүсийг ч хууран мэхэлнэ’** (Матай 24 :23–24). Паул ч бас: ‘Ах дүү нар аа, Эзэн Есүс Христийн маань ирэлт болон Түүн рүү цуглах тухайдаа одоо бид та нараас гуйж байна. Христийн өдөр ойрхон байгаа тул та нар ухаан бодлоороо гуйвж дайвалгүй, сүнсээр эсвэл үгээр, эсвэл биднээс ирсэн мэт захидлаар үймүүлэгдэхгүй байгтун. Хэн ч та нарыг ямар нэг аргаар бүү мэхлэг’ (2 Тесалоник 2:1–3) гэсэн. Хайрт ах, эгч нар минь, эцсийн өдрүүдэд аюултай өдрүүд ирэх бөгөөд Эзэний ирэлтийн тухай номлож байгаа хэнд ч итгэх хэрэггүй гэдгийг би Эзэн Есүсийн нэрээр та нарт зөвлөж байна. Бид туйлын болгоомжтой байж, Эзэний үгийг оюун санаандаа хадгалах ёстой, бид буруу замыг сонгож, Эзэнийг дургүйцүүлэх вий!”

Хоёр долоо хоногийн дараа би тэднээс өөр нэгэн захиа авсан бөгөөд ингэж бичсэн байв: “Су эгч ээ, бидэнд зориулж таны олсон бичвэрүүд алдаа мадагтай биш, гэхдээ бид Эзэн Есүс эдгээр үгийг хэлсний жинхэнэ утга учрыг тодорхой мэдэж, Эзэний хүслийг буруугаар ойлгохгүй байх ёстой. Эцсийн өдрүүдэд Эзэнийг ирэхэд хуурамч Христүүд гарч ирэх болно, мөн хуурамч Христүүд Эзэний нэрийг ашиглан дүр үзүүлж, хүмүүсийг мэхлэхийн тулд гайхамшиг үзүүлнэ гэж Эзэн Есүс бидэнд тодорхой хэлсэн. Үүгээрээ Эзэн бидэнд ялгаж салга гэж хэлж байгаа болохоос Эзэний ирэлтийг номлодог бүх хүн хуурамч гэж хэлж байгаа юм биш. Хэрвээ таны хэлснээр, Эзэний ирэлтийн тухай номлодог бүх хүн хуурамч бөгөөд бид тэднээс сэрэмжилж, тэднээс татгалзах ёстой бол махбодоор эргэн ирсэн Эзэн Есүсийг хаалганы гадна үлдээх нь бидний хувьд маш амархан биш гэж үү? Эзэн дахин ирнэ гэж хэлсэн болохоор бид ингэж хэлж байна. Мэдээж, иймэрхүү үзэл бодол Эзэний хүсэлтэй нийцдэггүй. Жинхэнэ Христ болон хуурамч Христийг хэрхэн ялгах талаар Төгс Хүчит Бурханы үгийн хэсгээс бичиж явууллаа, таныг сайтар харна гэдэгт найдаж байна. Төгс Хүчит Бурхан ингэж хэлсэн: **‘Өнөө үед тэмдэг, гайхамшиг үзүүлж, чөтгөрүүдийг хөөн зайлуулж, өвчтэйг эдгээж, олон ид шид үзүүлж чадах хүн гарч ирээд, Есүс ирлээ хэмээн өөрийгөө зарлавал энэ нь Есүсийг дуурайсан муу ёрын сүнснүүдийн дүр эсгэлт байх болно. Үүнийг санаж яв! Бурхан нэг ажлаа давтдаггүй. Есүсийн ажлын үе шат аль хэдийн биелсэн ба ажлын тэрхүү үе шатыг Бурхан дахин хэзээ ч хийхгүй’** (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурханы өнөөдрийн ажлыг мэдэх нь”). Бурханы ажил үргэлж өөрчлөгдөшгүй байх боломжгүй. Бурханы ажил хэзээ ч хуучин

---

биш, үргэлж шинэ байдаг ба хэзээ ч давтагддаггүй. Яг л Хуулийн эрин үе болон Нигүүлслийн эрин үе дэх Бурханы ажил нь ажлын хоёр өөр үе шат байсантай адил. Эцсийн өдрүүдэд Бурхан хүн төрөлхтний хэрэгцээнд үндэслэн үгээрээ хүмүүсийг шүүж, цэвэрлэх ажлын нэг алхмыг хэдийн хийчихсэн. Энэ бол хүмүүсийг нэгд нэггүй ариусгаж, аврах үе шат юм. Энэ нь урьдын ажлаас илүү шинэ, илүү өндөр, илүү бодит. Бурханы илэрхийлдэг үнэнийг Бурханы ажлын үе шат болгоноос харж болох ба Бурханы ажлын мэргэн ухаан, эрх мэдэл, хүч чадлыг ч харж болно. Харин хуурамч Христүүд муу ёрын сүнсэнд эзэмдүүлсэн байдаг бөгөөд Бурханы мөн чанарыг эзэмшдэггүй. Тэдэнд үнэн огт байдаггүй тул үнэнийг илэрхийлэх чадваргүй, мөн Бурханы төгс хүчин, мэргэн ухаан болон зан чанарыг илэрхийлэх чадваргүй. Хуурамч Христүүд Бурханы ажлыг огтхон ч хийж чаддаггүй гэдэг нь тодорхой юм. Хуурамч Христүүд Эзэн Есүсийн аль хэдийн хийчихсэн ажлыг л дуурайж, хүмүүсийг мэхлэхийн тулд Христийн дүр үзүүлэхээр өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг хөөн зайлуулж, зарим нэг энгийн гайхамшиг үзүүлж л чаддаг. Эгч ээ, бид Эзэний үгийн талаар цэвэр ойлголттой байх хэрэгтэй; Эзэний хүслийг буруу тайлбарлаж болохгүй, хуурамч Христүүд эцсийн өдрүүдэд гарч ирдгээс болж тэмээн дээр ямааны гарз гаргаж бүр ч болохгүй. Тэгээд бүр Эзэний эргэн ирэлтийн ажлыг судлахгүй байж болохгүй...”

Захиан дахь ах, эгч нарын нөхөрлөл бүгд үндэслэлтэй байсан ч надад үүнийг эрж хайх юм уу тунган бодох санаа зорилго огт байсангүй. Өөрсдөд нь олж өгсөн бичвэрүүдийг минь тэд хүлээн зөвшөөрч, Эзэн рүү буцан эргэсэн эсэхийг л би анхаарч байв. Захиагаар мэтгэлцсэн энэ хоёр мэтгэлцээнийг эргээд бодоход тэд огтхон ч үнэмшээгүй байлаа. Харин ч эсрэгээрээ, би ямар ч нэр нүүргүй болтлоо тэднээр өөрийгөө няцаалгасан байв. Би яаран Эзэнд залбирч, Библи болон бүх сүнслэг номоо авч, орон дээрээ тавилаа. Тэднийг няцаах үндэслэл олохыг хүсэн, номын хуудаснуудыг эргүүлсээр байв. Тэр үед, номын хуудас эргүүлэх чимээнээс бусдаар бол өрөө нам гүм байлаа. Анзаараа ч үгүй байтал шөнө болж, би юу ч олоогүй хэвээр байв. Би ихэд ядарч, гүнзгий санаа алдан: “Энэ захианд хариу бичих үнэхээр амаргүй юм” гэж бодлоо. Тэгээд үзгээ барин ингэж хариу бичихээс өөр яаж ч чадсангүй: “Ах, эгч нар аа, захиаг чинь уншихад та нар өхөөрдөм жижиг хурга байхаа больжээ гэж санагдаж байна. Та нар намайг сонсохгүй байгаад зогсохгүй, бүр Эзэний замыг орхихоор зүтгэж байна, бас намайг ч та нар няцаалаа. Та нарын зан авир Эзэнийг гуниглуулна гэж бодож байна, би ч гэсэн маш их гунигтай байна. Эзэн Есүс та нарын сэтгэлийг хөдөлгөж, удалгүй буцан эргэхэд чинь энэ захиа туслах болтугай. Амен!”

Хоёр долоо хоногийн дараа би тэднээс өөр нэг хариу авсан бөгөөд харамсалтай нь тэд миний хайр, зоригжуулалтаас болж эргэн ирээгүй байлаа. Харин ч эсрэгээрээ, тэд эрс



---

хатуу байдлаар ингэж хэлсэн байв: “Су эгч ээ, та биднийг элсүүлсэн нь үнэн, гэхдээ үүний төлөө бид Эзэнд талархах ёстой, учир нь төөрч, тэнүүчилсэн хоньд болох биднийг таны тусламжтайгаар Бурхан сүрэгтээ нийлүүлсэн. Та бол ердөө хонин сүргийг харж ханддаг зарц, харин Эзэн Есүс л бидний жинхэнэ хоньчин. Эзэн Есүсийн хэлсэнчлэн: **‘Би бол сайн хоньчин бөгөөд Өөрийнхөө хонийг мэднэ, Өөрийнхөн хонь маань Намайг мэднэ’** (Иохан 10:14). Өөрийнх нь төлөө ажилладаг хүн бүрд Эзэн хонин сүргийг даатгадаг. Хүний хариуцлага бол ердөө тэднийг харж хандах явдал бөгөөд Эзэнийг эргэн ирэхэд хонин сүргийг буцааж өгөх ёстой. Су эгч ээ, Библи дэх Эзэн Есүсийн ярьсан ‘муу цэцэрлэгч’-ийн талаарх сургаалт зүйрлэлийг бид бүгд мэднэ. Хүчээр хөрөнгийг нь булаан эзлэхийн тулд муу цэцэрлэгчид жимс цуглуулахаар ирсэн зарцыг зоддог ба эзэн хүүгээ явуулахад тэд хөрөнгийг нь булаан авахын тулд хүүг нь алсан билээ. Эзэн эргэж ирэхдээ, энэ муу цэцэрлэгчдэд яаж хандах бол? Бид тэдэнтэй адил байх ёсгүй. Одоо Эзэн эргэн ирсэн, бид Эзэний хонийг Эзэнд шилжүүлж өгөх ёстой. Энэ бол бидэнд байх ёстой эрүүл ухаан юм шүү.”

Энэ захиа намайг үнэхээр гайхширууллаа. “Тэд нүд ирмэхийн зуурт яаж ийм ихийг ойлгож чадав аа? Шаньдунд очиж, тэр чуулганыг байгуулснаас хойш хоёрхон жил л өнгөрсөн шүү дээ. Намайг явах үед тэд итгэлээрээ ‘нялх хүүхэд’ шиг л байсан. Зүүний Аянгыг хүлээн зөвшөөрснөөс хойш хэдхэн сарын дотор тэдний үг ийм хүчирхэг болж, намайг няцаахдаа Библийн яг зөв хэсгүүдийг олж, хэлэх үггүй болгох юм гэж би огт санасангүй” гэж бодогдов. Энэ агшинд би ихэд сэтгэлээр унан, энэ ах, эгч нар Зүүний Аянгыг дагахаар тууштай шийдэж, буцахыг огтхон ч хүсэхгүй байгаа мэт санагдав. Би тэднийг эргэн ир гэж ятгаж чадахгүйгээ мэдэж байлаа. Үнэхээр сул дорой, чадал мөхөс санагдан, дөрөв дэх захиагаа дурамжхан илгээхдээ би: “Хүслээрээ болцгоо. Библид бичсэнчлэн, эрт урьдын цагаас хойш, Бурханаас үүддэг зүйл хөгжин цэцэглэж, хүнээс үүддэг зүйл ялагдана. Над руу дахин бүү бичээрэй. Та нар Эзэн Есүсийг гэх итгэл, хайраа хадгалж чадна гэдэгт найдаж байна!” гэж бичсэн юм.

Шаньдуны чуулганы ах, эгч нарын надтай хуваалцсан Бурханы эцсийн өдрүүдийн ажлаас татгалзсанаас хойш миний сүнс харанхуй, сул дорой болж, нөхцөл байдал минь ерөнхийдөө доройтлоо. Би байнга мацаг барьж, залбирч, Эзэний эсрэг яаж нүгэл үйлдсэнээ эргэцүүлсэн хэдий ч Эзэний хүслийг огт ойлгож чадаагүй ба Эзэний байгааг ер мэдэрч чадахгүй байв. Энэ хугацаанд пасторууд, ахлагч нар хандивын мөнгөний төлөө тэмцэлдэхийн тулд намайг зохиомлоор буруутгаж, чуулганаас амжилттай хөөн гаргасан юм. Би тун хөөрхийлөлтэй байсан ба хаашаа явахаа мэдэхгүй байлаа. Би үргэлж голын эрэгт очин, уйлах зуураа “Эзэн минь, Та миний хамгийн дотнын найз” хэмээх дууг дуулдаг байв. Эзэн удалгүй эргэн ирж, уй гашуугаас минь намайг аварна гэж би найдаж

---

байлаа.

Зургаан сарын дараа нэгэн өдөр, өдрийн хоолоо хийж байтал хаалганы гаднаас хадам ээж маань миний нэрийг дуудах сонсогдлоо. Хаалгаа нээгээд би аятайхан төрхтэй гоолиг залуу эмэгтэй хадам ээжийн ард зогсож байхыг харав. Хадам ээж: “Энэ бүсгүй чамтай уулзахаар ирсэн гэнэ. Хаяг чинь байгаа ч гэсэн чамайг олж чадалгүй, чуулган руу очсон байна. Чамтай даруйхан уулзах хэрэгтэй байна гэж хэлэхийг нь сонсоод би бушуухан дагуулаад ирлээ” гэв. Би тэр эгчийг анхааралтай ажиглаад, дотроо: “Яагаад түүнийг таньдаг юм шиг санагдахгүй байна аа?” гэж бодлоо. Намайг хараад тэр эгч шалавхан гарыг минь татаж, сэтгэл хөдөлсөн байдлаар: “Та тэгэхээр Су эгч байх нь ээ. Эцэст нь би таныг оллоо!” гэв. Түүний үйлдэлд цочирдсон би гайхсан харцаар түүн рүү харангаа: “Чи чинь хэн билээ? Би чамтай уулзаж байгаагүй л юм шиг байх юм?” гэж асуулаа. Тэр урам зоригтойгоор ингэж хариулав: “Эгч ээ, миний овог Ван. Шаньдуны чуулганы Мэн ах, Жао эгч хоёр намайг явуулсан. Мэн ах болон бусад маань эндхийн Төгс Хүчит Бурханы Чуулган руу захиа бичиж, яаж ч байсан таныг олох арга зам бодож ол гэж гуйсан юм. Тэд үнэхээр завгүй байгаа ба биечлэн ирэх цаг зав байхгүй байгаа учир Бурханы хаанчлалын сайн мэдээг тантай хуваалцахыг бидэнд даалгасан. Энэ захиа хэчнээн хүний гар дамжсаныг би мэдэхгүй, гэхдээ нэлээд олон хүн дамжсаны дараа бидэнд ирсэн. Би таныг сураглаж маш олон удаа энд ирсэн. Таныг олох амаргүй байлаа шүү.” Энэ хүртэл яриад залуухан эгч уйлж, захиаг гарт минь атгууллаа. Би захиаг аваад, ингэж уншив: “Су эгч Эзэнд чин сэтгэлээсээ итгэдэг. Гуйя, чи түүнийг олж, Бурханы хаанчлалын сайн мэдээг түүнтэй хуваалцах ёстой...” Эдгээр үгийг уншаад зүрх сэтгэл минь дулаацаж, нулимсаа барьж чадсангүй. Хадам ээжийн минь сэтгэл хөдөлж: “Энэ үнэхээр Эзэний ач! Энэ үнэхээр Эзэний хайр!” гэв. Сайхан сэтгэлт, чин үнэнч, залуухан эгчийг харангаа захиандахь сэтгэл хөдөлгөм, үнэн зүрхний үгийг бодоод, Эзэний эргэн ирэлтийн сайн мэдээг надтай хуваалцах гэсэн ах, эгч нарын яарсан сэтгэлийг би мэдэрсэн юм. Энэ хайр Бурханаас ирсэн гэдгийг сүнслэг зөн совин минь хэлж байлаа. Бурхан л сэтгэл зүрх нэг бүрийг ийм маягаар хайрлаж, Бурханд үнэхээр итгэдэг хүн бүрийг гүнээ анхаардаг. Иймээс, энэ удаа би Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг эрж хайж, судална хэмээн шийдэв. Би ахин татгалзаж чадаагүй билээ. Тэгээд урам зоригтойгоор: “Эгч минь, орж ирээд суу л даа” гэж хэлэв. Эгч баяртайгаар толгой дохисон ба нүдэнд нь нулимс цийлгэнэсээр байлаа.

Хооллосны дараа би цуг ажилладаг Жан эгчийг ч бас дуудав. Манай нөхөр нөхөрлөхөөр явж байгааг маань сонссон бөгөөд ажлаасаа бас чөлөө авав. Залуухан эгч найрсгаар: “Эгч ээ, Мэн ахын захианд, тэд танд Бурханы эцсийн өдрүүдийн ажлын талаар хэд хэдэн захиа бичсэн боловч таныг хүлээн зөвшөөрөөгүй гэсэн байсан. Та энэ талаар

---

ямар бодолтой байна вэ? Эгч ээ, танд ямар нэгэн бэрхшээл байвал, тэдгээрийгээ хэл л дээ, хамтдаа нөхөрлөж, эрж хайя!” гэж асуулаа. Би: “Нэгэнт чи асуусан учир би чамд дэлгэж, хэлье. Өмнө нь би эцсийн өдрүүдэд гарч ирдэг хуурамч Христүүдэд хууртахаас айж, ‘Эзэний эргэн ирэлтийн тухай номлодог бүх хүн хуурамч’ гэдгийг баримталсан тул Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг огт судлаагүй. Дараа нь би, Мэн ах болон бусдынх нь хэлснийг бодож үзсэн ба энэ нь үндэслэлтэй мэт санагдсан. Хуурамч Христүүд эцсийн өдрүүдэд гарч ирдгээс болж Эзэний эргэн ирэлтийн тухай сайн мэдээнээс сохроор татгалзах нь үнэхээр өчүүхэн эрсдэлээс болж ихийг алдаж байгаа хэрэг юм. Хэдий тийм ч гэсэн, Эзэний эргэн ирэлтийг угтъя гэвэл жинхэнэ Христ болон хуурамч Христийг ялган таних чадваргүй байж болохгүй. Чи өнөөдөр энд ирсэн юм чинь энэ талаар бидэнд нөхөрлөөч” гэлээ. Жан эгч, нөхөр болон хадам ээж минь ч санаа нэгтгэйгээр толгой дохив.

Тэгээд эгч Бурханы үгийн хэсгээс бидэнд уншиж өгсөн ба Төгс Хүчит Бурхан ингэж хэлсэн байв: **“Ийм зүйлийг судалж шинжлэх нь хэцүү биш боловч бид дор бүрнээ энэ нэг үнэнийг мэдэх шаардлагатай байдаг: Бие махбодтой болсон Бурхан Тэрбээр Бурханы мөн чанарыг эзэмшинэ, бие махбодтой болсон Бурхан Тэрбээр Бурханы илэрхийллийг эзэмшинэ. Бурхан махбод болдог тул хийхээр зорьж буй ажлаа авчирна, мөн Бурхан махбод болдог тул Өөрийн юу болохыг илэрхийлж, хүнд үнэнийг авчирч, амь хайрлаж, замыг заан харуулж чадна. Бурханы мөн чанаргүй махбод нь харваас бие махбодтой болсон Бурхан биш; үүнд эргэлзэх зүйл үгүй. Хэрвээ хүн, Бурханы махбод болсон бие мөн эсэхийг судалж шинжлэхээр зорьж байгаа бол Түүний илэрхийлдэг зан чанар, хэлдэг үгээс үүнийг нотлох ёстой. Өөрөөр хэлбэл, Бурханы махбод болсон бие мөн эсэх, үнэн зам мөн эсэхийг нотлохын тулд хүн Түүний мөн чанарт үндэслэн ялган таних ёстой. Иймээс Бурханы махбод болсон бие мөн эсэхийг тодорхойлох гол түлхүүр нь гадаад дүр төрхөөс илүүтэйгээр Түүний мөн чанарт (Түүний ажил, Түүний айлдвар, Түүний зан чанар болон өөр олон талд) оршдог. Хэрвээ хүн Түүний гадаад дүр төрхийг л шинжлээд, үүний үр дүнд мөн чанарыг нь орхигдуулбал хүн харанхуй бүдүүлэг, мунхаг гэдгийг энэ нь харуулдаг”** (Үг нь махбодоор илэрсэн номын Өмнөх үг). Бурханы үгийг уншсаны дараа, залуу эгч ингэж нөхөрлөв: “Жинхэнэ Христ болон хуурамч Христийг ялгах гол түлхүүр нь тэдний мөн чанарыг харах явдал гэдгийг Төгс Хүчит Бурханы үгээс харж болно. Үүнийг тэдний ажил, үг болон зан чанараас ялган таньж болно. Эзэн Есүс нэгэнтээ: **‘Би бол зам, үнэн, амь юм’** (Иохан 14:6) гэсэн. Мэдээж, Тэрээр махбод дахь Бурхан тул үнэнийг илэрхийлж, Бурханы ажлыг хийж чадна; бас Бурханы Өөрийн зан чанар, Түүнд юу байгаа, Тэр юу болохыг ч илэрхийлж чадна. Нигүүлслийн эрин үед Эзэн Есүс олон үнэнийг илэрхийлж,

---

голдуу өршөөл болон хайрын зан чанарыг илэрхийлж, бүх хүн төрөлхтнийг золин аврах ажлыг гүйцэлдүүлсэнтэй яг адилхан. Эзэн Есүсийн ажил, үг болон илэрхийлсэн зан чанарыг хараад Эзэн Есүс бол үнэн, зам, амь, бас бие махбодтой болсон Бурхан Өөрөө байсан гэдэгт бид итгэлтэй байж чаддаг. Одоо Төгс Хүчит Бурхан ирээд, хүн төрөлхтнийг ариусгаж, аврахын тулд бүх үнэнийг илэрхийлсэн; Тэрээр хүмүүсийг шүүж, гэсгээх эцсийн өдрүүдийн ажлыг хийчихсэн. Төгс Хүчит Бурханы үг Сатан хүн төрөлхтнийг завхруулсан тухай үнэнийг болон хүний уг чанар, мөн чанарыг илчилдэг. Тэдгээр нь аврал хүртэх гэж юу болох, зан чанарын өөрчлөлт болон түүнд хүрэх зам гэж юу болох, хүн төрөлхтний ирээдүйн хүрэх газар гэж юу болох, төрөл бүрийн хүмүүсийн төгсгөл ямар байх гэх мэт үнэний бүх талыг бидэнд хэлж өгдөг. Түүний үг бас Бурханы зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөний нууц болон бие махбодтой болохын нууцыг илчилж, Бурханы төрөлх зан чанар, мөн чанар, Түүнд юу байгаа, Тэр юу болохыг илэрхийлдэг. Бид Бурханы үгийг хичээнгүйлэн уншсан тохиолдолд Төгс Хүчит Бурханы айлдсан үг бол үнэний Сүнсний дуу хоолой, эцсийн өдрүүд дэх шүүлтийн зам мөн гэдгийг харж чадна. Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажил нь Библи дэх зөгнөлүүдийг биелүүлсэн, жишээлбэл, **‘Шүүлт Бурханы гэрээс эхэлнэ’** (1 Петр 4:17). **‘Гэхдээ үнэний Сүнс болох Тэр ирэх үедээ та нарыг бүх үнэн рүү удирдана’** (Иохан 16:13). Мөн **‘Намайг голж, Миний үгийг хүлээж авдаггүй хүнийг шүүх шүүгч байдаг: Миний хэлсэн үгс түүнийг эцсийн өдөр шүүх болно’** (Иохан 12:48). Төгс Хүчит Бурханы илэрхийлсэн үнэн, Түүний хийсэн хүмүүсийг шүүж, гэсгээж, ариусгах ажил болон Төгс Хүчит Бурханы илэрхийлсэн, зөвт байдлаар тодорхойлогдсон зан чанар нь Төгс Хүчит Бурхан бол эцсийн өдрүүдийн Христийн илрэл гэдгийг бүрэн баталгаажуулдаг. Харин эсрэгээрээ, хуурамч Христүүдэд Бурханы мөн чанар байдаггүй. Тэдний ихэнх нь муу ёрын сүнсэнд эзэмдүүлсэн байдаг, эсвэл тэд хэтэрхий бие тоосон чөтгөрүүд болон ямар ч эрүүл ухаангүй муу ёрын сүнснүүд юм. Тэд хүмүүсийг хангах үнэнийг илэрхийлж чаддаггүй, хүмүүсийг ариусгах шүүлтийн ажлыг явуулж ч чаддаггүй. Тэд өлсгөлөнгөө дарахын тулд ходоодоо талхаар дүүргэхээр эрж хайдаг тэнэг, мэдлэггүй, будилсан хүмүүст энгийн тэмдэг, гайхамшиг үзүүлэн хууран мэхэлж л чадна. Тиймээс, Христ бол үнэн, зам, амь хэмээх энэ нэг зарчмаар жинхэнэ Христ болон хуурамч Христүүдийг ялган танихад маш амархан юм. Энэ нь Бурханы хүсэлтэй бүхэлдээ нийцдэг.”

Эгчийн нөхөрлөлийг сонсоод би сэтгэлдээ ахин дахин ингэж бодсоор байлаа: “Би энэ бүх хугацаанд Эзэнд итгэсэн боловч иймэрхүү нөхөрлөл хэзээ ч сонсож байгаагүй. Одоо Төгс Хүчит Бурханы үг жинхэнэ Христ болон хуурамч Христийг ялгах талаар маш нэгд нэггүй хэлж байна; Төгс Хүчит Бурханы үг үнэхээр Ариун Сүнсний дуу хоолой байж магадгүй юм байна. Өө Эзэн минь! Таны эргэн ирэхийг би үргэлж сэтгэл түгшин хүлээсэн

---

авч сүүлийн энэ хэдэн жилд би хуурамч Христүүдээс сэрэмжлэхэд л анхаарсан ба эрж хайх зүрх сэтгэл надад бараг байсангүй. Төгс Хүчит Бурханы Чуулганы гэрчилдэгчлэн Таныг эцсийн өдрүүдийн шүүлтийн ажлыг хийхээр эргэн ирснийг би хэзээ ч судлаагүй, харин ердөө сохроор эсэргүүцэж, яллажээ. Эзэн минь, би үнэхээр Таныг гадна үлдээлээ гэж үү?” Үүнийг бодоод зүрх дэлсэж эхэллээ. Би сандарч, тайван сууж чадахгүй байсан тул босож, гал тогоо ороод өөртөө аяга ус хийж байгаа дүр эсгэн, өөрийгөө бага зэрэг тайвшруулахаар хичээж байлаа. Ус хийж байхдаа би: “Энэ эгч тун залуу боловч үнэний тухай нөхөрлөл нь үнэхээр бодит юм. Төгс Хүчит Бурханы ажлыг хүлээн зөвшөөрсний дараа Шаньдуны чуулганы ах, эгч нар ч бас маш хурдан өсжээ. Библийн талаарх ойлголт, Бурханы ажлын тухай мэдлэг нь минийхээс хамаагүй илүү байна. Энэ зам хүмүүст үнэнийг ойлгуулж, тэднийг Бурханы ажлын тухай мэдлэгтэй болгожээ. Энэ Бурханы ажил биш гэж үү?” хэмээн бодлоо. Энэ бүхнийг бодоод би баярлан хөөрөхийн зэрэгцээ бас харамсав. Тэгээд Шаньдун дахь ах, эгч нарт захиа бичиж байсан үеэ эргэн дурслаа. Би үзгээ эргүүлэн, биеэ тоосон өнгөөр тэднийг загнасан. Эзэний эргэн ирэлтэд хандаж байгаа хандлагаараа би үнэнийг эрж хайж чадаагүйгээс гадна, ах, эгч нарын нөхөрлөлийг ч хүлээн зөвшөөрөөгүй, харин ч эсрэгээрээ, хамаг чадлаараа няцааж, голсон. Би өөрийгөө үнэний эзэн хэмээн бодож, ах, эгч нарт өөрийгөө сонсгохыг хүсэхийн зэрэгцээ үнэн замыг хамгаалахын тулд чадах бүхнээ хийж байна гэж бодсон. Би өөрийгөө Бурханыг эсэргүүцэж байна хэмээн огт бодоогүй. Тэгвэл би орчин үеийн Фарисай биш гэж үү? Энэ үед, толгойноосоо хөлөө хүртэл хүйтэн усанд норсон мэт санагдсан бөгөөд тэр чигтээ үлбэгэр, сул дорой санагдаж байлаа. Миний хоёр гар хянах аргагүйгээр чичирч, оюун санаандаа би Бурханыг эсэргүүцэж байгаа дүр зургаа ахин дахин бодсоор байв... Тэгээд өөрийгөө хянаж чадахаа больж, тэсэлгүйгээр уйллаа. Хэтэрхий бие тоосон, харалган байсандаа өөрийгөө үзэн ядаж байв. Нэлээд хэсэг хугацааны дараа би нулимсаа арчиж, аягатай усаа аван өрөө рүү явав. Эгч над руу харан: “Эгч ээ, та энэ нөхөрлөлийг хүлээн зөвшөөрч байна уу?” хэмээн санаа зовнин асуусан юм. Би санаа алдаж, өөрийгөө зэмлэн: “Төгс Хүчит Бурханы үг болон чиний нөхөрлөлийг сая сонссоны дараа, Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс мөн гэдгийг би мэдэрч байна. Би Эзэний эргэн ирэхийг өдөр бүр хүлээдэг байсан боловч одоо ингээд Эзэнийг эргэн ирэхэд үнэндээ фарисай шиг авирлах юм гэж огт төсөөлсөнгүй. Би үнэхээр асар их мууг үйлджээ! Би Бурханыг эсэргүүцсэн” гэж хэлэв. Тэгээд маш их уйлж эхэлсэн болохоор цааш ярьж чадсангүй.

Дараа нь, Төгс Хүчит Бурханы үгийг хэсэг хугацаанд уншсаны дараа, Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс мөн гэдэгт Жан эгч, хадам ээж, нөхөр бид нар бүрэн итгэх болов. Би тун их баярлан хөөрч, сэтгэл хөдлөлдөө автан Шаньдуны ах, эгч нарт тав дахь захидлаа илгээсэн юм: “Хүндэт ах, эгч нар минь! Бурханы хаанчлалын сайн мэдээг

---

надтай олон удаа хуваалцсанаар чинь дамжуулан би одоо Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн зөвшөөрч, Төгс Хүчит Бурханы Чуулганы гишүүн болсон учир Бурханд талархъя. Хэдийгээр би та нараас сүүлд хүлээн зөвшөөрсөн ч, хойно хоцрохыг хүсэхгүй байна. Гүйцэж авахын тулд би зүрх сэтгэл, сүнсээ зориулах болно...” Энэ агшинд, миний зүрх сэтгэл тэнд байгаа ах, эгч нартайгаа дотночлон нэгдэхээр захиатай хамт Шаньдун руу нисэж байгаа мэт санагдав. Хайрынх нь төлөө Бурханд талархъя!

## **20. Би ХКН-ын засгийн газрын худал хуурмагийг нэвт харж, Бурханы хайр намайг Түүн рүү буцаан татдаг**

Кэму, Өмнөд Солонгос

“Би чамд дахиад нэг хэлчихье—надад наад Бурханы юмаа битгий яриад бай, чи тэр Бурханд итгэгчидтэй дахиад огт холбогдож болохгүй. Хэрвээ чи тэдэнтэй дахиад холбоо барьсан харагдвал утсыг чинь хэмх цохино шүү!”

“Яагаад? Яагаад чи миний итгэлийн замд саад болоод байгаа юм бэ?” гэж будилж гүйцсэн царай гарган, эхнэр минь асуув.

“Яагаад гэж үү? Өөрийн чинь сайн сайхан, гэр бүлийнхээ сайн сайхны төлөө тэгж байна. ХКН-ын засгийн газар Төгс Хүчит Бурханы Чуулганыг ноцтойгоор нухчин дарж, дарлаж байгааг мэдэхгүй юу? 2014 оны 5-р сарын 28-ны Жаоюанийн хэргийн талаар мэдэхгүй юу? Тэр хэргийн гол буруутан болох Жан Лидон Төгс Хүчит Бурханы Чуулганы гишүүн байсан гэж интернэтэд бичсэн байна. Хэрэв чи тэр хүмүүстэй нийлэх юм бол өөрийгөө л асар их аюулд оруулна шүү дээ!”

Эхнэр минь шийдмэгээр: “Жан Лидон болон бусад нь Төгс Хүчит Бурханы Чуулганыхан биш байсан юм—чи интернэтэд бичээтэй байгаа тийм зүйлд зүгээр л итгэхэж болохгүй шүү дээ. Би Төгс Хүчит Бурханы Чуулганы ах эгч нартай хоёр, гурван сарын турш холбоотой байлаа, тэгээд бүгд сайхан сэтгэлтэй, бусдад чин сэтгэлээсээ ханддаг шударга хүмүүс гэдгийг нь харсан. Тэд асуудал гарах бүрд бие биедээ тусалдаг, интернэтэд бичсэн зүйлтэй огт адилгүй байдаг шүү дээ” гэж хариуллаа.

Би багтартлаа уурлан, итгэж өгсөнгүй. “Интернэтэд ороод өөрөө хар л даа, тэгээд миний зөв үү, үгүй юу гэдэг нь мэдэгдэнэ.”

Дараа нь эхнэр минь намайг сандал дээр аваачиж суулгаад, “Чи минь юмыг нэгд нэггүй бодож үздэг хүн. Үүнд үндэслэлтэй хандаж, баримтын дагуу ярих хэрэгтэй—зүгээр

---

л нэг талынх нь яриаг сонсоод байж болохгүй! Хятадын томоохон хэвлэл мэдээллийн хэрэгслүүд бүгд ХКН-ын засгийн газрын гар хөл. Тэд зүгээр л ард түмнийг хуурах засгийн газрын хэрэгсэл юм. Тэдний мэдээ яаж үнэн зөв байх юм бэ? 1989 оны Тяньаньмэнийн талбайн жагсаалыг санахгүй байна уу? Тяньаньмэнийн талбай дээр оюутнууд авлига хээл хахуулийг эсэргүүцэж, ардчилсан эрх чөлөөг өмгөөлөн жагсаж байсан ч ХКН-ын засгийн газар хэсэг танихгүй хүн олж оюутны дүр эсгүүлэн оюутнуудын эгнээнд нэгтгээд, дараа нь тэднээр цэргийн машинуудыг балбуулж, хэмхлүүлж, дээрэмдүүлж, түймэрдүүлж, хөмрүүлж эхэлсэн шүү дээ. Тэр хүмүүс ихээхэн үймээн үүсгээд, дараа нь ХКН-ын засгийн газар тэдний гэмт хэрэгт оюутнуудыг зохиомлоор буруутгасан. Үүний дараа ХКН-ын засгийн газар телевиз, радио зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан агаарын долгионыг өөрсдийн мэдээгээр дүүргэж, оюутны хөдөлгөөнийг эсэргүү бослого хэмээн гүжирдсэний улмаас наад зах нь хэдэн мянган оюутан буудуулж, эсвэл танканд дайруулж амь үрэгдсэн. ХКН-ын засгийн газар үргэлж зөв шударга байдлын эсрэг цохилт өгдөг, улс төрийн өөр үзэл бодол, саналтай ямар ч бүлэг, хувь хүний оршин тогтнолыг ер тэвчдэггүй гэдгийг тэдний түүхийг мэддэг хэн бүхэн мэднэ. ХКН-ын засгийн газар дарангуйлал байгуулахын тулд ийм бүлэг, хүмүүсийг ямагт дайрч давшлан, яллаж ирсэн бөгөөд бүр тэднийг нухчин дарж, бүрмөсөн хориглоход ч хүрсэн юм. ХКН-ын засгийн газар шашин шүтлэг, ардчилсан эрхийн төлөөх хөдөлгөөн, үндэстний цөөнхийн жагсаалыг харгисаар нухчин дарах болгондоо хуурамч хэрэг зохиохоос эхэлдэг, тэгээд ард түмнийг өдөөн турхирах олон нийтийн томоохон эсэргүүцэл гаргаад, дараа нь тэднийг харгисаар нухчин дардаг. Энэ бол баримт. 5-р сарын 28-ны Жаоюанийн хэрэг бол ХКН-ын засгийн газар Төгс Хүчит Бурханы Чуулганыг гүтгэсэн, сайтан зохиосон бас нэгэн хуурамч хэрэг байсан юм.”

Би эхнэрийнхээ хэлсэн үгийг няцааж огт чадаагүй бөгөөд “Манай эхнэр Тяньаньмэнийн талбайн жагсаалын хохирогчдын гэр бүлийнхнийг таньдаг, бас цаад түүхийг нь мэддэг хүн. Эхнэрийн маань хэлсэн бүхэн үнэн. Гэхдээ л тэр Жаоюанийн хэрэг Төгс Хүчит Бурханы Чуулгантай ямар ч холбоогүй байлаа ч гэсэн би тэдний гишүүдтэй огт холбоотой байгаагүй, бас ямаршуу чуулган болохыг нь мэдэхгүй. Бид одоо ийм түгшүүртэй ертөнцөд амьдарч байхад эхнэр минь луйвардуулбал яана?” гэж дотроо бодлоо. Иймээс би эхнэртээ Төгс Хүчит Бурханы Чуулганы хэнтэй ч холбоо тогтоож болохгүй гэж дахин хэллээ. Тэгээд хаалга саван гарч явсан бөгөөд эхнэр минь уйлсаар хоцорсон юм.

Ямар ч сарны туяагүй, нэг ч одгүй гойд харанхуй шөнө байлаа. Зам даган алхаж байхад сэтгэл санаа минь үнэхээр тавгүй байсан юм. Арван жилийн хамтын амьдралаа би бодов—анх эхнэртэйгээ танилцсанаас эхлээд хайртай болж, гэрлэх хүртлээ бид маш ихийг

---

туулсан ч гэлээ юутай ч тулгарсан бай, аливааг байнга нэгд нэггүй ярилцаж, бие биеэ дэмжиж явсан юм. Бид хэзээ ч томоохон хэрүүл хийдэггүй байв. Гэтэл би итгэлийнх нь төлөө эхнэрээ үнэхээр үг хэлээр дайрчихлаа—эхнэртээ үнэхээр тэгж хандах ёсгүй байсан мэт санагдав. Гэхдээ бас Төгс Хүчит Бурханы Чуулганыг сайнгүй гэж интернэтэд бичсэн байсан болохоор итгэлээ хэрэгжүүлэхийг нь зөвшөөрөхгүй байснаараа би эхнэртээ тус хүргэж байсан юм. Эхнэр минь яагаад намайг ойлгож болохгүй байгаа юм бэ? Тэр мөчид би асар их ядарч, сэтгэл гонсойж байв. Тэгээд утсаа гаргаж ирэхэд аз жаргалтай гэр бүлийн минь сайхан зураг нүдний өмнө үзэгдэж, охины минь хонгор инээмсэглэл алжаалыг минь агшин зуур үргээлээ. Би гэр бүлийнхээ ноён нуруу бөгөөд итгэлээ хэрэгжүүлэхэд нь эхнэртээ саад хийнэ гэдэг өөрийг нь хамгаалахын төлөөх, мөн гэр бүлийн маань сайн сайхны төлөөх зүйл гэж бодсон тул шийдвэртээ үнэнч үлдэхээр сэтгэл шулуудсан юм.

Үүний дараах хугацаанд би эхнэрийнхээ намайг гэх сэтгэлд юм хийхээс айсандаа томоохон маргаан дэгдээж зүрхлээгүй болохоор зүгээр л Бурхантай холбоотой ямар ч зүйл надад битгий ярь гэж хэлсэн юм. Хэдийгээр бид гаднаа хэвийн эв эетэй байгаа харагдсан ч бидний хооронд аль хэдийн ан цав үүсэж байлаа.

Нэг өдөр би өглөөний ээлжийн ажлаа тараад, гэртээ орж ирмэгцээ унтлагын өрөөнөөс эгшиглэх цог золбоотой дууны хамт эхнэр, охин хоёрынхоо аз жаргалтайгаар инээд алдах чимээг сонсов. “Хм? Нэлээд урт удаан хугацаанд гэртээ ийм баяр хөөртэй чимээ сонсоогүй юм байна. Эхнэр минь Өмнөд Солонгост ирсэн цагаасаа хойш амьдралын хэв маяг, хэл, соёлын ялгаанаас үүдэн эндэхийн орчинд үнэндээ хэзээ ч дасаагүй юм. Ялангуяа настай ээж, дуртай ажлаа орхисон, хажууд нь ямар ч хамаатан садан, найз нөхөд байхгүй болохоор эхнэр минь үргэлж ганцаараа суугаад уйлдаг шүү дээ. Эхнэрийнхээ шаналантай, сэтгэл дундуур байгааг би хардаг байсан ч эхнэрээ яаж тайтгаруулахаа огт мэддэггүй байсан, гэтэл ямар гээч дуу эхнэрт минь одоо ийм их аз жаргал авчирч байж болох вэ?” гэж би сониучирхан бодов. Хаалгаа тун чимээгүйхэн онгойлгоод би Төгс Хүчит Бурханы Чуулганы бүтээсэн “Бурханы жинхэнэ хайр” хэмээх бүжиг, дууны видео компьютерын дэлгэц дээр гарч байхыг харлаа. Зургаан залуухан бүсгүй маш их сэтгэл хөдлөлтэйгөөр баясан бүжиглэж, дуулж байсан ч ялангуяа маш баяр хөөртэй инээмсэглэлээр дүүрэн тэдний царай сэтгэлийг минь даруй татав. Тэгээд сониуч зангаар дүүрч, “Энэ ямар гээч чуулган, ямархуу бүлэг юм бэ? Яагаад тэдний дуу, бүжиг ийм чихэнд хоногшим, сэтгэл тайвшруулам байгаа юм бэ? Хэрэв тэд үнэхээр муу хүмүүс юм бол яаж ийм эелдэг, чин сэтгэлийн инээмсэглэлтэй байж чадах юм бэ?” гэж бодлоо.

Намайг хараад охин маань: “Аав аа, энэ гоё дуу байгаа биз? Ээж бид хоёр энэ дуунд



---

үнэхээр дуртай. Бид хоёртой цуг дуулж, бүжиглэ л дээ!” гэж баяртайгаар хэлэв. Би охиноо тэврэн, өргөж аваад бяцхан царайг нь үнссэн бөгөөд дараа нь “Охин минь, аав нь эрч хүчтэй, хүчирхэг дуу, бүжигт дуртай шүү дээ” гэж эрхлүүлэн хэллээ. Охин минь толгойгоо ганхуулан, хэсэг зуур бодов. “Аав аа, та тогшуур бүжигт дуртай биз дээ? Ээж ээ, үнэхээр гоё бүжигтэй нөгөө видеог аавд тавиад өгөөч” гэлээ. Би охиныхоо үгийг тасалж чадаагүй бөгөөд Төгс Хүчит Бурханы Чуулганы бичлэг байлаа ч гэсэн жоохон үзчихье гэж бодсон юм—ойрын өдрүүдэд манай гэрт ийм эв найртай уур амьсгал ховорхон тохиолдох болсон билээ. Охиноо тэврэн эхнэрийнхээ хажууд суугаад би тэр видеог үзэж эхэллээ. “Бурхан алдар суугаа Зүүн зүгт аваачсан” гэх бүжиг дууны видео нь цоглог хэмнэлтэй, хүчирхэг, эрч хүчтэй байлаа. Товшуур бүжгийн хэв маягаар тэд тун баатарлаг ид хавтайгаар бүжиглэв. Би үргэлж дуулж бүжиглэх дуртай байсан тул үүнд үнэхээр татагдсан юм. Хэчнээн их сонирхож байгааг минь хараад эхнэр минь: “Энэ дуу бүжгийг бүгдийг нь Төгс Хүчит Бурханы Чуулганы ах эгч нар найруулж, бичсэн юм. Тэдний хэн нь ч мэргэжлийн хүмүүс биш” гэж догдлонгуй хэллээ. Үүнийг би өөрийн эрхгүй нухацтайгаар эргэцүүлэв. “Мэргэжлийн бүжгийн сургуулилтгүй хүмүүс яаж ийм гойд сайн бүжиглэж чаддаг билээ?” гэж бодогдлоо. “Гайхалтай байгаа биз дээ? Бурханы Өөрийн ажил, удирдамжгүйгээр мэргэжлийн бус хүмүүс ингэж бүжиглэж чадна гэж үү? Чи тэдний хийсэн кинонуудыг үзвэл бүр ч гайхна даа. Төгс Хүчит Бурханы Чуулган Ариун Сүнсний ажилтай, бас Бурханы ерөөлтэй. Тийм болохоор дуу, бүжиг, кино нь ийм сайн хийгдсэн байдаг юм. Үүнээс гадна, тэдний кинондoo хэлэлцдэг бүх үнэн хүмүүст их ашиг тус өгдөг. Интернэтэд байгаа тэр бүх сөрөг суртал ухуулга бол ердөө л ХКН-ын засгийн газраас Төгс Хүчит Бурханы Чуулганы талаар худал хуурмагийг түгээж байгаа явдал юм. Тэдгээр нь огтхон ч үнэн биш. Хүн бүрийг Төгс Хүчит Бурханы Чуулганд дайсагнуулж, Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг судалж зүрхлэхгүй болгож, улмаар Бурханы авралыг алдуулахын тулд ХКН-ын засгийн газар энэ худал хуурмагийг түгээдэг юм шүү дээ” хэмээн эхнэр маань инээмсэглэн хэллээ.

Эхнэрийнхээ хэлэхийг сонсож, гэрэлтсэн царайг нь хараад би бүр ч сониучирхав. Эхнэр маань Төгс Хүчит Бурханд итгэж эхэлснээсээ хойш нутгаа үгүйлж, ээжийгээ санан сэтгэлээр унахаа больсон юм. Түүнчлэн эхнэр минь охиндоо илүү тэвчээртэй ханддаг болж, уурлахаа больсон бөгөөд намайг тун сайн халамжилж эхэлсэн билээ. Үнэхээр Төгс Хүчит Бурхан эхнэрийг минь өөрчилсөн юм гэж үү? Төгс Хүчит Бурханы Чуулган үнэхээр эхнэрийн минь хэлсэн шиг сайн юм болов уу? Энэ бүгдийг нэгд нэггүй бодож үзээд сэтгэл минь зовов—би итгэлээ үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийг эхнэртээ зөвшөөрөх ёстой эсэхээ мэдэхгүй байсан юм. Хэсэгхэн дотроо тэмцэлдсэний дараа би Төгс Хүчит Бурханы Чуулганд өөрөө очиж үзэхээр шийдэв. Интернэтэд бичсэн шиг биш байх юм бол

---

эхнэрийнхээ замд цаашид хөндөлсөхгүй байх байлаа.

Ажилдаа явахгүй амралтын өдрүүдээр би эхнэртээ хандан, Төгс Хүчит Бурханы Чуулганд очиж үзмээр байна гэдгээ хэллээ. Эхнэр минь гайхах, баярлах зэрэгцсэн юм. Биднийг тэнд очмогц ах эгч нар халуун дотноор хүлээн авсан бөгөөд тэд эелдэг, чин үнэнч хүмүүс гэдэг нь илэрхийлэл, үйл хөдлөл, бусадтай хэрхэн харилцаж байгаагаас нь мэдрэгдсэн билээ. Миний сандрал, сонор сэрэмжтэй байдал аажмаар намжив. Дараа нь нэг эгч: “Ах эгч нар аа, Шиаужэний түүх мюзикл олон улсын шагнал хүртсэн байна!” гэж бүгдэд догдлонгуй хэллээ. “Тэрийг чинь үзэж болох уу?” гэж би сониучирхан асуусан юм. Тэд нэгэн дуугаар зөвшөөрөөд, мюзиклийг тоглуулж эхлэв. Шиаожэнийн эрээн бараантай түүх зүрх сэтгэлийг минь үнэхээр хөдөлгөж, би өөрөө ч бас нэгэн Шиаожэнь юм гэж бодлоо. Гэр бүлийнхээ золгүй явдлаас үүдэн би багадаа нийгмийн урсгал даган хөвж, ердөө л амиа зогоохын төлөө элдэв янзын дээрэлхэл, доромжлолыг туулж, үл тоомсорлуулж явсан билээ. Харин одоо би амин зуулгаа залгуулахын төлөө зүтгэж, шаргуу ажиллаж байсан бөгөөд сайхан, муухай бүхий л төрлийн зүйл туулсан байсан юм. Олон жилийн турш маш их сайн мууг туулсан би ядарч, гуньдаг ч эхнэр, найз нөхдийнхөө өмнө үргэлж хүч чадалтай дүр эсгэж явсан юм. Миний зүрх сэтгэл дэх шаналлыг хэн мэдэж чадах билээ дээ? Мюзиклийн сүүл хэсэгт ийм дуу дуулав: **“Гүнээ зовсон энэ хүмүүсийг Төгс Хүчит Нэгэн өршөөдөг; үүний зэрэгцээ, хүмүүсийн хариултыг хэтэрхий удаан хүлээх ёстой байсан тул ухаан алдсан энэ хүмүүсээс Тэр залхсан. Тэр эрж хайхыг хүсдэг, зүрх сэтгэл, сүнсийг чинь эрж хайн, чамайг цаашдаа өлсөж, цангахгүй байгаасай гэсэндээ чамд ус, хоол хүнс авчирч, чамайг сэрээхийг хүсдэг. Эцэж ядран, энэ дэлхийн зэврүүн хоосролын заримыг мэдэрч эхлэх үедээ бүү төөрөлд, бүү уйл. Төгс Хүчит Бурхан, Харгалзагч, чамайг хэдийд ч ирсэн тэврэн авна”** (Хургыг дагаж, шинэ дуу дуулъя номын “Бурхан зүрхийг чинь, сүнсийг чинь хайж байна”). Энэ дууны мөр болгон нь төөрсөн, зовж шаналж байгаа сэтгэлийг минь дулаацуулж, дуулсан өнгө эгшиг бүр нь төөрөөд удсан хүүхдэдээ гараа сунгах эх мэт санагдав. Хайрын дуудлагыг би мэдэрч, сэтгэл минь асар их хөдөллөө. Мюзикл дуусах үед би хацар даган урсах нулимсаа барьж дийлээгүй юм. Би анх удаа ийм олон хүний өмнө уйлж үзсэн бөгөөд жаахан ичсэндээ чимээгүйхэн, хурдхан шиг нүүр буруулж, нулимсаа арчив. “Ёстой гайхалтай мюзикл байна!” гэж би чин сэтгэлээсээ дуу алдлаа. Тэгээд Шиаужэний түүх-д зориулан алга ташив.

Эхнэр минь над руу хараад, асар их сэтгэл хөдлөн, баяртайгаар ингэж хэллээ: “Бурхан чамайг минь хөдөлгөсөн болохоор Шиаужэний түүх-нд сэтгэл чинь уярчээ! 5-р сарын 28-ны Жаоюанийн хэрэг чамд нөлөөлж, Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн талаар маш их буруу ойлголттой болсныг чинь би мэднэ. Бас миний аюулгүй байдал, охины маань

---

аюулгүй байдалд санаа зовдог гэдгийг чинь мэдэж байна, тэгэхээр тэр хэрэг дээр үнэндээ юу болсон талаар өнөөдөр харцгаая.”

Ах эгч нар дараа нь “5 сарын 28-ны Жаоюаний хэргийн ард илчлэгдсэн үнэн” хэмээх видео үзүүллээ. Үүнд хэргийн томоохон сэжиг бүхий хэд хэдэн талыг ил болгоод, дараа нь тэдгээрийг давхарга бүрээр нь задлан шинжилсэн байв. Би үүнд үнэхээр анхаарлаа төвлөрүүлж, үнэнийг олж мэдэхийн тулд видеог даган тус хэрэгт өөрийн дүн шинжилгээг хийсэн юм. Видео үргэлжлэх явцад зангирсан хөмсөг минь аажмаар тэнийж, худал хуурмагийн давхарга бүр ил болж байгааг хараад уртаар санаа алдлаа. Шашин шүтлэгийг нухчин дарж, Төгс Хүчит Бурханы Чуулганыг устгахын тулд 5-р сарын 28-ны Жаоюанийн хэргийг ХКН-ын засгийн газар гардан зохион байгуулсан гэдгийг би ухаарсан юм. Жан Лидон, Жан Фань болон тус хэргийн бусад буруутан Төгс Хүчит Бурханы Чуулганы гишүүд гэдгээ өөрсдийн амаар үгүйсгэж, тус чуулгантай ямар ч холбоогүй гэж хэлсэн байжээ. Гэвч ХКН-ын засгийн газар сэжигтнүүдийн мэдүүлгийг бүрмөсөн үл тоомсорлож, улаан цайм баримтуудын эсрэг явж, тэр гэмт хэргийг Төгс Хүчит Бурханы Чуулганы хүмүүс үйлдсэн гэж зүтгэсэн байлаа. Бүр хачирхалтай нь, ХКН-ын засгийн газар чуулганыг нухчин дарж, газрын хөрснөөс арчихын тулд олон нийтийн үймээн шуугиан дэгдээх гэж шүүх хурал, шүүхийн шийдвэр ч үгүй байж телевиз, интернэт дэх хэвлэл мэдээллийн хэрэгслээр тус хэргийг яаран ил тод, баттайгаар Төгс Хүчит Бурханы Чуулганд тохсон байв. ХКН-ын засгийн газар тус чуулганы Христэд итгэгчдийг ямар ч саадгүйгээр улайран нухчин дарж, баривчилж эхлэхийн тулд Төгс Хүчит Бурханы Чуулганыг гүтгэж, ийм хуурамч хэрэг үүсгэсэн байлаа. Энэ нь 1989 оны 6-р сарын 4-ний оюутнуудын хөдөлгөөнийг нухчин дарсантай нь яг адилхан байв. Тэд эхлээд оюутнуудын эх оронч хөдөлгөөнийг эсэргүү бослого гэж харуулах цуу яриа зохиогоод, дараа нь баривчилгаа хийж, хүмүүсийг хөнөөж эхэлсэн юм. Аливаа санал зөрөлдөгчийг уг үндсээр нь устгах ХКН-ын засгийн газрын арга бол эхлээд цуу яриа зохиож, баримтыг гуйвуулаад, дараа нь гүжирдэж, харгисаар нухчин дарах явдал байсныг би баримтуудтай нүүр тулаад эцэст нь тов тодорхой олж харлаа. ХКН-ын засгийн газар үнэнийг орвонгоор нь эргүүлж, бодит байдлыг гуйвуулж, Төгс Хүчит Бурханы Чуулганыг гүтгэснээр үнэнийг мэддэггүй хүмүүс худал үгэнд нь хууртан, чуулганыг буруугаар ойлгоно—ХКН-ын засгийн газар тун жигшүүртэй юм! Гэхдээ Төгс Хүчит Бурханы Чуулганы ах эгч нар интернэтэд бичсэнтэй огт адилгүй шулуун шударга хүмүүс байтал ХКН-ын засгийн газар чуулганыг яагаад тэтгэлээ улайран хяхаж хавчиж, Төгс Хүчит Бурханы Чуулганд тэр хүн амины хэргийг нялзаан, гишүүдийг нь баривчлахын тулд яагаад тэтгэлээ их зовсон юм бэ? Үнэндээ юу болоод байна аа?

Намайг будилсан тухайгаа ярих үед нэг эгч ийнхүү хариулсан юм: “Эхлээд Бурханы

---

үгээс хоёр хэсгийг уншицгаая. ‘Сатан хүмүүсийг мэхлэх замаар нэр хүнд олж авдгийн дээр үргэлж өөрийгөө зөв шударга байдлын манлайлагч, үлгэр дуурайл болгодог. Зөв шударга байдлыг хамгаалах нэрийдлээр хүмүүст хор учруулж, сүнсийг нь залгиж, хүнийг хөшүүн болгож, хууран мэхэлж, турхирахын тулд бүхий л төрлийн арга барил ашигладаг. Түүний зорилго нь, ёрын муу үйл хэргийг нь хүн хүлээн зөвшөөрч, дагадаг болгож, Бурханы эрх мэдэл, дээд эрхийг эсэргүүцэхэд хүнийг өөртөө нэгтгэх явдал юм. Гэвч, хүн түүний явуулга, хуйвалдаан, өөдгүй төрхийг мэддэг болж, түүнд гишгэчүүлж, хууртаж, үргэлжлүүлэн түүнд боолчлогдож, түүнтэй хамт шийтгүүлж, сүйрэхийг хүсэхгүй байх үед Сатан урьдын ариун гэгээн төрхөө өөрчилж, хуурамч багаа хуулан ёрын муу, харгис догшин, муухай, хэрцгий жинхэнэ нүүр царайгаа илчилдэг. Тэр өөрийг нь дагахаас татгалзаж, өөрийнх нь муу ёрын хүчийг эсэргүүцдэг бүх хүнийг үгүй хийхэд юунаас ч илүү дуртай’ (Үг нь махбодоор илэрсэн номын “Цор ганц Бурхан Өөрөө II”). ‘Сатан унтууцаж, улангасан уурладгийн шалтгаан нь гэвэл: Түүний үгээр хэлшгүй явуулга ил болсон; түүний хуйвалдаан зүгээр өнгөрөхөд амаргүй байдаг; Бурханыг орлож, Бурхан шиг авирлах гэсэн түүний галзуу санаархал, эрмэлзэл нь цохигдож, саад учирсан; бүх хүн төрөлхтнийг захирах түүний зорилго нь одоо талаар болж, хэзээ ч биелэх боломжгүй болсон’ (Үг нь махбодоор илэрсэн номын “Цор ганц Бурхан Өөрөө II”).”

Бурханы үгийг уншсаны дараа тэр эгч надад ийн нөхөрлөлөө: “Сатан яагаад Бурханыг эсэргүүцэж, хүн төрөлхтөнд хор хөнөөл учруулдгийн уг шалтгааныг Бурханы үг илчилдэг. Тэгээд бид Бурханыг эсэргүүцэж, Христэд итгэгчдийг хяхаж хавчдаг ХКН-ын засгийн газрын үйлдлийг авч үзэхдээ Бурханы үгийг ашиглавал тэд бол диавол Сатаны биелэл, мөн үнэнийг хамгийн их үзэн ядаж, Бурханыг эсэргүүцдэг сатанлаг дэглэм гэдгийг тодорхой хардаг. Тэд бүх шашин шүтлэгийг үгүй хийхийг хүсдэг бөгөөд Хятадад бурхангүй бүс нутаг байгуулахын тулд хүмүүст Бурханд итгэж, зөв замаар явахыг яасан ч зөвшөөрөхгүй. Ялангуяа эцсийн өдрүүдэд энэ нь үнэн байдаг—бие махбодтой болсон Төгс Хүчит Бурхан Хятадад илэрч ажиллан, хүн төрөлхтөнд гэрэл авчрахын тулд үнэнийг илэрхийлээд байна. Бурханд чин сэтгэлээсээ итгэж, үнэнийг хайрладаг бүх шашин, урсгалын хүмүүс Төгс Хүчит Бурханы үгийг уншсанахаа дараа тэдгээр нь үнэн гэдэгт итгэх болж, эцсийн өдрүүдийн ажлыг нь нэг нэгээрээ хүлээн зөвшөөрч байгаа. Бурханы үгийг уншсанаар олон хүн үнэнийг ойлгож авсан бөгөөд сайн мууг хэрхэн ялган танихыг сурчээ. Ийнхүү тэд ХКН-ын засгийн газрын ёрын муу мөн чанарыг тодорхой харах болж, тэднийг голоход бэлэн болдог бөгөөд үнэнийг эрэлхийлж, амьдралын зөв замаар явж эхэлдэг. Улам олон хүн Бурханд итгэж, Бурханыг дагаж байгааг хараад тэд багтартлаа уурладаг. Тэгээд хүмүүсийг хуарандаа эргүүлэн чирч аваачин, үргэлжлүүлэн боолчилж,

---

дарлалдаа байлгана гэж хий дэмий найддаг юм. Ингэхийн төлөө ХКН-ын засгийн газар элдэв янзын худал хуурмаг зохион Төгс Хүчит Бурханы Чуулганыг гүтгэж, гүжирдээд зогсохгүй зүйл бүрийн жигшүүртэй арга ашиглан улайран хяхаж хавчиж, нухчин дардаг. Тэд Бурханы сайн мэдээний ажил түгэхийг зогсоож, Төгс Хүчит Бурханы Чуулганыг бүрмөсөн устгах төөрөлдсөн оролдлого хийхдээ улс орон даяар Төгс Хүчит Бурханы Чуулганы Христэд итгэгчдийг улайран баривчилж, хяхаж хавчихын тулд үлэмж их тооны зэвсэгт цагдаа, цэрэг дайчлахаар олон удаа нууц баримт бичиг гаргаж байсан юм. Ялангуяа сүүлийн хэдэн жилд Төгс Хүчит Бурханы Чуулганы бүтээсэн бүхий л төрлийн сайн мэдээний кино, видеонууд интернэтэд ар араасаа нийтлэгдэж, Бурханы хаанчлалын сайн мэдээ дэлхий даяар хээрийн түймэр мэт хурдацтай түгж байна. ХКН-ын засгийн газар засгийн эрхэнд гарснаасаа хойш тоо томшгүй олон аллага, элдэв янзын ёрын мууг үйлдсэн тул гэмээ мэдэж байгаа бөгөөд Христэд итгэгчдийг хяхаж хавчсан асар их цусан өр тэдэнд бий. Дэлхий дахины хүмүүс Бурханы ажлыг хүлээн зөвшөөрч, үнэнийг ойлгож, тэдний ёрын муу төрхийг тодорхой олж харан, тэднийг голох вий гэж ХКН-ын засгийн газар айж байна. Тэгвэл тэд дэлхийд ямар ч гишгэх газаргүй болох юм. Тэгээд бүх хүн төрөлхтнийг хянаж, бурхан болох жолоогүй эрмэлзэл нь нуран унана. Ийм учраас Төгс Хүчит Бурханы Чуулганы эсрэг ХКН-ын засгийн газрын хяхалт хавчлага эрчимжээд байна. Тэд чуулганыг гүтгэж, үнэнийг мэддэггүй хүмүүсийг төөрөгдүүлэн, Бурханыг болон Төгс Хүчит Бурханы Чуулганыг үзэн ядуулж, өөрсөдтэй нь цуг мууг үйлдэхэд хүргэхийн тулд 5-р сарын 28-ны Жаоюанийн хэргийг нягт нямбай зохион байгуулсан юм. ХКН-ын засгийн газар бол гажууд, Тэнгэрт тэрслэгч бөгөөд Бурханыг туйлын их жигшиж, үнэнийг үзэн яддаг гэдгийг бид эндээс харж болно. Тэд бол Бурханы дайсан, Бурханыг эсэргүүцдэг чөтгөр юм. Гэвч Бурхан төгс хүчит бөгөөд Сатаны заль мэхэнд үндэслэн мэргэн ухаан нь хэрэгждэг. ХКН-ын засгийн газар улайрсан эсэргүүцэл, дарлалаараа дамжуулан үзэшгүй муухай төрхөө ил болгодог бөгөөд Бурханы сонгосон хүмүүс тэдний ёрын муу, харгис уг чанарыг улам ч тодорхой харж чаддаг. Бас тэдний жигшүүртэй, ёрын муу уг чанарыг ялган таних чадвартай болж, Бурханыг дагах хүсэл нь улам батаждаг бөгөөд Бурханыг дагахаа больсноос амиа өгөхийг илүүд үздэг. ХКН-ын засгийн газар хэчнээн зэрлэг балмад байлаа ч Бурханыг дагахад нь жинхэнэ итгэгчдэд саад хийж чадахгүй, Бурханы ажлыг зогсоож бүр ч чадахгүй гэдэг нь эндээс харагддаг.”

ХКН-ын засгийн газар үнэнийг үзэн яддаг мөн чанартай, Бурханы дайсан учраас л Төгс Хүчит Бурханы Чуулганыг хяхаж хавчдаг гэдгийг би Төгс Хүчит Бурханы үг болон энэ эгчийн нөхөрлөлийг сонссоныхоо дараа ойлгосон юм. Тэд ард түмнийг хянаж, хүмүүсийг эрхэндээ баттай байлгахыг хүсдэг боловч Төгс Хүчит Бурханы илэрхийлсэн үнэн нь хүмүүсийн зүрх сэтгэлд гүн үндэслэдэг. ХКН-ын засгийн газар ард түмнийг

---

бүгдийг нь Бурхантай хамт алхаасай гэж яавч хүсдэггүй тул олон нийтийг хуурч, худал хэрэг зохиохоор чадах бүхнээ хийн, Төгс Хүчит Бурханы Чуулганыг хяхаж хавчихын тулд олон нийтийн эсэргүүцлийг өдөөн турхирдаг. 5-р сарын 28-ны Жаоюанийн хэрэг ийнхүү бий болжээ. Үнэнийг ойлгомогц Төгс Хүчит Бурханы Чуулганы талаарх эргэлзээ минь үгүй болсон юм. Гэвч санаа зовоосон зүйл байсаар байлаа: ХКН-ын засгийн газар тус чуулганыг тэгтлээ дарладаг юм чинь манай эхнэр Бурханд итгэвэл аюулгүй байх болов уу?

Дараа нь ах эгч нар надад “Коммунизмын худал үгс” хэмээх кино үзүүлсэн юм. Тэнд гарсан Бурханы үгийн нэг хэсэг миний зүрх сэтгэлийг үнэхээр хөдөлгөсөн билээ. **“Ямар ч орон, ямар ч хүч Бурханы биелүүлэхээр хүссэн зүйлийн замд саад болж чадахгүй гэдэгт бид итгэдэг. Бурханы ажилд саад хийдэг, Бурханы үгийг эсэргүүцдэг, Бурханы төлөвлөгөөг үймүүлж, сүйтгэдэг хүмүүс эцэстээ Бурханаар шийтгүүлнэ. Бурханы ажлыг эсэргүүцдэг хүн там руу илгээгдэнэ; Бурханы ажлыг сөрдөг ямар ч улс устгагдана; Бурханы ажлыг эсэргүүцэхээр бослого гаргадаг ямар ч үндэстэн газрын хөрснөөс арчигдаж, оршин тогтнохоо болино”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Бүх хүн төрөлхтний хувь заяаг Бурхан захирдаг”). Бурханы үгээс би эрх мэдэл, сүр жавхланг нь мэдэрч чадсан юм. Сатаны ямар ч муу ёрын хүчин, ямар ч хүн Бурханы ажилд саад хийх боломжгүй юм байна. Хэдийгээр ХКН-ын засгийн газрынхан Төгс Хүчит Бурханы Чуулганы нэр хүндийг унагаж, яллахаар тархиа гашилгаж, тэр ч бүү хэл чуулганы ах эгч нарыг улайран баривчилж, хяхаж хавчиж байгаа ч ах эгч нар тууштайгаар Бурханд итгэж, Бурханыг дагаж байгаа бөгөөд тэдний бүтээдэг сайн мэдээний кино, найрал дууны бүтээл, дуу бүжгийн видео ХКН-ын засгийн газрын ямар ч саадгүйгээр интернэтэд байнга нийтлэгдэж байна. Бурхан хэчнээн төгс хүчтэй болох, Түүний ажлыг ямар ч хүчин зогсоох боломжгүй болохыг би эцэст нь олж харсан юм. Эхнэр минь Бурханд итгэхэд Бурхан тулах хүч нь болох учраас надад санаа зовох зүйл байхгүй юм байна. Энэ бүхнийг ойлгосны дараа зүрх сэтгэлд минь байсан зовнил, эргэлзээ бүгд тайлагдсан билээ. Би инээмсэглэсээр эхнэртээ: “Төгс Хүчит Бурханд итгэдэг чинь зөв. Би урьд нь маш харалган байж, сонссон зүйлдээ эндүү итгэж, чамайг маш их зовоожээ. Үнэхээр миний буруу байж. Одооноос би итгэлийг чинь бүрэн дэмжинэ” гэж хэлэв. Эхнэрийн минь нүдэнд нулимс цийлгэнэж, сэтгэл нь хөдлөн: “Бурханы ачаар чи минь ХКН-ын засгийн газрын худал хуурмагийг нэвт харж, төөрөгдлийн манангаас гарч чадлаа. Энэ бол Бурханы удирдамж, удирдлага шүү дээ!” гэлээ.

Тэр үеэс хойш би эхнэрийнхээ хамтаар Төгс Хүчит Бурханы Чуулганы хийсэн видеог хааяа үзэж эхэлсэн бөгөөд эхнэрийнхээ итгэлийнхээ талаар ярихыг сонсдог болсон юм. Гэвч Бурханд итгэнэ гэдэг энгийн хялбар итгэл мэт санагдсаар байлаа. Мэдээж би зүрх

---

сэтгэлдээ Бурханд итгэж болох байв. Гэхдээ би амин зуулгаа залгуулж, гэр бүлээ тэжээж, сайхан амьдралаар амьдарч чадахуйц хангалттай зүйлээр хангах ёстой хэвээр байсан юм. Сүүлд нь өвчин туссаныхаа дараа л би Бурханд итгэх талаар цоо шинэ ойлголттой болсон билээ.

Нэгэн орой нар жаргаж байх үеэр гэр бүлийнхэн маань хооллоцгоож байхад ходоод аймшигтай өвдөж, нүүрэн дээгүүр хүйтэн хөлс бөнжгөнөн урсаж эхлэв. Эхнэр минь намайг даруйхан эмнэлэгт хүргэсэн бөгөөд надад мухар олгой хагарсан гэх онош тавилаа. Энэ нь яаралтай мэс засал шаардлагатай ноцтой нөхцөл байдал байсан юм. Би урьд өмнө нь хэзээ ч мэдэрч үзээгүй арга мухардал, айдас мэдрэв. Хэрвээ амьд мэнд үлдэхгүй бол эхнэр, жаахан охин хоёр минь гаднын оронд яаж амь зуух болж байна аа? Хэн тэднийг харж хандах болж байна? Миний бодож байгаа зүйлийг эхнэр ойлгоод, гарыг минь атган ингэж хэлэв: “Юунд санаа зовж байгааг чинь мэдэж байна аа. Бурхан бол төгс хүчит, бүх зүйл Түүний гарт байдаг. Хагалгаа амжилттай болох эсэх дээр ч Бурхан эцсийн шийдвэрийг гаргана. Бид Бурханд түшиглэх хэрэгтэй, бас хагалгаа яаж ч дууслаа гэсэн Бурханыг буруутгаж болохгүй, харин Түүний захиралт, зохион байгуулалтад захирагдах ёстой.” Эхнэрийнхээ хэлсэн үгийг сонсоод би толгой дохилоо. Мэс заслын өрөөний хаалга хаагдмагц би нүдээ аниад, Бурханд залбирав. “Өө Төгс Хүчит Бурхан минь! Би үхтлээ айж байна. Айхыг минь болиулахын тулд надад итгэл хайрлаач. Би Танд найдахад бэлэн байна.” Залбирсны дараа миний айдас багасаж, нэг видеон дээрх Бурханы үгийн эшлэл санаанд орсон юм: **“Хүнд байдаг бүхэн—амар амгалан болон баяр хөөр, ерөөл хийгээд хувийн аюулгүй байдал нь—бүгд үнэндээ Бурханы хяналтан дор байдаг; Тэрээр хүн нэг бүрийн хувь заяаг залж чиглүүлж, шийдэж байдаг гэж Би хэлдэг”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Цор ганц Бурхан Өөрөө VI”). “Тийм шүү. Бурхан бол төгс хүчит, миний амь Түүний гарт байгаа. Өнөөдөр хагалгааны минь үр дүн Бурханы захиралт, зохион байгуулалтаас хамаарч байгаа тул бүх зүйлийг Бурханд даатгаснаар надад санаа зовох зүйл алга” гэж би бодлоо. Бурханы үг надад итгэл хайрлаж, түгшсэн зүрх минь тайвширсан бөгөөд хагалгаа бүтэлгүйтэх магадлалын тухайд би төдийлөн санаа зовохоо больсон юм. Мэдээ алдуулагчийн нөлөөгөөр би аажмаар ухаан алдлаа. Ухаан орох үед минь эмч хагалгаа амжилттай болсныг надад дуулгасан бөгөөд Бурхан намайг хамгаалсан гэдгийг би мэдэв. Тэгээд Бурханд талархал, магтаалаа ахин дахин өргөсөн юм.

Дараа нь би Бурханы ийм үгийг харав: **“Хүн хаанаас гаралтай, яагаад хүмүүс амьд байгаа, хүний хувь заяаг хэн шийддэг, хүний оршин тогтнолыг хэн хангадаг, үүнийг захирах дээд эрх хэнд байдаг вэ гэдэг нь энэ хорвоод хөл тавингуутаа хамгийн түрүүнд ойлгох учиртай зүйл юм байна. Гэр бүлээ хэрхэн тэжээж, алдар нэр, эд баялагт хэрхэн хүрэхэд суралцах биш, хэрхэн бусдаас онцгойроход, эсвэл илүү**

---

чинээлэг амьдрахад суралцах ч бас биш, хэрхэн бусдаас илүү дээр байж, амжилттай өрсөлдөхөд суралцах явдал бүр ч биш харин энэхүү мэдлэг бол хүний амьдрах жинхэнэ арга хэрэгсэл, гол суурь мөн. Хэдийгээр хүмүүсийн амьдралаа зарцуулан сурч эзэмшдэг олон янзын амь зуух ур чадвар нь асар их материаллаг тав тухыг өгч чадах боловч зүрх сэтгэлд нь жинхэнэ амар амгалан, тайтгарлыг хэзээ ч авчирдаггүй, харин ч хүмүүсийг байнга зүг чигээ алдаж, биеэ барихад хэцүү болж, амьдралын утга учрыг мэдэж авах боломж болгоныг алдахад хүргэдэг; амьд үлдэх эдгээр ур чадвар нь үхэлтэй хэрхэн зүй ёсоор нүүр тулах тухай сэтгэл зовних далд мэдрэмжийг төрүүлдэг. Хүмүүсийн амьдрал ийм байдлаар сүйрдэг. Бүтээгч хүн болгонд шударга хандаж, Өөрийнх нь дээд эрхийг туулж, мэдэх насан туршийн үнэт боломжийг хүн бүрд олгодог хэдий ч зөвхөн үхэх нь дөхөж, үхэл заналхийлэх үед л хүн ухаарч эхэлдэг боловч тэр үед хэтэрхий оройтсон байдаг!” (Үг нь махбодоор илэрсэн номын “Цор ганц Бурхан Өөрөө III”).

Бурханы үгийг уншсаны дараа сэтгэл цэлмэсэн бөгөөд бид ердөө л гэр бүлээ тэжээж, хөрөнгө чинээтэй болж, эсвэл бусдаар атаархуулж, хүндлүүлж, алдар нэр, ашиг хонжоо хөөцөлдөх дунд зэргийн амьдралаар амьдрах гэж энэ газар дэлхий дээр амьдардаггүй гэдгийг ойлгосон юм. Хүмүүс бид Бурханы бүтээл бөгөөд Бурханд итгэж, Бурханыг шүтэн мөргөж, үнэнийг эрэлхийлж ойлгон, Бурханы тухай мэдлэгтэй болж, Бурхан бидний амьдрал дахь бүх зүйлийг захирдаг, хувь заяа маань Бурханы гарт байдаг гэдгийг тодорхой ойлгосноор л Түүний захиралт, зохицуулалтыг үнэхээр дуулгавартай дагаж, Түүний үгийн дагуу авирлаж, биеэ авч явж чадна. Энэ бол утга учиртай, үнэ цэнтэй амьдрах цорын ганц арга зам; энэхүү амьдралаа хий дэмий өнгөрөөхгүй байх цорын ганц арга зам юм. Бурханд итгэнэ гэдэг энгийн хялбар итгэл бөгөөд амьдралдаа миний хийх ёстой зүйл бол гэр бүлийнхээ төлөө мөнгө олох явдал гэж урьд нь бодож явснаа би санах. Амь насанд халтай өвчин тусах үедээ л би эцэст нь ухаарсан юм. Хэчнээн их мөнгө олж, хэдий өндөр дээд байр суурьтай болсон ч гэсэн өвдөх үед зүрх сэтгэлийнхээ гүнд мэдэрдэг зовлон, айдас, арга мухардлыг маань тэдгээр зүйл намжааж чаддаггүй. Үхлийн ирмэг дээр байхад мөнгө, алдар нэр, эд хөрөнгө бидэнд амийг минь эргүүлэн өгч, насыг минь уртасгах боломжгүй. Бурханд талархъя. Өвчинтэй нүүр тулж, маш их айн, арга мухардаж байх үед минь Бурхан л үгээрээ надад итгэл, хүч чадал хайрласан билээ. Тэр надад түшиж тулах зүйл өгч, айсуй бүхэнтэй тайвнаар нүүр тулах боломж олгосон юм. Тэр тусмаа Бурханы халамж, хамгаалалтаар л би хагалгаагаа саадгүй давж чадав. Бурхан бодитой, бас амьд бөгөөд хэдийд ч бидэнд тус, дэм болж чаддаг, мөн бидний хүчирхэг ар тал байдаг гэдгийг тэр туршлагаар би үнэхээр мэдэрч авлаа. Хүмүүс бидний насан туршдаа хамгийн их эрэлхийлэх ёстой зүйл бол Бурханд итгэж, Бурханыг шүтэн мөргөх явдал бөгөөд бид



---

Бурханы захиралтыг ойлгож, үүнд захирагдах ёстой. Энэ бол бидний сүнсэнд хамгийн их хэрэгтэй зүйл, мөн бидний эрэлхийлэх ёстой хамгийн утга учиртай амьдрал юм. Түүнчлэн Бурханд итгэнэ гэдэг энгийн хялбар итгэл гэх миний эндүү ташаа бодлыг тэр туршлага өөрчилсөн бөгөөд би эхнэртэйгээ хамт итгэлээ хэрэгжүүлж, Бурханы үгийг уншиж, үнэнийг эрэлхийлэн, Бурханыг мэдэх замаар явахаар сэтгэл шулуудлаа.

Төгс Хүчит Бурханы Чуулганы ах эгч нар намайг өвдсөн гэж сонсоцгоосон тул эмнэлэг дээр эргэхээр ирсэн юм. Би хэсэг хугацаанд ажиллаж чадахгүй болж, гэр бүл маань орлогын ямар ч эх үүсвэргүй байна гэдгийг тэд дуулаад хөдөлмөрийн чадавхаа түр алдсаны тэтгэмж авах, эмнэлгийн зардлынхаа дийлэнх хэсгийг нөхөн төлүүлэхээр өргөдөл гаргахад минь тусалсан юм. Ийм хүйтэн хөдий, тоомжиргүй нийгэмд ах эгч нарын чин сэтгэлийн тусч байдал надад халуун дулааныг үнэхээр мэдрүүлсэн бөгөөд бид бүгд нэгэн гэр бүл мэт санагдав. Тэд бол бусадтай харилцахдаа Бурханы үгэнд найдаж, бусад хүнд чин сэтгэлээсээ ханддаг, үг үйлдэлдээ шулуун шударга, нэр төртэй, яг Христэд итгэгчдэд байх ёстой хүн чанар, амьдралын хэв маягтай хүмүүс гэдгийг би хэсэг хугацаанд тэдэнтэй холбоотой байсныхаа дараа олж харлаа. Тэд миний хамт ажилладаг хүмүүсээс шал өөр байсан бөгөөд энэ ертөнцөд тэдэн шиг хүмүүс тун цөөхөн байсан юм. Төгс Хүчит Бурханы үг үнэхээр хүмүүсийг өөрчилж, биднийг зөв зам руу залж чаддаг, мөн энэхүү чуулган хайраар бялхаж, хүмүүст халуун дулаан сайхан мэдрэмж өгдгийг би мэдэрсэн билээ.

Урьд нь би ХКН-ын засгийн газрын худал хуурмагт сохорч, Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг эрж хайх, судлахаас ахин дахин татгалзаж, тэр ч бүү хэл эхнэрийнхээ итгэлийн замд хөндөлсөж байсан ч Бурхан намайг аврахаар оролдохоо больсонгүй. Ах эгч нарын уншиж өгсөн Бурханы үг, үзүүлсэн видеогоор дамжуулан Бурхан надад ХКН-ын засгийн газрын худал хуурмагийг нэвт харж, тэдгээрийн ар дахь олиггүй үнэнийг тодорхой харах боломж олгосон билээ. Хагалгааныхаа үр дүнд санаа зовон айдас дунд амьдарч байхад минь Бурханы үг намайг гэгээрүүлж, замчилж, надад итгэл, хүч чадал хайрлан, эндүү ташаа үзэл бодлыг минь залруулсан юм. Хагалгааны дараа ажиллаж чадахгүй байх үед минь Бурхан ах эгч нараар дамжуулан надад тусалж, намайг дэмжлээ. Намайг гэх Бурханы хайр, өршөөл болон Түүний үгийн эрх мэдэл, эрхэм байдлыг би туулж, Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг маш баяртайгаар хүлээн зөвшөөрөв. Одоо би эхнэртэйгээ хамт цуглаанд байнга оролцож, Бурханы үгийг уншин, сэтгэл хангалуун байж, баяр хөөрөөр бялхдаг болсон билээ! Намайг аварсанд нь Бурханд талархъя!

## **21. Цуу ярианы занганаас мултрах нь**

---

## Шиаоюнь, Хятад

Би армийн офицер эмэгтэй байлаа. 1999 оны нэг өдөр Солонгос пастор надад Эзэн Есүсийн сайн мэдээг номлосон юм. Үнэн сэтгэлийн эрэл хайгуулынхаа улмаас би удалгүй пасторын сургалтын анхаарлын төвд орж, гол туслагч нь боллоо. 2000 оны зун пастор, Солонгосын Сайн Мэдээний Чуулганы арав гаруй, коллежийн оюутантай хамт номлогчийн богино хугацааны аяллаар Юннаньд ирсэн юм. Санаанд оромгүйгээр энэ нь ХКН-ын засгийн газрыг түгшээжээ. Бид пасторын гэрт цуглаан хийж байгаад баривчлагдаж, Юннань мужийн Олон нийтийн аюулгүй байдлын хэлтэст байцаалт өгөхөөр хүргэгдсэн юм. Солонгосын их сургуулийн оюутнуудыг тэр шөнөдөө албадан нутаг буцааж, солонгос пасторыг ч бас улсаас хөөжээ. Чуулган ХКН-ын хавчлагыг амсаж, олон итгэгч айж хулчийн, итгэж зүрхэлсэнгүй. Түүнчлэн итгэгчдийн нэг хэсэг нь албан хүчээр Гурван Өөрөө сүмд явж, ийнхүү ХКН-ын засгийн газар чуулганыг нураасан билээ. Би чуулган дахь гол хамтран зүтгэгчдийн нэг байсан бөгөөд ХКН-ын засгийн газрын энэ удаагийн хавчлага намайг ч бас ажилгүй болгосон юм.

2005 оны 3-р сард би Төгс Хүчит Бурханы хаанчлалын сайн мэдээг сонслоо. Эзэн Есүс эргэн ирснийг дуулаад ихэд догдолсондоо баярын нулимс хоёр нүдийг минь бүрхэж, би үгээр илэрхийлэхийн аргагүй талархаж байв. Би ах эгч нараа аль болох хурдан Бурханы өмнө аваачихыг л хүссэн билээ. Бурханы удирдамж дор ах эгч нар ар араасаа Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн зөвшөөрлөө. Гэвч санаанд оромгүй нь, чуулганы хамгийн авьяас билигтэй хамтран зүтгэгчдийн нэг нь Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлын тухай гэрчлэлийг сонссоныхоо дараа “Энэ сургаал зөв сонсогдож байна, гэхдээ бид эхлээд пастороос асууж, юу гэхийг нь харах хэрэгтэй” гэлээ. Удалгүй пастор над руу утасдаж, “Одоо гадуур тун эмх замбараагүй байна. Чи Бурханд тийм ч удаан хугацаанд итгээгүй бөгөөд биеийн хэмжээ чинь өчүүхэн. Юу ч хийлээ гэсэн чи чуулганы гаднаас хамаагүй номлол битгий сонс, тэгвэл чи замаа алдахгүй. Бид энэ чуулганы хариулгыг л хүлээн зөвшөөрч болно. Бусад чуулганы номлодог замыг битгий сонс” гэж хэллээ. Үүнийг сонсоод би тайвнаар: “Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг судалсан энэ хугацаанд би тэдний номлодог бүх зүйл Библитэй нийцдэг, Ариун Сүнсний гэгээрэл, гэрэлтүүлэлттэй, үнэн зам гэдгийг нь олж тогтоосон” гэв. Пастор маань ингэж хэллээ: “Тэд үүнийг хэчнээн сайн номлох нь хамаагүй, Эзэн Есүс л жинхэнэ Бурхан гэдгийг бид ойлгох ёстой. Бид Эзэнийг орхих ёсгүй!” Тэгэхэд нь би баттайгаар: “Би Эзэнийг орхиогүй, харин Хурганы мөрийг дагаж байна. Эзэн Есүс аль хэдийн эргэн ирсэн. Бид яг ухаалаг охид шиг Эзэнийг угтан авах нь л зөв юм” гэж хэлэв. Пастор ширүүнээр, “Эзэн эргэн ирсэн гэдгийг Солонгосын Сайн Мэдээний Чуулган яаж мэдэхгүй байх билээ?” гэлээ. “Энэ бол цөөн хэдэн үгээр тайлбарлаж болох зүйл биш” гэж би хэлэв. Пастор уран яруу

---

үгээр ингэж баталлаа: “Тэдний итгэдэг зүйл бол ХКН-ын засгийн газрын эрс арга хэмжээний бай болох Зүүний Аянга юм. Үүнийг интернэтэд маш тодорхой тайлбарласан байгаа. Интернэтэд ороод үз, тэгээд чи ойлгоно. Чи үүнийг нягталж үзэхийн тулд интернэтэд орох хэрэгтэй...” Утсаа тасалсныхаа дараа зүрх сэтгэл минь удаан хугацаанд тайвширч чадсангүй. Пасторын үг чихэнд хангинасаар байлаа. Ялангуяа би интернэтэд яг юу гэсэн байсныг мэдмээр байв.

Олж мэдэхийн тулд би Интернэт кафе руу яаран гүйлээ. Вэб сайтуудыг нээх хоромдоо би мэгдэж цочирдсон юм. Вэб сайтуудад Бурханы эсрэг ХКН-ын засгийн газрын ихээхэн доромжлол, яллалт, түүнчлэн эрх мэдэл бүхий шашны хүмүүсийн гүжирдлэг, доромжлол байлаа. Надад зарим нэг эргэлзээ төрөв: Төгс Хүчит Бурханы үгийг ямар ч хамаагүй хүн хэлж чадахгүй. Тэдгээр нь үнэний Сүнсний илэрхийлэл юм. Энэ бол Эзэнд чин сэтгэлээсээ итгэдэг, үнэнийг хүсэн эрмэлздэг, олон өөр урсгалын хүмүүсийн хүлээн зөвшөөрдөг баримт юм. Гэтэл вэб сайтууд яагаад Төгс Хүчит Бурханыг хүмүүсээр үгүйсгүүлэх цуу яриа дэгдээдэг билээ? Бас ХКН-ын засгийн газрын хамтаар Бурханыг яллаж, доромжилдог олон алдартай пастор байдаг. Энд юу болоод байна аа? Энэ бүх сөрөг суртал ухуулгыг хараад би эргэлзэж тээнэгэлзлээ. Дараа нь би Ариун Сүнсний ашигладаг хүн рүү дайрч давшилсныг интернэтээс харав. Зүрх сэтгэл минь дахин нэг удаа тавгуйтлээ. Би үнэхээр хүнд итгэдэг гэж үү? Интернэт дэх мэдээллийг үргэлжлүүлэн үзэх зуураа би улам барьц алдаж, ихэд гайхан, самгардсан болохоор эцэст нь Интернэт кафенаас яаж гарч явснаа ч мэдсэнгүй.

Гэртээ харих замдаа би Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг эрж хайн, судалж өнгөрүүлсэн үеэ санахад. Намайг зарим нэг асуулт асуухад Төгс Хүчит Бурханы Чуулганы ах эгч нар Бурханы үгийг уншиж өгдөг байлаа. Асуудал болгон ар араасаа шийдвэрлэгдэж, би бүрэн үнэмшсэн юм. Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс мөн гэдэгт бат итгэхэд минь бүхэл бүтэн арван нэгэн өдрийн мэтгэлцээн, судалгаа шаардагдсан. Түүнчлэн би Бурханы зарим үгийг уншсан. Бурхан ажлын гурван үе шат болон зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөний бүх нууцыг дэлгэсэн бөгөөд Библийн дотоод түүх болон мөн чанар, Библи дэх аль нь Бурханы үг, аль нь хүмүүсийн үг болох, хүмүүс Библид хэрхэн хандах ёстой зэрэг үнэнийг тодорхой болгосон билээ. Энэ нь, аливааг тодорхой харж, ихийг олж авахад намайг хүргэсэн. Эдгээр зүйлийг унших үед бүх зүйл тодорхой болж, би асар их ашиг тус хүртсэн юм. Бурханы эдгээр үгээс би Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс байх учиртай гэдгийг харсан. Гэтэл яагаад интернэт дэх суртал ухуулга бүгд сөрөг байв? Эдгээр цуу ярианы талаар бодох тусам зүрх сэтгэл минь улам хямарч, хүнд оргин, зам гарч явахдаа би золтой л машинд мөргүүлчихсэнгүй.

---

Гэртээ хариад зүрх сэтгэл минь ер тайвшраагүй бөгөөд интернэт дэх тэдгээр цуу яриа үе үе санаанд орж, тэндээ эргэлдсээр байв. Нэгээс нөгөөг бодох үед зүрх сэтгэл минь үймэрч байлаа. Шөнө нь би унтаж чадаагүй бөгөөд “Хэрвээ би буруу замаар явбал итгэл минь хий дэмий болох бус уу? Үгүй ээ, би даруйхан буцах ёстой. Гэхдээ Төгс Хүчит Бурхан эргэн ирсэн Эзэн Есүс байвал яах юм бэ? Тэгвэл би Эзэнийг угтан авч, аврагдах боломжоо алдах биш үү?” хэмээн бодсон юм. Эргэж буцан байхдаа би Бурханы өмнө очин залбирлаа: “Өө Бурхан минь! Ажлын энэ алхмыг хүлээн зөвшөөрснөөс хойш зүрх сэтгэл минь үргэлж тайван байж, Бурханы үгийг унших нь надад маш таатай санагдан, сүнс минь маш их тэжээгдсэн мэт санагдаж байсан. Гэвч интернэт дэх зарим нэг сөрөг суртал ухуулгыг харсны дараа би тайвширч чадахгүй байна. Миний зүрх сэтгэлийг хамгаалаач. Өө Бурхан минь! Биеийн хэмжээ минь хэтэрхий өчүүхэн бөгөөд эдгээр зүйлийг яаж ялган танихаа мэдэхгүй байна. Хэрэв Төгс Хүчит Бурхан нь үнэхээр эргэн ирсэн Та мөн бол ямар ч хүн, ямар ч зүйлээс болж үймрэлгүй Таны ажилд бат итгэлтэй байхад намайг замчлаач гэж би гуйж байна. Хэрвээ биш бол, ялган таньж чаддаг болоход минь намайг замчлаач гэж Танаас гуйя...” Залбирсны дараа, энэ нь Бурханы дуу хоолой мөн эсэхийг тогтоохын тулд Төгс Хүчит Бурханы үгийг хурдхан уншиж дуусгая хэмээх санаа зүрх сэтгэлд минь төрөв. Тэр шөнөжингөө би Бурханы үгийг уншсан бөгөөд хэзээ ширээн дээр унтаад өгснөө мэдэхгүй юм.

Маргааш өглөө нь би эрт хаалга тогших дуунаар сэргэж, хаалга тайлахаар нойрмоглон очив. Ирсэн хүн нь намайг усалсан Ву эгч болж таарлаа. Эгч нойрмог байгааг минь хараад санаа нь зовсон байдалтайгаар юу болсныг асуув. “Би өчигдөр интернэтэд ороод Бурханыг эсэргүүцэж, доромжилсон маш олон зүйл харсан, тэгээд одоо маш их будилж байна...” гэж би хэллээ. Үүнийг сонсоод Ву эгч надтай ингэж нөхөрлөв: “Эгч ээ, Христэд итгэгчдэд хандах ХКН-ын засгийн газрын хандлагыг та маш сайн мэднэ. Тэд тоо томшгүй олон Христэд итгэгчийг баривчилж, хяхаж хавчсан. Энэ бол хөдөлшгүй баримт. Интернэт дэх цуу яриаг бүгдийг нь ХКН-ын засгийн газраас Төгс Хүчит Бурханы Чуулганыг хяхаж хавчихын тулд зохиосон юм. Тэд Бурханы ажлыг дарж, Хятадыг бурхангүй үзэлтэй бүс нутаг болгож, Бурханыг дагах юм уу шүтэн мөргөхийг хүмүүст зөвшөөрөхгүй байхыг зорьдог. Эгч ээ, ХКН бол бурхангүй үзэлтэй засгийн газар. Тэдний хэлдэг зүйлд итгэж болно гэж үү?” Эгчийн үг надад амжиж сануулав. Тийм ээ! ХКН бурхангүй үзэлтэй. Тэд Бурханыг хамгийн их үзэн ядаж, эсэргүүцдэг. Тэдний хэлдэг зүйлд хүн яаж итгэж болох вэ дээ! ХКН-ын засгийн газар “шашин шүтэх эрх чөлөө”-ний далбаан дор явдаг боловч нүднээс далдуур, Бурханд итгэдэг хүмүүсийг улайран албадаж, баривчилдаг. Өмнө нь ХКН-ын засгийн газар манай чуулганы хүмүүсийг хэрхэн албадаж, дарангуйлсныг болон үүнээс болж хэчнээн олон ах эгч итгэлээ алдаж, итгэж зүрхлэхгүй болж, би ч бас ажилгүй

---

болсноо бодохоор Бурханд итгэдэг хүмүүст хандах ХКН-ын засгийн газрын хандлага энэ биш гэж үү? Шашин шүтлэгийг хязгаарлахын тулд ХКН Гурван Өөрөө сүмийг байгуулж, эхлээд “улсаа хайрлаж”, дараа нь “шашнаа хайрлах”-ыг хүмүүсээс хүссэн юм. Тэд хүмүүсийг гартаа бат хянаж, шашин шүтэх эрх чөлөөг нь хязгаарлахыг зорьдог. Энэ тухай бодоод би ХКН-ын засгийн газрын жигшүүрт санаа зорилгыг жаахан ялган таньдаг боллоо. ХКН-ын засгийн газар үргэлж шашин шүтлэгийг хяхаж хавчин, үнэн замыг яллаж ирсэн. Иймээс тэд цуу яриа зохиож, Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг яллаж байгаа нь Бурханыг үзэн ядагч, Бурханыг эсэргүүцэгч сатанлаг уг чанарыг нь ихэд ил болгож байгаа бус уу?

Бу эгч үргэлжлүүлэн ингэж нөхөрлөв: “ХКН-ын засгийн газар бол бурхангүй үзэлтэй сатанлаг дэглэм бөгөөд Бурханы дайсан юм. Хүмүүсийг байнга хянадаг болох зэрлэг санаархлаа биелүүлэхийн төлөө тэд Төгс Хүчит Бурханы Чуулганыг яллаж, нэр хүндийг нь гутаахаар харыг цагаан болгон мушгин гуйвуулдаг. Бид үүнийг нэлээд сайн ялгаж салгаж чаддаг. Гэхдээ шашны пастор, ахлагч нар яаж бурхангүй үзэлт дэглэмийг даган, Бурханыг эсэргүүцэж, яллаж, доромжилж чадна вэ? Ихэнх хүмүүс энэ асуудлыг ойлгож чаддаггүй. Үнэндээ энэ нь Бурханыг эсэргүүцэж, үнэнийг үзэн яддаг шашны удирдагчдын уг чанар, мөн чанартай холбоотой. Эзэн Есүс хүн төрөлхтнийг золин аврах ажил хийсэн хоёр мянган жилийн өмнөхийг эргээд санавал Тэрээр ахлах тахилчид, хуулийн багш нар болон фарисайчуудын туйлын их эсэргүүцэл, хавчлагатай нүүр тулсан. Тухайн үед Эзэн Есүсийн номлосон зам, үзүүлсэн гайхамшиг нь Иудейн газар нутагт шуугиан дэгдээснээс энэ нь үүдэлтэй. Эгэл жирийн олон хүн Эзэний үгэнд татагдаж, нэг нэгээрээ Эзэн Есүс рүү эргэн ирсэн юм. Ахлах тахилчид, хуулийн багш нар болон фарисайчууд үүнийг өөрсдийнх нь байр суурь, ашиг орлогод заналхийлж байна гэж хараад Ромын засгийн газартай хуйвалдан Эзэн Есүсийг эсэргүүцэж, ялласан. Тэд цуу яриа тарааж, Эзэний ажлыг гүтгэж, Эзэн Есүсийг загалмайд цовдолсон билээ. Одоо хоёр мянган жилийн өмнөх түүх давтагдаж байна. Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг улам олон хүн хүлээн зөвшөөрч байгааг шашны удирдагчид хараад даруй атаархаж, ХКН-ын засгийн газартай нэгдэн Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг эсэргүүцэж, ялладаг. Шашны ихэнх удирдагч бол үнэнийг хайрладаггүй, байр суурийг л хайрладаг антихристүүд гэдгийг энэ нь бүрэн харуулдаг. ‘Эрт дээр үеэс хойш үнэн замыг үргэлж дарангуйлж ирсэн.’ Иймээс Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг ХКН-ын засгийн газар болон шашны нийгэмлэгийн муу ёрын хүчин эрс эсэргүүцэж, ялладаг гайхах зүйлгүй.” Тийм ээ, фарисайчууд, ахлах тахилчид болон хуулийн багш нар бүгд шашны нийгэмлэгийн эрх мэдэл бүхий хүмүүс боловч Бурханы жинхэнэ итгэгчид байгаагүй бөгөөд үнэнийг хайрлаагүй. Эзэн Есүсийн үг эрх мэдэл, хүч чадалтай гэдгийг тэд мэдэж байсан ч огт эрж

---

хайж, судлаагүй. Харин ч, байр суурь, амин зуулгаа хадгалахын тулд Эзэнийг яллаж, доромжилсон. Тэдний уг чанар үнэхээр л Бурханыг эсэргүүцэж, Бурханы дайсан байх явдал. Одоо шашны нийгэмлэгийн пастор, ахлагч нар Эзэний хоёр дахь ирэлтийн тухайд хэрхэн авирладаг нь фарисайчуудын хийсэн зүйлтэй адилхан. Тэд Бурханыг үзэн ядагч, үнэнийг үзэн ядагч антихристүүд болж таарч байна! Эзэн Есүсийн эргэн ирэлтийг Библид зөгнөх үедээ **“Гэхдээ Тэр эхлээд олон зовлон туулах ёстой бөгөөд энэ үеийнхэнд гологдоно”** (Лук 17:25) гэсэн байдаг. Одоо Төгс Хүчит Бурхан ажлаа хийхээр ирсэн атал Түүнийг ХКН-ын бурхангүй үзэлт дэглэм болон шашны нийгэмлэг эсэргүүцэж, яллаж байна. Эзэний зөгнөлийн биелэл энэ биш үү? Энэ мөчид миний зүрх сэтгэл гэрэлтүүлэгдлээ. Ву эгч нөхөрлөлөө цааш ийн үргэлжлүүлэв: “ХКН-ын засгийн газар болон шашны нийгэмлэгийн интернэтээр түгээдэг сөрөг суртал ухуулга Бурханы ажлыг мөн чанартаа сүйрүүлж, үймүүлэх зорилготой. Сатан хүмүүсийг мэхэлж, төөрөгдүүлэн, Бурханд эргэлзэж, Бурханыг үгүйсгэж, Бурханаас урвахад хүргэхийн тулд үргэлж худал хуурмагийг ашиглаж ирсэн. Эцэстээ тэд Бурханаар шийтгүүлж, там руу илгээгдэж, Бурханаар авруулах боломжоо үүрд алдана. Бид тэдний цуу яриаг ялган салгаж, цуу яриа дэгдээх өөдгүй муу санаа, жигшүүрт зорилгыг нь ухаарах ёстой. Эс тэгвээс бид төөрөгдөлд автаж, Бурханаар авруулах боломжоо алдана.” Би санаа нийлэн толгой дохиж, эгчийн нөхөрлөл болон тусламж үнэхээр цагаа олж гэж бодлоо. Цааш сонсоно гэхээс би тэсэж ядан байв...

Ву эгч Бурханы үгийн номыг гаргаж ирээд надад ингэж хэлэв: “Эгч ээ, Төгс Хүчит Бурханы үгийн хэсгээс уншицгаая! Төгс Хүчит Бурхан ингэж хэлсэн: **‘Миний төлөвлөгөөнд Сатан алхам бүрийг үргэлж өсгий даран дагасаар ирсэн ба Миний мэргэн ухааны товойллогчийн хувиар Миний анхдагч төлөвлөгөөг тасалдуулах арга зам олох гэж үргэлж оролдсоор ирсэн. Гэхдээ түүний зальхай явуулгад Би автаж болно гэж үү? Тэнгэр, газар дээр буй бүх зүйл Надад үйлчилдэг; Сатаны зальхай явуулга өөр байж чадна гэж үү? Яг энд Миний мэргэн ухаан огтлолцдог; энэ нь яг нарийндаа Миний үйл хэргийн гайхалтай байдал бөгөөд Миний бүхий л удирдлагын төлөвлөгөө хэрэгждэг зарчим юм. Хаанчлалыг байгуулах эринд Би Сатаны зальхай явуулгаас мөн л зайлсхийдэггүй, харин хийх ёстой ажлаа үргэлжлүүлэн хийдэг. Орчлон ертөнц болон бүх зүйлийн дундаас Би Сатаны үйл хэргийг Өөрийн товойллогч болгон сонгосон. Энэ нь Миний мэргэн ухааны илрэл биш гэж үү? Миний ажлын гайхалтай байдал яг энэ биш гэж үү?’** (“Үг нь махбодоор илэрсэн” номын Бүх орчлон ертөнцөд хандсан Бурханы айлдваруудын “8-р бүлэг”).”

Бурханы үгийг уншсанахаа дараа Ву эгч ингэж нөхөрлөв: “Бурханы ажлын алхам бүр нь Бурханы хүсэл, мэргэн ухаан, гайхалтай байдлыг агуулдаг гэдгийг бид Төгс Хүчит

---

Бурханы үгээс харж байна. Эхлэлээс төгсгөл хүртэл Бурханы ажил Сатаны заль мэхээс зайлсхийдэггүй, харин Бурханд үнэхээр итгэдэг хүмүүсийг төгс болгож, хүн төрөлхтнийг аврах Бурханы удирдлагын төлөвлөгөөг гүйцэлдүүлэхийн тулд Бурханы ажлын ашиг тусын төлөө Сатаны заль мэхийг ашигладаг. Гаднаа Сатан Бурханыг эсэргүүцэх биеэ тоосон зангаар дүүрэн харагддаг боловч Бурханы мэргэн ухаан үргэлж Сатаны заль мэхэнд үндэслэн хэрэгждэг. Анх Сатан хүмүүсийг завхруулсан боловч Бурхан үүнийг шууд устгаагүй. Харин Бурхан хүн төрөлхтнийг аврахын тулд ажлынхаа гурван үе шатыг ашигладаг бөгөөд хүн төрөлхтнийг завхруулж, төөрөгдүүлдэг, Бурханыг улайран эсэргүүцэж, Бурханд дайсагнадаг диавол Сатаны жинхэнэ нүүр царайг харуулж, Сатаны үзэшгүй муухай царай болон муу ёрын мөн чанарыг хүн төрөлхтөнд үнэхээр харуулах зорилгоор, хүн төрөлхтнийг аврах явцдаа Сатанд үймүүлж, саад хийх боломж олгодог. Ингэснээр хүмүүс Сатаныг идэвхтэйгээр голж, хаяад, Бурхан руу эргэн ирж чаддаг бөгөөд Сатан бүрмөсөн шившиг болж, бүтэлгүйтнэ. Энэ бол Сатаны эсрэг хамгийн хүчирхэг гэрчлэл бөгөөд Бурханы мэргэн ухаан, төгс хүчнийг илчилдэг. Иов муугаас зайлсан, Бурханаас эмээдэг хүн байсан ч Иовд зовлон учруулахыг Бурхан Сатанд зөвшөөрч, эцэст нь шалгалтын үеийн Иовын гэрчлэлийг ашиглан Сатаныг шившиглэж, Иовын талаарх Бурханы үнэлгээ тэр чигтээ зөв байсан гэдгийг нотолсонтой яг адилхан. Энэ нь Бурханы мэргэн ухаан байлаа. Үүнээс гадна, эцсийн өдрүүдэд Бурханы хийдэг зүйл бол хүмүүсийг аварч, төгс болгох ажил юм. Энэ нь бас хүмүүсийг төрлийнх нь дагуу ангилж, эрин үеийг төгсгөх ажил юм. Бурхан ХКН-ын засгийн газар болон шашны нийгэмлэгийн хавчлагыг ашиглан хүмүүсийг янз бүрийн шалгалт, гай зовлон туулахад хүргэдэг. Бурханд үнэхээр итгэдэг хүмүүс гай зовлон туулснаар үнэнийг ойлгож, ялган таньж, Бурханы төгс хүчит байдал, мэргэн ухааныг мэдэж, Сатаны хорон муу байдлыг нэвт харж, эцэст нь Сатаныг бүрмөсөн голж, Бурханы авралыг хүртэж чаддаг. Харин хулчгар, хуурамч итгэлтэй, үнэнээс уйдсан хүмүүс болон үнэнийг үзэн яддаг муу хүмүүс шалгалт, гай зовлонгоор дамжуулан бүгд илчлэгдэж, хөөн зайлуулагдах бай болдог. Ийнхүү хонь ба ямаа; буудай ба үрийн сүүл; сайн зарц ба муу зарц; ухаалаг охид ба мунхаг охид бүгд төрлийнхөө дагуу ангилагддаг. Энэ бол Бурханы мэргэн ухаан, төгс хүчин юм.” Ву эгчийн нөхөрлөлийг сонссоныхоо дараа би Иудейн фарисайчууд болон Ромын засгийн газар Эзэн Есүсийг цовдолсон хоёр мянган жилийн өмнөх үеийг эргэн санахгүй байж чадсангүй. Хүний өнцгөөс бол Эзэн Есүсийн ажил бүтэлгүйтсэн боловч Эзэн Есүс **“Биелэгдлээ!”** гэж хэлсэн юм. Сатаны хавчлага, цовдолоор дамжуулан Бурхан хүн төрөлхтнийг золин аврах ажлыг гүйцэлдүүлсэн билээ. Өнөөдөр эцсийн өдрүүдэд ХКН-ын засгийн газар болон шашны нийгэмлэгийн яллалт, гүжирдлэг нь Бурханд үнэхээр итгэдэг хүмүүсийг төгс болгох Бурханы зорилгод яг таг үйлчилсэн төдийгүй тэднийг яллах Бурханы нотолгоо болсон билээ. Төгс Хүчит Бурхан ингэж хэлдэг: **“Миний мэргэн ухаан Сатаны арга мэхэнд**

---

үндэслэн хэрэгждэг” (Үг нь махбодоор илэрсэн номын “Байлдан дагуулалтын ажлын дотоод үнэн (1)”). Библид ингэж тэмдэглэгдсэн байдаг: “Өө, Бурханы мэргэн ухаан болон мэдлэгийн аль алины баялаг юутай гүн билээ! Түүний шүүлтүүд яасан ойлгохын аргагүй, Түүний замууд нь яасан олж илрүүлэхийн аргагүй билээ!” (Ром 11:33). Энэ тухай бодоод би Бурханы ажил маш ухаалаг, дэндүү гайхалтай болохыг харж, зүрх сэтгэлийнхээ угаас Бурханыг магтсан юм.

Бу эгчийн нөхөрлөлөөр дамжуулан би Бурханы ажлын талаар жаахан ойлгодог болж, мөн ХКН-ын засгийн газар болон шашны нийгэмлэг Бурханыг эсэргүүцдэгийн мөн чанарыг бага зэрэг ялгаж салгаж чаддаг болсон боловч биднийг хүнд итгэдэг буюу Ариун Сүнсний ашигладаг хүнд итгэдэг гэж интернэтэд бичсэн зүйлийг ойлгохгүй хэвээр байв. Бу эгчээс би: “Интернэтэд биднийг хүнд итгэдэг гэж бичсэн байна. Энэ үнэн гэж үү?” хэмээн асуув. Бу эгч энэ асуултын талаар ийнхүү нөхөрлөлөө: “Чи Бурханы ажил болон хүний ажлын хоорондох ялгаатай холбоотой үнэнийг тодорхой ойлгоогүй байгаад асуудал оршиж байна. Эхлээд Төгс Хүчит Бурханы үгээс хоёр хэсгийг уншицгаая. Төгс Хүчит Бурхан ингэж хэлдэг: **‘Бурханы Өөрийн ажил бүх хүн төрөлхтний ажлыг хамардаг ба энэ нь бас бүхэл бүтэн эриний ажлыг төлөөлдөг. Өөрөөр хэлбэл, Бурханы Өөрийн ажил нь Ариун Сүнсний ажлын хөдөлгөөн, чиг хандлага бүрийг төлөөлдөг, харин элч нарын ажил нь Бурханы Өөрийн ажлын дараа явагдаж, араас нь дагадаг ба эрин үеийг удирддаггүй, мөн бүхий л эрин дэх Ариун Сүнсний ажлын чиг хандлагыг ч төлөөлдөггүй. Тэд хүний хийх учиртай ажлыг л хийдэг бөгөөд энэ нь удирдлагын ажилтай ямар ч хамаагүй байдаг. Бурханы Өөрөө хийдэг ажил бол удирдлагын ажил доторх төсөл юм. Хүний ажил нь зөвхөн ашиглагдаж байгаа хүмүүсийн үүрэг бөгөөд удирдлагын ажилтай холбоогүй’** (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурханы ажил ба хүний ажил”). **‘Бурханы хийдэг ажил Түүний махбодын туршлагыг төлөөлдөггүй; хүний хийдэг ажил хүний туршлагыг төлөөлдөг. Хүн бүр хувийн туршлагынхаа тухай ярьдаг. Бурхан үнэнийг шууд илэрхийлж чадна, харин хүн зөвхөн үнэнийг туулсныхаа дараа холбогдох туршлагыг илэрхийлж чадна... Бурханы Өөрийн ажил уу, хүний ажил уу гэдгийг танихын тулд чи энэ хоёрын ялгааг л харьцуулах ёстой’** (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурханы ажил ба хүний ажил”). Бурханы ажил бол шинэ эринийг эхлүүлэх ажил гэдгийг Төгс Хүчит Бурханы үг бидэнд ойлгуулж байна. Энэ нь бүх хүн төрөлхтнийг авардаг ажил юм. Хүн ямар ч эрин үеийг эхлүүлж чадахгүй, мөн хүн төрөлхтнийг аврах ажлыг ч хийж чадахгүй. Хүний ажил бол ердөө л Бурханы ажлын суурин дээр хүний үүргийг биелүүлэх явдал юм. Энэ нь, Бурханы үгийн бодит байдалд ороход нь хүмүүсийг усалж, хангаж, залж чиглүүлэх зарим ажлыг хийх явдал бөгөөд Бурханы ажилтай хамтран хийгддэг боловч хүний ажил Бурханы Өөрийн ажлыг орлож огт



---

чадахгүй, үүнийг Бурханы ажилтай адил ангилалд авч үзэж ч болохгүй. Эзэн Есүс Нигүүлслийн эрин үеийг эхлүүлж, Хуулийн эрин үеийг төгсгөн, хүн төрөлхтнийг шинэ эрин үе рүү хөтөлсөн Нигүүлслийн эрин үеийг жишээ болгоод үз. Эзэн Есүс ажлаа дуусгасны дараа Петр болон бусад элч Эзэн Есүсийн ажлыг үргэлжлүүлж эхэлсэн бөгөөд чуулганыг удирдан чиглүүлж, хариулж, ах эгч нарыг Эзэний замыг дагахад хөтөлсөн билээ. Энэ нь тэр чигтээ Эзэн Есүсийн ажилтай хамтран ажиллаж байсан. Тухайн үед чуулганы хүмүүс Петрийн хариулга, удирдлагыг хүлээн зөвшөөрсөн боловч Петр юм уу бусад элчид итгэж байна гэж хэн ч хэлээгүй. Энэ бол баримт. Үүний адилаар эцсийн өдрүүдийн Төгс Хүчит Бурхан ирээд Нигүүлслийн эрин үеийг төгсгөж, Хаанчлалын эрин үеийг эхлүүлсэн; Тэрээр Бурханы гэрээс эхлэн шүүлтийн ажлыг хийж, хүн төрөлхтнийг ариусгаж, аврах бүх үнэнийг илэрхийлдэг. Хэрвээ эдгээр үнэнийг ойлгож, хэрэгжүүлж, дотор нь орж чадвал жинхэнэ аврал хүртэж, төгс болгуулах хүмүүс нь бид юм. Гэхдээ дорд хэв чанараас маань болоод Бурханы үгийг өөрсдөө уншиж, Бурханы үгийг туулж, жинхэнэ авралд хүрэх нь амаргүй, хэтэрхий удаан байдаг. Иймээс Бурхан биднийг удирдан чиглүүлэх гэж Ариун Сүнсний ашигладаг хүнийг өсгөсөн. Ариун Сүнсний ашигладаг хүнийг Бурхан урьдчилан бэлдэж, төгс болгосон юм. Тэрээр Бурханы ажлыг туулснаар аврал, төгс болголтыг хүртсэн туршлагатай. Тэрээр Бурханы үгийн туршлагаа ашиглан Бурханы үгийг мэдэх, Бурханы үгэнд ороход биднийг удирдан чиглүүлдэг. Энэ нь бидэнд замаасаа бага гажих боломжийг олгодог. Бид Ариун Сүнсний ашигладаг хүний удирдлага, усалгааг хүлээн зөвшөөрч, дуулгавартай дагаж л байвал Бурханд итгэж, жинхэнэ аврал хүртэх зөв замд орж чадна. Энэ нь тэр чигтээ биднийг гэх Бурханы сайхан сэтгэл, ерөөл билээ. Ариун Сүнсний ашигладаг хүний хийдэг ажил нь Бурханыг өргөмжилж, гэрчлэх, мөн Бурханыг дуулгавартай дагаж, шүтэн мөргөхөд биднийг залж чиглүүлэх явдал юм. Тэрээр өөрт нь Бурхан гэж хандахыг биднээс хэзээ ч хүсээгүй, мөн өөрт нь итгэ гэж ч гуйгаагүй. Бурханы сонгосон бүх хүн энэ талаар маш тодорхой ойлгодог: Ариун Сүнсний ашигладаг хүн бол бидний ах, удирдагч төдий, харин бид Ариун Сүнсний ашигладаг хүнд бус, эцсийн өдрүүдийн Христ, Төгс Хүчит Бурханд итгэдэг. Биднийг Ариун Сүнсний ашигладаг хүнд итгэдэг гэж интернэтээр цуурхдаг. Энэ бол цэвэр баримтыг гуйвуулж, зөв бурууг хольж хутгасан явдал. Энэ нь хүмүүсийг төөрөгдүүлэх гэсэн Сатаны төөрөгдөл, худал хуурмаг юм. Өөрөө харахын тулд та Төгс Хүчит Бурханы Чуулган руу очиж, ах эгч нарын дунд байж, тэднийг сонсож, үнэхээр ойлгосон нь дээр байх. Тэгвэл, бид Төгс Хүчит Бурханы үгийг уншиж, Төгс Хүчит Бурханы нэрээр залбирч, бие махбодтой болсон Бурханд Өөрт нь буюу эцсийн өдрүүдийн Христ, Төгс Хүчит Бурханд итгэдэг гэдгийг олж харна. Төгс Хүчит Бурханы Чуулганыг бүхэлд нь Христ удирддаг. Бурханы үг л хүч чадал эзэмшдэг. Тэгэхээр хэл дээ, бид хүнд итгэдэг үү, Бурханд итгэдэг үү? Энэ илэрхий биш байна гэж үү?” Эгчийн нөхөрлөлийг

---

сонссоныхоо дараа би Бурханы ажил болон хүний ажлын талаар бага зэрэг мэдэж авч, бас Ариун Сүнсний ашигладаг хүнийг өсгөх Бурханы санаа зорилгын талаар жаахан ойлгов. Түүнчлэн бид хүнд бус, бие махбодтой болсон Төгс Хүчит Бурханд итгэдэг гэдгийг мэдэж авлаа. Би дотроо өөрийн эрхгүй ингэж бодов: Бидний хүлээн авсан зүйл бол Бурханы ажил, Бурханы үгийн хангалт юм. Бид Төгс Хүчит Бурханд итгэдэг; бид хүнийг дагаж, хүнд итгэдэггүй. Интернэт дэх эдгээр цуурхал нь үнэхээр л хүмүүсийг төөрөгдүүлэх гэсэн Сатаны худал хуурмаг, худал үг юм шиг байна. Эхэндээ бидний анхны өвөг дээдэс болох Адам, Ева хоёр Сатаны заль мэхэнд автсан; тэд Сатаны худал үгийг сонссон учраас нүгэл үйлдэн, Еден цэцэрлэгээс хөөгдсөн. Эзэн Есүсийг цовдлохоор фарисайчуудтай нэгдсэн иудей хүмүүс ч бас цуу яриа сонсож, Сатаны заль мэхэнд хууртан, Бурханы эсрэг мөнхийн нүгэлтнүүд болсон. Би урьдын бүтэлгүйтлүүдээс сургамж авах ёстой. Тэгээд Сатанд мэхлэгдэхээ болих ёстой!

Бу эгч явахдаа надад Бурханы үгийг илүү их унш гэж хэлээд, Ариун Сүнсний ашигладаг хүний нөхөрлөлийг надад уншуулахаар үлдээв. Нэг өдөр би нөхөрлөлийн дараах хэсгийг харсан юм: “Энэхүү шийдвэрлэх чухал мөчид хүмүүс, Бурханы үгийг идэж уух, өөрсдөд нь Бурханы даалгасан юуг ч хийх, үүргээ гүйцэтгэх, Бурханыг хангалуун байлгах, Бурханыг алдаршуулах явдлыг хэрэгжүүлэлтийнхээ эн тэргүүнд тавих ёстой— ийм маягаар хэрэгжүүлснээр л хүмүүс Бурханд үнэнч байж чадна. Урьдын ариун хүмүүс: ‘Ашиг, алдагдал маань хамаагүй; бид Бурханы хүсэлд анхаарал хандуулах ёстой’ гэж үргэлж хэлдэг байв. Энэ нь бүх хүний уриа болох ёстой. Тодорхой хэрэгжүүлэлт дараах байдалтай байна: Хэрвээ хүнд Сатан яршиг удвал Бурханы гэрчлэл болон Бурханы ажлыг хамгаалж, Сатаныг ялахын тулд үнэнийг ашиглах нь эхний үүрэг юм; хэрвээ хүн нүгэл юм уу уруу таталттай нүүр тулбал Бурханыг алдаршуулах нь эн тэргүүнд байх ба хүн нүгэл үйлдэж, Бурханыг шившиглэх ёсгүй; хэрвээ хүний үүргийн хэрэгжилтэд хүмүүс, асуудал, зүйлс саад болбол Бурханы даалгасан зүйл эн тэргүүнд байх бөгөөд хүн бүх ээдрээ бартаанаас ангижирч, Бурханд үнэнч байх ёстой; хүний хувийн ашиг сонирхолтой холбоотой асуудал гарч ирэх юм бол Бурханы гэрийн ашиг сонирхол эн тэргүүнд байна. Хувийн ашиг сонирхлоо орхиж, Бурханы зүрх сэтгэлд хайхрамжтай байх нь амин чухал билээ. Хэрвээ хорвоо ертөнцийн хэрэг явдал хүнийг хүлж, хязгаарлах юм бол эхлээд үүргээ биелүүлж, Бурханыг хангалуун байлгах ёстой бөгөөд бусад бүх зүйлийг хөсөр хаяж, өөрийгөө Бурханы төлөө зарлагадах ёстой” (Дээрхийн нөхөрлөлөөс). Бурханы хүслийг хангалуун байлгахын тулд бодит амьдрал дээр хэрхэн хэрэгжүүлэх, Бурханд үнэнч байхын тулд юу хийх талаар Ариун Сүнсний ашигладаг хүний нөхөрлөлөөс би тун тодорхой мэдэж авав. Ариун Сүнсний ашигладаг хүн Бурханыг дуулгавартай дагах, үнэнд орох, Бурханы хүслийг биелүүлэхэд биднийг үнэхээр залж чиглүүлж байгаа санагдлаа.

---

Бидэнд зориулж Бурханы зохицуулсан “орчуулагч” үнэхээр сайн болохыг би мэдэрсэн юм! Үнэнийг илүү хурдан ойлгож, Бурханыг мэддэг болоход биднийг залж чиглүүлэхийн тулд Бурхан Ариун Сүнсний ашигладаг хүнийг бидэнд зориулан урьдчилан бэлдсэн болохыг би улам тодорхой мэдэрлээ. Энэ бол биднийг гэх Бурханы чин сэтгэлийн хайр юм! Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг яллан, Ариун Сүнсний ашигладаг хүнийг дайрч давшилсан, интернэтэд түгсэн тэдгээр цуу яриаг энэ үед би бүрэн дүүрэн нэвт харж, хөсөр хаясан билээ. Байж сууж чадахгүй байсан би эцэст нь нэг санаа амарч болохоор болов. Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс гэдэгт би үнэхээр итгэсэн юм. Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн авснаар би Хурганы мөртэй хөл нийлүүлж, Хурганы хуримын найрт оролцож, Бурханы сэнтийн өмнө өргөгдсөн!

Сатаны энэхүү үймээнийг туулсныхаа дараа би Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажилд улам бүр үнэмшсэн юм. Одоо би Төгс Хүчит Бурханыг арав гаруй жил дагаж байна. Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг дөнгөж хүлээн зөвшөөрөөд байх үедээ тэр бүх үзэлтэй байснаа дараа нь зарим үнэнийг ойлгож, ХКН-ын засгийн газар болон шашны нийгэмлэгийн цуу яриаг нэвт харж, үзлээ хаяж, төөрөгдөлд автахдаа больж, үнэнийг эрэлхийлэхээр хичээж, бүтээгдсэн зүйлийн үүргээ биелүүлж, Бурханы хайрыг хариулж, Төгс Хүчит Бурханыг шийдвэртэйгээр дагасан үеэ би эргэн саналаа. Энэ нь надад Бурханы эдгээр үгийн үнэнийг үнэхээр мэдрүүлдэг: **“Махбод дахь Бурхантай харилцахдаа хүн эсэргүүцлээс дуулгавартай байдал руу, хавчлагаас хүлээн зөвшөөрөл рүү, үзлээс мэдлэг рүү, гололтоос хайр луу хөгжин дэвшдэг—эдгээр нь бие махбодтой болсон Бурханы ажлын үр дүн юм”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Завхарсан хүн төрөлхтөнд бие махбодтой болсон бурханы аврал илүү их хэрэгтэй”). Бурханд талархъя!

## 22. “Барын үүр”-ээс дайжсан нь

Шиаоёу, Хятад

Миний нэрийг Шиаоёу гэдэг, би 26 настай. Анх би Католик шашинтай байсан юм. Бага байхдаа Мөргөлд оролцож, Библи уншиж, нүглээ улайн, ариун зоог хүлээн авахаар ээжтэйгээ хамт сүмд явдаг байлаа. Миний ээж итгэлдээ маш махруу зүтгэлтэй байв. Тэрээр гэрийнхээ хоол хүнс, янз бүрийн бусад зүйлсийг чуулгандаа хандивлаж, мөн мөнгө хандивладаг байсан юм. Чуулганы удирдагч, гэлэнмаа нарт ээж маш их таалагддаг байв. Ээжийг харахаараа тэд инээмсэглэн мэндэлж, маш их анхаарал хандуулж, бас ээж рүү байн байн утсаар ярьж, сүмийн бүхий л төрлийн үйл ажиллагаанд оролцон, янз бүрийн үүрэг даалгавар гүйцэтгэхэд туслахыг хүсдэг байлаа. Би ч бас гэлэнмаа нарын заадаг

---

хичээлд идэвхтэй оролцдог байсан бөгөөд сүмийн гишүүдтэйгээ хамт Библи уншдаг байв. Тэр үед би, Эзэнийг дэргэдээ байлгаснаас ирдэг баяр хөөр, амар тайвныг мэдэрч, өдөр бүр аз жаргалтай байдаг байлаа. Хэдий тийм боловч цаг хугацаа өнгөрөхийн хэрээр сүмийн гишүүдийн маань итгэл улам бүр хөрч байв. Миний сүнс ч бас сул дорой болж, Эзэний сургаалуудыг мөрдөх чадваргүй боллоо. Би байн байн нүгэл үйлдэж, дараа нь нүглээ улайдаг байсан бөгөөд гэрлэснийхээ дараа нөхөртэйгээ хамт ажиллахаар улсынхаа өөр хэсэг рүү нүүв.

Нүд ирмэхийн зуурт 2013 оны Зул сарын баяр болж, Төгс Хүчит Бурханы Чуулганы нэг эгчтэй уулзах завшаан надад тохиосон юм. Эгч надад Эзэн Есүс аль хэдийнэ эргэж ирсэн, тэгээд Өөрийн ажлын шинэ үе шатыг гүйцэтгэж байгаа гэж хэлэв. Үүнийг сонсоод би гайхаж, сэтгэл хөдлөн: “Тийм үү? Эзэн эргээд ирчихэж! Эзэн хэзээ эргэж ирсэн юм бэ? Эзэн яг одоо хаана байгаа юм бэ? Эгч ээ, надад хэлээч” гэлээ. Эгч надтай нөхөрлөж, “Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс юм. Төгс Хүчит Бурхан хэдэн сая үг илэрхийлсэн бөгөөд эцсийн өдрүүд дэх шүүлтийн ажлаа хийж байгаа. Тэрээр хүн төрөлхтнийг аврахын тулд Бурханы гүйцэтгэдэг ажлын гурван үе шат, бие махбодтой болохын нууц, Библийн нууц, Бурханы нэрийн утга учир, хүн төрөлхтний төгсгөл, хүрэх газар зэргийг оролцуулаад хүнийг ариусгаж, аврах бүх үнэнийг илчилсэн. Энэ нь Эзэн Есүсийн: **‘Та нарт хэлэх зүйл Надад олон байгаа боловч та нар одоо тэдгээрийг дааж чадахгүй. Гэхдээ үнэний Сүнс болох Тэр ирэх үедээ та нарыг бүх үнэн рүү удирдана: Учир нь Тэр Өөрийн санаагаар ярихгүй; харин сонссон зүйлээ Тэр ярих болно: Мөн Тэр ирэх зүйлсийг та нарт харуулна’** (Иохан 16:12–13) хэмээх үгийг биелүүлдэг” гэж хэлэв. Би эгчийн нөхөрлөлийг чин сэтгэлээсээ сонсож, “Эзэний эргэн ирэлтийг угтан авч чадах юм гэж би хэзээ ч бодож байсангүй. Энэ ч гайхмаар байна шүү” гэж бодлоо. Дараа нь эгч надад Бурханы ажлын гурван үе шат болон Бурханы нэрсийн утга учрын талаар гэрчлэл хийв. Намайг ойлгохгүй байж магад гэж айсандаа эгч зүйрлэл, жишээ ярьж өгөв. Тэрээр тодорхой, илэрхий байдлаар нарийвчлан дэлгэрэнгүй нөхөрлөсөн юм. Түүний нөхөрлөлөөр дамжуулан би урьд нь ойлгоогүй байсан олон үнэнийг ойлгож авав. Түүнчлэн хүнийг шүүж, гэсгээж, цэвэрлэж, төгс болгох ажлыг гүйцэтгэхээр Эзэн эргэн ирснийг мэдсэн юм. Төгс Хүчит Бурхан бол үнэхээр эргэн ирсэн Эзэн Есүс байх тун боломжтой гэж надад санагдсан бөгөөд би эцсийн өдрүүд дэх Бурханы ажлыг судлах хүсэлтэй байгаагаа эгчид хэллээ. Дараа нь би ах, эгч нартай хамт цуглаанд оролцож, Бурханы үгийг уншиж, Бурханыг магтсан магтан дуу дуулж, бүжиглэдэг байв. Бурханы үгийг унших зуур ойлгохгүй зүйлс тулгарах бүрд ах, эгч нар тэр талаар маш тэвчээртэй нөхөрлөдөг байлаа. Тэдний нөхөрлөлд Ариун Сүнсний гэгээрэл, гэрэлтүүлэлт байсан бөгөөд тэдэнтэй хамт цуглаанд оролцох нь Ариун Сүнсний ажлын таашаалыг дахин

---

нэгэнтээ эдлэх боломжийг надад олгосон юм. Би туйлын их аз жаргалтай байлаа. Төгс Хүчит Бурханы энэ том гэр бүлд дээд доод, баян ядуугийн зааг ялгаа байсангүй. Ах эгч нар бүгд бие биетэйгээ нээлттэй байж, үргэлж сэтгэлээ уудалдаг байлаа. Энэ бол үнэхээр аз жаргалтай амьдрал мөн гэж надад санагдав! Нэг сар гаруй хугацаанд судалсны дараа би Бурханы олон үгийг уншсан ба Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс мөн гэдэгт итгэх боллоо. Би их хувьтай хүн мэт надад санагдахын зэрэгцээ энэ сайн мэдээг ээждээ болон сүмийн гишүүддээ хэлэхийг хүсэв.

Хятадын цагаан сарын үеэр нөхөр бид хоёр төрсөн нутагтаа очлоо. Гэртээ харьж ирээд би ээждээ Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлын талаар нэн даруй гэрчлэл хийсэн боловч намайг юу ч гэж хэлсэн бай, ээж маань үүнийг хүлээж авахаас татгалзав. Миний урам жаахан хугарч, нэлээн их балмагдлаа. “Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс гэдэг нь тодорхой. Ээж үүнийг яагаад хүлээн зөвшөөрч чаддаггүй байна аа?” гэж би бодов. Ээж маань хүлээн авахгүй байгааг хараад би энэ асуудлыг орхихоос өөр аргагүй болсон юм. Төрсөн нутагтаа очих аялал маань дууссаны дараа би ажиллаж байсан газар луугаа буцав. Би ах, эгч нартай хамт цуглаанд оролцож, чуулгандаа үүрэг гүйцэтгэж байлаа. Тэр үед сүнс минь таашаалаар бялхаж, амьдрал минь харьцуулшгүй аз жаргал, баяр хөөрөөр дүүрч байсан юм. Иов шалгалтаар бүх эзэмшлээ, хөвгүүд, охидоо алдаж, түүний бие яр хатгинд бүрхэгдсэн атал тэрээр Бурханы нэрийг магтаж, Бурханд жинхэнэ итгэлтэй байж чадсан тухай би Бурханы үгээс уншлаа. Мөн цорын ганц хүү Исаакаа тахил болгож, Бурханд эргүүлэн өгч чадсан Абрахам бас байв. Эдгээр зүйлийн тухай унших үед ялангуяа тэдний итгэл, Бурханд дуулгавартай байдал сэтгэлийг минь хөдөлгөж, би ч бас ийм хүн байхыг хүслээ.

Яг Бурханы хайранд умбан байх үед миний амьдрал гэнэт хар дарсан зүүд болж хувирав. 2014 оны 8 дугаар сарын нэгэн өдөр ээж гэнэтхэн над руу утсаар ярьж, охин маань хүнд өвчтэй байгааг хэллээ. Үүнийг сонсоод би сандарч цочирдлоо. “Охин маань тийм жаахан; тэр яаж тийм хүнд өвчтэй байж болох юм бэ?” гэж би бодов. Охиныхоо төлөө би маш их санаа зовж, үнэхээр аймшигтай санагдаж байлаа. Тэгээд би Бурханы өмнө очиж: “Өө Бурхан минь, Таны зөвшөөрлөөр ийм нөхцөл байдал надад тулгарлаа. Миний охины өвчин Таны гарт байгаа. Би охиноо Танд даатгахыг хүсэж байна. Надад жинхэнэ итгэл өгөөч” хэмээн залбирав. Залбирсны дараа би бага зэрэг тайвширлаа. Тэгээд нөхөр бид хоёр яаравчлан төрсөн нутаг дахь гэртээ харив. Биднийг гэртээ очиход охин маань орондоо маш тайван унтаж байсан нь миний гайхшийг төрүүллээ. Би охиноо сэрээхийг хүссэн боловч ээж гараараа дохин намайг болиулж, “Битгий сэрээ. Тэр зүгээр!” гэж ширүүн хэлсэн юм. Тэр үед л би олон хамаатан маань манайд цугласан байхыг анзаарсан бөгөөд Төгс Хүчит Бурханд итгэхийг минь болиулах гэсэндээ гэртээ хурдан

---

ирүүлэхийн тулд ээж намайг хуурсан болохыг ухаарлаа. “Бурхан өнөөдөр надад зориулж энэ нөхцөл байдлыг зохицуулсан. Энэ бол миний туулах ёстой зүйл байж таарна” гэж би бодов. Тэгээд би ээжээсээ: “Ээж ээ, охин маань зүгээр байна. Та яагаад намайг хуурч ирүүлсэн юм бэ?” гэж асуулаа. Намайг ярьж дуусахаас өмнө ээж уурлан хашхирч: “Би сүм рүү явж, тахилч нар болон чуулганы удирдагчдаас асуусан. Зүүний Аянга аюултай, бас тэдэнтэй нэгдмэгцээ чи дахин хэзээ ч тэднийг орхин явж чадахгүй гэж тэд хэлсэн. Цаашид битгий итгэ. Би чиний сайн сайхны төлөө л ингэж байна. Чамайг буруу замд орсон байх гэж би айж байна” гэлээ. Ээж маань бас Төгс Хүчит Бурханы Чуулганы эсрэг шашны ертөнцийн зохиосон худал үг, гүтгэлгийг давтан хэлсэн юм. Ээжийнхээ хэлэхийг сонсоод би ингэж бодлоо: “Миний итгэл огтхон ч буруу биш. Харин ч эсрэгээрээ, би Бурханы шинэ ажилтай хөл нийлүүлж байна. Миний итгэдэг Төгс Хүчит Бурхан бол өнөө үед хүнийг шүүх, гэсгээх, цэвэрлэх ажлыг хийж байгаа эргэн ирсэн Эзэн Есүс юм. Энэ бол үнэн зам гэдэгт би туйлын итгэлтэй байна, тэгэхээр би яагаад үүнээс татгалзана гэж? Тахилчид болон чуулганы удирдагчид: ‘Хэрвээ Зүүний Аянгад итгэж, чуулганд нь нэгдэх юм бол хэзээ ч гарч чадахгүй’ гэж хэлж байгаа нь хүмүүсийг мэхлэхийн тулд зохиосон цэвэр цуу яриа, төөрөгдөл юм. Би Төгс Хүчит Бурханы Чуулганы цуглаануудад оролцоод хагас жил илүү хугацаа өнгөрч байна. Энэ талаар би хүмүүс та нараас илүү ихийг мэднэ. Төгс Хүчит Бурханы Чуулганы үүд хаалга үргэлж нээлттэй байдаг ба хүмүүс чөлөөтэй явж болно. Энэ нь тахилч, чуулганы удирдагчдын хэлдэгтэй огт адилгүй. Ах, эгч нар бүгд Бурханы үгийг уншсанаар үнэн замыг мэдэж авсан ба амийн хангалт хүртэж, амийн усны булгийг олсон. Ийм учраас тэд чуулганыг орхиж явахыг хүсдэггүй. Төгс Хүчит Бурханы үгийг уншаад бидний сүнс хангалуун болдог. Хуучны эзгүйрч, хоосорсон сүм рүү эргэн очихыг хэн хүсэх билээ дээ? Тахилч, чуулганы удирдагч нар Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг огт судлаагүй. Тэд Төгс Хүчит Бурханы үгийг уншаагүй, түүнчлэн Төгс Хүчит Бурханы Чуулганы цуглаанд оролцоогүй. Тэд юунд суурилан ингэж хэлж байгаа юм бэ? Тэд ор үндэсгүй цуу яриаг санаанаасаа зохиож байгаа бус уу?” Хариу хэлэхгүй байгааг минь хараад ээж уурсан хүрч ирээд, намайг хэдэнтээ алгадан, Бурханаас урвасан зүйл албан хүчээр хэлүүлэх гэж оролдов. Ээжийнхээ ийм байгааг харахад үнэхээр сэтгэл өвдөж байлаа. Хэрвээ тахилч, чуулганы удирдагч нарын зохиосон худал хуурмаг байгаагүй бол ээж маань яавч Төгс Хүчит Бурханд итгэхийг минь болиулахаар хүчлэхгүй байсан гэж бодогдсон юм. Тэгээд би ээждээ “Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс. Төгс Хүчит Бурханд итгэх нь тэнгэрийн хууль, газрын зарчим. Би Түүнд эцсээ хүртэл итгэх болно!” гэж хэллээ. Ингэж хэлэхийг минь сонсоод ээж уурласандаа минчийн улайж, нүд нь улаанаар эргэлдэв. Тэгээд над руу: “Би чиний ээж. Чи намайг сонсох ёстой!” гэж чангаар хашхичлаа. Ээжийнхээ ийм бодлогогүй байхыг хараад би өөр юу ч хэлэхгүй байхаар шийдэв. Яг тэр үед хамаатнууд маань ч бас намайг нэгэн зэрэг

---

шүүмжилж эхэлсэн бөгөөд намайг Бурханаас урвуулахаар оролдон олон зүйл хэллээ. “Би Эзэн Есүсийг аль хэдийн угтан авсан. Миний итгэдэг Бурхан жинхэнэ, миний алхдаг зам зөв. Би яавч Бурханаас урвахгүй!” гэж би бодов. Би тэдэнд Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг судалж, мөн тахилч, чуулганы удирдагч нарын цуу ярианд хууртан Төгс Хүчит Бурханыг сохроор яллаж, эсэргүүцэхгүй бай гэж зөвлөхийг үнэхээр хүссэн юм. Гэвч үнэнийг болон Бурханыг үзэн ядсан хандлагыг нь хараад тэд үнэнийг хүлээн авахгүй гэж надад санагдсан ба би юу ч хэлсэн нэмэргүй байх учраас тэдэнд дахин юу ч хэлсэнгүй. Хэсэг хугацааны дараа ээж болон хамаатнууд маань хамтдаа гарч явцгаалаа. Гэвч ээж маань намайг зүгээр орхисонгүй, харин дүүг манайд амьдруулахаар болов. Дүү маань намайг гэмт хэрэгтэн мэт өдөр бүр ажиглаж, хаашаа ч явсан дагадаг байлаа. Ингээд л миний хувийн эрх чөлөө алдагдсан юм.

Хоёр хоногийн дараа би гэр бүлийнхэнтэйгээ хамт оройн хоолоо идэж байтал ээж маань гэнэт орж ирэв. Ээж маасайтал инээж, дүр эсгэсэн өнгөөр “Шиаоёу, хэн ирснийг хараач!” гэж надад хэлэв. Ээжийн дууны өнгө, илэрхийллээс улбаалан би: “Миний ээжийг ийм ааш зантай байхад хүргэдэг ямар хүн ирсэн юм бол оо. Энэ ч сайн юм биш дээ” гэж гайхахад хүрэв. Яг тэр үед чуулганы удирдагч Лиу, сүмийн гишүүн Ван орж ирлээ. Би тэдэнтэй тайвнаар мэндэлж, суухыг урив. Биднийг хоолоо идэж дууссаны дараа чуулганы удирдагч Лиу над руу харж инээмсэглээд, “Шиаоёу! Шулуухан ярилцацгаая. Ээжийн чинь хэлснээр бол чи одоо Зүүний Аянгад итгэдэг юм байна. Үүнд итгэхээ боль гэж би чамд хэлэх ёстой. Танай гэр бүлийнхэн олон үеэрээ Католик шашинтай байсан. Чи Эзэнийг орхиж болохгүй, эс бөгөөс Тэр чамайг орхино. Өнөөдөр бид чамд зөвлөгөө өгөхөөр ирлээ, гэхдээ чи биднийг сонсохгүй бол цаг нь ирээд, тамд унах үедээ биднийг буруутгаж болохгүй шүү. Шиаоёу, бид чиний сайн сайхны төлөө л ингэж байна. Нөхрийнхөө өвчнийг бодоод үз. Хэрвээ чиний ээж бид хоёр өдөр бүр Эзэнд залбираагүй бол нөхрийн чинь бие сайжрахгүй байх байсан. Хэрвээ чи Зүүний Аянгад үргэлжлүүлэн итгээд, нөхрийн чинь өвчин дахих юм бол хэн ч туслахгүй” гэж хэллээ. Түүний ингэж хэлэхийг сонсоод зүрх маань дэлсэж, би өөрийн эрхгүй бага зэрэг айв. Тэгээд би: “Нөхөр маань маш их өвдөж, бид их мөнгө зарцуулсан боловч тэр сайжраагүй. Эцэст нь бид өдөр бүр залбирсны хүчээр л түүний биеийн байдал сайжирсан. Хэрвээ юмс үнэхээр тэдний хэлснээр болж, нөхрийн маань өвчин дахивал би яах вэ?” гэж бодлоо. Тэдний заль мэхэнд автаж эхэлж байтал **“Төгс Хүчит Бурхан бол хэмжээлшгүй чадалтай эмч билээ!”** (“Үг нь махбодоор илэрсэн” номын Христийн эхэн үеийн айлдваруудын “6-р бүлэг”) хэмээх Бурханы үгийн мөр санаанд орлоо. Энэ тухай бодоод би гэнэт сэрж, ухаан санаа цэлмэв. “Тийм шүү. Би эргэн ирсэн Эзэн болох Төгс Хүчит Бурханд итгэдэг. Миний нөхөр дахин өвдөх эсэх нь Бурханы гарт байгаа; энэ нь тэднээс хамаарахгүй. Бурхан бүхнийг захирдаг.

---

Надад айгаад байх юм юу байна аа? Ямартай ч тэд биш, Эзэн л миний нөхрийг эмчилсэн. Намайг сүрдүүлж Бурханаас урвуулах гэсэндээ нөхрийн маань өвчнийг ашиглаж, бас гэр бүлд маань бэрхшээл тохиолдохоос айсандаа Бурханыг үгүйсгэж, урвахад намайг хүргэхээр оролдоно гэж би хэзээ ч төсөөлсөнгүй. Тэд ямар өөдгүй юм бэ!” гэж би бодлоо. Хорлонтой сэдлийг нь нэвт хараад би тэднийг жигшиж, тэдэнтэй цаашид ярихыг хүссэнгүй.

Дуугүй байгааг минь хараад чуулганы удирдагч Лиу ёжтойгоор: “Чи их шаргуу байх шиг байна! Бид чамд зөндөө хэллээ, тэгэхээр чи юу бодож байгаагаа бидэнд хэл дээ!” гэв. Тэд дөнгөж сая нөхрийн маань өвчний талаар ярьснаас хойш надад жаахан эвгүй байлаа. Гэвч Бурхан бүхнийг захирдаг тухай бодох үедээ би гэнэт өөртөө итгэлтэй болов. Юу ч тохиолдсон бай хамаагүй, би Бурханаас урвахгүй. Би зоригоо чангалан тэдэнд ийн хэллээ: “Би Төгс Хүчит Бурханд бат итгэдэг гэдгээ та бүхэнд хэлье! Бурханд итгэх итгэлээсээ би татгалзахгүй!” Намайг сонсоод ээж маань: “Явцгаая! Сүм рүү явж залбиръя” гэж бархирав. Түүнийг ингэж хэлэхэд бүгд уурлан гарч одлоо. Тэдний догшин ширүүн төрхийг хараад би өөрийн эрхгүй бага зэрэг айв. “Тэд залбирах гэж байна. Арай намайг хараах юм биш биз? Би яах вэ?” гэж бодогдлоо. Ийнхүү яах ч аргагүй байдалд орсон би Бурханы өмнө очиж, “Өө Төгс Хүчит Бурхан минь! Тэд бүгд миний эсрэг тулалдахаар зогсоод намайг бүсэлж байна! Надад ганцаархнаа байгаа мэт санагдаж байна. Өө Бурхан минь! Би юу хийхээ мэдэхгүй байна. Маш их айж байна. Намайг залж чиглүүлээч!” хэмээн залбирлаа. Залбирч дуусаад би Бурханы зарим үгийг саналаа: **“Чамайг хүрээлэн буй орчны бүх зүйл Миний зөвшөөрлөөр оршдог, Би бүгдийг нь төлөвлөдөг гэдгийг чи мэднэ. Тодорхой харж, Миний чамд өгсөн орчинд Миний зүрх сэтгэлийг хангалуун байлга. Бүү ай, олон түмний Төгс Хүчит Бурхан чамтай гарцаагүй хамт байна; Тэр та нарын ард зогсдог, Тэр та нарын бамбай билээ”** (“Үг нь махбодоор илэрсэн” номын Христийн эхэн үеийн айлдваруудын “26-р бүлэг”). Бурханы үгийн гэгээрэл, удирдамж дор сэтгэл маань цэлмээд ирэв: “Тийм ээ! Бурхан бол миний баттай түшиг тулгуур. Бурхан миний хажууд байхад айх зүйл юу ч байхгүй. Чуулганы удирдагч болон Ван гэгч хүн намайг тамд очно гэж айлган, гэр бүлд маань бэрхшээл тохиолдож, нөхөр маань өвдөхөөс айлган, улмаар Бурханыг орхиулахын тулд л тэдгээр зүйлийг хэлсэн. Хэрвээ би хулчийж, айх юм бол Сатаны арга залинд автсан гэсэн үг болох бус уу? Нөхөр бид хоёрын хувь заяа, хүрэх газар, зол завшаан, азгүйтэл өөр хэн нэгнээс хамаарахгүй, тахилч болон чуулганы удирдагчдаас бүр ч шалтгаалахгүй. Тэдгээр нь Бурханы гарт байдаг. Тэд намайг яллаж, хараагаад ямар ч нэмэргүй” гэж би бодлоо. Ингэж бодоод би дахин тайвширч, ердөө ч айхгүй байлаа. Үгээрээ намайг удирдаж, Сатаны явуулгыг нэвт харах итгэл, хүч чадал өгснийх нь төлөө би Бурханыг магтаж, Түүнд талархсан ба ингэснээр би ээждээ болон



---

бусад хүмүүст мэхлэгдэж, самуураагүй юм.

Нэг өдрийн үдээс хойш би хүүхэдтэйгээ хамт дуг хийх гэж байтал хуучин чуулганы маань Жао эгч, Жан эгч хоёр ирж намайг үймүүлэв. Жао эгч намайг айлган сүрдүүлэх зүйл хэлж, Жан эгч маш ноцтой царайлан: “Энэ үнэн шүү. Бид урьд нь Төгс Хүчит Бурханы Чуулганы хүмүүстэй холбогдож, тэдэнд хууртах дөхсөн” гэв. Түүний ингэж хэлэхийг сонсоод миний уур хүрлээ. Ах, эгч нар маань хүн хуурахаар оролдож яавч чадахгүй гэдгийг би мэдэж байв. Тэдний хэлж байсан бүхэн ердөө л худал хуурмаг, гүтгэлэг байлаа. Иймд би түүнээс: “Тэд таныг яаж хуурсан юм бэ?” гэж асуув. Жан эгч ноцтой өнгөөр: “Чи мэдэх аргагүй. Тэд надад ном өгсөн!” гэв. Би цааш нь түүнээс: “Надад хэлээч, тэдний өгсөн ном ямаршуу байсан бэ? Номны нэр нь юу юм? Юуны тухай байсан бэ?” гэж асуулаа. Жан эгч сандарсан харагдсан ба хэсэг зуур ээрч, түгдэрч байснаа эцэст нь “Би мартчихжээ” хэмээн асуултаас булзахаар оролдов. Ингэж хэлэхийг нь сонсоод би: “Та нар бол гэлэнмаа! Яаж бусдыг зориуд үндэслэлгүй буруутган худал гэрчлэл хийж зүрхлэв ээ? Та нар яагаад Бурханд ийм хүндэтгэлгүй хандаж байгаа юм бэ? Та нар үнэхээр Бурханд итгэгчид мөн үү? Бурханаар шийтгэгдэхээс айхгүй байна уу?” гэж бодлоо. Дараа нь Жао эгч надаас: “Чи ажилдаа явах гэж байна уу?” гэж дахин асуув. Би “Тийм ээ!” гэж эрс шийдэмгий хариулсан юм. Тэрээр худал тал засаж, надад: “Битгий ажилдаа яв. Гэртээ суугаад хүүхдээ харсан нь хавьгүй дээр!” гэж зөвлөв. Би тэдний хоёр нүүртэй занг маш их үзэн ядсан тул өрөөнөөс гарч явахдаа: “Өөрсдийгөө л хичээ” гэж хэлсэн юм. Надад саад хийх оролдлого нь бүтэлгүйтсэнийг хараад тэд цөхөрсөн байдалтай явж одлоо. Тэднийг явсны дараа би маш их бухимдаж, бачимдав. Чуулганы удирдагчид болон энэ гэлэнмаа нар саяхнаас намайг дарамтлахаар байн байн ирж, нэг бол Төгс Хүчит Бурханыг болон ах эгч нарыг гүтгэж, дайрч давшилж, тэдний талаар цуу яриа тарааж, эсвэл намайг мэхэлж, айлган сүрдүүлэхийн тулд гажууд онол түгээж байгаа тухай би бодов. Хэдийгээр би тэдэнд хуурталгүй, тэдэнтэй маргаж, тэдний хэлснийг няцааж байсан боловч тухай бүрд нь маш их цухалдан, Бурханы өмнө өөрийгөө тайван байлгаж, Бурханы үгийг уншиж чадахгүй байлаа. Дүү маань намайг цаг үргэлж ажигласан хэвээр байв. Би залбирч, магтан дуу дуулж, Бурханы үгийг унших болгондоо маш их хязгаарлагдсан мэт санагдаж, тун их сэтгэлээр унаж байлаа. Зовж шаналсандаа би Бурханд хандан залбирлаа: “Төгс Хүчит Бурхан минь! Чуулганы энэ удирдагч, энэ гэлэнмаа нар надад саад хийх гэж ахин дахин ирлээ. Би маш их бачимдаж, бухимдаж байна. Яг одоо би тэдэнтэй хэрхэн учраа олохоо мэдэхгүй байна. Хүндэт Бурхан минь, намайг гэгээрүүлж, залж чиглүүлээч!”

Залбирсныхаа дараа би MP5 тоглуулагчаа гаргаад Бурханы үгийн энэ хэсгийг харж таарлаа: **“Том сүмд Библи уншиж, үүнийг бүхэл өдөржингөө цээжээр уншдаг хүмүүс байдаг атал тэдний дундаас нэг нь ч Бурханы ажлын зорилгыг ойлгодоггүй. Тэдний**

---

дундаас нэг нь ч Бурханыг мэдэж чаддаггүй; тэдний дундаас бүр нэг ч хүн Бурханы хүсэлд нийцэж чаддаггүй. Тэд бүгдээрээ үнэ цэнгүй, өөдгүй хүмүүс бөгөөд Бурханд зааж сургахын тулд дор бүрнээ өндөрт зогсдог. Тэд Бурханы нэрээр далайлгадаг атлаа Түүнийг дур зоргоороо эсэргүүцдэг. Бурханд итгэдэг гэх атлаа тэд хүний махыг идэж, цусыг уусаар байдаг. Ийм хүмүүс бүгд хүний сүнсийг залгидаг диаволууд, зөв замд орохоор хичээж буй хүмүүст зориуд саад учруулдаг толгойлогч чөтгөрүүд, мөн Бурханыг эрж хайдаг хүмүүст садаа болдог бул хар чулуу билээ. Тэд ‘эрүүл чийрэг бие махбодтой’ харагдаж болох ч Бурханыг эсэргүүцэхэд хүмүүсийг хөтөлдөг антихристүүдээс цаашгүй гэдгийг дагагчид нь яаж мэдэх юм бэ? Хүний сүнсийг залгидаг амьд диаволууд гэдгийг дагагчид нь яаж мэдэх юм бэ?” (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурханыг мэддэггүй бүх хүн бол Бурханыг эсэргүүцдэг хүмүүс юм”).

Бурханы үгийг уншиж дууссанахаа дараа би тэр даруй ойлгов. Энэ тахилчид, чуулганы удирдагч нар Өөрийн үгээр Бурханы илчилсэн шашны антихристүүд яг мөн болж таарлаа. Хэдийгээр тэд Эзэнд итгэдэг боловч үнэнийг огтхон ч эрэлхийлдэггүй, Бурханаас эмээх зүрх сэтгэл ч байдаггүй байв. Тэд Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг өөрсдөө судлаагүйгээр барахгүй, бас Бурханыг доромжилж, Бурханы шинэ ажлыг яллаж, ээжийг минь мэхлэхийн тулд цуу яриа зохиосон ба ингэснээр ээж намайг цохиж, загнаж, гэрийн хорионд байлгах байлаа. Тэгээд тэд намайг дарамталж, хуурч, мэхэлж, сүрдүүлэхийн тулд манайд ахин дахин ирсэн юм. Аз болоход, Бурханы үг намайг залж чиглүүлж, хөтөлж байсан болохоор би тэдний явуулгад автсангүй, Бурханаас ч урвасангүй. Фарисайчууд ч бас жирийн иудейчүүд Эзэн Есүсийн сайн мэдээг хүлээн авахад саад учруулахын тулд төрөл бүрийн жигшүүрт арга хэрэглэж байсан. Тэд хүмүүсийг мэхлэхийн тулд худал яриа хүртэл ашиглан, Эзэн Есүсийн ажил Хуучин Гэрээнээс хальж гарсан бөгөөд Есүс бол эргэн ирсэн Мессиа биш гэж хэлж байв. Энэ нь жирийн иудейчүүдийг фарисайчуудтай нийлж, нүгэлгүй Эзэн Есүсийг цовдлоход хүргэсэн юм. Эзэн Есүс тэднийг зэмлэн: **“Хоёр нүүрт хуулийн багш нар, фарисайчууд та нар золгүй еэ! Яагаад гэвэл та нар хүмүүсээс тэнгэрийн хаанчлалыг хааж, өөрсдөө орохгүй бөгөөд орж буй хүмүүсийг ч оруулахгүй”** (Матай 23:13) гэж хэлсэн. Би фарисайчуудын хийсэн зүйлийг тахилчид, чуулганы удирдагчид, гэлэнмаа нарын үйлдэлтэй харьцуулаад, фарисайчуудын мөн чанарыг хэрхэн ялгах тухай ах, эгч нарын урьдын нөхөрлөлийг бодлоо. Тэгээд тахилч, чуулганы удирдагч нар үндсэндээ өнгөрсөн үеийн фарисайчуудаас өөрцгүй болохыг тов тодорхой харав. Өөрсдийн байр суурь, амин зуулгыг хамгаалахын тулд тэд Төгс Хүчит Бурханд итгэхэд минь саад хийхээр боломжит бүх аргыг ашиглаж байлаа. Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг би ээж болон бүх гэр бүлийнхэндээ номлож, гэр бүлийнхэн маань Төгс Хүчит Бурханд итгэж эхэлнэ хэмээн тэд айж байжээ. Энэ нь тэдний хонин сүргийн хэмжээг цөөрүүлж, сар бүр авдаг хандивыг ч багасгах байв. Тэд үнэхээр

---

Бурханы тахилыг хулгайлж, тэнгэрийн хаанчлалд ороход нь хүмүүст саад учруулдаг муу зарц нар, антихристүүд юм! Тэдний антихрист мөн чанарыг тодорхой хармагцаа би энэ хүмүүстэй хэрхэн харьцахаа мэдлээ. Тэд Бурханд итгэдэг ч Бурханыг эсэргүүцдэг, Бурханы дайснууд байсан бөгөөд тийм болохоор би тэднийг орхих ёстойгоо мэдэж байсан юм. Хэдийгээр саяын хэдэн өдөр тэд надад төвөг удсаны улмаас би зовж шаналсан ч Бурханы үгийн удирдамж, гэгээрэл надад байв. Бурханы сөрөг товойлгогч болсноороо тэд намайг ялган таних чадвартай болгосон бөгөөд Бурханы үгтэй холбоотой зарим бодит туршлагатай болох боломж олгосон. Би Бурханы үг бол үнэн, зам, амь болохыг биечлэн мэдэрч, Төгс Хүчит Бурхан бол жинхэнэ Бурхан гэдэгт улам их итгэх болов. Би зүрх сэтгэлдээ туйлын их баяр хөөр, амар тайвныг мэдэрч, чимээгүйхэн сэтгэл шулуудлаа: Сатан яаж ч үймүүлэхээр оролдсон бай, би Бурханаас хэзээ ч урвахгүй. Бурханы төлөө гэрчлэлд зогсон, диавол Сатаныг шившиглэхээр шийдсэн!

Амар тайван өнгөрүүлсэн хоёрхон өдрийн дараа Сатаны дарамт, шахалттай дахин нэг удаа тулгарна гэж би хэзээ ч төсөөлж байсангүй. Нэг шөнө ээж, хэдэн нагац ах эгч нар, бас ээжийн нагац эгч Төгс Хүчит Бурханд итгэхэд минь саад хийх гэж ирлээ. Бүгдээрээ цугласныг нь хараад би маш их уурлав. “Би ердөө л жинхэнэ Бурханд итгэдэг. Юу ч нь буруу байгаа юм бэ? Тэд яагаад энэ талаар дахин дахин хөөцөлдөөд байгаа юм бэ?” гэж бодогдов. Энэ үед ээжийн нагац эгч нэг л жигтэйгээр “Алив, Шиаоёу. Эмээгийн чинь очъё” гэж хэлэв. Ээжийн нагац эгчийн ингэж хэлэхийг сонсоод би гайхан, ингэж бодлоо: “Тэд намайг ээжийнх рүү авч явах гэж иржээ. Тэгээд намайг сэтгэцийн асуудалтай эмээтэй минь хамт түгжихийг хүсэж байна! Миний хамаатнууд надад яаж ийм юм хийж чадаж байна аа? Тэд яахаараа ийм цэвдэг байж чаддаг байна аа!” Яг ингэж бодож байтал ээж маань олс шүүрэн авч, над руу яаран хүрч ирээд, явган сууж, хөлийг маань холбон уяж эхлэв. Би маш их түгшлээ. Тэгээд ээжийн гарыг түлхэн: “Та юу хийж байгаа юм бэ? Яагаад намайг хүлэх гээд байгаа юм?” гэж хашгирлаа. Үүнийг хараад хоёр нагац ах хүрч ирээд, хоёр мөрөн дээр маань дарж, намайг эсэргүүцэл үзүүлэх аргагүй болгов. Тэр үед би буйдан дээр сууж байсан бөгөөд босож чадахгүй байлаа. Би зүрх сэтгэлдээ Бурханыг яаран дуудлаа: “Өө Бурхан минь! Тэд намайг хүлээд, авч явахаар оролдож байна. Хэрвээ тэд амжилтад хүрвэл би Танд итгэх боломжгүй болно, бас чуулганыг олж чадахгүй болно. Өө Бурхан минь! Надад итгэл, хүч чадал, гарах гарц өгөөч!” Залбирч дуусаад биед маань хүч чадал бялхахыг мэдрэв. Би тэгээд: “Та нар яах гээд байгаа юм? Намайг тавиач!” гэж хашгиран тэмцэв. Ямар их эсэргүүцэж байгааг минь хараад тэд намайг суллалаа. Би Бурханд маш их талархаж байв. Хүн Бурханд чин сэтгэлээсээ найдаж байгаа цагт Бурханы үйл хэргийг харна гэдгийг би үнэхээр мэдэрсэн юм. Бас Бурхан миний хажууд байж, цаг ямагт намайг харж, хамгаалж байдгийг үнэхээр мэдэрсэн билээ. “Энэ орчин нөхцөлд би

---

үнэн зүрх сэтгэлээ Бурханд өргөн барих ёстой, бас диавол Сатаныг бүхэлд нь шившиглэх ёстой” гэж би бодлоо. Тэгээд би тэдэнд: “Бусад зүйлийн тухайд бол би та нарыг сонсоно. Гэхдээ Бурханд итгэх тухайд бол зөвхөн Бурханыг л сонсоно! Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс гэдэгт би аль хэдийн хатуу итгэсэн. Та нар намайг яаж ч хүчилсэн бай, би гуйвж дайвахгүй!” хэмээн тууштай хэлэв. Бурханыг дагахаар нэгэнт шийдмэгцээ би Бурханы үйл хэргийг дахин харлаа. Нагац эгч нарын нэг нь: “Түүнийг битгий хүл. Ингээд ямар ч нэмэргүй. Тэр баттай итгэснийг би харж байна” гэлээ. Нагац эгчийг тэгж хэлэхэд л тэд цөхөрсөн байдатай явцгаав. Тэднийг явсан даруй би хазганан, бие бялдар, сэтгэл санааны хувьд маш их ядарснаа мэдэрлээ. Надад өчүүхэн төдий ч хүч чадал үлдээгүй байв. Би орон дээрээ хэвтэж, нойронд умбасан юм. Дараа өглөө нь урьд шөнө болсон зүйлийн талаар бодоход сэтгэл санаа нэлээд хүнд байлаа. Хамаатнуудын надад хандаж байсан хандлагыг эргэн санаад ингэж бодохгүй байж би чадаагүй юм: “Ээ, халаг! Миний ээж болон хамаатнууд маань тахилчид, чуулганы удирдагчдын тараасан цуу ярианд хууртаад, намайг албадан шахах гэж үргэлжлүүлэн оролдсоор байна. Энэ бүхэн хэзээ дуусах юм бэ?” Тэгээд би Төгс Хүчит Бурханы Чуулганы ах, эгч нартай хамт байсан үеэ санав. Бид хамтдаа үнэнийг эрэлхийлж, үүргээ биелүүлж, бие биедээ тусалж, дэмжиж байлаа. Хэн ч, хэнийг ч дээрэлхэхээр оролдож байгаагүй бөгөөд сэрэмжлэх шаардлагагүй байсан юм. Надад маш эрх чөлөөтэй, чөлөөлөгдсөн санагдаж, өдөр бүр сэтгэл хангалуун, амар тайван байдаг байжээ. Гэтэл одоо би гэртээ хоригдож, ямар ч эрх чөлөөгүйгээр, өдөр бүр сэтгэл түгшин амьдарч байв. Хамаатнууд юм уу хуучин чуулганы хүмүүс хэдийд ирэхийг би огт мэдэхгүй байлаа. Сайндаа л тэд намайг хөнгөхөн зэмлэж, хамгийн муудаа л, заналхийлж, айлган сүрдүүлэхээр оролддог байсан юм. Би маш их шаналж, аз жаргалгүй байлаа. Бас Төгс Хүчит Бурханы Чуулган руу буцан очиж, цуглаанд оролцож, ах эгч нартайгаа хамт магтан дуу дуулж, Бурханыг магтахыг үнэхээр хүсэж байсан юм.

Энэ явдлын дараа тун удалгүй бүр ч төсөөлөөгүй нэг зүйл болов. Нэг өдөр нөхөр бид хоёр юм худалдан авахаар гадагш гарлаа. Гэртээ эргэж ирээд би MP5 тоглуулагч дээрх Бурханы үгийг уншихыг хүссэн боловч олж чадсангүй. Миний сэтгэл ихэд түгшин, өрөөн дотуур нааш цааш холхин, “MP5 тоглуулагч маань хааччихав аа? Би гарцаагүй гэртээ орхисон шүү дээ. Яагаад олж чадахгүй байна аа?” гэж бодов. Ээж маань аваад явсан байж таарна гэж гэнэт бодогдлоо. Нэг өдөр ээж өрөөнд минь орж ирээд, MP5 тоглуулагч дээрээ Бурханы үгийг сонсож байгааг минь харсан гэдгийг би саналаа. Дараа нь ээж үе үе манай гэрт ирж, юмыг маань онгичдог байв. MP5 тоглуулагч маань олдохгүй байгаагийн шалтгаан нь ээж түүнийг авсных гэдэгт би итгэлтэй байв. Энэ тухай бодоод миний уур хүрч, ээжийнхээ гэр рүү бөөн уур болж очив. Хаалгаар орох үедээ би ээж нагац эгчтэй ярьж байгааг харлаа. Би ээж рүү очиж: “Ээж ээ, та миний MP5 тоглуулагчийг авсан уу?

---

Тэр чинь минийх. Хэрвээ та авсан бол яг одоо буцаагаад өг” гэж хэлэв. Гайхалтай нь, ээж маань үүнийг авснаа эрс үгүйсгэлээ. Ээжийн ихэмсэг харцыг хараад би ууртайгаар: “Би MP5 тоглуулагчаа гэртээ байлгадаг. Өөр хүн үүнд хүрсэн байх ёсгүй. Та л миний юмсыг байнга онгичиж байдаг. Та авсан нь тодорхой. Надад буцаагаад өг!” гэлээ. Намайг ингэж байцаахад ээж маань ширүүн дуугаар: “Би тэрийг чамд буцааж өгөхгүй. Чи тэрийг надаас хэзээ ч буцаан авахгүй тул гэртээ харьсан чинь дээр!” гэж хэлэв. Тэгээд намайг хэчнээн их шаардсан ч бай, надад өгөх шинжгүй байсан тул би гар хоосон харихаас өөр аргагүй болсон юм. Гэртээ харих замд надад үнэхээр таагүй санагдаж байлаа. “Би MP5 тоглуулагчгүй боллоо. Цаашид Бурханы үгийг уншиж чадахгүй нь. Урьд нь ээж болон бусад хүмүүс намайг дарамтлахаар ирдэг байсан хэдий ч би Бурханы үгийг уншиж, Бурханы үгийн удирдамж, удирдлагыг авч чаддаг байсан. Үр дүнд нь би Бурханы хүслийг ойлгож, итгэлтэй байж, тэдний дайралтыг тэвчих хүч чадалтай байж чадсан. Одоо MP5 тоглуулагч маань алга болчихлоо. Би яах вэ? Бурханы үг байхгүй болохоор би ингээд дуусаж байгаа биш үү?” гэж би бодов. Ингэж бодох тусам төдий чинээ найдваргүй санагдаж, сүнс маань сөрөг боллоо. Надад туйлын өрөвдөлтэй санагдаж байв. Хамгийн сул дорой болж, хамгийн их сэтгэлээр унах мөчид Бурханы үгийн магтан дуу санаанд орлоо: **“Өнөөдөр ихэнх хүмүүст тийм мэдлэг байдаггүй. Тэд зовлон үнэ цэнгүй, дэлхий ертөнц өөрсдийг нь хаясан, ар гэрийнх нь амьдрал төвөгтэй, өөрсдийг нь Бурхан хайрладаггүй, хэтийн ирээдүй нь бүрхэг гэж итгэдэг. Зарим хүний зовлон тодорхой нэг цэгт хүрэхэд тэдний бодол үхэл рүү ханддаг. Энэ бол Бурханыг гэх жинхэнэ хайр биш; тийм хүмүүс бол хулчгарууд, тэд ямар ч хатуужилгүй, сул дорой, хүчин мөхөс!... Тиймээс эцсийн энэ өдрүүдэд та нар Бурханд гэрчлэл хийх ёстой. Зовлон чинь хэчнээн их байх нь хамаагүй, та нар бүр эцсийг нь хүртэл алхах ёстой, эцсийн амьсгалаа авч байхдаа ч Бурханд үнэнч байж, Бурханы зохицуулалтад захирагдсаар байх ёстой; энэ нь л Бурханыг үнэхээр хайрлаж байгаа хэрэг бөгөөд энэ нь л хүчтэй, цангинасан гэрчлэл юм”** (Хургыг дагаж, шинэ дуу дуулъя номын “Зовлон чинь хэчнээн их байсан ч Бурханыг хайрлахаар эрж хай”). Энэ нөхцөл байдалд Өөрт нь гэрчлэл хийж чадна гэж Бурхан надад найдаж байсныг би Бурханы үгийн удирдамж дор ойлгосон билээ. Юмс хэчнээн хүнд хэцүү болсон ч бай, би эцсээ хүртэл Бурханд үнэнч байж, Бурханд итгэх итгэлээ алдахгүй байх ёстой байжээ. Би өөрийн туулсан бүх хяналт хавчлагыг бодоод, хэрэг явдал бүр сүнсний ертөнц дэх тулаан байсныг ухаарсан юм. Намайг бага багаар сүйрүүлэхийн тулд Сатан бүхий л төрлийн арга барил ашиглаж байлаа. Яг одоо тэр сүнснийг минь залгихыг хүссэндээ миний “сүнслэг амийн тэжээл”-ийг маань булаагаад авчихлаа. Сатан үнэхээр харгис хэрцгий юм. Би зальт арга мэхэнд нь автах ёсгүй. Хэдийгээр MP5 тоглуулагч маань байхгүй болсон хэдий ч надад Бурхан байсаар байв. Бурхан намайг мөн л гэгээрүүлж, залж чиглүүлсээр байх байсан бөгөөд

---

хором бүрд Бурханд найдаж байгаа цагт хүндрэл бэрхшээл бүрийг даван туулахад Бурхан надад тусална гэдэгт би итгэж байлаа. Ирээдүйд би ямар ч нөхцөлтэй нүүр тулгарсан бай, биед маань эцсийн ганц амьсгал үлдсэн цагт би Бурханы төлөө гэрчлэлд зогсоно. Бурханы үг дахин нэг удаа намайг чиглүүлж, цааш явахад хэрэгтэй итгэлийг надад өгсөн юм.

Энэхүү хавчлага, саад бэрхшээлийг ахин дахин туулснаар дамжуулан би Бурханы үгийн хүч чадал, эрх мэдлийг харсан билээ. Намайг сөрөг, сул дорой болж, будилж, самгардах бүрд Бурханы үг надад хэрэгтэй итгэл, хүч чадлыг өгч, Сатаны заль мэхийг нэвт харан, Бурханы төлөө гэрчлэлд зогсоход намайг залж чиглүүлж байв. Үүний зэрэгцээ, Бурхан хором бүрд миний хажууд байж, миний түшиг тулгуур болж, надад замыг нээж өгч байсныг би бас харж чадсан билээ. Бурханд итгэх итгэл минь бага багаар нэмэгдэж, гэр бүлийнхнээ орхиж явах хүсэл улам бүр хүчтэй болж байв. Би энэхүү “барын үүр”-ээс аль болох хурдан зугтаж, чуулган болон ах эгч нараа олж авах ёстой гэдгээ мэдэж байлаа. Тиймээс би Бурханд залбирч, энэ асуудлыг Түүнд даатгасан бөгөөд намайг залж чиглүүлэхийг Бурханаас гуйсан юм. Хэдэн өдрийн дараа би дүүгийнхээ ажиглалтаас бултаж, гэрээсээ амжилттай оргон зайлав. Би чуулганы амьдралаар амьдарч, чадлынхаа хэрээр үүргээ биелүүлэхийн тулд Төгс Хүчит Бурханы Чуулган руу буцаж очсон билээ. Нэг сар гаруйн шаналал зовлон тэгэхэд л эцэстээ дуусаж, миний зүрх сэтгэл дэх дарамт, санаа зовнилын мэдрэмж агаарт замхрах утаа адил сарнив. Сатаны харанхуй нөлөөг эвдэн гарч, “барын үүр”-ээс оргон зайлахад намайг залж чиглүүлэн, дахин нэг удаа Бурханы гэр бүл рүү замчилсных нь төлөө Бурханд талархъя.

Энэ хугацаанд би Бурханы хайр, авралыг тодорхой харж, Бурхан цаг ямагт намайг хамгаалан миний хажууд байж, Сатанд мэхлэгдэх, залгигдахаас намайг сэргийлж байсныг харсан учраас энэхүү туршлага оюун санаанд минь шинэ сэргэг хэвээр үлджээ. Үүний зэрэгцээ энэ ер бусын туршлага надад тахилч, чуулганы удирдагч нар болон бусад хүмүүсийг ялган таних чадвартай болгосон юм. Тэд Төгс Хүчит Бурханыг улайран яллаж, доромжлон, намайг мэхлэхийн тулд цуу яриа зохиож, худал гэрчлэл хийсэн. Мөн Төгс Хүчит Бурханыг дагахыг минь болиулахаар оролдон төрөл бүрийн арга заль ашигласан. Тэд бол Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн зөвшөөрч, Бурханы авралыг хүлээн авч, Бурханаар авхуулахад саад болдог бул хар чулуу, түүнчлэн хүмүүсийн сүнсийг залгихын тулд энд байгаа сатаны чөтгөрүүд! Энэ үед л би Төгс Хүчит Бурханы хэлсэн дараах үгийн жинхэнэ утга учрыг эцэст нь ойлгосон билээ: **“Итгэгчид, үл итгэгчид нь хоорондоо таарамжгүй; харин ч нэг нэгнийхээ эсрэг байдаг”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурхан хүн хоёр амралтад хамт орох болно”). Хэдийгээр тахилчид, чуулганы удирдагчид, гэлэнмаа нар, хуучин сүмийн гишүүд болон миний ээж гаднаа Бурханд итгэдэг мэт харагддаг боловч Бурханы дуу хоолойг ойлгодоггүй, Бурханыг мэддэггүй болохыг би

---

ухаарсан юм. Тэд эргэн ирсэн Эзэний ажлыг хүлээн авахаас татгалздаг тул Бурхан тэдний итгэлийг хүлээн зөвшөөрдөггүй. Бурханы нүдээр бол тэд үл итгэгчид. Тэд бол эцсийн өдрүүд дэх Бурханы ажлаар илчлэгдсэн үрийн сүүлнүүд бөгөөд мөн чанартаа Бурханыг эсэргүүцдэг чөтгөрүүд, антихристүүд юм. Түүнчлэн, гэр бүлийн гишүүдийн хавчлага болон шашны хүмүүсийн саад бэрхшээл нь бүгд Сатанаас үүдэлтэй дайралтууд, мөн сүнсний ертөнцөд явагдаж буй ширүүн тулаан юм гэдгийг би бас харав. Надад саад бэрхшээл учруулан, үнэн замыг хөсөр хаяж, Бурханаас урваж, өөрийнх нь “тэвэр”-т орж, Бурханаар авруулах боломжоо алдаж, түүнтэй хамт тамд сүйрэхэд намайг хүргэхийн тулд Сатан энэ хүмүүс, үйл явдал, зүйлсийг ашиглахыг хүсжээ. Гэхдээ Бурханы мэргэн ухаан Сатаны явуулгад суурилан хэрэгждэг. Сатан над руу дайрч, саад бэрхшээл учруулах болгонд Бурхан намайг хором бүрд удирдаж, залж чиглүүлсэн ба ингэснээр би Бурханы үгийг туулж, Түүний үгээр дамжуулан ялган таних чадвар, гүн ухаантай болж чадах байв. Бурхан бас Түүнд итгэх итгэлийг минь төгс болгож, Бурханд итгэх миний итгэлийг жинхэнэ, тууштай болгож, сул дорой байхыг нь болиулсан юм. Намайг залж чиглүүлэн, сар гаруйхны хугацаанд зарим үнэнийг ойлгоход минь тусалсан Бурханд талархаж байна. Одоо би сайн муу, сайхан муухайн ялгааг мэднэ. Бурханд итгэх итгэл минь улам бэхжиж, би Бурханд илүү ойр болсон. Зовлон шаналал бол үнэхээр Бурханы ерөөл юм! Ирээдүйн итгэлийн амьдралдаа би Бурханы ажлыг бүр их туулахыг хүсэж байгаа бөгөөд эцсээ хүртэл Төгс Хүчит Бурханыг дагахад бэлэн байна!

## **23. Аюулын ирмэгт**

Жан Хуй, Хятад

2005 онд би Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн авсныхаа дараахан хуучин чуулганыхаа нэг ахад сайн мэдээ түгээсэн юм. Дараа нь нэг өдөр Ли пастор, Ван хамтран зүтгэгч хоёр манай гэрт ирлээ. Миний зүрх дэлсэж, “Яах гэж ирсэн юм бол оо? Төгс Хүчит Бурханыг хүлээн авсан гэдгийг минь мэдэж байгаа болов уу? Чуулганы бусад гишүүн Төгс Хүчит Бурханыг хүлээн авах үед тэр хоёр цуу яриа дэгдээж, тэднийг сүрдүүлж, гэр бүлийнхнээр нь итгэлийг нь эсэргүүцүүлж эхэлсэн. Миний эсрэг ямархуу арга мэх хэрэглэх бол” гэж гайхлаа. Төд удалгүй хүү охин хоёр маань ирсэн. Би ч гайхлаа. Хүүхдүүд маань үнэхээр завгүй гэсэн байж өнөөдөр яагаад хоёул хоёулаа ирдэг билээ? Ли пастор тэгж зохицуулсан юм болов уу? Үүнийг тэд урьдаас бэлдсэн гэдгийг би ухаарсан юм. Тэгээд шууд Бурханд залбирлаа: “Өө Бурхан минь, тэд над дээр юу туршихыг мэдэхгүй байна. Миний биеийн хэмжээ дэндүү өчүүхэн болохоор үүнтэй яаж нүүр тулахаа мэдэхгүй юм. Намайг замчилж, үнэн зам дээр бат зогсоход минь туслаач” гэсэн.

---

Залбирсны дараа арай тайвширлаа.

Яг тэгтэл Ли пастор инээмсэглээд, “Жан ах аа, таныг Зүүний Аянгыг хүлээн авсан гэж сонслоо. Энэ үнэн үү? Зүүний Аянгад хэчнээн их үнэн байлаа ч, бид хүлээн авч болохгүй. Бид бүгд Эзэнд олон жил итгэж, Түүний төлөө номлосон. Эзэн Есүс цовдлогдож, нүглийн тахил болсноор биднийг нүглээс маань золин аварсан гэдгийг бид бүгд мэднэ. Эзэний нэр, зам хоёрыг бид цаг ямагт баримтлах ёстой. Өөр Бурханд итгэж болохгүй. Эзэн Есүсийг орхиж, Төгс Хүчит Бурханд итгэснээрээ та Эзэнээс урваж байгаа биш үү?” гэсэн.

Би ч сандралгүй тайвнаар, “Ли пастор оо, бид үндэслэлтэй, бодитой байж, нотолгоог дагах ёстой, харин дураараа яллаж болохгүй. Та Зүүний Аянгын замыг судлаагүй, Төгс Хүчит Бурханы үгийг уншаагүй байж намайг Зүүний Аянгыг хүлээн авснаар Эзэнээс урваж байна гэж дүгнэж яаж болдог юм бэ? Үнэн хаанаас гардгийг та мэдэх үү? Үнэнийг хэн илэрхийлдгийг мэдэх үү? Эзэн Есүс: **‘Би бол зам, үнэн, амь юм’** (Иохан 14:6) гэж хэлсэн. Бурхан бол үнэний эх сурвалж. Зүүний Аянгад хэчнээн их үнэн байлаа ч хүлээн авч болохгүй гэж хэлж яаж болдог юм бэ? Ингэх нь албаар үнэнийг эсэргүүцэж, Бурханыг эсэргүүцэж байгаа хэрэг биш үү? Биднийг ер нь Эзэнд итгэгчид гэж тооцох уу? Ойрд би Төгс Хүчит Бурханы маш олон үгийг уншсан, тэгээд тэдгээр нь үнэн юм байна, олон үнэн болон нууцыг илчилдэг юм байна гэдгийг харсан. Энэ олон жилийн турш итгэхдээ амссан бүх бэрхшээлээ Төгс Хүчит Бурханы үгээр шийдвэрлэсэн. Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс гэдэгт би бат итгэдэг. Төгс Хүчит Бурханыг дагах нь Эзэний ирэлтийг угтан авч байгаа хэрэг! Төгс Хүчит Бурханд итгэх нь Эзэн Есүсээс урваж байгаа хэрэг гэж та хэллээ. Энэ чинь үнэнтэй нийцдэг үү? Эзэн Есүсийг ажиллахаар ирэхэд Түүнийг дагахаар маш олон хүн сүмийг орхисон. Тэглээ гээд тэд Ехова Бурханаас урвасан гэсэн үг үү? Эзэн Есүсийн золин авралын ажил Ехова Бурханы хийсэн хууль тунхаглах ажлаас өөр байсан, бас Бурханы нэр өөрчлөгдсөн, гэхдээ Эзэн Есүс, Ехова хоёр бол нэг л Бурхан шүү дээ. Эзэн Есүст итгэснээрээ тэд Ехова Бурханаас урваагүй, харин Хурганы мөрийг дагаж, Бурханаас аврал хүртэж байсан юм. Үнэндээ Ехова Бурханд итгэдэг ч Эзэн Есүсийг хүлээн аваагүй хүмүүс л Бурханыг орхиж, Бурханаас урвасан хүмүүс. Төгс Хүчит Бурханы ажил Эзэн Есүсийнхээс өөр, бас Бурханы нэр өөрчлөгдсөн ч гэлээ тэд нэг Бурхан мөн. Бурхан зүгээр л өөр өөр эрин үед өөр өөр ажил хийдэг. Нигүүлслийн эрин үед Эзэн Есүс золин авралын ажил хийснээр нүглийг маань л уучилсан. Хүн төрөлхтний нүгэлт уг чанарыг шийдвэрлээгүй. Тийм болохоор Эзэн шүүлтийн ажил хийхээр дахин ирнэ гэж амласан. Эцсийн өдрүүдэд Төгс Хүчит Бурхан ирээд сатанлаг зан чанар, нүгэлт уг чанарыг маань шийдвэрлэж, биднийг нүглээс бүрэн аварч, олж авахын тулд Эзэний золин авралын ажлын суурин дээр биднийг шүүх үнэнийг илэрхийлж байна. Төгс Хүчит Бурханы ажил, үг Эзэн Есүсийн зөгнөлийг бүрэн биелүүлдэг. Төгс Хүчит Бурханд итгэдэг минь Эзэн



---

Есүсээс урваж байгаа хэрэг биш. Харин Хурганы мөрийг дагаж байгаа хэрэг. Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн авалгүй Эзэн Есүст итгэснээр бид Ехова Бурханд л итгээд, Эзэн Есүсийг голсон фарисайчуудтай яг адилхан болох биш үү? Тийм хүмүүс л Эзэнийг эсэргүүцэж, Эзэнээс урвадаг шүү дээ! Та нар Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг зохих ёсоор судалж, Түүний үг Бурханы дуу хоолой мөн эсэхийг харах хэрэгтэй. Битгий дураараа шүүж ялла, тэгэхгүй бол Эзэнийг эсэргүүцсэнийхээ төлөө яллагдах байх шүү!” гэлээ.

Ли пастор үнэхээр тавгүйрхсэн харагдаж байсан болохоор Ван хамтран зүтгэгч байдлыг намжаахаар яаран, “Бид чуулганаа хамгаалж, сүргээ харж хандахын тулд л Зүүний Аянгыг эсэргүүцдэг, гишүүдээ үүнтэй орооцолдуулмааргүй байна. Ингэсний төлөө Эзэн биднийг яллаж яаж болох юм бэ? Ли пастор таны амийг хариуцдаг. Таныг буруу замаар яваасай гэж хүсэхгүй шүү дээ! Та хамтран зүтгэгч байж, чуулганы төлөө маш их юм хийсэн. Хүн болгон танд итгэж, таныг хүндэлдэг. Хэрвээ та Төгс Хүчит Бурханд итгэх гээд яваад өгвөл бүгд маш их гонсойно шүү!” гэлээ. Ли пастор яаран хошуу нэмэрлэж, “Ван хамтран зүтгэгчийн зөв өө. Та энэ олон жил маш шаргуу ажилласан. Олж авсан нэр хүндээ зүгээр л хаяад явчих үнэхээр харамсалтай шүү! Эргээд ир л дээ. Хүн болгон таныг хүлээж байгаа. Манай чуулган ахмадын асрамжийн газар байгуулсан, бас гадаадын шашны бүлгүүдтэй холбоо тогтоогоод, тэднээс санхүүгийн дэмжлэг авч байгаа. Хэрвээ таныг эргээд ирвэл шууд машин гаргаж өгье. Та ахмадын асрамжийн газрыг удирдана уу, чуулган удирдана уу, эсвэл үргэлжлүүлээд чуулганы санхүүг зохицуулна уу, өөрөө л мэд” гэлээ.

Тэднийг сонсох тусам нэг л биш байгааг нь улам бүр мэдэрсэн юм. Итгэгчид тийм юм хэлж яаж болдог юм бэ? Тэгээд Библид Эзэн Есүсийг диавол уруу татсан байдаг нь санаанд орлоо: “Диавол Түүнийг дахин асар өндөр ууланд аваачаад дэлхийн бүх хаанчлалыг болон алдар сууг нь үзүүллээ; Тэгээд тэр Түүнд, ‘Хэрвээ Чи газар унан, надад мөргөвөл би энэ бүхнийг чамд өгнө’ гэв” (Матай 4:8–9). Тэдний хэлж байсан бүх зүйл Сатаны хэлсэнтэй яг адилхан мэдрэмж, өнгө аястай байсан биш үү? “Энэ нь Сатаны заль мэх байна! Тэд намайг Төгс Хүчит Бурханаас урвуулахын тулд байр суурь, мөнгөөр урхидан үнэн замаас холдуулж байна. Тэд намайг урхидаж, сүйрүүлэх гэж байна!” гэж бодогдлоо. Би 10 гаруй жил итгэж, Эзэнийг эргэн ирэхэд нь угтан авах маш их аз завшаан тохиосон. Сатанд хууртаж, Эзэнээс урваж болохгүй гэдгээ мэдэж байсан юм. Тийм болохоор, “Би Бурханы дуу хоолойг сонсож, мөнх амийн замыг олсон. Би Бурханыг дагахаар сонгож байна. Та дэмий юм яриад яах вэ. Би Төгс Хүчит Бурханаас холдохгүй” гэж хэллээ.

---

Тэгтэл охин минь уйлж эхлэн, “Аав аа, та зүгээр л миний хэлэхийг сонс доо! Ээж саяхан өөд болсон. Бид хангалттай их зовлоо. Та Зүүний Аянгад итгэж, чуулганаас хөөгдчихөөр ах эгч нар биднээс ч бас нүүр буруулна шүү дээ!” гэсэн. Охиноо тэгж уйлахыг харах хэцүү байлаа. Миний дотор ширүүн тэмцэл өрнөлөө: “Би чуулганд эргээд орно гэж зөвшөөрвөл гологдохгүй, бас албан тушаалаа авч үлдэнэ, гэхдээ тэгвэл Эзэнд хаалгаа хаасан хэрэг болж, ноцтой урвалт болно шүү дээ!” Амар сонголт гэж байгаагүй. Энэ шаналал дунд би чимээгүйхэн Бурханд хандаж, “Өө Төгс Хүчит Бурхан минь, би дээшээ тэнгэр хол, доошоо газар хатуу гэгч боллоо. Үймээнд автахгүй байх итгэл, хүч хайрлаач, тэгвэл би бат зогсож, Таныг тууштай дагаж чадна” гэлээ. Яг тэгтэл хэд хоногийн өмнө уншсан Төгс Хүчит Бурханы зарим үг санаанд орлоо: **“Та нар цаг ямагт сэргэг байж, хүлээх ёстой бөгөөд Миний өмнө илүү их залбирах ёстой. Сатаны янз бүрийн явуулга, башир заль мэхийг олж харж, сүнсийг таньж мэдэн, хүмүүсийг мэдэж, бүх төрлийн хүмүүс, үйл явдал, юмсыг ялган таних чадвартай байх ёстой”** (“Үг нь махбодоор илэрсэн” ном). Бурханы үг надад хүч өгч, ялган таньж сурах хэрэгтэйг санууллаа. Тэр өдөр надад тохиолдсон зүйлийн ард Сатаны заль мэх байсан юм. Сатан намайг уруу татаж, дайрч давшлахын тулд байр суурь, гэр бүлийн холбоог минь ашиглан, Бурханаас урвуулах зорилгоор оюун санааг минь үймүүлж байсан. Би Сатаны урхинд орж болохгүй шүү дээ! Тэгээд хүүхдүүддээ, “Аав нь үүнийг судалсан, бүгд тодорхой байгаа. Төгс Хүчит Бурхан бол жинхэнэ Бурхан, Түүний үг, ажил бол үнэн зам мөн. Бид Эзэний ирэхийг ийм олон жил маш их хүсэн хүлээлээ. Одоо Эзэн ирээд, шүүлтийн ажлынхаа төлөө үнэнийг илэрхийлж байгаа болохоор бид гамшгаас мултарч, Бурханы хаанчлалд орохын тулд ажилтай нь хөл нийлүүлж, Бурханы шүүлт, цэвэрлэлтийг хүлээн авах хэрэгтэй. Бид бусдад гологдохоос биш, Эзэнээр таягдан хаягдаж, өргөгдөх боломжоо алдах вий гэдгээс айх ёстой. Тэгвэл бид их гамшигт уйлж, шүдээ хавирна шүү дээ! Та хоёр Төгс Хүчит Бурханы үгийг харах хэрэгтэй. Тэгвэл Бурханы дуу хоолойг сонсож, Төгс Хүчит Бурхан эцсийн өдрүүдийн Христ гэдгийг баталгаажуулж болно!” гэж хэллээ. Хүүхдүүд маань тэр асуудлаар шахалт үзүүлэхээ больж, би ч Бурханы удирдамжид чимээгүйхэн талархлаа.

Тэр хоёр буулт хийлгүй, унтууцаад л яваад өгсөн. Тэгээд хэд хоногийн дараа гэрлэх боломжоор уруу татах гэж эргэн ирлээ. Ли пастор надад, “Чи саяхан эхнэрээ алдлаа. Охин чинь гэрлэсэн, танай хүү дэргэд чинь нэг их байдаггүй. Гав ганцаараа байх үнэхээр хэцүү байгаа байлгүй. Энд тогоо барьдаг нэг хүн байвал танд үнэхээр хэрэгтэй шүү. Чуулганы Ван эгч бас ганц бие шүү дээ. Бэл бэнчинтэй, нэр хүндтэй, итгэлдээ ч урам зоригтой хүн. Та хоёр нэг гэрт орж, хоёр биеэ харж хандаж, хамтдаа Эзэнд үйлчилбэл сайхан хэрэг биш үү?” гэлээ. Тэр орой Ван эгч утасдаж, Зүүний Аянгад итгэхээ боль гэж шавдуулсаар

---

байсан юм. Бас хүүгийн чинь хуримд мөнгө дутагдаж байгаа бол шууд хэлээрэй гэлээ. Үүнийг сонсоод сэтгэл үнэхээр хоёрдсон. Эхнэр маань өвдөж, хэвтэрт ороод байх үед охин маань ээждээ эм авах гэж яваад авто осолд орж, эмнэлэгт хэвтсэн. Тэгэхэд Ван эгч эхнэр, охин хоёрыг минь хоёуланг нь асрахаар ирж, би эгчид үргэлж маш их талархаж ирсэн. Эгчийн зөвлөгөөг сонсохгүй бол сэтгэлийг нь шархлуулах биш үү? Гэхдээ харилцаагаа хамгаалахын тулд эгчийн үгээр явбал Эзэнээс урвасан болно. Би үнэхээр шаналж, Бурханд ахин дахин залбирлаа. Ингээд бага зэрэг тэмцэлдээд, дараа нь эгчийн саналаас маш эвтэйхэн татгалзсан юм.

Нэг өдөр намайг талбай дээр ажиллаж байтал Ли пастор ирж уулзлаа. Тэгээд, “Жан аа, та өөрийгөө биш юм гэхэд үр хүүхдээ бодооч. Танай хүү саяхан сүй тавьсан, сүйт бүсгүйн гэрийнхэн бүгд Эзэнд итгэдэг юм билээ. Хэрвээ тэд Төгс Хүчит Бурханд итгэдгийг тань олж мэдвэл охиноо танай бэр болгох уу? Энэ нь танай хүүгийн гэрлэлтэд гай болох биш үү? Та энэ талаар дахиад бодож үзэх хэрэгтэй дээ” гэсэн. Тэгэхээр нь би: “Намайг үнэн замаас хол байлгахын тулд хүүгийн минь хуримаар сүрдүүлж байгаа юм биз дээ? Жигшүүртэй юм!” гэж бодлоо. Тэгээд би маш тодорхойгоор: “Төгс Хүчит Бурханд итгэх нь миний асуудал. Хүүгийн маань хуримтай ямар ч хамаагүй. Тэгээд ч, хүүгийн маань хурим бүтэх эсэх нь Бурханы гарт байгаа. Төгс Хүчит Бурхан эргэн ирсэн Эзэн Есүс мөн гэдгийг би олж тогтоосон болохоор Түүнийг эцсээ хүртэл дагана. Хүүхдүүд маань ойлгохгүй байгаа ч ойлгох өдөр ирнэ” гэж хэлсэн. Эхэндээ би Ли пасторыг зүгээр л ярихаас цаашгүй гэж бодож байтал намайг Төгс Хүчит Бурханаас урвуулахын тулд үнэндээ тийм чухал юм ашигласан нь гайхмаар байлаа.

Хэд хоногийн дараа би хүүгийнхээ гагнуурын газарт очсон. Хүү маань хөмсөг зангидан, “Аав аа, сүйт бүсгүй маань Ли пасторыг гэрийнхэнтэй нь очиж уулзаад, таныг Зүүний Аянгад итгэдэг гэж хэлсэн гэсэн. Таныг итгэхээ болихгүй бол хурим хийхгүй гээд байна” гэлээ. Би балмагдаж, уур хүрсэн юм. Ли пастор намайг сүрдүүлэхийн тулд үнэхээр хүүгийн минь гэрлэлтийг ашиглаж байлаа. Эзэнд итгэгч яаж тийм жигшүүртэй юм хийж чаддаг байна аа? Хүүгээ бүр сэтгэлээр унасан байгааг хараад сэтгэл өвдлөө. Хуримынх нь өдөр болоход 18-хан хоног үлдээд байсан юм. Хурим нь үнэхээр тийм маягаар бүтэлгүйтэх юм гэж үү? Нүдэнд минь нулимс цийлгэнэлээ. Хүү минь цааш ярихдаа, “Аав аа, сүйт бүсгүй маань бас гэрлэхэд гурван болзол тавина гэсэн. Нэгдүгээрт, эцэг хүүгийн харилцаагаа таслах. Хоёрдугаарт, таныг хөгшрөх үед асрахгүй байх. Гуравдугаарт, гэр бүлийн бүх холбоогоо таслах. Ээж өөд болчихсон. Та гэр бүлийнхээ төлөө Зүүний Аянгад итгэхээ больчих л доо” гэлээ. Хүүгийнхээ үгийг сонсож, шаналсан царайг нь хараад зүрх минь хутгаар сүлбүүлэх шиг л болсон. Зүгээр л Төгс Хүчит Бурханд итгэдгээс минь болж энэ шашныхан надад дайсан мэт хандаж, хүүг минь надаас холбоогоо тасал гэж хүчилж

---

байлаа. Ой гутмаар юм аа! Би ч хүүдээ хэлсэн, “Хүү минь, чи одоо том болсон, надаар харж хандуулах шаардлагагүй. Би ч нас дээр гарлаа. Насныхаа бөгсөнд зүгээр л итгэлээ хэрэгжүүлж, Бурханыг дагамаар байна. Чамайг ойлгоно гэж найдъя” гэлээ. Тэгж хэлчхээд гэдрэг эргэн, гагнуурын газраас явсан юм. Гэртээ хариад Бурханы өмнө очин, “Төгс Хүчит Бурхан минь! Пастор надад төвөг удаж, намайг хүчлэхийн тулд байж болох бүх арга мэхийг ашиглаж, хүү минь надтай бүх холбоогоо таслах гэж байгаа. Одоо би маш сул дорой байна. Намайг замчилж, итгэл хайрлаач” гэж залбирлаа.

Маргааш нь Төгс Хүчит Бурханы Чуулганы Линь ахыг манайд ирэхээр нь би юу болоод байгааг хэлсэн юм. Ах надад Төгс Хүчит Бурханы үгийн нэг хэсгийг уншиж өгсөн. **“Хүмүүс дээр Бурханы хийдэг ажлын алхам бүрд, гаднаа энэ нь хүмүүсийн хоорондын харилцаа мэт, хүний зохицуулалт, хүний хөндлөнгийн оролцооноос үүдэлтэй мэт харагддаг. Гэвч нүднээс далдуур, ажлын алхам бүр, тохиолдож буй юм бүхэн нь Бурханы өмнө Сатаны тавьсан бооцоо бөгөөд Бурханд гэрчлэл хийхдээ бат зогсохыг хүмүүсээс шаарддаг. Жишээ нь, Иовыг шалгасан үеийг авч үзье: Нүднээс далдуур Сатан Бурхантай мөрий тавьж байсан бөгөөд Иовд тохиолдсон зүйл нь хүмүүсийн үйл хэрэг, хүмүүсийн хөндлөнгийн оролцоо байсан. Та нарт хийдэг Бурханы ажлын алхам бүрийн ард Сатаны Бурхантай тавьсан мөрий байдаг—энэ бүгдийн ард тэмцэл байдаг... Хүмүүс бүх зүйлийг хийхэд хүчин чармайлтдаа тодорхой хэмжээний төлөөс төлөх шаардлагатай болдог. Бодит зовлон бэрхшээлгүйгээр Бурханыг сэтгэл хангалуун болгож чадахгүй; Бурханыг сэтгэл хангалуун болгоход дөхөж очих ч үгүй, хоосон уриа лоозон урсгахаас цаашгүй!”** (“Үг нь махбодоор илэрсэн” ном). Шашныхан бидэнд саад хийж, төвөг удаж, албадахад хүмүүс хийж байгаа юм шиг харагдаж болох ч үнэндээ Сатан биднийг үймүүлэхээр оролдож байгаа хэрэг гэдгийг Бурханы эдгээр үгэн дэх сүнслэг тулааны талаар ахыг ярих үед би ойлгосон юм. Бурхан хаана ажиллаж байна, Сатан тэнд саад хийж байдаг. Хүн төрөлхтнийг аврах Бурханы ажлыг Сатан үзэн яддаг болохоор Бурханыг дагахад нь хүмүүст саад хийж, хүмүүсийг там руу авч явахын тулд элдэв янзын арга заль, ов мэх гаргадаг. Ли пастор бусадтайгаа хамтраад намайг үнэн замаас хол байлгахаар оролдож, ахин дахин төвөг удаж, автомашин өгнө, чуулганы санхүүг юм уу ахмадын асрамжийн газрыг удирдуулна гэгцээсэн. Тэгээд бас эхнэр олж өгье гэж санал болгоод, аль нь ч бүтээгүй болохоор намайг сүрдүүлэхдээ хүүгийн маань хуримыг ашигласан. Тэд шагнал, шийтгэлийн аль алийг туршиж үзсэн. Үнэхээр өөдгүй, хорлонтой байсан юм.

Линь ах надад цааш нь ингэж нөхөрлөлөө: “Эзэн Есүсийг гарч ирж, ажиллах үед Иудейн шашны удирдагчид үнэнийг үзэн ядаж, Бурханыг үзэн ядсан. Эзэн Есүсийн зам эрх мэдэлтэйг тэд сайн мэдэж байсан ч үүнийг судлахаас татгалзаад зогсохгүй, Эзэнийг

---

улайран эсэргүүцэж, яллаж, доромжилсон. Эзэнийг дагахад нь хүмүүст саад болохын тулд чадах бүхнээ хийж, Эзэнийг цовдлоход оролцоод, хүмүүс Эзэн Есүсийг дагах юм бол байр суурь, амин зуулгаа алдана гэж айсандаа тэд ийм юм хийсэн юм. Яг Библид бичсэн байдгаар, ‘Тэгээд ахлах тахилчид болон фарисайчууд зөвлөлд цуглаж, “Бид юу хийх вэ? Учир нь энэ хүн олон гайхамшиг үйлдэж байна. Хэрвээ бид Түүнийг ингээд орхивол бүх хүн Түүнд итгэнэ: тэгвэл ромчууд ирээд, манай газар нутаг, үндэстнийг хоёуланг нь булаан авна...” гэв. Тэр өдрөөс хойш тэд Есүсийг алахаар зөвлөлдөв’ (Иохан 11:47–48, 53). Бурхан хүн төрөлхтнийг цэвэрлэж, аврах шүүлтийн ажил хийхийн тулд эцсийн өдрүүдэд ирсэн. Төгс Хүчит Бурханы үг үнэн гэдгийг шашны пастор, ахлагч нар мэддэг ч эрж хайж, судалдаггүй. Тэр ч бүү хэл Түүнийг улайран эсэргүүцэж, яллаж, Түүнийг дагахыг бусдад хорьдог. Тэдний мөн чанар Эзэн Есүсийг эсэргүүцсэн фарисайчуудынхаас юугаараа ялгаатай юм бэ? Тэр хоёр нүүртнүүдийг Эзэн Есүс аль эрт яллаж, хараасан. Эзэн Есүс: **‘Хоёр нүүрт хуулийн багш нар, фарисайчууд та нар золгүй еэ! Яагаад гэвэл та нар хүмүүсээс тэнгэрийн хаанчлалыг хааж, өөрсдөө орохгүй бөгөөд орж буй хүмүүсийг ч оруулахгүй’** гэж хэлэв (Матай 23:13). **‘Хоёр нүүрт хуулийн багш нар, фарисайчууд та нар золгүй еэ! Та нар тэнгис далай болон газар нутгийг тойрч, ганц хүнийг сүсэгтнээ болгохын тулд уруу татдаг. Түүнийг сүсэгтэн болоход та нар түүнийг өөрсдөөсөө хоёр дахин дор тамын хүү болгодог’** (Матай 23:15). Шашны удирдагчид Бурханыг эсэргүүцдэгийн мөн чанар, уг шалтгааныг Төгс Хүчит Бурханы үг бас илчилдэг” гэсэн юм. Төгс Хүчит Бурхан ингэж хэлсэн байдаг: **“Том сүмд Библи уншиж, үүнийг бүхэл өдөржингөө цээжээр уншдаг хүмүүс байдаг атал тэдний дундаас нэг нь ч Бурханы ажлын зорилгыг ойлгодоггүй. Тэдний дундаас нэг нь ч Бурханыг мэдэж чаддаггүй; тэдний дундаас бүр нэг ч хүн Бурханы хүсэлд нийцэж чаддаггүй. Тэд бүгдээрээ үнэ цэнгүй, өөдгүй хүмүүс бөгөөд Бурханд зааж сургахын тулд дор бүрнээ өндөрт зогсдог. Тэд Бурханы нэрээр далайлгадаг атлаа Түүнийг дур зоргоороо эсэргүүцдэг. Бурханд итгэдэг гэх атлаа тэд хүний махыг идэж, цусыг уусаар байдаг. Ийм хүмүүс бүгд хүний сүнсийг залгидаг диаволууд, зөв замд орохоор хичээж буй хүмүүст зориуд саад учруулдаг толгойлогч чөтгөрүүд, мөн Бурханыг эрж хайдаг хүмүүст садаа болдог бул хар чулуу билээ. Тэд ‘эрүүл чийрэг бие махбодтой’ харагдаж болох ч Бурханыг эсэргүүцэхэд хүмүүсийг хөтөлдөг антихристүүдээс цаашгүй гэдгийг дагагчид нь яаж мэдэх юм бэ? Хүний сүнсийг залгидаг амьд диаволууд гэдгийг дагагчид нь яаж мэдэх юм бэ?”** (“Үг нь махбодоор илэрсэн” ном). Бурханы үгийг уншаад би, үнэнийг үзэн ядаж, Бурханыг эсэргүүцдэг шашны удирдагчдын чөтгөрлөг уг чанарыг илүү сайн ойлгосон. Тэд Бурханы хоньдыг үүрд эрхэндээ байлгахыг хүсдэг болохоор Төгс Хүчит Бурханыг улайран эсэргүүцэж, яллаж, Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг гэрчилдэг ах эгч нарыг хяхаж хавчдаг. Тэд Бурханы хоньдыг өөрсдийнх

---

болгож, чанд хянахыг хүсдэг. Тэд өөрсдөө Бурханы хаанчлалд орж чаддаггүй, тэгээд итгэгчдийг ч бас тийш ороход саад хийдэг. Тэд тамд унахдаа бусдыг араасаа чирч байгаа. Тэд үнэхээр сүрэг чөтгөрүүд! Хэрвээ замд минь саад болох гэсэн шашныхны хүчин зүтгэлийг биеэр туулаагүй бол, хэрвээ бие махбодтой болсон Бурхан эцсийн өдрүүдэд гарч ирж, ажиллаж, чуулганд нуугдаж байгаа эдгээр муу зарц, антихристийг ил болгоогүй бол Бурханыг эсэргүүцдэг тэдний чөтгөрлөг мөн чанарыг би хэзээ ч олж харахгүй байх байлаа. Тэгээд тэд намайг огт мэдээгүй байхад төөрөлдүүлж, сүйрүүлэх байж. Тэдний хоёр нүүртэй, үзэшгүй муухай царайг хараад, Төгс Хүчит Бурханыг дагах итгэл минь улам батажсан.

Би хуучин чуулганыхаа ах эгч нарт сайн мэдээ түгээсээр байсан юм. Нэг өглөө биднийг цуглаан хийж байтал Ли пастор бүлгийнхэнтэйгээ хамт манайд хүрч ирээд, “Зүүний Аянгыг орхи гэж танд ахин дахин хэллээ. Гэтэл та үгэнд орохгүй байгаад зогсохгүй, миний хоньдыг хулгайлж, тэдэнд Зүүний Аянгыг номлож байна. Та үнэхээр надтай үзэлцмээр байна гэж үү?” гэлээ. Би хариуд нь: “Ли пастор оо, тэгж хэлж болохгүй шүү дээ. Чуулган Бурханых, хонин сүрэг ч Бурханых. Та бол зүгээр л пастор. Хоньдыг таных гэж хэлж яаж болдог юм бэ? Ах эгч нар Бурханы дуу хоолойг сонсож, Бурханы сэнтийн өмнө эргэн ирээсэй гэсэндээ би тэдэнд сайн мэдээ түгээж байна. Ингэх нь зөв, зүйтэй хэрэг. Та яагаад замд хөндөлсөөд байгаа юм бэ? Хүн болгон сул дорой, сөрөг байна. Сүнс нь хатаж, харанхуйд байна, ямар ч амийн хангалт авахгүй байна. Төгс Хүчит Бурхан үг айлдаж, бидэнд мөнх амийн замыг өгсөн. Үүнийг та яагаад хүмүүст уншуулахгүй гээд байгаа юм бэ? Үнэн замыг судлах хүмүүсийн эрх, эрх чөлөөг яагаад боогдуулж байгаа юм бэ? Үүнд нь саад хийснээрээ та хүмүүсийг цангааж алаад, шашинд гацааж байгаа биш үү? Энэ нь сайн зарц байгаа хэрэг үү, муу зарц байгаа хэрэг үү?” гэсэн. Ли пасторын царай дорхноо хувьсхийж, “Та засал авахаасаа өнгөрсөн байна. Итгэлдээ биднийг дагахгүй юм бол та тамд шийтгүүлнэ дээ, харж л байгаарай!” гэж уурсан хашхирлаа. Тэгэхээр нь би, “Тамд унах эсэхийг минь та шийддэг юм биш. Та Эзэний дуу хоолойг таньж, Түүнийг угтан авахаа ч мэдэхгүй байж Бурханы хаанчлал руу бусдыг залж чиглүүлж яаж чадах юм бэ? Эцсийн өдрүүдийн Христ л тэнгэрийн хаанчлалд орох үүд хаалга мөн. Би Христээр дамжуулан мөнх амийн замыг олсон. Миний амийг та биш, Бурхан хариуцдаг” гэсэн. Намайг тэгж хэлсний дараа тэд цөхрөөд яваад өглөө. Тэгээд дахиж над дээр хэн ч ирж, төвөг удаагүй.

Энэ сүнслэг тулааныг туулсныхаа дараа би Сатаны заль мэхийг бага зэрэг ялган таних чадвартай болсон. Бас шашны пастор, ахлагч нар зүгээр л хоёр нүүрт фарисайчууд, Христийг үгүйсгэж, эсэргүүцдэг антихристүүд гэдгийг олж харсан. Тэгээд тэдний хязгаарлалтаас бүрэн чөлөөлөгдсөн юм. Сатаныг ялж, үнэн замд бат зогсох алхам бүрд

---

минь Төгс Хүчит Бурханы үг намайг хөтөлсөн. Бурханд үнэхээр талархъя! Туулсан бүхнээ эргээд бодохоор бүгд нэг том сорилт байж. Би үхэл, сэхлийн ирмэгт дэнжгэнэж байсан юм. Бурханы үгийн удирдамжгүйгээр би Сатаны явуулгыг хэзээ ч нэвт харж чадахгүй байх байлаа. Хэрвээ би махан биеийг дагаж, Сатанд буулт хийж, үнэн замаас гарсан бол Бурханаас урвасан ноцтой урвалт болж, Бурханы зан чанарт халдаж, аврагдах боломжоо бүрэн алдах байлаа. Би үнэхээр аюулын ирмэгт байсан шүү! Бурханы хамгаалалт, авралд би маш их талархдаг!

## **24. Тэнгэрийн хаанчлалд хүрэх замд хэн саад болдог вэ**

Мэн'ай, Малайз

Нөхөр минь нас барсан жил би гүнээ цөхөрч, дээр нь үр хүүхдүүдээ өсгөх давхар ачаатай болсон билээ. Амьдралд минь гэнэт хүндрэл бэрхшээл тулгарсан боловч Эзэний хайр надтай байнга хамт байсан бөгөөд ах эгч нарынхаа туслалцаатайгаар энэ бэрх цаг үеийг туулсан юм. Эзэний хайрыг хариулахын тулд би чуулганд хандив өргөж, үйлчилсэн хэвээр байсан бөгөөд 30 гаруй жилийн турш ингэж ирсэн билээ. Энэ хугацаанд би чуулганы хөгжил цэцэглэлтийг туулж, Эзэн Есүсийн сайн мэдээ түгсэн суу алдарт үеийг харсан юм. Бас би чуулганы хоосрол, арга мөхөс байдлыг ч нүдээр үзсэн. Ариун Сүнс чуулганд агуу ажлыг хийж эхлэн, бид пасторын номлолыг сонсоод баясаж, их зүйл олж авдаг байсан үеийг би эргэн саналаа. Ах эгч нарын дунд яг л бүгд нэгэн гэр бүл мэт бие биеэ гэсэн хайр байсан бөгөөд хүн бүр сайн мэдээ түгээж, Эзэнд гэрчлэл хийхдээ гар нийлдэг байв. Дараа нь юу болсныг бүү мэд, пасторын номлосон зүйлд ямар ч гэрэл байхаа болилоо. Бүх зүйл ахин дахин давтагддаг улиг болсон түүх шиг болж, итгэгчид өөрсдийгөө тэжээх юу ч олж авч чадахгүй байв. Тэдний итгэл, хайр аажмаар буурч, цуглаанд ирдэг хүн улам бүр цөөрөв. Үйлчлэлд оролцдог бид ч бас ердөө л ёс төдий хийж байв. Бид бүгд ердөөсөө Бурханд үйлчилж бус, харин үйлчлэл дэх хүмүүсийн хүслийн дагуу үйлдэж, харин ч бусад хүмүүсийн өмнө хүчин зүтгэл гарган, тэдний хүндлэл бишрэлийг олж авахаар хичээж байлаа. Энэ төрлийн үйлчлэл нь Бурханы хүсэлтэй нийцэхгүй гэдгийг би мэддэг байсан тул энэ нь надад их зовлонтой байв. Би мөн аргаа барж, урдах замдаа хэрхэн алхахаа огт мэдэхгүй байлаа. Энэ бүх асуудлыг шийдэхийн тулд Эзэн аль болох түргэн ирээсэй гэж би улам бүр найдаж байсан юм.

Би яг учраа олохгүй болоод байх үедээ 2016 онд эцсийн өдрүүд дэх Төгс Хүчит Бурханы ажлыг судалж, Бурханы үгийг ихээхэн уншив. Төгс Хүчит Бурханы Чуулганы ах эгч нарын нөхөрлөж, гэрчлэл хийсэн зүйлийг сонсож, Эзэн Есүс аль хэдийн бие

---

махбодтойгоор эргэн ирсэн гэдгийг эцэст нь ойлголоо. Тэрээр хүн төрөлхтнийг бүрэн ариусгах, аврах, хүн төрөлхтнийг тэнгэрлэг хаанчлалд аваачихын тулд аль хэдийн үг илэрхийлж, эцсийн өдрүүдийн шүүлтийн ажлыг Бурханы гэрээс эхлэн хийсэн гэдгийг олж мэдэв. Төгс Хүчит Бурханы үг маш олон жилийн турш миний бодож явсан Эзэний эргэн ирэлтийн нууцыг тодорхой ойлгууллаа. Эзэний эргэн ирэлт нь нууцаар гарч ирэх болон ил тодоор эргэн ирэх гэсэн хоёр хэлбэрт хуваагддаг болохыг би ойлгов. Эзэн эхлээд үгээ илэрхийлж, хүнийг шүүж, цэвэрлэх, гамшгийн өмнө бүлэг ялагчдыг бий болгохын тулд нууцаар гарч ирэхдээ хүний Хүүгийн дүрээр бие махбодтой болсон. Агуу гамшиг бууж ирэх үед Тэрээр сайныг шагнаж, мууг шийтгэн, бүх улс орон, хүн ардад илрэн, ил тодоор гарч ирэх болно. Тэр үед нууцаар гарч ирсэн бие махбодтой Бурханы ажил аль хэдийн дууссан байх бөгөөд эцсийн өдрүүд дэх Бурханы ажлыг эсэргүүцэж, ялладаг бүх хүн уйлж, шүдээ хавиран гамшигтай нүүр тулна. Ах эгч нар бас надад хүн төрөлхтнийг аврах Бурханы ажлын гурван үе шат, Бурхан бие махбодтой болохын ач холбогдол болон Бурхан эцсийн өдрүүдэд шүүлтийн ажлыг хэрхэн хийх тухай нөхөрлөлөө. Өмнө нь чуулганд үйлчилж байх үед бидэнд яагаад Бурханы удирдамж байгаагүйг, мөн яагаад судрыг уншиж, залбирч, судлах зам урд маань байгаагүйг би тэр үед ойлгов. Ариун Сүнс байгааг бид яагаад мэдрээгүйг би ойлголоо. Бурхан аль хэдийн шинэ ажил хийж, Нигүүлслийн эрин үеийг төгсгөн, Хаанчлалын эрин үеийг авчирсан байв. Ариун Сүнс Нигүүлслийн эрин үеийн чуулганууд дотор ажиллахаа больсон учраас хүмүүсийн сүнс хатаж, харанхуйлж, баяр хөөр, сэтгэл ханамжгүй болж, сүнслэг амьдралдаа ямар ч тэжээл олж авч чадахгүй байсан юм. Бурханы удирдамж, зааврын ачаар л би Төгс Хүчит Бурханы үгээс Бурханы дуу хоолойг таньж чадсан билээ. Би эцсийн өдрүүд дэх Бурханы ажлыг баяртайгаар хүлээн зөвшөөрөв. Дараа нь ах эгч нар надтай Төгс Хүчит Бурханы үгийг интернетээр ойр ойрхон хуваалцах боллоо. Төгс Хүчит Бурханы Чуулганы хийсэн кино, найрал дуут бүжгийн бичлэгүүд болон дууны клипүүдийг үзсэн нь надад их тэжээл болсон бөгөөд намайг сэнтийнхээ өмнө аваачсаных нь төлөө би Бурханд чин сэтгэлээсээ талархаж байв. Бурханы үгээр хариулуулж, тэжээгдэхдээ би баясаж, Бурхантай нүүр нүүрээ харан амьдрах жаргалтай амьдралд орсон юм.

Нэгэн өдөр чуулганы нэг пасторын эхнэр надад гэнэтхэн ингэж бичсэн зурвас илгээв, “Чи яагаад Зүүний Аяндын нийтлэл дээр таалагдлаа гэж дарсан юм бэ? Бас үүнийг цагийн хүрдэн дээрээ нийтэлсэн чинь Эзэний хүслийн эсрэг байна. Мөргөлчид Зүүний Аяндын тухай нийтлэлийг харж, Төгс Хүчит Бурханы үгийг сонирхдог болбол бүгдээрээ Зүүний Аяндын тухай уншиж судлахаар явна шүү дээ. Бид яах ёстой юм бэ? Чи дахиж Зүүний Аяндын хүмүүстэй холбоо барьж болохгүй. Тэдний холбоо барих мэдээллийг даруйхан устгах хэрэгтэй...” Би ингэж хариуллаа: “Төгс Хүчит Бурханы Чуулганы сайн мэдээний



---

кино, магтан дуу болон дууны клипүүд бүгд нэлээд сайн юм байна, би тэдгээрээс ихийг олж авсан. Интернетээр би тэдгээрт таалагдлаа гэж дарах эрхтэй байх аа!” Пасторын эхнэрт би дахиад зурвас илгээмээр байсан боловч дараагийн зурвасаа дуусгахаас минь ч өмнө тэр Төгс Хүчит Бурхан руу дайрч давшлан, буруутгаж, Төгс Хүчит Бурханы Чуулганыг гүжирдсэн олон зүйл хэллээ. Тэрээр Эзэний эргэн ирэлтийн тухай энэ агуу асуудлыг судлах ямар ч зүрх сэтгэлгүй, ердөө л өөрийнхөө тохиромжтой гэж бодсон бүх шүүмжлэл, буруушаалыг хэлж байгааг би харав. Би түүнтэй өөр ямар ч зүйл яриааргүй байсан учир сэдвийг өөрчиллөө.

Энэ явдал тохиолдсоноос хэд хоногийн дараа Ян пастор надтай ярилцахаар сураглаж ирэв. Жаахан дэл сул ярианы дараа Ян пастор надаас: “Та интернэтээр шашны бусад бүлгийг судалж үзсэн үү?” гэж асуулаа. Ян пастор надаас яагаад ийм асуулт асуусныг би мэдээгүй бөгөөд “Фэйсбүүкийн маань найзууд олон өөр урсгалд харьяалагддаг, тэдний нийтэлдэг нийтлэлүүд зөв зүйтэй, сайн санагдвал би тэдгээрийг ойлгож, шинэ гэрэл байгаа эсэхийг нь харахаар оролддог. Ингэх нь буруу гэж та хэлээд байна уу?” гэж хариулав. Ян пастор надаас дахин ингэж асуув: “Та хоёр жилийн өмнө Зүүний Аянга руу шилжсэн үү? Яагаад та Зүүний Аянгыг судлах гээд байгаа юм бэ? Бас та ойр ойрхон нөгөө хэнийг (эцсийн өдрүүд дэх Бурханы ажлыг хүлээн зөвшөөрсөн бөгөөд зураг нь нийтлэгдэж, хуучин чуулганахаа пасторт буруутгагдан, хаягдсан эгч) хайж явсан уу?...” Ян пастороос дараалсан олон асуулт сонсоод миний дургүй хүрч, ингэж хэлэв: “Төгс Хүчит Бурханы Чуулган бол сайн, дотор нь үнэн ба Ариун Сүнсний ажил байдаг юм. Би хаана үнэн ба Ариун Сүнсний ажил байна, түүнийг дагана, энэ бол миний хийх ёстой зүйл. Манай чуулганд ямар ч шинэ гэрэл алга, сүнс минь харанхуйлж, тэндээс ямар ч тэжээл олж чадахгүй байна. Би Ариун Сүнсний ажилтай чуулганыг олж, тэндээсээ үнэний тэжээлийг хүлээж авмаар байна. Зүүний Аянгын сургаал надад таалагддаг, бас Төгс Хүчит Бурханы үг бүгдээрээ үнэн. Эдгээр нь надад тэжээл олж авах боломж олгодог. Зүүний Аянгыг судалсан минь буруу байгаагүй, судлах нь миний эрх.” Ян пастор: “Зүүний Аянгын хүмүүсийн номлодог зүйл Библиэс хальдаг. Библиэс өөр Бурханы үг гэж үгүй. Тэдний номлодог зүйл Библиэс гаждаг бол буруу гэсэн үг” гэж хэлэв. Би ингэж хэллээ: “Нэг удаа би нэг номлогч ингэж хэлэхийг сонссон, би ч өөрөө ингэж боддог байсан. Гэхдээ Төгс Хүчит Бурханы үгийг уншиж, Төгс Хүчит Бурханы Чуулганы ах эгч нарын нөхөрлөсөн зүйлийг сонсоод би эдгээр нь ердөө өөрсдийн маань үзэл, төсөөлөл гэдгийг мэддэг болсон. Эдгээр нь үнэнтэй огт нийцдэггүй бөгөөд бодит байдалтай таардаггүй. Бурхан бол бүхнийг хамардаг бөгөөд мэргэн ухаанаар баян. Бурханы үг болон ажлыг бид ердөө Библиэр хязгаарлаж яаж болох вэ? Библид ингэж хэлдэг: ‘Түүнчлэн Есүсийн хийсэн өөр олон зүйл байгаа ба хэрэв тэд тэр бүгдийг бичсэн бол тэдний бичсэн номуудыг ертөнц

---

хүртэл өөрөө багтааж чадахгүй байх байсан гэж би боддог’ (Иохан 21:25). Библид тэмдэглэгдсэн Бурханы үг болон ажил цар хүрээгээрээ хэтэрхий хязгаарлагдмал гэдгийг бид эндээс харж болно. Эргэн ирсэн Эзэний хэлсэн үг байтугай Эзэн Есүсийн тухайн үед хэлсэн бүхэн Библид бичигдээгүй байдаг. Үүний зэрэгцээ Төгс Хүчит Бурханы ажил нь Эзэн Есүсийн тавьсан суурин дээр босдог. Төгс Хүчит Бурханы ажил болон Эзэн Есүсийн ажил нь нэг Бурханы ажил юм...” Ян пастор миний хэлсэн ганц ч үгийг сонсоогүй бөгөөд эрж хайх, судлах ямар ч сонирхолгүй байлаа. Тэр ердөө л Төгс Хүчит Бурхан болон Төгс Хүчит Бурханы Чуулганыг эсэргүүцэж, буруутгасан зүйл үргэлжлүүлэн хэлж, “Та яаж Төгс Хүчит Бурханы Чуулганы вэб хуудасны талаар мэдэж авсан юм бэ? Танд тэдний номууд байгаа юу? Та Төгс Хүчит Бурханы ажлыг өөр хүнд номлосон уу? Хүүхдүүдээ номлосон уу? Төгс Хүчит Бурханы Чуулган дахь хүмүүсийн нэрийг надад өгөөдөх...” гэж асуув. Тэрээр Төгс Хүчит Бурханы Чуулганы хүмүүстэй хамт цуглаанд дахиж хэзээ ч оролцохгүй байхыг надаас шаардлаа. Хэрвээ би түүний үгийг сонсолгүй, Төгс Хүчит Бурханы Чуулганы хүмүүстэй холбоо барьсан хэвээр байвал чуулганаас хөөх байв. Тэр намайг дахиж ямар ч чуулганд явуулалгүй, нэр төрийг минь бүрмөсөн гутаах байв. Өмнө минь байсан Ян пасторыг хараад би цочирдлоо. Үргэлж зан сайтай, даруу төлөв байж, аядуу зөөлөн үгээр ярьдаг байсан Ян пастор яаж ийм зэрлэг, үндэслэлгүй хүн болж хувирав аа? Би Ян пасторт ингэж хэлэв: “Үнэнийг судлах нь миний эрх. Үүнд саад хийх эрх хэнд ч байхгүй. Зүүний Аянгын сургаал нь үнэн зам мөн эсэх тухайд бол юун түрүүнд та сохроор шүүмжилж, буруутгахгүй байх ёстой. Төгс Хүчит Бурханы Чуулган веб хуудсыг та өөрөө судалж болно, тэнд ихээхэн контент бий. Бурханы үгийн тухай бүх төрлийн ном байгаа. Төгс Хүчит Бурханы үг нь эргэн ирсэн Эзэн Есүсийн дуу хоолой мөн эсэхийг өөрөө очоод хар...” Ян пастор миний хэлсэн зүйлийг огт сонсолгүй, ердөө л үргэлжлүүлэн эсэргүүцэж, буруутгасаар байв. Намайг сүрдүүлж, Төгс Хүчит Бурханы Чуулганыг орхих ёстой гэлээ. Ян пастор ярих тусмаа хэрээс хэтэрч байв. Би ихэд дургүй хүрч, түүнд ингэж хэллээ: “Эзэн Есүс: **‘Өөрсдөө шүүгдэхгүйн тулд бүү шүү. Та нар өөрсдийн шүүсэн шүүлтээр шүүгдэх болно: өөрсдийнхөө хэмжсэн хэмжүүрээр хэмжигдэнэ’** (Матай 7:1–2) гэж хэлсэн. Та Төгс Хүчит Бурханы үг, ажлыг хэзээ ч судлаагүй юм бол хүссэн шүүмжлэл, буруутгалаа хэлж яаж болох юм бэ? Ингэж авирладаг чинь Бурханыг хүндэлж байгаа хэрэг үү?” Ян пастор, үгийг нь сонсолгүй, няцаасныг минь хараад өөр юм хэлсэнгүй.

Дараагийн хэд хоногт Ян пастор намайг ажиглаж эхлэв. Үүнээс болж би ихэд санаа зовон, итгэх эрх чөлөөгөө ч бас алдлаа. Чуулганд Ян пасторын ажлын өрөөг минийхээс заагладаг ганцхан коридор байв. Пастор миний юу хийж байгааг харахаар байн байн өрөөнд минь орж ирж, заримдаа бие засах өрөө рүү явж байна гэж хэлээд, коридороос

---

намайг ажигладаг байлаа. Нэг өдөр Төгс Хүчит Бурханы Чуулганы хоёр эгч надтай ярилцахаар өрөөнд минь ирэв. Эгч нарыг явмагц Ян пастор туслахыг минь олохоор явлаа. Тэр хоёр хүн хэн байсан, яагаад ирсэн бэ гэдгийг Ян пастор асуусан гэж туслах маань дараа нь надад хэлсэн юм... Ян пастор гэмт хэрэгтнийг хараандаа байлгаж байгаа мэт өдөржин намайг ажигладаг байв. Ингэх нь надад их дарамт болж, зүрх сэтгэлд минь ямар ч чөлөө өгсөнгүй. Нэг өдөр би чуулган руу явалгүй зарим ах эгчтэй интернэтээр цуглаанд оролцож байв. Зочны өрөөндөө цуглааны тэмдэглэлийг хичээнгүйлэн бичиж авч байх үед минь Ян пастор гэнэт миний ард зогсоод (хаалга ялимгүй онгорхой байсан бөгөөд ирсэн хэн боловч өрөөнд орж ирэх боломжтой байсан юм): “Та юу хийж байгаа юм бэ? Юу бичиж байгаа юм бэ?” гэлээ. Гэнэт араас хүн дуугарахаар би айсандаа цочив. Түүний ийм маягаар намайг үймүүлсэн нь эвгүй санагдсан бөгөөд юу ч хийлээ гэсэн би буцаад тайвширч чадсангүй. Түүнд би асар их зэвүүцэж, “Бурханд итгэхдээ үнэн замыг судална гэдэг зөв зүйтэй бөгөөд Христэд итгэгчийн эдлэх ёстой эрх” гэж бодлоо. Ариун Сүнс манай чуулган дотор ажиллахаа больсон бөгөөд мөргөлчид бүгд сөрөг, сул дорой болж, сүнс нь хатсан байлаа. Тэд харанхуйд живсэн нөхцөлд амьдарч байсан бөгөөд би Ариун Сүнсний ажиллаж байгаа чуулганыг хайж байсан юм. Бурханы мөрийг хайх нь яахаараа буруу гэж? Яагаад тэр намайг цагдахыг хүснэ вэ? Яагаад тэр намайг зүгээр байлгахгүй байна вэ?

Пастор намайг ажиглаж, үймүүлээд зогсохгүй нэг ахлагч бүр над руу утсаар ярьж зовоов. Тэрээр надад ингэж хэлсэн юм: “Төгс Хүчит Бурханы Чуулганы хүмүүсийн номлодог зүйл нь Библиэс хэтэрдэг. Хэрэв чи Эзэнд итгэдэг юм бол чамд ийм их сайхан сэтгэл гаргасан Эзэнээс урваж болохгүй. Чи мөс чанаргүй байж болохгүй...” Би бухимдсандаа, “Төгс Хүчит Бурхан болон Эзэн Есүс бол адилхан нэг Бурхан, би Төгс Хүчит Бурханд итгэснээрээ Эзэн Есүсээс яавч урваагүй. Би ердөө л Хурганы мөртэй хөл нийлүүлж байгаа төдий...” гэв. Гэхдээ намайг яаж ч тайлбарлалаа гэсэн ахлагч яг пастортой адил байлаа. Тэрээр буруутгал, доромжлол хэлж, эцсийн өдрүүд дэх Төгс Хүчит Бурханы ажлыг хүлээн зөвшөөрөхөд минь саад хийхээс өөрөөр бол миний нөхөрлөж, зөвлөсөн зүйлээс ганц ч үг сонссонгүй. Би түүнтэй цааш ярилцахыг хүсээгүй учраас нэг шалтаг хэлээд утсаа таслав. Гэвч ахлагч намайг зүгээр орхисонгүй. Тэрээр намайг зовоох гэж байнга залгасаар байсан бөгөөд намайг Төгс Хүчит Бурханд итгэснээрээ Эзэний нигүүлслийг мартаж, Түүнээс урвасан гэж хэллээ. Илчлэлд: **“Тэд бол Хургыг хаашаа ч явсан дагадаг хүмүүс юм”** (Илчлэл 14:4) гэж хэлсэн байдгийг би санав. Эзэн Есүсийн золин авралын ажлын суурин дээр Төгс Хүчит Бурхан хүмүүсийг үгээр дамжуулан шүүж, ариусгах ажлын өөр нэгэн үе шатыг хэрэгжүүлж буй бөгөөд эцсийн өдрүүд дэх Төгс Хүчит Бурханы ажлыг хүлээн зөвшөөрсөн маань Хурганы мөртэй хөл нийлүүлэн явж

---

байгааг минь тодорхой харуулсан юм. Намайг Эзэн Есүсээс урвалаа гэж хүмүүс яаж хэлж чадаж байна аа? Эхэндээ Эзэн Есүсийг ажил хийх гэж ирэхэд Ехова Бурханд итгэдэг байсан хүмүүс хуулиас гарч ирж, Эзэн Есүсийн номлосон тэнгэрийн хаанчлалын сайн мэдээг хүлээн зөвшөөрсөн юм. Тэд Эзэн Есүсийг дагасан боловч Ехова Бурханы авралыг мартсан уу? Энэ нь Ехова Бурханаас урвасан хэрэг байсан уу? Энэ буруу ойлголт биш гэж үү? Ийм явдал болсны дараа пастор надад интернетээр Төгс Хүчит Бурханыг доромжилж, эсэргүүцэж, буруутгасан зарим нэг зурвас дахиад илгээв. Ийм муухай үг уншаад би дахин ой гутаж, уур хилэнд автав. Сатан л ийм доромжлол хэлэх чадвартай байдаг. Чуулганы удирдагчдын хувиар тэд яахаараа Бурханаас огт эмээлгүй, бүх төрлийн доромжлол хэлж зүрхэлдэг билээ? Энэ нь надад Эзэн Есүсийн: **“Тэвч Ариун Сүнсний эсрэг үг хэлдэг хэн боловч энэ насандаа ч, мөн хойд насандаа ч уучлагдахгүй”** (Матай 12:32) гэх үгийг санагдуулав. Бурханыг доромжилно гэдэг бол томоохон, аймшигт нүгэл! Тэдний өмнөөс сэтгэлд минь айдас хурсан боловч намайг юу ч гэж хэллээ гэсэн тэд чихээ бөглөөд, сонсохоос татгалзсаар байв. Тэд зүгээр л буруутгаж, эсэргүүцэж, доромжилсоор байлаа. Ахлагч, пастор хоёр хоёулаа Библийн тухай мэдлэгтэй, бас теологи судалсан байж Төгс Хүчит Бурхан үгээ тэгтэл нь тодорхой хэлээд байхад яагаад Түүний үгийг эрж хайж, судлахгүй байна вэ? Яагаад тэд заавал Төгс Хүчит Бурханыг яллаж, эсэргүүцэхээр гэжүүдэлсээр байна вэ? гэдгийг би огт ойлгож чадахгүй байлаа.

Энэ асуултыг бодон Төгс Хүчит Бурханы Чуулганы ах эгч нартай уулзахаар явлаа. Линь эгч надад ингэж нөхөрлөв: “Ахлагч, пастор хоёр яагаад эцсийн өдрүүд дэх Төгс Хүчит Бурханы ажлыг эрж хайж, судлалгүй, харин Түүнийг улайран буруутгаж, эсэргүүцсэн тухайд бол Төгс Хүчит Бурхан энэ асуудлын мөн чанар, гарал үүслийг аль хэдийн тодорхой болгосон. Төгс Хүчит Бурхан ингэж хэлдэг: **‘Фарисайчууд Есүсийг эсэргүүцсэний уг шалтгааныг та нар мэдмээр байна уу? Фарисайчуудын мөн чанарыг мэдэхийг хүсэж байна уу? Тэд Мессиагийн талаарх уран зөгнөлөөр дүүрэн байсан. Үүнээс гадна, тэд Мессиа ирнэ гэдэгт л итгэсэн ч амийн үнэнийг эрж хайгаагүй. Иймээс өнөөдөр ч гэсэн тэд Мессиаг хүлээсээр л байдаг, учир нь тэдэнд амийн замын талаар ямар ч мэдлэг байдаггүй, мөн үнэний зам гэж юу болохыг мэддэггүй. Ийм мунхаг, зөрүүд, мэдлэггүй хүмүүс Бурханы ерөөлийг олж авч чадах уу, та нар хэл дээ? Тэд яаж Мессиаг харж чадах юм бэ? Тэд Ариун Сүнсний ажлын чиглэлийг мэдээгүй, Есүсийн хэлсэн үнэний замыг мэдээгүй, түүнчлэн Мессиаг ойлгоогүй учраас Есүсийг эсэргүүцсэн. Тэд Мессиаг хэзээ ч харж байгаагүй, Мессиагаар хэзээ ч хамт байгаагүй болохоор Мессиагийн нэртэй дэмий зууралдах зуураа Мессиагийн мөн чанарыг боломжит бүх аргаар эсэргүүцэх алдаа гаргасан. Энэ фарисайчууд мөн чанарын хувьд зөрүүд, биеэ тоосон байж, үнэнийг**

---

дуулгавартай дагаагүй. Тэдний Бурханд итгэх зарчим нь энэ: Таны номлол хэр гүн гүнзгий, Таны эрх мэдэл хэчнээн өндөр дээд ч бай, Мессиа гэж нэрлэгдээгүй л бол Та Христ биш. Эдгээр үзэл бодол нь утга учиргүй, хөгийн биш гэж үү?’ (Үг нь махбодоор илэрсэн номын “Есүсийн сүнслэг биеийг харах үед чинь Бурхан тэнгэр, газрыг шинээр бүтээсэн байх болно”). **‘Зүгээр л урсгал болгоны удирдагчдыг харцгаа—тэд бүгд биеэ тоож, өөрсдийгөө зөвтгөдөг бөгөөд Библийг агуулгаас нь гажуудуулж, өөрсдийн төсөөллөөр тайлбарладаг. Ажлаа хийхдээ тэд бүгд билиг авьяас, эрдэм мэдлэгт түшиглэдэг. Хэрэв тэд юу ч номлох чадваргүй байсан бол энэ хүмүүс тэднийг дагана гэж үү? Эцсийн эцэст тэд жаахан мэдлэгтэй бөгөөд зарим нэг хоосон сургаалын тухай номлож чаддаг, эсвэл бусдыг хэрхэн өөрийн талд оруулах, заль мэх хэрхэн ашиглахаа мэддэг. Тэд хүмүүсийг өөрсдийнхөө өмнө авчирч, хуурахдаа эдгээрийг ашигладаг. Тэд Бурханд нэр төдий итгэдэг боловч бодит байдал дээр удирдагчдаа дагадаг. Хэрэв үнэн замыг номлож байгаа хүнтэй таарах юм бол зарим нь, “Бид итгэлийнхээ талаар удирдагчтайгаа зөвлөлдөх ёстой” гэгцгээдэг. Тэдний итгэл хүнээр дамжих ёстой байна гэдэг чинь асуудал бус уу? Тэгвэл тэрхүү удирдагчид юу болсон бэ? Фарисайчууд, хуурамч хоньчид, антихристүүд, мөн үнэн замыг хүлээн зөвшөөрөхөд нь хүмүүсийг бүдрээх бул хар чулуу болсон бус уу?’** (Христийн ярианы тэмдэглэл номын “Үнэний эрэл хайгуул л Бурханд итгэх жинхэнэ итгэл юм”). Эзэн Есүс анх ажлаа хийх гэж ирэхдээ Иудейн удирдагчид буюу ахлах тахилчид, хуулийн багш нар болон фарисайчуудын улайрсан буруутгал, эсэргүүцэлд автсан билээ. Эцэстээ тэд Эзэн Есүсийг цовдолсон. Фарисайчуудын өвөг дээдэс Бурханд итгэдэг, хуулийн мэргэжилтнүүд байсан. Тэгвэл яагаад тэд Эзэн Есүсийг эсэргүүцэж, буруутган, загалмайд цовдлох билээ? Тэдний гэжүүд, биеэ тоосон, үнэнд захирагддаггүй сатанлаг уг чанараас энэ нь үүдэлтэй гэдгийг Бурханы үгээс бид харж болно. Эзэн Есүс маш их үнэнийг илэрхийлсэн бөгөөд тэд үүнийг эрж хайж, судлахын оронд өөрсдийн үзэл бодлоо дагасан юм. Тэдний өөрсдийнхөө үзэл, төсөөлөлд л түшиглэн Бурханд итгэж, эшлэлүүдийг хам сэдвээс нь салгах замаар Библийг тайлбарладаг байсан. Энэ нь тэднийг сохор болгож, Бурханаас гэгээрэл хүртэхгүй байхад хүргэсэн юм. Тэд Ариун Сүнсний ажлыг мэддэггүй, үнэнийг ойлгодоггүй, мөн Бурханы дуу хоолойг ч ойлгодоггүй байсан. Энэ нь Библийн **‘Та нар сонсдог ч ойлгодоггүй; хардаг ч ухамсарладаггүй: Учир нь энэ ардуудын зүрх сэтгэл хатуурч, чих нь дүлийрэн хатуурч, нүд нь хаагджээ’** (Матай 13:14–15) гэх үгийг үнэхээр биелүүлсэн юм. Эцсийн өдрүүд дэх шашны хүрээллийн пастор, ахлагчид нь Библийн мэдлэг, теологийн онолын судалгаанд л ач холбогдол өгдгөөрөө тухайн үеийн фарисайчуудтай адил юм. Тэд Эзэний үгийг тайлбарлаж, Эзэний эргэн ирэх арга замыг хязгаарлахдаа өөрсдийн бодол, төсөөлөлд түшиглэдэг. Тэд өөрсдийн үзэл, төсөөлөлтэй гэжүүдээр зууралдаж, үнэнийг огт эрж хайдаггүй. Тэд эцсийн өдрүүд дэх Бурханы ажлыг судалдаггүйгээр зогсохгүй Түүнийг

---

сохроор эсэргүүцэн буруутгаж, өөрсдийн зөрүүд, биеэ тоосон, үнэнд дайсагнасан сатанлаг зан чанарыг ил болгодог. Тэд теологи судалж, өөрсдийгөө Библийн тухай мэдлэгээр зэвсэглэдэг боловч энэ нь тэд үнэнд хайртай гэсэн үг биш, үнэнийг хүлээн зөвшөөрч, дуулгавартай дагах чадвартай гэсэн үг ч биш. Тэд Библийн мэдлэг болон теологийн онолыг тайлбарладаг бөгөөд өөрсдийн алдар хүнд, нэр төрийг л нэмэгдүүлэхээр зорьдог. Тэд өөрсдийн байр суурийг хамгаалж, итгэгчдээр хүндлүүлж, хайрлуулж, дагуулахын тулд ингэдэг. Төгс Хүчит Бурханы илэрхийлдэг үг нь үнэн, мөн хүмүүсийг байлдан дагуулж, аврах чадвартай бөгөөд үнэнийг хайрлаж, Бурханы илрэлтийг хүсэн хүлээдэг олон хүн Төгс Хүчит Бурханы үгийг уншиж, Төгс Хүчит Бурхан руу эргэсэн гэдгийг тэд мэддэг. Тэд Төгс Хүчит Бурханы ажил өөрсдийнх нь байр суурь, амьжиргаанд аюул занал болно хэмээн боддог учраас улайран тэмцэж, Төгс Хүчит Бурханыг буруутгаж, эсэргүүцэхийн тулд чадах бүхнээ хийдэг. Бурханы сонгосон хүмүүсийг цаг ямагт ноёрхохоор оролдсондоо итгэгчдийг Төгс Хүчит Бурхан руу эргэхэд нь саад хийж, үймүүлэхийн тулд шаардлагатай арга хэмжээг авдаг. Ахлагчид болон номлогчид яагаад Төгс Хүчит Бурханы ажлыг эрж хайж, судалдаггүйн, мөн яагаад Төгс Хүчит Бурханыг улайран эсэргүүцэж, буруутгадгийн уг үндэс энэ юм. Бурханыг эсэргүүцдэг ахлагчид болон номлогчид бол өнөө үеийн фарисайчууд бөгөөд итгэгчид үнэнийг хүлээн зөвшөөрч, тэнгэрлэг хаанчлалд өргөгдөхийг хориглодог саад гэдгийг тэдний ёрын муу үйл хэргээс харж болно. Тэд бол Бурханыг эсэргүүцэж, дайснаа болгодог антихристүүд бөгөөд эцсийн өдрүүд дэх Бурханы ажлаар илчлэгдсэн билээ.”

Би Төгс Хүчит Бурханы үг, эгч нарын нөхөрлөсөн зүйлийг сонсоод, пастор болон ахлагчийн хэлсэн, хийсэн зүйлтэй харьцууллаа. Төгс Хүчит Бурханы үг маш бодитой байдлаар хэлэгдсэн бөгөөд пастор, ахлагч хоёр Библийг ахин дахин уншиж, тайлбарлаж болох ч, энэ нь тэд бол Бурханыг талаарх мэдлэгтэй хүмүүс гэсэн үг биш гэдгийг би ойлгосон юм. Тэд бусдад шүтүүлж, бусдыг дагуулах гэсэндээ өөрсдийгөө өргөмжлөхийн тулд ажлаа хийхдээ байгалиас заяасан авьяас, мэдлэгтээ түшиглэдэг. Гаднаа тэд Бурханд үйлчилж буй мэт байдаг ч үнэн хэрэгтээ өөрсдийн үзэл төсөөлөл, байр суурь, амьжиргаанд үйлчилж байгаа юм. Пастор, ахлагч хоёр намайг удаа дараа зовоож, саад болсаноор дамжуулан би тэдний үнэхээр хэн болохыг нь харж чадсан. Тэд бол Бурханд итгэдэг атлаа үнэнийг эрж хайдаггүй, Бурханд үйлчилдэг атлаа Бурханыг эсэргүүцдэг антихристүүд билээ. Пастор, ахлагч хоёр өнөөдрийг хүртэл намайг зовоохоо болиогүй ч, үнэнд дайсагнаж, Бурханыг эсэргүүцдэг тэдний жинхэнэ антихрист уг чанарыг би аль хэдийн тодорхой харсан. Би цаашид өөрийгөө тэднээр зовоолгож, хянуулахгүй бөгөөд эцсийн өдрүүд дэх Төгс Хүчит Бурханы ажил бол үнэн гэдгийг би бүрэн гүйцэд тогтоосон. Би Төгс Хүчит Бурханыг эцсээ хүртэл дагаж, хэзээ ч өөрчлөгдөхгүй байхыг хүсэж байна!

---

Амен!

## **25. Би жинхэнэ Христ, хуурамч Христийг ялган таньж чаддаг боллоо**

Шянванг Малайз

“Махбод болсон Бурханыг Христ гэдэг, иймээс хүмүүст үнэнийг өгч чаддаг Христийг Бурхан гэдэг. Энэ тухайд ямар ч хэтрүүлсэн зүйл байхгүй, учир нь Тэр хүний хүрэх боломжгүй Бурханы мөн чанар болон Бурханы зан чанарыг, мөн ажлаа хийх мэргэн ухааныг эзэмшсэн байдаг. Өөрсдийгөө Христ гэдэг атлаа Бурханы ажлыг хийж чаддаггүй хүмүүс бол луйварчид юм. Христ бол газар дэлхий дээрх Бурханы илрэл төдий биш, харин хүмүүсийн дунд ажлаа хэрэгжүүлж, гүйцэлдүүлэхдээ Бурханы авсан онцгой махбод билээ. Энэ махбод нь газар дээрх Бурханы ажлыг зүй ёсоор гүйцэтгэж, Бурханы зан чанарыг илэрхийлж, Бурханы сайн төлөөлөл байж, хүнийг амиар хангаж чаддаг учир хүссэн хүн бүр үүнийг орлочхож чадахгүй” (“Хургыг дагаж шинэ дуу дуулья” ном). Бие махбодтой болох гэж юу болох, жинхэнэ Христийг хуурамч Христүүдээс яаж ялгахыг Бурханы үг илчилдэг. Би Эзэнийг дагаж байхдаа энэ үнэнийг ойлгодоггүй, хуурамч Христийг яаж танихыг мэддэггүй, зүгээр л пастор, ахлагчдын үгэнд ордог байсан. Төөрөлдөхөөс айдаг болохоор хуурамч Христээс сэрэмжлэх нь миний итгэлийн эн тэргүүний асуудал байлаа. Би нуухыг нь авах гээд нүдийг нь сохлох гэгч болоод Бурханы илрэлт, ажлыг эрж хайж зүрхлээгүй юм. Бурханы эцсийн өдрүүдийн авралыг алдах шахсан шүү. Тэгэх тун дөхсөнөө одоо ойлгож байна.

Би бага байхаасаа ээжтэйгээ хамт чуулганд явж, Библи уншдаг байгаад, жаахан том болоод залуучуудын бүлэгт элссэн юм. Манай пастор теологийн докторын зэрэгтэй байсан, тэгээд пастор байх хэцүү, энэ хэвээр байхын тулд Ариун Сүнсээр хөдөлгөгдөх хэрэгтэй гэж үргэлж хэлдэг байлаа. Бид пастороо үнэхээр хүндэлдэг байсан. Ариун Сүнсээр хөдөлгөгдсөн, Эзэнийг баярлуулсан хүн гэж боддог байсан юм. Пастор судрын нэг эшлэлийг маш их эш татдаг байсан: “Тэр үед хэн нэгэн хүн та нарт ‘Хараач, Христ энд байна’, эсвэл ‘Христ тэнд байна’ гэвэл түүнд бүү итгэ. Учир нь хуурамч Христүүд болон хуурамч эш үзүүлэгчид гарч ирэн агуу тэмдэг, гайхамшгуудыг үзүүлэх ба боломжтой бол сонгогдсон хүмүүсийг ч хууран мэхэлнэ” (Матай 24:23–24). Эцсийн өдрүүдэд хуурамч Христүүд хүмүүсийг хуурдаг учраас болгоомжлох хэрэгтэй гэж бидэнд үргэлж хэлдэг байлаа. Ялангуяа Библийн мэдлэг нимгэнтэй, биеийн хэмжээ багатай

---

биднийг төөрөлдөхгүйн тулд өөр урсгалын юм сонсож, уншиж, судлахгүй бай гэсэн юм. Чуулганыхан бас Зүүний Аянгын талаар маш их сөрөг юм ярьж, тэднээс хол бай гэлээ. Пастор биднийг зүгээр л Библи уншиж, өдөр болгон Эзэнд нүглээ улайж, гэмшиж, Эзэнийг ирэхэд хаанчлал руу нь хүргэгдэхийн тулд үргэлж сэргэг байх ёстой гэсэн. Тухайн үед би үүнд бүрэн итгээд өөр чуулган руу явж зүрхлээгүй. Тэгээд пасторын хэлсэн бүхнийг хийдэг байлаа. Ингэснээр Эзэний ирэхийг аюулгүй хүлээж байна гэж боддог байсан юм.

Нэг өдөр чуулганы Ху ах сургууль дээр намайг олж уулзаад, манай ээж, эгч хоёрыг Зүүний Аянгад элссэн юм шиг байна гэлээ. Үүнийг сонсоод би цочирдож, “Зүүний Аянгаас хол бай гэж пастор бидэнд байнга захидаг биш үү? Ээж тэднийд элсэж яаж болдог юм бэ?” гэж бодлоо. Дараа нь Ху ах Зүүний Аянгын тухай аймаар цуу яриа ярьж өгсөн. Би ч улам айж, самгардлаа. Ху ах намайг гэртээ хариад, энэ үнэн эсэхийг ээжээсээ асуугаад бичлэг хий, тэгээд тэр бичлэгээ өөрт нь явуул гэж хүслээ. Би ээжийг төөрөлдөж байж магад гэж айгаад тэгье гэж зөвшөөрсөн.

Гэртээ харьтал ээж яг л, Эзэн Есүс Төгс Хүчит Бурхан болж эргэн ирсэн, тэгээд хүмүүсийг цэвэрлэж, өөрчилж, биднийг нүглээс бүрэн аврахын тулд үнэнийг илэрхийлж, Бурханы гэрээс эхлэн шүүлтийн ажил хийж байгаа гэж хэллээ. Тэгээд намайг шууд Төгс Хүчит Бурханы үгийг уншиж, эцсийн өдрүүдийн ажлыг нь судал гэж хүссэн. Ингэж хэлэхийг нь сонсоод Зүүний Аянгын талаар пасторын хэлсэн муу муухай юм санаанд орлоо. Би үнэхээр эсэргүүцэж байсан ч ээжийн бичлэгийг хийж байсан болохоор биеэ барьж, үгийг нь сонссон юм.

Маргааш нь ээж намайг Төгс Хүчит Бурханы ажлыг судал гэж дахин шавдууллаа. Тухайн үед, тэдний тухай пасторын хэлсэн муу муухай юмаар толгой минь дүүрсэн байсан болохоор үнэндээ үгийг нь сонсоогүй. Би ээжид, “Зүүний Аянгыг битгий сонс гэж пастор, ахлагчид үргэлж хэлдэг. Тэднээс хол бай!” гэж зөвлөхөд ээж хариуд нь, “Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг судлах замд маань тэд яагаад хөндөлсдөг юм бэ? Энэ нь Эзэний сургаалд нийцдэг гэж үү? Эзэн Есүс бидэнд, **‘Сүнсээрээ ядуу хүмүүс ерөөлтэй еэ: учир нь тэнгэрийн хаанчлал бол тэднийх юм’** (Матай 5:3). **‘Шөнө дөлөөр хашхирах дуу гарч, “Хараач, Сүйт залуу ирлээ; Түүнийг угтан авцгаа” гэлээ’** (Матай 25:6) гэж хэлсэн. Бурхан биднийг даруухнаар эрж хай гэж хүсдэг. Зүүний Аянга Эзэн эргэн ирсэн гэж гэрчилдэг, тийм болохоор бид үүнийг судлах ёстой. Гэтэл пастор Эзэнийг угтан авахад маань саад хийх гээд байх юм. Энэ нь Эзэний сургаалаас зөрж байгаа биш үү? Бид сохроор пасторын үгэнд оролгүй Эзэнийг сонсох ёстой. Эзэний цаг үед Иудейн шашны итгэгчид Эзэний дуу хоолойг сонсолгүй, ахлах тахилчид, хуулийн багш нар,



---

фарисайчуудын худал үгийг даган Эзэнийг яллаж, эсэргүүцсэн шүү дээ. Тэд Эзэн Есүсийг цовдлохоор хуйвалдаад, Бурханд шийтгүүлсэн. Бид тэднээс сургамж авах ёстой! Илчлэлд: **‘Чуулгануудад Сүнс юу айлдаж буйг чихтэй бүхэн сонсогтун’** (Илчлэл 2, 3) гэж зөгнөсөн байдаг. Тэгэхээр Эзэн эргэж ирээд илүү их үг хэлнэ гэсэн үг. Эзэнийг угтан авахыг хүсвэл Бурханы дуу хоолойг таньж сурах ёстой. Төгс Хүчит Бурханы үг Бурханы дуу хоолой мөн эсэхийг чи өөрөө хар, тэгвэл эргэн ирсэн Эзэн Есүс мөн гэдгийг нь мэднэ” гэсэн. Ээж ярьж байхдаа “Эцсийн өдрүүдийн Христийн айлдварууд” гэх ном барьж авлаа. Би үүнд нь сэтгэл гонсойж, өрөөндөө орсон.

Тэгээд тайвширч, ээжийн хэлсэн үгийг эргэн бодлоо. Бурханы дуу хоолойг таньж сурах, Эзэнийг угтан авахын тулд даруухнаар эрж хайх нь Эзэний сургаалтай нийцдэг. Зүүний Аянга Эзэн эргэн ирж, үнэнийг илэрхийлсэн гэж гэрчилж байгаа болохоор Төгс Хүчит Бурханы үгийг уншилгүй сохроор пасторын үгэнд орох нь жаахан бодлогогүй санагдсан. Төгс Хүчит Бурхан эргэн ирсэн Эзэн Есүс мөн байтал би хүлээн зөвшөөрөхгүй бол Эзэнийг угтан авах боломжоо алдах биш үү гэж бодлоо. Гэхдээ дараа нь, эцсийн өдрүүдэд хуурамч Христүүд гарч ирнэ гэж пастор ахин дахин хэлдэг нь санагдлаа. Одоо төөрөлдөх юм бол итгэл минь хий дэмий зүйл болно биз дээ? Сэтгэл үймэрч, хэний үгэнд орохоо мэдэхгүй байсан болохоор Эзэний өмнө очиж залбиран, намайг гэгээрүүлж, замчлаач гэж гуйсан юм.

Дараа нь ээж Төгс Хүчит Бурханы Чуулганы нөхөрлөл сонс гэж надад дахин зөвлөсөн. Би хоромхон зуур тээнэгэлзээд, дараа нь зөвшөөрлөө. Эхэндээ толгойд юу ч орохгүй байсан ч авралын төлөөх Бурханы удирдлагын төлөвлөгөө, Бурханы ажлын гурван үе шатны нууцыг дурдмагц би тэр даруй шимтэн сонслоо. Энэ бүгд маш шинэлэг санагдаж байсан. Библи судлах олон бүлэгт байсан ч ийм юм хэзээ ч сонсож байгаагүй шүү. Цуглааны дараа би бодлоо өөрчиллөө. Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг судалж, ээжийн бичлэгийг устгахаар шийдсэн.

Хоёр дахь цуглаан дээр Жан ах ухаалаг охид, мунхаг охидын талаар ярилаа. “Ухаалаг охид Бурханы илрэлтийг хүсэн хүлээж, Бурханы дуу хоолойг сонсож чаддаг болохоор ухаалаг юм. Эзэн ирснийг сонсоод тэд идэвхийлэн эрж хайж, судалдаг. Бусдад боогддоггүй, өөрсдийн үзэлтэй зууралддаггүй. Бурханы дуу хоолой мөн гэдгийг нь баталгаажуулмагцаа эргэлт буцалтгүйгээр Эзэнийг угтан авч, дагадаг. Тийм хүн хуурамч Христүүдээс болж төөрөлдөхгүй. Мунхаг охид ялган таних чадваргүй, бас үнэнийг хайрладаггүй. Эзэнийг угтан авахын тулд дуу хоолойг нь сонсох гэж хичээдэггүй, харин байр суурь, эрх мэдэлд дурлаж, бусад бүх хүн шиг пастор, алхагчдыг сонсдог. Эзэн яаж ч тогшлоо гэсэн тэд чихээ таглан, хаалгаа хаадаг. Тэд мунхаг байдаг. Зарим хүн Бурханы

---

дуу хоолойг таньдаг ч хүмүүст гологдож, чуулганаасаа хөөгдөх вий гэж айгаад Бурханыг дагаж зүрхэлдэггүй. Тэд үнэнийг огт эрж хайдаггүй болохоор Эзэнийг эргэн ирэхэд угтан авч яаж чадах вэ дээ?” гэсэн.

Үүнийг сонсоод би ухаан орсон юм. Удаан хугацаанд пастор, ахлагчдыг л сонсоод, Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг эрж хайж зүрхэлдэггүй байснаа олж харсан. Эргэн ирсэн Эзэн Есүс үнэхээр мөн байхад Төгс Хүчит Бурханыг хүлээн зөвшөөрөхгүй бол мунхаг охин гэдэг минь илчлэгдэх биш үү? Эзэн Есүс бидэнд: **“Гуй, тэгвэл та нарт өгнө; хай, тэгвэл олно; тогш, тэгвэл та нарт нээгдэнэ”** (Матай 7:7) гэж хэлсэн. Би Эзэнийг угтан авна гэж найддаг байсан. Зүүний Аянга Эзэн эргэн ирсэн гэж гэрчилж байхад би эрж хайж, судалдаг ухаалаг охин байх учиртай. Тэр нь Бурханы хүсэл! Тийм болохоор би тэдэнд төөрөгдлөө хэллээ. **“Тэр үед хэн нэгэн хүн та нарт “Хараач, Христ энд байна”, эсвэл “Христ тэнд байна” гэвэл түүнд бүү итгэ. Учир нь хуурамч Христүүд болон хуурамч эш үзүүлэгчид гарч ирэн агуу тэмдэг, гайхамшгуудыг үзүүлэх ба боломжтой бол сонгогдсон хүмүүсийг ч хууран мэхэлнэ”** (Матай 24:23–24) гэж Эзэн Есүс хэлсэн. Пастор, ахлагчид эдгээр эшлэлийг ашиглан, эцсийн өдрүүд дэх хуурамч Христүүдээс биднийг сэрэмжлүүлж, Эзэн ирсэн тухай ямар ч мэдээ худал гэдэг. Бид төөрөлдөх вий гэж айгаад Эзэн ирсэн талаар судалж зүрхэлдэггүй, гэхдээ ингэх нь зөв хэрэгжүүлэлт биш юм шиг байна. Тэгвэл бид Эзэний хэлсэн үгийг яаж ойлгох ёстой юм бэ? Яаж бид хуурамч Христүүдэд төөрөлдөхөөс зайлсхийж, Эзэнийг угтан авч болох вэ?” гэсэн.

Хариуд нь Жан ах ингэж нөхөрлөлөө: “Эзэнийг эргэн ирэх үед хүмүүсийг хуурдаг хуурамч Христ, хуурамч эш үзүүлэгчид байна гэдгийг Библи уншсан хүмүүс мэддэг. Ялангуяа шашныхан хуурамч Христ, хуурамч эш үзүүлэгчээс хүмүүсийг сэрэмжлүүлэх гэж энэ бичвэрийг байнга ашигладаг болохоор ихэнх хүн үүнийг итгэлд нь нэн чухал зүйл гэж үздэг. Тэгээд Эзэн ирэх тухай бүх мэдээ хуурамч гэж боддог. Гэхдээ Эзэн Есүсийн үгийн жинхэнэ утгатай энэ нь нийцдэг үү? **“Тэр үед хэн нэгэн хүн та нарт “Хараач, Христ энд байна”, эсвэл “Христ тэнд байна” гэвэл түүнд бүү итгэ. Учир нь хуурамч Христүүд болон хуурамч эш үзүүлэгчид гарч ирэн агуу тэмдэг, гайхамшгуудыг үзүүлэх ба боломжтой бол сонгогдсон хүмүүсийг ч хууран мэхэлнэ”** (Матай 24:23–24) гэж Эзэн Есүс хэлсэн. Эцсийн өдрүүдэд хуурамч Христ, эш үзүүлэгчид гарч ирнэ, тэгээд хүмүүсийг хуурахын тулд агуу тэмдэг, гайхамшиг үзүүлнэ, тиймээс бид ялган таних чадвартай байх ёстой гэж л Эзэн Есүс бидэнд хэлсэн нь эндээс харагддаг. Эзэн эргэн ирсэн гэх бүх мэдээ хуурамч гэж Эзэн хэзээ ч хэлээгүй. Эзэн Есүс дахин ирнэ гэж хэлснийг ч бид мартаж болохгүй, тэгэхээр Эзэн эргэн ирсэн тухай ямар ч мэдээ худал гэж хэлснээр шашныхан Эзэн эргэн ирэхийг үгүйсгэж, Эзэний үгийг ичгүүргүйгээр үгүйсгэж, Бурханы

---

илрэлт, ажлыг яллаж байгаа биш үү? Тэд хүмүүсийг төөрөлдүүлж, Эзэний үгээс улайм цайм зөрж байгаа биш үү? Хэрвээ бид эдгээр эшлэлийг хам сэдвээс нь салган үзэж, Эзэний үгийн утгыг буруу тайлбарлан, тийм мэдээг хуурамч гэж хязгаарлах юм бол Бурханы илрэлт, ажлыг яллаж байгаа хэрэг бус уу? Тэгвэл бид Эзэнийг эргэн ирэхэд угтан авч яаж чадах юм бэ?” гэлээ.

Ахын нөхөрлөлийг сонсоод миний нүд нээгдсэн. Эцсийн өдрүүдэд хуурамч Христүүд хүмүүсийг хуурахын тулд агуу тэмдэг, гайхамшиг үзүүлнэ гэж тэдгээр эшлэлд үнэхээр хэлдэг. Пастор, ахлагчид Библийг сайн мэддэг юм байж хуурамч Христийг ялган таних тухай энэ зүйлийг яагаад олж хараагүй юм бол? Дараа нь Жан ах Төгс Хүчит Бурханы үгийн хоёр хэсгийг уншиж өглөө: **“Өнөө үед тэмдэг, гайхамшиг үзүүлж, чөтгөрүүдийг хөөн зайлуулж, өвчтэйг эдгээж, олон ид шид үзүүлж чадах хүн гарч ирээд, Есүс ирлээ хэмээн өөрийгөө зарлавал энэ нь Есүсийг дуурайсан муу ёрын сүнснүүдийн дүр эсгэлт байх болно. Үүнийг санаж яв! Бурхан нэг ажлаа давтдаггүй. Есүсийн ажлын үе шат аль хэдийн биелсэн ба ажлын тэрхүү үе шатыг Бурхан дахин хэзээ ч хийхгүй... Хэрвээ эцсийн өдрүүдэд Бурхан тэмдэг, гайхамшиг үзүүлсээр, чөтгөрүүдийг хөөн зайлуулж, өвчтэйг эдгээсээр—яг Есүс шиг үйлдсэн бол нэг ажлаа давтаж байгаа хэрэг болж, Есүсийн ажил ямар ч ач холбогдол, үнэ цэнгүй байх байсан юм. Тиймээс Бурхан эрин үе бүрд ажлын нэг үе шатыг хэрэгжүүлдэг. Түүний ажлын үе шат бүрийг гүйцэлдмэгц муу ёрын сүнснүүд удалгүй дуурайдаг ба Сатан Бурханыг өсгий даран дагаж эхэлсний дараа Бурхан өөр арга барилд шилждэг. Бурхан ажлынхаа нэг үе шатыг биелүүлмэгц муу ёрын сүнснүүд үүнийг нь дуурайдаг. Та нар энэ талаар тодорхой ойлгох ёстой.”** “Хэрвээ эцсийн өдрүүдэд өвчтэйг эдгээн, чөтгөрийг зайлуулж, хүний төлөө цовдлогдсон Есүстэй адилхан нэг ‘Бурхан’ гарч ирэх юм бол тэр ‘Бурхан’ хэдийгээр Библи дэх Бурханы тодорхойлолттой адилхан, хүлээн зөвшөөрөхөд хүнд хялбар байх ч мөн чанартаа Бурханы Сүнсний өмссөн махбод биш, харин муу ёрын сүнсний өмссөн махан бие байна. Учир нь Өөрийнхөө аль хэдийн дуусгасан зүйлийг хэзээ ч давтдаггүй нь Бурханы ажлын зарчим билээ” (“Үг нь махбодоор илэрсэн” ном).

Үүнийг уншсаныхаа дараа ингэж нөхөрлөсөн: “Бурхан үргэлж шинэ байж, хэзээ ч хуучин байдаггүй, бас ажлаа давтдаггүй. Ажлын шинэ үе шат эхлүүлэх болгондоо Бурхан шинэ үг айлдаж, хэрэгжүүлэлтийн шинэ зам руу хүмүүсийг хөтөлдөг. Жишээ нь, Эзэн Есүс ирээд дахин хууль, тушаал гаргаагүй, харин өмнөх тэр ажилдаа суурилан золин авралын ажил хийж, гэмшлийн замыг илэрхийлж, нүглээ улайж, гэмш, дайснаа хайрла, бие биеэ уучилж, хайрла гэх мэтийг хүмүүст зааж сургаад, эцэст нь хүний төлөө нүглийн тахил болон цовдлогдсон. Эцсийн өдрүүдэд Төгс Хүчит Бурхан тэмдэг, гайхамшиг

---

үзүүлж, өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг хөөдөггүй. Харин золин аврах ажилд үндэслэн шүүж, цэвэрлэх ажил хийж, үнэнийг илэрхийлж, хүний завхарсан зан чанар, сатанлаг уг чанарыг илчилж, зөв шударга бус байдлыг нь шүүдэг. Бас цэвэрлэгдэж, бүрэн аврагдахад нь хэрэгтэй бүх үнэнийг өгч, тэднийг Сатаны харанхуй нөлөө, завхралаас бүрэн авардаг, тэгээд Бурхан тэднийг олж авдаг. Хүн төрөлхтнийг аврах Бурханы ажил ингэж бүрмөсөн дуусдаг. Бурханы ажил үе шат болгондоо улам ахин дэвшиж, хэзээ ч давтагддаггүй. Хэрвээ Эзэн эргэж ирээд тэмдэг гайхамшиг үзүүлж, өвчтэйг анагааж, чөтгөрүүдийг хөөсөн бол Бурханы ажил давтагдах байсан. Энэ нь утгагүй байх байлаа. Гэхдээ зарим хүн, Бурхан зөвхөн тэмдэг, гайхамшиг үзүүлж, өвчтэйг эдгээж, чөтгөрийг хөөж л чадна гэдэг. Тэд Бурханыг хязгаарлаж, ажил нь ахин дэвшиж болохгүй гэж боддог. Тийм болохоор Бурхан хэзээ ч ажлаа давтахгүй, тэр бүх зүйлийг хийдэг хэн бүхэн хуурамч Христ байх нь гарцаагүй. Ихэнх хуурамч Христ муу ёрын сүнсэнд эзэмдүүлсэн байдаг. Тэд үнэнийг илэрхийлж чадахгүй, шинэ эрин үеийг эхлүүлж, хуучныг нь төгсгөж бүр ч чадахгүй. Гагцхүү Эзэн Есүсийн ажлыг дуурайж, хүмүүсийг хуурахын тулд энгийн гайхамшиг үзүүлж л чаддаг. Гэхдээ буцаан амилуулах, 5,000 хүнийг таван талх, хоёр загасаар хооллох гайхамшиг гэх зэрэг Эзэн Есүсийн хийсэн зүйлийг хуурамч Христүүд дуурайж чадахгүй. Хуурамч Христүүд биш, Бурхан л тийм хүч чадал, эрх мэдэлтэй. Хэрвээ үнэнийг илэрхийлж чаддаггүй, харин өчүүхэн тэмдэг, гайхамшиг үзүүлчхээд, өөрийгөө Христ гэдэг бол жинхэнэ Христ биш гэдэг нь гарцаагүй. Бид энэ зарчмаар хуурамч Христүүдийг жинхэнэ Христээс ялган таньж болно” гэлээ.

Бурханы ажил үргэлж шинэ байж, хэзээ ч хуучин байдаггүй, Бурхан нэг ажлаа хэзээ ч давтдаггүй гэдгийг би Жан ахын нөхөрлөлөөс сурсан юм. Хуурамч Христүүд Бурханы ажлыг хийж чадахгүй. Зүгээр л Бурханы хуучин ажлыг дуурайж, хүмүүсийг хуурахын тулд гайхамшиг үзүүлдэг. Энэ бол хуурамч Христийг ялган таних нэг зарчим юм. Дэлхий дээр бүх хуурамч юм жинхэнэтэйгээ адилхан харагдахуйц хийцтэй байдаг ч эцсийн эцэст хуурамч л байдагтай энэ нь яг адил. Хуурамч Христүүд ч тийм байдаг. Энэ надад гэгээрэлтэй байлаа.

Жан ах цааш нь: “Христийн мөн чанарыг мэдэх нь хуурамч Христүүдийг ялган танихад хамгийн чухал. Энэ нь хамгийн үндсэн, чухал хэсэг юм” гэж нөхөрлөсөн. Дараа нь ах Төгс Хүчит Бурханы үгийн хоёр хэсгийг уншиж өглөө: **“Бие махбодтой болсон Бурхан Тэрбээр Бурханы мөн чанарыг эзэмшинэ, бие махбодтой болсон Бурхан Тэрбээр Бурханы илэрхийллийг эзэмшинэ. Бурхан махбод болдог тул хийхээр зорьж буй ажлаа авчирна, мөн Бурхан махбод болдог тул Өөрийн юу болохыг илэрхийлж, хүнд үнэнийг авчирч, амь хайрлаж, замыг заан харуулж чадна. Бурханы мөн чанаргүй махбод нь харваас бие махбодтой болсон Бурхан биш; үүнд эргэлзэх зүйл**

---

үгүй. Хэрвээ хүн, Бурханы махбод болсон бие мөн эсэхийг судалж шинжлэхээр зорьж байгаа бол Түүний илэрхийлдэг зан чанар, хэлдэг үгээс үүнийг нотлох ёстой. Өөрөөр хэлбэл, Бурханы махбод болсон бие мөн эсэх, үнэн зам мөн эсэхийг нотлохын тулд хүн Түүний мөн чанарт үндэслэн ялган таних ёстой. Иймээс Бурханы махбод болсон бие мөн эсэхийг тодорхойлох гол түлхүүр нь гадаад дүр төрхөөс илүүтэйгээр Түүний мөн чанарт (Түүний ажил, Түүний айлдвар, Түүний зан чанар болон өөр олон талд) оршдог. Хэрвээ хүн Түүний гадаад дүр төрхийг л шинжлээд, үүний үр дүнд мөн чанарыг нь орхигдуулбал хүн харанхуй бүдүүлэг, мунхаг гэдгийг энэ нь харуулдаг.”

“Махбод болсон Бурханыг Христ гэдэг, иймээс хүмүүст үнэнийг өгч чаддаг Христийг Бурхан гэдэг. Энэ тухайд ямар ч хэтрүүлсэн зүйл байхгүй, учир нь Тэр хүний хүрэх боломжгүй Бурханы мөн чанар болон Бурханы зан чанарыг, мөн ажлаа хийх мэргэн ухааныг эзэмшсэн байдаг. Өөрсдийгөө Христ гэдэг атлаа Бурханы ажлыг хийж чаддаггүй хүмүүс бол луйварчид юм. Христ бол газар дэлхий дээрх Бурханы илрэл төдий биш, харин хүмүүсийн дунд ажлаа хэрэгжүүлж, гүйцэлдүүлэхдээ Бурханы авсан онцгой махбод билээ. Энэ махбод нь газар дээрх Бурханы ажлыг зүй ёсоор гүйцэтгэж, Бурханы зан чанарыг илэрхийлж, Бурханы сайн төлөөлөл байж, хүнийг амиар хангаж чаддаг учир хүссэн хүн бүр үүнийг орлочхож чадахгүй. Христийг дуурайдаг хүмүүс эрт орой хэзээ нэгэн цагт бүгд унах болно, учир нь тэд өөрсдийгөө Христ гэгцгээдэг ч, Христийн ямар ч мөн чанарыг эзэмшдэггүй. Иймд Би, Христийн жинхэнэ байдлыг хүн тодорхойлох боломжгүй, харин Бурхан Өөрөө үүнийг хариулж, шийддэг гэж хэлдэг” (“Үг нь махбодоор илэрсэн” ном).

Үүнийг уншсаныхаа дараа ах ингэж нөхөрлөсөн: “Христ бол махбод дахь Бурхан. Ердийн хүний махбод өмссөн, хэвийн хүн чанартай, бүрэн бурханлаг чанартай Бурханы Сүнс юм. Христ маш эгэл жирийн харагддаг ч мөн чанар нь бурханлаг болохоор үнэнийг болон Бурханы зөвт зан чанарыг илэрхийлж, шинэ эрин үеийг эхлүүлж, хуучныг нь төгсгөж, хүн төрөлхтнийг золин аварч, мөн аварч чаддаг, бас хүмүүсийг хангаж, хариулахын тулд үнэнийг илэрхийлж хэзээд чаддаг. Түүнийг орлож чадах хэн ч үгүй. Эзэн Есүс бие махбодтой болсон Бурхан буюу Христ байсан. Тэр ердийн хүн шиг харагдсан ч Хуулийн эрин үеийг төгсгөж, Нигүүлслийн эрин үеийг эхлүүлээд, хүнд гэмшлийн зам өгсөн. Тэгээд нүглийг уучлах эрх мэдэлтэй байж, цовдлолоороо хүн болгоны нүглийг золин аварсан. Эзэн шуурга намжаах, таван талх, хоёр загас, бас хүмүүсийг амилуулах гэх мэт олон тэмдэг, гайхамшиг үзүүлж, Бурханы хүч чадал, эрх мэдлийг харуулсан. Бас тухайн үеийн хэрэгцээнд нь үндэслэн хүмүүсийг хангаж, хариулахын тулд газар сайгүй номлож, үнэнийг илэрхийлсэн. Эзэн Есүс бол зам, үнэн, амь гэдгийг ажил, үг нь бидэнд харуулсан, бас бие махбодтой болсон Бурхан, хүн төрөлхтний Золин Аврагч мөн гэдгийг

---

ажил, үг нь бүрмөсөн нотолсон. Эцсийн өдрүүдэд Төгс Хүчит Бурхан ирээд Нигүүлслийн эрин үеийг төгсгөн, Хаанчлалын эрин үеийг эхлүүлж, эцсийн өдрүүд дэх хүмүүсийг шүүж, цэвэрлэхээр ажилласан. Тэр ямар ч зөрчлийг хүлцдэггүй зөвт зан чанараа илэрхийлдэг. Түүний үг 6,000 жилийн удирдлагын төлөвлөгөөнийх нь нууцыг тайлаад зогсохгүй хүн нүгэл үйлдэж, Бурханыг эсэргүүцдэгийн уг үндэс, хүний завхарсан зан чанарыг илчилж, шүүж, ариусаж, бүрэн аврагдахад нь хэрэгтэй бүх үнэнийг маш тодорхой хэлдэг. Бурхан хүнийг яаж шүүж, ариусгадаг, Бурханыг хүн яаж дуулгавартай дагаж, Түүнд итгэх ёстой, Бурхан хэнийг таалж, хэнийг жигшиж, таягдан хаядаг, ямар эрэл хайгуулаар ариусаж, төгс болж болдог, хүн төрөлхтний үр дүн, хүрэх газар гэх мэт үүнд багтдаг. Бурханы шүүлт, гэсгээлтийн үгээр бид Сатаны завхралд өртсөн гэх үнэнээ харж, Бурханы зөвт, ариун, халдашгүй зан чанарыг мэдэж, Бурханы өмнө нүүрээрээ газар унан мөргөөд, гэмшсэн. Бид Бурханаас айж, Бурханд захирагдаж, амь зан чанар маань өөрчлөгдөж эхэлсэн. Төгс Хүчит Бурхан бол махбод дахь Бурхан, эцсийн өдрүүд дэх Христийн илрэлт гэдгийг ажил, үг нь нотолдог. Хуурамч Христүүд бол мөн чанартаа муу ёрын сүнснүүд. Тэд үнэнийг илэрхийлж чадахгүй, хүн төрөлхтнийг аварч бүр ч чадахгүй. Зүгээр л хүмүүсийг төөрөлдүүлж, хорлохын тулд үндэслэлгүй худал хуурмаг, төөрөгдөл чалчдаг. Хуурамч Христүүдийг дагаж байгаа хэн боловч амийн хангалт юм уу Ариун Сүнсний ажлыг олж авч чаддаггүй. Хэчнээн удаан итгэсэн ч Бурханыг, эсвэл үнэнийг хэзээ ч ойлгохгүй, бас амь зан чанар нь хэзээ ч өөрчлөгдөхгүй. Үнэндээ хуурамч Христийг дагана гэдэг муу ёрын сүнс, чөтгөрийг дагаж байгаа хэрэг. Өөрсдийгөө Бурхан, Христ гэдэг хэрнээ үнэнийг илэрхийлж чаддаггүй хэн бүхэн хуурамч Христ, ов мэхтэй муу ёрын сүнс гэдэг нь гарцаагүй. Хуурамч Христ үнэнийг илэрхийлж, Бурханы ажлыг хийж чадахгүй. Тэд өөрсдийгөө Бурхан, Христ гэж хэчнээн их хэллээ ч тийм биш байдаг. Үнэн, худал хоёр тэнгэр, газар шиг ялгаатай. Христ гэж хэллээ гээд Христ болчихдоггүй. Энэ нь Түүний мөн чанар, хийдэг ажлаар тодорхойлогддог. Христ л үнэн, зам, амь. Христ үнэнийг, Бурханы зөвт байдлыг илэрхийлж, Бурханы Өөрийн ажлыг хийдэг. Христийн мөн чанараар энэ нь тодорхойлогддог” гэлээ. Жан ах бас ингэж хэлсэн, “Бурханы юм бүхэн цэцэглэнэ. Бурханы ажлыг хүмүүс яаж ч эсэргүүцэж, яллаж, үгүйсгэлээ гэсэн ямар ч хүн, эсвэл хүч энийг зогсоож чадахгүй. Христийн мөн чанарыг хэн ч үгүйсгэж чадахгүй. Христ бол Христ, бас ямагт Христ хэвээр байх болно. Эзэн Есүсийг ажиллаж байх үед Иудейн шашны удирдагчид, Ромын засгийн газар яллаж, эсэргүүцэж, загалмайд цовдолсон. Тэр үеийнхэн Эзэнийг голсон, гэхдээ одоо 2,000 жилийн дараа Эзэний сайн мэдээ ертөнцийн өнцөг булан бүрд түгж, Христ мөн гэдгийг нь шашны ертөнцийнхөн тэр аяараа хүлээн зөвшөөрч байна. Одоо эцсийн өдрүүдэд Төгс Хүчит Бурханыг ХКН болон шашны хүрээнийхэн улайран эсэргүүцэж, ялладаг ч үнэн зам, үнэн хоёр үргэлж хэвээр үлдэнэ. Эдгээрийг хэн ч үгүйсгэж чадахгүй! Төгс Хүчит Бурханы үг ертөнц даяар гэрчлэл хийн,

---

интернэтэд тавигдаад хэсэг хугацаа өнгөрлөө. Төгс Хүчит Бурханы үгээс Бурханы дуу хоолойг таньж, эргэн ирсэн Эзэн Есүс гэдгийг нь олж хараад, Түүн рүү эргэх хүмүүс олширч байна. Хуурамч Христүүдэд үнэн байдаггүй. Тэд хүмүүсийг байлдан дагуулж чадахгүй. Тэдний үг, үйл хэрэг ил тод байж болдоггүй, бас тэд хүн болгоныг эрж хай, судал гэж интернэтэд орж хэзээ ч зүрхлэхгүй, яагаад гэвэл хуурамч Христүүд харанхуй, ёрын муу байдаг, гэрэлтэй байж чаддаггүй. Тэд мэдлэггүй, мунхаг хүмүүсийг далдаас төөрөлдүүлэн, зүгээр л өчүүхэн тэмдэг, гайхамшиг үзүүлж, үндэслэлгүй худал үг чалчдаг. Хуурамч Христ, муу ёрын сүнсний юу ч удаан үргэлжилж чадахгүй. Тэдгээр нь удалгүй тарж бутран, алга болно” гэлээ.

Хуурамч Христүүд, жинхэнэ Христийг ялган таних тухай үнэнийг энэ нөхөрлөл надад харуулсан. Би ч бөөн баяр боллоо. Христ л үнэн, зам, амь. Христ л үнэнийг илэрхийлж, Бурханы Өөрийн ажлыг хийж чаддаг. Өөрсдийгөө Христ гэдэг ч үнэнийг илэрхийлж, хүн төрөлхтнийг аварч чаддаггүй хэн боловч хуурамч Христ мөн. Үүнийг мэдэх сайхан байсан! Би пасторыг сохроор шүтэж, хэлсэн үгэнд нь үргэлж итгэдэг байсан юм. Хуурамч Христээс болж төөрөлдөх вий гэж айгаад Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг эрж хайж зүрхлээгүй. Чуулган, пастортойгоо зууралдах нь аюулгүй сонголт, тэгснээр Эзэнийг ирэх үед хаанчлалд нь орно гэж бодсон. Пастор, ахлагчид үргэлж Эзэн ирсэн тухай ямар ч мэдээ худал гэгцгээн, үнэн замыг судлахад минь бидэнд саад хийдэг байж. Тэд ов мэхтнүүд, сохор замчид гэдгийг одоо би олж харлаа. Би ч мунхаг байж. Эзэний дуу хоолойг сонсолгүй зүгээр л тэдэнд эргэлзээгүй итгэсэн. Нуухыг нь авах гээд нүдийг нь сохлох гэгч болж, хаалгаа хаан, Эзэнийг угтан авах боломжоо алдах шахлаа. Тун дөхсөн байж шүү!

Дараа нь би Төгс Хүчит Бурханы үгийг илүү их уншиж, бие махбодтой болохын нууц, Бурхан, хүн хоёрын ажлын ялгаа, Библийн дотоод түүхийн талаар илүү их зүйл сурсан. Энэ үнэхээр гэгээрэлтэй байлаа. Төгс Хүчит Бурхан эргэн ирсэн Эзэн Есүс мөн гэдэгт би бат итгэж, Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн зөвшөөрсөн юм даа.

## **26. Зүрх сэтгэлийнхээ үүдийг нээж, Эзэнийг эргэн ирэхэд угтан авах нь**

Ёнюань, АНУ

1982 оны 11-р сард манайх гэр бүлээрээ АНУ руу цагаачиллаа. Өвөөгийн минь үеэс хойш манай гэр бүлийнхэн Эзэнд итгэж ирсэн учраас АНУ-д очсоныхоо дараахан,

---

мөргөлд оролцохын тулд Нью-Йоркын хятад хороолол дахь нэгэн хятад чуулганыг олсон билээ. Бид ганц ч мөргөл алгасалгүй явсан бөгөөд Бурханы ерөөл, хамгаалалтыг эрж хайхын тулд ээж, эгч хоёр маань зав л гарвал судрыг тун сайн уншдаг байв. Тухайн үед тахилч: “Эзэн ирэхдээ хүмүүсийг ил тод шүүж, ангилан хуваана: Үнэхээр гэмшиж, нүглээ улайж, итгэлээ хэрэгжүүлдэг хүмүүс тэнгэр лүү явж чадна; ноцтой бус, багахан нүгэл үйлддэг хүмүүс ариусгалын зовлон амсах боловч мөн л аврагдаж, тэнгэрт гарч чадна; Эзэнд итгэдэггүй юм уу хэтэрхий ноцтой нүгэл үйлддэг хүмүүс тамын шийтгэлийг хүртэнэ” гэж үргэлж хэлдэг байлаа. Эдгээр үг зүрх сэтгэлд минь сийлэгдсэн мэт гүн гүнзгий сэтгэгдэл үлдээсэн юм. Эдгээрээс үүдэн би Эзэнд урам зоригтойгоор итгэсэн бөгөөд хэчнээн завгүй байлаа ч гэсэн мөргөлд явахаа хэзээ ч болиогүй билээ.

Яах ийхийн завдалгүй 2014 он гарлаа. Нэг өдөр нэгэн мөргөлчин надад гэнэт “Танай эгч одоо Төгс Хүчит Бурханд итгэж байгаа...” гэж хэлэв. Тэрээр Төгс Хүчит Бурхан болон Төгс Хүчит Бурханы Чуулганыг гүжирдэж, ялласан өөр олон зүйл хэлсэн билээ. Энэхүү гэнэтийн мэдээг сонсоод сэтгэл минь ихэд түгшиж, эгч минь замаа алдсан байх вий гэж тун их санаа зовсон юм. Эгч минь эцсийн өдрүүд дэх Төгс Хүчит Бурханы ажлыг хүлээн зөвшөөрсөн тухай мэдээ чуулган даяар хурдан түглээ. Намайг эгчээсээ зай барь гэж тахилч захисан бөгөөд чуулганы хэд хэдэн гишүүн ч бас нүүрэн дээр минь Төгс Хүчит Бурханыг гүжирдэж, ялласан зүйлс хэлсэн юм. Тахилч, мөргөлчид надад олон удаа “тусалсны” дараа би тэдний үгэнд итгэж эхэлсэн бөгөөд эгч маань замаа алдчихаж гэж үзэв. Би эгчийнхээ үгийг дахиж сонсохгүй, мөн боломж олдвол эгчийг Эзэнд гэмшүүлэхийн тулд бүлэгтээ эргүүлэн авчирна гэж тахилч, мөргөлчдөд хэллээ. Би гэртээ хариад ах дүүс рүүгээ утасдсан бөгөөд тэд миний талд оров. Бид бүгдээрээ хамт эгчийг ятгах гэж оролдсон ч, эгч маань Төгс Хүчит Бурханд тууштай итгэсээр байсан төдийгүй, Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн гэж бидэнд гэрчлэл хийлээ. Бурханы авралыг хүртэх боломжоо алдахгүйн тулд эцсийн өдрүүд дэх Бурханы ажлыг хүлээн зөвшөөр гэж эгч биднийг ятгахаар хичээсэн юм. Гэвч зүрх сэтгэл минь тахилч, мөргөлчдийн итгүүлсэн сөрөг санаагаар аль хэдийн дүүрсэн байв. Эгч минь надад яаж ч нөхөрлөж, яаж ч гэрчлэл хийлээ гэсэн би ер сонссонгүй.

Дараа нь ээж бид хоёр Төгс Хүчит Бурханд итгэснээс нь болоод эгчтэй хэд хэдэн удаа маргалдсан боловч эгч минь юу ч гэж хэлсэн бай, би интернэтээс уншсан цуу яриа болон тахилчид итгэсээр байсан бөгөөд Төгс Хүчит Бурханы ажлыг эрж хайж, судалж огт зүрхлээгүй юм. Бидний маргаан хэзээ ч бүтэлтэй болдоггүй байсан боловч ээж минь яваандаа эгчийн нөхөрлөл, гэрчлэлтэй санал нийлж эхэлснийг би анзаарлаа. Ээж үнэндээ эгчтэй минь хамт “нэгдсэн фронт” байгуулсан бөгөөд эцэстээ Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүд дэх ажлыг хүлээн зөвшөөрөв. Ээж минь ч бас Төгс Хүчит Бурханд итгэдэг болсныг



---

хараад би санаа зовж эхэллээ. Энэ нь үнэхээр тахилч, мөргөлчдийн хэлсэн шиг байгаад, гэр бүлд маань ямар нэг зүйл тохиолдвол яах билээ? Цөхөрсөндөө би, эгч бид хоёрын хэн хэнтэй нь сайн харилцаатай байсан Чианьхэ эгчийг олж уулзахаар явсан ба тэр эгчээр ээж, эгч хоёроо ятгуулсан юм. Гэвч тэр эгч манай ээж, эгч хоёрыг ятгаж чадаагүйгээр зогсохгүй, өөрөө ч бас Төгс Хүчит Бурханд итгэх болов. Энэ нь надад тун хачин санагдлаа: Энэ эгч шулуун шударга, урам зоригтой эрэлч байсан, гэтэл яахаараа тэр хоёрыг ятгаж чадаагүйгээр зогсохгүй, өөрөө Төгс Хүчит Бурханд итгэдэг болчихов оо? Төгс Хүчит Бурханы үг үнэхээр тийм их хүч чадалтай гэж үү? Төгс Хүчит Бурханы үг үнэхээр хүний амийг хангаж чаддаг юм болов уу? Гэвч Төгс Хүчит Бурханыг дайрч давшилсан тахилч, мөргөлчдийн үгийг санаж, Төгс Хүчит Бурханы Чуулганыг эсэргүүцэж, ялласан зүйл интернэтээс харснаа бодмогц зүрх сэтгэлдээ дахин айдас мэдэрч, тэдэнтэй цаашид холбогдсонгүй. Үүний дараа ээжтэйгээ уулзахаар очих минь ховордлоо. Би хааяа нэг зочилж оччихоод яаран буцдаг байсан бөгөөд ээж, эгч хоёрынхоо нөхөрлөлийг сонсохоос татгалздаг байв. Ээж, эгч бид гурвын хоорондох энэхүү “хүйтэн дайн” ийм маягаар жил хагас үргэлжилсэн билээ.

2016 оны 3-р сарын нэгэн өдөр, чуулганы зарим нэр нөлөө бүхий гишүүд ч бас эгчийг ятгахаар явсан тухай сонсоод би эгч минь зүрх сэтгэлээ өөрчилсөн эсэхийг харахаар очихыг хүслээ. Эгчтэйгээ уулзаад би юу бодож байгааг нь асуув. Эгч минь надад: “Би Хурганы мөртэй хөл нийлүүлж, Төгс Хүчит Бурханы зам бол үнэн зам гэдгийг баталгаажуулсан. Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн бөгөөд би Төгс Хүчит Бурханыг яавч орхихгүй” гэлээ. Эгчийн туйлбартай харц болон цангинасан, хүчирхэг хариулт зүрх сэтгэлийг минь бага зэрэг хоёрдуулж, сонирхол төрүүллээ. Тэгээд би ингэж бодов: “Манай гэр бүлийнхнээс эгч минь хамгийн гал цогтойгоор эрж хайдаг, чуулган дотроос бол Чианьхэ эгч ч гэсэн сайн эрж хайдаг, ялган таних чадвартай хүн. Ээж минь ч бас Эзэнд үргэлж тууштай итгэж ирсэн. Одоо тэд бүгд Төгс Хүчит Бурханд итгэгчид болж, Төгс Хүчит Бурханыг дагасны дараа итгэл нь улам нэмэгдсэн байна. Тэд улам их мэдлэг ухаантай ярьж байсан бөгөөд хэн ч тэднийг ганхуулж, няцааж чадахгүй байсан. Ийм олон хүний эсэргүүцлийн өмнө ийм их итгэлтэй хэвээр байх боломжийг ямар хүч тэдэнд олгосон юм бол? Эцсийн өдрүүд дэх Төгс Хүчит Бурханы ажил үнэхээр үнэн зам юм болов уу? Төгс Хүчит Бурхан үнэхээр эргэн ирсэн Эзэн юм болов уу? Манай эгч, ээж, Чианьхэ эгч Төгс Хүчит Бурханыг хүлээн зөвшөөрснөөс хойш бараг хоёр жил болох гэж байгаа атал тэдний хувьд бүх зүйл зүгээр байгааг хараад би, тахилч болон интернэтээр уншсан зүйлсийн минь айлгаж, түгшээх тактик тэдний хувьд биелээгүйг харж байна...” Үүнийг ухаараад зүрх сэтгэл минь бага зэрэг зөөлөрч, Төгс Хүчит Бурханы үг, ажлыг судлах хүсэл төрлөө. Энэ бодлоо би эгчтэйгээ хуваалцав. Эгч тун баяртайгаар зөвшөөрч,

---

намайг ээжийн гэрт урьсан ба Төгс Хүчит Бурханы Чуулганы нэг эгч эцсийн өдрүүд дэх Төгс Хүчит Бурханы ажлын талаар надтай нөхөрлөж, гэрчлэл хийх байлаа.

Амралтын өдрүүдээр би ээжийн гэрт очив. Манай эгч, Чианьхэ эгч болон Төгс Хүчит Бурханы Чуулганы Жан Шиао гэх эгч бүгд тэнд байв. Намайг эрж хайж, судлахыг хүссэн гэж сонсоод Чианьхэ эгч тун их баяртай байсан юм. Тэрээр надад ингэж нөхөрлөлөө: “Бурхан эцсийн өдрүүдэд ирдгийн гол шалтгаан нь биднийг нүглийн хүлээсээс аврахын тулд үг илэрхийлж, хүмүүсийг шүүж, цэвэрлэх ажил хийх явдал юм. Одоо Нигүүлслийн эрин үе дэх хүмүүс нүгэл үйлдээд, дараа нь нүглээ улайх мөчлөгт амьдарч байна. Бид тууштайгаар мөргөлд оролцож, судар уншиж, түүнчлэн тахилчид нүглээ улайдаг боловч худал хэлж, хууран мэхэлж, биеэ тоосон байдал, шунал, аминч байдал зэрэг завхарсан зан чанарынхаа дунд амьдарсан хэвээр байна. Бид өөрсдөө ч мэдэлгүй нүгэл үйлдэж, Бурханыг эсэргүүцдэг бөгөөд энэхүү нүгэлт уг чанарын хүлээсээс ангижирч чаддаг хэн ч үгүй, мөн нүглээ улайж, гэмших замаар цэвэр, ариун байдалд хүрч чадах хүн ч байхгүй. Тийм учраас эцсийн өдрүүдэд Бурханы хийхээр ирсэн, хүмүүсийг шүүж, цэвэрлэх ажлыг бид мөн л хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Ингэснээр л бид нүглийн хүлээсээс бүрэн ангижирч, цэвэрлэгдэж, өөрчлөгдөж, Бурханы авралыг хүртэж чадна.” Үүнийг сонсоод гайхаж будилсан би: “Хүмүүс бага нүгэл үйлдвэл, Эзэн хүмүүсийг ил тод шүүхээр эргэн ирэх үед ариусгалын ертөнцөд зовж дуусаад тэнгэрт гарч чадна. Ноцтой нүгэл үйлддэг хүмүүс шийтгүүлэхээр там руу шууд явна’ гэж тахилч байнга хэлдэг. Гэтэл Бурханы эргэн ирээд хийх шүүлтийн ажил нь хүмүүсийг цэвэрлэж, аврахын төлөө байдаг гэж та яаж хэлж чадаж байна аа?” хэмээн асуулаа. Чианьхэ эгч: “Би ч гэсэн тахилчийн үгэнд итгэдэг байсан. Эзэн шүүлтийн ажил хийхээр хэрхэн эргэн ирэх тухай би ч гэсэн чамтай адил үзэлтэй байсан, гэхдээ энэ талаар одоо бодоход тахилчийн хэлсэн зүйл үнэндээ Библитэй нийцдэг үү? Энэ нь Бурханы үгэнд тулгуурласан уу? Эзэн Есүс ариусгалын ертөнц байдаг гэж хэлсэн үү? Багахан нүгэл үйлддэг хүмүүс ариусгалын ертөнц дэх зовлонгоо дуусгаад тэнгэр лүү гарч чадна, ноцтой нүгэл үйлддэг хүмүүс л там руу явна гэх тухай Тэрээр ямар нэг зүйл хэлсэн үү? Мэдээж үгүй! Тэгвэл эдгээр үг хаанаас гаралтай вэ? Мэдээж эдгээр нь хүмүүсийн үзэл, төсөөллөөс гардаг бөгөөд зүгээр л хүний таамаглал, эргэцүүлэл юм. Эдгээр нь Бурханы үгтэй огт нийцдэггүй, Бурханы ажлын бодит байдалтай ч таардаггүй. Үүнийг баримтлах нь бидэнд ямар хэрэгтэй юм бэ?” гэж хариулав. Эгчийн нөхөрлөлийг сонсоод би чимээгүйхэн толгой дохив. Эгч цааш үргэлжлүүлэн: “Бид одоо нүглээр дүүрэн байгаа, цэвэр ариун хүн ганц ч байхгүй. Тахилчийн хэлсэн зүйлд тулгуурлавал, Эзэн бүх хүнийг ил тод шүүхээр эргэн ирэх үед багахан нүгэл үйлддэг хүмүүс ариусгалын ертөнц рүү явж, харин ноцтой нүгэл үйлддэг хүмүүс там руу явна. Ийм тохиолдолд бид бүгд яллагдаж, там руу явах шийтгэл хүлээх бус уу? Хүн төрөлхтнийг аврах Бурханы ажил

---

бүгд талаар өнгөрөх бус уу? Эзэн эргэж ирэх ямар хэрэг байх юм бэ?” гэж хэлэв. Эгчийн нөхөрлөсөн зүйлд зүрх сэтгэлийг минь хөдөлгөлөө. Энэ үнэн шүү—бид Бурханд итгэдэг ч гэсэн байнга нүгэл үйлдэж, нүглээ улайхаас өөрийг хийдэггүй бол хэн ч цэвэрлэгдэхгүй. Үнэндээ Бурханыг харахад хэн ч тохирохгүй бөгөөд Бурхан хүмүүсийг ил тод шүүж, яллаж, шийтгэхээр ирсэн бол хүн бүр там руу явах ёстой болно. Хэн ч аврал хүртэж чадахгүй... Тэр үед л би “Эзэн бүх хүнийг ил тод шүүхээр дахин ирэх үед томоохон нүгэл үйлддэг хүмүүс шууд там руу явах бол багахан нүгэл үйлддэг хүмүүс ариусгалын ертөнц рүү явж, зовлонгоо дуусгасныхаа дараа тэнгэр лүү гарна” гэх үг хэчнээн бодитой бус болохыг ухаарлаа. Энэ нь хүн төрөлхтнийг аврах Бурханы хүсэлтэй огт нийцдэггүй. Чианьхэ эгч тэгээд ингэж хэллээ: “Эцсийн өдрүүд дэх Бурханы шүүлтийн ажлын тухайд гэвэл, Төгс Хүчит Бурханы үгэнд үүнийг хэрхэн дүрсэлсэн байдгийг харцгаая! Төгс Хүчит Бурхан ингэж хэлдэг: **‘Бурхан хөнөөх юм уу устгахын тулд ирээгүй, харин шүүж, харааж, гэсгээж, аврахын тулд ирсэн юм. Түүний 6,000 жилийн удирдлагын төлөвлөгөө төгсөх хүртэл—Тэрээр төрөл бүрийн хүний төгсгөлийг илчлэхээс өмнө—газар дээрх Бурханы ажил авралын төлөө байх болно; үүний зорилго нь гагцхүү Өөрийг нь хайрладаг хүмүүсийг бүрмөсөн бүрэн төгс болгож, Өөрийн ноёрхол дор аваачихын төлөө байдаг. Бурхан хүмүүсийг хэрхэн авардаг нь хамаагүй, энэ нь бүхэлдээ, тэднийг хуучин сатанлаг уг чанараас нь салгаснаар хийгддэг; өөрөөр хэлбэл, тэднээр амийг эрж хайлгуулснаар Бурхан тэднийг авардаг. Хэрвээ тэгэхгүй бол Бурханы авралыг хүлээн авах ямар ч аргагүй байх болно’** (Үг нь махбодоор илэрсэн номын “Та нар байр суурийн ерөөлийг хойш тавьж, хүнийг аврах Бурханы хүслийг ойлгох ёстой”). **‘Эцсийн өдрүүдэд Христ хүнийг сургах, хүний мөн чанарыг ил болгох, хүний үг болон үйлдэлд нь дүн шинжилгээ хийхийн тулд төрөл бүрийн үнэнийг хэрэглэдэг. Хүний үүрэг, хүн яаж Бурханд дуулгавартай байх ёстой, хүн яаж Бурханд үнэнч байх ёстой, хүн яаж хэвийн хүн чанарыг амьдран харуулах учиртай болон Бурханы мэргэн ухаан, зан чанар гэх зэрэг төрөл бүрийн үнэн эдгээр үгэнд агуулагддаг. Эдгээр үг нь бүгд хүний мөн чанар болон ялзарсан зан чанар луу чиглэдэг. Ялангуяа, хүн Бурханыг хэрхэн голдгийг илчилсэн үгсийг хүн бол Сатаны биелэл, Бурханы эсрэг дайсны хүч болдог тухайд хэлсэн байдаг. Шүүлтийн ажлаа хийхдээ Бурхан хүний уг чанарыг ердөө хэдхэн үгээр тодорхой болгодог юм биш; Тэрээр удаан хугацааны туршид илчилж, харьцаж, засдаг. Илчлэл, харьцалт болон засалтын эдгээр аргыг энгийн үгээр бус, харин хүнд огт байдаггүй үнэнээр л орлуулж болно. Зөвхөн ийм төрлийн арга барилыг л шүүлт гэж нэрлэж болно; ийм төрлийн шүүлтээр л дамжуулан хүн номхорч, Бурханд захирагдахаар бүрэн үнэмшээд зогсохгүй, Бурханы тухай жинхэнэ мэдлэгийг олж авч чаддаг. Шүүлтийн ажлын авчирдаг зүйл гэвэл Бурханы жинхэнэ дүр төрх болон өөрийнх нь тэрслүү байдлын**

---

**үнэний талаарх хүний ойлголт юм. Шүүлтийн ажил нь хүнд Бурханы хүслийн тухай, Бурханы ажлын зорилгын тухай, хүний ойлгошгүй нууцуудын тухай ихээхэн ойлголт олж авах боломж олгодог. Түүнчлэн, өөрийн ялзарсан мөн чанар болон ялзралынхаа үндсийг таньж мэдэх, хүний муу муухайг нээн илрүүлэх боломжийг олгодог. Энэ бүх үр дүнг шүүлтийн ажил авчирдаг, учир нь энэ ажлын мөн чанар нь үнэндээ Бурханы үнэн, зам, амийг Түүнд итгэдэг бүх хүнд нээх ажил юм. Энэ ажил нь Бурханы хийдэг шүүлтийн ажил билээ’ (Үг нь махбодоор илэрсэн номын “Христ шүүлтийн ажлыг үнэнээр хийдэг”).”**

Бурханы үгийг уншсаны дараа Жан Шио эгч ингэж нөхөрлөлөө: “Эцсийн өдрүүд дэх шүүлтийн ажлын утга учир, шүүлтийн нарийн уг чанар болон шүүлтийн ажлын хүнд үзүүлэх үр дүнг Төгс Хүчит Бурханы үг тов тодорхой болгодог. Бурханы шүүлтийн ажил нь бидний үзэл, төсөөлөлд байдаг шиг хүмүүсийг хөнөөж, шийтгэх явдал биш юм. Харин энэ ажил нь хүмүүсийн бодол, үг яриа, үйлдлийг ил болгож, Бурханыг эсэргүүцдэг гүн гүнзгий шингэсэн сатанлаг, завхарсан уг чанарыг маань үндсээр нь устгахын тулд үгийг ашигладаг. Энэ нь Сатан биднийг хэрхэн завхруулсан тухай үнэнийг мэдэх боломж олгохын зэрэгцээ Бурханы зөвт, ариун зан чанарыг мэдүүлдэг. Бид эдгээр зүйлийг ойлгоод, өөрсдийгөө үзэн ядаж эхлэх үед энэ нь жинхэнэ гэмшлийг бий болгож, Бурханыг үнэхээр хүндэлдэг зүрх сэтгэлийг төрүүлдэг. Бурханы үгийн шүүлтээр дамжуулан бид үнэнийг илүү сайн ойлгож, олж авч чаддаг ба аяндаа үнэнд найдан амьдарч чаддаг. Ийм маягаар бидний дотроо хадгалдаг ямар ч сатанлаг зүйл аажмаар хаягдаж, бид Бурхантай эв зохицолтой байж чадна. Тэр үеэс эхлэн бид Бурханы эсрэг тэрсэлж, Бурханыг эсэргүүцэхээ болиод, харин Бурханыг үнэхээр дуулгавартай дагаж чадна—энэ л аврал хүртэж байгаа хэрэг юм. Сатанаар завхруулагдсанахаа дараа бид хүний төрхтэй байхаа больж, хэвийн хүнд байх учиртай мөс чанар, эрүүл ухаанаа алдсан. Харин ч биеэ тоосон, өөртөө итгэлтэй, хувиа хичээсэн зан болон сатанлаг зан чанарын бусад талаар дүүрэн байдаг. Аливаа зүйлд хандах бидний хандлага, үзэл ч бас Бурхантай нийцэлгүй болдог. Жишээлбэл: Эцсийн өдрүүд дэх Бурханы шүүлтийн ажилтай тулгарах үедээ бид бүгд өөр өөр зүйлийг хүлээн зөвшөөрдөг бөгөөд Бурханы үгэнд үндэслэсэн эсэхээс үл хамааран өөрсдийн үзэлтэй зууралддаг. Бид Бурханы хүслийг эрж хайдаггүй, харин өөрсдийн маань боддог арга зам зөв гэж сохроор итгэдэг. Бурханы ажил үзэл, төсөөлөлтэй маань нийцэхгүй үед бид Бурханы талаар өөрсдийн дүгнэлтийг хийж, Түүнийг үгүйсгэж, Түүн рүү дайрч давшилж, Түүнийг ялладаг. Энэ нь биеэ тоосон зан чанарын маань үр дүн юм. Бид ийм сатанлаг уг чанартай болохоор Бурханыг эсэргүүцэхэд амархан байдаг, иймээс Бурхан шүүлтийн ажлын үе шатыг яаралтай хэрэгжүүлж, бидний сатанлаг зан чанарыг цэвэрлэж, өөрчлөх шаардлагатай. Үүнгүйгээр хэн ч завхралаас ангижирч, аврал хүртэж

---

чадахгүй.”

Төгс Хүчит Бурханы үг болон эгчийн нөхөрлөлийг сонсоод гэнэт зүрх сэтгэл цэлмэж, эдгээр үгийг маш сайн хэлжээ гэж санагдлаа. Хэдийгээр зарим зүйлийг би сайн ойлгоогүй ч эдгээр үг надад Бурханы ажил маш ухаалаг болохыг, мөн Бурхан хүнийг үнэхээр их хайрладгийг мэдрүүлэв. Урьд нь, Бурхан хүн төрөлхтнийг шүүхээр ирэх тухайд, хүмүүс нэг бол там руу явж, эсвэл ариусгалын ертөнцийн тарчлааныг амсана гэж би боддог байсан юм. Үнэн хэрэгтээ, Бурханы шүүлтийн ажил нь бидний төсөөлсөнтэй огт адилгүй, харин ч энэ нь, үнэнийг бодитоор илэрхийлж, шүүлтийн ажлыг явуулахын тулд Бурхан махбодоор ирэх явдал юм. Ингэж Тэр хүмүүсийг цэвэрлэж, авардаг. Бурханы шүүлтийн ажил үнэхээр утга учраар дүүрэн юм. Энэ нь завхарсан хүн төрөлхтөн бидэнд яг хэрэгтэй зүйл билээ!

Энэ бүхнийг би маш их сонирхон сонсож байтал манай нөхөр машин хэрэгтэй байна гэж хэлэхээр гэнэт залгав. Энэ удаад үүнийг сонсож чадна гэдгийг минь ээж хараад намайг яг явах гэж байхад “Хурганы нээсэн хуйлмал ном” гэдэг ном өгч, үүний доторх үг бол Бурханы Өөрийн дуу хоолой юм гэж хэллээ. Ээж бас Төгс Хүчит Бурханы үгийг уншихыг надад зөвлөсөн юм. Гэртээ харьсныхаа дараа би цаг зав гарах бүрд тэр номыг уншдаг байлаа. Төгс Хүчит Бурханы үгийг уншсанаар би олон үнэнийг ойлгож, нэлээд их мэдлэгтэй болсон юм. Үүний зэрэгцээ хүмүүсийн сэтгэлийн гүнийг Бурхан ажиглаж байдаг гэдгийг би үнэхээр мэдрэлээ. Төгс Хүчит Бурханы үг бүр зүрх сэтгэлийг минь шууд нэвтэлж, дотоод завхарсан уг чанарыг минь илчилсэн юм. Заримдаа би, Бурханы үг бидний завхралыг хэрхэн илчилдгийг харах үедээ Бурхан бидний завхралыг тун их жигшдэгийг мэдрэсэн билээ. Бурхан бидэнд уур хилэнгээ илэрхийлж байгаа мэт байдаг бөгөөд хөшүүн, мэдрэмжгүй зүрх сэтгэл минь тэр дороо хөдөлсөн юм. Зүрх сэтгэлдээ би Бурханыг биширч, айх зүйлгүй нүгэл үйлддэг байсан урьдынхтайгаа адилгүй болов. Төгс Хүчит Бурханы шүүлтийн ажил үнэхээр хүмүүсийг нүглээс аварч, нүглээс чөлөөлж чаддаг юм байна гэдгийг би Бурханы үгийнс Хүчит Бурханы шүүлтийн ажил үнэхээр хүмүүсийг нүгсан юм. Бурханы ажил болон үг хэчнээн бодитой юм бэ! Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд Бурханы ажлыг яаж эсэргүүцэж байснаа бодоод би асар их гэмшив. Би маш мунхаг, мэдлэггүй байсандаа, мөн Эзэний хоёр дахь ирэлт шиг агуу асуудлыг ойлгож, судлахаар эрэлхийлээгүйдээ өөрийгөө үзэн ядсан юм. Харин ч би тэдгээр цуу ярианд сохроор итгэн, Бурханд хаалгаа хааж, Бурханыг яллаж, эсэргүүцжээ. Би эцсийн өдрүүд дэх Эзэний авралыг алдах дөхжээ. Би үнэхээр маш сохор байж! Төгс Хүчит Бурханы эсрэг гүтгэлэг, шүүлт, доромжлол болон Төгс Хүчит Бурханы Чуулганыг гутаасан зүйлс нь бүгд Сатаны худал хуурмаг байсныг би тодорхой харлаа. Эдгээр нь хүмүүсийг будилуулж, урхидаж, эцсийн өдрүүд дэх Бурханы ажлыг хүлээн зөвшөөрөхөд нь саад хийхээр Сатаны

---

тусгайлан ашигладаг арга мэх юм. Би Сатаны худал хуурмагт цаашид итгэхгүй. Ирээдүйд би юутай ч тулгарч, юу ч сонслоо гэсэн, үргэлж Бурханы үг болон бодит байдлын дагуу зөв, бурууг үнэлж дүгнэх болно. Би Сатаны худал хуурмаг, заль мэхийг сонсохоо болино, ингэснээр л хүн Бурханы хүсэлтэй нийцэлтэй байж чадна. Ингэж бодоод би надад хайрласан өршөөл, авралынх нь төлөө Төгс Хүчит Бурханд чин сэтгэлээсээ талархал илэрхийллээ. Бурхан тэрслүү байдал, эсэргүүцлээс минь болоод намайг аврахаа болиогүй, харин надад сайн мэдээ дамжуулж, намайг Бурханы гэрт буцаан аваачих хүмүүсийг байнга зохицуулсаар байсан. Бурханы хайр ямар агуу юм бэ! Би “Чин сэтгэлийн барилдлагын дуу” хэмээх клипний “Бие махбодтой болсон Бурхан гэх Нэгэн байдаг. Түүний хэлдэг, хийдэг бүхэн нь үнэн байдаг. Түүний зөвт байдал, мэргэн ухааныг би ихэд хайрладаг. Түүнтэй уулзаж, Түүнийг дуулгавартай дагана гэдэг үнэхээр ерөөл” гэх үгийг сонсох болгонд зүрх сэтгэл ихэд хөдөлж, урам зориг авдаг юм. Эзэний эргэн ирэлтийг угтан авч, Бурханы үгтэй шууд учирсан минь хэчнээн азтайг би мэдэрдэг. Энэ хэчнээн агуу ерөөл вэ!

Дараа нь би Төгс Хүчит Бурханы Чуулганы амьдралд оролцож эхэлсэн билээ. Ах эгч нар хамтдаа магтан дуу дуулж, бүжиглэж, Бурханыг магтдаг. Тэд Бурханы үгийг уншиж, ямар нэг завхрал илчлэгдвэл зүрх сэтгэлээ нээж, энэ тухай нөхөрлөдөг. Хүн бүр Төгс Хүчит Бурханы үгийн тухай мэдлэг, туршлагаа хэлэлцэж, хэрэгжүүлэх, орох замыг эрж хайдаг. Чуулганы ийм амьдрал нэн эрх чөлөөтэй бөгөөд би асар их хангалт авдаг юм. Ариун Сүнсний ажиллаж байгаа ийм чуулган л Бурханы гэр байж болохыг би үнэхээр ухаарсан билээ. Энэ бол миний харьяалагддаг газар. Төгс Хүчит Бурхан бол хоёр дахиа ирсэн Эзэн мөн гэдгийг би одоо бүрэн дүүрэн тогтоосон ба эцсээ хүртэл Төгс Хүчит Бурханыг дагахаар шийдсэн!

## **27. Эзэнтэй дахин уулзсан нь**

Жиандин, АНУ

Би Католик шашинтай гэр бүлд төрсөн бөгөөд бага байхаас минь эхлээд манай ээж Библи уншихыг заасан юм. Тэр үед Хятадын Коммунист Нам иргэний дайны дараа үндэстнээ сэргээн босгож байсан бөгөөд ХКН бүх шашныг дарангуйлж байхад би 20 настайдаа л анх удаа чуулганд очиж, номлол сонсох боломжтой болсон билээ. Тахилч бидэнд байнга ингэж хэлдэг байлаа: “Католик шашинтнууд бид зохих ёсоор нүглээ улайж, гэмшдэг байх ёстой. Бид мууг бус, сайныг хийж, үргэлж цугларалтад явдаг байх ёстой. Эцсийн өдрүүдэд Эзэн ирж, хүн бүрийг шүүж, газар дэлхий дээр хэрхэн үйлдэж, биеэ авч

---

явж байсных нь дагуу тэнгэр лүү юм уу там руу илгээх болно. Хамгийн том нүгэлтнүүд үүрд тамд шийтгүүлнэ, харин бага нүгэл үйлдсэн хүмүүс өөрсдийн нүглийг Эзэнд улайж, гэмшиж байгаа цагт тэнгэр лүү явж мөн л чадна. Эзэнд итгэдэггүй хэн боловч хэчнээн сайн байх нь хамаагүй хэзээ ч тэнгэр лүү явахгүй.” Үүнийг сонсох болгондоо би үргэлж өөрийгөө азтайд тооцон, Католик шашны цуглааны гишүүн болж төрсөндөө өөртөө баяр хүргэдэг байв. Хичээнгүйлэн эрэлхийлж, цугларалтад илүү их оролцож, нүглээ Эзэнд илүү их улайж, гэмших ёстой, ингэснээр би тамд зоволгүй, тэнгэр лүү явах болно гэж би өөртөө үргэлж хэлдэг байв. Тиймээс тэр үеэс би чуулганд явж, цугларалтад тогтмол оролцдог болохоор шийдсэн юм. Тухайн үед тахилч маань бидэнд, 2000 онд Эзэн эргэн ирнэ гэж бас хэлсэн бөгөөд энэ мэдээ нь бид бүгдийг маш их баярлууллаа. Тиймээс бид бүгдээрээ чин сэтгэлээсээ эрэлхийлж, Эзэний эргэн ирэхийг хүлээж эхэлцгээв. Гэтэл 2000 он болоод өнгөрөх үед бид Эзэний эргэн ирэлтийн ямар ч тэмдгийг харсангүй. Манай шашны цуглааны олон хүн итгэл үнэмшлээ алдаж, цугларалтад оролцох хүмүүсийн тоо улам бүр цөөрсөөр байв. Надад ч бас төөрөлдсөн мэдрэмж төрсөн боловч бусад хүмүүс юу хийж байгаа нь хамаагүй Эзэнд итгэх итгэл маань ганхахгүй гэдгийг бас мэдэрсэн юм. Энэ нь үндсэндээ, олон удаа аюултай тулгарах үед минь Эзэн намайг хамгаалж, аюулыг арилгаж байснаас үүдэлтэй. Эзэний хамгаалалтгүйгээр би аль эрт үхэх байсан, иймээс би Эзэнд итгэх итгэлээ алдахуйц тийм талархалгүй хүн хэзээ ч болохгүй гэж шийдсэн юм.

Дараагийн жилүүдэд би эргэн тойрныхоо хүмүүсээс АНУ бол “газар дээрх диваажин” гэж сонсоод, улмаар тийшээ очихыг маш их хүсэх болсон юм. 2014 оны 12 дугаар сард манай гэр бүлийнхэн бүгд АНУ руу цагаачилсан ч эндхийн бодит амьдрал миний бодсон шиг сайхан биш байлаа. Эхлээд АНУ дахь бүх зүйл танил бус санагдаж, бид хэнийг ч таньдаггүй байв. Хүрээлэн буй орчин, уур амьсгал нь Хятадад дассанаас минь маш өөр байсан бөгөөд бие маань ч төд удалгүй гомдоллож эхлэв. Надад үргэлж сул дорой, үлбэгэр санагддаг байсан ч эмнэлгийн эмч нар юу нь болохгүй байгааг олж чадахгүй байлаа. Би яахаа мэдэхгүй байсан тул Эзэнд улам чин сэтгэлээсээ залбирч эхлэн, Эзэн намайг хамгаална гэж найдаж байв. Би илүү их залбирч, цугларалтад явж болох чуулганыг хайж эхэлсэн бөгөөд эцэст нь Хятадын Христэд итгэгчдэд зориулсан чуулганыг олов. Гэвч тэр чуулганд хэдэн удаа явсныхаа дараа энэ нь нийгэмд өдөр тутам болдог зүйлээс ямар ч ялгаагүй болохыг олж мэдлээ: Цуглааны гишүүд гаднаа найрсаг байдаг ч тэдний харилцааг эрх мэдэл, мөнгө захирдаг байв. Чуулганд ийм нөхцөл байдалтай тулгарсандаа сэтгэл минь маш их гонсойв. Тэгээд би дотроо ингэж бодлоо: “Өө Эзэн минь, Та хэзээ эргэн ирэх юм бэ? Таныг эргэн ирэх үед сайн хүмүүс хорон муу хүмүүсээс тусгаарлагдаж, дэлхий цэвэрлэгдэх болно.” Хэдийгээр би цугларалтад явсан хэвээр байсан ч чуулганд Бурханы байгааг хэзээ ч мэдэрч чадаагүй юм. Энэ нь миний урмыг хугалж, сэтгэлээр

---

унагааж, Эзэнд итгэх итгэлд минь нөлөөлөв.

Гэхдээ 2015 оны 7 дугаар сарын нэгэн өдөр өөр мужид ажиллаж байх үед эхнэр минь над руу утсаар ярьсан юм. Тэрээр сэтгэл нь хөдөлсөн байдалтайгаар: “Эзэн эргэн ирсэн. Тэрээр үг илэрхийлж, эцсийн өдрүүдийн шүүлтийн ажлыг хийж байна! Хурдан эргээд ир, хоёулаа хамтдаа Бурханы шинэ ажлыг хүлээн авъя” гэв. Үүнийг сонсоод надад өөрийн эрхгүй бага зэрэг сэжиг төрлөө: Эзэн эргэн ирсэн гэнэ ээ? Энэ боломжтой гэж үү? Эзэн дэлхийн шүүхээр эргэн ирэх үед сайн хүмүүс муу хүмүүсээс тусгаарлагдах болно. Гэтэл яг одоо сайн, муу хүмүүс бүгд холилдсон байгаа шүү дээ. Тийм байтал эхнэр маань яагаад Эзэн эргэн ирсэн гээд байгаа юм бол? Эхнэр маань өөр шашны урсгалд орсон юм болов уу? Бид ихэнх амьдралынхаа туршид Католик шашинтнууд байсаар ирсэн, бид одоо үүнээс яасан ч хазайх ёсгүй! Тиймээс би хийж байсан ажлаа яаравчлан дуусгаж, гэр лүүгээ буцлаа.

Гэртээ хариад би эхнэрээсээ ингэж асуув: “Эзэн эргэн ирснийг чи яаж мэдэж байгаа юм бэ? Чи Католик итгэл үнэмшлээсээ хазайгаагүй биз дээ? Эзэн шүүлтийн ажил хийхээр эргэн ирсэн гэж чи хэлж байна, гэтэл яг одоо сайн, муу хүмүүс бүгд холилдсон хэвээр байгаа. Тэгэхээр Эзэн яаж аль хэдийн эргэн ирсэн байх юм бэ? Бид Эзэнийг эргэн ирэхийг тэсэн ядан хүлээж болно, гэхдээ бид Түүнд үнэнч бус байж болохгүй!” Эхнэр маань намайг сонсож байгаад тэвчээртэйгээр ийнхүү хариулав: “Битгий ингэж их санаа зов. Эзэн эргэн ирсэн тухай би өөрөө ч дөнгөж сая олж мэдлээ. Одоогоор Төгс Хүчит Бурханы Чуулган Эзэн эргэн ирснийг гэрчилж, Бурханы гэрээс эхэлсэн шүүлтийн ажлыг хийхийн тулд Төгс Хүчит Бурхан үнэнийг илэрхийлж байна. Яг юу болоод байгаа талаар би сайн мэдэхгүй байгаа ч Төгс Хүчит Бурханы илэрхийлсэн олон үгийг интернетээр уншлаа. Тэдгээр үг бүгд Бурханы дуу хоолой мөн гэдэгт би итгэлтэй байна. Эзэн нэг удаа: **‘Миний хонин сүрэг Миний дуу хоолойг сонсдог, Би тэднийг мэддэг бөгөөд тэд Намайг дагадаг’** (Иохан 10:27) гэж хэлсэн. Бид Төгс Хүчит Бурханы Чуулганд очиж, судлах замаар л Төгс Хүчит Бурхан нь эргэн ирсэн Эзэн мөн эсэхийг олж мэдэж чадна, тийм үү?” гэв. Эхнэрийн маань хэлсэн зүйл үндэслэлтэй сонсогдсон ба Эзэн шүүлтийн ажил хийхээр эргэн ирэхийг Библид зөгнөсөн байдаг тул эхнэртэйгээ хамт тэр чуулганд очиж, байдлыг харсныхаа дараа шийдвэрээ гаргахад буруудах зүйл байхгүй байв.

Ингээд эхнэр бид хоёр Төгс Хүчит Бурханы Чуулганы Жан ах хэмээх нэгэн гишүүний гэрт очихоор тохиров. Ван ах, Ли эгч болон зарим нэг Католик найзууд маань бас ирсэн юм. Нэлээд олуулаа байхыг хараад сэтгэл минь ихэд тайвшрав. Хэсэг хугацаанд эелдгээр ярилцсаны дараа бид бүгд сууцгааж, би ах эгч нараас ингэж асуув: “Эзэн эргэн ирсэн тухайд бол би ингэж ойлгож байна: Эзэн шүүлтийн ажил хийхээр эргэн ирэх үед сайн



---

хүмүүс хорон муу хүмүүсээс тусгаарлагдах болно. Тэгээд сайн хүмүүсийг Эзэн тэнгэр лүү хүлээн авч, тэд Түүнтэй уулзана, харин хорон муу хүмүүс там руу илгээгдэж, шийтгэгдэнэ. Та нар, Эзэн эргэн ирсэн бөгөөд шүүлтийн ажлыг хийж байгаа гэдэг, тэгвэл бид нар яагаад энэ бүх зүйл тохиолдож байгааг хараагүй байдаг билээ?” Жан ах ингэж хариулав: “Дүү минь, миний үзэл бодол чинийхтэй яг адил байдаг байсан. Би ч бас Эзэн эргэн ирнэ гэдэг нь сайн хүмүүс хорон муу хүмүүсээс тусгаарлагдаж, сайн хүмүүс үүрд мөнх тэнгэрт амьдарч, хорон муу нь шийтгэгдэнэ гэсэн үг, хэрэв бид ийм зүйл болохыг олж харахгүй бол Эзэн эргэн ирээгүй байгааг нотолж байна гэж итгэдэг байлаа. Гэвч Төгс Хүчит Бурханы үгийг уншсаны дараа энэ нь зөвхөн бидний үзэл бодол, төсөөлөл бөгөөд Бурханы ажилладаг бодит байдал биш гэдгийг ухаарсан юм. Бурхан эцсийн өдрүүдийн шүүлтийн ажлыг хэрхэн явуулах нь зөвхөн Бурханы ганцаараа төлөвлөж, зохион байгуулдаг зүйл юм. Бурханы мэргэн ухаан тэнгэрээс ч өндөр бөгөөд Бурханы нүдэнд хүмүүс тоосны ширхэг шиг өчүүхэн харагддаг, тэгэхээр бид яаж Бурханы ажлыг ухан ойлгож чадах билээ дээ? Библид ингэж хэлсэн байдаг: ‘Хэн Эзэний Сүнснийг удирдсан бэ? Эсвэл хэн Түүний зөвлөх байж, Түүнд заасан бэ?’ (Исаиа 40:13). ‘Харагтун, үндэстнүүд хувин доторх дусал мэт бөгөөд дэнсэн дээрх тоосны ширхэг гэж тооцогддог: харагтун арлууд өчүүхэн тоос мэт’ (Исаиа 40:15). Бодохдоо бид бүгд тархиа ашигладаг, иймээс бид Бурханы ажлын талаар хүссэнээрээ бодож болох ч Бурхан Өөрийнхөө ажлыг хэзээ ч бидний төсөөллийн дагуу хийдэггүй. Хэрэв бид Бурханы ажилд хэмжүүр тогтоохын тулд өөрсдийн төсөөллийг ашиглаж байгаа бол туйлын биеэ тоосон байдлаар авирлаж байгаа хэрэг биш гэж үү? Тэгвэл Бурхан шүүлтийн ажлаа хэрхэн хийдэг вэ? Тэрээр сайныг муугаас хэрхэн тусгаарладаг вэ? Үүнийг ойлгоход тус болох үүднээс Төгс Хүчит Бурханы үгээс хэдэн хэсгийг уншицгаая. Төгс Хүчит Бурхан ингэж хэлсэн байдаг: **‘Шүүлтийн ажил бол Бурханы Өөрийн ажил тул мэдээж үүнийг Бурхан Өөрөө хийх ёстой; хүн Түүний оронд хийж чадахгүй. Шүүлт бол үнэнийг ашиглан хүн төрөлхтнийг байлдан дагуулах явдал учраас, энэ ажлыг хүмүүсийн дунд хийхээр Бурхан дахиад л бие махбод болсон дүрээрээ гарч ирэх нь дамжиггүй юм. Өөрөөр хэлбэл, эцсийн өдрүүдэд Христ газар дэлхий даяарх хүмүүсийг сургахын тулд үнэнийг ашиглаж, бүх үнэнийг тэдэнд мэдэгдэнэ. Энэ бол Бурханы шүүлтийн ажил юм’** (Үг нь махбодоор илэрсэн номын “Христ шүүлтийн ажлыг үнэнээр хийдэг”). **‘Эцсийн өдрүүд аль хэдийн ирчихсэн. Бүтээлийн бүх зүйл төрлийнхөө дагуу ангилагдаж, уг чанарынхаа үндсэн дээр өөр өөр төрөлд хуваагдана. Энэ бол Бурхан хүмүүсийн төгсгөлийг, мөн хүрэх газрыг илчилдэг мөч юм. Хэрвээ хүмүүс гэсгээлт, шүүлт туулахгүй бол дуулгаваргүй байдал болон зөв шударга бус байдлыг нь ил болгох ямар ч аргагүй байх болно. Гэсгээлт, шүүлтээр л бүх бүтээлийн төгсгөлийг илчилж болно. Гэсгээгдэж, шүүгдэх үедээ л хүн жинхэнэ төрхөө харуулдаг. Мууг нь муутай, сайныг нь сайнтай тавих бөгөөд бүх хүн**

---

төрлийнхөө дагуу ангилагдана. Гэсгээлт, шүүлтээр дамжуулан бүх бүтээлийн төгсгөл илчлэгдэнэ, ингэснээр муу нь шийтгүүлж, сайн нь шагнуулж, бүх хүн Бурханы эрх мэдэлд харьяалагдаж болох юм. Энэ бүх ажил зөв шударга гэсгээлт, шүүлтээр хийгдэх ёстой. Хүний завхрал дээд цэгтээ хүрч, дуулгаваргүй байдал нь хэтэрхий ноцтой болсон учраас үндсэндээ гэсгээлт, шүүлтээс бүрддэг, эцсийн өдрүүдэд илчлэгддэг Бурханы зөвт зан чанар л хүнийг бүрмөсөн өөрчилж, бүрэн төгс болгож чадна. Энэ зан чанар л мууг ил болгож, улмаар зөв шударга бус бүхнийг хатуу шийтгэж чадна’ (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурханы ажлын үзэгдэл (3)”). ‘Байлдан дагуулах ажил хийх Миний зорилго бол гагцхүү байлдан дагуулалтын төлөө байлдан дагуулах бус, харин зөв шударга байдал ба зөв шударга бус байдлыг илчлэх, хүнийг шийтгэх нотолгоо олж авах, хорон мууг яллах, түүнчлэн дуртайяа дуулгавартай дагадаг хүмүүсийг төгс болгохын төлөө байлдан дагуулах явдал билээ. Эцэстээ бүгд төрлийнхөө дагуу ангилагдах бөгөөд төгс болгуулдаг хүмүүсийн бодол, санаа нь ч дуулгавартай байдлаар дүүрдэг. Энэ нь эцэстээ гүйцэлдэх ёстой ажил юм. Харин үйлдэл болгон нь тэрслүү хүмүүс шийтгүүлж, мөнхийн хараалын объект, галд шатаагдахаар хаягдах болно’ (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурханд үнэнч зүрх сэтгэлээр дуулгавартай байдаг хүмүүсийг Бурхан гарцаагүй олж авна”). Бурханы шүүлтийн ажил нь буудайг үрийн сүүлээс, ямааг хониноос, сайн зарцыг муу зарцаас шууд тусгаарлах, өөрөөр хэлбэл, сайн хүмүүсийг хорон муу хүмүүсээс салгаж, тус тусынх нь төрөлд нийлүүлэх ажил гэж бид боддог. Гэхдээ бид энэ тухай бодох юм бол одоо дэлхий даяар 2 тэрбум гаруй Христэд итгэгч байдаг—тэд бүгд Бурханд чин сэтгэлээсээ итгэдэг, Бурханд хайртай гэж хэлдэг—тэгвэл бид сайныг нь муугаас, зөв шударгыг нь хорон муугаас хэрхэн ялгаж салгаж юм бэ? Хэрэв Бурхан таныг сайн, намайг муу гэж үзвэл үүнийг нь би яавч хүлээн зөвшөөрөхгүй, яагаад гэвэл би ч бас өөрийгөө сайн хүн гэж үзэх болно. Хэрэв Бурхан намайг сайн, харин хэн нэгнийг муу хүн гэвэл тэд ч бас үүнийг хүлээн зөвшөөрөхгүй нь гарцаагүй. Тэгэхээр хэн нь сайн, хэн нь мууг бид ер нь яаж мэдэх болж байна аа? Бид чадахгүй, яагаад гэвэл хүмүүс бидэнд үүнийг хэмжих зарчим, стандарт байдаггүй. Хэрэв Бурхан биднийг ингэж хэмжсэн бол бид дуулгавартай байхгүй нь гарцаагүй бөгөөд Бурхан шударга бус, ёс бус гэж бодох гэх мэтээр энэ талаар үзэлтэй болох байсан. Тэгвэл хүн тус бүрийг төрлөөр нь ангилах ажил хэрхэн явагдах юм бол? Эцсийн өдрүүдэд эргэн ирдэг Эзэн бол эцсийн өдрүүдийн Христ—Төгс Хүчит Бурхан—бөгөөд шүүлтийн ажил хийхийн тулд үнэнийг ашигладаг. Бүх Христэд итгэгчийн хувьд хэн нь буудай, хэн нь үрийн сүүл, хэн нь ямаа, хэн нь хонь, хэн нь сайн зарц, хэн нь муу зарц, хэн нь ухаалаг охин, хэн нь мунхаг охин болохыг үнэнийг ашиглах замаар илчилдэг. Бурханы үг хүн бүрийг илчилдэг бөгөөд ухаалаг охид бол Бурханд үнэхээр итгэдэг, үнэнийг хайрладаг хүмүүс юм. Хэн нэгэн хүн Бурханы ирэлтийг гэрчилж буйг сонсох

---

үедээ тэд угтахаар гарч, Бурханы үг болон Бурханы ажлыг идэвхтэйгээр судалдаг. Тэд Бурханы дуу хоолойг таньж, Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн зөвшөөрч, эцэст нь Бурханы шүүлтээр дамжуулан ариусгалт, авралыг олж авдаг. Агуу гамшгийн үеэр тэдэнд Бурханы хамгаалалт байдаг ба амьд үлдэж, эцэст нь Бурханы хаанчлал руу хүргэгддэг. Эсрэгээрээ, мунхаг охид үнэнийг хайрладаггүй тул, өөрсдийн үзэл бодол, төсөөлөлтэй зууралдаж, худал цуурхалд итгэдэг тул, Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг эрж хайдаггүй, судалдаггүй тул, зарим нь бүр Бурханыг эсэргүүцэж, яллаж, Бурханы эцсийн өдрүүдийн авралаас татгалзахад нь удирдагчдаа дагадаг тул Бурханы эцсийн өдрүүдийн шүүлтийн ажлаар мууг үйлдэгчид гэж илчлэгдэн, таягдан хаягдана. Агуу гай гамшгийн үеэр шийтгэл амсах нь тэдний хувь заяа байх болно. Эцсийн өдрүүдэд хүн бүрийг төрлөөр нь ангилах Бурханы ажил бидний үзэл, төсөөллийн дагуу хийгддэггүй гэдгийг үүнээс бид харж болно. Харин ч Бурхан хүмүүсийг илчлэх ажил хийхийн тулд шүүлтийн аргыг ашигладаг бөгөөд эцсийн үр дүнд хүн болгон бүрэн илчлэгдэж, үнэнийг хүлээн зөвшөөрдөг үү, эсвэл эсэргүүцдэг үү гэдгээс хамааран тус тусын төрлөөр ангилагдана. Энэ нь Бурханы мэргэн ухаан, Бурханы шударга байдал, Бурханы зөвт байдал яг мөн бус уу?”

Төгс Хүчит Бурханы үг болон Ван ахын нөхөрлөлийг сонссоны дараа би чуулганыхаа тахилчийн “Эзэн эргэн ирэх үед сайн хүмүүс муу хүмүүсээс тусгаарлагдах болно” гэж хэлж байсныг санаж, энэхүү үзэл хэтэрхий тодорхойгүй, хэтэрхий бодитой бус бөгөөд Бурханы ажлын бодит байдалд огт нийцэхгүй байгааг ухаарав. Бид бүгд нүгэл дунд амьдардаг бөгөөд тасралтгүй нүгэл үйлдэж, нүглээ гэмшин, энэ мөчлөгөөс зугтах чадваргүй байдаг, тэгвэл үнэхээр сайн хүмүүс нь хэн юм бэ? Эзэнийг эргэн ирэх үед хэрэв нүгэл маань цэвэрлэгдээгүй байвал биднийг тэнгэрийн хаанчлал руу оруулах болов уу? Энэ тухай бодонгуут зүрх сэтгэлд минь гэрэл асах шиг болж, удирдлагынх нь төлөө би Эзэнд талархав. Миний энд ирсэн нь хий дэмий зүйл болоогүй, яагаад гэвэл, хүмүүс үнэнд яаж хандаж байгаагийнх нь дагуу Бурхан сайныг муугаас ялгадаг болохыг одоо би ойлгосон. Өөрөөр хэлбэл, Бурханы үгийн шүүлт, гэсгээлтийг хүлээн авч, дуулгавартай дагаж байгаа эсэхээсээ хамааран хүмүүс сайн юм уу муу байдаг бөгөөд энэ нь Бурханы зөвт байдлыг бүрэн илтгэж байна. Бурхан буудайг үрийн сүүлээс, ямааг хониноос, ухаалаг охидыг мунхаг охидоос, жинхэнэ итгэгчдийг хуурамч итгэгчдээс, үнэнийг хайрладаг хүмүүсийг үнэнийг үзэн яддаг хүмүүсээс салгахдаа үг болон ажил ашигладаг. Бурхан маш ер бусын ухаалаг! Гэхдээ тахилч маань, Эзэн хүмүүсийг шүүхээр эргэн ирэх үедээ үүнийгээ нэг нэгээр нь хийх бөгөөд тухайн хүн тэнгэр лүү явах уу, эсвэл там руу явах уу гэдгийг шийдэхийнхээ өмнө хүн тус бүрийн нүглийг жагсааж, нэг нэгээр нь шүүдэг гэж хэлж байсныг би бас саналаа. Харин одоо бол Төгс Хүчит Бурхан, Бурханы эцсийн өдрүүдийн шүүлтийн ажил үгээр нь дамжин хийгдэж байгаа гэж хэлж байна. Тэгэхээр

---

хүмүүсийг шүүхийн тулд эдгээр үгийг яг яаж ашиглаж байгаа юм бэ?

Тиймээс би энэ асуултаа бүлгийнхэнд тавихад Жан ах Төгс Хүчит Бурханы үгийн дараах хоёр хэсгийг надад уншиж өгөх замаар үүнд хариулав: “Бурхан хэзээ нэг цагт газар дэлхий дээр ирж, хүмүүст харагдаж, улмаар бүх хүн төрөлхтнийг биечлэн шүүж, хэнийг нь ч үлдээлгүй нэг нэгээр нь туршиж магадгүй гэж зарим хүн итгэдэг. Ингэж боддог хүмүүс бие махбодтой болох ажлын энэ үе шатыг мэддэггүй. Бурхан хүмүүсийг нэг нэгээр нь шүүдэггүй ба нэг нэгээр нь туршдаггүй; ийнхүү хийвэл шүүлтийн ажил биш. Бүх хүн төрөлхтний завхрал адилхан бус уу? Бүх хүн төрөлхтний мөн чанар ижилхэн бус уу? Шүүгддэг зүйл нь хүн төрөлхтний завхарсан мөн чанар, Сатаны завхруулсан хүний мөн чанар, хүний бүх нүгэл билээ. Хүний ялихгүй, аар саар алдааг Бурхан шүүдэггүй. Шүүлтийн ажил бэлгэдлийн чанартай бөгөөд ялангуяа тодорхой нэг хүнд зориулж хийгддэггүй. Харин ч энэ нь, бүх хүн төрөлхтнийг шүүх ажлыг төлөөлөхийн тулд бүлэг хүмүүсийг шүүдэг ажил юм. Бүлэг хүмүүс дээр Өөрийн ажлыг биечлэн гүйцэтгэснээр махбод дахь Бурхан, бүх хүн төрөлхтний ажлыг төлөөлүүлэхийн тулд Өөрийг ажлыг ашигладаг ба үүний дараа энэ нь аажмаар тархдаг. Шүүлтийн ажил ч гэсэн ийм байдаг. Бурхан тодорхой нэг төрлийн хүн, эсвэл тодорхой бүлэг хүмүүсийг шүүдэггүй, харин бүх хүн төрөлхтний зөвт бус байдал буюу тухайлбал, Бурханд хандах хүний эсэргүүцэл, Бурханыг хүндэлдэггүй байдал, эсвэл Бурханы ажлыг үймүүлдэг байдал зэргийг шүүдэг. Шүүгддэг зүйл нь хүн төрөлхтний Бурханыг эсэргүүцдэг мөн чанар бөгөөд энэ ажил нь эцсийн өдрүүдийн байлдан дагуулалтын ажил юм” (Үг нь махбодоор илэрсэн номын “Завхарсан хүн төрөлхтөнд бие махбодтой болсон бурханы аврал илүү их хэрэгтэй”). “Эцсийн өдрүүдэд Христ хүнийг сургах, хүний мөн чанарыг ил болгох, хүний үг болон үйлдэлд нь дүн шинжилгээ хийхийн тулд төрөл бүрийн үнэнийг хэрэглэдэг. Хүний үүрэг, хүн яаж Бурханд дуулгавартай байх ёстой, хүн яаж Бурханд үнэнч байх ёстой, хүн яаж хэвийн хүн чанарыг амьдран харуулах учиртай болон Бурханы мэргэн ухаан, зан чанар гэх зэрэг төрөл бүрийн үнэн эдгээр үгэнд агуулагддаг. Эдгээр үг нь бүгд хүний мөн чанар болон ялзарсан зан чанар луу чиглэдэг. Ялангуяа, хүн Бурханыг хэрхэн голдгийг илчилсэн үгсийг хүн бол Сатаны биелэл, Бурханы эсрэг дайсны хүч болдог тухайд хэлсэн байдаг. Шүүлтийн ажлаа хийхдээ Бурхан хүний уг чанарыг ердөө хэдхэн үгээр тодорхой болгодог юм биш; Тэрээр удаан хугацааны туршид илчилж, харьцаж, засдаг. Илчлэл, харьцалт болон засалтын эдгээр аргыг энгийн үгээр бус, харин хүнд огт байдаггүй үнэнээр л орлуулж болно. Зөвхөн ийм төрлийн арга барилыг л шүүлт гэж нэрлэж болно; ийм төрлийн шүүлтээр л дамжуулан хүн номхорч, Бурханд захирагдахаар бүрэн үнэмшээд

---

**зогсохгүй, Бурханы тухай жинхэнэ мэдлэгийг олж авч чаддаг”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Христ шүүлтийн ажлыг үнэнээр хийдэг”).

Жан ах дараа нь надтай ингэж нөхөрлөлөө: “Эцсийн өдрүүдийн шүүлтийн ажлынхаа үеэр Бурхан хүн тус бүрийг дуудан, Өөрийнхөө цагаан сэнтийн өмнө ирүүлж, дараа нь тэднийг шүүх болно. Хүн тус бүр газар дээр өвдөглөн сөхөрч, амьдралынхаа туршид үйлдсэн нүгэл болгоноо улайна. Тэгээд нүглийнх нь ноцтой байдлаас хамааран Бурхан, хүн тэнгэр лүү явах уу, там руу явахыг гэдгийг шийднэ гэсэн үзэл бидэнд байдаг. Бие махбодоор болон хэл амаар бусдыг доромжилж, эцэг эхдээ ачлалгүй байж, хулгай дээрэм хийх гэх мэт нүглийнх нь дагуу Бурхан хүмүүсийг шүүдэг гэж бид боддог. Гэтэл үнэн хэрэгтээ Бурханы эцсийн өдрүүдийн шүүлтийн ажил нь бидний ийм гадаад зан авир, ёс суртахууны дутагдалтай талуудыг огт анхаардаггүй, харин ч хүн төрөлхтний Бурханыг эсэргүүцдэг сатанлаг уг чанар болон завхарсан зан чанар болгоныг шүүхээр зорьдог. Эдгээр нь бидний биеэ тоосон, ихэрхүү зан, шударга бус, зальжин байдал, аминчхан, олиггүй байдал, шунал, муу муухай зэргийг агуулдаг. Бидэнд бас Бурхантай үл нийцэх олон үзэл бодол, шашны хоцрогдсон үзэл, феодалын сэтгэлгээ байдаг. Эдгээр зүйл нь бүгд Бурханыг эсэргүүцдэг байдлын маань эх сурвалж юм. Эдгээр нь завхарсан хүн төрөлхтөнд бүгдэд нь нийтлэг тохиолддог асуудлууд билээ. Тиймээс эдгээр нь Бурханы шүүлтийн ажлаар ариусгаж, хувирган өөрчлөхөөр зорьж буй зүйлс юм. Тиймээс Бурханы илэрхийлдэг үгс хүн төрөлхтний уг чанар, мөн чанарыг илчилдэг ба газар дээрх завхарсан хүн бүр ямар ч ялгаагүй үүний нэг хэсэг юм. Өөрөөр хэлэх юм бол Бурханы үг нийт хүн төрөлхтөнд чиглэдэг тул хүмүүсийг тус тусад нь шүүх шаардлагагүй. Төгс Хүчит Бурханы үгийг уншиж, Бурханы үгийн шүүлт, гэгсгээлтийг хүлээн авснаар бид олон үнэнийг ойлгож, өөрсдийн уг чанар, мөн чанар, Сатанаар завхруулагдсан бодит нөхцөл байдлаа тодорхой харж чадна. Үүнийг хийснээр бид Бурханы зөвт зан чанарыг танин мэдэж, Бурханыг хүндлэх, өөрсдийгөө жигших зүрх сэтгэлтэй болж, улмаар өөрсдийн махан биеэс урваж, үнэнийг хэрэгжүүлэх хүсэлтэй болно. Ийм маягаар завхарсан сатанлаг зан чанар маань аажмаар ариусаж, үзэл санаа, амьдралыг үзэх үзэл маань бас өөрчлөгдөнө. Бурханы үгээр амьдарч эхлэх үедээ, Бурханыг сөрж, эсэргүүцдэгээ больж, оронд нь Бурханыг үнэхээр дуулгавартай дагаж, хүндлэн, муугаас зайлах үедээ бид Бурханы авралыг олж авч, Бурханы санаа зорилгод нийцсэн хүмүүс болох болно. Энэ бол эцсийн өдрүүдэд шүүлтийн ажлыг хийхийн тулд Бурхан үнэнийг илэрхийлдгийн бодит нөхцөл байдал болон зорилго юм.”

Жан ахын нөхөрлөлийг сонссоны дараа би Бурханы шүүлтийн ажил үнэхээр практик бөгөөд бодит байдалд суурилсан болохыг мэдрэв! Би түүний хэлснийг хүлээн зөвшөөрч чадсан ба энэ нь зүрх сэтгэлд минь гүн цуурайтсан юм. Тийм ээ, хүмүүс биеэ тоосон

---

зантай байдаг, тэд алдар нэр, эд хөрөнгө, байр суурийн араас хөөцөлддөг, тэд янз бүрийн завхарсан зан чанараараа амьдардаг. Бурхан дотор маань буй бүх бохир, завхралаас биднийг салгахын тулд Өөрийн үгийн шүүлтийг ашигладаг. Бурханыг эсэргүүцдэг уг чанар маань тийнхүү шийдвэрлэгдэж, завхарсан зан чанар маань өөрчлөгдөж, бид үнэхээр сайн хүмүүс болдог. Ийм маягаар үүнийг харсан чинь, Эзэн хүн төрөлхтнийг шүүхээр эргэн ирэхдээ тус тусад нь шүүж, нүглийг нь нэг нэгээр нь шүүх болно хэмээн тахилчийн хэлж байсан энэхүү санаа нь ердөө хүний үзэл бодол, төсөөлөл бөгөөд Бурхан Өөрийнхөө ажлыг бодитоор хийдэг арга замтай ямар ч хамаагүй болох нь харагдав. Төгс Хүчит Бурханы үг үнэхээр үнэнийг агуулдаг бөгөөд үнэхээр Бурханы дуу хоолой мөн! Тэр өдөр сонссон зүйл маань Төгс Хүчит Бурханы ажлыг сайтар судлахаар шийдэхэд хүргэсэн билээ.

Судалж байх явцдаа би Төгс Хүчит Бурханы Чуулганы бүтээсэн Ноагийн өдрүүд ирсэн нь, Сүсэг бишрэлийн нууц, Сүүлчийн галт тэргэнд суусан нь гэх мэт сайн мэдээний олон кино үзэж, Хүний төлөөх Бурханы хайр хэчнээн чухал билээ гэх мэт Бурханы үгийн магтан дууны видео үзсэн юм. Мөн Төгс Хүчит Бурханы олон үгийг уншиж, үнэний бүх талын тухай ах эгч нарын нөхөрлөхийг сонссон юм. Энэ нь надад Төгс Хүчит Бурхан бол үнэхээр эргэн ирсэн Эзэн Есүс мөн гэдгийг баталгаажуулахад тусалсан билээ! Төгс Хүчит Бурхан бол нэгэн жинхэнэ Бурхан, мөн бидний хүлээж байсан эргэн ирсэн Эзэн мөн! Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн авахдаа би маш их баяр баясгалантай байлаа.

Төгс Хүчит Бурханд итгэснээс хойш би ах эгч нартайгаа ойр ойрхон уулзалдаж, тэдэнтэй хамт номлол сонсдог болсон бөгөөд одоо өдөр бүр аз жаргалтай санагдаж, сүнслэг хоол тэжээл авч байгаа мэт санагддаг. Ариун Сүнсний ажлаас ирдэг амар амгалан байдлыг эдэлж, улам их үнэнийг ойлгож эхэлж байгаа. Төгс Хүчит Бурханы Чуулганд ах эгч нар бүгд нэг нэгнийгээ таньдаг, өөр хоорондоо үнэнч шударга байдаг бөгөөд хэн ч бусдыгаа мэхлэх гэж оролддоггүй, хэн ч сэрэмжилдэггүй. Хүн бүр энгийн, нээлттэй, чин сэтгэлээсээ байдаг, тэр ч байтугай завхарсан зан чанараа илчлэх үедээ тэд дор бүрнээ Бурханы үгээр дамжуулан өөрсдийгөө мэддэг бөгөөд завхарсан зан чанараа шийдвэрлэхийн тулд үнэнийг эрж хайдаг. Миний хувьд тэд бол жинхэнэ Христэд итгэгч ах эгч нар. Надад маш өндөр сэтгэгдэл төрүүлдэг зүйл бол Төгс Хүчит Бурханы Чуулганы бүтээсэн магтан дууны видео, дуу хөгжмийн видео, бүжиг, дууны видео, сайн мэдээний кинонууд юм. Эдгээр нь бүгд үнэнийг маш их дээдэлж, Бурхан болон Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг гэрчилдэг. Энэ бүх бүтээлийн зорилго нь Бурханд захирагдаж, Бурханыг шүтэн мөргөхөд нь хүмүүст туслах явдал бөгөөд энэ чуулган нь үнэхээр Бурхан Өөрийнхөө ажлыг хийдэг газар мэт санагддаг! Миний харсан, сонссон, туулж мэдэрсэн

---

зүйл бол Төгс Хүчит Бурханы Чуулган нь Бурхан Өөрийнхөө хонин сүргийг биечлэн тэжээж, хариулдаг жинхэнэ чуулган мөн гэдгийг харуулж буй зүрх сэтгэлийн минь нотолгоо юм. Бурханы гэрт орж, Бурхантай өдөр бүр нүүр тулан амьдрах чадвартай байсан гэдэг маань Бурхан намайг онцгойлон өргөмжилсөн гэсэн үг юм. Би үнэхээр азтай! Баярлалаа, Төгс Хүчит Бурхан минь!

## **28. Гэрлийг харахын тулд мананг нэвтлэх нь**

Шиньшинь, Хятад

Би бол ердийн л нэг ажилчин. 2013 оны 11 дүгээр сарын сүүлчээр хамт ажиллагч маань, эхнэр бид хоёр өчүүхэн зүйлээс болж үргэлж маргалдан, цаг үргэлж санаа зовж, бачимддагийг харсан тул Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг бидэнд номлолоо. Төгс Хүчит Бурханы үгээс бид тэнгэр, газар болон бүх зүйлийг Бурхан бүтээсэн бөгөөд хүний амийг Бурхан хайрласан болохыг мэдэж авав. Бид бас зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөний нууц, бие махбодтой болохын нууц, хүн төрөлхтнийг аврах Бурханы ажлын гурван үе шат, эцсийн өдрүүд дэх Бурханы шүүлтийн ажлын ач холбогдол гэх мэт үнэнийг ойлгосон юм. Амьдрах хугацаанд маань, бие махбодтой болсон Бурхан хүн төрөлхтнийг аврахаар ажиллаж таарсан нь асар их ерөөл гэж эхнэр бид хоёрт санагдав. Бид эцсийн өдрүүд дэх Бурханы ажлыг баяртайяа хүлээн авч, чуулганы амьдралаар амьдарч эхэллээ. Бурханы үгийн удирдамж дор бид хоёр хоёулаа үнэнийг эрэлхийлж, өөрсдийгөө өөрчлөхөөр чармайсан бөгөөд ямар нэгэн зүйл тохиолдон, маргаж эхлэх болгондоо бид урьдынх шигээ нэг нэгнээсээ алдаа мадаг олохоо болиод, харин ч өөрсдийгөө эргэцүүлж, мэдэхээр оролддог байв. Тэгээд махан биеэ хаяж, Бурханы шаардлагад нийцүүлэн үйлддэг байлаа. Гэр бүлийн харилцаа улам бүр сайжирч, зүрх сэтгэл маань амар тайван, тогтвортой болов. Бурханд итгэх нь үнэхээр сайн зүйл мэт санагдаж байлаа. Гэвч Бурханыг баяр хөөртэй, жаргалтайгаар дагаж, аз жаргалтай амьдралыг эдэлж байхдаа бид гэр бүлийнхнийхээ зүгээс ирэх ширүүн дайралттай нүүр тулгарсан билээ... Гэсэн хэдий ч намайг замаа алдаж байх яг тэр үед, Сатаны төлөвлөгөөг нэвт харж, мананг нэвтлэн, амьдралын гэрэл гэгээтэй зөв замд ороход Төгс Хүчит Бурханы үг л намайг хөтөлсөн юм.

Би 2014 оны 2 дугаар сард тэтгэвэрт гарсан ба хөгшин бид хоёроор ач хүүг маань харж хандуулах гэсэндээ бэр маань биднийг Сычуань руу яваач гэж гуйв. Бид тун эвгүй байр сууринд очиж байгаа мэт санагдсан тул би Бурханд ийн залбирлаа: “Төгс Хүчит Бурхан минь! Бэр охин надаас ачийгаа харж өгөөч гэж гуйсан боловч тэндхийн амьдралд

---

дасахад бэрхшээл тулгарна, бас тэнд очоод Танд итгэх юм уу Таны үгийг уншихад хэцүү байх болно. Бидэнд гарц нээж өгөөч...” Тун удалгүй, ач хүүг маань бидэн дээр авчрахаар болсноо хэлэх гэж бэр маань над руу дахин утасдав. Энэ мэдээг сонсоод би хагартлаа баярлан Бурхан хэчнээн төгс хүчит болохыг мэдэрсэн юм. Бурхан миний залбирлыг сонсож, надад гарах гарц нээж өгчээ. Хэд хоногийн дараа бэр охин, аав ээжтэйгээ хамт ач хүүг маань авч ирэв. Тэр өдрийн маргааш нь би чуулганы цуглаанд явах байсан бөгөөд Төгс Хүчит Бурханд итгэдгээ тэдэнд хэллээ. Үүнийг сонсоод бэр маань баяр хөөргүйгээр: “Аав аа, та яаж Төгс Хүчит Бурханд итгэдэг байна аа? Засгийн газар хүмүүст Төгс Хүчит Бурханд итгэхийг зөвшөөрдөггүй гэдгийг та мэднэ гэдэгт би итгэлтэй байна. Сүүлийн жилүүдэд тэд Төгс Хүчит Бурханд итгэгчдийг байнга баривчилсаар ирсэн. Та Түүнд үргэлжлүүлэн итгэж болохгүй” гэв. “Бид Бурханд итгэхдээ улс төрд оролцдоггүй. Бид зөвхөн цуглаанд оролцож, Бурханы үгийг уншиж, үнэнийг эрэлхийлж, зөв замыг дагадаг. Тэд яагаад бидний итгэлийг зөвшөөрөхгүй гэж?” хэмээн би үг сөргөлөө. Бэр охин маань: “Та юу ч гэж хэлсэн бай, бас Бурханд итгэх нь зөв зам байсан ч гэсэн, засгийн газраас үүнийг эсэргүүцэж байгаа л бол Түүнд итгэж болохгүй!” гэж хэлсэн юм. “Чи юу ч хэлсэн бай хамаагүй, миний итгэдэг Бурхан бол жинхэнэ Бурхан. ХКН-ын засгийн газар үүнийг зөвшөөрөхгүй байсан ч гэсэн би итгэсээр байх болно” гэж би дотроо бодов. Тэгээд бэр маань явж миний эхнэрийг олж уулзаад, биднийг Бурханд итгэхээ боль гэж ятгасан бөгөөд дараа нь алс холын Сычуаниас хүү маань утасдаж: “Аав аа, таныг Төгс Хүчит Бурханд итгэдэг гэж сонслоо. Энэ бол ХКН-ын засгийн газрын эсэргүүцдэг зүйл, тэгэхээр та Түүнд цаашид итгэж болохгүй” гэж хэллээ. Хүүгээ ингэж хэлэхийг сонсоод сэтгэл түгшиж, “Бурханд итгэх нь тэнгэр, газрын хувиршгүй хууль, гэтэл та нар яагаад бүгдээрээ Бурханд итгэхийг минь болиулах гэж ахин дахин оролдоод байгаа юм бэ? Бурханд итгэж, зөв замыг дагах нь маш хэцүү юм!” гэж бодогдов. Тэгээд би Бурханд хандан чимээгүй залбирч, итгэлд минь саад хийх гэсэн хүү бэр хоёрын оролдлогоос намайг хамгаалахыг гуйлаа. Залбирсны дараа зүрх сэтгэл аажмаар амар тайван болсон юм. Хэдийгээр хүү, бэр хоёр маань ойлгоогүй боловч Бурханд итгэж, зөв замыг дагах нь зүйтэй гэдгийг би тов тодорхой мэдэж байсан бөгөөд тэдний нөлөөнд автах ёсгүй гэдгээ ч мэдэж байв. Гурван өдрийн дараа бэр маань гэртээ яаран гүйж ирэхдээ гартаа хоёр хэсэг хэвлэсэн зүйл барьсан байхыг би харлаа. Тэр намайг тэдгээрийг хурдан хар гэж шавдуулсан бөгөөд тэдгээр нь ХКН-ын засгийн газраас Төгс Хүчит Бурханы Чуулганыг гутааж, яллаж, гүжирдсэн цуу яриа, худал хуурмагаар дүүрэн байв. Хэсэг хугацаанд би бага зэрэг будилж, “Ийм байж таарахгүй, би хэдэн сарын турш цуглаанд оролцсоор ирсэн ба гар хөлгүй болсон нэг ч ах, эгчийг ер хараагүй! ХКН-ын засгийн газар яагаад цуу яриа тарааж, Төгс Хүчит Чуулганы талаар цуу яриа тарааж, нэр хүндэд нь халдахыг хүсэж байгаа юм бэ? Энд ер нь юу болоод байна аа?” гэж бодов. “Өө, ХКН-ын засгийн газар Бурханд итгэгчдийг ихэд улайран



---

хавчдаг, миний хүү, бэр хоёр ч бас Бурханд итгэхийг минь болиулахаар маш их хичээж байна. Тэгэхээр би юу хийх хэрэгтэй вэ?” гэж бодогдсоор байсан учир би тэр шөнө унтаж чадсангүй.

Маргааш нь би ойр хавьдаа салхилахаар гараад, Төгс Хүчит Бурханыг гүтгэж, ялласан цуу яриаг зарлалын самбарт байрлуулсан байгааг харав. “Миний итгэдэг зүйл бол жинхэнэ Бурхан, тэгтэл ХКН-ын засгийн газар яагаад үүнийг ийм маягаар эсэргүүцдэг билээ? Бурхангүй үзэлт ХКН-ын засгийн газрын хяналтад байдаг энэ улсад Бурханд итгэх үнэхээр амаргүй юм!” гэж би бодлоо. Энэ тухай бодоод сүнсээрээ сул дорой болж, уруу царайлан, сэтгэлээр унаад гэртээ харив. Гэртээ очингуут бэр маань надад: “Аав аа, би танаас итгэлээ орхихыг гуйж байна. Хэрвээ засгийн газар Бурханд итгэдгийг чинь олж мэдвэл би ажилтайгаа үлдэж чадахгүй. Хүү чинь удахгүй докторын зэргээ авах ч та Төгс Хүчит Бурханд итгэдгээс болоод ажилд орж чадахгүй байх гэж би айж байна. Тэр ч байтугай бяцхан ач хүү чинь үүнд өртөж, ирээдүйд сургуульд ч орж чадахгүй байх боломжтой” гэж дахин хэлэв. Энэ бүхэн маш аймшигтай сонсогдож байлаа—Бурханд итгэх нь хүний хүүхдүүдийн ирээдүйг ч хамарч болно! Хүмүүсийг шийтгэдэг ХКН-ын засгийн газрын арга зам туйлын харгис болохоор хүмүүсийг нүд ирмэх төдийд ч хөнөөж чадна гэдгийг би мэдэж байсан тул улам их айлаа. Хүүгээ докторын сургалтаа төгстөл нь тусалж дэмжих хэчнээн хэцүү байсныг би бас бодсон бөгөөд хэрвээ Бурханд итгэх нь хүүд минь нөлөөлөх юм бол би одоо яах вэ? Бурханд итгэж, зөв замыг дагасныхаа төлөө миний төлөх төлөөс хэтэрхий өндөр байсан тул зүгээр л мартсан нь дээр юм байна гэж бодов. Яг тэр мөчид бэр маань: “Хэрвээ таныг Бурханд итгэсэн хэвээр байвал манай аав цагдаад мэдэгдэнэ гэж хэлсэн. Манай аав Намын нарийн бичгийн дарга, амьдралынхаа гуч гаруй жилийг Коммунист Намд зориулсан гэдгийг та мэднэ. ХКН-ын хэлдэг бүхнийг тэр сонсож, дуулгавартай дагадаг. Тэр хэлсэндээ хүрдэг хүн тул таныг айлгахын тулд л хэлж байгаа юм биш” хэмээн намайг сүрдүүллээ. Сэтгэл дэх хамгаалалт маань тэгэхэд бүрмөсөн сүйрч, нуран унаад Бурханд итгэхэд дэндүү хэцүү, маш их дарамттай санагдав. Хүү, бэр хоёр маань ээлжлэн над руу ингэж дайрч, ХКН-ын цагдаад үнэхээр намайг мэдээлээд, би баривчлагдаж, шоронд хоригдох юм бол над шиг хөгшин хүн тийм зүйлийг тэсвэрлэж чадахгүй. “Мартаж үз, зүгээр л итгэлээ орхисон нь дээр” гэж би бодлоо. Түүнээс хойш би дахин цуглаанд очоогүй бөгөөд эгч нар намайг хайж хэд хэдэн удаа гэрт ирэхэд би үргэлж нуугдан, тэднээс зайлсхийдэг байв.

Гэвч цуглаанд оролцохгүй байх хугацаандаа би, Бурханы агуу хайр намайг зовлонгоос минь аварсныг, бас ах эгч нартай хамт байж, магтан дуу дуулж, Бурханыг магтахын аз жаргал, баяр хөөрийг л боддог байсан бөгөөд чуулганы амьдралыг ихэд санаж, хүсэн эрмэлздэг байлаа. Гэвч бэр маань цагдаад мэдээлэх вий гэж айсаар байсан

---

бөгөөд зүрх сэтгэлдээ асар их зовлон шаналал, тарчлааныг мэдэрч байсан юм. Яавал юм зөвөөр эргэхийг би мэдэхгүй байлаа. Тэр үед хамт ажилладаг нэг хүн (Бурханд итгэдэг нэг ах) сүүлийн үед яагаад цуглаанд оролцохгүй байгааг минь мэдэхийн тулд надтай уулзахаар ирэв. Бурханд итгэх итгэлийн талаар бэр охин маань намайг хэрхэн дарамталж байсныг би түүнд тайлбарласан бөгөөд үүнийг сонсоод тэр надтай ингэж нөхөрлөв: “Биднээс ийм зүйлс салахгүй байвал яг үнэндээ сүнсний ертөнцөд тулаан явагдаж байдаг. Энэ нь яг л Иовт нүүрлэсэн гамшигтай адил, гаднаа дээрэмчид түүнийг дээрэмдсэн мэт боловч үнэн хэрэгтээ үүний цаана Сатан хүмүүсийг тарчилгаж, хүн төрөлхтний төлөө Бурхантай дайтаж байсан. Иов Бурханаас эмээдэг хүн байсан ба муугаас зайлж чадсан; эцэст нь тэр Бурханы төлөө гэрчлэлд зогсож, Сатан ялагдал хүлээн шившиглэгдсэн. Тэгэхээр биднээс ийм зүйлс салахгүй байх үед Бурханы санаа зорилго нь биднээр Сатаны ёрын муу мөн чанарыг ялган таниулахын төлөө байдаг. Бурханд итгэх үедээ бүх зүйл дээр Бурханд найдаж, үнэнийг эрэлхийлэх нь л бидний хийх ёстой зүйл юм. Тэр үед л бид Сатаны явуулгыг нэвт харж, гэрчлэлд зогсож чадна, мөн тэр үед л бид Сатанд олзлогдохоос зайлсхийж чадна. Тэгэхгүй бол, бид бүрэн аврал хүртэх боломжоо алдана!”

Дараа нь хамт ажиллагч маань Төгс Хүчит Бурханы үгээс надад уншиж өгөв: “Бурхан Өөрийн ажлыг хийж, Бурхан нэг хүнийг халамжилж, энэ хүнээ харж ханддаг ба тэр зуур Сатан Түүний алхам бүрийг тувт салахгүй мөрддөг. Бурхан хэнийг л ивээнэ Сатан араас нь мөшгөж, мөн л ажигладаг. Хэрвээ Бурхан энэ хүнийг хүсвэл, Сатан Бурханд саад болохын тулд Бурханы хийдэг ажлыг уруу татаж, үймүүлж, сүйрүүлэхээр янз бүрийн хорон муу заль мэх ашиглан далд зорилгодоо хүрэхийн төлөө чадах бүхнээ хийнэ. Энэ зорилго нь юу вэ? Бурхан хэнийг ч олж авахыг тэр хүсдэггүй; Бурханы хүсдэг бүх хүнийг тэр өөртөө авахыг хүсдэг, тэднийг эзэмдэж, хянаж, удирдахыг хүсдэг ба ингэснээр тэд түүнийг шүтэж, муу үйл үйлдэхэд нь түүнтэй нэгдэх юм. Энэ нь Сатаны хорлонтой сэдэл биш гэж үү? Сатан бол маш муу, маш ёрын гэж та нар дандаа хэлдэг, гэхдээ та нар түүнийг харсан уу? Та нар зөвхөн хүн хэчнээн муу болохыг л харсан. Бодит байдалд Сатан үнэндээ хэчнээн муу болохыг хараагүй. Гэхдээ Иовын тухай энэ хэрэг дээр Сатаны мууг та нар харав уу? (Тийм.) Энэ хэрэг нь Сатаны зэвүүн царай зүс болон мөн чанарыг тун тодорхой болгосон. Бурхантай дайсагнаж, Түүний араас мөшгөхдөө Сатаны зорилго бол Бурханы хийхийг хүсдэг бүх ажлыг нурааж, Бурханы олж авахыг хүсдэг хүмүүсийг эзэмдэж, хянах, Бурханы олж авахыг хүсдэг хүмүүсийг бүрмөсөн устгах явдал юм. Хэрвээ тэднийг устгахгүй бол тэд Сатаны эзэмшилд орж, түүгээр ашиглуулдаг—энэ бол түүний зорилго” (Үг нь махбодоор илэрсэн номын “Цор ганц Бурхан Өөрөө IV”). “Та нар цаг ямагт сэргэг байж, хүлээх ёстой бөгөөд Миний өмнө илүү их залбирах ёстой.

---

**Сатаны янз бүрийн явуулга, башир заль мэхийг олж харж, сүнснийг таньж мэдэн, хүмүүсийг мэдэж, бүх төрлийн хүмүүс, үйл явдал, юмсыг ялган таних чадвартай байх ёстой. Мөн Миний үгийг илүү их идэж, уух ёстой бөгөөд үүнээс ч чухал нь өөрсдөө идэж, ууж чаддаг байх ёстой. Бүх үнэнээр өөрсдийгөө зэвсэглэж, Миний өмнө ирэх аваас, Би та нарын сүнслэг нүдийг нээж, сүнсэн дотор орших бүхий л нууцыг та нарт харуулж болох юм...** (“Үг нь махбодоор илэрсэн” номын Христийн эхэн үеийн айлдваруудын “17-р бүлэг”).

Бурханы үгээс уншиж дуусаад хамт ажиллагч маань надтай энэ талаар нөхөрлөлөө: “Биднээс ийм зүйл салахгүй бол энэ нь ширүүн сүнслэг тулаан байдаг. Одоогоор бүх дэлхий ертөнц муу ёрын нэгэн болох Сатаны эзэмшил дор байгаа бөгөөд Сатан Бурханы бүтээсэн хүн төрөлхтнийг бүрэн эзэмшиж, залгихаар дэмий найдан хүн төрөлхтнийг үргэлжлүүлэн завхруулж, Бурханы ажилд саад болж, үймүүлж байгаа—энэ нь Сатаны ёрын муу зорилго юм. Бурханы зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө нь хүн төрөлхтнийг Сатаны харанхуй нөлөөнөөс аврахын төлөө байдаг ба ингэснээр тэд Бурханаар авхуулж чадна. Ялангуяа эцсийн өдрүүдэд, Бурханыг үгээ илэрхийлж, хүн төрөлхтнийг цэвэрлэн, аврах ажлын эцсийн үе шатыг гүйцэтгэж байхад бид Бурханы ажлыг хүлээн авч, үнэнийг ойлгож, бүрэн аврал хүртэнэ гэдгээс Сатан айж байдаг. Түүний муу ёрын, харгис мөн чанарыг бид ялган таньж, түүнийг орхиж, хаяна гэхээс тэр айдаг. Үүнээс болоод тэр үхэхийн өмнө амь тэмцэн байхдаа Бурханы сонгосон хүмүүсийн төлөө Бурхантай тулалдан, Бурханы өмнө ирэхийг маань болиулахын тулд жигшүүртэй арга мэх бүрийг ашиглаж байна. ХКН-ын засгийн газрын тараасан төрөл бүрийн цуу яриа, худал хуурмаг болон итгэгчдийг улайран дарангуйлж, баривчилж байгаа явдал, итгэгчдийг гэр бүлийнхэн нь зовоож, хавчиж байгаа байдал, түүнчлэн шашны ертөнцийн түгээсэн яллалт, гүжирдлэг гэх мэт зальжин явуулгыг Сатан хэрэгжүүлдэг ба биднийг Бурхан руу эргэхээс сэргийлэх зорилготой байдаг. Гэвч Бурханы мэргэн ухаан Сатаны зальжин явуулгад суурилан хэрэгждэг ба Өөрийн ажилд үйлчлэл хийлгэхийн тулд Бурхан Сатаны үймээн самууныг ашиглан, улмаар бидний итгэл, үнэнч байдлыг төгс болгодог. Гаднаа, ХКН-ын засгийн газар болон танай гэр бүлийнхэн биднийг хяхан хавчиж, Бурханд итгэхээс сэргийлэн саад хийх гэж бүх төрлийн заль мэх, арга барилыг ашиглаж байгаа боловч үнэн хэрэгтээ энэ дүр зургийн цаана Сатаны бүх зальжин явуулга бий. Бид үнэнийг эрэлхийлж, Бурханы хүслийг ойлгохын тулд илүү ихийг хийж, Бурханы ажлын тухай зарим нэг мэдлэгтэй болж, Сатаны бүх арга заль, ов мэхийг ялган таньж, Бурханы төлөө гэрчлэлд зогсож чадаж байгаа цагт Сатан ялагдах хүлээн шившиглэгдэнэ. Бид үнэнийг ойлгохоор эрэлхийлэхгүй бол сүнсний ертөнц дэх тулааныг ойлгож чадахгүй бөгөөд Сатан бидэнд үймээн учруулах үед замаа алдаж, Бурханы талаар эргэлзэх болж, бүр Бурханыг үгүйсгэж,

---

Бурханаас урваж, Бурханд итгэх итгэлээ орхиход хүрэх боломжтой. Хүн яг ингэж л Сатаны заль мэхэнд автаж, Бурханы авралыг хүртэх боломжоо алддаг; эцэст нь, Сатан хүнийг ингэж залгидаг. Тиймээс бид залбирч, Бурханд улам ойртох ёстой ба асар их яаравчлан Бурханы үгийг уншиж, өөрсдийгөө үнэнээр зэвсэглэх ёстой. Зөвхөн ийм маягаар л бид Бурханы хүслийг ойлгож, Сатаны заль мэхийг нэвт харж, Бурханы төлөө гэрчлэлд зогсож чадна.”

Бурханы үг болон хамт ажиллагчийнхаа нөхөрлөлийг сонсоод би гэнэт ингэж ухаарав: “Энэ үнэхээр сүнсний ертөнц дэх тулаан юм байна. Бурхан биднийг аврахын тулд эцсийн өдрүүдэд үнэнийг илэрхийлдэг боловч Бурханд итгэж, Бурханыг дагахыг минь болиулахын тулд Сатан ХКН-ын засгийн газрын оноодог дарангуйлал, хавчлагыг ашиглах боломжит арга зам болгоныг бодож олдог. Сатан намайг Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн авч, үнэнийг ойлгоно, улмаар өөрийнх нь ёрын муу, жигшүүрт, сатанлаг, чөтгөрлөг мөн чанарыг ялган таньж, өөрийг нь голж, хаяад Бурханы авралыг хүртэнэ гэхээс айдаг. Өнөөдөр би эцэст нь Сатаны жигшүүртэй хорон санааг харж, бас хүн төрөлхтнийг аврахын тулд Бурханы зориулсан уйгагүй анхаарал халамж, бодлыг ойлголоо.” Яг тэр үед би удаан хугацаанд барьж байсан сэтгэл хөдлөлөө чөлөөтэй тавьсан бөгөөд дахин төрөх мэт үнэхээр аз жаргалтай санагдсан юм. “Бурханд талархъя! Сатанд дахин хууртахгүйн тулд одоогоос эхлээд би Бурханы үгээс илүү ихийг уншиж, өөрийгөө үнэнээр зэвсэглэнэ” гэж би бодов.

Үл итгэгч гэр бүлийнхэн маань Бурханд итгэсний төлөө надад төвөг удсан нь ердөө л Сатаны заль мэхний нэг гэдгийг, бас Сатанд хууртаж болохгүй гэдгийг би ойлгосон хэдий ч ХКН-ын засгийн газраас миний итгэлийн талаар олж мэдвэл хүү, бэр хоёрын маань ажил мэргэжилд энэ нь нөлөөлнө гэдэгт санаа зовсон хэвээр байлаа. Тэр ч байтугай ач хүүг минь сургуульд ороход энэ нь нөлөөлнө гэдгээс илүү их айж байв. Тиймээс би хамт ажиллагчдаа санаа зовнилынхоо талаар хэлсэн бөгөөд тэр надад Төгс Хүчит Бурханы үгээс өөр нэг хэсгийг уншиж өглөө: “Бурханы эрх мэдэл нь нөхцөл байдлыг үл харгалзан оршдог. Бүх нөхцөл байдалд Бурхан хүн бүрийн хувь заяа болон бүх зүйлийг Өөрийн бодол, Өөрийн хүслийн дагуу захиран, зохицуулдаг. Хүмүүс өөрчлөгдсөнөөс болж энэ нь өөрчлөгдөхгүй; энэ нь хүний хүслээс хамаарахгүй, цаг хугацаа, орон зай, газар зүйн ямар ч өөрчлөлтөөс болж хувирах боломжгүй, учир нь Бурханы эрх мэдэл бол Түүний үнэн мөн чанар билээ... Бурхан цаг ямагт Өөрийн эрх мэдлийг ашиглаж, Өөрийн сүр хүчийг харуулж, Өөрийн удирдлагын ажлыг үргэлж хийдэг шигээ үргэлжлүүлдэг; үргэлж хийдэг шигээ л Тэр цаг ямагт бүх зүйлийг захирч, хангаж, зохион байгуулдаг. Хэн ч үүнийг өөрчилж чадахгүй. Энэ бол бодит үнэн; балар эртний үеэс хойш энэ нь өөрчлөгдөшгүй үнэн байсаар ирсэн!” (Үг нь

---

махбодоор илэрсэн номын “Цор ганц Бурхан Өөрөө III”). Хамт ажиллагч маань энэ талаар үргэлжлүүлэн нөхөрлөв: “Бурхан бол Бүтээгч бөгөөд тэнгэр, газар, түүний доторх юм бүхнийг захирдаг. Тэр бас хүн бүрийн хувь заяаг хянадаг бөгөөд бид ямар ажилтай, хэтийн ирээдүйтэй байхыг аль эрт урьдчилан тогтоосон байдаг. Энэ бол хэн нэгний шийдэж, өөрчилж чадах зүйл биш. Таны хүү, бэрийн ажил мэргэжил болон хэтийн ирээдүйг бүгдийг нь Бурхан хянаж байдаг. Тэд Бурханд итгэдэг эсэх нь хамаагүй, тэдний хувь заяаг Бурхан захирч, зохицуулдаг. Бидний хувьд энэ тэр зүйлийн тухай санаа зовох шаардлагагүй. Иов энэ тухайд хэзээ ч санаа зовдоггүй байсан, учир нь түүнд байгаа бүхнийг Бурхан өгсөн ба түүнд юуг ч өгч, түүнээс юуг ч авсан бай, энэ бүхэн Бурханы гарт байдаг гэдгийг тэр тодорхой мэдэж байлаа. Тиймээс та зөвхөн Бурханд хандан залбирах тухайд санаа зовж, хүү бэрх хоёрынхоо ирээдүйг Бурханы гарт даатган, Бурханд тохиромжтой төлөвлөгөө бий гэдэгт итгэх хэрэгтэй.” Бурханы эрх мэдэлтэй холбоотой Бурханы үгийн талаар нөхөрлөснөөр дамжуулан би Бурханд итгэх итгэлтэй болж, зүрх сэтгэлдээ тайван, амгалан болсон юм. Би хүү бэр хоёрынхоо хэтийн ирээдүйн талаар цаашид санаа зовохгүй.

Дараа нь Бурханы үгийг уншсанаар дамжуулаад би ХКН-ын засгийн газрын Бурханыг эсэргүүцдэг, ёрын муу мөн чанарыг ялган таньдаг болсон билээ. Төгс Хүчит Бурхан ингэж хэлсэн байдаг: **“Диавол хүний биеийг бүхэлд нь чанга хүлж, хоёр нүдийг нь сохолж, амыг нь бат хамхидаг. Дияволуудын хаан өнөөг хүртэл хэдэн мянган жилийн турш догшин ширүүн авирлангаа нэвтрэхийн аргагүй чөтгөрүүдийн өргөө мэт чөтгөрт хотыг нүд салгалгүй харсаар байдаг; тэр хооронд, энэхүү сүрэг манаач нохой нь догшин харцаар ширтэж, Бурхан мэдээгүй байхад нь барьж аваад, бүгдийг нь устгаж, амар тайван, аз жаргалтай газаргүй болгоно гэдгээс гүнээ айж байдаг. Чөтгөрт хотын ийм хүмүүс яаж ер нь Бурханыг харсан байж чадах юм бэ?”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Ажил ба оролт (8)”). Амийн оролтын тухай номлол ба нөхөрлөл –д бас ингэж хэлдэг: “Бурхан өөрт нь хамьяалагддаг бүх хүнийг булаан авахаар ирсэн бөгөөд өөрийг нь дайснаа болгож байна гэж агуу улаан луу зүрх сэтгэлдээ боддог. Энэхүү агуу улаан луу нь захирангуй, бодлогогүй зүйл юм! Хүн төрөлхтнийг Бурхан бүтээсэн ба хүн төрөлхтнийг аврах эрхтэй. Анх, хүн төрөлхтөн Бурханд харьяалагддаг байсан бөгөөд агуу улаан луу л Бурханы сонгосон хүмүүсийг түрэмгийлэн булаан авч, хүссэнээрээ ялзруулан, дэвсэлж, эцэст нь тэднийг бүгдийг нь цөлмөн залгидаг. Гэвч Бурхан хүн төрөлхтнийг аврахаар ирэх үед тэр Түүнийг эсэргүүцдэг. Агуу улаан лууны уг чанар болон мөн чанар нь Тэнгэртэй сөргөлддөг, туйлын харгис, бодлогогүй, утгагүй гэдгийг эндээс харж болно. Тэр бол зэрлэг араатан, чөтгөр юм” (Амийн оролтын тухай номлол, нөхөрлөл (III) дахь “Аврал хүлээн авахын тулд агуу улаан лууг хаяхын жинхэнэ ач холбогдол”). Бурхангүй үзэлт энэ

---

оронд ХКН-ын эрх мэдэл нь Сатаны эрх мэдэл юм гэдгийг би одоо ойлгосон. Бурхан энэ газар нутагт ирж, хүмүүсийг аврах ажил хийхийг Хятадын засгийн газар зөвшөөрдөггүй, мөн хүмүүс харанхуй нөлөөллөөс нь ангижирч, Бурханаар авхуулж, үзэсгэлэнтэй сайхан хүрэх газар луу Бурханаар удирдуулан очихыг ч зөвшөөрдөггүй. Тиймээс тэд Төгс Хүчит Бурханы ажлыг эсэргүүцэж, яллахын тулд чадах бүхнээ хийн, Төгс Хүчит Бурханыг дагахад маань биднийг улайран дарамталж, саад хийдэг. Хэрвээ бид үнэнгүй, ХКН-ын зальжин арга мэхийг нэвт харж чаддаггүй, муу ёрын, харгис мөн чанарыг нь нэвт харж чаддаггүй бол тэдний тараадаг янз бүрийн худал хуурмагаас болж амархан төөрөлдөх ба айсандаа түүний дарангуйлал, хавчлагад захирагдана. Бид Бурханы өмнө ирж зүрхлэхгүй бөгөөд тэрээр хүмүүсийг аврах Бурханы ажлыг сүйтгэн, хүмүүсийг залгих зорилгодоо хүрсэн гэсэн үг юм. Гэвч Бурханы мэргэн ухааныг ойлгож чадах хэн ч үгүй. Өөрийн сонгосон хүмүүсийг төгс болгохдоо Бурхан ХКН-ын засгийн газрын яг энэ хавчлагыг ашиглан үйлчлэл хийлгэдэг бөгөөд бидэнд үнэнийг ойлгуулан, ХКН-ын засгийн газар бол үнэнд бүрэн дайсагнадаг, Бурханыг дайснаа гэж үздэг сатанлаг чөтгөр гэдгийг нэгд нэггүй ойлгуулдаг, ингэснээр бид үүнийг бүрмөсөн хаяж, Бурхан руу бүрэн эргэж чаддаг. Өөрийн үгийг ашиглан намайг удирдаж, гэгээрүүлж, гэрэлтүүлэн, ХКН-ын засгийн газрын Бурханыг эсэргүүцдэг чөтгөрлөг уг чанарыг ялган таньж, улмаар тэдний сүрдүүлэгт автахгүй байх боломжийг надад олгосных нь төлөө Бурханд талархъя. Намайг сөрөг, сул дорой болж, уруудан доройтож, замаа алдаад байх үед над руу хамт ажиллагчийг маань явуулж, надад дэмжлэг үзүүлж, үнэний талаар нөхөрлүүлэхээр зохицуулсных нь төлөө ч бас Бурханд талархаж байна. Бурхан намайг Сатаны уруу таталтаас аварсан бөгөөд би Сатаны торыг сэт цохин, Бурханы өмнө эргэн ирсэн билээ. Би одоо бүрэн аврал хүртэх боломжтой болсон. Урдах зам маань хэчнээн хэцүү байсан ч хамаагүй, эцсийг нь хүртэл Төгс Хүчит Бурханыг дагана гэж би шийдсэн!

## **29. Харанхуй хонгилын дараах халуун дулаан гэрэл**

Ван Юпин, Хятад

Эзэн Есүсийн эргэн ирэхийг хүсэн хүлээж буй бусад бүх ах эгчийн нэгэн адилаар би ч бас Эзэнийг удахгүй эргэн ирж, тэнгэрийн хаанчлалд биднийг хүлээн авч, бидэнд ерөөлөө хайрлахыг тасралтгүй хүлээж байсан юм. 2006 оны 11 дүгээр сарын нэгэн өдөр би Эзэн эргэн ирсэн тухай мэдээг эцэст нь нэг юм сонсож билээ. Төгс Хүчит Бурханы илэрхийлсэн үгийг уншиж, ах эгч нараас эцсийн өдрүүд дэх Бурханы ажлын талаар нөхөрлөж, гэрчилж байгааг сонссоны дараа бие махбодтой болсон Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс мөн гэдгийг би эцэст нь ухаарав. Иймээс би эцсийн өдрүүд дэх Төгс Хүчит Бурханы

---

ажлыг дуртайяа хүлээн авсан юм.

Нэг удаа цуглааны үеэр Ян эгч надад маш нухацтай өнгө аястайгаар ингэж нөхөрлөв: “Ойрын үед Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн авсныхаа дараа Сатаны учруулж буй саад, уруу таталттай тулгарсан олон ах эгч байгаа. Зарим нь ХКН-ын худал үгэнд хууртаж, зарим нь пастор, ахлагчдын саад, заналхийлэлтэй тулгарч, зарим нь гэр бүлийнхээ албадлага, хавчлагад орж, заримынх нь гэр бүлийн гишүүд өвдөж, гай барцадтай тулгарч байна. Энэ бүхэн нь биднийг Бурхан руу эргэн очиход саад хийх гэсэн Сатаны урхи юм. Төгс Хүчит Бурханы шүүлтийн ажил Бурханы гэрээс эхэлдэг, хүн төрөлхтнийг аврах Бурханы ажлын эцсийн үе шат гэдгийг бид бүгд хэдийнээ ойлгож байгаа. Бурхан хүнийг аврахын тулд хийж чадах бүхнээ хийж байна. Харин Сатан биднийг Бурханы өмнө очиж, Түүний авралыг хүлээн авахад саад учруулахын тулд арга заль гаргаж, бидэнд саад учруулж байгаа. Яг одоо сүнсний ертөнцөд явагдаж буй тулаан улам бүр эрчимжиж байгаа тул Сатаны заль мэх нүүрлэх болгонд хууртахгүй байж, Бурханы гэрчлэлд зогсохын тулд бид үнэнээр зэвсэглэж, ялган таних чадвар эзэмших яаралтай шаардлага гарч байна. Одоо Төгс Хүчит Бурханы үгийн нэг хэсгийг уншицгаая” гэв. Тэгээд би Бурханы үгийн номыг авч, дараах хэсгийг үнэн сэтгэлээсээ уншлаа: **“Бурхан ажиллаж байхад Сатан үймүүлдэг. Эцсийн өдрүүдэд түүний үймээн самуун дууссан байх болно; үүний нэгэн адил Бурханы ажил ч бас дуусаж, Бурханы бүрэн төгс болгохыг хүсдэг хүмүүс бүрэн төгс болгуулна. Бурхан хүмүүсийг эерэгээр чиглүүлдэг; Түүний амь бол хэмжээлшгүй агаад хязгааргүй амийн ус билээ. Сатан хүнийг тодорхой хэмжээнд завхруулсан; эцэст нь амийн амьд ус хүнийг бүрэн төгс болгоно, тэгээд Сатан хөндлөнгөөс оролцож, өөрийн ажлыг явуулах боломжгүй болно. Тийнхүү Бурхан энэ хүмүүсийг бүрэн олж авч чадна. Сатан одоо ч гэсэн үүнийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсаар байгаа; тэр байнга Бурханы эсрэг сөрөн зогсдог ч Бурхан түүнд огт анхаарал хандуулдаггүй. ‘Би Сатаны бүх харанхуй хүчийг, үүний бүх харанхуй нөлөөг ялна’ гэж Бурхан хэлсэн... Бурхан Сатанаас илүү ухаалаг бөгөөд Бурханы ажил түүнээс хамаагүй хол давдаг. Тиймээс өмнө нь Миний хэлж байсанчлан: ‘Миний хийдэг ажил Сатаны ов мэхний хариуд хэрэгждэг; эцэстээ Би Өөрийн төгс хүчийг болон Сатаны хүчин мөхөс байдлыг илчилнэ.’ Бурхан урд талд нь Өөрийн ажлыг хийх үед Сатан араас нь дагах ба эцэстээ бүрмөсөн устгагдана—өөрийг нь юу цохисныг ч тэр мэдэхгүй! Аль хэдийн сүйрэн унаж, няцлуулмагцаа л тэр үнэнийг ухаарна, харин тэр үед аль хэдийн галт нууранд шатчихсан байх болно. Тэгэхэд Сатан бүрэн үнэмшихгүй гэж үү? Учир нь тэр үед түүнд ашиглах арга заль байхгүй байх болно!”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Бүх хүн төрөлхтөн өнөөг хүртэл хэрхэн хөгжсөнийг чи мэдэх ёстой”). Ян эгч надад зөөлнөөр

---

ингэж хэлэв: “Бурханы удирдлагын ажлын алхам бүрийг Сатан ойр нэхэн дагаж байдгийг Бурханы үгээс бид олж харлаа. Наана нь Бурхан хүнийг аврах ажил хийж байхад цаана нь Сатан үймүүлж, эвдэн сүйтгэж байдаг. Сатан хүнийг авахын тулд Бурхантай байнга өрсөлдөж байдаг бөгөөд ялангуяа хүн төрөлхтнийг бүрмөсөн аврах Бурханы ажлын эцсийн үе шатанд энэ нь нэн хамааралтай. Энэ удаад Бурханы ажлыг хүлээн авч, захирагдахад маань саад, төвөг учруулахын тулд Сатан бүр ч илүүтэйгээр чадах бүхнээ хийж, бүх төрлийн хүмүүс болон эд юмсыг ашиглаж байна. Хүнийг Бурханаас холдуулж, Бурханыг үгүйсгэх, Бурханаас урвахад хүргэж, улмаар Бурханы аврал хүртэхээргүй болгох нь Сатаны жигшмээр зорилго юм. Гэвч Сатаны заль мэхийн хариуд Бурхан мэргэн ухаанаа хэрэгжүүлдэг. Бурхан Сатаны саадыг ашиглан Өөрийн ажил, мэргэн ухаан, төгс хүчийг бидэнд ойлгуулж, мөн Сатаны хорон муу, ой гутам байдлыг тод томруун харуулдаг. Тиймээс цаашид юу ч тохиолдсон бай бид бүгд Бурханд залбирч, Бурханд найдаж, үнэнийг эрэлхийлэх ёстой. Мөн Сатаны заль мэхийг нэвт харж, ингэснээр Бурханы гэрчлэлд зогсох чадвартай байх ёстой. Энэ нь яг л Иовын туулсан шалгалттай адил. Иов Бурханы гэрчлэлд зогсож, Сатаныг ичгүүртэйгээр ухрахад хүргэсэн юм...” Ян эгчийн нөхөрлөлийг сонсоод би бүрэн итгэл үнэмшилтэйгээр: “Тийм ээ, бид жинхэнэ Бурханд итгэдэг. Бурханыг түшиж тулбал бидэнд айх зүйл байхгүй. Хэрэв би Сатаны сорилттой таарвал Бурханы талд заавал зогсох болно” гэж хариуллаа.

Төд удалгүй нэгэн өдөр сайн мэдээ тарааж дуусаад, гэрийнхээ үүдэнд ирж байтал хөрш маань гар даллан гүйж ирээд: “Чи чинь яагаад ингэж оройтоо вэ? Том осол гарчхаад байна! Түрүүн танай хүүгийн найз Лиу ирээд, ачааны машиныг чинь түр зээлж авсан боловч ачааны машин нь асаж өгөхгүй байсан юм. Тэгэхээр нь трактороор чирүүлж, хэд хэдэн удаа оролдсон ч хөдлөхгүй байсан гэнэ. Ху бас тэнд байж таарсан болохоор трактор дээр гараад, шууд тав дахь араанд нь хийчхэж. Трактор ч ухасхийн, ачааны машиныг татаж байсан металл утас гэнэт тасарч, тэр нь Хугийн чамархай руу түсхийтэл цохисон байна. Шууд л цус асарч эхэлсэн болохоор цаадхыг чинь эмнэлэг рүү аваад явсан...” гэв. Толгойд юу ч бодогдохоо байж, би шууд л гэртээ ороод Бурханд залбирав: “Ээ Бурхан минь! Би Таны хүслийг ойлгохгүй байна. Надад яагаад гэнэт ийм зүйл тохиолдов оо? Намайг гэгээрүүлж өгөөч дээ...” Ингэж залбирсны дараа сүнслэг тулаантай холбогдсон үнэний тухай Ян эгчийн хийсэн нөхөрлөл бодогдов. Тэгээд л би ойлгосон юм. Сатан намайг сорьж, үймүүлж байгаа нь л энэ юм байна. Сатан эдгээр таагүй үйл явдлыг ашиглан над руу дайрч, ингэснээр намайг Бурханд эргэлзэж, Бурханыг буруушааж, Бурханыг үгүйсгэдэг болгохыг л хүсжээ. Энэ үнэхээр сүнслэг тулаан гэдгийг би ухаарлаа! Яг тэр үед Бурханы хэлсэн ийм үг бодогдов: **“Бурханыг Сатантай тулалдахад Бурханы талд зогсох чадвартай байж, Сатан руу эргэж очихгүй бол Бурханыг гэх хайрыг олж**



---

**авч, гэрчлэлдээ бат зогссон байх болно”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурханыг хайрлах нь л үнэхээр Бурханд итгэж буй хэрэг”). Бурханы үг намайг агуу итгэл үнэмшлээр дүүргэж, би дотроо ингэж бодлоо: “Сатан, чи намайг яаж ч үймүүлж байсан заль мэхэнд чинь би унахгүй, Бурханы буруушаахгүй, Бурханд эргэлзэхгүй, харин Бурханы талд зогсож, Төгс Хүчит Бурханыг зохих ёсоор дагах болно.” Бурханы хүслийг ойлгосон даруйд сэтгэл минь хавьгүй тогтуун боллоо.

Гэвч Сатан ялагдлаа хүлээе гэж бодолгүй, хүмүүс болон эд зүйлсээр дамжуулан намайг үймүүлсээр байв. Ху эмнэлэгт хэвтсэн байх хойгуур гэр бүлийнхэн нь бүх хариуцлагыг манай гэр бүлд тохож, эмчилгээний бүх зардлыг биднээр төлүүлэх гэлээ. Би тал зардлыг нь төлөхөд бэлэн байгаагаа хэлж, тэдэнтэй хэлэлцэх гэж оролдсон ч тэд татгалзсаар байв. Гурван долоо хоногийн дараа Ху аль хэдийн эдгэрсэн ч эмнэлгээс гарахгүй байлаа. Манай гэр бүлийг сүрдүүлж мөнгө авахын тулд санаатайгаар ингэсэн байв. Тэгээд нэгэн өдөр Ху: “Ачааны машин чинийх тул бүх зардлыг чи төлөх ёстой” гэв. Хугийн эхнэр бас босож ирээд: “Тэр зөв шүү! Чиний ачааны машин осолд орсон юм чинь чи бүх зардлыг төлөх ёстой...” гэж хашхирлаа. Тэнд зогсон тэдний тасралтгүй яншихыг сонсоод уур маш их хүрэв. Би энэ асуудалд санаандгүй орооцолдсон болохоор маш их шаналж, сэтгэлийн хямралд орлоо. Тэдэнтэй дахиж яримааргүй байсан тул бухимдсаар өрөөнөөс гарав. Шатаар доош бууж байхдаа дотроо ингэж бодлоо: “Би Бурханд итгэгч юм чинь иймэрхүү зүйл тохиолдох үед тэгтлээ уурлахынхаа оронд энэ асуудлыг Бурханы гарт даатгах ёстой. Би Бурханд найдах хэрэгтэй.” Гэртээ хариад Бурханы үгийн номоо нээж, ийн уншив: “Хүмүүс дээр Бурханы хийдэг ажлын алхам бүрд, гаднаа энэ нь хүмүүсийн хоорондын харилцаа мэт, хүний зохицуулалт, хүний хөндлөнгийн оролцооноос үүдэлтэй мэт харагддаг. Гэвч нүднээс далдуур, ажлын алхам бүр, тохиолдож буй юм бүхэн нь Бурханы өмнө Сатаны тавьсан бооцоо бөгөөд Бурханд гэрчлэл хийхдээ бат зогсохыг хүмүүсээс шаарддаг. Жишээ нь, Иовыг шалгасан үеийг авч үзье: Нүднээс далдуур Сатан Бурхантай мөрий тавьж байсан бөгөөд Иовд тохиолдсон зүйл нь хүмүүсийн үйл хэрэг, хүмүүсийн хөндлөнгийн оролцоо байсан. Та нарт хийдэг Бурханы ажлын алхам бүрийн ард Сатаны Бурхантай тавьсан мөрий байдаг—энэ бүгдийн ард тэмцэл байдаг... Чамд тохиолддог бүхэн асар их шалгалт гэдгийг, мөн Бурхан чамаар гэрчлэл хийлгэх хэрэгтэй болох тэр цаг үеийг чи мэдэх ёстой” (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурханыг хайрлах нь л үнэхээр Бурханд итгэж буй хэрэг”). Сатаны сорилттой учрах болгондоо би заавал Бурханы талд зогсоно гэж Ян эгчийн өмнө тэр өдөр гайхуулж байснаа эдгээр үгийг уншаад санах. Сатан намайг удаа дараа хашраах үед би тайвнаар Бурханы өмнө ирж, Түүний хүслийг эрж хайж чадалгүй үргэлж бодолд автдаг болно гэж төсөөлсөн ч үгүй. Үүндээ би маш их эмзэглэсэн юм. Энэ

---

чинь Сатаны мэхэнд унаж байгаа хэрэг бус уу? Энэ асуудлын нарийн ширийнийг эргэцүүлснийхээ дараа л Сатан үнэхээр муу ёрын, хорон болохыг эцэст нь олж харсан юм. Сатан энэ явдлыг ашиглан намайг үймүүлж, махан биеийн сонирхлынхоо төлөө уурлахад хүргэж, тэр ч байтугай үүнийг ашиглан Төгс Хүчит Бурханыг үгүйсгүүлж, Төгс Хүчит Бурханаас урвуулах гэжээ. Би Сатаны мэхэнд унаж болохгүй гэдгээ мэдээд, Бурханд найдаж, энэ асуудлыг Бурханд даатгахад бэлэн байв. Ху эмнэлгээс гарах эсэх, эцэст нь би хэчнээн их мөнгө төлөх ёстой эсэх асуудлыг бүгдийг нь Бурханы гар зохион байгуулдаг гэдэгт итгэн, ямар ч үр дагавар гарлаа гэсэн дуулгавартай дагахыг хүсэж байлаа. Бурханы хүслийг ойлгон, Бурханыг гэрчлэлд зогсох хүсэлтэй болмогцоо би Бурханы гайхамшигт үйлийг дараа өдөр нь санамсаргүй гэрчилсэн юм. Бурхан нэгэн залууг Хугийн хэвтэж байсан эмнэлэг рүү явуулж: “Сайн хүмүүсийг дээрэлхдэг, бусдыг сүрдүүлж мөнгө салгадаг чам шиг хүмүүсийг би үзэж чаддаггүй юм. Би л байсан бол чамд сохор зоос ч өгөхгүй байх байсан!” гэж хэлүүлжээ. Өрөөнд байсан бусад хүн ч ам уралдан: “Тийм шүү, өөрөө л дурандаа трактор луу явж орчихоод одоо энэ хүнээс мөнгө авна гэж байдаг. Ямар цадиггүй юм бэ!” “Зөв шүү! Ачааны машиныг нь зээлж авсан хүн ч бас мөнгө төлөх хэрэгтэй! Ачааны машины эзнээр л бүгдийг нь төлүүлээд байж болохгүй шүү дээ!” гэгцээв. Ху үүнийг сонсоод толгой гудайлган, ганц ч үг дуугарсангүй. Тэгээд гурван хоногийн дараа Ху эмнэлгээс гарсан юм. Энэ бүхний ард Бурхан байж, надад ийм гарц нээж өгсөн гэдгийг би зүрх сэтгэлийнхээ гүнд мэдэж байв.

Үүнийг туулсны дараа би Сатаны хорон муу, жигшүүрт байдлыг олж харсан юм. Сатан намайг мөнгөө алдах гэж байгаагаасаа үүдэн Бурханд гомдоллож, Түүнийг буруушааж, Түүнээс зайгаа барин, зовлон дунд амьдраасай гэсэндээ эргэн тойрны минь хүмүүс, эд юмсыг ашиглан намайг үймүүлж, над руу дайрч давшилжээ. Үүний зэрэгцээ махан биеийн ашиг, алдагдлыг тоохоо больж, итгэлдээ Бурханд найдаж, Бурханы талд зогсдог болох үед маань Бурхан үл итгэгчдийн үгийг ашиглан надад гарах гарц нээж өгч, Сатаныг ичгүүртэйгээр ухрахад хүргэсэн нь харагдаж байлаа. Бүх зүйлийг дайчилж, захирдаг Бурханы эрх мэдлийг харах боломж үүгээр олдсон билээ. **“Би бүхнийг Өөртөө үйлчлүүлэхээр дайчилна, мөн түүнчлэн Өөрийн хүч чадлыг илчилнэ, тэгж байж л бүх орчлон ертөнц дээр бидний гарт байдаггүй нэг ч юм байхгүй гэдгийг, бидэнд үйлчилдэггүй нэг хүн ч байдаггүй гэдгийг, бидний төлөө гүйцэлдээгүй нэг ч зүйл үгүй гэдгийг хүн бүхэнд харуулна”** (“Үг нь махбодоор илэрсэн” номын Христийн эхэн үеийн айлдваруудын “119-р бүлэг”). гэж Бурханы үгэнд бичсэн байдаг. Бурханы үгийг унших тусмаа би Бурханы төгс хүчин, гайхамшигт байдлыг улам их хардаг юм. Бүх зүйл Бурханы гарт байдгийг хараад Бурханд итгэх итгэл минь батажсан бөгөөд цаашид юу тохиолдсон ч бай хамаагүй Бурханы ажлыг илүү их туулж, Сатаны сорилтыг ялан

---

дийлэхийн тулд Бурханд найдах хүсэлтэй болсон билээ.

Сарын дараа би Сатаны сорилттой дахин учрав. Гэрлээд удаагүй охин маань нэг өдөр гэртээ ирээд, хаалганы яг өмнө гэнэт ухаан алдаж унасан юм. Хөрш маань охиныг өргөж, гэрт оруулахад туслав. Би эхлээд хамрын ханиад хүрчхэж гэж бодон нэг их анхаарал хандуулсангүй. Гэвч огт санаанд ороогүй зүйл болж, шөнө дундын үед гэнэт охины маань хамаг бие чичирч эхэллээ. Би маш их айж, яахаа мэдэхгүй байсан боловч охиноо хурдхан шиг энгэртээ тэврэн авахад хэсэг хугацааны дараа арай дээрдэх шиг болов. Маргааш өглөө нь охин минь: “Ээж ээ, явж үүргээ биелүүл. Би зүгээр ээ” гэсэн юм. “Хүндэт Бурхан минь! Бүх зүйл Таны гарт байдаг тул охиноо би Танд даатгая” гэж Бурханд би чимээгүйхэн залбирлаа. Үүний дараа охиндоо хандан: “Жин, чи Бурханд илүү их залбирч, Бурханд найдах хэрэгтэй, Тэр бол биднийг дэмжигч хүчтэй ар тал юм” гэв. Охиноо залбир гэж ятгачхаад би үүргээ биелүүлэхээр явлаа. Хоёр хоногийн дараа эргэн ирэхэд охин маань эмнэлгийн орон дээр ухаангүй хэвтэж байна гэж огт санаагүй билээ. Бэр маань надад хандан гунигтайгаар ингэж хэлэв: “Ээж, таныг явсны дараа Жиний бие муудаж эхэлсэн. Эмч үзээд тархины цус харвалт байна, хагалгаа хийх хэрэгтэй гэсэн. Даанч өнгөрсөн хоёр хоногт Жиний нөхөр та хоёр энд байгаагүй болохоор гарын үсэг зурах хүн байгаагүй. Одоо хагалгаа хийж болох хугацаа өнгөрчихсөн. Бас Жиний өвчин эдгэх боломжгүй, сэхээ орлоо ч комд байна гэж хадам ээжид нь эмч хэлж байхыг сонссон” гэв. Үүнийг сонсоод зүрх рүү минь хутга шаах мэт болж, нүднээс нулимс урсаж эхлэв. Би үүнийг үнэн гэж хүлээж авч чадахгүй байлаа. Тэгээд багахан ч гэсэн найдвар өвөртлөн мэргэжилтэнтэй нь очиж уулзахад тэрээр толгой сэгсрэн ингэж хэлэв: “Бид чадах бүхнээ хийж, хамаг чадлаараа л хичээлээ. Гэхдээ танай охин хамгийн сайндаа сэхээ орсон ч комд байх болно”. Үүнийг сонсох үед тэнгэр нураад ирэх шиг л боллоо. Эцэс төгсгөлгүй зовлон шаналал дунд би амьдарч байлаа... Дараа нь охины минь ямар байдалтай байгааг харсан хүргэн маань эхнэрийнхээ үхэх үү, сэхэх үү гэдгийг тоохгүй, харин ч надад хандан хүний үнэргүй байдлаа харуулж, хурим хийхдээ өгсөн сүйн мөнгөө буцааж авахыг хүсэв. Тэр өдөр эмнэлгээс гэр хүрэх зам маш урт санагдаж, би тэр замаар тэнүүчлэх төөрсөн сүнс болсон байлаа. Яг л урт, харанхуй хонгилоор алхан, урд минь ямар ч гэрэл харагдахгүй байх шиг санагдсан юм.

Гэртээ хариад би Бурханы үгийн номыг арай гэж нээн, ийнхүү уншив: “Газар дээр төрөл бүрийн муу ёрын сүнс амрах газар хайн үүрд тэнүүчилж, идэж болох хүний цогцсыг эцэс төгсгөлгүй хайж байна. Миний ардууд аа! Та нар Миний халамж, хамгаалалт дотор үлдэх ёстой. Хэзээ ч бүү садар самуун бай! Хэзээ ч бүү болчимгүй авирла! Харин үнэнч байдлаа Миний гэрт өргөл болго, та нар диаволын арга мэхний эсрэг зөвхөн үнэнч байдлаар л сөрөг дайралт хийж чадна” (“Үг нь махбодоор илэрсэн”

---

номын Бүх орчлон ертөнцөд хандсан Бурханы айлдваруудын “10-р бүлэг”). **“Зовлон зүдүүртэй тулгарах үедээ чи махан биеийн төлөөх зовнилоо хойш тавьж, Бурханы эсрэг гомдол гаргахгүй байж чаддаг байх ёстой. Бурхан Өөрийгөө чамаас нуух үед Түүнийг дагах итгэлтэй байж, урьдын хайраа бөхөөж, сарниулалгүйгээр хадгалж чаддаг байх ёстой. Бурхан юу ч хийсэн чи Түүний хэв загварт захирагдаж, Түүний эсрэг гомдол гаргахаасаа илүү махан биеэ хараахад бэлэн байх ёстой. Чи шалгалттай тулгарах үедээ хэдийгээр гашуун нулимс унагаж, хайртай эд зүйлээсээ хагацах дургүй байсан ч гэсэн Бурханыг сэтгэл хангалуун болгох ёстой. Энэ л жинхэнэ хайр, итгэл билээ”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Төгс болгуулах хүмүүс цэвэршүүлэлт туулах ёстой”). Бурханы эдгээр үгийг уншиж байхдаа дөнгөж сая болсон явдлыг эргэн бодоод Сатаны жигшүүртэй, хорлонт, хэрцгий байдлыг үнэхээр харж чадсан юм. Сатан намайг Бурханы гараас булааж, сүнсийг минь залгих гэсэндээ алхам тутамд миний эсрэг зальхай явуулга хийж, намайг үймүүлж, над руу дайрч давшилж байв. Эхлээд би хүний сүрдүүлэгт автан, санхүүгийн хохирол амсах вий гэж зовсон бол энэ удаад Сатан хайртай охиноор минь намайг дахин сорьж, охины минь өвчнийг ашиглан намайг Бурханд гомдоллож, Бурханыг үгүйсгэж, Бурханаас урвахад хүргэх гэж оролдож байлаа. Ингэсэн бол би Бурханы эцсийн өдрүүдийн авралыг алдах байсан юм. Эдгээр нь бүгд Сатаны зальжин явуулга байсан билээ. Иов өөрийн цаг үедээ нүүр тулж байсан сорилттой энэ нь яг ижил байв. Энэ бүхний цаана далд тулаан өрнөж байсан бөгөөд Сатан Иовыг эд хөрөнгө, үр хүүхдүүдээ алдахад хүргэж, улмаар Бурханыг орхиулж, Бурханыг үгүйсгэдэг болгохыг хүсэж байсан юм. Гэвч Иов хэзээ ч Бурханыг буруутгаагүй. Харин ч Бурханы нэрийг магтаж, Сатаныг ичгэвтэртэйгээр ухрахад хүргэн, Бурханд үзэсгэлэнтэй сайхан, цангинасан гэрчлэл хийсэн билээ. Махан бие минь сул дорой хэдий ч Сатаны зальжин явуулгыг би нэвт харж, Бурханы талд зогсох ёстой. **“Та нар диаволын арга мэхний эсрэг зөвхөн үнэнч байдлаар л сөрөг дайралт хийж чадна.” “Хэдийгээр гашуун нулимс унагаж, хайртай эд зүйлээсээ хагацах дургүй байсан ч гэсэн Бурханыг сэтгэл хангалуун болгох ёстой. Энэ л жинхэнэ хайр, итгэл билээ.”** гэж Бурхан хэлдэг. Бурханд итгэх итгэл, үнэнч байдлыг минь төгс болгохын тулд Бурхан Сатаны довтолгоог ашиглаж байлаа. Хүний амьдрал, үхлийн аль аль нь Бурханы гарт байдаг тул би охиноо Түүний гарт даатгахад бэлэн байв. Ингэж бодонгоо би газар сөхрөн сууж, гашуун нулимс хацар даган урсаж, Бурханд ийнхүү залбирсан юм: “Төгс Хүчит Бурхан минь! Хүний хувь заяа Таны гарт байдаг. Таныг зөвшөөрөхгүй бол охины минь биед ганц амьсгал үлдсэн ч үхэхгүй. Хэрэв эмчийн хэлсэн шиг охин минь комд орох юм бол би Таныг яасан ч буруутгахгүй, харин Таныг дагасан хэвээр байх болно.”

Тэр шөнө би эмнэлэгт охиныхоо орны дэргэд сууж байгаад зүүрмэглэчихсэн байлаа.

---

“Ээж ээ, ээж, надад ус өгөөч” гэж охиныхоо хэлэхийг сонсоод нойрноосоо сэрэв. Охиныхоо дууг сонсоод зүрх зогсох шахаж, би үсэрч бослоо. Нүдээ нухаад, охин руугаа ширтэв. Охины минь гар үнэхээр хөдөлж, нүдээ нээсэн байлаа. Үүнээс болж сэтгэл хөдлөл минь тэр даруй дээд цэгтээ хүрч, хэлэх үг олдохгүй байсан бөгөөд, “Хөөх, Бурхан минь! Хөөх, Бурхан минь!” гэж уулга алдахаас өөр юм хэлж чадсангүй. Тасагт байсан бас нэг хүн гайхширан: “Хөөх, гайхамшигтай юм! Яаж ингэж гэнэт сайжирчхав аа?” гэв. Би хөл газар хүрэхгүй баярласандаа ямар ч хяналтгүйгээр инээмсэглэж байлаа. Хүний амьдрал, үхэл хоёр Бурханы гарт байдгийг би үнэхээр харсан юм. Бурханы үйл хэрэг үнэхээр гайхамшигтай. Охиныг минь Бурхан л аварсан билээ. Гурван хоногийн дараа охины минь бие гайхмаар сайжирч, яг л эрүүл саруул хүн шиг болсон байлаа. Сатаны гараас ийм цохилт амссаны дараа сүнсний ертөнцөд явагдаж буй тулаан нь маш ширүүн тулаан болохыг би харж чадсанаас гадна Сатаны ёрын гэмээр жигшүүрт байдал, хорон харгислалыг тодорхой харж чадав. Үүний зэрэгцээ би Бурханы хүслийн талаар хавьгүй сайн ойлголттой болсон юм. Бурхан намайг сайтар аварч, төгс болгохын тулд ийм шалгалт нүүрлэхийг зөвшөөрсөн байв. Үүгээр Бурханы төгс хүчин, мэргэн ухааныг ухаарч ойлгон, Бурханы эрх мэдэл, дээд эрхийг бас харах боломж надад олдлоо. Ингэснээр Бурханд итгэх итгэл, үнэнч, дуулгавартай байдал маань төгс болсон бөгөөд Сатаны нөлөөнөөс аврагдаж, амиа өсгөх боломж олдсон юм. Бурхан үнэхээр хайр татам юм байна!

Хожим нь би Бурханы үгийн дараах хэсгийг уншсан юм: “**Миний бүхий л удирдлагын төлөвлөгөө болох зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө нь эхний Хуулийн эрин үе; Нигүүлслийн эрин үе (энэ нь бас Золин авралын эрин үе юм); эцсийн өдрүүдийн Хаанчлалын эрин үе гэсэн гурван үе шат буюу гурван эрин үеэс бүрддэг. Энэ гурван эрин үе дэх Миний ажил өөр өөр эрин үеийн дагуу агуулгаараа ялгардаг боловч энэхүү ажил нь үе шат бүрд хүний хэрэгцээнд нийцдэг—илүү нарийн хэлбэл, энэ нь Сатаны эсрэг Миний явуулдаг дайнд Сатаны хэрэглэдэг арга мэхийн дагуу хийгддэг. Миний ажлын зорилго бол Сатаныг ялж, мэргэн ухаан, төгс хүчээ харуулж, мөн Сатаны бүх арга мэхийг илчилж, улмаар Сатаны эзэмшил дор амьдардаг бүхий л хүн төрөлхтнийг аврах явдал билээ. Энэ нь Өөрийн мэргэн ухаан, төгс хүчийг харуулж, мөн Сатаны тэвчишгүй муу муухайг илчлэхийн төлөө байдаг; цаашлаад сайн мууг ялгах, Би бол бүх зүйлийн Захирагч гэдгийг мэдэх, Сатан бол хүн төрөлхтний дайсан, адгийн муу, ёрын нэгэн гэдгийг тодорхой харах боломжийг бүтээгдсэн зүйлсэд олгож, мөн сайн ба муу, үнэн ба гажууд онол, ариун байдал ба бузар булай болон юу агуу, юу жигшүүртэй гэдгийн хоорондох ялгааг туйлын тодорхой ялган таних боломж олгохын төлөө байдаг. Тийнхүү хүн төрөлхтнийг завхруулдаг нь Би биш, зөвхөн Бүтээгч болох Би л хүн төрөлхтнийг**

---

аварч, таашаан эдэлж чадах зүйлсийг нь хүмүүст хүртээж чадна хэмээн мэдлэггүй хүн төрөлхтөн Надад гэрчлэл хийж чаддаг болно; Би бол бүх зүйлийн Захирагч, Сатан бол Миний бүтээсэн зүйлсийн нэг төдий бөгөөд хожим нь Надаас урвасан юм гэдгийг тэд мэдэж авна” (Үг нь махбодоор илэрсэн номын “Золин авралын эрин үеийн ажлын цаад үнэн түүх”). Бурханы эдгээр үгээр дамжуулан Бурханы хүслийг би илүү сайн ойлгосон юм. Бурханы хийж буй бүх зүйл хүн төрөлхтнийг аврах, хайрлахад чиглэдэг болохыг мөн харж чадсан билээ. Шил дараалан давсан шалгалтуудаа эргэн бодоход хэдийгээр би зарим нэг хүнд бэрхийг туулсан ч маш олон зүйлийг бас олж авсан байлаа. Сатан эргэн тойрны минь хүмүүс болон эд юмсыг үргэлж ашиглан намайг зовоодог байсан ч энэ бүх цаг хугацаанд Бурхан миний дэргэд байж, үгээрээ намайг гэгээрүүлж, замчлан, аливааг илүү сайн ялган таних боломж олгосон гэдгийг би эдгээр туршлагаар дамжуулан олж харсан юм. Бурхан надад дагах зам өгч, итгэл үнэмшил, хүч тэнхээ хайрласан бөгөөд ингэснээр би сул дорой, идэвхгүй байх үедээ тууштай байж чадсан билээ. Энэ замын алхам бүрд би Сатаны харанхуйн нөлөөнөөс салж, Бурханы гайхамшигт үйлийг гэрчилж чадлаа. Эдгээр туршлагаар дамжуулан би амьдралдаа илүү их боловсорч, хатуужсан юм. Дэргэд минь Бурхан байгаа тул Сатаны эдгээр саад тотгор, зовлон шаналлаас айх хэрэггүй гэдгийг би энэ бүхнийг туулснаар мэдэрч авав. Бурханд найдаж, Бурханы үгийг үл орхин, Бурханд итгэж байгаа цагт Сатаны сорилт, довтолгоог ялан дийлэхэд Бурхан биднийг үргэлж чиглүүлэн, ажигч хараан дор нь бид хамгаалуулан амьдрах болно. Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс мөн гэдэгт би улам ч бат үнэмшлээ. Тэр бол миний Эзэн, миний Бурхан билээ! Мөн бид бүтээгдсэн зүйл тул ерөөл хүртэнэ үү, эсвэл хүнд бэрхийг туулна уу хамаагүй үргэлж Бурханыг дуулгавартай дагаж, шүтэн мөргөдөг байх ёстой гэдгийг би хүлээн зөвшөөрч байна. Зүрх сэтгэл минь Төгс Хүчит Бурханыг эцсээ хүртэл дагахаар шийдэн, эргэлт буцалтгүйгээр сэтгэл шулуудсан билээ!

## **30. Тэр өдөр тэнгэр тун цэлмэг, нартай байлаа**

Тиан Инг, Хятад

Би Хятад дахь Гурван-Өөрөө сүмийн итгэгч байлаа. Анх цуглаанд оролцож эхлэхэд пастор: “Ах, эгч нар аа: ‘Учир нь хүн зүрх сэтгэлдээ итгэн зөв шударга байдалд хүрдэг; мөн амаараа хүлээн зөвшөөрч авралд хүрдэг’ (Ром 10:10) гэж Библид бичигдсэн байдаг. Бид итгэлээрээ зөвтгөгдсөн, Есүст итгэдэг тул аврагдсан. Хэрвээ бид өөр бусдад итгэсэн бол аврагдахгүй байх байсан...” хэмээн үргэлж бидэнд хэлдэг байлаа. Би пасторын эдгээр үгийг үргэлж санадаг байв. Иймээс би гал халуунаар эрэлхийлж, цуглаанд идэвхтэй оролцон, Эзэн ирж, намайг тэнгэрийн хаанчлал руу хүлээн авахыг хүлээх болсон юм.

---

Дараа нь, хууль бус үйл хэрэг сүмд үргэлжлүүлэн гарсаар байсан тул би тэндхийн цуглаанаас залхаж эхэллээ. Пасторууд өөр хоорондоо хуваагдаж, өөрсдийгөө бүлэглэлийн тэргүүнд томилж, бие даасан хаанчлалуудыг бий болгохоор хичээгээд зогсохгүй, пасторуудын номлол нь Нэгдсэн Фронтын Ажлын Алба (НФАА)-ны тогтоосон хүрээнд хязгаарлагдаж байв. НФАА “ард түмний дунд үймээн өдөөх” вий гэхээс айсандаа Илчлэлийн Номоос номлохыг пасторуудад зөвшөөрдөггүй байсан учраас пасторууд Илчлэлийн номоос номлодоггүй байлаа. Пасторууд ихэнхдээ хандивын талаар номлон, хүн ихийг хандивлах тусам, Бурханаас илүү их ерөөл хүлээн авна хэмээн хэлдэг байлаа. Сүм ийм нөхцөл байдалтай байхыг хараад би нэлээд будилав: Яагаад сүм ийм байхад хүрэв? Пасторууд Эзэнд итгэдэггүй гэж үү? Яагаад тэд Эзэний үгийг дагадаггүй билээ? Яагаад тэдэнд Эзэнийг гэх хүндлэл өчүүхэн ч байдаггүй вэ? Тэд бол Бурханд үнэн сэтгэлээсээ итгэдэггүй, ах эгч нарын зовж олсон мөнгийг олж авахын тулд Бурханд итгэсэн дүр үзүүлдэг хуурамч хоньчид хэмээн бодсон учир тэр үеэс хойш би Гурван-Өөрөө сүмийн цуглаан руу явахыг хүсэхээ болив.

1995 оны сүүлчээр би ямар ч эргэлзээгүйгээр сүмийг орхиж, гэр чуулганд (дан ганц итгэлийн талыг баримтлагч чуулган) нэгдсэн юм. Эхэндээ би тэдний номлолуудыг улсын засгийн газар хязгаарлаагүй гэж бодсон бөгөөд тэд Илчлэлийн номыг хүртэл номлолдоо багтааж, эцсийн өдрүүд, Эзэний эргэн ирэлт гэх мэтийг хэлэлцдэг байв. Тэдний номлол Гурван-Өөрөө сүмийн пасторуудынхаас хавьгүй дээр байсан ба Гурван-Өөрөө сүм дэх цуглаантай харьцуулахад эндхийн цуглаан илүү таатай санагдсан нь намайг машид баяр хөөртэй болгов. Гэвч хэсэг хугацааны дараа, энд ч бас, атаархаж, аливаа зүйл дээр маргаж, хагалан бутаргахыг хүсдэг зарим хүн хамтран зүтгэгчдийн дунд байгааг олж мэдэв. Ах, эгч нарын хэн нь ч Эзэний шаардлагуудыг амьдран харуулахгүй байсан бөгөөд тэд урьдынх шигээ элэгсэг биш байлаа. Энэ чуулган Гурван-Өөрөө сүмээс ямар ч ялгаагүй байсан тул би ихэд сэтгэлээр унаж, бас Ариун Сүнсний ажилтай чуулганыг хаанаас олж болохоо мэдэхгүй байв. Илүү дээр сонголт байхгүйн улмаас би энэхүү дан ганц итгэлийн талыг баримтлагч чуулгантай үлдэхээс өөр аргагүй байсан тул цуглаануудад нь оролцсоор байлаа. Пастор болон номлогчид бүгд “нэг удаа аврагдах гэдэг нь үүрд аврагдах юм”, мөн “эцсийг нь хүртэл тэвчээртэй байж, Эзэний төлөө хөдөлмөрлөж, Эзэний замыг хамгаалж байгаа цагт чи тэнгэрийн хаанчлалд орж чадна” гэдэг байв. Иймээс тэр үед би: “Бусад хүмүүст юу ч тохиолдлоо гэсэн, Эзэн Есүст итгэх итгэлээ үргэлжлүүлж, Эзэний замаас холдохгүй байсан цагт, Эзэнийг эргэн ирэхэд би тэнгэрийн хаанчлал руу өргөгдөх боломжтой болно” гэж бодсон юм.

Нүд ирмэх зуур хэдийнээ 1997 оны сүүлч болж, Бурханы хаанчалын сайн мэдээ хэдийнээ бидэнд хүрч, чуулган эмх замбараагүй болов. Удирдагч Ли бидэнд хэлэхдээ:

---

“Өнөө үед, Зүүний Аянгыг түгээж буй бүлэг гарч ирсэн, тэд янз бүрийн бүлэглэлээс хоньдыг хулгайлж, Эзэн Есүс хэдийнээ эргэн ирсэн бөгөөд ажлын шинэ үе шатыг хэрэгжүүлж байгаа хэмээн хэлж байна. Эзэн Есүс бидний төлөө загалмайд цовдлогдож, биднийг золин аврахын тулд хэдийнээ Өөрийн амиар төлөөс төлсөн. Бид аль хэдийн аврагдсан. Бид ердөө эцсийг нь хүртэл тэвчих хэрэгтэй бөгөөд Эзэнийг эргэн ирэх үед гарцаагүй тэнгэрийн хаанчлал руу өргөгдөнө. Иймээс бид анхааралтай байж, Зүүний Аяндын энэ хүмүүсийг яавч хүлээн авч болохгүй. Тэднийг хүлээж авсан хэн ч бай чуулганаас хөөгдөх болно! Бас та нар тэдний хэлж байгааг яасан ч сонсохгүй байх ёстой, тэдний номыг яасан ч уншихгүй байх ёстой...” гэлээ. Бүх түвшний хамтран зүтгэгчид эдгээр зүйлийн талаар бараг цуглаан болгон дээр ярьж байв. Тэднийг сонссоны дараа ах эгч нар өөрийн мэдэлгүй Зүүний Аянтыг эсэргүүцэж, тэднээс сэрэмжилж эхэлсэн юм. Би Зүүний Аянгад хулгайлагдаж, улмаар тэнгэрийн хаанчлалд орох боломжоо алдах вий гэдгээс айсандаа бүр ч илүү их хянуур, сэрэмжтэй болж эхэллээ.

Гэвч, 1998 оны шинэ жил дөнгөж эхэлж байтал нэгэн өдөр би Төгс Хүчит Бурханы Чуулганы хүнтэй санамсаргүй таарч, Зүүний Аяндын замыг анх удаа сонсох хувь тохиов. Тэр өдөр эгч минь над руу утасдаж, гэртээ урьсан юм. Эгч өөрийнхөө тосгоны Ху эгчийг ч бас хүрч ирээч гэж урьсан байв. Ху эгч намайг хараад инээмсэглэн: “Өө ашгүй чи ирээ юу. Эзэнд итгэдэг холын хамаатан маань ч бас ирж байгаа. Бүгдээрээ цуглаан хийвэл яасан юм бэ?” гэж хэллээ. Би баяртайаа зөвшөөрөв. Удалгүй Ху эгч хамаатантайгаа хамт буцаж ирэв. Тэр эгч биднийг хараад урам зоригтойгоор мэндчиллээ. Хэдийгээр түүнтэй өмнө нь хэзээ ч уулзаж байгаагүй боловч надад нэг л дотно санагдсан юм. Тэрээр ингэж хэлэв: “Ойрын өдрүүдэд чуулганы эзгүйрэл өргөн тархаад байна. Номлогчдод номлох ямар ч шинэ, шинэлэг зүйл байхгүй болжээ. Цуглаан болгон дээр Зүүний Аянтыг хэрхэн эсэргүүцэх талаар номлохоос бусад үед ердөө бичлэг сонсож, магтан дуу л дуулцгааж байна. Цуглаанууд дээр ийм юм л тохиолдож байна. Хамтран зүтгэгчид нэг нэгэндээ атаархаж, маргалдаж, сүлбэлдэж, хуйвалдаж, бүгд өөрсдийгөө туйлын их зөвтгөдөг, хэн нь ч хэнийгээ сонсдоггүй. Ах, эгч нар сөрөг, сул дорой бөгөөд тэд итгэл, хайраа алдчихсан. Олон хүн мөнгө олохын тулд дэлхий ертөнц рүү буцахаар Эзэнийг орхисон.” Миний дотор ч бас яг тэгж санагдсан ба толгой дохингоо би эгчид: “Манай чуулганд ч бас яг тийм байгаа. Урьд нь сар тутмын цуглаан дээрээ бид 20–30 хүнтэй байдаг байсан, харин одоо тэнд ердөө хэдхэн ахимаг насны хүмүүс л байдаг бөгөөд номлогч нар хүртэл мөнгө олохоор дэлхий ертөнц рүү явчихсан! Цуглаануудаас авах таашаал огт байхгүй болсон” гэлээ. Эгч толгой дохин, ингэж хэллээ: “Энэ төрлийн нөхцөл байдал хэдхэн чуулганд л байгаа юм биш ээ, энэ бол шашны ертөнц даяар тархсан түгээмэл үзэгдэл. Ариун Сүнсний ажил чуулган дотроос олдохоо больсон тул хууль бус үйл хэрэг цаг ямагт үйлдэгдсээр



---

байгааг энэ нь харуулдаг. Энэ бол Эзэний эргэн ирэлтийн дохио юм. Хуулийн эрин үеийн төгсгөлд сүм нь мал зарж, мөнгө сольдог газар болсон байсантай энэ нь яг ижилхэн. Энэ нь, Бурхан Өөрийн ажлыг сүмд хэрэгжүүлэхээ хэдийнээ больж, оронд нь, ажлынхаа шинэ үе шатыг сүмийн гадна хэрэгжүүлэхээр Эзэн Есүсийн бие махбодтой болсон байснаас үүдсэн.” Би анхааралтай сонсож, байн байн толгой дохиж байлаа. Эгч үргэлжлүүлэн: “Эгч ээ, Лук 17:24-26–д: **‘Учир нь тэнгэрийн нэг хязгаараас нөгөө хязгаар хүртэл цахилдаг аянга шиг; хүний Хүү ч бас Өөрийн өдөртөө тийнхүү байх болно. Гэхдээ Тэр эхлээд олон зовлон туулах ёстой бөгөөд энэ үеийнхэнд гологдоно. Ноагийн өдрүүдэд ямар байсан шиг Хүний Хүүгийн өдрүүдэд ч бас тийм байх болно’** гэж байдаг. Бичвэрийн эдгээр мөрийг та хэрхэн тайлбарлах вэ?” гэв. Би эдгээрийн талаар хэсэг зуур нухацтай бодоод, эв хавгүй инээмсэглэн: “Эгч ээ, Бичвэрийн энэ мөрүүд Эзэний ирэлтийн талаар ярьж байгаа юм биш үү?” гэлээ. Эгч ингэж хариуллаа: “Бичвэрийн эдгээр мөр Эзэний ирэлтийн тухай хэлж байгаа. Гэхдээ хуучны тэр өдрүүдэд ирсэн Эзэн Есүсийн ирэлтийн талаар хэлж байгаа юм биш. Харин ч эдгээр нь эцсийн өдрүүдийн Эзэний ирэлтийг хэлж байгаа юм, учир нь Өөрийг нь эцсийн өдрүүдэд эргэн ирэхэд юу тохиолдохыг Эзэн энд тун тодорхой зөгнөж байна. Эгч ээ, яг одоо чуулган дахь итгэгчдийн итгэл нь хөрч, тэд сөрөг, сул дорой болсон. Үүний учир нь ажлын шинэ үе шатыг хэрэгжүүлэхээр Бурхан дахин нэг удаа махбод болсон юм. Бурханы ажил урагшилсан ба Бурханы шинэ ажлыг дагадаггүй хүн бүр Ариун Сүнсний ажлыг алдах болно.” Эзэн Есүс аль хэдийн эргэж ирсэн гэж эгчийн хэлэхийг сонсмогцоо би тэр даруй Зүүний Аянгад харьяалагддаг гэдгийг нь таамагласан бөгөөд зүрх сэтгэл минь тэр дороо гуниглав. Нүүрэн дээрх инээмсэглэл алга болохын зэрэгцээ чуулганыг битүүмжилсэн удирдагчдын маань үг даруй толгойд минь эргэлдэж эхлэв: “Есүст итгэх гэдэг нь аврагдах юм, нэгэнт аврагдсан бол үүрд аврагдсан!... Зүүний Аянгын хүмүүсийг бүү хүлээж ав!...” Удирдагчдынхаа эдгээр үгийг бодоод би гэртээ хурдан харихыг хүсэв. Гэвч оюун ухаанд минь энэ санаа орж ирэх үед Эзэн надад магтан дууны энэ бадгийг сануулж, намайг гэгээрүүллээ: “Есүс бол бидний хоргодох газар, асуудалтай байх үедээ Түүнтэй хамт нуугд, Эзэнтэй цуг байхад чамд айх зүйл юу байх юм бэ?” “Тийм шүү дээ! Хэрвээ Эзэн хажууд минь байвал надад айх зүйл юу байх билээ? Миний айдаг зүйлс Бурханаас ирдэггүй, Сатанаас ирдэг” гэж би бодлоо. Яг тэр үед эгч: “Хэрвээ хэн нэгэнд ямар нэг асуулт байвал, алив, тэрийгээ хуваалц. Бидэнд байгаа асуудал, бэрхшээлийг бүгдийг нь Бурханы үг шийдвэрлэж чадна” гэж хэллээ. Би эгчийн ингэж хэлэхийг сонсоод: “Та миний асуултуудад хариулж чадахгүй байж магадгүй! Маш олон сайн хонийг хулгайлж чадсан Зүүний Аянгад яг үнэндээ юу номлодгийг би одоо олж мэдэх хэрэгтэй” гэж дотроо бодлоо.

Энэ тухай бодоод би шууд гол зүйлдээ орж, санаачилга гаргахаар шийдэн, ингэж

---

хэллээ: “Эзэн Есүс бидний төлөө загалмайд цовдлогдсон, мөн биднийг золин аврахын тулд аль хэдийн Өөрийн амиар төлөөс төлсөн, тиймээс бид аврагдсан гэж манай удирдагчид байнга хэлж байгаа. Бичвэрт: ‘Учир нь хүн зүрх сэтгэлдээ итгэн зөв шударга байдалд хүрдэг; мөн амаараа хүлээн зөвшөөрч авралд хүрдэг’ (Ром 10:10) гэж тэмдэглэгдсэн байдаг. Бид нэгэнт аврагдсан л бол үүрд аврагдсан, иймээс эцсийг нь хүртэл тэвчих л юм бол Эзэнийг эргэн ирэхэд гарцаагүй тэнгэрийн хаанчлал руу өргөгдөнө. Энэ бол Эзэний бидэнд өгсөн амлалт. Тиймээс бид Бурханы хэрэгжүүлж байгаа ямар ч шинэ ажлыг хүлээн зөвшөөрөх шаардлагагүй.”

Эгч инээмсэглэн, надад ийн хэллээ: “Эзэн Есүс бидний төлөө загалмайд цовдлогдсон бөгөөд биднийг золин аврахын тулд Есүс Өөрийн амиар төлөөс төлсөн учраас бид аврагдсан гэж олон итгэгч боддог. Нэгэнт аврагдсан бол үүрд аврагдсан хэрэг бөгөөд бид ердөө эцсийг нь хүртэл тэвчих л хэрэгтэй, тэгээд Эзэнийг эргэн ирэхэд бид тэнгэрийн хаанчлал руу гарцаагүй өргөгдөнө, харин Бурханы хэрэгжүүлдэг аливаа шинэ ажлыг хүлээн зөвшөөрөх шаардлагагүй гэж хүмүүс боддог. Гэхдээ ингэж бодох нь үнэхээр зөв үү? Энэ нь Эзэний хүсэлтэй үнэхээр нийцдэг үү? Үнэндээ, ‘нэгэнт аврагдсан бол үүрд аврагдсан хэрэг бөгөөд Эзэнийг эргэн ирэхэд бид тэнгэрийн хаанчлал руу өргөгдөнө’ гэх санаа нь ердөө л хүний үзэл, төсөөлөл бөгөөд Эзэн хэлсэн зүйлтэй ердөө нийцдэггүй. Эзэн Есүс, итгэлээрээ аврагдсан хүмүүс тэнгэрийн хаанчлалд орж болно гэж нэг ч удаа хэлээгүй, харин ч Тэрээр **‘харин тэнгэрт байгаа Миний Эцэгийн хүслийг биелүүлдэг хүн орно’** (Матай 7:21) хэмээн хэлсэн. Аврагдах болон тэнгэр дэх Эцгийн хүслийг биелүүлэх гэдэг нь адилхан зүйл биш. Бид итгэлээрээ аврагдах тухай ярих үед энэхүү аврагдах гэдэг нь нүглээ уучлуулахыг хэлдэг. Өөрөөр хэлбэл, хэрвээ хүн хуулийн дагуу цаазаар авхуулах ёстой байсан боловч Эзэний өмнө ирж, гэмшиж, Эзэний авралыг хүлээн авбал Эзэн нүглийг нь уучилж, тухайн хүн хуулийн ялаас ангижрах бөгөөд хуулийн дагуу цаазлуулахаа болино. Энэ бол аврагдах гэдгийг жинхэнэ утга учир юм. Харин аврагдах гэдэг нь тухайн хүн нүглээсээ чөлөөлөгдөж, цэвэрлэгдсэн гэсэн үг биш. Бид бүгдээрээ үүнийг гүн гүнзгий туулсан. Хэдийгээр бид Эзэнд олон жилийн турш итгэж, Эзэнд нүглээ үргэлж улайж, гэмшиж, бас нүглээ уучлуулахын баяр хөөр, амар тайвныг эдэлдэг хэдий ч бид үргэлж өөрийн эрхгүй нүгэл үйлдэж, нүгэлдээ хүлэгддэг. Энэ бол баримт. Жишээ нь, биеэ тоосон зан, овжин байдал, аминч зан, шунал, хорон муу байдал гэх мэт ялзарсан зан чанар маань оршин байсаар байгаа; бид дэлхий ертөнцийн чиг хандлага, эд хөрөнгө, нэр хүнд, махан биеийн зугаа цэнгэлээр хөөцөлдөх дуртай бөгөөд нүгэлт таашаалд шунадаг. Хувийн ашиг сонирхлоо хамгаалахын тулд бид ихэвчлэн худал хэлж, бусдыг хууран мэхлэх чадвартай байдаг. Иймээс, аврагдах гэдэг нь хүн бүрэн авралыг олж авсан гэсэн үг биш. Энэ бол бодит баримт. Бичвэрт: **‘Тиймээс та нар ариун бай, учир нь Би ариун**

---

**билээ’** (Леви 11:45) гэж тэмдэглэгдсэн байдаг. Бурхан ариун, тэгвэл үргэлж нүгэл үйлддэг, Бурханыг эсэргүүцдэг хүмүүст Тэр тэнгэрийн хаанчлалд орохыг зөвшөөрнө гэж үү? Хэрвээ чи итгэлээрээ аврагдсан хүмүүс тэнгэрийн хаанчлалд орж болно гэж итгэдэг юм бол яагаад Эзэн Есүс бас дараах үгийг хэлсэн юм бэ? **‘Намайг, “Эзэн минь, Эзэн минь” гэсэн бүхэн тэнгэрийн хаанчлалд орохгүй; харин тэнгэрт байгаа Миний Эцэгийн хүслийг биелүүлдэг хүн орно. Тэр өдөр олон хүн, “Эзэн минь, Эзэн минь, бид Таны нэрээр эш үзүүлээгүй гэж үү? Таны нэрээр чөтгөрүүдийг хөөгөөгүй гэж үү? Мөн Таны нэрээр гайхамшгуудыг үйлдэж байгаагүй гэж үү?” гэх болно. Тэгэхэд нь Би тэдэнд ингэж хэлнэ, “Би та нарыг хэзээ ч танихгүй: ёс бусыг үйлдэгчид та нар Надаас зайл” гэж хэлнэ’** (Матай 7:21–23). Эзэн эргэн ирэх үедээ ямааг хониноос, буудайг үрийн сүүлнээс салгах болно гэж яагаад хэлдэг вэ? Тиймээс, итгэлээрээ аврагдсан хүмүүс тэнгэрийн хаанчлалд орж болно гэж хэлж огт болохгүй. Энэ нь Эзэн Есүсийн үгтэй огт нийцдэггүй ба Эзэний үгийг эсэргүүцдэг! Тэгэхээр хэрвээ бид Эзэний үгийг хүлээж авдаггүй, үүнд итгэдэггүй, харин ч пастор, ахлагчдын тараасан гажууд онолтой зууралдан, Бурханд итгэхдээ өөрсдийн үзэл, төсөөлөлд найддаг бол Эзэний шаардлагад хэзээ ч нийцэж чадахгүй бөгөөд тэнгэрийн хаанчлал руу хэзээ ч өргөгдөж чадахгүй.”

Би эгчийн үгийг тунгаан бодоход хэлсэн зүйл нь үнэхээр ортой юм гэж санагдсан тул чимээгүйхэн сонсоод сууж байлаа. Эгч цааш үргэлжлүүлэн ингэж ярих: “Төгс Хүчит Бурханы үг аврагдах болон бүрэн аврал хүртэхийн нууцыг аль хэдийн илчилсэн, иймээс Төгс Хүчит Бурханы үгийг харж, энэ тухай юу гэж хэлэхийг нь үзэцгээе. Төгс Хүчит Бурхан ингэж хэлдэг: **‘Тухайн үед Есүсийн ажил бүх хүн төрөлхтнийг золин аврахын төлөө байв. Түүнд итгэсэн бүх хүний нүгэл уучлагдсан; чи Түүнд итгэдэг л бол Тэр чамайг золин аврах байсан; хэрвээ Түүнд итгэсэн бол чи нүгэлтэн байхаа больж, нүглээсээ чөлөөлөгдөх байв. Аврагдах, итгэлээр зөвтгөгдөх гэдэг нь энэ юм. Гэхдээ итгэсэн хүмүүст ч Бурханыг эсэргүүцдэг, тэрслүү зүйл үлдсэн бөгөөд үүнийг мөн л аажмаар арилгах хэрэгтэй байлаа. Аврал гэдэг нь Есүс хүнийг бүрэн олж авсан гэсэн үг биш, харин хүн нүгэлтэн байхаа больж, нүглээ уучлуулсан гэсэн үг юм. Чи итгэх л юм бол дахиад хэзээ ч нүглийнх байхаа болих юм’** (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурханы ажлын үзэгдэл (2)”). **‘Хүнийг золин аврахаас өмнө Сатаны олон хор аль хэдийн түүний дотор суучихсан бөгөөд Сатанаар олон мянган жил завхруулагдсаны дараа хүний дотор Бурханыг эсэргүүцэх уг чанар тогтсон байдаг. Тиймээс хүнийг золин аврах нь хүнийг өндөр үнээр буцаан авсан золин авралаас цаашгүй байсан боловч хүний доторх хорт уг чанарыг таягдан хаяагүй юм. Ингэж их бузартсан хүн Бурханд үйлчлэхүйц болохоосоо өмнө өөрчлөгдөх ёстой. Шүүлт, гэсгээлтийн энэ ажлаар дамжуулан өөрийнхөө доторх бохир, завхарсан мөн чанарын талаар хүн**

---

бүрэн мэдэж авах бөгөөд бүрэн өөрчлөгдөж, цэвэр болж чадна. Ийм маягаар л хүн Бурханы сэнтийн өмнө буцан очих үнэ цэнтэй болж чадна... Хүнийг золин аварч, нүглийг нь уучилсан тухайд бол, Бурхан хүний гэм бурууг санадаггүй, гэм буруугийнх нь дагуу хүнд ханддаггүй гэж л авч үзэж болох юм. Гэвч махан биед амьдардаг хүн нүглээс ангижраагүй бол үргэлжлүүлэн нүгэл үйлдэж, завхарсан сатанлаг зан чанараа эцэс төгсгөлгүй илчилж л чадна. Энэ бол хүний амьдардаг, нүгэл үйлдэж, нүглээ уучлуулдаг эцэс төгсгөлгүй орчлын амьдрал юм. Хүн төрөлхтний ихэнх нь өдөр нь нүгэл үйлдээд орой нь нүглээ улайдаг. Ийм маягаар нүглийн тахил хүний хувьд үүрд хүчинтэй байдаг ч энэ нь хүнийг нүглээс аварч чадахгүй. Хүн завхарсан зан чанартай байсаар байгаа тул авралын ажлын хагас нь л гүйцэлдсэн... Нүглээс илүү гүн нэвчсэн энэ нь Сатаны суулгасан, хүний дотор гүнзгий үндэслэсэн зүйл юм. Хүн өөрийнхөө нүглийг мэддэг болох нь маш амаргүй; тэр өөрийнх нь дотор гүнзгий үндэслэсэн уг чанарыг таних ямар ч аргагүй байдаг бөгөөд энэ үр дүнд хүрэхийн тулд үгийн шүүлтэд найдах ёстой. Тэгж байж л хүн энэ үеэс эхлэн аажмаар өөрчлөгдөж чадна’ (Үг нь махбодоор илэрсэн номын “Бие махбодтой болохын нууц (4)”). ‘Есүс эцсийн өдрүүдэд бууж ирнэ гэдгийг л чи мэддэг, гэхдээ Тэр яг яаж бууж ирэх вэ? Дөнгөж золин аврагдсан, өөрчлөгдөөгүй, эсвэл Бурханаар төгс болгуулаагүй чам мэтийн нүгэлтэн Бурханы зүрх сэтгэлийн дагуу байж чадах уу? Одоо ч гэсэн хуучин хэвээрээ байгаа чиний хувьд, Есүсээр авруулж, Бурханы авралын улмаас нүгэлтэн гэж тооцогдохгүй байгаа чинь үнэн боловч нүгэлтэй биш, бохир заваан биш гэдгийг чинь энэ нь нотлохгүй. Хэрвээ өөрчлөгдөөгүй юм бол чи яаж ариун байж чадах юм бэ? Дотроо чи бохир заваанаар дүүрч, хувиа хичээсэн, өөдгүй байдаг мөртөө Есүстэй хамт буухыг хүссээр байдаг— тийм азтай явдал байна гэж үү дээ! Бурханд итгэх итгэлдээ чи нэг алхмыг орхисон: Чи зүгээр л золин аврагдсан, гэхдээ өөрчлөгдөөгүй. Чи Бурханы зүрх сэтгэлийн дагуу байхын тулд чамайг өөрчилж, цэвэрлэх ажлыг Бурхан биечлэн хийх ёстой; чи зөвхөн золин авруулсан бол ариун байдалд хүрч чадахгүй. Ийм маягаар чи Бурханы сайн ерөөлийг хуваалцах эрхгүй байх болно, учир нь чи хүнийг удирдах Бурханы ажилд нэг алхмыг орхигдуулсан, энэ нь өөрчлөгдөж, төгс болох гол алхам юм. Тиймээс дөнгөж золин аврагдсан нүгэлтэн чи Бурханы өв залгамжлалыг шууд өвлөн авч чадахгүй’ (Үг нь махбодоор илэрсэн номын “Нэршил болон ялгамж чанарын талаар”).

Эгч тэгээд нөхөрлөлөө ийн үргэлжлүүлээ: “Төгс Хүчит Бурханы үгээс бид, Бурханы гүйцэтгэдэг ажлын үе шат бүр нь завхарсан хүн төрөлхтний хэрэгцээний дагуу явагддагийг харж болно. Хуулийн эрин үеийн төгсгөлд, хүнийг Сатан улам бүр гүн завхруулж, хүн улам их нүгэл үйлдэх болсон. Хүн Еховагийн хуулийг зөрчиж, чулуу

---

шидүүлж үхэх, тэнгэрийн галд шатаагдах аюултай тулгарсан. Бурхан хүн төрөлхтөнд хайртай. Тэрээр нүгэлт махан биеийн төрхтэй болохын тулд Өөрөө бие махбодтой болж, хүн төрөлхтнийг нүглээс золин аврахаар загалмайд цовдлогдсон. Тиймээс бид Эзэн Есүст итгэж л байвал аврагдах болно. Эзэн бидний нүглийг санахгүй. Бид Бурханы өмнө шууд очиж, Түүнд залбирч, Түүний хайрласан арвин нигүүлслийг эдэлж болно. Гэхдээ бид хэдий золин аврагдсан ч энэ нь нүгэлгүй гэдгийг маань нотолдоггүй. Хүн төрөлхтөн биднийг Сатан олон мянган жил завхруулж, Сатаны хор бидний дотор гүн үндэслэж, бидний амь, бидний уг чанар болсон. Биеэ тоосон, ихэрхүү байдал, заль мэх, шударга бус зан, хувиа хичээсэн байдал, үзэн ядалт, шунал болон ёрын муу гэх мэт сатанлаг уг чанар маань биднийг хянадаг. Бид одоо ч үргэлж худал хэлж, Бурханыг эсэргүүцэн, хууран мэхэлж, нүгэл үйлдэх чадвартай. Энэ бол байнга нүгэл үйлдээд, дараа нь нүглээ улайх мөчлөгт амьдардгийн маань уг үндэс юм. Тиймээс Бурхан завхарсан хүн төрөлхтний хэрэгцээ болон хүн төрөлхтнийг аврах Бурханы удирдлагын төлөвлөгөөнд үндэслэн биднийг цэвэрлэж, завхарсан зан чанарыг маань өөрчлөхийн тулд хүнийг шүүж, гэсгээхээр эцсийн өдрүүдэд ажлын шинэ үе шатыг гүйцэтгэх гэж ирсэн ба эцэст нь Бурхан аврал хүртэж, төгс болгуулсан хүмүүсийг хаанчлал руугаа хөтөлнө. Хэрэв бид одоо ч ‘нэг л аврагдсан бол үүрд аврагдсан’ хэмээх үзэлтэй зууралдсаар байвал эцсийн өдрүүд дэх Бурханы шүүлтийн ажлыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж байгаа хэрэг. Тэгвэл цусанд маань байгаа Сатаны хор хэзээ ч цэвэрлэгдэхгүй, бид Бурханы бүрэн авралыг хүртэж хэзээ ч чадахгүй бөгөөд тэнгэрийн хаанчлал руу өргөгдөж бүр ч чадахгүй. Эдгээр үр дагавар маш ноцтой. Тиймээс, одоо энэ эцсийн өдрүүдэд Нигүүлслийн эрин үеийг орхиж, Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн шүүлтийн ажлыг хүлээн зөвшөөрснөөр л хүн бүрэн цэвэрлэгдэж, Бурханы бүрэн авралыг хүртэж, сайн хүрэх газарт очих болно.”

Эгчийн нөхөрлөхийг сонсонгоо би дотроо: “Тийм ээ, Төгс Хүчит Бурханы үг маш бодитой юм. Сүүлийн энэ хэдэн жилд би өдөр нь нүгэл үйлдэж, шөнө нь нүглээ улайдаг амьдралаар байнага амьдарч ирсэн биш үү? Бид үнэхээр Эзэнд итгэх итгэлийнхээ ачаар зөвхөн нүглээ уучлуулсан боловч бидний нүгэлт уг чанар оршсон хэвээр байна. Бид нүгэл үйлдэж, Бурханыг эсэргүүцэж бас л чадна. Эзэн бол ариун, тэгэхээр үргэлж нүгэл үйлдэж, Түүнийг эсэргүүцдэг хүмүүс яаж тэнгэрийн хаанчлал руу өргөгдөж чадах билээ? Миний оюун санаанд олон жил хүнд ачаа болж явсан эдгээр асуудлыг Төгс Хүчит Бурханы үг тайлж өглөө. Төгс Хүчит Бурханы үг бидний эрж хайх үнэнийг үнэхээр агуулдаг. Төгс Хүчит Бурхан үнэхээр эргэн ирсэн Эзэн мөн юм гэж үү? Би үнэхээр энэ талаар зохих ёсоор судлах хэрэгтэй юм байна” гэж бодов.

Би аажмаар эгчээс сэрэмжлэхээ больж эхэлсэн ч хэлэлцсэн асуудлынхаа талаар судалъя гэж яг бодож суутал хаалгыг чанга, яаруу байдалтай тогших сонсогдлоо. Ху эгч

---

яаран хаалга тайлахад манай пастор өрөө рүү дайран орж ирлээ. Тэрээр над руу харснаа, дараа нь Төгс Хүчит Бурханы хаанчлалын сайн мэдээг түгээж байсан эгч рүү хараад, дараа нь надад хандан гайхширч, уурласан өнгөөр: “Энд юу хийж яваа юм бэ? Би танд энд тэнд танихгүй хүмүүсийн номлохыг битгий сонсоорой гэж хэлээгүй юу? Тэгсээр байтал энд гүйж ирж, эднийг сонсож яаж чадаж байна аа? Даруйхан гэртээ харь, эднийг дахиж бүү сонс. Хэрвээ хууртах юм бол гэмшихэд хэтэрхий оройтно шүү!” гэлээ. Пастор намайг зэмлэж дуусаад, эгчийг сүрдүүлж эхэллээ: “Тэгээд Зүүний Аянгыг түгээж байгаа та нар, манай чуулганд ирж, хонин сүргийг хулгайлахаас өөр юу ч хийдэггүй. Даруйхан явж үз! Хэрэв явахгүй бол би найр тавихгүй шүү!” Пастор эгчид ингэж хандахыг хараад нэлээд эгдүүцсэн тул би түүнд ингэж хэллээ: “Пастор аа, энэ эгч ердөө үнэхээр сайхан зүйлс хэллээ, тэгээд хэлсэн зүйл нь Библитэй нийцэж байна. Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн байж тун магадгүй гэж санагдаж байна. Та зүгээр л сонсоод үзвэл яасан юм бэ, дараа нь бид шийдэж болно шүү дээ. Тэгээд ч, Библид ‘Танихгүй хүмүүсийг дайлахаа бүү март: учир нь үүгээрээ зарим хүн өөрийн мэдэлгүйгээр тэнгэрэлчүүдийг дайлсан юм’ (Еврей 13:2) гэж хэлдэг биш үү? Эзэнд итгэдэг бид хайр энэрэл харуулах ёстой, бид хүмүүст ингэж хандаж болохгүй. Энэ эгчийг ингэж дайрах нь Эзэний сургаалаас гажих биш үү?” Пастор тэгтэл: “Та юу ойлгодог юм бэ? Есүст итгэдэг бид аль хэдийн аврагдсан. Дахиж аврагдах шаардлагагүй! Тэд энд манай хонин сүргийг хулгайлах гэж ирээд байна, тиймээс тэднийг хүлээж авах ёсгүй!” гэж над руу хашхичлаа. Энэ удаад сайн мэдээ түгээж байсан эгч инээмсэглэн: “Бид бүгд л Эзэний эргэн ирэхийг хүлээж байгаа, тэгэхээр яагаад суугаад ярилцаж болохгүй гэж? Хэрэв бид Эзэний эргэн ирэлтийг өнгөрөөчихвөл, үүндээ ихээхэн харамсана шүү—” гэж хэллээ. Эгчийг яриулж дуусгалгүй пастор, “Битгий ярь! Чи хэчнээн сайн ярьдаг байлаа ч, би сонсохгүй! Бушуу яв!” гэж хэлээд эгчийг гадагш түлхэж эхэллээ. Яг л ийм байдлаар пастор эгчийг нааш цааш түлхэж, татаж, харааж, гэрээс хөөн гаргалаа. Эгчийг явсны дараа пастор эргэж хараад, намайг сүрдүүлэн: “Бушуу гэртээ харь. Одооноос таныг Зүүний Аяндын хүмүүстэй холбоотой байхыг зөвшөөрөхгүй. Эс бөгөөс, таныг чуулганаас хөөнө, хэрэв тэгвэл танд Бурханы магтаалыг хүлээн авч, тэнгэрийн хаанчлалд орох боломж хэзээ ч олдохгүй” гэв. Би эгчийн нөхөрлөлийг аль хэдийн сонссон байсан учраас Эзэн Есүсийн ажил хүнийг ариусгах биш, золин аврах ажил байсан, харин Эзэн шүүлтийн ажлаа явуулахаар эргэн ирэх үедээ л хүнийг бүрэн цэвэрлэж, аварна гэдгийг ойлгосон байлаа. Эцсийн өдрүүд дэх Бурханы шүүлтийн ажлыг хүлээн авалгүйгээр хүний завхарсан зан чанар өөрчлөгдөхгүй бөгөөд Бурханы авралыг хүртэж, тэнгэрийн хаанчлалд орж чадахгүй. Тиймээс пасторын үг надад төдийлөн нөлөөлсөнгүй, би ердөө зөвшөөрсөн дүр үзүүлэн толгой дохиж, дараа нь гэртээ харилаа.

Гэртээ харьсны дараа би эгчийн нөхөрлөлийн талаар байн байн бодож, дотроо:

---

“Эгчийн хэлж байсан зүйл бүгд Библитэй нийцэж байна. Өмнө нь ‘нэгэнт аврагдсан бол үүрд аврагдсан’ гэдэгт итгэдэг байсан минь үнэхээр ул үндэслэлгүй байж” гэж бодлоо. Би Эзэнд итгэж ирсэн бүхий л жилүүдээ эргэн санаад, нүгэл үйлдэж, дараа нь нүглээ улайдаг байдалд үргэлж амьдарч, энэ асуудлыг хэзээ ч шийдэж чадалгүй, маш их зовлонг биеэр туулснаа ухаарсан юм. Хэрэв би энэ маягаараа итгэсээр байсан бол эцэстээ Бурханы магтаалыг хүртэж чадахгүй мэт санагдлаа. Эгчийн нөхөрлөлийг сонссоныхоо дараа би, Эзэнд итгэдэг хүмүүс аврал хүртэж, тэнгэрийн хаанчлал руу орохыг хүсвэл, эргэн ирсэн Эзэн Есүсийн хэрэгжүүлдэг хүнийг шүүж, цэвэрлэх ажлыг үнэхээр хүлээн авах ёстой гэдэгт улам бүр итгэх болсон юм. Тэгээд би, эцсийн өдрүүд дэх Төгс Хүчит Бурханы шүүлтийн ажил гэж үнэндээ юу вэ? Төгс Хүчит Бурхан хүнийг хэрхэн цэвэрлэж, өөрчилдөг вэ? хэмээн гайхширлаа. Эдгээр зүйлийг эргэцүүлэн, Библийн хуудсыг эргүүлж байгаад Эзэн Есүсийн ингэж хэлсэн хэсгийг харав: **“Та нарт хэлэх зүйл Надад олон байгаа боловч та нар одоо тэдгээрийг дааж чадахгүй. Гэхдээ үнэний Сүнс болох Тэр ирэх үедээ та нарыг бүх үнэн рүү удирдана: Учир нь Тэр Өөрийн санаагаар ярихгүй; харин сонссон зүйлээ Тэр ярих болно: Мөн Тэр ирэх зүйлсийг та нарт харуулна”** (Иохан 16:12–13). Бас Библиэс үүнийг уншлаа: **“Учир нь шүүлт Бурханы гэрээс эхлэх цаг болжээ”** (1 Петр 4:17). **“Чуулгануудад Сүнс юу айлдаж буйг чихтэй бүхэн сонсогтун”** (Илчлэл 2:7). Үүнийг уншаад эцэст нь зүүднээсээ сэрсэн мэт санагдлаа: Эцсийн өдрүүдэд Бурхан илүү их үнэнийг илэрхийлж, ажлын шинэ үе шатыг гүйцэтгэнэ хэмээн Эзэн Есүс аль эрт зөгнөсөн болж таарав. Энэ чинь хүнийг шүүж, цэвэрлэх ажлыг гүйцэтгэхээр Төгс Хүчит Бурхан ирж байгаа хэрэг биш үү? “Өө, өнөөдөр пастор орж ирж, тийм үймээн учруулаагүй бол Төгс Хүчит Бурханы замын тухай илүү анхааралтай сонсож чадах байсан юм. Урьд нь би үргэлж пастор, ахлагчдын үгийг сонсож, эцсийн өдрүүд дэх Төгс Хүчит Бурханы ажлыг хэзээ ч эрж хайж, судлаагүй. Ердөө л пастор, ахлагчдын хэлсэн болгоныг хийсэн. Зүрх сэтгэлд минь Эзэнийг гэх орон зай огт байгаагүйг би өнөөдөр л мэдлээ. Эзэний эргэн ирэлтийг судалж байхдаа би Эзэний хүслийг эрж хайлгүй, пастор, ахлагчдын үгийг сонссон. Би үнэхээр тэнэг явжээ! Эзэнд итгэдэг бид Түүнийг хүндлэх хэрэгтэй, тэгээд Эзэний эргэн ирэлттэй холбогдуулан Бурханы мөрийг идэвхтэй эрж хайх ёстой, учир нь тэгж байж л бид Бурханы хүсэлтэй нийцнэ. Өнөөдөр би пасторын үйлдэл Эзэний хүсэлтэй ер нийцдэггүйг харлаа. Би тэдний хэлэхийг цаашид сохроор сонсож болохгүй, харин Төгс Хүчит Бурханы замыг эрж хайн, судлах ёстой” гэж би бодлоо.

Дараа өдөр нь хамгийн эхлээд би Ху эгчийн гэрт очиж, Төгс Хүчит Бурханы сайн мэдээг түгээсэн эгчийг хайн, хамтдаа үргэлжлүүлэн нөхөрлөхөөр шийдлээ. Гэрээсээ гарч ч амжаагүй байхад Ху эгч өнөөх эгчийг манай гэрт авчирчихсан байна гэж хэн санах билээ.

---

Энэ үнэхээр Эзэний удирдамж байлаа. Эгч эхлээд санаа зовсон байдалтай, өчигдөр пастор надад төвөг удсан эсэхийг асуув. Би ихэд шийдэмгийгээр: “Үгүй ээ, өчигдрийн нөхөрлөлийн дараа би энд ирээд бүх зүйлийг анхааралтай эргэцүүлэн бодсон, тэгээд бид Эзэн Есүст итгэлээ гээд цэвэрлэгдэж үнэхээр чадахгүй, бидний завхарсан уг чанар бас л оршсоор байх бөгөөд үүнтэйгээр Бурханы бүрэн авралыг хүртэж чадахгүй гэдгийг ухаарсан. Түүнчлэн, би эцсийн өдрүүдэд Эзэн шүүлтийн ажлаа хэрэгжүүлэхээр эргэн ирнэ гэж үнэхээр зөгнөсөн Библийн хэсгийг бас уншсан. Одоо би, эцсийн өдрүүдэд Төгс Хүчит Бурханы хэрэгжүүлэх шүүлтийн ажил гэдэг нь яг болохыг, мөн Төгс Хүчит Бурханы шүүлтийн ажил яаж хүнийг цэвэрлэж, бас өөрчилдөг вэ? гэдгийг л хамгийн их мэдсээр байна” хэмээн хариулсан юм.

Эгч баяртайгаар ингэж хэллээ: “Бурханд талархъя! Таны асуусан асуулт үнэхээр тун чухал, учир нь, Бурханд итгэх итгэл маань бидэнд бүрэн аврал хүртэж, тэнгэрийн хаанчлалд орох боломжийг олгох эсэх тухай чухал сэдвийг энэ нь хөнддөг. Эхлээд Төгс Хүчит Бурханы үгэнд юу гэж хэлдгийг харъя. Төгс Хүчит Бурхан ингэж хэлдэг: **‘Энэ удаа бие махбодтой болсон Бурханы ажил нь үндсэндээ гэсгээлт, шүүлтээр дамжуулан Өөрийн зан чанарыг илэрхийлэх явдал юм. Энэ сууринд үндэслээд Тэрээр хүнд илүү их үнэнийг авчирч, хэрэгжүүлэлтийн илүү олон замыг заан үзүүлж, улмаар хүнийг байлдан дагуулж, завхарсан зан чанараас нь аврах зорилгодоо хүрдэг. Энэ бол Хаанчлалын эрин үе дэх Бурханы ажлын ард оршдог зүйл юм’** (Үг нь махбодоор илэрсэн номын Өмнөх үг). **“Шүүлт”** гэдэг үгийг дурдах үед чи Еховагийн бүх газар оронд хэлсэн үг болон Есүсийн фарисайчуудад хэлсэн зэмлэлийн үгийн тухай бодох болно. Эдгээр үг хэдийгээр хатуу ч гэлээ хүнийг шүүх Бурханы шүүлт байгаагүй, ердөө л өөр өөр орчинд буюу өөр өөр нөхцөлд Бурханы хэлсэн үг байсан юм. Эдгээр үг нь эцсийн өдрүүдэд хүнийг шүүхдээ Христийн хэлдэг үгтэй адилгүй. Эцсийн өдрүүдэд Христ хүнийг сургах, хүний мөн чанарыг ил болгох, хүний үг болон үйлдэлд нь дүн шинжилгээ хийхийн тулд төрөл бүрийн үнэнийг хэрэглэдэг. Хүний үүрэг, хүн яаж Бурханд дуулгавартай байх ёстой, хүн яаж Бурханд үнэнч байх ёстой, хүн яаж хэвийн хүн чанарыг амьдран харуулах учиртай болон Бурханы мэргэн ухаан, зан чанар гэх зэрэг төрөл бүрийн үнэн эдгээр үгэнд агуулагддаг. Эдгээр үг нь бүгд хүний мөн чанар болон ялзарсан зан чанар луу чиглэдэг. Ялангуяа, хүн Бурханыг хэрхэн голдгийг илчилсэн үгсийг хүн бол Сатаны биелэл, Бурханы эсрэг дайсны хүч болдог тухайд хэлсэн байдаг. Шүүлтийн ажлаа хийхдээ Бурхан хүний уг чанарыг ердөө хэдхэн үгээр тодорхой болгодог юм биш; Тэрээр удаан хугацааны туршид илчилж, харьцаж, засдаг. Илчлэл, харьцалт болон засалтын эдгээр аргыг энгийн үгээр бус, харин хүнд огт байдаггүй үнэнээр л орлуулж болно. Зөвхөн ийм төрлийн арга



---

**барилыг л шүүлт гэж нэрлэж болно; ийм төрлийн шүүлтээр л дамжуулан хүн номхорч, Бурханд захирагдахаар бүрэн үнэмшээд зогсохгүй, Бурханы тухай жинхэнэ мэдлэгийг олж авч чаддаг. Шүүлтийн ажлын авчирдаг зүйл гэвэл Бурханы жинхэнэ дүр төрх болон өөрийнх нь тэрслүү байдлын үнэний талаарх хүний ойлголт юм. Шүүлтийн ажил нь хүнд Бурханы хүслийн тухай, Бурханы ажлын зорилгын тухай, хүний ойлгошгүй нууцуудын тухай ихээхэн ойлголт олж авах боломж олгодог. Түүнчлэн, өөрийн ялзарсан мөн чанар болон ялзралынхаа үндсийг таньж мэдэх, хүний муу муухайг нээн илрүүлэх боломжийг олгодог. Энэ бүх үр дүнг шүүлтийн ажил авчирдаг, учир нь энэ ажлын мөн чанар нь үнэндээ Бурханы үнэн, зам, амийг Түүнд итгэдэг бүх хүнд нээх ажил юм. Энэ ажил нь Бурханы хийдэг шүүлтийн ажил билээ’ (Үг нь махбодоор илэрсэн номын “Христ шүүлтийн ажлыг үнэнээр хийдэг”).”**

Бурханы үгийг уншсаны дараа эгч үргэлжлүүлэн ийнхүү нөхөрлөлөө: “Эцсийн өдрүүд дэх Төгс Хүчит Бурханы шүүлтийн ажил нь хүнийг илчилж, задлан шинжлэхийн тулд үнэний олон талыг ашигладаг бөгөөд хүний зөрчлийг тэвчдэггүй Түүний зөвт, сүр жавхлант зан чанараар энэхүү шүүлтийн ажил явагддаг болохыг бид Бурханы үгээр дамжуулан ойлголоо. Хүний завхарсан мөн чанар болон завхралынх нь үнэнийг илчлэх, Бурханыг эсэргүүцэж, Бурханаас урвадаг сатанлаг уг чанарыг маань шүүхийн тулд Бурхан үг ашигладаг. Тийм завхралын жишээ нь Бурханы ажлын тухай үзэл, төсөөллөөр дүүрэх, өөрийн үзлийг үнэн гэж үзээд Бурханы ажлыг хэмжих, хүссэнээрээ Бурханыг шүүж, яллаж, эсэргүүцэх зэргийг агуулдаг. Өөр нэг жишээ нь, бид Бурханд итгэдэг хэдий ч үл итгэгчдээс өөрцгүй; бид бүгд алдар нэр, эд хөрөнгө хөөцөлдөж, үүний төлөө ямар ч төлөөс төлөхөд бэлэн байдаг боловч Бурханыг сэтгэл хангалуун байлгахын төлөө амьдардаг ганц ч хүн байдаггүй. Бурханы хүслийг л дагаснаар л хүн тэнгэрийн хаанчлалд орж чадна гэж Бурхан үнэндээ хэлсэн байтал бид Эзэнд итгэж л байвал аврагдана, Эзэнийг ирэхэд тэнгэрийн хаанчлал руу өргөгдөнө гэж итгэх зэргээр олон зүйлийн талаарх үзэл бодол маань Бурхантай нийцдэггүй. Эдгээр нь дотроо өвөрлөдөг завхралын маань ердөө цөөн хэдхэн жишээ юм. Бурханы шүүлт, гэсгээлтээр дамжуулан эдгээр завхарсан зан чанар, эндүү ташаа үзэл бодол, Сатаны амьдралын дүрэм цэвэрлэгдэж, өөрчлөгдөх бөгөөд бид Бурханд үнэхээр дуулгавартай болно. Үүний зэрэгцээ, Бурханы шүүлт, гэсгээлтээр дамжуулан бид бас Бурханы зөвт зан чанар хүний халдахыг тэвчдэггүй гэдгийг таньж, Бурхан ямар төрлийн хүнийг хайрладгийг, ямар төрлийн хүнийг жигшдэгийг мэдэж авч, хүнийг аврах Бурханы санаа зорилгыг ойлгож, Бурханыг хүндлэх болж, Бурханы магтаалыг хүртэхийн тулд үнэнийг хэрхэн эрэлхийлж, үүргээ хэрхэн зүй зохистойгоор биелүүлэхээ мэдэж авдаг. Бурханы үгийг туулж, хэрэгжүүлэх замаар бид олон үнэнийг ойлгож авдаг. Тухайлбал, Бурханд итгэх гэдэг нь ямар утгатайг, үнэхээр аврал хүртэх,

---

Бурханыг дуулгавартай дагах, Бурханыг хайрлах, Бурханы хүслийг дагах гэх мэт нь юу гэсэн үг болохыг мэдэж авдаг. Бидний завхарсан зан чанар бүгд янз бүрийн түвшинд өөрчлөгдөж, амьдралыг үзэх үзэл, үнэт зүйл маань ч бас өөрчлөгдөнө. Энэ бол бидний дунд Бурханы хэрэгжүүлдэг шүүлт, гэсгээлтийн ажил бөгөөд үүнийг Бурханы хайрын аврал ч гэж нэрлэж болно. Тэгэхээр, эцсийн өдрүүдийн Христ болох Төгс Хүчит Бурханы суудлын өмнө шүүлтийг хүлээн авснаар л бид үнэнийг олж авч чадах ба тэр үед л бид нүглээс ангижирч, цэвэрлэгдэж, бүрэн аврал хүртэж чадна. Эгч ээ, та энэ нөхөрлөлийг ойлгож чадаж байна уу?”

Бурханы үгийг уншиж, эгчийн нөхөрлөлийг сонсоод би Бурханы ажил болон хүслийг ойлгож авлаа. Би толгой дохин, сэтгэл ихэд хөдлөн ингэж хэлэв: “Бурханд талархъя, Төгс Хүчит Бурханы үгийг сонссоноор би эцсийн өдрүүдэд Бурхан хүнийг шүүх, цэвэрлэх ажлыг явуулахдаа Өөрийн үгийн үнэнийг ашигладаг гэдгийг ойлгож авлаа. Миний урьдын эрэл хайгуул маш тодорхойгүй, бодитой бус байжээ. Харин одоо би эцсийн өдрүүд дэх Бурханы шүүлт, гэсгээлтийн ажлыг хүлээн авснаар л хүн Бурханаар цэвэрлүүлж, бүрэн аврал хүртэж, тэнгэрийн хаанчлалд орж чадна гэдгийг ойлголоо. Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс юм! Би өөрийн завхарсан зан чанарыг удалгүй өөрчлөхийн төлөө Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн зөвшөөрч, Бурханы үгийн шүүлт, гэсгээлтийг хүлээн зөвшөөрөхөд бэлэн байна.” Ингэж хэлэхийг минь сонсоод эгч баяртайгаар инээмсэглэн, Бурханд тасралтгүй талархаж байлаа.

Төгс Хүчит Бурханы үг намайг оюун ухаандаа өвөрлөж байсан үзлээс минь чөлөөлж, өөрийн завхарсан зан чанарыг хөсөр хаяж, цэвэрлэгдэх замыг харуулсан юм. Бүрэн авралыг эрэлхийлэн явах зүг чиг, зорилго маань одоо тодорхой болсон мэт надад санагдаж, сүнс минь гэрэл гэгээтэй, тууштай, чөлөөлөгдсөн санагдаж байна. Цонхоор гадагш хараад би тэр өдөр тэнгэр тун цэлмэг, нартай байгааг анзаарсан юм. Тэгээд газар сөхрөн унаж, “Өө Бурхан минь, би Танд талархлаа илэрхийлье. Амьдрах хугацаандаа Таныг эргэн ирэхэд угтан авч, Таны илрэлтийг нүдээр харах нь үнэхээр ерөөл билээ! Гэхдээ би сохор, мэдлэггүй хүн юм, учир нь би пастор, ахлагчдын түгээсэн цуу ярианд итгэж, үзэл төсөөлөлтэйгөө зууралдан, мөнхийн авралаа алдах шахлаа! Өө Бурхан минь, би үнэхээр мэдлэггүй, мэдрэлгүй юм! Би гэмшихэд бэлэн байна, бас бүрэн аврал хүртэх энэхүү туйлын ховор боломжийг нандигнаж байна. Түүнчлэн Таны авралыг хүртээхийн тулд илүү олон ах эгч нарыг Таны өмнө авчрахад бэлэн байна! Амен!” хэмээн Бурханд залбирлаа.

## **31. Бөөрөлзгөнийн моддын дунд ургасан бяцхан өвс**

---

## Ишинь, Сингапур

2016 оны 11-р сард би Төгс Хүчит Бурханы Чуулганы Линь ах, Жан, Шиаошиао эгч нартай Фэйсбүүкээр танилцсан юм. Тэд Библийн зарим зөгнөлийг нэгтгэн, надтай нөхөрлөж, эцсийн өдрүүдийн Бурханы ажилд гэрчлэл хийсэн билээ. Төгс Хүчит Бурхан шүүлтийн ажил явуулж, Эзэн Есүсийн хийсэн золин аврах ажилд үндэслэсэн үгсээр хүмүүсийг ариусгаж байгааг тэдний нөхөрлөл, гэрчлэл надад ойлгуулсан юм. Төгс Хүчит Бурхан хүн төрөлхтнийг Сатаны хүч чадлаас бүрэн аварч, биднийг завхарсан зан чанараас маань салгахыг хүсдэг бөгөөд ингэвэл бид Бурханы эсрэг тэрсэлж эсэргүүцэхээ больж, оронд нь Түүнийг үнэхээр дагаж, шүтэн биширдэг хүмүүс болох юм. Эцсийн өдрүүд дэх Бурханы ажил нь буудай ба зэрлэг өвс, хоньд ба ямаад, ухаалаг охид ба мунхаг охидыг бүгдийг илчилснээр тэд тус бүр төрөлтэйгөө нэгдэж, сайн үйл шагнагдаж, муу үйл шийтгэгдэх болно гэдгийг би Төгс Хүчит Бурханы үгсээс ойлгох болов. Би Төгс Хүчит Бурхан нь миний хүлээж байсан Эзэн Есүсийн эргэн ирэлт болохыг ойлгож, эцсийн өдрүүд дэх Төгс Хүчит Бурханы ажлыг баяртайгаар хүлээн зөвшөөрсөн юм.

Нэгэн өдөр миний явдаг бүлэглэлийн Жу эгч ойрд юу хийгээд завгүй байсныг минь гэнэт асуухад би түүнд эцсийн өдрүүд дэх Төгс Хүчит Бурханы ажлыг судалж байснаа хэлэв. Жу эгч Төгс Хүчит Бурханы Чуулганы талаар олон муу зүйл хэлж, Төгс Хүчит Бурханыг доромжилсон юм. Тэрээр надад тэдэнтэй огт холбогдохгүй байхыг шавдуулав. Би хариуд нь: “Би Төгс Хүчит Бурханы хэсэг ах эгч нартай нэлээд хугацаанд холбоотой байсаар ирсэн ба тэдэнтэй санаа бодлоо солилцоход сайхан байсан. Тэд үнэнийг нөхөрлөх шинэлэг, тодорхой аргатай бөгөөд тэднийг сонссоноор би олон үнэнийг ойлгосон юм. Би их өсөж, их үр ашиг хүртсэн, тэд таны хэлсэнтэй огт адилгүй юм билээ. Мөн Төгс Хүчит Бурханы үгс маш бодитой бөгөөд зарим асуудлын талаар надад мэдрэгдсэн олон мухардлыг шийдвэрлэсэн юм. Тэдгээр үгс аминд минь тэжээл өгч, надад хэрэгжүүлэх замыг заагаад байна ...” гэлээ. Миний хандлага нугаршгүй байгааг хараад Жу эгч сэдвээ өөрчилж, намайг эцсийн өдрүүдийн Төгс Хүчит Бурханы ажлыг судалж байгаа тухайгаа Эзэний тухай сайн мэдээг бидэнд номлодог Юнь эгчид хэлэх эсэхийг асуулаа. Би түүнд “Одоо ч надад ойлгоогүй зүйл олон байна, харин судалж дуусахаараа би юу олсон тухайгаа хүн бүрт хэлнэ” гэж хэлэв. Юнь эгчид аливаа зүйл хэлэхээсээ өмнө намайг тодорхой ойлголттой болох хэрэгтэй гэдэг дээр тэр санал нэгдсэн юм.

Тиймээс 5 өдрийн дараа миний ажилладаг салоны захирал над дээр ирээд “Ишинь аа, Юнь надаас чиний төлөө залбирахыг хүслээ. Үнэндээ би яаж залбирахыг мэдэхгүй ч чадах чинээгээрээ хичээнэ ээ ...” гэж хэлэхэд би ихэд гайхав. Эцсийн өдрүүдийн Төгс Хүчит Бурханы ажлын талаар судалж байгааг минь Жу эгч Юнь эгчид аль хэдийн хэлчихсэн

---

гэдгийг би үүнийг сонссон даруйдаа ойлголоо. Надад Жу эгч төдийлөн сайн зүйл хийгээгүй мэт санагдсан тул би түүнд жаахан унтууцав. Тэр намайг хуурч, надаас урвасан мэт санагдаж, Эзэний доторх ах эгч нар маань хүртэл итгэл даахгүй юм байна гэж надад санагдаж эхэлсэн юм ... гэвч яг ийм зүйл бодож байтал минь манай захирал надтай юу ч зөвлөлдөлдгүй салоны арав гаруй ажилтны анхаарлыг татаж, намайг сайн Христэд итгэгч биш, буруу замаар явж байгаа хэмээн тэдэнд хэлэв. Тэрээр цааш нь Төгс Хүчит Бурханыг ялласан олон зүйл хэлсэн юм. Энэ бүхэн маш хурдан болж өнгөрсөн учраас би хариуд нь яахаа мэдээгүй бөгөөд сэтгэл маш гонсойлоо. Тэгээд би “Эзэн минь, тэд Таныг эргэн ирсэн гэдгийг сонссон атлаа судлах сонирхол яагаад огт алга байна вэ? Тэд яагаад зөвхөн онлайн цуу яриа сонсож, Таныг эсэргүүцэн, ялласан тэр бүх зүйлийг хэлнэ вэ? Төгс Хүчит Бурхан маш олон үнэнийг илэрхийлсэн, тэгвэл энэ нь Төгс Хүчит Бурхан бол Таны эргэн ирэлт гэдгийг батлахгүй гэж үү? Тэд намайг Төгс Хүчит Бурханд итгэхийг яагаад ингэж эсэргүүцнэ вэ? Эсвэл буруутсан хүн нь би байж болох уу? Ээ Эзэн минь, би яахаа мэдэхгүй байна. Намайг хөтөлж, намайг чиглүүлээч ...”

Тэр өдөр юу болсныг би Линь ахад дараа нь хэлэв. Линь ах надад Төгс Хүчит Бурханы үгсийн хоёр мөр олж өгсөн юм: **“Миний талаар хүмүүсийн зүрх сэтгэлдээ тээдэг мэдлэгийг Сатан байнга ховх сорж, бас байнга шүдээ ярзайлган, хумсаа сарвайлгаж, сүүлчийн амь тэмцсэн тулаандаа ордог. Энэ мөчид та нар түүний зальжин ов мэхэнд олзлогдохыг хүсэж байна уу? Та нар Миний ажлын сүүлийн үе шат дуусах энэ мөчид өөрийнхөө амийг таслахыг хүсэж байна уу? Мэдээж та нар Намайг өршөөл энэрлээ дахиад нэг удаа хүртээнэ гэж хүлээсээр байгаа юм биш биз дээ? Намайг мэдэхээр эрж хайх нь хамгийн чухал зүйл, гэхдээ та нар бодит хэрэгжүүлэлтэд анхаарал хандуулахаа умартах ёсгүй. Та нар Миний удирдамжид захирагднагэж найдсандаа Би нарийн ойлголтыг шууд Өөрийнхөө үгээр та нарт илчилж байна”** (“Үг нь махбодоор илэрсэн” номын Бүх орчлон ертөнцөд хандсан Бурханы айлдваруудын “6-р бүлэг”). **“Бурхан махбодоор ажиллах үедээ үнэндээ махан биеэр Сатантай тулалдаж байдаг. Тэр махбодоор ажиллах үедээ сүнсний ертөнцөд Өөрийн ажлыг хийж, сүнсний ертөнц дэх бүх ажлаа газар дээр бодит болгодог”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Завхарсан хүн төрөлхтөнд бие махбодтой болсон бурханы аврал илүү их хэрэгтэй”). Линь ах эдгээр мөрийн тухай дараах байдлаар нөхөрлөл хийв: “Чамд тохиосон зүйл бол сүнсний тулалдаан бөгөөд чи Сатаны сорилттой тулгарсан болохыг Бурханы үгсээс харж болохоор байна. Эцсийн өдрүүдэд Бурхан ярьж, хүмүүсийг аврахын тулд хүний бие махбодтой болсон юм. Бурханы үгсээс бид үнэнийг ойлгож, Бурханы ажлыг мэдэж, Бурханы зан чанарыг мэдэн, Сатаныг бүрэн орхиж, Бурханд эргэн очиж чадна. Бид аврал хүртэж, Бурханаар олж авагдаж чадна. Бурханы ажлыг үймүүлж,

---

саатуулахыг оролдохын тулд Бурханы ард үргэлж Сатан дагадаг. Эцсийн өдрүүдийн Христ болох Төгс Хүчит Бурханыг гутааж, яллан, биднийг Бурханы өмнө ирэхээс сэргийлэхийн тулд Сатан чадах хүн бүрээ ашигладаг. Шашны удирдагчид, эрх мэдэлтэй шашингүй үзэлтнүүд бол Сатаны биелэл бөгөөд Бурхан ажлаа хийхээр газар дээр бие махбодтой болох бүрт Түүнийг эсэргүүцэж, яллан, Түүний ажлыг бусниулж, хүмүүс Түүнийг дагахаас сэргийлдэг билээ. Эзэн Есүс ажлаа хийхэд тухайн үеийн ахлах тахилчид, хуулийн багш нар, фарисайчууд Сатаны турхиралтаар Түүний ажлыг яллаж, эсэргүүцэхийн тулд чадах бүхнээ хийсэн юм. Тэд худал цуу яриа дэгдээж, хуурамч гэрчлэл хийж, Түүнийг гүтгэж, доромжилсон билээ. Тэд Эзэн Есүс чөтгөрүүдийг Вельзевулаар дамжуулан хөөж байна гэгцээсэн; тэд Эзэн Есүс нутгийн иргэдийг Цезарьт татвар төлөхгүй байхад турхирч байна гэсэн; тэд зарим цэргийг хахуульдаж, Эзэн Есүс дахин амилаагүй, Түүний цогцсыг дагалдагчид нь нууцаар авч явсан гэх хуурамч мэдүүлэг тэднээр өгүүлсэн. Эцсийн өдрүүдийн Бурхан Өөрийн шинэ ажлыг хийхээр бие махбодтой болоход, Хятадыг шашингүй бүс нутаг болгохоор оролдож байгаа Хятадын Коммунист засгийн газар болон өөрсдийн амин зуулга, байр сууриа хамгаалахыг хүсдэг олон пастор, ахлагчидтай хамтран хүмүүсийг хуурч, айлган, эцсийн өдрүүд дэх Бурханы ажлыг судалж, хүлээн зөвшөөрөхөөс сэргийлэхийн тулд Төгс Хүчит Бурхан болон Төгс Хүчит Бурханы Чуулганы тухай тоо томшгүй олон худал хуурмаг, хуурамч гэрчлэл тарааж эхэлсэн байна. Үнэнийг ойлгодоггүй, зохих ёсоор ялган таньж чадахгүй олон хүн эдгээр цуу ярианд сохроор итгэн, бусдыг үймүүлэх, үнэн замыг хүлээн авахаас тэднийг сэргийлэх эдгээр цуу яриаг түгээж, Сатаны даалгаврыг биелүүлж байна. Энэ мэт хүмүүс Бурханыг эсэргүүцдэг Сатаны муу хамсаатнууд болдог. Иймд, Бурханы дайсан болох шашингүй үзэлт Коммунист засгийн газрыг таньж, Бурханы ажлыг судлахаас хүмүүсийг сэргийлдэг пасторууд, ахлагчид нь манай үеийн фарисайчууд учраас бид тэднийг таних хэрэгтэй байна. Интернэтэд байгаа бүх цуу яриа бол биднийг Бурханд эргэн очихоос сэргийлэх Сатаны төлөвлөгөөний нэг хэсэг гэдгийг бид ойлгох ёстой. Хэрэв бид үнэн замыг судлахыг хүсвэл зөвхөн Бурханы үгсийг сонсох хэрэгтэй ба Сатаны цуу яриаг огтхон ч сонсох ёсгүй. Ингэснээр бид сүнсний тулалдааны үеэр Бурханы талд зогсож, Бурханд гэрчлэл хийж, Сатаны эрхшээлд орохгүй байж чадна ...”

Линь ахын нөхөрлөл надад цуу ярианы гарлыг ойлгоход тусалсан юм. Намайг эцсийн өдрүүдийн Бурханы авралыг олж авахаас сэргийлэхийн тулд цуу яриа тарааж, замыг минь сүйтгэж, саад учруулж байгаа Сатаны зорилгыг одоо би ойлгосон юм. Энэ тухай илүү бодсоны дараа над руу дайрч байсан эдгээр хүмүүс Төгс Хүчит Бурханы үгсийг хэзээ ч уншаагүй, эцсийн өдрүүдийн Төгс Хүчит Бурханы ажлыг хэзээ ч судлаагүй, ердөө цуу яриаг сохроор сонсож, Төгс Хүчит Бурханыг эсэргүүцэн яллаж байсныг би ойлгов. Тэдний

---

оюун ухаан Сатанд бүрэн түйвээгдэж, өөрсдөө ч мэдэлгүй Сатаны даалгаврыг биелүүлэн Бурханыг эсэргүүцэж байлаа. Мэргэн хүн бол дүгнэлтэд хүрэхийнхээ өмнө эхлээд Төгс Хүчит Бурханы үгсийг няхуур уншиж, бүрэн судалгаа явуулна. Гэвч Бурханд итгэнэ гэдэг бол том зүйл, тиймээс би ч бас буруу замыг сонгохоос айж байсан учраас хэсэг зовнилыг сэтгэлдээ тээсэн хэвээр байсан юм. Ажлаасаа гэртээ ирээд би нүдэндээ нулимстайгаар Эзэнд залбирав: “Ээ Эзэн минь, би маш их төөрч, будилж байгаа ч бусдын хэлдэгт сохроор итгэгч болохыг хүсэхгүй байна. Би Таны эрмэлзэл дагуу явмаар байна, тиймээс намайг хөтөлж, чиглүүлээч дээ.” Би унтаад шөнө дунд болж байхад намайг нэг юм дарж байгааг бүдэг бадаг, нойрмогоор мэдэрлээ. Би нүдээ нээх гэж зүтгэсэн ч чадсангүй. Ингэж зүтгэх нь нэмэргүй байсныг ойлгоод би яаран “Эзэн Есүс минь намайг авраач!” хэмээн хашхирав. Ингэж би хоёронтоо хашхирсан ч нэмэр болсонгүй. Тэр зүйл намайг дарахыг мэдэрсэн хэвээр байлаа. Би яах учраа ололгүй ихэд айсан юм. Гэнэт би Төгс Хүчит Бурханы тухай санаж, “Төгс Хүчит Бурхан минь! Төгс Хүчит Бурхан минь!” хэмээн хоёр удаа хашхираад тэр дороо сэрэв. Сэрснийхээ дараа би жаахан сандарсан хэвээр байсан бөгөөд бүрэн ухаан ортлоо жаал хугацаа зарцуулав. Эзэн Есүсийн нэрийг дуудахад нэмэр болоогүй атал “Төгс Хүчит Бурхан минь!” гэж дуудсан нь намайг тэр дороо сэрээсний учрыг би бодлоо. Тэгэхэд Бурхан эрин бүрт нэртэй бөгөөд Бурхан эрин бүрт шинэ ажил хийсний дараа Арин Сүнс шинэ эриний нэрийг хамгаалдаг хэмээн Линь ах надад хэлснийг санах. Тиймээс итгэгчид Бурханы сайшаал, халамж, хамгааллыг хүртэхийн тулд Бурханы шинэ эринд зориулсан нэрийг хэрэглэн залбирах ёстой. Энэ эринд Эзэн Есүс аль хэдийн эргэн ирсэн бөгөөд Нигүүлслийн Эринийг эцэслэж, Хаанчлалын Эринийг нээхийн тулд Төгс Хүчит Бурхан гэх нэрийг хэрэглэж байна. Эцсийн өдрүүдэд Бурханы нэр Төгс Хүчит Бурхан тул бид энэ нэрийг ашиглан залбирах ёстой, эс бөгөөс Бурхан биднийг хайхрахгүй. Тэгэхэд би хар дарсан зүүд маань тохиолдлын зүйл биш, харин Бурхан миний залбирлыг сонсож, Төгс Хүчит Бурхан бол Эзэн Есүсийн эргэн ирэлт гэх нотолгоог надад өгсөн явдал гэдгийг ойлгов. Бурханд талархъя! Үүнийг ойлгосныхоо дараа зүрх сэтгэл минь хүч чадлаар дүүрч, одоо би захирал болон хамтран ажиллагсдынхаа үг хэлээр дайралттай тулгарах итгэлтэй боллоо.

Дараа өдөр нь ажил дээр манай захирал бүгдэд намайг буруу замаар явж байна гэж дахин хэлээд, Төгс Хүчит Бурханыг доромжилсон олон зүйл ярих. Түүнийг сонсоод миний уур ихэд хүрсэн тул би түүнээс ингэж асуув: “Ямар ‘муу’-гийн тухай та яриад байгаа юм бэ? Бид бол Бурханд итгэгчид. Та Түүнийг сохроор яллаж, доромжлохын оронд Төгс Хүчит Бурханы үгс, ажлыг судалж, Бурханы хүсэл зорилгыг эрж хайвал яасан юм бэ? Та зүрх сэтгэлдээ үнэхээр Бурханаас эмээж, биширдэг үү?” Энэ бүхнийг хэлснийхээ дараа би уурандаа яваад өгөв. Төд удалгүй манай захирал намайг хайж ирээд өөрт нь уурлах

---

хэрэггүй байсан юм гэж надад хэлэв. Би хариуд нь “Би уурлахыг хүсээгүй ч та тийм зүйлс ярих хэрэггүй байсан юм. Бурханы нэр төрийг гутааж, эсэргүүцэн, ялласан үгс Бурханыг хилэгнүүлдэг тул Бурханд итгэгч бид хэзээ ч ийм зүйлс хэлж болохгүй. Таны өнцгөөс харвал намайг бодлоо өөрчлөхийг шавдуулж байгаагаараа та сайн үйл хийж байгаа мэт санагдаж болох юм. Гэхдээ би насанд хүрсэн хүн бөгөөд аливааг ухаалаг байдлаар бүрэн бодолцдог. Төгс Хүчит Бурхан нь Эзэн Есүсийн эргэн ирэлт мөн эсэх тухай асуудал бол миний мэдэхийг хүсэж, судалгаа хийсэн зүйл. Энэ бол би зүгээр л тохиолдлоор итгэе гэж шийдсэн зүйл биш. Миний шийдвэрийг хүндэтгэж, эцсийн өдрүүдийн Бурханы ажлын тухай мэдлэг эрж хайн, судлахыг минь битгий хорьж, сэргийлээч” гэлээ. Тэгэхэд захирал маань надаас Төгс Хүчит Бурханы Чуулганы тухай аль нэг телевизийн хөтөлбөр үзэж, эсвэл интернэтэд байгаа цуу ярианаас уншсан эсэхийг асуулаа. Би хариулахдаа: “Сөрөг зүйлс үргэлж Сатанаас гардаг. Миний уншдаг зүйл бол Төгс Хүчит Бурханы үгс бөгөөд миний үздэг зүйл нь Төгс Хүчит Бурханы Чуулганы хийсэн кино, найрал дууны бичлэгүүд, хөгжмийн клипүүд юм. Би таны үздэг зүйлийг үздэггүй. Та нарын хэлж байгаагаас яг эсрэгээр Төгс Хүчит Бурханы Чуулган гишүүдээ муу үйл хийхийг зөвшөөрдөггүй. Төгс Хүчит Бурхан биднээс хүнлэг, ухамсар сайтай, шударга, ухаалаг хүмүүс болохыг шаарддаг.” Захирал маань хэлсэн үгийг маань сонссоны дараа хэлэх үггүй болж, надтай яаж харьцахаа мэдэхгүй байгаа юм шиг царайлж гарлаа.

Үүнээс хойш манай захирал намайг дээрэлхэж, тэр ч бүү хэл миний тухай ёжтой зүйлс хэлэх болсон юм. Тэр надаар Төгс Хүчит Бурхан дахь итгэлийг минь орхиулах гэж оролдож байгааг би мэдэж байв. Нэг өдөр гэнэтхэн тэр надад ингэж хэлэв: “Юнь томилолтоосоо буцаж ирээд чамтай ярилцах хүсэлтэй байна.” Үүнийг сонсоод би жаахан сэтгэл гонсойж, сандрав. Би ийн бодлоо: “Тэр миний Төгс Хүчит Бурханд итгэдгийг болиулахаар оролдох нь гарцаагүй. Би Юнь эгчийн номлол айлдахыг сонсоод Христэд итгэгч болсон бөгөөд тэр манай салоны тусгай үйлчлүүлэгч, тиймээс түүнийг уурлуулбал захирал маань баярлахгүй нь лавтай, бас түүнтэй цаашид нийцтэй байхад надад улам хэцүү болно.” Юнь эгчийн буцаж ирэх өдөр ойртох тусам би улам сандарч, айх болов. Нэгэн үдэд би тусгай үйлчлүүлэгчдийн өрөөнд Бурханд залбиран сууж байв. Намайг залбирлаа дөнгөж дууссаны дараа утас дуугарлаа. Манай дарга ярьж байв: “Юнь удахгүй ирнэ. Түүнд нүүрний арчилгаа хий.” Би үүнийг хийхийг ер хүсээгүй ч татгалзах арга огт байсангүй. Нүүр арчилгааны өрөөнд эргэж ирээд би Бурханы дэргэд өөрийгөө тайвшруулахын тулд Бурханы үгийн магтан дууны бичлэгийг тавилаа. “Би зүрх сэтгэлээрээ Бурханыг хайрлахаар шийдсэн” магтан дууг сонсож байх зуур эдгээр мөр дуулдав: **“Та сүнсний минь нүдийг нээж, Таны Сүнс миний зүрх сэтгэлийг хөдөлгөх болтугай. Ингэснээр би Таны өмнө бүх сөрөг зүйлийг хаяж, аливаа хүн, хэрэг явдал,**

---

зүйлээр хязгаарлагдахгүй байж, бүхий л оршихуйгаа Таны өмнө зориулахуйцаар зүрх сэтгэлээ Таны өмнө бүрэн дэлгэж байна. Та намайг яаж ч туршсан бай, би бэлэн. Одоо би хэтийн ирээдүйгээ огт бодохгүй, мөн үхэлд ч хүлэгдэхгүй. Таныг хайрладаг зүрх сэтгэлээр би амьдралын замыг эрж хайхыг хүсэж байна.” Бурханы үгс надад итгэл өгч, би аажмаар тайвширч, төлөв боллоо. Тэр тийм шүү: Би үнэн замыг сонгохдоо ямар ч хүн, эд, зүйлд баригдаж болохгүй. Нэгэнт би Төгс Хүчит Бурханыг Эзэн Есүсийн эргэн ирэлт мөн гэж шийдсэнээс хойш хумсын чинээ ч эргэлзээ, тээнэгэлзэлгүйгээр шийдвэртээ үнэнч байх хэрэгтэй. Захирал минь намайг хэрхэн харж, яаж харьцдаг, Юнь эгчтэй харилцаа маань хэрхэн үргэлжлэх нь бүгд Бурханаас шалтгаална. Би санаа зовохоо больж, Бурханы зохицуулалтыг дагах хэрэгтэй. Иймд би итгэлтэйгээр нөхцөл байдалтай нүүр тулахаар явав.

Цөөн хормын дараа Юнь эгч ирлээ. Би Бурханд чимээгүйхэн ингэж залбирав: “Төгс Хүчит Бурхан минь, тэр Таныг доромжилж, эсэргүүцэж, ялласан зүйл хэлэх вий гэхээс би айж байна. Бас би түүнийг надад төвөг удах вий гэж айж байна. Бурхан минь, надад тусалж, намайг хамгаалаач.” Эхлээд Юнь эгч Израиль руу хийсэн томилолтынхоо тухай, энэ нь хэр амжилттай байсныг л ярив. Гэвч сүүлд нь тэр асуудлыг бөөрөнхийлсөн маягаар ингэж хөндлөө: “Эцсийн өдрүүдэд хүмүүсийг мэхлэх гэсэн хуурамч Христүүд, зөнчид олширно...” Түүний Төгс Хүчит Бурханыг доромжлох зүйл хэлэхийг би сонсмооргүй байсан тул яриаг нь таслан, ингэж хэлэв: “Тийм ээ, тэмдэг, гайхамшиг үзүүлэн Эзэн Есүсийг дуурайдаг тэдгээр хуурамч Христүүдээс сэрэмжлүүлэхийн тулд Эзэн бидэнд ингэж сануулсан юм. Гэхдээ Эзэн биднийг ялган таних чадвартай болгохыг эрмэлздэгээс бус Эзэний эргэн ирэлтийн сайн мэдээг түгээж байгаа бүх хүнийг сонсохоос татгалзуулах гээгүй юм. Эзэн Есүс ингэж хэлсэн: **‘Миний хонин сүрэг Миний дуу хоолойг сонсдог, Би тэднийг мэддэг бөгөөд тэд Намайг дагадаг’** (Иохан 10:27). Эзэн биднийг үнэн замд хөтлөх учир бид эцсийн өдрүүдийн хуурамч Христүүдэд төөрөгдөх тухай л санаа зовох бус, эцсийн өдрүүдийн үед Эзэний эргэн ирэлтийг мөн харгалзаж үзэх хэрэгтэй. Бурханы хоньд Бурханы дуу хоолойг сонсож чадна гэж Тэр хэлсэн учраас Эзэнийг бид эрж хайж л байвал Эзэний илрэлийг олох болно.” Гэвч Юнь эгч миний хэлсэнд огт анхаарал хандуулалгүй эцсийн өдрүүдэд хуурамч Христүүд хүмүүсийг хуурдаг тухай ярьж, намайг илүү болгоомжтой бай хэмээн давтсаар л байв. Дараа нь тэр Төгс Хүчит Бурханы Чуулган хэр муу болох тухай нэмж ярив. Би түүнийг ойшоогоогүй ба тэр намайг хариу хэлэхгүйг мэдээд ярихаа болив.

Гэвч захирал маань намайг Төгс Хүчит Бурханд итгэдэгт баяртай байгаагүй бөгөөд хамтран зүтгэгчдийн минь өмнө намайг дээрэлхэж, дайрахаа үргэлжлүүлсээр байв. Энэ үед Төгс Хүчит Бурханы Чуулганы ах эгч нар надад Бурханы эрмэлзлийг ойлгуулахын



---

тулд нөхөрлөж, Бурханы үгсийг хуваалцахаар үргэлж дэргэд минь байлаа. Мөн тэд надад Бурхан бол ариун, Бурхан хүн төрөлхтнийг бүтээхдээ чөлөөт хүсэл зориг, сонгох эрх чөлөөг хайрласан гэж хэлэв. Бурхан хэнийг ч юу ч хийлгэхээр огт хүчилдэггүй, харин биднийг тэжээлээр хангаж, Түүний эрмэлзлийг ойлгон, сайныг муугаас ялгахад маань туслах үнэнийг л илэрхийлдэг гэж тэд хэлэв. Энэ нь Бурхан Адам, Ева хоёрт Едений цэцэрлэг дэх мэдлэгийн модноос жимс идвэл үхэх учир үүнээс бусад аль ч модноос жимс идэж болно гэж айлдсантай төстэй юм. Бурхан хүн төрөлхтөнд сонгох эрх чөлөөг олгодгоороо мөн чанартаа өгөөмөр, харин Сатан л муу учраас хүмүүсийг хянаж, албаддаг болохыг энэ харуулжээ. Тиймээс эцсийн өдрүүдийн Төгс Хүчит Бурханы ажлыг хүлээн зөвшөөрөх эсэх нь хүн бүрийн шийдвэр бөгөөд хэнийг ч болов үүнд хүчилдэггүй. Ах эгч нар Бурханы дараах үгтэй мөр олжээ: **“Хүмүүс дээр Бурханы хийдэг ажлын алхам бүрд, гаднаа энэ нь хүмүүсийн хоорондын харилцаа мэт, хүний зохицуулалт, хүний хөндлөнгийн оролцооноос үүдэлтэй мэт харагддаг. Гэвч нүднээс далдуур, ажлын алхам бүр, тохиолдож буй юм бүхэн нь Бурханы өмнө Сатаны тавьсан бооцоо бөгөөд Бурханд гэрчлэл хийхдээ бат зогсохыг хүмүүсээс шаарддаг. Жишээ нь, Иовыг шалгасан үеийг авч үзье: Нүднээс далдуур Сатан Бурхантай мөрий тавьж байсан бөгөөд Иовд тохиолдсон зүйл нь хүмүүсийн үйл хэрэг, хүмүүсийн хөндлөнгийн оролцоо байсан. Та нарт хийдэг Бурханы ажлын алхам бүрийн ард Сатаны Бурхантай тавьсан мөрий байдаг—энэ бүгдийн ард тэмцэл байдаг... Бурхан, Сатан хоёр сүнсний ертөнцөд тулаан хийх үед чи Бурханыг хэрхэн сэтгэл хангалуун болгож, Түүнд хийх гэрчлэлдээ хэрхэн бат зогсох ёстой вэ? Чамд тохиолддог бүхэн асар их шалгалт гэдгийг, мөн Бурхан чамаар гэрчлэл хийлгэх хэрэгтэй болох тэр цаг үеийг чи мэдэх ёстой”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурханыг хайрлах нь л үнэхээр Бурханд итгэж буй хэрэг”). Тэдэнтэй харилцсан нь надад энэ мөрийг арай сайн ойлгоход тус болов. Надад юу ч тохиолдсон, тэр нь Бурханаар зөвшөөрөгдсөн болохыг би одоо ойлголоо. Бурхан намайг Өөрт нь үнэн итгэлтэй байгаа эсэхийг харж, намайг ялган таних ухаантай болгохын тулд эдгээр байдлыг ашиглаж байжээ. Бурхан Өөрөөс нь гардаг зүйл, Сатанаас гардаг зүйлийг надад тодорхой харуулахыг хүсэж, намайг Бурханд найдаж, Түүн өөд харж, Иов шиг Түүнд гэрчлэл хийж, Сатаныг шившиглэхэд сорилтоор сургах гэжээ.

Бурханы үгсээр удирдуулж, ах эгч нарын туслалцаатайгаар би үнэн замын тухай илүү тодорхой ойлголттой болж чадлаа. Би Төгс Хүчит Бурханыг дагаснаараа буруу замд ороогүй, харин Хурганы мөрийг дагаж байгаа гэдэгтээ итгэлтэй байв. Төгс Хүчит Бурханы Чуулганы ах эгч нар надад үнэн болон Бурханы эрмэлзлийг нөхөрлөж байлаа. Тэд хүн төрөлхтнийг аврах Бурханы ажил болон Бурхан оршдог, Түүнд байдаг бүхний тухай гэрчлэл хийж байлаа. Тэд намайг юунд ч итгүүлэхээр албадалгүй, харин надад өөрөө

---

сонголтоо чөлөөтэй хийхэд минь туслах гэж төрөл бүрийн дуу хоолойг яаж ялган танихыг суралцахад минь тусалсан юм. Гэвч Юнь эгч, манай захирал хоёр бүх онлайн цуу ярианд итгэж, намайг албадан, эцсийн өдрүүдийн Бурханы ажлыг хүлээн зөвшөөрөхөөс минь сэргийлэхийн тулд Бурханыг эсэргүүцэж, доромжилсон юу ч хэлэхээс буцахгүй байлаа. Тэд намайг өөрсдийнх нь үзлийг хүлээн зөвшөөрөхгүй байхаар дээрэлхэж, дооглон, үг хэлээр доромжилж эхэлсэн юм. Гэвч хүмүүсийг дээрэлхэж, албадаж, дайрах нь Сатанаас гаралтай үйлдлүүд учир тэдний хэлж, хийсэн болгон Сатанаас ирсэн болохыг би тодорхой харсан билээ. Бурхан, Сатанаас ирдэг зүйлсийг зэрвэс хараад л мэдэх чадварыг надад хайрласанд Бурхандаа талархав. Би одоо амьдралд минь гэрэл гэгээ байгааг, зүрх сэтгэлээс минь хүнд ачаа авч хаясныг мэдрэв. Эцсийн өдрүүдэд хүний дүрээр бие махбодтой болж, маш олон үнэнийг илэрхийлсэн Бурханд би маш талархаж байсан ба үүний ачаар би дээрэлхүүлэх бүртээ Бурханы үгсэд хандаж, Түүний эрмэлзлийг ойлгон, хэрэгжүүлэх арга олж чадсан юм. Бурханы хайрласан тэжээлээр би ямх, ямхаар өсөх боломжтой байсандаа тун азтай санагдаж байна.

Эхэндээ би бүх зүйл эцэс болсон гэж бодож байсан тул шинэ дайралтууд эхлэхэд гайхсан юм. Намайг нэг үйлчлүүлэгчид гоо сайхны эмчилгээ хийж дөнгөж дуусаад байтал захирал маань ирж, намайг хажуу өрөөнд аваачлаа. Бид хаалганд очиход дотор нь Юнь эгч намайг хүлээж байгаа гэж тэр хэлэв. Дотогш ороод би Юнь эгч, Лиу пастор, түүний эхнэр гурвыг хараад юу хийх гэж байгааг нь мэдээгүй тул тэр даруй жаахан сандрав. Би Бурханд түргэхнээр чимээгүй ингэж залбирлаа: “Бурхан минь, тэд надтай ярилцахаар дахиад иржээ. Намайг хамгаалж, тэдний хэлэх үгст ухаалаг хариулт өгч надад туслаач.” Залбирсныхаа дараа би сандрахаа больж, тэд намайг Төгс Хүчит Бурханыг орхиулах гэж албадахаар ирсэн эсэхийг бодов. Хэрэв би татгалзвал ажилгүй болох болов уу? Гэвч дараа нь би бүх зүйл Бурханы гарт байдаг бөгөөд Бурханы төлөвлөгөө үргэлж нийцтэй байдгийг санаад ажлаа алдсан ч Төгс Хүчит Бурханыг орхихгүй гэж шийдлээ.

Пастор надаас хэзээ анх Эзэнд итгэж эхэлснийг асуугаад, Эзэнд итгэхтэй холбоотой олон зүйлийн тухай яриу. Дараа нь тэр надаас “Төгс Хүчит Бурханы Чуулганы тухай чи мэдэх үү? Тэдэнтэй холбоотой хэвээр байгаа юу? ...” гэж асуув. Тэгснээ тэр Төгс Хүчит Бурханыг доромжилж, Төгс Хүчит Бурханы Чуулганыг хилс хэрэгт гүтгэсэн олон зүйл ярилаа. Түүнийг сонсоод миний уур хүрч, “Таны ярьж байгаа Төгс Хүчит Бурханы Чуулган яагаад миний холбоотой байдаг, мэддэг тэр Чуулгантай огт адилгүй байна вэ? Бид бүгд онлайнаар юм үзсэн. Би Төгс Хүчит Бурханы үгс, Төгс Хүчит Бурханы Чуулганы кино, видео бичлэг, мөн ах эгч нарын бичгэн гэрчлэлийг үзсэн юм. Би мөн зарим сөрөг суртал ухуулгыг харсан ч, надад тэд бүгд үндэслэлгүй олон цуу яриа, худал хуурмаг л байгаа харагдсан. Аль ч цуу яриа байсан гэлээ, тэд үүнийгээ нотлох ганц ч итгэмээр

---

баримт гаргаж ирж чадахгүй. Тэд оргүй хоосноос юм зохиож, эсвэл байгаа худал хуурмагийг чимээд улам цааш түгээдэг. Эдгээр нь цөм Сатаны худал хуурмаг учир би тэдгээрт итгэдэггүй, тэдгээрт ямар ч сонирхол байхгүй. Та нар яахаараа сөрөг цуу ярианд л итгэж, Төгс Хүчит Бурханы Чуулганы вэбсайт дээрх Бурханы үгсийг огт хардаггүй юм бэ? Та нарын хэн нь ч Төгс Хүчит Бурханы үгсийг уншиж, эцсийн өдрүүд дэх Бурханы ажлыг судалдаггүй атлаа дураараа үүнийг яллаж байна. Энэ зөв үйлдэл мөн үү?” Пастор миний асуултад шууд хариулсангүй, харин оронд нь ингэж хэлэв: “Төгс Хүчит Бурханы Чуулган тун хурдан өргөжиж, бусад чуулганы гишүүдийг хулгайлахаар идэвхтэй явж байна. Хэрэв чи Төгс Хүчит Бурханд итгэнэ гэж зүтгэвэл бид чамд сайхан хандахгүй. Бид чуулганахаа бүх ах эгч нарт чамайг одоо Төгс Хүчит Бурханд итгэдэг болсныг хэлж, ингэснээр чи дараа нь манай чуулганд ирэхэд өөрсдийг нь хулгайлахаар ирж гэж тэд бодон хүйтэн хөндий хандах болно.” Тэрээр бүр намайг айлгахын тулд худал гэрчлэл ашиглахаар оролдсон ч түүний хэлсэн юу ч надад нөлөөлсөнгүй. Харин ч, би улам зориг орж, “Та яриад байгаа эдгээр зүйлээ болж байгааг нь өөрийн нүдээр үзсэн үү? Эсвэл та бүрэн судалгаа хийж, баттай нотолгоо олсон уу? Төгс Хүчит Бурханы Чуулганы гишүүд энэ бүхнийг хийсэн гэх ямар нотолгоо танд байгаа юм бэ? Та Төгс Хүчит Бурханыг яллаж, Төгс Хүчит Бурханы Чуулганыг хилс хэрэгт гүтгэх гэж ХКН болон шашны нийгэмлэгийн түгээсэн цуу яриа, худал гэрчлэлийг л ашиглаж байна шүү дээ. Та яг л фарисайчууд шиг Эзэнд яллагдах вий гэж санаа зовохгүй байна уу?” гэж хэлэв.

Би мөн ингэж хэллээ: “Эзэн Есүс Өөрийн эргэн ирэх тухай ингэж зөгнөсөн: ‘Гэхдээ Тэр эхлээд олон зовлон туулах ёстой бөгөөд энэ үеийнхэнд гологдоно’ (Лук 17:25). Энэ юу гэсэн үг вэ? Эдүгээ шашны нийгэмлэг тэр аяараа, мөн Хятадын шашингүй үзэлт Коммунист засгийн газар эцсийн өдрүүд дэх Төгс Хүчит Бурханы ажлыг эсэргүүцэж, яллахын тулд чадах бүхнээ хийж байна. Үүгээр Эзэний зөгнөл биелэхгүй байна гэж үү? Төгс Хүчит Бурханы эсрэг шашны ертөнцийн эсэргүүцэл, ялалт нь Эзэн Есүсийн эсрэг фарисайчуудын эсэргүүцэл, ялалттай ижил биш үү? Фарисайчууд Эзэн Есүсийг эсэргүүцэж, Тэрээр эргэн ирж байгаа Мессиа гэдгийг няцаасан ч Эзэний дагалдагч нар Эзэн Есүсийг зөгнөлүүдэд хэлсэн Мессиа мөн гэдгийг таниад, Түүнийг дагасан байдаг. Энэ цаг үед бид адилхан байдалтай тулгараад байна. Пасторууд, ахлагчид эцсийн өдрүүд дэх Бурханы ажлыг хүлээн зөвшөөрөлгүй, тэр ч бүү хэл Төгс Хүчит Бурханыг эсэргүүцэн, ялладаг ч төрөл бүрийн бүлэглэлийн сайн хоньд Төгс Хүчит Бурханы үгээс Бурханы хоолойг таньж, Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс гэдгийг таньж чадна. Яагаад тэр билээ? Бурханы хоньд Бурханы дуу хоолойг сонсох чадвартай бөгөөд Бурханы эргэн ирэлт хонийг ямаанаас салгах болно гэж Эзэн Есүс хэлсэн юм. Би Эзэнд итгээд удаагүй, Библийг тийм ч сайн ойлгодоггүй учраас Эзэн хэрхэн хоньдыг ямаадаас салгахыг

---

мэдэхгүй байна. Лиу пастор та шашны сургуульд сурч, олон жил пастор байлаа. Магадгүй та надад үүнийг тайлбарлаж өгөх юм биш биз?” Лиу пастор надад үүнийг яаж тайлбарлахаа илт мэдэхгүй байсан тус над руу ууртайгаар харав. Тэр ердөө ингэж хэлсэн юм: “Итгэгчид бид баптисм хүртсэн учраас мөнхийн амийг олдог.” Тэгэхэд нь би “Юу гэнэ ээ? Мөнхийн амийг олох нь тийм амар гэж үү? Тэгвэл танай чуулганд очиж, баптисм хүртсэн хүн бүр тэнгэрийн хаанчлалд орно гэж үү? Энэ чинь Эзэний хэлсэн үгтэй нийцдэг үү? Тэд бүгд Эзэнд үнэн зүрх сэтгэлээсээ ханддаг хүмүүс мөн үү? Тэд бүгд тэнгэрлэг Эцэгийн хүслийг дагадаг гэж үү? Чуулган дахь номлол бүрт тахил өргөх тухай дурддаг ч Эзэн тахил өргөх Өөрийг нь хайрлахтай ижил гэж огт айлдаагүй. Тэгвэл Эзэнийг хайрлана гэж юу гэсэн үг вэ?” гэлээ. Лиу пастор ингэж хариулав: “Библи их уншиж, их залбирах нь Эзэнийг хайрлаж байгаа хэрэг юм.” Би хэдийгээр Эзэнийг үнэхээр хайрлана гэж юу гэсэн үг болохыг мэдэхгүй байсан ч, Библийг уншиж, залбирах нь Эзэнийг хайрлаж байгаа хэрэг гэж хэлэх нь хоосон дэмийрэл гэдгийг мэдэж байв. Фарисайчууд Библи уншиж, их залбирсан ч тэд Эзэнийг хайрласан гэж хэлж болох уу? Хэрэв тэд Эзэнийг хайрласан бол юунд Түүнийг доромжлон яллаж, загалмайд цовдлох билээ? Пастор Эзэнийг хайрлана гэдэг юу гэсэн үг болохыг огт ойлгоогүй мэт надад санагдав. Пасторууд библийн мэдлэг, шашны онолуудыг сайн ойлгож болох ч, энэ нь тэд үнэнийг ойлгодог гэсэн үг биш! Гэхдээ өмнө нь хангалттай ялган таних чадваргүй байж, тэднийг дээгүүр үнэлэн явсан өөрийгөө л буруутгахаас аргагүй байв.

Үүнийг ойлгосныхоо дараа би Лиу пастортой үргэлжлүүлэн мэтгэлцэх утгагүй санагдсан тул ярихаа болив. Гэвч пасторт цааш ийн хэлэв: “Эзэн ажлаа хийхээр эмэгтэй хүний бие махбодтойгоор эргэн эрсэн гэж тэд хэлдгийг чи мэдэх үү?” Үүнийг сонсоод би хариулах ёстой мэт санагдаж: “Эзэн эргэн ирж, бие махбодтой болохдоо ямар дүртэй байх нь Бурханы шийдэх асуудал. Бид бол ердөө Бурханы бүтээсэн асар өчүүхэн биетэн учир Бурханы ажилд дүрэм тогтоож яаж болох вэ? Библид ингэж хэлсэн байдаг: ‘Учир нь, хэн Эзэний хүслийг мэдсэн юм бэ? Эсвэл хэн Түүний зөвлөх байсан бэ?’ (Ром 11:34). Төгс Хүчит Бурханы үгст хэлэхдээ: **‘Хүн Бурханы ажлыг тодорхойлох ёсгүй; түүнчлэн, хүн Бурханы ажлыг тодорхойлж чадахгүй. Бурханы нүдээр бол хүн шоргоолж шиг өчүүхэн юм; тэгэхээр хүн яаж Бурханы ажлыг ойлгож чадах юм бэ?’** (Үг нь махбодоор илэрсэн номын Өмнөх үг) гэсэн байдаг. Бурхан бол бүх зүйлийг Бүтээгч бөгөөд Бурханы мэргэн ухаан бүхнийг даван гардаг учраас Бурхан ажлаа яаж ч хийсэн хүмүүн бидэнд эхэлж хэлэх шаардлагагүй!” Тэдэнд эцсийн өдрүүд дэх Бурханы ажлыг эрж хайн, судлах хумсын төдий ч сонирхол байхгүй, харин хэл ам хийж, Бурханыг дайрч, доромжлох боломж хайж, намайг эцсийн өдрүүдийн Бурханы ажлыг хүлээн зөвшөөрөхөөс сэргийлэх л хүсэлтэйг хараад би яриаг үргэлжлүүлэхгүй байхаар шийдлээ. Тэдэнд тавьсан сүүлийн

---

асуулт маань энэ байв: “Өнөөдөр салонд ирсэн чинь миний эндэх ажилд яаж нөлөөлөх тухай бодолцов уу?” Пастор улаан нүүрэн дээр минь худал ярьж, намайг бүр гайхшруулав: “Танай захирал энэ яриа юун тухай болохыг мэдэхгүй.” Хэрэв би түүний ингэж хэлэхийг өмнө нь сонссон бол номлол хийж, хүмүүст зааварчлан, Библийг маш сайн мэддэг хүн болох энэ пастор ингэж цагаандаа гарсан худал үг хэлж чадаж байгаад их цочирдох байлаа. Гэхдээ тэд Эзэнийг доромжилсон худал хуурмаг зохиож байгааг харсны дараа би огтхон ч гайхаагүй юм. Тэдэнд худал ярих ер нь хэвийн үзэгдэл гэдэг нь илт байлаа. Би яах аргагүй Эзэн Есүсийн үгсийг бодов: **“Та нар эцэг диаволаасаа гаралтай бөгөөд эцгийнхээ хүслийг хийх болно. Тэр анхнаасаа алуурчин байсан ба түүнд ямар ч үнэн байхгүй тул Үнэнийг баримталдаггүй. Худлаа хэлэхдээ тэр өөрөөсөө хэлдэг: учир нь тэр бол худалч бөгөөд худал хуурмагийн эцэг мөн”** (Иохан 8:44). Би зүрх сэтгэлдээ Бурханд энэ үгсийг хэлэв: “Баярлалаа, Бурхан минь! Өнөөдөр энэ үйл явдал надад тохиохыг Та зөвшөөрснөөр тэд үнэний талаар ямар ч ойлголтгүйг би харж чадлаа. Тэд ичгүүргүйгээр худал хуурмагийг түгээж, хүмүүсийг хуурдаг худалчид гэдгийг Та надад харуулах ёстой байж. Тэд бол хоёр нүүрт фарисайчууд юм байна.” Надад өөр тэдэнд хэлэх зүйл үлдээгүй бөгөөд даруйхан явах хүсэлтэй байв.

Яриаг үргэлжлүүлэх бодолгүй байгааг минь хараад, Юнь эгч надад ингэж хэлэв: “Ишинь, чи үр хүүхэд, эцэг эхийнхээ тухай бодох хэрэгтэй.” Би хариуд нь: “Тэд сайн байгаа, бид бүгдээрээ тайван, аюулгүй байна. Би бүх зүйлийг Бүтээгч, ганц үнэн Бурханд итгэдэг. Төгс Хүчит Бурхан бол Эзэн Есүсийн эргэн ирэлт юм. Бурхан бол хүмүүсийг хайрлаж, авардаг Бурхан, Бурханы ерөөл, удирдлагаар манай гэр бүл улам бүр дэгжих болно” гэлээ. Пастор, Юнь эгч хоёр миний төлөө залбирахыг хүссэн ч би татгалзав. Тиймээс Лиу пастор анхааруулгаар яриагаа өндөрлөв: “Хэрэв чи Төгс Хүчит Бурханы Чуулганыг орхихгүй бол манай чуулганаас цөлөгдөнө дөө!” Би ингэж бодов: “Чуулган сүүлийн үед ямар байгаа бол? Яг л Эзэн Есүс Өөрийн ажлыг анх эхэлж байсан үеийн сүм шиг хулгайчдын үүр байгаа. Цуглаан ямар ч сүнсний тэжээл өгдөггүй, надад санах зүйл юу байх юм бэ” гэж бодов. Өнөөдөр би Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн авч, Хурганы мөрийг даган, Бурханы сэнтийн өмнө ирээд байна. Би Христийн өгсөн амийн амьд усаар хангуулж, Бурханы нүүр тулсан тэтгэлт, хариулгыг эдэлж байна. Надаас золтой хүн гэж үгүй бөгөөд Төгс Хүчит Бурханы Чуулган одоо миний жинхэнэ гэр билээ.

Төгс Хүчит Бурханы үгст ингэж хэлсэн байдаг: **“Одоо үед зохицуулагдсан бүх зүйл нь та нарыг амиа өсгөхөд сургах, та нарын сүнснийг нарийн мэдрэмжтэй, хурц болгох, мөн Бурханаас ямар зүйлс ирдгийг танин мэддэг болгохын тулд та нарын сүнслэг нүдийг нээх зорилготой юм”** (“Үг нь махбодоор илэрсэн” номын Христийн эхэн үеийн айлдваруудын “13-р бүлэг”). Намайг өрөвдөж, шашны хүчний үймээнийг ашиглан надад

---

ялган таних чадвар суулгасан Бурханд талархъя. Тэдгээр пастор худал хуурмагаар дүүрэн бөгөөд эцсийн өдрүүдийн Бурханыг хэрхэн эсэргүүцэн, яллаж, Бурханаас өчүүхэн ч эмээж, Түүнийг хүндэтгэдэггүй болохыг нь би харлаа. Тэдний гишүүд нүгэлт замтай хэрхэн зууралдаж, тэд хэрхэн материаллаг ертөнцийн чиг хандлага, загварыг сохроор дагаж, сүсгээр хэр дутдагийг би харлаа. Энэ бүхэн надад шашны нийгэмлэг Ариун Сүнсний ажилгүй болж, харанхуйд автаж, Сатаны хяналтад оржээ гэдгийг үнэмшүүлэв. Үүний хажуугаар би Төгс Хүчит Бурханы ах эгч нар Бурханы үгс дэх удирдамжаар үнэн болоод Бурханы мэдлэгийг эрж хайж байгааг харж болохоор байв. Тэд бэрхшээлтэй тулгарахдаа асуудлаа шийдвэрлэхийн тулд Бурханы үгсийг ашиглахаар чармайж, тэгснээр энэ нь тэр чигтээ үнэн, Бурханы үгс, Ариун Сүнсний эдэлдэг хүч чадал болдог. Төгс Хүчит Бурханы үгсийг буцааж болохгүй бөгөөд хэлсэн бүхэн хийгдэх болно. Бурханы биелүүлэхийг хүссэн зүйлд хэн ч саад болж чадахгүй, энэ бол няцаагдашгүй баримт мөн! Төгс Хүчит Бурханы үгс нь маргаангүй үнэн бөгөөд Төгс Хүчит Бурхан бол бүтээгч Эзэний илрэл юм. Одоо би Төгс Хүчит Бурханыг үлдсэн амьдралынхаа туршид дагахад бэлэн байна.

## **32. Өнгөрснөөс бүрмөсөн салсан нь**

Фанфан, Хятад

Манай гэр бүлийнхэн бүгдээрээ Эзэн Есүст итгэдэг, би бол энгийн л итгэгч бөгөөд аав минь чуулганы хамтран зүтгэгчдийн нэг билээ. 2004 оны хоёрдугаар сард би Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн зөвшөөрсөн бөгөөд тун удалгүй хаанчлалын сайн мэдээг хамгийн бага охин дүүдээ номлосон юм. Анхандаа би Бурханы зарим нэг үг болон үнэнээр өөрийгөө зэвсэглэн Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг аавдаа гэрчлэх гэж байв. Харин надад гайхшрал төрүүлсэн зүйл нь, Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн зөвшөөрсөн гэдгийг минь сонсоод аав надад саад болж, үүнээс сэргийлэхийг оролдон галзууртлаа уурласан юм.

Нэг орой, аав гэрт минь уцаарлан ирээд, надад: “Би чамайг миний болон чуулганы удирдлагын зөвлөгөөг үл тоож, Зүүний Аянгад итгэх юм гэж хэзээ ч санасангүй! Чи удирдагчийн гэр лүү яаралтай явж, гэмшсэн чинь дээр дээ. Эзэнээс нүглийг чинь өршөөхийг гуй” гэж хэллээ. Би хариуд нь: “Аав аа, би Төгс Хүчит Бурханы үгнээс их уншсан, тэдгээр нь Бурханы дуу хоолой гэдэгт үнэхээр итгэж байна. Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс бөгөөд би үүнд итгэлтэй байна. Нигүүлслийн эрин үе хэдийнээ дууссан, бид нар одоо Хаанчлалын эрин үед байна. Бурхан шинэ ажил хийж, биднийг

---

Хурганы хуримын зоогонд аваачихаар ирсэн. ‘Тэд бол Хургыг хаашаа ч явсан дагадаг хүмүүс юм’ (Илчлэл 14:4) гэж Библид хэлдэггүй гэж үү? Төгс Хүчит Бурханд итгэснээр би Хурганы хөлийн мөрийг дагаж байна...” гэв. Гэхдээ намайг юу ч хэлсэн бай аав минь алийг нь ч сонсох сонирхолгүй байсан ба чуулганы удирдагчдын нэгтэй уулзуулахаар авч явах гэж зүтгэсээр байлаа. Нөхөр минь ч бас аавтай нэгдэж надад шахалт үзүүлэв. Аавын минь нүүр царайны байдал анхны бүлэглэл рүү минь намайг буцаан аваачихаар бүрэн шийдсэн байгааг надад хэлж өгөв. Сэтгэл хөдлөл нь ширүүсэж, нөхцөл байдал дордож болохыг ухаараад би өөрийн эрхгүй бага зэрэг сандрав. Иймд, би Бурханд чимээгүй залбирч, хамгаалалт болон удирдамж гуйлаа. Бүх зүйл миний төсөөлсний дагуу болов: Намайг ямар ч үг хэлүүлэлгүйгээр аав машинд хүчээр суулгаж, нөхөр маань чуулганы цуглааны байр луу жолоодов. Би барилга руу орохдоо, жар далан хүн тэнд хүлээж байхыг харав, миний хамгийн бага охин дүүг хадам ээж нь авчирсан байлаа—тэд бүгд нууцаар үгсэж, бид хоёр луу бүгд зэрэг дайрах гэж байгааг би ухаарсан юм. Өрөөнд байсан хүн бүр дүү бид хоёр луу жигтэй харж байсан бөгөөд зарим нь бидэн рүү зааж, өөр хоорондоо шивнэлдэж байлаа. Чуулганы ахлах удирдагчдын нэг нь бидэн рүү яаран алхаж ирээд, Төгс Хүчит Бурханд итгэхээ болихыг даруй шаардаж эхлэв. Тэгээд тэр эцсийн өдрүүдийн Бурханы ажлыг өчүүхэн ч болгоомжлолгүйгээр яллаж, доромжилж эхэллээ. Тэр бүр баахан цуу яриа ч хэлэв, жишээлбэл: “Зүүний Аягад нэгдсэн хүмүүс хэзээ ч гардаггүй, эсвэл хэрвээ тэд орговол, хамраа огтлуулж, нүдээ ухуулдаг...” Эдгээр худал хуурмаг болон удирдагчдын турхиралт нь аав болон охин дүүгийн минь хадам ээжийг улам унтууцуулж, тэвдүүлсэн ба удирдагчийг бидний төлөө залбирал хэлэхэд тэд бидний нүдийг аниуллаа. Тэдний хийж байгаа зүйлийг би маш их эсэргүүцсэн бөгөөд удирдагчийг бидний төлөө залбирч байхад бид юу ч хэлсэнгүй. Гэхдээ удирдагчийн тараасан цуу яриа надад хэдийнээ гүнзгий сэтгэгдэл үлдээсэн билээ.

Гэртээ харихад тэдгээр айдас төрүүлсэн цуу яриа чихэнд минь цуурайтаж, сэтгэл санааны минь тайван байдлыг алдагдуулж байгааг би сонссоор байлаа. Би Бурханы үгэнд ч анхаарлаа төвлөрүүлж чадсангүй. Төгс Хүчит Бурханы Чуулганы Жанг эгчтэй хэдийнээ хэсэг хугацаанд холбоотой байснаа мөн түүний үг яриа, ааш зан нь үргэлж даруу төлөв агаад илэн далангүй байсныг бодов. Жанг эгч мөн бидэнтэй нөхөрлөхдөө их хайр халамжийг харуулсан бөгөөд энэ нь чуулганы удирдагчийн дүрсэлсэнтэй огтхон ч адилгүй байлаа. Гэхдээ үүнээс ч илүү чухал нь Төгс Хүчит Бурханы үг үнэн байсан ба эрх мэдэл, хүч чадлаар дүүрэн байлаа. Тэдгээр нь ямар ч хүний илэрхийлж чадах зүйл биш байсан учраас магадгүй Бурханы хоолой байсан байх аа. Тийм юм бол Төгс Хүчит Бурханы Чуулганыг тойроод яагаад ийм олон аймшигтай цуу яриа байсан хэрэг вэ? Тэгээд би Төгс Хүчит Бурханы эерэг талыг эхэлж бодоод, дараа нь сөрөг талыг нь ахин дахин бодон

---

унтаж чадалгүй орондоо шөнөжин хөрвөөлөө. Маргааш өдөр нь би нойрмог, тамир тэнхээгүй—илэрхийлэхийн аргагүй түгшүүртэй байлаа—юу ч хиймээргүй санагдаж байсан юм. Миний хамгийн бага охин дүү хүрч ирэв, тэрээр удирдагчийн болон хадам ээжийнхээ дайралтуудыг тэсэж чадаагүй нь, мөн Төгс Хүчит Бурханд итгэхээ больсон нь удалгүй тодорхой болсон ба одоо надаас ч мөн тэгэхийг шаардаж байлаа. Би тэсвэр алдан түүнд ингэж хэлэв: “Дүү минь, санаа зовсныг чинь би мэдэж байна, би ч бас их будилж, сэтгэл гонсгор байна. Гэхдээ энэ асуудлыг би их тунгааж үзсэн ба Эзэнээс ч удирдамж хүсэн залбирсан, иймээс удирдагчид юу ч хэлсэн бай, бидэнд итгэлтэй байж болох нэг зүйл бий, тэр нь Төгс Хүчит Бурханы үгийг хэзээ ч хүн хэлж чадахгүй юм. Эдгээр үг Бурханы дуу хоолой мөн гэдэгт би итгэлтэй байна. Би ‘Хурганы нээсэн хуйлмал ном’-г олон удаа уншсан бөгөөд энэ ном Бурханы зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөөний нууцуудыг ил болгодог. Номыг уншсан нь, хүн төрөлхтнийг аврах Бурханы ажил 3 үе шатаар хийгдэж байгааг болон эцсийн өдрүүдийн үгээр шүүх шүүлтийн ажил нь хүмүүсийг нэгд нэггүй аврах ажил гэдгийг надад сургасан билээ. Зөвхөн шүүлтийн ажил л биднийг нүгэлт уг чанарын дөнгөнөөс салгаж, ариусгалтад хүргэж чадна, тэгснээр бид тэнгэрийн хаанчлал руу өргөгдөж болох юм. Номын агуулга нь Библи дэх Эзэний зөгнөлүүдтэй бүрэн нийцдэг ба Библид байхгүй олон үнэнийг бас илчилдэг. Зөвхөн Бурхан л эдгээр үнэн болон нууцыг мэдэж чадна. Ийм учраас, Төгс Хүчит Бурханы үг бол Бурханы дуу хоолой гэдэгт, мөн Төгс Хүчит Бурхан бол бидний хүсэн хүлээж байсан эргэн ирсэн Эзэн Есүс гэдэгт би маш итгэлтэй байна! Дүү минь, бидний итгэл буруу биш ээ. Чи юу ч хийсэн бай, үнэн минь, бидний итгэл бугий орхиорой!” Хамгийн бага охин дүүгээ явсны дараа, би маш их гуниглаж, ийнхүү бодлоо: “Төгс Хүчит Бурхан бол мэдээжийн хэрэг эргэн ирсэн Эзэн Есүс. Энэ бол үнэхээр үнэн бөгөөд зөв. Ийм байхад, яагаад чуулганы удирдагчид болон гэр бүл маань биднийг Түүнд итгүүлдэггүй билээ?” Намайг яг үүнийг бодож байтал, нөхрийн минь гар утас дуугарав: Энэ нь аав байлаа, намайг гэр лүү нь яаралтай очихыг тэр хүсжээ. Аав намайг ахин зовоох гэж байгааг би мэдсэн учраас явмааргүй байна гэж хэлсэн боловч нөхөр минь намайг барьж аваад, машиндаа суулгав. Гэрт нь очиход, хамгийн бага дүү болон хадам ээж нь хэдийн тэнд байхыг харлаа. Намайг хараад аавын минь царай ширүүсэж: “Урд шөнө, чуулганы удирдагч Эзэн Есүсийн өмнө та нарын нүглийг наманчлахын төлөө залбирсан. Гэтэл та хоёрын хэн нь ч нүглээ улайж, гэмшихийг хүсэхгүй байна. Би та хоёрыг өнөөдөр энд дуудлаа, ингэж байж л та нар Эзэний өмнө бүрэн гэмшсэн залбирал хэлж чадна. Тэгээд ахиж Төгс Хүчит Бурханд итгээд үзээрэй...” гэв. Энэ бүгдийг сонсоод, би маш их уурлав. Би дотроо: “Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн зөвшөөрснөөр би Хурганы хөлийн мөрийг дагаж байгаа ба Эзэний эргэн ирэлтийг угтаж байгаа юм. Үүнд нүгэл хаана байна вэ? Би мэдсээр байж худал хэлж, утгагүй зүйл ярихгүй” гэж бодлоо.



---

Намайг гэмшлийн залбирал хэлэх шинжгүй байхыг хараад, аав, ээж, охин дүүгийн хадам ээж намайг бүслэн авч, үгийн дайралтаар гал нээв. Тэд намайг хүчээр “улайлгаж, гэмшүүлэх”-ийн тулд Бурханыг гүжирдэж, доромжилж эхэлсэн бөгөөд нөгөө аймшигтай цуу яриануудын талаар таамаглал дэвшүүлж байлаа. Тэр бүх цуу яриа толгойд минь эргэлдэж, гэр бүлийнхэн маань над руу ойртон давшлахад амьсгал давчдаж, толгой эргэн, бие сульдаж эхлэв. Би дотроо бодлоо: “Хэрвээ тэд над руу энэ мэтээр өдөр бүр дайрвал, би ах эгч нартай холбоо барьж чадахгүй, Бурханы үгийг ч зохих ёсоор унших чадахгүй. Би Бурханд итгэх итгэлийн энэ замаар явж чадна гэж бодохгүй байна...” Тэр агшинд, миний эцэг эх болон хадам ээж нь намайг барьж, дүү бид хоёрын нүдийг хүчээр аниулж, “гэмшүүлэв”. Тэдний хэчнээн түрэмгий аашилж байхыг хараад, би туйлын их гонсойж, нүдэнд минь мэлмэрэх нулимсыг тогтоон барьж чадахгүй байлаа. Би уйлангаа, Эзэнд ингэж залбирлаа: “Эзэн Есүс минь, Төгс Хүчит Бурхан бол Таны эргэн ирэлт гэдгийг би мэднэ, гэхдээ одоо Танд итгэх зориг надад алга. Намайг уучилж, нүглийг минь өршөөхийг би Танаас гуйя...” Энэ үед, би маш их уйлж байсан болохоор үргэлжлүүлж чадаагүй ба залбирал ийнхүү дууссан билээ. Үүний дараа, надад гэнэтхэн маш сул дорой оюун ухаантай агаад зүрх зориг дутмаг санагдаж, Бурханы байгааг огт мэдэрч чадахгүй байлаа. Надад маш тайван бус санагдаж, хамгийн бага охин дүүдээ ингэж хэлэв: “Гэмшлийн залбирлын өмнө надад жаахан хүч үлдсэн мэт санагдсан ч, залбирлын дараа Ариун Сүнс намайг орхисон юм шиг, миний хүч бүхэлдээ шавхагдсан мэт санагдсан. Үнэн хэрэгтээ, Төгс Хүчит Бурханд итгэнэ гэдэг нь Эзэнийг дагаж байгаа хэрэг бөгөөд гэмшлийн залбирал бол Эзэнээс урвах урвалт юм.”

Миний зүрх сэтгэл дэх тэмцэл гэртээ харьсны дараа үргэлжиллээ: Би Төгс Хүчит Бурханы үгээс ихийг уншиж, эдгээр нь Бурханы айлдвар гэдгийг таньсан. Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс бөгөөд үүнийг хүлээн зөвшөөрөхгүй байх нь Бурханаас урвасан хэрэг, энэ нь намайг аврагдахгүй байхад хүргээд зогсохгүй, мөн Бурханаар яллагдахад хүргэнэ. Гэхдээ хэрвээ би Төгс Хүчит Бурханд итгэхээр зүтгэсэн бол чуулганы удирдагчид болон аав минь намайг үргэлжлүүлэн зовоох байсан бөгөөд одооноос эхлээд би ганц ч өдөр амар тайван байж чадахгүй байх байлаа. Надад цөхрөлтгүй оролдох зориг байхгүй хэмээн би үнэхээр бодов. Миний зүрх сэтгэл үймэрсэн байлаа, би хаашаа л эргэнэ саад бэрхшээлтэй нүүр тулж, юу хийхээ огт мэдэхгүй байлаа. Миний толгой дүйнгэтэж байсан бөгөөд сэтгэлийн хямралд ороход ойрхон мэт санагдаж байлаа. Би Жанг эгчийг ирээсэй гэж хүсэв, тэгснээр би түүнд номыг нь эргүүлэн өгч, амьдралдаа авчирсан зовлонгоосоо салж чадах байлаа.

Хэдэн өдрийн дараа Жанг эгч салонд туслахаар ирэв. Би туйлын их сандарч байсан бөгөөд нөхөр минь түүнийг хараад аавд хэлэх вий гэдгээс санаа зовж байлаа. Улмаар, би

---

сүүлийн хэдэн өдөр болсон зүйлсийг амьсгаа ч авалгүй бүгдийг нь түүнд хэлэв. Тэгээд би хайрцагтай бараан дор нуусан байсан Бурханы үгийн номыг яаран гаргаж, түүнд өглөө. Би түүнд: “Эгч ээ, эцэг эх, нөхөр маань намайг дарамталж байгаа бөгөөд миний анхны урсгалын удирдагчид болон ах, эгч нар надад маш их саад болж, би зодуулж, гэмтлээ. Би цаашид үүнийг тэвчиж чадахгүй нь, иймд та энэ номыг аваад явна уу” гэж хэлэв. Жанг эгч над руу хараад, асар их чин сэтгэлээр ингэж хэллээ: “Эгчээ, бид Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн зөвшөөрснөөс шашны удирдагчид болон гэр бүлийнхний зүгээс үймээн самуун, хавчлага ирж байгаа нь сүнслэг тулаанд оролцож байгааг харуулж байна! Эзэн Есүс ингэж хэлсэн: **‘Намайг газар дээр энх тайвныг авчрахаар ирсэн гэж бүү бод: Би энх тайван биш, харин илд илгээхээр ирсэн юм’** (Матай 10:34). **‘Хүний дайсан нь өөрийнх нь гэрийнхэн байх болно’** (Матай 10:36). Бурхан авралын ажил хийхээр газар дэлхийд ирж байгаа нь зайлшгүй сүнслэг тулааныг бий болгоно гэдгийг бид Эзэний үгнээс харж болно. Учир нь Бурханд чин сэтгэлээсээ итгэж, үнэнийг хайрладаг хүмүүс Бурханы айлдварыг сонсоод, Бурханыг дагах болно. Энэ нь үнэнийг үзэн ядаж, Бурханыг эсэргүүцдэг хүмүүсийн үзэн ядалтыг өдөөх нь гарцаагүй. Үүний үр дүнд, хоёр тал—Бурханд харьяалагддаг эерэг, Сатанд харьяалагддаг сөрөг тал—илчлэгдэж, өөр өөрийн төрөлдөө тавигдах болно. Энэ бол Бурханы төгс хүчит байдал болоод мэргэн ухаан! Эзэн Есүс анх Өөрийн ажлыг хийж эхэлсэн үеийг эргээд бод, Эзэн Есүсийн айлдварыг сонсож, Түүний агуу чадваруудыг нүдээр харсан олон тооны жирийн иудей хүмүүс, Эзэн Есүс бол ирж буй Мессиа гэдэгт итгэж, Түүнийг дагасан. Гэтэл энгийн ардууд өөрсдөөс нь холдож, Эзэн Есүс рүү зүглэж байгааг харсан Иудейн бүх тахилчид, хуулийн багш нар болон фарисайчууд энгийн ардыг хуурахын тулд маш их цуу яриа зохиож, тарааж эхлэх болсон. Эзэн Есүс чөтгөрүүдийг зайлуулахдаа чөтгөрүүдийн хаан Беелзебүлд найддаг бөгөөд Тэр хоол идэж, дарс уух дуртай хэмээн тэд хэлсэн билээ. Эзэн Есүсийг амилахад, Эзэн Есүсийн биеийг шавь нар нь хулгайлсан хэмээн цуу яриа зохиож, үүнийгээ тараахаар Ромын цэргүүдийг мөнгөөр хахуульдсан байдаг. Энэ бол Эзэн Есүсийн авралыг хүлээн зөвшөөрөхөд нь хүмүүст саад болохоор оролдсон тэдний зарим нэг арга зам юм. Эцэст нь шашны удирдагчдынхаа хэлсэн үгэнд итгэж, Эзэн Есүсийг дагаж зүрхлээгүй бүх иудейчүүдэд юу тохиолдсон билээ? Тэд Эзэний авралыг алдаад зогсохгүй, Бурханд шийтгүүлж, хараагдсан: Израиль бараг 2000 жилийн турш алга болсон бөгөөд иудейчүүд дэлхий даяар цөлөгдсөний олонх нь хяхан хавчигдаж, алагдсан билээ. Энэ бол Эзэнийг цовдолж, түүнчлэн Бурханы зан чанарыг ноцтойгоор зөрчсөнийхөө төлөө тэдний туулсан аймшигт залхаан цээрлүүлэлт байсан юм. Өнөөдөр, Бурхан Өөрийн ажлыг хийхээр дахин нэгэнтээ махбод болсон ба түүх давтагдаж байна. Өнөөдрийн шашны удирдагчид бол хуучны фарисайчуудтай адил: Тэд үнэнийг илэрхийлж, хүмүүсийг аврах ажлаа хийхээр ирж байгаа Бурханы бодит байдлыг хардаг боловч үнэнд дургүй учраас Бурханы эцсийн

---

өдрүүдийн ажлыг үгүйсгэж, ялладаг. Өөрсдийн байр суурь, амин зуулгыг хамгаалахын тулд тэд Бурханыг эсэргүүцэж, яллах цуу яриа зохиож, хүмүүсийг хуурч, хянахын тулд эдгээр цуу яриаг ашигладаг. Үнэн замыг хүлээн зөвшөөрсөн итгэгчдэд дарамт үзүүлэхийн тулд тэд юугаа ч мэдэхгүй зарим хүмүүсийг ашиглаж, турхирдаг бөгөөд Төгс Хүчит Бурхан руу эргэхэд хүмүүст саад болж, сэргийлэх үүднээс бүх төрлийн галзуу арга барилыг ашиглан, тийнхүү энэ хүмүүсийн аврагдах боломжийг сүйрүүлдэг. Эгч минь, энэ бол сүнслэг тулаан гэдгийг бид тодорхой харж, Сатаны хорон муу явуулгыг нэвт харах чадвартай байх ёстой...” Жанг эгчийн нөхөрлөлийг сонссоны дараа надад гэнэтийн ухаарал төрөв: Эрт цаг үеэс хойш одоог хүртэл, үнэн зам үргэлж хавчигдаж ирсэн бөгөөд бид үнэхээр одоо явагдаж буй сүнслэг тулаан дунд байжээ! Хуучин урсгалын минь удирдагчид цуу яриа зохиож, Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг яллаж байлаа—мөн Төгс Хүчит Бурханд итгэхийг минь болиулахын тулд хяхан хавчиж, дарласан—тэд үнэнийг үзэн яддаг, Бурханы дайснууд байсан учраас тэр юм. Нөхөрлөсөн нь эдгээр зүйл яагаад надад тохиолдож байгааг ойлгоход тусалсан боловч би сул дорой, мөн Бурханы үгийн номыг хадгалахаас хэтэрхий их айсан хэвээрээ л байв. Хэрвээ би хадгалбал, аав болон бусад хүмүүс миний гэрт ирж, үймээн шуугиан тарина гэдгийг, мөн амьдралыг минь улам түвэгтэй болгоно гэдгийг би мэдэж байлаа. Намайг хадны завсар хавчуулагдсан халиуны зулзага шиг байхыг хараад, Жанг эгч надад утасны дугаар өгч: “Эгч ээ, ингэвэл ямар вэ— би Бурханы үгийн номыг гэр лүүгээ авч яваад, танд зориулан аюулгүй хадгалж байя. Та үүнээс жаахан уншмаар санагдах үедээ, зүгээр л над руу залга, би үүнийг тэр дор нь авчирья” гэлээ. Би зөвшөөрч, Жанг эгчийг гаргаж өгөв. Яг тэр агшинд нөхөр минь гүйж ирээд, Жанг эгч рүү заагаад: “Наад номоо аваад яг одоо яв. Тэгээд дахин битгий ирээрэй, ирэх юм бол би чамд сануулаад өгнө шүү!” гэж ориллоо. Би Жанг эгчийн холдон явахыг хараад, дүрслэхийн аргагүй байдлаар гуниглав.

Анхандаа би, Бурханы үгийн номыг Жанг эгчид буцаан өгвөл, аав намайг дарамтлахаа зогсоож, нэгэнтээ надад байсан тайван амьдрал минь сэргэнэ гэж бодсон юм. Үнэн хэрэгтээ, юмс эсрэгээр эргэж таарав: Би зүрх сэтгэлдээ амар амгаланг олоогүйгээс гадна, үнэн хэрэгтээ тайлбарлахын аргагүй хоосон байдлыг мэдэрч байлаа. Би юу ч хийсэн үхээнц байдалтай байсан бөгөөд Төгс Хүчит Бурханы үг болон Бурханы үгийн магтан дуу миний толгойд өдөр шөнөгүй цаг ямагт эргэлдсээр байв. Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс мөн бөгөөд Төгс Хүчит Бурханы илэрхийлсэн үг бол үнэн гэдгийг би мэдэж байлаа; гэхдээ чуулганы удирдагчийн надад хэлсэн зүйл болон аав болон бусад хүмүүс намайг дарамталж, дайрч байгаа дүр зураг санаанд орсоор байсан юм. Би ихэд зовон, авирч гарч чадахгүй ёроолгүй нүхэнд унасан мэт санагдаж байлаа. Бас сайн идэж, унтаж чадахгүй байсан ба тархи задрах гэж байгаа мэт сэтгэлээр унасан байлаа. Энэ бүх

---

өвчин дунд би Бурханд сөгдөн, ингэж гуйв: “Өө Бурхан минь, тэнгэр, газар, бүх амьд зүйлийг Бүтээгч минь, би маш их өвдөлт, будилаан дунд байна. Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс гэдгийг би мэддэг боловч биеийн хэмжээ минь жижигхэн, бас аавынхаа саад болон дайралтуудыг бодохоор би Бурхан Таныг дагахаас айж байна. Бурхан минь, би шийдвэр гаргах чадалгүй, салаа зам дээр гацчихлаа. Би юу хийхээ мэдэхгүй байна, иймд намайг залж чиглүүлж, хөглөөч...” Залбирлынхаа үеэр ямар нэгэн үл мэдэгдэх шалтгаанаар, би Төгс Хүчит Бурханы эдгээр үгийг гэнэт бодож эхлэв: **“Чи энэнээс ч нэг, тэрнээс ч нэг айх хэрэггүй; Хэчнээн олон бэрхшээл, аюултай тулгарч магадгүй ч гэсэн чи ямар ч сааданд түүртэлгүй Миний өмнө тууштай байх чадвартай байна, тэгж Миний хүсэл саадгүй хэрэгжиж болно... Бүү ай; Миний дэмжлэг байхад энэ замыг хэн хааж чадах билээ? Үүнийг сана! Бүү март!”** (“Үг нь махбодоор илэрсэн” номын Христийн эхэн үеийн айлдваруудын “10-р бүлэг”). Бурханы үг надад хулчгар зүрхээ хатуу болгох хангалттай хүч чадлыг гэнэт өгсөн юм. Тийм ээ! Бурхан миний бамбай байтал энэ газар дээр надад айх юу байх билээ? Нэгэнт би үүнийг үнэн зам гэж хэдийн шийдсэн учир аливаа хүн, үйл явдал, эд зүйлээр хязгаарлагдах ёсгүй. Би харанхуйн хүчийг сэт цохиж, гуйвшгүй шийдвэртэйгээр Бурханыг дагах хэрэгтэй. Бурханы жинхэнэ итгэгчийн хувьд, Сатаны дайсагнасан хүчтэй нүүр тулахдаа Бурханы оршин тогтнолыг зөвшөөрч чадахгүй бол би ямар итгэгч байх юм бэ? Би Сатанд бууж өгч, Бурханаас урваж байгаа юм биш үү? Тэгээд би, гэр бүл болон чуулганы удирдагчдын дарлал бол бүгд сүнслэг тулааны хэсэг бөгөөд хэрвээ тэдэнтэй цуг зогсохоор сонговол Сатаны зальжин урхинд унаж байгаа хэрэг гэж Жанг эгч нөхөрлөлийнхөө үеэр надад хэлснийг санав. Энэ нь аврагдаж, тэнгэрийн хаанчлал руу орох боломжоо би бүхэлд нь алдана гэсэн үг байлаа. Тэгээд би Жанг эгч Бурханы үгийн номыг буцаан авч явснаас хойш өөрийн туулсан сүнслэг зовлонгийн талаар бодсон бөгөөд амьдралдаа Бурхангүй байж чадахгүй юм байна гэдгээ болон Бурханыг орхих нь гэр бүл болон хуучин чуулгандаа хаягдахаас илүү шаналгаатай гэдгийг мэдрэв. Иймд би утсаа авч, Бурханы үгийн номыг буцаан авахын тулд Жанг эгч руу залгаж, уулзах газраа товллоо.

Үүний дараагаар, нөхрийгөө гэрт байхгүй байх болгонд би Бурханы үгийг уншиж, магтан дуу дуулан өлсгөлөнгөө дарах завшааныг ашигладаг байлаа. Үгийг унших тусам, илүү их таашаадаг байлаа; магтан дуу дуулах тусам, илүү их тайвширч, уужуу санагддаг байв. Миний анхны итгэл үнэмшил дахин сэргэж, бүх шаналал, бэрхшээл өглөөний манан шиг л алга болов. Бурханы үг бол миний амийн тэжээл бөгөөд Бурхангүйгээр байж чадахгүй мэт надад санагдав. Гурван сарын дараа Жанг эгч намайг цуглаанд оролцуулахаар Төгс Хүчит Бурханы Чуулган руу авч явлаа.

Миний нөхөр намайг цуглаанд оролцох гэж байгааг мэдээд, аавд минь хэлэх юм гэж

---

би санаагүй юм. Нэг орой, дээд давхарт байхдаа би хашаанд үлэмж үймээн болохыг гэнэт сонсов. Би хөшгөө нээн, аав минь чуулганы дөрөв, таван хамтран зүтгэгчийн хамт асуудал үүсгэхэд бэлэн мэт яаран ирж байгааг хараад хүйтэн хөлс асгарав. Миний зүрх дэлсэж эхэлсэн бөгөөд би хурдхан сөгдөж, Бурханыг дуудлаа: “Төгс Хүчит Бурхан минь, аав минь намайг ахиж дарамтлахаар өнөө чуулганы хүмүүсийг дагуулан ирлээ, би үнэхээр айж байна. Өө Бурхан минь, миний биеийн хэмжээ жижиг гэдгийг Та мэднэ, тиймээс итгэл үнэмшил болон зүрх зориг хайрлаач...” Тэгтэл Бурханы эдгээр үг гэнэт бодогдов: **“Чи дотроо Миний зоригийг тээж, итгэдэггүй төрөл төрөгсөдтэйгөө нүүр тулахдаа зарчимтай байх ёстой. Харин чи бас Миний төлөө ямар ч харанхуй хүчинд бууж өгөх ёсгүй. Төгс замаар алхахын тулд Миний мэргэн ухааныг түш; Сатаны хуйвалдаан биелэх боломж бүү олго. Миний дэргэд зүрх сэтгэлээ байлгахад бүх хүчин чармайлтаа гарга, Би чамайг тайтгаруулж, амар амгалан, баяр хөөр авчирна”** (“Үг нь махбодоор илэрсэн” номын Христийн эхэн үеийн айлдваруудын “10-р бүлэг”). Бурханы үг надад илүү их итгэл үнэмшил өгч, би цаашид хулчгар, аймхай байхаа болив. Би ингэж бодлоо: “Тэд намайг хэчнээн их дарамтлах нь хамаагүй, би ахин Сатаны урхинд унаж, тэдэнд хууртахгүй. Бурхан намайг бүтээсэн. Бурханд итгэлтэй байж, Бурханыг дагана гэдэг нь зөв, зүй зохистой бөгөөд хэн ч, миний хамгийн ойр дотнын хүмүүс ч, хөндлөнгөөс оролцох эрхгүй.” Эцэст нь, би доошоо бууж, аавыгаа болон түүний хамтран зүтгэгчдийг тайван байдлаар угтах боломжтой болов. Тэд намайг хармагцаа бүгд нэгэн зэрэг ярьж эхлэв. Нүүрэндээ “элэгсэгээр халамжилсан” харцтай нэг эмэгтэй хамтран зүтгэгч нь надад: “Фанфанг, чи үнэхээр ухаантай охин шүү дээ, бидэнд ямар санагдаж байгааг чи яагаад ойлгож чаддаггүй билээ. Бид зүрх сэтгэлдээ чиний сайн сайхны төлөө л байдаг шүү дээ. Битгий зөрүүдэл л дээ. Хурдан Эзэн рүү эргэн ирж, гэмш, за юу?” гэж хэллээ. Би хариуд нь маш тайвнаар: “Эгч минь, та нарын хэн нь ч Зүүний Аянгын номлолыг сонсоогүй, хэн нь ч Төгс Хүчит Бурханы үгийг уншаагүй. Төгс Хүчит Бурханыг сохроор яллаж, эсэргүүцэлгүй, үүнийг зүй зохистой судалж шинжлэхийг би та нараас хүсэж байна. Та нар Төгс Хүчит Бурханы үгийг уншихад л болно, тэгээд Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс мөн эсэхийг мэднэ” гэв. Эгч ингэж хариуллаа: “Тэр номын агуулга нь хэтэрхий сэтгэл булаам учир бид уншиж зүрхэлдэггүй. Үүнд автахад үнэхээр амархан.” Би: “Төгс Хүчит Бурханы илэрхийлдэг зүйл бол бүгд үнэн бөгөөд хүмүүсийг үнэмшүүлж чадах хүчтэй Бурханы дуу хоолой учраас энэ юм шүү дээ. Зөвхөн Бурханы үг л ийм төрлийн эрх мэдэл болон хүч чадалтай. Хүмүүс Бурханы үгэнд татагддагийн шалтгаан нь гэвэл тэдгээрийг уншсанаар хүмүүс үнэнийг ойлгож, амийн хоол тэжээлийг олж авч чаддаг. Хэн амийн амьд усны булгийг олсныхоо дараа орхих билээ?” гэж хэллээ. Тэд үүнд хариулаагүй бөгөөд Бурханыг доромжилсон баахан зүйл хэлж, “гэмшихгүй” бол тамд шүүгдэх болно хэмээн айлгахаар оролдов. Хатуу дуу

---

хоолойгоор би ингэж хэллээ: “Та нар ‘Зүүний Аянгад нэгдсэн хүмүүс хэзээ ч гардаггүй, эсвэл хэрвээ орговол тэд хамраа огтлуулж, нүдээ ухуулдаг...’ хэмээн хэлж Төгс Хүчит Бурханы Чуулганыг гүтгэсэн. Үүнд ямар ч бодитой нотолгоо байхгүй, энэ бол бүгд цуу яриа, хорлонтой гүтгэлэг! Та нар надад хамраа огтлуулж, нүдээ ухуулсан нэг хүн олоод ир. Хэрвээ бодитой нотолгоо гаргаж чадахгүй бол та нар бүгд хүмүүсийг хуурах гэсэн хэдэн худалч л болно. Төгс Хүчит Бурханы хаанчлалын сайн мэдээ хэдийнээ Хятад даяар газар сайгүй тархсан ба айл гэр болгон сайн мэдээг сонссон. Одоо Төгс Хүчит Бурханы Чуулганд дор хаяж хэдэн сая гишүүн бий. Мэдээжийн хэрэг, сайн мэдээг дамжуулах үед үнэнийг үзэн яддаг, үүнийг хүлээн зөвшөөрдөггүй хүмүүс үргэлж байдаг. Харин та нар хамраа огтлуулж, нүдээ ухуулсан ганц хүн харсан уу? Хэрвээ нэг ч гэсэн хүн байсан бол хэвлэл мэдээлэл хэдийнээ үүнийг мэдээлж, улс үндэстэн даяар дуулиан болох байсан. Та нар дүү бид хоёрыг зориудаар их дарамталсан учир бид итгэлээ орхисон. Гэхдээ бид хоёр зүгээр л харагдаж байна, тийм биш гэж үү? Та нар хүмүүсийг хуурахын тулд худал үг хэлж байна. Одоо би Төгс Хүчит Бурханд итгэдэг, би үнэн замыг сонгож, Бурханы хөлийн мөрийг дагаж байна. Надад буруу хийсэн зүйл байхгүй учир гэмших зүйл ч байхгүй. Төгс Хүчит Бурханд итгэх миний итгэл хэзээ ч гуйвахгүй, хэрвээ та нар итгэхгүй бол зүгээр ээ, харин ядаж намайг итгэхэд бүү саад бол. Надад юу тохиолдох тухайд, хүмүүс юу хэлэх нь хамаагүй, учир нь хүн бүрийн хувь заяа Бурханы гарт бий. Бурханы ажилтай хөл нийлүүлж, Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн зөвшөөрснөөр л хүмүүс сайхан эцсийн хүрэх газартай байх болно. Иймд дахиж ирж, надад бүү саад хий.” Миний амнаас үг гараад удаа ч үгүй байхад, аав минь хурдан, огцом босож, түрэмгий дуу хоолойгоор: “Хэрвээ чи Төгс Хүчит Бурхандаа итгэсэн хэвээр байвал, би чамайг цаашид охиноо гэж үзэхгүй!” гэж сүрдүүллээ.

Харилцаагаа дуусгана гэсэн аавын заналхийллийг сонсоод би өөрийн эрхгүй бага зэрэг гуниглав. Би ингэж бодлоо: “Төгс Хүчит Бурханы үнэний илэрхийлэл бол үнэндээ чуулгануудад хандан Сүнсний хэлдэг зүйл юм. Гэхдээ та сонсдоггүй, харин оронд нь чуулганы удирдагчдын тараадаг цуу яриа, худал хуурмагийг сонсдог. Намайг Төгс Хүчит Бурханд итгэсний төлөө үзэн ядаж, надтай харилцаагаа хүртэл дуусгавар болгохыг хүсэхдээ та яаж тэдэнтэй адилхан байдаг байна аа?” Би энэ талаар бодох тусам, улам гуниглаж, Бурханы үгийн хэсгээс гэнэт бодов: **“Бурхан энэ дэлхийг бүтээж, Өөрийн амь хайрласан амьд бодгаль болох хүнийг дэлхийд авчирсан. Дараа нь хүн эцэг эх, төрөл төрөгсөдтэй болж, ганцаар байхаа больсон юм. Хүн энэхүү материаллаг ертөнцийг анх харснаасаа хойш Бурханы тогтоосноор оршин байх заяатай байв. Бурханаас гарсан амийн амьсгал л амьд бодгаль болгоныг өсөж, нас бие гүйцэх хүртэлх нь дэмждэг билээ. Энэ явцад, хүн Бурханы халамж дор өсөж байна гэдгийг хэн ч**

---

мэдэрдэггүй, харин эцэг эхийнхээ хайр халамж дор өсөж байгаа ба хүний амийн зөн мэдрэмж өсөх үйл явцыг нь чиглүүлдэг хэмээн итгэдэг. Учир нь өөрийнх нь амийг хэн хайрлаж, амь нь хаанаас ирснийг хүн мэддэггүй бөгөөд амийн зөн мэдрэмж хэрхэн гайхамшгийг бүтээдгийг бүр ч мэддэггүй” (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурхан бол хүний амийн эх сурвалж”). Хэдийгээр миний махан бие эцэг эхээс минь гарсан боловч, миний амийн эх үүсвэр нь Бурхан гэдгийг ойлгоход Бурханы үг надад тусаллаа. Бурханы амийн бэлэггүйгээр, миний бие ялзрах байсан бөгөөд өнөөдөр амьд байгаа минь бүгд Бурханы халамж, хамгаалалтын ач бөгөөд тэгээгүй байсан бол Сатан намайг залгих байсан. Миний эцэг, эх биш, харин Бурхан л миний амийн эх үүсвэр ба Бурханаас өөр хэнтэй ч би харилцаагаа тасалж болно. Миний эцэг эх Эзэний эргэн ирэлтийг эрж хайж, судлах сонирхолгүй байгаад зогсохгүй, тэд Бурханы ажлыг гүтгэж, доромжилж, намайг Бурханаас урвуулахаар хүчээр оролдож байгаа чуулганы удирдагчдын ард 100% зогсож байна. Энэ нь, мөн чанартаа тэд Бурханыг эсэргүүцдэг, Бурханы дайснууд гэдгийг баталдаг, харин би тэдэнд автаж, Бурханыг эсэргүүцэхгүй. Би Бурханы дэргэд зогсож, эцэг эх минь харилцаагаа тасалсан ч эцсээ хүртэл Бурханыг дагах болно. Би бат зогсож, Бурханд гэрчлэл хийх болно. Иймд, би аавдаа хэлэв: “Аав аа, Бурханд итгэх итгэлийн тухайд, би хүмүүсийг биш, Бурханыг дуулгавартай дагах бөгөөд би сэтгэл хөдлөлд ч захирагдахгүй. Хэрвээ таны хэлсэн үнэн болон Бурханы санаа зорилготой нийцсэн бол би таныг сонсох байсан. Харин та намайг Бурханаас урва гэж хэлбэл, би хэзээ ч үүнийг хийхгүй!” Миний шийдвэртэй хандлагыг хараад бүгд толгой сэгсэрч, босоод, урам хугаран явав. Тэр үед надад ялалт байгуулсан мэт санагдаж, Бурханд өөрийн эрхгүй залбирч, чимээгүй талархлаа: “Төгс Хүчит Бурхан минь, Та бол үнэхээр төгс хүчит юм. Таны үг надад итгэл үнэмшил, эр зориг өгч, Сатанд энэхүү шившигтэй ялагдлыг авчирлаа.”

Хэдийгээр шашны нийгэмлэгийн хүмүүс надад түвэг удахаар дахин ирээгүй ч, чуулганы удирдагчид намайг дарлахаар манайхныг өдөөсөөр байлаа. Хэдэн өдөр болоод л тэд гэрт минь ирж намайг бодол санаагаа өөрчлөхийг шахаж, удирдагчийн гэрт очиж, “гэмшихийг” үргэлж шаарддаг байв. Нэг өдөр, манай гэрийнхэн ирж, аав минь намайг хуурахаар Библийн хэсгийг ашиглаж байх зуур ээж минь нэг талд зогсон, удирдагчийн гэрлүү явж, “гэмшихийг” нулимс дуслуулан гуйх болов. Ээжийгээ маш их гунигтай байхыг хараад үнэхээр сэтгэл гонсойв. Би түүний 3 настай байхдаа ээжийгээ алдаж, хойд ээждээ хүчирхийлүүлдэг байсныг нь бодов. Ээж минь амьдралдаа их зовсон бөгөөд одоо жил жилээр сайжирч байв, харин би үнэхээр охины ёсоор ачилж чадаагүй, ялангуяа одоо энэ маягаар би түүний санааг ихээхэн зовоож байлаа. Дараа нь би аавынхаа цагаан царай, буурал үсийг нь харсан бөгөөд энэ нь нулимсаа барьж чадахааргүй болтол минь бүр ч

---

гуниглуулав. Яг хамгийн эмзэг үедээ байхдаа би Бурханы үгийн хэсгээс бодлоо: “Хүмүүс дээр Бурханы хийдэг ажлын алхам бүрд, гаднаа энэ нь хүмүүсийн хоорондын харилцаа мэт, хүний зохицуулалт, хүний хөндлөнгийн оролцооноос үүдэлтэй мэт харагддаг. Гэвч нүднээс далдуур, ажлын алхам бүр, тохиолдож буй юм бүхэн нь Бурханы өмнө Сатаны тавьсан бооцоо бөгөөд Бурханд гэрчлэл хийхдээ бат зогсохыг хүмүүсээс шаарддаг. Жишээ нь, Иовыг шалгасан үеийг авч үзье: Нүднээс далдуур Сатан Бурхантай мөрий тавьж байсан бөгөөд Иовд тохиолдсон зүйл нь хүмүүсийн үйл хэрэг, хүмүүсийн хөндлөнгийн оролцоо байсан. Та нарт хийдэг Бурханы ажлын алхам бүрийн ард Сатаны Бурхантай тавьсан мөрий байдаг—энэ бүгдийн ард тэмцэл байдаг” (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурханыг хайрлах нь л үнэхээр Бурханд итгэж буй хэрэг”). Өнгөн дээрээ эцэг эх минь намайг дарлаж байгаа мэт харагдаж байгаа ч, сүнсний ертөнцөд бол Сатан Бурхантай мөрий тавьж байсныг ойлгоход Бурханы үг надад туслав. Бурхан Иовыг туршиж байх үед Сатаны зарц болж үйлчилсэн эхнэр нь түүнд: “Чи одоо ч гэсэн үнэнч шударга байдлаа хадгалж байна уу? Бурханыг хараа, тэгээд үх” (Иов 2:9) гэж хэлсэнтэй адилхан байв. Гэвч Иов Бурханаас айж, хүндэлж, муугаас зайлсан, иймээс эхнэрээ зэмлэн, түүнийг мэдлэггүй, зөрүүд эмэгтэй хэмээн дуудсан бөгөөд өөрийнхөө хэлсэн юугаар ч нүгэл үйлдээгүй билээ. Тэр Сатаны өмнө Бурханд гэрчлэл хийсэн ба Ехова Бурханы нүдэнд тэрээр бүрэн төгс хүн байлаа. Одоо харин би пастор болон ахлагч нарын хэлж байгаа бүх тэнэг утгагүй зүйлд итгэсэн эцэг эхдээ дарлуулж байна. Энэ бол Сатаны сорилтуудын нэг байлаа, учир нь намайг тэдэнд ихээхэн санаа тавьдгийг Сатан мэдсэн ба оролцох боломжийг ашиглаж байсан юм. Надаар Бурханыг үгүйсгүүлж, урвуулахын тулд Сатан эцэг эхээ гэсэн сэтгэлийг минь ашиглахыг оролдсон, энэ нь Сатан хэчнээн өөдгүй, зальжин болохыг харуулдаг! Гэхдээ би явуулга нь үр дүнгээ өгөхийн сэтгэл ханамжийг Сатанд өгөх гээгүй байлаа. Би Бурханы урмыг хугалж, гуниглуулах гээгүй учраас Бурханы дэргэд зогсохоор шийдсэн. Үүнийг дараа миний эцэг эх юу ч хэлж, яаж ч намайг шахсан бай, миний зүрх сэтгэл өчүүхэн ч хөдлөөгүй юм. Миний сэтгэл огтхон ч хөдлөөгүйг хараад эцэг эх минь ихэд урам хугарсан байдалтай явав.

Хожим нэг өдөр, чуулганы удирдагч аавыг минь чуулганы бүх гишүүдийн өмнө зогсоож, намайг чуулганаас хөөгдсөнийг зарлуулав. Удирдагч мөн эцэг эхийг минь ч надаас холдуулав. Чуулганы удирдагч, манай гэрийнхний дарлалын улмаас, нөхөр минь намайг улайран хавчиж эхлэв. Үүргээ биелүүлж байгаад гэртээ харих болгонд тэр намайг цохиж, эсвэл над руу харааж зүхэн хашхичиж, заримдаа бүр намайг оруулалгүй, хаалгаа түгждэг байлаа. Тэр миний цахилгаан скүтер, эсвэл унадаг дугуйг эвдэлж, нэг удаа намайг бүр цагдаагийн газарт хүргэв. Намайг бие, сэтгэлийн ядаргаанд ортол хэрцгийлсэн бөгөөд



---

манай тосгоны хөршүүд ч бас намайг дооглож, гүжирдэж эхлэв. Энэ нөхцөл байдалтай нүүр тулаад, Бурханд итгэх нь үнэхээр тэвчишгүй гэдгийг миний сэтгэл зүйн дорой байдал надад мэдрүүлж эхлэв. Би яаж урагшлахаа мэдэхгүй байсан ба үргэлж Бурханы өмнө сөгдөж, залбирч, уйлж, надад итгэл үнэмшил, хүч хайрлахыг Бурханаас гуйж байлаа. Дараа нь нэг удаа би Бурханы эдгээр үгийг уншив: **“‘Ялагч’ гэж Бурханы нэрлэдэг хүмүүс нь Сатаны нөлөөн дор, Сатаны бүслэлтэд байхдаа, өөрөөр хэлбэл, харанхуйн хүчний дунд байх үедээ гэрчлэлд зогсож, итгэлээ хадгалж, Бурханд үнэнч байдлаа хадгалж чадсаар байдаг хүмүүс юм. Юу ч болж байсан, чи Бурханы өмнө цэвэр ариун зүрх сэтгэлээ хадгалж, Бурханыг хайрлах жинхэнэ хайраа хадгалж чадсаар байдаг бол Бурханы өмнө гэрчлэлд зогсож байгаа бөгөөд үүнийг Бурхан ‘ялагч’ байх гэж нэрлэдэг. Бурхан чамайг ерөөх үед эрэл хайгуул чинь гойд сайн байдаг боловч Түүний ерөөл байхгүй үед ухарч няцдаг бол энэ нь цэвэр ариун байдал мөн үү? Энэ зам нь үнэн гэдэгт итгэлтэй байгаа л бол чи эцсийг нь хүртэл дагах ёстой; чи Бурханд үнэнч байдлаа хадгалах ёстой. Чамайг төгс болгохын тулд Бурхан Өөрөө газар дээр ирсэн гэдгийг харсан болохоор чи зүрх сэтгэлээ Түүнд бүхлээр нь өгөх ёстой. Тэр юу хийдэг нь хамаагүй, бүр эцэст нь чамд тааламжгүй үр дүн товлосон ч гэсэн чи Түүнийг дагасаар байж чаддаг”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Чи Бурханд өгсөн үнэнч байдлаа хадгалах ёстой”). Эцсийн өдрүүдэд, Бурхан бүлэг ялагчдыг бий болгох бөгөөд хүмүүсийг сорихыг Сатанд зөвшөөрөх болно гэдгийг би Бурханы үгээс ойлгов. ХКН-ын дарангуйлал, шашны нийгэмлэгүүдийн дарлал, хамаатан садандаа хаягдах явдал, эсвэл олон нийтийн доог тохуу болон доромжлол байх нь хамаагүй, итгэгч бид нар эдгээр шалгалтыг бодитойгоор туулах ёстой, учир нь дуулгавартай дагаж, үнэнч байж, ямар ч нөхцөл байдалд Бурханд гэрчлэл хийж чаддаг итгэгчид л Бурханаар бүрэн төгс болгуулсан ялагчид юм. Намайг төгс болгож, үнэхээр Түүнд итгэж, найдаж, дуулгавартай болоод үнэнч байж чадах эсэхийг минь харах үүднээс Бурхан эдгээр нөхцөл байдлыг зохицуулсан. Бурханы санаа зорилгыг ойлгосны дараа би Бурханы өмнө очиж, энэ амлалтыг өгөв: Би ямар ч бэрхшээл, дарангуйлалтай нүүр тулах нь хамаагүй, Бурханыг сэтгэл хангалуун байлгах үүднээс би Бурханыг үргэлж шийдвэртэйгээр дагаж, Бурханы бүтээлийн нэг болохын хувьд үргэлж өөрийнхөө үүргийг биелүүлж, Сатаны өмнө Бурханд ялгуусан гэрчлэл хийх болно. Үүний дараа, хэдийгээр нөхөр минь намайг үргэлжлүүлэн дарлаж, саад болохоор улангассан хэвээрээ байсан ч, би Бурханд байнга залбирч, Бурханыг хүндэлж, өдөр бүр Бурханы үгээр зэвсэглэж байв, ийм ч учраас надад зовж байгаа юм шиг санагдаагүй юм. Бурхан ч мөн надад зам нээж өгөв: Миний нөхөр улангасаж, намайг дээрэлхсэнийхээ хариуд Бурханаар хэд хэдэн удаа шийтгүүлсэн ба үүний дараа тэр намайг цохиж, унадаг дугуйг минь дахин эвдэж зүрхэлсэнгүй. Үүнийг туулснаар би Бурханы төгс хүчит байдал, дээд эрх болон Түүний гайхамшигтай үйл

---

хэргийг харав. Бурханы эрх мэдэл болон чадварыг давж чадах ямар ч харанхуйн хүч байхгүйг харсан бөгөөд бид ердөө Бурханд бүрэн найдаж, Бурханы үгийг ашиглан бэрхшээлүүдтэй нүүр тулах хэрэгтэй, тэгвэл Бурхан бидэнд урагшлах зам нээж өгч, Сатаны харанхуйн нөлөөллийг давж гарахад биднийг хөтлөх болно гэдгийг би өөрийн биеэр туулав. Бүхий л хавчлага, зовлонг туулсны дараа, хэдийгээр махан бие минь жаахан зовсон ч гэлээ, би маш ихийг олсон мэт санагдсан юм. Бурханд итгэх миний итгэл үнэмшил улам бүр их болсон нь Бурханы надад өгсөн ерөөл билээ. Төгс Хүчит Бурхан, Тандаа баярлалаа!

Жилийн дараа би Жанг эгчийн хамт хамгийн бага охин дүүгийнхээ ажил дээр очиж, Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг түүнд гэрчлэв. Охин дүү минь үүнийг хүлээж авсан бөгөөд түүнийг Бурханы үгийн номыг авах үед, хүн Бурханаар аврагдахад хэчнээн хэцүү болохыг би гүнзгий ойлгов. Хүмүүсийг аврах тухайд Бурхан тун их бодитой юм. Би хацар даган урсах талархлын нулимсаа барьж чадахгүй байсан ба Бурханыг гэсэн талархал, магтсаалаар зүрх сэтгэл минь хөөрлөө! 2006 онд миний хамгийн бага охин дүү, надтай нийлэн, өөр нэг эгчийгээ хаанчлалын сайн мэдээнд итгүүлсэн бөгөөд үүний дараа өөр хэд хэдэн хамаатнаа ч бас Төгс Хүчит Бурханы өмнө авчирч чадав. Үүгээр дамжуулан, худал хуурмагийг зохиож, жинхэнэ итгэгчдэд саад болж, дарлахаар шашны удирдагчид хэчнээн их улайрахаас үл хамааран Бурханы хаанчлалын сайн мэдээ түгэх бөгөөд хэн ч үүнийг зогсоож чадахгүй гэдгийг би харж чадсан юм. Бурханы хурга үргэлж Бурханы дуу хоолойг сонсож, Бурханы сэнтийн өмнө эргэн ирэх болно. Төгс Хүчит Бурханы хэлдэгчлэн: **“Хаанчлал хүмүүсийн дунд өргөжиж, хүмүүсийн дунд бүрэлдэж, хүмүүсийн дунд өндийн босож байна; Миний хаанчлалыг устгаж чадах ямар ч хүч байхгүй”** (“Үг нь махбодоор илэрсэн” номын Бүх орчлон ертөнцөд хандсан Бурханы айлдваруудын “19-р бүлэг”).

### **33. Золгүй явдлаар ерөөл хүртсэн нь**

Дүжуан, Япон

Төгс Хүчит Бурхан ингэж хэлсэн байдаг: **“Хүн туулж өнгөрүүлсэн замаа эргэн харж, амьдралын замналын үе шат бүрээ дурсан санахдаа, замнал нь энхэл донхолтой, эсвэл толигор аль нь ч бай, Бурхан алхам бүрд замыг нь залж чиглүүлж, төлөвлөж өгч байсныг ойлгодог. Өнөөдрийг хүртэл хүнийг мэдэгдэлгүйгээр хөтөлж байсан зүйл нь Бурханы нямбай зохицуулалт, Түүний хичээнгүй төлөвлөлт байжээ. Бүтээгчийн дээд эрхийг хүлээн зөвшөөрч, Түүний авралыг хүртэх чадвартай байна**

---

гэдэг хэчнээн агуу завшаан бэ!... Хүнд Бурхан байхгүй, Түүнийг харж чадахгүй, Бурханы дээд эрхийг тодорхой танин мэдэж чадахгүй үед өдөр бүр нь утга учиргүй, үнэ цэнгүй, хөөрхийлөлтэй байдаг. Хүн хаана ч байсан, ажил нь ямар ч байсан, амьдрах арга зам болон зорилгоор хөөцөлдөх нь эргэн дурсаж ч чадамгүй эцэс төгсгөлгүй их уй гашуу, хөнгөвчлөхийн аргагүй зовлон шаналлаас өөр юуг ч авчрахгүй. Бүтээгчийн дээд эрхийг хүлээн зөвшөөрч, Түүний зохион байгуулалт, зохицуулалтад захирагдаж, жинхэнэ хүмүүний амьдралыг эрж хайсан цагт л хүн бүх уй гашуу, зовлон шаналлаас аажмаар ангижирч, амьдралын бүхий л утгагүй хоосон байдлаас салж эхэлнэ” (Үг нь махбодоор илэрсэн номын “Цор ганц Бурхан Өөрөө III”). Бурханы энэ үг миний амьдралыг үнэн зөв дүрсэлсэн болохоор сэтгэлийг минь үнэхээр их хөдөлгөдөг.

Хөдөөгийн ядуу гэр бүлд төрсөн намайг хүмүүс насан туршид минь дорд үзэж ирсэн юм. Манай гэр бүл ядуу байсан болохоор би заримдаа дараачийн хоол хэзээ байхыг мэддэггүй, бас дандаа эгчийнхээ хуучин хувцсыг өмсдөг, тэр хувцаснууд надад томддог байсан. Ангийнхан минь бүгд надаар доог тохуу хийж, найзлахыг хүсдэггүй, хүүхэд нас минь үнэхээр зовлонтой байсан юм. Том болоод заавал маш их мөнгө олж, сайхан амьдарна, дахиж хэнд ч дорд үзэгдэхгүй гэж тэр үеэс эхлэн сэтгэл шулуудлаа. Гэр бүл минь ямар ч мөнгөгүй байсан болохоор дунд сургуулиа дүүргэхээсээ өмнө сургуулиа хаяж, хошууны эмийн үйлдвэрт ажиллахаар явсан. Арай их мөнгө олохын тулд шөнийн 10 цаг хүртэл илүү цагаар ажиллах нь олон байлаа. Манай эгч тав хоног ногоо зараад миний нэг сарын цалинг олж чаддаг гэж дараа нь сонссон. Тэгээд ногоо зарахаар эмийн үйлдвэр дэх ажлаасаа шууд гарлаа. Гэрлэсний дараа нөхөр бид хоёр зоогийн газар нээсэн юм. Зоогийн газар ажиллуулаад илүү их мөнгө олно, дараа нь бусдын атаархал, хүндлэлийг хүлээн сүрлэг, нэр төртэй амьдралаар амьдарч болно гэж бодсон. Гэхдээ тэр салбар ширүүн өрсөлдөөнтэй болохоор бид мөнгө хэмнэхийн тулд ганц л үйлчлэгч хөлсөллөө. Би гал тогоо, хооллох танхимын хооронд гүйн, бүгдийг амжуулж, заримдаа хөл дээрээ ч тогтохооргүй болтлоо дэндүү их ядардаг байлаа. Төрийн зарим албан тушаалтан ирээд тооцоогоо хэзээ ч хийдэггүй байсан, бас элдэв янзын торгууль, татвар төлөх болдог байлаа. Заримдаа тэд биднийг торгохын тулд ямар ч хамаагүй шалтаг ашиглаж, өдрийн орлогыг минь аваад явчихдаг байсан. Үүнд үнэхээр уур хүрдэг байсан ч Хятадад үүнийг яах ч аргагүй. Зүгээр л асуудлаас холуур байх ёстой байдаг юм. Бид шаргуу ажиллаад ч нэг их мөнгө олдоггүй байлаа. Би нэг хэсэг бизнес хийснийхээ дараа, “Хэзээ маш их мөнгөтэй сайхан амьдралаар амьдрах бол?” гэж санаа зовж эхэлсэн.

2008 онд нэг найз маань, Хятадад арван өдөр ажиллаад авах мөнгийг Японд нэг өдрийн ажлаар олж болдог гэж надад хэллээ. Үүнийг сонсоод би бөөн баяр болж, бага

---

зэрэг мөнгө олох сайхан боломж эцэст нь олдлоо гэж бодсон юм. Япон явах зуучлалын төлбөр өндөр байсан ч “Зовсны эцэст жаргана. Японд ажилд орж л байгаа цагт тэр мөнгөө үнэхээр хурдан эргүүлээд олчихно” гэж бодлоо. Тэр мөрөөдлөө хөөхөөр нөхөр бид хоёр шууд Япон явахаар шийдсэн. Тэнд очоод өдөр бүр 13-14 цаг ажиллах ёстой боллоо. Тэгээд үхтлээ ядарсан. Ажлын дараа зүгээр л хэвтэж амрахыг хүсдэг, хоол идмээргүй байдаг байсан. Би нурууны доод хэсгээр цаг үргэлж өвдөөд, эмчид үзүүлэх мөнгөгүй болохоор зүгээр л өвчин намдаагч уун аргалдаг байлаа. Өвдөөд зогсохгүй даргадаа загнуулж, ажлынхандаа дээрэлхүүлж байсан юм. Ажилд ороод удаагүй байхдаа нэг удаа ялихгүй алдаа гаргаж, даргадаа үнэхээр их дайрч давшлуулаад, гутарсандаа уйлж билээ. Гэхдээ өөр яалтай билээ? Үргэлжлүүлэн мөнгө олохын тулд зүгээр л сэтгэлээ хатамжлах ёстой байсан юм. “Одоо хэцүү байгаа ч, жаахан мөнгө олчихвол нүүр бардам болж, хүмүүсийг эгцлэн харж чадна. Тэвчих л хэрэгтэй” гэж өөртөө ахин дахин хэлсэн. Тэгээд өдөр болгон мөнгөний машин мэт ажиллан, гүрийсээр л байлаа. 2015 онд би гэнэтхэн хүнд ажилдаа туйлдаад өвчин туссан юм. Тэгээд эмнэлэгт очиж үзүүлтэл эмч, нурууны диск мултран, мэдрэлийг дарж байна гээд, цаашид ажиллаад байх юм бол хэвтэрт орж, хүний асаргаанд орно гэлээ. Тэгэхэд үүлгүй тэнгэрээс аянга ниргэх шиг л болж, шууд л хамаг бие сулбайсан. Амьдрал минь дөнгөж өнгөлөг харагдаж, мөрөөдөл минь биелэх дөхөж байсан. Гэтэл оронд нь би гэмтээд дууссан юм. Үүнийг хүлээн зөвшөөрч чадалгүй, “Би одоо ч залуу байна. Зүгээр л шүд зуух юм бол үүнийг даваад гарч чадна. Одоо мөнгө олж чадалгүй Хятад руу гар хоосон буцвал ичгүүртэй биш үү?” гэж бодсон. Тийм болохоор шүд зуугаад, өвчтэй биеэ чирэн ажилдаа явсаар л байлаа. Өвдөлт ихсэх үед зүгээр л эмтэй наалт наачхаад зүтгэсээр байсан. Бүтэн өдөржин ажиллаад, шөнө нь маш их өвдсөндөө унтаж чаддаггүй, бараг эргэж хөрвөөж ч чаддаггүй байлаа. Хэдхэн хоногийн дараа бие маш их муудаж, бүр орноосоо мөлхөөд босож ч чадахгүй болсон.

Маш цөхөрч, ганцаардан орондоо хэвтэж байхдаа би, “Цэл залуу насандаа яаж яваад ийм болчхов оо? Эцэстээ би үнэхээр хэвтэрт орно гэж үү?” гэж гайхсан. Тэгээд үгээр илэрхийлшгүй гаслан мэдэрч, “Эцсийн эцэст хүн юун төлөө амьдардаг юм бэ? Үнэндээ зүгээр л мөнгө олж, онцгойрохын төлөө гэж үү? Мөнгө үнэхээр аз жаргал гэсэн үг үү? Мөнгөний төлөө үхэн хатан зүтгэх үнэхээр үнэ цэнтэй гэж үү?” гэж гайхлаа. Би гуч орчим жилийн турш цуцталаа хөдөлмөрлөхдөө үйлдвэрт ажиллаж, ногоо зарж, зоогийн газар ажиллуулж, бас Японд ажиллахаар ирлээ. Энэ хооронд бага зэрэг мөнгө олсон ч маш их шаналсан юм. Эхэндээ би Японд ирээд мөрөөдлөө биелүүлж, дорхноо баяжиж, атаархмаар амьдралаар амьдарна гэж бодсон. Гэвч оронд нь хэвтэрт орж, бүр үлдсэн амьдралаа тэргэнцэртэй өнгөрөөж ч магадгүй болсон. Тэгж бодохоор, мөнгө олж, бусдын дээр гарахын төлөө эцэж туйлдсандаа бүр их харамслаа. Би гомдож, шаналж, гуниглаж байсан.

---

Тэгээд өөрийн эрхгүй уйлсан юм. “Тэнгэр минь, намайг авраач! Яагаад миний амьдрал ийм ядаргаатай, ийм хэцүү юм бэ?” гэж зүрх сэтгэлдээ орь дуу тавилаа.

Яг тэгж арга мухардан, шаналж байх үед эцсийн өдрүүдийн Бурханы аврал над дээр ирсэн юм. Би Бурханд итгэдэг хоёр эгчтэй санаандгүй уулзсан. Бүх зүйлийг Бурхан бүтээсэн, орчлонг бүхэлд нь Бурхан захирдаг, хүн болгоны хувь заяа Бурханы гарт байдаг, Бурхан цаг ямагт хүн төрөлхтнийг замчилж, тэтгэж ирсэн, бас үргэлж хүн төрөлхтнийг харж хандаж, хамгаалдаг гэдгийг эгч нартай хамт Бурханы үг уншиж, үнэний тухай нөхөрлөлийг нь сонсоод ойлголоо. Гэхдээ би нэг юман дээр будилсаар байсан юм. Бидний хувь заяаг Бурхан хянадаг, бас Бурхан биднийг цаг үргэлж удирдаж, хамгаалж ирсэн, тэгэхээр бид аз жаргалтай байх учиртай. Гэтэл бид яагаад өвчин, шаналал туулсаар байгаа юм бэ? Амьдрал яагаад ийм хэцүү юм бэ? Энэ бүх шаналал үнэндээ хаанаас ирдэг юм бэ?

Энэ тухай эгч нараас асуутал Чинь эгч Төгс Хүчит Бурханы үгээс заримыг нь надад уншиж өглөө: **“Төрөлт, үхэл, өвчин, өтөл наснаас эхлээд хүмүүсийн туулдаг насан туршийн зовлонгийн эх сурвалж юу вэ? Юунаас болоод хүмүүст эдгээр зүйл байх болсон бэ? Анх бүтээгдэхэд нь хүмүүст ийм зүйлс байгаагүй, тийм биз дээ? Тэгвэл эдгээр зүйл хаанаас бий болсон бэ? Хүмүүс Сатанд уруу татагдаж, махан бие нь доройтсоны дараа бий болсон юм. Хүний махан биеийн өвдөлт, зовлон шаналал, хоосон байдал, мөн түүнчлэн хүний ертөнцийн туйлын золгүй хэрэг явдал нь Сатан хүн төрөлхтнийг завхруулсны дараа л бий болжээ. Сатан хүмүүсийг завхруулсныхаа дараа тарчилгаж эхэлсэн юм. Үүний үрээр хүмүүс улам бүр доройтлоо. Хүмүүсийн өвчин эмгэг улам бүр хүндэрч, зовлон нь улам хэцүү бэрх болжээ. Хүмүүс хүний ертөнцийн хоосон байдал, эмгэнэлт явдал, түүнчлэн тэнд үргэлжлүүлэн амьдрах аргагүй байдлаа улам их мэдэрч, дэлхий ертөнцөд улам бага найдах болов. Тийнхүү энэ зовлонг Сатан хүмүүст авчирсан билээ”** (Христийн ярианы тэмдэглэл номын “Бурхан дэлхий ертөнцийн зовлонг амсахын ач холбогдол”). Дараа нь эгч ингэж нөхөрлөсөн: “Бурхан хүнийг бүтээх үед хүн Бурханыг сонсож, захирагддаг байсан. Бурхан тэдэнтэй хамт байж, тэднийг асарч, хамгаалдаг байсан юм. Төрөлт, өтлөлт, өвчин, үхэл гэж байгаагүй, бас зовнил, бухимдал байгаагүй. Хүн Еден цэцэрлэгт эрх дураараа амьдарч, Бурханы хайрласан, эдэлж болох бүх зүйлийг эдэлж, Бурханы удирдамж дор аз жаргалтай, баяр хөөртэй амьдарсан. Гэхдээ дараа нь хүнийг Сатан хуурч, завхруулсан. Тэд Сатаны худал хуурмагт итгэж, нүгэл үйлдэж, Бурханаас урвасан болохоор Бурханы халамж, хамгаалалтыг алдсан. Тэр цагаас хойш бид Сатаны эзэмшилд амьдарч, харанхуйд унасан юм. Нөр их хөдөлмөр, зовнил, шаналал, гунигтай амьдралаар бид амьдардаг. Олон мянган жилийн турш Сатан хүмүүсийг төөрөлдүүлж, хорлохын тулд материализм, бурхангүй үзэл, хувьсал гэх зэрэг тэрс үзэл, төөрөгдөл, бас ‘Хорвоо ертөнцөд Бурхан гэж үгүй’, ‘Эзэн

---

хичээвэл заяа хичээнэ’, ‘Хүн бүр өөрийгөө боддог, би үхэхээр чи үх’, ‘Өөрөө онцгойрч, өвөг дээдэстээ алдар нэр авчрах’, ‘Баяжихын тулд хүн юу ч хийнэ’, ‘Амьдрал мөнгөн дээр тогтдог’ гэх мэт алдартнууд болон агуу хүмүүсийн түгээсэн онч үгийг тууштай ашиглаж ирсэн. Эдгээр сатанлаг төөрөгдлийг хүлээн зөвшөөрснийхөө дараа хүмүүс Бурханы оршин тогтнол, захиралтыг үгүйсгэж, Бурханаас зайгаа барьж, урвасан. Хүний зан чанар улам биеэ тоосон, ихэрхүү, илүү аминчхан, зальхай, хорлонтой болсон. Алдар нэр, байр суурь, эд баялгийн төлөө хүмүүс явуулга хийж, тэмцэлдэж, нэгнээ хөнөөдөг. Эхнэр нөхөр, найз нөхөд бие биеэ хуурч, урваж, эцэг хүү хүртэл бие биеийнхээ эсрэг болж, ахан дүүс нэг нэгнээ дайрч давшилдаг. Бид хэвийн хүн чанараа бүрэн алдаж, хүн гэхээсээ илүү адгуус шиг амьдардаг болсон. Сатаны төөрөгдөл маш олон хүнийг хорлосон. Тэд хянаж, өөрчилж чадна гэж бодон, хувь заяаныхаа эсрэг тэмцдэг. Насан туршдаа тэмцээд ч хувь заяагаа өөрчилж чаддаггүйгээс гадна, тэгж оролдож яваад өөрсдөө сүйрдэг. Хүн төрөлхтнийг Сатан төөрөлдүүлж, завхруулсан. Бид бие сэтгэлээ тамлуулан өдөржин хөдөлмөрлөдөг. Элдэв янзын өвчин, зовлон ихсэж байна. Эдгээр зовлон, түгшүүрээс болж энэ ертөнц дэх хүний амьдрал дэндүү хүнд бэрх, ядаргаатай санагддаг. Сатан хүнийг завхруулсны дараа энэ бүхэн бий болдог, Сатан биднийг хорлож байгаа нь энэ, бас хүн төрөлхтөн Бурханыг үгүйсгэж, Бурханаас урвасны гашуун үр дагавар энэ юм” гэлээ.

Хүний өвчин анх Сатанаас үүссэн гэдгийг Чинь эгчийн нөхөрлөл надад харуулсан юм. Сатан хүнийг завхруулсны дараа бид Бурханы халамж, хамгаалалтыг алдаж, элдэв янзын өвчин, шаналалд өртсөн юм байна. Дараа нь эгч ингэж хэллээ: “Сатан хүн төрөлхтнөөр тоглоом тохуу хийж, зовоохыг Бурхан харж тэвчдэггүй. Хүн төрөлхтнийг золин аварч, бүрэн аврахын тулд Бурхан хоёр удаа бие махбодтой болсон. Эхний удаад Эзэн Есүс болж бие махбодтой болоод, нүглээс маань биднийг золин аврахын тулд хүн төрөлхтний төлөө нүглийн тахил болон цовдлогдсон. Эзэн Есүст итгэснээр нүгэл маань уучлагддаг ч нүгэлт уг чанар маань хэвээр үлддэг, бас бид нүглээс бүрэн ангижраагүй л байдаг. Биднийг Сатанаас бүрэн аврагдаж, нүглээс ангижирч, цэвэрлэгдэж, эцэст нь Бурханы хаанчлалд хүргэгдээсэй гэсэндээ эцсийн өдрүүдэд Бурхан үнэнийг илэрхийлж, шүүлт, цэвэрлэлтийн ажил хийхээр хүмүүсийн дунд дахин нэг удаа бие махбодтой болсон. Бурханы үгийг илүү их уншсанаар бид үнэнийг ойлгож, ялган таних чадвартай болж чаддаг. Сатан хүнийг яг яаж завхруулдгийг ойлгож, ёрын муу мөн чанарыг нь нэвт харна. Тэгээд Сатаныг голж, нөлөөнөөс нь мултарч чадна, дараа нь Сатан биднээр дахин тоглож, биднийг хорлож чадахгүй” гэсэн. Бурхан биднийг аврахаар биечлэн ирсэн гэдгийг сонсоод би магнай хагартлаа баярласан. Сатанд тэгж хорлуулсаар байхыг үнэхээр хүсээгүй боловч Сатанд яг яаж хорлуулаад байгаагаа сайн ойлгохгүй байсан болохоор, “Би бусдын дээр гарч, онцгойрохын төлөө маш шаргуу ажилласан ч үүнээсээ болж тэсвэрлэхийн аргагүй

---

өвдлөө. Сатан намайг ингэсэн гэж үү?” гэж эгч нараас асуулаа.

Дараа нь Жан эгч миний асуулттай холбоотой Төгс Хүчит Бурханы үгийг уншиж өгсөн. “Сатан тун аядуу зөөлөн арга буюу хүмүүсийн үзэлтэй тун их нийцдэг арга ашигладаг нь ямар нэг төрлийн радикал арга биш бөгөөд үүгээр дамжуулан хүмүүс Сатаны амьдрах арга зам, амьдардаг дүрэм журмыг өөрийн мэдэлгүй хүлээн зөвшөөрч, амьдралын зорилго, чиглэлээ тогтоож, улмаар өөрийн мэдэлгүй амьдралдаа амбицтай болдог. Амьдралын эдгээр амбиц гаднаа хэчнээн агуу сүрлэг санагдах нь хамаагүй, тэдгээр нь ‘алдар нэр’, ‘ашиг хонжоотой’ салшгүй холбоотой байдаг. Ямар ч агуу, алдартай хүн, үнэндээ бүх хүний амьдралдаа дагадаг бүхэн нь ердөө ‘алдар нэр’, ‘ашиг хонжоо’ хэмээх энэ хоёр үгтэй л холбоотой байдаг. Алдар нэр, ашиг хонжоотой болмогцоо тэдгээрийг ашиглан, өндөр байр суурь, асар их эд баялгийг эдэлж, амьдралыг таашааж болно гэж хүмүүс боддог. Алдар нэр, ашиг хонжоо нь зугаа цэнгэлээр хөөцөлдөх амьдрал болон махан биеийн цадиггүй таашаалыг олж авахдаа ашиглаж болох нэг төрлийн хөрөнгө юм гэж тэд боддог. Хүн төрөлхтний ихэд шунадаг энэхүү алдар нэр, ашиг хонжооны төлөө хүмүүс сайн дураараа хэрнээ өөрсдийн мэдэлгүйгээр бие, сэтгэл, өөртөө байгаа бүхнийг, өөрсдийн ирээдүй, хувь заяаг бүгдийг нь Сатанд хүлээлгэн өгдөг. Тэд нэг хором ч эргэлзэхгүйгээр, өгсөн бүхнээ буцаан авах хэрэгтэйг ер мэдэхгүйгээр үүнийг хийдэг. Ийм маягаар Сатанд хоргодож, түүнд үнэнч болмогцоо хүмүүс өөрсдийгөө хянасаар байж чадах уу? Мэдээж үгүй. Тэднийг Сатан бүрмөсөн, бүрэн дүүрэн хянадаг. Мөн тэд намагт бүрмөсөн, тэр чигтээ живсэн бөгөөд өөрсдийгөө чөлөөлж чаддаггүй. Хүн алдар нэр, ашиг хонжооны намагт живмэгцээ гэрэл гэгээтэй зүйлийг, зөв шударга зүйлийг, эсвэл сайн, сайхан зүйлсийг эрж хайхаа больдог. Яагаад гэвэл, хүмүүсийг уруу татах алдар нэр, ашиг хонжооны хүч чадал дэндүү их; тэдгээр нь хүмүүсийн насан туршдаа, бүр эцэс төгсгөлгүйгээр үүрд мөнх хөөцөлддөг зүйлс болдог. Энэ нь үнэн биш гэж үү?... Сатан, алдар нэр, ашиг хонжооноос өөр юу ч бодохгүй болтол нь хүний бодлыг хянахын тулд алдар нэр, ашиг хонжоог ашигладаг. Тэд алдар нэр, ашиг хонжооны төлөө тэмцэж, алдар нэр, ашиг хонжооны төлөө зовлон бэрхшээл туулж, алдар нэр, ашиг хонжооны төлөө доромжлолыг тэвчиж, алдар нэр, ашиг хонжооны төлөө өөрсдөдөө байгаа бүхнийг золиосолдог ба алдар нэр, ашиг хонжооны төлөө ямар ч үнэлгээ, шийдвэр гаргана. Ийм маягаар Сатан хүнийг үл үзэгдэх гав дөнгөөр хүлдэг ба тэдгээрээс ангижрах хүч ч, зориг ч хүнд байдаггүй. Хүмүүс өөрийн мэдэлгүйгээр энэ гав дөнгийг зүүж, асар их хүндрэлтэйгээр урагшаа арай ядан сажилдаг” (Үг нь махбодоор илэрсэн номын “Цор ганц Бурхан Өөрөө VI”).

Эгч Бурханы үгийг уншсанахаа дараа Сатан хүнийг завхруулахын тулд алдар нэр,

---

ашиг хонжоог яаж ашигладаг тухай үнэнийг нөхөрлөлөө. Сатан хэчнээн үзэн ядмаар гэдгийг тэгэхэд л ухаарсан! “Зовсны эцэст жаргана”, “Ажлын сайнаар амьдрал дээшилнэ, бэлчээрийн сайнаар мал таргална”, “Амьдрал мөнгөн дээр тогтдог” гэх мэт амьдрах дүрмээрээ биднийг үзэл сурталжуулахын тулд Сатан албан боловсрол, нийгмийн нөлөөг ашигладаг. Эдгээр амьдрах дүрэмд хууртаад хүмүүс мөнгөгүй амьдарч чадахгүй гэж бодон, баяжвал бусдад хүндлэгдэж, нэр төртэй болно, ядуу байна гэдэг бага үнэ цэнтэй байна гэсэн үг гэж үздэг. Тийм болохоор хүмүүс мөнгө, алдар нэр, ашиг хонжооны төлөө насан туршдаа зүтгэж, тэдгээрт хүрэхийн тулд, үр дагаврыг нь үл харгалзан юу ч хийхээс буцдаггүй. Хүмүүс улам завхарч, амьдрал нь улам шаналантай болдог. Сатаны бидэнд зүүлгэсэн дөнгө, бас биднийг завхруулах заль мэх энэ юм. Бусдаас дээр гарч, бусдад өндрөөр үнэлэгдэхийн тулд илүү их мөнгө олох гэж зүтгэсээр би мөнгөний машин болсон байж. Хүсэл минь нэмэгдэж, хэзээ ч сэтгэл ханаагүй, тэгээд эрүүл мэндээ сүйтгэснээр л зогсохоос өөр аргагүй болсон. Би мөнгө, алдар нэр, ашиг хонжооны боол болсон байсан. Алдар нэр, ашиг хонжооны эрэл хайгуул амьдралыг минь үнэхээр маш хүнд, ийм туйлдмаар болгосон юм! Энэ олон жил тийм юм эрэлхийлээд өвдөж, эцэстээ гэмтэж бэртлээ. Сатанд хорлуулж, завхарснаас л энэ бүх зовлон үүдэлтэй байж! Бурханы үгийн илчлэлгүйгээр би, Сатан хүмүүсийг завхруулах гэж мөнгө, алдар нэр, ашиг хонжоо ашигладгийг хэзээ ч мэдэхгүй, алдар нэр, ашиг хонжоо нь хүмүүсийг хүлдэг Сатаны дөнгө гэдгийг бүр ч мэдэхгүй байх байлаа.

Дараа нь Чинь эгч надтай нөхөрлөхөөр маш олон удаа ирсэн. Яваандаа би, хүнийг завхруулахдаа Сатаны ашигладаг арга мэхийг олж харж эхэлсэн юм. Бас Бурханы үгийг уншиж, үнэнийг эрэлхийлж, Бурханы захиралт, зохицуулалтыг дуулгавартай дагах нь хамгийн чухал гэдгийг ухаарч авсан. Энэ бол хамгийн утга учиртай, аз жаргалтай амьдрах арга, бас Бурханы сайшаадаг цорын ганц арга зам юм!

Манай ажлын нэг хүн бүх хүчээ дайчлан мөнгө олохоор нөхөртэйгөө хамт Японд ирсэн гэдгийг би нэг өдөр олж мэдлээ. Тэд багахан мөнгө олсон ч хожим нь нөхрийнх нь бие муудаж, Хятад руу явж эмчлүүлэх ёстой болоод, эцэст нь хорт хавдрын сүүлийн шат гэж оношлогдсон юм. Тэдний гэр бүл айдас, уй гашуу дунд амьдардаг байлаа. Тэдний золгүй явдлаас бие хэврэг, амь нандин гэдгийг гүнээ мэдэрсэн. Амьгүй бол илүү их мөнгөөр яах юм бэ? Мөнгөөр амь худалдаж авч болох уу? Дараа нь би Төгс Хүчит Бурханы үгээс ингэж уншлаа: **“Хүмүүс мөнгө, алдар нэрийн хойноос хөөцөлдөн амьдралаа үрдэг; эдгээр хэрэггүй зүйл тэдэнд байвал амьд явж, үхлээс мултарч чадах юм шиг, цорын ганц найдвар нь хэмээн бодож тэдгээрээс зуурдаг. Гэвч үхэх гэж байхдаа л эдгээр зүйл тэднээс хэчнээн хол, үхлийн өмнө тэд хэчнээн сул дорой болох, хэчнээн амархан сүйрдэг, хаашаа ч явах аргагүй, хэчнээн ганцаардмал, арчаагүй**



---

болохоо тэд ухаардаг. Амийг мөнгө, эсвэл алдар нэрээр худалдан авч болдоггүй, хүн хэчнээн баян чинээлэг байх, байр суурь нь хэчнээн өндөр дээд байх нь хамаагүй, үхлийн өмнө бүх хүн адилхан ядуу дорой, өчүүхэн гэдгийг ухаардаг. Мөнгөөр амь худалдан авч чадахгүй, алдар нэр үхлийг баллуурдаж чадахгүй, мөнгө, алдар нэрийн аль нь ч хүний амьдралыг ганц минут, ганц секундээр уртасгаж чадахгүй гэдгийг тэд ухаардаг” (Үг нь махбодоор илэрсэн номын “Цор ганц Бурхан Өөрөө III”). Бурханд итгэж, үнэнийг ойлгохгүй бол Сатаны явуулгыг нэвт харж чадахгүй, бас Сатан хүмүүсийг завхруулахдаа мөнгө, алдар нэр ашигладгийг олж харж чаддаггүй гэдгийг би Бурханы үг надад илүү сайн ойлгуулсан. Бид энэ эргүүлэгт татагдан орж, эргээд гарч чаддаггүй. Тэгээд өөрийн мэдэлгүй Сатанд мэхлүүлж, хорлуулж, бүр амьдралаа сүйтгэдэг. Энэ маш эмгэнэлтэй. Би итгэгч болж, Бурханы маш олон үгийг уншсаны ачаар эдгээрийг эцэст нь ойлгож авсан юм. Итгэгч болж, Бурханы үгийг уншаагүй бол Сатаны завхралыг хаяж хэзээ ч чадахгүй байсан. Зүгээр л харанхуйд, шаналал дунд гарах гарцгүй зовж байх байлаа.

Намайг бэртсэн байхад чуулганы эгч нар олон удаа эргэж, өвдөлтийг минь намжаахад тусалдаг байлаа. Бас гэр орны ажил хийж, намайг гэр бүл нь мэт харж хандсан. Харь нутагт намайг анхаарч харж хандсанд нь миний сэтгэл маш их хөдөлсөн. Тэгээд Төгс Хүчит Бурханд бүр их талархсан юм. Бурханы халамж, хамгаалалтаар миний бие нэг л мэдэхэд сайжирсан.

Дараа нь Төгс Хүчит Бурханы үгээс ингэж уншлаа: “Хүн туулж өнгөрүүлсэн замаа эргэн харж, амьдралын замналын үе шат бүрээ дурсан санахдаа, замнал нь энхэл донхолтой, эсвэл толигор аль нь ч бай, Бурхан алхам бүрд замыг нь залж чиглүүлж, төлөвлөж өгч байсныг ойлгодог. Өнөөдрийг хүртэл хүнийг мэдэгдэлгүйгээр хөтөлж байсан зүйл нь Бурханы нямбай зохицуулалт, Түүний хичээнгүй төлөвлөлт байжээ. Бүтээгчийн дээд эрхийг хүлээн зөвшөөрч, Түүний авралыг хүртэх чадвартай байна гэдэг хэчнээн агуу завшаан бэ! Хэрвээ хүн хувь заяанд сөрөг ханддаг бол, түүнд зориулж Бурханы зохицуулсан бүхнийг тэр эсэргүүцдэг, түүнд захирагдах хандлага байхгүйг энэ нь батална. Хэрвээ хүний хувь заяаг захирах Бурханы дээд эрхийн талаар хүн эерэг хандлагатай бол амьдралын замналаа эргэн харж, Бурханы дээд эрхийг үнэхээр ухан ойлгох үедээ Бурханы зохицуулсан бүх зүйлд захирагдахыг чин сэтгэлээсээ хүсэж, хувь заяагаа зохион байгуулахыг Бурханд зөвшөөрч, Бурханы эсрэг тэрслэхээ болихдоо илүү шийдэмгий, итгэлтэй болно. Учир нь хувь заяаг ухаарч ойлгохгүй, Бурханы дээд эрхийг ойлгохгүй, манан дундуур гуйвж дайван зоргоороо урагшаа тэмтчин явахад уг замнал хэтэрхий хэцүү, хэтэрхий зүрх зүсэм байдгийг ойлгодог. Иймээс хүмүүс хүний хувь заяаг захирдаг Бурханы дээд эрхийг

---

танин мэдэхээрээ ухаалаг хүмүүс нь өөрийн гараар сайхан амьдрал бүтээх гэж хичээж байсан бэрх өдрүүдтэйгээ салах ёс хийж, хувь заяаны эсрэг тэмцэж, ‘амьдралын зорилго’ гэх зүйлээ өөрийнхөөрөө эрэлхийлэхээ болихоор мэдэж, хүлээн зөвшөөрөх замыг сонгодог. Хүнд Бурхан байхгүй, Түүнийг харж чадахгүй, Бурханы дээд эрхийг тодорхой танин мэдэж чадахгүй үед өдөр бүр нь утга учиргүй, үнэ цэнгүй, хөөрхийлөлтэй байдаг. Хүн хаана ч байсан, ажил нь ямар ч байсан, амьдрах арга зам болон зорилгоор хөөцөлдөх нь эргэн дурсаж ч чадамгүй эцэс төгсгөлгүй их уй гашуу, хөнгөвчлөхийн аргагүй зовлон шаналлаас өөр юуг ч авчрахгүй. Бүтээгчийн дээд эрхийг хүлээн зөвшөөрч, Түүний зохион байгуулалт, зохицуулалтад захирагдаж, жинхэнэ хүмүүний амьдралыг эрж хайсан цагт л хүн бүх уй гашуу, зовлон шаналлаас аажмаар ангижирч, амьдралын бүхий л утгагүй хоосон байдлаас салж эхэлнэ” (Үг нь махбодоор илэрсэн номын “Цор ганц Бурхан Өөрөө III”). Бурханы үг маш бодитой байж, үг бүр нь зүрх сэтгэлийн минь угт хүрдэг. Бурхан бол Бүтээгч, бид бол Бурханы бүтээл гэдгийг Бурханы үгээс би ойлгодог. Хүн болгоны амь Бурханы гарт, Бурханы хяналт, зохицуулалт дор байдаг. Амьдралд бидний олж авдаг бүхнийг Бурхан хянаж, урьдчилан тогтоодог. Ийш тийш яарах нь шийдвэрлэх хүчин зүйл яавч биш. Бурхан хэдий ихийг хайрлана, бид төдий ихийг хүртэнэ. Хэрвээ Бурхан юу ч хайрлахгүй бол бид хэчнээн их хөдөлмөрлөөд ч нэмэргүй. Яг л “Хүн тариа тарьдаг ч Тэнгэр ургацыг шийддэг”, “Хүн санаачилж, Бурхан болгоодог” гэдэг шиг. Бид амьдрахдаа Бүтээгчийн захиралт, зохицуулалтад захирагдах ёстой. Аз жаргалтай амьдрахын нууц энэ шүү дээ! Бас мөнгө, албан тушаал бол ертөнцийн өмч гэдгийг би ойлгосон. Алдар нэр, ашиг хонжооны эрэлд өөрийгөө зориулснаар эцэст нь хоосрол, шаналалд л орно. Эцэстээ тэгээд Сатанд залгиулна. “Зовсны эцэст жаргана” гэх мэт сатанлаг гүн ухаанаар амьдарч, мөнгө, алдар нэр хөөцөлдөж явснаа эргээд бодлоо. Би аз жаргалтай амьдарч, бусдад өндрөөр үнэлэгдэж, атаархуулна гэж бодсон ч оронд нь шаналал, зовлон амсана гэж төсөөлөөгүй юм. Би огт амар амгалан, аз жаргалгүй байсан. Бурханы үгийг уншаад би Бурханы хүслийг ойлгосон. Дахиж хувь заяатайгаа тэмцмээргүй байна, бас алдар нэр, ашиг хонжоо үнэхээр хөөцөлдмөөргүй байна. Би тийм амьдрал хүсэхээ больсон. Амьдралын өөр замаар явахаар шийдээд, үлдсэн амьдралыг минь зохицуулаг гэж Бурханы гарт даатган, Бурханыг дуулгавартай дагаж, үүргээ биелүүлэхээр чармайхыг л хүссэн юм.

Тэгээд итгэлдээ илүү их цаг гаргаж, цуглаанд оролцохын тулд хуучин ажлаасаа гарч, шинэ, арай амархан ажилд орлоо. Ажиллаагүй үедээ ихэвчлэн Бурханы үг уншиж, унших тусам зүрх сэтгэл минь гэгээлэг болдог. Бас хүн нүгэл үйлддэгийн эх сурвалжийг олж мэдээд, Бурхан хүн төрөлхтнийг яаж алхам алхмаар авардаг, хүн юуны төлөө амьдрах ёстой, бас утга учиртай амьдралаар яаж амьдрах ёстойг ойлгодог болсон юм. Ах эгч

---

нартай ойр ойрхон цуглаж, туршлагаа хуваалцан, Бурханы үгийн магтан дуу дуулж сурдаг. Одоо миний амьдрал аз жаргалтай болсон. Урьдынх шигээ их мөнгө олохгүй байгаа ч урьд нь хэзээ ч мэдэрч байгаагүй амар амгалан, тогтвортой байдлыг мэдэрдэг. Одоо эргээд бодоход би золгүй явдлаар дамжуулан ерөөл хүртжээ! Энэ үнэхээр намайг аврах Бурханы аврал юм.

## **34. Христэд итгэгчийн сүнслэг сэрэлт**

Линву, Япон

Би наяд оны хүүхэд бөгөөд жирийн нэгэн тариачин гэр бүлд төрсөн юм. Ах маань багаасаа л бие султай, өвчин ороомтгой хүүхэд байв. Аав маань намайг 10 настай байхад осолд орж, бэртсэн юм. Тэгээд ослоос хойш хоёр жилийн дараа бүрэн саажилттай боллоо. Манай гэр бүл угийн ядуу тарчиг байсан тул аавын эмчилгээг хийлгэх гэж их хэмжээний өр тавьсан юм. Найз нөхөд, хамаатан садан маань биднийг өрөө хэзээ ч төлж чадахгүй гэж эмээж байсан болохоор мөнгө зээлдүүлэх хүсэлгүй байв. Иймээс би аргагүйн эрхэнд 16 насандаа сургуулиа хаяж, өөр газар ажилд орох шаардлагатай болсон юм. “Бага балчир байхдаа үеийнхэн маань хичээлийн дараа хүссэнээрээ тоглож нааддаг байсан бол харин би тариан талбай руу очиж, тариалангийн ажил хийх ёстой болдог байсан. Одоо бид бүгд өсөж том болсон ч тэд сургуульд явж, эцэг эхийнхээ өмнө эрх хүүхэд шиг аашилсаар байхад харин би гэр бүлээ тэжээхийн тулд бага залуугаасаа эхлэн ажиллаж, янз бүрийн хатуу бэрхийг туулах ёстой болж байдаг” хэмээн шөнө дундын нам гүм үед би байнга бодлогоширдог байлаа. Ийм үедээ, намайг анхнаасаа яах гэж төрүүлсэн юм бэ гэж ээж аавыгаа зүхдэг байв. Мөн яагаад би энэ ертөнцөд зөвхөн хөдөлмөрлөж, зовж шаналах гэж ирсэн юм бэ гэж асуудаг байлаа. Гэвч би аргагүйн эрхэнд ийм бодит байдалтайгаа эвлэрэх ёстой болсон юм. Тухайн үед миний хамгийн том хүсэл бол эцэх эхээ тав тухтай амьдруулж, бусдад дор үзэгдэхгүйн төлөө шаргуу ажиллаж, мөнгө олох явдал байв.

Хөнгөн цагааны хайлшны хувийн үйлдвэрт би ажлын гараагаа эхэлсэн юм. Намайг хүүхэд байсан болохоор дарга маань үргэлж хоол унд, байрлах байраар хангаж, анхаарал халамж тавьдаг байв. Нэг жилийн дараа цалин маань дэндүү бага санагдаж эхэлсэн тул тавилгын үйлдвэрт би бусад хүний хийхийг хүсдэггүй лак шүршдэг ажилд орохоор шийдэв. Тухайн үед хууль ёсны л бол илүү их мөнгө олох боломжтой ямар ч ажлыг би хийдэг байлаа. Миний зорилго бол чинээлэг болж, ядуу хүний амьдралаар дахин амьдрах шаардлагагүй болох явдал байв. Хожим нь хамаатан маань намайг гадаадад ажиллах боломжтой нэг компанид ажилд орууллаа. Хэдэн жилийн дараа гайхмаар зүйл болж, би

---

үнэхээр л гадаад явж чадсан юм.

2012 оны хавар би өөрийнхөө хүссэнчлэн Японд ирж, шинэ амьдралаа эхэлсэн билээ. Тэгээд усан онгоц үйлдвэрлэх салбарт орж, компанитайгаа гурван жилийн гэрээ байгууллаа. Ажиллаж эхлэх үедээ би хоол хийж чаддаггүй байсан тул бүтэн сарын турш бэлэн гоймон идэв. Эцэст нь бэлэн гоймон идэхээр бөөлжис цутгадаг болсон тул аргагүйн эрхэнд хоол хийж сурлаа. Хагас болгосон будааг хэдэн хоног идсэн юм бүү мэд. Японд бид гаднын хүмүүс тул нутгийн ажил олгогчдын шударга бус хандлагатай зайлшгүй тулгардаг байв. Бохир заваан, хүнд хэцүү, аюул эрсдэлтэй маш олон ажлыг биднээр хийлгэдэг байлаа. Ялангуяа лак шүрших үедээ би маш их айдаг байсан юм. Учир нь хий галд хүрмэгц гал авалцдаг тул ганц хором л анхаарлаа сарниулбал амь нас маань аюулд орж болохоор байв. Гэвч би амьдралдаа зовж шаналж, ажил дээрээ аюултай байдалд орсон ч хамаагүй гэр лүүгээ илгээх илүү их мөнгө олно, мөн Хятад руу буцаж очоод байр, машин худалдан авна, бусдаас дээр гарч, ядуу амьдралаар дахин үл амьдарна, бусдад дорд үзэгдэхээ болино гэж бодох болгонд тухайн үеийн зовлон шаналал маань үнэндээ тийм ч муугүй санагддаг байлаа. Тэнд ажилласаар амьдралын минь гурван жил харвасан сум мэт өнгөрсөн юм. Визний маань хугацаа бараг дуусах гэж байх үед би компани маань гэрээ шинэчлэх бодлоготойг олж мэдсэн тул нэмж мөнгө олохын тулд гэрээгээ шинэчлэн, Японд үргэлжлүүлэн ажиллах сонголт хийлээ. Гэрээгээ шинэчилснээс хойш удалгүй гайхаж, баярламаар үйл явдал болж, Төгс Хүчит Бурханы хаанчлалын тухай сайн мэдээтэй учирсан юм.

2015 оны 9 дүгээр сард, Японд танилцсан найз маань надад эцсийн өдрүүд дэх Төгс Хүчит Бурханы ажлын талаар ярьж өгөв. Тэрээр Бурханд итгэх тухай ярьж байхад нь би нэг ёсны итгэл бишрэл л юм байна гэж бодоод огт сонирхсонгүй. Бурханд итгэснээр миний хувь заяа өөрчлөгдөхгүй мэт санагдаж байлаа. Төд удалгүй би найздаа өөрийн үзэл бодлыг хэлээд, ингэж асуув: “Бурханд итгэснээр миний хувь заяа өөрчлөгдөж чадах уу? Би багаасаа л маш их зовлон үзсэн, тун заяа муутай хүн. Мөнгөтэй сэн бол би цаашид ингэж зовох шаардлагагүй болох байсан. Яг одоо бол нэмж мөнгө олох л надад хамгийн бодитой зүйл. Харин Бурханд итгэх нь миний хувьд хол хөндий зүйл байгаа юм.” Найз маань хариуд нь Бурханы үгээс дараах хэсгийг надад уншиж өгөв: **“Өдөр бүр хаашаа явах, юу хийх, хэнтэй эсвэл юутай таарах, юу хэлж ярих, чамд юу тохиолдох гээд эдгээрийн аль нэгийг тааварлаж болох уу? Хүмүүс эдгээр нөхцөл байдал хэрхэн өрнөхийг хянах нь байтугай энэ бүх үйл явдлыг урьдаас мэдэж чаддаггүй. Амьдрал дээр, урьдчилан харах боломжгүй эдгээр зүйл цаг үргэлж тохиолддог; тэдгээр нь өдөр тутмын үйл явдал юм. Өдөр тутмын эдгээр нөхцөл байдлын өөрчлөлт болон тэдгээрийн өрнөж байгаа байдал, эсвэл дагаж буй буй зүй тогтол нь ямар ч зүйл**

---

санаандгүй тохиолддоггүй, үйл явдал бүрийн болж буй явц, зайлшгүй байдлыг хүний хүслээр өөрчилж болдоггүй гэдгийг хүн төрөлхтөнд байнга сануулж байдаг. Үйл явдал бүр нь Бүтээгчээс хүн төрөлхтөнд өгч буй сануулгыг дамжуулдаг бөгөөд мөн хүмүүс өөрсдийн хувь заяаг хянаж чадахгүй гэсэн санааг илгээдэг. Үйл явдал бүр хувь заяагаа гартаа авах гэсэн хүн төрөлхтний ойворгон, хий дэмий, хүсэл, эрмэлзлийг няцаадаг... Өдөр тутмын эдгээр нөхцөл байдлын өөрчлөлтөөс эхлээд хүний бүхий л амьдралын хувь заяа хүртэл, Бүтээгчийн төлөвлөгөө болон дээд эрхийг илчилдэггүй зүйл нэгээхэн ч үгүй; ‘Бүтээгчийн эрх мэдлийг даван гарч чадахгүй’ гэсэн санааг илгээдэггүй, мөн ‘Бүтээгчийн эрх мэдэл бол эрхэм дээд юм’ гэсэн мөнхийн үнэнийг дамжуулдаггүй зүйл нэгээхэн ч үгүй” (Үг нь махбодоор илэрсэн номын “Цор ганц Бурхан Өөрөө III”). Эдгээр үг надад маш их утга учиртай санагдаж, гэрээгээ шинэчилж чадсан маань Тэнгэрийн зохицуулсан зүйл мэт санагдах болов. Мөн төрж өссөн гэр орон, гэр бүлийнхэнтэйгээ хамт өнгөрүүлсэн амьдрал, эргэн тойронд минь болсон бүх зүйлийн тухай бодоод үзэхэд тэр бүгд миний хяналтаас давсан, тааварлахын аргагүй зүйлс байжээ. Хаа нэгтээ Дээд Захирагч хяналтыг атгаж байгаа мэт мэдрэмж надад төрж билээ.

Дараа нь найз маань Үг нь махбодоор илэрсэн номын “Цор ганц Бурхан Өөрөө III”, дэх Бурханы үгийн нэг хэсгийг надад уншуулав. Тэр хэсэгт хүний амьдралдаа туулж өнгөрүүлэх ёстой зургаан үе шатыг дурдсан байлаа. Эхний үе шат нь төрөх; хоёр дахь үе шат нь өсөж бойжих; гурав дахь үе шат нь бие даах; дөрөв дэх үе шат нь гэрлэх; тав дахь үе шат нь үр хүүхэдтэй болох; зургаа дахь үе шат нь үхэл гэсэн байв. Бурханы үгийг уншаад би гайхаж орхисон юм. Бурхан хүний насан туршийн хувь заяаны талаар ийм тодорхой хэлсэн гэж би огт бодоогүй явсан бөгөөд баримтууд ч үнэхээр Түүний дүрсэлсэнчлэн байв. Хүмүүс төрсөн гэр бүлээ сонгох ямар ч боломжгүй, ямар эцэх эхтэй болохоо ч сонгож чадахгүй. Өсөж том болоод ямар хүнтэй ханилах нь ч тэдний сонголт биш. Энэ талаар эргэцүүлэх тусам эдгээр үг амьдралд маш ойр болохыг мэдэрсэн бөгөөд хувь заяа бол хүн өөрөө өөрчилж чадах зүйл биш хэмээх Төгс Хүчит Бурханы хэлсэн үгэнд би зүрх сэтгэлдээ итгэж эхлэв. Үүнээс хойш би Бурханд итгэх тухай илүү их сонирхох болж, Бурхан байдаг юм байна, хүн хувь заяагаа өөрөө хянадаггүй юм байна гэдэгт итгэсэн юм. Гэвч би Бурханы талаар төдийлөн мэддэггүй байсан тул Бурхан надаас маш хол хөндий санагддаг байлаа. Гэхдээ Бурхан дэргэд минь байж, намайг харж, хамгаалдаг болохыг би удалгүй тохиолдсон үйл явдлаар дамжуулан чин сэтгэлээсээ мэдэрсэн билээ.

Бороо орж байсан тэр өдөр би ажил дээрээ заншил ёсоор цагтаа ирэв. Өглөөний 10 цаг дөнгөж өнгөрч байх үед би ажлын талбай дээр байж байтал гэнэт түсхийх чимээ

---

гарлаа. Юу ч юм бэ, нэг зүйл газар дээр бяц унасан бөгөөд айсандаа би дагжин чичирсэн юм. Эргээд хартал 40 сантиметрийн диаметртэй, 4 метр урт, бараг хагас тонн жинтэй урт төмөр хоолой кранаас унасан байсан бөгөөд үүнийг хараад би мэл гайхав. Кранаас унасан тэр хоолой миний зогсож байсан газраас хагас метр хүрэхгүй зайд ойчсон байлаа. Би тэр мөчид үнхэлцгээ хагартал айсан тул үг дуугарч ч чадахгүй байсан бөгөөд цочролоос гарч, хэвийн болох хүртэл нэлээд хугацаа оров. “Баярлалаа Бурхан минь! Баярлалаа Бурхан минь! Та тэнд намайг харж хамгаалаагүй бол тэр төмөр хоолой эгц дээрээс минь унаж, өчүүхэн улаан амийг минь таслах байлаа” гэж сэтгэлдээ би тасралтгүй уулга алдсаар байсан билээ.

Ажлаас буусныхаа дараа тэр өдөр болсон зүйлийн талаар ах эгч нартаа хэлтэл тэд үүнийг Бурханы хамгаалалт байсан гэж надад нөхөрлөв. Тэд бас Төгс Хүчит Бурханы дараах үгийг надад уншиж өгсөн юм: **“Хүний амьдралын урт удаан замналд, бараг хүн бүр аюултай олон нөхцөл байдалтай тулгарч, олон уруу таталттай нүүр тулсан. Учир нь Сатан харцаа чам дээр байнга тогтоон, чиний хажууд зогсож байгаа. Чамайг гай зовлон нэрвэхэд Сатан баясдаг; чамд гай гамшиг тохиолдоход, бүх юм чинь бүтэлгүйтэхэд, чамайг Сатаны урхинд орооцолдоход, Сатан эдгээр зүйлээс асар их таашаал авдаг. Бурханы хийж байгаа зүйлийн тухайд бол, Тэр чамайг хором бүрд хамгаалж, нэгээс нөгөө золгүй явдлаас, нэгээс нөгөө гай гамшгаас зайлсхийлгэж байгаа. Ийм учраас хүнд байдаг бүхэн—амар амгалан болон баяр хөөр, ерөөл хийгээд хувийн аюулгүй байдал нь—бүгд үнэндээ Бурханы хяналтан дор байдаг; Тэрээр хүн нэг бүрийн хувь заяаг залж чиглүүлж, шийдэж байдаг гэж Би хэлдэг”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Цор ганц Бурхан Өөрөө VI”). Хүмүүс өдөр бүр Сатаны торонд амьдардаг бөгөөд аль ч мөчид Сатанаас ирдэг янз бүрийн аюулт сорилттой нүүр тулгарч, гамшиг, осолтой учирч, аливаа зүйл хүссэнээр нь эргэхгүй байж болдгийг би Бурханы үгийг уншсаны дараа ойлгов. Бурхан харж хамгаалаагүй бол хүмүүс аль эрт Сатанд залгиулах байжээ. Ажил дээр тулгарсан аюулын талаар бодох үед хагас тонн шахуу жинтэй төмөр хоолой унаж, надаас хагас метрийн зайтай газар ойчсон гэж бодохоор л энэ нь зүгээр ч нэг аз биш байсан гэдгийг би мэдэж байлаа. Бурхан намайг харж хамгаалсан болохоор л би энэ азгүй явдалд өртөөгүй билээ. Энэ бүх он жилүүдэд Бурхан намайг хэдэн удаа харж хамгаалж, ашиг тусаа хүртээснийг мэдэхгүй ч гэлээ Бурханыг би хэзээ ч ойлгож, Түүнийг шүтэн мөргөдөггүй байжээ. Би үнэхээр мөс чанаргүй явж. Яг тэр мөчөөс эхлэн Бурханы авралын нигүүлслийг би илүү сайн ойлгодог болсон юм. Бурханы хайр энэрэлт гар намайг хамгаалж байдгийн ачаар л өнөөг хүртэл би амьд яваа юм байна. Бурханд би чин сэтгэлээсээ талархахын зэрэгцээ тэр үеэс эхлэн Бурханыг дагахын тулд чадах бүхнээ хийхээр шийдлээ. Удаах өдрүүдэд нь би цуглаанд ойр ойрхон очиж, ах эгч

---

нартай хамт Бурханы үгийг уншиж, Бурханы үгийн талаарх туршлага, мэдлэгээ нөхөрлөн, хуваалцаж, Бурханыг магтан дуу дуулдаг болсон юм. Би зүрх сэтгэлдээ эрх чөлөөг мэдрэн, чөлөөтэй боллоо. Ах эгч бид сүнслэг амьдралдаа нэг нэгнээ тусалж дэмждэг байв. Тэдний хэн нь ч намайг доош хийдэггүй, хэн нь ч ядууг дорд үзэж, баянд тал засдаггүй байсан бөгөөд би нэр төртэй амьдарч чадах юм шиг санагддаг болсон юм. Төгс Хүчит Бурханы Чуулганы энэхүү том, халуун дулаан, аз жаргалтай гэрт амьдрах үед амьдралд минь аажмаар өөрчлөлт гарлаа. Би урьд өмнөх шигээ түгшиж, зовж шаналж, улиран одох өдөр хоногуудыг хоосон мэт мэдрэхээ болив. Тэгээд урьдынхаасаа хавьгүй аз жаргалтай, сэтгэл ханамжтай байх болсон билээ.

Нэгэн өдөр манай компанид удаан ажиллаж байгаа нэг ажилтанд таагүй явдал тохиолдож билээ. Тэрээр компанид аль хэдийн арав гаруй жил ажилласан япон хүн байсан юм. Аюулгүй ажиллагаа, техникийн тал дээр аль алинд нь үнэхээрийн чадварлаг байсан тэрээр ээлжид гарсан нэг өдрөө өргөгч машин жолоодон 20 метрийн өндөрт ачаа өргөхөөд ажиллаж байжээ. Ажлын явцад анхаарал болгоомж алдсаны улмаас ачааны машины шингэрүүлсэн хий гоожиж эхэлсэн байв. Өөр нэг ажилчин түүний дээхэн талд зүүгдээтэй гагнуурын ажил хийж байгаад түүний хувцсан дээр оч унагажээ. Гоожсон хийнд оч хүрсэн даруйд гал авалцаж, тэр дороо түймэр гарсан юм. Он удаан хамт ажилласан нөхөр маань галд шатаж буйг тэнд байсан бид бүгд зүгээр л харахаас өөрөөр юу ч хийж чадсангүй. Түүнийг очиж аваръя гэлээ ч аль хэдийн оройтсон байсан бөгөөд хэдхэн хормын дотор тэр хүн шатаж үхсэн билээ. Ийм эмгэнэлтэй үйл явдал болж байгааг харсан олон хүн түүнийг өрөвдөн, амьдралын талаар нэг зүйлийг ухаарсан юм: Эцсийн эцэст хүмүүс юун төлөө амьдардаг юм бэ? Ийм зүйл яг дэргэд минь тохиолдсон болохоор Бурханаас холдож, Бурханы хяналт, хамгаалалтгүй болбол хүний амь амьдрал дээсэн дөрөөн дээр дэнжгэнэж байдгийг би үнэхээр ухаарсан юм. Хүний амь аливаа гамшигтай тулгарах үедээ өчүүхэн цохилтыг ч тэсвэрлэж чадахааргүй үнэхээрийн хэврэг байдаг. Хүн хэдий их чадвар чадавхтай, хэчнээн их хөрөнгө мөнгөтэй байлаа ч өөрийн хувь заяаг захирах аргагүй бөгөөд өөрийгөө гамшиг, үхлээс аварч бүр ч чадахгүй гэдгийг би бас гүнээ мэдэрсэн билээ.

Төд удалгүй би Бурханы үгийн дараах хэсгийг уншив: **“Өөрийн гэсэн юу ч үгүй эхэлсэн ганцаардмал сүнс, Бүтээгчийн дээд эрх болон урьдчилан тогтоосны улмаас эцэг эх, гэр бүлтэй болж, хүн төрөлхтний нэг гишүүн болох боломж, хүмүүний амьдрал туулж, дэлхий ертөнцийг харах боломжийг олж авдаг. Энэхүү сүнс мөн Бүтээгчийн дээд эрхийг мэдэрч, Бүтээгчийн бүтээлийн гайхалтай сайхныг мэдэж, түүнээс ч илүүтэйгээр Бүтээгчийн эрх мэдлийг мэдэж, захирагдах боломжийг олж авдаг. Гэхдээ ихэнх хүн энэхүү ховор, агшин зуурын боломжийг үнэндээ барьж**

---

авдаггүй. Хүн, хувь заяаны эсрэг тэмцэж насан туршийн эрч хүчээ шавхан, гэр бүлээ тэжээх гэж хичээн, эд баялаг, байр суурийн хооронд нааш цааш давхиж, хөл үймээн болж хамаг цагаа зарцуулдаг. Хүмүүсийн нандигнадаг зүйл нь гэр бүл, мөнгө, алдар нэр байдаг, тэд эдгээрийг амьдралын хамгийн үнэ цэнтэй зүйлс гэж үздэг. Бүх хүн хувь заяаныхаа талаар гомдоллодог боловч, хүн яагаад амьд байдаг, хүн хэрхэн амьдрах ёстой, амьдралын үнэ цэн, утга учир юу вэ гэсэн шинжилж, ойлговол зохих хамгийн чухал асуудлуудыг бодлынхоо мухар луу түлхсээр байдаг. Хэчнээн урт наслах байсан ч бай, залуу нас нь нисэн одож, үрчлээтэж, буурал болох хүртлээ ердөө л алдар нэр, эд баялаг эрж хайн тэвдэж гүйсээр хамаг амьдралаа үрдэг. Нэр хүнд, эд баялаг өтөл насны доройтол руу уруудахыг нь зогсоож чадахгүй гэдгийг, мөнгө сэтгэлийн хоосролыг дүүргэж чадахгүй, төрж, хөгширч, өвдөж, үхэх хуулиас хэн ч ангид байдаггүй, хувь заяаны төөргөөс хэн ч зугтаж чадахгүй гэдгийг ойлгох хүртлээ тэд ингэж амьдардаг. Тэд амьдралын эцсийн онцгой үетэй тулгарахаас аргагүй болсон үедээ л, асар их эд баялаг, үлэмж их эд хөрөнгөтэй, эрх дархтай, өндөр зиндаатай байсан ч гэсэн хэн ч үхлээс зугтаж чадахгүй, анхны байрандаа эргэн очиж, өөрийн гэх ямар ч юмгүй орь ганц сүнс болно гэдгийг лавтай ухаардаг” (Үг нь махбодоор илэрсэн номын “Цор ганц Бурхан Өөрөө III”). Бурханы эдгээр үгийг уншсаны дараа миний сэтгэл маш их хөдөллөө. Хүмүүсийн сүнс Бурханаас гарч, Бурханы зурсан төөргөөр энэ ертөнцөд ирдэг. Гэлээ ч хүмүүс одоог хүртэл Бурханд итгэж, Бурханыг шүтэн мөргөхийг хүсдэггүй, Бүтээгчийн эрх мэдлийг өөрийн биеэр мэдрэх энэ боломжийг үнэлдэггүй бөгөөд хөрөнгө мөнгө, алдар нэр, хайр дурлалын төлөө амьдрахаас өөр зүйл мэддэггүй. Тэд аль хэдийн зурагдсан төөргөөс зайлсхийх гэж ухаан жолоогүй ийш тийш гүйлдэж байгаа ч дээрх зүйлсийг эрэлхийлснээр хүмүүс яг юу олж авч чадах юм бэ? Үхэх цаг нь ирэх үед тэднийг хайртай хүмүүс, алдар нэр, эд хөрөнгө гэх зүйлсийн аль нь аварч чадах юм бэ? Ажлын анд нөхрийн минь үхэл энэ баримтыг бэлхнээ харуулсан бус уу? Өнгөрсөн хугацаанд би эрж хайж байсан зүйлээ бодоход үүнээс ямар ч ялгаагүй байна бус уу? Би ердөө л илүү их мөнгө олж, хүмүүст хүндлэгдэн, улмаар ядуурлаас гарахын тулд гадаадад ажиллахаар ирж, бохир заваан, хүнд хэцүү, аюултай гээд ямар ч хамаагүй ажлыг хийж байсан юм. Хүнд зовлон амссан хэдий ч амьдралын энэ хэв маягаа өөрчилье гэж хэзээ ч бодож байгаагүй билээ. Би зүгээр л нэг замаараа уруудсаар байлаа. Бурхан байдаг эсэх, хүний хувь заяа Бурханы гарт байдаг эсэхийг би зүрх сэтгэлдээ мэддэггүй, мөн хувь заяагаа өөрчлөхийн тулд өөрийн шаргуу зүтгэлд л найддаг байв. Амьдралд минь зориулсан Бурханы зохицуулалт, зохион байгуулалтаас би зугтахыг оролдож байжээ. Би сүйрлийн замаар явж байгаагүй гэж үү? Бурханы аврал байгаагүй, Бурхан намайг харж хандаж, хамгаалж байгаагүй бол өчүүхэн амийг минь Сатан аль хэдийн авах байсан юм. Тэгвэл амьдрал минь яаж одоогийнх шиг сэтгэл дүүрэн, утга учиртай болох билээ?



---

Амьдралын утга учир бол эд хөрөнгө, алдар нэрийг эрэлхийлэх, бусдын дээр гарч, бусдаар хүндлүүлэхийг эрэлхийлэх явдал бус, харин Бурханы дэргэд очиж, Түүний авралыг хүлээн авахад оршдог гэдгийг би тэр мөчид эцэст нь олж харсан юм. Бурханыг шүтэн мөргөж, Бурханд захирагдсанаар л бид Сатаны хор хөнөөлөөс ангижирч, аз жаргалтай, амар амгалан амьдарч чадна. Энэ тухай бодох тусам сэтгэл минь улам их хөдөлж байна. Бурханд итгэж чаддаг маань миний хувьд онцгой нигүүлсэл гэдгийг би ухаарсан билээ. Намайг аварсанд нь Төгс Хүчит Бурханд талархъя!

## **35. Би жинхэнэ аз жаргалыг оллоо**

Жан Хуа, Камбож

Би жирийн нэг тариачны гэр бүлд төрсөн юм. Манайх чинээлэг айл биш байсан хэдий ч аав, ээж хоёр бие биеэ хайрлаж, надад маш сайн ханддаг байв—манай гэр бүлийг аз жаргалтай, ерөөгдсөн амьдралтай байсан гэж хэлж болох нь гарцаагүй. Өсөж том болсныхоо дараа би өөртөө ингэж хэлэв: Би надад сайн хандах нөхөртэй болж, жаргалтай сайхан гэр бүлийг бүтээх ёстой. Энэ бол хамгийн чухал зүйл. Би эд баялаг эрэлхийлэхгүй—нөхөртэйгээ хайрын харилцаатай байх, гэр бүлийн амар тайван амьдрал л надад хэрэгтэй.

Бид хоёрыг хоёуланг нь таньдаг хүнээр дамжуулан би нөхөртэйгөө танилцсан юм. Нэлээд намхан болохоор нь анх би түүнд дургүй байсан ч аав, ээж маань түүнд нааштай хандаж, түүнийг сайхан сэтгэлтэй, надад сайн хандана гэж хэлсэн билээ. Нөхөр маань хүмүүст чин сэтгэлээсээ хандахыг би хараад гэр бүлдээ сайн хандах хүн шиг санагдав. Би “Тэр намхандуу байгаа нь зүгээр ээ. Надад сайн хандах юм бол болно” гэж бодлоо. Ингээд би хурим хийхийг зөвшөөрч, 1989 онд бид гэрлэв. Гэрлэсний дараа нөхөр минь надад маш зөөлөн хандаж, намайг сайн халамжилдаг байлаа. Нөхөрт гарсны дараа миний амьдрал жаргалтай, элбэг дэлбэг байсан. Би ч бас нөхрөө үнэн сэтгэлээсээ халамжилж, сэтгэлдээ түүнийг үргэлж боддог байв. Хоёр охиноо төрсний дараа нөхрийнхөө санааг зовоолгүй ажилд нь явуулахын тулд би гэртээ сууж, гэр орноо арчилж тордлоо. Хожим нь хоёр хүүхэд маань сургуульд сурахаар хотоосоо явсан тул сурах хугацаанд нь хүүхдүүдтэйгээ хамт байхаар ойролцоох байрыг нь түрээслэв. Би ер нь ямар нэг юмыг шийдэж чадах л юм бол том ч бай, жижиг ч бай гэр бүлийн асуудлаар нөхрийгөө хэзээ ч зовоодоггүй байлаа. Заримдаа юмс хэцүү, залхмаар байсан ч нөхөр, эхнэрийн харилцаа маань харилцан хайр, халамж, анхаарлаар дүүрэн байсан бөгөөд бид амар тайван амьдарч байсан юм. Үнэхээр аз жаргалтай амьдарч байна гэж надад санагдаж байлаа.

---

Тухайн үед нөхрийн олдог мөнгө бидний өдөр тутмын зардалд дөнгөж хүрэлцдэг байв. Амьдрал маань жаахан хэцүү байсан ч би нөхөртөө хэзээ ч гомдоллож байсангүй. Эхнэр нөхөр хоёр амьдралын баяр баясгалан, уй гашууг хуваалцах ёстой гэж боддог байлаа. Гэвч дараа нь нөхрийн маань ажлын газрын санхүүгийн нөхцөл байдал хүндэрч, сар бүр авдаг байсан цалингийнхаа хагасыг л авахад хүрсэн бөгөөд хүүхдүүдийнхээ сургалтын төлбөрийг төлөхөд бэрх боллоо. Нөхрийнхөө үүрсэн дарамтыг хуваалцаж туслахын тулд би хамаатан саднаасаа байн байн мөнгө зээлж эхлэв. “Энэ бэрхшээл ердөө түр зуурынх. Аяндаа байдал сайжирна” гэж би бодож байсан юм. Маш удаан хугацаанд мөнгө зээлсээр байж таарсан тул бидний өр улам өсөж, бид хоёр хоёулаа тун их хямарлаа. 2013 онд нөхөрт маань гадагшаа явж мөнгө олох санаа төрөв. Надад хэлэхэд нь би нөхрөө явуулах дургүй байсан ч “Хэрэв нөхөр маань 2-3 жил гадагшаа явж, мөнгө олбол бид өрөө төлж, гэр бүлийнхээ нөхцөл байдлыг сайжруулж чадна. Дээр нь бас хүүхдүүд маань өсөж байна, бид тэднийг сайхан амьдруулмаар байна” гэж бодсон юм. Гэр бүлийнхээ төлөө би, гадагшаа явж ажиллахыг нөхөртөө зөвшөөрлөө.

Миний нөхөр Камбож явж, тэндээ гурван жил болсон бөгөөд энэ хугацаанд би гэртээ үлдэж, хүүхдүүд болон хөгшин эцэг эхээ асарч байв. Эхэндээ нөхөр маань гэр лүүгээ байнга утасдаж, гэр бүлдээ анхаарал халамж тавьдгаа харуулж байлаа. Бас гэр лүүгээ мөнгө илгээдэг байв. Гэвч цаг хугацаа өнгөрөхийн хэрээр утасдах нь улам бүр цөөрсөөр, эцэст нь байдал бүр дордож, удаан хугацаанд утасддаггүй, мөнгө явуулдаггүй боллоо. Түүнд ямар нэг юм тохиолдсон байх гэж би санаа зовсон тул нөхөртэйгээ уулзахаар охидоо авч явав. Камбожид очоод нөхөр маань аюулгүй, эрүүл саруул байхыг хараад тун их санаа амарлаа. Камбожид анх удаа ирсэн болохоор би нөхөртэйгээ хамт байх зуураа тэнд охидтойгоо хэсэг байж байгаад дараа нь Хятад руу буцъя гэж төлөвлөж байв. Гэвч нөхөртэйгээ хамт гэрээс гарч явах бүрд нөхрийн маань танилууд намайг сонин харцаар харж байгааг би олж мэдлээ. Хэлний бэрхшээлээс болоод би тэдний юу хэлж байгааг ойлгодоггүй байсан юм. Нэг долоо хоногийн дараа нөхөр маань танихгүй хүүхэд тэврээд надтай уулзахаар гэнэт орж ирлээ. Тэр хүүхдэд “Алив, эгчтэйгээ мэндэл дээ” гэж хэлэв. Тухайн үед би юу болоод байгааг мэдэхгүй байсан учраас зүгээр л гөлрөн ширтэж байлаа. Нөхрөөсөө асуугаад би Камбожид уулзсан эмэгтэйгээс нь гарсан хүүхэд гэдгийг олж мэдсэн юм. Би маш их уурласандаа ганц ч үг хэлж чадсангүй бөгөөд дүйнгэтэн, яахаа ч мэдэхгүй байсан юм. Нөхрөө зэмлэхээр оролдоход тэрээр: “Энэ чинь тун хэвийн зүйл. Энд олон хүн ингэдэг!” гэж тун тайван хариулсан юм. Ингэж хэлэхийг нь сонсоод би маш их уурлаж, бүх бие минь чичирч эхэллээ. Намайг маш олон жил хайрласан нөхөр минь ийм хүйтэн хөндий, хэрцгий зүйл хэлж, ийм увайгүй юм хийж чадна гэж хэзээ ч бодож байсангүй. Уурлаж хилэгнэсэндээ би түүнийг хоёр ч удаа чанга алгадав. Нөхрийн минь

---

урвалт цэлмэг тэнгэрээс аянга буух мэт болж, би энэ баримтыг хүлээн зөвшөөрч ер чадахгүй байлаа. Тэгээд шалан дээр сууж, гашуунаар уйлав. “Яагаад тэр ийм юм хийв ээ? Миний мэддэг байсан нөхөр хаачив аа? Тэр надад үүрд хайрлах амлалт өгсөн—тэр хайр, энхрийлэл, халамж бүгд хуурамч байсан гэж үү? Би энэ гэр бүлд бүхнээ зориулсан. Нөхрөөсөө би мөнгө, сайхан зүйлс хэзээ ч гуйж байгаагүй. Гэтэл одоо...” гэж би өөрөөсөө ахин дахин асууж байв. Надад асар их доромжлогдсон мэт санагдаж, сэтгэлийнхээ гүнд шархалж, хилсэдсэн мэт санагдаж байлаа. Бас цааш амьдрах аргагүй болсон мэт санагдаж байсан юм.

Дараагийн хэдэн өдөр нь би нүүрээ байнга нулимсаараа угааж байлаа. Би тэр эмэгтэйг, тэр хүүхдийг үзэн ядаж байв. Би нөхөртөө салахыг хүсэж байгаагаа, бас охидоо авч Хятад руу буцан, мөн энэ гэр бүл гээчийг орхино гэдгээ хэлсэн юм. Гайхмаар нь, нөхөр минь надаас салахыг зөвшөөрөөгүй төдийгүй тэр эмэгтэйг ч орхихыг хүсээгүй юм. Нөхөр маань өөр эмэгтэйтэй холбогдож, түүнээсээ хүүхэдтэй болсныг манай гэр бүлийнхний зарим нь мэдэж байсан боловч тэр бүх хугацаанд надаас нууж байсныг би дараа нь олж мэдэв. Тэгээд бүр амьдралынхаа нэр хүндийг ч дээрэмдүүлчихсэн мэт санагдлаа. Би бүх зүрх сэтгэлээ гэр бүлдээ зориулсан ба энэ бүхэнд минь урвалт, хууралтаар хариу барина гэж хэзээ ч төсөөлж байсангүй. Миний зүрх сэтгэл шархаллаа. Энэхүү хүнд цохилт хангалттай шаналгаатай байсан боловч нөхрийн маань танилуудын намайг харах тэр хачин харцыг би үнэхээр хүлээн зөвшөөрч чадахгүй байв; тэд бүр миний талаар хов жив ярьж байлаа. Эхлээд нөхөр минь надаас урваж, тэр эмэгтэй гэр бүлийг минь сүйтгэсэн боловч тэр үед бусдын нүдээр бол би гуравдагч этгээд байв. Тухайн үед мэдэрч байсан шаналлаа би дүрслэн хэлж чадахгүй нь. Өдөр болгон нэг жил мэт удаан өнгөрч, би арав гаруй килограмм жин хассан юм.

Бүрмөсөн арга барагдаад байх яг тэр үед Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн аврал над дээр ирлээ. Миний хөрш Линь Тин юу тохиолдсон талаар олж сонсоод над дээр ирж, сайн мэдээг надтай хуваалцав. Тэрээр: “Итгэлтэй бай, Бурхан чамд тусалж чадна” гэж хэлсэн юм. Гэвч, бурхангүй үзэлт боловсролтойгоор өссөн над шиг хүн яаж гэнэтхэн итгэлтэй болж чадах билээ дээ! Би түүнд огт хариу хэлсэнгүй. Дараа нь Линь Тин дахин надтай ярихаар ирээд, “Бурханы үгийг унш. Бурхан л чамайг зовлонгоос чинь аварч чадна...” гэж хэлэв. Тэр үнэхээр чин сэтгэлээсээ хэлсэн тул миний сэтгэл бага зэрэг хөдөлж, хоёр дахь удаагаа түүнд татгалзахад ичмээр санагдсан тул “Үг нь махбодоор илэрсэн” номыг хүлээн авлаа. Энэ номыг нээгээд би дараах хэсгийг харсан юм: “**Төгс Хүчитийн амийн хангалтаас холдсон хүмүүс оршин тогтнолын зорилгыг мэддэггүй хэдий боловч үхлээс эмээдэг. Тэд тусламж, дэмжлэггүй байдаг атлаа нүдээ аних дургүй хэвээр бөгөөд энэ дэлхий дээр өөрийн сүнсийг мэдэрдэггүй махан биед**

---

өөдгүйгээр оршин тогтнохын тулд өөрсдийгөө хатамжилдаг. Чи ийм маягаар итгэл найдваргүй, тэр ч тийм маягаар зорилгогүй амьдардаг. Зовлонгийнхоо дунд ёолон, Өөрийнх нь ирэхийг цөхрөнгөө баран хүсэн хүлээж байгаа хүмүүсийг үлгэр домгийн Ариун Нэгэн л аварна... Эцэж ядран, энэ дэлхийн зэврүүн хоосролын заримыг мэдэрч эхлэх үедээ бүү төөрөлд, бүү уйл. Төгс Хүчит Бурхан, Харгалзагч, чамайг хэдийд ч ирсэн тэврэн авна” (Үг нь махбодоор илэрсэн номын “Төгс Хүчитийн санаа алдалт”). Бурханы чин сэтгэлийн үгийг унших үедээ би чангаар уйлж, Бурхан хүн төрөлхтнийг үнэхээр ойлгодог юм байна гэж санагдав. Нөхрийнхөө урвалттай тулгараад би үхэхийг хүсэж байсан ч эр зориг дутаж, бас тийм маягаар үхэхийг хүсээгүй юм. Би амьдралынхаа зүг чиг, зорилгыг алдаж, биеэ барих талаар огт анхаарахгүй байх хэмжээнд хүрсэн байв. Бурханы үгийг унших үед амьдралд найдвар байгааг олж харах шиг болсон бөгөөд зүрх сэтгэл минь амар амгаланг олсон юм. Нөхөр минь надаас урвасан ч би Бурханд найдаж болно. Би ганцаараа биш байв. Төгс Хүчит Бурхан: “Энэ дэлхийн зэврүүн хоосролын заримыг мэдэрч эхлэх үедээ бүү төөрөлд, бүү уйл. Төгс Хүчит Бурхан, Харгалзагч, чамайг хэдийд ч ирсэн тэврэн авна” гэж хэлсэн. Намайг анхаарч халамжлах хэн ч байхгүй, шархалсан нэгэн байсан тулд би Бурханд найдахыг хүсэх болов. Надад Бурханы тэврэлт хэрэгтэй байлаа. Өдөр болгон маш хэцүү, ядаргаатай байсан бөгөөд би тийм маягаар үргэлжлүүлэхийг хүссэнгүй. Бурхан хүн төрөлхтнийг маш сайн ойлгодог болохоор энэ шаналлаас намайг ангижруулж гарцаагүй чадна гэж би бодлоо. Иймээс би Линь Тинтэй хамт Бурханы үгийг уншиж, Бурханыг магтсан магтан дуу дуулж сурч эхлэв. Линь Тин надад: “Хүнд хэцүү үеийг туулахдаа Бурханд залбирч, Бурханы үгийг унш. Шархалсан зүрх сэтгэлийг маань Бурхан тайтгаруулж чадна” гэж хэлсэн юм. Би түүний хэлснийг л хийлээ. Төгс Хүчит Бурханы Чуулганы ах, эгч нарын хийсэн клип болон магтан дууны видеог үзэх үед зүрх сэтгэлд минь аз жаргал буцлав. Ялангуяа “Канааны нутаг дахь баяр баясгалан” гэх видеог үзэхэд миний зүрх сэтгэл ах, эгч нартай хамт дуулж, бүжиглэж байгаа мэт санагдсан юм. Зүрх сэтгэл дэх хямрал, шаналал аажмаар үгүй болж, эцэст нь нүүрэнд минь инээмсэглэл тодрох болов. Энэ нь үнэхээр миний хүсэж байсан гэр бүл мөн гэдгийг, бас ах эгч нартай хамт байснаар л жинхэнэ аз жаргалыг олж чадна гэдгийг би гэнэт мэдэрлээ. Иймээс би Төгс Хүчит Бурханы Чуулганд нэгдэж, ах, эгч нартайгаа хамт чуулганы амьдралаар амьдарч эхлэв.

Дараа нь би Бурханы ийм үгийг уншив: “Сатан нийгмийн хандлагаар дамжуулан хүнийг завхруулдаг. ‘Нийгмийн хандлага’ нь олон зүйлийг агуулдаг. Зарим хүн: ‘Энэ нь сүүлийн үеийн загвар, оо энгэсэг, үс засалт, тансаг хоол хүнс гэсэн үг үү?’ гэдэг. Эдгээр зүйлийг нийгмийн хандлага гэж авч үздэг үү? Тэдгээр нь нийгмийн хандлагын нэг хэсгийг бүрдүүлдэг боловч тэдгээрийн талаар бид энд ярихгүй. Бид

---

зөвхөн нийгмийн хандлагын хүмүүст авчирдаг үзэл санаа, хүмүүсийн энэ дэлхий дээр биеэ авч явах байдалд хүргэдэг арга зам болон хүмүүст авчирдаг амьдралын зорилго, амьдралыг үзэх үзлийн тухай ярилцахыг л хүсэж байна. Эдгээр нь маш чухал; тэд хүний сэтгэл санааны байдлыг хянаж, үүнд нөлөөлдөг. Эдгээр чиг хандлага ар араасаа гарч ирдэг бөгөөд хүн төрөлхтнийг тасралтгүй доройтуулдаг ёрын муу нөлөө үзүүлэн, мөс чанар, хүн чанар, эрүүл ухаанаа алдахад тэднийг хүргэж, ёс суртахуун, жудгийг нь улам бүр дордуулж, дийлэнх хүмүүс одоо ёс жудаггүй, хүн чанаргүй болсон, тэдэнд эрүүл ухаан бүү хэл, ямар ч мөс чанар байдаггүй гэж хэлж болохуйц хэмжээнд хүрсэн... Шинэ чиг хандлага дэлхий даяар сэвэлзэх үед магадгүй ердөө цөөн тооны хүмүүс л эн тэргүүнд байж, шинэ хандлагыг тогтоогчид болдог. Тэд шинэ зүйл хийж эхлээд, дараа нь зарим нэг үзэл санаа, зарим нэг үзэл бодлыг хүлээн зөвшөөрдөг. Гэвч хүмүүсийн дийлэнх нь нэг л мэдэхэд ийм төрлийн чиг хандлагаар тасралтгүй халдварлагдаж, үүнд уусаж, сэтгэл татагдан, өөрийн мэдэлгүйгээр, аяндаа бүгд үүнийг хүлээн зөвшөөрч, үүнд автаж, хяналтад нь орохдоо тулдаг. Ийм чиг хандлага нь ээлж дараалан, эрүүл саруул бие, оюун ухаантай биш, үнэн гэж юу болохыг мэддэггүй, эерэг сөрөг зүйлсийг огт ялгаж чаддаггүй хүмүүсээр энэ чиг хандлага, Сатанаас ирдэг амьдралыг үзэх үзэл, үнэт зүйлсийг баяртайяа хүлээн зөвшөөрүүлдэг. Тэд амьдралд хандах талаар Сатаны хэлсэн зүйл, Сатаны ‘хайрласан’ амьдрах арга замыг хүлээн зөвшөөрдөг бөгөөд тэдэнд эсэргүүцэх хүч чадал ч, чадвар ч байдаггүй, эсэргүүцэх ухамсар бүр ч байдаггүй” (Үг нь махбодоор илэрсэн номын “Цор ганц Бурхан Өөрөө VI”). Нөхөр минь надад: “Энэ чинь тун хэвийн зүйл. Энд олон хүн ингэдэг!” гэж хэлснийг Бурханы эдгээр үг сануулав. Нөхрийн минь бодол, үзэл санаа, нийгмийн муу чиг хандлага хүмүүсийг хэрхэн залгиж, замыг нь алдуулдаг талаар Бурханы үгэнд илчлэгдсэн зүйлийн бодит жишээ биш гэж үү? Миний нөхөр нутгаасаа явахаас өмнө гэр бүлээ халамжилж, намайг болон үр хүүхдүүдээ халамжилж чаддаг байсан. Гэвч, ажилд орохоор гэрээсээ явсны дараах гуравхан жилд нийгмийн муу чиг хандлагыг бүрэн дагаж, хамгийн ойр дотно байсан хүмүүсээсээ урважээ. Өнөөдрийн нийгмийг бодож үзэхэд, нууц амраг байх нь ичгүүртэй зүйл гэж олон эмэгтэй боддоггүй—харин ч өөрсдөд нь мэдлэг чадвар байгаа гэсэн үг гэж боддогийг би ухаарсан юм. “Тэрт буй улаан дарцаг дээр байдаг байхад хаа сайгүй байдаг өнгөлөг дарцгууд салхинд дэрвэлздэг” гэх мэт муу сэтгэлгээгээр олон хүн хорлогдсоор иржээ. Иймэрхүү санаа тэднийг ичгүүр сонжуургүй харилцаанд ороход хүргэдэг байна. Тэд үүнийг ичгүүртэй гэж боддоггүй, харин ч бахархаж болох зүйл гэж боддог. Миний нөхөр надаас салахыг хүсээгүй ч тэр эмэгтэйг орхихыг бас хүсээгүй. Тэрээр иймэрхүү муу ёрын сэтгэлгээ, үзэл бодлын хяналтад автсан юм биш үү? Төгс Хүчит Бурханы үгийг уншсанаар би эцэст нь үнэндээ бол хүн бүр хохирогч гэдгийг ойлгож чадсан юм. Бидэнд Сатаны

---

суулгасан муу сэтгэлгээнээс болж хүн бүр мэхлэгджээ. Бид ямар ч ёс суртахуунгүй, ичгүүргүй болтлоо завхарсны цорын ганц шалтгаан энэ юм. “Хүмүүс хувиа хичээсэн хүслээ л биелүүлснээр юу олж авдаг юм бэ? Тэд үнэндээ аз жаргалыг олж авч чаддаг гэж үү?” хэмээн би гайхширлаа. Миний харж байгаагаар, миний нөхөр, тэр эмэгтэй хоёр надаас илүү аз жаргалтай байсан гэж би бодохгүй байна. Дээр нь нэмээд, тэр хүүхэд ч бас гэм зэмгүй хохирогч. Манай гэр бүлд учирсан зовлон Сатаны завхрал, хор хөнөөлийн л үр дагавар биш гэж үү? Өөрийнхөө тухай бодоод үзэхэд, хэрэв Бурханы аврал над дээр ирээгүй бол би ч бас нийгмийн муу чиг хандлагаас болж дотроосоо илжрэх байжээ. Нөхөр минь өөр эмэгтэйтэй болсон юм чинь би ч бас адилхан зүйл хийж, намайг гэх өөр олон эрчүүдээс хэн нэгнийг хайж болно гэж би бодсон. Сатанд залгиулах гэж байхад минь намайг аварсных нь төлөө Бурханд талархаж байна. Бурхан намайг Өөрийнхөө өмнө ирүүлж, хамгаалалтыг нь хүлээн авахыг зөвшөөрсөн. Тэгээгүй бол би энэ нийгмийн ёрын муу чиг хандлагад сүйрэх байлаа.

Би дараа нь Бурханы эдгээр үгийг уншив: **“Бурханы мөн чанар ариун учраас зөвхөн Бурханаар л дамжуулан чи амьдралын гэрэл гэгээтэй, зөв замаар алхаж чадна; зөвхөн Бурханаар л дамжуулан амьдралын утга учрыг мэдэж чадна; Бурханаар л дамжуулан жинхэнэ хүн чанарыг амьдран харуулж, үнэнийг эзэмшиж, мэдэж чадна. Бурханаар л дамжуулан чи үнэнээс амийг олж авч чадна. Бурхан Өөрөө л муугаас зайлахад чинь чамд тусалж, Сатаны хор хөнөөл, хяналтаас чамайг ангижруулж чадна. Чамайг дахин зовоохгүйн тулд Бурханаас өөр хэн ч, юу ч чамайг зовлонгийн далайгаас аварч чадахгүй. Энэ нь Бурханы мөн чанараар тодорхойлогддог. Зөвхөн Бурхан Өөрөө л чамайг амь бие хайрлалгүй авардаг; эцсийн эцэст Бурхан л ирээдүй, хувь заяа, амьдралыг чинь хариуцдаг бөгөөд бүх зүйлийг чиний төлөө зохицуулдаг. Энэ нь бүтээгдсэн, эсвэл бүтээгдээгүй ямар ч зүйлийн хүрч чадахгүй зүйл юм. Учир нь бүтээгдсэн, эсвэл бүтээгдээгүй юу ч Бурханых шиг мөн чанарыг эзэмшдэггүй, иймээс ямар ч хүн, эсвэл зүйлд чамайг аврах, удирдан хөглөх чадвар байхгүй. Энэ бол Бурханы мөн чанарын хүнд өгдөг чухал ач холбогдол юм”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Цор ганц Бурхан Өөрөө VI”). Бурханы үгээс би, хүн төрөлхтнийг гэх Түүний хайр, халамжийг мэдэрч чадсан бөгөөд биднийг завхруулж, хорлохын тулд Сатан янз бүрийн нийгмийн чиг хандлагыг ашиглаж болох боловч Бурхан биднийг аврахаа хэзээ ч болиогүй гэдгийг ч бас ойлгож авсан билээ. Биднийг Өөрийнхөө өмнө аваачиж, авралаа хүртээх гэсэндээ Бурхан үргэлж чимээгүйхэн биднийг хамгаалж, төрөл бүрийн нөхцөл байдлыг зохицуулж байдаг. Нөхрийнхөө урвалтын дараа гомдол, шаналал зовлонд амьдарч байснаа эргээд бодоход, Бурханы халамж, өршөөл байгаагүй бол, мөн Бурханы үг намайг тайтгаруулж, зоригжуулан

---

хүмүүсийг завхруулахдаа Сатаны ашигладаг заль мэх, зальхай явуулгыг нэвт харуулж, Сатаны ёрын муу чиг хандлага биднийг хэрхэн хордуулдгийг тодорхой харуулаагүй бол гомдол, шаналалтай ийм байдалд үүрд амьдарсаар байх байсан гэдгээ би мэдэж байв. Би үүнээс өөрийгөө ангижруулж хэзээ ч чадахгүй байх байлаа. Тэгээд бүр зүрх сэтгэл дэх үзэн ядалтаа үгүй болгохын тулд өөрийгөө бүрмөсөн сүйрүүлэх байжээ. Энэ туршлагааар дамжуулан би Бурханы хайрыг туулаад зогсохгүй, бас Бурхан л хүн төрөлхтнийг Сатаны завхрал, хор хөнөөлөөс аварч чадна, Бурхан л биднийг амийн гэрэлтэй зам руу хөтөлж чадна гэдгийг үнэхээр мэдрэх болсон юм. Тэрхүү шаналлын ангалаас намайг аварсных нь төлөө Төгс Хүчит Бурханд талархъя!

Өнөө үед би Бурханы үгийг улам их уншиж байгаа болохоор үнэнийг бага зэрэг ойлгож авсан ба ихээхэн асуудлыг нэвт харж чаддаг. Би нөхрөө юм уу тэр эмэгтэйг үзэн ядахаа больсон. Тэд хүсэж буй амьдралаа сонгох эрхтэй. Хамаатан садан, найз нөхөдтэйгээ би тайван, төлөв томоотой байж чаддаг. Бид бүгдийг Сатан завхруулсан, бүгд түүний хохирогч учраас би гэр бүлийнхнээ буруутгахаа больсон. Одоо би ах, эгч нартайгаа хамт байнга цуглаанд оролцож, Бурханы үгийг уншиж, нөхөрлөж, хувийн туршлагаа хуваалцдаг. Би өдөр бүр Бурханы үгийн ашиг тусыг хүртдэг. Тэгээд зүрх сэтгэлдээ амар амгалан, баяр хөөртэй байж, амьдрал минь найдвараар дүүрэн байдаг. Амьдралын зөв зам руу намайг замчилж, жинхэнэ гэрийг надад өгсөнд нь Төгс Хүчит Бурханд талархаж байна. Эндээс би жинхэнэ аз жаргалыг олсон бөгөөд Бурханыг үүрд дагахыг хүсэж байна!

## **36. Эцсийн өдрүүдэд Бурханы авралыг хүлээн зөвшөөрсний дараа бид шинэ амьдралыг олж авдаг**

Жуй Чиу, Малайз

Би гоо сайханч, харин манай нөхөр фермер юм. Бид хоёр Малайзад хайраа олох гэж байгаа эмэгтэйчүүдэд зориулсан уламжлалт үйл ажиллагаа болох жүрж шидэх арга хэмжээн дээр танилцсан билээ. Хуримыг маань нэг жилийн дараа пастор гэрчилж, чуулганд зохион байгуулсан юм. Гэрлэлтийн маань төлөөх пасторын залбиралд би маш их сэтгэл хөдөлсөн бөгөөд хэдийгээр шашин шүтлэггүй байсан ч “Энэ эрэгтэй намайг эргэж буцалтгүй нандигнаж, харж халамжлан, насан туршийн минь хань байх болтугай” гэж Бурханаас чимээгүйхэн гуйлаа.

Гэр бүлийн амьдралаа эхэлсний дараа нөхөр бид хоёрын хооронд зөрчилдөөн ар араасаа гарах болов. Нөхөр маань өглөө бүр ногоо зарахаар үүрийн 4 цагт гэрээс гараад

---

оройн 7 цаг өнгөртөл эргэж ирдэггүй, харин миний ажил оройн 10 цаг өнгөртөл тардаггүй байлаа. Бид хамтдаа маш бага цагийг өнгөрүүлдэг байв. Би эцэж цуцсан байдалтай сажилсаар гэртээ ирээд нөхрийнхөө анхаарал, халамж, ойлголтыг хүртэнэ гэж маш их найддаг байсан юм. Ажил маань ямаршуу байсан, би аз жаргалтай байсан эсэхийг нөхөр маань асуугаасай гэж хүсдэг байв. Гэвч харамсалтай нь намайг ажлаасаа харьж ирэх бүрийд нөхөр маань телевиз үздэггүй юм аа гэхэд утсаа оролдон, заримдаа бүр надтай мэндэлдэггүй байлаа. Намайг зүгээр л байхгүй мэт аягладаг байв. Үүнээс үүдэн би үнэхээр их гуньж гутарч, яваандаа нөхөртөө сэтгэл дундуур байх болсон юм.

Нэг удаа би үйлчлүүлэгчтэйгээ санал зөрөлдсөн бөгөөд үнэхээр унтууцаж, хэлмэгдсэн мэт санагдаж байв. Гэртээ харьсныхаа дараа, нөхөр маань намайг тайвшруулна гэж найдсандаа энэ талаар сэтгэлээ уудалсан боловч гайхмаар нь манай нөхөр утсаараа тоглож байхдаа намайг дөнгөн данган сонссон болоод, бараг анхаарал тавьсангүй. Тэгээд тэрээр толгой гудайлган, шууд утсаа үргэлжлүүлэн оролдов. Намайг огт тоохгүй байгаад нь би үнэхээр их гонсойсон болохоор нөхөр лүүгээ дайрч очоод, “Чи чулуунаас бүтсэн хүн үү? Ярилцаж ч чадахгүй нь уу? Чи хүнд анхаарал тавьдаг юм уу?” гэж хашхичлаа. Намайг ийм ууртай байгааг хараад нөхөр маань хариу хэлсэнгүй. Чимээгүй байх тусам нь миний уур улам буцалсан юм. Нөхрөөрөө үг хэлүүлэхээр эргэлт буцалтгүй шийдэн, үглэсээр л байлаа. Гэнэт нөхөр маань над руу: “Одоо боллоо юм биш үү?” гэж хашхирав. Би үүнд нь улам ч их уурлаж, бүр их хэлмэгдсэн мэт санагдсан тул нөхөртөө учирлахаар оролдсоор байлаа. Эцэст нь нөхөр маань ам нээхээс бүр татгалзсан тул бид хоёрын хэрүүл ингэсгээд дууссан юм. Өөр нэг удаад, нөхөр маань миний сэтгэлийг засах гэж хичээнэ гэж бодон, ажил дээр сэтгэл дундуур байсан зүйлийнхээ талаар нөхөртөө гомдоллолтол нөхөр маань харин “Овоо босгоогүй бол шаазгай юунд суух вэ. Чи бусад хүний асуудлыг л харах юм—өөрийгөө нэг харвал яасан юм бэ?” гэж гэнэт мөс шиг хүйтнээр хариуллаа. Би тэр дороо багтартлаа уурлаж, бодож санаж байгаагаа өөрийн эрхгүй түүнд хэлэв. Тэгээд хорсолд автан, “Энэ ямар гээч хүн бэ? Яагаад ийм хүнтэй гэрлэхэв ээ? Миний сэтгэлийг ерөөсөө бодохгүй юм—намайг тайтгаруулах ганц ч үг хэлэхгүй юм!” гэж бодлоо. Тэр цагаас хойш би ажил дээр юу болсон талаар нөхөртөө ярихаа бараг бүрмөсөн больсон юм. Дараа нь нэг удаа нөхөр маань миний ажлын талаар асуух гэж үзсэн ч би нөхрөө огт тоомооргүй санагдсан билээ. Аажмаар нөхөр маань надаас юуны ч талаар асуухаа болилоо. Бидний ярилцдаг нийтлэг сэдэв улам бүр цөөрч, бухимдмаар зүйл гарах болгонд би зүгээр л найз дээрээ очиж, сэтгэлээ уудалдаг болсон юм. Заримдаа би ярьж хөөрсөөр оройтож, шөнө дунд өнгөртөл гэртээ харьдаггүй байв. Намайг маш орой гэртээ ирлээ ч гэсэн нөхөр маань тоодоггүй мэт байсан бөгөөд гэрээ зочид буудал мэт үзлээ л гэж хэлдэг байлаа. Би үнэхээр гутарч, нөхөртөө улам сэтгэл ханамжгүй болсноос үүдэн бид хоёр тун ойр ойрхон



---

хэрэлдэж, маргалдах болсон юм. Бид хоёр хоёулаа зовж байлаа. Би ийм маягаар үргэлжлүүлэхийг хүсээгүй тул боломж олдвол нөхөртэйгөө сайн ярилцахаар шийдэв.

Нэг өдөр оройн хоолны дараа би нөхрөөсөө: “Чи намайг үнэхээр тэсвэрлэж ч чаддаггүй юм аа даа? Яагаад намайг огт хайхардаггүй юм бэ? Надад асуудал байвал зүгээр шууд хэлчих” гэж асуулаа. Хариуд нь ганц ч үг хэлэхгүй болохоор би нөхрөө шалсаар л байв. Гэнэт нөхөр маань ууртайгаар, “Ийм олон долоон юм асуухаа болиоч! Чиний бүх зүйл асуудалтай—би үүнээс чинь залхаж байна!” гэж хашхичлаа. Нөхрөөсөө ийм хариулт сонсоод уур минь буцалж, бид хоёр дахин маргаж, бие бие рүүгээ дайрч эхэллээ. Хэсэг хугацаанд ингэсний эцэст нөхөр минь намайг түлхчихэв. Би гишгэл алдан буйдан руу унасан юм. Нөхөр минь миний өмнөөс гар далайж байхыг харах туйлын сэтгэл шимшрэм байлаа. “Маш няхуур сонгосон нөхөр минь энэ гэж үү? Маш их итгэл найдлага өвөрлөж явсан гэрлэлт минь энэ гэж үү? Тэр надад яаж ингэж хандаж чадав аа?” гэж бодогдов. Тэр үеэс хойш би нөхөртөө ямар ч найдлага тавихаа болилоо.

2016 оны 4-р сард санаандгүй тохиолдлоор нэг эгч Эзэн Есүсийн сайн мэдээг надтай хуваалцсан юм. Эзэн биднийг хайрладаг бөгөөд биднийг аврахын тулд загалмайд цовдлогдсон гэдгийг эгч хэллээ. Эзэний хайранд сэтгэл минь үнэхээр хөдөлсөн тул сайн мэдээг нь хүлээн зөвшөөрсөн юм. Тэгээд дараа нь гэрлэлтэд маань гарсан асуудлын талаар пастортоо ярихад, “Бид эхлээд өөрсдийгөө өөрчлөхгүй бол өөр хэнийг ч өөрчилж чадахгүй. Бид Эзэн Есүсийн жишээг дагаж, бусдад хүлээцтэй, тэвчээртэй хандах ёстой” гэж пастор маань надад хэллээ. Иймээс би өөрийгөө өөрчлөхөөр оролдож эхлэв. Ажлаа тармагцаа гэртээ харьж, гэр орноо цэвэрлэдэг болсон бөгөөд заримдаа нөхөр маань намайг үл тоомсорлоход уурлах шахах үедээ би Эзэнд залбирч, надад хүлцэл, тэвчээр хайрлахыг Түүнээс гуйдаг байлаа. Заримдаа би өөрийгөө хянаж чадалгүй нөхөртэйгөө хэрэлдээд, дараа нь эвлэрэх эхний хүчин чармайлтыг гаргахаар хичээдэг байв. Надад гарсан өөрчлөлтүүдийг хараад нөхөр маань ч бас Эзэнд итгэж эхэллээ. Бид хоёр хоёулаа итгэгч болмогц маргалдах маань багасаж, илүү их ярилцах болов. Эзэн биднийг биечлэн аварсныг хараад би Түүнд талархах сэтгэлээр дүүрсэн юм.

Гэвч цаг хугацаа өнгөрөх тусам бид сэтгэл санааныхаа байдлыг хянаж чадахгүй хэвээр байв. Заримдаа гэр бүлийн маргаан гарсаар байсан бөгөөд ялангуяа нэгний маань сэтгэл санаа муу байгаа үед бид хоёр хоёулаа хүлээцтэй, тэвчээртэй байж чадахгүй байсан болохоор маргаан маань улам ширүүслээ. Маргаан болгоны дараа шаналсандаа сэтгэл минь хүндэрч, “Эзэн минь, Та бидэнд хүлээцтэй, тэвчээртэй бай гэж сургадаг, гэхдээ би тэгж ер чадахгүй байх шиг байна. Миний дургүй зүйлийг хийхээр нь нөхөртөө би үнэхээр бухимдах юм. Эзэн минь, би яах ёстой вэ?” хэмээн Эзэнд залбирдаг байв. Дараа нь би

---

хэрэгжүүлэх зам олно гэж найдан чуулганы зохион байгуулдаг сургалт болгонд явж эхэлсэн ч хүссэн зүйлээ олж авсангүй. Бүлгийнхээ ахлагчаас тусламж хүсэхэд, тэр ердөө л: “Эхнэр бид хоёр ч бас байнга маргалддаг. ‘Учир нь миний дотор (өөрөөр хэлбэл, миний махан биед) ямар ч сайн зүйл оршдоггүйг би мэднэ: Учир нь миний дотор хүсэл байдаг; гэхдээ үйлдэл маань хүссэнээр болдоггүй’ (Ром 7:18) гэж Паул хүртэл хэлсэн байдаг шүү дээ. Байнга нүгэл үйлдэж, нүглээ улайх тойрогтой нүүр тулдаг асуудлын шийдэл хэнд ч байхгүй. Бид гагцхүү Эзэнд залбирч, Түүнээс өршөөл гуйхаас өөр аргагүй” гэж хэлсэн юм. Түүний ингэж хэлэхийг сонсоод би яахаа мэдэхээ байв: Бид үлдсэн амьдралаа зөрчилдөөнд автан өнгөрөөх хувь тавилантай юм гэж үү?

2017 оны 3-р сард ямагт үг дуу цөөтэй байдаг байсан нөхөр маань гэнэт яриа хөөрөө сайтай хүн болов. Түүнчлэн судрын талаарх ойлголтоо надтай байнга нөхөрлөлөөр хуваалцах болсон бөгөөд бүр гайхмаар нь, түүний хуваалцсан нөхөрлөл үнэхээр гэрлээр дүүрэн байлаа. Би гайхаж орхив; нөхөр маань гэнэт л өөр хүн болчих шиг санагдсан бөгөөд түүний хэлж байгаа зүйлс үнэхээр мэдлэгтэй байлаа. Юу болоод байгааг олж мэдэхийг би үнэхээр их хүссэн юм. Түүнийг олон нийтийн сүлжээний апп дээрх нэгэн бүлгийн гишүүн гэдгийг би нэг өдөр санаандгүй олж мэдээд, тэдэнтэй юун тухай ярилцдагийг нь цаг алдалгүй асуув. Нөхөр минь тун нухацтай царай гарган, Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийг ажлыг авч үзэж байгаагаа хэлээд, Эзэн Есүс аль хэдийн эргэн ирсэн, Түүний нэр нь Төгс Хүчит Бурхан гэлээ. Төгс Хүчит Бурхан аль хэдийн олон сая үг айлдаж, эцсийн өдрүүдэд хүн төрөлхтнийг шүүж, цэвэрлэх ажил хийж байгаа гэж мөн хэлэв. Тэгээд энэ нь **“Учир нь шүүлт Бурханы гэрээс эхлэх цаг болжээ”** (1 Петр 4:17) хэмээх Библийн зөгнөлийг биелүүлсэн гэлээ. Бид Бурханы илрэлт, ажлыг эрж хайхдаа зүгээр л өөрсдийн үзэл, төсөөлөлтэй сохроор зууралдахын оронд Бурханы дуу хоолойг сонсоход анхаарах ёстой. Хэрэв бид үнэнийг эрж хайлгүй, зүгээр л Бурханы илчлэлийг идэвхгүй хүлээх юм бол Эзэнийг эргэн ирэхэд нь угтан авч чадахгүй гэж нөхөр маань надад хэлсэн юм. Үүнийг сонсоод би мэл гайхаж, байж боломгүй зүйл мэт санагдлаа. Бид Эзэний эргэн ирсэн тухай хэзээ нэгэн цагт ямар нэг зүйл сонсох юм бол нээлттэй зүрх сэтгэлээр эрж хайж, зүтгэлтэйгээр судлах ёстой; харин үзэл, төсөөлөлдөө найдаж, зүгээр л харалганаар дүгнэлт хийж болохгүй гэж энэтхэг пастор нэг удаа хэлэхийг сонссон минь дараа нь санаанд оров. Иймээс би Эзэнд ийнхүү залбирсан юм: “Эзэн минь, хэрэв Төгс Хүчит Бурхан үнэхээр Таны эргэн ирэлт мөн бол намайг удирдаж, замчлаач. Тэгснээр би нээлттэй зүрх сэтгэлээр үнэнийг эрж хайж, үүнийг судалж чадна. Эс бөгөөс Та намайг төөрүүлэхгүйн тулд зүрх сэтгэлийг минь хамгаалаач. Амен!”

Энэ залбирлын дараа би Библийг нээн, Илчлэл 3:20-д: **“Харагтун, Би үүдэнд зогсоод тогшиж байна: Хэрвээ хэн нэгэн Миний дуу хоолойг сонсоод хаалгаа нээвэл, Би түүн**

---

**дотор орж, түүнтэй хамт, тэр Надтай хамт хооллох болно”** хэмээсэн байхыг харав. Тэгээд гэнэт тэр мөчид онгод орсон бөгөөд Эзэн надтай ярьж, эргэн ирэх үедээ хаалгыг минь тогшино гэж хэлж байгаа мэт санагдсан юм. Тэр надад дуу хоолойг нь сонсож, хаалгаа тайл гэж тушааж байгаа мэт санагдлаа. Энэ нь яг л дуу хоолойг нь сонсоод, сүйт залууг угтан авахаар яаран очсон Библи дэх ухаалаг охид шиг байсан юм. Дараа нь Иохан 16:12–13-ыг би бодлоо: **“Та нарт хэлэх зүйл Надад олон байгаа боловч та нар одоо тэдгээрийг дааж чадахгүй. Гэхдээ үнэний Сүнс болох Тэр ирэх үедээ та нарыг бүх үнэн рүү удирдана: Учир нь Тэр Өөрийн санаагаар ярихгүй; харин сонссон зүйлээ Тэр ярих болно: Мөн Тэр ирэх зүйлсийг та нарт харуулна.”** Бичвэрийн эдгээр эшлэлийг эргэцүүлэх явцад догдолсон мэдрэмж сэтгэлд хурсан юм. Эзэн эргэж ирэхдээ илүү олон үг айлдаж, бидэнд үнэнийг хайрлана гэдгээ аль эрт бидэнд хэлсэн болохыг би ухаарав. Мөн Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажил бол хүн төрөлхтнийг шүүж, цэвэрлэхийн тулд үг илэрхийлэх ажил юм—Төгс Хүчит Бурхан үнэхээр эргэн ирсэн Эзэн Есүс байж болох уу? Хэрэв Эзэн үнэхээр эргэн ирчхээд, хүн төрөлхтний бүх хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэхээр үнэнийг илэрхийлсэн бол бидэнд нүглийн хүлээсээс ангижрах найдлага байна. Тэгвэл нөхөр бид хоёрын хоорондох асуудлууд шийдвэрлэгдэж болох бус уу? Би Төгс Хүчит Бурханы Чуулганы ах эгч нартай намайг холбож өгөөч гэж нөхрөөсөө цаг алдалгүй гуйлаа; мөн Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг ч судлахыг хүсэв.

Цуглаан дээр Төгс Хүчит Бурханы Чуулганы зарим ах эгч Библийн зарим нэг эшлэлийг сонгон, Эзэний эргэн ирэлтийн хэв маяг, Эзэний шинэ нэр, Эзэн ямар ажил хийх гэх зэрэг үнэний янз бүрийн талын тухай надтай нөхөрлөсөн юм. Тэдний нөхөрлөл туйлын үнэмшилтэй, цоо шинэ санагдав. Би Эзэний эцсийн өдрүүдийн ажлын талаар илүү их мэдэхийг үнэхээр их хүссэн тул Бурханд ахин дахин залбирч, намайг гэгээрүүлэн Бурханы үгийг ойлгуулаач гэж Түүнээс гуйлаа. Бурханы үгийг уншин, ах эгч нарын нөхөрлөлийг сонссоноор би хүн төрөлхтнийг удирдах Бурханы зорилго, хүн төрөлхтнийг аврах Бурханы ажлын гурван үе шат, хүн төрөлхтний үр дүн, хүрэх газрын талаар аажмаар ойлголт авсан юм. Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг судалж байхдаа би зарим нэг ялихгүй зүйлээс болж нөхөртөө өөрийн эрхгүй үглэсээр л байлаа. Дараа нь би үнэхээр гэмшиж, сэтгэл гонсойн, “Би яагаад Бурханы үгийг хэзээ ч хэрэгжүүлж чаддаггүй юм бэ?” гэж өөрөөсөө асуудаг байв. Үүнээс үүдэн би гайхаж гүйцэв. Нэг удаа цуглаан дээр би: “Нөхөр бид хоёр яагаад байнга маргаж байдаг юм бол? Яагаад бид хоёр амар тайван эв найртай байж болдоггүй юм бэ?” гэж эгчээс асуусан юм. Эгч надад Бурханы үгийн хоёр хэсгийг олж өглөө. **“Хүнийг золин аврахаас өмнө Сатаны олон хор аль хэдийн түүний дотор суучихсан бөгөөд Сатанаар олон мянган жил завхруулагдсаны**

---

дараа хүний дотор Бурханыг эсэргүүцэх уг чанар тогтсон байдаг. Тиймээс хүнийг золин аврах нь хүнийг өндөр үнээр буцаан авсан золин авралаас цаашгүй байсан боловч хүний доторх хорт уг чанарыг таягдан хаяагүй юм. Ингэж их бузартсан хүн Бурханд үйлчлэхүйц болохоосоо өмнө өөрчлөгдөх ёстой. Шүүлт, гэсгээлтийн энэ ажлаар дамжуулан өөрийнхөө доторх бохир, завхарсан мөн чанарын талаар хүн бүрэн мэдэж авах бөгөөд бүрэн өөрчлөгдөж, цэвэр болж чадна. Ийм маягаар л хүн Бурханы сэнтийн өмнө буцан очих үнэ цэнтэй болж чадна” (Үг нь махбодоор илэрсэн номын “Бие махбодтой болохын нууц (4)”). “Хэдийгээр Есүс хүмүүсийн дунд их ажил хийсэн ч бүх хүн төрөлхтний золин авралыг л гүйцэлдүүлж, хүний нүглийн тахил болсон юм; Тэрээр хүнийг бүх завхарсан зан чанараас нь салгаагүй. Хүнийг Сатаны нөлөөнөөс бүрэн аврах нь, Есүсээс нүглийн тахил болж хүний нүглийг үүрэхийг шаардаад зогсохгүй, бас хүнийг сатанлаг завхарсан зан чанараас нь бүрэн салгахын тулд улам их ажил хийхийг Бурханаас шаардсан. Ингээд хүний нүгэл уучлагдсаны дараа Бурхан хүн төрөлхтнийг шинэ эрин үе рүү хөтлөхийн тулд махбодод эргэн ирж, гэсгээлт, шүүлтийн ажлыг эхлүүлсэн юм. Энэ ажил нь хүнийг илүү өндөр хүрээнд аваачсан. Түүний ноёрхол дор захирагддаг бүх хүн илүү өндөр үнэнийг эдэлж, илүү агуу ерөөлийг хүлээн авна. Тэд үнэхээр гэрэлд амьдарч, үнэн, зам, амийг олж авна” (Үг нь махбодоор илэрсэн номын Өмнөх үг).

Дараа нь эгч ийнхүү нөхөрлөлөө: “Эхэндээ Адам, Ева хоёр Еден цэцэрлэгт Бурханы өмнө аз жаргалтай амьдардаг байсан юм. Хэрүүл маргаан, зовлон гэж байсангүй. Гэвч тэд могойн үгэнд орж, сайн мууг мэдүүлэгч модны жимсийг идсэнээр Бурханаас холдож, урвасан бөгөөд Бурханы халамж, хамгаалалтыг алдаж, Сатаны эрхэнд амьдрах болжээ. Тэгээд уй гуниг, зовлонгийн өдрүүд эхэлсэн юм. Өнөөг хүртэл ийм маягтай байж ирсэн бөгөөд биднийг Сатан улам бүр гүн гүнзгий завхруулсан. Бид бүгд завхарсан, сатанлаг зан чанараар дүүрэн, бас туйлын биеэ тоосон, аминчхан, ов мэхтэй, дураараа зантай. Тэгээд бүх зүйл дээр өөрийгөө бодож, үргэлж бусдыг үгэндээ оруулах гэдэг. Тийм учраас хүмүүс бие биетэйгээ маргаж, нэг нэгнээ хөнөөдөг. Эцэг эх, үр хүүхэд, эхнэр нөхөр ч нэг нэгнээ хүлцэж, тэвчдэггүй бөгөөд бие биетэйгээ эв найртайгаар зохицож чаддаггүй—бидэнд хамгийн үндсэн мөс чанар, эрүүл ухаан ч байдаггүй. Эзэн Есүс биднийг золин аварсан, Эзэнд бид залбирч, нүглээ улайж, гэмшиж, Эзэний сургаалыг баримтлахаар шаргуу ажилладаг ч өөрийн эрхгүй нүгэл үйлдэж, Бурханыг эсэргүүцдэг. Учир нь Эзэн Есүс хүн төрөлхтнийг золин аврах ажлыг л хийсэн болохоос хүн төрөлхтнийг бүрэн аварч, цэвэрлэх ажлыг хийгээгүй юм. Эзэн Есүсийн авралыг хүлээн зөвшөөрнө гэдэг ердөө л бид нүглийнх байхаа больж, залбирлаараа Эзэний өмнө очих боломжтой болж, Түүний өршөөлийг хүлээн авч, нүглээ уучлуулна гэсэн үг. Гэвч бидний завхарсан зан чанар

---

цэвэрлэгдээгүй. Нүгэлт уг чанар маань бидний дотор гүн үндэслээтэй хэвээр байгаа бөгөөд эцсийн өдрүүдэд Бурхан эргэн ирж, хүн төрөлхтнийг цэвэрлэж, өөрчлөн, улмаар нүгэлт уг чанарын маань асуудлыг шийдэх ажлын үе шатыг хийх нь бидэнд хэрэгтэй хэвээр байгаа юм. Харин одоо Бурхан дахин махбод болчихоод, биднийг завхарсан зан чанараас маань бүрмөсөн авран, Сатаны нөлөөнөөс ангижирч, бүрэн аврагдах боломжийг бидэнд олгохын тулд шүүлт, цэвэрлэлтийн ажил хийхээр үг илэрхийллээ. Бид Бурханы шинэ ажилтай хөл нийлүүлэн алхаж, Түүний үгийн шүүлт, гэсгээлтийг хүлээн зөвшөөрч, үнэнийг эрж хайж, Бурханы үгийг хэрэгжүүлж байгаа цагт завхарсан зан чанар маань аажмаар өөрчлөгдөнө. Энэ маягаар л бид жинхэнэ хүний төрхийг амьдран харуулж чадах бөгөөд тэгсэн цагт л бусадтай эв эетэйгээр харилцаж чадна.”

Эзэн Есүс хүн төрөлхтнийг золин аврах ажил хийсэн хэдий ч итгэгч бидний нүгэл уучлагдсан төдий л болохоос дотоод нүгэлт уг чанар маань маш гүн нэвчсэн хэвээр бөгөөд сатанлаг зан чанар маань хараахан цэвэрлэгдээгүй тул бид үргэлж нүгэл үйлдээд, дараа нь нүглээ улайх ийм байдалтайгаар амьдарч байгаа гэдгийг би Бурханы үг болон энэ эгчийн нөхөрлөлөөс эцэст нь ойлгов. Би Эзэний сургаалын дагуу тэвчээр, хүлээцтэй байдлыг хэрэгжүүлэхээр зорьсон ч нөхөр маань миний дургүй зүйлийг хэлэх юм уу хиймэгц уураа барьж дийлдэггүй байсан нь үүний сонгодог жишээ юм. Би юу ч болсон бай хамаагүй, өөрийгөө хянаж ер чаддаггүй байлаа. Биднийг аврах Бурханы ажил байгаагүй бол бид өөрсдийн хичээл зүтгэлд түшиглэн сатанлаг, завхарсан зан чанараасаа ангижрах боломжгүй. Харин одоо Бурхан дахин нэг удаа бие махбодтой болж, хүн төрөлхтнийг шүүж, цэвэрлэх ажил хийхээр ирлээ. Бурханы шинэ ажлыг хүлээн зөвшөөрч, үнэнийг үнэхээр эрэлхийлснээр зан чанараа өөрчлөх боломж бидэнд бий. Эзэний дуу хоолойг сонсох боломжийг олгосон Эзэний өршөөлд сэтгэл минь үнэхээр их хөдөлж, асар их талархсан юм. Гэвч би тов тодорхой ойлгоогүй л байсан юм—Бурхан энэ удаад биднийг ариусгаж, өөрчлөхийн төлөө үг айлдахаар ирсэн гэдгийг би мэдэж байсан ч үг яаж бидний завхарсан зан чанарыг шүүж, цэвэрлэж чадах юм бэ? Иймээс би төөрөгдлөө тайлбарлав.

Эгч Бурханы үгийн бас нэгэн хэсгийг надад уншиж өглөө: **“Эцсийн өдрүүдэд Христ хүнийг сургах, хүний мөн чанарыг ил болгох, хүний үг болон үйлдэлд нь дүн шинжилгээ хийхийн тулд төрөл бүрийн үнэнийг хэрэглэдэг. Хүний үүрэг, хүн яаж Бурханд дуулгавартай байх ёстой, хүн яаж Бурханд үнэнч байх ёстой, хүн яаж хэвийн хүн чанарыг амьдран харуулах учиртай болон Бурханы мэргэн ухаан, зан чанар гэх зэрэг төрөл бүрийн үнэн эдгээр үгэнд агуулагддаг. Эдгээр үг нь бүгд хүний мөн чанар болон ялзарсан зан чанар луу чиглэдэг. Ялангуяа, хүн Бурханыг хэрхэн голдгийг илчилсэн үгсийг хүн бол Сатаны биелэл, Бурханы эсрэг дайсны хүч болдог тухайд хэлсэн байдаг. Шүүлтийн ажлаа хийхдээ Бурхан хүний уг чанарыг ердөө хэдхэн үгээр**

---

тодорхой болгодог юм биш; Тэрээр удаан хугацааны туршид илчилж, харьцаж, засдаг. Илчлэл, харьцалт болон засалтын эдгээр аргыг энгийн үгээр бус, харин хүнд огт байдаггүй үнэнээр л орлуулж болно. Зөвхөн ийм төрлийн арга барилыг л шүүлт гэж нэрлэж болно; ийм төрлийн шүүлтээр л дамжуулан хүн номхорч, Бурханд захирагдахаар бүрэн үнэмшээд зогсохгүй, Бурханы тухай жинхэнэ мэдлэгийг олж авч чаддаг. Шүүлтийн ажлын авчирдаг зүйл гэвэл Бурханы жинхэнэ дүр төрх болон өөрийнх нь тэрслүү байдлын үнэний талаарх хүний ойлголт юм. Шүүлтийн ажил нь хүнд Бурханы хүслийн тухай, Бурханы ажлын зорилгын тухай, хүний ойлгошгүй нууцуудын тухай ихээхэн ойлголт олж авах боломж олгодог. Түүнчлэн, өөрийн ялзарсан мөн чанар болон ялзралынхаа үндсийг таньж мэдэх, хүний муу муухайг нээн илрүүлэх боломжийг олгодог. Энэ бүх үр дүнг шүүлтийн ажил авчирдаг, учир нь энэ ажлын мөн чанар нь үнэндээ Бурханы үнэн, зам, амийг Түүнд итгэдэг бүх хүнд нээх ажил юм. Энэ ажил нь Бурханы хийдэг шүүлтийн ажил билээ” (Үг нь махбодоор илэрсэн номын “Христ шүүлтийн ажлыг үнэнээр хийдэг”).

Тэгээд эгч надтай илүү их нөхөрлөл хуваалцсан юм. “Бурхан шүүлтийн ажлыг хэрхэн хийдгээ Өөрийн үгээр тодорхой тайлбарладаг. Бурхан хүн төрөлхтнийг шүүж, ариусгахын тулд үгээ ашигладаг бөгөөд бидний завхарсан уг чанар, мөн чанар, сатанлаг зан чанарыг шууд илчилж, задлан шинжлэхийн тулд үндсэндээ үгээ ашигладаг. Түүнчлэн бид Бурханд хэрхэн захирагдаж, Бурханыг хэрхэн шүтэн мөргөх ёстой, хэвийн хүн чанарыг хэрхэн амьдран харуулах, зан чанарын өөрчлөлтөд хүрэхийн тулд үнэнийг хэрхэн эрэлхийлэх, хэрхэн үнэнч хүн байх, хүмүүсээс хүсдэг Бурханы хүсэл, шаардлага юу болох талаар Бурхан бидэнд тодорхой хэлсэн. Тэрээр ямар хүмүүст дуртай, ямар хүмүүсийг таягдан хаядаг болон бусад зүйлсийнхээ талаар бидэнд хэлсэн юм. Бурхан бас бидэнд засалт, харьцалт, туршилт, цэвэршүүлэлт хийхийн тулд хүмүүс, үйл явдал, юмсыг зохицуулдаг. Энэ нь бидний завхарсан зан чанарыг ил болгож, Бурханы өмнө очин, үнэнийг эрэлхийлэх, Түүний үгийн шүүлт, гэсгээлтийг хүлээн зөвшөөрөх, өөрсдийгөө эргэцүүлж, мэдэхээс өөр аргагүй болгодог. Бурханы шүүлт, гэсгээлтийн үгийг хүлээн зөвшөөрөх үед Бурхан бидэнтэй нүүр тулан, тод томруунаар ярилцаж, Бурханы эсрэг тэрслүү байдал, эсэргүүцэл, буруу сэдэл, үзэл, төсөөллийг маань бүрэн илчилж байгаа мэт санагддаг. Тэр үед л бид уг чанар, мөн чанар маань биеэ тоосон, ихэрхүү, ов мэхтэй, гажууд, аминчхан, жигшүүртэй байдлаар дүүрэн гэдгийг олж харж чаддаг. Бидэнд Бурханыг хүндлэх зүрх сэтгэл огт үгүй бөгөөд бид гагцхүү сатанлаг, завхарсан уг чанартаа л үндэслэн амьдарч, сатанлаг зан чанараа л илчлэн, хүний төрхөөр бүрэн дулимаг байдаг гэдгээ олж хардаг. Тэгээд зүрх сэтгэлийнхээ угаас өөрсдийгөө үзэн ядаж, өөрсдөдөө зэвүүцэж эхэлдэг бөгөөд Сатаны нөлөөн дор амьдран, Сатаны тоглоом тохуу болж, Сатанд хорлогдох хүсэлгүй

---

болдог. Үүний зэрэгцээ Бурханы шүүлт, гэсгээлтээр дамжуулан ямар ч халдлагыг хүлцдэггүй Бурханы ариун мөн чанар, зөвт зан чанарыг бид хардаг. Бидний дотор Бурханыг хүндлэх сэтгэл төрж, Бурханыг хангалуун байлгахын тулд үнэнийг хэрэгжүүлэх хүсэлтэй болдог. Үнэнийг хэрэгжүүлж эхэлмэгц Бурханы сайн санаат, өршөөнгүй зан чанар бидэнд ил болдог. Бурханы үгийг тасралтгүй уншин, Түүний шүүлт, гэсгээлтийг туулснаар бид өөрсдийнхөө завхарсан уг чанарыг илүү гүн гүнзгий ойлгож, Бурханы илэрхийлсэн үнэнийг илүү сайн ойлгодог бөгөөд Түүний шүүлт, гэсгээлтийг хүлээн авч, захирагдах, махан биеийг хаях, үнэнийг хэрэгжүүлж, Бурханыг хангалуун байлгахад улам бүр бэлэн болдог. Бидний илчилдэг завхрал улам бүр багасаж, үнэнийг хэрэгжүүлэхэд улам амархан болдог бөгөөд аажмаар Бурханаас эмээж, муугаас зайлах замд ордог. Бурханы үгийн шүүлт, гэсгээлтийг туулснаар бид, энэ нь биднийг завхарсан зан чанараас маань аварч, эдгээдэг бүхнийг анагаагч эм гэдгийг зүрх сэтгэлээсээ баталгаажуулж чаддаг. Энэ бол завхарсан хүмүүс биднийг гэх Бурханы хамгийн жинхэнэ хайр юм. Бурханы үгийн шүүлт, гэсгээлтийг туулахгүйгээр бид хэзээ ч жинхэнэ хүний төрхийг амьдран харуулж чадахгүй.”

Бурханы үг болон эгчийн нөхөрлөл надад асар их нөлөө үзүүлсэн юм. Эцсийн өдрүүд дэх Бурханы шүүлт, гэсгээлтийн ажил үнэхээр маш бодитой бөгөөд хэрэв бид завхарсан зан чанараа өөрчлөхийг хүсвэл Бурханы үгийн шүүлт, гэсгээлтийг туулах ёстой гэдгийг би мэдэрлээ. Эс бөгөөс бид нүгэл үйлдээд, дараа нь нүглээ улайх тойрогт үүрд амьдран, нүглийн хүлээсээс хэзээ ч ангижрахгүй. Иймээс би зүрх сэтгэлдээ Бурханд залбирсан бөгөөд намайг үгээрээ усалж, тэжээн, надад өөрийг минь мэдүүлж, завхарсан зан чанарыг минь удалгүй өөрчлөн, жинхэнэ хүний төрхийг амьдран харуулах боломж олгохын тулд намайг шүүж, гэсгээх орчныг бүрдүүлээч гэж Түүнээс гуйв.

Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн зөвшөөрснийхөө дараа би бас надад зориулж Бурханы зохицуулсан гэрлэлтийн талаар шинэ ойлголттой болсон юм. Нэг удаа эгч Бурханы үгийн хэдэн хэсгийг надад уншиж өглөө. **“Хүмүүс өөрсдөө биеэрээ үзэж туулахаасаа өмнө гэрлэлтийн талаар олон төөрөгдөлтэй байдаг бөгөөд энэ бүгд нь тун сайхан төөрөгдөл юм. Эмэгтэйчүүд хань ижлээ Царайлаг ханхүү байх болно гэж төсөөлдөг бөгөөд эрчүүд өөрсдийгөө Цасан гуатай гэрлэнэ гэж төсөөлдөг. Хүн бүр гэрлэлтэд тавих тодорхой болзол, өөрсдийн гэсэн шаардлага, стандарттай байдаг гэдгийг эдгээр хоосон төсөөлөл харуулж байдаг”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Цор ганц Бурхан Өөрөө III”). **“Гэрлэлт бол хүний амьдралын чухал онцгой үе юм. Энэ нь хүний хувь заяаны үр дүн, хувь заяаных нь шийдвэрлэх холбоос юм; энэ нь аливаа хүний хувийн хүсэл зориг, шилж сонгох дээр үндэслэдэггүй бөгөөд ямар ч гадаад хүчин зүйлс нөлөөлдөггүй, харин энэ нь хоёр талын хувь заяагаар, тэр хосын**

---

хоёулынх нь хувь заяаг Бүтээгчийн зохицуулж, урьдчилан тодорхойлсноор бүрэн тодорхойлогддог” (Үг нь махбодоор илэрсэн номын “Цор ганц Бурхан Өөрөө III”). “Гэрлэх үед хүний амьдралын замнал нэгэн биеийнх нь нөгөө талд нөлөөлж, хөндөн, үүний нэгэн адилаар ханийнх нь амьдралын замнал эргээд өөрийнх нь амьдралын хувь заяанд нь нөлөөлж, хөндөх болно. Өөрөөр хэлбэл, хүмүүний хувь заяа хоорондоо холбогдсон байдаг бөгөөд хэн ч бусдаас тусдаа бүрэн бие даан амьдралын даалгавраа биелүүлж, үүргээ гүйцэтгэж чадахгүй. Хүний төрөлт харилцааны асар том гинжин хэлхээнд нөлөөлдөг; өсөж торних нь мөн л харилцааны нарийн төвөгтэй гинжин хэлхээтэй хамаатай; үүний адилаар гэрлэлт нь хүний харилцаа холбооны өргөн уудам, нарийн төвөгтэй сүлжээн дотор гарцаагүй оршиж, байж, тэрхүү сүлжээний гишүүн бүрийг оролцуулан, түүний нэг хэсэг нь болох хүн бүрийн хувь заяанд нөлөөлж байдаг. Гэрлэлт бол хоёр гишүүний гэр бүл, тэдний өссөн нөхцөл байдал, дүр төрх, нас, яс чанар, авьяас чадвар, аливаа өөр бусад хүчин зүйлийн үр дүн биш; харин ч энэ нь хамтын даалгавар болон хувь заяаны хамаарлаас үүсдэг. Бүтээгчийн зохион байгуулж, зохицуулсан хүмүүний хувь заяаны бүтээгдэхүүн, гэрлэлтийн эх үүсвэр энэ билээ” (Үг нь махбодоор илэрсэн номын “Цор ганц Бурхан Өөрөө III”). Дараа нь эгч ийнхүү нөхөрлөв. “Бид бүгдийн гэрлэлтийг Бурхан урьдчилан тогтоосон байдаг бөгөөд хэнтэй гэр бүл болохыг маань аль эрт тогтоосон байдаг. Энэ бүхнийг Бурхан мэргэн ухаанаараа зохицуулдаг. Бидэнд зориулж Түүний сонгосон гэрлэлт бидний нийгэмд эзлэх байр суурь, гадаад төрх, хэв чанараас хамаардаггүй, харин хоёр хүний хэн хэнийх нь амьдралын даалгавраар тодорхойлогддог. Гэвч биднийг завхарсан зан чанар маань хянадаг тул бид хань ижилдээ цаг үргэлж олон шаардлага тавьж, аливааг дандаа өөрийнхөөрөө хийлгэх гэдэг. Тэгэхгүй бол үүнийг нь хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж, сэтгэл дундуур болдог бөгөөд хань ижилтэйгээ маргаж, уурлаж, тэр ч бүү хэл гомдоллон, Бурханыг буруутгаж, буруугаар ойлгодог. Ингэснээр хоёр хүн хоёулаа шаналалд амьдрахад хүрдэг. Иймэрхүү шаналлыг өөр хэн нэгэн авчирдаггүй, Бурханы захиралт, зохицуулалт ч бий болгодоггүй, харин бид биеэ тоосон, ихэрхүү завхарсан зан чанараараа амьдардаг учраас ийм зүйл тохиолддог юм. Иймэрхүү завхарсан зан чанар маань биднийг Бурханы захиралттай нийцэлгүй болгодог; бид Түүний зохион байгуулалт, зохицуулалтад захирагдаж чаддаггүй.”

Энэ эгчийн нөхөрлөлийг сонсоод би нөхөртэйгөө харилцах харилцаагаа эргэн бодлоо. Би үргэлж нөхөртөө сэтгэл ханамжгүй байгаагаа илэрхийлж, аливааг өөрийнхөөрөө хийлгэх гэж байнга шаарддаг байсан юм. Хэрэв нөхөр маань намайг бодож, хайхарч, халамжтай байхгүй, миний биеийг асуухгүй байх юм бол би нөхрийнхөө талаар гомдоллож, бүтэхгүй хүн юм гэж боддог байв. Тэгээд нөхрөө элдэв янзаар дорд үзэж,



---

хүйтэн дайн хийж, үл тоомсорлодог байлаа. Би үнэхээр биеэ тоосон, ихэрхүү, аминчхан, жигшүүртэй хүн байснаа эцэст нь олж харсан юм. Би гагцхүү өөрийн ашиг сонирхлыг л боддог хүн байсан ба бусад хүний мэдрэмжийг огт бодолцож үздэггүй байжээ. Үүнийг хянуур бодоод үзэхэд, нөхөр минь ердөө л илүү бүрэг ичимхий, сэтгэл хөдлөлөө төдийлөн илэрхийлдэггүй байсан болохоос намайг тоодоггүй гэдэг нь огт үнэн биш байлаа. Түүнчлэн нөхөр минь өөрийн гэсэн бодол, сонирхолтой байсан боловч би үргэлж дургүй зүйлийг нь албадан хийлгэхээр зүтгэдэг байж. Нөхрийн минь хийдэг бүхэн намайг тойрон эргэлдэж байхыг би үргэлж хүсдэг байсан бөгөөд үүнээс үүдэн бид хоёрын хооронд маш их зөрчил үүсжээ. Дараа нь би урьдын зан авиртаа өөрийн эрхгүй харамссан юм. Мөн, “урьд нь Эзэний сайн мэдээг чи надтай хуваалцсан бол харин одоо Бурханы эцсийн өдрүүдийн сайн мэдээг би чамтай хуваалцлаа” хэмээн нөхрийнхөө хэлсэн үгийг би бодлоо. Энэ бол бидэнд зориулсан Бурханы агуу нигүүлсэл, гайхалтай зохицуулалт байсан юм. Бид хоёр хоёулаа туйлын их ерөөгдсөн хүмүүс байсан ч би огт талархаж мэддэггүй байжээ. Харин ч надад зориулан Бурханы зохицуулсан гэрлэлтэд захирагдахыг хүсэлгүй, Бурханыг байнга буруутгадаг байлаа. Би маш биеэ тоосон, ямар ч эрүүл ухаангүй байснаа олж харсан юм! Намайг үгээрээ замчилсан Бурханд талархъя. Би гэрлэлт дэх бүх зовлонгийнхоо уг үндсийг олсон бөгөөд зүрх сэтгэлдээ тайвшрал, чөлөөлөлтийг олж авсан юм. Түүнчлэн тэр цагаас эхлэн амьдралдаа Бурханд түшиглэн, Бурханыг хүндэлж, биеэ тоосон, ихэрхүү завхарсан зан чанараа хаяж, нөхөртэйгөө эв эетэйгээр харилцахад бэлэн болсон билээ.

Тэр үеэс хойш нөхөр бид хоёр байнга Бурханы үгийг уншин, үнэний талаар хамтдаа нөхөрлөдөг болсон бөгөөд бүтээгдсэн зүйлийн үүргээ чадах чинээгээрээ гүйцэтгэж байгаа юм. Түүнчлэн бид өдөр бүр Бурханы үгээр тэжээгдэж, услуулдаг ба асуудалтай тулгарах үедээ Бурханы үгийн дагуу Түүний хүслийг эрж хайдаг. Завхрал илчлэх юм уу маргалдах юм бол бид хоёр хоёулаа Бурханы өмнө ирж, өөрсдийгөө эргэцүүлж, мэдэж авдаг. Үүнийг хэрэгжүүлэх үедээ бид бие биеэ илүү их ойлгож, уучилдаг. Бид хоёрын маргаан улам бүр цөөрч, гэр орны маань амьдрал эв эетэй болсон бөгөөд амьдрал маань улам бүрэн дүүрэн болсон билээ. Нөхөр маань үнэний талаар надаас илүү сайн ойлголттой байгаад миний сэтгэл хамгийн их хөдөлсөн юм. Тэрээр Бурханы үгийн талаарх ойлголтоо надтай байнга нөхөрлөдөг бөгөөд завхарсан зан чанараа илчилж байгааг минь харах үедээ үнэний талаар болон Бурханы хүслийн талаар надтай нөхөрлөл хийдэг. Намайг гэх нөхрийнхөө халамж, хайрыг би үнэхээр мэдэрсэн бөгөөд зүрх сэтгэлийнхээ угаас баярладаг. Өөрсдийн замыг эргээд харахад би хэн байсан, тэр хэвээрээ, нөхөр минь ч бас хэн байсан, тэр хэвээрээ байгаа. Гагцхүү бид Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн зөвшөөрч, зарим үнэнийг ойлгосон учраас бүх зүйл тэр чигтээ өөрчлөгдсөн билээ. Биднийг аварсанд

---

нь Төгс Хүчит Бурханд талархъя!

### **37. Ачлалгүй хүү эргэн ирсэн нь**

Рүүт, АНУ

Би өмнөд Хятадын жижиг тосгонд, элэнц эмээгийн үеэс л итгэгч байсан гэр бүлд төрсөн юм. Хүүхэд насны минь жаргалтай өдөр хоногууд Библийн түүх, магтан дуу, чуулганд эгшиглэдэг ариун хөгжимтэй үргэлж хамт байсан билээ. Өсөж том болж, хичээлийн ачаалал нэмэгдэхийн хэрээр зүрх сэтгэл минь Эзэнээс аажмаар холдож эхлэв. Гэхдээ Эзэн намайг хэзээ ч орхилгүй, дуудах бүрд минь тусалдаг байлаа. Эзэн Есүсийн нигүүлсэл, ариун нэр зүрх сэтгэлд минь гүн үндэслэсэн юм. Их сургуулийн элсэлтийн шалгалт өгсөн жилээ би санаж байна. Хэн ч, тэр дундаа багш нар ч намайг сайн сургуульд тэнцэж чадна гэж бодоогүй юм. Удаа дараагийн цохилттой тулгаран бараг горьдлого тасарч, орохыг хүссэн сургуульдаа хэзээ ч тэнцэхгүй нь гэж би ч бас бодож байлаа. Харин тэгтэл багадаа чуулган дээр сонсож байсан үг гэнэт санаанд оров: “Хүн хаана дуусна, Бурхан тэндээс эхэлдэг”. Тэгээд хормын төдийд би гэгээрсэн мэт санагдсан юм. Би хаана хязгаартаа хүрнэ, Бурхан тэндээс эхэлдэг нь үнэн гэдгийг би мэдэж байлаа. Эзэний чадвар туйлын агуу бөгөөд Эзэнийг чин сэтгэлээсээ түшиж байгаа цагт Тэр надад гарцаагүй тусална гэдэгт би итгэсэн юм. Иймээс би Эзэн Есүст байнга залбирч эхэллээ: “Өө Эзэн минь, надад туслаач. Хүссэн сургуульдаа саадгүй тэнцэж чаддаг л юм бол одоогоос эхлэн би Танаас хэзээ ч холдохгүй, Таныг энэ амьдралын минь цор ганц Аврагч гэдгийг хүлээн зөвшөөрнө гэж амлая.” Үүнийхээ хажуугаар би бас ихэнх хүмүүсийн санаанд ч багтамгүй их төлөөс төлж байлаа; ахлах сургуулиа төгсөх жилийн турш би идэж, унтахаас бусад бүх цагт төгөлдөр хуураар хичээллэж байсан юм. Өдөрт бараг л 10–12 цаг хичээллэдэг байв. Намайг дэмжих тэр хүч хаанаас гарч байсныг мэдээгүй ч Эзэн залбирлыг минь сонсоод ийнхүү чимээгүйхнээр надад тусалж байгаа нь лавтай гэдгийг ухаж ойлгож байлаа. Зүрх сэтгэлдээ Эзэнд талархах минь нэмэгдэв. Эцэст нь удаан хүсэн хүлээсэн хүсэл минь биелж, улсынхаа шилдэг хөгжмийн сургуулиудын нэгд тэнцээд, улмаар Эзэн Есүс бол миний ганц Аврагч гэдэгт бат итгэх болсон юм. Коллеж төгсөх жил би төгсөөд ямар зам сонгохоо мэдэхгүй байсан болохоор Эзэн Есүсийг дуудаж, Түүнээс чигийг минь зааж, өмнө минь зам нээж өгөхийг гуйлаа. 2004 онд АНУ-д болсон 9-р сарын 11-ний террорист халдлагын дараахан нэвтрэх виз олголт бараг бүгд зогссон байсан ч хачирхалтай нь би мэргэжлийн түвшинд бичүүлсэн CD-нийхээ ачаар АНУ-ын нэгэн их сургуулиас бүрэн тэтгэлэг хүлээн авсан билээ. Оюутны визээ ямар ч төвөггүй аваад би эрдэм номын мөр хөөхөөр Америк явсан юм. өөрийнхөө хүчээр бол хэзээ ч хүрч чадахааргүй байсан

---

мөрөөдлөө биелүүлэхэд минь Эзэн тусалсан гэдгийг би их сургуульд тэнцэж, гадаад явсан энэ хоёр туршлагаасаа харлаа. Эзэн Есүс бол жинхэнэ Бурхан, миний Аврагч бөгөөд би Эзэнд итгэх итгэлээ зохих ёсоор хэрэгжүүлж, Түүнийг дагах хэрэгтэй гэдэгт улам бүр үнэмших болсон юм.

2007 оны нэг өдөр би дадсан зангаараа Хятадад суугаа ээж рүүгээ залган, ярьж хөөрөв. Яриан дундуур ээж гэнэтхэн: “Эзэн Есүс Христ аль хэдийн эргэж ирсэн гэдгийг чи мэдсэн үү?” гэлээ. Ингэж хэлэхийг нь сонсоод баярлах, гайхах зэрэгцсэн ч эцсийн өдрүүдэд хуурамч Христүүд гарч ирнэ гэж Библид хэлдэг нь тэр даруй санаанд орсон тул Эзэн эргэн ирсэн гэх энэ яриа нь үнэн, худлын алийг мэдэхгүй байлаа. Үүнд болгоомжтой хандах ёстойг би мэдэж байв. Өнөө үед интернэт маш хурдан, ойр дөхөм болохоор интернэт ороод шалгаж үзэх хэрэгтэй гэж бодлоо. Утсаар ярьж дуусаад би догдолсон сэтгэлээр интернэт орж, мэдээллийн найдвартай эх сурвалж олохыг хичээв. Хачирхалтай нь миний тааралдсан бүхэн эргэн ирсэн Эзэн Есүс болох Төгс Хүчит Бурханыг гутааж, ялласан эсэргүүцлийн дуу хоолой л байлаа. Энэ нь үнэн худал эсэхийн учир нь олдохгүй байсан тул ээж минь зөв бурууг ялгаж чадалгүй, буруу замаар орох вий хэмээн эмээж, айдас түгшүүрт автсан юм. Тэгээд ээж рүүгээ даруй залгаж, цахимаар уншсан тэр бүх муу муухай зүйлээ хэлсэн ч, ээж маш тайван байж, намайг тайтгаруулан ингэж хэлэв: “Үр минь, чи Төгс Хүчит Бурханы үгийг уншиж үзээгүй болохоор ойлгохгүй байна, чамд үүнийг тайлбарлахад их цаг орно, гэхдээ бүү санаа зов, би буруу замаар ороогүй. Харин ч ээж нь Хурганы мөрийг дагаж байгаа. Энэ талаар дахиж утсаар ярилцахаа больё.” Хятадыг бурхангүй үзэлт дарангуйлал захирдаг, бас ХКН-ын засгийн газар Христэд итгэгчдийг үргэлж хавчиж, баривчилж байгаа болохоор итгэлтэй холбоотой аливаа зүйлийг утсаар ярих нь ээжид тусгүй гэдгийг би мэдэж байлаа. Энэ талаар ээжтэй нэг их юм ярьж зүрхлээгүй болохоор Хятадад байдаг сайн таньдаг пастор луугаа залган тусламж эрж, ээжийг минь очиж “авраач” гэж гуйсан юм. Хожим нь пастор ээжийг бүлэгт буцааж оруулж чадахгүй байгаагаа дуулгахад би бараг багтартлаа уурласан билээ. Тэгээд Төгс Хүчит Бурханд итгэдэг ээжийнхээ итгэлийн замд хөндөлсөх гэсэндээ Төгс Хүчит Бурхан бид хоёрын нэгийг нь сонго гэж хүртэл хэллээ. Ингэж хэлснийхээ дараа би гурван шөнө дараалан нэг зүүдээ зүүдэлсэн бөгөөд зүүдэнд түнэр харанхуй шөнөөр аадар бороо асгарч, харин би хар шүхэр бариад нэг л танил далайн эргээр алхаж байв. Эргэн тойронд нэг ч хүнгүй байхад гэнэт өдрийн гэрэл мэт аянгын хурц гялбаа шүхрийг минь цажилаа... Энэ зүүдийг зүүдлэх болгондоо би айчихсан, хүйтэн хөлстэй сэрдэг байсан ч туйлын мэдрэмжгүй, мунхаг, зөрүүд болохоороо яагаад ийм зүүд зүүдлээд байгаагаа ухаж ойлгохын тулд эрж хайж, залбирья гэж өчүүхэн ч хичээл зүтгэл гаргасангүй. Бурханыг эсэргүүцэх замаасаа буц, оронд нь Түүн рүү эргэн оч гэж Эзэн надад хэлж, анхааруулж

---

байсан юм болов уу? Хожим нь би ээжийгээ ятгах гэж яаж ч оролдоод ямар ч нэмэргүй болохыг ухаарлаа. Бас дээр нь алс хол харь нутагт, завгүй амьдарч байсан болохоор ээжийгээ хүчлэх гэж оролдохоо болив.

2010 онд намайг Хятадад буцаж очиход ээж минь Төгс Хүчит Бурханд итгэдэг тухайгаа яриа дэлгэв. Тэгээд юу бодож байгааг минь нэвт харсан юм шиг шулуухан асуулаа: “Төгс Хүчит Бурханд итгээд хэдэн жил болж байгааг минь чи мэднэ. Намайг чи тэр цахимд бичдэг элдэв янзын зүйл шиг хачин болчихсон гэж бодож байна уу?” Ээжийн асуулт намайг хэлэх үггүй болгож, яг тухайн үедээ хэлэх хариу олдсонгүй. Сайтар бодоод үзэхэд, миний айн дагжиж байсан цахимд бичсэн тэдгээр зүйл ээжид минь тохиолдоогүйг ухаарлаа. Ээж минь харин ч эгэл жирийнээрээ, өмнө минь эсэн мэнд зогсож байв. Үнэндээ ээж Төгс Хүчит Бурханд итгэдэг болсноосоо хойш Эзэн Есүст итгэж эхэлснийхээ дараах үеэс ч илүү их өөрчлөгдсөнийг нь би харлаа. Үг, үйлдэл нь илүү ухаалаг болоод зогсохгүй, аливаад хандах хандлагадаа илүү их ойлголт олж авчээ. Энэ бүгдийг хараад би, “Нүд үнэн, чих худал гэдэг тул цахимд байсан цуу яриа үнэн биш бололтой” гэж бодлоо. Ээж минь тэгэхэд, “Чи яагаад ээждээ итгэхгүй байгаа юм бэ? Бас баримтыг олж харахгүй, юунд цахим цуу ярианд итгэнэ вэ? Тэр зүйлсийн талаар судалж, нотолгоо цуглуулсан юм уу?” гэж хэллээ. “Үгүй ээ” гэж би бантан хариулав. Ээж цааш ийн ярилаа: “Чи өөрөө судалж үзээд, энэ бүгд ердөө л цуурхал гэдгийг олж мэдэхийн оронд цахимаар уншсан цуу яриандаа итгэж, яаран дүгнэлт хийсэн байна. Ийм өндөр боловсролтой юм байж эрүүл ухаанаар тун дулимаг байгаа чинь ичгүүртэй юм. Чи дөрвөн сайн мэдээг сайтар судлах хэрэгтэй, тэгвэл Эзэн Есүсийг ажлаа хийж байх үед Иудейн шашны ахлах тахилчид, хуулийн багш нар, фарисайчууд төрөл бүрийн цуу яриа, хуурамч гэрчлэлийг санаанаасаа зохиодог байсныг харна. Тэд Эзэн Есүсийг нүгэлтний нөхөр, идээ унд, архи дарсанд дурлагч хүн гэгцгээдэг байсан бөгөөд Цезарьт татвар төлөхөө боль хэмээн хүмүүсийг турхирсан гэх худал ял тулгасан байдаг. Тэгээд бүр цэргүүдийг хахуульдан худал гэрчлэл хийлгэж, Эзэн Есүсийн биеийг шавь нар нь хулгайлсан, Тэр дахин амилаагүй гэж хэлүүлж байсан. Энэ талаар чи мэдэж байгаа биз дээ? Дөрвөн сайн мэдээнд бичигдсэн зүйл бол Эзэн Есүсийн хэрэгжүүлсэн ажлын ердөө л багахан хэсэг. Эзэн Есүсийн талаар Иудейн удирдагчдын тараасан олон цуу яриаг тэнд бичсэн байдаг. Чи энэ талаар өмнө нь бодож үзсэн үү? Тэр үед интернэт байсан бол Иудейн шашны ахлах тахилчид, хуулийн багш нар, фарисайчууд цуу яриа, худал гэрчлэлээ гарцаагүй цахимаар тарааж, Эзэн Есүсийг гүтгэж, доромжилж, гүжирдэж, ялласан үг нь өнөөгийн шашны ертөнц Төгс Хүчит Бурханыг ялладгийн яг адилаар интернэтийн хаа сайгүй тархах байсан. Энэ юу гэсэн үг болохыг мэдэж байна уу? **‘Энэ бол ёрын муу үеийнхэн’** (Лук 11:29). **‘Энэ бол яллалт бөгөөд хүмүүсийн үйлс ёрын муу учраас гэрэл дэлхийд ирэхэд тэд харанхуйг гэрлээс илүү**

---

хайрласан юм. Учир нь үйл хэрэг нь зэмлүүлэх вий гэсэндээ мууг үйлдэг хүн бүр гэрлийг үзэн ядаж, гэрэлд гарч ирдэггүй’ (Иохан 3:19–20) гэж Эзэн Есүс хэлсэн байдаг. Бас ‘Сатанаар завхруулагдсаны дараа хүн Бурханаас эмээх зүрх сэтгэлээ алдаж, Бурханы бүтээлд оногдсон чиг үүргээ ч алдаж, улмаар Бурханд дуулгаваргүй дайсан болжээ. Тэгээд хүмүүс Сатаны эзэмшилд амьдарч, Сатаны тушаалыг дагасан...’ (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурхан хүн хоёр амралтад хамт орох болно”). ‘Бурхан дэлхий ертөнцийг олон мянган жилийн өмнө бүтээсэн, Тэрээр хэмжээлшгүй их ажил хийхийн тулд газар дээр ирсэн бөгөөд хүний ертөнцийн гололт, гүтгэлгийг бүрэн туулсан юм. Бурханыг ирэхэд хэн ч угтан авдаггүй; Түүнтэй хүйтэн хөндий мэндэлдэг. Бэрхшээл зовлонгоор дүүрэн энэ хэдэн мянган жилийн хугацаанд, хүний биеэ авч явах байдал хэдийнээ Бурханы зүрх сэтгэлийг шархлуулжээ’ (Үг нь махбодоор илэрсэн номын “Ажил ба оролт (4)”) гэж Төгс Хүчит Бурхан хэлсэн нь бий. Бурханыг эсэргүүцэж, Бурхантай дайсагнадаг ялзарсан хүн төрөлхтний уг мөн чанарыг Бурханы үг маш тодорхой илчилдэг. Сатан хүн төрөлхтнийг гүн завхруулж, бүх хүн төрөлхтөн Бурханы дайсан болсон тул хэн ч үнэнд дурладаггүй, хэн ч Бурханыг ирэхэд нь угтдаггүй. Эзэн Есүс Иудад ажиллаж, үнэнийг илэрхийлж байхдаа маш олон гайхамшиг үзүүлж, олон эгэл ард Түүнд татагдан дагаж байсан болохоор бүх эгэл ард Эзэн Есүсийг дагаж, өөрсдийг нь орхих вий гэж Иудейн шашны удирдагчид санаа зовних болсон юм. Иймээс тэд Эзэн Есүсийн талаар цуу яриа зохиож, худал гэрчлэл хийж, Түүнийг улайран эсэргүүцэж, яллан, эцэст нь загалмайд цовдолжээ. Завхарсан хүн төрөлхтөн үнэнийг үзэн ядаж, Бурханыг дайснаа гэж үздэгийн хөдөлшгүй нотолгоо энэ. Өнөөдөр Бурхан ахин нэг удаа махбод болоод, завхарсан хүн төрөлхтний улайрсан эсэргүүцэл, ялалттай дахин тулгарч байна. ХКН-ын засгийн газар Төгс Хүчит Бурханыг хүмүүс дагаж, өөрсдийнх нь ёрын муу мөн чанарыг ялган таних чадвартай болох вий, тэгээд гологдож, эрх мэдлийн байр сууриа алдах вий гэж айдаг. Шашны ертөнцийн удирдагчид ч мөн адил итгэгчид Төгс Хүчит Бурханыг дагаснаас болж өөрсдийн байр суурь, амь амьжиргааг алдах вий гэж айдаг. Тэгээд яг л Ромын дэглэм, тухайн цаг үеийн Иудейн шашны удирдагчдын адилаар өөдгүй, хорлонт арга сонгож, Төгс Хүчит Бурханы Чуулганы талаар элдэв цуу яриа зохион, маш олон худал гэрчлэл хийж, улмаар Төгс Хүчит Бурханыг гүтгэж яллан, Төгс Хүчит Бурханы Чуулганы нэр төрийг гутааж байгаа юм. Төгс Хүчит Бурханы үг, ажлыг эсэргүүцэн босож, яллаж, голоход хүмүүсийг хүргэж, Бурханы аврал хүртэх замд хөндөлсөх нь тэдний зорилго. Бид Сатаны залигч ялган таньж чаддаг байх ёстой! ХКН-ын засгийн газар бол хэзээд Бурханы дайсан байсаар ирсэн бурхангүй үзэлт сатанлаг дэглэм. Анх засгийн эрхэнд гарч ирэхдээ тэд Ариун Библийн хувиудыг устгаж, сүм чуулганыг нурааж, Христэд итгэгчийг хядаж, тэр ч бүү хэл дэлхий даяар хүлээн зөвшөөрөгдсөн бүтээл болох Ариун Библийг гаж урсгалын номд тооцон, Протестант, Католик

---

шашинтнуудыг нухчин дарж, хяхаж хавчвал зохих ёрын муу гаж урсгалын гишүүд хэмээн үзсэн байдаг. Тэд ой тойнд орж болох бүх гэмт үйлийг үйлддэг хойно тэдний зохиож зүрхлэхгүй ямар цуу яриа байх билээ? ХКН-ын засгийн газар, шашны ертөнцийн удирдагчдын аль аль нь үнэнийг үзэн яддаг сатанлаг диаволууд, Бурханы дайснууд гэдгийг баримт харуулдаг. Энэ бол бидний тодорхой ойлгох ёстой зүйл. Бид итгэгч хүмүүс хойно Бурханы үгэнд итгэх ёстой, бас үнэнд итгэх ёстой. Харин ХКН-ын засгийн газар, шашны ертөнцийн удирдагчдын цуу яриа, худал үгэнд яавч итгэж болохгүй. ХКН-ын засгийн газар болон шашны ертөнцийн тараасан цуу яриаг ялган таних чадвар дутвал, мөн Төгс Хүчит Бурханы үг, ажлыг эрж хайж, судлахгүй бол эцэстээ бид яг л Иудейн эгэл ардууд шиг сонссон цуу яриандаа мэхлэгдээд Христийг хаяж, үнэн замаас татгалзана. Тэгснээр Бурханы авралыг алдаад зогсохгүй Бурханыг эсэргүүцсэнийхээ төлөө эцэст нь Түүний зөвт шийтгэлтэй учирна!”

Ээжийнхээ хэлсэн үгийг сонсоод би зүүднээсээ сэрэх мэт болж, эдгээрийг өөрийн эрхгүй эргэцүүллээ: “Ээжийн зөв. Би яагаад Төгс Хүчит Бурханы үгийг уншиж, ямар нэг судалгаа хийлгүй цахимд байсан сөрөг зүйлд сохроор итгэчхэв ээ? Энэ хорвоо Сатаны завхралд маш их автаад худал хуурмаг, заль мэхэнд живж байна; урвалт хаа сайгүй гарч байгаа болохоор үүнээс үнэндээ сэрэмжлэхийн арга алга. Гэтэл би цахимд байсан мэдээллийн талаар ямар ч судалгаа хийлгүй зүгээр л сохроор итгэчхэж. Хүн болгоны хэлснийг тоть мэт давтан, дур зоргоороо дүгнэлт гаргажээ. Ингэсэн минь үнэхээр хайхрамжгүй, мунхаг явдал бус уу? Хорон мууг дагаж, дур зоргоороо шүүсэн хэрэг бус уу?” Үг дуугарахгүй байгааг минь хараад ээж “Үг нь махбодоор илэрсэн” номын хувийг өгөөд, тайвнаар хэлэв: “Энэ ном эцсийн өдрүүдэд Бурханы хэлсэн үгийг агуулдаг. Чамайг үзлээ хойш тавин, няхуур судалж үзнэ гэж найдъя. Асуулт гарвал асуугаарай, тэр талаар чинь хамтдаа нөхөрлөж болно шүү.” Би номыг аваад үг дуугүй уншиж эхэллээ. Гэвч үнэндээ би үнэнийг эрж хайх хандлагаар уншаагүй юм. Харин судлаачийн сэтгэлгээг баримтлан, Бурханы үгийг өөрийн мэдлэгээр хэмжиж магадлах, бүр үндэсгүй болохыг нь нотлохыг ч хүсэж байлаа. Чухамдаа Бурханы үгэнд хүндэтгэлгүй, эсэргүү хандсанаасаа болж л би Ариун Сүнсний гэгээрэл, гэрэлтүүлэлтийг хүртэж чадаагүй бөгөөд тиймдээ ч тэр бүх хугацаанд Төгс Хүчит Бурханы ажлыг үнэндээ мэдэж аваагүй юм. Тэгээд бүр өөрийн буруу үзэлтэй үргэлжлүүлэн зууралдаж, Бурханы шинэ ажлыг хүлээн зөвшөөрөхийг хүссэнгүй. Энэ тухай ээжтэйгээ би ярилцлаа: “Ээж ээ, өмнө нь би цахимаар уншсан бүх цуу яриандаа итгэж, Төгс Хүчит Бурханд итгэхэд чинь саад хийх гэж оролдсон ч үнэндээ харалган, мунхаг нэгэн нь би байжээ. Одоогоос эхлэн би Төгс Хүчит Бурханд итгэхийг чинь эсэргүүцэхгүй, гэхдээ би тантай хамт Төгс Хүчит Бурханы нэрээр залбирах ямар ч боломжгүй, учир нь би Эзэн Есүсийн нэрээр залбиран мөрөөдлийн

---

сургуульдаа тэнцэж, хилийн чанадад эрдэм номын мөр хөөх бүтэн тэтгэлэг хүлээн авсан. Тийм агуу нигүүлсэл хүртчихээд Эзэн Есүсийг орхиж яаж болох юм бэ? Тэгэх юм бол ачлалгүй, итгэл эвдсэн хэрэг болох биш үү?” Ээж Төгс Хүчит Бурханы үгээс миний энэ үзэлд чиглэсэн хэсгийг өгч уншуулав: **“Еховагийн ажлаас Есүсийнхийг хүртэл, Есүсийн ажлаас одоогийн энэ үе шатны ажил хүртэлх энэ гурван үе шат тасралтгүй уялдаатайгаар Бурханы удирдлагын бүхий л цар хүрээг хамардаг ба бүгдээрээ нэг Сүнсний ажил юм. Дэлхий ертөнцийн бүтээлээс хойш Бурхан үргэлж хүн төрөлхтнийг удирдан ажилласаар ирсэн. Тэр бол Эхлэл ба Төгсгөл, Эхэн ба Эцэс, эрин үеийг эхлүүлдэг Нэгэн, бас эрин үеийг төгсгөдөг Нэгэн юм. Өөр өөр эрин үе, өөр өөр байршил дахь ажлын гурван үе шат нь гарцаагүй нэг Сүнсний ажил мөн. Энэ гурван үе шатыг хуваадаг бүх хүн Бурханыг эсэргүүцэн зогсдог. Эхний үе шатнаас өнөөдрийг хүртэлх бүх ажил нь нэг Бурханы ажил, нэг Сүнсний ажил юм гэдгийг одоо ч ийлговол зохино. Үүнд эргэлзэх юмгүй”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурханы ажлын үзэгдэл (3)”). Дараа нь надтай ийнхүү нөхөрлөлөө: “Төгс Хүчит Бурханы нэрийг хүлээн зөвшөөрөх нь Эзэн Есүсээс урваж байгаа хэрэг гэж чи бодож байгаа ч энэ бол бүхэлдээ чиний үзэл, төсөөлөл юм. Ехова Бурхан, Эзэн Есүс болон Төгс Хүчит Бурхан бол чухамдаа бүгд нэг Бурхан. Хуулийн эрин үед Бурханыг Ехова гэх нэрээр дуудаж байсан. Тэр газар дээрх хүн төрөлхтний амьдралыг замчлахын тулд хууль гаргаж, хүн төрөлхтнийг жолоодож, замчлахын тулд хууль, тушаалаа хүнээр мөрдүүлсэн юм. Хуулийн эрин үеийн төгсгөлд хүн төрөлхтөн хуулийг цаашид сахиж чадахгүй болтлоо Сатаны завхралд автан, бүгд хуулийн ял, хараал дор амьдарч байсан. Бурхан Нигүүлслийн эрин үеийн ажлыг хэрэгжүүлэхээр Есүс гэх нэрээр махбод болсон бөгөөд хүн төрөлхтнийг золин аврахын тулд хүний төлөө нүглийн мөнхийн тахил болж загалмайд цовдлогдсон. Тэр үеэс хойш бид Бурханы өмнө очин нүглээ улайж, гэмшиж л байгаа цагт нүглээ цагаатгаж, хуулиар яллуулж, хараагдахаа болих болсон. Дээр нь бас Эзэний энгүй их ерөөл, өршөөлийг бид хүртдэг. Гэхдээ нүглээ уучлуулж, Эзэн Есүсийн арвин их нигүүлслийг эдэлж болох ч нүгэлт уг чанар, ялзарсан зан чанараа бид таягдан хаяагүй байдаг. Бид нүгэл үйлдээд, түүнийгээ улайх ёрын тойрогт амьдарсаар, үүнээсээ ангижирч чаддаггүй. Эцсийн өдрүүдэд Бурхан хүнийг шүүж, цэвэрлэх үнэнийг илэрхийлэхийн тулд Төгс Хүчит Бурханы дүрээр дахин махбод болсон. Энэ нь хүнд Бурханы шүүлтээр үнэнийг ойлгож, үнэнийг олж аван, сатанлаг, ялзарсан зан чанараа хаяж, Бурханаар бүрмөсөн цэвэрлэгдэн, жинхэнэ хүний төрхийг амьдран харуулах боломж олгодог. Энэ маягаар эцэстээ хүн Бурханы амлалтыг өвлөн авч, Түүний хаанчлал руу хүргэгдэхэд тохирохоор болж чаддаг. Тиймээс Эзэн Есүс болон Төгс Хүчит Бурхан бол хоёул өөр өөр эрин үед бие махбодтой болсон Бурхан бөгөөд нэг Бурхан юм.”

---

Ээжийн нөхөрлөл үндэслэлтэй, няцаахаар зүйлгүй байсан ч би төрөл бүрийн үзэлтэй хэвээр байсан болохоор: “Төгс Хүчит Бурхан эргэн ирсэн Эзэн Есүс юм хойно Түүнийг би Есүс гэх нэрээр дуудна уу, Төгс Хүчит Бурхан гэх нэрээр дуудна уу ямар ч ялгаагүй. Ямартай ч Тэр бол нигүүлсэл хайрладаг Бурхан” гэж тэр даруй хариуллаа. “Ехова Бурхан, Эзэн Есүс, Төгс Хүчит Бурхан бол нэг л Бурхан” гэж ээж хариулаад, “энэ эргэлзээгүй үнэн хэдий ч Бурхан эрин үе бүрд өөр нэр авдаг. Тиймээс Бурханы шинэ нэрийг хүлээн зөвшөөрснөөр л Бурханы авралыг хүлээн авч чадна. Энэ нь Хуулийн эрин үед Бурхан Ехова хэмээх нэрээр ажлаа хэрэгжүүлж, хүмүүс Еховагийн нэрээр залбирахад Бурхан хүнийг сонсож, ерөөдөг байсантай адил юм. Дараа нь Нигүүлслийн эрин үед Бурхан Эзэн Есүс гэх нэрийг ашиглан ажлаа хэрэгжүүлсэн тул хүмүүс Есүсийн нэрээр залбирах хэрэгтэй болсон. Эс бөгөөс тэд нүглээ ч уучлуулахгүй, Эзэний нигүүлсэл, ерөөлийг ч хүртэхгүй байх байсан юм. Израильчууд Эзэн Есүсийн нэрийг хүлээн зөвшөөрөөгүй учраас сүмд Ехова Бурханыг дуудан хашхирсан ч Бурханы өмнө очоогүй бөгөөд Эзэн Есүсийн авралыг хүртээгүйтэй энэ яг адилхан. Одоо Хаанчлалын эрин үе ирж, Бурхан Төгс Хүчит Бурхан гэх нэрээр шинэ ажлаа хэрэгжүүлж байна. Төгс Хүчит Бурханы нэрээр залбирснаар л чи Ариун Сүнсний ажил, Бурханы авралыг хүртэж чадна. Хэрэв Есүс гэх нэртэй зууралдан, Төгс Хүчит Бурхан гэх нэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол чухамдаа Бурханы урьдын ажилд итгэн, өнөөгийн ажлыг эсэргүүцэж, улмаар мөн чанартаа Бурханыг эсэргүүцэж, урваж байгаа хэрэг юм. **‘Чи амьд нэртэй боловч үнэндээ үхдэл юм’** (Илчлэл 3:1) гэж Ариун Библид хэлсэн байдаг. Бурханы шинэ нэрийг хүлээн зөвшөөрч, өнөөгийн үг, ажилд нь захирагдсанаар л бид Бурханд бодитоор итгэдэг болно. Миний хэлж байгааг чи ойлгож байна уу?” гэв.

Ээжийн минь хэлж байгаа бүхэн ухаалаг, бодитой санагдсан ч Эзэн надад тийм агуу нигүүлсэл хайрласан болохоор би Есүсийн нэрийг сэтгэлдээ тавьж явуулж чадахгүй л байлаа. Өнөөдөр надад байгаа бүхнийг Эзэн Есүс өгсөн, харин би Эзэнд итгэх итгэлээ зүй ёсоор хэрэгжүүлж, Эзэнийг дагана хэмээн анх өгсөн амлалтдаа тууштай байж чадаагүй. Тийм болохоор би Төгс Хүчит Бурханы сайн мэдээнээс татгалзсаар байлаа.

Зуны амралт дууссаны дараа би АНУ руу буцаж, завгүй хичээл ном, түргэн хэмнэлтэй амьдрал минь намайг “бодит” ертөнц рүү маш хурдан буцаан авчирлаа. Чуулганы үйлчлэл рүү эргэж очих бүрдээ пастор нь хятад чуулганых ч бай, англиар ярьдаг чуулганых бай ялгаагүй ямар ч номлолд нь шинэ зүйл гардаггүйг олж мэдэв. Үргэлж л нөгөө хуучин дуу, бүжиг байдаг байлаа. Чуулганы амьдрал залхмаар байсан бөгөөд аминдаа тэжээл авч байгаа мэт санагдахгүй байв. Сүргээ авч үлдэх гэсэндээ чуулганы хамтран зүтгэгчид ойр ойрхон аялал, зугаалга, үдэшлэг болон бас бус арга хэмжээ зохион байгуулж, бид бүгдийг оролцуулна. Чуулган дахь элдэв янзын хүмүүс дунд үнэн сүсэгтэй эрэлчид биш, зүгээр л



---

үерхэх хүн, өрөөний хамтрагч, хамт аялж зугаалж, хамт хоолонд орох хань хайсан гэх мэт хүмүүс олон байсан бөгөөд чуулган миний хувьд сэтгэлийн амар амгаланг олж болох газар байхаа больсныг ухаарсан юм. Энэ нь намайг шаналал, гунигт автуулаа. Хожим нь би үйлчлэлд оролцохоо бүр больсон ч байнга сэтгэлийн зовнилтой байх болов. Надад яг л замаасаа төөрчхөөд, амьдралд хагас ухаантай яваа цөхөрсөн хүүхэд шиг санагдаж байлаа.

2014 онд хүүгээ төрүүлсний дараа хөх минь сүүгүй байснаас болж нөхөр бид хоёрын дундах зөрчил хурцдав. Өдөр бүр нөхөр минь ажлаасаа тарж ирээд хамгийн түрүүнд: “За юу болж байна, бас л сүү ороогүй юу? Хөхөө хөхөхгүй бол хүүгийн минь дархлаа муудчихна даа” гэдэг байв. Тэгэхэд би огтоос эх хүн байх эрхгүй мэт санагдан, анх удаа л тэтгэлээ арга мухардаж үзсэн юм. Өрнө, дорнын эмч нарын аль алинд нь үзүүлж, гэрийн нөхцөлд эмчлэх арга хүртэл цахимаар хайсан ч сүү оруулахад юу ч тус болсонгүй. Галзуурахад ганц хуруу дутуу байгаа мэт сэтгэл өвдөн, гуньж гутарч, уур хилэн төрж, энэ чигээрээ яваад байвал удалгүй үнэхээр солиорох юм шиг санагдаж байлаа. Төрсний дараах амралтынхаа туршид цаг ямагт нүдэндээ нулимстай байж, надад яагаад ийм зүйл тохиолдож байгааг яагаад ч ойлгож чадсангүй. Зүйрлэхийн аргагүйгээр байнга сэтгэл үймж, “эхийн сүү” юм уу “хөхүүлэх” гэсэн үг сонсмогцоо л шууд уйлж эхлэхэд бэлэн, өөрийгөө хянах ямар ч чадваргүй байлаа.

Хэцүү нөхцөлд байгааг минь мэдээд, ээж хилийн чанадаас намайг асрахаар ирэв. Намайг яаж зовж байгааг хараад, ээж ингэж хэллээ: “Амьдрал чинь яагаад улам бүр харанхуйлж, зовлонтой болж байгааг чи ер нь бодож үзсэн үү? Бурханд итгэдэг ч үнэнийг эрж хайхгүй болохоор тэр шүү дээ. Эзэн эргэн ирчхээд байхад чи эрж хайж, судалдаггүй. Оронд нь өөрийнхөө үзэл, төсөөлөлтэй сохроор зууралдаж, бусад бүх хүний ам дагуулан, дур зоргоороо Бурханы шинэ ажлыг шүүж байна. Энэ бол Бурханыг эсэргүүцэж байгаа хэрэг! Чи Бурханы шинэ ажлыг хүлээн зөвшөөрдөггүй болохоор Бурханы халамж, хамгаалалтыг алджээ. Тэгээд Сатаны эзэмшил дор амьдарч байгаа чинь чиний амьдралыг улам бүр зовлонтой болгож, эцэстээ чи цөхөрч, Сатаны доог тохуу л болж үлдэнэ.” Ээжийнхээ ингэж хэлэхийг сонсоод би дуугаа хураалаа. Дараагийн өдрүүдэд нь ээж хүүг минь унтуулчхаад надад дандаа Бурханы үгийн магтан дуу сонсгодог байв. Тэгээд гайхмаар зүйл тохиолоо. Эдгээр магтан дууг сонсохтой зэрэгцээд оюун санаа минь гэнэт аажмаар тайвширч эхлэв. Нэг удаа би ийм магтан дуу сонссон юм: “...Хүний зүрх сэтгэл болон сүнс Бурханаас хэтэрхий хол байдаг учраас, тиймдээ ч хэдий Бурханыг дагаж байсан ч сатанд үйлчилсээр л байдаг бөгөөд үүнийгээ ч хүртэл мэддэггүйд оршиж байгаа юм. Бурханы мөр болон илрэлтийг хэн ч идэвхийлэн эрж хайдаггүй бөгөөд Бурханы халамж, хамгаалалт дор оршихыг хэн ч хүсдэггүй. Харин оронд нь тэд энэ хорвоо, хорон муу хүн төрөлхтний дагадаг оршин тогтнолын дүрэмд дасан

---

зохицохын тулд ёрын муу нэгэн болох сатаны муу нөлөөнд түшиглэхийг хүсдэг. Энэ цаг үед хүн зүрх сэтгэл, сүнсээ Сатанд барих өргөл, Сатаны идэш тэжээл болгосон. Тэр ч бүү хэл хүний зүрх сэтгэл, сүнс нь Сатаны орогнож болох газар, зугаацахад тохиромжтой талбар болсон билээ. Тиймээс, хүн байх зарчим, хүний оршин тогтнолын үнэ цэн, утга учрын талаарх ойлголтоо хүн өөрөө ч мэдэлгүй гээдэг. Бурханы хууль, Бурхан, хүн хоёрын гэрээ хүний зүрх сэтгэлд аажмаар бүдгэрч, хүн Бурханыг эрж хайн, Бурханд анхаарал хандуулахаа больдог. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр хүн Бурхан яагаад өөрийг нь бүтээснийг, түүнчлэн Бурханы амнаас гарч байгаа үг болон Бурханаас гаралтай бүхнийг ч бас ойлгохоо больдог. Дараа нь хүн Бурханы хууль, зарлигийг эсэргүүцэж эхэлдэг ба зүрх сэтгэл, сүнс нь мэдээгүй болдог... Бурхан анх бүтээсэн хүнээ алдаж, хүн эх үндсээ алддаг: Энэ бол энэ хүн төрөлхтний уй гашуу билээ” (Хургыг дагаж, шинэ дуу дуулья номын “Завхарсан хүн төрөлхтний харуусал”). Төгс Хүчит Бурханы үгийн хамгийн сүүлийн мөр сэтгэлийн минь утсыг хөндлөө. Би Бурханы үгэнд дүрсэлсэн яг тийм байдалд орж, аман дээрээ Бурханыг хүлээн зөвшөөрсөн ч бодит байдал дээр зүрх сэтгэл минь бүхэлдээ Сатанд эзэмдүүлсэн байсныг олж харав. Бүх бодол, мэдрэмжээ махан биеийн асуудалд хандуулан, махан биеийн араас л бас хөөцөлдөж, сүсэг бишрэлгүй замаар уруудаж явжээ. Ариун Библид ийн хэлдэг: “Учир нь махбодоор анхаарал тавих нь үхэл; харин сүнсээр анхаарал тавих нь амь ба амар тайван юм” (Ром 8:6). “дэлхийтэй найзлах нь Бурхантай дайсагнаж байгаа хэрэг гэдгийг чи мэдэхгүй юу? Тиймээс дэлхийтэй найз хэн боловч Бурханы дайсан байх болно” (Иаков 4:4). Миний үйлдэлд Бурханы хүсэлтэй нийцэх зүйл огт байхгүй, бүгд Бурханы яг эсрэг чиглэсэн байгаа талаар би бодлоо. Тэгээд Бурханы өмнө очиж залбирав: “Өө Бурхан минь, эрдмийн зэрэг, хувь хүний онцлог, гэрлэлт, дэлхийн бас бус зүйлийг л эрхэмлэж, энэ байхад л хангалттай гэж боддогоосоо болж өнөөдөр би ийм байдалд оржээ. Би үнэнийг ердөө ч эрж хайгаагүй, Бурханыг мэдье гэж ч эрэлхийлээгүй. Тэгээд бүр Таныг зүрх сэтгэлийн минь хаалгыг тогшиж, яг нүдний минь өмнө Бурханы үг, үнэнийг дэлгэж байхад хүртэл би нандигнаж чадсангүй. Таныг шинэ ажил хэрэгжүүлэхээр ирсэн гэж сонсохдоо би гөжүүд, үзэл сурталжсан байсан тул үндэслэлгүй дүгнэлт хийсэн. Ээжийн минь нөхөрлөл үндэслэлтэй гэдгийг би сайн мэдэж байсан ч өөрийн үзлийг зөрүүдлэн баримталж, үнэн замыг судлаагүй. Өө Бурхан минь, би үнэнийг голчхоод, нигүүлслийг тань л нандигнаж, үнэхээр зөрүүд, тэрслүү байжээ! Хэрэв Та надад дахин боломж олгох юм бол Таны ажлыг би чадах чинээгээрээ заавал судална.” Ийм залбирлыг минь Бурхан сонсох эсэхийг тухайн үед мэдэхгүй байсан ч би Бурханд хандан ийнхүү залбирсаар байсан юм.

2015 оны дөрөвдүгээр сард би эрүүл мэндийн асуудлаар ээжтэйгээ цуг Хятад

---

буцсанаар Төгс Хүчит Бурханы Чуулгантай холбоо тогтоох боломж тохиосон билээ. Би энэ хорвоод аз жаргалыг ололгүй шамдан, зүдэрч явснаа, бас зүрх сэтгэлээ харанхуй, хоосролоос ангижруулж чадах үнэнийг шашин дотроос ч олж чадаагүй талаараа бодлоо. Магадгүй миний хүлээн зөвшөөрөхөөс татгалзсаар ирсэн Төгс Хүчит Бурхан бол намайг коллежид тэнцэж, Америкийн нэгдсэн улс руу явахад тусалсан Аврагч Есүс байсантай энэ бүхэн холбоотой байх гэсэн хүчтэй мэдрэмж зүрх сэтгэлд минь төрж байв. Ийм бодол төрөхөөр нь би Төгс Хүчит Бурханы Чуулганы үйл ажиллагаанд оролцмоор байна гэж ээждээ хэллээ. Төд удалгүй Төгс Хүчит Бурханы Чуулганы ах эгч нар надтай уулзахаар ирсэн бөгөөд тэдний цуглах үедээ уншдаг зүйл нь Бурханы үг, нөхөрлөж хэрэгжүүлдэг зүйл нь үнэн болохыг би харлаа. Тэд юу ч хийсэн бай Бурханы үг тэдний стандарт, үнэн тэдний зарчим болж байв. Тэд махан биеийн эрхээр үйлддэггүй, өөр хоорондоо сүсэггүй харьцалт ч хийдэггүй ажээ. Төгс Хүчит Бурханы Чуулган бол үнэнд захирагддаг Канааны сайхан нутаг болохыг би харав. Тэр газарт сүнс минь цадаж, хангагдаж, зүрх сэтгэл минь хоосрохоо болиң, сэтгэл ханамжийг би олж авсан юм.

Нэг өдөр хэдэн ах эгчтэй дахин цуглаж байх үеэр Ван эгч Бурханы үгээс энэхүү хэсгийг уншив: **“Гүнээ зовсон энэ хүмүүсийг Төгс Хүчит Нэгэн өршөөдөг; үүний зэрэгцээ, хүмүүсийн хариултыг хэтэрхий удаан хүлээх ёстой байсан тул ухаан алдсан энэ хүмүүсээс Тэр залхсан. Тэр эрж хайхыг хүсдэг, зүрх сэтгэл, сүнсийг чинь эрж хайн, чамайг цаашдаа өлсөж, цангахгүй байгаасай гэсэндээ чамд ус, хоол хүнс авчирч, чамайг сэрээхийг хүсдэг. Эцэж ядран, энэ дэлхийн зэврүүн хоосролын заримыг мэдэрч эхлэх үедээ бүү төөрөлд, бүү уйл. Төгс Хүчит Бурхан, Харгалзагч, чамайг хэдийд ч ирсэн тэврэн авна. Тэр хажууд чинь чамайг ажиглаж, эргэж буцахыг чинь хүлээж байгаа. Бурханаас ирсэн гэдгээ, мөн хэдийд ч юм зүг чигээ алдаж, хэдийд ч юм замдаа ухаан балартаж, хэдийд ч юм ‘эцэгтэй’ болсон гэдгээ ухаарахыг чинь; түүнчлэн Төгс Хүчит үргэлж ажиглаж, эргэн ирэхийг чинь маш урт удаан хугацаанд хүлээж байсан гэдгийг ухааран, гэнэтхэн ой санамжаа сэргээх өдрийг чинь Тэр хүлээж байна”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Төгс Хүчитийн санаа алдалт”). Бурханы үгийн энэ хэсэг сэтгэлийг минь их хөдөлгөлөө. Төгс Хүчит Бурханыг би яг л төөрсөн үрээ дуудан, удахгүй эргээд ирнэ дээ гэсэн хүлээлттэй суугаа элбэрэлт эх хүн адилаар мэдрэв. Энэ бол Эзэний дуу хоолой гэдгийг би сонсож чадлаа. Төгс Хүчит Бурхан бол ар араасаа тохиох хямралыг даван туулахад минь удаа дараа тусалж, замын алхам тутамд намайг хэзээ ч орхилгүй, буцан ирэхийг минь цөхрөлтгүй хүлээсэн Эзэн Есүс болохыг ухаарав. Би Бурханд итгэдэг атлаа үнэнийг эрж хайж, Бурханы үгэнд итгэхийн оронд цахим цуу яриа, пасторын үгэнд итгэж байснаа бодлоо. Би дайсны талд орж, ХКН-ын засгийн газар болон шашны нийгэмлэгийн пасторуудтай нийлээд, өдөр

---

шөнөгүй намайг халамжилж байсан Бурханыг муулан, дайрч давшилж байжээ. Бурханы авралыг би голсон байж. Тэгээд үнэхээр харалган, мунхаг байжээ. Бурханд итгэх итгэл минь үзэл, төсөөлөл дээр минь суурилсан хэвээр байсан бөгөөд их сургуульд амжилттай тэнцэж, эрдэм номын мөр хөөхөөр хилийн чанад руу саадгүй явахад минь Эзэн Есүс тусалсан болохоор Эзэн Есүсийн нэрд үргэлж үнэнч үлдэх ёстой, Эзэн Есүст сүсэгтэй байхад л хангалттай гэж итгэжээ. Аливааг харах өнцөг минь үзэл, төсөөлөлд минь тулгуурлаж байсан. Бурхан шинэ эринийг эхлүүлж, шинэ нэр авах үед би Бурханы ажлыг хүлээн зөвшөөрөлгүй, намайг гэсэн Бурханы авралаас удаа дараа татгалзжээ. Үүнийг юу гэж Бурханд итгэх итгэл гэх юм бэ? Зүгээр л өөртөө итгэж байсан хэрэг биш үү? Бурханы надад гагцхүү хайр л өгч байсан атал Бурханыг би удаа дараа шархлуулжээ. Бурханд асар их өртэй болсноо би мэдэж байлаа ...

Би үнэхээр өөрийн эрхгүй сөгдөн мөргөж, гашуун нулимс унаган Бурханд ийнхүү залбирав: “Өө Төгс Хүчит Бурхан минь! Би харалган, мунхаг байжээ. ХКН-ын засгийн газар болон шашны ертөнцийн цуу ярианд итгэн, Таныг хаяж, яллаж, үзэл төсөөлөлдөө тулгуурлан Таныг хязгаарласан. Эцсийн өдрүүдийн сайн мэдээнээс тань би татгалзсан. Би бол орчин цагийн фарисай юм байна. Зан байдал, үйл хэргээр минь дүгнээд л намайг Сатантай хамт устгавал зохих хэдий ч Та намайг хайрлан, цаг байгаа учраас гэмших боломж дахин олгожээ. Өө Бурхан минь, би Ниневегийн хүмүүс шиг Таны өмнө ирж ‘таар өмсөн, үнсэнд сууж’, нүглээ Танд үнэн сэтгэлээсээ улайж, гэмшихэд бэлэн байна. Намайг өршөөгөөч гэж Танаас гуйя. Би Тантай хамтран ажиллаж, Таны үгээр цэвэрлэгдэж, аврагдмаар байна.”

Дараа нь Төгс Хүчит Бурханы Чуулганы ах эгч нар надтай уулзахаар долоо хоногт гурван удаа ирэх болов; ингэж тасралтгүй ирсээр дөрвөн сар гаруйн нүүр үзлээ. Энэ хугацаанд би бараг өдөр бүр шахуу Бурханы үгээс хэд хэдэн хэсгийг уншдаг байсан ба үнэнийг ойлгож авах тусам Бурхантай харилцах харилцаа минь улам зөв зохистой болж, анх байсан итгэл минь сэргэсэн юм. Зүрх сэтгэл минь амар тайван болж, түгшүүр, хоосролыг мэдрэхээ болилоо. Төгс Хүчит Бурханы үгийг уншиж, цуглаан дээр үнэнийг нөхөрлөснөөр эцсийн өдрүүд дэх Бурханы ажилд бат үнэмшин, Төгс Хүчит Бурхан бол миний эргэн ирээсэй гэж хүсэмжилж байсан Эзэн Есүс гэдэгт туйлын итгэлтэй болсон юм. Би Төгс Хүчит Бурханыг эцсээ хүртэл дагаж, үнэнийг эрэлхийлдэг нэгэн болж Бурханы хайрыг хариулахаар шийдлээ.

2016 онд би АНУ-д буцаж очоод тэндээ Төгс Хүчит Бурханы Чуулганы ах эгч нартай вэбсайтаар нь холбоо тогтоож, чуулганых нь үйл ажиллагаанд оролцож эхэлсэн юм. Бурханд талархъя! Одоогийн минь байгаа газар луу Бурхан л намайг алхам алхмаар

---

хөтөлжээ. Бурханы хайрыг хариулахын тулд би Бурханы сайн мэдээ түгээх ажлыг бүх чадлаа дайчлан хэрэгжүүлэхийг хүсдэг бөгөөд тэгснээр Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс гэдгийг үнэнийг эрж хайн, үүгээр ангаж цангаж буй улам олон хүн мэдэж авч чадна. Миний замаар орж, Сатаны цуурхалд сохроор итгэн, Сатантай хамт Бурханыг эсэргүүцэх юм бол эцэстээ өөрсдөө л хохирч үлдэнэ гэдгийг ч би тэдэнд хэлнэ.

## **38. Бурхан миний дэргэд байдаг**

Гуожи, АНУ

Би Христэд итгэгч гэр бүлд төрсөн бөгөөд намайг нэг настай байхад ээж маань эмээгийн эрс эсэргүүцлийг үл тоон, эргэн ирсэн Эзэн Есүс буюу Төгс Хүчит Бурханы шинэ ажлыг хүлээн авсан юм. Намайг бага байхад эмээ маань үргэлж л “Хэрэв сэтгэл санаа чинь сайнгүй, эсвэл гэрийн даалгавраа хийж чадахгүй бол Эзэн Есүст залбираарай. Тэр чамд оюуны чадамж, мэргэн ухаан хайрлана, бас чамайг хамгаална” гэж хэлдэг байлаа. Гэвч ээж надад: “Бурхан энэ дэлхийг бий болгож, хүн төрөлхтнийг бүтээсэн. Тэр үргэлж бидэнтэй хамт байдаг. Ямар нэгэн асуудал тулгарвал Төгс Хүчит Бурханд залбирахаа битгий март, Тэр чамайг харж хандаж, хамгаална” гэж үргэлж хэлдэг байв. Ийм хоёр өөр дуу хоолой миний чихэнд байнга сонсогддог байв. Би ээжээсээ: “Эмээ намайг Эзэн Есүст залбир гэсэн, харин та намайг Төгс Хүчит Бурханд залбир гэж хүсдэг. Би хэний үгийг сонсох ёстой вэ?” гэж нэг удаа эргэлзэнгүй асуусан юм. Ээж маань: “Үнэндээ, Эзэн Есүс, Төгс Хүчит Бурхан хоёр бол нэг л Бурхан юм. Зүгээр л цаг хугацаа нь өөр, Бурханы авдаг нэрс нь өөр, бас хийдэг ажил нь ялгаатай. Эзэн Есүс Нигүүлслийн эрин үеийн ажлыг хийсэн бөгөөд Төгс Хүчит Бурхан Хаанчлалын эрин үеийн ажлыг хийдэг. Тэрээр эрин үе болгонд ажиллах арга замаа өөрчилдөг, бас нэрээ өөрчилдөг. Түүний нэр болон ажил яаж ч өөрчлөгдсөн бай, мөн чанар нь өөрчлөгддөггүй. Жишээлбэл, өнөөдөр чи сургуульд явахдаа улаан өнгийн хувцас өмсөж, маргааш ресторанд орохдоо цэнхэр хувцас өмслөө гэж бодъё—өөр хувцас өмсөж, өөр өөр газарт өөр өөр зүйл хийсэн хэдий ч чи бол чи хэвээр л байна. Харин Бурханы шинэ эрин үе ирэхэд бид Түүний шинэ ажилтай хөл нийлүүлэх ёстой. Тийм учраас бид одоо Төгс Хүчит Бурханд залбирах хэрэгтэй” гэж хэлсэн юм. Ээжийнхээ тайлбарыг сонссон ч гэсэн би тун их будилсан хэвээр байсан бөгөөд Төгс Хүчит Бурханы шинэ ажилд нэг л эргэлзсэн хандлага өвөрлөсөөр байлаа.

2014 оны 8 дугаар сард би АНУ-д суралцахаар ирлээ. Ээж маань ч бас хэдэн сарын дараа ирээд АНУ дахь Төгс Хүчит Бурханы Чуулгантай холбоо тогтоов. Тэр цагаас эхлэн

---

би Төгс Хүчит Бурханы оршин тогтнолыг бага багаар мэдэрч эхэллээ. Би АНУ-д суралцахаар дөнгөж ирснийхээ дараа эндхийн амьдрал, тэр дундаа айлд амьдрангаа суралцана гэдэг дасан зохицоход үнэхээр хэцүү болохыг мэдсэн юм. Би үнэхээр хулчгар тул ганцаараа унтахаас айдаг байв. Ээж маань надад: “Бурханы эрх мэдэл цор ганц гэдэгт бид итгэх ёстой. Сатан, чөтгөрүүд ч бас Түүний эрх мэдэл дор байдаг тул чи шөнө айх юм бол зүгээр л Бурханд залбир. Зүрх сэтгэлд чинь Бурхан байгаа цагт Сатан чамд ойртож чадахгүй” гэж хэлсэн юм. Ээжийнхээ нөхөрлөхийг сонсох болгонд хавьгүй тайван амгалан, санаа амар санагддаг байлаа.

2015 оны 12 дугаар сард би Төгс Хүчит Бурханы Чуулганы цуглаанд оролцож эхэлсэн боловч итгэлийн талаар сайн ойлголтгүй байсан учраас ихэнхдээ өөрийгөө хүчлэн оролцдог байв. Хоёр үйл явдлыг биеэр туулсныхаа дараа л би Бурханы жинхэнэ оршин тогтнолыг бодитоор ухаарах болж, түүнээс хойш, Төгс Хүчит Бурхан бол нэгэн жинхэнэ Бурхан бөгөөд үргэлж миний дэргэд байдаг гэдгийг зүрх сэтгэлийн угаас баталж чадсан юм...

Нэг Баасан гарагийн үдээс хойш тэр өдрийн хичээлээ үндсэндээ дуусгаад гэртээ харихын өмнө ганцхан дүрслэх урлагийн хичээл л үлдсэн байлаа. Гэтэл ангийн маань нэг хүүхэд надад гэнэт: “Хамгийн сүүлийн цагийг таслаад, хотын төв орж, хоол идэж, дэлгүүр хэсэцгээе. Тэнд үнэхээр сайхан хоолтой далайн хоолны шинэ газар нээгдсэн гэнэ” гэж хэлэв. Үүнийг сонсоод би уруу татагдав—өдрийн хоолонд юу ч идээгүй болохоор үнэхээр өлсөж байлаа. Ходоод хонхолзон, бараг л далайн хоолны ресторан руу хурдан оч гэж шавдуулж байгаа мэт байв. Гэхдээ би эргэлзсээр байлаа. “Би хэзээ ч хичээлээ тасалж байгаагүй шүү дээ. Баригдвал яах болж байна аа?” гэж бодогдов. Гэхдээ дараа нь би: “Манай ангийн Шиаоли бүр чухал хичээлүүдийг ч тасалдаг, тэгээд баригдалгүйгээр маш олон удаа тасалсан юм чинь би ч гэсэн баригдахгүй” гэж бодлоо. Тиймээс би ангийнхаа хүүхэдтэй хамт явахыг зөвшөөрч, үдээс хойш эмчид үзүүлэх ёстой учир эрт явах хэрэгтэй байна хэмээн дүрслэх урлагийн багшдаа хэлээд чөлөө авав. Тэгээд ангийнхаа хүүхэдтэй хамт хотын төвд хоол идэж, дэлгүүр хэсэхээр такси барьсан бөгөөд оройн найм, есөн цаг болтол гэртээ харьсангүй. Харьсныхаа дараа би гадаад оюутан хариуцсан багшаас, дараа сургуульдаа ирэхдээ эмчид үзүүлсэн бичиг баримтаа авч ирэхийг хүссэн э-мэйл хүлээн авлаа. Үүнийг хараад би сандарч, ангийнхантайгаа яаравчлан зөвлөлдөв. Нэг нь: “Багшид ямар ч бичиг баримт аваачиж өгөх хэрэггүй. Тэр бол хувийн асуудал” гэж хэллээ. Би түүний хэлснийг зөв гэж бодсон боловч энэ асуудлын хувьд миний буруу байсан тул өөрийнхөө төлөө эгдүүцэн маргалдана гэхээс ичиж байсан юм. Тиймээс би энэ асуудлаас гарах арга олоход минь туслаач гэж байрны эзэн эмэгтэйгээс хүсэв. Тэрээр хариуцсан багш дээр очиж, буруугаа хүлээ гэж хэлсэн юм. Хэлснийг нь сонсоод санаа зовлоо—би

---

буруугаа хүлээх ёстой юу, эсвэл үргэлжлүүлэн мэхлэх үү гэдгээ мэдэхгүй байв. Тэгээд унтаж чадалгүй шөнөжингөө эргэж хөрвөөлөө. Би буруугаа хүлээхийг хүсэж байсан боловч багш, бас ангийнхан маань намайг юу гэж бодох бол гэдгээс, миний үргэлж хадгалдаг эерэг дүр төрх нүд ирмэх зуур устаж үгүй болох вий гэхээс айж байлаа. Зовж шаналан байхдаа би залбирч, эрж хайхаар Бурханы өмнө очсон ба дараа нь Бурханы үгээс энэ хэсгийг уншив: **“Тэхдээ ов мэхтэй хүмүүс ингэж үйлддэггүй. Тэд Сатаны гүн ухаан, өөрсдийн ов мэхтэй уг чанар, мөн чанарт үндэслэн амьдардаг. Бусад хүн өө сэвийг нь атгачих вий гэсэндээ тэд бүх зүйл дээр анхааралтай байх хэрэгтэй болдог; эрт орой хэзээ нэгэн цагт өөрсдийгөө илчлэх вий гэж айсандаа үнэн нүүр царайгаа далдлахын тулд тэд хийж байгаа бүхэндээ өөрсдийн арга барилыг, мөн өөрсдийн ов мэхтэй, шударга бус ов мэхийг ашиглах ёстой болдог—тэгээд үнэн төрхөө харуулах үедээ тэд аливааг өөрчлөхөөр оролддог. Тэгээд аливааг өөрчлөхөөр оролдоход тийм ч амар биш үе олон байдаг бөгөөд чадахгүй бол тэд түгшиж эхэлдэг. Бусад хүн өөрсдийг нь нэвт харна гэдгээс тэд айдаг; тийм зүйл тохиолдох үед, өөрсдийгөө шившиг болголоо гэж тэдэнд санагддаг, тэгээд нөхцөл байдлыг засаж залруулах ямар нэгэн зүйл хэлэх арга зам бодох хэрэгтэй болдог... Оюун ухаандаа тэд, чамд өөрсдийгөө буруугаар ойлгуулахаас сэргийлэх талаар, өөрсдийнхөө хэлж байгааг чамд хэрхэн сонсгох талаар, мөн санаанд нь байгаа зорилгод хүрэх талаар юу хийж байгаагаа чамд харуулах талаар үргэлж боддог. Иймээс тэд үүнийг толгойдоо ахин дахин эргэцүүлдэг. Шөнө унтаж чадахгүй байх үедээ тэд энэ талаар боддог; өдрийн цагаар хоол идэж чадахгүй бол энэ тухай бодож байдаг; бусадтай ярилцах үедээ үүнийг зөвшилцдөг. Өөрсдийг нь тийм хүн гэж бүү бодоосой гэсэндээ, өөрсдийг нь сайн гэж бодоосой гэсэндээ, эсвэл тэд ийм санаатай байгаа юм байна гэж бүү бодоосой гэсэндээ тэд үргэлж дүр эсгэдэг”** (Христийн ярианы тэмдэглэл номын “Үнэнч хүн байх хамгийн үндсэн хэрэгжүүлэлт”). Бурханы үг болгон ар араасаа доторх бодлыг минь ил болгон, зүрх сэтгэлийн минь харанхуй хэсэгт гэнэт гэрэл цацруулж, гэрэлтүүлэх мэт намайг ихэд ичээж, нүүр хийх газаргүй болгож орхив. “Тийм шүү! Би хичээлээ тасалж, худлаа ярьсан. Дараа нь алдаагаа хүлээн зөвшөөрөх санаачилга гаргаагүйгээр үл барам, харин ч худал үгээ нуун далдалж, үнэнийг нуун дарагдуулах арга зам бодож олохоор тархиа гашилгасан. Гэмших, харамсах сэтгэл өчүүхэн төдий ч төрөөгүй. Тэр ч бүү хэл, гадаад оюутан хариуцсан багш бусдын хэрэгт хошуу дүрэх ёсгүй гэж бодсон. Өө! Иймэрхүү үйлдэл нь Бурханы эсрэг тэрсэлдэг бөгөөд Бурхан үүнийг зэвүүцдэг! Миний бодол санаа, үйл хэргийн аль нь ч Бурханы шаардлагад нийцэхээргүй байна—Бурханд итгэгч ингэж авирладаггүй! Үгүй ээ, би үл итгэгчдийн аргаар асуудлаа шийдэх ёсгүй. Би Бурханы өмнө гэмшиж, Түүний шаардлагын дагуу үйлдэх ёстой. Үнэнээ хэлж, үнэнч хүн байх ёстой” гэж би бодлоо.

---

Тиймээс, маргааш нь хичээлдээ очоод би багш дээр очиж, хичээл тасалсан буруугаа хүлээн зөвшөөрөв. Гадаад оюутан хариуцсан багш намайг огт зэмлэлгүй, харин оронд нь намайг маш үнэнч байна, алдаагаа хүлээн зөвшөөрч чаддаг байх нь сайн зүйл гэж хэлэхэд би гайхан цочирдсон юм! Гэвч, хичээл тасалсны шийтгэл заавал байх ёстой тул хичээл тарсны дараа багш намайг үлдээж, юу хийснийг минь сайтар бодуулахын тулд нэг цаг суулгалаа. Хичээл тасалж, худал ярьсныхаа төлөө би маш өчүүхэн шийтгэл хүлээсэн хэдий ч Бурхан намайг хамгаалж байгаа болохыг мэдрэсэн юм. Хожим нь би цуглаан дээр энэ үйл явдлын талаар чуулганы эгчтэйгээ нөхөрлөв. Миний яриаг сонсоод эгч надад Бурханы хэлсэн үгээс энэ хэсгийг уншиж өглөө: **“Хэрэв чи Бурханы захиралтад итгэдэг бол өдөр бүр тохиолддог сайн, муу аль ч зүйл санаандгүй тохиолдол биш гэдэгт итгэх ёстой. Хэн нэгэн чамд зориуд хатуу хандаж, чамайг онилж байгаа юм биш; үнэн хэрэгтээ энэ бүгдийг Бурхан зохицуулдаг. Бурхан юуны төлөө эдгээр зүйлийг зохион байгуулдаг вэ? Дутагдлыг чинь илчилж, чамайг ил болгохын төлөө ингэдэг юм биш; чамайг илчлэх нь эцсийн зорилго биш. Харин чамайг төгс болгож, аврах нь эцсийн зорилго юм. Бурхан яаж тэгдэг вэ? Нэгдүгээрт, Тэр чамд завхарсан зан чанар, уг чанар, мөн чанар, дутагдал, дутагддаг зүйлийг чинь ухамсарлуулдаг. Чи зүрх сэтгэлдээ эдгээр зүйлийг мэдэж, ойлгосноор л үнэнийг эрэлхийлж, завхарсан зан чанараа аажмаар хаяж чадна. Энэ нь Бурхан чамд боломж олгож байгаа хэрэг юм”** (Христийн ярианы тэмдэглэл номын “Үнэнийг олж авахын тулд эргэн тойрныхоо хүмүүс, юмс, зүйлсээс суралцах ёстой”). Бурханы үгийн талаар нөхөрлөснөөр би, ангийнхан маань хичээлээ маш олон удаа тасалсан ч юу ч тохиолдоогүй атал би яагаад эхний удаадаа л багшид баригдсанаа ойлгож авсан юм: Энэ нь үнэхээр Бурханы дээд эрх байлаа. Бурхан намайг илчилж, цээрлүүлж, сахилгажуулах орчныг бодитой байдлаар бий болгосон; намайг өөрийнхөө сатанлаг уг чанарыг ойлгож, худал хэлж, хууран мэхэлдэг завхарсан зан чанараа мэдэж, улмаар үнэнийг эрэлхийлж, үнэнч хүн байж, хүний төрхийг амьдран харуулахад хүргэх гэсэндээ үүнийг хийсэн байв. Энэ нь Бурхан намайг хайрлаж, аварч байгаа хэрэг байв! Урьд нь хүн бүр намайг сайн хүүхэд гэж магтдаг, би ч бас өөрийгөө үргэлж тэгж боддог байсан юм. Гэвч баримтуудын илчлэлээр дамжуулан, мөн Бурханы үгээр шүүгдэж, илчлэгдээд би өөрийнхөө уг чанарын шударга бус, зальжин байдлыг эцэст нь ухаарсан билээ. Би улайм цайм худлаа ярьж, хууран мэхэлж чаддаг байсан бөгөөд үнэхээр жаахан биеийн хэмжээтэй байжээ. Цаг ямагт, газар сайгүй би үл итгэгчдийг дагаж, завхарсан зан чанар дотроо амьдарч, улмаар Бурханы нэрийг шившиглэх чадвартай байв. Багш намайг ангид үлдээж шийтгэсэн. Хэдийгээр махан бие маань бага зэрэг зовсон ч энэ сургамжийг санаж, цаашид хэзээ ч худлаа ярихгүй. Хэрэв би тэр үед хичээл таслаад баригдаагүй бол дараа нь туршилт, уруу таталттай тулгарах үедээ үүнийгээ дахин хийхийг хүсэх байсан. Тэгээд би зүгээр л ахин дахин худлаа ярьж, улам найдваргүй, улам зальтай



---

болж, эцэстээ Сатан намайг бүрмөсөн үхүүлэх байжээ. Бурхан үнэнч хүмүүсийг хайрлаж, авардаг ба ов мэхтэй хүмүүсийг үзэн ядаж, таягдан хаядаг учраас тэр үед Бурхан намайг бүр хүлээн зөвшөөрөхөө ч болих байв. Яг тэр мөчид би худал ярих нь ямар их хор хөнөөл учруулдгийг эцэст нь тодорхой харсан бөгөөд бас үнэнч хүн байх нь хэчнээн чухал болохыг олж харсан юм!

Нэг их удалгүй бид тооны шалгалт өгсөн юм. Урд орой нь хичээлээ давтаж байхдаа би, эзэмшиж чадаагүй сэдэв бас л олон байгааг олж мэдэв. Дараа өдөр нь шалгалттай байсан болохоор би үнэхээр их санаа зовлоо. Их сургуульд ороход тэр улирлын шалгалтын дүн хамгийн чухал байдаг учраас тэр жилийн дүнгүүдийг минь хараад, хэрвээ тооны хичээл дээрээ уначихсан байх юм бол урьдын бүх шаргуу хөдөлмөр минь талаар болох байв. Бодох тусам би улам түгшиж байлаа. Маргааш нь шалгалтаас хэдхэн минутын өмнө би бүх томьёог бичсэн дэвтрээ авчрахаа мартсанаа анзаарсан юм. Би бүр самгардаж орхилоо. Тэр тэмдэглэлийн дэвтэр дээр маш олон жишээ бодлого нууцаар тэмдэглэчихсэн байсан боловч одоо алга болгочихсон болохоор шалгалтдаа унах нь гарцаагүй болов. Хаа нэгтээ шалан дээр санамсаргүй унагаачихсан байх вий гэх өчүүхэн найдвар тээгээд би хаа сайгүй хайлаа. Дээгүүр доогуур хайж байхдаа би хажууд сууж байгаа сурагчийн шалгалтын хуудсан дээрх хариултыг нууцаар харчхав. Ийм аз дайрсанд баясаж, найдварын оч харсан мэт санагдлаа. Багшийг хулгайгаар сэм харахад компьютерынхоо урд ажилдаа төвлөрчихсөн сууж байлаа. Тэгэхээр нь би тооны шалгалтын бүх асуултад хурдхан шиг хариулж биччихээд хажуугийн сурагчаа хөнгөхөн цохиж, хариултуудаа харьцуулъя гэж дохив. Хэдий хариултуудаа харьцуулъя гэж хэлсэн ч үнэндээ би түүний хариултуудыг өөрийнхөө шалгалтын цаасан дээр хуулахыг хүссэн юм. Тэр бүх хугацаанд сэтгэл түгшин, энэ маягаар сэм харсаар тооны хичээлийн шалгалтыг би давлаа.

Би хамгийн муу мэддэг хичээлийнхээ учрыг эцэст нь нэг юм олчихлоо хэмээн бодоод, амралт эхэлмэгц цагийг сайхан өнгөрүүлэхээр төлөвлөж байлаа. Хачирхалтай нь гэхдээ хэдэн өдрийн дараа сургууль эцэг эх, асран хамгаалагчдын хурал хийж, байрны маань эзэн эмэгтэй миний оронд дүнгийн дэвтрийг авахаар очив. Тэгээд намайг бүх хичээл дээрээ сайн дүн авсан боловч хичээлийн шударга байдалтай холбоотой асуудал байж магад гэж сургууль сэжиглэсэн учраас тооны хичээлийн дүнг бусад дүнтэй хамт тавиагүй гэж тэр хэлэв. Үүнийг сонсоод би сэтгэлээр навс уналаа—сэтгэл минь зовнин, үймэрч, юу хийхээ мэдэхгүй байсан юм. Би дотроо: “Хичээлийн шударга байдалтай холбоотой асуудал гэнэ үү? Ангийнхаа хүүхдийн хариултыг хуулсныг минь мэдчихсэн юм болов уу? Тийм бол би яах билээ? Хүнээс хуулах бол ноцтой асуудал болохоор их сургуульд орох боломжид минь ч нөлөөлж магадгүй. Гэхдээ одоогоор сургууль зөвхөн сэжиглэж л байгаа болохоор надад найдвар байна. Тодорхой тайлбар өгч чадах л юм бол зүгээр байх хэдий ч би үүнийг

---

яаж тайлбарлах билээ? Би үнэхээр хүнээс хуулсан шүү дээ. Магадгүй зүгээр л очоод, хэргээ хүлээх хэрэгтэй юм болов уу?” гэж ахин дахин бодлоо. Тэгээд үүнийг ахин дахин эргэцүүлэв. Ангийнхан маань ямар ч тохиолдод хэргээ хүлээж болохгүй, ямар нэг өгөх тайлбар бодож олоод л мултарч гарах замаа олох хэрэгтэй гэж зөвлөв. Гэхдээ дараа нь би: “Энэ бол Бурханд итгэгчийн хийх ёстой зүйл биш. Би ер нь яах вэ?” хэмээн бодлоо. Яг тэр орой нь чуулганы цуглаантай байж таарсан тул би эгч нартаа өөрийнхөө нөхцөл байдлын талаар ам нээн нөхөрлөлөө. Нэг эгч маань надаар Бурханы үгийн энэ хэсгийг уншуулав: **“Одоо бол хүмүүс үнэний талаар маш их номлол сонсож, Бурханы ихээхэн ажлыг туулсан. Гэсэн ч олон янзын хүчин зүйлс, нөхцөл байдлаас үүдсэн хөндлөнгийн оролцоо, саад бартааны улмаас ихэнх хүн үнэнийг амжилттай хэрэгжүүлж чаддаггүй, бас Бурханыг сэтгэл хангалуун байлгаж ч чаддаггүй. Хүмүүс улам их хойрго болж, улам итгэлгүй болсон... Тэр эдгээр үнэнийг тэдэнд хайрлаж, Өөрийн замыг тэдэнд суулгаж өгч, дараа нь тэднийг өөр өөр арга замаар шалгахын тулд өөр өөр орчин нөхцөл зохицуулдаг. Түүний зорилго нь эдгээр үг, эдгээр үнэн болон Өөрийн ажлыг авч, хүн Бурханаас эмээж, муугаас зайлж чаддаг болох төгсгөлийг авчрах явдал билээ. Миний харсан ихэнх хүн Бурханы үгийг хоосон сургаал, цаасан дээрх зүгээр нэг үсэг, сахин мөрдөх журам гэж үздэг. Тэд үйлдэж, ярихдаа, эсвэл шалгалттай тулгарахдаа Бурханы замыг өөрсдийн мөрдөх ёстой зам гэж үздэггүй. Хүмүүс ялангуяа томоохон шалгалттай тулгарахад энэ үнэн байдаг; Бурханаас эмээж, муугаас зайлахаар хэрэгжүүлж байгаа ямар ч хүнийг Би хараагүй”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурханы зан чанар болон Түүний ажлаар хүрэх үр дүнг хэрхэн мэдэх вэ?”). Эдгээр үгийг уншсаны дараа сэтгэлд минь зэмлэх мэдрэмж төрлөө. Би үнэнч хүн байх тухай үнэнийг бага зэрэг ойлгож, тэр талаар Бурханы цээрлүүлэлт, сахилгажуулалтыг туулаад удаагүй байсан хэр нь өөр нэг шалгалттай тулгармагцаа бас л үнэнийг хэрэгжүүлж чадсангүй. Хүнээс хуулах нь буруу гэдгийг маш тодорхой мэдэж байсан ч дүнгийнхээ төлөө би, үнэнч хүмүүс бай гэж биднээс шаарддаг Бурханы үнэний тухай таг мартжээ. Би Бурханд гэрчлэл хийгээгүйгээр үл барам бүр Түүнийг шившиглэжээ. Тэр шөнө би үүнийг ахин дахин бодсоор унтаж чадсангүй. Эцэст нь би үнэнч хүн байж, хувийн ашиг сонирхлоо хамгаалахын төлөө Бурханы нэрийг дахин шившиглэхгүй байхаар шийдсэн юм. Ийм шийдвэрт хүрмэгцээ би орноосоо үсрэн босоод, компьютероо асааж, хийсэн буруу үйлээ наманчлан, өөртөө шүүмж бичлээ. Маргааш өглөө нь би сургууль дээрээ маш эрт очин, өөрийнхөө шүүмж бичгийг багшдаа өгөөд, зан байдалдаа уучлал гуйж, ирээдүйд дахиж хэзээ ч хуурахгүй гэж амлалаа. Тооны хичээлдээ тэг оноо авна гэдэгт би өөрийгөө бэлтгэн хурцалж, сургуулиас өгөх ямар ч шийтгэлийг хүлээн зөвшөөрөхөд бэлэн байлаа. Багш дахин шалгалт өгүүлэхээр шийднэ гэж би огт төсөөлөөгүй юм. Тэр мөчид би өөрийн эрхгүй зүрх сэтгэлийнхээ гүнээс талархал,

---

магтаалаа Бурханд илэрхийлэв: Надад өршөөл үзүүлснийх нь төлөө Бурханд талархъя! Бурхан хүний зүрх сэтгэлийн гүнийг шинжилдэг гэдгийг энэ нь надад харуулсан бөгөөд хувийн ашиг сонирхлоо хойш тавьж, үнэнч хүн байх тухай үнэнийг хэрэгжүүлэх үед минь Бурхан надад гарах гарц нээн өгч, шалгалтыг дахин өгүүлэхийг багшаар зөвшөөрүүлжээ. Бурхан дэргэд минь байж, хийсэн хөдөлгөөн бүрийг минь ажиглаж, эргэн тойрны минь бүх хүн, үйл явдал, зүйлс, орчныг зохицуулж байсныг би үнэхээр мэдэрсэн ба тэгснээр би Түүний жинхэнэ оршин тогтнолыг биечлэн мэдэрч чадах байлаа. Намайг гэх Бурханы хайр маш бодит!

Хэд хоногийн дараа, тэр улиралд бүх хичээлдээ А үнэлгээ авсан сурагчдад жуух бичиг гардуулах сургуулийн хэмжээний хурал дээр бүр ч хачирхалтай явдал болов. Багш миний нэрийг дуудахад нь би алдаа байх гэж бодлоо. Ангийнхны маань зарим нь надад ямар нэг зүйл хэлэх үед л би үнэхээр жуух бичиг хүлээн авч байгаагаа ухаарсан юм. Ангийнхан маань бүгд маш их гайхаж, тооны шалгалт дээрээ хүнээс хуулсныхаа дараа яаж жуух бичиг авч чадсан юм бол гэж гайхширч байв. Би зүрх сэтгэлдээ чимээгүйхэн уулга алдлаа: “Энэ бүхэн бол Бурханы үйл хэрэг! Энэ жуух бичгийг миний дүнд зориулаагүй, харин үнэнч хүн байхаар хэрэгжүүлсний минь төлөө Бурханы өгч буй шагнал гэдгийг би мэдэж байна.” Бурхан үнэхээр цаг ямагт миний дэргэд байж, хором бүрд намайг ажиглаж байгаа гэдгийг энэ нь улам бүр баталгаажуулав. Надад зориулж Бурханы зохицуулдаг бүхэн үргэлж хамгийн сайн үр дүнд хүрдэг.

Одоо би цуглаанд дуртай болж, Бурханы үгийг улам их уншиж байгаа. Завхарсан зан чанараа амьдрал дээр илчилсээр байгаа хэдий ч, юутай ч тулгарсан бай, би асуудлаа шийдвэрлэхийн тулд эгч нартайгаа үргэлж нөхөрлөж, Бурханы үгээс үнэнийг эрж хайж чадна. Хамтдаа ажиллаж, бодитой арга замаар хамтран ажилласнаар би улам их үнэнийг ойлгож авч, улам эрч хүчтэйгээр тэдгээрийг хэрэгжүүлдэг. Бурхан дэргэд минь байгаа бөгөөд төрөл бүрийн хүн, үйл явдал, зүйлсээр дамжуулан намайг хэдийд ч илчилж чадна гэдгийг би мэдэрдэг төдийгүй Тэр бас, үнэнд ороход минь намайг хөтөлж, залж чиглүүлэхийн тулд үгээ ашигладаг. Одоо Бурхантай харилцах харилцаа минь улам дотно болж байгаа мэт санагддаг бөгөөд Төгс Хүчит Бурхан бол жинхэнэ Бурхан гэдэгт, Тэр бол хэдийд ч, хаана ч намайг харж хандаж, халамжилж, хамгаалдаг Бурхан мөн гэдэгт би туйлын итгэлтэй байдаг!

## **39. Би жинхэнэ гэрээ оллоо**

Янъян, АНУ

---

Намайг гурван настай байхад аав минь өөд болов. Тэр үед ээж эрэгтэй дүүг минь дөнгөж төрүүлээд байсан бөгөөд миний эмээ мухар сүсэгт итгэн, ээж, эрэгтэй дүү хоёрыг маань аавыг үхэлд хүргэсэн гэж хэлсэн юм. Өөр гайгүй сонголт байгаагүй учраас манай ээж эцгийнхээ гэрт амьдрахаар эрэгтэй дүүг минь авч явсан тул би мэдээ орсон цагаасаа л өвөө, эмээтэйгээ хамт амьдарч байв. Хэдийгээр өвөө, эмээ минь надад сайн ханддаг байсан ч би мөн л ганцаардаж, ээж, жаахан дүү хоёртойгоо хамт амьдрахыг үнэхээр их хүсдэг байлаа. Би бусад хүүхдийн адилаар эхийн хайрыг амсахыг хүсдэг байв. Үнэндээ, миний хүсэж байсан зүйл тийм ч их биш—би жинхэнэ гэр бүлийг, намайг халуун дотноор хайрлаж, жинхэнэ мэдрэмжээ надтай хуваалцаж чадах ээжтэй байхыг л хүссэн билээ. Гэвч ийм өчүүхэн хүсэлт хүртэл хэрээс хэтэрсэн горьдлого болон хувирч, би ээжтэйгээ амралтын өдрүүдээр л уулзаж чаддаг байв. Сургууль дээрээ асуудалд орох бүрд маань ээж хэзээ ч миний хажууд байсангүй; би замын хажуугийн хэсэгхэн өвс мэт хэн ч намайг сонирхдоггүй байлаа. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр би өөрийгөө дорд үздэг болж, бүх зүйлийг зүрх сэтгэлдээ хадгалж, бусадтай харилцах санаачилга гаргаж чаддаггүй байв. Намайг 16 настай байхад манай тосгоны зарим хүн гадагшаа ажиллахаар явсан бөгөөд энэ санаа намайг уруу татав. Тэгээд би: Миний гэр бүлийн нөхцөл байдал тийм ч сайнгүй, хэрвээ би гадаад явбал, амь зуух мөнгө олж, зарим орлогоо гэр бүлдээ ч өгч чадна. Энэ маягаар, би арай дээр амьдрахад нь гэр бүлдээ тусалж чадна гэж бодсон юм.

2000 оны 8 дугаар сард би Америкт ажиллахаар ганцаараа ирэв. Энд би өглөө эрт босож, шөнө дүл болтол өдөржин ажилладаг байсан бөгөөд бодол санаагаа хуваалцаж болох хэн ч миний хажууд байсангүй. Би гаднаа хүчтэй харагдаж байсан ч дотроо ганцаардал, хоосролыг мэдэрч байлаа. Ингэж санагдах болгонд би гэр бүлээ үнэхээр санадаг байсан бөгөөд аз жаргалтай гэр бүлтэй байхыг бүр ч их хүсэн эрмэлздэг байв.

Би 21-тэйдээ ресторанд ажиллаж байгаад нөхөртэйгөө танилцав. Тэр сайн залуу байсан бөгөөд эцэг эхдээ ачлалтай байсан учир надад таатай сэтгэгдэл төрүүлсэн юм. Нэг удаа, би болгоомжгүйгээсээ болж хөлөө булгалсан бөгөөд гайхалтай нь тэр намайг асрахаар ажлаасаа гарч, энэ нь миний сэтгэлийг үнэхээр хөдөлгөсөн билээ. Би аажмаар түүнд найдаж эхлэв. 2008 оны 4 дүгээр сард бид гэрлэсэн юм. Амьдралаа даатгаж болох хүн олсон мэт надад санагдаж, эцэст нь нэг юм өөрийн гэх гэр бүлтэй болсон мэт санагдлаа. Би зүрх сэтгэлдээ тун аз жаргалтай болж, олон жилийн турш миний найдаж байсан зүйл эцэст нь биеллээ олов. Гэрлэснийхээ дараа би барилгын материалын компани байгуулахаар нөхрийнхөө эгчтэй хамтарсан боловч гэр бүлийнхнээсээ би л Англи хэл мэддэг байсан учраас компанийг тэр чигт нь голчлон ажиллуулдаг байлаа. Би гэр бүлийнхээ хүн бүрийг харж хандаж, бас компаниа удирддаг байсан юм. Олон жил шаргуу ажилласны дараа би нөхрийнхөө урьдын өрийг дарж чадсанаар үл барам, гэр бүлдээ

---

хадгаламж хуримтлуулж чадав. Анх, миний хүчин чармайлт нөхрийнхөө гэр бүлийн хүндлэлийг өөртөө татна гэж бодсон ч бодит байдал огтхон ч тийм биш байлаа. Бизнес амжилттай болж эхэлмэгц бид хүүхэдтэй болохоор төлөвлөсөн авч би жирэмсэлж чадсангүй. Тэгээд маш их эм ууж, олон эмчид үзүүлсэн боловч өчүүхэн ч найдлага харагдсангүй. Нөхөр минь айлын ууган хүү байсан бөгөөд бид ачийг нь төрүүлж өгөөгүй тул нөхрийн эцэг эх болон бусад хамаатнууд бидэнд тун сэтгэл дундуур байх болов. Ийм дарамттай тулгараад нөхрийн минь надад хандах хандлага ч бас урьдынхаасаа эрс өөрчлөгдлөө. Үүнийг дагаад нөхрийн минь гэр бүлийн бүх хүн надад хандах ханлагаа өөрчлөв. Нөхрийн минь эгч үргэлж намайг гадуурхсан зүйл хэлэх болж, нөхрийн минь өмнө миний талаар муу зүйл хэлэхийн тулд бодит баримтуудыг ч мушгин гуйвуулах боллоо. Надад шударга бус хандсан мэт санагдсан учир ямар санагдаж байгаагаа нөхөртөө хэлсэн юм. Тэр намайг ойлгоогүйгээр үл барам, бүр над руу хашхиран загнаж, энэ нь намайг улам их шархлуулж, гомдоосон билээ. Хожим нь, бид ахин нэг үзлэг хийлгэхээр эмнэлэг явсан бөгөөд үнэндээ нөхөрт маань асуудал байсныг эцэст нь мэдэж авав. Гэхдээ энэ нь чухал биш болсон байв, учир нь олон жил хэрэлдсэний дараа бидний харилцаа хэдийн муудаж эхэлсэн байлаа. 2012 оны эхэн үеэс эхлэн нөхөр маань эмчид үзүүлж, бизнесээ явуулахаар Хятад руу байнга буцах болж, зургаан сард нэг удаа л гэртээ ирдэг болов. Буцаж ирэх болгондоо мөнгө авах л гэдэг байсан бөгөөд Хятадад ажиллуулж байгаа компанийн зардлыг нөхөхийн тулд санхүүжилт шаардлагатай байгаа гэж хэлдэг байсан ч намайг огт хайхардаггүй байсан юм. Ийм маягаар бид гурван жил бараг цуг байгаагүй бөгөөд харилцаа маань улам холдож хөндийрлөө.

2015 оны 9 дүгээр сард бид эцэст нь саллаа. Биднийг эд хөрөнгөө хувааж байхад, хэрвээ шүүх салалтыг маань зөвшөөрөхгүй бол долоо хоногийн дотор бүх хөрөнгөө түүнд өгөх ёстой гэсэн гэрээнд надаар гарын үсэг зуруулахыг миний нөхөр хуульчид хүртэл даалгасан нь намайг хамгийн их шархлуулсан юм. Өөр нэгэн хуульч надад үүнийг сайтар бодож үз гэж хэлээд, хэрвээ энэ гэрээнд гарын үсэг зурвал надад маш хохиролтой байх бөгөөд тэтгэмж авч чадах гэрээ байгуулахад минь тусалж чадна гэж хэлэв. Нөхрөө ийм хүйтэн, харгис байхыг хараад би сэтгэл санаагаар уналаа. Анх дурлахаас гэрлэх хүртэл, бараг арван жилийн турш ямар ч мөнгө, эд зүйлтэй харьцуулж болшгүй бүх зүйлээ би нөхөртөө болон энэ гэр бүлд өгсөн. Гэтэл одоо, миний нөхөр хүүхэдтэй болж чадахгүйгээс болоод нөхөр болон түүний гэр бүл бүх бурууг надад өгч, миний мэдрэмжийг огтхон ч хайхралгүйгээр надад цэвдэг хандах болжээ. Зориулсан зүйлийнхээ хариуд авсан зүйл минь маш их шаналал, шархалсан зүрх сэтгэл л байв. Би туйлдаж байлаа. Тэгээд энэ гэр бүлтэй холбоотой байхыг огт хүссэнгүй. Аль болох хурдан энэ гэрийг орхиж, намайг гүнзгий шархлуулсан энэ хүмүүсээс холдохыг хүсэв. Ингээд би огтхон ч эргэлзэлгүйгээр

---

гарын үсгээ зурлаа.

Салалтын дараа би тун арга мөхөстөж байв. Би хэнд итгэхээ, хэн рүү очиж сэтгэлээ хуваалцахаа мэдэхгүй байлаа. Бүтэлгүйтсэн гэрлэлтээ бодох болгондоо би сэтгэлээр унаж, уй гашууд автдаг болов. Би одоо байгаагаа дахин шинжиллээ. Хүүхэдтэй болохын тулд гормонтой эм их хэмжээгээр ууснаас анхны жин дээрээ ахиад талыг нь нэмсэн байв. Хүмүүс намайг ийм асар их зовлон дунд, энэ хэцүү нөхцөл байдалд байхыг харах вий гэдгээс маш их айж байлаа. Гаднаа би хүчтэй байгаа дүр үзүүлсэн ч зүрх сэтгэлдээ туйлын сул дорой байв. Сүнсээ чөлөөлж чадах амьдралаар амьдрах боломжтой байх өдрийг би үнэхээр их хүссэн билээ. Энэ мөчөөс эхлэн би Бурханд итгэх хүсэлтэй болж эхэлсэн юм.

Үүний дараахан, хувцас авахаар дэлгүүр хэсэж явахдаа Кармэнтэй таарав. Тэр надад туслахыг үнэхээр хүссэн бөгөөд бид утасны дугаараа солилцлоо. Дараа нь би ВиЧат дээр нийтэлсэн зурвасыг нь хараад Христэд итгэгч гэдгийг нь олж мэдсэн юм. Хүнийг гэх Бурханы хайрыг Кармэн надтай байнга хуваалцдаг байсан бөгөөд миний сэтгэл үнэхээр хөдөллөө. Анх хаалттай нэгэн байсан би зүрх сэтгэлээ нээж, бусад хүмүүстэй харилцахыг хүсэж байгаагаа аажмаар олж мэдэв. Кармэн, бид хоёр бие биенээ мэдэж авахын хэрээр би өнгөрсөн олон жилийн турш зүрх сэтгэлдээ тээсэн зовлонгийнхоо талаар түүнд ярих. Кармэн миний зовлонг үнэхээр ойлгож, өөрийнхөө туулсан ижилхэн туршлагыг надтай хуваалцлаа. Намайг үнэхээр анхаардаг хүнтэй уулзсан мэт надад санагдан, энэ нь зүрх сэтгэлийг минь дулаацууллаа. Нэг өдөр Кармэн намайг өөр нэг эгчийн гэрт урьсан ба тэнд би Кевин ах болон Төгс Хүчит Бурханы Чуулганы нэлээд хэдэн эгчтэй уулзсан юм. Тэдэнтэй цуг байхад тэд миний урьд нь уулзаж байсан хүмүүсээс тун өөр мэт санагдав. Миний хамаатан садан, эсвэл найзууд байлаа ч, бусад хүмүүстэй хамт байх тоолондоо зүрх сэтгэлээ нээхэд тэд намайг үнэхээр ойлгохгүй байгаа мэт санагддаг байсан юм. Эсрэгээрээ, тэд намайг дооглох вий гэж санаа зовдог байсан тул би өөрийн сэтгэлийг хэнтэй ч хуваалцахыг хүсдэггүй байлаа. Харин, Кармэн болон энэ хүмүүстэй хамт байхад надад үнэхээр тайван санагддаг байв, учир нь тэд бүгд миний зовлонг ойлгож чаддаг байсан ба өөрсдийн туршлагыг ч надтай хуваалцсан билээ. Би анх удаа уулзахдаа л энд байгаа хүн бүрд зүрх сэтгэлээ үнэнчээр нээж, ярилцаж, бид бүгд өөр хоорондоо туршлагаа хувцаалцах юм гэж хэзээ ч төсөөлж байсангүй. Энэ ах эгч нар надад гэр бүлийнхнээс минь илүү хамаатан садан шиг хандсан мэт надад санагдсан нь өнгөрсөн хэдэн арван жилийн турш энэ дэлхий дээр амьдрахдаа миний хэзээ ч эдэлж үзээгүй зүйл байсан ба миний сэтгэл үнэхээр хөдөлж байв.

Дараа нь, Төгс Хүчит Бурханы Чуулганы “Шиажүжэний түүх” мюзиклийг үзэхээр бид бүгд цуглаж, миний сэтгэл хөдөллөө. Кинон дахь түүх үнэхээр үнэн байв: Хүүхэд болохын

---

хувьд, киноны гол дүр нь найзуудтайгаа гэнэн цайлган, цэвэр ариунаар тоглодог ч тэд өсөж том болоод ашиг сонирхол нь зөрчилдөж эхэлмэгц хүн бүрийн зүрх сэтгэл өөрчлөгдөж эхлэв. Тэд нэг нэгнийхээ эсрэг хуйвалдаж эхлэн, бүр дайснууд болоод, өөр хоорондоо тэмцэлдлээ. Тэгээд хайр энэрэл, эсвэл нөхөрлөлийн аль нь ч байхаа болив. Нөхөр бид хоёрын тэмцсэн тэр олон жилийг би бодохгүй байж чадсангүй. Гэхдээ бид хүүхэдтэй болж чадаагүйгээс бидний харилцаанд ан цав гарч, эцэст нь эд хөрөнгөө хуваах цаг болоход нөхөр минь үнэхээр сохор зоос болгоны төлөө надтай тэмцэлдсэн. Хүмүүс үнэхээр ямар аймшигтай болохыг энэ нь надад бодогдуулсан бөгөөд ашиг сонирхол нь эрсдэлд орох бүрд бүх мэдрэмжийг мартдаг. Аз болоход киноны гол дүр эцэст нь Бурханыг олж, Бурханы гэр лүү буцаж, найдаж болох цорын ганц зүйл нь Бурхан болдог ба тэрээр ганцаардахаа больж, шийдэмгий бус, арчаагүй байхаа ч больдог. Үүнийг үзсэний дараа сэтгэл ихэд хөдөлж, нүдийг минь нулимс бүрхлээ. “Шиаожэнь Бурхан руу эргэн ирэхдээ амьд үлдэхийн тулд зүүсэн багаа тайлсан; тэр үнэхээр Бурханы өмнө амьдарч, Түүний авралыг хүлээн аваад, чөлөөлөгдсөн, эрх чөлөөтэй амьдралаар амьдарч чадсан. Төгс Хүчит Бурхан намайг ч бас гарцаагүй аварч, би Шиаожэнь шиг аз жаргалтай амьдарч болох юм” гэж би бодлоо. Кинон дээрээс би Төгс Хүчит Бурханы ийм үгийг сонссон юм: **“Төгс Хүчитийн амийн хангалтаас холдсон хүмүүс оршин тогтнолын зорилгыг мэддэггүй хэдий боловч үхлээс эмээдэг. Тэд тусламж, дэмжлэггүй байдаг атлаа нүдээ аних дургүй хэвээр бөгөөд энэ дэлхий дээр өөрийн сүнсийг мэдэрдэггүй махан биед өөдгүйгээр оршин тогтнохын тулд өөрсдийгөө хатамжилдаг. Чи ийм маягаар итгэл найдваргүй, тэр ч тийм маягаар зорилгогүй амьдардаг. Зовлонгийнхоо дунд ёолон, Өөрийнх нь ирэхийг цөхрөнгөө баран хүсэн хүлээж байгаа хүмүүсийг үлгэр домгийн Ариун Нэгэн л аварна. Одоог хүртэл, ухаан алдсан хүмүүст ийм итгэл биеллээ олоогүй. Гэсэн ч хүмүүс ингэж хүсэн эрмэлзсээр байдаг. Гүнээ зовсон энэ хүмүүсийг Төгс Хүчит Нэгэн өршөөдөг; үүний зэрэгцээ, хүмүүсийн хариултыг хэтэрхий удаан хүлээх ёстой байсан тул ухаан алдсан энэ хүмүүсээс Тэр залхсан. Тэр эрж хайхыг хүсдэг, зүрх сэтгэл, сүнсийг чинь эрж хайн, чамайг цаашдаа өлсөж, цангахгүй байгаасай гэсэндээ чамд ус, хоол хүнс авчирч, чамайг сэрээхийг хүсдэг. Эцэж ядран, энэ дэлхийн зэврүүн хоосролын заримыг мэдэрч эхлэх үедээ бүү төөрөлд, бүү уйл. Төгс Хүчит Бурхан, Харгалзагч, чамайг хэдийд ч ирсэн тэврэн авна. Тэр хажууд чинь чамайг ажиглаж, эргэж буцахыг чинь хүлээж байгаа. Бурханаас ирсэн гэдгээ, мөн хэдийд ч юм зүг чигээ алдаж, хэдийд ч юм замдаа ухаан балартаж, хэдийд ч юм ‘эцэгтэй’ болсон гэдгээ ухаарахыг чинь; түүнчлэн Төгс Хүчит үргэлж ажиглаж, эргэн ирэхийг чинь маш урт удаан хугацаанд хүлээж байсан гэдгийг ухааран, гэнэтхэн ой санамжаа сэргээх өдрийг чинь Тэр хүлээж байна”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Төгс Хүчитийн санаа алдалт”). Эдгээр үгийг сонсоход ээж минь намайг дуудаж байгаа

---

мэт байсан бөгөөд би ээжийнхээ дэргэд эргэн очиж, зүрх сэтгэлдээ харьцуулшгүй дулааныг мэдрэх шиг санагдлаа. Бурхан үргэлж миний хажууд намайг хамгаалж, эргэн ирэхийг минь хүлээж байсан болж таарав. Би ганцаараа байхаа больжээ. Бурхан миний хүнд бэрх байдал болон хэрэгцээг мэддэг. Надад хамгийн хэрэгтэй байсан үед, миний сүнс хамгийн ихээр өвдөж шаналах үед энэ ах, эгч нар надад сайн мэдээ номлосноор дамжуулан Тэр намайг Бурханы гэр лүү аваачсан бөгөөд тэнд би Бурханы авралыг хүлээж авч, намайг гэх Бурханы хайрыг эдэлсэн юм. Тэр агшинд надад, эцэст нь гэрээ, гэр бүлээ олж ирсэн төөрсөн хүүхэд шиг санагдсан бөгөөд би үнэхээр аз жаргалтай байлаа!

Үүний дараа би чуулганы амьдралаар амьдарч эхэлсэн бөгөөд Төгс Хүчит Бурханы үгийг уншаад үнэхээр найдаж болох нэг зүйлийг олсон мэт, мөн амьдралдаа зорилго, чиглэлтэй болсон мэт санагдсан юм. Хэдий тийм боловч, үнэний талаар дэндүү бага ойлгож байсан тул бүтэлгүйтсэн гэрлэлтээ бодох бүрдээ би зүрх сэтгэлдээ шаналдаг байлаа. Нөхрийнхөө гэр бүлийн надад хандаж байсан байдлыг би үзэн ядсан бөгөөд энэ талаар бодох бүрдээ шаналалд автдаг байв. Иймээс би бэрхшээлийнхээ талаар Бурханд залбирч, ах, эгч нарт сэтгэлээ нээж, өөрийнхөө асуудлуудыг тэдэнтэй нөхөрлөн, асуудлуудаа шийдвэрлэх үнэнийг эрж хайсан юм. Нэг удаа, Кевин ах Төгс Хүчит Бурханы үгээс энэ хэсгийг надтай хуваалцав: **“Хүн эдгээр цаг үеийн турш Бурхантай хамт алхаж ирсэн атлаа Бурхан бүх зүйл болон амьд бодгалийн хувь заяаг захирдгийг, мөн Бурхан бүх зүйлийг хэрхэн зохион байгуулж, чиглүүлдгийг мэддэггүй. Балар эртний цаг үеэс өнөөдрийг хүртэл хүн үүнийг ухаараагүй явжээ. Үүний шалтгаан нь, Бурханы үйл хэрэг хэтэрхий нуугдмал байдагт бус, Бурханы төлөвлөгөө биелэх болоогүйдээ ч бус, харин хүний зүрх сэтгэл болон сүнс Бурханаас хэтэрхий хол байдаг учраас, тиймдээ ч хэдий Бурханыг дагаж байсан ч сатанд үйлчилсээр л байдаг бөгөөд үүнийгээ ч хүртэл мэддэггүйд оршиж байгаа юм. Бурханы мөр болон илрэлтийг хэн ч идэвхийлэн эрж хайдаггүй бөгөөд Бурханы халамж, хамгаалалт дор оршихыг хэн ч хүсдэггүй. Харин оронд нь тэд энэ хорвоо, хорон муу хүн төрөлхтний дагадаг оршин тогтнолын дүрэмд дасан зохицохын тулд ёрын муу нэгэн болох сатаны муу нөлөөнд түшиглэхийг хүсдэг. Энэ цаг үед хүн зүрх сэтгэл, сүнсээ Сатанд барих өргөл, Сатаны идэш тэжээл болгосон. Тэр ч бүү хэл хүний зүрх сэтгэл, сүнс нь Сатаны орогнож болох газар, зугаацахад тохиромжтой талбар болсон билээ. Тиймээс, хүн байх зарчим, хүний оршин тогтнолын үнэ цэн, утга учрын талаарх ойлголтоо хүн өөрөө ч мэдэлгүй гээдэг. Бурханы хууль, Бурхан, хүн хоёрын гэрээ хүний зүрх сэтгэлд аажмаар бүдгэрч, хүн Бурханыг эрж хайн, Бурханд анхаарал хандуулахаа больдог. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр хүн Бурхан яагаад өөрийг нь бүтээснийг, түүнчлэн Бурханы амнаас гарч байгаа үг болон Бурханаас гаралтай бүхнийг ч бас ойлгохоо**



---

**больдог. Дараа нь хүн Бурханы хууль, зарлигийг эсэргүүцэж эхэлдэг ба зүрх сэтгэл, сүнс нь мэдээгүй болдог... Бурхан анх бүтээсэн хүнээ алдаж, хүн эх үндсээ алддаг: Энэ бол энэ хүн төрөлхтний уй гашуу билээ**” (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурхан бол хүний амийн эх сурвалж”). Кевин ах дараа нь энэ тухай нөхөрлөн, ингэж хэллээ: “Бидний амьдрал шаналлаар дүүрэн байдгийн шалтгаан нь бид Сатаны үзэл санаа, үзэл бодол, амьдралын зарчмыг хүлээн авдаг, мөн Сатан биднийг хорлож, завхруулдгаас болдог. Үнэн хэрэгтээ, Сатан хүн төрөлхтнийг олон мянган жилийн турш завхруулсан. Удаан хугацааны туршид бид Сатаны бидэнд шингээсэн бүхэнд дасчихсан байдаг. Амьдрахын тулд бид Сатаны амьдралын хуулинд найдан, өөрсдийн ашиг сонирхлыг л анхаарч, хувиа хичээсэн, жигшмээр, мөс чанаргүй болдог. Хуучин нөхрийн чинь гэр бүл чамд тэгж хандсаны учир нь тэд ч бас Сатаны өөрсдөд нь шингээсэн ‘Өөрийн удмыг үлдээ,’ ‘Ачлал элбэрэлгүй байх гурван зам байдгаас хамгийн муу нь хүүгүй байх явдал’, ‘Өтөл насандаа асруулахын тулд үр хүүхдээ өсгө’ гэсэн феодалын бодлуудад баригдсанаас болсон. Нөхөр чинь эд хөрөнгөө хувааж байхдаа олон жил эхнэр, нөхрийн хувиар хамт амьдарснаа огтхон ч тоогоогүй нь ч бас ‘Мөнгө нэгдүгээрт’, ‘Хүн бүр өөрийнхөө төлөө байдаг, би үхэхээр чи үх’ гэсэн амьдралын хууль түүнд нөлөөлж, хянаснаас болсон бөгөөд тэрээр аминч, хатуу сэтгэлтэй болжээ. Сатаны завхралаас болоод хүмүүс нэг нэгтэйгээ эвтэй байж ер чаддаггүй ба бидний амьдралд аз жаргал байдаггүй. Бидний туулдаг бүх зовлонг Сатаны гаслан шаналал учруулдаг. Сатан бидний гэр бүлийг бүгдийг нь зовоож, хүн төрөлхтөн бүхэлдээ Сатаны эзэмшилд байдаг бөгөөд Сатан хор хөнөөл учруулахад яаж ч чаддаггүй. Иймээс Бурханы удирдамжгүйгээр, Сатаны гүн ухаан, зарчмаар амьдардаг хүмүүс жинхэнэ баяр хөөр, аз жаргалгүй амьдралаар амьдардаг. Бидэнд хамгийн хэрэгтэй зүйл бол материаллаг эд хөрөнгө, эсвэл гэр бүлийн хайр биш, харин ч Бурханы аврал билээ. Бидэнд хэрэгтэй зүйл бол Бурханы үгийн хангалт юм. Гагцхүү Бурхан л биднийг Сатаны завхрал болон зовлон зүдгүүрээс ангижруулж, бидний мөс чанар, эрүүл ухааныг сэргээн, жинхэнэ хүний адил амьдарч, эрх чөлөө, чөлөөлөлт олж авах боломжтой болгож чадна.” Кевин ахын нөхөрлөхийг сонсоод би гэнэт ингэж ухаарлаа: Шаналалд амьдарч байгаа хүн нь зөвхөн би биш, харин бүх хүн төрөлхтөн Сатанд мэхлэгдэж, завхруулагдаж, шаналан тэмцэлдэж байгаа болж таарлаа. Бурханы өмнө ирж, Бурханы авралыг хүлээн авснаар л хүмүүс Сатаны зовлон зүдгүүрээс ангижирч, энэ зовлонг давж чадна. Аз жаргал болон эрх чөлөөг олж авах цорын ганц зам энэ юм. Үүнийг ойлгомогц оюун санаа минь тов тодорхой болж, маш их чөлөөлөгдсөн мэт санагдав.

Хүн яагаад өвчин шаналалд амьдардгийн уг шалтгааныг ойлгомогц, хуучин нөхрийнхөө гэр бүлд дургүйцэж байсан минь Сатаны зовлон зүдгүүрийн үр дүн байсан гэдгийг би ухаарсан бөгөөд тэднийг уучлахаар оролдож, тэдний эсрэг хорсол тээхээ

---

болихыг ч хүсэх болов. Тэгээд Бурханы үгийг хэрэгжүүлж эхлэх үедээ зүрх сэтгэлдээ маш их баяр баяслыг мэдэрлээ. 2016 оны 8 дугаар сарын нэг өдөр би гудамжинд хуучин нөхөртэйгөө тааралдав. Бид нэг нэгэнтэй мэндэлсэн бөгөөд түүнд гомдохоо больсноо би зүрх сэтгэлдээ тов тодорхой мэдрэв, учир нь түүнийг Сатаны зовлон зүдгүүртэй амьдарч байсныг, Сатан түүнийг мэхэлж, тарчилгаж байсныг би мэдэж байсан юм. Хэрвээ надад боломж олдвол Бурханы эцсийн өдрүүдийн сайн мэдээг би түүнд түгээж, тэгснээр тэр ч гэсэн Бурханы өмнө ирж, Бүтээгчийн авралыг хүртэж чадах байв. Тэр хоромд, Бурхан үнэхээр хайр татам бөгөөд Бурханы үг бол үнэн гэдгийг би мэдэрсэн юм. Бурханы өмнө ирж, Түүний авралыг хүлээн авч байгаа цагт бид өөрсдийгөө Сатаны хүлээсээс чөлөөлж, эрх чөлөө, чөлөөлөлтийг олж авч, аз жаргалтай, ерөөгдсөн амьдралаар амьдарч чадна.

“Канааны нутаг дахь баяр баясгалан” гэх дуу, бүжгийн видеог үзэх болгондоо би маш их аз жаргалтай байдаг бөгөөд энэхүү магтан дууны үг мэдрэмжийг минь бүрэн дүүрэн илэрхийлж байгаа мэт санагддаг: “Би Бурханы гэр бүлд эргээд ирлээ, баяртай байна, жаргалтай байна. Гар минь хайртаасаа атгана, зүрх минь Түүнийх болсон. Нулимсны хөндийгөөр алхаж үзсэн ч гэлээ би Бурханы хайрыг харсан. Бурханыг гэсэн хайр минь өдрөөс өдөрт өсөж байна, Бурхан бол баяр хөөрийн минь эх ундарга. Бурханы гоо үзэсгэлэнд ховсдуулж, зүрх сэтгэл минь Түүнд татагдсан. Бурханыг би хэзээ ч хангалттай хайрлаж чадахгүй, магтаалын дуу зүрхэнд минь оргилж байна. Бурханы гоо үзэсгэлэнд ховсдуулж, зүрх сэтгэл минь Түүнд татагдсан. Бурханыг би хэзээ ч хангалттай хайрлаж чадахгүй, магтаалын дуу зүрхэнд минь оргилж байна. Ерөөлтэй энэ Канаан нутагт бүх юм шинэ, бүх зүйл шинэ, амьдралыг хөдөлгөгч хүч бургилж байна.... Канаан нутаг, Бурханы үгийн ертөнц; Түүний хайр бидэнд дуусашгүй баяр хөөр өгнө. Жимсний анхилуун үнэр агаарт түгнэ. Хэрэв чи энд хэдхэн өдөр л амьдарвал, энэ нутгийг юу юунаас илүү хайрлах болно. Тэгээд тэндээс явахыг огт хүсэхгүй.” Туулсан замаа эргээд бодвол, зам зууртаа би юу ч туулсан бай хамаагүй, Бурхан үргэлж миний дэргэд намайг харж хандаж байсан бөгөөд эцэст нь намайг гэр лүүгээ аваачсан юм. Одоо би Төгс Хүчит Бурханы үгийн усалгаа болон хангалтыг өдөр бүр эдэлдэг. Дотроо мэдэрч байсан шаналал арилсан бөгөөд би амьдралдаа чиг зүгээ олж, жинхэнэ эрх чөлөө, аз жаргалыг олж авсан юм. Намайг аварсанд нь Бурханд талархъя. Бурханы хайрыг чадлынхаа хэрээр хариулахын тулд би үнэнийг эрэлхийлж, бүтээлийн үүргээ биелүүлэхээр зорих болно!

## **40. Өөр аргаар аврагдсан нь**

Хуан Линь, Хятад

---

Би Каризматик Христийн шашны жирийн нэгэн итгэгч байсан бөгөөд Эзэнд итгэж эхэлснээсээ хойш цуглаан алгасаж байсан удаагүй билээ. Тэр тусмаа одоо эцсийн өдрүүдийн цаг үе ирж, Эзэн эргэн ирэх тухай Библи дэх зөгнөл үндсэндээ биелээд байлаа. Эзэн удахгүй эргэн ирэх тул цуглаанд би улам ч урам зоригтойгоор оролцож, Эзэнтэй уулзах боломжоо алдах вий гэсэндээ Түүний эргэн ирэхийг тэсэн ядан хүлээдэг байв.

Нэг өдөр дүү маань ирээд, “Эгч ээ, өнөөдөр танд хамгийн сайхан мэдээг дуулгахаар ирлээ—Эзэн Есүс эргээд иржээ! Тэгээд ч зогсохгүй махбодод эргэн ирчхээд үнэнийг илэрхийлж, мөн хүнийг шүүж, цэвэрлэх эцсийн өдрүүдийн ажлаа гүйцэтгэж, улмаар Библи дэх **‘Учир нь шүүлт Бурханы гэрээс эхлэх цаг болжээ’** (1 Петр 4:17) гэх зөгнөлийг биелүүлж байна. Та даруйхан Бурханы шинэ ажлыг дагасан нь дээр!” хэмээн надад баяртайгаар хэллээ. Би Эзэн эргэн ирсэн гэх мэдээг дуулаад гайхах, эргэлзэх зэрэгцэн, “Илчлэлийн номд **‘Харагтун, Тэр үүлсийн хамт ирнэ; нүд бүр Түүнийг харна’** (Илчлэл 1:7) гэсэн байдаг. Бас Эзэн эргэн ирэхдээ бидэн рүү цагаан үүлэн дээр ирнэ гэж пастор, ахлагч хоёр үргэлж номлодог шүү дээ. Чи Эзэнийг эргээд ирсэн, бас махбодод ирсэн гэх юм, гэхдээ яаж тийм байж болох юм бэ?” гэлээ. Дүү маань, “Эгч ээ, Эзэн Есүс эргэн ирэхдээ үүлсийн хамт ирнэ гэж та хэлж байна, гэхдээ үүндээ итгэлтэй байна уу? Библид бас **‘Харагтун, Би хулгайч мэт ирнэ’** (Илчлэл 16:15), түүнчлэн **‘Шөнө дөлөөр хашхирах дуу гарч, “Хараач, Сүйт залуу ирлээ; Түүнийг угтан авцгаа”** гэлээ” (Матай 25:6) гэж зөгнөсөн байдаг шүү дээ. Эзэнийг нууцаар ирэх боломжгүй гэж та хэлж зүрхлэх нь үү? Эзэний эргэн ирэлтэд нууц бий, иймээс бид энэ талаарх үнэнийг нээлттэй сэтгэлгээгээр эрж хайх ёстой! Бид өөрсдийнхөө үзэл, төсөөлөлтэй зууралдах юм бол Эзэн Есүсийг эргэн ирэхэд нь яаж угтаж чадах юм бэ?” хэмээн чин сэтгэлээсээ хэлэв. Гэхдээ дүү маань яаж ч нөхөрлөлөө гэсэн би үнэмшээгүй бөгөөд харин ч Эзэн цагаан үүлэн дээр эргэн ирнэ, махбодод ирж таарахгүй хэмээн итгэж байв. Дараа нь манай дүү гэрийнхэнд сайн мэдээ номлосон бөгөөд хэд хэдэн удаагийн нөхөрлөлөөр нь манай нөхөр, бага хүү, бэр гурав (тэд бүгд үл итгэгч байсан юм) бүгд Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн зөвшөөрлөө. Гэсэн ч би өөрийн үзэлтэй зууралдсаар, үүнийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан юм.

Дараа нь би хуучин чуулганыхаа цуглаанд оролцсоор байсан бол манай нөхөр, бага хүү, бэр гурав гурвуулаа Төгс Хүчит Бурханы Чуулганы цуглаанд оролцдог болов. Би цуглаанаас харьж ирэх бүрдээ цог золбоогүй болж, эдгээр цуглаанд оролцсоноор зүгээр л ёс төдий зүйл хийж байгаа мэт мэдрэмж төрдөг байлаа; зүрх сэтгэл минь хоосон, бас би юу ч олж авахгүй байсан юм. Гэтэл тэр хэд цуглаанаас ирэхдээ үргэлж тун баяртай байдаг бөгөөд асуудалтай тулгарах үедээ ямар завхарсан зан чанар илчилдэг тухай, мөн Бурханы хүслийг хэрхэн эрж хайх учиртай, өөрсдийгөө хэрхэн мэдэж, өөрсдөдөө хэрхэн дүн

---

шинжилгээ хийх ёстой тухай олж мэдэхээр байнга хамтдаа нөхөрлөж, эрж хайдаг байлаа. Түүнчлэн үнэнийг хэрхэн хэрэгжүүлж, Бурханы үгээр амьдрах, завхарсан зан чанараа хэрхэн хаяж, ариусгагдах зэргийн тухай хэлэлцдэг байв. Тэдний ийм зүйл ярихыг сонсоод би гайхаж, “Хэдхэн хоног л итгэж байгаа юм байж, асуудалтай тулгарах үедээ Бурханы хүслийг хэрхэн эрж хайх, мөн хэрэгжүүлэх арга зам олох талаар яаж мэдээд, ийм ухаалаг, үнэмшилтэй байдлаар ярьж чаддаг билээ? Би Эзэн Есүст энэ олон жил итгэж ирлээ. Залбирч, цуглаанд оролцон, Библийг тууштай уншиж ирсэн атлаа өөрт минь юм тохиолдох үед Бурханы хүслийг яахаараа ойлгодоггүй юм бэ? Ганц би ч гэлтгүй, манай чуулганы бүх ах эгч ийм байгаа. Бид бүх төрлийн нүгэлд хүлэгдчихээд чөлөөтэй байж чаддаггүй, сүнс маань хатаж гандсан, хар бараан, найдлагагүй байдаг, бас бидэнд Эзэнээс улам бүр холдож байгаа мэт санагддаг. Ер нь юу л болоод байна даа?” гэж бодлоо. Тэдний хэлэлцэж байсан сэдэв тун шинэ, соргог байсан бөгөөд өөрсдөө ямар завхарсан зан чанар илчилж байгаа тухай, мөн өөрсдөдөө дүн шинжилгээ хийж, өөрсдийгөө мэдэх, ариусгагдах гэх мэтийн тухай ярьж байв. Би Эзэнд маш олон жил итгэсэн боловч чуулганыхаа пастор, ахлагчийг ийм маягаар номлохыг огт сонсож байгаагүй, гэтэл гэр бүлийнхэн маань яаж ийм ихийг ойлгож авсныг ер ойлгож чадахгүй байв! Би яахаа мэдэхгүй байлаа.

Нүд ирмэхийн зуур ургац хураах цаг ирсэн бөгөөд хоёр хүү маань эрдэн шишээ хурааж, гэртээ авчрав. Урьд жилүүдэд би үргэлж том хүүдээ эрдэнэ шиш хальслахад нь туслаад, дараа нь бага хүүдээ тусалдаг байсан боловч энэ жил манай бага хүүгийн гэр бүл өөрсдөө эрдэнэ шишээ хальсалсан бөгөөд би дотроо: “Энэ удаад бага хүүгийнхээ гэр бүлийн ажилд тусалсангүй, тэгэхээр бага бэр маань надад уурласан нь лавтай, тэгээд ад шоо үзлээ гэж хэлэх биз” гэж бодлоо. Гэвч гайхмаар нь, манай бага бэр уурлаагүйн дээр надад хөгжүүнээр, “Ээж ээ, аав та хоёр нас дээр гарч байна. Цаашид бидний ажилд туслах гэж санаа зовоод яах вэ. Зүгээр л биеэ бод!” гэлээ. Бэрийнхээ ингэж хэлэхийг сонсоод би маш их гайхав. Бид хоёрт санаа тавьсан үг ёстой л анх удаа хэлж байгаа нь энэ байлаа! Урьд нь ийм үг огт хэлж байгаагүй юм! Дараа нь ийм зүйл дахин тохиолдлоо. Би, “Ач нар маань дунд сургуульд явах ёстой болохоор нэг нэг унадаг дугуй авч өгье” гэж хөвгүүд, бэрүүддээ хэлсэн юм. Тэгээд том хүүгийнхээ хүүхдэд дугуй авч өгсөн боловч дараа нь нэг хэрэг гарч, үлдсэн бүх мөнгөө зарцуулах ёстой болоод бага хүүгийнхээ хүүхдэд дугуй авч өгч чадахгүй болчхов. Дараа нь худ маань ачид дугуй авч өгсөн бөгөөд надад таагүй санагдлаа. Тэгээд “Бэр охин маань надад гомдсон нь лавтай, бас намайг хэлсэн үгэндээ хүрдэггүй гэж хэлэх биз” хэмээн дотроо бодов. Гэвч гайхмаар нь, манай бэр надад гомдоогүйгээр үл барам, “Ээж ээ, манай хүүхдэд унадаг дугуй авч өгсөнгүй гэж харамсах хэрэггүй. Одоогоос аав та хоёр мөнгөө хадгалж, өөрсдөдөө зарцуулцгаа. Бидэнд санаа

---

зоволтгүй!” гэж хэлэн намайг тайтгарууллаа. Энэ хоёр явдал намайг их гайхшируулав. Бэр маань Төгс Хүчит Бурханд итгэж эхэлснээсээ хойш аливаа юман дээр надтай маргахаа больсон бөгөөд харин ч бидэнд халамж, анхаарал тавьдаг болж, үнэхээр өөрчлөгджээ. Бас манай нөхөр үргэлж шалихгүй юмнаас болж надад уурлан, хатуу үг хэлдэг байсан юм. Гэтэл одоо надтай ярихдаа инээмсэглэж, заримдаа намайг өөрт нь уурлалаа ч тэвчээр гарган, “Бид нэг л Бурханд итгэдэг. Биеийн хувьд яривал бид эхнэр нөхөр хоёр, харин сүнсний хувьд яривал ах эгч хоёр шүү дээ. Хоёулаа хоёр биеэ хайрлаж, нэг нэгнээ ойлгож, уучлан, Бурханы үгээр амьдрах хэрэгтэй. Чи юу гэж бодож байна вэ? Би үргэлж муухай аашилж, амархан уурладаг байсан, харин энэ нь сатанлаг завхарсан зан чанарын маань үр дүн байж. Би хэтэрхий биеэ тоосон, их зантай, ямар ч хэвийн хүн чанаргүй байж. Бурханы эцсийн өдрүүдийн ажил нь үгээ илэрхийлэх замаар хүнийг аврах явдал гэдгийг Төгс Хүчит Бурханы олон үгийг уншаад одоо ойлгож авлаа. Хэрвээ хүмүүс Бурханы авралыг хүртэхээр эрэлхийлдэг бол Бурханы үгийг авч, бодит амьдралдаа хэрэгжүүлэн, асуудал бүрийг үнэний дагуу, зарчимтайгаар зохицуулах ёстой. Би махан биеэ хаяж, Бурханы үгийн дагуу хэрэгжүүлж, хэвийн хүн чанарыг амьдран харуулах учиртай” гэж тайвнаар хэлдэг болов. Би нөхөр, хүү, бэр гурваа хараад: “Энэ гурав маань Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг дөнгөж хоёрхон жилийн өмнө хүлээн зөвшөөрсөн атлаа яаж ингэтлээ их өөрчлөгддөг байна? Энэ намайг үнэхээр үнэмшүүлж байна! Эзэнд би ийм олон жил итгэлээ, бас өдөр бүр Библи уншиж, залбирдаг юм байж энэ бүх хугацаанд яагаад огт өөрчлөгдсөнгүй вэ? Сорилт ирэхээр би яагаад дандаа нүгэлд живчхээд эргээд гарч чаддаггүй юм бэ? Бурханд л хүмүүсийг өөрчлөх хүч чадал бий. Энэ гурвын маань итгэдэг Төгс Хүчит Бурхан нь эргэн ирсэн Эзэн Есүс юм биш биз? Энэ үнэхээр үнэн байгаад, би хүлээн зөвшөөрөхөөс татгалзсаар байвал Эзэн намайг хаях бус уу? Өмнө минь ийм агуу аврал байгаа атал үүнийг олж авахгүй бол маш мулгуу хэрэг бус уу?” гэж зүрх сэтгэлдээ бодлогоширсоор байлаа. Ингэж бодохоор санаа зовохоос өөр аргагүй байсан юм. Эрж хайж, судлахыг хүссэн боловч гэр бүлийнхэнтэйгээ энэ тухай ярихаас ичээд байв.

Нэг өдөр би нөхрийгөө гадагш гарсан хойгуур байнга уншдаг номыг нь нууцаар гаргаж ирлээ. Хавтсыг нь харах мөчид гялалзсан алтлаг өнгөөр бичигдсэн “Үг нь махбодоор илэрсэн” хэмээх дөрвөн том үг үзэгдсэн бөгөөд, “Энэ ном яг ямар нууцыг агуулдаг юм бэ? Хүмүүсийг тэгтэл нь их өөрчилж чаддаг юм чинь, үүнийг няхуур унших хэрэгтэй” гэж бодогдлоо. Болгоомжтойгоор номыг нээхэд дараах үг бичээстэй харагдав: “Энэ удаад бие махбодтой болсон нь Есүсийн ажил дууссаны дараа Бурхан хоёр дахь удаа бие махбод болсон хэрэг юм. Мэдээж, энэ удаа бие махбодтой болсон нь дангаараа тохиолддоггүй; харин энэ нь Хуулийн эрин үе, Нигүүлслийн эрин үеийн

---

дараах, ажлын гурав дахь үе шат юм. Бурхан ажлын шинэ үе шатыг эхлэх бүрд үргэлж шинэ эхлэл байх ёстой, мөн шинэ эрин үеийг үргэлж авчрах ёстой. Иймээс Бурханы зан чанар, Түүний ажиллах арга зам, ажлын байршил болон Түүний нэрэнд ч гэсэн харгалзах өөрчлөлтүүд гардаг. Тиймээс хүний хувьд, шинэ эрин үе дэх Бурханы ажлыг хүлээн зөвшөөрөхөд хэцүү байдагт гайхах зүйлгүй. Гэхдээ Өөрийг нь хүн хэрхэн эсэргүүцэхээс үл хамааран Бурхан үргэлж Өөрийн ажлыг хийж, бүх хүн төрөлхтнийг урагш хөтөлж байгаа. Есүс хүний ертөнцөд ирэх үедээ Нигүүлслийн эрин үеийг эхлүүлж, Хуулийн эрин үеийг төгсгөсөн. Эцсийн өдрүүдэд Бурхан дахин нэг удаа махбод болсон ба энэ удаа бие махбодтой болохдоо Нигүүлслийн эрин үеийг төгсгөж, Хаанчлалын эрин үеийг эхлүүлсэн юм. Хоёр дахь удаа бие махбодтой болсон Бурханыг хүлээн зөвшөөрч чаддаг бүх хүн Хаанчлалын эрин үе рүү хүргэгдэж, Бурханы удирдамжийг биечлэн хүлээн авч чадна” (Үг нь махбодоор илэрсэн номын Өмнөх үг). Үүнийг уншсаныхаа дараа би ингэж бодлогошров: Хоёр дахь удаа бие махбодтой болсон Бурхан Нигүүлслийн эрин үеийг эцэслэсэн юм чинь Нигүүлслийн эрин үеийн чуулгануудад Бурхан ажиллахаа больсон юм болов уу? Одоо бид Хаанчлалын эрин үед орсон гэж үү? Энд: **“Хоёр дахь удаа бие махбодтой болсон Бурханыг хүлээн зөвшөөрч чаддаг бүх хүн Хаанчлалын эрин үе рүү хүргэгдэж, Бурханы удирдамжийг биечлэн хүлээн авч чадна”** гэсэн байна. Манай нөхөр, хүү, бэр гурав Төгс Хүчит Бурханы ажлыг хүлээн зөвшөөрснөөсөө хойш үнэхээр өөрчлөгдсөн. Тэдний итгэдэг Төгс Хүчит Бурхан нь үнэхээр эргэн ирсэн Эзэн Есүс байж болох уу? Тэд үнэхээр Бурханы хөлийн мөрийг дагаж, Бурханы биечилсэн удирдамжийг хүлээн зөвшөөрч байгаа гэж үү? Үгүй бол яаж ийм олон үнэнийг ойлгож, ингэтлээ их өөрчлөгдөж чадах юм бэ? Энэ бол Ариун Сүнсний ажилгүйгээр өөртөө түшиглэн хүрч болох зүйл биш, тэгэхээр Ариун Сүнсний ажлын үр дүн байж таарлаа.... Яг ингэж бодтол гэнэтхэн нөхөр маань гэр лүү ирж яваа харагдав. Би номыг байсан газар нь хурдхан хийгээд: Номыг нь уншиж байсан гэж мэдэгдүүлж болохгүй, мэдчихвэл намайг шоолно гэж бодлоо.

Маргааш нь манай нөхөр цуглаанд оролцохоор явсан бөгөөд би өнөөх номоо дахиад гаргаж ирэн, уншиж эхэллээ. Тэгээд энэ хэсгийг уншив: **“Хэдийгээр Есүс хүмүүсийн дунд их ажил хийсэн ч бүх хүн төрөлхтний золин авралыг л гүйцэлдүүлж, хүний нүглийн тахил болсон юм; Тэрээр хүнийг бүх завхарсан зан чанараас нь салгаагүй. Хүнийг Сатаны нөлөөнөөс бүрэн аврах нь, Есүсээс нүглийн тахил болж хүний нүглийг үүрэхийг шаардаад зогсохгүй, бас хүнийг сатанлаг завхарсан зан чанараас нь бүрэн салгахын тулд улам их ажил хийхийг Бурханаас шаардсан. Ингээд хүний нүгэл уучлагдсаны дараа Бурхан хүн төрөлхтнийг шинэ эрин үе рүү хөтлөхийн тулд махбодод эргэн ирж, гэсгээлт, шүүлтийн ажлыг эхлүүлсэн юм. Энэ ажил нь хүнийг**

---

илүү өндөр хүрээнд аваачсан. Түүний ноёрхол дор захирагддаг бүх хүн илүү өндөр үнэнийг эдэлж, илүү агуу ерөөлийг хүлээн авна. Тэд үнэхээр гэрэлд амьдарч, үнэн, зам, амийг олж авна” (Үг нь махбодоор илэрсэн номын Өмнөх үг). Би энэ хэсгийг уншсанахаа дараа ойлгож авах гэж хичээв: Эзэн Есүс цовдлуулснаараа бүх хүн төрөлхтнийг золин аварсан боловч хүний завхарсан зан чанарыг таягдан хаяагүй бөгөөд хүний дотор нүгэлт уг чанар нь үлдсэн—энэ бол гарцаагүй үнэн. Эзэнд итгэдэг хүмүүс бидний хувьд Эзэний сургаалыг байнга дагаж мөрдөж чаддаггүй, бас худал хэлж, хуурч мэхлэн, өдөр бүр нүгэл үйлдээд, дараа нь нүглээ улайж, нүглийн хүлээснээс мултрах хүч чадалгүйгээр цаг ямагт нүгэлд хөлбөрөн байдаг. Энэ бол үгүйсгэшгүй баримт юм. Тэр мөчид Библи дэх: **“Тиймээс та нар ариун бай, учир нь Би ариун билээ”** (Леви 11:45) хэмээх Бурханы үг бодогдлоо. Бурхан биднийг ариун бай гэж хүсдэг ч бид байнга нүгэл үйлдэн, Эзэний дургүйг хүргэдэг—энийг яаж ариун гэх юм бэ? Бурхан бол ариун, бас хамгийн гол нь Бурханы хаанчлал бузартаж болохгүй. Тэгэхээр ингэж ойр ойрхон нүгэл үйлддэг бид тэнгэрийн хаанчлалд орж яаж чадах юм бэ? Ингэж бодоод би барьц алдаж, цааш нь номоос ийнхүү уншлаа: **“Хүнийг Сатаны нөлөөнөөс бүрэн аврах нь, Есүсээс нүглийн тахил болж хүний нүглийг үүрэхийг шаардаад зогсохгүй, бас хүнийг сатанлаг завхарсан зан чанараас нь бүрэн салгахын тулд улам их ажил хийхийг Бурханаас шаардсан.”** Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажил нь махбодод эргэн ирсэн Эзэн Есүсийн явуулдаг бүр ч илүү агуу ажил юм болов уу? Төгс Хүчит Бурханы шүүлтийг хүлээн зөвшөөрч, туулснаар л бид нүглээс ангижирч, ариусан өөрчлөгдөж чадах гэж үү? Нөхөр, бэр хоёрт маань гарсан өөрчлөлт Төгс Хүчит Бурханы гэсгээлт, шүүлтийн ажлыг туулсан туршлагаас нь үүдэлтэй байж болох уу? Манай нөхөр, хүү, бэр гурав Бурханд багахан хугацаанд л итгэж байгаа атлаа зарим үнэнийг ойлгож авч, өөрсдийнхөө завхарсан зан чанарын талаарх ойлголтын тухай ярьж, өөрсдөд нь ямарваа зүйл тохиолдвол Бурханы хүслийг эрж хайн, хэрэгжүүлэх арга зам олж чадсан. Гэтэл би Эзэнд олон жил итгэсэн боловч Бурханд итгэнэ гэж яг юу болох, Бурханы хүсэл яг юу болохыг надаас асуусан бол үнэндээ хэлж чадахгүй, зан чанар дахь ямарваа өөрчлөлтийнхөө талаар ярьж бүр ч чадахгүй байх сан. Өөрийгөө тэр хэдтэй харьцуулаад бодоход үнэхээр ичгүүртэй санагдав! Одоо би Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг чин үнэнчээр судлах ёстой санагдав.

Тэр үеэс эхлээд би **“Үг нь махбодоор илэрсэн”** номыг өдөр бүр нөхөртөө мэдэгдэлгүй нууцаар унших болсон бөгөөд унших тусам зүрх сэтгэл минь улам гэгээлэг болж, уншихад улам их баясал төрдөг байлаа. Заримдаа өөрийнхөө чуулганы цуглаанд оролцмооргүй санагдаж, зүгээр л гэртээ үлдээд энэ номыг уншдаг байв. Нэг удаа Төгс Хүчит Бурханы энэ үгийг уншлаа: **“Зөвт байдлын төлөө өлсөж цангадаг, чин**

---

сэтгэлээсээ хайдаг бүх хүнийг Би заавал гэрэлтүүлж, гэгээрүүлнэ. Би та бүхэнд сүнсний ертөнцийн бүх нууц болон урагшлах замыг харуулж, хуучин ялзарсан зан чанарыг чинь аль болох хурдан хаяулна, ингэснээр амь чинь төлөвшиж, Надад ашиглагдахад тохирохуйц болж, сайн мэдээний ажил удалгүй саадгүйгээр урагшилж болох юм. Тэр үед л Миний хүсэл ханана, тэр үед л Бурханы зургаан мянган жилийн удирдлагын төлөвлөгөө аль болох хурдан гүйцэлдэнэ. Бурхан хаанчлалыг олж авч, газар дэлхий рүү бууж ирнэ, тэгээд бид хамтдаа алдар луу орно!” (“Үг нь махбодоор илэрсэн” номын Христийн эхэн үеийн айлдваруудын “8-р бүлэг”). Үүнийг уншсаны дараа Эзэн Есүсийн: **“Зөвт байдлын төлөө өлсөж, цангадаг хүмүүс ерөөлтэй еэ: учир нь тэд цатгагдах болно”** (Матай 5:6) гэсэн үг яах аргагүй бодогдлоо. Төгс Хүчит Бурханы үг, Эзэн Есүсийн үг хоёр адилхан эх сурвалжтай гэдгийг би унших тусмаа улам их мэдрэв. Хэн хэнийх нь үг эрх мэдэл, хүч чадалтай байгаа тул Төгс Хүчит Бурхан үнэхээр л эргэн ирсэн Эзэн Есүс байх өндөр магадлалтай санагдлаа! Ингэж бодоод би гайхширав: Энэ үнэн бол би Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн зөвшөөрөхөөр яаравчлах хэрэгтэй, учир нь зөвшөөрөхөөс татгалзаад байвал Бурханы ажлын ард хоцорно! Гэхдээ гэрийнхэндээ үүнийг яаж хэлэх вэ? Урьд нь тэд надад сайн мэдээ маш их номлодог байсан, харин би үргэлж хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж ирсэн юм. Одоо Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн зөвшөөрөхөд бэлэн гэж хэлбэл намайг юу гэж бодох бол? Шийдвэр гаргаж чадалгүй хойшлуулж байх яг тэр үед маань Бурхан надад арга зам нээж өгсөн юм.

Нэг өдөр бэр маань чуулганы нэг эгчийнхээ хамт сайн мэдээ номлохоор над дээр ирлээ. Энэ бол Бурханы өгсөн боломж гэдгийг би тэгэхэд мэдсэн тул тэдэнтэй шударгаар ярилцлаа: “Үнэндээ би Төгс Хүчит Бурханы маш их үгийг нууцаар уншиж байсан юм, тэгээд тэдгээр үг Бурханаас ирдгийг мэдэрч байна. Ийм их эрх мэдэл, хүч чадалтай тэдгээр үгийг ямар ч хүн хэлэх аргагүй.” Ингэж хэлэхийг маань сонсоод манай бэр гайхширч, эгч рүү хараад баяртайгаар инээд алдлаа. Би цааш нь ингэж хэлэв: “Гэхдээ надад одоо ч яг ойлгохгүй байгаа нэг зүйл байна. **‘Дараа нь тэд сүр хүч болон агуу алдартайгаар үүлэн дээр ирэх хүний Хүүг харна’** (Лук 21:27) хэмээн Эзэн Есүс зөгнөсөн. Итгэгч бид бүгд Эзэн Есүсийг эргэн ирж, бидний дунд цагаан үүлэн дээр бууж ирэхийг хүсэн хүлээдэг шүү дээ. Гэтэл Эзэн аль хэдийн эргээд ирсэн, бас Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс гэж та нар хэлж байна. Тэгвэл бид яахаараа Эзэний цагаан үүлэн дээр ирэхийг хараагүй байдаг билээ? Энэ тухай надад нөхөрлөөч.”

Эгч чин сэтгэлээсээ ингэж хэллээ, “Бурханд талархъя! Бидний мэддэгчлэн Библид Эзэний эргэн ирэхийг зөгнөсөн олон эшлэл байдаг. Гэхдээ анхааралтай ажвал, Эзэний эргэн ирэх тухай хоёр өөр янзаар зөгнөсөн байгааг харна: Нэг нь Лук 21:27-д **‘Дараа нь**



---

тэд сүр хүч болон агуу алдартайгаар үүлэн дээр ирэх хүний Хүүг харна’ хэмээн өгүүлдэгчлэн Эзэнийг үүлэн дээр ил тод ирж, нүдтэй бүхэнд харагдана гэдэг. Нөгөө нь Матай 24:36-д **‘Харин тэр өдөр цагийг хэн ч мэдэхгүй, тэнгэрийн тэнгэрэлчүүд ч мэдэхгүй, Хүү ч мэдэхгүй, зөвхөн Миний Эцэг л мэднэ’** гэж хэлдэгчлэн Эзэнийг хулгайч мэт, хэнд ч мэдэгдэлгүй нууцаар ирнэ гэдэг. Эзэний ирэлт хоёр үе шаттайгаар тохиохыг харж болно: Эхлээд Эзэн нууцаар ирнэ, тэгээд ажлынхаа нэг үе шатыг гүйцэтгэснийхээ дараа ирсэн гэдгээ мэдэгдэнэ. Таны яриад байгаа зүйл бол Эзэний ил тод ирэх тухай зөгнөл юм, харин одоо бид Эзэний нууцаар ирэх тухай зөгнөл биелж байгаа үе шат буюу Бурхан ажлаа гүйцэтгэж, хүн төрөлхтнийг аврахын тулд махбод болдог үе шатанд байна. Бурхан махбодод ажиллаж дуусах үедээ бүгдэд харагдахын тулд ил тодоор ирэх болно....”

Эгчийн ийм нөхөрлөл хийхийг сонсоод зүрх сэтгэл минь гэрэлтэж, ийнхүү бодлоо: Библид Эзэнийг хоёр өөр янзаар ирнэ гэж зөгнөсөн болж таарлаа. Эхлээд нууцаар ирж, дараа нь ил тод ирэх юм байна—энэ үнэхээр нууц юм! Би Библийг ийм олон жил уншиж явсан байж яагаад үүнийг огт олж мэдсэнгүй вэ? Харин одоо ингээд бодоход, үнэхээр тийм байдаг гэдэгт би бат итгэж байна!

Бэр маань надад ингэж хэллээ, “Ээж ээ, махбод дахь Төгс Хүчит Бурхан үгээр хүнийг шүүж, ариусгах ажлаа явуулдаг цаг үе бол Бурханы нууцаар ирдэг үе шат бөгөөд Бурхан хүмүүсийг ил болгож, биднийг нэг бүрчлэн төрлөөр нь ялгадаг цаг үе юм. Үнэний энэ талыг илүү их ойлгохын тулд Төгс Хүчит Бурханы үгийг уншицгаая.” Ингэж хэлчхээд бэр маань ийнхүү уншлаа: **“Олон хүн Миний хэлсэн зүйлийг тоохгүй байж магад, гэвч Есүс тэнгэрээс цагаан үүлэн дээр бууж ирэхийг хоёр нүдээрээ харах үед чинь зөвт байдлын Нар олон нийтэд үзэгдэнэ гэдгийг Би Есүсийг дагадаг ариун хүмүүс гэгддэг хүн бүрд хэлэхийг хүсэж байна. Есүс тэнгэрээс буун ирж буйг нүдээр үзэх тэр үе чамд маш сэтгэл догдлом мөч байж болох ч энэ үе бас шийтгүүлэхээр там руу буух үе чинь гэдгийг мэдэх хэрэгтэй. Энэ нь Бурханы удирдлагын төлөвлөгөөний төгсгөлийн цаг үе байх бөгөөд Бурхан сайныг шагнаж, мууг шийтгэх үе байх болно. Учир нь, хүн тэмдгийг харахаас өмнө, үнэний илэрхийлэл л байх үед Бурханы шүүлт дууссан байх болно. Үнэнийг хүлээн авдаг, тэмдгийг эрж хайдаггүй хүмүүс ариусаж, Бурханы сэнтийн өмнө эргэн ирж, Бүтээгчийн тэвэрт орсон байх болно. ‘Цагаан үүл хөлөглөн ирээгүй Есүс бол хуурамч Христ’ хэмээн муйхарлан итгэдэг хүмүүс мөнхийн шийтгэл хүртэнэ, учир нь тэд тэмдэг үзүүлдэг Есүст л итгэдэг, харин хатуу шүүлт зарлан, амийн үнэн замыг гаргадаг Есүсийг хүлээн зөвшөөрдөггүй. Тэгэхээр Есүс цагаан үүлэн дээр ил тодоор эргэн ирэх үедээ л үүнийг шийдвэрлэх болно. Тэд хэтэрхий зөрүүд, өөртөө итгэлтэй, биеэ тоосон. Иймэрхүү өөдгүй хүмүүс яаж Есүсээр шагнуулж**

---

**чадах билээ? Есүс эргэн ирнэ гэдэг нь үнэнийг хүлээн зөвшөөрөх чадвартай хүмүүсийн хувьд агуу аврал, тэгж чаддаггүй хүмүүсийн хувьд ялалтын тэмдэг юм”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Есүсийн сүнслэг биеийг харах үед чинь Бурхан тэнгэр, газрыг шинээр бүтээсэн байх болно”).

Эгч нөхөрлөлөө ийнхүү үргэлжлүүлэв, “Төгс Хүчит Бурхан ажлаа нууцаар гүйцэтгэж байхдаа хүмүүсийг үгээр шүүж, гэсгээх ажлаа л хийдэг гэдгийг бид Бурханы үгээс ойлгож авлаа. Өөрөөр хэлбэл, амьдралд хэрэгтэй зүйлээр маань биднийг хангахын тулд бүх үнэнийг Тэрээр илэрхийлдэг. Тэгээд Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн зөвшөөрч, Бурханы үгийн шүүлт, гэсгээлтийг туулан, үнэнийг ойлгож, Бурханыг мэддэг болж, амьзан чанар нь өөрчлөгддөг хүмүүс бол гамшигын өмнө Бурханы бүрэн төгс болгодог ялагчид билээ. Эдгээр ялагч бүрэн төгс болох үед Бурханы агуу ажил дуусаж, нууцаар гүйцэтгэдэг ажил нь бас төгсөх болно. Тэгээд Бурхан үүлсийн хамт ирж, бүх улс үндэстэн, ард түмэнд ил тод харагдах болно. Зарим хүн өөрийн үзэлтэй сохроор зууралдаж, Эзэн Есүсийг үүлсийн хамт л ирэхийг хүлээх атлаа Бурханы нууц ажлаа явуулж байхдаа илэрхийлсэн ямар ч үнэнийг хүлээн зөвшөөрөхөөс татгалздаг. Энэ хүмүүс бүгд Бурханы эсрэг тэрслэн, Бурханыг үл ойшоодог бөгөөд тэд Бурхан руу эргэж, эцсийн өдрүүдийн авралыг нь хүлээн зөвшөөрч чадахгүй бол агуу гамшигт унаад, цурхиран уйлж, шүдээ хавирах болно. Илчлэлийн 1-р бүлэг, 7-р эшлэлд: **‘Харагтун, Тэр үүлсийн хамт ирнэ; нүд бүр Түүнийг харна, Түүнийг жадалсан хүмүүс ч бас харна: газар дэлхийн бүх овог Түүнээс болж гашуудна. Тийм ээ, Амен’** хэмээн зөгнөсөн байдаг. Бодоод үз дээ: Эзэнийг үүлсийн хамт ирэхэд хүн болгон харна, тэгээд хийхэд зөв үйл бол Эзэнийг ирэхэд асар их баяр хөөртэйгөөр угтах явдал байх учиртай. Тэгвэл яагаад бүх овог гаслан уйлна гэж? Учир нь тэд Бурханыг ил тод ирэх үед өөрсдийнх нь үл ойшоосон Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс үнэхээр мөн гэдгийг харах болно, тэгэхээр цээжээ дэлдэн уйлж, шүдээ хавирахаас өөр яах билээ?”

Эгчийн нөхөрлөлийг сонсож байхдаа би толгой дохисоор байсан бөгөөд ингэж хэллээ, “Аан, энэ эшлэлийг би өмнө нь огт ойлгоогүй, тэгээд чуулганыхаа пастороос асуусан боловч тодорхой тайлбарлаж өгөөгүй юм. Энэ эшлэл нь эцсийн өдрүүд дэх Төгс Хүчит Бурханы авралыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж, Түүнийг үл ойшоодог бүх хүнийг хэлж байгаа болж таарлаа.” Гэрийнхэн маань надад олон удаа сайн мэдээ номлосон атал би эсэргүүцэж, хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж байснаа тэр мөчид яах аргагүй санаад, маш их гутарлаа. Тэгээд эгчид гэмшингүйгээр ингэж хэлэв, “Төгс Хүчит Бурханы үгийг уншаагүй бол, Төгс Хүчит Бурханы үг зүрх сэтгэлийн минь үүдийг нээж, надад үнэнийг эрж хайдаг зүрх сэтгэл өгөөгүй бол би одоо ч та нарын нөхөрлөлийг сонсохгүй, харин Эзэн Есүсийг цагаан үүлэн дээр ирж, хүмүүст ил тод харагдахыг хүлээн,

---

ухаангүй хэвээр байх байж! Би үнэхээр маш мэдлэггүй, мунхаг юм! Бурханы нууц ажил бол аврал хүртэхийн тулд Бурханы үгийн шүүлт, гэсгээлтийг хүлээн зөвшөөрч, завхарсан зан чанараа хаях үнэхээр сайхан боломж гэдгийг би одоо л ойлгож байна! Бурхан үүлэн дээр ирж, хүнд ил тод харагдах үедээ авралын ажлаа аль хэдийн дуусгасан байх бөгөөд сайныг шагнаж, мууг шийтгэж эхэлнэ. Тэгэхэд би харамссандаа амаа барьсан ч, нэгэнт оройтсон байх болно. Намайг хаялгүй, аврал хүртэх энэ боломжийг олгосонд нь Бурханд талархъя. Би Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн зөвшөөрмөөр байна!”

Дараа нь би санаачилга гаргаж, Төгс Хүчит Бурханы Чуулганд орохыг хүссэн бөгөөд нөхөр, хүү, бэр гурвынхаа адилаар өдөр бүр Бурханы үгийг уншиж, үнэнийг нөхөрлөн, Бурханы үгийн шүүлт, гэсгээлт, ариусгалт, авралыг туулдаг билээ. Төгс Хүчит Бурханы Чуулганы өнөр өтгөн гэр бүлд би жинхэнэ чуулганы амьдралаар амьдарч, сүнс минь амар амгалан, баяр баяслаар дүүрэн байдаг. Намайг хайрлах Бурханы агуу хайрыг би үнэхээр мэдэрдэг; би ердөө л хэтэрхий хөшүүн байсан болохоороо Бурханыг ийм удаан хүлээлгэжээ. Бурханы гэр бүл рүү намайг алхам алхмаар эргүүлэн хөтөлж, чиглүүлэхийн тулд янз бүрийн хүмүүс, үйл явдлыг нямбайлан зохион байгуулсанд нь Бурханд талархъя, бас намайг өөр аргаар аварсанд нь Бурханд талархъя!

## **41. Эзэнийг эргэн ирэхэд нь би угтан авлаа**

Чуанян, Америкийн Нэгдсэн Улс

2010 оны өвөл би Америкийн Нэгдсэн Улсад маш их даарч билээ. Салхи шуурга, цас хосолсон хахир хүйтний хажуугаар зүрх сэтгэлийг минь “хүйтэн жавар” нөмөрсөн нь бүр ч ноцтой явдал байсан юм. Дотоод засал чимэглэлийн бизнес эрхэлдэг над шиг хүмүүсийн хувьд өвөл бол жилийн хамгийн хүнд цаг үе байдаг. Учир нь өвөл эхлэнгүүт хийх ажил бараг гардаггүй, тэр ч байтугай бид ажлаа алдахад хүрдэг юм. Тэр жил миний хувьд Америкийн Нэгдсэн Улсад өнгөрүүлсэн анхны жил байсан бөгөөд шинэхэн цагаач надад бүх зүйл танил бус санагдаж байлаа. Байр түрээслэх, ажил олохын аль аль нь амаргүй байсан бөгөөд өдөр хоногууд хүндрэл бэрхшээлээр дүүрэн байв. Би бүр шалдаа бууж, байрныхаа түрээсийг төлөхийн тулд мөнгө зээлэхэд хүрсэн юм. Ийм бэрхшээлтэй тулгарсан би сэтгэлээр унаж, ингэж амьдрах үнэхээр хүнд санагдав. Шөнөдөө цэв хүйтэн хана руу хараад маш их гуньж, гагцхүү уйлахыг л хүсдэг байлаа. Нэгэн өдөр гуниг, шаналалдаа автаад үлбийн алхаж байхад минь Эзэн Есүсийн сайн мэдээ түгээж байсан хүн надад карт өгөнгөө: “Эзэн Есүс танд хайртай. Ах аа, манай чуулганд ирж, Эзэний сайн мэдээг сонсоорой!” гэж хэлэв. “Яг одоо хийх зүйлгүй юм чинь очоод сонссон ч яах вэ дээ.

---

За тэгье. Ямартай ч хийх зүйлтэй боллоо” гэж би дотроо бодов. Ингээд л би сүм рүү орсон юм. Эзэн Есүсийн хэлсэн дараах үгийг пастор чангаар уншиж байгааг сонслоо: **“Бурхан дэлхийн хүмүүсийг үнэхээр хайрласандаа цорын ганц Хүүгээ өгсөн болохоор Түүнд итгэдэг хэн ч мөхөхгүй, харин мөнх амьтай болно”** (Иохан 3:16). Үүнийг сонсоод Эзэний хайранд сэтгэл минь маш их хөдөлж билээ. Юу мэдэрснээ би тодорхой тайлбарлаж чадахгүй ч Эзэний хайр бодитой, энэ дэлхий дээр олдох ямар ч хайрыг давсан хайр гэдгийг мэдэрч чадсан юм. Шаналалд автсан зүрх сэтгэл минь ихээхэн тайтгарлаа. Иймээс би Эзэн Есүст чин сэтгэлээсээ итгэхээр шийдсэн юм. Хожим нь ням гараг бүр цуглаанд идэвхтэйгээр оролцдог болж, ийнхүү идэвхтэй эрэлхийлснээр төд удалгүй чуулганы хамтран зүтгэгч болов.

Чуулганд хоёр жил үйлчилсний дараа Эзэн надтай хамт байхгүй байх шиг санагдах нь улам нэмэгдлээ. Библи унших үед гэгээрч байгаа мэдрэмж төрөхөө больж, залбирах үед сэтгэл хөдлөхөө больж, цуглаанаас ямар ч үр өгөөж авахгүй байгаа мэт санагдах болов. Үүний зэрэгцээ чуулганд хүн бүр өдөр нь нүгэл үйлдэж, шөнө нь нүглээ улайдаг амьдралаар амьдарч, пастор, ахлагч, жирийн итгэгч гээд л хүн бүхэн нүгэлд хүлэгдэж, атаа жетөө бүхий маргаан хийж, бие биетэйгээ хуйвалдан бүлэглэл үүсгэж, алдар нэр, ашиг хонжооны төлөө тэмцэлдэж, өнгө мөнгөнд шунахайрч байгааг харсан юм. Хууль бус элдэв хэрэг улам их гарах болов. Мөн нийгэм дэх хүмүүс нийтээрээ өдөр хоног өнгөрөх тусам улам бүр ёс суртахуунгүй, ёрын муу, амиа хичээмтгий болж, дэлхий даяар гамшиг тохиож, газар хөдлөлт, өлсгөлөн, тахал байнга гарч байгааг харлаа. Эцсийн өдрүүд ирсэн бөгөөд Эзэн Есүс удахгүй эргэж ирэхийг янз бүрийн тэмдгүүд тодорхой илтгэж байв. Пастор, ахлагчид Библийн дараах эшлэлүүдийн талаар бидэнд ойр ойрхон номлодог байсан юм: **“Тэр үед хэн нэгэн хүн та нарт ‘Хараач, Христ энд байна’, эсвэл ‘Христ тэнд байна’ гэвэл түүнд бүү итгэ. Учир нь хуурамч Христүүд болон хуурамч эш үзүүлэгчид гарч ирэн агуу тэмдэг, гайхамшгуудыг үзүүлэх ба боломжтой бол сонгогдсон хүмүүсийг ч хууран мэхэлнэ”** (Матай 24:23–24). Тэгээд эцсийн өдрүүдэд хуурамч Христүүд гарч ирнэ гэж дур зоргоороо номлон, танихгүй хүмүүсийн номлолыг яасан ч сонсож болохгүй гэж бидэнд хэлдэг байв. Тэр ч байтугай манай чуулганыхнаас бусад урсгалын итгэгчид бүгд буруутсан бөгөөд бид хууртаж, буруу замаар орохгүйн тулд бусад хүнийг хянуур ялгаж салгадаг байх ёстой гэж хэлдэг байв. Пасторуудын ийн номлохыг би байнга сонсдог байсан тул, “Эзэн мөдхөн ирэх гэж буй энэхүү нэн чухал мөчид замаасаа хазайж болохгүй. Эзэнд итгэх итгэлээ заавал хадгалж үлдэх ёстой” гэж дотроо боддог байлаа.

2016 оны 9-р сарын дундуур Жу эгч гэнэт нэг өдөр утсаар залгав. Жу эгч удаан хугацаанд итгэсэн, манай чуулган дахь үнэнийг идэвхтэй эрэлхийлэгч байсан юм. Бид хоёр үргэлж сайн харилцаатай байсан тул эгчийг залгахад нь би маш их баярлаж билээ.

---

Жу эгч надад: “Дүү минь, чамд дуулгах сайхан мэдээ байна. Эзэн Есүс Төгс Хүчит Бурхан болоод эргэн иржээ! Энэ удаад Бурхан хүнийг шүүж, цэвэрлэж, аврах ажлыг хийхээр бие махбодтой болсон байна!” гэж догдолсон байртай хэлэв. Ийм үг сонсоод би бага зэрэг гайхширч: “Жу эгч Эзэний замыг баримтлаагүй гэж үү? Өөр урсгал руу орчихсон юм уу? Эгч яаж ийм мунхаг байж чадав аа? Эцсийн өдрүүдэд хуурамч Христүүд гарч ирнэ гэдгийг пастор, ахлагчид удаа дараа онцолж байхад тэдний үгийг яагаад сонсоогүй юм бол? Эзэн удахгүй ирэх энэхүү эгзэгтэй мөчид итгэлдээ төөрөгдөх юм бол ийм олон жил итгэсэн маань талаар өнгөрөх бус уу?” гэж дотроо бодлоо. Ийнхүү бодоод, Жу эгчид: “Эгч минь, Библид хэлэхдээ эцсийн өдрүүдэд хуурамч...” гэж зовнингуйгаар хэлж эхэлтэл эгч үгийг минь таслан: “Дүү минь, **‘Бүү шүү’** гэж Эзэн Есүс анхааруулсан тул Бурханы яллалт амсахгүйн тулд бид бусдыг дураараа шүүх ёсгүй” гэв. Эгчийн анхааруулгаас үүдэн Эзэний дараах үг бодогдлоо. **“Бүү шүү, тэгвэл та нар шүүгдэхгүй; бүү ялла, тэгвэл та нар яллагдахгүй”** (Лук 6:37). Би нэмж юм хэлж зүрхэлсэнгүй. Гэхдээ Эзэний эргэн ирэлт гэх ийм чухал үйл явдлын тухайд Жу эгч бид хоёр өөр өөр үзэл бодолтой байсан бөгөөд нэгнээ ятгаж үнэмшүүлэхийг хүсэж байлаа. Иймээс санаагаа хэлэх гэж ээлжлэн оролдсон ч, эцэст нь хэн нь ч хэнийгээ ятгаж чадаагүй юм.

Үүнээс хойш Жу эгч сар гаруйн турш байнга утасдаж, Төгс Хүчит Бурханы хаанчлалын сайн мэдээг номлож байсан ч би үүнийг нь хүлээн зөвшөөрөхөөс үргэлж татгалзаж, эгчийг буцаж ирээд, Эзэнд үргэлжлүүлэн итгэ гэж шаардсаар байв. Эгч Төгс Хүчит Бурханд маш тууштай итгэдэг бөгөөд итгэл нь огт ганхахгүй гэдгийг би яваандаа олж харсан тул түүнийг зөнгөөр нь орхиод, ятгах оролдлогоо зогсоосон юм. “Цаашдаа би Эзэн Есүстээ итгэсээр байя, харин та Төгс Хүчит Бурхандаа итгэж болно. Тэгээд хоёулаа нэг нэгнийхээ замд хөндөлсөхгүй!” гэж хэлэв. Үүний дараа Жу эгчийг утасдаж, Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг гэрчлэх болгонд нь би бултах шалтаг хайдаг болов. Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсаар байсан ч эгч надад сайн мэдээ тараахаа огт больсонгүй.

11-р сарын нэгэн өглөө үүр цайгаа ч үгүй, дөнгөж 5 цаг өнгөрч байхад хаалга тогшив. Хаалгаа тайлтал Жу эгчтэй хамт ах, эгч хоёр зогсож байлаа. Жу эгчийг хараад миний дотор зөрчилдөж эхлэв. “Танд ойлгомжтой хэлээ биз дээ? Яах гэж ийм хол зам туулж, манайд ирж байгаа юм бэ? Таныг юу ч гэж хэллээ гэсэн би Төгс Хүчит Бурханд итгэхгүй” гэж дотроо бодов. Нэг чуулганы гишүүдийн хувиар эгч бид хоёр олон жилийн турш танил явсан ч би тэдэнд таагүй үг хэлж, гэртээ оруулаагүй юм. Жу эгч хэчнээн шийдэмгий байгааг минь хараад, царай нь цонхийж, багтарсан хоолойгоор ингэж хэлэв: “Дүү минь, би Ариун Сүнсээр хөдөлгөгдсөн болохоор хаанчлалын сайн мэдээг чамд дуулгахаар ирсэн юм. Бурханы хайр байгаагүй сэн бол би бардам зангаа хойш тавьж, сайн мэдээг чамд

---

дуулгахаар ахин дахин зүтгэж чадахгүй байх байсан. Дүү минь, Эзэн Есүс үнэхээр эргээд ирж. Яг одоо Бурханы шинэ ажлыг хүлээн авсан хүмүүс дээр Ариун Сүнс ажиллаж байна. Хэрэв Ариун Сүнсний ажил байгаагүй бол чамд сайн мэдээ номлохоор ирэх ийм их итгэл, сэтгэлийн тэнхээ хэнд байх вэ дээ? Чуулганыхаа одоогийн байдлыг чи ч харсан. Ах эгч нар маань бүгд нүгэлд хүлэгдэн, түүнээсээ ангижрах чадалгүй байна. Бурхан энэ удаад хүнийг шүүх үгээ илэрхийлж, биднийг нүглээс ангижруулж, цэвэрлэх ажил хийхээр ирлээ. Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг алдвал Бурханы авралыг олж авах өөр боломж гарахгүй шүү” гэв. Эгчийн чин зүрхний үгэнд сэтгэл минь хөдөлж, би жаахан зөөлрөв. Ялангуяа чуулганы байр байдлын талаар ярьж байх үед нь чуулганууд дотор харагдсан бүх явдал гэнэтхэн санаанд зурсхийж эхэллээ: Миний үйлчилж байсан эхний чуулганд пасторуудын үг, үйлдэл нь зөрдөг байв. Их мөнгө хандивласан хэн бүхнийг инээмсэглэн угтаж, ихээхэн санаа тавьдаг байлаа. Харин их мөнгө хандивлаагүй хүмүүсийг үл тоож, дорд үздэг байсан юм. Би ийм зүйл болж байгааг үнэхээр тэвчиж чадаагүй тул өөр чуулганд орсон билээ. Тэр чуулганы хамтран зүтгэгчид нэг нэгнээ гадуурхаж, атаа жөтөө бүхий маргаан хийж, бие биетэйгээ хуйвалдан янз бүрийн бүлэглэл үүсгэж, шашингүй ертөнцийн хүмүүсээс ямар ч ялгаагүй байгааг би нүдээр үзэв. Тэгээд үүндээ асар их сэтгэл гонсойлоо. Эхэндээ би дахин өөр чуулганд ормоор байсан ч нэг ах аль хэдийн олон чуулган сольсноо яриад, хаана ч очсон үргэлж ийм эзгүйрэл, харанхуйтай таардаг гэсэн юм... Үүний зэрэгцээ нүгэлд амьдарч байхдаа гаргасан янз бүрийн ааш авираа би бодохоор: “Эзэн Есүс үнэхээр нүглийг үндсээр нь устгах ажил хийхээр махбодод эргэж ирсэн юм биш байгаа?” гэж сэтгэлдээ тээнэгэлзэж эхлэв. Энэ үед Жу эгч цааш нь ингэж хэллээ: “Төгс Хүчит Бурхан эргэн ирсэн Эзэн мөн эсэхийг олж мэдье гэвэл Төгс Хүчит Бурханы үгийг уншихад л хангалттай. Эзэн Есүс ажлаа хийхээр ирэх үед шавь нар нь Түүнийг зөгнөлд хэлсэн Мессиа мөн гэдгийг үг, ажлаар нь дамжуулан таньж мэдсэн тул дагасан юм. Өнөөдөр бид Төгс Хүчит Бурхан Өөрийн ажлыг хийхээр ирсэн Эзэн Есүсийн илрэлт мөн эсэхийг бас л Төгс Хүчит Бурханы үг, ажлаар дамжуулан тодорхойлох ёстой. Хэрэв чи Төгс Хүчит Бурханы бүх үгийг уншсанахаа дараа Түүнийг эргэн ирсэн Эзэн биш гэж бодсоор байвал би чамайг итгэ гэж хүчлэхгүй, бас чамд сайн мэдээ номлохоо больё. Учир нь Бурхан сайн мэдээг нь хүлээн зөвшөөр гэж хэнд ч хүчээр тулгаж байгаагүй.”

Жу эгчийг ингэж хэлсний дараа би тэрхэн зуур эргэлзэж: “Төгс Хүчит Бурханы үгийг уншиж үзээд, тэнд хэлсэн яг аль үнэн нь Жу эгчийг Төгс Хүчит Бурханд ингэтлээ бат итгэхэд хүргэснийг олж мэдсэн ч яах вэ” гэж дотроо бодов. Тэгээд би хаалгаа тайлж, Жу эгчийг бусадтай нь хамт гэртээ орууллаа. Жу эгч нөгөө хоёрыгоо Төгс Хүчит Бурханы Чуулганы Жан Чин эгч, Лю Каймин ах гэж танилцуулав. Жу эгч: “Чуанянг дүү минь, би Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн аваад хэдэн сар болж байна. Би Төгс

---

Хүчит Бурханы Чуулганыг өөрөө шалгаж үзэхээр очсон, бас тэдний чуулганы амьдралд оролцож үзсэн. Төгс Хүчит Бурханы Чуулган үнэхээр Ариун Сүнсний ажилтай чуулган гэдгийг би хувийн туршлага, няхуур судалгаагаар дамжуулан олж мэдсэн юм. Энэ бол Бурханаас ирсэн жинхэнэ чуулган гарцаагүй мөн. Чи бид хоёр олон жилийн турш хамтдаа нэгэн чуулганы гишүүд байлаа. Одоо тэр чуулганд юу болж байгааг чи чуулганы хамтран зүтгэгчийн хувьд надаас сайн мэдэж байх учиртай. Ариун Сүнс манай чуулганд ажиллахаа аль эрт больсон. Үүнийг ч хүн бүр мэдэж байгаа. Пасторууд нь биднийг амиар хангах номлол номлож чаддаггүй. Гагцхүү бусад урсгалыг хэрхэн дайрч давшлах, тэднээс сэрэмжлэх тухай л номлож, бидэнд Эзэний нэрийг баримтлах ёстой, чуулганаа орхиж яваагүй цагт аврагдана гэж хэлдэг. Гэтэл Эзэний үгээр ингэж аашлах ямар ч үндэслэл байдаггүй. Тэд олж авсан байр сууриа хамгаалж, амь амьжиргаагаа авч үлдэхийн тулд л ингэдэг болохоос бидний амийг огтхон ч бодолцдоггүй. Хэрэв тэд үнэхээр л аминд маань хариуцлага хүлээдэг байсан бол биднийг Ариун Сүнс аль эрт ажиллахаа больсон шашинд зөрүүдлэн байлгаж, Ариун Сүнсний ажилгүй чуулганд урхидан, өлсөж үхэхийг маань хүлээлгэхийн оронд санаачилга гарган, Ариун Сүнс ажилладаг чуулганыг хайхад биднийг удирдах ёстой байсан юм” гэлээ. Үүнийг сонсоод би: “Жу эгч үнэхээр л болж байгаа зүйлийг ярьж байна. Чуулган маань өнөөдөр үнэхээр Ариун Сүнсний ажилгүй болсон. Пастор, ахлагчдын хийдэг бүх зүйл нь үнэндээ итгэгчдийн амийг бодолцож үзээгүй байдаг. Энэ чуулганд би олон жилийн турш үйлчлэхдээ Эзэн бидэнтэй хамт байхгүй мэт мэдрэх нь улам ихэссэн юм. Сүнс минь мухардалд орсон мэтээр хатаж гандан, гэрлээс холдсоноо мэдрээд удаж байна шүү дээ” гэж дотроо бодов. Эгчийн ийм ухаалаг, үндэслэлтэй байдлаар ярьж байгааг сонсоод би тэдний ирснийг эсэргүүцэхээ больсон юм.

Энэ үед эгчтэй хамт ирсэн Лю ах: “Дүү минь, Бурхан шинэ ажил хийхээр ирж, Ариун Сүнсний ажил урагшилсан ч хүмүүс Бурханы хийж буй шинэ ажилтай хөл нийлүүлээгүйгээс үүдэн шашны ертөнц ийнхүү эзгүйрч байгаа юм. Хамгийн гол нь пастор, ахлагчид Эзэний тушаалыг дуулгавартай дагаж, Эзэний үгийг хэрэгжүүлэхийн оронд ертөнцийн ёрын муу чиг хандлагыг дагахад итгэгчдийг хөтөлж, тэр ч байтугай Бурханы шинэ ажлыг эсэргүүцэж, ялласнаас энэ нь үүдэлтэй. Энэ нь Эзэн Есүс ажлаа хийхээр ирэх үед сүм нь үхэр, хонь, тагтаа зарж, мөнгө солилцдог газар болж хувирсан байсантай яг адил. Тахилч нар хууль зөрчиж, Бурханыг хуурахын тулд согогтой амьтнаар өргөл барьж, фарисайчууд эд баялагт шунахайрч, албан тушаалынхаа олз ашгийг эдэлж, энэ мэт бусад нүглийг үйлддэг байсан. Бурханд үйлчилдэг хүмүүс ч нүгэлд амьдарч, сэтгэлдээ Бурханыг огтхон ч хүндэлдэггүй байсан юм. Ариун Сүнс сүмд ажиллахаа больж, Ариун Сүнсний ажил урагшлан, Хуулийн эрин үе дэх Бурханы ажил дуусгавар болсныг энэ нь хангалттай харуулсан. Эзэн Есүс Хуулийн эрин үеийн ажилд суурилан

---

золин аврах ажил хийхээр ирсэн бөгөөд Ехова Бурханы нэрийг баримталж, хуультай зөрүүдлэн зууралдаж байсан хүмүүс дээр Ариун Сүнс ажиллахаа больсон байдаг. Үүний оронд Ариун Сүнсний ажил Эзэн Есүсийн шинэ ажлыг хүлээн авсан хүмүүс рүү шилжсэн юм. Сүм Бурхангүй болсон тул улам бүр эзгүйрч, эцэстээ хулгайчдын үүр болон хувирсан. Харин Эзэн Есүсийн шавь нар Эзэний авралыг авч, Эзэний сургаалыг хэрэгжүүлж, Эзэнийг итгэл үнэмшил, хүч чадалтайгаар дагаж, орон гэрээ орхин, ажил төрлөө хаяад хавчлага, бэрхшээлээс айлгүйгээр Эзэний сайн мэдээг гэрчилж түгээсэн байдаг. Ариун Сүнсний ажлаас л ийм үр нөлөө гарсан бус уу? Үүний адилаар өнөөдөр Эзэний эргэн ирэлт хуучин эрин үе дуусаж, шинэ эрин үе эхэлснийг илтгэж байна. Ариун Сүнс Нигүүлслийн эрин үеийн чуулгануудад ажиллахаа аль эрт болиод, Бурханы шинэ ажлыг хүлээн авсан хүмүүс дээр ажиллаж эхэлсэн нь Библи дэх дараах зөгнөлийг биелүүлдэг: **‘Мөн ургац хураах хүртэл гурван сар дутуу байхад Би та нараас бороог татсан: Би нэг хотод бороо оруулж, нөгөө хотод бороо оруулаагүй: нэг хэсэгт нь бороо орсон, харин бороо ороогүй хэсэг нь хатсан’** (Амос 4:7). **‘Харагтун, газар дээр өлсгөлөн илгээх өдрүүд ирлээ, талхаар өлсөж, усаар цангах биш, харин Еховагийн үгийг сонсохын төлөө өлсөнө’** (Амос 8:11). Төгс Хүчит Бурхан бас хэлэхдээ: **‘Бурхан энэ баримтыг гүйцэлдүүлнэ: Тэр орчлон ертөнц даяар бүх хүнийг Өөрийнхөө өмнө ирүүлж, газар дээрх Бурханыг шүтүүлэх ба өөр газрууд дахь Түүний ажил зогсож, хүмүүс албан хүчээр үнэн замыг эрж хайна. Энэ нь Иосеф шиг байх болно: Түүнд идэх юм байсан учраас хүн бүр хоол хүнс авахаар түүн рүү очиж, түүнд бөхийдөг байсан. Өлсгөлөнгөөс зайлсхийхийн тулд хүмүүс албан хүчээр үнэн замыг эрж хайна. Шашны нийгэмлэг тэр чигтээ асар их өлсгөлөн амсах ба зөвхөн өнөөдрийн Бурхан л хүний таашаалыг хангах мөнх урсах булагтай амийн усны ширгэшгүй булаг бөгөөд хүмүүс Түүн рүү очиж, Түүнд найдна’** (Үг нь махбодоор илэрсэн номын “Мянган жилийн хаанчлал ирчихсэн”). **‘Бүхий л орчлон ертөнц даяарх Бурханы бүх ажил зөвхөн энэ бүлэг хүмүүс дээр төвлөрсөн. Тэрээр та нарын төлөө бүхнээ золиосолсон; Тэрээр орчлон ертөнц даяарх Сүнсний бүх ажлыг буцаан авч, та нарт өгсөн. Тийм учраас та нар бол хувьтай хүмүүс гэж Би хэлдэг. Түүнчлэн Тэрээр алдар суугаа Өөрийн сонгосон хүмүүс болох Израилиас та нар луу шилжүүлсэн, Өөрийн төлөвлөгөөний зорилгыг энэ бүлэг хүнээр дамжуулан бүрэн харуулна. Тиймээс та нар бол Бурханы өвийг хүлээн авах хүмүүс, бүр түүгээр ч барахгүй Бурханы алдрын өв залгамжлагчид билээ’** (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурханы ажил хүний төсөөлдөг шиг энгийн үү?”). **‘Шашны хүмүүс Бурханы шинэ ажлыг хүлээн зөвшөөрөх чадваргүй, өнгөрсөн үеийн хуучин ажилтай л зууралддаг учраас Бурхан тэр хүмүүсийг орхисон бөгөөд шинэ ажлыг нь хүлээн зөвшөөрдөг хүмүүс дээр энэхүү шинэ ажлаа хийдэг. Тэд бол Бурханы шинэ ажилд хамтран ажилладаг хүмүүс бөгөөд**



---

**ийм маягаар л Түүний удирдлага гүйцэлдэж чадна'** (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурханы ажил ба хүний хэрэгжүүлэлт”) гэжээ. Ариун Сүнс Нигүүлслийн эрин үеийн чуулгануудад ажиллахаа больсон тул хүмүүс чуулгануудыг сэргээх гэж хэдий их хичээж, хүний ямар ч аргыг хэрэглэсэн үр ашиггүй гэдгийг Бурханы эдгээр үгээс харж болно. Католик Сүм, Протестант урсгалынхан бүгд адил. Тэдний итгэгчдийн сүнс нь хатаж, өлбөрөн, итгэл, хайр нь аажмаар хөрж, Эзэний сургаалыг дагах чадваргүй болж, олонх нь ертөнцийн ёрын муу чиг хандлагыг дагаж, эд баялаг хөөцөлдөж, өнгө мөнгөнд сувдаглаж байна. Чуулганууд эзгүйрсэн газар болжээ. Харин Төгс Хүчит Бурханы Чуулганы ах эгч нар бол янз бүрийн урсгалыг орхин, Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн авсан, төрөл бүрийн ажил мэргэжилтэй хүмүүс бөгөөд Бурханы дуу хоолойг сонсоод Түүний сэнтийн өмнө эргэн ирсэн ухаалаг охид юм. Тэд Бурханы сэнтийгээс ундрах амийн амьд усыг хүртэж, Бурханы Өөрийн хариулга, удирдлагыг авч, Бурханы хаанчлалын сайн мэдээг нэгэн үзүүрт сэтгэлээр түгээж, гэрчилж байгаа хүмүүс юм. Дэлхий ертөнцийн доог тохуу, доромжлол, элдэв урсгалын удирдагчдын зүхэл, яллалт, тэр ч байтугай зодуур, ХКН-ын засгийн газрын баривчилгаа, гэр оронд нь хийдэг нэгжлэг, өмч хөрөнгийнх нь хураалга, харгис хэрцгий эрүү шүүлт, шоронгийн хорио бүү хэл түүнээс цаадхыг ч тэд туулдаг. Гэлээ ч тэдэнд итгэл үнэмшил, хүч тэнхээ, хайр байдаг бөгөөд цөхөршгүй, тууштай байдлаар Төгс Хүчит Бурханыг дагаж, Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг гэрчилдэг юм. Тэд өөрсдийн хүчээр ингэж чаддаг юм биш. Энэ бүгд бол Ариун Сүнсний ажлаас гардаг үр нөлөө юм! Үүнээс гадна, шашны ертөнц рүү өлсгөлөн илгээж байгаа явдлаас Бурханы хүслийг олох учиртай. Бурхан Өөрт нь жинхэнээсээ итгэдэг, үнэнээр цангаж байгаа хүмүүсийг шашнаас чөлөөлж, шашны антихристүүдийн ов мэх, хяналтаас ангижруулж, шашныг орхиулах зорилгоор ингэдэг. Ингэснээр тэд Бурханы мөр, илрэлтийг эрэлхийлж, эцсийн өдрүүд дэх Бурханы шүүлтийн ажлыг хүлээн авч, Бурханаар цэвэрлэгдэн, төгс болгуулж чаддаг. Үүнээс гадна, шашинд үлдчихээд цадталаа талх идэхээр эрэлхийлдэг, Бурханд үнэн сэтгэлээсээ итгэхийн оронд хүнийг шүтэж, дагадаг үл итгэгчдийг ил болгож, таягдан хаяна. Ингэснээр бүх хүнийг төрлийнх нь дагуу ангилах болно. Бурханы мэргэн ухаан, төгс хүчин энэ бус уу?”

Бурханы үг болон энэ ахын нөхөрлөлийг сонссоны дараа энэ бүгд маш бодитой, үнэн байр байдалд бүрэн нийцтэй байгааг нь би мэдрэв. Тэгээд зүүднээсээ сэрэх мэт болж, янз бүрийн чуулганы эзгүйрлийн эх үүсвэрийг ойлголоо. Би ямар мэдрэмжгүй байснаа энэ мөчид эцэст нь олж харав. Пастор, ахлагчдаас авхуулаад жирийн итгэгчид хүртэл бүгд нүгэлд хүлэгдэж, чуулган хууль ёсгүй, шударга бус байдлаар бялхаж байгааг би харсан ч Бурханы хүсэл, Ариун Сүнсний ажлыг эрэлхийлэхгүй хэвээр байсан юм. Түүнчлэн Бурханы дуу хоолойг сонсоход ямар ч анхаарал хандуулаагүйн улмаас өөрөө ч

---

мэдэлгүйгээр Ариун Сүнсний ажилд таягдуулжээ. Би Төгс Хүчит Бурханы үгийг анхааралтай унших шаардлагатай гэдгээ ухамсарлан ойлгов. Тэр өдөр Жу эгч бусдынхаа хамт явах гэж байхдаа эргэн ирж, надтай дахин нөхөрлөх цагаа товллоод, бас “Хурганы нээсэн хуйлмал ном” гэх ном үлдээснийг нь би маш баяртайгаар хүлээн авсан юм.

“Хурганы нээсэн хуйлмал ном” гэх Төгс Хүчит Бурханы үгийн номыг хожим нь уншиж байхдаа, хүн төрөлхтнийг аврахын тулд Бурханы хийсэн ажлын гурван үе шат, эцсийн өдрүүд дэх Түүний шүүлтийн ажил, Түүний хаанчлалын гоо үзэсгэлэн гэх зэрэг маш олон нууцыг Төгс Хүчит Бурханы үг ил болгосныг би олж хараад, Бурханы ажлын талаар илүү гүн гүнзгий ойлгодог болсон юм. Ангаж цангасан сүнс минь цангаагаа тайлсан мэт болж, унших тусмаа би тэр номд дурлаж байв. Би өглөө 5:30-д босдог байсан бол “Хурганы нээсэн хуйлмал ном” гэх номыг олж авснаас хойш 4:30-д босон, Төгс Хүчит Бурханы үгийг уншиж, эргэцүүлдэг болсноор маш сэтгэл хангалуун байлаа. Нэгэн өглөө “Чи Бурханы жинхэнэ итгэгч мөн үү?” гэсэн бүлгийг уншиж байхад сэтгэл үнэхээр их хөдөлж билээ. Төгс Хүчит Бурхан бол хүмүүсийн зүрх сэтгэлийн чанадыг шинждэг Бурхан бөгөөд бидний өөрсдөө хэзээ ч олж мэдэж чадахааргүй завхарсан уг чанарыг маань илчилсэн юм. Ингэснээр би Сатаны завхралд өртсөн гэх үнэнээ олж харах чадвартай болсон билээ. Ялангуяа Төгс Хүчит Бурханы дараах үгийг уншаад, завхралынхаа үнэнийг яг олж харсан юм: **“Ямар ч байсан, үнэнийг үнэлдэггүй бүх хүн бол үл итгэгчид, үнэнээс урвагчид юм гэж Би хэлдэг. Ийм хүмүүс хэзээ ч Христийн сайшаалыг хүртэхгүй... Бурхан бол дэлхий ертөнцөд ч, хэн нэг хүнд ч биш, харин Түүнд үнэхээр итгэж, Түүнийг шүтэн мөргөж, Түүнд үнэнч агаад итгэлтэй байдаг бүх хүнд харьяалагддаг гэдгийг чи ойлгох ёстой.”** Эдгээр үгийг эргэцүүлэх зуур би өөрөөсөө ингэж асуусаар байсан юм: “Би Бурханд үнэн сэтгэлээсээ итгэдэг хүн мөн үү? Би үнэнийг дээдэлдэг бил үү? Өнгөрсөн жилүүдэд Бурханд итгэж байхдаа би юуг дээдэлдэг байв?” Тэгээд ихэнх ах эгч нарын нэгэн адил байснаа бодов: Гаднаа би Библи уншиж, цуглаанд оролцдог ч Эзэний үгийг туулж, хэрэгжүүлэхэд огт анхаардаггүй байжээ. Харин пасторуудын номлодог номлол, Библи дэх бичиг үсгийн үгчилсэн утгыг дээдэлдэг байж. Пасторуудын номлодог Библийн мэдлэг, шашны сургаалд би бүрэн дүүрэн итгэдэг байлаа. Тэдний хэлж байгаа зүйл үнэнийг үнэхээр агуулж байгаа эсэх, Эзэний хүсэлд нийцэж байгаа эсэхийг хэзээ ч боддоггүй байв. Би чухамдаа тэдний хэлж байгаа зүйлийг судалж, цэгнэхэд Эзэний үгийг хэзээ ч ашиглаж байсангүй. Итгэгч бид зүгээр л тэдний номлосон бүхэнд итгэдэг байсан юм. Одоо ингээд бодохоор би хүмүүсийг сохроор шүтэж, үнэхээрийн мунхаг, мэдлэггүй явснаа ухаарав! Пастор, ахлагчдын хийдэг байсан номлолыг эргээд бодлоо. Тэд өргөл өргөх, бусад урсгалаас сэрэмжлэх, чуулганыг битүүмжлэх талаар номлож, эсвэл олон жилийн турш номлосоор ирсэн улиг болсон зүйлээ

---

л ярьдаг байсан юм. Шинэ гэрэлтүүлэлт, шинэ гэгээрэл гэж байсангүй. Тэд биднийг хангах ямар ч зүйлгүй, бас ангаж цангасан сүнсний маань асуудлыг шийдэж чаддаггүй, чуулган дахь эзгүйрлийг бүр ч шийдэж чаддаггүй байв. Үүний улмаас ах эгч нар цуглаанд оролцох үедээ зүгээр л хэлбэрддэг болсон юм. Цуглаан дээр зарим нь хоорондоо ярьж, зарим нь зүүрмэглэж, зарим нь утсаараа тоглодог байв... Би ийм харанхуй, эзгүйрсэн чуулганд амьдарч байсан ч Бурханы хүсэл, Ариун Сүнсний ажлыг эрж хайхаа мэддэггүй байж. Мэдээж би үнэнийг эрэлхийлдэг, Бурханд чин сэтгэлээсээ итгэдэг нэгэн огт биш байлаа. **“Үнэнийг үнэлдэггүй бүх хүн бол үл итгэгчид, үнэнээс урвагчид юм гэж Би хэлдэг.”** **“Бурханхэн нэг хүнд ч биш, харин Түүнд үнэхээр итгэж, Түүнийг шүтэн мөргөдөг бүх хүнд харьяалагддаг”** гэж Төгс Хүчит Бурхан хэлсэн байдаг. Эдгээр үг үнэхээр бодит байсан бөгөөд **“Би бол зам, үнэн, амь юм”** (Иохан 14:6) хэмээх Эзэн Есүсийн үгийг гэнэт бодогдуулав. Бурхан бол үнэн, Бурхан хүнд үнэн, зам, амийг өгөхийн тулд ажлаа хийдэг, Бурханд үнэхээр итгэдэг хүмүүс үнэнийг эрэлхийлж, олж авахад анхаардаг гэдгийг би тэр үед ойлголоо. Бурханд итгэгчийн хувьд би үнэнийг эрэлхийлэхэд анхаарал хандуулдаггүй байсан тул итгэхдээ төөрөлдсөн бус уу? Энэ маягаар Бурханд итгэх юм бол Бурханы сайшаалыг яаж хүртэх юм бэ? Төгс Хүчит Бурханы үг надад үлэмж их үр өгөөж авчирлаа! Төгс Хүчит Бурханы үгийг унших тусмаа би маш олон дутагдалтайгаа мэдэрсэн юм. Иймээс би ажиллахаас бусад үед бүх чөлөөт цагаа Төгс Хүчит Бурханы үгийг уншин өнгөрөөдөг боллоо. Үүнийг үнэн зам гэдэгт би сэтгэлийнхээ угаас бат итгэж байсан юм. Гэсэн ч Эзэн Есүсийн хэлсэн дараах үгийг уншаад самгардсан хэвээр байв: **“Тэр үед хэн нэгэн хүн та нарт ‘Хараач, Христ энд байна’, эсвэл ‘Христ тэнд байна’ гэвэл түүнд бүү итгэ. Учир нь хуурамч Христүүд болон хуурамч эш үзүүлэгчид гарч ирэн агуу тэмдэг, гайхамшгуудыг үзүүлэх ба боломжтой бол сонгогдсон хүмүүсийг ч хууран мэхэлнэ”** (Матай 24:23–24). Эдгээр үгийн цаад утга учир нь юу болохыг мэдэхгүй байсан тул Жу эгчийг бусадтайгаа дахин ирэхээр нь энэ талаар эрж хайхаар шийдлээ.

Жу эгч бусдын хамт болзсон цагтаа манайд ирсэн бөгөөд би эгчид хандан ийн хэллээ: **“Өнгөрсөн хэдэн өдөр би Төгс Хүчит Бурханы үгийг их уншаад, Төгс Хүчит Бурханы үг бүр нь үнэн, надад үнэхээр хэрэгтэй зүйл болохыг нь мэдэрлээ. Өмнө нь Жу эгч намайг урьж, Төгс Хүчит Бурханы ажлыг судлуулах гэж ахин дахин оролддог байсан ч эцсийн өдрүүдэд хуурамч Христүүд гарч ирж, хүмүүсийн хуурна гэж пасторууд маань номлосон болохоор би үнэн замыг судлахаас татгалзаж байсан юм. Одоо би үүндээ үнэхээр харамсаж байна. Гэхдээ энэ талаар төөрөгдөл минь арилаагүй байгаа тул та нартай хамт эрж хаймаар байна. ‘Тэр үед хэн нэгэн хүн та нарт “Хараач, Христ энд байна”, эсвэл “Христ тэнд байна” гэвэл түүнд бүү итгэ. Учир нь хуурамч Христүүд болон хуурамч**

---

**эш үзүүлэгчид гарч ирэн агуу тэмдэг, гайхамшгуудыг үзүүлэх ба боломжтой бол сонгогдсон хүмүүсийг ч хууран мэхэлнэ’** (Матай 24:23–24) гэж Эзэн Есүс хэлсэн байдаг. Та бүхэн эдгээр үгийг хэрхэн ойлгож байна вэ?”

Жан эгч ингэж хариулав: “Бурханд талархъя! Энэ нөхөрлөлд Бурхан биднийг удирдах болтугай! Дүүгийн асуусан асуултын тухайд бол бид эхлээд Эзэн Есүс эдгээр үгийг хэлсний зорилго, утга учрыг ойлгох ёстой. Эзэн Есүс эргэн ирэхдээ хүний Хүү, Христийн дүрээр махбод болно гэж бидэнд хэлсэн байдаг. Харин энэ эшлэлд хуурамч Христүүд бас гарч ирж, хүмүүсийг хуурахын тулд тэмдэг, гайхамшиг үзүүлэх болно гэж Эзэн хэлсэн байна. Өөрөөр хэлбэл, Бурхан дараагийн удаа махбодод илрэх үед тэдгээр хуурамч Христ бас гарч ирнэ. Эзэн биднийг хуурамч Христүүдэд хууртахаас сэргийлэхийн тулд ялган таних чадвартай болох ёстой гэж ийм үг хэлснийг эндээс харж болно. Харин хаалгаа үргэлж хаалттай байлгаж, Эзэн ирсэн гэх сайхан мэдээ түгээж буй хэний ч үгийг битгий сонсоорой гэж ийм үг хэлээгүй юм. Энэ нь буруу хэрэгжүүлэлт болж, Эзэний санаа зорилгыг бүрмөсөн буруугаар ойлгосон явдал болно. **‘Шөнө дөлөөр хашхирах дуу гарч, “Хараач, Сүйт залуу ирлээ; Түүнийг угтан авцгаа” гэлээ’** (Матай 25:6). **‘Харагтун, Би үүдэнд зогсоод тогшиж байна: Хэрвээ хэн нэгэн Миний дуу хоолойг сонсоод хаалгаа нээвэл, Би түүн дотор орж, түүнтэй хамт, тэр Надтай хамт хооллох болно’** (Илчлэл 3:20). **‘Миний хонин сүрэг Миний дуу хоолойг сонсдог, Би тэднийг мэддэг бөгөөд тэд Намайг дагадаг’** (Иохан 10:27) гэж Эзэн Есүс зөгнөсөн байдаг. Эзэн эргэн ирэх үедээ дуу хоолойгоо ашиглан Бурханы хоньдыг дуудах бөгөөд Бурханы хоньд дуу хоолойг нь таньж, Түүн рүү буцаж очно гэдгийг Эзэний үг тун тодорхой харуулж байна. Өөрөөр хэлбэл, Эзэнийг эргэн ирэх үед нь угтан авч чадах эсэх маань Бурханы дуу хоолойг таньж чадах эсэхээс голлон хамаарна. Хэрэв бид Бурханы дуу хоолойг сонсохоор хүчин чармайлт гаргалгүй, Эзэн эргэн ирсэн гэх сайн мэдээ түгээж буй хүмүүст байнга татгалзаад байвал хаалгаа хааж, Эзэнийг гадаа үлдээх эрсдэлтэй бус уу? Хуурамч Христүүдийн онцлог шинж чанар бол тэмдэг, гайхамшиг үзүүлэх чадвар гэдгийг бид Эзэний үгээс харж байна. Тэд хүмүүсийг хууран мэхлэхийн тулд өвчтэйг эдгээж, чөтгөрүүдийг үлдэн хөөх гэх мэт зарим нэг тэмдэг гайхамшиг үзүүлж, Эзэн Есүсийн урьд нь хийсэн ажлыг дуурайдаг. Гэхдээ хуурамч Христүүд бол муу ёрын сүнсний биелэл тул ямар ч тэмдэг үзүүллээ гэсэн үнэнийг илэрхийлж чаддаггүй. Энэ бол гарцаагүй. Төгс Хүчит Бурханы үг хуурамч Христүүдийн илэрхийлэл, мөн чанарыг хангалттай тод харуулдаг. Төгс Хүчит Бурханы үгийн зарим хэсгийг харвал чи ойлгоно. Төгс Хүчит Бурхан хэлэхдээ: **‘Хэрвээ эцсийн өдрүүдэд өвчтэйг эдгээн, чөтгөрийг зайлуулж, хүний төлөө цовдлогдсон Есүстэй адилхан нэг “Бурхан” гарч ирэх юм бол тэр “Бурхан” хэдийгээр Библи дэх Бурханы тодорхойлолттой адилхан, хүлээн зөвшөөрөхөд хүнд**

---

хялбар байх ч мөн чанартаа Бурханы Сүнсний өмссөн махбод биш, харин муу ёрын сүнсний өмссөн махан бие байна. Учир нь Өөрийнхөө аль хэдийн дуусгасан зүйлийг хэзээ ч давтдаггүй нь Бурханы ажлын зарчим билээ. Иймээс хоёр дахь удаа бие махбодтой болсон Бурханы ажил нь эхнийхийн ажлаас өөр байдаг’ (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурханы оршдог махбодын мөн чанар”). ‘Өнөө үед тэмдэг, гайхамшиг үзүүлж, чөтгөрүүдийг хөөн зайлуулж, өвчтэйг эдгээж, олон ид шид үзүүлж чадах хүн гарч ирээд, Есүс ирлээ хэмээн өөрийгөө зарлавал энэ нь Есүсийг дуурайсан муу ёрын сүнснүүдийн дүр эсгэлт байх болно. Үүнийг санаж яв! Бурхан нэг ажлаа давтдаггүй. Есүсийн ажлын үе шат аль хэдийн биелсэн ба ажлын тэрхүү үе шатыг Бурхан дахин хэзээ ч хийхгүй... Хэрвээ эцсийн өдрүүдэд Бурхан тэмдэг, гайхамшиг үзүүлсээр, чөтгөрүүдийг хөөн зайлуулж, өвчтэйг эдгээсээр—яг Есүс шиг үйлдсэн бол нэг ажлаа давтаж байгаа хэрэг болж, Есүсийн ажил ямар ч ач холбогдол, үнэ цэнгүй байх байсан юм. Тиймээс Бурхан эрин үе бүрд ажлын нэг үе шатыг хэрэгжүүлдэг. Түүний ажлын үе шат бүрийг гүйцэлдмэгц муу ёрын сүнснүүд удалгүй дуурайдаг ба Сатан Бурханыг өсгий даран дагаж эхэлсний дараа Бурхан өөр арга барилд шилждэг. Бурхан ажлынхаа нэг үе шатыг биелүүлмэгц муу ёрын сүнснүүд үүнийг нь дуурайдаг. Та нар энэ талаар тодорхой ойлгох ёстой’ (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурханы өнөөдрийн ажлыг мэдэх нь”). Хуурамч Христүүд бүгд Христийн дүр эсгэгч муу ёрын сүнснүүд гэдгийг Төгс Хүчит Бурханы үг маш тодорхой харуулж байна. Өөрсдийгөө тэд Бурхан гэж дууддаг ч өчүүхэн ч үнэнийг эзэмшээгүй байдаг бөгөөд Христийн мөн чанаргүй тул Бурханы ажлыг хэрхэвч хийж чаддаггүй. Харин хүмүүсийн хууран мэхлэх зорилгоор Эзэн Есүсийн аль хэдийн хийсэн ажлыг дуурайн, Бурханы араас нэхэж л чаддаг. Хуурамч Христүүд хүмүүст үнэнийг өгч, хэрэгжүүлэх шинэ зам авчирч хэзээ ч чадахгүй. Энэ дэлхий дээрх бүх хуурамч бүтээгдэхүүн нь жинхэнэ бүтээгдэхүүнийг дуурайлган хийгдсэн гэдгийг хүн бүр мэддэг. Хуурамч Христүүд үүнтэй яг адилхан. Тэд хүмүүсийг хуурахын тулд Эзэн Есүсийн хийсэн ажлыг хуулбарлах замаар өвдсөн хүмүүсийг эдгээж, чөтгөрүүдийг хөөн зайлуулж, зарим нэг энгийн гайхамшиг үзүүлдэг. Гэхдээ хуурамч Христүүд хэзээ ч үхсэнийг амилуулж, 5,000 хүнийг таван талх, хоёр загасаар хооллох гэх мэт гайхамшиг үзүүлж чадахгүй. Тиймээс өөрсдийгөө Христ хэмээн дуудаж, эргэн ирсэн Эзэн Есүс гэгцгээж, тэмдэг, гайхамшиг үзүүлж, өвдсөнийг эдгээж, чөтгөрүүдийг хөөн зайлуулж байгаа хэн бүхэн бол хүмүүсийг хуурч буй хуурамч Христ гэдэг нь эргэлзээгүй. Харин Христ бол бие махбодтой болсон Бурхан Өөрөө бөгөөд махбод болсон Бурханы Сүнс юм. Хэвийн хүн чанар, бүрэн бурханлаг чанартай Тэрээр Бурхан Өөрөө гэдэг нь гарцаагүй. Төгс Хүчит Бурхан хэлэхдээ: **‘Махбод болсон Бурханыг Христ гэдэг, иймээс хүмүүст үнэнийг өгч чаддаг Христийг Бурхан гэдэг. Энэ тухайд ямар ч хэтрүүлсэн зүйл байхгүй, учир нь Тэр хүний хүрэх боломжгүй**

---

Бурханы мөн чанар болон Бурханы зан чанарыг, мөн ажлаа хийх мэргэн ухааныг эзэмшсэн байдаг. Өөрсдийгөө Христ гэдэг атлаа Бурханы ажлыг хийж чаддаггүй хүмүүс бол луйварчид юм. Христ бол газар дэлхий дээрх Бурханы илрэл төдий биш, харин хүмүүсийн дунд ажлаа хэрэгжүүлж, гүйцэлдүүлэхдээ Бурханы авсан онцгой махбод билээ. Энэ махбод нь газар дээрх Бурханы ажлыг зүй ёсоор гүйцэтгэж, Бурханы зан чанарыг илэрхийлж, Бурханы сайн төлөөлөл байж, хүнийг амиар хангаж чаддаг учир хүссэн хүн бүр үүнийг орлочхож чадахгүй. Христийг дуурайдаг хүмүүс эрт орой хэзээ нэгэн цагт бүгд унах болно, учир нь тэд өөрсдийгөө Христ гэгчээдэг ч, Христийн ямар ч мөн чанарыг эзэмшдэггүй. Иймд Би, Христийн жинхэнэ байдлыг хүн тодорхойлох боломжгүй, харин Бурхан Өөрөө үүнийг хариулж, шийддэг гэж хэлдэг’ (Үг нь махбодоор илэрсэн номын “Эцсийн өдрүүдийн Христ л хүнд мөнх амийн замыг өгч чадна”). Тиймээс Христ л Бурханы Өөрийн ажлыг хийж, үнэнийг илэрхийлж чаддаг. Христ л Бурханы зан чанарыг илэрхийлж, хүнийг хангаж, хариулж чаддаг. Мөн Христ л хүн төрөлхтнийг золин аврах болон аврах ажлыг хийж, хуучин эрин үеийг дуусган, шинэ эрин үеийг залан авчирч чаддаг. Түүнчлэн Бурханы ажил үргэлж шинэ байдаг, хэзээ ч хуучин байдаггүй бөгөөд Бурхан хэзээ ч нэг ажлаа давтан хийдэггүй. Тиймээс Христ ажил хийхээр ирэх болгондоо үргэлж шинэ ажил авчирч, Бурханы зан чанар болон Түүнд юу байгаа, Тэр юу болохыг илэрхийлдэг. Жишээлбэл, Эзэн Есүс ажил хийхээр ирэхдээ Хуулийн эрин үеийг дуусган, Нигүүлслийн эрин үеийг авчирч, хүмүүст нүглээ улайх, гэмших боломж олгосон номлол хийж, дайснаа хайрлах, даруу, тэвчээртэй байх, бусдыг уучлахыг хүмүүст заасан юм. Эзэн Есүсийн хийсэн зүйлсийн ердөө л зарим нь энэ байв. Эзэн Есүс Бурханы хайр энэрэлтэй, өршөөнгүй зан чанарыг хүмүүст илчилсэн. Үүний адилаар Төгс Хүчит бурхан эцсийн өдрүүдэд ирээд Нигүүлслийн эрин үеийг дуусгаж, Хаанчлалын эрин үеийг авчирлаа. Тэрээр Эзэн Есүсийн золин аврах ажил дээр үндэслэн хүнийг үгээрээ шүүх, аврах ажлыг хийж, цэвэрлэгдэх, аврал хүртэхэд маань шаардагдах бүх үнэнийг бидэнд өгч, нүглээс ангижирч, аврал хүртэх замыг зааж, Бурханы зөвт, сүр жавхлант, уур хилэнт зан чанарыг илэрхийлж байна. Төгс Хүчит Бурхан бол бие махбодтой болсон Бурхан, мөн эцсийн өдрүүдэд хүн төрөлхтний дунд илэрсэн Бурхан Өөрөө гэдгийг Төгс Хүчит Бурханы ажил, үгээр дамжуулан бид бүрэн таньж чаддаг юм.”

Бурханы үг, энэ эгчийн нөхөрлөлийг сонссоны дараа би зүүднээсээ сэрсэн мэт болж, жинхэнэ Христийг хуурамч Христүүдээс хэрхэн ялгахыг сая л ойлгов. Үүндээ баярлахын зэрэгцээ өөрийнхөө үнэнгүй, өрөвдөлтэй хүн байсныг олж харсан тул ичиж байсан юм. Бурханы эцсийн өдрүүдийн ажлаас ахин дахин татгалзаж байснаа бодохоор, нуухыг нь авах гээд нүдийг нь сохлох гэгчийн үлгэрээр хуурамч Христүүдэд хууртахаас айсандаа жинхэнэ Христийг голсон гэдгээ ухаарлаа. Эзэнийг эргэн ирж, хаалга тогших үед би

---

Бурханы дуу хоолойг сонсохоос татгалзан, ахин дахин Эзэнд хаалгаа тайлаагүй. Гэсэн ч Бурхан намайг аврах тал дээр бууж өгөлгүй, энэ ах эгч нарыг хөдөлгөн манайд ирүүлж, сайн мэдээ түгээлгэжээ. Намайг үнэхээр хэзээ ч орхиогүй Бурханы хайр үнэхээр агуу юм! Би пасторуудынхаа хэлсэн үгэнд итгэсэн тул эргэн ирсэн Эзэнийг гэрчилсэн хүн бүр хуурамч Христийг номлож байна гэж бодож явсан билээ. Тэгээд Эзэний үгийг буруугаар ойлгон, Төгс Хүчит Бурханыг голж, яллаж, эсэргүүцэхийн зэрэгцээ өөрийн зууралддаг үзлийг зөв гэдэгт итгэн, үнэхээр хөгийн аашилсан байв! Төгс Хүчит Бурханы үгийг уншиж, жинхэнэ Христ ба хуурамч Христийн ялгааны талаар энэ ах эгч нарын нөхөрлөлийг сонсоогүй бол би жинхэнэ Христийг хуурамч Христээс ялгаж хэзээ ч чадалгүй, пастор, ахлагчдын л үгэнд хууртаж явах байж. Мөн пастор, ахлагчдыг даган Бурханы ирэлтийг эсэргүүцэн, татгалзаж, Бурханы авралыг хүртэх энэхүү нэн ховор боломжоо алдах байсан юм. Ингэж бодоод би Жу эгч болон бусдад нь хандан: “Төгс Хүчит Бурханы үгийг уншиж, та нарын нөхөрлөлийг сонсоод би одоо жинхэнэ Христ, хуурамч Христийг хэрхэн ялгаж салгааа мэддэг боллоо. Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс мөн гэдэгт одоо би үнэмшлээ, тэгээд эцсийн өдрүүд дэх Төгс Хүчит Бурханы ажлыг хүлээн авахад бэлэн байна” гэлээ.

Чуулганы амьдралд оролцож эхэлсний дараа, ах эгч нар олон үнэнийг ойлгосон гэдгийг, мөн тэдэнтэй харьцуулахад би ихээхэн дутуу дулимаг байгаагаа олж харсан юм. Тэгээд “Жу эгч болон бусдаар нь Бурханы үгийн талаар илүү их нөхөрлүүлж, үнэнийг илүү хурдан ойлгохдоо туслуулах ёстой юм байна” гэж дотроо бодов. Жу эгчтэй энэ талаар хэлэлцэж, манай гэрийг цуглааны газар болгож болох эсэхийг асуухад эгч тэр дороо зөвшөөрлөө. Үүний дараа бид долоо хоног бүр цуглаад Бурханы үгийг уншиж, үнэний тухай нөхөрлөдөг болов. Би Бурханы үгийг яваандаа улам сайн мэдэж, илүү олон үнэнийг ойлгодог болсон юм. Эдгээр үг нь үнэний илэрхийлэл мөн гэдгийг би зүрх сэтгэлийнхээ угт мэдэрч байлаа. Тэр мөчид Эзэн Есүсийн хэлсэн дараах үг бодогдов: **“Та нарт хэлэх зүйл Надад олон байгаа боловч та нар одоо тэдгээрийг дааж чадахгүй. Гэхдээ үнэний Сүнс болох Тэр ирэх үедээ та нарыг бүх үнэн рүү удирдана: Учир нь Тэр Өөрийн санаагаар ярихгүй; харин сонссон зүйлээ Тэр ярих болно: Мөн Тэр ирэх зүйлсийг та нарт харуулна”** (Иохан 16:12–13). Миний сэтгэл улам ч их хөдөлж, Эзэний хэлсэн эдгээр үг бүгд биеллээ олсныг олж харлаа. Төгс Хүчит Бурханы үг бол **“Чуулгануудад Сүнс юу айлдаж буйг”** (Илчлэл 2:7) хэдэг. Төгс Хүчит Бурхан бүх үнэнийг ойлгож, түүн рүү ороход нь хүнийг хөтөлж байна. Эцсийн өдрүүд дэх Бурханы ажлыг хүлээн авч, Бурханы илэрхийлсэн үнэнийг хүлээн зөвшөөрснөөр л цэвэрлэгдэж, аврал хүртэж, Бурханы зүрх сэтгэлийн дагуух хүн болж болно. Төгс Хүчит Бурханы үг л намайг Бурханы гэрт буцаан авчирч, Бурханы сэнтийн өмнө аваачсан юм. Одоо би өдөр

---

бүр Бурханы үгээр хангуулж, замчлуулан, амар амгалан, баяр баясалтай, тайван болж, гэрлээр дүүрсэн билээ. Би эцсээ хүртэл үнэнийг эрэлхийлж, Төгс Хүчит Бурханыг дагахын тулд чадах бүхнээ хиймээр байна!

## 42. Гэртээ харьсан нь

Муи, Өмнөд Солонгос

**“Бурханы бялхам хайр хүнд харамгүй хүрч, хүнийг хүрээлж байна; хүн гэмгүй, ариун, санаа зовох зүйлгүй байж, Бурханы харцан дор баяр цэнгэлээр дүүрэн амьдарч байна... Хэрвээ чи мөс сайтай, хүн чанарын мэдрэхүйтэй хүн байсан бол дулаан илч мэдэрч, халамжлуулж, хайрлуулж байгаагаа мэдрэх ба аз жаргалыг мэдрэх байсан”** (Хургыг дагаж, шинэ дуу дуулъя номын “Хүний төлөөх Бурханы хайр хэчнээн чухал вэ”). Бурханы үгийн энэ магтан дууг дуулж эхлэх бүрд дотор минь төрдөг сэтгэл хөдлөлийг хянахад хэцүү байдаг. Учир нь би нэгэн цагт Бурханаас зайлж, Түүний эсрэг тэрсэлсэн юм. Би төөрсөн хурга мэт гэртээ харих замаа олж чадахгүй байсан бөгөөд Бурханы тууштай хайр намайг Бурханы гэр лүү буцаан аваачсан билээ. Дараах өгүүллээр би Бурханы гэрт эргэн ирсэн туршлагаа Эзэн доторх ах эгч нартай төдийгүй Бурхан руу хараахан эргээгүй найзуудтайгаа хуваалцахыг хүссэн юм.

Ээж аав маань үргэлж муудалцдаг байсан учраас бага байхдаа би өдөр бүр айдас дунд амьдарч байв. Намайг дунд сургуулиа төгссөний дараа ээж маань хөршийн шавдуулснаар Эзэн Есүст итгэж эхэлсэн бөгөөд би ээжийг даган чуулганд орсон юм. Тэр цагаас эхлээд би, Бурхан бол бүх бүтээгдсэн зүйлийн Эзэн гэдгийг, мөн хүн төрөлхтнийг нүглээс золин аврахын тулд бие махбодтой болсон Бурхан Өөрөө хүний төлөөх нүглийн тахил болохоор загалмайд цовдлогдсон гэдгийг мэдэж авсан юм. Хүнийг гэх Бурханы хайр үнэхээр агуу юм! Эзэний хайраар зоригжоод би Эзэнд чин сэтгэлээсээ итгэж, Эзэний хайрыг хариулахаар шийдэж, улмаар амьдралын чиглэл, зорилгоо олсон юм. Үүний дараа би цуглаанд тогтмол оролцож, Судрыг уншин, Эзэнд магтаал өргөдөг болсон бөгөөд цаг хугацаа өнгөрөхийн хэрээр би аз жаргалтай болж эхлэв. Ялангуяа Эзэн эцсийн өдрүүдэд үүл хөлөглөн дахин ирж, биднийг тэнгэрийн хаанчлал руу угтан авна хэмээн Библиэс уншаад зүрх сэтгэл минь итгэл найдвараар улам дүүрсэн билээ. Үүнээс гадна, пастор цуглаан дээр Судрын энэ эшлэлийг бидэнд үргэлж тайлбарлаж өгдөг байв: “Галилын эрчүүд ээ, яагаад та нар тэнгэр өөд ширтэн зогсоно вэ? Та нараас өргөгдөн тэнгэр лүү аваачигдсан энэ Есүс тэнгэр лүү явсныг нь та нар харсантай адил байдлаар ирэх болно” (Үйлс 1:11). Эзэн Есүс биднийг тэнгэрлэг гэр лүү маань угтан авахаар цагаан үүлэн дээр



---

бууж ирнэ гэдэгт би улам үнэмших боллоо!

2005 онд би солонгос найз залуутай болж, түүнийгээ даган Солонгост ирлээ. Хэлний бэрхшээлээс болж би хятад цагаачдын чуулган олохоор оролдсон боловч нэгийг ч олж чадаагүй тул сүнс минь улам сул дорой болж байв. Өөрөө ч мэдэлгүйгээр би Бурханаас холдсон билээ. Бид хоёр гэрлэсэн боловч соёлын ялгаа хэтэрхий их байсан учраас хамт амьдрах аргагүй болж, нэг их удалгүй салав. Гэрлэлт минь бүтэлгүйтсэн нь сэтгэлийг минь асар их цочирдуулж, намайг ихээхэн шаналгасан юм. Харь оронд ямар ч найз нөхөд, гэр бүлгүй байсны дээр би улам бүр ганцаардах боллоо. Би гагцхүү Бурханд чимээгүйхэн залбирч, зүрх сэтгэл дэх зовлонгоо Түүнд хэлж л чадах байв. Тэгээд хятад чуулган руу намайг замчилж, Бурханы гэрт буцаан аваачаач гэж Бурханаас хүссэн билээ.

Нэг жилийн дараа би Пресвитерианы чуулганд хятад үйлчлэл байдгийг олж мэдээд, туйлын их баярлав. Эцэст нь би чуулганд Бурханыг дахин магтаж чадахаар болсон юм. Гэхдээ миний сэтгэлийг гонсойлгосон зүйл гэвэл биднийг цуглаан хийх бүрд пасторууд ердөө л судрын хэсгүүдийг уншиж өгөөд, үгийн үгчилсэн утгын талаар жаахан тайлбарладаг байв. Тэдний номлолд ямар ч гэрэл байгаагүй бөгөөд баясах ямар ч зүйл алга байв. Мөн бидний амийг огт хангахгүй байсан ба цуглаан ердөө л ёс төдий байдлаас цаашгүй болсон байлаа. Цуглааны үеэр зарим хүн өөр хоорондоо шивнэлдэж, зарим нь утсаараа тоглоом тоглож, зарим нь зүүрмэглэж, зарим нь зөвхөн найз залуу, найз бүсгүй хайн ирдэг байсан бөгөөд бүр хүзүү сээрээрээ тэврэлддэг хүмүүс ч байв. “Чуулган бол сүм, Бурханыг хүндэлдэг газар юм. Бид энд цуглаанд оролцохоор ирдэг ч Бурханаас өчүүхэн ч гэсэн эмээдэг зүрх сэтгэлтэй хүн алга. Бурхан харж буй зүйлээ маш их зэвүүцэж байгаа нь лавтай! Эзэн ийм бузар булай газрыг орхихгүй гэж үү?” хэмээн би бодлоо. Гэхдээ пастор, номлогчид энэ бүхнийг огт анзаараагүй дүр эсгэн, ямар ч анхаарал хандуулсангүй.

Дэлхий ертөнц гэх энэхүү асар том, ёрын муу тогоонд амьдраад би аажмаар замаа алдаж эхэлсэн ба чөлөөт цагаараа найз нөхөдтэйгөө архи уун, гадуур гарч, Бурханд итгэгч шиг авирлахаа бүр болилоо. Гэхдээ зүрх сэтгэл минь Эзэнээс холдож эхлэх бүрд Түүний үг ой тойнд минь ордог байв: **“Бузар сүнс хүнээс гарахдаа хуурай газраар хэрэн хэсэж, амралт хайдаг ба ганцыг ч олдоггүй. Тэгээд тэр, ‘Би гарч ирсэн гэртээ эргэн очъё’ гэдэг; ирэх үедээ өнөөх нь хоосон, шүүрдсэн, цэгцтэй болсныг хардаг. Тэгээд тэр явж, өөрөөсөө илүү хорон муу өөр долоон сүнстэй хамт тийшээ орж, тэнд амьдардаг: тэрхүү хүний хувьд сүүлчийнх нь байдал өмнөхөөсөө илүү дор болдог”** (Матай 12:43–45). Эзэний үг намайг хязгаарлаж, хамгаалсан бөгөөд Эзэнийг хилэгнүүлж, Түүгээр үзэн ядуулах вий гэж айсандаа би Бурханаас хэтэрхий холдож, хэрээс хэтэрсэн зүйл хийж

---

зүрхлэхээгүй билээ. Би Эзэнд хаягдаж, бузар сүнсний гарт орохоос айж байв.

2016 оны зул сараар, чуулган маань уур амьсгалаа хөгжөөхийн тулд тоглолт зохион байгуулахаар бүлэг авьяаслаг ах эгчийг олжээ. Тэнд миний өмнө нь огт харж байгаагүй нэг эгч Бурханыг магтсан дуу дуулсан юм: **“Бурханы Адамд тушаал өгч байгаа библи дээрх зураглал Сэтгэл хөдлөм халуун дулаанаар дүрслэгдсэн байдаг Энд зөвхөн Бурхан хүн хоёр гардаг ч Тэдний хоорондын харилцаа нь үнэхээр ойр дотно байдагт Бид гайхаж биширч эхэлдэг. 1 Бурханы бялхам хайр хүнд харамгүй хүрч, хүнийг хүрээлж байна; хүн гэмгүй, ариун, санаа зовох зүйлгүй байж, Бурханы харцан дор баяр цэнгэлээр дүүрэн амьдарч байна; Бурхан хүнд санаа тавьж, хүн Бурханы хамгаалалт, ерөөл дор амьдарч, хүний хийж, хэлж буй бүхэн Бурхантай нягт холбоотой, салшгүй байна. 2 Бурхан хүнийг бүтээсэн мөчөөсөө эхлэн хүний төлөө хариуцлага үүрэхээ мэдэрсэн. Түүний хариуцлага юу вэ? Тэр хүнийг хамгаалж, харж хандах ёстой. Хүн Өөрт нь итгэж, үгийг нь дагаж чадна гэж Тэр найддаг. Энэ нь мөн л хүнд тавьж буй Бурханы анхны найдвар юм. 3 Бурхан тийм найдвартайгаар дараах зүйлийг хэлдэг: ‘Цэцэрлэгийн бүх модны жимснээс чөлөөтэй идэж болно. Харин сайн мууг мэдүүлэгч модны жимснээс л идэж болохгүй, учир нь идсэн тэр өдөртөө л чи гарцаагүй үхнэ’. Эдгээр энгийн үг Бурханы хүслийг төлөөлдөг. Эдгээр нь мөн Бурхан зүрх сэтгэлдээ аль хэдийн хүнд санаа тавьж эхэлснийг илчилдэг. 4 Энэ энгийн хэдэн үгээс бид Бурханы зүрх сэтгэлийг хардаг. Бурханы зүрх сэтгэлд хайр байдаг уу? Зовнил байдаг уу? Эдгээр мөрд байгаа Бурханы хайр, зовнилыг хүмүүс үнэлээд зогсохгүй гүнзгий мэдэрч чадна. Хэрвээ чи мөс сайтай, хүн чанарын мэдрэхүйтэй хүн байсан бол дулаан илч мэдэрч, халамжлуулж, хайрлуулж байгаагаа мэдрэх ба аз жаргалыг мэдрэх байсан. 5 Чи эдгээр зүйлийг мэдрэхээрээ Бурханд хэрхэн хандах вэ? Бурханд ээнэгшин дассан мэт санагдах болов уу? Чи зүрх сэтгэлийнхээ угаас Бурханыг хайрлан хүндэтгэх болов уу? Зүрх сэтгэл чинь Бурханд улам ойртох болов уу? Чи үүнээс Бурханы хайр хүнд яг хэр чухал болохыг харж болно. Гэвч хүмүүс Бурханы хайрыг үнэлж, ойлгох нь бүр ч илүү чухал юм”** (Хургыг дагаж, шинэ дуу дуулъя номын “Хүний төлөөх Бурханы хайр хэчнээн чухал вэ”).

Магтан дууны үг бүрд зүрх минь улам хүчтэй цохилж, сэтгэл хөдлөлийн нулимс тасралтгүй урсаж байлаа. Энэхүү үзэсгэлэнтэй сайхан дүр зурагт Бурхан намайг дагалдаж, хайрлаж, би бүтээлд зориулан Бурханы хайрласан бүх зүйлийг эдэлж байгаа мэт санагдсан юм. Агаар, гэрэл, ус гэх мэт—бүгд Бурханы хайраар бялхаж байлаа! Бурханы бидэнд хайрласан бүх зүйлийг би эдэлж байсан боловч зүрх сэтгэл минь Бурханаас холдсон, Бурхан үүнээс болж хэчнээн их гунигласан бол. Ялангуяа **“Хэрвээ чи мөс сайтай, хүн чанарын мэдрэхүйтэй хүн байсан бол дулаан илч мэдэрч, халамжлуулж, хайрлуулж**

---

**байгаагаа мэдрэх ба аз жаргалыг мэдрэх байсан”** гэх үгээр Бурхан миний зүрх сэтгэл, сүнсийг дуудаж байгааг би мэдрэв. 2007 онд нөхөртэйгээ хамт амьдарч чадахаа больж, гэр орон гэх газаргүй болох үед минь Бурхан надад зориулж Солонгосын Эмэгтэй Цагаачдын Хүний Эрхийн Төвийг бэлтгэж өгсөн юм. Тэд намайг үнэгүй хоол хүнс, байрлах газраар хангаж, хуульч олж өгөв. Мөн гэрлэлтээ цуцлуулах заргыг минь ямар ч төлбөргүйгээр зохицуулж өгсөн юм. Иргэний харьяаллаа өөрчлөх өргөдөл гаргах цаг маань болоход Бурхан Пресвитериан чуулганы номлогчийн сэтгэлийг хөдөлгөж, миний ивээн тэтгэгч болгосон билээ. Ердийн үед солонгосчууд, ялангуяа над шиг тэр чуулганд гурав, дөрвөн удаа л явсан гадаад хүнд батлан даалт гаргахыг бараг хүсдэггүй. Энэ бүхэн Бурханы далд тусламжаар л боломжтой болсон гэдгийг би мэдэж байлаа. Мөн иргэн болохоор өргөдөл гаргаж байгаа гадаад иргэд 30 сая воны үл хөдлөх хөрөнгөтэй байх ёстой боловч надад бүр 3 сая ч байсангүй. Цагаачлалын алба надаас амин зуулгаа залгуулах чадвартай гэдгээ харуулах ажил эрхлэлтийн нотолгоо гаргаж өгөхийг хүссэн бөгөөд надад огт хүндрэл учруулсангүй... Надад хамгаас хэрэгтэй байх үед Бурхан үргэлж гайхамшиг бий болгодог байсан бөгөөд энэ нь бүгд Бурханы дээд эрхийн илэрхийлэл юм! Бурханы хайр уужим, гүн гүнзгий байдаг атал би хэтэрхий тэрслүү байжээ. Би Бурханыг аль эрт мартаж, зүрх сэтгэлийг нь шархлуулжээ. Энэхүү магтан дуу сүнсийг минь хөдөлгөсөн ба би итгэлээ сэргээн, дахин хэзээ ч садар самуунд оролцож, Бурханд уй гашуу учруулахгүй хэмээн шийдсэн юм.

2017 оны 2-р сарын 19-нд толгой, нүд минь аймшигтай их өвдөж эхэллээ. Тэгээд эмнэлэгт очсон ч эмчилгээ нэмэр болсонгүй. Манай чуулганд байсан Ли эгч намайг хятадын уламжлалт анагаах ухаан мэддэг нэг найзтайгаа танилцуулж, эмчилгээ нь ердөө долоо хоногийн дотор үр дүнгээ өгдөг гэлээ. Би эмчлүүлэхийн тулд түүнтэй хамт явсан бөгөөд тэр өдөр бид хятадын анагаах ухаан мэддэг ахын найз Жинь овогт ахтай уулзсан юм. Би Эзэн дотор ахтай уулзана гэж бодоогүй байсан бөгөөд үүнийг Бурхан зохицуулсан байх гэж бодлоо. Би Жинь ахтай Библийн талаар ярьж эхлэв. Жинь ах бидэнд Библиэс арван охины үлгэрийг уншиж өглөө. Ах надаас: “Эгч ээ, та Эзэний эргэн ирэхийг хүсэн хүлээж байна уу?” гэж асуув. Би: “Тэгэлгүй яах вэ!” гэж хариуллаа. Ах: “Тэгвэл Эзэн яаж эргэн ирэх вэ?” гэж асуухад би эргэлзэлгүйгээр: “Сударт Түүнийг үүлэн дээр бууж ирнэ гэсэн байдаг!” гэлээ. “Юу гээч? Эзэн аль хэдийн эргээд ирчихсэн” гэж ах хэлсэн юм. Би үүнийг сонсоод мэл гайхаж, ингэж хэллээ: “Маркын 13-р бүлгийн 32-р эшлэлд: **‘Харин тэр өдөр цагийг хэн ч мэдэхгүй, тэнгэр дэх тэнгэрэлчүүд ч, Хүү ч мэдэхгүй, зөвхөн Эцэг л мэднэ’** гэж хэлдэг. Эзэн хэзээ ирэхийг хэн ч мэдэхгүй. Та Эзэн эргэж ирсэн гэж хэлж байна, гэхдээ яаж мэдсэн юм бэ?” Жинь ах надад шууд хариулсангүй, харин Эзэний эргэн ирэлтийн тухай Библи дэх зарим нэг зөгнөлийг олж өглөө. Лук 12:40-д ингэж

---

хэлдэг: “Тиймээс та нар ч бас бэлэн бай: учир нь та нарын бодоогүй цагт хүний Хүү ирнэ.” Лук 17:24–26 ингэж хэлдэг: “Учир нь тэнгэрийн нэг хязгаараас нөгөө хязгаар хүртэл цахилдаг аянга шиг; хүний Хүү ч бас Өөрийн өдөртөө тийнхүү байх болно. Гэхдээ Тэр эхлээд олон зовлон туулах ёстой бөгөөд энэ үеийнхэнд гологдоно. Ноагийн өдрүүдэд ямар байсан шиг Хүний Хүүгийн өдрүүдэд ч бас тийм байх болно.” Илчлэл 3:20-д: “Харагтун, Би үүдэнд зогсоод тогшиж байна: Хэрвээ хэн нэгэн Миний дуу хоолойг сонсоод хаалгаа нээвэл, Би түүн дотор орж, түүнтэй хамт, тэр Надтай хамт хооллох болно.” Иохан 10:27-д: “Миний хонин сүрэг Миний дуу хоолойг сонсдог, Би тэднийг мэддэг бөгөөд тэд Намайг дагадаг.”

Жинь ах уншиж дуусмагцаа ингэж хэллээ: “Эзэн биднээс сонор сэрэмжтэй ажиглахыг хүсдэг, учир нь Түүний ирэх өдрийг хэн ч мэдэхгүй. Гэхдээ зөгнөлд хэлдэг зүйлийн дагуу бол Эзэн эргэн ирэхдээ хүний Хүүгийн дүртэй байх болно. Хүний Хүү гэдэг нь Бурхан хүн болох явдал бөгөөд Бурхан бие махбодтой болно гэсэн үг. Бид Эзэний ирэх цагийг яг таг мэдэхгүй ч гэлээ дуу хоолойгоор нь Түүнийг мэдэх болно. Учир нь Бурханы хоньд Бурханы дуу хоолойг сонсоно, мөн сонсох үедээ тэд Түүнийг дагана...” Тэр үед би, Эзэн Есүс махбодоор эргэн ирсэн гэж хэлсэн хэн боловч залилан мэхлэгч гэж хэлсэн пасторынхоо талаар бодлоо. Жинь ахын хэлж байгаа зүйлийг би цааш нь сонсож чадахаа больсон пасторт ийм зурвас илгээсэн юм: “Эзэн бие махбодтой болж эргэн ирсэн гэж нэг хүн надад хэлж байна. Тэд ямар чуулганд харьяалагддаг юм бэ?” Пастор надад: “Тэд Зүүний Аянгынх” гэсэн хариу илгээв. Тэр надаас даруйхан явж, тэдэнтэй дахин ямар ч холбоо тогтоохгүй байхыг хүссэн юм. Мөн тэдний номыг хэзээ ч битгий унш гэсэн бөгөөд тэрс үзлээс сэргийлэх зарим номлолыг над руу илгээлээ. Пасторын хэлсэн юу ч бай зөв байх ёстой гэж би бодсон тул тэдний нөхөрлөлийг дахин сонсохгүй байж, тэднийг зүгээр л үл тоомсорлохоор шийдсэн юм.

Гайхалтай нь, 20-ны өдрийн үдээс хойш Жинь ах дүүтэйгээ хамт миний эмчилгээ хийлгэж байсан газар ирж, Эзэний эргэн ирэлтийн ажлын талаар маш ихийг ярив. Гэхдээ тэр өглөө би ээжийнхээ нас барсан тухай мэдээг дөнгөж авсан байснаас гадна тэдний номлож байсан зүйлд жаахан эргэлзэж байсан учраас хэлсэн зүйлийг нь сонсож ер чадсангүй. Гурван өдөр энэ маягаар өнгөрч, Жинь ах надад сайн мэдээ номлохоо болихгүй мэт байв. Гэхдээ дотоод хямралаасаа болоод би түүнд намайг орхи гэж хэлсэн юм. “Боль. Надтай яриад байвал, бас таныг явахгүй бол би яваад өгье!” гэж би хэлэв. Жинь ах үнэхээр сонсохгүй байгааг минь хараад явахаас өөр аргагүй боллоо. Би Жинь ахыг дахин ирэхгүй байх гэж бодсон боловч дараагийн өдөр нь Чэн гэх ахтай цуг ирээд, надад үргэлжлүүлэн сайн мэдээ номлоно гэж би бодоогүй билээ. “Ах яахаараа ингээд байдаг билээ?” гэж би дотроо бодлоо. Нэр нүүрээ хамгаалахын тулд би үүнийг тэвчихээс өөр аргагүй байсан

---

боловч тэдэнтэй огт ярилцсангүй. Өөрсдөд нь хүйтэн хөндий хандаж байсан хэдий ч Чэн ах тэвчээртэйгээр надтай ярьсаар байв. Тэрээр: “Эзэн аль хэдийн бие махбодтой болж дэлхий ертөнцөд ирээд, шүүлт, гэсгээлтийн ажил явуулж байгаа...” гэлээ. Түүний хэчнээн тэвчээртэй, элэгсэг байгааг, мөн надад номлохдоо төвөгшөөхгүй байгааг хараад би: “Манай чуулганы хүмүүс сул дорой. Тэдний итгэл, хайр хөрчихсөн. Гэтэл Зүүний Аянгад итгэдэг хүмүүсийн итгэл, хайр яагаад ийм их байдаг билээ? Надад сайн мэдээ түгээхээр цөхрөлтгүй хүчин зүтгэл гаргахад нь ямар хүч тэднийг дэмждэг юм бол? Ариун Сүнсний ажил байгаагүй бол тэд зөвхөн өөрсдийн хүч чадлаар үүнийг хийж хэзээ ч чадахгүй дээ!” гэж бодлоо.

Энэ хугацаанд Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг надтай хамт судалж байсан Ян овогтой өөр нэг ах байсан юм. Би үргэлж хайнга, салан задгай хандлагатай байсан бол Ян ах Төгс Хүчит Бурханы Чуулганыг чин сэтгэлээсээ судалдаг байв. Өмнө нь хүмүүс өөрт нь номлох үед Төгс Хүчит Бурханы сайн мэдээг голсон боловч өнөөдөр үүнийг дахин сонссон нь Бурханы олгосон боломж байх учиртай тул үүнийг судлахыг хүссэн гэж гэж Ян ах хэлсэн юм. Мөн зөвхөн пасторын үгийг л сонсож, нээлттэй зүрх сэтгэлээр эрж хайхгүй байгааг минь Ян ах харжээ. Тэгээд надад нэгэн эшлэлийг олж өгсөн нь Матай 5:3–6 байлаа: **“Сүнсээрээ ядуу хүмүүс ерөөлтэй ээ: учир нь тэнгэрийн хаанчлал бол тэднийх юм... Дөлгөөн хүмүүс ерөөлтэй ээ: учир нь тэд дэлхийг өвлөж авна. 6Зөвт байдлын төлөө өлсөж, цангадаг хүмүүс ерөөлтэй ээ: учир нь тэд цатгагдах болно.”** Эзэний үгийг уншаад би: “Эзэний өмнө би яагаад өөрийгөө тайван байлгаж, үнэнийг эрж хайж чаддаггүй билээ? Ямар нэг тохиолдлоор Эзэн үнэхээр эргэн ирсэн байгаад би тэдний номлолыг сонсож, судлахгүй бол үлдэж хоцрох биш үү? Би бас арай жаахан нээлттэй зүрх сэтгэлтэй байх ёстой, харин өөрийнхөө төсөөлөлд үндэслэн сохроор дүгнэлт хийх ёсгүй” гэж гайхширлаа. Намайг зүрх сэтгэлээ тайвшруулж, үүнийг чин сэтгэлээсээ судлахаар дөнгөж шийдээд байх үед чуулганы номлогч над руу гэнэт утсаар ярьж, Төгс Хүчит Бурханы Чуулганы хүмүүстэй хамт байсаар байгаа эсэхийг минь асуув. Намайг тийм гэж хэлэхэд номлогч, тэднээс холбоогоо таслахыг\ дахин нэг удаа сануулсан юм. Төгс Хүчит Бурханы Чуулганыг судлахыг хүсэж байсан саяын бодлыг минь номлогчийн ятгалга сарниаж орхилоо. “Пастор болон номлогч Библийг надаас хамаагүй сайн ойлгодог, бас Эзэн эргэн ирсэн гэдгийг хүлээн зөвшөөрдөггүй. Би Библийн талаар хэтэрхий бага ойлгодог, ялган таних чадваргүй учраас пастор, номлогч хоёрын хэлсэн зүйлийг сонссон нь дээр юм байна” гэж би бодов. Би утсаа таслаад, Чэн ахад: “Ян ах судалмаар байгаа бол та хоёр цааш нь ярьцгаа. Би энэ тухай сонсмооргүй байна” гэж хэлсэн юм. Яг ингээд би Бурханы авралаас дахин нэг удаа эрс татгалзсан билээ.

Би долоо хоногийн эмчлүүлсний дараа ажилдаа эргэн орлоо. Ээж минь өнгөрсний

---

улмаас зүрх сэтгэл минь уй гашуу, гаслангаар дүүрч, ээжийнхээ талаар бодохгүй байж чадахгүй байв. Өдөр бүр ажлаа тараад гэртээ харих үедээ би ээжийнхээ зургийг харж, ээжтэйгээ ярьдаг байлаа. Нэгэн өдөр, “Би Эзэнд итгэгч бөгөөд ямар нэг бэрхшээл, сул дорой байдлыг туулах болгондоо эдгээр зүйлийг Эзэнд үргэлж хэлж болно” гэж гэнэт бодогдов. Үүний дараа би бэрхшээлтэй тулгарах бүрдээ Эзэний өмнө очин залбирч, намайг тайтгаруулахыг Эзэнээс гуйдаг байв. Гэхдээ би яаж ч залбирлаа гэсэн сэтгэл хөдөлсөнгүй. Заримдаа би залбирч байгаад унтчихдаг байв. Тухайн үед би өдөр бүр асар их түгшүүртэй байдалд амьдарч байсан болохоор ард минь сонсогдсон өчүүхэн төдий чимээ ч надад үгээр илэрхийлэхийн аргагүй айдас төрүүлдэг болсон юм. Ийнхүү айж, арга мухардсандаа би Эзэнд чин сэтгэлээсээ ийн залбирлаа: “Өө Эзэн минь! Миний зүрх сэтгэл харанхуйгаар дүүрч, би айсандаа дагжин чичирч байна. Би хаа нэгтээ алдаа гаргасан юм гэж үү? Өө Эзэн минь! Өнгөрсөн хэд хоногт хүмүүс надад Таныг Төгс Хүчит Бурхан болж эргэн ирсэн гэж хэлж байлаа. Өө Эзэн минь! Та үнэхээр эргэн ирсэн бөгөөд тэдний надад хэлсэн Төгс Хүчит Бурхан үнэхээр мөн бол Ян ахын над руу утасдах юм уу зурвас илгээх цагийг товлж, тохиромжтой орчин нөхцөлийг бэлдэж өгөөч гэж гуйя. Тэд буцаж ирээд юу ч гэж хэлсэн бай, би Таны шинэ ажил болон үгийг дуулгавартай, хүсэн хүлээсэн зүрх сэтгэлээр зөвшөөрнө. Энэ нь Таны ажил биш бөгөөд тэдний надад номлож байгаа зүйл худал, хуурмаг бол тэдний замыг хааж, дахин хэзээ ч бүү ирүүлээч.”

Гайхалтай нь, намайг ингэж залбирсны дараа Бурхан яг миний залбирсан зүйлийг биелүүлсэн юм. Ян ах над руу үнэхээр залгасан бөгөөд би түүнд өнгөрсөн хэд хоногт тохиолдсон бүхний талаар хэллээ. Намайг Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг голж, Түүний эсрэг тэрсэлсэн учраас зүрх сэтгэл минь харанхуйлсан гэж Ян ах хэллээ. Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг үргэлжлүүлэн судална гэж найдаж байгаа гэдгээ ах хэлсэн бөгөөд энэ удаад би түүний зөвлөгөөнөөс татгалзсангүй.

Удалгүй Ян ах надад сайн мэдээний кино илгээсэн юм. Энэ киноны “Бид Бурханд итгэдэг учраас хүмүүсийг биш, Бурханыг сонсох ёстой” гэх мөр намайг сэрээсэн юм. “Тийм шүү! Би Бурханд л итгэдэг бөгөөд Бурханы үгийг л сонсох ёстой! Гэхдээ Жинь ах, Чэн ах хоёр Бурханы эцсийн өдрүүдийн ажлын талаар надад хэлж байх үед би энэ тухай пастороос асуусаар байсан. Би пастор, номлогч хоёрын хэлснийг дагаж, Төгс Хүчит Бурханы шинэ ажлыг чин сэтгэлээсээ судлах юм уу Бурханы үгийг сонсохыг хүсээгүй. Би Эзэнд итгэдэг байсан ч Эзэнд залбирч, Эзэнээс эрж хайхын оронд пастор, номлогч хоёрын хэлсэн зүйлд сохроор итгэж байжээ. Би ямар тэнэг байгаа вэ! Библид ‘Бид хүнээс илүү Бурханд дуулгавартай байх ёстой’ (Үйлс 5:29). Би Эзэнд итгэсэн боловч Түүнийг дуулгавартай дагасангүй. Харин ч хүмүүсийг дуулгавартай дагасан учраас хүмүүст итгэж, хүмүүсийг дагадаг хүн болсон бус уу? Энэ чинь Эзэнийг эсэргүүцэж, Эзэнээс урваж

---

байгаа хэрэг биш үү? Төгс Хүчит Бурхан эргэн ирсэн Эзэн Есүс мөн байгаад би ийнхүү Түүний эсрэг тэрсэлж, эсэргүүцэн, Төгс Хүчит Бурханыг хүлээн зөвшөөрөхийг хүсээгүй юм бол харалган тэнэг байж ирсэн бус уу?” гэж бодогдлоо. Ингэж бодоод би зүрх сэтгэлдээ гүнээ гэмшиж, нүдэнд нулимс цийлгэнэлээ.

Би Эзэний өмнө дахин очиж, ийнхүү залбирав: “Эзэн Есүс Христ минь! Таныг аль хэдийн бие махбодтой болж эргэн ирсэн, Та бол эцсийн өдрүүдийн Христ, Төгс Хүчит Бурхан гэх сайн мэдээг нэг хүн номлолоо. Би үүнд бат итгэж зүрхлэхгүй нь байгаа ч Таны өмнө очиж эрж хайхад бэлэн байгаа бөгөөд Таны дуу хоолойг танихад намайг гэгээрүүлээч гэж Танаас гуйж байна. Хэрвээ Та үнэхээр эргэн ирсэн бөгөөд Төгс Хүчит Бурхан мөн бол би Танд гэмшиж, Таны ажил болон авралыг хүлээн зөвшөөрөхийг хүсэж байна. Намайг Өөрийнхөө өмнө аваачаач гэж Танаас гуйя.” Залбирсны дараа надад үгээр илэрхийлэхийн аргагүй баяр хөөр, тайтгарлын мэдрэмж төрлөө. Би удаан хугацаанд ийм зүйл мэдрээгүй бөгөөд Эзэн залбирлыг минь сонссон гэдгийг, Эзэн л намайг тайтгаруулж байгаа гэдгийг, мөн энэ нь Бурханы надад өгсөн нотолгоо гэдгийг мэдсэн юм. Би тэр даруй Төгс Хүчит Бурханы Чуулган руу явж, судлахыг хүссэн боловч Төгс Хүчит Бурханы Чуулганы ах эгч нарыг би гомдоосон байж таарна гэж бодсон тул тэдний чуулган руу явахаас ихэд ичиж байлаа.

Яг ийм ацан шалаанд байхад Ян ах завтай эсэхийг минь асуухаар залгасан бөгөөд намайг Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг үргэлжлүүлэн судалж чадна гэж найдаж байгаагаа хэлэв. Би түүнд болгоомжлолынхоо талаар хэллээ. Ян ах: “Зүгээр ээ, Бурханд итгэгч бид бол бүгд нэг гэр бүл, Төгс Хүчит Бурханы Чуулганы ах эгч нар үүнийг огтхон ч тоохгүй” гэлээ. Ян ахын ингэж хэлэхийг сонсоод Бурхан миний боловсроогүй биеийн хэмжээг ойлгож байгааг мэдсэн тул би дараа өдөр нь Ян ахтай цуг Төгс Хүчит Бурханы Чуулган руу явлаа.

Замаа олсныг минь хараад ах эгч нар баяртай байв. Эзэн Есүс эцсийн өдрүүдэд үнэнийг илэрхийлж, Бурханы гэрээс эхлэн шүүлтийн ажил хийхээр эргэн ирсэн гэдгийг тэд надад албан ёсоор гэрчиллээ. Түүнчлэн тэд надад бие махбодтой болсон Бурханы эцсийн өдрүүдийн ажлын утга учир болон бие махбодтой болох нь хүн төрөлхтнийг аврахад ач холбогдолтой талаар надад нөхөрлөлөө. Үүний дараа би Бурханы үгээс ингэж уншив: **“Би та нарт хэлье, тэмдгийн улмаас Бурханд итгэдэг хүмүүс бол гарцаагүй устгагдах ангилалд багтдаг. Махбодоор эргэн ирсэн Есүсийн үгийг хүлээн зөвшөөрөх чадваргүй хүмүүс бол гарцаагүй тамын үр удам, тэргүүн тэнгэрэлчийн үр хойч, мөнхийн сүйрэлд өртөх ангилал юм. Олон хүн Миний хэлсэн зүйлийг тоохгүй байж магад, гэвч Есүс тэнгэрээс цагаан үүлэн дээр бууж ирэхийг хоёр нүдээрээ харах үед**

---

чинь зөвт байдлын Нар олон нийтэд үзэгдэнэ гэдгийг Би Есүсийг дагадаг ариун хүмүүс гэгддэг хүн бүрд хэлэхийг хүсэж байна. Есүс тэнгэрээс буун ирж буйг нүдээр үзэх тэр үе чамд маш сэтгэл догдлом мөч байж болох ч энэ үе бас шийтгүүлэхээр там руу буух үе чинь гэдгийг мэдэх хэрэгтэй. Энэ нь Бурханы удирдлагын төлөвлөгөөний төгсгөлийн цаг үе байх бөгөөд Бурхан сайныг шагнаж, мууг шийтгэх үе байх болно. Учир нь, хүн тэмдгийг харахаас өмнө, үнэний илэрхийлэл л байх үед Бурханы шүүлт дууссан байх болно. Үнэнийг хүлээн авдаг, тэмдгийг эрж хайдаггүй хүмүүс ариусаж, Бурханы сэнтийн өмнө эргэн ирж, Бүтээгчийн тэвэрт орсон байх болно. ‘Цагаан үүл хөлөглөн ирээгүй Есүс бол хуурамч Христ’ хэмээн муйхарлан итгэдэг хүмүүс мөнхийн шийтгэл хүртэнэ, учир нь тэд тэмдэг үзүүлдэг Есүст л итгэдэг, харин хатуу шүүлт зарлан, амийн үнэн замыг гаргадаг Есүсийг хүлээн зөвшөөрдөггүй. Тэгэхээр Есүс цагаан үүлэн дээр ил тодоор эргэн ирэх үедээ л үүнийг шийдвэрлэх болно. Тэд хэтэрхий зөрүүд, өөртөө итгэлтэй, биеэ тоосон. Иймэрхүү өөдгүй хүмүүс яаж Есүсээр шагнуулж чадах билээ? Есүс эргэн ирнэ гэдэг нь үнэнийг хүлээн зөвшөөрөх чадвартай хүмүүсийн хувьд агуу аврал, тэгж чаддаггүй хүмүүсийн хувьд ялалтын тэмдэг юм. Та нар өөрсдийн замыг сонгох хэрэгтэй ба Ариун Сүнснийг доромжилж, үнэнийг голох ёсгүй. Та нар юм мэдэхгүй, биеэ тоосон хүн байх бус, харин Ариун Сүнсний удирдамжийг дуулгавартай дагаж, үнэнийг хүсэн хүлээж, эрж хайдаг хүн байх хэрэгтэй; ийм байдлаар л та нар ашиг тус хүртэх болно” (Үг нь махбодоор илэрсэн номын “Есүсийн сүнслэг биеийг харах үед чинь Бурхан тэнгэр, газрыг шинээр бүтээсэн байх болно”).

Бурханы үгийг уншсаныхаа дараа би ах эгч нарынхаа нөхөрлөж, гэрчилсэн үнэний талаар анхааралтай бодлоо. Эзэн эцсийн өдрүүдэд эргэн ирэх хоёр арга зам байдаг бөгөөд нэг нь нууцаар ирэх бол нөгөө нь бүгдэд ил тод харагдан ирэх явдал юм гэдгийг би ойлгов. Тэгвэл бие махбодтой болсон Төгс Хүчит Бурханы, Бурханы гэрээс эхэлдэг шүүлтийн ажил бол үнэхээр нууцаар ирсэн Эзэний ажил юм байна. Бие махбодтой болсон Бурхан хүн төрөлхтний дунд эргэн ирсэн учраас Түүний илрэлт нь эгэл хүнийх шиг бөгөөд Түүнийг хараад хэн ч Бурхан гэдгийг нь хэлж чадахгүй. Түүний жинхэнэ ялгамж чанарыг хэн ч мэддэггүй бөгөөд энэ нь хүмүүсээс нууцлагддаг. Бурханы дуу хоолойг ялган таньж чаддаг хүмүүс л Түүнийг мэдэж, хүлээн зөвшөөрч, дагана. Яг л Эзэн Есүсийн хэлсэнчлэн: **“Миний хонин сүрэг Миний дуу хоолойг сонсдог, Би тэднийг мэддэг бөгөөд тэд Намайг дагадаг”** (Иохан 10:27). Бурханы дуу хоолойг таньдаггүй хүмүүс бие махбодтой болсон Бурханыг эгэл хүн хэмээн авч үзэх нь гарцаагүй. Тэд тухайн үеийн Иудейн фарисайчуудын яг адилаар Бурханыг үгүйсгэж, эсэргүүцэх ба Бурханыг дагахаас татгалзана. Фарисайчууд Эзэн Есүсийг харсан боловч ялгамж чанарыг нь мэдэлгүй,



---

Эзэнийг сохроор ялласан билээ. Өнөө үе бол хүн төрөлхтнийг аврах Бурханы нууцлаг ажлын үе шат юм. Төгс Хүчит Бурхан хүмүүсийг шүүх, ариусгах, төгс болгохын тулд үг илэрхийлдэг. Гамшгаас өмнө Тэрээр бүлэг хүмүүсийг ялагч болгох бөгөөд энэ бүлэг ялагчийг бүрэн төгс болгомогц нууцаар ирсэн бие махбодтой болсон Бурханы ажил төгсгөл болно. Гамшиг эхлэх үед Бурхан сайныг шагнаж, мууг шийтгэн, бүх улс үндэстэн, ард түмэнд ил тод харагдана. Тэр үед Эзэн ил тод эргэн ирнэ гэх зөгнөлүүд яг л Библид ийн хэлсэнчлэн биелэх болно: **“Тэгээд хүний Хүүгийн тэмдэг тэнгэрт илрэн харагдана: газар дээрх бүх овог гашуудан уйлах ба тэд хүний Хүү тэнгэрийн үүлэн дээр хүч чадал, агуу алдартайгаар ирэхийг харах болно”** (Матай 24:30). **“Харагтун, Тэр үүлсийн хамт ирнэ; нүд бүр Түүнийг харна, Түүнийг жадалсан хүмүүс ч бас харна: газар дэлхийн бүх овог Түүнээс болж гашуудна”** (Илчлэл 1:7). Ийм учраас Эзэнийг үүлэн дээр бууж ирэх үед газар дэлхийн бүх овог цурхиран уйлна. Энэ үед зүрх сэтгэл минь гэнэтхэн цэлмэж, нууцаар ирсэн Эзэний ажил бол бидний хувьд агуу аврал мөн гэдгийг ойлгосон юм. Бид Эзэнийг нууцаар ирэх үед Бурханы үгийн шүүлтийг хүлээн зөвшөөрснөөр л цэвэрлэгдэж, Бурханы авралыг хүртэж чадна. Харин Бурханы шүүлтийн ажлыг одоо хүлээн зөвшөөрөхгүй бол Түүнийг үүлэн дээр ил тод ирэх үед бид Эзэнийг эсэргүүцсэн хүмүүс болох бөгөөд уйлж, шүдээ хавирах нь гарцаагүй. Тэр үед гэмшихэд хэтэрхий оройтсон байх болно, учир нь Төгс Хүчит Бурхан: **“Учир нь, хүн тэмдгийг харахаас өмнө, үнэний илэрхийлэл л байх үед Бурханы шүүлт дууссан байх болно.”**

Төгс Хүчит Бурханд талархъя! Бурханы үг бүх нууцыг тайлж, үнэнийг бүх талаар тодорхой болгодог—миний нүд нээгдэж, тэр үеэс хойш би зүрх сэтгэлээрээ, бас үгээрээ бүрэн үнэмшсэн. Дараагийн өдрүүдэд нь би ах эгч нартай хамт Бурханы эцсийн өдрүүдэд илэрхийлсэн үгийг уншихын тулд чуулганд тогтмол явсан билээ. Бид магтан дуу сонсож, Төгс Хүчит Бурханы Чуулганы ах эгч нарын хийсэн дууны клип, Бурханы үгийн уран уншлагын видео, сайн мэдээний кинонуудыг үзсэн юм. Цуглаан бүрээс би нэг шинэ зүйл олж авсан мэт санагдаж, зүйрлэшгүй аз жаргалтай байсан билээ. Ялангуяа сайн мэдээний кинонуудад ах эгч нар бүх асуултыг тун дэлгэрэнгүй, тодорхой нөхөрлөсөн болохоор маш олон жил Эзэнд итгэхэд минь төрсөн бүх эргэлзээ, будилаан бага багаар шийдвэрлэгдэв. Төгс Хүчит Бурханы Чуулганд Ариун Сүнсний ажил үнэхээр байгаа гэдгийг, Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүс мөн гэдгийг би харсан юм. Чуулганд явснаас хойш гурав дахь өдрөө би 2016 оны зул сараар тайзан дээр магтан дуу дуулсан эгчтэй уулзсан нь намайг бүр ч догдлуулсан билээ. Тэр эгч бас Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн зөвшөөрсөн байв. Би Бурханд үнэхээр талархаж байна, учир нь Бурханы удирдамж, гэгээрэл л биднийг Хурганы мөртэй хөл нийлүүлэхэд хүргэж, цөлөөс Канааны сайхан газарт хүрч, Бурханы гэрт эргэн ирэн, Бурханы амийн үгийн элбэг дэлбэг байдал,

---

хангалтыг Бурхантай хамт эдлэхэд биднийг хөтөлсөн билээ!

Бурханы онцгой сайхан сэтгэлийн ачаар л би Бурханы гэрт эргэн ирж чадсан гэж би боддог. Тэрслүү уг чанарыг минь харгалзан үзвэл Бурханы удирдлага, удирдамж, Бурханы үгийг надад нөхөрлөсөн ах эгч нарын тэвчээр байгаагүй бол би Эзэний эргэн ирэлтийг яаж угтан авч чадах билээ? Намайг гэх Бурханы хайр үнэхээр үгээр илэрхийлэхийн аргагүй агуу билээ! Би магтан дуугаар дамжуулан Бурханыг магтан дуулж, Төгс Хүчит Бурханыг тууштай дагахыг л хүсэж байна!

### **43. 5дугаар сарын 28-ны Жаоюанийн хэрэг гэр бүлийн хямрал учруулав**

Эньхуй, Хятад

Би жирийн л нэгэн хөдөөний эмэгтэй бөгөөд гэр орны ажлын хүнд ачаанд байнга дарагддаг байсан болохоор амсхийж бараг чаддаггүй байлаа. Үр дүнд нь би үнэхээр түргэн ууртай болсон бөгөөд нөхөр бид хоёр өдөр болгон маргалддаг байв. Бид тэр хэвээрээ үргэлжлүүлэн амьдарч ер болохгүй байлаа. Зовж шаналах бүрдээ би “Тэнгэр минь! Намайг авраач!” гэж хашгирдаг байсан юм. 2013 онд эцсийн өдрүүд дэх Төгс Хүчит Бурханы сайн мэдээ надад ирлээ. Ах, эгч нартай хамт Бурханы үгийг уншиж, цуглаануудад оролцсоноор би Төгс Хүчит Бурхан бол зовж шаналан байхдаа миний дууддаг байсан Нэгэн мөн гэдэгт итгэлтэй болсон тул эцсийн өдрүүд дэх Төгс Хүчит Бурханы ажлыг баяртайяа хүлээн авсан юм.

Би Бурханы эдгээр үгийг уншив: “Дэлхийг бүтээснээс хойш Би энэ бүлэг хүмүүсийг, тухайлбал, өнөөдрийн та нарыг урьдчилан тогтоож, сонгож эхэлсэн. Та нарын зан авир, хэв чанар, гадаад төрх, биеийн хэмжээ, та нарын төрсөн гэр бүл, ажил, гэрлэлт гээд чамайг бүхэлд чинь, үс болон арьсны чинь өнгийг, мөн чиний төрөх цаг, газрыг хүртэл бүгдийг нь Би гараараа зохицуулсан. Өдөр тутам чиний хийдэг зүйлс болон уулздаг хүмүүс хүртэл Миний гараар зохицуулагдсан ба өнөөдөр чамайг Өөрийнхөө дэргэд авчрах нь ч үнэн хэрэгтээ Миний зохицуулалт гэдгийг дурдаад ч хэрэггүй. Өөрийгөө эмх замбараагүй байдалд бүү оруул; чи тайван урагшлах хэрэгтэй” (“Үг нь махбодоор илэрсэн” номын Христийн эхэн үеийн айлдваруудын “74-р бүлэг”). Бүх зүйл Бурханы гарт байдаг бөгөөд Бурханы сэнтийн өмнө ирж, эцсийн өдрүүд дэх Бурханы ажлыг хүлээн авч, Түүний үгийн усалгаа, тэжээлийг олж авах сайн зол завшаантай байсан минь олон зуун жилийн өмнө Бурханаар урьдчилан тодорхойлогдсон гэдгийг би Бурханы үгээс эцэст нь ухаарсан юм. Ямар нөхөртэй, гэр

---

бүлтэй болохыг минь ч бас Бурхан урьдчилан тогтоосон. Бурханы учруулсан, зохицуулсан зүйлийг хүлээн авч, захирагдах ёстой гэдгээ би мэдэж байв. Тэр үеэс эхлээд надад тааламжгүй зүйл тохиолдох бүрд би урьдынх шигээ гомдоллохоо болив. Харин ч үүнийг Бурхан зохицуулсан гэдэгт итгэж, Түүгээр замчлуулан, гэр бүлийнхэнтэйгээ эв найрамдалтай амьдарч сурахын тулд Түүнд захирагдахыг хүсэж байлаа. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр би нөхөртэйгээ маргалдахаа больж чадсан юм. Бурханд итгэснээс хойш надад гарсан өөрчлөлтийг хараад нөхөр маань ч бас миний итгэлийг маш их дэмждэг болов. Ах, эгч нар цуглаан хийхээр манай гэрт ирэхэд тэдэнд маш эелдэг хандаж, заримдаа тэдэнтэй хууч хөөрдөг байлаа. Тэр үед би Бурханы үгийг өдөр бүр уншиж, цуглаануудад байнга оролцож, бусад ах, эгч нартай туршлагаа хуваалцаж байв. Сүнсээрээ баяжсан мэт санагдаж, урьд нь хэзээ ч мэдэрч байгаагүй амар амгалан, баяр хөөрийг эдэлсэн юм. Бурханд итгэх нь үнэхээр гайхалтай зүйл болохыг би мэдэрлээ!

Гэхдээ бүх сайн зүйл төгсөх ёстой болсон бөгөөд 2014 оны 05 дугаар сарын 28-нд Шаньдуны Жаоюуанийн хэрэг гарсны дараа манай гэрт тэдгээр эв эетэй, амар амгалан өдрүүд дахиад ирсэнгүй. Анхнаасаа энэ нь ердийн л нэг эрүүгийн хэрэг байсан боловч гурван өдрийн дараа өөр хэлбэртэй болж, Хятадын Коммунист Намын засгийн газар үүнийг шашны сэдлээр үйлдсэн зүйл гэж тодорхойлсон юм. Энэхүү шалтгаар ХКН-ын засгийн газар, Төгс Хүчит Бурханы Чуулганыг гол байгаа болгож, хуурамч нотолгоо дур зоргоороо нэмж, хуурамч хэрэг үүсгэж, Төгс Хүчит Бурханы Чуулганы нэр хүндийг гутаахын тулд хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглалаа. Тэр дороо Төгс Хүчит Бурханы Чуулганы талаар төсөөлж болох төрөл бүрийн цуу яриагаар хүмүүсийг булаав. Хэвлэлээр энэ тухай мэдээлснийг нөхөр минь олж хараад ХКН-ын засгийн газрын суртал ухуулгад хууртлаа. Нөхөр минь агшин зуур өөрчлөгдөх мэт болсон юм. Тэгээд Төгс Хүчит Бурханд итгэх итгэлийн маань эсрэг чадах бүхнээ хийж эхлэв.

Нэг орой нөхөр маань уурандаа шатсан хүн гэртээ ирээд: “Чиний итгэдэг энэ шашин чинь яг үнэндээ юу юм бэ?” гэж над руу чангаар хашхичив. Түүний энэ хачин жигтэй хандлагатай нүүр тулаад би бүрмөсөн мэгдэн сандарч, “Миний итгэдэг зүйл бол бидний ‘Тэнгэр’ гэж хэлдэг байсан, эргэн ирсэн Эзэн Есүс, Төгс Хүчит Бурхан” гэж би хариуллаа. Нөхөр минь: “Чи Төгс Хүчит Бурханд итгэдэг! Зурагтаар тэд юу ярьж байгааг хар даа!” гэв. Ингэж хэлээд зурагт асаасан ба яг тэр үед Шаньдуны Жаоюуань дахь 5 дугаар сарын 28-ны аллагын хэргийн талаар дамжуулж байлаа. Тэд Төгс Хүчит Бурханы Чуулганыг ялласан элдэв төрлийн зүйлийг ярьж, Төгс Хүчит Бурханд итгэгчид нь олон нийтийн дэг журмыг алдагдуулдаг хүмүүс бөгөөд Шаньдун дахь Олон Нийтийг Аюулаас Хамгаалах Товчоо хүчтэй сөрөг дайралт хийж, ямар ч өршөөл үзүүлэлгүй баривчлахаар төлөвлөж байгаа тухай үргэлжлүүлэн яриу. Үүнийг хараад би зөв шударга эгдүүцлээр дүүрч, тэр

---

даруй нөхөртөө ингэж хэллээ: “Энэ нь гүтгэлэг, цуу ярианаас цаашгүй. Энэ алуурчин яавч Төгс Хүчит Бурханд итгэгч биш! Төгс Хүчит Бурханы Чуулганд сайн мэдээг түгээхдээ Бурханд итгэдэг сайхан сэтгэлтэй сайн хүмүүст л түгээнэ гэсэн сайн мэдээний зарчим байдаг. Бид сайн мэдээг хорон муу хүмүүст хэзээ ч түгээдэггүй. Жан Лидон шиг муу хүмүүс Төгс Хүчит Бурханы Чуулганы сайн мэдээ түгээх зарчимд огтхон ч нийцэхгүй байгаа тул тэд Төгс Хүчит Бурханд итгэгч байж яавч чадахгүй нь гарцаагүй. Өөр нэг зүйл гэвэл, Жан Лидон тэр эмэгтэйгээс утасны дугаарыг нь асуугаад хэлэхээс татгалзах үед доромжлуулсандаа болоод Жан уурлан хилэгнэж, аллага үйлдсэн. Төгс Хүчит Бурханы Чуулганы ах, эгч нар бид сайн мэдээ түгээхдээ Төгс Хүчит Бурханы ажлыг хүлээн зөвшөөрүүлэх гэж хүмүүсийг хэзээ ч албаддаггүй, учир нь **‘Хаанчлалын эрин үед Бурханы сонгосон хүмүүсийн дуулгавартай дагах ёстой захиргааны арван зарлиг’** —д Бурхан ингэж хэлсэн: **‘Чи итгэл үнэмшилгүй төрөл төрөгсдөө (үр хүүхэд, хань ижил, эгч дүүс, эцэг эх гэх мэт) хүчээр чуулганд оруулах ёсгүй. Бурханы гэр гишүүдээр дутахгүй бөгөөд ашиггүй хүмүүсээр орон тоо дүүргэх хэрэг үгүй. Дуртайяа итгэдэггүй бүх хүнийг чуулган руу хөтлөх ёсгүй. Энэ зарлиг бүх хүнд хамаатай. Энэ талаар та нар бие биеэ хянаж, шалгаж, нэг нэгэндээ сануулж байх ёстой бөгөөд хэн ч үүнийг зөрчиж болохгүй.’** Төгс Хүчит Бурханы Чуулганы ах, эгч нар сайн мэдээ түгээхдээ хүмүүст хэзээ ч хүчээр тулгадаггүй—энэ бол хэний ч зөрчиж болохгүй зүйл юм. Энэ мэдээ бол гүжир гүтгэлэг, зохиомол зүйл байна. Энэ нь ХКН-ын засгийн газар цуу яриа тарааж, Төгс Хүчит Бурханы Чуулганы нэр хүндийг гутааж байгаагаас цаашгүй.” Гэвч үүнийг сонсоод нөхөр маань нүдээ бүлтийлгэн: “Үнэн эсэх нь хамаагүй. ХКН л эсэргүүцэж байгаа цагт чи үүнд итгэж болохгүй! Засгийн газраас манайд ирээд нэгжлэг хийгээсэй гэж би хүсэхгүй байна. Хүү маань гэрлээ ч үгүй байна!” гэж над руу орилно гэдгийг хэн мэдэх билээ? Зурагтаар гарсан, оргүй хоосноос үүдсэн тэр бүх цуу яриа, худал хуурмагт нөхөр маань хууртсаныг хараад миний зүрх сэтгэл үзэн ядалтаар дүүрэв: ХКН-ын засгийн газар шашны итгэл үнэмшлийг нухчин дарах гэсэндээ Төгс Хүчит Бурханы Чуулганыг хэлмэгдүүлж, хавчихын тулд яахаас ч буцахгүй. Тэд Төгс Хүчит Бурханы Чуулганыг зохиомлоор буруутгаж, хуурамч ял тулгахын тулд Жаоюуанийн хэргийг ашиглаж байна—ямар өөдгүй муу арга мэх вэ!

Түүний дараа нөхөр бид хоёр хэн хэн нь сайхан унтаж чадсангүй. ХКН-ын цагдаа нар манай гэрт нэгжлэг хийх тохиолдолд намайг нуугдаж, Бурханы үгийн номыг сайтар нуух юм уу чуулгандаа буцааж өг хэмээн нөхөр минь шавдууллаа. Нөхрийнхөө ингэж хэлэхийг сонсоод баривчлагдаж, гэр орноо нэгжүүлж, торгуулж, шоронд хоригдож байсан ах, эгч нарын туршлагын талаар сонсож байсан минь санаанд орлоо; бас үеэлийнхээ талаар бодлоо. Үеэл маань, энгийн иргэдэд пээдгэр зан гаргаж, дээрэлхэж байгааг нь тэвчиж

---

чадаагүй учраас орон нутгийн цагдаагийн хэсгийн даргатай маргалдан, нэг жилийн хугацаатай хөдөлмөрөөр засан хүмүүжүүлэх газарт ял эдлэх болсон юм. Гэрийнхэн маань бүгдээрээ хөгшин, залуугүй зовж шаналсан. ХКН бол учир зүйгээ ололцохын аргагүй чөтгөр. Хэрвээ би итгэлээсээ болж баривчлагдан, шоронд орвол, манай гэрийг нэгжвэл энэ нь нөхөр хүүхдийн минь хувьд шударга байна гэж үү? ХКН-ын цагдаа нар намайг баривчилж, гэр орныг маань нэгжиж, нөхөр хүүхэд минь орооцолдож байгаа дүр зургийг би ахин дахин төсөөлж, унтаж чадалгүй эргэн хөрвөж байлаа... Би зүрх сэтгэлдээ цөхрөл, айдсын давлагааг мэдрэхгүй байж чадсангүй. Хятадад Бурханд итгэж, сайн хүн байж, зөв замыг дагах нь хэчнээн хэцүү болохыг, мөн миний амьдрал байнгын аюулд байгааг би мэдэрч байв. Гэвч хэрвээ би ХКН-ын засгийн газрын хавчлагаас айсандаа Бурханаас урвасан бол үлдсэн амьдралын минь туршид мөс чанар минь намайг яллах байлаа. Би урсгал даган, зорилгогүй амьдарсан ч гэсэн үндсэндээ би амьд үхдэл л байх байсан ба үхсэнийхээ дараа Бурханыг дахин харах нүүргүй болох байв. Би зүрх сэтгэлдээ зовниж, шаналж байсан ба ямар ч хүч чадалгүй, ер бусын сөрөг, сул дорой санагдаж байсан юм.

Зовлонгийн дунд байхдаа би Эзэн Есүсийн эдгээр үгийг санав: **“Биеийг хөнөөх боловч сүнсийг хөнөөж үл чадах хүмүүсээс бүү ай: харин бие болоод сүнс хоёуланг нь тамд устгаж чадах Түүнээс ай”** (Матай 10:28). **“Учир нь өөрийн амийг аварсан хүн үүнийгээ алдах болно: харин Миний төлөө амиа алдсан хүн үүнийгээ олох болно”** (Матай 16:25). Эзэн Есүсийн үг надад итгэл, хүч чадал өгч, зүрх сэтгэлээс маань санаа зовнил, айдсыг үлдэн хөөлөө. “Бурхан бүх зүйлийг болон амьд амьтдыг захирдаг бөгөөд миний амьдрал, гэр бүл ч бас Бурханы хяналтад байдаг. Надад байгаа бүх зүйл Бурханаас ирсэн, энэ чухал цаг үед би Бурханаас урваж болохгүй” гэж би бодсон юм. Тэгээд би Иовын гэр бүлийн эзэмшлийг тонон дээрэмдэж, хүүхдүүдийг нь булаан авсан тухай бодлоо; Иовд юу ч үлдээгүй боловч тэр Бурханд үнэнч байдлаа хадгалан үлдэж чадсан юм. Тэрээр Ехова Бурханы ариун нэрийг магтаж, Бурханы гэрчлэлд зогссон. Харин би ХКН-ын засгийн газрын зохиосон цуу яриа болон үймээнээс цаашгүй зүйлтэй нүүр тулаад, баривчлагдаж, гэр орноо нэгжүүлээгүй байхдаа л сул дорой, сөрөг болсон байв. Миний биеийн хэмжээ үнэн хэрэгтээ өрөвдмөөр жаахан гэдгийг, бас надад Бурханд итгэх жинхэнэ итгэл өчүүхэн ч байхгүй гэдгийг би харлаа. Энэ тухай бодоод зүрх сэтгэл маань Бурханы өмнө ичгүүрээр дүүрч, би чимээгүйхэн ингэж шийдэв: Юу ч болж байсан би Бурханаас урвах ёсгүй, хэчнээн их зовлон, бэрхшээлтэй тулгарах байсан ч хамаагүй би итгэлээ хадгална!

Дараа өдрийнх нь үд дунд нөхөр маань гэртээ буцаж ирээд гартаа барьсан сонингоо миний өмнө шидээд, “Сайн хар! Төгс Хүчит Бурханд итгэдгийг нь олж илрүүлэх л юм бол хэнийг ч баривчилна гэж энд бичсэн байна. Шорон бол цагаа өнгөрүүлэхийг хүсэх газар

---

огтхон ч биш. Хүмүүс зодуулаад зогсохгүй, хэдэн арваараа хамт ганц вандан орон дээр чихэлдэнэ. Хэн нэг нь шөнө дунд бие засахаар явбал буцаад ирэхэд нь унтах газар байхгүй болчихсон байна. Хэрвээ чи баривчлагдвал батлан даалтаар гаргаж авах мөнгө манай гэр бүлд байхгүй. Иймээс хэрвээ чамайг баривчилж, хэдэн жилийн ял өгвөл чи буулт хийхээс өөр аргагүй болно!” гэж хэлэв. Нөхрөөсөө ийм хүйтэн хөндий үг сонсоод би гүнээ шаналж, чөтгөрийн ХКН-ын засгийг газрыг бүр ч их үзэн ядлаа. Тэдний мэхлэлт, цуу яриа, дарангуйлал, хавчлага байгаагүй бол миний нөхөр итгэлийг минь дэмжих байв. Тэр намайг тийм маягаар яавч дарамтлахгүй байх байлаа. Арга мухардсандаа би өөрийн эрхгүй зүрх сэтгэлдээ Бурханаас ийн гуйв: “Төгс Хүчит Бурхан минь! ХКН-ын засгийн газар ердөө л Таны эсрэг цуу яриа, хов жив, гүтгэлэг, доромжлол тарааж байгааг би мэднэ. ХКН-ын засгийн газар бол Таны дайсан болох Сатанаас өөр юу ч биш. Гэвч одоо зүрх сэтгэлд минь бага зэрэг сул дорой санагдаж байна, намайг хамгаалж, мэргэн ухаан өгч, Сатаны арга заль, ов мэхийг нэвт харах боломж олгооч гэж би Танаас гуйя, тэгснээр би Таны талд бат зогсож, ХКН-ын засгийн газрын муу ёрын хүчнээс айн сүрдэхгүй байж чадна.” Залбирсны дараа зүрх сэтгэлд маань Бурханаас зайлах хүсэл огт байхгүй байсан бөгөөд Төгс Хүчит Бурханы эдгээр үг санаанд орлоо: **“Лазарыг үхлээс буцаан авчрах зэрэг зүйлийг Эзэн Есүс хийхэд Түүний зорилго нь хүн болон Сатанд нотолгоо харуулах, мөн хүн төрөлхтний бүх зүйлийг, хүн төрөлхтний амьдрал, үхлийг Бурхан шийддэг ба Тэр хэдийгээр бие махбодтой болсон ч гэсэн урьдын адилаар харж болох бодит ертөнц, түүнчлэн хүний харж чадахгүй сүнсний ертөнцийг захирсан хэвээр байгаа гэдгийг хүмүүс болон Сатанд мэдэгдэх явдал байсан юм. Үүгээрээ хүн төрөлхтний бүх зүйл Сатаны тушаал дор байдаггүй гэдгийг хүмүүст болон Сатанд харуулах гэсэн. Энэ нь Бурханы эрх мэдлийг илчилж, харуулсан хэрэг байсан ба энэ нь мөн хүн төрөлхтний амьдрал, үхэл Бурханы гарт байдаг гэсэн үгийг бүх зүйлд илгээх Бурханы арга байсан юм. Эзэн Есүс Лазарыг амилуулсан—ийм арга барил нь хүн төрөлхтөнд зааж, зааварлах Бүтээгчийн аргуудын нэг байлаа. Энэ нь хүн төрөлхтөнд зааварлаж, хүмүүсийг хангахын тулд Өөрийн чадвар, эрх мэдлийг ашигласан бодит үйлдэл байсан юм. Энэ нь Тэр бүх зүйлийг удирддаг хэмээх үнэнийг харах боломжийг хүн төрөлхтөнд олгох Бүтээгчийн үггүй арга байв. Мөн Түүгээр дамжихгүйгээр ямар ч аврал байхгүй гэдгийг хүн төрөлхтөнд бодит үйлдлээр хэлэх Түүний арга зам байлаа. Хүн төрөлхтөнд Түүний зааварчлах ийм төрлийн чимээгүй арга барил нь үүрд үргэлжилдэг—энэ нь арилшгүй бөгөөд хүмүүсийн зүрх сэтгэлд цочрол болон хэзээ ч гандан буурахгүй гэгээрлийг авчирсан юм. Лазар амилсан явдал Бурханыг алдаршуулсан—энэ нь Бурханы дагалдагч нэг бүрд гүн нөлөө үзүүлсэн. Энэ нь уг үйл явдлыг гүнээ ойлгодог хүн бүрд гагцхүү Бурхан л хүн төрөлхтний амьдрал, үхлийг тушааж чадна гэсэн ойлголт, үзэгдлийг бат суулгасан”**

---

(Үг нь махбодоор илэрсэн номын “Бурханы ажил, Бурханы зан чанар ба Бурхан Өөрөө III”). Бурхан Лазарт үхлээс амилах боломж олгосон тухай баримт намайг маш их зоригжуулав. Би зүрх сэтгэлдээ дахин нэгэнтээ хүчтэй болж, тууштайгаар дахиад өндийн бослоо: Тийм ээ! Орчлон ертөнц дээрх бүх зүйлийг Бурхан хянадаг бөгөөд хүмүүсийн амьдрал, үхэл бүгд Бурханы гарт байдаг. Нэг ч хүн үүнийг хянаж чадахгүй, баривчлагдах эсэх минь ч бас л Бурханы гарт байгаа гэдгийг би мэдэв. Бурханы үг намайг дахин нэгэнтээ хамгаалж, зүрх сэтгэл доторх Бурханд итгэх итгэл маань дахиад нэг удаа нэмэгдлээ. Сэтгэл дэх сандрал болон айдас ч бас нэлээд их намжив.

ХКН-ын засгийн газрын цуу яриа гэр оронд маань нэгэнтээ байсан амар тайван, аз жаргалыг нураасан юм. Гэртээ цаашдын ямар нэгэн үймээнээс зайлсхийхийн тулд би цуглаанд оролцох, үүргээ биелүүлэхдээ тун хянуур, тун болгомжтой байх хэрэгтэй болов; миний хувьд энэ нь үнэхээр тэвчишгүй байлаа. Хожим нь аав маань 5 дугаар сарын 28-ны өдрийн Жаоюуанийн хэргийг сонсоод бас л замд минь хөндөлсөж эхэлсэн юм. Тэрээр: “Хүссэн бүхэндээ итгэж болно, гэхдээ чи дахиад гадагш гарч сайн мэдээ түгээхгүй, эсвэл цуглаанд оролцохоор явахгүй шүү. Ийм хөгшин насандаа би ямар ч бэрхшээлийг дааж чадахгүй. Чи гэр бүлийнхнээ хөгшин, залуу гэлтгүй бүгдийг нь бодох хэрэгтэй! Бурханд итгэх нь сайн хэрэг, гэвч чи итгэх эрх чөлөөтэй оронд төрөөгүй. Сул дорой нэгэн хүчтэнтэй тэмцэж чадахгүй бөгөөд ‘хүчтэн’ болох ХКН итгэлтэй хүмүүст улс төрийн хоригдол адил ханддаг. Чи энэ бүхнийг мэднэ, иймээс өөрийнхөө мэдэрдэг айдсыг бидэнд мэдрүүлэх хэрэггүй” гэж хэллээ. Манай гэр бүлийнхний дарамт, тэдний дутуу дулимаг ойлголт намайг үнэхээр тарчлааж байв. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр, байнга дээсэн дөрөөн дээр дэнжигнэж байгаа мэт санагдаж, өчүүхэн төдий л алдаа гаргах юм бол ХКН-ын засгийн газарт баривчлагдаж, гэр бүлийнхэндээ төвөг удах вий гэсэн айдастай амьдарч байлаа. Тэгээд би гарах тоолондоо Бурханы үгийн номууд болон Бурханд итгэхтэй холбоотой аливаа зүйлийг болгоомжтой нуудаг байв. Цуглаанд оролцохоор явахдаа намайг хэн нэг нь мэдээлээд, гэр бүлийнхнээ чирчих вий гэж асар их айдаг байсан тул би байнгын өндөр сэрэмжтэй, хянуур байдаг байв; цагдаагийн машин, эсвэл офицер харах тоолонд зүрх амаар гарах шахдаг байлаа. Энэ нь үгээр илэрхийлэх аргагүй зовлон байсан бөгөөд Хятадад Бурханд итгэх нь хутганы ирэн дээр амьдрахтай адил гэж санагдаж байсан юм. Би өөрийн эрхгүй энэ ёрын муу бурхангүй үзэлт намыг бүр ч их үзэн ядлаа: Итгэл бишрэлтэй байж, зөв замыг дагахад юу нь муу байгаа юм бэ? Тэд яагаад хүмүүст Бурханд итгэхийг зөвшөөрдөггүй юм бэ? Яагаад тэд итгэлтэй хүмүүсийг улайран дарангуйлж, баривчилж, хяхаж хавчдаг юм бэ? Хүмүүс Бурханд итгэхийг тэд яагаад ийм их үзэн яддаг юм бэ? Тэд үнэхээр ёрын муу юм!

Хожим нь би Төгс Хүчит Бурханы үгийг уншаад хэрэг явдлын үнэн мөнийг эцэст нь

---

ойлгож авсан билээ. Бурханы үгэнд хэлсэнчлэн: **“Бурхан Өөрийн ажлыг хийж, Бурхан нэг хүнийг халамжилж, энэ хүнээ харж ханддаг ба тэр зуур Сатан Түүний алхам бүрийг тувт салахгүй мөрддөг. Бурхан хэнийг л ивээнэ Сатан араас нь мөшгөж, мөн л ажигладаг. Хэрвээ Бурхан энэ хүнийг хүсвэл, Сатан Бурханд саад болохын тулд Бурханы хийдэг ажлыг уруу татаж, үймүүлж, сүйрүүлэхээр янз бүрийн хорон муу заль мэх ашиглан далд зорилгодоо хүрэхийн төлөө чадах бүхнээ хийнэ. Энэ зорилго нь юу вэ? Бурхан хэнийг ч олж авахыг тэр хүсдэггүй; Бурханы хүсдэг бүх хүнийг тэр өөртөө авахыг хүсдэг, тэднийг эзэмдэж, хянаж, удирдахыг хүсдэг ба ингэснээр тэд түүнийг шүтэж, муу үйл үйлдэхэд нь түүнтэй нэгдэх юм. Энэ нь Сатаны хорлонтой сэдэл биш гэж үү?... Энэ хэрэг нь Сатаны зэвүүн царай зүс болон мөн чанарыг тун тодорхой болгосон. Бурхантай дайсагнаж, Түүний араас мөшгөхдөө Сатаны зорилго бол Бурханы хийхийг хүсдэг бүх ажлыг нурааж, Бурханы олж авахыг хүсдэг хүмүүсийг эзэмдэж, хянах, Бурханы олж авахыг хүсдэг хүмүүсийг бүрмөсөн устгах явдал юм. Хэрвээ тэднийг устгахгүй бол тэд Сатаны эзэмшилд орж, түүгээр ашиглуулдаг—энэ бол түүний зорилго”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Цор ганц Бурхан Өөрөө IV”). Бурханы үгээр дамжуулан би гэнэт ингэж ухаарлаа: Гаднаас нь харахад, ХКН-ын засгийн газар итгэгчид биднийг дарангуйлж байгаа мэт байсан боловч үүний ард сүнслэг тулаан явагдаж байжээ; энэ нь Сатан хүмүүсийг авахын төлөө Бурхантай тэмцэлдэж байгаа хэрэг байв. Сатан бол Бурханы заналт дайсан, бас Бурханаас урваж, Бурханыг эсэргүүцдэг чөтгөр учраас хүн төрөлхтнийг ялзруулсан цагаасаа эхлэн тэднийг хянахыг хүссэн; бас Бурханыг шүтэн мөргөхийг хүмүүст зөвшөөрдөггүй, эсвэл Бурханы бүтээсэн хүн төрөлхтнийг авах боломжийг Бурханд олгодоггүй. Тиймээс хүн төрөлхтнийг аврах Бурханы ажлын эхлэлээс хойш өнөөдрийг хүртэлх бүхий л хугацаанд Сатан үймээн үүсгэж, Бурханы ажлыг нураахын тулд чадах бүхнээ хийсэн. Хүмүүсийн Бурхан руу эргэх замд хөндөлсөхийн тулд Сатан төрөл бүрийн жигшүүрт арга барил ашигладаг. Миний итгэлд саад учруулахын тулд Сатан, гэр бүлийн минь дотор зөрчилдөөн үүсгэхээр цуу яриа ашиглаж байгааг би мэдэж байв. Намайг айлгах, уруу татах, сүрдүүлэх, дайрч давшлахын тулд Сатан гэр бүлийнхнээ гэсэн мэдрэмжийг минь ашиглаж, сэтгэл зүйн дайны тактик хэрэглэж байлаа. Энэ бүхнийг хийх Сатаны зорилго бол Бурханаас зай барьж, Бурханыг үгүйсгэж, Түүнээс урвахад намайг хүргэх, намайг атгандаа байлган, боолоо болгох, улмаар эцэст нь намайг өөртэйгээ хамт Бурханаар устгуулах явдал байв. ХКН-ын засгийн газрын санаа зорилго нь үнэхээр хорлонтой бөгөөд тэд бол Бурханыг улайран эсэргүүцдэг Бурханы дайсан юм. Тэд бол үнэхээр хүмүүсийн сүнсийг залгидаг чөтгөр мөн. Яг л Бурханы үгэнд хэлсэнчлэн: **“Сатан хүмүүсийг мэхлэх замаар нэр хүнд олж авдгийн дээр үргэлж өөрийгөө зөв шударга байдлын манлайлагч, үлгэр дуурайл болгодог. Зөв шударга байдлыг хамгаалах нэрийдлээр**



---

хүмүүст хор учруулж, сүнснийг нь залгиж, хүнийг хөшүүн болгож, хууран мэхэлж, турхирахын тулд бүхий л төрлийн арга барил ашигладаг. Түүний зорилго нь, ёрын муу үйл хэргийг нь хүн хүлээн зөвшөөрч, дагадаг болгож, Бурханы эрх мэдэл, дээд эрхийг эсэргүүцэхэд хүнийг өөртөө нэгтгэх явдал юм. Гэвч, хүн түүний явуулга, хуйвалдаан, өөдгүй төрхийг мэддэг болж, түүнд гишгэчүүлж, хууртаж, үргэлжлүүлэн түүнд боолчлогдож, түүнтэй хамт шийтгүүлж, сүйрэхийг хүсэхгүй байх үед Сатан урьдын ариун гэгээн төрхөө өөрчилж, хуурамч багаа хуулан ёрын муу, харгис догшин, муухай, хэрцгий жинхэнэ нүүр царайгаа илчилдэг. Тэр өөрийг нь дагахаас татгалзаж, өөрийнх нь муу ёрын хүчийг эсэргүүцдэг бүх хүнийг үгүй хийхэд юунаас ч илүү дуртай” (Үг нь махбодоор илэрсэн номын “Цор ганц Бурхан Өөрөө II”). Бурханы үгэн дэх илчлэлүүд надад ХКН-ын засгийн газрын үнэн нүүр царайг нэвт харж, энэ нь үнэхээр Сатаны биелэл мөн болохыг, энэ нь Бурханыг эсэргүүцдэг хамгийн муу сатанлаг дэглэм мөн гэдгийг харах боломж олгосон юм. Тэд хүмүүсийг хууран мэхэлж, өдөөн хатгаж, хэрэг явдлын үнэн мөнийг ойлгодоггүй хүмүүсийг өөрийн талд зогсоож, хамт Бурханыг эсэргүүцэх гэж оролдон цуу яриа зохиож, Төгс Хүчит Бурханы Чуулганыг зохиомлоор буруутгахын тулд 5 дугаар сарын 28-ны Жаоюуанийн хэргийг ашиглаж байлаа. Жаоюуанийн хэргийг зохиож, бурууг Төгс Хүчит Бурханы Чуулганд тохих ХКН-ын засгийн газрын зорилго нь Христэд итгэгчдийг баривчилж, хяхан хавчих шалтгаан, шалтаг хайхын төлөө байв. Энэ нь Христэд итгэгчдийг бүгдийг нь нэг дор баривчилж, уг үндсээр нь устгах, улмаар Төгс Хүчит Бурханы Чуулганыг бүрмөсөн арчин хаях хий дэмий оролдлого байсан юм. Тэд Хятадад бурхангүй үзэлт бүс байгуулах зэрлэг санаархлаа хэрэгжүүлэхийг ч хүсдэг. ХКН-ын засгийн газрын мөн чанар бол үнэхээр туйлын тэрслүү агаад ёрын муу юм!

Сүнслэг дайны бодит байдал болон ХКН-ын засгийн газрын ёрын муу мөн чанарыг ухаармагц өөр нэг асуулт санаанд орлоо: Бурхан бүхнийг чадагч биш гэж үү? Бурхан яагаад ХКН-ын засгийн газарт биднийг хяхан хавчихыг зөвшөөрдөг юм бэ? Би өөрийн доторх энэхүү эргэлзээг тайлж чадалгүй Төгс Хүчит Бурханы эдгээр үгийг уншлаа: “Миний мэргэн ухаан Сатаны арга мэхэнд үндэслэн хэрэгждэг гэдгийг Би нэгэнтээ хэлсэн. Яагаад Би тэгж хэлсэн бэ? Миний яг одоо хэлж, хийж байгаа зүйлийн ар дахь үнэн энэ биш гэж үү?” (Үг нь махбодоор илэрсэн номын “Байлдан дагуулалтын ажлын дотоод үнэн (1)”). “Бурхан хүн төрөлхтний нэг хэсгийг төгс болгохын тулд муу ёрын сүнсний ажлын нэг хэсгийг ашиглахаар зорьдог, ингэснээр энэ хүмүүс диаволуудын үйл хэргийг нэвт шувт бүрэн харж, бүх хүн төрөлхтөнд ‘өвөг дээдсээ’ үнэхээр мэдэх боломжийг олгодог. Зөвхөн энэ аргаар хүмүүс бүрэн чөлөөлөгдөж, диаволуудын үр садыг байтугай өвөг дээдсийг нь ч хаядаг. Энэ нь агуу улаан лууг бүрэн ялах

---

**Бурханы жинхэнэ зорилго бөгөөд ингэснээр бүх хүн агуу улаан лууны жинхэнэ төрхийг мэдэж, үүний багийг бүрмөсөн хуулан хаяж, жинхэнэ төрхийг нь харах юм. Энэ нь Бурханы хүрэхийг хүсэж байгаа зүйл, энэ нь Түүний газар дээр хийсэн бүх ажлын эцсийн зорилго бөгөөд бүх хүн төрөлхтөнд хэрэгжүүлэхийг зорьсон зүйл юм. Үүнийг Бурханы зорилгын төлөө бүх зүйлийг дайчлах гэж нэрлэдэг”** (“Үг нь махбодоор илэрсэн” номын Бүх орчлон ертөнцөд хандсан Бурханы айлдваруудын нууцын тухай тайлбарын “41-р бүлэг”). Өөрийн сонгосон хүмүүсийг төгс болгоход үйлчлэл хийлгэхийн тулд Бурхан ХКН-ын засгийн газрын ёрын муу сатанлаг хүчний дарангуйллыг ашиглаж байна гэдгийг би Бурханы үгээс ойлгов. Төгс Хүчит Бурханы Чуулганы нэр хүндийг сэвтээх гэсэн ХКН-ын засгийн газрын эсэргүүцэл, яллалт, цуу яриа тараалт болон Христэд итгэгчдэд хандах дарангуйлал, баривчилгаагаар дамжуулан Бурханд бидэнд, үнэн болон Бурханыг үзэн яддаг ХКН-ын засгийн газрын сатанлаг, чөтгөрлөг мөн чанарыг харах боломжийг олгодог. Энэ нь бидэнд түүнийг үнэхээр ялган таньж, түүнийг голж, түүнд хэзээ ч хууртахгүй байх боломж олгосон. Харин ч бид Сатаны эзэмшлээс гарч, Бурханы өмнө эргэн ирж чаддаг. Үүний зэрэгцээ, Бурхан ХКН-ын чөтгөрүүдийн баривчилгаа, хавчлагыг ашиглан бүх хүнийг илчилж, төрлийнх нь дагуу ангилдаг. Хулчгар, хуурамч итгэлтэй, Иудастай адил хүмүүс ХКН-ын засгийн газрын харгис хавчлагаар дамжуулан илчлэгдэж, таягдан хаягддаг. Харин Бурханд үнэхээр итгэж, үнэнийг эрэлхийлдэг, Бурханд үнэнч хүмүүс ХКН-ын засгийн газрын улайрсан хавчлага дор Бурханы төлөө гэрчлэлд зогсож, Бурханаар ялагчид болгуулдаг. Энэ бүхнийг ойлгомогц миний буруу ойлголт, гомдол, Бурханы талаарх эргэлзээ бүгд шийдвэрлэгдэв. Түүнчлэн, Бурхан үнэхээр ухаалаг, төгс хүчит болохыг, Бурханы мэргэн ухаан үнэхээр Сатаны арга зальд суурилан хэрэгждэг болохыг би харсан юм.

Би бас Бурханы эдгээр үгийг уншив: **“Ямар ч орон, ямар ч хүч Бурханы биелүүлэхээр хүссэн зүйлийн замд саад болж чадахгүй гэдэгт бид итгэдэг. Бурханы ажилд саад хийдэг, Бурханы үгийг эсэргүүцдэг, Бурханы төлөвлөгөөг үймүүлж, сүйтгэдэг хүмүүс эцэстээ Бурханаар шийтгүүлнэ. Бурханы ажлыг эсэргүүцдэг хүн там руу илгээгдэнэ; Бурханы ажлыг сөрдөг ямар ч улс устгагдана; Бурханы ажлыг эсэргүүцэхээр бослого гаргадаг ямар ч үндэстэн газрын хөрснөөс арчигдаж, оршин тогтнохоо болино”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Бүх хүн төрөлхтний хувь заяаг Бурхан захирдаг”). Бурханы үг надад Түүний зөвт, сүр жавхлант зан чанарыг харуулсан бөгөөд Бурханы төгс хүчин, эрх мэдлийг ямар ч хүч даван гарч чадахгүйг би харсан юм. Хэдийгээр ХКН-ын засгийн газар Бурханыг байнга улайран эсэргүүцэж, Бурханы сонгосон хүмүүсийг дарангуйлж, баривчилж, хяхан хавчиж, хүмүүсийг төөрөлдүүлэн, Бурхан руу буцаж очиход нь саад учруулахын тулд бүх төрлийн цуу яриаг зохиодог ч

---

Бурханы ажил бүх Хятад даяар тархсан хэвээр байна. Түүнчлэн, Хятадад бүлэг ялагч бий болж, Бурханы хаанчлалын сайн мэдээ одоогоор бүх дэлхий даяар түгэн өргөжиж байна. Бурханы ажлын замд хэн ч хөндөлсөж чадахгүй. Бурханыг эсэргүүцэж, Бурханы ажлыг үймүүлж, сүйтгэдэг хүмүүс Бурханы зөвт шүүлтийг амсаж, газрын хөрснөөс арчигдах тавилантай. Энэ нь Бурханы зөвт зан чанараар тодорхойлогддог. Төгс Хүчит Бурханы үг надад гэнэтийн гүн ойлголт өгч, би тэр дороо гэгээрлээ. Би сэтгэл дотроо хачирхан гайхаж, Бурханы гайхамшигт ажлыг магтахгүй байж чадсангүй. Бурханы мэргэн ухаан үнэхээр тэнгэрүүдээс өндөр юм; Бурхан ХКН-ын засгийн газрыг ашиглан үйлчлэл хийлгэдэг нь үнэхээр ухаалаг. Хүн төрөлхтнийг аврах Бурханы аврал маш бодитой бөгөөд би туйлын их үнэмшиж, Түүнийг магтахдаа больж чадахгүй нь! Зүрх сэтгэлээсээ би Бурханд ийн чимээгүйхэн залбирлаа: “Бурхан минь! Би үтрэмийн талбайгаас Таны гарган хаях будааны хальс болохыг хүсэхгүй байна, бас ХКН-ын засгийн газрын муу ёрын салхинд үлээгдэн хийсэхийг хүсэхгүй байна. Би Таны хураах буудай болохыг хүсэж байна. Бурхан минь! Би Таныг хэзээ ч сэтгэл хангалуун болгоогүй, гэхдээ ХКН-ын засгийн газрын догшин ширүүн хавчлагын дунд би чин үнэн сэтгэлээ харуулж, үнэнийг үнэхээр эрэлхийлж, ХКН-ын засгийн газрын ёрын муу хүчний өмнө бууж өгөхгүй байж чадна гэдэгтээ итгэж байна. Би шударга ёсоор цангадаг, гэрлийг хүсэн тэмүүлдэг, Таны төлөө гэрчлэлд зогсдог хүн болж, Та алдрыг олж авч чадна гэж найдаж байна...”

Ийм мэдэгтэй болсны дараа зүрх сэтгэл минь хүчирхэгжив. Гэр бүлийнхнийхээ буруу ойлголт, саад бартаатай тулгарах үед энэ бүгд Бурханы зөвшөөрлөөр болсон бөгөөд миний итгэл, үнэнч зан, дуулгавартай байдлыг төгс болгохын тулд Бурхан энэ бүхнийг нягт нарийн зохицуулсан болохыг би ойлгосон юм. Би эргэн тойрныхоо орчин нөхцөлийн талаар гомдоллохоо больсон, хүрээлэн буй орчиндоо хүлэгдэхээ ч больсон. Харин ч би Бурханд талархаж, Бурхан надад зориулж ямар ч орчныг зохицуулсан бай, үргэлж Түүний төлөө гэрчлэлд зогсож, үүргээ үнэнчээр биелүүлнэ гэж чимээгүйхэн шийдсэн юм; би Бурханаас яавч урвахгүй! Хожим нь би Бурханы үйл хэргийг харлаа—нөхөр маань намайг эсэргүүцэхээ больж, урьдынх шигээ дарангуй байхаа болив. Харин ч надад: “Чамайг итгээсэй гэж би хүсэхгүй байгаа юм биш. Бурханд итгэж эхэлснээсээ хойш өөрчлөгдсөн гэдгийг чинь би хүлээн зөвшөөрч байна; цаашид чи анхааралтай байж, цуглаанд оролцохоор явахдаа сэрэмжтэй байх хэрэгтэй шүү!” гэж хэлсэн юм. Нөхрийнхөө ингэж хэлэхийг сонсоод нүдийг маань нулимс бүрхэв. Үнэн болон шударга ёс, харанхуй, ёрын муу бүхнийг ялан дийлж чадна гэдгийг харсан учраас би үйл хэргийнх нь төлөө зүрх сэтгэлдээ Бурханд талархал, магтаал өргөлөө. Сатаны муу ёрын хүчин эцэст нь Бурханы ажлаар дамжуулан ор мөргүй арилна! Энэ туршлагаар дамжуулаад би цэвэршүүлэгдэх бэрхшээлийг бага зэрэг туулсан боловч Бурханы ухаалаг ажлын талаар зарим нэг

---

мэдлэгтэй болсон юм. Тэгээд бас эерэг, сөрөг зүйлсийг ялган таних чадвартай болсон— энэ бүхэн нь нэг төрлийн амийн эд баялаг бөгөөд үнэнийг эрэлхийлж, гэрлийг хүсэн тэмүүлэх шийдвэр болон итгэлийг төрүүлсэн билээ.

## **44. Салах маргаан намжсан нь**

Лу Ши, Япон

2015 онд би нэг найзаасаа болж Төгс Хүчит Бурханд итгэж эхэлсэн юм. Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн зөвшөөрснийхөө дараа би Бурханы үгийг шунаглан уншдаг боллоо. Тэгээд хүн төрөлхтнийг аврах Бурханы ажил нь 3 үе шатад хуваагддаг болох, мөн Бурхан үе шат болгонд Өөрийн ажлыг хэрхэн гүйцэтгэдэг болох, ажлын гурван үе шатын хоорондох холбоо, бие махбодтой болно гэж юу болох, Бурхан яагаад махбод болох ёстой эсэх гэх мэт үнэний тухай өмнө нь мэддэггүй байсан олон нууцыг Бурханы үгээр дамжуулан ойлгож авав. Ингэснээр би Төгс Хүчит Бурхан бол эргэж ирсэн Эзэн Есүс гэдэгт улам бат итгэх болсон юм. Бурханы үгийн удирдамжтай болсноос хойш би урьдын адил зурагт үзэж цаг нөхцөөхөө больсонд нөхөр маань: “Бурханд итгээд чи ном уншдаг болжээ. Өдөр болгон солонгос савангийн дуурь үзэж байснаас ингэсэн нь дээр шүү дээ. Үүнд чинь би үнэхээр баяртай байна!” гэж надад хэлэв. Манай нөхөр хэдий цуглаанд явдаггүй ч гэлээ ээж нь итгэгч тул Бурхан байдаг гэдэгт үргэлж итгэн, Бурханд итгэхийг минь ч бас дэмждэг байлаа. Ер нь би Бурханы үгээс гэгээрэл авах бүрд нөхөртэйгөө хуваалцдаг байсан бөгөөд нөхөр минь ч Бурханд итгэхийг сайшаадаг байв. Хожим нь нөхөр маань, ээж нь Эзэн Есүст итгэдэг атал намайг юунд дандаа “Төгс Хүчит Бурхан” гэж дурдаад байгаа юм бол гэж сониучирхан, Төгс Хүчит Бурханы Чуулганы талаар олж мэдэхээр интернэт оржээ. Тэгээд интернэт тэр чигтээ Төгс Хүчит Бурханы эсрэг цуу үг, хуурамч гэрчлэл, доромжлолоор дүүрэн байгааг санаандгүйгээр харсан байж. Нөхөр маань үүнд маш их хордож, Төгс Хүчит Бурханд итгэхийг минь эсэргүүцэж эхэлсэн юм. Би Төгс Хүчит Бурханы үгийг уншиж, ах, эгч нарынхаа нөхөрлөл, гэрчлэлийг сонсчихсон тул Төгс Хүчит Бурхан бол цорын ганц жинхэнэ Бурхан гэдэгт сэтгэлдээ аль хэдийн бат итгэсэн байсан бөгөөд интернэт дэх зүйлс нь хүмүүсийг хуурч мэхлэх гэсэн цуу үг, худал ярианаас цаашгүй гэдгийг мэдэж байлаа. Гэвч нөхөр маань цуу үгэнд хууртаад, бодит байдлыг ойлгохгүй байсан учраас яаж ч ятгаж, эцсийн өдрүүд дэх Бурханы ажлын талаар гэрчлээд нэмэргүй байв.

Хэсэг хугацааны дараа, нөхөр маань Еингэ эгчээр ахин дахин нөхөрлөл, гэрчлэл хийлгэсний ачаар эцсийн өдрүүд дэх Бурханы ажлыг судалъя гэж эцэст нь дурамжхан

---

зөвшөөрсөн юм. Гэвч манай нөхөр ээжийнхээ нөлөөнд автсан, Библийн талаар харьцангуй хуучинсаг үзэлтэй хүн байсан тул энэ асуудлыг нь шийдвэрлэхийн тулд “Библийн тухай нууцыг задлах нь” гэх сайн мэдээний киног цуг үз гэж эгч нар санал болгов. Харин би тэр киног нөхөртөө үзүүлэхийн оронд санаачилгыг гартаа авч, ХКН-ын засгийн газар хийгээд шашны ертөнцийн антихристүүд Бурханы ажлыг хэрхэн эсэргүүцдэгийг илчилсэн “Урхи зангыг сэт цохь” киног үзүүлсэн юм. Киноны багахан хэсгийг үзчихээд нөхөр маань: “ХКН бол бурхангүй үзэлт засгийн газар, Хятад бол шашинд итгэгчдийг үргэлж хяхаж хавчсаар ирсэн бурхангүй үзэлт улс шүү дээ. Төгс Хүчит Бурханы Чуулганыг ХКН-ын засгийн газар нухчин дарж байна, харин бид тэднийг эсэргүүцэж хүчрэхгүй жирийн л хүмүүс. Хятадад буцаж очоод баривчлагдвал яана? Тэгээд ч интернэтэд элдэв янзын зүйл бичээтэй байхад аль нь үнэн, аль нь худал болохыг ялгах аргагүй. Тэгэхээр би чамайг Төгс Хүчит Бурханд итгээгүй нь дээр гэж бодож байна” гэлээ. Киног дуустал нь үзсэнийхээ дараа шийдвэрээ гарга гэж би ятгасан ч, нөхөр маань үгэнд орсонгүй. Итгэлдээ үнэнч үлдэнэ гэж зүтгэж байгааг минь хараад, нэг удаа нөхөр минь над руу уурласандаа ийн дайрав: “Чи итгэнэ гэж зүтгээд байгаа юм бол итгэ, баривчлагдахыг хүсээд байвал баривчлагд, гэхдээ баривчлагдах юм бол намайг нөхрөө гэж битгий хэлээрэй! Одоо би ямар их дарамттай байгааг чи мэдэж байна уу? Итгэхгүй гэж байтал жинхэнэ Бурхан байх вий гэхээс айж байна. Бас итгэх юм бол интернэтэд бичсэн тэр бүх зүйлээс гадна, би баривчлагдах аюулд орно. Тэгэхээр би эцсийн эцэст хэнийг нь сонсох болж байна?” Интернэт дэх тэдгээр цуу үгэнд баригдан шаналж байгаа нөхрөө хараад ХКН-ын засгийн газраас гаргасан цуу үг, хуурамч гэрчлэл хэчнээн их хор хөнөөлтэйг би ойлгов. Тэр нь үнэн замыг хүлээн авахад нь хүмүүст саад болохоос гадна гэр бүлийн харилцааг мөн сүйтгэдэг аж. Цууг үг гаргаж, хуурамч гэрчлэл тараадаг тэр хүмүүс гарцаагүй диавол Сатаны үрс болж таарлаа!

Нэг өдөр нөхөр маань ажлаасаа тарж ирээд цуглаантай байгааг минь харсан бөгөөд царай нь тэр дороо барайн, хаалга саваад гараад явчлав. Оройн хоолны цаг өнгөрчхөөд байхад эргэж ирэхгүй байсан болохоор нь би өөрийн эрхгүй санаа зовж эхэлсэн юм. Найман цагт нөхөр маань арай гэж нэг юм гэртээ эргэж ирсэн ч уур нь гараагүй л байлаа. Түүнд хоол бэлдэх гэсэн боловч надад хүйтэн хөндий өнгөөр: “Хэрэггүй ээ! Нэгэнт чи миний үгэнд орохгүй, Бурханд үргэлжлүүлэн итгэсээр байгаа хойно одоогоос эхлээд миний хэрэгт битгий оролц. Цаашид би амьжиргааны зардлаа л хариуцна, харин энэ гэрээс гадуур би юу ч хийсэн гэсэн чамд огт хүртээлгүй шүү! Би энэ гэр бүлийг хөөдөх зүйл хийлээ ч хамаагүй!” гэж хэлэв. Нөхрөөсөө ийм үг сонсчихоод энэ тухай бодох тусам сэтгэл минь улам ч хямарлаа. Тэр шөнө би унтаж чадалгүй орон дотроо эргэж хөрвөөн, сэтгэлдээ Бурханд ахин дахин ийн залбирсан юм: “Өө Бурхан минь! Нөхөр маань цуу үгэнд

---

хууртаад Танд итгэх итгэлийг минь хааж боогдуулах гэж оролдон, ийм хахир хатуу үг хэлж байна. Би яавал дээр вэ? Надад арга зам харуулаач! Би Танаас хагацмааргүй байна.” Маргааш өглөө нь, цуглаан дээр бидний нөхөрлөж байсан Бурханы зарим үг гэнэт санаанд оров: **“Хүмүүс дээр Бурханы хийдэг ажлын алхам бүрд, гаднаа энэ нь хүмүүсийн хоорондын харилцаа мэт, хүний зохицуулалт, хүний хөндлөнгийн оролцооноос үүдэлтэй мэт харагддаг. Гэвч нүднээс далдуур, ажлын алхам бүр, тохиолдож буй юм бүхэн нь Бурханы өмнө Сатаны тавьсан бооцоо бөгөөд Бурханд гэрчлэл хийхдээ бат зогсохыг хүмүүсээс шаарддаг. Жишээ нь, Иовыг шалгасан үеийг авч үзье: Нүднээс далдуур Сатан Бурхантай мөрий тавьж байсан бөгөөд Иовд тохиолдсон зүйл нь хүмүүсийн үйл хэрэг, хүмүүсийн хөндлөнгийн оролцоо байсан. Та нарт хийдэг Бурханы ажлын алхам бүрийн ард Сатаны Бурхантай тавьсан мөрий байдаг—энэ бүгдийн ард тэмцэл байдаг... Бурхан, Сатан хоёр сүнсний ертөнцөд тулаан хийх үед чи Бурханыг хэрхэн сэтгэл хангалуун болгож, Түүнд хийх гэрчлэлдээ хэрхэн бат зогсох ёстой вэ? Чамд тохиолддог бүхэн асар их шалгалт гэдгийг, мөн Бурхан чамаар гэрчлэл хийлгэх хэрэгтэй болох тэр цаг үеийг чи мэдэх ёстой”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурханыг хайрлах нь л үнэхээр Бурханд итгэж буй хэрэг”). Бурханы үгийн гэгээрлээр би нэг зүйлийг ухаарлаа: “Өнөөдөр дэлхий дээр луйвар, залилан маш олноор гарч, ялангуяа ХКН-ын мэдээллийн хэрэгслээс гарсан бүх худал үг, хуурамч мэдэгдлээс үүдэн газар сайгүй худал хуурмаг, хууран мэхлэлтээр дүүрч байгаа гэж бодон, энэ хугацаанд би нөхөртөө байнга анхаарч ирсэн юм. Ямар ч богино бодолтой хүн хэсэгхэн зуур эргэцүүлэх л юм бол Төгс Хүчит Бурхан руу дайрч давшилсан, Түүнийг шүүж, ялласан интернэт дэх эдгээр үг нь бүгд худал хуурмаг, хий дэмий үг гэдгийг ухаарч, тэдгээрт хууртаж, төөрөгдөж болохгүй гэдгээ ойлгоно гэж би бодож явлаа. Харамсалтай нь манай нөхөр интернэтэд бичээтэй цуу үгэнд итгэсэн бөгөөд нөхөр маань үнэхээр тэгэх ёсгүй байсан мэт надад санагдаж байсан юм. Одоо би уг шалтгааныг гаднаас эрж хайж чадахааргүй боллоо. Бурхан намайг ийнхүү шалгаж, Бурханд итгэх итгэл минь жинхэнэ эсэх, Сатаны дайралтад өртөх үедээ үнэн замыг баримталж чадах эсэх, мөн энэхүү шалгалт дунд Бурханд гэрчлэл хийж чадах эсэхийг минь шалгахын тулд үүнийг ашиглаж байжээ.” Бурханы хүслийг ухаарахтай зэрэгцэн зүрх сэтгэл, оюун санааг минь халхалж байсан манан будан арилж, сэтгэл маань нэлээд өөдрөг боллоо.

Маргааш нь өглөөний цайгаа ууж байхдаа ч нөхөр маань муухай царайлж, надтай ярихгүй хэвээр байсан ч Бурханы үгийн удирдамжтай болсон би өмнөх өдөр шигээ санаа зовж, айж эмээсэнгүй. Нөхөртөө би тайвуухан ингэж хэллээ: “Би Бурханд итгэдэг ч гэлээ энэ гэр бүлийг хөөдөх зүйл огт хийж байгаагүй. Чи гэр бүлээ хөөдмөөр байгаа бол тэр чинь Бурханд итгэх итгэлээс минь болоогүй, харин чи өөрөө л өөдгүй амьтан болохыг

---

хүссэнтэй холбоотой.” Ингэж хэлэхийг минь сонсоод, нөхөр маань: “Үгэнд минь орохгүй, Бурханд итгэнэ гэж зүтгээд байхаар чинь л би тэгж хэлсэн биз дээ?” гэж зөөлөрсөн өнгөөр хэллээ. Тэгээд өөр зүйл нэмж хэлсэнгүй тул бидний маргаан ийнхүү дуусав. Бурханд талархъя! Бурханы үг л надад Сатаны сорилтыг ялан дийлэх хүч хайрласан юм!

Гэвч сайн зүйл мөнхөд үргэлжилдэггүй билээ. Сарын дараа манай нөхөр интернэтэд ороод, өнөөх цуу үгээ дахин уншиж эхэлжээ. Нэг өдөр нөхөр маань ажлаасаа тарж ирэхдээ намайг компьютерын ард сууж байхыг хараад ийнхүү хашхичиж эхлэв: “Чи солиорчихсон юм шиг ээ! Би сайн бодож үзлээ. Чи нэг бол итгэхээ даруй боль, эсвэл хоёулаа салсан нь дээр юм байна. Би бас хоёр хүүхдийнхээ талаар ч бодож үзлээ. Чи хоёуланг нь өөр дээрээ авч болно. Гэхдээ миний бодлоор чи Японд үлдэж чадахгүй болохоор хүүхдүүдээ аваад Шанхай руу буц! Шанхай дахь байраа чи ав, би бас сар бүр хүүхдийн тэтгэмж болгож 100 мянган иен өгье. Хүүхдүүдээ авахгүй гэвэл дураараа л бол, яахаа чи өөрөө шийд! Гэрлэлт цуцлуулах журмыг ч би судалсан. Хэсгийн хороон дээр очоод салах өргөдөл дээр хоёулаа гарын үсгээ зураад л болчихно. Тийм болохоор чи яах бодолтой байгаагаа л хэлчих!” Ингэж хэлснийх нь дараа миний зүрх дэлсэж, чих шуугиад явчлав. Бурханд залбирахаа ч мартчихаад хэлэх үг олдохгүй, тэндээ суусаар л байлаа. Салчихвал хүүхдүүд маань яах болж байна гэхээс өөр зүйл надад бодогдсонгүй. Би өөр дээрээ авдаг юм гэхэд өсгөх санхүүгийн бололцоо байхгүй шүү дээ! Өөр дээрээ авдаггүй юм бол хоёр хүүхэд маань ээжгүйгээр маш хөөрхийлөлтэй байдалд орно! Тэгээд ч эцэг эх, найз нөхөд, садан төрлийнхөн маань намайг юу гэж бодох болж байна? Гадаадад байх уг нь тун сайхан хэрэг боловч, биднийг салчихвал эцэг эх маань яаж хүний царай эгцэлж харах юм бэ... Иймээс би нөхөртөө хариу хэлсэнгүй. Зүгээр л энэ тухай бодох хэрэгтэй байна гэж хэлчхээд өрөөндөө ороод эхэр татан уйлж гарав. Салсны дараа яаж амьдрахаа бодох тусам сэтгэл минь улам их шаналж байлаа. Цурам ч хийгээгүй тэр шөнө дэр минь нулимсанд нэвт норсон байж билээ. Маргааш нь манай нөхөр нэг ч үг хэлэлгүй ажилдаа явсан тул эцэст нь би Бурханы өмнө очиж залбиран, махан биеийн сул дорой байдлаа ялан дийлэх илүү их хүч чадал хайрлаач гэж гуйв. Би шаналанд автан, яахаа мэдэхгүй амьдарч байсан болохоор зарим ах, эгчид болсон явдлын талаар ярьсан юм. Тэд үүнийг миний туулж буй Сатаны нэг сорилт гээд, намайг бүгд зоригжуулан тайтгаруулж, Бурханд найдаж сурахад минь тусаллаа. Тэгээд надад Бурханд итгэхээ больж, Бурханыг буруугаар ойлгож болохгүй гэж хэлцгээв. Үүний зэрэгцээ тэд бусад ах, эгчийн туршлага, гэрчлэлийг хуваалцсан бөгөөд Бурхан бол хүн төрөлхтнийг авардаг Нэгэн, харин Сатан л биднийг зовоож, шаналган бусад хүнтэй харилцах харилцааг маань сүйрүүлдэг талаар нөхөрлөлөө. Мөн тэд Төгс Хүчит Бурханы үгээс нэг хэсгийг уншиж өгсөн юм: **“Хүмүүс хараахан аврагдаагүй байх үед тэдний амьдралд Сатан үргэлж оролцож, бүр хянаж байсан. Өөрөөр хэлбэл,**

---

аврагдаагүй хүмүүс бол Сатаны хоригдлууд бөгөөд тэд эрх чөлөөгүй, Сатан тэднийг суллаагүй, тэд Бурханыг шүтэн мөргөх шаардлага хангаагүй, эсвэл тэгэх эрхгүй байдаг бөгөөд тэднийг Сатан ойрхон мөшгин хөөж, хайр найргүй дайрч байдаг. Тийм хүмүүст яриад байх аз жаргал байдаггүй, яриад байх хэвийн оршин тогтнох ямар ч эрх байхгүй, түүнчлэн яриад байх ямар ч нэр төр байдаггүй. Чи зөвхөн бат зогсож, Сатантай тэмцэл хийж, Бурханд итгэдгээ, Түүнд дуулгавартай байдгаа, Бурханаас эмээдэг байдлаа Сатантай үхэх сэхэхээ үзэх тулааныхаа зэвсэг болгон ашиглах л юм бол Сатаныг бүрэн ялж, чамайг хараад л сүүлээ хавчин зугтаж, хулчийдаг болгоно, ингэснээр тэр чиний эсрэг өөрийн дайралт, буруушаалтуудыг бүрэн орхино—зөвхөн тэр үед л чи аврагдаж, эрх чөлөөтэй болно” (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурханы ажил, Бурханы зан чанар ба Бурхан Өөрөө II”). Бурханд итгэх итгэлээ хэрэгжүүлээгүй байх үедээ би Сатаны эзэмшилд бүрмөсөн амьдарч, Сатаны боол, тоглоом тохуу болж байсныг Бурханы үг надад ойлгууллаа. Бурханд итгэх болсноор би Сатаны хүрээллээс гарч Бурханы өмнө эргэж ирсэн билээ. Сатан надад хаягдчихаад ялагдах хүсэлгүй байсан тул нөхрийг маань ашиглан эмзэг цэг рүү минь довтолжээ. Намайг албадан Бурханаас урвуулж, өөрийн эзэмшилд эргүүлэн авчрахын тулд салалтыг ашиглаж байж. Энэ бол үнэхээр Сатаны ов мэх байлаа. Салсны дараа хүүхдүүдээ яах вэ, нутгийн маань хүмүүс намайг юу гэж бодох вэ, аав ээж маань айл хөршийнхөө царайг яаж эгцлэн харах вэ гэж санаа минь зовж байсан юм. Сатаны үймээнээс энэ бүх бодол урган гарсан бөгөөд эдгээр бодолд захирагдах юм бол Сатанд захирагдаж, эцэстээ би Бурханаас холдон, бүр Бурханыг үгүйсгэж, Сатаны хүрээлэлд дахиад эргэн очих байж. Бүтээгчид итгэж, шүтэн мөргөх нь тэр чигтээ эерэг зүйлс, мөн тэнгэрийн хууль, газрын зарчим бөгөөд үүнд ямар ч хүн хөндлөнгөөс оролцох эрхгүй атал Сатан намайг захирч, Бурханаас урвахад хүргэхээр бүхий л аргаар үзэж байна. Сатан үнэхээрийн жигшмээр, үзэн ядмаар юм! Тэр мөчид би Сатаны сорилттой ганцаар нүүр тулах итгэл дулимаг байгаагаа мэдэж байсан ч Бурханд түшиглэж, Бурханы үгийн удирдамжид найдан урдах замаар алхахыг хүссэн бөгөөд Сатанд би яасан ч бууж өгөлгүйгээр Бурханы талд зогсон, Бурханд гэрчлэлд хийхээр сэтгэл шулуудсан билээ. Ингэж бодоод үймсэн сэтгэл минь эцэстээ тогтуун болж, шаналал минь намжив.

Хожим нь зарим ах эгч надтай Бурханы үгийг дахин хуваалцсан юм: “Бурханы зөвшөөрөлгүйгээр газар дээрх дусал ус юм уу элсний ширхэгт хүрэх ч Сатанд хэцүү; Бурханы зөвшөөрөлгүйгээр Бурханы бүтээсэн хүн төрөлхтөн байтугай газар дээрх шоргоолжийг ч хөдөлгөх эрх чөлөө Сатанд байхгүй. Бурханы нүдээр бол Сатан, уулын сараана цэцэгс, агаарт нисэх шувууд, тэнгисийн загас, хөрс шороон дээрх өтнөөс ч дорд. Бүх зүйлийн дундах түүний үүрэг гэвэл бүх зүйлд болон хүн



---

төрөлхтөнд үйлчилж, бас Бурханы ажил болон удирдлагын төлөвлөгөөнд үйлчлэх явдал юм. Түүний уг чанар хэчнээн ч хорлонтой, мөн чанар нь хэчнээн ч ёрын муу бай, Бурханд үйлчлэл үзүүлж, Бурханы товойлгогч байх чиг үүргээ л ухамсартайгаар биелүүлэх нь түүний хийж чадах ганц зүйл юм. Сатаны мөн чанар, байр суурь ийм байдаг. Түүний мөн чанар нь амь, хүч чадал, эрх мэдэлтэй холбоогүй; тэр бол ердөө л Бурханы гар дахь тоглоом, Бурханд үйлчлэх машин төдий юм!” (Үг нь махбодоор илэрсэн номын “Цор ганц Бурхан Өөрөө I”). Бурхан дээдийн дээд эрх мэдэлтэй байж, тэнгэр газар, бүх зүйлийг хянадаг бөгөөд бидний бүх зүйл Бурханы гарт байдгийг Бурханы үгээс би ухаарсан юм. Миний гэрлэлт, гэр бүл мөн Бурханы гарт байдаг тул Бурханы зөвшөөрөлгүйгээр Сатаны хийж чадах зүйл нэгээхэн ч үгүй билээ. Салах эсэхийг нөхөр маань эцэслэн шийддэггүй, харин энэ бүгд Бурханы дээд эрх, урьдаас тогтоосон заяа төөрөг дор байдаг тул Бурханы дээд эрх, төлөвлөгөөнд захирагдахыг би хүсэж байлаа. Гэр бүл цуцлуулсан үл итгэгчдийн талаар бодов. Тэдний зарим нь мөнгөнөөс болж салдаг бол заримынх нь хань ижил гэр бүлээс гадуурх харилцаатай болж, зарим нь гэр бүлийн харилцаа нь нэгэнт сүйрсэн тул салдаг... Бурханд итгэж, амьдралын зөв замаар алхан, үнэнийг эрэлхийлж, утга учиртай амьдралыг амьдран харуулахаар шийдсэний минь төлөө нөхөр маань надаас салахыг хүсжээ. Энэ бол ичгүүртэй бус, нэр төртэй хэрэг! Тэрхэн үед Бурханы ийм үг санаанд орсон юм: **“Итгэл бол дан гуалин гүүртэй адил, өрөвдөлтэйгээр амьтайгаа зууралддаг хүмүүс гатлахад хэцүү, харин өөрсдийгөө золиослоход бэлэн хүмүүс хөл алдалгүй, санаа амар гаталж чаддаг. Хүн бүрэг, аймхай бодол тээдэг бол Сатан биднийг итгэлийн гүүрийг гаталж, Бурхан руу орох вий гэж айсандаа хуурч буй хэрэг юм. Сатан өөрийн бодлыг бидэнд илгээхийн тулд боломжит бүх арга замыг сэдэж байгаа. Бид Бурханаас гэрлээрээ биднийг гэрэлтүүлэхийг гуйн хором мөч бүрд залбирч, дотроосоо Сатаны хорыг гадагшлуулахын тулд хором мөч бүрд Бурханд найдан, Бурханд хэрхэн ойртох талаар хором мөч бүрд сүнсэн дотроо хэрэгжүүлж, бүхий л оршихуйгаа Бурханаар ноёрхуулах учиртай”** (“Үг нь махбодоор илэрсэн” номын Христийн эхэн үеийн айлдваруудын “6-р бүлэг”). Бурханы үг надад дахин нэг удаа итгэл, хүч, дагах зам, нөхөртэйгөө нүүр тулах эр зориг өгсөн юм. Тийм шүү! Болгоомжлохоо болихоос өөр арга алга. Цаашдын замд минь юу тулгарлаа ч хамаагүй итгэлийн замаар алхахад буруутах учиргүй!

Тэр үдэш нөхрөө гэртээ ирснийх нь дараа би шулуухан ингэж хэлэв: “Чи намайг Төгс Хүчит Бурханд итгэхгүй байгаасай гэж хүсэж байгаа ч энэ чинь миний хувьд боломжгүй хэрэг. Салмаар байвал чинийхээр болцгооё!” Нөхөр маань үүнийг сонсоод бага зэрэг цочирдсон бөгөөд өөр сонголтгүй тул болсон тул: “Би чамайг угаасаа хянаж чадахааргүй болж! Интернэтэд элдвийн зүйл бичээтэй байна. Хэрвээ би чамайг хянаж байхгүй бол

---

хэзээ нэг өдөр чамд элдэв юм тохиолдлоо гэхэд би л хариуцлага хүлээнэ шүү дээ. Чамайг айлгах гэсэндээ л би салъя гэсэн юм. Даанч чи Бурханд итгэхээ болихгүй л байна. Бурханд итгэдгээс чинь болоод чамд ямар нэг зүйл тохиолдвол, ээж чинь тэр тухай олж мэднэ шүү. Иймээс намайг битгий буруутгаарай” гэж хэлэв. Үүнээс хойш нөхөр маань Бурханд итгэдэгт минь анхаарахаа больсон бөгөөд бидний харилцаа гайхалтайгаар сэргэж, нөхөр маань салах тухай дахин үг цухуйлгасангүй. ХКН-ын засгийн газрын цуу үгээс үүдэлтэй салах тухай маргаан маань ийнхүү намжсан билээ.

Хожим нь нэг удаа манай бага охин бид хоёр хоёулаа ханиад хүрчхэв. Тэр үед гадаа бороо шивэрч байсан ч том охин маань давтлага руугаа явах ёстой тул туйлдаж ядарсан биеэ чирч, бага охиноо дагуулаад том охиноо хүргэж өгөхөөс өөр арга байсангүй. Нөхөр маань энэ талаар сонсоод: “Өнөөдөр чи том ажил амжуулжээ. Лу Ши, сүүлийн үед чиний өөрчлөгдөж байгааг би анзаарлаа. Чи минь хүүхдүүдээ улам их хайрлаж, бас их шаргуу болсон байна” гэлээ. Төгс Хүчит Бурханы үгийн ачаар өөрчлөгдсөн гэдгээ би мэдэж байсан тул нөхрийнхөө ингэж хэлэхийг сонсоод сэтгэлдээ Төгс Хүчит Бурханд талархсан юм. Бурханы үгэнд тулгуурласнаар амьдрал минь зүг чигтэй болсон бөгөөд хэвийн хүн чанар, завхарсан зан чанар гэж юу болохыг би мэддэг болсон юм. Бурханы үгийн дагуу бие авч явснаар л хэвийн хүн чанарыг амьдран харуулж чаддаг. Иймээс би үр хүүхдэдээ хамаагүй уураа гаргахаа больсны дээр зөвхөн баяр баяслын төлөө амьдрахаа больсон юм. Манай нөхөр ч бас өөрчлөгдсөнийг би аажмаар анзаарав. Урьд нь тэр үргэлж өөрийнхөө зөв гэж боддог байсан бол одоо зарим асуудлыг шийдэхдээ миний саналыг асуух болсон юм. Үүнээс гадна Бурханы эрх мэдэл, дээд эрхийн талаар хүртэл найзууддаа гэрчлэл хийсэн билээ. Эдгээр зүйлийг хараад зүрх сэтгэл минь талархлаар бялхаж байна. Өө Бурхан минь, Та үнэхээр төгс хүчит, Таны үг бидний амийн хүч юм! Сатаны хүч хэчнээн түрэмгий, ширүүн догшин байлаа ч Таны үгээр замчлуулж байгаа цагт бид Сатаны бүх сорилтыг ялан дийлж чадахаас гадна Таны халамж, хамгаалалт дор энх тунх амьдрах болно.

Миний төлөө энэ бүхнийг зохицуулж, үгийг нь туулж, олон үнэнийг ойлгох боломж олгосонд нь Бурханд талархъя. Сатан үнэхээр жигшмээр бөгөөд Бурханыг орхиулж, хүмүүсийг олзлон залгих бүхий л боломжит аргыг сэддэг болохыг би ийм нөхцөл байдлыг туулснаар олж харсан юм. Үүний зэрэгцээ Бурхан бүх зүйлийг хянаж, бүхнийг зохицуулдаг; Бурханы зөвшөөрөлгүйгээр Сатан хэчнээн улангаслаа ч нэмэргүй, юу ч хийж чадахгүй, юунд ч хүрч чадахгүй, бидний толгой дээрх ширхэг үсийг ч хөндөж чадахгүй гэдгийг би харсан билээ. Бурханд итгэж, Бурханы үгэнд найдан амьдарч байгаа цагт бид Сатаны харанхуйн нөлөөг ялж, Бурханы гэрчлэлд зогсон, Бурханыг алдаршуулж чадна! Интернэт дэх цуу үг, хуурамч гэрчлэл нь үндэслэлгүй болохыг баримтууд мөн нотолж

---

байна. Баримт болоод цаг хугацаа бүхнийг харуулж, эдгээр цуу үг эцэстээ “шашингүй үзэл”, “Дарвины хувьслын онол”, “коммунизм”-тай яг адилаар түүхэнд мөнх шившиг болон үлдэхийн дээр ХКН-ын засгийн газрыг мөнхөд шившиглэх нэгэн толбо болно. Сатаны саад тотгор хэчнээн том байлаа ч Бурханы хоньд Бурханы дуу хоолойг сонсоно. Бурханд чин сэтгэлээсээ итгэж, үнэнд дурладаг бүх хүн цуу ярианы ов мэх, хүлээсийг хөсөр орхиж, Бурханы өмнө очин Бурханаар авхуулж чадна. Учир нь Бурхан үүнийг биелүүлэхийг хүсдэг бөгөөд Сатаны ямар ч хүч үүнд саад болж чадахгүй билээ!

## **45. Төөрөөд замаа дахин оллоо**

Шэйли, АНУ

Би амьжиргааны түвшин өндөртэй, аз жаргалтай амьдралыг эрэлхийлэн чадлынхаа хэрээр шаргуу ажиллахаар АНУ-д ирсэн юм. Эхний хэдэн жилд багагүй зовсон хэдий ч би аажмаар өөрийн гэсэн компани, машин, байшин гэх мэттэй болж чадсан билээ. Эцэст нь би мөрөөдөж байсан “аз жаргалтай” амьдралаараа амьдарч байв. Энэ хугацаанд би хэдэн найзтай боллоо; чөлөөт цагаараа бид хамт хооллож, ууж, наргин зугаацдаг байв. Бид бүгд хоорондоо нэлээд эвтэй байсан бөгөөд хэдэн сайн залуутай танилцлаа даа гэж би боддог байлаа. Гэтэл тэд ганц ч үнэн бодит юм ярьдаггүй, архины найзууд болохыг би ухаарсан юм. Санаа зовж, сэтгэлээр унасан байх үедээ би тэдний хэнтэй ч бэрхшээлээ хуваалцаж чаддаггүй байв. Түүгээр ч зогсохгүй тэд намайг луйвардахаар хуйвалдсан юм: Тэдний нэг нь надад ээж нь Хятадад хүнд өвдсөн гэж хэлээд, намайг мөнгө зээлдүүлэх үед ул мөргүй алга болсон. Нөгөөх нь миний төрсөн хотоос ирсэн бөгөөд нэгэн төсөлд санхүүжилт хэрэгтэй байгаа талаар баахан худал хэлээд, надаас мөнгө луйвардаж авсан юм. Миний хамгийн дотнын, хайртай хүн буюу найз охин маань ч надаас урваж, олон жилийн турш цус, хөлс, нулимсаа урсган байж хураасан их хэмжээний мөнгийг луйвардсан. Энэ хүмүүсийн хатуу сэтгэл, нийгмийн хайхрамжгүй байдал намайг сэтгэлээр унагаж, мохоосон билээ. Хэсэг хугацаанд би цааш үргэлжлүүлэн амьдрах итгэлээ алдав; зүрх сэтгэл минь хоосорч, би шаналж, арга мухардаж байлаа. Үүнээс хойш би доторх хоосролоо дүүргэхийн тулд үргэлж идэж, ууж, зугаацах болсон ч бие махбодын түр зуурын эдгээр таашаал сүнсний минь шаналлыг шийдвэрлэж огт чадахгүй гэдгийг мэдэж байлаа.

2015 оны намар санаандгүй хувь заяагаар би одоогийн эхнэр болох эмэгтэйтэй танилцсан юм. Тэр үед эхнэр маань хэдийнээ Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн авсан байв. Тэр надтай хаанчлалын сайн мэдээг хуваалцах үед итгэлтэй байх

---

нь сайн сайхан мэт санагдаж байсан ч ажилдаа маш завгүй байсан тул би эхнэртээ: “Надад Бурхан итгэх цаг алга, гэхдээ чи итгэмээр байвал итгэ. Бурхан байдаг гэдгийг зүрх сэтгэлдээ мэддэг байхад л надад хангалттай” гэж хэлсэн юм. Хагас жилийн дараа нэгэн өдөр эхнэр маань Төгс Хүчит Бурханы Чуулганы “Ноагийн өдрүүд ирсэн нь” гэдэг видеог надад үзүүлэв. Видеог үзээд би үнэхээр цочирдлоо: Гай гамшигтай тулгарах үедээ хүн төрөлхтөн үнэхээр өчүүхэн, эмзэгхэн бөгөөд ялихгүй цохилтыг ч тэсвэрлэх чадваргүй. Хүн хэчнээн их мөнгөтэй, хэчнээн тансаг амьдралтай, хэчнээн өндөр байр суурьтай байсан ч хамаагүй, энэ бүгд утга учиргүй гэдгийг би гэнэт мэдэрлээ. Гай гамшиг тохиолдож, үхэл бидэнтэй нүүр тулах үед энэ бүх зүйл ямар ч үнэ цэнгүй, хэрэггүй юм. Яг л Төгс Хүчит Бурханы үгэнд хэлдэгчлэн: **“Гэвч, Ноагийн цаг үед хүмүүс Бурханы хувьд харж гэвчишгүй байх хэмжээнд идэж уун, гэрлэж, нөхөрт гарч байсан тул Тэрээр хүн төрөлхтнийг утсгахын тулд асар их үер буулган, зөвхөн Ноагийн гэр бүлийн найман хүн болон бүх төрлийн жигүүртэн шувууд, араатан амьтдыг өршөөсөн гэдгийг Би чамд хэлэх ёстой. Гэхдээ эцсийн өдрүүдэд Бурханы өршөөсөн хүмүүс бол эцсээ хүртэл Түүнд үнэнч байсан бүх хүн юм”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурхан хүмүүсийн дунд агуу зүйл хийснийг чи мэдсэн үү?”). **“Өнөө үеийг одоо хар л даа: Бурханд шүтэн мөргөж муугаас зайлж чадах Ноа шиг зөв шударга хүмүүс байхаа больжээ. Гэсэн ч Бурхан хүн төрөлхтөнд нигүүлсэнгүй хэвээр, энэхүү төгсгөлийн эрин үед тэднийг уучилсаар байдаг. Өөрийг нь гарч ирэхийг хүсэн хүлээдэг хүмүүсийг Бурхан эрж хайдаг. Өөрийнх нь үгийг сонсож чаддаг, Түүний даалгаврыг мартаагүй, зүрх сэтгэл, бие махбодоо Түүнд өргөн барьдаг хүмүүсийг Тэр эрж хайдаг. Өөрийнх нь өмнө хүүхэд шиг дуулгавартай байдаг, Өөрийг нь эсэргүүцдэггүй хүмүүсийг Тэр эрж хайдаг”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Бүх хүн төрөлхтний хувь заяаг Бурхан захирдаг”). Эдгээр үгээс би хүн төрөлхтнийг аврах гэсэн Бурханы яаруу санаа зорилгыг мэдэрч байлаа. Өнөө үед хэн ч эерэг зүйлийг хайрладаггүй, Бурханыг эргэн ирэхийг хүсэн хүлээдэггүй мэт байдаг тухай би бодов. Хүмүүсийн зүрх сэтгэл аминчхан, биеэ тоосон зан, заль мэхээр дүүрсэн. Алдар нэр, ашиг хонжооны төлөө тэд нэг нэгнийхээ эсрэг хуйвалдаж, үгсэн тохирч, нэг нэгнээ хууран мэхэлж, тэр ч байтугай нэг нэгнээ хөнөөхөд хүрдэг. Хүмүүс дур хүслийнхээ боол болж, ёс суртахуун, ариун журмыг байнга зөрчиж, мөс чанараа булшилж байдаг. Хүмүүс бүх хүнлэг чанараа алдсан... Эцсийн өдрүүд дэх хүн төрөлхтний завхралын түвшин Ноагийн эрин үеийнхээс үнэхээр хаа хол давсан билээ. Гэвч Бурхан энэхүү хорон муу байдал, завхралаас нь болж хүн төрөлхтнийг шууд устгаагүй, харин хүн төрөлхтөнд анхааруулж, Бурхан руу эргэх боломжийг өгөхийн тулд янз бүрийн гай гамшигийг буулгаж байна. Бурханы үгийг эргэцүүлэн бодох үед Бурханы хайр зүрх сэтгэлийг минь гүнээ хөдөлгөсөн юм. Дэлхий ертөнц өдөр ирэх тусам улам бүр муу болж, завхарч байгаа тухай, гай гамшиг улам ихсэж байгаа тухай, мөн Бурхан ёрын

---

муу хүн төрөлхтөнд уураа гаргаж, хүн төрөлхтнийг устгах үед миний хөөцөлдөж байсан бүх мөнгө, байр суурь намайг аварч чадахгүй тухай бас бодов. Бурханы өмнө очиж, үнэнийг эрж хайснаар л хүн хамгаалалт олж авч чадна. Энэ бүхнийг сайтар бодох үед яг л зүүднээсээ сэрэх мэт болсон бөгөөд Бурханы өмнө очиж, Түүний авралыг хүлээн авах ёстой, энэ нь аврагдах цорын ганц арга зам гэдгийг зөн билиг маань надад хэллээ. Хэрэв би түр зуурын бие махбодын таашаалын төлөө аврагдах боломжоо алдах юм бол насан туршдаа харамсах болно! Улмаар 2016 оны 5 дугаар сард би Бурханд итгэж эхэлсэн бөгөөд цуглаанд оролцдог болсон юм.

Бурханд итгэж эхэлснээс хойш төд удалгүй би вэбээр хэсүүчилж байгаад Төгс Хүчит Бурханы Чуулганыг яллаж, доромжилсон сөрөг суртал ухуулгыг санамсаргүй харав. Тэрнийг уншаад би агшин зуур мэл гайхлаа. “Хүмүүсийг хүчээр хандив өргүүлж, эр, эмийн хоорондох хил хязгаарыг үл тоодог” гэж юу гэсэн үг юм бэ? Уншсан зүйл маань ортой мэт санагдаж байсан тул зөвийг буруугаас, бодит байдлыг зохиомлоос ялгахад надад тун хэцүү болов. Би будилан самуурч, миний уншиж байсан сөрөг зүйлээс болж Бурханд итгэх итгэлийн минь дүрэлзэж буй гал тэр даруй унтарлаа. Яг тэр мөчид хадам ээж чуулганд мөнгө хандивлах талаар эхнэртэй маань утсаар ярьж байхыг сонсоод интернетээр уншсан зүйлдээ илүү их итгэхэд хүрэв. Үүний дараа би луйвардуулахаас сэргийлэх үүднээс хадам ээжийнхээ мөнгө хандивлахыг нь болиулж, эхнэрээсээ итгэхээ болихыг шаардав. Гэвч эхнэр маань намайг огт сонсолгүй: “Бодит нөхцөл байдал интернетээр уншсантай чинь огт адилгүй. Интернет дэх зүйлс бүгд цуу яриа, хуурамч гэрчлэл!...” гэж тууштай хэлэв. Тэгээд эхнэр маань Бурханы үгийн ном авч, надтай нөхөрлөж эхэлсэн ч би хэдийнээ цуурхалд бүрэн итгээд, хэлж байгааг нь өчүүхэн төдий ч сонсоогүй юм. Төд удалгүй хэдэн ах эгч манай гэрт ирсэн ч би тэднийг бас л үл тоов. Тэр хэдэн өдөрт би тэр чигтээ харанхуйд амьдарч, эхнэр, хадам ээж хоёр маань луйвардуулах вий хэмээн байнга санаа зовж байлаа. Би дэндүү их санаа зовсондоо идэж, унтаж ч чадахаа больж, сэтгэл санааны хувьд ихээхэн шаналав. Зовж байгааг минь хараад эхнэр надтай дахин нөхөрлөх гэж оролдов. Тэрээр Төгс Хүчит Бурханы үгийн номыг нээж, дараах хэсгийг надад харуулахаар сонгосон юм: **“Миний хүсдэг зүйл бол хүний үзэл болон хүний бодол биш, тэр ч бүү хэл чиний мөнгө, эсвэл чиний эзэмшил биш. Миний хүсдэг зүйл бол чиний зүрх сэтгэл, ойлгов уу? Энэ бол Миний хүсэл, үүнээс ч илүүтэйгээр энэ нь Миний авахыг хүсдэг зүйл юм”** (“Үг нь махбодоор илэрсэн” номын Христийн эхэн үеийн айлдваруудын “61-р бүлэг”). Тэгээд бас чуулганы амьдралыг удирдах зарчмуудын заримыг уншиж өгөв: “Номлолоороо хандив гуйхыг, эсвэл өөр ямар нэг шалтгаанаар хандив гуйхыг чуулган хэнд ч зөвшөөрдөггүй” (Ажлын зохицуулалт). Дараа нь тэрээр надтай ингэж нөхөрлөж: “Төгс Хүчит Бурханы Чуулган, чуулганы

---

амьдралын бүх талд хатуу стандарт, зарчим баримталдаг. Мөнгө хандивлах тухайд бол Бурхан хүн төрөлхтний мөнгө, эд зүйлийг хүсдэггүй гэдгийг Төгс Хүчит Бурханы үгэнд маш тодорхой өгүүлдэг. Мөнгө хандивлах тухай номлох, ямар нэг шалтгаанаар мөнгө хандивлахад хүмүүсийг өдөөн хатгахыг чуулган үл зөвшөөрнө гэж чуулганы ажлын зарчмуудад ч бас тодорхой заасан байдаг. Төгс Хүчит Бурханыг дагаснаас хойш чуулган надаас ганц цент хандивлахыг ч хүсэж байгаагүй. Чуулган мөнгө хандивлахыг хүмүүст уриалдаггүйгээр үл барам, харин ч бүх жинхэнэ итгэгч ах эгч нарт төрөл бүрийн ном, CD болон бусад зүйлсийг үнэ төлбөргүй өгдөг. Одоо ээж маань санхүүгийн хүндрэлд орсон зарим нэг ах эгч нарт туслахын тулд тодорхой хэмжээний мөнгө өгөхийг хүсэж байгаа юм. Ээж үүнийг сайн дураараа хийж байгаа; хэн ч ээжийг албадаагүй. Ямартай ч хэрэгтэй үед нь хүмүүст туслах чинь сайн үйл тул зэмлэх шалтгаан байхгүй, тийм үү?” гэв.

Төгс Хүчит Бурханы үгийг уншиж, эхнэрийнхээ нөхөрлөлийг сонссоны дараа, урьд нь нэг эгчийн надад нөхөрлөж байсан зүйл гэнэт санаанд оров: Төгс Хүчит Бурханы Чуулган шинэ гишүүдээсээ мөнгөн өргөл авдаггүй бөгөөд мөнгө хандивлахыг хүссэн хүн, үнэхээр үүнийг хийхэд бэлэн, хэзээ ч үүндээ харамсахгүй гэдэгтээ итгэлтэй болохын тулд эхлээд хэд хэдэн удаа залбирах ёстой. Хэрвээ тэд өгөхийг хүсэхгүй байвал чуулган яавч хүлээн авахгүй. Үүнийг санасан даруйд надад байсан зарим нэг санаа зовнил, шаналал бага зэрэг намжсан хэдий ч зүрх сэтгэл дэх ээдрээ бүрэн тайлагдаагүй юм. Эхнэр баргар царайлсаар байгааг минь хараад, юу бодож байгааг минь мэдэж байсан тул: “Тэдгээр цуурхалд бүү итгэ. Сатан хүмүүсийг аврах Бурханы ажилд саад учруулж, сүйтгэн, Бурханы өмнө очиж, аврал хүлээн авахад маань саад болохын тулд янз бүрийн хогийн зүйл ярьж, төрөл бүрийн хуурамч гэрчлэл хийдэг. Бурхан ариун бөгөөд хүн төрөлхтний ёрын мууг жигшдэг. Нэр хүнд муутай, эсрэг хүйсийн хүмүүсийн хажууд биеэ яаж зөв авч явахаа мэддэггүй хүмүүсийн тухайд бол Төгс Хүчит Бурханы Чуулган хэзээ ч тэднийг хүлээн авдаггүй. Энэ бол Төгс Хүчит Бурханы маш тодорхой хэлсэн зүйл юм” гэж хэллээ. Тэгээд эхнэр маань Бурханы үгийг нээн, ингэж уншив: **“Долоон аянгын нүргээнээс болж олон хүн өвдөг сөгдөн өршөөл, уучлал эрнэ. Гэвч Нигүүлслийн эрин үе байхаа болино: Энэ нь уур хилэнгийн цаг үе байх болно. Хорон мууг үйлддэг хүмүүсийн хувьд (Миний сонгосон хүмүүсээс бусад завхайрдаг, бохир мөнгөөр наймаалцдаг, эр эмийн хоорондох зааг хязгаарыг зөрчдөг, Миний удирдлагад саад, хор учруулдаг хүмүүс, эсвэл сүнс нь хаагдсан, муу ёрын сүнсэнд эзэмдүүлсэн гэх мэт бүх хүн) нэгийг нь ч зүгээр өнгөрөөж, өршөөлгүй, бүгдийг нь Үхэгсдийн оронд унагаж, үүрд мөхөөнө!”** (“Үг нь махбодоор илэрсэн” номын Христийн эхэн үеийн айлдваруудын “94-р бүлэг”). Хүмүүсийн зүрх сэтгэлд айдас, хүндлэл төрүүлэхийн тулд Төгс Хүчит Бурханы айлдвар сүр жавхлантай, уур хилэнтэй байдаг; энэ нь надад хүний халдахыг тэвчдэггүй

---

Бурханы зөвт зан чанарыг мэдүүлсэн юм. Бурхан садар самуун үйлддэг хүмүүсийг туйлын их үзэн яддаг бөгөөд тэр хүмүүс эцэст нь Бурханы зөвт шийтгэлийг амсана. Үүнийг ойлгоод санаа зовнил минь бага зэрэг намжлаа. Дараа нь эхнэр маань надтай ингэж нөхөрлөв: “Бурхан Хуулийн эрин үед Өөрийн ажлыг хийж байх үед садар самуун авирласан хэнийг ч чулуугаар цохиж алдаг байсан. Энэ нь Бурханы зөвт, сүр жавхлант, уур хилэнт зан чанарыг бүрэн харуулдаг. Хаанчлалын эрин үед эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн харилцааны тухайд бол Бурханы захиргааны зарлиг бүр ч илүү хатуу чанд болсон. Бурханы үгэнд хэлдэгчлэн: **‘Хүн ялзарсан зан чанартайгаас гадна сэтгэл хөдлөлтэй байдаг. Ийм болохоор Бурханд үйлчлэх үед эсрэг хүйсийн хоёр гишүүн хоёулхнаа хамт ажиллах туйлаас хориотой. Ийм үйлдэл хийж байгаад баригдсан хэн боловч гарцаагүй хөөгдөнө, хэнийг ч ялгахгүй’** (Үг нь махбодоор илэрсэн номын “Хаанчлалын эрин үед Бурханы сонгосон хүмүүсийн дуулгавартай дагах ёстой захиргааны арван зарлиг”).”

Эхнэр маань үүнийг чангаар уншиж өгөх үед би 2016 оны хавар тохиолдсон явдлыг санасан юм. Тэр үед би Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг зохих ёсоор судалж амжаагүй байлаа. Би эхнэр болон чуулганы нэг эгчийг өөр муж руу машинаар хүргэж өгч байсан юм. Замдаа эхнэр маань нэг зүйл хийх шаардлагатай болсон тул бид зогсоод, эхнэр маань машинаас бууж, нөгөө эгч ч бас буув. Гадаа хүйтэн, салхитай байсан тул эгч машины хажууд зогсон, дулаацахын тулд хөлөө дэвсэлж байлаа. Би түүнийг машинд суу гэж дуудсан ч тэрээр: “Зүгээр ээ. Би гадаа жаахан зогсмоор байна” гэв. Эхнэр маань ирэх хүртэл нэлээд удаан хугацаа өнгөрсөн бөгөөд түүнийг эргэн ирэхэд л эгч машинд суусан юм. Даарсандаа илт чичирч байгааг нь хараад эхнэр маань түүнээс: “Гадаа маш хүйтэн байна. Та яагаад машинд байж байгаагүй юм бэ?” гэж асуулаа. Эгч хариуд нь: “Эрэгтэй, эмэгтэй хүмүүс хоёулхнаа байж болохгүй, бие махбодоороо хүрч болохгүй гэж заасан захиргааны зарлиг манай чуулганд байдаг. Энэ бол Өөрийн сонгосон хүмүүст тавьдаг Бурханы шаардлагуудын нэг бөгөөд бид хатуу чанд мөрдөх ёстой” гэсэн юм. Би үүнийг сонсоод Төгс Хүчит Бурханы Чуулганы хүмүүс үнэхээр жирийн хүмүүсээс өөр болохыг ухаарсан—ийм хамгийн ялихгүй зүйл дээр ч тэд өөрсдийгөө хянадаг. Энэ явдлыг эргэн санаад би бодит баримтуудыг зохих ёсоор судалж үзэлгүй, интернетийн худал цуурхалд сохроор итгэж байсандаа өөрөө өөрийгөө жигшин, толгойгоо цохихоос өөр яаж ч чадсангүй. Төгс Хүчит Бурханы Чуулганы ах эгч нартай харилцаж байсан бүх үеэ бодож, эсрэг хүйсийн хүмүүсийн дэргэд байхдаа тэд биеэ хэрхэн зөв авч явж байсныг, үг болон үйлдэл нь хэчнээн зөв, зохистой байсныг, хүмүүстэй харьцахдаа хэчнээн зарчимч байсныг эргээд бодоход тэдгээр цуурхал үнэнээс хол зөрүүтэй гэдэг нь илт байв. Энэ мөчид би маш их ичлээ—интернет дэх тэр цуу ярианууд нь бүгд зохиомол зүйл, гүтгэлэг, илт

---

мушгин гуйвуулсан зүйл болж таарсан атал би тэр худал үгсэд сохроор итгэж, Төгс Хүчит Бурхан болон Төгс Хүчит Бурханы Чуулганд эргэлзсэн. Би үнэхээр будилуу мунхаг байв! Тэгээд эхнэр маань үргэлжлүүлэн ийнхүү нөхөрлөв: “Эцсийн өдрүүдэд, хүмүүсийг шүүж, цэвэрлэхийн тулд Бурхан махбод болж, үнэнийг илэрхийлж байгаа нь хүн төрөлхтнийг Сатаны эзэмшлээс бүрэн аварч, биеэ тоосон зан, заль мэх, хууран мэхлэлт, аминч, олиггүй байдал, ёрын муу, бузар булай гэх мэт завхарсан зан чанараас маань биднийг салгаж, амь зан чанараа өөрчлөхөд маань туслахын төлөө байдаг бөгөөд ингэснээр бид жинхэнэ хүний төрхийг амьдран харуулж болох юм. Хүн төрөлхтнийг Сатан гүнээ завхруулсан тул нүглийг ялан дийлэх чадваргүй гэдгийг Бурхан мэддэг; иймээс Бурханы авралыг хүлээн авч байх үедээ Бурханы зан чанарт халдаж, улмаар таягдуулж, шийтгүүлэхээс хүмүүсийг сэргийлэхийн тулд Бурхан итгэгчдийг хяналтад байлгах зорилгоор Хаанчлалын эрин үеийн захиргааны зарлигуудыг гаргажээ. Эдгээр захиргааны зарлигийг зөрчсөн хэн боловч Бурханаар шийтгүүлэх бөгөөд ноцтой зөрчил гаргагчид Бурханы гэрээс хөөгдөж, аврагдах боломжоо алдана. Бурхан тус чуулганд зориулж эдгээр зарлигийг гаргасан нь биднийг Бурханы халдашгүй зөвт зан чанарын талаар бодит мэдлэгтэй болгож, бас биднийг өөрсдийгөө хянаж байх зарлигуудтай болгохын төлөө байдаг. Ийм маягаар бидний бүх зан авирт давж болохгүй хил хязгаар гэж үргэлж байх бөгөөд хэрвээ бид тэдгээр хил хязгаар дотор байх юм бол Сатаны олон уруу таталтаас зайлсхийж чадна. Энэ бол биднийг хамгаалах Бурханы арга зам бөгөөд үүнээс ч илүүтэйгээр, биднийг гэх Бурханы жинхэнэ хайр юм!” Эхнэрийнхээ нөхөрлөлийг сонсонгоо би өөрийн эрхгүй толгой дохиж байгаагаа анзаарав. Улмаар миний зүрх сэтгэл дэх ээдрээ бүрэн тайлагдаж, зүрх сэтгэлийг минь нөмөрсөн зовлон шаналал намжсан юм. Үүнээс хойш би чуулганы цуглаанд дахин оролцож эхэлсэн билээ.

Энэ туршлагын талаар эргэн дурсах болгонд зүрх сэтгэлд минь айдас үргэлж хурдаг. Тэдгээр цуурхал ямар их хор хөнөөл учруулдгийг би харсан бөгөөд тэдгээрт бараг хууртаж, Бурханы эцсийн өдрүүдийн авралыг алдах дөхсөн юм. Нигүүлслийн эрин үед израильчууд ч бас худал цуурхалд автан, Эзэн Есүсийг Мессиагийн ирэлт гэдгийг хүлээн зөвшөөрөөгүй билээ. Тэд Эзэн Есүсийг голж, улмаар Эзэний авралыг алдсан юм. Жинхэнэ итгэлийн замд ийм цуу яриа ямар том саад бэрхшээл болдгийг энэ нь надад ухааруулав! Гэвч Төгс Хүчит Бурханы Чуулган сайн чуулган гэдэг нь илт байхад яагаад үүний талаар ийм олон худал цуурхал, хуурамч буруутгал байдаг юм бэ гэдгийг л би ойлгож чадахгүй хэвээр байлаа. Тиймээс энэ талаар нээлттэй нөхөрлөх гэсэндээ би чуулганы нэг цуглааны үеэр энэ асуултыг ах эгч нарт тавив. Тэд надад чуулганы сайн мэдээний кинонуудын нэг болох “Урхи зангыг сэт цохь” киног үзүүлсэн бөгөөд энэ кино миний төөрөгдлийг бүрэн шийдвэрлэсэн юм. Ах эгч нар дахиад жаахан нөхөрлөснөөр би бүр ч тодорхой ойлгож



---

авлаа. Бурханы ажилд саад учруулж, сүйтгэх зорилгоор цуурхал ашиглах нь Сатаны нийтлэг арга байсаар иржээ. Эзэн Есүсийг ажлаа хийхээр ирэх үед иудейн тэргүүн тахилчид, хуулийн багш нар болон фарисайчууд Бурханы сонгосон хүмүүсийг байнга хянаж байхыг хүссэн тул Эзэн Есүсийн талаар олон худал цуурхал зохиосон байдаг. Тэд Эзэн Есүсийг доромжилж, чөтгөрүүдийг хөөн зайлуулахдаа Беелзебүлийн хүч чадалд найддаг хэмээн хэлж, Цезарьт татвар төлөхийг Эзэн Есүс хүмүүст зөвшөөрдөггүй гэж хуурамчаар буруутгаж, бас Эзэн Есүсийн махбодыг шавь нар нь хулгайлсан бөгөөд Тэрээр дахин амилаагүй гэж худал гэрчлэл хийж байлаа. Хэрэв тэр үед интернет байсан бол шашны тэрхүү удирдагчид Эзэн Есүсийг доромжилж, дайрч давшилж, яллахын тулд бүх худал цуурхал, хуурамч гэрчлэлээ интернетэд байршуулах байсан гэдэгт би итгэлтэй байна. Өнөө үед буюу Хаанчлалын эрин үед Төгс Хүчит Бурхан хүн төрөлхтнийг шүүж, ариусгахын тулд үгийн ажил хийж байгаа; Хятадын засгийн газар, шашны нийгэмлэгийн пасторууд болон ахлагчид Сатаны хэрэгслийн үүрэг гүйцэтгэж байна. Хүмүүсийн хянаж, урхихах зорилгодоо хүрэхийн тулд тэд Төгс Хүчит Бурханыг доромжилж, яллаж байгаа бөгөөд хүмүүсийг будилуулж, мэдэхгүй хэвээр байлгахын тулд цуу яриа, хуурамч гэрчлэл дур зоргоороо зохиож, Төгс Хүчит Бурханы Чуулганы нэр төрийг гутааж байгаа. Биеэ тоосон тэд хүмүүсээр Бурханы эцсийн өдрүүдийн авралын ажлыг орхиулж, Бурханыг эсэргүүцэхэд өөрсдийг нь дагадаг болгож чадна гэж боддог. Сатан үнэхээр маш ёрын муу, жигшмээр юм!

Дараа нь ах эгч нар Бурханы үгээс дахиад хоёр хэсгийг надад уншиж өгөв: **“Газар дээр төрөл бүрийн муу ёрын сүнс амрах газар хайн үүрд тэнүүчилж, идэж болох хүний цогцсыг эцэс төгсгөлгүй хайж байна”** (“Үг нь махбодоор илэрсэн” номын Бүх орчлон ертөнцөд хандсан Бурханы айлдваруудын “10-р бүлэг”). **“Миний талаар хүмүүсийн зүрх сэтгэлдээ тээдэг мэдлэгийг Сатан байнга ховх сорж, бас байнга шүдээ ярзайлган, хумсаа сарвайлгаж, сүүлчийн амь тэмцсэн тулаандаа ордог. Энэ мөчид та нар түүний зальжин ов мэхэнд олзлогдохыг хүсэж байна уу? Та нар Миний ажлын сүүлийн үе шат дуусах энэ мөчид өөрийнхөө амийг таслахыг хүсэж байна уу?”** (“Үг нь махбодоор илэрсэн” номын Бүх орчлон ертөнцөд хандсан Бурханы айлдваруудын “6-р бүлэг”). Төгс Хүчит Бурханы үг бидэнд сүнслэг тулааны тухай үнэнийг буюу Бурханы өмнө очиход нь хүмүүст саад учруулж, хүмүүсийг залгих зорилгоо биелүүлэхийн тулд Сатан бүх төрлийн заль мэх хэрэглэдэг тухай хэлдэг гэж тэд бас надад нөхөрлөсөн юм. Үүнд интернетээр худал цуурхал, хуурамч гэрчлэл тарааж, итгэгчдийг шашны удирдагчдаар дамжуулан зовоож, айлган сүрдүүлж, гэр бүлийн гишүүдээр нь шахалт дарамт үзүүлж, Төгс Хүчит Бурханыг дагахыг нь болиулах зэрэг багтдаг. Товчхондоо биднийг эргэлзүүлж, Бурханыг үгүйсгэх юм уу Түүнээс холдоход хүргэх аливаа зүйл

---

Сатанаас ирдэг. Хэрвээ бид үнэнийг эрж хайж чадахгүй бол Сатаны заль мэхийг хэзээ ч нэвт харж чадахгүй бөгөөд Бурханы авралыг хүртэх боломжоо амархан алдаж, Сатантай хамт гай гамшигт живнэ. Бурханы удирдлагын ачаар, Төгс Хүчит Бурханы Чуулганы сайн мэдээний киног үзэж, ах эгч нарын нөхөрлөлийг сонссоноор дамжуулан би Сатаны ёрын муу, жигшүүрт мөн чанарыг илүү тодорхой харж, Сатаны заль мэхийг нэвт харж чадсан юм.

Төгс Хүчит Бурханыг дагаснаас хойш би үнэхээр чөлөөлөгдөж, эрх чөлөөг олж авсан билээ. Одоо хүндрэл бэрхшээлтэй тулгарах бүрдээ би Бурханы үгийг уншиж, Бурханд залбирч, хэрэгжүүлэлтийн замыг олоход минь туслаач гэж гуйж чадна. Чуулганы ах эгч нар бүгд Бурханы шаардлагыг мөрдөж, үнэнч шударга хүмүүс болохоор зорьдог. Тэдний хоорондын харилцаа төвөгтэй бус, нээлттэй байдаг; тэд бие биедээ тусалж, дэмждэг. Хэн нэгэн намайг доош хийж, хуурч, луйвардах вий гэж санаа зовох хэрэггүй. Би үнэхээр аз жаргалтай, сэтгэл хангалуун байгаа ба энэ бол миний үргэлж хүсэж байсан амьдрал мөн.

## 46. Би гэртээ ирлээ

Чу Кийнь Пон, Малайз

Би Эзэнд арав гаруй жил итгэсэн бөгөөд чуулганд хоёр жил үйлчилж, дараа нь ажиллахаар гадаад явахдаа чуулганыг орхисон юм. Би Сингапур зэрэг олон газар очиж, их мөнгө олсон боловч хүчтэй нь хүчгүйгээ дийлж, хүн бүр нэг нэгэнтэйгээ өрсөлдөн, бие биеийнхээ эсрэг явуулга хийж, хүн бүр нэгнээсээ илүү урваж тэрслэх гэж хичээдэг орчин үеийн нийгэмд амьдарч байлаа. Би хүн хоорондын тоо томшгүй олон ээдрээтэй харилцаатай тулгарч, үргэлж бусдаас сэрэмжилдэг байв. Тэд ч бас надаас сэрэмжилдэг байсан нь зүрх сэтгэлийн минь гүнд, гишгэх тогтвортой газар олж чадахгүй мэт мэдрэмж төрүүлдэг байлаа. Ийм маягийн амьдрал бие, сүнсийг минь туйлдуулж орхив. Надад тайтгарал өгдөг цорын ганц зүйл гэвэл судрын зарим хэсгийг эш татсан, миний авч явдаг өдрийн тэмдэглэл л байлаа. Заримдаа би тэдгээрийг уншиж, сүнсэн дэх хоосролоо нөхдөг байв. Чуулганы цуглаанд би олон жил яваагүй боловч Эзэнд чин сэтгэлээсээ үйлчилж чадах чуулган олох гэсэн нэг л зүйл өнгөрсөн жилээс эхлэн толгойд минь эргэлдэх боллоо. Дараа нь би чөлөөт цагаа ашиглан Малайз дахь том, жижиг чуулгануудад явж үзсэн боловч дандаа баяртай очоод, сэтгэл дундуур буцдаг байв. Дотор минь ямар нэг зүйл дутагдаж байгаа мэт үргэлж санагдавч яг юу болохыг нь үгээр илэрхийлж ер чаддаггүй байлаа. Энэ зөрчилдөөнтэй тулгараад би өөр нэгэн туйлд хүрч, зүгээр л интернетээр видео тоглоом тоглож, кино үзэн, заримдаа үүр цайтал тоглох юм уу кинонуудыг ар араас нь

---

угсруулан үздэг байлаа. Ажил, амралтын минь хуваарь замбараагаа алдсан юм. Ийм зүйл хийж эхлэх үедээ би Эзэн надад сэтгэл дундуур байгааг бага зэрэг мэдэж байсан боловч аажмаар мэдрэлээ алдлаа. Яг тэр үед би гар утсаа алдсан юм. Тухайн үед би дотроо энэ талаар гомдоллож байв. Гар утас минь алга болж, үүний хамтаар олон мэдээлэл алдагдсан бөгөөд Фэйсбүүкт нэвтрэх аргагүй болов. Гаднаа энэ нь муу зүйл байсан ч амьдралын минь эргэлтийн цэг болно гэж би огт төсөөлсөнгүй. Энэ нь яг л “Сохорсон биш завшив” хэмээх хуучны үгтэй адил байсан юм.

2017 оны эхээр би шинэ гар утас худалдан авав. Хоёрдугаар сарын сүүлчээр нэгэн өдөр Фэйсбүүкт нэвтэрснийхээ дараа би нэг хэрэглэгчийн англи хэл дээрх профайлын цагийн хүрдэн дээр санамсаргүй дарсан бөгөөд нийтлэлүүд дээр Судрын бичвэр байгааг олж харлаа. Би бас Библийн бус эшлэлүүдийг харсан боловч тэдгээр нь намайг үнэхээр их зоригжуулж, зүрх сэтгэлийг минь татав. Дараагийн хэд хоногт би Фэйсбүүкийн энэ хэрэглэгчид ихээхэн анхаарал хандуулж, бүр зарим үгийг нь эрж хайн хэсэг хугацааг өнгөрүүлээ. Эцэст нь би өөрийн сонирхсон нийтлэлийг уншиж дууссан юм. Энэ нийтлэлийн гол агуулга нь Эзэн Есүсийн **“Намайг, ‘Эзэн минь, Эзэн минь’ гэсэн бүхэн тэнгэрийн хаанчлалд орохгүй”** (Матай 7:21) хэмээн хэлдэг Судрын хэсгийн тайлбар мөн гэдгийг би бүгдийг нь уншсанахаа дараа мэдэж авсан юм. Энэ нь нэлээд өвөрмөц тайлбар бөгөөд урам зориг, гэрлээр дүүрэн байгааг нь би мэдэрлээ. Тэр хүнийг найзаар нэмээгүй байсан учраас цагийн хүрдэн дээрх өөр нийтлэлийг нь харж чадахгүй байв. Гэхдээ Фэйсбүүкийн энэ хэрэглэгч Өмнөд Солонгост байдаг, Сюзан гэх нэртэй эгч гэдгийг цагийн хүрдэн дээрээс нь харж чадсан юм. Би түүнд найз болох хүсэлт илгээсэн боловч эгч тухайн үед интернетэд байхгүй байсан байж магадгүй бөгөөд миний хүсэлтийг тэр дор нь хүлээж авсангүй. Хоёр хоногийн дараа би Өмнөд Солонгост байдаг өөр нэг Христэд итгэгч, Чи Фэй гэх Фэйсбүүк нэртэй, хятадаар ярьдаг хүнийг найзаар нэмлээ. Тэрээр өөрийн итгэлийн зарим нэг туршлагын талаар надтай ярилцсан бөгөөд эгчийн хэлсэн зүйл надад үнэхээр таалагдсан юм. Гайхалтай нь, Чи Фэй эгч ч бас Сюзан эгчтэй найз байсан тул энэ удаа бид хоёр бие биеэ найзаар нэмэв. Тэдний Фэйсбүүкийн нийтлэлийг уншиж, хааяа нэг ярилцсанаар би Бурханд итгэх талаар ихийг ойлгосон хүмүүс гэдгийг нь мэдэрлээ.

Тэдэнтэй Библийн талаар хэлэлцэж, амьдралынхаа зарим зүйлийг ярилцан хэсэг хугацааг өнгөрөөсний дараа би амьдралын минь зарим нэг санаа зовоосон зүйлийг засаж залруулахад туслах онцгой арга тэдэнд байдаг бөгөөд хэлдэг зүйл нь эрүүл ухаан, ойлголт арвинтай юм гэж бодогдов. Тэд бусдаас өөр гэдгийг би шуудхан харж чадаж байлаа. Би тэдэнтэй холбоотой байснаар дотроо илүү тогтвортой, тайван болсон бөгөөд тэднийг төдийлөн сайн таньдаггүй байсан боловч энгийн, шударга байдлаас нь үүдэн өөрөө ч

---

мэдэлгүй дотнын найзаа гэж тооцдог болсон байв. Би тэдэнтэй зүрх сэтгэлээ хуваалцахыг хүсдэг байсан. Аажмаар би амьдралдаа зарим нэг өөрчлөлт хийж эхэллээ.

Долоо хоног орчмын дараа 3-р сарын 11-ний орой намайг Фэйсбүүкт ороход Сюзан интернетэд байж байлаа. Эхлээд би түүнтэй ажлынхаа зарим зүйлийн талаар ярилцаж, дараа нь үйлчлэх чуулган олох хүсэлтэйгээ хэлж, түүний саналыг сонсмоор байна гэлээ. Сюзан эгч надад, бүх зүйлийг Бурхан зохицуулж, захирдаг гэж хэлсэн бөгөөд энэ талаар Бурханд илүү их залбирч, эрж хайх хэрэгтэй гэлээ. Бүх зүйлд Бурханы тогтоосон цаг гэж байдаг, бид бүгд хүлээж, дуулгавартай байж сурах хэрэгтэй гэж тэр хэлсэн юм. Үүний дараа тэрээр олон чуулганы өнөөгийн нөхцөл байдлын талаар ярилаа: Номлогчдод номлох зүйл огт байхгүй, зарим чуулганд цуглаанд оролцож байгаа ямар ч хүн байхгүй, мөн цуглаанд олон хүн оролцлоо ч гэсэн ердөө мөнгө олох тухай, бизнесийн холбоо сүлбээ тогтоох тухай, итгэлтэй ямар ч холбоогүй бусад зүйлийн талаар ярьж байгаа. Эдгээр нь үнэндээ чуулганд Ариун Сүнсний ажил байхгүй болж, хоосорсон гэдгийг харуулдаг гэж эгч хэллээ. Энэ бүгдийг хэлэхийг нь сонсоод надад адилхан сэтгэгдэл төрсөн юм. Урьд нь намайг чуулганд үйлчилж байх үед тэндхийн хамтран зүтгэгчид алдар нэр, эд хөрөнгийн төлөө үзэлцэж, өөр хоорондоо тэмцэлдэн, явуулга хийж, нэгнийхээ нэр хүндэд халдаж, өөрсдийн өчүүхэн нутаг дэвсгэрийг ноёрхохоор оролдож байсан. Бүр завхайрах тохиолдол ч байсан. Эдгээр зүйл ээлж дараалан тохиолдохыг хараад би сэтгэлээр унаж, эгдүүцсэн юм. Тухайн үед пастор болон зарим хамтран зүтгэгчдээс энэ талаар юу гэж бодох ёстойг асуухад минь тэд тодорхой тайлбарлаж чадаагүй. Намайг маш удаан хугацаанд зовоож байсан энэ асуудлыг Сюзан эгч шийдвэрлэж өгнө гэж би хэзээ ч бодоогүй юм. Зүрх сэтгэлдээ би үгээр илэрхийлэх аргагүй аз жаргалыг мэдэрч байв.

Бид бас тухайн үед болж байсан бүх төрлийн гамшиг, дайны тухай сэдвийг судалсан ба хаа сайгүй гамшиг нүүрлэн, дайн болох гэж байгаа тэмдгүүдээс үзвэл Эзэний хоёр дахь ирэлтийн тухай библийн зөгнөлүүд үндсэндээ бүгд биелсэн бөгөөд Эзэн удахгүй ирэх байв. Энэ нь, өдөр интернетээр танилцсан итгэгч Эзэнийг 1991 онд эргэн ирсэн гэж хэлснийг сануулсан бөгөөд үүнд би нэлээд эргэлзэж байсан юм. Би Сюзанаас үүнийг асуулгүй өнгөрч чадсангүй. Сюзан надаас энэ тухай юу гэж бодож байгааг минь асуухад би: “Тийм байх боломжгүй. Эзэн эргэн ирэхдээ үүлэн дээр буун ирж, хүн бүрд үзэгдэнэ. Гэтэл бид Эзэний үүлэн дээр бууж ирэхийг хараагүй байхад Эзэнийг аль хэдийн эргэн ирсэн гэж хүмүүс яаж хэлж чадаж байна вэ?” гэж хариулав.

Сюзан ингэж хариуллаа: “Ах аа, та Библийг тун сайн уншсан хүн. Библийн үгийг няхуур судалбал хариултаа олно гэдэгт тань эргэлзэхгүй байна. Үнэндээ Эзэний хоёр дахь эргэн ирэлтийн тухай олон өөр зөгнөл байдаг. Библийн зөгнөлүүд гол төлөв хоёр төрөлд

---

хуваагддаг гэдгийг бид бүгд харж болно. Нэг нь таны хэлсэнчлэн Эзэн үүлэн дээр буун ирж, хүн бүрд мэдэгдэн, бүгд Түүнийг харж чадна гэх зөгнөл юм. Нөгөөх нь Эзэн нууцаар ирж, энэ талаар тодорхой бүлэг хүмүүс л мэдэх тухай зөгнөдөг. Энэ нь яг Эзэн Есүсийн **‘Харагтун, Би хулгайч мэт ирнэ’** (Илчлэл 16:15). **‘Шөнө дөлөөр хашхирах дуу гарч, “Хараач, Сүйт залуу ирлээ; Түүнийг угтан авцгаа” гэлээ’** (Матай 25:6) гэж хэлсэнтэй адил юм. ‘Хулгайч мэт’, бас ‘шөнө дунд хашхирах чимээ гарав’ гэдэг нь чимээгүй, хөдөлгөөнгүй, хэнд ч мэдэгдэхгүй байна гэсэн утгатай. Тэнгэр дуугарахгүй, газар доргихгүй бөгөөд энэ нь бүх хүнд илэрхий зүйл биш юм. Цөөн тооны хүн л Эзэний дуу хоолойг сонсож, Түүнийг угтаж чадна. Энэ бол Эзэний нууцаар ирэх тухай зөгнөл юм. Хэрэв бид Эзэн үүлэн дээр ил тод буун ирэх тухай зөгнөлтэй л зууралдан, нууцаар ирэх тухай зөгнөлийг хэрэгсэхгүй бол энэ нь зөв зүйтэй юу? Энэ маягаар бид Эзэний дуу хоолойг сонсож чадалгүй, Эзэнийг угтан авч, тэнгэрийн хаанчлал руу өргөгдөх боломжоо алдах биш үү?”

Сюзаны асуулт намайг хэлэх үггүй болголоо. Би энэ хоёр хэсгийг ахин дахин уншаад, “Библид зөрчилдөөн байж болох уу? Үгүй, үгүй, үгүй! Яаж болох юм бэ? Гэхдээ үнэндээ, Эзэний эргэн ирэх тухай Библид үнэхээр хоёр өөр төрлийн зөгнөл байна! Үүнийг яаж тайлбарлаж болох вэ?” гэж бодов. Би будилсандаа эгчээс цааш нь нөхөрлөхийг хүслээ. “Библийн зөгнөлүүдээс харвал Эзэний хоёр дахь ирэлт хоёр өөр арга замаар тохиолдоно. Нэг нь нууцаар ирэх, нөгөө нь ил тод илрэх явдал. Эцсийн өдрүүдэд Бурхан дэлхий ертөнц дээр хүний Хүүгийн бие махбодтой болох бөгөөд гаднаа Христ яг л Эзэн Есүс бие махбодтой болсон шиг эгэл, жирийн хүн мэт харагдана. Тэрээр хэвийн хүн чанартай байж, хооллож, хувцаслаж, амьдарч, яг л эгэл хүн шиг үйлдэнэ. Тэгээд хүмүүсийн дунд амьдрах бөгөөд Түүний Бурхан гэдгийг хэн ч харахгүй, мөн жинхэнэ ялгамж чанарыг нь хэн ч мэдэхгүй тул бидний өнцгөөс үүнийг нууц гэж үздэг. Хүний Хүү ажиллаж, үг хэлж эхэлмэгц Бурханы дуу хоолойг сонсож чаддаг хүмүүс хүний Хүүгийн үг, ажлаар дамжуулан Бурханы зан чанарын илэрхийллийг харах болно. Бурханы сүр хүч, эрх мэдлийг тэд харж, Эзэн эргэн ирсэн гэдгийг ойлгоно. Энэ нь Эзэн Есүсийн: **‘Миний хонин сүрэг Миний дуу хоолойг сонсдог, Би тэднийг мэддэг бөгөөд тэд Намайг дагадаг’** (Иохан 10:27) хэмээх зөгнөлийг биелүүлнэ. Бурханы дуу хоолойг ялгаж таних чадваргүй хүмүүс гадаад дүр төрхөд нь үндэслэн бие махбодтой болсон Бурханыг эгэл хүн гэж үзэх нь гарцаагүй. Тэд эцсийн өдрүүдийн Христийг үгүйсгэж, голж, тэр ч бүү хэл эсэргүүцэж, буруутгаж, доромжлох болно. Яг л Эзэн Есүс ажлаа хийхээр ирсэн үетэй адилхан—гаднаа Тэр хүний Хүүгийн эгэл жирийн дүр төрхтэй байсан тул ихэнх хүн Түүнийг үгүйсгэж, эсэргүүцэж, яллахад хүрсэн. Ердөө цөөн бүлэг хүмүүс л Эзэн Есүс бол бие махбодтой болсон Христ мөн гэдгийг үг, ажлаар нь дамжуулан таньсан. Тэд Түүнийг

---

Бурханы илрэл мөн хэмээн таньж, улмаар Эзэн Есүсийг даган, золин авралыг нь хүлээн авсан” гэж Сюзан хэллээ. Эгчийн нөхөрлөлийг сонсоод, энэ нь бүгд бодит баримт байсан учраас нэлээд ортой юм байна гэж санагдав. Эзэн Есүсийг ажлаа хийхээр ирэхэд яг ийм байлаа. Гэхдээ энэ тухай дахин бодоод үзэхэд, Эзэн Есүс эргэн ирэхдээ үүлэн дээр буун ирж, бүгдэд мэдэгдэнэ гэж Илчлэлд бичсэн байдаг бөгөөд пастор, ахлагч нар бүгд ингэж номлодог байв. Үүнийг бодоод би Сюзан эгчээс: “Хоёр дахь ирэлт нь үүлэн дээр байна гэж Эзэн Есүс Өөрөө хэлсэн. Яахаараа бие махбодтой болдог билээ? Библийн тэдгээр үгийг та яаж үгүйсгэж чадаж байна аа?” гэж итгэлтэйгээр асуулаа. Сюзан эгч: “Та Библийг л тун анхааралтай судлах хэрэгтэй, тэгвэл Эзэн Есүс бие махбодтойгоор эргэн ирнэ гэж тодорхой зөгнөсөн олон газар байгааг олж мэдэх болно” гэж хэллээ. Сюзан эгчийн хэлсний дагуу би Судраас зарим нэг хэсгийг олоод, уншиж эхлэв: **“Тиймээс та нар ч бас бэлэн бай: учир нь та нарын бодоогүй цагт хүний Хүү ирнэ”** (Лук 12:40). **“Учир нь тэнгэрийн нэг хязгаараас нөгөө хязгаар хүртэл цахилдаг аянга шиг; хүний Хүү ч бас Өөрийн өдөртөө тийнхүү байх болно. Гэхдээ Тэр эхлээд олон зовлон туулах ёстой бөгөөд энэ үеийнхэнд гологдоно”** (Лук 17:24–25).

Судрын эдгээр хэсгийг уншиж дууссаны дараа Сюзан эгч ингэж хэллээ: “Энэ бүх зөгнөлд ‘хүний Хүүгийн ирэлтийг’ болон ‘хүний Хүү ч бас тийм байх болно’ гэж дурддаг. ‘Хүний Хүү’ бол хүнээс төрсөн, хэвийн хүн чанартай. Ехова Бурхан нь Сүнс бөгөөд хүний Хүү гэж дуудагдаж болохгүйтэй адил хэрвээ Тэр сүнсэн биеэр үзэгдсэн бол хүний Хүү гэгдэхгүй байсан. Хүмүүс мөн тэнгэрэлчүүдийг харсан, тэд бол сүнслэг зүйлс бөгөөд хүний Хүү гэж нэрлэгдэж бас л чадахгүй. Хүний дүрстэй боловч сүнслэг бүх зүйлийг хүний Хүү гэж нэрлэж болохгүй. Бие махбодтой болсон Эзэн Есүс нь Бурханы Сүнс бие махбодтой болж, Сүнс махбодод биелсэн явдал байсан учраас Түүнийг хүний Хүү, Христ гэж дууддаг. Тэрээр эгэл, жирийн хүн болж, хүн төрөлхтний дунд амьдарсан. Эзэн Есүс хүний Хүү, бие махбодтой болсон Бурхан байсан учраас дахин хүний Хүүгийн дүрээр эргэж ирнэ гэж хэлсэн нь сүнслэг хэлбэрээр бус, хүний Хүүгийн бие махбодоор дахин ирнэ гэх утгатай байсан. Түүнчлэн Библид: **‘Гэхдээ тэр эхлээд олон зовлон туулах ёстой бөгөөд энэ үеийнхэнд гологдоно’** хэмээсэн байдаг. Эзэн бие махбодтой болсон байдлаар дахин ирнэ гэдгийг энэ нь улам нотолдог. Бодоод үз: Эзэн бие махбодтой бололгүй, сүнслэг биеэр эргэн ирээд бидэнд харагдсан бол төдий л зовохгүй, энэ үеийнхэнд бүр ч гологдохгүй байсан. Бурханы Сүнсийг хэн голж зүрхлэх юм бэ? Сүнсийг зовоож хэн чадах юм бэ? Иймээс Эзэн бие махбодтойгоор эргэн ирэх үү, сүнслэг биед ирэх үү гэдэг нь ойлгомжтой байна биш үү?”

“Хүний Хүү” гэх үгийг уншаад би гайхширч орхив. Би урьд нь “хүний Хүү”-гийн тухай асуултыг бодож үзсэн боловч ер тодорхой ойлгоогүй юм. Сюзан эгчийн

---

тайлбарласан зүйл миний бүх эргэлзээг тайлж, энэ тухай сонсоод би сэтгэл хөдлөлдөө автлаа. Орой болсон учраас бид баяртай гэгцгээгээд, интернетээс гарцгаав. Тэр шөнө миний сэтгэл хөдөлсөн бөгөөд нэлээд орой болтол унтсангүй. Эзэнд ийм олон жил итгэж ирсэн атлаа ийм гайхалтай нөхөрлөл хэзээ ч сонсоогүй тухайгаа би бодлоо. Би мэл гайхсан бөгөөд зүрх сэтгэлд минь үгээр илэрхийлэх аргагүй жаргалтай тодорхой байдал мэдрэгдэж байв.

Дараа өдөр нь буюу 3 дугаар сарын 12-нд би үл ялиг итгэл найдвар болон үгээр илэрхийлшгүй догдлол мэдэрч байв. Өнгөрсөн шөнө Сюзантай хүний Хүү болон бие махбодтой болох талаар гол төлөв хэлэлцсэнээс энэ нь үүдэлтэй байв. Би хүний Хүү болон бие махбодтой болохын хоорондох холбоог тогтоож, Эзэн Есүс бол бие махбодтой болсон Христээс өөр хэн ч биш гэдгийг онолын хувьд мэдэж байсан боловч бие махбодтой болох гэдэг үнэндээ юу болох, Христ гэж юу болох, Бурхан бие махбодтой болсон гэдгийг ямар үндэслэлээр баттай хэлж болох гэх мэт асуултуудад хариулт авахыг хүссээр байсан юм. Гэвч Сюзан бид хоёр хоёулаа өдрөөр ажиллаж, орой л завтай байдаг тул цаг жаахан хурдан өнгөрөөсэй гэж л найдаж суув.

Эцэст нь орой болж, бид интернетэд холбогдлоо. Холбогдсоны дараа Сюзан эгчээс асуусан эхний асуулт маань бие махбодтой болох тухай байв. Тэр надад Төгс Хүчит Бурханы үгээс зарим хэсгийг илгээсэн бөгөөд тэдгээрийг уншихыг надаас хүсэв. Тэгээд би уншиж эхэллээ: **“Бие махбодтой болох” нь Бурхан махбодоор илрэх явдал; Бурхан Өөрийн бүтээсэн хүн төрөлхтний дунд махбодын дүрээр ажилладаг. Иймээс, бие махбодтой болохын тулд Бурхан эхлээд махбод буюу хэвийн хүн чанартай махбод байх ёстой; энэ нь хамгийн үндсэн урьдач нөхцөл юм. Үнэндээ, Бурхан бие махбодтой болохын цаад учир нь Бурхан махбодод амьдарч, ажилладаг бөгөөд чухам мөн чанартаа Бурхан махбод болж, хүн болдог**” (Үг нь махбодоор илэрсэн номын “Бурханы оршдог махбодын мөн чанар”). **“Бие махбодтой болсон Бурханыг Христ гэдэг ба Христ бол Бурханы Сүнсний өмссөн махбод билээ. Энэхүү махбод нь махан биетэй ямар ч хүнтэй адилгүй. Христ бол мах, цуснаас бүрдсэн бус, харин Сүнсний биелэл учраас ийм ялгаа байгаа юм. Түүнд хэвийн хүн чанар, бүрэн дүүрэн бурханлаг чанарын аль аль нь бий. Түүний бурханлаг чанарыг ямар ч хүн эзэмшдэггүй. Түүний хэвийн хүн чанар нь махбод дахь бүх хэвийн үйл ажиллагааг хангадаг байхад бурханлаг чанар нь Бурханы Өөрийн ажлыг гүйцэтгэдэг**” (Үг нь махбодоор илэрсэн номын “Христийн мөн чанар бол Тэнгэрлэг Эцэгийн хүсэлд дуулгавартай байх явдал юм”). **“Бие махбодтой болсон Бурхан Тэрбээр Бурханы мөн чанарыг эзэмшинэ, бие махбодтой болсон Бурхан Тэрбээр Бурханы илэрхийллийг эзэмшинэ. Бурхан махбод болдог тул хийхээр зорьж буй ажлаа авчирна, мөн Бурхан махбод болдог тул Өөрийн юу болохыг**

---

илэрхийлж, хүнд үнэнийг авчирч, амь хайрлаж, замыг заан харуулж чадна. Бурханы мөн чанаргүй махбод нь харваас бие махбодтой болсон Бурхан биш; үүнд эргэлзэх зүйл үгүй. Хэрвээ хүн, Бурханы махбод болсон бие мөн эсэхийг судалж шинжлэхээр зорьж байгаа бол Түүний илэрхийлдэг зан чанар, хэлдэг үгээс үүнийг нотлох ёстой. Өөрөөр хэлбэл, Бурханы махбод болсон бие мөн эсэх, үнэн зам мөн эсэхийг нотлохын тулд хүн Түүний мөн чанарт үндэслэн ялган таних ёстой. Иймээс Бурханы махбод болсон бие мөн эсэхийг тодорхойлох гол түлхүүр нь гадаад дүр төрхөөс илүүтэйгээр Түүний мөн чанарт (Түүний ажил, Түүний айлдвар, Түүний зан чанар болон өөр олон талд) оршдог” (Үг нь махбодоор илэрсэн номын Өмнөх үг). Уншиж дууссаны дараа, эдгээр үг бие махбодтой болохын нууцыг маш тодорхой тайлбарласан, тэр дундаа Христийг “Бие махбодтой болсон Бурханыг Христ гэдэг” гэж тодорхойлон, маш сайн тайлбарласан санагдлаа. Энэ тодорхойлолт маш тодорхой, энгийн атлаа уран яруу байв! Би Эзэнд арав гаруй жил итгэсэн боловч Есүсийг Христ гэж л мэддэг байсан болохоос Эзэн Есүсийг яагаад Христ гэж хэлдэг тухай үнэний нууцын ийм талуудыг хэзээ ч ойлгож байгаагүй юм. Үнэндээ бидний Христ гэж нэрлэдэг зүйл нь бие махбодтой болсон Бурхан гэдгийг, мөн Христ бол Бурханы бие махбод болсон Нэгэн гэдгийг эгчийн надад явуулсан Бурханы үгийн хэсгүүдээс ойлгож авсан юм. Эдгээр үгийг би маш анхааралтай эргэцүүлсэн бөгөөд эргэцүүлэх тусам миний зүрх сэтгэл улам цэлмэсэн билээ.

Дараа нь Сюзан эгч, эдгээр нь Төгс Хүчит Бурханы үг гэж хэлсэн юм; бас Бурханы үг бол үнэн, Бурхан Өөрөө л үнэнийг илэрхийлж чаддаг гэж ч хэлэв. Эгчийг Төгс Хүчит Бурханы Чуулганд харьяалагддаг байж магадгүй гэж өмнө нь таамаглаж байсан болохоор энэ нь надад бүхэлдээ гэнэтийн зүйл байгаагүй боловч эгчийг “Төгс Хүчит Бурхан” гэх үгийг дурдах үед би хормын турш гөлөрч орхилоо. Энэ чуулганы талаар би интернетээс зарим нэг цуу яриа уншсан юм. Би өөрийгөө зөвхөн Христэд итгэгч гэж үзэж, Бурханыг зүрх сэтгэлдээ хүндлэх нь миний үүрэг гэж боддог учраас асуудлын үнэн мөнийг ойлголгүйгээр ямарваа хөнгөн хуумгай дүгнэлтэд хүрэхийг хүссэнгүй. Энэ нь үгээрээ нүгэл үйлдэж, Бурханд халдахаас зайлсхийхийн төлөө байлаа. Түүнчлэн би сүүлийн хэдэн өдөр ингэж бодож байв: Сюзан эгч бид хоёр нэлээд хэдэн удаа ярилцсан, тэгээд би хэнтэй ярьж байгаагаа харж чадахгүй байсан ч эгчийн надад нөхөрлөсөн үнэн нь миний асуудлыг бас л шийдвэрлэж чадсан. Бидний хэлэлцүүлэг болон эгчийн цагийн хүрдэн дээрээ тавьсан нийтлэлүүдийг уншсанаар дамжуулан Чи Фэй тэр хоёр хоёулаа чин үнэнч, дулаахан сэтгэлтэй, сайн хүмүүс гэж би бодсон юм. Тэдний нөхөрлөлийн агуулга миний хувьд үнэхээр сургамжтай, ашиг тустай байлаа. Модыг жимсээр нь мэддэг; сайн мод сайн жимс өгдөг бол муу мод муу жимс өгдөг гэж Библид бичигдсэн байдаг. Иймээс Сюзан болон Чи Фэй эгчтэй холбогдсоноор би зүрх сэтгэл дэх эргэлзээ, болгоомжлолоо аажмаар



---

орхиж, үргэлжлүүлэн нөхөрлөөч гэж Сюзанаас хүслээ.

Сюзан эгч ингэж хэлэв: “Тэрээр бие махбодтой болсон Бурхан учраас Түүнд Бурханы илэрхийлэл байдаг, өөрөөр хэлбэл, Тэрээр үг айлддаг. Эцсийн өдрүүдийн бие махбодтой болсон Бурхан хүмүүсийг шүүж, цэвэрлэж, аврахын тулд гол төлөв үнэнийг илэрхийлэхээр ирсэн юм. Эргэн ирсэн Эзэний дуу хоолойг сонсдог, үүнийг эрж хайн, хүлээн зөвшөөрч чаддаг бүх хүн бол Эзэнтэй хамт зоогт оролцдог ухаалаг охид бөгөөд энэ нь Эзэн Есүсийн айлдсан **‘Шөнө дөлөөр хашхирах дуу гарч, “Хараач, Сүйт залуу ирлээ; Түүнийг угтан авцгаа” гэлээ’** (Матай 25:6) хэмээх зөгнөлийг биелүүлдэг. Ухаалаг охид Бурханы дуу хоолойг сонсож, Түүнтэй уулзахаар гардаг. Тэд өөрсдөө мэдэлгүй Бурханы сэнтийн өмнө өргөгдөж, Эзэнтэй нүүр тулж учран, эцсийн өдрүүд дэх Бурханы шүүлт, цэвэрлэлтийг хүлээн зөвшөөрдөг. Бурханы үгийн шүүлтээр тэдний завхарсан зан чанар өөрчлөгдөж, ариусдаг ба Бурхан тэднийг гамшгаас өмнө ялагч болгодог. Одоо Төгс Хүчит Бурхан хүмүүсийг аварч, төгс болгохын тулд нууцаар ажиллах үе шатандаа явна. Бүлэг ялагчид бий болмогц Бурханы махбод болсон бие дэх нууц ажил нь дуусаж, дэлхий ертөнцөд гамшиг нүүрлэнэ. Бурхан сайныг шагнаж, мууг шийтгэж эхлэх бөгөөд дараа нь дэлхийн бүх улс үндэстэн, хүн ардад Өөрийгөө мэдэгдэнэ. Тэр үед Эзэн үүлэн дээр бууж ирэх тухай Илчлэл 1:7 дахь зөгнөл биелнэ: **‘Харагтун, Тэр үүлсийн хамт ирнэ; нүд бүр Түүнийг харна, Түүнийг жадалсан хүмүүс ч бас харна: газар дэлхийн бүх овог Түүнээс болж гашуудна’** (Илчлэл 1:7). Эзэн үүлэн дээр буун ирж, бүх хүнд өөрийгөө харуулж байхыг хүмүүс хараад магнай хагартал баярлана гэж үндэслэлтэйгээр хэлж болох юм. Гэхдээ сударт газар дэлхийн бүх овог цурхиран уйлна гэсэн байдаг. Яагаад тэр вэ? Учир нь Бурхан ил тод үзэгдэхэд Бурханы махбод болсон бие дэх авралын нууц ажил аль хэдийн дууссан байх бөгөөд Бурхан сайныг шагнаж, мууг шийтгэх ажлаа эхэлнэ. Тэр үед Бурханы нууц ажлыг голсон бүх хүн аврал хүртэх боломжоо бүрмөсөн алдаж, Түүнийг шархлуулан, эцсийн өдрүүдийн Христ, Төгс Хүчит Бурханыг эсэргүүцэн, ялладаг байсан хүмүүс өөрсдийнх нь эсэргүүцэж, ялласан Төгс Хүчит Бурхан бол эргэн ирсэн Эзэн Есүсээс өөр хэн ч биш байсныг харах болно. Тэр үед тэд өөрсдийгөө зүхэж, уйлан, шүдээ хавирахгүй байж яаж чадах билээ? Энэ бол **‘газар дэлхийн бүх овог Түүнээс болж гашуудна’** хэмээх үгийн нөхцөл байдал юм.”

Эгчийн нөхөрлөлийг сонсоод надад байсан сэтгэл ханаж, догдлох мэдрэмж эргэн ирлээ. Би хуучин чуулганыхаа гишүүн байх үед эдгээр хэсгийг үнэндээ ойлголгүй, Эзэн үүлэн дээр эргэн ирж, бүгдэд мэдэгдэнэ гэж бодон, шууд утгаар нь л ойлгож байсан юм. Бурхан эхлээд хүнийг шүүж, аврах ажлын үе шатыг хийхийн тулд нууцаар ирдэг гэдгийг би тэгэхэд л эцэст нь ойлгосон билээ. Бүлэг ялагчдыг бүтээмэгцээ Тэрээр дэлхийн бүх улс үндэстэн, хүн ардад ил тод үзэгдэх болно. Хэрвээ бид Эзэн эргэн ирэхдээ үүлэн дээр бууж

---

ирнэ гэх санаатай сохроор зууралдаж, Бурханы махбод болсон бие дэх нууц ажлыг хүлээн авахаас татгалзан, Эзэн үүлэн дээр ил тод бууж ирэхийг хүлээсэн бол хүн төрөлхтнийг аврах Бурханы ажил аль хэдийн дууссан байх учраас тэр үед бид шууд там руу явах болно. Удирдамжийнх нь төлөө Эзэнд талархъя. Сюзан эгчийн надад нөхөрлөсөн богинохон хугацаанд би асар ихийг ойлгож авсан юм.

Дараа нь Сюзан эгч надаас Төгс Хүчит Бурханыг Аврагчаа гэж хүлээн авахыг хүсэж байна уу гэж асуулаа. Эхлээд асуухад нь би хариу хэлээгүй бөгөөд дахиад асуух үед нь дотроо үгээр илэрхийлшгүй догдолсон мэдрэмжээр бялхаж, нүдэнд минь нулимс цийлгэнэлээ. Би чин сэтгэлээсээ: “Би...хүсэж... байна!” гэж хариулав. Эдгээр үгийг хэлмэгц эзгүй зэлүүд газар удаан хугацаагаар хэрэн хэссэн үрэлгэн хүү эцэст нь дулаан гэртээ эргэн ирсэн мэт санагдав. Зүрх сэтгэлдээ би баяр хөөр, амар тайвнаар дүүрч байлаа.

Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн зөвшөөрснийхөө дараа би Сюзан эгчийн зарим нийтлэлийг нийтэлсэн юм. Удалгүй Фэйсбүүкийн тав, зургаан найз маань надад “сэр” гэсэн зурвас илгээж, Төгс Хүчит Бурханы Чуулганыг дайрч давшилсан, буруутгаж, нэр төрд нь халдсан зүйлээр дүүрэн зарим нэг сайтын холбоосыг над руу явуулсан юм. Энэ нь Сатаны саад гэдгийг би мэдэж байсан учраас ойшоож үзсэнгүй. Дараа өдөр нь пастор интернетэд орж ирээд, надтай хэсэг зуур ярилцаж байснаа, “Чи үнэхээр Төгс Хүчит Бурханд итгэдэг юм уу? Яагаад Төгс Хүчит Бурханд итгэхийг хүсээд байгаа юм бэ?” гэж асуув. Үүнийг сонсоод би ихэд уурлаж: “Бурханы хоньд Бурханы дуу хоолойг сонсдог. Төгс Хүчит Бурханы илэрхийлсэн бүх зүйл үнэн бөгөөд Бурханы дуу хоолой мөн гэдгийг би Төгс Хүчит Бурханы үгээс таньсан, тэгэхээр би яагаад Төгс Хүчит Бурханд итгэх ёсгүй гэж? Яагаад?” гэж пастороос асуулаа. Намайг ийм зүйл асууна гэж бодоогүй бололтой, нэг хэсэгтээ хариулсангүй. Би түүнээс, “Пастор аа, та Төгс Хүчит Бурханы эцсийн өдрүүд дэх ажлыг судалсан юм уу? Төгс Хүчит Бурханы үгийг уншсан юм уу? Пастор хүний хувьд та эрж хайж, судлахаас татгалзах атлаа зүгээр л дураараа дүгнэж, буруутгаж яаж чадаж байна аа?” гэж дахиад асуув. Пасторыг хариулахдаа гацаж, түгдэрч эхэлнэ гэж би бодоогүй бөгөөд пастор гэнэт интернетээс гарчихлаа. Пасторыг ингэж сандарсныг хараад би ихэд баярлаж, Сатаны нэг туршилтыг давж гарсан мэт сэтгэл хангалуун байдлыг мэдэрлээ. Үнэндээ би Сюзан эгч, Чи Фэй эгч хоёртой хэлэлцдэг байсан зарим асуултаа л ашиглаж, Төгс Хүчит Бурханы үгээс ойлгосон зүйлээсээ хэлсэн төдий боловч миний асуултад энэ агуу пастор бүдэрнэ гэж хэзээ ч бодоогүй байсан юм. Ийм өчүүхэн туршлага надад ихээхэн итгэл өглөө. Бурханд талархъя!

Нэг л мэдэхэд таван сар гаруй хугацаа өнгөрсөн байв. Цуглаанд оролцож, Бурханы үгийг уншсанаар би бие махбодтой болох гэж юу болох, тэнгэрийн хаанчлалд ямар

---

төрлийн хүмүүс орж болох болон үнэний бусад талын тухай ойлгосон юм. Энэ бүх хугацаанд би пастор, ахлагчдын миний талаар тараасан цуу ярианаас болж саад тотгор амсаж байв. Зарим үед би Сатаны заль мэхийг ялган таньж чадаагүй учраас сөрөг, сул дорой болж байсан боловч Бурхан надаас хэзээ ч холдоогүй юм. Эгч нар надад Бурханы үгийг уншиж өгч, үнэний талаар тэвчээртэйгээр нөхөрлөдөг байсан болохоор би, үнэнд дайсагнаж, Бурханыг эсэргүүцдэг ахлагч, пасторуудын сатанлаг уг чанарыг ялган таньж чаддаг болсон билээ. Түүнчлэн үнэн замыг эрж хайж, судлахаас итгэгчдийг сэргийлэхийн тулд чадах бүхнээ хийх гэдэг тэдний жигшүүрт санааг ялган таних чадвартай болж эхлэв. Би дахин хэзээ ч тэднээс болж замаа алдаж, тэдний хяналтад орохгүй. Сатаны харанхуйн нөлөөнөөс ангижирч, Бурханы сэнтийн өмнө өргөгдөж чадсан минь Бурханы хайрласан нигүүлсэл, ерөөл байсан юм. Төгс Хүчит Бурханд талархъя! Бурхан руу эргэж чадсан минь аль эрт Бурханаар урьдчилан тогтоогдож, зохицуулагдсан байжээ. Урагшаа тууштай явахын тулд би Бурханд найдах болно! Бурханы гэрт эргэн ирээд анх сурсан дуу минь “Хүний амьдралын зөв замаар алхах нь” гэдэг магтан дуу байсан: “Бурханы бүх үг үнэн, унших тусам зүрх сэтгэл минь гэрэлтдэг. Бурханы үг амьдралын нууцыг илчилдэг, тэгээд би гэгээрдэг. Надад байгаа бүхэн Бурханаас ирснийг би хардаг—энэ нь бүгд Бурханы нигүүлсэл. Би Христийг дагаж, үнэн ба амийг эрэлхийлдэг; би амьдралын зөв замаар алхаж байна...” (“Хургыг дагаж шинэ дуу дуулья” ном). Одоо би чуулган дахь ах эгч нартайгаа хамт сайн мэдээ номлож, Бурханд гэрчлэл хийдэг. Би үүргээ биелүүлж, Бурханы хайрыг хариулахын тулд чадах бүхнээ хийхийг хүсэж байна!

## **47. Үхлийн ирмэгээс буцсан минь**

Жао Гуанмин, Хятад

1980-аад оны эхээр би 30-аад настай байсан бөгөөд барилгын компанид ажилладаг байлаа. Би өөрийгөө идэр залуу, эрүүл чийрэг, хүмүүст үнэнчээр, хүндэтгэлтэй хандаж, ажлаа хариуцлагатай хийдэг хүн гэж боддог байв. Барилгын авьяас чадвар маань ч өндөр зэрэглэлийнх байсан бөгөөд компанидаа амжилтад хүрч, ажил мэргэжил маань үнэхээр хөгжин цэцэглэсний дараа ханхүү шиг амьдрах болно гэдэгтээ итгэлтэй байв. Ийм зорилготой байсан учраас би компанидаа үлдэж, олон жил шаргуу ажилласан юм. Гэвч өөлөх юмгүй зан авир, мэргэжлийн ур чадварыг минь үл харгалзан миний хүчин чармайлтыг компани хэзээ ч үнэлэхгүй байх шиг санагддаг байсан бөгөөд үүнийг би хэзээ ч ойлгодоггүй байв. Манай компанийн хамгийн дээд цалингийн зэрэглэл нь 6-р зэрэглэл байсан боловч миний цалин хэзээ ч 3-р зэрэглэлээс давж байсангүй. Над шиг чадвартай биш, компанид над шиг удаан ч ажиллаагүй хэд хэдэн хамтран ажиллагч маань цалингаа

---

нэмүүлэхийг би харж байсан боловч ийм зүйл надад хэзээ ч тохиолдоогүй юм. Яагаад тэдний цалинг нэмж, минийхийг нэмдэггүй тухайд би гайхаж, эгдүүцдэг байлаа. Эцэст нь надтай нэлээд эвтэй байдаг нэг хамтран ажиллагч маань надад зөвлөгөө өгөв: “Энэ компанид хамгийн чухал зүйл гэвэл менежерт долигонож, Хятадын цагаан сар болон бусад баяраар ч бэлэг сэлт өгөх явдал юм.” Үүнийг сонсоод компани намайг яагаад үл анзаарч байсны үнэн учрыг би эцэст нь ойлгосон бөгөөд энэ шударга бус байдалд уур минь ихэд хүрлээ. Гэхдээ би, компани дахь тэр бялдуучдыг үзэн яддаг, багахан ажил хийдэг ч башир арга ашиглан цалингаа мөн л нэмүүлж, тушаал ахидаг хүмүүсийг бүр үл ойшоодог байсан хэдий ч компани доторх байр сууриа батжуулах хэрэгтэй байсан тул эдгээр бичигдээгүй дүрэмд дасан зохицох ёстой болсон юм. Иймээс дараагийн Хятадын цагаан сар болоход би менежерт “чин сэтгэлээсээ сайн сайхныг хүсдэгээ илэрхийлж”, тэр даруй багийн ахлагч болж тушаал дэвшлээ.

Багийн ахлагчийн хувьд би улам ч хариуцлагатай, ухамсартайгаар ажилладаг болов. Би барилгын талбай руу явж, ажлыг нарийн хянаж, залж чиглүүлэн, стандартад нийцэхээр хийгдэж байгаа эсэхийг, мөн төслийн зорилт биелсэн эсэхийг баталгаажуулдаг байлаа. Бас ажилчдын аюулгүй байдлыг цаг үргэлжид анхаардаг байсан бөгөөд багийн маань ажилчид бүгд миний ажлын хандлага, мэргэжлийн удирдамжийг магтдаг байсан юм. Гэхдээ эдгээрийн аль нь ч багийн ахлагчдыг халж солиход хамаагүй байв, харин багийн ахлагч бүрийн менежерт өгсөн бэлгийн үнэ цэн л хамгийн чухал байв. Компанидаа ажлаа хадгалж үлдэхийн тулд амьд үлдэх энэ хуулийг дагахаас өөр сонголт надад байгаагүй бөгөөд “хүчтэй нь хүчгүйгээ” гэх үгээр биеллээ олсон харгис, арга мухардсан байдлыг туулах боломж олгосон юм.

Дараагийн жилүүдэд нь засгийн газраас эдийн засгийг шинэчилж, хязгаарлалтыг сулруулснаас үүдэн Хятад даяар бүтээн байгуулалт, өргөжилтийн өргөн цар хүрээтэй төслүүд хэрэгжлээ. Иймээс манай компани хувь хүмүүст төсөл хуваарилж эхэлсэн бөгөөд багийн ахлагчид гэрээний төлөө өрсөлдөх ёстой гэсэн үг байв. Энэ нь улам их дайлж цайлж, бэлэг сэлт өгөхөд хүргэсэн ба багийн ахлагч бүр бусдаасаа давж гарахаар хичээж байлаа. Ажлын нэгжид тендерт оролцуулах төсөл байгааг багийн ахлагч бид сонсмогцоо тухайн нэгжийн холбогдох хүмүүст бэлэг сэлтээ аль болох хурдан хүргэж хахуульдахаар тэмцэлддэг байв. Эдгээр нэгжийн удирдагчдын дургүйг хүргэхээс зайлсхийхийн тулд бид тэдэнд өгөх хамгийн сайхан бэлэг болон шилдэг арга замыг бодон тархиа гашилгадаг байсан юм: Зарим хүн загас, тахианы гэдсэн дотор алт хийж; зарим нь бэлэн мөнгө өгч; зарим нь алтан эдлэл юм уу, алмаазан бөгж өгч байв. Би ч бас энэ хахуулийн соёлд автаж, энэ хүмүүст зусардахын тулд ямар бэлэг өгөхөө бодон олон цаг зарцуулсан билээ. Эцэст нь би ихээхэн чирэгдэл болж байж нэг гэрээ авсан боловч ажлаа дөнгөж эхлэв үү, үгүй юу,

---

Барилгын Товчоо, Барилгын Зураг Төслийн Хүрээлэн, Чанар болон Техникийн Хяналтын Товчоо, түүнчлэн орон нутгийн захиргааны албаныхан бүгд “ажлыг хянаж, чиглүүлэхээр” ирлээ. Тэд барилгын талбай дээр ийм ч, тийм ч асуудал байна, энэ ч, тэр ч стандартад нийцээгүй байна гэгцгээсэн бөгөөд өглөөжин үргэлжилсэн үзлэг шалгалтын дараа ч бид ажлаа эхэлж чадаагүй л байв. Би тэднийг даруйхан тансаг зоогийн газарт архи дарстай үдийн зоогт урьсан бөгөөд хоолонд олон мянган юань зарлагадлаа. Хооллож дуусаад би тэдэнд нэг бүрчлэн 2,000-аас 10,000 юанийн хэмжээтэй хахууль өгөх хэрэгтэй болсон юм. Ажлаа эхлэхийн тулд тэдний батламж, зөвшөөрлийг авах цорын ганц арга энэ байв. Гэвч ажил эхэлсний дараа ч гэсэн эдгээр хяналтын байгууллагууд байнга байцаагч явуулж, төслийг шалгуулсаар л байлаа. Тэд эдгээр шалгалтыг “тогтсон журам” гэж нэрлэдэг байсан ч үнэндээ энэ нь ердөө нэмж мөнгө салгах өөр нэгэн шалтаг байлаа. Тэднийг ажлын талбай дээр ирэх бүрд нь би хөл алдан яаравчилж, тэднийг цэнгүүлэхийн тулд хоол унд зохицуулдаг байсан бөгөөд хяналтын байгууллагуудын энэ дарга нар бүр их дэлгүүр орохдоо ч намайг дагуулан явах шалтаг олж, загварын хувцас аваад надаар төлбөрийг нь төлүүлнэ гэдэг байв. Заримдаа тэд бүр цагаандаа гарч, мөнгөгүй байна гэдгээ хэлээд надаас шууд бэлэн мөнгө нэхдэг байсан юм. Төслөө үргэлжлүүлэн явуулахын тулд би шүдээ зууж, уураа дараад, тэдэнд сайхан хандаж, золиос гаргахаас өөр аргагүй байлаа. Үүнээс ч дор зүйл нь гэвэл би удаан хугацаанд энэ агентлагийн дарга нарыг дагалдан улаан дэнлүүний гудамж руу явах ёстой болсон юм. Удаан хугацааны туршид хэтэрхий их архидаж, тогтмол унтаж амарч чадалгүй явсаар ходоодны асуудал, цусны өндөр даралттай болж дууссан бөгөөд би үнэхээр ядарч туйлдаж байлаа. Ингээд төсөл эцэст нь дуусаж, би хөлсөө аваад бараг ямар ч мөнгө олж чадаагүй гэдгээ олж мэдэв. Үнэхээр уйлмаар байсан юм. Амьдралын ийм хэцүү замтай тулгараад би: “Өөрийнхөө ур чадвар, шаргуу ажилд түшиглэж мөнгө олно гэдэг надад яагаад ийм хэцүү байдаг юм бэ? Яахаараа энэ улсын систем дэх хэлтэс нэг бүрийн удирдагчид ийм их авлигад идэгдсэн байдаг юм бэ?” гэж бодов. Тэгээд туйлын арга мөхөстсөн боловч мөнгө олох бүх найдвараа эдгээр албаныханд даатгахаас өөр сонголт байсангүй. Би анх, тэдэнтэй сайн харилцаа тогтоох нь ажил мэргэжлээ хөгжүүлэх сууриа бас тавина гэсэн үг гэж бодож байсан бөгөөд нүглийн намагт улам гүн живж, найдлагагүй нөхцөл байдлыг туулах юм л хийж байна гэж хэзээ ч бодогдоогүй юм.

1992 онд ээдрээтэй, хүнд хэцүү үйл явцын дараа би хотод барилгын төслийн гэрээ авсан бөгөөд энэ төслөөр өөртөө жаахан мөнгө олно гэх тооцоолж байлаа. Ажлаа эхлэхээр бэлдэн урамтайгаар бүхнээ зориулж байх яг тэр үед менежер маань надад, эхлээд хотын дөрвөн албан тушаалтанд тус бүрд нь хувийн харш барьж өгөх ёстой гэж хэллээ. Энэ нь карьераа хөгжүүлэх сайхан боломж бөгөөд хотын албан тушаалтнуудад тус хүргэх нь

---

ирээдүйд мөнгөний төлөө хэзээ ч санаа зовохгүй байх баталгаа болж, удалгүй сайхан амьдарна гэж менежер маань хэлсэн юм. Сэтгэл минь итгэл найдвараар бялхан, дөрвөн харш барихад хүрэхүйц мөнгө босгохын тулд би банкнаас зээл авч, бас найз нөхөд, хамаатан саднаасаа мөнгө зээлж, боломжтой бүх аргаар мөнгө босгосон юм. Гэвч яг барилгын ажил дуусах дөхөж байхад Сахилга бат шалгах хорооноос дээд тушаалтнууд ирж, би асуудлыг зохицуулан, хотын дөрвөн албан тушаалтныг хамгаалахын тулд нэмж мөнгө үрэх ёстой боллоо. Гэвч эцэст нь миний бүх хүчин чармайлт хуулийн төмөр нударгаас тэднийг хамгаалж чадсангүй: Дөрвөн албан тушаалтныг хахууль авч, авлигын хэрэгт холбогдсон хэмээн сэжиглэж байсан учраас байцаан шалгах байгууллага тэдэнд арга хэмжээ авсан юм. Ингээд уйгагүй төлөвлөсөн бүх сайхан төлөвлөгөө минь бүтэлгүйтэж, барьж дуусаагүй дөрвөн харшийг эрх баригчид хураан авлаа. Би буцаан төлөх ямар ч аргагүй хэдэн зуун мянган юанийн өрөнд орсон ба үгээр илэрхийлэхийн аргагүй хорсол, сэтгэл доторх бул хар чулуу мэт байв.

Арга мухардахдаа би бас нэгэн барилгын төсөлд найдлага тавихаас өөр аргагүй байлаа. Тэгээд өрөө төлөхийн тулд бүх ажил мэргэжлийнхээ туршид хэзээ ч хийж үзээгүй, хийх хамгийн дургүй зүйлээ хийж—хэмнэлт хийн, муу материал ашиглаж эхэллээ. Улсын стандартад нийцсэн ган ашиглахын оронд хоёрдугаар зэрэглэлийн материал ашиглаж, бетонд зургаан багц бэхлэгч ган тор ашиглахын оронд дөрвөн багцыг ашиглаж эхлэн, улмаар гангийн зардлаа 30 гаруй хувь буурууллаа. Түүнчлэн нийт зардлаа улам бууруулахын тулд муу бетон хольдог байлаа. Үнэнийг хэлэхэд, барьж дууссан барилгын чанарт ноцтойгоор нөлөөлөх вий гэж би айдаг байсан учраас ийм зүйл хийх бүрд зүрх амаар гарах шахдаг байсан юм. Мөн Хятадын хаа сайгүй чанаргүй барилгууд нурж, маш олон энгийн иргэнийг хөнөөж, гэмтээж, дампууруулсан тухай мэдээ сонсох үедээ би тун их түгшиж, үргэлж хар дарж зүүдэлдэг байв. Бүр аянга нүргэлэх чимээ хүртэл айсуй сүйрлийг минь тунхаглах мэт, магадгүй аянгад ниргүүлэх ч юм шиг санагддаг болсон юм. Айдас намайг өдөр бүр дагадаг байв. Энэ нөхцөл байдлаас үүдэн би эцэст нь өвчилж, цусны өндөр даралтаас болж байнга толгой эргэж, толгой өвдөн, нойргүйдэх боллоо. Би бие махбод, сүнсээрээ аль алинаар нь сүйрч, амьдрал миний хувьд амьдын там болов. Ийнхүү би ертөнцийн чиг хандлагад автаж, нүглийн намагт улам гүн живсэн юм. Гайхмаар нь, төслийн тал нь дуусчхаад байх үед миний ажиллаж байсан нэгж гэрээнд зөвшилцсөн ёсоор төлбөрөө төлөхөөс татгалзав. Банкнаас авсан зээл маань ажилчдын цалинг төлөхөд хүрэлцэхгүй байсан учраас би мөнгө хүүлэгчээс өндөр хүүтэй зээл авахаас өөр сонголтгүй боллоо. Өөр олон бүтэлгүйтлийн дараа би, гэрээ байгуулсан нэгж маань аль хэдийн өрөнд баригдчихаад барилгын төслийг санхүүжүүлэх ямар ч аргагүй болсныг эцэст нь олж мэдэв. Ийнхүү бас нэг төсөл маань бүтэлгүйтэж, би үүнийг засах арга зам

---

бодон тархиа гашилгасан юм. Би бүр туйлдаж гүйцээд, цөхөрсөн байдалтай амьдарч байв. Тэгтэл, барилгын төсөл авсан өөр нэг компанийн багийн ахлагч асар их зээл аваад, өрөө барагдуулж чадаагүй тул өөрийгөө дүүжилсэн тухай мэдээ сонслоо. Тэгэхэд би ч бас тамын үүдэд зогсож байгаа мэт, мөн цөхрөлд живж байгаа мэт санагдсан юм. Үүний дараа зээлдүүлэгчид маань мөнгөө авахын тулд манай гэрт ирж эхэллээ: Зарим нь орон дээр минь хэвтээд, явахаас татгалзаж, харин зарим нь хэл ам хийж, намайг сүрдүүлдэг байв. Би тэдэнд чадах чинээгээрээ эелдэг, даруу хандаж байсан бөгөөд бүрэн шившиглэгдсэн мэт санагдаж байлаа. Хамгийн ойр дотнын найз нөхөд, хамаатнууд маань хүртэл намайг өрөө төлж чадахгүй нь гэж бодоод, миний эсрэг хандаж эхлэв. Тэр өдрүүдэд л би хүний харилцаа хэчнээн хувирамтгай болохыг үнэхээр ухаарсан юм. Тэр олон жилийн нөр их хөдөлмөр намайг сохор ч зоосгүй үлдээсэн төдийгүй бие, сэтгэлийн хувьд туйлдуулж, хэдэн зуун мянган юанийн өртэй болгосон билээ. Би тэнгэр лүү хараад, уртаар санаа алдан: “Тэнгэр минь, энэ ердөө хэтэрхий хэцүү юм. Би цааш амьдрахыг үнэхээр хүсэхгүй байна!” гэж хэлсэн юм.

Тамын хаалган дээр эргэлдэж байх яг тэр үед Төгс Хүчит Бурханы хаанчлалын сайн мэдээ чихэнд минь хүрлээ. Би Төгс Хүчит Бурханы эдгээр үгийг харсан юм: **“Өнөөдөр та нарыг өдий хүртэл удирдан хөтөлсөн учраас Би тохирсон зохицуулалтыг хийсэн бөгөөд Надад өөрийн гэсэн зорилго бий. Хэрвээ Би үүнийгээ та нарт өнөөдөр хэлсэн бол та нар үнэхээр тэдгээрийг мэдэж чадна гэж үү? Би хүний оюун ухаан дахь бодол, хүний зүрх сэтгэлийн хүслийг нэлээд сайн мэддэг: Өөрсдөдөө гарах гарц хэзээ ч хайж байгаагүй хэн байна вэ? Өөрсдийн хэтийн ирээдүйг хэзээ ч бодож байгаагүй хэн байна вэ? Хүн баялаг, гялалзсан оюуны чадавхтай хэдий ч эрин үеүдийн дараа өнөө үе ийм болно гэдгийг хэн урьдчилан таамаглаж чадсан билээ? Энэ нь үнэхээр бодит хичээл чармайлтын чинь үр дүн гэж үү? Цуцашгүй зүтгэлийн чинь төлбөр гэж үү? Оюун ухаандаа ургуулан бодсон үзэсгэлэнт дүр зураг чинь гэж үү? Хэрвээ Би бүх хүн төрөлхтнийг залж чиглүүлээгүй бол хэн өөрсдийгөө Миний зохицуулалтаас салгаж, өөр гарц олж чадах юм бэ? Хүний төсөөлөл, хүсэл нь түүнийг өдий хүргэсэн юм гэж үү? Олон хүн өөрсдийн хүслийг биелүүлэлгүйгээр бүх амьдралаа өнгөрүүлдэг. Энэ нь үнэхээр тэдний сэтгэхүй дэх алдаанаас болсон гэж үү? Олон хүний амьдрал гэнэтийн аз жаргал, сэтгэл ханамжаар дүүрэн байдаг. Энэ нь, үнэхээр тэд хэтэрхий багыг хүлээдгээс болдог гэж үү? Бүх хүн төрөлхтнөөс хэн нь Төгс Хүчитийн нүдэнд анзаарагддаггүй вэ? Хэн Төгс Хүчитийн урьдаас тогтоосон тавилангаар амьдардаггүй вэ? Хүний амьдрал, үхэл өөрсдийнх нь сонголтоор тохиолддог уу? Хүн хувь заяагаа хянадаг уу?”** (“Үг нь махбодоор илэрсэн” номын Бүх орчлон ертөнцөд хандсан Бурханы айлдваруудын “11-р бүлэг”). Эдгээр үгийг уншаад би туйлын их

---

үнэмшлээ. Бидний хувь заяа үнэхээр өөрсдийн маань гарт байдаггүйг би үнэхээр мэдэрсэн юм. Би өнгөрсөн жилүүдийг болон өөрийнхөө ирээдүйг яаж ч төлөвлөж, тооцоолсон бай, аль нь ч бүтээгүй талаар бодов. Би их мөнгө олж, дээд зэргийн амьдралын хэв маягаар амьдрахад бүхнээ зориулж байсан боловч ямар ч мөнгө олоогүйгээр үл барам өчнөөн их мөнгө үржээ. Нэгэн цагт чухал хүн явсан би ийм хөөрхийлөлтэй ядуурлын байдалд орж дуусах юм гэж хэзээ ч төсөөлсөнгүй. Яагаад би ирээдүйнхээ төлөө тэгтлээ шаргуу ажилласан атлаа ээлж дараалан бүтэлгүйтэлтэй тулгарсан юм бэ? Учир нь хүн бүрийн хувь заяа өөрсдийнх нь гарт бус, харин Бурханы гарт байдаг. Бүх зүйлийг Бурхан захирч, урьдчилан тогтоодог; зол завшаан, золгүйтэл бүгдийг Бурхан хянадаг. Энэ нь Бурханы үг мөн гэдгийг би зүрх сэтгэлийнхээ угаас мэдэрч чадсан бөгөөд өөрийн эрхгүй Төгс Хүчит Бурханыг ийн дуудлаа: “Өө Бурхан минь! Өмнө нь би Таныг мэддэггүй байсан. Би өөртөө болон хүний хүч чадалд найдах гэж оролдсон боловч горьгүй нөхцөл байдалд орж дууслаа. Өнөөдөр би, хүн нэг бүрийн хувь заяа, амьдрал, үхэл Таны гарт байдгийг эцэст нь ойлголоо. Хэрвээ ийм нөхцөл байдал надад тохиолдоогүй бол би Таны өмнө очихгүй байх байжээ. Өө Бурхан минь! Намайг үхлийн ирмэгээс аварч, амьдралтай шинээр нүүр тулах зүрх зориг хайрласанд тань талархъя. Одоогоос эхлээд би дагах ёстой амьдралын замдаа Таны зохицуулалтад захирагдах болно.”

Үүний дараа би чуулганы амьдралаар амьдарч эхэллээ. Төгс Хүчит Бурханы Чуулган дахь орчин гадаад ертөнцөөс тэс өөр байлаа: Ах эгч нар бие биетэйгээ энгийн, шулуухан харилцаатай байсан бөгөөд дүр эсгэж, хоорондоо тэмцэлдэж, явуулга хийх ямар ч шинжгүйгээр нэг нэгэндээ үнэнч шударгаар ханддаг байв. Хүн бүр Бурханы үгийг уншиж, Бурханыг магтсан магтан дуу дуулж; цуглаан дээр ах эгч нар бие биетэйгээ үнэнч, нээлттэй байж, өөрсдийн туршлага, дутагдал, хүндрэл бэрхшээл, түүнчлэн Бурханы үгийн талаарх ойлголт, мэдлэгээ нөхөрлөдөг байлаа. Оролцсон цуглаан бүр минь шинэ, сэргэг, амин чанараар дүүрэн санагддаг байсан юм. Ах эгч нарын хооронд ямар ч зай завсар, сэжиг байгаагүй бөгөөд хүн бүр нэг нэгнээ ойлгож, бие биеэ сайн мэддэг байлаа. Тэнд би урьд өмнө мэдэрч байгаагүй тайвшрал, эрх чөлөөг мэдэрч, өмнөхөөсөө илүү тайван, аз жаргалтай байдаг байв. Үүний зэрэгцээ, өнгөрсөн хэдэн арван жилд яагаад ийм зовлон дунд амьдарснаа ойлгоход Бурхан намайг залж чиглүүлсэн юм. Би Төгс Хүчит Бурханы эдгээр үгийг уншив: **“Чи гэрэлгүй ертөнцөд амьдарсаар ирсэн тул чиний зүрх сэтгэлд асар том нууц байгааг хэзээ ч анзаарч байгаагүй. Зүрх сэтгэл, сүнснийг чинь муу ёрын нэгэн булаан авчихсан. Нүд чинь харанхуйд халхлагдаад тэнгэрийн нарыг ч, шөнийн огторгуйд анивчих тэр одыг ч харж чаддаггүй. Чих чинь худал хуурмаг үгээр дүүрээд Еховагийн нүргэлсэн дуу хоолойг ч, сэнтийгээс урсах их усны чимээг ч сонсдоггүй. Өөрт байх ёстой бүхнээ, Төгс Хүчитийн хайрласан бүхнийг чи алдчихсан. Чи аврах**



---

хүч чадалгүй, амьд гарах найдлагагүйгээр эцэс төгсгөлгүй зовлонгийн далайд орчхоод тэмцэж, сандрахаас өөрийг хийдэггүй... Тэр мөчөөс эхлээд чи ёрын муу нэгэнд хорлогдож, Төгс Хүчитийн ерөөлөөс холдож, Төгс Хүчитийн хангалтаас салж, эргэж буцалтгүй замаар алхах тавилантай болсон. Сая дуудлага ч зүрх сэтгэл, сүнсийг чинь сэрээж бараг чадахгүй. Чамайг зүг чиггүй, замын тэмдэггүй эх захгүй ертөнцөд уруу татаж оруулсан ёрын муу нэгний гарт чи дугжирдаг. Энэ үеэс хойш чи анхдагч гэм зэмгүй, цэвэр байдлаа алдаж, Төгс Хүчитийн халамжаас зайлсхийж эхэлсэн. Ёрын муу нэгэн чиний зүрх сэтгэлд бүх хэрэг явдлыг залж чиглүүлэн, чиний амь болсон. Чи түүнээс айж, зайлсхийж, түүнд эргэлзэхээ больсон; харин ч зүрх сэтгэлдээ түүнийг Бурхан мэт үздэг. Чи түүнийг хүндэлж, шүтэж эхэлсэн бөгөөд та хоёр бие, сүүдэр хоёр шиг салшгүй болж, амьдрал, үхлийн алинд нь ч бие биедээ удтал үнэнч байлаа. Чи хаанаас ирсэн, яагаад төрсөн, яагаад үхэхээ огт мэддэггүй” (Үг нь махбодоор илэрсэн номын “Төгс Хүчитийн санаа алдалт”). “Улс орны засгийн газар, алдартай, агуу хүмүүсийн боловсрол болон нөлөөллөөр дамжуулан Сатан хүмүүсийг завхруулдаг. Тэдний худал үг, утгагүй яриа хүний амь, уг чанар болсон юм. ‘Хүн бүр өөрийгөө боддог, би үхэхээр чи үх’ гэдэг нь хүн бүрд шингэж, хүний амь болсон сатаны алдартай үг юм. Амьдралын гүн ухааны иймэрхүү өөр үг ч бас бий. Сатан хүмүүсийг боловсруулахын тулд улс орон бүрийн сайхан уламжлалт соёлыг ашиглан, хүн төрөлхтнийг сүйрлийн эх захгүй ангал руу унаж, залгиулахад хүргэсэн бөгөөд Сатанд үйлчилж, Бурханыг эсэргүүцдэг учраас эцэстээ хүмүүс Бурханаар устгагддаг” (Христийн ярианы тэмдэглэл номын “Хүний уг чанарыг хэрхэн мэдэх вэ”). Иймээс, сүүлийн хэдэн арван жилд энэ дэлхий ертөнц дээр яаран самгардаж өөрийгөө туйлдуулж, маш хөөрхийлөлтэй болгосны маань шалтгаан нь “Хүн хувь тавилангаа өөрөө атгадаг”, “Дэлхий мөнгөн дээр тогтдог”, “Хүн бүр өөрийнхөө төлөө байдаг ба би үхэхээр чи үх”, “Бялдуучлал чамайг хаа ч хүргэнэ” гэх мэт Сатаны амьдралын дүрмээр амьдарч ирснээс үүдэлтэй байжээ. Эдгээр сатанлаг гүн ухаанаар амьдарснаар би Бурханы оршин тогтнолын талаар огт мэдэхгүй явсан бөгөөд Бурхан хүн бүрийн хувь заяаг захирч, зохицуулдгийг мэдээгүй юм. Би амьдралын чиглэл, биеэ авч явах зарчимгүйгээр энэ харанхуй ертөнцийн урсгалыг даган хөвсөн. Энэхүү харанхуй ертөнцийг Сатан захирдаг гэдгийг, мөн хүний нийгэм нь Сатаны сорилт, урхидалт болон заль мэхээр дүүрэн гэдгийг би лавтайяа харж чадаагүй. Энэ харанхуй, муу ёрын ертөнцөд мөнгө олохын тулд би эрх мэдэлтэй хүмүүст бялдуучилж, тал засаж сурсан төдийгүй барилгын төсөлдөө чанаргүй материал ч нууцаар ашигласан. Мөс чанар минь бага багаар алга болж, надад өчүүхэн төдий ч ёс жудаг, нэр төр үлдээгүй. Нүгэлд улам гүн шигдэх тусмаа хүн шиг байх минь улам багассан. Эцэстээ би ямар ч мөнгө ололгүй, овоорсон их өртэй үлдэж, бараг амиа хорлохдоо тултал цөхөрч байсан юм. Асар их өрнөөсөө болж амиа хорлосон өнөөх багийн

---

ахлагчийг би бодлоо—тэрээр Сатанд өргөсөн тахил байсан биш үү? Жил бүр өдөр болгон үүнтэй адил хэчнээн эмгэнэлт явдал тохиолдож байгааг хэн мэдэх билээ? Хүмүүс ийм байдалд ордгийн шалтгаан нь Сатаны хорны учруулсан хор хөнөөл болон Сатаны захиралтаас үүддэг дэлхий ертөнцийн чиг хандлагаас болж байгаа гэдгийг би тэр үед ухаарсан юм. Энэ бүгдийг бодох үед зүрх сэтгэл минь Бурханд талархах талархлаар бялхаж, Бурханы өршөөл, авралд би үнэхээр их талархаж байв. Бурхан намайг харанхуй ертөнцөөс аварч, халамж, хамгаалалтыг нь эдэлж болох Бурханы гэрт буцаан авчирсан юм.

Хэсэг хугацааны дараа би зээлдүүлэгчидтэйгээ дахин нүүр тулах ёстой болсон бөгөөд зүрх сэтгэл минь асар их үймэрч байв. Төлөх ёстой бүх өрөө бодохоор дахин нэг удаа барилгын төсөл авахыг хүсэв. Гэвч чадвар минь хүсэл эрмэлзэлтэй минь тохирохгүй гэдгийг бас мэдэж байлаа. Цусны даралт ихсэх асуудал дахин сэдэрч, би яахаа огт мэдэхгүй байв. Нэг цуглаан дээр ах нарын нэг нь надад Бурханы зарим үгээс уншиж өглөө: **“Бурханд итгэх жинхэнэ итгэл гэдэг нь Бурхан бүх зүйлийг захирдаг хэмээх итгэлд үндэслэн Бурханы үг ба ажлыг туулж, завхарсан зан чанараасаа ангижирч, Бурханы хүслийг хангаж, Бурханыг мэдэж авна гэсэн үг юм. Ийм төрлийн аяныг л ‘Бурханд итгэх итгэл’ хэмээн нэрлэж болно”** (Үг нь махбодоор илэрсэн номын Өмнөх үг). Ах дараа нь ийнхүү нөхөрлөлөө: “Бид Бурханд итгэдэг тул Бурханд жинхэнээсээ итгэдэг байх ёстой. Бурханы эрх мэдэл, бүх зүйлийг захирдаг хүч чадалд нь бид зүрх сэтгэлийнхээ угаас итгэх ёстой бөгөөд амьдралынхаа бүх зүйлийг Бурханд хариуцуулах ёстой. Хамгийн чухал нь бид Бурханд найдаж, Бурханыг хүндэлж, Бурханы ажлыг туулж, Бурханы удирдлагыг эрж хайж сурах ёстой ба өөрсдөө бүгдийг нь хийж чадна гэж бодон, завгүй ийш тийш яаравчлан гүйхээ болих ёстой. Өрөө төлнө гэдэг бол эрүүл ухаантай, мөс чанартай бүх хүний хийдэг зүйл, иймээс бид эр зоригтой байж, өртэйгээ нүүр тулах ёстой. Бүх зүйл Бурханы гарт байгаа, мөн бидний авирч чадахгүй уул гэж үгүй гэдэгт бид итгэх ёстой. Та өрнийхөө талаар Бурханд улам их залбирч, Түүний хүслийг эрж хайх хэрэгтэй.”

Ахын тусламжтайгаар би хэрэгжүүлэх замтай болов. Ойролцоох барилгын талбайд би, цуглаанд оролцох, үүргээ биелүүлэхэд минь саад болохгүй ажил олсон бөгөөд өрөө төлөхийн тулд мөнгө олж эхлэв. Би амжилтад хүрэхийн тулд зөвхөн өөртөө найддагаа болилоо. Зээлдүүлэгчид маань мөнгөө авахаар ирэхэд би тэдэнтэй үнэнч шударга байж, байгаа бүхнээ өгдөг байв. Бас тариалангийн талбайгаасаа хураасан ургацыг зарж олсон мөнгөнөөсөө зарим өрөө төлж чадсан юм. Би бүх өрөө заавал төлнө гэх ариун амлалтыг бүх зээлдүүлэгчдээ өгсөн бөгөөд үүний дараа тэд надад хүндрэл учруулахаа болив. Банк намайг өрөө төл гэж дарамтлахаар хүмүүс илгээх үед би Бурханд залбирч, энэ бүхнийг Түүнд даатгасан юм. “Ийм их хэмжээний зээлийг төлж чадаагүйгээсээ болоод шоронд

---

орох ёстой бол би Бурханы бүх зохион байгуулалт, зохицуулалтыг дуулгавартай дагана” гэж би бодсон билээ. Бурханы ажлыг туулах зуур Түүнд захирагдах үедээ Түүний үйл хэрэг хэчнээн гайхамшигтайг харж, Тэр надад урагшлах зам нээснийг харсан билээ: Засгийн газар 1993 оноос өмнө банкнаас авсан бүх зээлийг төлөх шаардлагагүй болсныг зарлалаа. Учир нь тэдгээрийн аль нь ч банкны компьютерын системд бүртгэгдээгүй бөгөөд бүрэн бус мэдээллээс үүдэн зарим зээл хэзээ ч эргэн төлөгдөж чадахгүй гэсэн үг байв. Бурханд талархъя! Би бүх зээлээ 1993 оноос өмнө авсан учраас олон зуун мянган юанийн өр маань цуцлагдлаа. Сэтгэл минь догдлон Бурханд талархал, магтаалаа өргөв. “Хэрвээ би ийм их хэмжээний мөнгө олох ёстой байсан бол бүгдийг нь цуглуулж амжихаасаа өмнө туйлдаж үхэх байсан биз” гэж би бодсон юм. Энэ нь надад, хүн бүрийн хувь заяа үнэхээр Бурханы гарт байдаг гэдгийг биечлэн мэдрэх боломж олгосон бөгөөд Бурханы эдгээр үгэнд дүрслэн хэлсэнчлэн: **“Хүний хувь тавилан Бурханы гараар удирдуулдаг. Чи өөрийгөө удирдах чадваргүй: Өөрийнхөө төлөө үргэлж яарч, завгүй байдаг мөртөө хүн өөрийгөө удирдах чадваргүй хэвээр л байдаг. Хэрвээ чи өөрийнхөө хэтийн ирээдүйг мэдэж чадах байсан бол, өөрийнхөө хувь заяаг хянаж чадах байсан бол бүтээл хэвээр байх байсан гэж үү? Товчхондоо гэвэл, Бурхан яаж ч ажилладаг бай, Түүний бүх ажил хүний төлөө байдаг. Жишээлбэл, хүнд үйлчлүүлэхээр Бурханы бүтээсэн тэнгэр, газар, бүх зүйлийг аваад үз: Сар, нар, одыг Тэр хүний төлөө бүтээсэн, амьтан, ургамал, хавар, зун, намар, өвөл гэх зэрэг нь бүгд хүний оршин тогтнолын төлөө бүтээгдсэн байдаг. Иймээс Тэр хүнийг яаж ч гэсгээж, шүүлээ гэсэн, энэ нь бүгд хүний авралын төлөө юм. Тэр хүнийг махан биеийн итгэл найдвараас нь салгадаг хэдий ч энэ нь хүнийг ариусгахын төлөө байдаг бөгөөд хүнийг ариусгадгийн шалтгаан нь түүнийг амьд үлдээхийн төлөө юм. Хүний хувь заяа нь Бүтээгчийн гарт байдаг, иймд хүн өөрийгөө удирдаж яаж чадах юм бэ?”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Хүний хэвийн амьдралыг сэргээж, түүнийг гайхалтай сайхан хүрэх газарт аваачих нь”).

Туршлагынхаа үеэр би Төгс Хүчит Бурханы ажлын талаар улам бүр итгэлтэй болсон бөгөөд итгэл минь улам хүчирхэгжсэн юм. Удаах жилүүдэд нь би цуглаанд үргэлжлүүлэн явж, үүргээ биелүүлэхийн хажуугаар үлдсэн өрөө төлөх мөнгө олохын тулд орон нутгийн барилгын багуудад ажиллаж байлаа. Сайн мэдээ сонсоход тохирохуйц сайн зан авиртай хүнтэй уулзах бүрдээ би тэдэнд сайн мэдээг номлодог байсан бөгөөд надтай сайн харилцаатай байсан зарим хүнийг Бурханы өмнө авчирсан билээ. Хэдийгээр би бас л өдөр бүр завгүй байдаг байсан ч Сатаны гүн ухаан, дүрэм журмаар амьдрахаа больж, мөн ертөнцийн муу ёрын чиг хандлагыг дагаж, баян чинээлэг болж, дээд зэргийн амьдралын хэв маягтай байхаар эрэлхийлэхээ больсон учраас амьдрал өөр байлаа. Харин ч би

---

Бурханы захиралтад захирагдан, Түүний шаардлагын дагуу амьдарч, үнэний дагуу биеэ авч явж, үнэнч, хүнлэг байж, Бурханаас эмээн, муугаас зайлдаг байв. Ингэж авирлах нь нээлттэй, шулуухан санагдсан бөгөөд би тайвширч, дотроо гэгээлэг болж эхэллээ. Аажмаар би мөс чанар, эрүүл ухаанаа эргүүлэн олж авч, намайг зовоож байсан төрөл бүрийн өвчин арилж эхэлсэн юм. Энэ жил би 75 нас хүрсэн ч эрүүл, хурц ухаантай байгаа бөгөөд бүх өрөө төлчихсөн. Намайг сайн мэддэг хүмүүс бүгд намайг биширдэг гэж, бас намайг азтай гэж хэлдэг. Гэхдээ энэ бүхэн ямар ч эргэлзээгүйгээр Төгс Хүчит Бурханы аврал, нинжин сэтгэлийн үр дүн гэдгийг би мэддэг. Төгс Хүчит Бурхан л намайг үхлийн ирмэгээс аварч, хэрэгцээтэй үед минь амьдралыг минь эргүүлэн өгч, амьдралын зөв замыг надад харуулсан билээ. Бурханы удирдлага байхгүй бол хүмүүс бид гарцаагүй Сатанд хорлогдож, залгиулна гэдгийг энэ бүх туршлагын явцад би үнэхээр мэдэрсэн. Төгс Хүчит Бурхан л хүмүүсийг аварч чадна; Төгс Хүчит Бурханы илэрхийлсэн үг л хүмүүсийг нүглийн хүлээсээс холдуулж, хэрхэн жинхэнэ хүн шиг амьдрахыг бидэнд харуулж чадна. Төгс Хүчит Бурханы илэрхийлсэн үнэнийг хүлээн зөвшөөрч, Төгс Хүчит Бурханд захирагдан, Түүнийг шүтэн мөргөснөөр л хүн төрөлхтөн жинхэнэ аз жаргал дунд амьдарч, сайхан ирээдүй, сайн хүрэх газартай болж чадна!

## **48. Үхлийн ирмэгээс амьд үлдсэн нь**

Ян Мэй, Хятад

2007 онд би гэнэт бөөрний архаг дутагдалд орсон юм. Энэ мэдээг сонсоод Христэд итгэгч ээж, бэр эгч болон Католик шашинтай зарим найз маань бүгд надад сайн мэдээ номлохоор ирлээ. Эзэнд хандсан цагт өвчин минь эдгэнэ гэж тэд хэлсэн юм. Гэвч би Бурханд огт итгэдэггүй байлаа. Өвчнийг анагаахын шинжлэх ухааны эмчилгээгээр л эдгээж болно, шинжлэх ухаанаар эдгээх боломжгүй ямар ч өвчин эмчилгээгүй гэж би боддог байсан юм. Эцсийн эцэст, газар дэлхий дээр шинжлэх ухааны хүчин чадлаас агуу хүчин бий гэж үү? Бурханд итгэх итгэл гэдэг бол нэг ёсны сэтгэл санааны түшиг тулгуур л байсан бөгөөд би өндөр боловсролтой, соёлжсон, улсын сургуулийн нэр төртэй багш хүн учраас яасан ч Бурханд итгэж эхлэхээргүй байсан юм. Иймээс би тэднээс татгалзаж, эмийн эмчилгээ хайж эхлэв. Хэдэн жилийн дотор төрөлх хошууныхаа бараг бүх том эмнэлгээр явсан ч эрүүл мэндийн байдал минь дээрдэхгүй л байлаа. Харин ч дордож байсан боловч би нөхцөл байдлыг харах өөрийн үзэл бодолтой зөрүүдлэн зууралдаж, шинжлэх ухаан юуг ч өөрчилж чадна, өвчнийг анагаана гэдэг цаг хугацаа шаарддаг үйл явц хэмээн зүтгэж байсан юм.

---

2010 онд Төгс Хүчит Бурханы Чуулганы нэг эгч надад Бурханы хаанчлалын сайн мэдээг номлохоор ирэв. Эзэн Есүс шинэ ажил хийхээр хүний ертөнцөд эргэн ирсэн бөгөөд хүмүүсийг шүүж, цэвэрлэхийн тулд үнэнийг тунхагласан гэж тэр эгч хэлсэн юм. Энэ нь хүн төрөлхтнийг бүрмөсөн аврахад зориулагдсан Бурханы ажлын үе шат төдийгүй хүн төрөлхтний Бурханаар авруулах эцсийн боломж байлаа. Би энэ бүхнийг мөн л хүлээн зөвшөөрөхийг хүсээгүй ч сүүлийн хэдэн жилд эмийн эмчилгээ хайхад тулгарсан бүхий л бүтэлгүйтэл, бухимдлын улмаас хандлага маань урьдынх шигээ тууштай байхаа больсон бөгөөд ятгалгад нь орж, тэр эгчээс Бурханы үгийн ном авсан юм. Гэвч тухайн үед би тэр номд байсан үгийг Бурханы илэрхийлсэн үнэн гэдэгт лавтай итгээгүй билээ. Шинжлэх ухаан л хувь заяаг минь өөрчилж чадна гэж зүтгэсээр байсан тул эм л эрүүл мэндийн байдлыг минь дээрдүүлж чадна гэдэгт үргэлжлүүлэн итгэсээр байв. Эцэстээ би өдөр бүр иддэг хоолноосоо их эм уух болсон ч өчүүхэн ч дээрдэх шинж харагдсангүй. Тэр эгч манайд тоймгүй олон удаа ирсэн боловч би Бурханд итгэхээс татгалзсаар байлаа. Нэг жил гаруй энэ хэвээр үргэлжилсэн юм.

Дараа нь нэг өдөр гэв гэнэтхэн хоёр нүдний хараа бүрэлзэж, хоёр хөл минь ихэд бадайран алхаж ч чадахгүй боллоо. Хэдэн жилийн турш өндөр тунгаар эм ууж байснаас үүдэн эмийн хордлого болсноос ийм шинж тэмдэг илэрсэн гэж эмч нар хэлэв. Эхлээд би хошууны эмнэлэгт долоо хоноод, дараа нь Бээжин дэх цэргийн эмнэлэг рүү шилжин нэг сарын турш эмчлүүлсэн юм. Тэгээд хятадын уламжлалт анагаах ухааны эмчилгээ хийлгэхээр Бээжин дэх хятадын анагаах ухааны эмнэлэгт шилжлээ. Гэвч энэ хоёр сарын эмчилгээнд өвчин минь огтхон ч дээрдсэнгүй. Хариуцсан эмч маань бүр эмнэлгийн мэдрэлийн тасгийн тэтгэвэртээ гарсан хуучин даргыг гуйж авчран, намайг үзүүлсэн ч эрүүл мэндийн байдал маань өчүүхэн ч сайжирсангүй. Дараа нь бэр болох гэж байгаа охин маань минийх шиг хүнд, ярвигтай өвчин эмчилж чаддагаараа нэрд гарсан Юньнань дахь нэгэн эмчийг дурдахыг сонслоо. Янз бүрийн ээдрээтэй явдлын дараа би тэнд тэргэнцэртэй хүргүүлж дөнгөв. Гэвч нэг сар шахуу эмчлүүлсний дараа эрүүл мэндийн байдал дээрдээгүйн зэрэгцээ нүд, хөлдөө ууж байсан эм маань үнэндээ бөөрний өвчнийг маань хүндрүүлсэн юм. Туйлын их арга мухардан, асар их тавгүйтсэн би гэртээ харихаар шийдлээ. Үүний дараа, бөөрөө хамгаалахын тулд нүд, хөлд зориулсан бүх эмчилгээ, эмээ больсон юм.

Тухайн үед би ямар ч найдлагагүй болсон мэт санагдаж байлаа. Шинжлэх ухаанд бүх итгэлээ өгсөн ч, өвчнийг минь эмчлэхэд шинжлэх ухаан ямар ч үр нөлөөгүй болж таарсан талаар би үргэлж боддог байв. Шинжлэх ухаан намайг эдгээж чадна гэх хамаг найдлага минь тасарсны дараа би туйлын их хямарч, тэр чигтээ сэтгэлээр унасан юм. Тэгээд цаашид яаж амьдрахаа ер мэдэхгүй байлаа. Шаналал зовлонгийн манан дунд бодол минь үргэлж

---

хяналтаас гардаг байв: “Би яагаад ийм олон өвчнөөр өвдөж байгаа юм бэ? Өвчнийг минь яагаад эмээр эмчилж болохгүй байгаа юм бэ? Би шинжлэх ухаанд итгэж, найдаж, хамгийн сайн эмчилгээг чадах чинээгээрээ хайсан боловч юу ч нэмэр болсонгүй. Үнэндээ эрүүл мэндийн байдал минь бүр ч муудлаа. Шинжлэх ухаан намайг аварч үнэхээр чадахгүй юм гэж үү? Энэ дэлхийд үнэхээр Бурхан байдаг юм болов уу? Хүн бүрийн хувь заяа үнэхээр Бурханы гарт байдаг гэж үү?” Эдгээр асуудлын талаар хэчнээн их бодлоо ч ямар ч хариулт олдохгүй байлаа. Тэр үед би өдөр бүр асар их шаналал, зовлон дунд амьдарч байсан бөгөөд хэрэгцээгүй эрэмдэг хүн гэдгээ бодох бүрдээ нууцхан нулимс унагадаг байсан юм. Гэр бүлдээ маш их чирэгдэл учруулж байгаа мэт санагдаж, тэдэнд төвөг болохыг хүсэхгүй байв. Тэгээд нэг бус удаа амиа хорлохыг хүссэн ч үхлээс айж байлаа. Иймээс би өдөр хоногийг зүгээр л аргацаан, үхэл ирэхийг хүлээдэг байсан билээ...

Нэг өдөр нөхөр маань Төгс Хүчит Бурханы Чуулганы эгчийн надад үлдээсэн номыг хараад, нээж үзэв. “Бурхан хүмүүсийн дунд агуу зүйл хийснийг чи мэдсэн үү?” хэмээх гарчиг харагдсан нь нөхрийн маань анхаарлыг шууд татжээ. Иймээс нөхөр маань надад дараах хэсгийг уншиж өгсөн юм: **“Бурханы ажил бол чиний ойлгож ухаарч чадахгүй зүйл юм. Хэрвээ чи сонголт чинь зөв эсэхийг ч бүрэн ухаарч чадахгүй, Бурханы ажил амжилт олох эсэхийг ч мэдэж чадахгүй бол азаа үзээд, энэхүү эгэл жирийн хүн чамд асар их тус хүргэх эсэхийг, мөн Бурхан үнэхээр агуу ажлыг хийсэн эсэхийг харж яагаад болохгүй гэж?”** (“Үг нь махбодоор илэрсэн” ном). Энэхүү богино хэсэг зүрх сэтгэлийг минь донсолгох мэт болсон юм! **“Азаа үзээд яагаад болохгүй гэж?”** гэх үг тэр тусмаа санаанд орсоор байлаа. Энэ нь эзгүйрсэн зүрх сэтгэлд минь гэрлийн цацраг тусаж байгаа мэт санагдаж, амьд явах найдлага сүүмэлзэн харагдах мэт болов. Би Бурханы үгийн өөр 2 хэсгийг нөхрөөрөө даруйхан уншуулсан нь Бурхан хүмүүсийг шүүж, цэвэрлэж, амьзан чанарыг нь өөрчлөхийн тулд үгээ ашигладаг тухай үнэнийг агуулсан байлаа. Энэ бүхэн миний хувьд цоо шинэ байсан бөгөөд хэлж байгаа зүйлийнх нь бүрэн ач холбогдлыг би үнэндээ ойлгоогүй ч гэлээ эдгээр сургаал бусад хүнээс сонссон Эзэн Есүсийн сайн мэдээнээс өөр байгааг зүрх сэтгэлдээ мэдэрч чадсан юм. Тэд ихэвчлэн хэрхэн нигүүлсэл хүртэх тухай хэлж, өвчнөө эдгээхийн тулд Бурханд итгэхэд л хангалттай гэж ярьдаг байсан бөгөөд үүнд нь би итгээгүй билээ. Харин Төгс Хүчит Бурханы үг хавьгүй бодитой санагдан, сонсох тусмаа илүү ихийг сонсмоор санагдаж байлаа.

Үүний дараа би өдөр бүр нөхрөөрөө Бурханы зарим үгийг уншуулдаг болсон юм. Тэр номд, шашны хүмүүс Бурханд итгэдэг ч Бурханыг мэддэггүй, тэр ч бүү хэл Бурханыг эсэргүүцдэг, мөн өдөр нь нүгэл үйлдэж, шөнө нь нүглээ улайдаг хэмээсэн байлаа. Ээж, хоёр бэр эгч маань бүгд Христэд итгэгч байсан бөгөөд яг Бурханы үгэнд дүрсэлсэн хэв маягаар амьдардаг байсан тул би үүнд бүр ч их үнэмшсэн юм. Тэд үнэхээр нүгэл үйлдээд,

---

түүнийгээ улайн, дараа нь дахин нүгэл үйлддэг байв. Яг тэр үед би сүнсээрээ сэрлээ: Энэ үнэхээр Бурханы дуу хоолой гэж үү? Бурхан биш юм бол зохиолч нь шашны ертөнцийг яаж ийм сайн ойлгодог байх вэ? Үл итгэгчид ойлгодоггүй, агуу, алдартай хүмүүс огт мэддэггүй, шашны хүмүүс ч өөрсдөө Бурханд итгэдэг хэрнээ Бурханыг бас эсэргүүцдэгээ ухаардаггүй шүү дээ. Энэ тухай бодох тусам тус номын үг нь хүмүүсийн илэрхийлж чадах зүйл биш, магадгүй хүмүүний ертөнцөд бие махбодтой болсон Бурханы айлдвар мөн байх гэх мэдрэмж улам их төрсөн юм.

Хэдхэн хоногийн дараа, Төгс Хүчит Бурханы сайн мэдээг надад анх номлосон эгч намайг эмнэлэгт байж байгаад гэртээ эргэн ирсэн гэж дуулаад, сайн мэдээ дахин номлохоор өөр нэг эгчийн хамт манайд ирэв. Энэ удаад би “Намайг тахир дутуу болсон ч эгч нар ой гутан хаясангүй, тэр ч бүү хэл сайн мэдээ номлохоор ахин дахин ирлээ. Эгэл жирийн хүмүүс бол ийм юм хийж чадахгүй. Өөр хүмүүс бол намайг аль эрт мартчихсан байх байсан даа” хэмээх мөс чанарынхаа дууг сонсож байсан юм. Ийм хайр хүмүүний ертөнцөөс хэзээ ч олдохгүй тул Бурханаас ирсэн байж таарна гэдгийг би сэтгэлдээ маш тодорхой мэдэж байлаа. “Зовох цагт нөхрийн чанар танигдана” гэдгийг би тэр өдөр гүнээ мэдэрсэн юм. Гэр бүл маань аргагүйн эрхэнд миний дэргэд үлдсэн хэдий ч надтай ямар ч холбоогүй, мөн ямар ч далд сэдэл, болзолгүй энэ хүмүүсийн хувьд нэг жил гаруйн турш байнга ирж, надад сайн мэдээ номлон, над шиг тахир дутуу хүний төлөө хичээл зүтгэл гаргасан нь тэдний итгэл, хайр, тэвчээр үнэндээ хэчнээн гайхамшигтайг харуулж байлаа! Бурханы хайранд сэтгэл минь үнэхээр уярч, тэр цагаас хойш Бурханы сайн мэдээнээс татгалзах шалтгаан үлдсэнгүй. Иймээс нөхөр бид хоёр хоёулаа Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн зөвшөөрлөө.

2011 оны 6-р сард нөхөр бид хоёр Төгс Хүчит Бурханы Чуулган дахь чуулганы амьдралаа албан ёсоор эхэлсэн юм. Хараа минь ганцаараа уншиж болохуйц сайн биш байсан тул нөхөр минь байнга надад Бурханы үгийг уншиж өгдөг байсан бөгөөд чуулганы цуглааны үеэр ах эгч нар ч бас Бурханы үгийг уншиж өгдөг байлаа. Заримдаа би ганцаараа байх үедээ магтан дуу бас сонсдог байв. Дараа нь би өвчин зовлонгийнхоо шалтгааныг Бурханы үгээс олсон билээ: **“Төрөлт, үхэл, өвчин, өтөл наснаас эхлээд хүмүүсийн туулдаг насан туршийн зовлонгийн эх сурвалж юу вэ? Юунаас болоод хүмүүст эдгээр зүйл байх болсон бэ? Анх бүтээгдэхэд нь хүмүүст ийм зүйлс байгаагүй, тийм биз дээ? Тэгвэл эдгээр зүйл хаанаас бий болсон бэ? Хүмүүс Сатанд уруу татагдаж, махан бие нь доройтсоны дараа бий болсон юм. Хүний махан биеийн өвдөлт, зовлон шаналал, хоосон байдал, мөн түүнчлэн хүний ертөнцийн туйлын золгүй хэрэг явдал нь Сатан хүн төрөлхтнийг завхруулсны дараа л бий болжээ. Сатан хүмүүсийг завхруулсныхаа дараа тарчилгаж эхэлсэн юм. Үүний үрээр хүмүүс улам бүр доройтлоо. Хүмүүсийн**

---

өвчин эмгэг улам бүр хүндэрч, зовлон нь улам хэцүү бэрх болжээ. Хүмүүс хүний ертөнцийн хоосон байдал, эмгэнэлт явдал, түүнчлэн тэнд үргэлжлүүлэн амьдрах аргагүй байдлаа улам их мэдэрч, дэлхий ертөнцөд улам бага найдах болов. Тийнхүү энэ зовлонг Сатан хүмүүст авчирсан билээ... Иймээс чи өвдөж, хүндрэл бэрхшээлтэй тулгардаг ба амиа хорлох боломжтой байдаг, заримдаа бас дэлхий ертөнцийн эзгүйрлийг мэдрэх юм уу амьдрал утга учиргүй санагддаг. Өөрөөр хэлбэл, хүмүүний энэ зовлон одоо ч Сатаны удирдлага дор байдаг; энэ нь хүний аминд халтай сул талуудын нэгийг бүрдүүлдэг” (Христийн ярианы тэмдэглэл номын “Бурхан дэлхий ертөнцийн зовлонг амсахын ач холбогдол”). Өвчний шаналлаас үүдсэн зовлон асар их байсны улмаас би амьдрах бүх хүслээ алдаж, амьдралаа эцэслэхийг хүссэн гэдгийг Бурханы үг яг онож дүрсэлсэн байлаа. Гэхдээ тэр бүх өвчний шаналал, зовлон нь Сатаны хорлонт арга замаас үүдэлтэй гэдгийг Бурханы үгэнд хэлсэн байв. Бурхан яагаад ийм зүйл хэлснийг би эхэндээ төдийлөн ойлгохгүй байсан ч Бурханы үгийг илүү их уншсаныхаа дараа эдгээр үнэнийг аажмаар ойлгож авсан юм.

Нэг өдрийн үдээс хойш, нөхөр минь заншсан ёсоор Бурханы үгийг уншиж өгч байхад би Бурханы ийм үгийг сонсов: “Хүн төрөлхтөн нийгмийн шинжлэх ухааныг үүсгэсэн цагаас хойш хүний оюун санаа шинжлэх ухаан болон мэдлэгт эзэмдүүлсэн юм. Тэгээд шинжлэх ухаан, мэдлэг нь хүн төрөлхтнийг удирдах хэрэгсэл болсон ба хүнд Бурханыг шүтэн мөргөх орон зай хангалттай байхаа больж, Бурханыг шүтэн мөргөх таатай нөхцөл үгүй болсон. Хүний зүрх сэтгэл дэх Бурханы байр суурь улам доошилжээ. Зүрх сэтгэлд нь Бурхан байхгүй болохоор хүний дотоод ертөнц харанхуй, итгэл найдваргүй агаад хоосон... Шинжлэх ухаан, мэдлэг, эрх чөлөө, ардчилал, амралт, тав тух гэх мэт эдгээр зүйл хүнд зөвхөн түрхэн зуурын тайтгарал өгдөг. Эдгээр зүйл байсан ч хүмүүс гарцаагүй нүгэл үйлдэж, нийгмийн шударга бус байдалд гомдоллосоор байх болно. Эдгээр зүйл хүний эрэл хайгуул хийх хүсэл, хорхойслыг барьж чадахгүй. Учир нь хүнийг Бурхан бүтээсэн бөгөөд утга учиргүй золиос, эрэл хайгуул нь хүнийг илүү их гуниг зовлон руу л хөтөлж, хүн төрөлхтний ирээдүй эсвэл угтах замтай хэрхэн нүүр тулахаа мэдэхгүй байнгын айдастай оршин байхад хүргэдэг юм. Тэр ч бүү хэл, хүн шинжлэх ухаан, мэдлэгээс эмээдэг, хоосон мэдрэмжээс бүр ч их айдаг болно” (Үг нь махбодоор илэрсэн номын “Бүх хүн төрөлхтний хувь заяаг Бурхан захирдаг”). Эдгээр үгийг сонсоод л би хүн төрөлхтний бүх өвчин зовлон Сатанаас эхтэй гэж Бурхан яагаад хэлснийг эцэст нь ойлгосон юм. Сатан биднийг завхруулахын тулд мэдлэг, шинжлэх ухааныг ашигладаг. “Хүн мичнээс үүссэн” “Дэлхий дээр аврагч гэж огт байхгүй” “Мэдлэг хувь заяаг чинь өөрчилж чадна” “Бидний хувь заяа бидний гарт байдаг” “Шинжлэх ухаан хүмүүсийг авардаг” “Хүн байгалийг ялан дийлж чадна” гэх зэрэг утгагүй



---

санаагаараа Сатан биднийг дүүргэдэг. Эдгээр гүн ухаан, дүрэм журам, санаа, үзлээр Сатан хүн төрөлхтний тархийг угаасан юм. Тэдгээр нь хүмүүсийн зүрх сэтгэл, сүнсийг эзэлсэн бөгөөд хүмүүсийг албан хүчээр мэдлэгт сохроор итгүүлж, шинжлэх ухааныг шүтүүлдэг. Хүмүүс мэдлэгээр хувь заяагаа өөрчилж чадна, шинжлэх ухааныг ашиглан хэцүү асуудал бүрийг шийдвэрлэж болно гэж төөрөлддөг. Сатаны утгагүй санааг хүмүүс амьдралынхаа үндэс болгосноор Сатаны хоригдол болж, Сатанаар хүлүүлж, хянуулдаг. Хүмүүс Бурханаас ирдэг бүхнийг үгүйсгэж, өөрсдийгөө Бурханы халамж, хамгаалалтаас холдуулж эхэлсэн. Сатан тэднийг утсан хүүхэлдэй мэт удирддаг бөгөөд би ийм маягаар хорлогдож явсан олон сая хүний ердөө л нэг нь байжээ. Би өвчин тусах үедээ эмчлүүлэх гэж шинжлэх ухаанд найдсан; шинжлэх ухаанд сохроор итгэж, шинжлэх ухааныг шүтсэн. Нэртэй эмнэлгийн мэргэжилтнүүд дэвшилтэт техник, орчин үеийн эмнэлгийн тоног төхөөрөмжөөрөө өвчнийг минь анагааж чадна гэж би үнэхээр бодсон юм. Гэвч эрүүл мэндийн байдал минь дээрдээгүйн зэрэгцээ би үнэндээ үхлийн ирмэгт очсон билээ. Шинжлэх ухаан надад гагцхүү зүүд зэрэглээ шиг итгэл найдвар, засаршгүй өвчин шаналал л авчирсан. Шинжлэх ухаан намайг Бурханд итгэхгүй байхад хүргэсэн тул Бурханы эсрэг би удаа дараа тэрсэлж, Түүнийг эсэргүүцэж, авралаас нь татгалзсан юм. Гэвч тэрслүү байдлыг минь үл харгалзан Бурхан намайг аврахаа хэзээ ч болиогүй бөгөөд тэр цагаас хойш үгээрээ намайг замчилсан билээ. Тэгээд мэдлэг, шинжлэх ухаанд нэгэнтээ маш их боогдож явсан сүнсийг минь бага багаар сэрээв. Нэгэнтээ үхэлд ойрхон байсан би одоо Бурханы өмнө ирж, Бурханы авралыг хүртлээ.

Нөхөр минь өдөр бүр надад Бурханы үгийг уншиж өгсөөр байсан бөгөөд нэг өдөр би Бурханы ийм үгийг сонсов: **“Бурхан энэ ертөнцийг бүтээсэн, энэ хүн төрөлхтнийг бүтээсэн, түүнчлэн эртний Грекийн соёл, хүний соёл иргэншлийн зохион бүтээгч нь Тэр байсан. Бурхан л энэ хүн төрөлхтнийг тайтгаруулж, Бурхан л энэ хүн төрөлхтөнд өдөр, шөнөгүй санаа тавьдаг. Хүн төрөлхтний хөгжил, дэвшил нь Бурханы дээд эрхээс салшгүй, хүний түүх болон ирээдүй Бурханы зохиомжоос салшгүй билээ... Хэрвээ хүн төрөлхтөн сайн хувь заяатай байхыг хүсвэл, хэрвээ улс орон сайн хувь заяа хүсэж байвал хүн Бурханыг шүтэн мөргөж, Бурханы өмнө гэмшиж, нүглээ улайх ёстой, эс бөгөөс хүний хувь заяа, хүрэх газар гамшиг сүйрлээр дуусах нь гарцаагүй”** (Үг нь махбодоор илэрсэн номын “Бүх хүн төрөлхтний хувь заяаг Бурхан захирдаг”). Бүх хүний хувь заяа Бурханы гарт байдаг, Бурхан бол хүний амийн эх сурвалж гэдгийг би энэ хэсгийн тусламжтайгаар ухаарлаа. Бурханы өмнө очиж, Бурханыг дагаж, шүтэн мөргөснөөр л хүмүүс сайн сайхан хувь заяатай байж чадна. Бурханаас холдож, Бурханыг эсэргүүцэж, орхиж, оронд нь Сатанд найдах үедээ хүмүүс өөрсдийгөө Сатанд шилжүүлэн өгч байгаа. Үүний үр дүнд Сатан тэднийг хорлож, дэвсэлж, эцэс төгсгөлгүй их гамшиг,

---

хязгааргүй их зовлонд унагадаг. Хүмүүс ийнхүү өөрсдийгөө хорлож, өөрсдийгөө сүйрэлд хүргэдэг аж. Би яг хэчнээн мунхаг, харалган, хөөрхийлөлтэй явснаа тэр мөчид ухаарсан юм. Мэдлэг, шинжлэх ухааны талаарх үзэл бодол маань ердөө бүгд хор, намайг завхруулахдаа Сатаны ашигласан хэрэгслээс цаашгүй байсан гэдгийг би олж харав. Энэ олон жилийн туршид би диаволын хоронд хордож явсан бөгөөд одоо үүндээ үлэмж их гэмшлээ. Тэгээд зүрх сэтгэлийнхээ гүнээс Бурханыг үнэхээр гэмшлээ. Тэгээд зүрх сэтгэлийнхээ гүнээс Бурханыг үнэхээр хүсэн мөрөөсөв. Би Библид тэмдэглэгдсэн Ниневегийн ард түмний адилаар үйлдэж, Бурханы өмнө газарт сөгдөн, нүглээ улайж, гэмшихэд бэлэн байсан юм. Би бүхий л муу замаа орхиж, Бурханы хангасан удирдамж, хангалтыг хүлээн зөвшөөрөхийг хүсэж байлаа. Бурханыг дагаж, шүтэн мөргөхийг хүссэн тул гэртээ хүн байлгах үүрэг авахыг чуулганаас идэвхийлэн хүсэв. Ах эгч нартай харилцаж байхад өвчнөөс минь үүдэн хэн нь ч намайг дорд үзэж, басамжилж байсангүй. Харин ч надад асар их тусламж, дэмжлэг үзүүлдэг байсан бөгөөд тэдний чин сэтгэлийн хайранд өлгийдүүлж байгаагаа би үргэлж мэдэрдэг байлаа.

Хэсэг хугацаа өнгөрсний дараа өвчин минь мөн л дээрдэхгүй байсан тул би Бурханд шаардлага тавьж эхлэн, биеийг минь сайжруулж туслаач гэж гуйх боллоо. Гэвч эгч нар надад ийнхүү нөхөрлөсөн юм: “Бурхан бол бүх зүйлийн Бүтээгч, харин бид бол бүтээгдсэн зүйлс тул Бурхан бидэнд яаж ч хандлаа гэсэн Түүний зохион байгуулалт, зохицуулалтыг бид хүлээн зөвшөөрөх ёстой. Хэрэв бид Бурханаас аливааг хүсэх юм бол эрүүл ухаангүй байдлаа харуулж байгаагаас цаашгүй. Өвчин эдгээх, чөтгөрийг зайлуулах, гайхамшиг үзүүлэх нь Нигүүлслийн эрин үе дэх Бурханы ажлын нэг хэсэг байсан боловч одоо бид Хаанчлалын эрин үед байгаа бөгөөд үгээрээ дамжуулан бүх зүйлийг гүйцэлдүүлж, үгээ ашиглан хүмүүсийн завхарсан зан чанарыг цэвэрлэж, өөрчлөх нь одоо Бурханы үндсэн ажил юм. Бурхан биднийг Өөрийг нь дуулгавартай дагадаг, Өөрт нь үнэнч, Өөрийг нь мэдэж, хайрладаг хүмүүс болгоод, ийм бүлэг хүмүүсийг дараагийн эрин үед аваачихыг хүсдэг. Бурханыг мэдэж авсныхаа дараа хүмүүсийн аяндаа харуулдаг хайр, дуулгавартай байдлыг л Бурхан хүсдэг. Харин хүмүүс өвчнийг нь анагаасанд талархсан сэтгэлээсээ болоод Өөрийг нь дагаасай гэж хүсдэггүй. Бурханы үгэнд хэлдэгчлэн: **‘Бурхан хүнийг аврах үедээ Өөрийн ерөөл, нигүүлслээр дамжуулан сэтгэлийг нь хөдөлгөдөг болохоор хүмүүс зүрх сэтгэлээ Бурханд өгч чаддаг гэж хүмүүс итгэдэг. Өөрөөр хэлбэл, Тэр хүний сэтгэлийг хөдөлгөж байгаа нь түүнийг аварч байгаа хэрэг юм. Ийм аврал нь наймаацсанаар хийгддэг. Бурхан өөрсдөд нь зуу дахин ихийг өгөх үед л хүн Бурханы нэрийн өмнө захирагдаж, Түүний төлөө сайн ажиллаж, Түүнд алдар суу авчрахаар чармайна. Энэ нь хүн төрөлхтний төлөөх Бурханы санаа зорилго биш юм. Бурхан завхарсан хүн төрөлхтнийг аврахын тулд газар дээр ажиллахаар ирсэн; үүнд**

---

**ямар ч худал хуурмаг байхгүй. Эс бөгөөс Тэр ажлаа хийхийн тулд биечлэн ирэхгүй байх байсан нь лавтай. Урьд нь Түүний авралын арга барил хамгийн их хайр, энэрлийг харуулж байсан болохоор Тэр бүх хүн төрөлхтний төлөө Өөрт байгаа бүхнээ Сатанд өгсөн юм. Өнөөдөр өнгөрсөн үетэй огт адилгүй: Өнөөдөр та нарт хайрласан аврал эцсийн өдрүүдэд, бүх зүйл төрлийнхөө дагуу ангилагдах үед тохиолдож байгаа; та нарыг аврах арга барил хайр юм уу энэрэл биш, харин хүнийг илүү бүрэн дүүрэн аврахын төлөөх гэсгээлт, шүүлт юм’ (Үг нь махбодоор илэрсэн номын “Та нар байр суурийн ерөөлийг хойш тавьж, хүнийг аврах Бурханы хүслийг ойлгох ёстой”). Иймээс бид ерөөл хүртэх хүслээрээ өдөөгдөн, Бурхантай наймаацах харилцаатай байдагтаа дүн шинжилгээ хийж, үүнийгээ ойлгох ёстой. Түүнчлэн Бурханы үгийг илүү их уншиж, амьдралдаа хэрэгжүүлэн, Бурханы үг дэх шүүлт, гэсгээлтийг хүлээн зөвшөөрч, харьцалт, засалт, шалгалт, цэвэршүүлэлтийг хүлээн зөвшөөрч, завхарсан зан чанартаа ариусгалт, өөрчлөлтийг олж авахаар эрэлхийлэх хэрэгтэй. Таны өвчин дээрдэх эсэх нь Бурханы гарт байгаа бөгөөд Бурханы зохион байгуулалт, зохицуулалтад бид захирагдах ёстой.”**

Бурханы нигүүлслийг л эдэллээ гээд сатанлаг зан чанар маань өөрчлөгддөггүй гэдгийг эгч нарын нөхөрлөлөөр дамжуулан би ойлгож авсан юм. Бурханы эцсийн өдрүүдийн шүүлт, гэсгээлтийг хүлээн зөвшөөрснөөр л бид завхарсан зан чанараасаа ангижирч, мөс чанар, эрүүл ухаанаа эргүүлэн олж авч, улмаар Бурханы авралыг хүртэн, Түүний хүсэлтэй нийцэлтэй болж чадна. Бурханы эцсийн өдрүүдийн ажлыг хүлээн зөвшөөрдөггүй бүх Христэд итгэгчид Бурханы арвин их нигүүлслийг хүртэж болох ч нүгэл үйлдэж, нүглээ улайх тойрогт амьдарсаар л байдаг. Учир нь тэдний завхарсан зан чанар цэвэрлэгдээгүй ба тэд Бурханы ерөөл, нигүүлслийг хүртэх зорилготойгоор газар сайгүй явж, өөрсдийгөө зарлагаддаг. Өөрөөр хэлбэл, тэд Бурхантай наймаа хийхийг хүсдэг, ийм болохоор Түүний сайшаалыг хэзээ ч хүртэхгүй. Бурханы хүслийг ойлгосныхоо дараа би өвчнийг минь анагаагаач гэж Бурханаас хүсэхээ больж, үүнийхээ оронд эрүүл мэндийн байдал минь хэчнээн сайжирч, муудлаа ч хамаагүй Бурханд итгэж, Бурханыг шүтэн мөргөхөөр бат шийдсэн юм. Би бүтээгдсэн зүйлсийн нэг болохын хувиар үүргээ биелүүлж, үнэнийг эрэлхийлж, Бурханыг улам бүр чин сэтгэлээсээ мэдэхээр хичээж, завхарсан зан чанараасаа ангижран, Бурханыг хангалуун байлгахын тулд жинхэнэ хүн шиг амьдрахаар сэтгэл шулуудлаа. Энэ бүхнийг хэрэгжүүлж эхэлмэгц зүрх сэтгэлдээ би асар их чөлөөлөлт мэдэрсэн бөгөөд өвчин шаналалдаа хүлэгдэж, хязгаарлагдсан мэт санагдахаа больж, үхлээс тэглээ их айхаа больсон юм. Би гагцхүү Бурханд өөрийгөө бүрмөсөн даатгаж, Бурханы тушаал, зохицуулалтыг дуулгавартай дагахыг л хүссэн билээ.

Дараа нь би байнга ах эгч нартай цуглан, Бурханы үгийг уншиж, үнэний талаар нөхөрлөн, Бурханыг магтсан магтан дуулах болов. Зүрх сэтгэл минь асар их баяжиж,

---

тэрхүү баяжилтаар зовлон минь нимгэрч байгааг мэдэрсэн юм. Хамгийн гайхмаар нь гэвэл, бараг мэдэгдэлгүйгээр хөл бадайрахаа больж, аажмаар алхах чадвар маань сэргэж эхэлсэн бөгөөд нэг л мэдэхэд тэргэнцэрт найдах огт хэрэггүй боллоо. Бүр ч гайхмаар нь, нэг өдөр миний хараа гэнэт сайжраад, Бурханы үгийн номд хэвлэгдсэн үгийг харж чаддаг болов. Би Бурханы үгийг эцэст нь харж чадсан юм! Би итгэж чадахгүй байсан ч үнэхээр гайхамшигийг мэдрэв. Зүрх сэтгэлдээ би үгээр илэрхийлэхийн аргагүй баяр баясал мэдэрсэн тул Бурханд тасралтгүй залбирч, Түүнд талархан магтсаар байсан билээ. Энэхүү сайн мэдээг нөхөртөө догдлон дуулгатал нөхөр минь сэтгэл хөдлөлд автав. Тэгээд нүдэндээ нулимстайгаар “Баярлалаа Бурхан минь, баярлалаа Бурхан минь!” гэж ахин дахин дуу алдсаар байлаа. Тийм ээ, энэ үнэн—би Бурханд жаахан л захирагдсан ба Бурхан энэ агуу ерөөлийг надад хайрласан юм. Бурханы эцсийн өдрүүдийн ажилд гайхамшиг үзүүлэх явдал багтдаггүй ч гэлээ Бурханы үгийн эрх мэдэл нь Бурханы гайхамшигийн эрх мэдлээс хол давуу байдгийг би гүнээ мэдрэв. Бурхан бол үнэхээр хүмүүст хайртай, төгс хүчит Бурхан мөн!

Нэг өдөр нөхөр маань хошууны эмнэлэгт байхдаа миний эмчилгээг голлон хариуцаж байсан эмчтэй тааралджээ. Эмч бөөрний эмчилгээ минь хэр ахицтай байгаа, бөөр орлуулах эмчилгээ ашиглаж байгаа талаар нөхрөөс минь асуусан байв. “Бөөр орлуулах эмчилгээ хийлгээгүй ч эрүүл мэндийн байдал нь угаасаа сайжирч байгаа. Одоо алхаж чаддаг болсон, бас хараа нь ч сайжирсан” гэж нөхөр минь хариулжээ. Эмч маш их гайхан: “За, гайхамшиг л гэж тэр байна. Би эхнэрийг чинь бөөр орлуулах эмчилгээ хийлгээд нэлээд удаж байгаа гэж бодсон юм” гэсэн байлаа.

Одоо би хэвийн амьдралаар амьдарч байна. Хамаатан садан, найз нөхөд, хөршүүд маань үргэлж гайхаж, “Чиний эрүүл мэндийн байдал ийм хурдан сайжирна гэж огт бодсонгүй. Бие, сэтгэл чинь хэвийн хүнийх шиг л байна шүү!” гэх мэтийн зүйл хэлдэг юм. Ийм үг сонсох болгондоо би Бурханд талархсан цөөн хэдэн үгээ чимээгүйхэн хэлдэг билээ: “Бурхан минь, надад үзүүлсэн хайр, авралыг тань би насан туршдаа хэзээ ч мартаггүй. Таны төлөө хийж чадах зүйл надад үгүй ч би Таныг дагаж, шүтэн мөргөж, бүтээгдсэн зүйлийн тань нэгийн хувиар үлдсэн амьдралынхаа туршид үүргээ биелүүлж, Таны хайрыг хариулахаар сэтгэл шулуудсан.” Би гүн гүнзгий завхарсан байсан бөгөөд анх Бурханы оршин тогтнолыг хүлээн зөвшөөрөлгүй, Бурханы авралаас удаа дараа татгалзсан ч Бурхан нүглийг минь санагалзаагүйн зэрэгцээ намайг үнэхээр гайхамшигтай байдлаар аварсан юм. Би Бурханы асар их өршөөлийг хүртсэн бөгөөд ийм нигүүлслийг хүртэх ямар ч эрхгүйгээ мэддэг. Шинжлэх ухаан, мэдлэг хүмүүсийг аварч чаддаггүй, гагцхүү эцэс төгсгөлгүй зовлон, айдас, үхлийг л хүмүүст авчирдаг гэдгийг эдгээр мартагдашгүй туршлага надад харуулсан юм. Орчлон ертөнц дэх бүх зүйлийг Бүтээгч, Захирагч л

---

хүмүүст хэрэгтэй амь болон хангалтыг өгч чаддаг. Бурхан бол хүн төрөлхтний амьд үлдэх цорын ганц үндэс суурь бөгөөд хүн төрөлхтний цорын ганц найдвар, золин аврал юм. Хүмүүсийн сайн хувь заяатай байх цорын ганц найдвар нь Бурханыг шүтэн мөргөх явдал билээ. Сатанд гүнээ хууртаж, үхэлд ойр явсан намайг Сатаны нөлөөнөөс аварсанд нь Бурханд талархъя. Бурхан намайг буцаан амьдруулж, бүх зүйлийг Бүтээгч болох Өөрийнхөө өмнө эргүүлэн авчирсан билээ. Одоо би амьдралын гэрэлтэй замаар алхаж байна!